МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН

THE NATIONAL LIBRARY OF MONGOLIA

НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2023

УЛААНБААТАР ХОТ

2024 он

НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2023

(Тайлангийн эмхэтгэл)

УЛААНБААТАР ХОТ

2024 он

ННА 78
DDC 020
Н 615

Нийтийн номын сангуудын тайлан 2023

Эмхэтгэсэн: Б.Сарандэлгэр /Арга зүйч/

Хянасан: Т.Хайдав /МАЗЭШХ-ийн дарга/

ISBN 978-9919-9751-4-2

ӨМНӨХ ҮГ

Номын сангуудыг арга зүйгээр удирдах аргын нэг нь тайлан, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах юм. Монгол Улсын Үндэсний номын сангаас сүүлийн 20 шахам жилийн хугацаанд аймаг, нийслэлийн нийтийн номын сангуудын тайланг эмхэтгэж, уламжлалт хэвлэлээр болон цахимаар хэвлүүлж ирсэн. Энэ нь нийтийн номын сангуудыг бусад номын сангуудын үйл ажиллагаатай өөрийн үйл ажиллагаагаа харьцуулах, туршлага судлах, нэвтрүүлэхэд тус нэмэр болох, арга зүйгээр хангаж буйн нэг илрэл юм. Энэхүү эмхэтгэлийг хүлээдэг, ашигладаг номын санч, судлаачид ч бий болоод байна.

Тухайн жилийн онцлогоос хамаарч номын сангийн үйлчилгээ, тайлангууд онцлог бүхий гарах нь элбэг. 2023 оны тайлангийн эмхэтгэл өмнөх оныхоос ялгаатай онцлог нь: Энэ жил төрөөс соёлын талаар баримтлах бодлого, “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх зорилт, соёлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Соёлын яамнаас “Соёлын сэргэлт” аяныг зохион байгуулсан билээ.

Энэхүү аяны хүрээнд тус аяныг хэрэгжүүлэгч баг хамт олон 21 аймаг 329 сумдын нийтийн номын сангуудад хүрч орон нутгийн иргэд олон нийтэд чиглэсэн соёлын арга хэмжээг зохион байгуулан, соёлын салбарын ажилтан албан хаагчдыг чадавхжуулах сургалтуудыг өгч ажилласан юм. Ийнхүү энэ онд нийт номын сангуудад соёл олон түмний ажил ундарсан жил болж өнгөрлөө.

Эмхэтгэлийн төгсгөлд аймаг, нийслэлийн нийтийн номын сангуудын үйл ажиллагааны статистикийн зарим үзүүлэлтүүдийг хүснэгтээр хавсаргалаа.

Эдгээр мэдээллүүд номын сангуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, сайжруулахад нэмэр болно гэдэгт итгэлтэй байна. Тайлантай холбоотой санал, хүсэлтээ манай номын сангийн lavlagaanomzui@gmail.com хаягаар болон 70112397 утсаар ирүүлнэ үү.

МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Аливаа орны Үндэсний номын сан тухайн орны бичиг соёлын өв, оюуны үнэт бүтээлийг хадгалан хамгаалж хойч үедээ үлдээх үүргээс гадна хэрэглэгчиддээ өөрийн орны болон дэлхийн бусад орны мэдлэг мэдээлэлтэй холбогч гүүр болон ажилладаг. Монгол улсын Үндэсний номын сан энэ хариуцлагатай үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд урт, богино хугацааны стратеги хөтөлбөрөөр дэвшүүлэн төрийн бодлогодоо тусгуулж, хамтран ажиллагсад, үйлчлүүлэгчиддээ ил тод таниулан орчин үеийн мэдээллийн технологид суурилсан шинэ төрлийн үйлчилгээ, хэрэглээг бий болгоход анхаарч ажиллаж ирлээ.

НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ: Соёлын сайдын 2021 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх журам”-ын дагуу байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцэст тайлагнах 15 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 45 арга хэмжээний биелэлтийг Гүйцэтгэлийн удирлагын мэдээллийн цахим санд http://moc.igovernment.mn/ оруулж, баталгаажуулсан 98% биелүүлж ажилласан байна.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ:

Зорилт. 1.1. Уламжлалт төрт ёсны үзэл, нүүдэлчин монголчуудын эрдэм ухааны өвийг үндэсний бичиг, үсэг, баримтат өвөөр дамжуулан үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулан сурталчилна.

Арга хэмжээ 1.1.1. Эзэн Богд Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойд зориулсан "Алтан цуглуулбар-999" номын үзэсгэлэнг 3 сарын хугацаанд Үнэт ховор номын музейн танхимд Чингис хааны түүхэнд холбогдох 860 нэг сэдэвт номоор зохион байгуулж, нийт 2000 гаруй хүнд үзүүлж, энэ хүрээнд 7 арга хэмжээ, 13 судлаачийн яриа видео бичлэгийг хийж олон нийтэд хүргэсэн.[i1] Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн хамтран тус хүрээлэнгийн түүхт 100 гаруй жилийн хугацаанд хэвлэн, нийтлүүлсэн бүтээлийн дээжис номын үзэсгэлэнд 200 гаруй бүтээлийг гаргалаа.

"Алтан цуглуулбар-999" үзэсгэлэнгийн зөвлөхүүд дараах байдлаар бүлэглэн хувааж, хаяг, тайлбар бэлтгэн толилуулсан ба 2023 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн эрдэм шинжилгээний уншлагын танхимаар судалгаанд зориулж, эрдэмтэн судлаачдад чөлөөт сонголтоор байрлуулан уншуулж байна.

1. Монголын нууц товчоо
2. Монголын нууц товчооны эх бичиг
3. Монголын нууц товчоо орчуулга
4. Монголын нууц товчоо судлал
5. Монголын түүхэн сурвалж бичгүүд
6. Монгол цэргийн урлаг ба Эзэнт улсын элчин харилцаа
7. Чингис хааны их үйл хэргийг дэлхийн олон хэлээр бичсэн ном бүтээлүүд

---

1 https://www.facebook.com/National.Library.of.Mongolia/posts/pfbid026MAAS3cnYkyZzZAoa5m8ed5Mhiu1LxdqgQq4eKrNNUj9RD1xFkojv1d6GudB9Awgl

8. Чингис хааны тухай олон хэлээр бичсэн сурвалж бичгүүд
9. Чингис хааны амьдрал ба Монголын Эзэнт улсын түүх
10. Монголын эзэнт гүрний түүх
11. Чингис хааны билиг сургаал
12. Их засаг хууль
13. Чингис хааны түүх ба уран зохиол нийтлэлийн зүйлс
14. Монголын Эзэнт гүрний түүх, Чингис хаантай холбоотой сурвалж бичгүүд
15. Чингис хаан хийгээд түүний залгамжлагчдын тухай хэвлэгдсэн олон улсын үзэсгэлэнгийн цомог
16. Jack Weatherford-ын зохиолууд
17. Чингис хаан судлалын бүтээлүүд
18. Зурагт ном

- “Монгол бичгийн хэрэгслийн он цагийн хувьсал” үзэсгэлэн гаргаж, монголчуудын бичгийн хэрэглэгдэхүүнүүд он цагийг туулан одоо цаг үед хэрхэн хөгжиж өөрчлөгдсөнийг нийт 11 нэрийн 42 бүтээл, бичлэгийн үндсэн хэлбэр тигийг агуулсан бичвэрүүдийг бэлтгэн олны хүртээл болгосон.
- Үнэт ховр номын музейг танхимаар 1081 хүнд, байнгын болон сэдэвчилсэн үзэсгэлэнг нийт 6781 хүнд үзүүлж, цахимаар 43000 хүнд үзүүлэн сурталчилсан.

Арга хэмжээ: 1.1.2. Вэб хуудсанд цахим үзэсгэлэнгээр номыг сурталчлан нийт 6 сан хөмрөгийн 76 номын танилцуулгыг бэлтгэн, фэйсбүүк хуудсаар #ОНЦЛОХ_НОМ_2023 цуврал 26 танилцуулгыг түүх соёлын дурсгалт ном, судрын мэдээллийг зураг, тайлбартай оруулж сурталчилж байна. “Гэрийн номын сан” подкастыг 2 удаа ахмад номын санч, ном зүйч Н.Баясгалан, Баянхонгор аймгийн ахмад номын санч Б.Байгалмаа нар оролцож, веб болон youtbe хуудсаар нийт 2781 хүн үзсэн байна. Номын сан болон үнэт ховор номын сан хөмрөгийн талаар бичлэг контентыг 10 удаа бэлтгэн хүргэсэн ба МҮОНРТ, МОНЦАМЭ агентлагтай зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 18 нэвтрүүлэг хийлгэсэн.



Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоо "На.Болдтой хамт Музей" хөтөлбөрт

Арга хэмжээ: 1.1.3. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 183 дугаар тогтоолын дагуу “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг 2023 оны 8 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших Тайж хайрхан уулын өвөр байгалийн үзэсгэлэнт газар фестивалийн хоймрын индэр дээрх 5 гэрийг монголчуудын баримт өвийг сурталчлан таниулах хүндэтгэлийн өргөө болгож, Соёлын яамны харьяа байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд үзэсгэлэнг хариуцан зохион байгуулсан. Монгол Улсын Үндэсний номын сангийн захирлын 2023 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн А/48 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Ном соёлын баримтат өвийн өргөөг хариуцан “Монголчуудын бичиг номын өв” үзэсгэлэнг биетээр 16 үзмэр, хэвлэмлээр 17 үзмэрийг дэлгэн толилуулж , соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд Гүюг хааны тамгын хуулбар дардсыг үзэгчдэд дарж өгч үйлчлэв. Ном соёлын баримтат өвийн өргөөгөөр нийт 2800 орчим хүн үйлчлүүлж, “Монголчуудын бичиг номын өв” үзэсгэлэнг үзэж сонирхсон ба ажилтнуудын тайлбарт сэтгэл ханамж дүүрэн, ямагт тусгайлан талархлаа илэрхийлж байлаа. Монголын Үндэсний Олон

нийтийн телевизийн шууд нэвтрүүлэг хамтран хийсэн, мөн байгууллагын цахим сүлжээний хаягаар сурталчлан 24169 хүнд түгээх ажлыг хийв.





Зорилт 1.2. Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгаа хийж, бичгийн дурсгал, түүхэн сурвалж бичгийн өвийг бүртгэж мэдээллийн сан бүрдүүлж, эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулна.

Арга хэмжээ: 1.2.1. "Монгол улсын баримтат өвийн бүртгэл"-д нэр дэвшүүлэх маягтад 100 номын мэдээлэл тодорхойлолтыг бичиж, тайланг 2 удаа Соёлын өвийн үндэсний төвд илгээсэн ба бүртгэлийн болон өвийн талаар СӨҮТ-тэй 2 удаа санал, тодруулга өгсөн. Дэлхийн дурсамж хөтөлбөрт нэр дэвшүүлэн бүртгүүлэх өвийн судалгаа 2. Үүнд: "Дээрээс тогтоосон дүрс бүрийг бүртгэсэн дэвтэр" 4 дэвтэр модон үзгийн бичмэл тэжээхүй ухааны ном, "Монгол үсгийн модон бар" номын нэр "Богд ламын зохиосон хувь нэгнээс үүсгэнтуурвисан шашны үүдийг нээгч хэмээх оршив" 2 номын тодорхойлолт, судалгааг хийж байна. БНФУ-ын нийслэл Парис хотноо 2023 оны 5 дугаар сард хуралдсан ЮНЕСКО-ийн "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн Олон улсын зөвлөлдөх хорооны хурлаар гишүүн орнуудаас нэр дэвшүүлсэн баримтат өвийн материалыг судлан хэлэлцэж, 64 хосгүй үнэт дурсгалыг тус хөтөлбөрийн Олон улсын баримтат өвийн жагсаалтад бүртгэсний дотор Монгол Улсаас 2022 онд нэр дэвшүүлсэн Халхын Цогт Хунтайжийн хадны бичээс Олон Улсын баримтат өвийн жагсаалтад бүртгэгдсэн.


unesco
Memory of the World

UNITED NATIONS EDUCATIONAL, SCIENTIFIC AND CULTURAL ORGANIZATION

Certifies the inscription of

Stone Inscriptions of Tsogtu Khung-Taiji, Prince of Khalkha

The National Library of Mongolia
(Institution)

Ulaanbaatar (Town) — *Mongolia* (Country)

ON THE MEMORY OF THE WORLD INTERNATIONAL REGISTER

24 May 2023 (Date)

Audrey Azoulay
Director-General, UNESCO

Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/
May 25 at 1:47 PM

ЦОГТ ХУНТАЙЖИЙН ХАДНЫ БИЧЭЭС ДЭЛХИЙН СОЁЛЫН ӨВӨӨР БҮРТГЭГДЛЭЭ

ЮНЕСКО-ийн "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн Олон Улсын баримтат өвийн жагсаалтад "Халхын Цогт хунтайжийн хадны бичээс" (Stone Inscriptions of Tsogtu Khung-Taiji, Prince of Khalkha) бүртгэгдлээ.

Бүгд Найрамдах Франц Улсын нийслэл Парис хотноо 2023 оны 5 дугаар сард хуралдсан ЮНЕСКО-ийн "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн Олон улсын зөвлөлдөх хорооны хурлаар гишүүн орнуудаас нэр дэвшүүлсэн баримтат өвийн материалыг судлан х... See more

Арга хэмжээ 1.2.2. Гар бичмэл, барын ном, баримтат өвийг судалгааны эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах зорилгоор хүсэлт гаргасан 12 байгууллага, судлаач, иргэнтэй гэрээ байгуулан нийт 18 нэрийн гар бичмэл, барын ном, 3 нэрийн диссертацийг цахимаар хуулбарлан өгч, хамтран ажилласан. Мөн орчин үеийн хэвлэлийн буюу 1956, 1957 оны 2 номоос хэсэгчлэн

12 өгүүллийг цахимаар өгсөн байна. Нийт 23 нэрийн ном, диссертаци, номоос бүрнээр болон хэсэгчлэн цахимаар өгч үйлчлэв.

1.3. “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээ: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл болох утга зохиол, ном хэвлэлийн салбарын оролцоог нэмэгдүүлнэ.

- ХААИС-д байрлах "ОЮУНЫ КАФЕ" кофе шоптой хамтран "НОМ СОЛИЛЦООНЫ БУЛАН" -д 32 ширхэг ном хандивлаж, цаашдын үйл ажиллагааг дэмжин ажиллах эхлэлийг тавьлаа. Нийт 45 хүн.
- БҮТЭЭЛЧ ЗАЛУУС ҮНДЭСНИЙ ХЭЛ, СОЁЛЫН ӨВТЭЙГӨӨ ТАНИЛЦАХ аянд ЕБС-ийн 4 сургуулийн 136 сурагчид Үнэт ховор номын музей үзэж, номын сангийн үйл ажиллагаатай танилцлаа.
- СУИС-ийн Соёлын сургуулийн “Номын сан судлал” хөтөлбөрийн эчнээ, өдрийн ангийн оюутнуудын дунд зохион байгуулсан “Миний ирээдүйн мэргэжил” сэдэвт мэргэжил сурталчлах өдөрлөгт хамтран ажилласан. /60 оюутан/
- Говь сүмбэр, Хөвсгөл аймгийн номын санчдад тус бүр 2 өдрийн сургалт зохион байгуулж, нийт 98 номын санч хамрагдлаа.

- Азийн Өвийн Сан (Asian Legacy Library)-гаас Монгол Улсын Үндэсний номын санд хэрэгжүүлж буй Төвөд хэлт ном судрыг каталогжуулан цахимжуулах төслийн үр дүнгийн танилцуулга арга хэмжээг зохион байгуулж, Буддист цахим өвийн төвийн Цахим архивын инженер Трэйвис Детур, АНУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны ажилтан Эрдэнэчимэг болон Соёлын яам бусад байгууллагын төлөөлөл 64 хүн оролцлоо.
- “Соёлын бүтээлч сар-2023” аяны хүрээнд 3 дахь жилдээ "Mongolian Library Update-2023" Номын санч-Мэдээллийн ажилтнуудын улсын Х зөвлөгөөнийг Соёлын яам, Монгол Улсын Үндэсний номын сан, Монголын номын сангуудын консорциум, Соёл Урлагийн Их Сургууль хамтран 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Үндэсний номын санд зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд 9 илтгэл хэлэлцүүлж, “Үндэсний цахим номын сан нэвтрүүлэлт”, “Номын сангийн сургалт, судалгааг хөгжүүлэх нь” гэсэн хоёр салбар хуралдааныг зохион байгууллаа. Улсын Х зөвлөгөөнд 17 аймаг нийслэлийн төвийн 6 дүүргийн номын санчдын төлөөлөл 120 гаруй номын санч танхимаар оролцсон бол 200 гаруй хүн цахимаар хамрагдсан юм. "Mongolian Library Update-2023" Номын санч-Мэдээллийн ажилтнуудын улсын Х зөвлөгөөнд оролцогчдын зүгээс номын сангийн салбарт тулгамдаж буй асуудал, түүний шийдэл, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон санал зөвлөмж боловсруулан гаргав.

ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

2.1. Номын сангийн цахим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлж, мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах технологийн нөхцлийг бүрдүүлнэ.



Арга хэмжээ: 2.1.1. Цахим хуудасны дагагчдын тоог 44,624 болж дагагчдын тоо 1%-иар нэмэгдсэн . Сурталчилгаа мэдээллийг 936374 хүнд хүргэсэн байна.

Youtbe сувгаар @NationalLibraryofMongolia· 1.14 мянга Захиалагч· 134 видео байгаагийн 26

бичлэг контентыг 2023 онд байршуулан сурталчилж байна.





Соёлын яамны веб сайтын нэгдсэн портал системд байгууллагын веб сайтын мэдээлэл холбон мэдээ, мэдээллийг дамжуулж байна. Номын сангийн системийн шинэчлэл хөгжүүлэлттэй холбоотой хэрэглэгчийн бүртгэлийг "Хур", "Дан" системд холбох гэрээ хийгдэж, холбогдсон.

Үндэсний номын сангийн https://nationallibrary.mn/ вебийг шинэчлэн сайжруулах, хөгжүүлэх ажил хийгдэж номын сангийн маркетингийн менежер болон мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүд вебсайтыг шинэчлэх загвар төсөл, ажлын даалгаврыг судлан гаргаж, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, санал авч, вебсайтыг хариуцсан мэргэжилтэн сүлжээний инженер 2023 онд вебсайтын дизайн, доторх мэдээллүүд өөрчлөн шинэчлэх ажил хийгдэж, вебсайтын загвар болон мэдээллүүдийг өөрчлөн шинэчлэсэн. Вебсайт хөгжүүлэлтийн шатандаа явж байна.
Вебсайтад хуулийн хэрэгжилтийг хангах дараах мэдээллүүд багтсан. Үүнд:

1. Номын сангийн тухай- Танилцуулга, Түүхэн товчоон, Бүтэц, зохион байгуулалт, Захирлын мэндчилгээ, Мэдээ, Нийтлэл, Шинэ номын мэдээ, Архив,
2. Үйлчилгээ- Уншигчийн бүртгэл, Дотоод солилцоо, Гадаад солилцоо, Танхимууд, Журам, Номын санчаас асууя, Шинэ номын хүсэлт
3. Каталог- Цахим каталог, Монгол бичгээрх сурвалж, Үзэсгэлэн, Онцлох ном
4. Холбоосууд- Төвөд ном судрын цахим сан, Сэдэвчилсэн ном зүй, Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим сан, 360°, Шилэн данс, Тендер https://nationallibrary.mn/soyoliin-uviin-uzesgelen/ домейн дээр номын сангийн онцлох бүтээлүүдийг дээжлэн вебсайтад байршуулсан. Ашигласан програм Essential grid плагин.

Арга хэмжээ: 2.1.2. Соёлын яамны СОЯ/202202037/8 гэрээгээр гүйцэтгэгч Ай Си Ти ХК, МУҮНС-гийн ажлын хэсэг хамтран төслийг гүйцэтгэж, сисмемийг хүлээлгэн өгөх үйл ажиллагаа хийгдэж байна.

Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Номын сангийн мэдээллийн нэгдсэн системийн үр дүн, гүйцэтгэлд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилогдон ажиллаж байна.
“Цахим соёл” арга хэмжээний хүрээнд хийгдэж буй Нэгдсэн цахим номын сангийн системийн шинэчлэлт хийгдсэн. Серверийг үндэсний дата центрт байрлуулж, систем суурилуулсан. Коха 22.11 систем суурилуулж, тохируулсан. Цахим номын сангийн сайтын бүтэц, холбогдох хөгжүүлэлтийн эпик баримт бичгийг тус бүрийг судалж, санал өгч баталгаажуулсан. Төслийн гүйцэтгэлийг ажлын даалгаврын дагуу төлөвлөгөө, хуваарь гарган Номын сангийн Коха 22.11 хувилбарыг нэвтрүүлж, дата баазын хөрвүүлэлт, шинэчлэлт хөгжүүлэлтийг хийсэн. Дижитал номын сангийн систем, гар утасны аппликейшн хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэлийг 14 хоног тутам хянаж, гүйцэтгэлийн тайланг 3 удаа хүлээн авч хэлэлцэн, баталгаажуулсан. Цахим төлбөрийн системийн хэрэглээ Qpay үйлчилгээ Сангийн яамнаас шийдвэрлэх асуудлаас шалтгаалан хүлээгдэж байна. Ажлын даалгаврын дагуу гүйцэтгэл 90%.

Монгол Улсын Үндэсний номын сангийн программ хөгжүүлэлт, нэгдсэн сисмемийн тайлан болон дараах хавсралт баримт бичгийг хүлээн авсан.

1. Системийн шаардлагын баримт бичиг
2. Өгөгдлийн сангийн бүтэц зохион байгуулалт, ERD тайлбар толь
3. Сургалтын тайлан
4. Тестийн тайлан
5. Коха хөрвүүлэлтийн ажлын тайлан
6. Серверийн үзүүлэлтийн тайлан







3. ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Эзлэх жин	Ажлын явц	Төлөв	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
		100.0%	97%		9/16/2022	11/10/2023
1	Эхлэлийн үе шат	15.0%	15.0%		9/16/2022	9/8/2023
1.1	Судалгаа, шинжилгээ	10.0%	100%		10/18/2022	9/8/2023
1.1.1	Системийн ерөнхий бүтэц болон цар хүрээг нарийвчилж тодорхойлох	2.5%	100%	Дууссан	10/18/2022	7/25/2023
1.1.2	Өгөгдлийн судалгаа - датабэйс зохион байгуулах	2.5%	100%	Дууссан	11/16/2022	9/8/2023
1.1.3	Холбогдох системүүдийн судалгаа хийх	2.5%	100%	Дууссан	11/16/2022	9/8/2023
1.1.4	Ерөнхий архитектур зураг гаргах	2.5%	100%	Дууссан	12/1/2022	9/8/2023
1.2	Төлөвлөлтийн үе шат	5.0%	5.0%		9/16/2022	1/31/2023
1.2.1	Ерөнхий төлөвлөгөө гаргах	3.0%	100%	Дууссан	1/13/2023	1/31/2023
1.2.2	Оролцогч талуудыг тодорхойлох	1.0%	100%	Дууссан	9/16/2022	11/15/2022
1.2.3	Харилцаа холбооны төлөвлөлт	1.0%	100%	Дууссан	11/4/2022	11/15/2022
2	Гүйцэтгэлийн үе шат	71.0%	71.0%		10/18/2022	10/30/2023
2.1	Хөгжүүлэлтийн өмнөх үе шат	15.0%	15.0%		10/18/2022	7/25/2023
2.1.1	Хэрэглэгчийн шаардлагыг нарийвчлан гаргах, баталгаажуулах	10.00%	100%	Дууссан	10/18/2022	7/25/2023
2.1.2	Эпик документ боловсруулах,батлах	5.00%	100%	Дууссан	10/18/2022	7/25/2023
2.2	Хөгжүүлэлтийн үе шат	45.0%	45%		12/1/2022	10/31/2023
2.2.1	Коха системийн хөрвүүлэлт	10.0%	100%	Дууссан	12/1/2022	7/25/2023
2.2.2	Нэгдсэн хайлтын систем	5.0%	100%	Дууссан	12/1/2022	9/30/2023
2.2.3	Дижитал номын сангийн систем	30.0%	100%	Дууссан	12/1/2022	10/31/2023
2.3	Тестийн үе шат	11.0%	11.0%		5/25/2023	11/02/2023
2.3.2	Функционал тест хийх	6.0%	100%	Дууссан	5/25/2023	10/17/2023
2.3.3	Регресс тест хийх	5.0%	100%	Дууссан	6/5/2023	11/02/2023
3	Нэвтрүүлэлтийн үе шат	9.0%	7.5%		5/25/2023	11/10/2023
3.1	Систем суурилуулалт	5.0%	3.5%			11/10/2023
3.1.1	Сервер орчин бэлдэх / Эрх авч өгөх/	1.0%	100%	Дууссан	5/25/2023	9/20/2023
3.1.2	Production сервер дээрээ тестийн серверээ ажлуулж турших	1.0%	100%	Дууссан	5/25/2023	6/1/2023
3.1.3	Бүтээгдэхүүнийг production орчинд байршуулах	2.0%	100%	Дууссан	5/25/2023	11/06/2023
3.1.4	Интеграцийн тохиргоо	1.0%	50%	Хийгдэжбуй	11/07/2023	11/10/2023
3.2	Нэвтрүүлэлт	3.0%	1.8%			
3.2.1	Нэвтрүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах	1.0%	100%	Дууссан	6/1/2023	9/20/2023
3.2.2	Гарын авлага боловсруулах	2.0%	100%	Дууссан	6/5/2023	10/25/2023

3.2.3	Сургалт орох	1.0%	100%	Дууссан	6/16/2023	11/21/2023
4	Хаалтын үе шат	5.0%	3.5%			
4.1	Хаалтын тайлан	5.0%	3.5%			
4.1.1	Хаалтын тайлан бэлдэх, баталгаажуулах	5.0%	70%	Хийгдэжбуй	6/20/2023	12/01/2023

3.2 ТЕСТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ХавсралтҮ4 Тестийн тайлангаас харна уу.

3.4 СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Гүйцэтгэл	Төлөв	Төлөглөгөөт хугацаа	Бодит хугацаа
1	Сургалтын төлөвлөгөө гаргаж батлуулах	100%	Хангагдсан	2023/07/06	2023/07/06
2	Сургалтын гарын авлага боловсруулах	100%	Хангагдсан	2023/07/06	2023/10/31
2.1	Коха системийн цаасан гарын авлага боловсруулах	100%	Хангагдсан	2023/07/06	2023/10/21
2.2	Коха системийн видео гарын авлага боловсруулах	100%	Хангагдсан	2023/07/06	2023/10/21
2.3	ДНС системийн цаасан гарын авлага	100%	Хангагдсан		2023/10/25
2.4	ДНС системийн видео гарын авлага	100%	Хангагдсан		2023/10/31
3	Сургалт зохион байгуулах				
3.1	Коха /ҮНС ажилтнуудад/	100%	Хангагдсан	2023/07/24-2023/07/25	2023/07/24-2023/07/25
3.2	Коха /Орон нутгийн ажилтнуудад/	100%	Хангагдсан	2023/07/26-2023/07/27	2023/07/26-2023/07/27
3.3	ДНС /ҮНС ажилтнуудад/	100%	Хангагдсан	2023/09/21	2023/10/25
3.4	ДНС /Орон нутгийн ажилтнуудад/	0%	Хүлээгдэж байна	2023/09/22	

Нийслэл, 21 аймгийн бүх сумдын сан хөмрөгийн мэдээ, судалгааг хамтарч хийж, МҮҮНС болон орон нутгийн номын санчдад шинэ системийн туршилт сургалт хийгдсэн ба 2 шатны сургалтыг зохион байгуулж, нийт 200 гаруй мэргэжилтнийг хамрууллаа.

1. Коха программын сургалт
2. Дижитал номын сангийн систем

Сургалтын явцын зургууд:

Номын санч нарт зориулсан Коха программын шинэлчлэл хөгжүүлэлтийн тухай 2 өдрийн сургалтад МУҮНС-гийн 42 мэргэжилтнүүд, орон нутгаас 50 гаруй номын санч мэдээллийн ажилтнууд хамрагдав.

Дижитал номын сангийн системийн сургалтыг ICT Group дээр зохион байгуулж, МУҮНС-ын Ерөнхий номын санч Т.Баярлах, ICT группийн төслийн ахлах К.Сатыгул, систем аналист Г.Баяржаргал нар зохион байгуулж, компанийн мэргэжилтнүүд болох Б.Анужин, Н.Баттөр удирдан явууллаа. 2023.10.25-ны өдрийн сургалт: МУҮНС-аас 16 мэргэжилтэн, 2023.11.21-ний өдрийн орон нутгийн номын санчдын сургалтад 127 мэргэжилтнүүд хамрагдав.



Арга хэмжээ: 2.1.3 Номын сангийн ном, хэвлэлийг цахим хэлбэрт шилжүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

Нийт 41942 ном, хэвлэл, судар цахим хэлбэрт шилжүүлсэн энэ нь нийт сан хөмрөгийн нэр төрлөөр гаргасан /1,412,500 ойролцоогоор/ номын 6% цахимд шилжсэн. 2023 онд 1447 ш орчин үеийн ном, хэвлэлийг цахимд шилжүүлсэн болон цахимаар бүрдүүлсэн. Үүнд: - Орчин үеийн ном, сэтгүүлийн 555 ширхэг 64039-нүүр цахим хэлбэрт шилжүүлсэн. - Монгол бичгээр хэвлэгдсэн 20 ном, хэвлэлийг цахим шилжүүлсэн. - Daisy 3.0 ном-100Ш - Цахим бүрдүүлэлт гадаад дотоот-1010Ш - Төвөд номыг дижиталчлах төслийн ACIP-ийнердийн каталогич нар 2164 судар багцаар (баринтаг) оруулсан. ACIP-ийн каталогичид нийт 24636 гарчиг бүртгэлд оруулаад байна. Түүнээс 1466 багц 20000 гаруй судрын 479979 хуудас цахим хэлбэрт орсон бөгөөд 6100 багц судар зургын боловсруулалтанд орж бүрэн дууссан бөгөөд BDRC вебсайтад байршаад байна. Одоогийн байдлаар 5479 баринтаг судартт донтор хийжээ. Цахим уншлагын үйлчилгээний журам батлагдсан. үйлчилгээг Дижитал номын сангийн системээр дамжуулан хүргэх туршилт хийгдсэн.







Нэмэгдсэн цахим ном ЗЭХ зөрчилгүй

Нэмэгдсэн цахим сонин

Зорилт: 2.2. Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаа, өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага, үндэсний болон олон улсын стандартыг хангасан тав тухтай орчинг бүрдүүлнэ. Номын сангийн барилгыг ашиглалтад оруулах болон нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангана.

Арга хэмжээ: 2.2.1. Байгууллагын дулаан, хэрэглээний цэвэр, бохир ус, цахилгааны аюулгүй байдлыг хангаж, хэсэгчилсэн засвар үйлчилгээг 34 удаа 21 төрлийн засвар хийсэн. Ажлын байранд 6 удаагийн хортон шавьж устгал, ариутгал, халдваргүйтгэлийн ажил хийж гүйцэтгэсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан Ц.Доржбат ажилчдыг ажил үүргээ гүйцэтгэх тухай бүрт нь Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, зөвлөмж өгч гарын үсэг зуруулан тэмдэглэл хөтөлж ажиллаж байна. Цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол, чанартай хийж дотор талбайд нийт 57 удаа, гадна талбайд 6 удаа 1900 мкв тайлбайд их цэвэрлэгээг хийсэн. Уншигчдын хүртээмжийг нэмэгдүүлэх эрүүл мэнд, ногоон хөгжлийг дэмжин байгууллагын гадна талбайд дугуйн зогсоолыг хийж байрлуулав.



Уншлагын их танхимын 380 м2 талбайг хивсэн дрожтой болгож, ая тухтай нөхцөл бүрдүүлсэн.

Арга хэмжээ: 2.2.2. Үндэсний номын сангийн шинэ барилгын гүйцэтгэлд хяналт тавьж, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулалт, төлөвлөлт, баримтлах заавар гаргана.

Соёлын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/02 дугаар “Үндэсний номын сангийн барилгын ажлыг эрчимжүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх тухай” албан даалгаврын дөрөвдүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг Үндэсний номын сангийн баригдаж буй шинэ барилга, барилгын материал, хийцийн бүрэн бүтэн байдлыг хадгалж, харуул хамгаалалтыг хариуцаж, хяналт т Үндэсний номын сангийн барилгын гүйцэтгэгч байсан Акми холдинг ХХК-тай гэрээ цуцалсантай холбоотой 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Соёлын яамны СХОГ-ын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Бямбасүрэн, шинжээч Д.Буманбаяр, Барилгын хяналтын инженер Д.Батчимэг нар болон Үндэсний номын сангаас Захиргааны хэлтсийн дарга Л.Гансүх, Ерөнхий номын санч Т.Баярлах, Ашиглалтын өмнөх түр албаны дарга Б.Бат-Эрдэнэ, нярав Б.Буяннэмэх нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Акми холдинг ХХК-ны төлөөлөл Г.Ганбилэгээс барилгыг хүлээн авч, нийт үлдэгдэл барилгын материал, эд зүйлстйг тоолж хүлээн авч, жагсаалт гарган акт үйлдэн ажилласан.

Дараагийн гүйцэтгэгч шалгаруулах тендер шалгаруулалт, гэрээ байгуулах хугацаанд барилгын харуул хамгаалалтыг хариуцан ажиллах болсон тул 02 дугаар сарын 09-ний өдрөөс 5 дугаар сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд “Аляскийн чоно” хамгаалалтын албатай гэрээ байгуулж, өдөр бүр хяналт тавьж хамтран ажилласан.

Барилгын 1-р давхарын 5 хаалганы цоожны голыг сольж, НБ-03 тэмдэглэгээт лацаар лацадсан. Дээрх хугацаанд гарсан зөрчилгүй, сар бүр тус хамгалалтын албанаас хамгаалалтын нөхцөл байдлын талаарх мэдээллийг хүлээн авч ажилласан. Номын сангийн баригдаж буй барилгын харуул хамгаалалтын гэрээгээр гүйцэтгэсэн ажлын төлбөр 20 сая төгрөгийг Үндэсний номын сангийн урсгал зардлаас санхүүжүүлсэн болно.

2023 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Соёлын яамнаас зарласан 202303001 дугаартай барилгын гүйцэтгэгч шалгаруулах тендерт шалгарч, гэрээ байгуулсан барилгын ажил гүйцэтгэгч “Энхтөгс тэмүүлэл” ХХК-д Соёлын яамнаас ХОХ-ийн дарга Т.Бямбасүрэн, шинжээч Ган-Эрдэнэ, барилгын хяналтын инженер Одгэрэл нар болон Үндэсний номын сангаас Захиргааны хэлтсийн дарга Л.Гансүх, Ерөнхий номын санч Т.Баярлах, Ашиглалтын өмнөх түр албаны дарга Б.Бат-Эрдэнэ, нярав Б.Буяннэмэх нарын бүрэлдэхүүнтэй хүлээн авсан актын дагуу барилгын материалыг хүлээлгэн өгч, хаалганы бүх түлхүүрүүдийг хүлээлгэн өгч, харуул хамгаалалтын “Аляскийн чоно” хамгаалалтын албатай гэрээг дуусгавар болгов.



Гүйцэтгэгчээр шалгарсан “Энхтөгс тэмүүлэл” ХХК-ны барилгын гүйцэтгэлийн ажилд өдөр бүр хяналт тавьж хамтран ажиллаж байна.

“Нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлын тайлан”, “Үндэсний номын сангийн шинэ барилгад нүүлгэн шилжүүлэх ажлын цогц төлөвлөгөө”, "Нүүлгэн шилжүүлэхэд баримтлах заавар"-ыг шинэчлэн боловсруулан Соёлын яамны ажлын хэсэгт танилцуулж, чиглэл авч ажиллаж байна. Нүүлгэлтийн 80 сая төгрөгийн төсөв баталж, эрх шилжүүлснээр тендер шалгаруулж Grand max компани 10000 хайрцгийг МУҮНС-д хүлээлгэж өгсөн. үлдэгдэл 38,200,000 төгрөгийн нүүлгэн шилжүүлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, хэрэглэгдэхүүний үнийн судалгаа, төсвийн тооцооллыг хийж, 3 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж нүүлгэлтэнд шаардлагатай байгаа бараа материал худалдан авсан.

Арга хэмжээ: 2.2.3. Сан хөмрөгийн ном, хэвлэлийг нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллана.

Бэлтгэл ажил-100% хүрсэн. Өрнө дахины сан хөмрөгийн 141000 ширхэг номын баркод хэвлэж, зүсэж, нааж, буцаан байрлуулсан. 18000 ширхэг сэтгүүлийн нүүр, хаягийг хэвлэн, баркоджуулж, нэгжлэн хавтасласан ба буцаан байрлуулсан. Нийт 35500 нэгж бэлэн болсон. 56345 номын мэдээллийг КОХА системд редакц хийн засварласан. Төлөвлөгөөт тооллогыг Өрнө дахины сан хөмрөгийн аравтын ангийн редакц хийж, 490100 ширхэг номыг тоолсон байна.

Арга хэмжээ: 2.2.4 Шинэ барилгын хөрөнгө оруулалт, техник, тоног төхөөрөмж, тавилга тохижилтын б Соёлын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/02 дугаар “Үндэсний номын сангийн барилгын ажлыг эрчимжүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх тухай” албан даалгаврын дөрөвдүгээр зүйлийн 4.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэн нийлүүлж буй техник, тоног төхөөрөмж, дагалдах ажил, үйлчилгээг тухай бүр хүлээн авч, акт үйлдэн, эд хөрөнгийн бүртгэлд бүртгэж, баталгаажуулах ажлын гүйцэтгэл 92.2%-тай ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын “XIV.3.11 Үндэсний номын сангийн өргөтгөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ нийлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх Соёлын сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/156 дугаар тушаалаар баталсан “Тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн тодорхойлолт, багцлалт СОЯ/2022020337/1-14 дугаартай нийт 14 багцад хуваан 2022 онд 11 багцын нийлүүлэх газар шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Багц 7, 13, 14 Үндэсний номын сангийн өргөтгөлийн тавилга, тоног төхөөрөмжийн 2 багц 2023 онд гэрээ байгуулсан. Тоног төхөөрөмжийг хүлээн авч эхлээгүй болон хэсэгчлэн авсан дуусаагүй, багцууд: 1, 2, 7, 10, 13 зэрэг болно. Хүлээн авсан багцын тоног төхөөрөмжүүд нийлүүлэгч талын агуулахад гэрээний нөхцөлийн дагуу хадгалагдаж байна. Улсын хөрөнгө оруулалтын төсвөөр нийлүүлэх техник тоног төхөөрөмж хүлээн авах тушаал, холбогдох хууль, журмын хүрээнд ажил үргэлжилж, СХОГ-ны Хөрөнгө оруулалтын хэлтэстэй хамтран, өгсөн удирдлага, чиглэл авч ажиллаж байна.



(2023 оны 12 дугаар сарын 04-ний байдлаар)

Арга хэмжээ: 2.2.4 Шинэ барилгын хөрөнгө оруулалт, техник, тоног төхөөрөмж, тавилга тохижилтын бэлтгэл ажлыг хийнэ.

Соёлын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/02 дугаар “Үндэсний номын сангийн барилгын ажлыг эрчимжүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх тухай” албан даалгаврын дөрөвдүгээр зүйлийн 4.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэн нийлүүлж буй техник, тоног төхөөрөмж, дагалдах ажил, үйлчилгээг тухай бүр хүлээн авч, акт үйлдэн, эд хөрөнгийн бүртгэлд бүртгэж, баталгаажуулах ажлын гүйцэтгэл 92.2%-тай ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын “XIV.3.11 Үндэсний номын сангийн өргөтгөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ нийлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх Соёлын сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/156 д угаар тушаалаар баталсан “Тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн тодорхойлолт, багцлалт СОЯ/2022020337/1-14 дугаартай нийт 14 багцад хуваан 2022 онд 11 багцын нийлүүлэх газар шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Багц 7, 13, 14 Үндэсний номын сангийн өргөтгөлийн тавилга, тоног төхөөрөмжийн 2 багц 2023 онд гэрээ байгуулсан. Тоног төхөөрөмжийг хүлээн авч эхлээгүй болон хэсэгчлэн авсан дуусаагүй, багцууд: 1, 2, 7, 10, 13 зэрэг болно. Хүлээн авсан багцын тоног төхөөрөмжүүд нийлүүлэгч талын агуулахад гэрээний нөхцөлийн дагуу хадгалагдаж байна. Улсын хөрөнгө оруулалтын төсвөөр нийлүүлэх техник тоног төхөөрөмж хүлээн авах тушаал, холбогдох хууль, журмын хүрээнд ажил үргэлжилж, СХОГ-ын Хөрөнгө оруулалтын хэлтэстэй хамтран, өгсөн удирдлага, чиглэл авч ажиллаж байна.

Зорилт: 2.3. Соёлын салбар дахь нэгдсэн тогтолцоо, хамтын ажиллагааны хүрээнд соёлын үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэнэ.

Арга хэмжээ: 2.3.1 Аймаг, орон нутагт соёл, урлаг, соён гэгээрүүлэх чиглэлээр номын сангийн эрх зүйн орчин, мэргэжил арга зүйн сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, соёл танин мэдэхүйн ажлын хүрээнд хамтран иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлнэ.

Баруун бүс-Баян-Өлгий аймагт “Соёлын сэргэлт-2023” аяныг Соёлын яамнаас баталсан хуваарийн дагуу Монгол Улсын Үндэсний номын сан, Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа хамтран 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрүүдэд 13 сум, 1 тосгонд багийг маршрутын 4 багт зохион байгуулан нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Аймгийн төв болон сумдын хөтөлбөрийн дагуу Баян-Өлгий аймгийн СУГ, харьяа соёл урлагийн байгууллагууд, соёлын төв, уран бүтээлчидтэй хамтран соён гэгээрүүлэх лекц, чадавхжуулах сургалт, үзэсгэлэн, соёлын болон номын сангийн боловсролын хөтөлбөрийг нийт 10921 хүнд, зохион байгуулсан

ажлын соёлын хүртээмж нь нийт давхардсан тоогоор 33854 хүнд хүргэсэн ба арга хэмжээний мэдээ, мэдээллийг "Соёлын сэргэлт 2023" цахим хуудсаар сурталчлан түгээсэн.



1-р маршрут

№	Сумын нэр	Хүн амын тоо	Очих огноо	Зохион байгуулах өдөр	Сум хоорондын зай /км/
I баг					220
1	Сагсай	5405	09.15	09.15	25км
2	Буянт	2847	09.13	09.14	75 км
3	Алтай	4342	09.12	09.13	120 км

2-р маршрут

№	Сумын нэр	Хүн амын тоо	Очих огноо	Зохион байгуулах өдөр	Сум хоорондын зай /км/
II баг					545
4	Толбо	4364	09.15	09.15	70 км
5	Дэлүүн	7613	09.14	09.14	150 км
6	Булган	5163	09.12	09.13	320 км

3-р маршрут

№	Сумын нэр	Хүн амын тоо	Очих огноо	Зохион байгуулах өдөр	Сум хоорондын зай /км/
III баг					310
7	Улаанхус	9876	09.15	09.15	45 км
8	Цэнгэл	8922	09.14	09.14	75 км
9	Цагааннуур тосгон	1680	09.12	09.13	80 км
10	Ногоонуур	8254	09.12	09.12	110 км

4-р маршрут

№	Сумын нэр	Хүн амын тоо	Очих огноо	Зохион байгуулах өдөр	Сум хоорондын зай /км/
IV баг					170
11	Бугат	4021	09.15	09.15	5 км
12	Алтанцөгц	2887	09.14	09.15	45 км
13	Баяннуур	4971	09.12	09.13	120 км

Баян-Өлгий аймагт явагдаж байгаа "Соёлын сэргэлт-2023" аяны 2023 оны 09 дүгээр сарын 11-15-ны өдрүүдийн соёлын хүртээмжийн тоон мэдээ

№	Сумын нэр	Нээлтийн үйл ажиллагаа	Мэргэжил арга зүйн сургалт	Боловсролын хөтөлбөр	Урлагийн тоглолт	Үзэсгэлэн	СБҮ эрхлэгч	Нийт тоо
1	Өлгий	1462	128	968	1462	1256	60	**5336**
2	Ногоонуур	694	8	382	580	520	12	**2196**
3	Цагааннуур	397	6	265	365	300	14	**1347**

4	Цэнгэл	793	7	540	400	580	15	**2335**
5	Алтай	852	5	400	650	620	16	**2543**
6	Буянт	734	8	360	450	550	14	**2116**
7	Булган	860	6	582	620	560	20	**2084**
8	Дэлүүн	821	7	570	600	600	15	**2613**
9	Баяннуур	685	6	250	480	360	9	**1790**
10	Алтанцөгц	650	8	308	560	525	21	**2072**
11	Улаанхус	572	9	286	400	450	15	**1732**
12	Сагсай	863	6	549	580	600	12	**2610**
13	Толбо	726	6	580	450	560	25	**2347**
14	Бугат	812	9	618	620	652	22	**2733**
	Нийт	**10921**	**219**	**6658**	**8217**	**8133**	**270**	**33854**



“Номын сангийн нэг өдөр” боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэв.
/Буддаг зурагт хуудас/

Арга хэмжээ: 2.3.2 "Соёлын орон зай 2023" арга хэмжээг зохион байгуулна."Соёлын орон зай 2023" арга хэмжээ нь албан ёсоор зохион байгуулагдаагүй. Бичиг үсгийн дурсгал, ном хэвлэл, зохиолчдыг сурталчлах үзэсгэлэн, зөөврийн номын сангийн үйлчилгээ, цахим номын сангийн цахим үйлчилгээ, номоо солилцъё арга хэмжээнүүдийг "Соёлын бүтээлч сар 2023", "Соёлын сэргэлт-2023" аяны хүрээнд болон Үндэсний номын баярын арга хэмжээний төлөвлөгөөнд оруулж, олон нийтэд сурталчилсан. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Соёлын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын 2023 онд хамтран ажиллах гэрээнд нийслэлийн иргэд, олон нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр тусгагдсаны дагуу, Үндэсний эв нэгдэл, Монгол өв соёлыг сурталчилсан олон талт ажил зохион байгуулах, Хүмүүнлэг, оюунлаг хотын иргэдийг бэлтгэхэд боловсрол, соёлын байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлж, Хотын соёлыг төлөвшүүлнэ гэсэн зорилтын хүрээнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй Соёл, урлагийн байгууллагуудын нэгдсэн өдөрлөг 2023 оны 04 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж ажилласан.Мөн Соёлын яамны “Эцэг эхийн зөвлөл”-тэй хамтран "Эртэч өглөө", СУИС-ийн Соёлын сургуулийн багш нарын "Өөдрөг өглөө" лекц, Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтан,



албан хаагчдад "Өглөөний уулзалт" зэрэг арга хэмжээнд танилцуулга хийлээ.

Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ:

Зорилт: 3.1. Үндэсний соёлын өв, оюуны бүтээлийн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.

Арга хэмжээ: 3.1.1. Гар бичмэл, барын эртний гар бичмэл ном, судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор гар бичмэл, монгол судлалын сан хөмрөгөөс “Хэ Ван Юань-ы бичиг”, “Жүн дагинын тууж” зэрэг 6 нэрийн гар бичмэл номын 410 хуудас буюу 820 нүүр сэргээн засварласан. /Сэргээн засварлагч Ү.Доржоо ХБНГУ-ын Хумболтын Их сургуулийн Ази, Африк судлалын хүрээлэнгийн Төв Азийн семинарын Монгол судлалын салбарт 2023.04.16-06.14-ний хооронд ажиллаж, Берлин хот дахь

Германы Улсын төв номын сан болон тус номын сангийн Сэргээн засварлах төвийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлан, номын сангийн ажилтнуудад танилцуулга зохион байгуулсан./

Арга хэмжээ: 3.1.2 Түүх, соёлын дурсгалт зүйлийн хосгүй үнэт, үнэт зэрэглэлд хамаарах болон ганц хувь бүтээлийг цахим хэлбэрт оруулж баримтын хамгаалалтын хувь хийж, эх баримтаас тусад нь хадгалах зорилгоор 625 нэр төрөл “Эртний гар бичмэл ном судар, диссертаци, сонин сэтгүүл”-ийн 52389 хуудас 101586 нүүр тоон хэлбэрт оруулсан.

3.2. Сан хөмрөгтөө судалгаа хийсний үндсэн дээр үндэсний соёлын өв, оюуны бүтээлийг бүрдүүлж, баяжуулна.

Арга хэмжээ: 3.2.1. Сан хөмрөгийн бүрдүүлэлтийн судалгаа- 20 удаа хийсэн /2023 оны 1-4 улирал, 2023 оны бүрдүүлэлтийн төрөлд хэлний, шинжлэх ухааны, сан хөмрөгийн байдлаар хийсэн судалгаа/ Бүрдүүлсэн ном- Уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн 218 нэрийн 1057 ширхэг 30,704,876 төгрөгийн номыг шинээр худалдан авч, бэлэг хандивын журмаар 518 нэрийн 1526 ширхэг 25,481,800 төгрөгийн ном, заавал авах хувиар 88 нэрийн 388 ширхэг 8,710,000 төгрөгийн, 190 нэрийн 190 ширхэг 1,990,000 төгрөгийн диссертаци CD, нөхөн бүрдүүлэлтээр 19 нэрийн 32 ширхэг 951,000 төгрөгийн ном, солилцоогоор 381 нэрийн 385 ширхэг 10,049,600 төгрөгний ном Нийт 1414 нэрийн 3578 ширхэг 77,887,276 төгрөгийн номоор сан хөмрөгийг баяжуулсан.
Данс бүртгэлд бүртгэсэн - 3407 ном, 1940 нэрийн 3407 ширхэг номын нэгбүрчилсэн бүртгэлийг цахим хэлбэрт оруулсан. Ангилсан- 3407 ном, каталогт 5016 карт бичиж, 4380 карт байрлуулж, Редакц- 24680, Индикатор тавьсан -1358. Тооллогоор гар бичмэл болон барын 21340 ширхэг, монгол судлалын монгол, орос, гадаад хэл дээрх 23523 ширхэг, диссертаци, автореферат 13171 ширхэг нийт 58034 ширхэг ном, судар, диссертаци, автореферат тоолж, дүнг гаргасан. Өрнө дахины сан хөмрөгийн аравтын ангийн 3148 номонд редакц хийж, Өрнө дахины сан хөмрөгийн 10-н ангийн номыг тоолох тооллого эхэлж 475348 ширхэг номыг тоолоод байна.



Арга хэмжээ: 3.2.2. Заавал авах хувиар 190 нэрийн 190 ширхэг 1,990,000 төгрөгний диссертаци CD, 88 нэрийн 388 ширхэг 8,710,000 төгрөгний ном хүлээн авсан. Архивын сан хөмрөгт 636 нэрийн 636 ширхэг 13,350,389 төгрөгний ном хүлээн авч, 166 нэрийн тогтмол хэвлэлийн байрлуулж, карт бичсэн – 636 нэрийн 636. Бэлтгэл фондод хүлээн авч байрлуулсан номын тоо 95 нэрийн 365 ширхэг ном 8,909,800 төгрөгний ном хүлээн авсан. Гадаад солилцоогоор: Харилцаат номын санд илгээсэн (Гадаадын 14 улсын 22 номын сан, эрдэм шинжилгээний байгууллагууд руу) 16 нэрийн 172 ширхэг 4,195,000 төгрөгний ном - Харилцаат номын сангаас хүлээн авсан ном - 381 нэрийн 385 ширхэг 10,049,600 төгрөгний ном -Харилцаат номын сангаас хүлээн авсан сэтгүүл - 113 нэрийн 1106 ширхэг 3,965,370 төгрөгний, -Харилцаат номын сангаас хүлээн авсан сонин - 2 нэрийн 2361 ширхэг 436,840 төгрөг.

#ЭРДЭМ_НОМЫН_ЧУУЛГАН-2023 Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Монгол Улсын Үндэсний номын сан, Шинжлэх Ухааны Академи хамтран 2019 оноос хойш 5 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж буй “Эрдэм номын чуулган” үйл ажиллагааны хүрээнд номын танилцуулгыг цувралаар хүргэж нийт 12 цувралаар болон подкастыг бэлтгэн цахимаар сурталчилсан.

ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдээс 287 ном бүтээлийг Монгол Улсын Үндэсний номын санд хандивлалаа. Ингэснээр 2019 оноос эхэлсэн уг үйл ажиллагаагаар 692 нэр төрлийн 1137 номыг номын сангийн сан хөмрөгт хандивлаад байгаа ба эдгээр номын уншлага үйлчилгээнд гарч буй эргэлт жил ирэх тутам өссөн үзүүлэлттэй байгаа юм.

“Эрдэм номын чуулган-2023” аяны хүрээнд 2022 онд хэвлэгдсэн судалгааны бүтээлүүдийг хандивлах, батламж гардуулах ёслолын ажиллагааг 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж, Монгол Улсын Үндэсний номын сан, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Археологийн хүрээлэн, Газарзүй, геоэкологийн хүрээлэн болон "Болор судар" хэвлэлийн газраас эрхлэн гаргасан 300 гаруй нэр төрлийн ном бүтээлийг хямдралтай үнээр худалдааллаа.

Зорилт: 3.3. Үндэсний ном зүйн нэгдсэн мэдээллийн санг байгуулах ажлыг зохион байгуулах, бүх төрлийн номын санг эрдэм шинжилгээ, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.

Арга хэмжээ 3.3.1. Тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санг нийт **13392** өгүүллээр баяжууллаа. “Тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн сан”-д Өдрийн сонинд нийтлэгдсэн **973** материал шивж, баяжуулсан. Тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санг өргөжүүлж идэвхижүүлэх үүднээс орон нутгийн сургалт зөвлөгөөн дээр орон нутгийн ном зүйн бүртгэлийн ач холбогдол хийгээд түүнд нэгдсэн сан хэрхэн нөлөөлөх талаар мэдээ мэдээлэл өгч аймаг бүрийн ном зүйчидтэй холбогдож, заавар зөвлөгөөг тогтмол өгч алдааг нь засуулан хянан ажиллаж байна. "Монгол улсад хэвлэгдсэн ном зүйн бүртгэлүүд: Ном зүйн ном зүй" бүртгэлийг хянаж, “Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл" (2018)-г бэлтгэн хэвлүүлэхээр хэвлэлд өгсөн. Үзэсгэлэн, санамж өгөх ном зүйд зориулж нийт 59 удаагийн үзэсгэлэнд 4701 номын жагсаалт гаргажээ.

Ном зүйн лавлагаа нийт 915 удаа өгсөн. “Шинэ номын мэдээ” товхимолын 2023 оны №2-6,7 дугаарыг бэлтгэн, хянаж хэлтсүүд, харъяа байгууллага, номын сангийн уншигч, хувь хүмүүст сар бүр и-мэйл хаягаар нь хүргэж сурталчиллаа. /160 хүнд/.

Арга хэмжээ 3.3.2. Соёлын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/118 дугаар баталсан Үндэсний ном зүнй нэгдсэн мэдээллийн сан байгуулах тухай тушаалын хэрэгжилтийг ханган Үндэсний Цахим ном зүй бүртгэлд нийт 4016 нэрийн ном, диссертаци бүртгэв. Үндэсний цахим ном зүйн бүрдүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх, ном хэвлэлийн салбарынхан, олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор тус хэлэлцүүлгийг цахимаар зохион байгуулсан. 30 гаруй хүн хамрагдсан.

“Тогтмол хэвлэлийн өгүүллийн номзүйн бүртгэл" (2018)-г бэлтгэн хэвлүүлэхээр эх бэлтгэлд шилжүүлсэн. "Цахим эрин үеийн Үндэсний ном зүйн нийтлэг практик" гарын авлагын редакци дээр ажиллав.



- **ШУА-ийн Одон орон, герфизикийн хүрээлэн:** ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн Сансар судлалын төв Монгол Улсын баатар, сансрын нисгэгч Ж.Гүррагчаагийн хувийн ном, цуглуулгаар номын сан байгуулахаар ажиллаж буй бөгөөд уг ажилд мэргэжлийн зүгээс арга зүйн зөвлөгөө авах хүсэлт ирүүлсний дагуу Монгол Улсын Үндэсний номын сангийн номзүйч Т.Түвшинтунгалагийн хамтаар тус хүрээлэнд ажиллаж, зөвлөгөө өглөө. Цаашид сансар судлал, одон орны судлалын бүтээлүүдийг сурталчлан таниулах үйлсэд хамтран ажиллахаар боллоо. Таштрамд дуулгахад уг номын санг Монгол Улсын хөдөлмөрийн баатар, сансрын нисгэгч М.Ганзоригийн нэрэмжит болгохоор төлөвлөж буй ажээ.
- **УСУГ-ийн сургалт судалгааны төв:** "Үндэсний цахим ном зүй"-н ажлын хүрээнд 2022 онд хэвлэгдсэн ном, бүтээлийн цахим ном зүйн нээлттэй нэгдсэн санг үүсгэхээр ажилласан. Уг ажилд Ус сувгийн удирдах газрын хамт олон нэгдэж 2022 онд хэвлүүлсэн зохиол бүтээлүүдээ хандивлалаа. Ингэснээр тус байгууллагаас хэвлэгдсэн номын агуулга, хэвлэн нийтлэлийн мэдээллийг үндэсний болоод олон улсын байгууллагуудад дэлхий дахины жишиг, стандартын дагуу татаж ашиглах боломж бүрдэнэ. Мөн Монгол Улсын Үндэсний номын сангийн мэргэжилтнүүд тус байгууллагын номын сангийн үйл ажиллагаатай арга зүйч Б.Гантулгын хамтаар очиж, танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

3.4. Үндэсний номын сан нь бусад номын санг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

Арга хэмжээ 3.4.1. Үндэсний номын сан нь бусад номын санг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлнэ. Нийт зохион байгуулсан сургалт 24 үүнээс орон нутагт 13 аймагт арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Зохион байгуулсан хэлэлцүүлэг- 6.

Нийтийн номын сангуудын тайлангийн эмхэтгэл: 21 аймаг, 5 тусгай номын сангийн тайланг бичгээр болон статистикийн маягтаар хүлээн авч нэгтгэн гаргалаа. Ингэхдээ уг эмхэтгэлийг цахим хэлбэрээр гаргаж номын сангийн вэб сайтал байршуулсан. Цахим эмхэтгэлдээ ISBN буюу олон улсын номын дугаарыг авч, нийтлүүлсэн. Мөн уг тайлангаас шилдэг үйлчилгээ үзүүлсэн аймгийг шалгаруулж, Үндэсний бичиг үсгийн баяраар номын сангаас олгодог “Ном цом” шагналыг гардуулсан. Уг шагналын эзнээр Орхон аймгийн нийтийн номын сан шалгарсан.

Мэргэжил, арга зүйн сургалтаас онцлох ажлууд:

- “Ном хэвлэлийн салбарын зохиогчийн эрх, оюуны өмч, соёлын өвийн хамгаалалт” сэдэвт хэлэлцүүлэг: Дэлхийн ном, зохиогчийн эрхийн өдрийг тохиолдуулан тус хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр Соёлын яамны Стратеги, хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга З.Баянзул “Соёлын салбарын хууль, эрх зүйн баримтууд дахь зохиогчийн эрхийн зохицуулалт”, Монголын номын сангийн консорциумын Гүйцэтгэх захирал Ч.Мөнх-Эрдэнэ “Номын сангуудын цахим номын сангийн хэрэглээ, зохиогчийн эрхийн асуудал”, Оюуны өмчийн газрын Зохиогчийн эрхийн газрын мэргэжилтэн Г.Энхчимэг “Оюуны өмч, зохиогчийн эрхийн зарим асуудал”, МУБИС-ийн номын сангийн захирал Ж.Баатарсүрэн “Их, дээд сургуулийн номын сангийн цахим үйлчилгээ” сэдвээр илтгэж, хэлэлцүүлэг зохион байгуулав. 60 гаруй номын санч, мэдээллийн ажилтан хамрагдав.

- **Хамтын цахим мэдээллийн сан үүсгэх нь хэлэлцүүлэг:** УИХ-ын дарга Г.Занданшатарын ивээл дор 33 дахь удаагаа зохион байгуулагдаж буй "Үндэсний номын баяр"-ын өдрийг тохиолдуулан номын санч, мэдээллийн ажилтнуудын дунд уг чөлөөт хэлэлцүүлгийг Монгол Улсын Үндэсний номын сан, Mongolian Libraries Consortium - Монголын Номын Сангуудын Консорциум хамтран зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн эхэнд МУҮНС-ийн АӨТА-ны дарга Б.Бат-Эрдэнэ Цахимаар мэдлэгийг хуваалцаж ирсэн туршлагууд (МУҮНСангийн жишээн дээр), МУҮНС-ийн ном зүйч Г.Баяртуяа Баримт, мэдлэгийг цахимжуулж хуваалцах нь, МУБИС-ийн номын сангийн захирал Ж.Баатарсүрэн Мэдлэгийн үйлдвэрлэлийн гол бааз нь номын сан, СЭЗИС-ийн номын сангийн захирал Д.Нэргүй ИДС-ийн цахим сангийн хэрэглээ сэдвийн дор танилцуулга, мэдээлэл хийсэн. Үүний дараагаар уг сэдвийн дор чөлөөт хэлэлцүүлгийг явууллаа. Хэлэлцүүлэгт нийслэлийн, орон нутгийн нийтийн болон ЕБС, ИДС-ийн номын сангийн төлөөлөл 30 гаруй мэргэжилтэн хамрагдсан.

- "**Номын сангийн** мэдээлэл ном зүйн ажил" сэдэвт сургалтанд оролцогчдыг дадлагажуулах хичээл заасан. СУИС-аас зохион байгуулсан "Номын сангийн мэдээлэл ном зүйн ажил" сэдэвт сургалтанд "Лавлагаа-ном зүйн аппарат", "Гадаад орны ном зүйн туршлага", "Ном зүйн цахим мэдээллийн сан үүсгэх" сэдвээр хичээл бэлтгэн орсон. Сургалтанд оролцогчдыг Зотеро программ дээр дадлагажуулах хичээл орсон. Сургалтанд оролцогчдоос авах шалгалтын асуулт, тест бэлтгэсэн.
- **Өмнөговь:** Тус аймгийн ИТХ, ЗДТГ, Соёл урлагийн газраас хэрэгжүүлж буй "Нутгийн хишиг" хөтөлбөрийн хүрээнд тус аймгийн соёл урлагийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг 2023 оны 02 сарын 03-ны өдөр Даланзадгад хотод зохион байгуулсан. Номын сангийн салбар сургалтад аймгийн сумдын соёлын төв, ЕБС, нийтийн номын сангийн 46 номын санч, мэдээллийн ажилтан хамрагдсан. Сургалтаар "Цахимаар ном хэвлэл сурталчлах арга зүй", "Цахим контент бэлтгэх арга зүй," "Соёл танин мэдэхүйн ажил зохион байгуулах нь" зэрэг сэдвийн дор удирдан явууллаа.

- Хөвсгөл: 2023 оны 11 сарын 09, 10-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Мөрөн хотноо ном зүйч Г.Баяртуяагийн хамт ажиллаж нийтийн номын сангийн номын санчдад “Мэдээллийн сангийн тухай ойлголт”, “Тогтмол хэвлэлийн өгүүллийн сан/Онол, дадлага/”, “Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим сан”, “Soft skill (унших, бодох, ярих зан үйлд суурилсан ажилбар)”, “Лавлагаа мэдээллийн санг цахимд байршуулах нь/Дадлага/” зэрэг сэдвээр хоёр өдрийн сургалтыг зохион байгууллаа.

- **Хүүхдийн төв номын сан:** ОУ-ын ЕБС-ийн сургуулийн өдрийг тохиолдуулан Хүүхдийн төв номын санд хуран цугласан ЕБС-ийн 70 гаруй номын санчид “Уншигчийн судалгаа авах арга зүй” сэдвээр мэдээлэл өгч, сургалт хийлээ.
- **СУИС-ийн мэргэжил** дээшлүүлэх институтээс зохион байгуулж буй "НЭГДСЭН НОМ ЗҮЙН БИЧИЛТ: ОЛОН БОТИТ БОЛОН ЦУВРАЛ ХЭВЛЭЛИЙН БА ЗАДЛАГ БИЧИЛТИЙН ОНЦЛОГ", "БНСУ-ын ҮНДЭСНИЙ НОМ ЗҮЙН ТАНИЛЦУУЛГА" "НОМ ЗҮЙН БҮРТГЭЛ, түүний төрөл хэлбэр сэдвүүдээр чадавхижуулах сургалтад ном зүйч Б.Цогжаргал, Г.Баяртуяа, Т.Наранчимэг нар хичээл заасан.
- **Дорнод аймгийн** ЗДТГ-аас зохион байгуулж буй “Соёл урлагийн шилдэг ажилтан-2023” болзолт уралдааны 3-р шатны шалгаруулалтад шүүгчээр арга зүйч В.Түвшинтогтох, ном зүйч Б.Цогжаргал нар ажиллаж, шалгарч үлдсэн 6 оролцогчийн тайланг хүлээн авч, танилцан, шалгаруулалтын өдөр цахим хэлбэрээр ажиллаж, удирдамжийн дагуу дүгнэж ажиллалаа. Тус оролцогчдын дунд аймгийн нийтийн номын сангийн номын санч М.Алимаа байсан бөгөөд түүнд болон бусад оролцогчдод арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Номын санч М.Алимаа тус уралдааны ялагч болж 20 сая төгрөгийн эзэн болсон.

- Соёлын бүтээлч сарын хүрээнд "Mongolian Library Update-2023" Номын санч-Мэдээллийн ажилтнуудын улсын X зөвлөгөөн 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Үндэсний номын санд зохион байгууллаа. Уг зөвлөгөөн өнөө жил 10 дахь удаагаа зохион байгуулагдаж байгаагаараа онцлог бөгөөд зөвлөгөөнд Соёлын яам, Үндэсний номын сан, Монголын номын сангуудын консорциум, Соёл Урлагийн Их Сургууль, Бүгд Найрамдах Солонгос Улсын Чоннам их сургууль, шилдэг туршлага "Ном цом"-ын эзэн Орхон, Баян-Өлгий аймгийн нийтийн номын сангийн төлөөлөл тус тусын сэдвээр илтгэл хэлэлцүүлж, "Үндэсний цахим номын сан нэвтрүүлэлт", "Номын сангийн сургалт, судалгааг хөгжүүлэх нь" сэдвээр салбар хуралдааныг өрнүүллээ.

- Арга зүйчдэд "Номын сангийн чиг хандлага", "Цахим контент боловсруулах арга зүй", "Цахим номын сан, мэдээллийн сан", "Үйлчилгээний ажилтны харилцааны ур чадвар", "Орон нутгийн ном зүй", "Үйлчилгээний ажилтны харилцаа, манлайллын асуудалд" сэдвээр сургалт явуулсан. /20 гаруй хүн хамрагдсан./ ЕБС-ийн 70 гаруй номын санчид "Уншигчийн судалгаа авах арга зүй" сэдвээр мэдээлэл өгч, сургалт гэх мэт. Орон нутгийн номын санчдад зориулсан сургалтанд "Номын сангийн орон нутаг судлалын ажил", "Харилцаа, манлайллын асуудалд" сэдвүүдээр хичээл заав.

Төв аймгийн номын санчдад "Үндэсний цахим ном зүйн мэдээллийн сангийн ач холбогдол", "Номын сангийн орон нутаг судлалын ажил" сэдвээр хичээл оров.

Арга хэмжээ: 3.4.2 Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн дагуу эрдэм шинжилгээ-судалгааны ажлыг гүйцэтгэнэ.

"Монгол Улсын Үндэсний Номын санд хадгалагдаж буй донтрын дээжис" номыг хэвлэлтэд, Монгол Улсын Үндэсний Номын сангийн баримтын эмхэтгэл II ботийг хэвлэлтэд шилжүүлсэн.

Эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал 5 удаа зохион байгуулж, нийт 540 хүн оролцов. Үүнд: МУ-ын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын уран зохиолч, Д.Пүрэвдоржийн мэндэлсний 90 жилийн ойд зориулсан "XX зууны монгол найраглалын үнэн зүйл-Д.Пүрэвдоржийн уран бүтээл" сэдэвт эрдэм шинжилгээний хурал - 85 хүн,

Соёлын Гавьяат зүтгэлтэн Ч.Галсангийн уран бүтээл анх туурвисны 60 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал – 45 хүн, Олон улсын Монгол уран бичлэгийн холбоо, “Бичиг соёл” ТББ-тай хамтран “Монгол уран бичлэг” хэлэлцүүлэг, лекц 30 эрдэмтэн судлаачид. Түшээт хан аймгийн далай гүнгийн хошуу: "Түүх, Соёл, байгаль" эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан. Монгол Улсын Гавьяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D) Д.Лүндээжанцангийн “Монгол хаадын захидал, Монголын төрт ёс, эрх зүйн түүхэн уламжлал” /Эзэнт гүрний үе/ номын нээлт, зохиогчтой хийх уулзалт, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбараас пост-социалист Зүүн европын улс орнууд хөгжлийн ямар бодлого хэрэгжүүлсэн, хүрсэн үр дүн, тулгарч буй сорилт бэрхшээлийг хэрхэн даван туулсан зэргийг судлан тодруулах, харьцуулсан дүгнэлт хийх, улс орныхоо хөгжлийн бодлогодоо тусгах, энэ чиглэлийн судалгааны ажил эрхэлдэг эрдэмтэн судлаачдын эрдмийн бүтээл, судалгааны материалыг нийтийн хүртээл болгож эргэлтэнд оруулах зорилгоор зохион байгуулсан тус эрдэм шинжилгээний хуралд 9 илтгэгч илтгэл хэлэлцүүлсэн. Номын сан, номзүй, ном судлалын холбогдолтой эрдэм шинжилгээ, онол практикийн өгүүлэл, илтгэл бэлтгэж 19 хэлэлцүүлсэн байна.

Арга хэмжээ: 3.4.3 Үндэсний номын сан нь бусад номын санд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор жил бүр номын санчийн гарын авлага бэлтгэн гаргаж, гурав хүртэлх хувийг үнэ төлбөргүй түгээнэ.

Номын сан сэтгүүлийн 2023 оны №1, 2 бэлтгэн, нийт 100 ширхэгийг хэвлүүлэв. Нийтийн номын сангуудад түгээх хуваарийг гарган, хүргүүлж байна.

3.5. Нийгмийг соён гэгээрүүлэхэд номын сангийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, номтой нөхөрлөх соёл уламжлалыг таниулах, сан хөмрөгөөр дамжуулан олон нийтэд сурталчлах нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна.

Арга хэмжээ: 3.5.1 Уншигч, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ном хэвлэлээр танхимаар болон бусад номыны сангийн үйлчилгээг чанартай үзүүлнэ.

Уншигчийн сонирхол судлах болон үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар судалгаа улирал бүр хийж нийт -4 удаа. Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэм шинжилгээний уншлагын танхим: Ирц 4927 120%, Ном олголт 10710 107%, Гар бичмэл 1742, 78 уншигчид цахимаар уншуулсан. Уншигчид аман лавлагаа, зөвлөгөө - 1479, Номын татгалзал - 4. Нийтийн уншлагын танхим: Ирц 20217 120%, Ном олголт 33124- 92%, Уншигчид аман лавлагаа - 127, Номын татгалзал - 24. Цахим, төлбөрт үйлчилгээний танхим: Ирц 4780 159%. Ном олголт 1149 128%. Хувийн номтой уншигч: Үнэмлэхтэй: 3760, үнэмлэхгүй: 195 хүнд үйлчилсэн. Тогтмол хэвлэлийн танхим: Ирц 1574 143%, Ном олголт 15123 187%, Уншигчид аман лавлагаа - 107, Номын татгалзал - 19. Шинээр үнэмлэх нээлт- 5400, Сунгалт 863.



Шинэ уншигч-5400,

байнгын уншигч -6363,

ирц-32388, ном олголт-61559

Бүрдүүлсэн ном- Нийт 1414 нэрийн 3578 ширхэг 77,887,276 төгрөгийн

Зохион байгуулсан ЭШХ 5 удаа зохион байгуулж, нийт 540 хүн оролцов.,

Илтгэл өгүүлэл-19 тавьсан үүнээс 3 илтгэл гадаадын хуралд

Мэргэжил арга зүйн сургалт: 24 үүнээс орон нутагт 13 аймагт

Номын үзэсгэлэн 91 удаа 5692 ширхэг номоор гаргаж цахим болон танхимаар эрдэмтэн судлаач, уншигч, хэрэглэгчид сурталчилсан.

Цахимжуулсан номын тоо: Нийт 22072 ном, хэвлэл, судар цахим хэлбэрт шилжүүлсэн энэ нь нийт сан хөмрөгийн 6%

Арга хэмжээ: 3.5.2 Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэлийг цахим болон хуулбар хэлбэрээр уншуулна.

Гар бичмэл болон барын 1742 ном, бусад 1149 материал цахимаар нийт - 2891, 4858 уншигчид уншуулж судлуулан үйлчилгээ үзүүлсэн.

Арга хэмжээ: 3.5.3 Сан хөмрөгийн зохион байгуулалтыг сайжруулах, бүрэн бүтэн байдлыг хангах сэлбэн засаж, ном хэвлэлээр үйлчлэх уламжлалт номын сангийн үйлчилгээг боловсронгуй, чанартай үзүүлнэ.

Уншлагын танхимаар 44302 ном, диссертаци, 11469 тогтмол хэвлэл нийт 55771 уншуулсан. Шинээр ба буцаан байрлуулсан 81879 ширхэг ном. Сан хөмрөгүүд нийт 566658 ном хэвлэлийн байрын сунгалт хийж ялгаж цэгцлэж, бар кодыг засварлуулав. 40 удаа 552 хүнд сан хөмрөгөө танилцуулав. Төвөд цэгцэлсэн 32038, данс бүртгэлд бүртгэсэн- 4834, электрон каталогт оруулсан 1146, 930 ш карт бичиж хэвлэн гаргав. Хятад номын 2141 номын нүүр сканнердаж редакци хийсэн. Уншлаганд элэгдсэн 2355 ном, хэвлэлийг сэлбэн засч, 185 сонин сэтгүүлийг нэгжлэн хавтаслав. Ариутгагч нар 353042 ш ном хэвлэлийг ариутгасан.

Арга хэмжээ: 3.5.4 Нийгэмд номын сангийн гүйцэтгэх үүрэг, ном хэвлэлийн ач холбогдлыг сурталчлан таниулах соёл танин мэдэхүйн ажил, арга хэмжээг зохион байгуулна.

Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүд, шинэ номын, зохиолч уран бүтээлчдийн тэгш болон сондгой ойд зориулсан үзэсгэлэн 91 удаа 5692 ширхэг номоор гаргаж цахим болон танхимаар эрдэмтэн судлаач, уншигч, хэрэглэгчид сурталчилсан. 2023 онд тэгш болон сондгой ой тохиож буй 22 зохиолчдын 463

ном зохиол, 68 тогтмол хэвлэлийн үзэсгэлэн гаргасан. Үүнд: Данзанравжаа, Э.Оюун, Ши. Аюуш, М.Гүрсэд, Д.Тарваа, Н.Ширчинсүрэн, З.Дорж, Д.Мягмар, Т.Очирхүү, С.Дулам гэх мэт. Яруу найрагч М.Цэдэндоржийн Санамж өгөх номзүй хийх ажлын хүрээнд 130 гаруй номноос редакц хийж 993 ном зүйн мэдээ бэлдсэн. Зөөврийн номын сангийн үйлчилгээ - 407, 416-р цагдан хорих төвд 3 удаа 87 ширхэг номоор үйлчилгээ үзүүлсэн - 250 хүн. Зохион байгуулсан номын нээлт, уулзалт арга хэмжээ-20, хамрагдсан хүний тоо 4500.

"БНМАУ: СОЦИАЛИЗМ БА БУДДИЗМ" НОМЫН НЭЭЛТ: ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс эрхлэн гаргасан "БНМАУ: Социализм ба Буддизм /1944-1992/", "БНМАУ: Социализм ба бурхны шашин /аман түүх/" хоёр номын нээлтэд түүх, соёл, шашны салбарын эрдэмтэн судлаач, шашны зүтгэлтнүүдийн төлөөлөл оролцож, ШУГЗ, доктор, профессор З.Лонжид, МУИС-ийн ШУС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн багш, доктор С.Янжинсүрэн, ШУА-ийн ТУХ-ийн Нийгэм, соёлын хүн судлалын салбарын эрхлэгч Г.Бямбарагчаа нар судалгааны бүтээлүүдэд дүгнэлт хийснээ танилцуулан нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

- **ШШГЕГ-ий харъяа Эмэгтэйчүүдийн хорих**: 407-р нээлттэй, хаалттай хорих ангид Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, өв соёлоороо бахархах, сурч боловсрох эрхийг хангах, цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор Үндэсний бичгээр хэвлэгдсэн номын үзэсгэлэн гарган хүмүүжигчдэд сонирхуулан, ном унших боломжоор хангаж ажиллалаа. Энэ үеэр тус газрын номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөгөө өгөв.

- **ШШГЕГ-ий харъяа хорих 461:** Тус газрын сэтгэлзүйч н.Нямлхагва болон бусад албаны хүмүүсийг хүлээн авч уулзаад, хорих газрын номын сангийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцахыг санал болгосны дагуу УҮХ-ийн дарга С.Цоггэрэл, арга зүйч Б.Гантулга, номын санч О.Билэгсайхан, Э.Дэлгэрмөрөн нарын хамтаар очиж ажилласан.

- **Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх газар:** Монголын Буддын Соёлын төв ТББ-тай хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх газарт “Ном унших арга зүй” сургалт зохион байгуулж, номын санд нь ном болон номын тэмдэглэл бичих дэвтэр хандивлалаа. Тус арга хэмжээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх газрын албан хаагчид болон эмчлүүлэгч 150 гаруй хүн оролцлоо.

Арга хэмжээ: 3.5.5 Үндэсний бичиг соёл, номын өдрүүд - 2023 арга хэмжээ зохион байгуулна.

Монгол Улсын Соёлын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/139 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Монгол Улсын Үндэсний номын сангийн захирлын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/31 дүгээр “Үндэсний бичиг үсэг, номын өдрүүд”-ийн хүрээнд зохион байгуулагдах “Номын баяр-2023” арга хэмжээг “Илүү их уншъя” уриатайгаар 5, 9 дүгээр сард 2 удаа зохион байгуулж бүх нийтэд соёл, мэдээлэл, боловсролыг олгох, бүтээлч үйл ажиллагаанд чиглэсэн нийт 14 арга хэмжээ зохион байгууллаа. 33 дахь удаагийн Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2023 оны 5 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулах арга хэмжээний хөтөлбөр, урилгыг олон нийтэд мэдээлж, 13268 хүнд түгээсэн. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 33 дахь удаагийн номын баярын хүрээнд “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийг тэмдэглэхийн ач холбогдол, хүүхэд, залуучуудыг ном унших, үндэсний бичгээ сурахад уриалсан уралдаан, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх хүүхдүүдийн дунд номын хавчуурга хийлгэх, ном солилцоо, онцгой номын үзэсгэлэн арга хэмжээ, хамтран ажиллаж буй байгууллагуудын үзэсгэлэн, танилцуулга, номын худалдаа зэрэг үйл ажиллагааны талаар Монголын Үндэсний Олон нийтийн радио болон телевиз, ТВ5, https://www.parliament.mn/ болон бусад мэдээллийн сайтад ярилцлага, мэдээлэл өгөх байдлаар сурталчилж ажиллав. 34 дэх удаагийн Үндэсний бичиг соёл, номын өдрүүд арга хэмжээг “Номын соёлт ертөнц” ТББ ерөнхий зохион байгуулагчаар ажиллан 2023 оны 9 дүгээр сарын 15-18-ны өдрүүдэд 4 өдөр зохион байгуулсан ба арга хэмжээний хөтөлбөр, уриалгыг олон нийтэд мэдээлж, 8433 хүнд түгээсэн. Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/ цахим хуудсаар арга хэмжээний мэдээллийг 31 удаа бэлтгэн оруулж, 62,727 хүнд түгээсэн.

Арга хэмжээ: 3.5.6 “Үндэсний бичиг үсгийн баяр-2023” арга хэмжээ зохион байгуулна.

Монгол Улсын Үндэсний номын сангийн захирлын 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн А/114 дүгээр тушаалаар баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу "ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ–МОНГОЛ СОЁЛЫН ӨВ” уриатайгаар "Үндэсний бичиг үсгийн баяр – 2023” арга хэмжээ сэдэвчилсэн үзэсгэлэн-4, фото зургийн цахим үзэсгэлэн-2, уралдаан-1, цахимаар “Би монгол бичгээрээ” аян-1, уран бичвэрийн үзүүлбэр-1 зэрэг 10 арга хэмжээ зохион байгуулж, цахим хуудсанд 56 удаа нийтэлж, 281693 хүнд хүргэсэн. МҮОНРТ-ээр улс орон даяар нээлтийн арга хэмжээг шууд дамжуулсан ба МОНЦАМЭ агентлаг, “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, Ийгл ТВ зэрэг 10 орчим хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэв.

Арга хэмжээ: 3.5.7 Эх хэлний өдөр арга хэмжээг зохион байгуулна. "Эх хэлний өдөр"-ийн төлөвлөгөөний дагуу номын нээлт, зохиолчдын уулзалт 4 арга хэмжээ. монгол бичгийн цахим хичээлийг 8 удаа байгууллагын цахим хуудсанд оруулж, нийт 4 нийтлэл оруулж, 9126 хүнд хүрсэн. нийт хамрагдсан хүний тоо-

75.

Арга хэмжээ: 3.5.8 Бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд соён гэгээрүүлэх нөлөөллийн аян, хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

“Алсын хараа-2050”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний хүрээнд улсын хэмжээнд иргэдэд соёлын боловсрол олгох үндэсний сургагч багшийг ахисан түвшинд бэлтгэх сургалтыг Соёлын яамнаас 2023 оны 05 дугаар сарын 11-12 өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад ахисан түвшинд бэлтгэсэн ба МУҮНС-аас байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийн дарга, Ном зүйч Г.Баяртуяа 2 удаа хамрагдсан. Захирал Б.Ичинхорлоо “Нийгмийн харилцааны соёл, утга зохиол-нийгмийн соён гэгээрэл” сэдвээр сургалтыг МУҮНС дээр зохион байгууллаа. Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” буланд өөрсдийн нөөц бололцооны хүрээнд105 ширхэг гарын авлагыг

хуулбарлан байршуулж мэдээллийг баяжуулсан. Байгууллагын цахим хуудсаар урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ном, хэвлэлийн сурталчилгаа 16, 2 сэдэвчилсэн үзэсгэлэнгээр 124 номоор, бүрдүүлсэн номын судалгаагаар дайн, түрэмгийлэл, садар самууныг

сурталчилсан хэвлэлийн бүтээгдэхүүнийг сурталчилсан ном, хэвлэл худалдан аваагүй.

Зорилт: 4.1. Номын сангийн үйл ажиллагааны мэдээ, судалгаа, эрх зүйн орчин, хүний нөөцийн хөгжлийн сургалт, ажилтны нийгмийн баталгааг хангаж, бүтээлч хамт олныг бүрдүүлнэ.

Албан хаагчдад зориулсан монгол бичгийн цахим бичвэр буюу компьютерт бичих хичээлийг тогтмол явуулж, нийт ҮНС-гийн 89 албан хаагч, 2 байгууллага хамрагдсан. сурталчлах арга хэмжээ-6 удаа. "Би монгол бичгээрээ..." аянд 100 гаруй уран бүтээлчид нэгдсэн. БСШУС-ын сайдын А/181 дугаар тушаалын дагуу 2022 оны үйл ажиллагааны тайланг, Соёлын сайдын 2021 оны А/300 дугаар тушаалаар баталсан маягтаар 2023 оны 1,2, 3 дугаар улирлын мэдээг гаргаж, баталгаажуулан илгээсэн.

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан “Монгол бичгийн цахим бичвэр-II” улсын уралдааныг 2 дахь жилдээ зохион байгуулж, нийт 584 оролцогч бүртгүүлснээс 400 гаруй оролцогч цахимаар оролцож, 5 ангилалд шалгаруулж, урамшууллаа.

ЦЕГ-ын "Сүлд" чуулга, Монгол Улсын Үндэсний номын сан хамтран тус чуулгын 50 гаруй уран бүтээлч, албан хаагчдын дунд "Би монгол бичгээрээ..." уралдааныг хамтран зохион байгуулав.

Бийрийн болон үзгийн бичлэгийн уламжлалт хичээнгүй тигийг түгээн дэлгэрүүлэх, ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдын авьяас чадвар, сонирхлыг дэмжихэд уралдааны зорилгоор Бичиг соёл төвтэй хамтран “Бийрийн эрдэм” уралдааныг зохион байгуулав. /140 сурагч оролцов./

“Үндэсний бичиг үсгийн баярын 20 жилийн ой”-д зориулан олон нийтийг



хамарсан 2 аян зохион байгууллаа.

Монгол хүн газар шороондоо эх бичигтээ эзэн байна гэсэн бэлгэдэлт утгыг агуулж, Монгол улсын газрын зурагт монгол бичгээр гарын үсгээ зуран цогцлоох “**Үндэсний бичигтэн аян”** ёслолын ажиллагааг Занабазар арт фестивалийн дэмжлэгтэйгээр зохион байгууллаа.

Арга хэмжээ: 4.1.3 Хүний нөөцийн хөгжлийг дэмжсэн сургалтын хөтөлбөр, хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдох арга хэмжээ, ажилтнуудын нийгмийн баталгааг хангаж ажиллана.

Монгол Улсын Үндэсний номын сан нь нийт 118 ажилтантай. Үүнээс 11 нь Төвөд номыг дижиталчлах төслийн ажилтан байна. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу түр чөлөөтэй 4, идэвхтэй ажиллаж байгаа 114 албан хаагч байна.

Тухайн онд (2023.11.29-ний байдлаар) нийт 164 тушаалын төсөл боловсруулсан. Үүнээс Захирлын А тушаал-72, Б тушаал-92, албан бичиг-6 дугаарыг тус тус боловсруулан хянуулж, шийдвэрлүүлэн ажиллалаа.

Нийт танхим, цахим хосолсон 49 удаагийн сургалтад албан хаагчид шат дараатайгаар хамрагдсан байна. 2023.04.25-ны өдөр МУҮНС захиргаа, ҮЭХороо, ХАБЭАжилтан хамтран зохион байгуулж буй ХАБЭА-н Үндэсний хорооны зөвлөх, арга зүйч багш Т.Эрдэнэ "Хөдөлмөрийн эрүүл ахуй, ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн асуудал", "Ажлын байрны эрсдлийг үнэлэх, аюул ослоос урьдчилан сэргийлэх арга зам" танхимын сургалтыг нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан. Ай Си Ти ХХК-аас 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Дижитал номын сангийн системийн сургалт зохион байгуулж, нийт 14 албан хаагч

хамрагдсан. Соёлын яамнаас Авлигатай тэмцэх газартай хамтран 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/ ямар тохиолдолд мэдүүлэх, Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргах үндэслэл, журмын талаар мэдээлэлтэй болох, мэдэгдэл, тайлбарыг ямар тохиолдолд гаргах, авлигын эсрэг болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль хэрэглээний талаар мэдээлэл олгох сургалтад нийт 10 албан хаагч хамрагдсан. Сэргээн засварлагч О.Ангарагсүрэн, Ном зүйч, ҮЭ-ийн дарга Б.Цогжаргал, Сэргээн засварлагч Ү.Доржоо нар гадаад оронд хөтөлбөрт хамрагдсан. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасан үндэслэлээр нэр бүхий 10 ажилтанд буцалтгүй тусламж олгох, 13 ажилтанд урамшуулал олгох тушаалыг хянуулж, шийдвэрлүүлэн ажилласан. Байгууллагын үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтээс албан хаагчдыг эрүүл мэндийг үзлэгт хамрагдах асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 107 албан хаагчдад тэтгэмж олгох, мөн нийт 97 албан хаагчид урамшуулал олгох тухай тушаалыг хянуулж, шийдвэрлүүлэн ажилласан.

Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу Сар шинийн баярын өдрийг тохиолдуулан байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.

- Байгууллагын ХАБЭА-н зөвлөлтэй хамтран "Хөдөлмөрийн эрүүл ахуй, ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн асуудал", "Ажлын байрны эрсдлийг үнэлэх, аюул ослоос урьдчилан сэргийлэх арга зам" сэдэвт сургалт зохион байгууллаа.

- Соёл урлагийн байгууллагуудын дунд уламжлал болон зохион байгуулагддаг 2 удаагийн спортын тэмцээнд хамт олноороо идэвхтэй оролцлоо.

Үндэсний номын сангийн дэргэдэх “Эцэг, эхийн зөвлөл”-ийн тухай танилцуулга мэдээллийг хүргэж, Бүх нийтийн соёлын боловсролын хичээлийг орсон.Нийт ажилчдын гэр бүлийн аж байдлын талаар дэлгэрэнгүй судалгаа Цэцэрлэг болон сургуулийн насны хүүхдүүдтэй 58 эцэг эхээс дэлгэрэнгүй судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс гарсан саналыг Захиргааны зөвлөлд танилцуулж, дэмжлэг хүсч, судалгааг үндэслэн ажилчдын ажлын цагийг уян хатан байлгах тал дээр удирдлагад санал дэвшүүлсэн. Монгол улсын Үндэсний номын сангийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн мэдээ мэдээллийг түгээх зориуллаттай самбарыг 1 давхарт байрлуулж, цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэж байна. 2 арга хэмжээ зохион байгуулж 165 хүүхэд давхардсан тоогоор оролцсон. 2023.11.01-ний 09:00-11:40 цагт Соёлын яам ЦЕГ-тай хамтран зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр цахим сургалтад 8 хүнийг хамрууллаа. ХЭҮК-оос “Дэлхийн хүүхдийн өдөр”-ийг угтан /2023.11.13-ний 13:00-18:00 цагт ХЭҮК-ын байр 2 давхарт/ хэвлэл мэдээлэл, хууль, хүүхдийн эрх, нийгмийн салбарын мэргэжилтнүүдэд зохион байгуулсан сургалтад Эцэг эхийн зөвлөлийн дарга Г.Баяртуяа хамрагдаж, сертификат авсан.

Сургалт, сурталчилгаа:



Эх үрсийн баярын арга хэмжээ:

Мөн “Миний хүүхэд – Монголын ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд Чойжин ламын сүм музейтэй хамтран "Соёлын орон зай" арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд:

- Чойжин ламын сүм музейг тайлбартай үзэх
- Боловсролын хөтөлбөр:
- - Авдар дахь музей
- - Цам
- - Номын сангийн нэг өдөр
- Үлгэрийн цаг

Зорилт: 4.2. Номын сангийн үйл ажиллагаа,эрх зүйн орчин, төрийн албан хаагчийн ёс зүй, хөдөлмөрийн суурь зарчмыг мөрдлөг олгон хөдөлмөрлөх орчин, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд хамгаалалын зэрэг орчин бүрдүүлж ажиллана.

Дотоод хяналт, шалгалтын хүрээнд хяналт үнэлгээ-5 удаа /уншигч, хэрэглэгчдийн судалгаа, сан хөмрөгийн 3 удаагийн тооллогын дүн, Яамны Салбарын хяналтын газраас ирүүлсэн "Номын сангийн хяналтын хуудас/, Хэрэгжүүлсэн арга хэмжээ-2. / Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх судалгааг үндэслэн Соёлын сайдын тушаалын дагуу ажлын байрны 5 ажлын байрны 21 албан хаагчдад хөдөлмөрийн нөхцөл тодорхойлон хэмжилт, судалгаа хийх, үнэлгээг хийлгэн, дүгнэлтийг авсан. Ёс зүйн зөвлөлийн хурлаар төлөвлөгөөгөө хэлэлцэн, байгууллагын захирлаар батлуулан ажиллаж байна. Байгууллагын фэйсбүүк хуудсаар дамжуулан нийт ажилтан, албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ", мэдээ, мэдээлэл, цахим вебинар сургалтыг нийт 15 удаа нийтэлсэн, Сургалт-1, Тайлан-2. Соёлын яам, МААХҮЭХолбооны хамт/тариф/-ын хэлэлцээр, МҮҮНС-ийн захиргаатай хийсэн хамтын гэрээнд тусгагдсан ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Үйлдвэрчний эвлэлд шинээр 6 гишүүн бүртгэж гишүүнчлэлээ нэмэгдүүлсэн ба 2 удаагийн жагсаалд гишүүдийн төлөөлөлтэй оролцсон. СУ салбарын цалин нэмэгдүүлэх асуудлаар уулзалтад оролцсон. 2 журмын төсөл, ТҮСУ цалингийн нэмэгдэх асуудлаар үр дүнд хүрч цалин хөлс нэмэгдсэн.

Зорилт: 4.3. Үндэсний номын сангийн төсвийг зүй зохистой захиран зарцуулж, ил тод байдлыг хангаж ажиллана.

Тайлангийн хугацаанд улсын төсвөөс 2,173.4 сая төгрөгийн урсгал санхүүжилт, 172.0 сая төгрөгийн үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилт авч 2,107.3 сая төгрөгийн зардал гарсан байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 11, Нийгмийн даатгалын тайлан -11, Татварын тайлан -3, Санхүүгийн тайлан-1 Судалгаа-3, Хамт олны хурал 1. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн сургалтад-2 хүн оролцсон. СБХЗГ-тай хамтран, аймгийн номын сангуудад цахимаар сургалт мэдээлэл өгөхөд хамтран ажилласан. Гүйцэтгэлийг дүгнэх зорилгоор авсан судалгаа 1 удаа өгсөн. Санхүүжилт 172.0 сая төгрөгийн үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилт авч 37.7 сая төгрөгийн зардал гарсан байна. Байгууллагын үйл ажиллагааны орлого 60 сая төгрөг.

Зорилт: 4.4. Гадаадын номын сан, ном хэвлэл, соёлын байгууллагатай хамтран ажиллана.

Гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллага, судлаачидтай хамтран 19 ажил, арга хэмжээ зохион байгуулсан. Номын сангийн вэб хуудсанд зориулж нийт 13 гадаад мэдээ бичсэн. 23 гадаадын иргэнд номын сангийн үйл ажиллагаатай танилцуулах аялал хийсэн. Сургалт, семинарт хамрагдсан - 5. "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн сургагч багшийн сургалтад 3 албан хаагч хамргадсан. Гадаад оронд 2 албан хаагч туршлага судалсан. Цахимаар Олон улсын хуралд 3 ажилтан 5 удаа оролцсон.

Унгар Улсын Сечений нэрэмжит Үндэсний номын сангийн хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. 2023.04.05

Үндэсний номын сан, Улсын Их Хурлын Тамгын газрын хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулав. 2023.05.26

Монгол Улсын Үндэсний номын сан, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн хамтран Үндэсний номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй түүхэн баримт бичиг, эх сурвалжуудыг судалгааны эргэлтэд оруулах, хамтран судалгаа хийх, бүтээл туурвих, хэвлүүлэх, олон нийтийн хүртээл болгох, талуудын сан хөмрөг, ном зүйн бүртгэлийг баяжуулах замаар хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор санамж бичиг байгуулсан. 2023.04.19

Америкийн Нэгдсэн Улсын улс төрийн асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн даргын орлогч Виктория Нуланд Монгол дахь айлчлалынхаа үеэр Элчин сайд Ричард Буанганы хамт Монгол Улсын Үндэсний номын санд зочиллоо.

АНУ-ын Төрийн департментын Элчин сайдын нэрэмжит Соёлын өвийг хадгалан хамгаалах төсөлд шалгарсан Монгол Улсын Үндэсний номын сангийн Төвөд хэлт ном судрыг каталогжуулан цахимжуулах төслийн ажилтай энэ үеэр

танилцав.

ОХУ-ын Санкпетербургийн номын сантай хамтарсан онлайн хурал зохион байгуулж, арга зүйч В.Түвшинтогтох, ном зүйч Г.Баяртуяа нар илтгэл хэлэлцүүлэв. ОХУ-ын Буриадын Дорнод Сибирийн соёлын дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар уулзалтаар хэлэлцэж, номын санчдыг мэргэшүүлэх төлөвлөгөө боловсруулж байна. ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комиссоос зохион байгуулсан "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн сургагч багшийн сургалтад 3 албан хаагч хамргадсан. Байгууллагын ҮЭХ-ны дарга Б.Цогжаргал МААХ-ын ҮЭХ, Солонгос улсын Төр олон нийтийн албан хаагчдын ҮЭХ-ны хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-д тус Холбооны үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцов. МУИС болон ХБНГУ-ын Хумболтын Их сургуулийн хооронд хэрэгжүүлж буй Эразмус хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн докторант, МУҮНС-ийн Сэргээн засварлагч Ү.Доржоо ХБНГУ-ын Хумболтын Их сургуулийн Ази, Африк судлалын хүрээлэнгийн Төв Азийн семинарын Монгол судлалын төвд 2 сар ажиллаж, Германы Улсын төв номын сан, номын сангийн Сэргээн засварлах төвийн үйл ажиллагаатай танилцав.

Японы Киотогийн Дүрслэх Урлагийн Их Сургууль, Япон Улсын Элчин сайдын яам, Отани их сургууль, Тоттори муж, ХБНГУ-ын Штутгарт хотын Залуу зохиолчдын хороо, ОХУ-ын Санкт-Петербургийн Үндэсний номын сан, БНСУ-ын Соёлын яамны харьяа Азийн Соёл судлалын төв (АСС) болон ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд, СУИС-ийн Соёлын сургууль, МЗЭ, Бичиг соёл төв, Жендэрийн үндэсний хороо бусад ТББ-уудтай хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэн ажилласан.

- УИХ-ын сургалт судалгааны хүрээлэн, номын сантай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Төрийн ордон болон УИХ-ын чуулганы үйл ажиллагаа, номын сантай танилцлаа.

"Хил хязгааргүй номын сан" төсөл: Австралийн Элчин сайдын яам, Монгол Улсын Үндэсний номын сан, Монголын Номын сангийн холбоо хамтран 2022-2023 онд “Хил хязгааргүй номын сан” төсөл хэрэгжүүлж, номын сангийн мэргэжлийн хамтарсан баг 20 мянга гаруй км зам туулж, 21 аймагт хүрч ажиллан 800 гаруй номын санчид чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулж, нийтийн номын сангийн хүүхдийн номын сан хөмрөгийг шилдэг бүтээлээр баяжуулж, нөхцөл байдлын суурь судалгаа хийлээ.

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө, Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийн хүрээнд тус номын сангаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

2.6.2.1. Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн соёлын ордны номын сангийн фондын баяжилтыг жил бүр хийнэ.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар номын баяжилтын тендерийн ажил гүйцэтгэх гэрээг "Монсудар паблишн" ХХК-тай байгуулан захиалсан 2067 нэрийн 59,337,838 төгрөгийн номуудыг хүлээн авч технид ажиллагаа хийхэд бэлэн болгосон байна.

2.6.3.1. "Хотын соёл" цуврал контент бий болгож цахим аян хэрэгжүүлнэ.

Тайлант хугацаанд хотын соёлтой холбоотой сэдвүүдээр 60 удаагийн богино хэмжээний контент хийж номын сангийн пэйж хуудаснуудаар дамжуулан олон нийтэд хүргэсэн байна. Тухайлбал: Хоггүй орчин-Хотын соёлын тухай, Харилцаа хандлагаас эхтэй, Нийтийн тээврээр соёлтой зорчъё, Номыг хэрхэн соёлтой унших вэ, Хотын соёл танаас эхэлнэ зэрэг сэдвүүдээр цуврал бэлтгэн хүргэсэн байна.





__4.1.2.2. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.__

Тус номын сангийн Баянзүрх дүүрэг дэх салбар номын сангийн орох хаалганд засвар хийж тэргэнцэртэй иргэд аюулгүй орж гарах, тав тухтай үйлчлүүлэх боломжоор хангасан.

Мөн Хан уул дүүрэг дэх салбар номын санд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх танхим тохижуулахаар Монгол ярьдаг программтай “ДЭЙЗИ” цахим ном тоглуулагч, Монгол брайлтай Цахим брайл төхөөрөмж, Сканер, Суурин компьютер, Ярьдаг программ, Самбар /шивүүрийн хамт/ зэргээр тус тус тохижуулаад байна.

__4.1.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.__

Мэдээллийн ил тод байдлыг хангах хууль болон холбогдох бусад журмын дагуу төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж, 2022 оны жилийн эцсийн тайлан, Аудитын дүгнэлт, сар бүрийн ажил гүйлгээ зэргийг шилэн дансанд хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан.



Хоёр. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг

Жил бүр нийт үндэсний бичиг үсгийн баярыг зохион байгуулдаг уламжлалтай. Энэ жил үндэсний бичиг үсгийн баярыг “Үндэсний бичиг үсэг-Монгол соёлын үнэт өв” сэдвийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд тус номын сангаас дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

__Уулзалт, ярилцлага__

Үндэсний бичиг үсгийн баярыг угтаж "Утгын чимэг-2022" уралдааны тэргүүн өгүүллэгийн эзэн, Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт зохиолч

С.Баттулгатай зохиолч уншигчдын уулзалт хийсэн. Уулзалтанд нийслэлийн Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Ц.Урантөгс багштай 9ё ангийн 49 сурагч оролцсон. Мөн урилгаар МУГЖ Н.Нэргүйбаатар нар уран бүтээлийн тухай сурагчидтай сонирхолтой яриа өрнүүллээ.

Мөн Үндэсний бичиг үсгийн баярыг угтаж номын сангийн зочны ярилцлага буланд Эх бичиг судлаач, уран бичээч Б.Алтантуяаг урьж оролцуулан ярилцлагыг номын сангийн вэб болон фэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн

“Эрдэнэ болсон бичгээ эрхэмлэн дээдэлье” сэдэвт үзэсгэлэнг 1 удаа, 1 нэрийн, 33 ширхэг боть номоор, “Үндэсний бичиг үсэг- Монгол соёлын үнэт өв” сэдэвт үзэсгэлэнг 27 ширхэг номоор тус тус гаргаж уншигч хэрэглэгчдэд танилцуулсан.



Уралдаан, тэмцээн

Үндэсний бичиг үсгийн баяр-2023 угтан НЕБ-ын 6-р сургуулийн 4а ангийн сурагчдын дунд “ОЮУНЫ АМТАТ ЧИХЭР” сэдэвт уралдаан зохион байгуулж 52 сурагч хамрагдлаа.

Мөн үндэсний бичиг соёлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд НЕБ-ын 47-р сургууль, Күнз сургуулийн 7-р ангийн сурагчдын дунд “САЙХАН БИЧИГТЭН” уралдааныг зохион байгууллаа. Тус уралдаанд:

- 1-р байр: Күнз сургууль 7-ийн 1-р ангийн сурагч Б.Ирмүүнзаяа
- 2-р байр: 47-р сургууль 7в ангийн сурагч Б.Сайхантуяа
- 3-р байр: Күнз сургууль 7-ийн 2-р ангийн сурагч Г.Сувд-Эрдэнэ
- Тусгай байр:47-р сургууль 7в ангийн сурагч С.Мөнх-Үжин, Күнз сургууль 7-ийн 1-р ангийн сурагч М.Анар, Күнз сургууль 7-ийн 2-р ангийн сурагч Г.Хосчой нар байр эзэллээ.

"Үндэсний бичиг соёлын өдөр 2023"-ыг тохиолдуулан Нийслэлийн ЕБ-ын харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд:

- “Жамух” найраглалын шүлгийн уралдаан
- Түүх нийгмийн хичээлийн илтгэлийн уралдаан
- Чингис хааны алтан сургаал хэлэлцүүлэг уралдааныг тус тус зохион явууллаа.

2.2. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг

Жил бүр уламжлал болон зохион байгууллагддаг номын баяр арга хэмжээ Улсын их хурлын дарга Г. Занданшатарын ивээл дор “ Илүү их уншъя” уриан дор зохион байгуулагдаж манай номын сангаас дараах ажлуудыг зохион явуулсан. Үүнд:

- Номын сангийн байнгын уншигч НЕБ-ын 1-р сургуулийн 5е ангийн сурагч А.Мандухай, Х.Төрболд нар тэргүүний уншигч болж Д.Нацагдорж тэмдэгийн шалгуурыг хангасан тул

"Номын жим" номын сантай танилцах аялал

“Тэргүүний уншигч Нацагдорж тэмдэг”-ээр шагнуулсан.

- Мөн "Үндэсний номын баяр-2023"-ыг тохиолдуулан уншигч багачууддаа зориулан "Кикигийн хүргэлтийн үйлчилгээ" номын редактор Г.Лхамсүрэнтэй уулзалт ярилцлага, "Кикигийн хүргэлтийн үйлчилгээ" хүүхэлдэйн киноны цаг, "Кикигийн хүргэлтийн үйлчилгээ" үлгэрийг хэн сайн мэдэх вэ? танин мэдэхүйн АХА тэмцээн зэргийг тус тус зохион байгуулсан.

- “Монгол улс дахь Казах зохиолчдын эвлэлтэй хамтран БНКУ-ын зохиолчдын эвлэлийн хорооны зохиолчидтой уулзалт зохион байгуулж ажилласан. Уулзалтанд Улаанбаатар хотод сурдаг казах оюутан залуучууд болон зохиолч, уншигчид хамрагдлаа.

- Мөн “Уншихын ач холбогдол” сэдэвт “Уншигч-Зохиолч”-ийн уулзалтыг зохиолч, яруу найрагч, сэтгүүлч Х.Дуламсүрэнтэй хамтран зохион байгууллаа. Уулзалтанд уншигчдын төлөөлөл СХДүүрэг дэх НЕБ-ын Ирээдүй цогцолбор сургуулийн 10-р ангийн 53 сурагч, 82-р сургуулийн 8 сурагч оролцсон. Уулзалтад зохиолч өөрийн туурвисан уран бүтээлүүд болон номтой хэрхэн нөхөрлөх, ном уншихын ач холбогдлын талаар халуун яриа өрнүүлж, хүүхдүүдийн сонирхсон асуултад хариулж, сонирхолтой асуулт асуусан 6 хүүхдэд уран бүтээлийнхээ дээжээс

дурсгасан.

- “Үндэсний номын баярын өдөр”-өөр “Хүүхэд ба ном” сэдэвт хүүхдийн номын өдөрлөгийг чөлөөт уран бүтээлч Б.Энхжаргал, СХДүүрэг дэх 107

цэцэрлэгийн бэлтгэл А,Б,В,Г бүлгийн нийт 90 хүүхдүүд болон эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөлтэй хамтран зохион байгуулсан.

- Тус өдрөөр үндэсний эх хэл, өв соёлоо танин мэдэх, сурталчлах, монгол хэлний үгсийн баялаг, зөв бичих дүрмийг таниулах, хичээлээс олсон

мэдлэгээ бататгах, эх хэлээрээ дамжуулан үндэсний дархлааг суулгах, эх орноо хайрлан хамгаалах сэтгэлзүйг төлөвшүүлэх зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын 86-р бүрэн дунд сургуулийн Ж.Гэрэлмаа багштай 3ё ангийн 40 сурагчидтай хамтран" Үсэглэлийн хаад" тэмцээнийг тус тус зохиойн байгуулсан байна.

Үндэсний номын баярын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 3 удаа, 97 нэрийн, 119 ширхэг боть номоор гаргаж сан хөмрөгөө сурталчлахад 164 уншигч хэрэглэгч үзэсгэлэнтэй танилцсан байна. Үзэсгэлэнд:

1. "Бидний өнгө ижил ч утга өөр" 37 нэрийн, 37 ширхэг ном, 87 уншигч
2. " 2023 оны хамгийн эрэл хэрэгцээтэй Бестселлер" шилдэг ном 30 нэрийн, 52 ширхэг боть ном, 25 уншигч
3. "Номын баяр" 30 нэрийн, 30-ширхэг боть ном, 52 уншигч

- Дэлхийн номын баярын өдөрт зориулж "Би үлгэр сонсох дуртай" сэдэвт

жүжигчилсэн тоглолтын уралдааныг амжилттай зохион байгууллаа. Тус уралдаанд Хараны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн 4-7-р ангийн 6 бүлгийн 32 сурагчид, анги даасан багш нартайгаа оролцлоо. Уралдаанд Тэргүүн байрыг Н.Ням-Орших багштай 4а анги, Дэд байрыг н.Энэрэл

багштай 7а анги, Гутгаар байрыг н.Мөнх-Энэрэл багштай 6а анги, Тусгай байрыг н.Болормаа багштай 5в ангийн сурагчид тус тус эзэллээ.

2.3. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг

Тус зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Ногоон хот – Иргэний оролцоо" хаврын мод тарих аяны хүрээнд 2022 онд батлагдсан хуваарийн дагуу байгууллага хамт олноороо Хан Уул дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Айдсын аманд 60 ширхэг модны суулгац тарьж, усалгаа арчилгаа хийсэн. Мөн энэ онд Аяны хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 11^{00}-13^{00} цагийн хооронд заавар зөвлөмжийн дагуу ХУД-ийн 14 хороо айцийн амны заасан байршилд мод тарих үйл ажиллагааг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

1. 2022 онд тарьсан 60 модыг арчлан, цэнэг усалгаа, нөхөн сэргээлт хийж хог хаягдлыг цэвэрлэсэн.
2. 2022 онд тарьсан 60 модноос 10 мод нь сэргээх боломжгүй байсан тул шинээр 10 ширхэг монос, хар мод худалдан авч суулгалт тус тус хийсэн.

2.4. Монгол улсын засгийн газрын 2022 оны "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 7 дугаар тогтоол

Тус тогтоолын хэрэгжилтийн хүрээнд төрийн албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөхөд албан хаагчдын бэлтгэх үүднээс номын сангийн 36 албан хаагчийг хамруулсан Монгол бичгийн сургалтын хэл иргэншлийн сургуультай хамтран 2022 онд сарын хугацаанд зохион явуулж бүх албан хаагчдад анхан шатны мэдлэг олгож сертификат гардуулсан бол 2023 онд шинээр ажилд орсон болон сургалтын хоёр дахь шатанд хамрагдах албан хаагчдын мэдээллийг гаргаж сургалтын хоёр дахь шатлалыг эхлүүлэхээр ажиллаж байна.

2.5. Монгол улсын засгийн газрын 2021 оны "Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоол

Тус тогтоолын хүрээнд Номын сангийн 2023 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж төсөвт зардлыг хэмнэхэд чиглүүлж Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх, Шаардлагагүй албан конторын тавилга болон бусад тоног төхөөрөмж, хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх, Номын сангийн хэмжээнд зардал шаардсан сургалт

семинар, хурал зөвлөгөөн, тэмцээн уралдаан, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд хэмнэлт гаргах, удирдлагын болон ажиллагсдын цалин хөлсийг ажлын бүтээмж, үр ашигтай нь уялдуулан нарийн тооцож, үр чадвар, урамшуулалт цалинг хязгаараас хэтрүүлэхгүйгээр хавтгайруулан олгохгүй байх зэрэг арга хэмжээг авч ажиллахыг тасаг салбарын эрхлэгч, хүний нөөцийн мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч нарт үүрэг болгож ажилласан.


Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ
УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 16 өдөр Дугаар А/56 Улаанбаатар хот

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн 43 дугаар тоот тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 388 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Номын сангийн 2022 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч ажиллахыг тасаг салбарын эрхлэгч, хүний нөөцийн мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч нарт тус тус даалгасугай.

1.1 Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр настны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх.

1.2 Шаардлагагүй албан конторын тавилга болон бусад тоног төхөөрөмж, хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх.

1.3 Номын сангийн хэмжээнд сургалт семинар, хурал зөвлөгөөн, тэмцээн уралдаан, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх.

1.4 Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд хэмнэлт гаргах

1.5 Удирдлагын болон ажиллагсдын цалин хөлсийг ажлын бүтээмж, үр ашигтай нь уялдуулан нарийн тооцож, үр чадвар, урамшуулалт цалинг хязгаараас хэтрүүлэхгүйгээр хавтгайруулан олгохгүй байх.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын албаны дарга (Ж.Золбоо)-д үүрэг болгосугай.

2.6. Монгол улсын засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” 201 дүгээр тогтоол

Тайлангийн хугацаанд иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1328 жиргээ илгээгдэж, 512 дагагчтай, байгууллагын фейсбүүк хуудас 49000, үүнээс гадна АСМТ 43000 дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг өдөр бүр тогтмол түгээн ажиллаж байна.

Чи						
1	UB Public Library - Хот...	39.6K	▲0.1%	2	470	
2	Монгол Улсын Үндэсни...	19.2K	▲0.3%	11	3.4K	
3	American Corner, Ulaan...	18.5K	0%	1	71	
4	Хүүхдийн төв номын сан	9.2K	▲0.2%	34	816	

2.7. Монгол улсын ерөнхий сайдын 2022 оны 06 албан даалгавар

“Алсын хараа – 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” богино хугацааны сургалтад номын сангийн захирал Д.Индра хамрагдлаа. Мөн каталогч З.Золжаргал МУ-ын Урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хүрээнд “Монгол Улсын Соёлын Яам”-наас зохион байгуулсан “Бүх нийтийн соёлын боловсрол” ахисан түвшний сургалтанд 2023.05.11-12-ны өдрүүдэд хамрагдаж, “СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ СУРГАГЧ БАГШ”-ийн БАТЛАМЖ-аа гардаж авсан байна.

2.8. Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/480 дугаар захирамж

Тус номын сангаас “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Соёлын төв өргөөн дээр болсон “Хөгжлийн харандаа” хөтөлбөрт оролцож номын сангийн үйл ажиллагааг сурталчлан ажиллалаа.

Мөн Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах

өдрийг тохиолдуулан 5 удаагийн цахим мэдээлэл бэлтгэн уншигчдад хүргэсэн байна.

- “НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД” нэгдсэн аянд нэгдсэн уриалга
- Хараацай, хэдгэнэ хоёр монгол ардын үлгэр
- Хүүхэд хамгаалал,хүүхдийн эрх
- Гэр бүл,Хамтаараа амьдрах соёл



“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт” сэдэвт үзэсгэлэнг 1 удаа, 27ш номоор гаргасан.

2.9. Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Автомашингүй өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/472 тоот захирамж

Тус номын сангаас "АВТОМАШИНГҮЙ ӨДӨР-2023" нийтийг хамарсан олон талт арга хэмжээнд дараах ажлуудыг зохион явууллаа. Үүнд:
Номын сангийн веб болон пэйж хуудсаар дамжуулан 5 удаагийн мэдээлэл бэлтгэн хүргэсэн. Үүнд:

- “Хүүхдийн орчин- Аюулгүй автомашингүй” сэдэвт мэдээлэл
- “Агаарын бохирдол” сэдэвт мэдээлэл
- “Алхалтын ач тус”сэдэвт рейл байршуулахад
- Автомашингүй өдрийн арга хэмжээний талаарх мэдээлэл
- Эрсдэлгүй- эрүүл орчинд хамтдаа, алхалтын ач тус

Мөн “Эрүүл биед саруул ухаан оршино” сэдэвт үзэсгэлэнг 1 удаа, 1 нэрийн 37 ширхэг боть номоор гаргаж уншигчдад танилцуулсан байна.

2.10. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/1049 дүгээр захирамж

Тус захирамжийн хүрээнд тайлант хугацаанд албан хаагчдаас ирсэн 11 өргөдөл, иргэнээс ирсэн 3 гомдлыг байгууллагын дотоод удирдлагын UB ERP нэгдсэн цахим системын өргөдөл цэсэнд бүртгэн хуулийн дагуу шийдвэрлэн 100 хувь барагдуулж ажилласан.



Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам буюу 4 удаа гаргаж Нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлж ажилласан.

2.11. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Албан тушаалын зэрэглэл, үндсэн цалин, нэмэгдэл цалин шинэчлэн тогтоох тухай” Б/96 дугаар захирамж

Тус захирамжийн 2 дугаар хавсралт буюу Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дарга нарын үндсэн цалинг шинэчлэн тогтоосныг Нийслэлийн Засаг даргын тамгын газраас манай номын санд албан бичгээр ирүүлсэн. Үүний үндсэн дээр номын сангийн захирлын цалингийн шатлалын баталсан хавсралтын дагуу шинэчлэн хэрэгжилтийг ханган ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
сарын -ний өдрийн
захирамжийн 2 дугаар
хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРЫН
АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ, ЦАЛИН, НЭМЭГДЭЛ

№	Албан тушаалын нэр	Овог нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Үндсэн цалин	Нэмэгдэл	
					Төрийн алба хаасан хугацаа	Бусад
1	2	3	4	5	6	7
2	"Улаанбаатар хотын Нийтийн номын сан" ОНӨТҮГ-ын дарга	Д.Индра	ТҮСУ-6	1,137,793	7	

2.12. Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Мэдээллийн аюулгүй байдлын журам” А/477 дугаар захирамж

Ашиглагдаж байгаа бүх комьютер техник хэрэгслийг мэдээллийн ажилтнууд бүртгэлжүүлж, засвар үйлчилгээ, шинэ програм хангамж нэмэгдэх бүрт програмист болон хариуцагч ажилтан нар гарын үсэг зурж баталгаажуулдаг.

Мэдээллийн системийг хууль бус халдлагаас хамгаалах галт хана ашиглаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлогыг таслан зогсоох, илрүүлэх зориулалтаар хамгаалалт, хяналтын техникийн систем, зориулалтын програм хангамжинд байнга хяналт тавьж ажиллаж байна.

2.13. Нийслэлийн Засаг даргын 2014 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх тухай батлах тухай” А/718 дугаар захирамж

Веб хуудас

Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын төв номын сангийн веб http://www.pl.ub.gov.mn -ийн агуулгыг шинэчлэн сайжруулахад анхаарч ажилласан. Google Analytics программын тусламжтайгаар вебийн хэрэглээний үзүүлэлтийг 2022 оны 12 дугаар сарын 25-

аас 2023 оны 12 дугаар сарын 11-нийг хүртэлх хугацаанд тайлан гаргахад 68606 хэрэглэгч зочилж /visits/, 419221 хуудасны мэдээллийг үзжээ. *Зураг (1.1)*



Нийт сайтийн хэрэглэгчдийн 70.3% нь шинээр орж, 29.7% нь хуучин хэрэглэгчид хэрэглэгчид зочилсон байна.

<u>Вэб хуудас шинэчлэх ажлын хүрээнд</u>

Байгууллагын вэб сайтыг 2 удаа шинэчилж мэдээ, мэдээлэл оруулж тогтворжуулан ажиллаж байна. Мөн вэб сайтад 81 мэдээ, мэдээлэл оруулсан байна. Үүнээс Хүний нөөцийн нээлттэй мэдээлэлийн зар 25 удаа оруулсан байна.







<u>Онлайн каталог, хэрэгчдийн хэрэглээний үзүүлэлт</u>

<u>http://koha.pl.ub.gov.mn</u> -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2022 оны 12 дугаар сарын 25-аас 2023 оны 12 дугаар сарын 11-нийг хүртэлх хугацаанд 79613 хэрэглэгч зочилж /visits/, 245716 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 87,5% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 12,5% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна. Зураг(2.2-1)**.**



Зураг(2.2-1)

Тайлангийн хугацаанд сайтад зочилсан хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.

	Country	Users	% Users
1.	Mongolia	36,969	90.53%
2.	United States	933	2.28%
3.	Russia	581	1.42%
4.	South Korea	335	0.82%
5.	Japan	281	0.69%
6.	China	251	0.61%
7.	Ireland	168	0.41%
8.	Netherlands	163	0.40%
9.	Germany	127	0.31%
10.	Sweden	121	0.30%

<u>Номын сангийн үйлчилгээний koha програм хангамж</u>

Тайлангийн хугацаанд Koha програм номын сангийн програмын туршилтаар koha version: 21.11.23.000 суулган нэмэлт өөрчлөлтүүд,шинэ дизайн оруулах кохагийн шинэ сувилбарыг суулган туршилт хийж байна. Төв болон салбар номын сангуудын номын санч нарын ном каталогжуулсан статистик мэдээг гаргаж өгсөн. RFID болон уламжлалт аргааг хослуулан Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан, Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангуудын Нийтийн уншлагын танхимыг тоолсон.





<u>Facebook онлайн хуудас</u>

УБХНТНС-ийн Facebook хуудас

https://www.facebook.com/UBPubliclibrary1
49421 Лайктай болсон
УБХНТС-ийн Америк Соёл, мэдээллийн төвийн Facebook хуудас
https://www.facebook.com/ACinUlaanbaatar
47951 Лайктай болсон
ХНТС-ийн Хан-Уул дүүрэг дэх салбар номын сангийн Facebook хуудас
https://www.facebook.com/HanuulPublicLibrary
1178 Лайктай болсон
ХНТС-ийн Баянзүрх дүүрэг дэх салбар номын сангийн Facebook хуудас
https://www. facebook.com/3rdlibraryBZD
1803 Лайктай болсон

ХНТС-ийн Сонгино-Хайрхан дүүрэг дэх салбар номын сангийн Facebook хуудас
https://www.facebook.com/ubpubliclibrary4
3499 Лайктай болсон
ХНТС-ийн Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангийн Facebook хуудас
https://www.facebook.com/ChingilteiPublicLibrary
1814 Лайктай болсон



Нийт номын сангийн Фэйсбүүк пэйж хуудсуудаар 1102 удаа уншигчидын асуусан асуултанд хариулсан байна.

2.14. Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам батлах тухай” А/633 дугаар захирамж

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн, шинээр болон эгүүлэн томилогдсон, шилжин ажилласан 14 ажилтнуудын ажил хүлээлцэх комиссын гишүүдийг томилж, уг журмын хавсралт ажил хүлээлцэх маягтын дагуу цахим болон цаасан баримт, эд хөрөнгийг хүлээлцүүлэн тус бүр 3 хувь үйлдсэн.

2.15. Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам батлах тухай” А/252 дугаар захирамж

Тайлант хугацаанд Edoc системд нийт ирсэн 177 албан бичиг бүртгэгдсэнээс цахимаар 175 бичиг ирсэн байна. 171 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хааж, 6 албан бичиг судалж буй төлөвтэй байна.

Тайлант хугацаанд Edoc системээр нийт явуулсан 111 албан бичгийг бүртгэсэн ба үүнээс албан хэрэг хөтлөлтийн систем ашигладаг 107, систем

ашиглагдаггүй 2 байгууллагаруу 4 албан бичиг бүртгэн хугацаанд нь шилжүүлж шийдвэрлүүлсэн.

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн зөрчилтэй 4 албан тоот илэрснийг холбогдох ажилтнуудад мэдэгдэж дахин зөрчил гаргалгүй ажиллах тал дээр зааварчилгаа, зөвлөгөө өгсөн.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг сард 2 удаа гаргаж, удирдлагад 22 удаа танилцуулж ажилласан.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Уншлага үйлчилгээ

Номын сангийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар бүтээгдэхүүн нийлүүлэлтийг "хүснэгт 1"-ээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Шинэ уншигч	15,800	14,379	92%
2	Ирэгсэд	102,500	159,000	100%
3	Ном олголт	260,500	278,000	100%

Тайлант хугацааны төлөвлөгөөт үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хүснэгт 2

Он		2021			2022		
№	Төлөв-лөгөө	Төлөв-лөгөө	**Биелэлт**	**Хувь**	Төлөв-лөгөө	**Биелэлт**	**Хувь**
1	19,300	15,800	6527	41,3%	15,800	17,405	100%
2	119,700	102,500	21,352	20,8%	102,500	69,401	67,7%
3	299,250	260,500	43,112	16,5%	260,500	141,184	54,2%

Тайлбар

Тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд зарим албан хаагчид ажлаас чөлөөлөгдөх, шилжин ажиллах, жирэмсэний амралт авах зэрэгтэй холбогдуулан 4 удаагийн тооллого хийгдсэн.

3.2. Гэрээр ном олгох үйлчилгээ

Тус номын сан гэрээр ном олгохдоо уншигч үйлчлүүлэгчдийн иргэний үнэмлэхийг авч үлдэн ном олгодог байсан. Ингэснээр иргэдээс гомдол ирсэн учир гэрээр ном олгохыг зогсоосон. Ингэхдээ И Монголиа цахим системд номын сангийн 6 үйлчилгээг цахимаар оруулахаар ажиллаж байгаа бөгөөд 2024 онд гэрээр ном олгох үйлчилгээг цахимаар олгохоор ажиллаж байна.

3.3. Солилцоо болон зөөврийн үйлчилгээ

Номын сангийн тухай хууль болон БСШУ-ы Сайдын 2010 оны 570 дугаар "Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал" тушаалын дагуу байгууллагуудтай зөөврийн номын сангийн гэрээг байгуулан 24 удаа зөврөөр очиж 663 ширхэг номоор үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

- Хавдар Судлалын Үндэсний Төвийн үйлчлүүлэгчийг дэмжих албатай зөөврийн номын сангийн үйлчилгээг 1 удаа 20 ширхэг номоор

- Нийслэлийн БЗД-ийн 20-р цэцэрлэгийн 25-н албан хаагчдад 2 удаа 24 ширхэг номоор
- СХДүүргийн 35-р хороотой хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зөөврийн номын сангийн үйлчилгээг 2 удаа
- НЕБ-ын 45 дугаар сургуультай
- НЕБ-ийн 6-дугаар сургуультай
- Сонгинохайрхан дүүргийн 148 дугаар цэцэрлэгийн И.Отгонцэцэг багштай дунд бүлгийн 38 хүүхэд багачуудад сургуулийн өмнөх насны боловсролын түвшинд унших ном зохиолоос 7 нэрийн, 40 ширхэг номоор

- Нийслэлийн ерөнхий боловсролын 19-р сургуультай 2 удаа, 34 нэрийн, 59 ш боть номоор зөөврийн номын сангийн үйлчилгээг тус тус хүргэж ажиллаа.

- Хан-Уул дүүрэг дэх 2-р салбар номын сангийн ХУТанхимтай 4 ширхэг номоор солилцоо хийв. Эсрэг тэсрэгийн тухай “Миний анхны ном”, “Амьтад”, Хайр гэж юу вэ?, “Ороо хурааж дадъя”
- СХД дэх 4-р салбар номын сангийн ХУТанхимтай 11 ширхэг номоор солилцоо хийв. Хүүхдийн зохиолч Н.Энхтайваны зохиол бүтээлээс

<u>3.4. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар</u>

2023 оны байдлаар 32 нэрийн 195 ширхэг 4,409,000 төгрөгийн номыг худалдаагаар, 297 нэрийн 912 ширхэг 14,242,000 төгрөгийн номыг бэлэг хандиваар, 299 нэрийн 1872 ширхэг 54.931.338 төгрөгийн номыг тендерээр, 366 нэрийн 497 ширхэг 2,580,774 төгрөгийн номыг төлбөрөөр тус тус бүрдүүлэн авч, нийт 994 нэрийн 3476 ширхэг 76.160.612 төгрөгийн хэвлэмэл номонд техник ажиллагаа хийж, 466 нэрийн 1839 ш номын мэдээллийг электрон каталогт оруулан, 1540ш RFID-ийн баркодон tag-ыг хэвлэн идэвхжүүлж наасан байна. Дээрх бүх номыг Олон нийтэд үйлчлэх тасаг, салбар номын сангуудад хүлээлгэн өгч уншлаганд шилжүүллээ.

Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, энэ оны эхний хагас жилд төвлөрсөн номын сангийн хэмжээнд 16 нэр төрлийн 2,283,200 төгрөгийн тогтмол хэвлэл захиалсан. Урагдаж гэмтсэн

нийт 2609 ширхэг ном хэвлэлийг сэлбэн зассан байна. Төв болон салбар номын сангуудын тогтмол хэвлэлүүдийг нийт 388 нэгж, баримт 15 нэгж болгон тус тус хавтасласан байна.

3.5. Лавлагаа, номзүйн үйлчилгээ

Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааг амаар, цахимаар, утсаар, е mail-ээр нийт 4081 удаа лавлагаа өгсөн байна.



Ном зүй

Цахим номзүйг 6 удаа 379ш номоор гаргасан байна.

Үндсэн хуулийн өдөрт

- Олон улсын гэр бүлийн өдөрт
- Эх хэлний өдөрт
- Монголын дүрслэх урлагийн ноён оргилуудын нэг, эрдэмтэн, зураач Ням-Осорын Цүлтэмийн 90 насны ойд
- Уншлагын А танхимд байгаа жүжгийн зохиолуудаар

Их зохиолч Д.Нацагдоржийн төрсөн өдрийг тохиолдуулан уншигчдын бүтээлүүдээр цахим үзэсгэлэн болон номын санд байгаа ном хэвлэлээр нь цахим ном зүй гаргасан.

3.6.Мэргэжил арга зүйн сургалт, зөвлөгөө

Хотын төв номын сангийн нийт номын санчдад дараах мэргэжлийн сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд:

- Шинээр ажилд орсон номын санчдад зориулсан Коха програмын каталогжуулалтын сургалтыг каталогч З.Золжаргал өгч ажилласан байна.

- Налайх дүүргийн соёлын ордны номын санч Г.Хорлоод каталогжуулалтын сургалтыг каталогч З.Золжаргал өгч ажилласан байна.
- СУИС-ийн Соёлын сургуулийн эчнээ ангийн 3 оюутнуудын үйлдвэрлэлийн дадлагыг хариуцан ажиллаж, номонд техник ажиллагаа, данс номын баркод, формулярын уутыг хэрхэн бичих номын нэг бүрчилсэн бүртгэл хөтлөх, ном ангилах, каталогжуулах, талаар тус тус сургалт өгсөн.

- СУИС-ийн Соёлын сургуулийн 1-р курсын оюутнуудад номын нэг бүрчилсэн бүртгэл хөтлөх сургалт өгсөн.

<u>3.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ/-ийн мэдээллийн үйлчилгээ</u>

Ярьдаг номын сангийн уншлага, үйлчилгээ

2023 онд 955 ирцэд 2005 ширхэг ном олгож үйлчилсний 400 номыг танхимаар, 1482 номыг гэрээр, 8 номыг солилцоогоор, зөөврөөр 115 номыг тус тус олгож үйлчилсэн байна.

Харааны бэрхшээлтэй 187 иргэдэд 212 удаа лавлагаа өгсөн. Үүнд: Амаар 98, утсаар 107, цахимаар 7 удаа

Бага насны хүүхдүүдэд зориулж үлгэрийн 4 ширхэг номыг брайль бичигт шилжүүлэн бичиж уншигчдын хүртээл болгосон байна.

Брайль болон дэйзи номын сэдэвчилсэн үзэсгэлэн нийт 5 удаа 63 ширхэг номоор:

- Дэлхийн номын өдөр
- Зохиолч С.Батжаргалын уран бүтээл
- Ганс Христиан Андерсений уран бүтээл
- Хүртээмжтэй цахим номууд
- Брайль үсэгт хүүхдийн номууд

Үндэсний номын баярын өдөрт зориулан МХҮХолбоо дээр МЗЭ-ийн шагналт зохиолч Санжаагийн Батжаргалтай зохиолч уншигчдын уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтанд харааны бэрхшээлтэй 52 иргэн хамрагдлаа.

Хараaны бэрхшээлтэй хүмүүст зориулсан DAISY төв

Хараaны бэрхшээлтэй иргэдэд зориулсан (Daisy) стандартад нийцүүлэн E-PUB 30 нэрийн цахим ном бүтээсэн. Тайлангийн хугацаанд “Технологийн төв”-ийн YOUTUBE суваг, Facebook групп дээр дүрс бичлэг, зурагтай 80 мэдээлэл оруулсан байна.

YouTube: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний мэдээллийн суваг https://www.youtube.com/watch?v=syUksUaXi8w;- 35 мэдээ

Facebook групп: Онцлог хэрэгцээтэй иргэдийн нэгдсэн бүлэг групп – 30 мэдээ

Page: “Хараaны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний facebook хуудас -15 мэдээ




"Туслагч технологийн сургалт”-ыг 14 удаа зохион явуулсан

Үйлчилгээнд ашиглагдаж байгаа компьютер, и-ном тоглуулагч, цахим брайль төхөөрөмж гэх техник хэрэгслүүдийн програм хангамжийн шинэчлэлт, сайжруулалтыг 8 удаа, мөн үйлчилгээнд ашиглагдаж буй техник хэрэгсэлүүдийн

бүрэн ажиллагааг хариуцаж гарах 4 удаагийн засварыг тус тус хийж ажилласан байна.

Өдөр тутам хараагүй хүний ашигладаг цагаан таяг, ярьдаг даралтын аппарат, ярьдаг цаг, ярьдаг халуун хэмжигч, брайль бичгийн хэрэгсэл гэх мэт тусгай хэрэгсэл ашиглах тухай зөвлөмж тогтмол өгч нийт 60 харааны бэрхшээлтэй иргэнд 80 удаа амаар болон утсаар зөвлөмж өгч ажилласан.

Хүртээмжтэй Технологийн төвөөс МУИС-ын "Ярьдаг, сонсдог номын сан"-ийн үйлчилгээнд монгол дэлгэц уншигч программыг 5 компьютерт суулгаж, харааны бэрхшээлтэй оюутан ашиглахад бэлэн болгосон.

"NVDA" дэлгэц уншигч програм хангамжийн эхний улирлын сайжруулалтын хүрээнд монгол хэлнээ орчуулах ажлыг хийсэн.

3.8. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

Тус номын санд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

Одоо ажиллаж байгаа ажиллагсдын 45,7% буюу 32 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож, ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 150.000 төгрөг олгодог.

3.9. Зохион байгуулсан сургалтууд

Тус номын сангийн хэмжээнд нийт номын санчдыг чадавхжуулах мэргэжлийн багц сургалтыг 3 удаа зохион байгуулсан байна. Үүнд:

- "Бүх нийтийн соёлын боловсрол"-ын сургалтын танилцуулга сургалт 2 удаа
- Албан тушаалын үндсэн чиг үүргийн сургалт 3 удаа
- "Хөдөлмөрийн тухай хууль" ХЗҮХ-ийн арга зүйч багш Д.Цэцэгдарь
- СУ мэдээ гаргахад анхаарах зарим асуудал – АБХ-ийн ажилтан Б.Бадмаарагчаа
- "Миний хувийн санхүүч" - Эдийн засагч, хувийн санхүүч Д.Туяа
- Электрон болон татдаг тамхины тухай – НЭМҮТ-ийн мэргэжилтэн Г. Бадамцэцэг
- Орчин үеийн номын сангийн чиг хандлага" – Г.Ариунзаяа
- Ном зүйн мэдээлэл хийх буюу Коха програмд лист бэлдэх тухай. Н.Одхүү

- Стресс тайлах, тайвшруулах “Mindfulness” хөтөлбөр - В.Бэрцэцэг (“Art therapy” Монголын Урлагийн сэтгэл заслын холбооны ерөнхийлөгч) гэсэн чиглэлээр тус тус зохион явуулсан.



Мөн Австралийн элчин сайдын яам, Монгол Улсын Үндэсний номын сан, Монголын номын сангийн холбоо хамтран “Хил хязгааргүй номын сан” төслийн хүрээнд 2023.05.03-нд зохион байгуулсан “Номын санчдыг чадавхжуулах” сургалт, хэлэлцүүлэгт каталогч З.Золжаргал оролцсон.

“MARC 21: Стандарт бус номын каталог” Монгол улсын номын санчдад зориулсан мэргэжлийн сургалтанд каталогч З.Золжаргал, Ц.Байгалмаа нар хамрагдсан.

3.10. Үйл ажиллагааны ил тод байдал

Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, арга хэмжээний зар мэдээ зэрэг иргэдэд зайлшгүй шаардлагатай **26** холбогдох мэдээ, мэдээллийг www.pl.ub.gov.mn цахим хуудсаараа мэдээлсэн.



Номын сангийн эрхлэгч нарын овог нэр, албан тушаал, харилцах утас, ажиллах цагийн хуваарийн хамт цахим хуудсанд болон мэдээллийн самбартаа байршуулсан.

3.11. Хүний нөөцийн ил тод байдал:

Номын сангийн цахим хуудасны нээлттэй ажлын байр цэсэнд сул орон тооны зарыг тухай бүр байршуулан шинэчилсэн.

Тайлант хугацаанд мэргэжил шаардсан 48 албан тушаалд 3-аас дээш жил ажиллаж байгаа ажиллагсдын 40 нь буюу 83,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

3.12. Улсын болон Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажил

Нийслэлийн болон Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 54.931.338 төгрөгийн номын бүрдүүлэлт хийгдэж, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн номыг номын данс бүртгэл, тайлан балансд тусгалаа. Үүнд:

- Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 299 нэрийн 1872 ширхэг 54.931.338 төгрөгийн номын худалдан авсан.
- 366 нэрийн 497 ширхэг 2,580,774 төгрөгийн номыг төлбөрөөр тус тус бүрдүүлэн авсан.

Дөрөв. БУСАД МЭДЭЭЛЭЛ

4.1. Соёл, олон нийтийн ажлын талаар

Төв болон салбар номын сангуудын хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Үүнд:

Д/д	Үйл ажиллагааны ерөнхий нэр	Давтамж	Хамрагдсан хүний тоо
1	Контент	16	3000
2	Уулзалт, лекц,	34	1440
3	Сургалт	22	1760
4	Номын өдөрлөг, номын нээлт	7	760
5	Номын сангийн зочны ярилцлага	23	13133
6	Номын үзэсгэлэн	22	1540
7	Уралдаан, тэмцээн	5	520
8	Чанга уншлага, Уншлагын цаг хөтөлбөр	54	261
9	Үлгэрийн цаг хөтөлбөр	8	89
10	Номын жим	43	1043
11	Америкийн соёл мэдээллийн төв	34	16345
	нийт	**200**	**84891**

Эдгээрээс тоймлон үзвэл:

4.1.1. Контент

Дэлхийд ганцхан монгол наадам, Электрон катологоос өөрт хэрэгтэй номоо хэрхэн хайж олж унших талаар зөвлөмж, Номын сангаар үйлчлүүлэх зөвлөмж, номын сангийн хаяг байршил, хүүхдийн номын сангийн танилцуулга зэрэг цахим контентийг хийж номын сангийн пэйж хуудсаар дамжуулан уншигчдад хүргэсэн.



4.1.2. Уулзалт, лекц, ярилцлага

Хаврын тэргүүн сарын шинийн 5-ны өдөр буюу 02 дугаар сарын 25-ны өдөр “Алтайн магтаал, Аргил цагаан өвгөн тууль хайлах” арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.

Мөн “Гомбын Сэр-Одын шагналт зохиолчидтой лайв уулзалт”-ыг зохион байгуулсан.

Мөн цаг уур амьсгалын өөрчлөлт, Цахим орчин дахь худал мэдээллээс урьдчилан сэргийлье, Харвардын их сургуульд суралцсан туршлага олж авсан мэдлэгээс хуваалцах, Иргэний нийгмийн манлайлал ба төрийн бус байгууллагын менежмент зэрэг лекцүүдийг цувралаар хүргэсэн.

Намайг алгас” нөлөөллийн аяны хүрээнд “Мансууруулах бодисоос сэргийлье!” сэдэвт лекцийг доктор, профессор Ш.Лхагвасүрэнтэй хамтран зохион байгууллаа.

Соёлын бүтээлч сар аяны хүрээнд “Сэтгэлийн нар” үндэсний аяныг санаачлагч Олон улсын оюуны дасгалжуулагч, Эерэг сэтгэлгээний сургагч багш Ц.Ганцэцэгтэй хамтран "МӨРӨӨДЛИЙН ХҮЧ" сэдэвт уулзалт, лекцийг зохион байгуулла

4.1.3.Сургалт

“Film nomads" найруулагч нарын, Сайн дурынхныг чадавхжуулах сургалт , Инди киноны продюсер, маркетинг, “Competitive College Club” сургалт зэрэг сургалтууд, “Spelling bee” англи үг үсэглэх, “Digatal literacy”, Үндэсний их баяр наадамд зориулсан хүүхдийн хөтөлбөрүүдийг тус тус зохион байгуулж ажилласан.

Removement хөтөлбөр сургалт:

- Өвөрхангайгаас ирсэн сурагчдад Removement буюу хаягдал цаасан хайрцагийг хуучин номын хуудсаар хэрхэн чимэглэж бэлгийн хайрцаг хийх сургалтыг зохион байгуулсан.

- Сүхбаатар аймгаас ирсэн ахлах ангийн 30 сурагчидад шил будах, бэлгийн хайрцаг чимэглэх хөтөлбөрийг зохион байгуулсан.

Lego Mindstorms:

Lego Mindstorms буюу Лего програмчлах сургалтын элсэлтийн бүртгэлийг хүртээмжтэй байх үүднээс онлайнаар 2023 оны 01 дугаар сарын 09-23-ны хооронд пэйж хуудсаар дамжуулан зарлаж, ЕБС-ийн 6-9-р ангийн 85 хүүхдийн өргөдөл ирсэнээс 02 дугаар сарын 04-ний өдөр 32 хүүхдээс ярилцлага авч, 15 хүүхдийг элсэлтээр шалгаруулан авсан. Сургалт 2023 оны 03 дугаар сарын 01-ээс эхлэн 7 хоногт 3 удаа хичээллэж байна.



2D animation:

2D animation хөтөлбөрийн бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 12-30-ны хооронд ACMT-ийн пэйж хуудсаар зарлаж, 9-12-р ангийн 78 хүүхдийн өргөдөл ирснээс, 30 хүүхдийн ярилцлагыг 2023 оны 02 дугаар сарын 02-03-ны өдрүдэд зохион байгуулж, 12 хүүхэд ярилцлагын шатанд тэнцсэн. Одоогоор 2D animation хөтөлбөрийн сургалт 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн долоо хоногт 2-3 удаа хичээллэж байна.



E-Sport:

E-Sport хөтөлбөр 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр шинээр нээгдсэн. Уг хөтөлбөр клубийн зарчмаар явагдах ба шинээр элсэгчдийн өргөдлийг онлайнаар 2023 оны 01 дүгээр сарын 14-30-ны өдрүүдэд зарлаж, ахлах ангийн нийт 99 хүүхдийн өргөдөл ирснээс 16 хүүхэд ярилцлагын шатанд тэнцэж энэ оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн клубээ хөгжүүлэхийн зэрэгцээгээр хөтөлбөр амжилттай зохион байгуулагдаж байна.

E-Sport хөтөлбөр бол цахим спортыг хөгжүүлэх болон цахим спортын талаар хүмүүст мэдээлэл хүргэх зорилготой бөгөөд клубт элссэн хүүхдүүд багаар ажиллаж сурахаас гадна figma, canva, photoshop дээр ажиллах аргачлалыг суралцдаг. 2023 оны 4 дүгээр сард И-Спорт клубийнхэн 6 удаа цуглаж суралцах дадлага хийсэн ба монголын и-спортын төлөөлөл болсон тамирчин Леог клубтээ урьж чөлөөт ярилцлага хийсэн.

2023 оны 05 дугаар сарын 07-ны өдөр "2D Animation болон Lego Mindstorm клубүүдийн 5 дэх удаагийн төгсөлтийг зохион байгуулсан. Уг үйл ажиллагаанд Lego Mindstorm Club" клубын хувьд өөрсдийн хийсэн роботоо үзэгчдэд танилцуулж, баг болж роботуудаараа өрсөлдөж, "2D Animation" хөтөлбөрийн 3 сарын туршид хийсэн анимейшнээ үзэгчдэд танилцууллаа.

4.1.4. Номын өдөрлөг, номын нээлт

Дэлхийн хүүхдийн номын өдрийг тохиолдуулан "Гэгээн өглөө" номын өдөрлөгт Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор, Чингэлтэй дүүргийн хүүхдийн номын өргөө, Вервист, Өнөр бүл, Альфа, Цөлийн сарнай, Домбоско хүүхдийн асрамжийн төвийн нийт 70 гаруй хүүхэд багачууд багш нарын хамтаар оролцлоо. Уг арга хэмжээний үеэр Д.Нацагдоржийн болон МЗЭ-ийн шагналт, хүүхдийн зохиолч О.Сундуйтай уулзалт зохион байгуулж, ном солилцоо, номын худалдаа явагдсан. Мөн "Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн" болзлыг хангасан сурагч Б.Бат-Ирээдүй, А.Хулан нарыг шагнаж урамшууллаа.

Мөн Баянзүрх дүүргийн 16 дугаар хороонд байрлах хүүхдийг хууль эрх зүйн хүрээнд эрүүл, аюулгүй орчинд өсгөн асрах, нийгэмшүүлэх, боловсрол олгох, сэтгэл зүйн гэмтлийг нь эмчлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг СОС хүүхдийн хотхоны 99 хүүхдэд "Номын сангийн өдөрлөг" зохион явуулсан байна.

4.1.5. Зочны ярилцлага

Номын сангийн зочны ярилцлага буланд нийт 23 зочин урьж оролцуулсан байна.

- Гадаад худалдааны эдийн засагч, дэд профессор, Боловсролын тэргүүний ажилтан, аялал жуучлалын багш, I зэргийн хөтөч тайлбарлагч орчуулагч А.Эрдэнэчулуун
- МЗЭ-ийн нэрэмжит шагналт, Болор цомын эзэн яруу найрагч, МҮОНР-ийн найруулагч Б. Жамбалдорж

- МУИС-ийн Европ судлалын тэнхимын багш, доктор, профессор Б.Алтангул
- МУ-ын Ардын уран зохиолч Р.Шынай
- Дуучин С.Гантогоо
- МУСГЗ, сэтгүүлч Б.Галаарид
- Тагтаа” хэвлэлийн газрын орчуулагч, редактор Б.Дэлгэрмаа

- Яруу найрагч Ц. Дэлгэрмаа
- Гэр бүл , хүүхдийн сэтгэл зүйч Б. Алтанзаяа
- UBS телевизийн хөтлөгч, редактор, СУИС-РТМУС-ийн Сэтгүүл зүйн тэнхимын багш Н.Сувд-Эрдэнэтэ
- Хүүхдийн зохиолч Ц. Энхтүвшин
- Сэтгэл зүйч Г.Уянга-Үжин
- Сити их сургуулийн ахлах багш орчуулагч, редактор Х.Чойдогжамц

- Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн “Шинэ эрин хөдөө аж ахуй” редакцын редактор Н.Минжинсайхан

- Цэндүүхэй.Б.С: EGUL3 Creative Studio-н үүсгэн байгуулагч, уран бүтээлч Д.Гүн-Үйлс: Зохиолч, орчуулагч, түүх судлаач
- Д.Жаргалсайхан: Чөлөөт уран бүтээлч



- Х.Болор-Эрдэнэ: Зохиолч
- Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, ”Нийгмийн редакцид сэтгүүлч” редактор Э.Гантулга нартай тус тус ярилцаж номын сангийн вэб болон пэйж хуудсанд байршуулсан.



4.1.6. Номын үзэсгэлэн танилцуулга

Цахим номын үзэсгэлэн: 8 удаа 31 ширхэг номоор
Номын үзэсгэлэн: Нийт 22 удаа, 62 нэрийн 410 ширхэг боть номоор
Сэдэвчилсэн: нийт 12 удаа 36 нэрийн 261 ширхэг боть ном
Шинэ ном: нийт 10 удаа 26 нэрийн 122 ширхэг боть ном

- Зохиолч Ц. Дамдинсүрэнгийн 11нэрийн 11 ширхэг номоор
- “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулж 28ш номоор
- ‘’Наурызын баяр’’-ыг угтан 22ш номоор үзэсгэлэн
- ‘’Дэлхийн театрын өдөр’’-т 25 ш номоор үзэсгэлэн

- Дэлхийн эрүүл мэндийн өдөр-т 29ш номоор үзэсгэлэн
- Дэлхийн шашны өдөрт 37ш ном
- Дэлхийн яруу найргийн өдөрт 17ш номоор
- Цагаан сар 23 ном ,4 хэвлэмэл материал
- Валентины өдөрт 27ш номоор
- Олон улсын хүүхдийн номын өдөрт 26 ном
- Дэлхийн музейн өдөрт зориулан 13 ш номоор

4.1.7. Уралдаан тэмцээн

Уралдаан тэмцээнийг нийт 5 удаа 520 хүн хамрагдсан байна.

“Оюуны амттай чихэр” буюу “Ач тусын тухай” үлгэрийг хэн сайн мэдэх вэ? танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн НЕБ-ын 6-р сургуулийн Д.Ундармаа

багштай 4а ангийн хамт олны дунд номын санч Мөнхжаргал, Алтанзул нар зохион байгуулсан.

“Тусч охин Бөртэ”-ийн үлгэрийг хэн сайн мэдэх вэ? АХА тэмцээнийг НЕБ-ын сургуулийн 45-р сургуулийн 5д ангийн сурагчдын дунд зохион байгуулсан байна.

4.1.8. Чанга уншлага болон уншлагын цаг

- “Үрэл хотхон” цэцэрлэгийн н.Өлзийжаргал багштай Ахлах бүлгийн 23 хүүхдэд Тагнуулч Одко: Вирустэй тэмцсэн нь номоор
- БЗД-ийн 20-р цэцэрлэгийн Д.Гантөгс багштай Ахлах "А" бүлгийн 26 хүүхдэд орос ардын үлгэр ‘’Тэнгэрт өлгөөтэй бяслаг‘’ үлгэрийн номоор
- Лоринэт сангийн дэмжлэгтэйгээр Азийн сангийн хэрэжүүлж буй ‘’Хамтдаа уншицгаая’’ төслийн уншигч Э. Алтанзаяатай хамтран ‘’Сая долларын олз’’ зохиолоор
- БЗД-ийн 20-р цэцэрлэгийн Д.Гантөгс багштай Ахлах "А" бүлгийн 26 хүүхдэд орос ардын үлгэр ‘’ Өнхрүүш ‘’ үлгэрийн номоор
- НЕБ-ын БГДүүрэг дэх 73-р сургуулийн Ш.Угантуяа багштай 4д ангийн 34 сурагчид О.Сундуй “Тэнгэрт өлгөөтэй бяслаг” номноос “Өнчин хусны дууль” сургамжит өгүүллэгээр
- НЕБ-ын СБДүүрэг дэх Сант сургуулийн Б.Уранцэцэг багштай 5а ангийн 25 сурагчид “Бичиг мэддэггүй бамбарууш” сургамжит өгүүллэгээр
- НЕБ-ын Сант сургуулийн Л.Цэрэндолгор багштай 27 сурагчид “Өнчин хусны дууль” сургамжилт өгүүллэгээр
- НЕБ-ын 6-р сургуулийн О.Одончимэг багштай 2а ангийн 42 сурагчид “Зараа оготно хоёр” үлгэрээр
- НЕБ-ын СХД-ийн 154-р сургуулийн Ц.Баясгалан багштай 3а ангийн 40 сурагчид “Ойн парк” үлгэрээр

- НЕБ-ын 6-р сургуулийн П.Үндармаа багштай 1в ангийн 33 сурагчид “Өвгөр Бөөвгөр хоёр” үлгэрээр
- НЕБ-ын 6-р сургуулийн Д.Уранжаргал багштай 4а ангийн 46 сурагчид “Өгөөмөр охин Өэлүн” үлгэр
- НЕБ-ын 45-р сургуулийн Алтангэрэл багштай 5д ангийн 33 сурагчид “Тусч охин Бөртэ” үлгэрээр

Уншлагын цаг хөтөлбөрийг 4 удаа зохиойн байгуулж 60 сурагч хамрагдсан байна.

- НЕБ-ын СБДүүрэг дэх 1-р бүрэн дунд сургуулийн Л.Намууцэцэг багштай хамтран ажиллаж сурагчдыг хөтөлбөрт хамруулан танхимаар үйлчилж уншсан номын тэмдэглэлийг хөтлүүлж, номын хэлэлцүүлэг зохион байгуулсан.

<u>4.1.9. Үлгэрийн цаг хөтөлбөр</u>

Үлгэрийн цаг хөтөлбөрийг нийт 8 удаа зохион байгуулж 0-6 насны 89 хүүхдийг хамруулсан байна.

- Нийслэлийн тамгын газрын ажилчдын 2-6 насны бяцхан уншигч нар
- Лоринэт сангийн дэмжлэгтэйгээр Азийн сангийн хэрэгжүүлж буй “Хамтдаа уншицгаая” төслийн уншигч багш Даваасүрэн багш маань бяцхан хүүхдүүддээ "Чшш, бидэнд төлөвлөгөө бий", "Энэ малгай минийх биш" гэсэн зохиолуудыг маш сонирхолтой хөгжилтэйгөөр уншиж өгсөн ба уншсан номын агуулгатай холбоотойгоор өнгө өнгийн шувуу хийж, малгайгаа гээсэн загаснуудад малгайг нь олж өгөх тоглоом тогололоо.

- Төслийн уншигч Баасансүрэн “Сая долларын санаа”, “Толгойноос хөл хүртэл”, “Гэртээ харих зам” зохиолуудыг бяцхан уншигчид уншиж өглөө. Мөн зохиолын агуулгын дагуу өнгө өнгийг шувуу хийж сурлаа.
- Төслийн уншигч Э.Алтанзаяа “Миний муухай хамар”, “Толгойноос хөл хүртэл”, “Туулай чих тавин сонссон” зохиолуудыг бяцхан уншигчдад уншиж өглөө. Мөн зохиолын агуулгын дагуу сонирхолтой тоглоом тоглож цагийг хөгжилтэй өнгөрөөлөө.

- Төслийн уншигч Сэлэнгэ “Бяцхан хавч минь бүү санаа зов”, “Бид энд амьдардаг”, “Мангасуудад ч бас мэдрэмж бий” зохиолуудыг бяцхан уншигчдад маань уншиж өглөө. Мөн зохиолын агуулгын дагуу Halloween баярт зориулж сонирхолтой тоглоом хийж тоглон цагийг хөгжилтэй өнгөрөөлөө

- Төслийн уншигч Ганбагана “Энэ миний малгай биш”, “Мангасуудын оронд”, “Груффало” зохиолуудыг бяцхан уншигчдад уншиж өглөө. Мөн зохиолын агуулгын дагуу Halloween баярт зориулж сонирхолтой тоглоом тоглож мангас зурж цагийг хөгжилтэй өнгөрөөлөө.

- Хамтдаа уншицгаая” төслийн уншигч Баасансүрэн “Миний муухай хамар”, “Бяцхан хавч минь бүү санаа зов”, “Гэртээ харих зам” зохиолуудыг уншиж өгөхийн зэрэгцээ зохиолын агуулгын дагуу өнгө өнгийн шувуу хийж сурлаа . Мөн энэ удаагийн хөтөлбөрт зохиолч Б.Энхжаргал өөрийн "Бөөлхөний зүүдний найзууд", "Барилгачин бөөлхөн ба түүний найзууд" номуудыг бяцхан уншигчдад уншиж сонирхууллаа.

- “Хамтдаа уншицгаая” төслийн уншигч Ганбагана “Бэтгэлжин бор шувуу”, “Юуны чимээ вэ”, “Нар, Сар, Рах” зохиолуудыг бяцхан уншигчдад маань уншиж өглөө. Мөн зохиолын агуулгын дагуу сонирхолтой тоглоом тоглож зураг зурж, цаасаар шувуу хийж цагийг хөгжилтэй өнгөрөөлөө.

- Багш Даваасүрэн “Цөмөөхэй”, "Би цагаан гуталдаа хайртай” зохиолуудыг бяцхан уншигчдад уншиж өглөө. "Цөмөөхэй" номоо уншуулаад, сүлд модноосоо өлгөх оймс хийн, зураг зурж, шинэ жилийн тухай ярилцлаа.

ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

- ❖ Орон тоо, удирдлагын бүтэц
- ❖ Чиг үүрэг
- ❖ Тайлан, төлөвлөлт

ХОЁР. ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

- ❖ Захиргаа хүний нөөц төлөвлөлт хэрэгжилт
- ❖ Хүний нөөц төлөвлөлт бүрдүүлэлт
- ❖ Сургалт
- ❖ Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах
- ❖ Хэвлэл мэдээлэл, ил тод байдал
- ❖ Жендерийн тэгш байдал

ГУРАВ. СОЁЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

- ❖ Соёл гэгээрэл, бүх нийтийн боловсрол
- ❖ Соёлын өвийг хамгаалах
- ❖ Цахим бодлогын хэрэгжилт

ДӨРӨВ. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ТАЛААР

- ❖ Төсвийн төлөвлөлт
- ❖ Төсвийн зарцуулалт
- ❖ Худалдан авалт
- ❖ Шилэн дансны хэрэгжил

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

❖ Орон тоо, удирдлагын бүтэц

Хүүхдийн төв номын сан /удирдах 1, гүйцэтгэх 31/ 32 ажилтантай, 4 хэлтэстэй. Захирлын дэргэд

- Захиргааны зөвлөл
- Дотоод хяналтын комисс
- Эцэг эхийн зөвлөл
- Ёс зүйн дэд хороо
- Өмч хамгааллын комисс
- Баримт бичиг нягтлан шалгах комисс
- Гамшгаас урьдчилан сэргийлэх штаб ажилладаг.

Чиг үүрэг

Төрөөс соёлын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжид үндэслэн хүүхэд, залуучуудад ном хэвлэл, хэвлэмэл бус материал, бусад мэдээллийн нөөцөөр номын сангийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх, өмчийн хэлбэрийг үл харгалзан улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн номын сан, сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ЕБС-иудын номын сангуудыг мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэй.

1. Мэдээлэл технологи аргазүйн хэлтэс

Энэ хэлтэс нь байгууллагын үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, шинэчлэл хийх, хүүхдийн ном хэвлэлийн архивын болон мэдээллийн сан бүрдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн номын санг мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах үндсэн үүрэг хүлээнэ.

- Фонд хадгаламжийн хэлтэс

Энэ хэлтэс нь сан хөмрөгийг шинэчлэх, баяжуулах, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сан хөмрөгийн аюулгүйн ажиллагааг хангах, стандартын дагуу шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах үндсэн үүрэг хүлээнэ.

- Уншлага үйлчилгээний хэлтэс

Энэ хэлтэс нь хүүхэд залуучуудад ном хэвлэл болон хэвлэмэл бус материал бусад цахим нөөцөөр чөлөөт сонголттой, төрөлжсөн 6 уншлагын танхимаар шуурхай соёлтой үйлчлэх, соёлын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.

- Захиргаа аж ахуйн хэлтэс

Энэ хэлтэс нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хангах, үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, байгууллагын ил тод байдлыг ханган ажиллах, төсөв хөрөнгийг төлөвлөн, захиран зарцуулах, тайлагнах, хянах, архив, албан хэрэг хөтлөлтийг хууль, журмын дагуу явуулах үүрэг хүлээнэ.

❖ Тайлан төлөвлөлт

Хүүхдийн төв номын сан жил бүр МУ-ын Соёлын сайдын хянаж баталсан Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Хэлтсүүдийн төлөвлөгөө, Өмч хамгаалах зөвлөл, Дотоод хяналтын комиссын төлөвлөгөө гаргаж ажилладаг. Мөн Эцэг эхийн зөвлөл, Ёс зүйн дэд хороо, ББНШК-ын төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллалаа.
Соёлын яаманд 7 хоногийн тайлан, сарын мэдээ, улирлын мэдээ, хагас жилийн тайлан, жилийн гүйцэтгэлийн тайлан, Татварын тайланг улирал бүр, Нийгмийн даатгалын тайланг сар бүр, Сангийн яам, ТӨХ-нд санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр, Архивын ерөнхий газарт архивын мэдээг хагас болон бүтэн жилээр, СУ маягтын дагуу статистик мэдээллийг НСУГ-т улирал тутамд, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг СУГ-т жил бүр тус тус тайлагнадаг .

❖ Номын сангийн үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэх сайжруулах чиглэлээр

-Ном бүрдүүлэлт: Худалдаагаар 89 нэр төрлийн 350 ном, Монгол ном 72 нэр төрлийн 326, Гадаад хэлний 16 нэр төрлийн 16 ном, Хандив тусламжаар 221 нэр төрлийн 443 ном, Монгол ном 122 нэр төрлийн 332, Гадаад хэлний 99 нэр төрлийн 111 ном, нийт 310 нэр төрлийн 793 ширхэг номыг бүрдүүлсэн.

- Техник ажиллагаа : 2022 оны худалдааны монгол номын 7-25 дугаар баримтын 674 ном, 2023 оны Худалдааны монгол номын 1-4 дүгээр баримтын 181 ном, гадаад номын 1 баримтын 14 ном, хандиваар монгол номын 1-5 дугаар баримтын 183 ном, нийт 1052 номыг салбараар ангилж, нэг бүрчилсэн бүртгэлд дансалж, танхимуудад хуваарилсан.

Каталогжуулалт: 746 нэрийн 1431 номонд номзүйн бичилт хийж цахим каталогт оруулсан. Цахим каталогийн 2796 нэр төрлийн 8652 номонд засвар хийсэн. Цаасан каталогийн 8800 картад редакц хийж, 500 карт хэвлэж, 215 картыг шинэчилж, 15 картыг хассан.

- **Сэргээн засварлах, ариутгал**: Урагдаж гэмтсэн 550 хэвлэмэл номыг сэргээн засварлаж, 720 сониныг 24 нэгж болгосон. Монгол номын сан хөмрөгийн 3118 номыг ариутгалын төхөөрөмжөөр ариутгаж, Мөрөөдөл танхимын 12500 номд ариутгал хийсэн.

Номын сангийн үйлчилгээ: Шинээр 3596 уншигчдад /ЕБС-2134, Насанд хүрэгсэд-1462/ үнэмлэх нээж, 32695 ирцэд /танхимаар 32827ном, гэрээр 14519 ном, солилцоогоор 254 ном/ 47600 ном, хэвлэлийн бүтээгдэхүүн олгож үйлчилсэн.

Зөөврийн номын сан:

Гэрээт 12 төвд нийт 24 удаа 960 ном хүргэж 4567ирцэд 5286 ном олгож Зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэсэн.

Соёлын ажил: Танилцах аялал -1, Сургалт -1, Зохиолч уншигчийн уулзалт-1,Номын өдөрлөг-1, Зугаатай уншлага-1 удаа зохион байгуулж 269 хүнийг хамруулсан.

❖ Лавлагаа ном зүйн үйлчилгээ үзүүлэх

Лавлагаа мэдээлэл: Т.Бямбарагчаа “Цэрэг ахын захидал” зохиол, Ж. Дашдондог зохиолчийн бага насны хүүхдэд зориулсан зохиол бүтээлийн номзүйн жагсаалт, Цаасан баримтын хадгалалт хамгаалалтын тухай монгол хэл дээрх ном, Зөгий үржүүлэх арга, Зөгийн үүрийг барих арга, Аяны шувууд дууны үгийг зохиогч Дашдондог зохиолчийн “Хөвчийн зургаан охин”, “Яндан хөөлөгч” зохиол, Дуудлага худалдаа зохион байгуулах баримтат мэдээлэл, 2003-2023 оны 9 дүгээр ангийн сурах бичиг, Хүүхдийн ахмад 16 зохиолчийн бүтээл, О.Дашбалбар “Тэнгэр шиг бай”, “Амьдадаа бие биеэ хайрла” хоёр шүлгийг бүрэн эхээр, Дипломат, орчуулагч Б. Дэмчигдоржийн 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан орчуулгын хүүхдийн зохиол “Сээхэлзүүр” номд орсон 12 өгүүллэг, “Цэцэг” өгүүллэг, ЕБС-ийн номын санчийн албан тушаал анх хэдэн онд, ямар тушаалаар гарсан зэрэг бичгийн лавлагааг 3-7 хоног хайлт хийж өгсөн.

ХОЁР. ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

❖ **Захиргаа хүний нөөц төлөвлөлт хэрэгжилт**

Хүүхдийн төв номын сан батлагдсан орон тоонд төрийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн хангаж, холбогдох баримт бичгүүдэд суурилан уншигч хэрэглэгчдэд тасралтгүй үйлчлэх зорилгоор Зуны улиралд 1 ээлж, өвлийн улиралд 2 ээлжийн горимыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- ХТНС-гийн нийт ажилтан давхардсан ажил үүргийг хавсран гүйцэтгэдэг.

Давхардлыг арилгаж, орон тоог 51 болгон нэмэгдүүлэх талаар Соёлын яаманд үндэслэлээ тайлбарлаж, албан бичгээр хандсан. Тэдгээр ажилтанд хавсран гүйцэтгэсэн ажил үүргийн 20-40% ийн нэмэгдэл олгодог.
Үүрэг даалгаврын журнал хөтөлж, дээд газрын бичгүүдийн хариу болон албан даалгаврыг хариуцсан албан тушаалтанд үүрэгжүүлэн шуурхай болгох арга хэмжээг авч ажилласан.

- Солилцооны гэрээ
- Уншлага үйлчилгээний дотоод журам
- Эцэг эхийн зөвлөлийн ажиллах журам
- Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг боловсруулан баталж хэрэгжүүлж байна.

❖ **Хүний нөөц төлөвлөлт бүрдүүлэлт**

- Сул орон тоог олон нийтэд зарлаж, Хөдөлмөрийн хууль болон Дотоод журмыг

баримтлан ажилтныг сонгож авдаг. Эхний 3 сар туршилтаар ажиллуулж, мэргэжилтнүүдийг сургадаг. Захиргааны албан хаагчдад магистр болон магистраас дээш цолтой боловсон хүчнийг ажиллуулж байна.

- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн

албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу нийт албан хаагчдын хувийн хэргийг бүрдүүлэн баяжилт болон шинэчлэлт, хөдөлгөөнийг тухай бүр Хүний нөөцийн программ дээр шилжилт хөдөлгөөний болон бусад өөрчлөлтүүдийн мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулж байна.

- **Сургалт**

Ажилтнуудаа мэргэшүүлэх чадавхжуулахад анхаарч, ажлын байран дахь хөгжүүлэх сургалтуудыг зохион байгууллаа.

- Төрийн албаны зөвлөлийн 7:4:10, Үндэсний номын сангаас "Үндэсний цахим номзүй", Соёлын яамнаас зохион байгуулсан Удирдлагын манлайлал ёс зүй, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт анхаарах асуудал, Хүүхдийн эрх хүүхэд хамгаалал, хүүхдийн аюулгүй байдлын бодлого, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдэгдэл тайлбар гаргах нь, Соёлын засаглал эрх зүйн шинэчлэл, хуулийн, платформын гэх зэрэг 16 сургалтуудад хамрагдлаа.

- "Хос бичигтэн байгууллага" үндэсний бичгийн уралдаант сургалт, Гамшгаас хамгаалах комиссоос "Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт", "Эмэгтэйчүүдийн хөгжил хөдөлмөр эрхлэлтэд ҮЭ-ийн оролцоо", Ёс зүйн хорооноос "Ухаалаг санхүү", "Төрийн албан хаагчийн ёс зүй" зэрэг сэдвээр тус тус сургалт зохион байгуулж, ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулав. Мөн ХТНС-гийн 16 ажилтан өөрсдийн бэлдсэн сэдвээр дотооддоо сургалт хийж, мэдлэгээ хуваалцсан.

- **Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах**

- Хүүхдийн төв номын сангийн ажилтан албан хаагчид ТҮ1,ТҮСБ3, ТҮСБ 4, ТҮСБ5 ангилал зэрэглэлээр цалинждаг.
- 10-25 хувийн ур чадварыг давхардсан тоогоор 28 хүнд олгосон.
- Захирлын А/45 тушаалаар ажилчдын өдрийн хоолны мөнгийг 15.000 (арван таван мянга) төгрөг болгож нэмэгдүүлсэн.
- Захирлын А/42 тоот тушаал гаргаж, 3 ажилтанд буцалтгүй тусламж олгож, 11 ажилтанд нүүрсний тусламж 288.000 төгрөгийг олгосон.
- Тэтгэврийн 1 удаагийн тусламжийг 1 хүнд олгож, 1 хүний тэтгэмж төсөвт суусан, хүлээгдэж байна.
- Инженерийн болон бичиг хэрэг- архивын ажилтны өрөөг тусгаарлаж, шинэ өрөөтэй болгосон.

- 2 давхрын шатны хаалтыг өндөрлөж, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан.
- Гадаа орчны тохижилтод анхаарч, савтай Мод /3ш/, модон сандал /2ш/ зэргийг байршуулсан.
- Гадна орчинд дугуйн зогсоол хийсэн.
- Уншлагын танхимууд коридор болон гадаах орчныг бүрэн камержуулсан.
- Угтах үйлчилгээ болон танхимуудын гэрэлтүүлгийг сайжруулж, шинэчилсэн.
- Өлгүүр, каталогийн хэсэгт шинээр радиатор суурилуулсан.
- Орох үүдний хэсэгт халуун үлээгч хөшгөн тень суурилуулсан.
- Их мэдэх танхимд эко хаалт, хивс зэргээр тохижилтыг хийсэн.
- Үйлчилгээний стандарт, байгууллагын өнгө логонд нийцүүлсэн ажлын өвлийн бомбер хувцсаар жигдэлсэн.

❖ Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх

Дунд ангийн сурагчдын цахим үгийн санг 981 нэрийн 137,718 номын нүүр хуудас хөрвүүлсэн.ERP платформыг нэвтрүүлж чанар, хүртээмжийг дээшлүүлж, уншигчийн үнэмлэх нээлтийг цахимжуулан уншигчийн зургийг камераар авч компьютерт оруулж, хэрэглэгчийн и-баримтыг хувийн мэйлээр илгээдэг байсныг болиулж шууд хэвлэж өгдөг болсон.

ГУРАВ. СОЁЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

❖ *Засгийн газрын 2020 – 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.4 - т заасны хүрээнд шинэ Хүүхдийн төв номын сангийн үзэл баримтлалыг 9 үзүүлэлтээр суурь судалгааг хийж дүн шинжилгээг гаргасан. “Хүүхдийн төв номын сангийн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, МҮНС-гийн болон Соёлын яамны дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Төслийг Соёлын яаманд хүргүүлээд байна.*

❖ **Соёл гэгээрэл, бүх нийтийн боловсрол**

- Соёлын гэгээрлийн ажил: Нийт 16 нэр төрлийн 263 соёлын ажил арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

Өдөрлөг 15,

Соёлын солилцоо 1,

Дэлхийн хүүхдийн номын өдөр 1

Номын нээлт 2 ,

Танилцах аялал 49,

Зохиогч уншигчийн уулзалт-9

✓ Мэргэжил арга зүйн зөвлөгөө, сургалт

- Мэргэжил арга зүйн зөвлөгөөг анхан шатны бүртгэл хөтлөлт, ном ангилал, сан

хөмрөг зохион байгуулалт, чөлөөт уншлагын танхимын зохион байгуулалт, соёлын ажлыг зохион байгуулах аргачлал, номын үзэсгэлэн дэглэх, хүүхдийн уншлагыг нас сэтгэхүйн онцлогт тохируулан зохион байгуулах зэрэг чиглэлээр нийт 86 удаа өгсөн.

- ЕБС-ийн номын санчдад "Номын санч" анхан шатны мэргэшүүлэх сургалт, "Номын сангийн үйл ажиллагаа", "Номын сан ба чөлөөт цаг", "Сургуулийн номын сангийн онцлог", "Гадаад орны туршлагаас- Шведийн хүүхдийн номын сан" цахим болон танхимаар 7 сургалтыг зохион байгуулж, Нийслэл, орон нутгийн 547 номын санчид хамрагдсан.
- Соёлын өвийн, Номын ач тус, СБҮ, Танин мэдэхүйн зэрэг 21 сургалтыг зохион байгуулж, 897 уншигч хүүхэд, залуус хамрагдсан

- *Уншигч хүүхдүүдэд* 21 сургалт зохион байгуулж, нийт 897 хүүхдийг хамруулсан.
  Соёлын өвийн:
  Монголын нууц товчоо сургалт
  Сампин зангидах сургалт
  Баривч эсгэх
  Монгол цаг тоолол
  Монгол наадгай

  СБҮ сургалт:
  Эсгий урлал
  Даавуун ном
  Оригами

  Танин мэдэхүйн сургалт:
  Цэнхэр алт сургалтуудыг зохион байгуулсан.
- *Тогтмол зохион байгуулж буй* сургалт, уншлага үйлчилгээ
  Хувь хүний хөгжлийн:
  Мөрөөдөлдөө хүрэх арга зам
  Бие дааж хөгжих чадвар
  Номын тухай:
  Номын ач тус
  Ном уншлагад эцэг эхийн оролцоо
  Хуулийн мэдлэгтэй болцгооё уншлага
  Үлгэрч мод уншлага
  Хоёр хэлний уншлага

МУ-ын Гавьяат багш С.Батболд, Хүүхдийн зохиолч О.Сундуй нарын бүтээсэн "Өв соёл, цээрлэх ёс" үндэсний контентыг 8 удаа пейж хуудсаар дамжуулан сурталчилж 8198 хүнд хүргэсэн.

- Монгол бахархлын өдөрт зориулан "Монгол соёлоо дээдэлье" сэдвийн хүрээнд "Тусгаар тогтнол" шүлгээр уран уншлага, Монголын үндэсний хөгжим урладаг "ЭГШИГЛЭН" үйлдвэртэй танилцах аялал, "Монгол гэр" лекц зэргийг зохион байгуулсан.

- Эцэг эхийн зөвлөл: ШШГ 441 дүгээр анги, Рома театртай хамтран “Ногоон дэлхий-Эрүүл ирээдүй” өдөрлөгийг зохион байгуулж 100 хүнийг хамруулсан.

- "Хүүхдүүдээ хуулийн мэдлэгтэй болцгооё" чанга уншлага 10 хийсэн.

- Хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх: Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг 32 сургуулийн 5д ангийн сурагчдад, хүүхдийн заавал мэдэх ёстой утасны дугаар, холбогдох хуулийн зүйл заалтыг таниулах сургалтыг ЧД-ийн 5 сургуулийн сурагчдад зохион байгуулсан.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд: Үндэсний өв соёл, зан заншил, ахуйн соёлыг төлөвшүүлэх чиглэлээр Сонсголын бэрхшээлтэй НЕБ-ийн 29 дүгээр тусгай сургуульд дохионы хэлмэрч багштай хамтран өдөрлөг зохион байгууллаа.

Харааны бэрхшээлтэй 116 дугаар тусгай сургуулийн сурагчдад “Хүүхдүүдээ хуулийн мэдлэгтэй болцгооё” сэдэвт чанга уншлага, Хүүхдийн зохиолчидтой уулзалт, ярилцлага зохион байгуулсан.

- ✓ Уралдаан, өдөрлөг:

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 15 өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгийн үйл ажиллагаанд 3189 хүн хамрагдаж соёлын үйлчилгээ авсан байна.
Түргэн хэллэгийн, Хурдан дааганы, АХА, Монгол наадгай, Цагариг шидэх зэрэг уралдаан тэмцээнийг соёлын ажлуудад тогтмол зохион байгуулж байна. Нийт 5615 хүүхэд оролцсон байна.

Үндэсний бичиг үсгийн баяр

- Хурдан уншлагын аварга
- Уран бичлэгийн аварга шалгаруулах уралдааныг зохион байгуулж, Улаанбаатар

хотын болон 7 аймгийн нийт 130 гаруй хүүхэд залуус оролцсон. Хурдан уншлагын шилдэг 6 уншигч, Уран бичлэгийн 1, 2, 3, тусгай 2 нийт 5 байрыг шалгаруулж, мөнгөн шагнал өргөмжлөл номын бэлэг гардуулсан.
Шилдэг номын санч
Уралдааныг Бэхи цолтон ТББ-тай хамтран соёлын өвийг сурталчлан түгээх, бүтээлч ажил хийсэн байх шалгуураар ЕБС-иудын номын санчдын дунд зохион байгуулсан. Шилдэг номын санчаар Номын санч Г.Энхчимэг, Б.Шинэтуяа, Д.Оюунцэцэг нар шалгарч мөнгөн шагнал, номын бэлэг гардлаа.

Номын баяр - 33,34

33, 34 дэх удаагийн Номын баярт үндсэн үйл ажиллагаагаа сурталчилж, Үлгэрийн баатрууд парад, Шилдэг ном зохиолын нүүр үзэсгэлэн, Азын сугалаа, Номтой загвар, Хүүхэлдэйн жүжиг, Хүүхдийн зохиолчтой ярилцлага, АХА тэмцээн, “Шилдэг баг өмсгөлийн уралдаан зэргийг зохион байгуулж ажиллав. Шилдэг баг өмсгөлийн уралдаанд шилдэг хамт олны болон шилдэг ганцаарчилсан өмсгөлийг шалгаруулж, мөнгөн шагнал, номын бэлгийг гардуулсан. Номын баярт нийт 4500 хүн хамрагдлаа.



Сүнсний биш Хүнсний баяр

Хүнсний хувьсгал бодлоготой уялдуулан Сүнсний баярыг Монгол хүний оюун сэтгэлгээнд ойртуулах, эерүүлэх зорилгоор Монголд анх удаа Сүнсний биш Хүнсний баярыг Үндэсний үйлдвэрлэгчидтэй хамтран зохион байгууллаа. Шилдэг Хүнсний баг өмсгөлийг шалгаруулж, хамт олны 1, ганцаарчилсан шилдэг 3 байрыг шалгаруулж мөнгөн шагнал, соёлын бэлэг гардуулав.

ОУ-ын соёлын солилцоо

Үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, сурталчлан таниулах, өвлүүлэх зорилгоор Өвөрмонголын өвлөн уламжлагчидтай хамтран Соёлын өдөрлөгийг зохион байгууллаа. Соёлын солилцооны хүрээнд Өвөрмонголын 61 төлөөлөгчийг хүлээн авч, уран бичлэгийн нөхөрсөг тэмцээн, соёлын ажлыг зохион байгууллаа. Энэ хүрээнд 2 орны багачууд дуулж бүжин, мэдлэгээ солилцлоо.

Соёлын өвийн өдөрлөг

Үндэсний өв соёл, түүх уламжлалаа өвлүүлэх, үр хойчдоо сурталчлан таниулах зорилгоор Соёлын өв өдөрлөгийг ЕБС-ийн нийт 120 сурагчдыг хамруулан зохион байгууллаа. Өдөрлөгөөр цагаан идээ боловсруулах, баривч хийх, ногт чөдөр зангидах, монгол цаг тоолол, монгол гэр, сувсаар гоёл хийх зэрэг сургалтуудыг хийлээ. Үндэстний оршин байх суурь болсон Өв соёлоо өвлөх өвлүүлэхийн чухлыг ойлгууллаа.

Хэнтий өдөрлөг
Хэнтий аймгийн СУГ-тай хамтран хүүхэд багачуудад зориулсан Соёлын өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгийн хүрээнд Номтой загвар, АХА болон хурдан дааганы уралдаан, Азтан сугалаа, 5 хошуу мал- зөөврийн номын сан ажиллуулж, тэргүүний уншигч хүүхдүүдийг Д.Нацагдорж тэмдгээр шагналаа.

Би номд дуртай өдөрлөг
Нэпко хэвлэлийн газартай хамтран ОУ-ын хүүхдийн номын баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн. Өдөрлөгт БСШУ-ын сайд Л.Энх-Амгалан, жүжигчин Т.Өөдөө, Ч.Уранхолбоо нар зочилж уншлага хийлээ. Хүүхдүүдийг шүдний болон чих хамар хоолойн үзлэгт хамруулсан. Сансрын нисгэгчийн сорил, мод тарих аргыг зааж, шүдний өвчлөлөөс сэргийлэх сургалт хийв.

Ногоон дэлхий-Эрүүл ирээдүй өдөрлөг
Хүүхдэд зориулсан өдөрлөгийг ШШГ-ын 441 дүгээр анги, Эх нялхсын ЭМҮТ-тэй хамтран 100 хүүхдийг хамруулан зохион байгуулсан. Урлагийн тоглолт, хүүхэлдэйн жүжиг, уралдаан тэмцээн зохион байгуулж, чих, хамар хоолой, нүд, шүд, дотор, мэс заслын эмч нар зорин ирж, хүүхдүүдийг үзлэгт хамруулж зөвлөгөө өглөө.

Герман уншлагын танхим 20 жил

Танхимын 20 жилийн ойн хүрээнд түнш байгууллагатай хамтран өдөрлөг зохион байгуулж, гэрэл зургийн үзэсгэлэн гарган сан хөмрөгөө сурталчлан зохиогч уншигчийн уулзалт, герман хэл дээрх чанга уншлага зэргийг зохион байгууллаа.

- ✓ Бусад

Соёлын яам болон НСУГ-тай хамтран Нүүдэлчин фестиваль, Хаврын баяр, Хүүхдийн ертөнц - бүтээлч орон зай өдөрлөгийг зохион байгууллаа. Мөн Соёлын сэргэлт 2023 аяныг Булган аймгийн төв, 16 сум 1 тосгонд соёлын иж бүрэн хөтөлбөртэй зохион байгуулж, соёлын үйлчилгээг хүргэж ажиллалаа.

- ✓ Уншлага

Амттантай уншлага, Үлгэрч мод уншлага, Хуулийн уншлага, Чанга уншлага, Үдшийн уншлага, Хуруу хүүхэлдэйн уншлага, Хормогчтой үлгэр, Ширээний тоглолт бүхий уншлага зэрэг төрлөөр нийт 19 удаа зохион байгууллаа.

- ✓ Танилцах аялал

Нийт 49 удаагийн аялал зохион байгуулагдаж, 2341 хүүхэд номын санд зочилсон. Танилцах аяллын хүрээнд Соёлын өв үзэсгэлэнг үзүүлж, соёлын өвийн болон хуулийн мэдлэг мэдээлэл олгож, танхимуудын үйл ажиллагааг сурталчлан таниуллаа.

✓ Ярианы клуб

Герман, Англи, Орос хэлний ярианы клубууд ажиллаж байна. Нийт 77 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж, 669 хүн хамрагдсан байна. Мөн 2 хэлний уншлага 1 удаа зохион байгуулсан байна.

✓ Үзэсгэлэн

Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 58 удаа зохион байгуулсан.Тэгш ой нь тохиож буй зохиолчдын намтар уран бүтээлийн сурталчилгааг 8 удаа зохион байгуулж, 152 номыг дэлгэн танилцуулсан. Сар шинэ, Наадам, Цэргийн баяр, ОУ-ын Эмэгтэйчүүдийн баяр, Монгол бахархлын өдөр, Бичиг үсгийн баяр, Хүүхдийн баяр зэрэг тэмдэглэлт өдрүүдэд зориулж сэдэвчилсэн үзэсгэлэнг 576 номоор дэглэж, нийт 38 удаа зохион байгууллаа

✓ Зохиолч уншигчийн уулзалт

Зохиолч уншигчийн уулзалтыг нийт 9 удаа зохион байгуулсан. Зохиолч Ч.Галсан, Энхжаргал, О.Сундуй, О.Бяруузана, Б.Ганчимэг, Б.Батжаргал, Наранбаатар, Х.Дэмбэрэл, Бат-Эрдэнэ, Н.Мандал, Наранцэцэг, Амархүү, П.Бадарч, Т.Оюусудар, Н.Мөнх-Оргил нар оролцов.

✓ Хүүхэлдэйн жүжиг, тоглолт

Рома хүүхэлдэйн театртай хамтран Жаргалын адал явдал, Ханс, Геракл хоёр хүүхэлдэйн жүжгийг 17 удаа тоглож нийт 850 хүүхдэд хүргэлээ. Мөн Үлгэрийн цагийг 5 удаа зохион байгуулсан.

- **Соёлын бүтээлч үйлдвэрлэл**

- Соёлын өвийн үзэсгэлэнгийн үзмэрийн баяжилт хийж, 12 жилийн хавчуургыг хийж соёлын ажилд нэвтрүүллээ.
- Модон морь /2 төрөл/, Гацуур-номын тавиур зэргийг хийж, хүүхэд багачуудад зориулсан уралдаан тэмцээн, соёлын ажилд нэвтрүүллээ.
- Танин мэдэхүйн босоо самбар 2ш
- Үлгэрч мод /ярьдаг уншдаг/, Эсгий ном /7 төрөл/, 5 хошуу мал-номын тавиур зэргийг соёлын ажил үйлчилгээнд нэвтрүүллээ.

- Байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах

- Байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал: Телевиз- 20 Сайт-14, Сонин-7 Ийгл ТВ, Монголын радио, Монголын мэдээ, ММинфо, gogo.mn зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлав
- Үйл ажиллагааг пэйж хуудсанд тогтмол мэдээлж идэвхжүүлэн дагагчдын тоог 11.320 д хүргэлээ. Өөрийн пэйжээр 88 LIVE дамжуулалт хийж, нийт 1300 контент, 859 видео байршуулж, 802835 хүнд хүргэсэн. Ийгл ТВ, Монголын радио, Монголын мэдээ, ММинфо, gogo.mn зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлав

- Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

Хамтын ажиллагаа: - Гёте Институт, Австралид төгсөгчдийн холбоо, Хятад-Монголын соёлын төв, ОУ-ын Монгол уран бичлэгийн холбоо, NEPKO Хэвлэлийн газар, Бэхи цолтон ТББ, "Төгөлдөр Буяннэмэх сан" ТББ, "Сод номун" төв Өвөрмонголын өвлөн уламжлагчид, ӨМӨЗО ы хүүхэд залуучуудын хэвлэлийн хороо зэрэг гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажилласан.

- Астрид Линдгрений шагналд хүүхдийн зохиолч О.Сундуй, хүүхдийн номын зураач Б.Төрмөнх нарын нэрийг дахин дэвшүүлсэн.

- Үйлдвэрчний эвлэл болон Ёс зүйн дэд хороо хамтарч 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Удирдлагын академийн хууль зүйн тэнхимийн эрхлэгч А.Алтанзулыг урьж "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

- Булган,Төв, Хэнтий аймгийн нийтийн номын сан болон сумдын ЗДТГ, СУГ, номын санчидтай хамтарч өдөрлөг, сургалт зохион байгуулсан.

✓ Шилэн дансны мэдээллийг тогтмол тайлагнаж байна.

ДӨРӨВ. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ТАЛААР

- **Төсвийн төлөвлөлт, зарцуулалт** /өссөн дүнгээр/

Зардлын төрөл	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
I. ОРЛОГЫН ДҮН	**918,442,108.00**	**918,442,108.00**
Төсвөөс урсгал санхүүжилт	918,442,108.00	918,442,108.00

Төсвөөс хөрөнгө оруулалтын санхүүжилт		
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		
À. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	**918,442,108.00**	**864,824,445.34**
1. Бараа үйлчилгээний зардал	**918,442,108.00**	**864,824,445.34**
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	**541,081,400.00**	**521,116,450.26**
Үндсэн цалин	325,153,500.00	323,596,117.93
Нэмэгдэл цалин	94,927,900.00	89,848,431.64
Унаа хоолны хөнгөлөлт	88,015,900.00	66,620,984.29
Урамшуулал	32,984,100.00	41,050,916.40
Гэрээт ажлын цалин		
1.2 Ажил олгогоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	**67,635,000.00**	**66,413,486.08**
Тэтгэврийн даатгал	45,991,800.00	45,469,825.01
Тэтгэмжийн даатгал	5,411,000.00	5,274,797.46
ҮОМШӨвчний даатгал	4,328,400.00	4,193,277.99
Ажилгүйдлийн даатгал	1,082,200.00	1,043,820.47
Байгууллага төлөх ЭМД хураамж	10,821,600.00	10,431,765.15
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	**309,725,708.00**	**277,294,509.00**
Байрны түрээс хөлс	125,626,600.00	125,626,600.00
Бичиг хэрэг	385,000.00	1,298,000.00
Тээвэр шатахуун	481,800.00	
Шуудан холбоо	1,767,700.00	1,835,400.00
Ном холбоо	7,102,700.00	3,887,350.00
Хог хаягдал зайлуулах	298,100.00	550,000.00
Бага үнэтэй түргэн элэгдэх	1,769,600.00	3,757,507.00
Багаж техник хэрэгсэл	47,330,000.00	45,310,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,840,000.00	3,800,000.00
Урсгал засвар	8,030,000.00	1,084,600.00
Бусад нийтлэг, АҮТХураамж	44,555,100.00	44,475,000.00
Аудит бат, зэрэглэл тогтоох	823,800.00	819,200.00
Даатгалын үйлчилгээ	61,800.00	
Тээврийн хэрэгслийн татвар	40,100.00	
Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,700.00	
Мэдээлэл технологийн үйлчилгээ	717,200.00	380,000.00
Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж	44,376,708.00	22,300,852.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	294,800.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	22,200,000.00	22,170,000.00
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**0.00**	**0.00**
Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт		
Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт		
Мөнгөн хөрөнгийн 2023.11.30 ны үлдэгдэл	**0.00**	**53,617,662.66**
Үүнээс банкин дахь харилцах дансны үлдэгдэл	**0.00**	**53,617,662.66**

Бусад байгууллага иргэдээс авах авлагын эцсийн үлдэгдэл		
Бусад байгууллага иргэдэд өгөх өглөгийн эцсийн үлдэгдэл		
АЖИЛЛАГСАД БҮГД	**32**	**32**
Удирдах ажилтан	1	1
Гүйцэтгэх ажилтан	24	24
Үйлчлэх ажилтан	7	7

- ❖ **Худалдан авалт:**

2023 онд Улсын төсвөөр хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээ, тендер байхгүй. Үйл ажиллагааны зардалтай холбоотой бичиг хэргийн болон хангамжийн материалыг шууд худалдан авалтаар гүйцэтгэж байна.

- ❖ **Өр, авлага:**

2023 оны санхүүгийн тайлангийн жилийн эхний 141,320.00 /нэг зуун дөчин нэгэн мянга гурван зуун хорь/ төгрөгийн авлагыг барагдуулсан.

Мөн жилийн эхний 5,319,799.61 /таван сая гурван зуун арван есөн мянга долоон зуун ерэн есөн төгрөг 61 мөнгө/ -н Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг тайлант хугацаанд барагдуулсан.

- ❖ **Шилэн дансны хэрэгжилт:**

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг цаг тухай бүрд нь https://shilendans.gov.mn/ сайтад бүртгэж байна. Мөн Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас улирал бүр шалгалт хийгдэж, зөвлөмжийн дагуу энэ оны 3 дугаар улирлын байдлаар 57 нэр төрлийн мэдээллийг 99 талбарт бүрэн мэдээлсэн. Хагас жилийн аудитын дүгнэлтээр 96,5 хувьтай үнэлэгдсэн.

С.ЖАМЬЯНГАРАВЫН НЭРЭМЖИТ АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

НЭГ: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Эрхэм зорилго

1.2. Номын сангийн танилцуулга

ХОЁР: САН ХӨМРӨГ, КАТАЛОГИ

2.1. Сан хөмрөгийн өнөөгийн байдал

2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт

2.3. Каталоги зохион байгуулалт

ГУРАВ: ҮЙЛЧИЛГЭЭ

3.1. Уншлага үйлчилгээ

3.2. Нүүдлийн номын сангийн үйлчилгээ

3.3. “Их мэдэх” танхим

3.4. “Эко” танхим

3.5. Ангийн уншлага

3.6. “Боролдой” үлгэрийн цаг

3.7. Номын үзэсгэлэн

3.8. Лавлагаа мэдээлэл

3.9. Цахим үйлчилгээ

3.10. Мэргэжил, арга зүйн ажил

ДӨРӨВ: СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

ТАВ: ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

ЗУРГАА: ТӨСӨВ, САНХҮҮ

ДОЛОО: СУРГАЛТ, СЕМИНАР

НАЙМ: БУСАД АЖИЛ

Тайлбар: Архангай аймгийн нийтийн номын сангийн 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг 8 бүлэгт хуваан тайлагналаа.

НЭГ: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Эрхэм зорилго: Аймгийн нийт иргэдийг мэдээллээр хангах, соёлын үнэт өв болох ном хэвлэлийг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн мэдээллийн төв бий болгох, мэдээллийн чөлөөт урсгалыг хөгжүүлэх, ном хэвлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах.

1.2. Номын сангийн танилцуулга: Аймгийн нийтийн номын сан 1945 онд, Хүүхдийн номын ордон 1987 онд байгуулагдсан. 648 $м^2$ талбайтай хүүхдийн номын ордны шинэ барилга 2013 онд, 348 $м^2$ талбайтай нийтийн номын сангийн шинэ барилга 2017 онд тус тус ашиглалтанд орсон. Орон тооны нийт 11 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийтийн номын сан:

- ✓ Захирлын өрөө
- ✓ VIP өрөө
- ✓ Үндсэн фонд
- ✓ Тогтмол хэвлэлийн фонд
- ✓ Лавлагаа номзүйн фонд
- ✓ Нийтийн уншлагын танхим /Ойрын фонд/
- ✓ Үзэсгэлэнгийн танхим /Номын фонд/
- ✓ Зөөврийн номын санчийн өрөө
- ✓ Цайны өрөө

- ✓ Жижүүрийн өрөө

Хүүхдийн номын ордон:

- ✓ Хүүхдийн уншлагын танхим
- ✓ Мэдээлэл технологийн ажилтны өрөө
- ✓ Хүүхдийн уншлагын танхимын фонд
- ✓ Гадаад номын фонд
- ✓ “Их мэдэх” танхим
- ✓ Монгол бичиг, Англи номын фонд
- ✓ Эко танхим
- ✓ Нягтлан бодогчийн өрөө
- ✓ Архивын өрөө

Цахим хаяг: “Архангай – Нийтийн номын сан” пэйж хуудас, library.ar.gov.mn хаяг.

Цагийн хуваарь: Даваа - Баасан гаригт 9:00 - 13:00, 14:00 - 18:00 цаг, /13:00 – 14:00 цайны цаг/

Номын сангийн захирал: О.Мөнхтуяа

Байгуулагын утас: 70333248, 70332353

ХОЁР: САН ХӨМРӨГ, КАТАЛОГИ

2.1. Сан хөмрөгийн өнөөгийн байдал: Уншигчдын эрэлт хэрэгцээг үндэслэн татгалзлалын дэвтэр хөтөлж, тухайн жилийн батлагдсан төсвөөс сан хөмрөгийн баяжилтаа хийж ирсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар 3.442.900 төгрөгийн 164 ширхэг ном, 1.188.200 төгрөгийн 10 нэр төрлийн сонин сэтгүүл, 885.200 төгрөгийн 58 ширхэг хандивын номоор сан хөмрөгийн баяжилт хийсэн байна.

2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт: Номын сангийн чухал зүйлийн нэг бол сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт байдаг. Иймээс 2023 оны жилийн эцсийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа урагдаж, гэмтсэн 806 ширхэг номыг сэлбэн засаж уншлагад гаргахад бэлэн болгосон.

2. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа нийт ном, хэвлэл болон тавиурын тоосыг арчиж цэвэрлэсэн.

3. Номын сангийн фондын өрөөнүүдийн дулаан, чийгшилд өдөр бүр хяналт тавьж ажилладаг.

4. Байгууллагын өрөө тасалгаануудад улирал бүр их цэвэрлэгээ, ариутгал хийлгэдэг.

5. Шинээр ирсэн 222 номонд техник ажиллагаа хийж ШУ – ны салбараар ангилж тавиурт байрлууллаа.

6. 2023 онд 10 нэр төрлийн сонин, сэтгүүл захиалж уншлагад гаргасан ба үдэж хавтаслан, хаягжуулж сонин сэтгүүлийн нэг бүрчилсэн бүртгэлд дансалж, тогтмол хэвлэлийн фондод шилжүүллээ.

7. Нийтийн уншлагын танхимын ойрын фонд болон үндсэн фондын А танхимын бүх тавиурын хаяг ялгагчийг шинэчилсэн.

8. 2023 онд Архангайн амьдрал, Архангайн толь сонины 1947 оноос 2021 оны хооронд хэвлэгдсэн 3175 нүүр мэдээллийг үндэсний тогтмол хэвлэлийн цахим нэгдсэн санд байршуулсан.

2.3. Каталог зохион байгуулалт: Үүлэн технологид суурилсан электрон каталогийн коха программыг үйлчилгээндээ нэвтрүүлсэн бөгөөд хүүхдийн уншлагын танхимын фонд, нийтийн уншлагын танхимын фонд, тогтмол хэвлэлийн фонд, үндсэн сан хөмрөгт хадгалагдаж байгаа монгол хэл дээр хэвлэгдсэн нийт 16989 нэр төрлийн 57749 ширхэг номын мэдээллийг шивж оруулж ном бүрийн бар кодыг наасан. 2023 оны жилийн эцсийн байдлаар шинээр ирсэн 120 ширхэг номын мэдээллийг нэмж оруулсан ба 1170 ширхэг номын дутуу мэдээллийг засаж оруулсан.

ГУРАВ: ҮЙЛЧИЛГЭЭ.

Нийтийн номын сан нь төрөлжсөн 12 танхимаар иргэд, уншигчдад үйлчилгээ үзүүлдэг. 2023 онд үндсэн фонд, нийтийн болон хүүхдийн уншлагын танхимаар, гэрээр, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр нийт 2872 уншигч шинээр бүртгэж, давхардсан тоогоор 21900 ирэгсдэд 63050 ширхэг ном, 4004 ширхэг сонин, сэтгүүлээр үйлчилсэн.

3.1. Уншлага үйлчилгээ: Уншлага үйлчилгээг дараах байдлаар тус тус хүргэсэн байна.

1. Нийтийн уншлагын танхим: 955 уншигч шинээр бүртгэж, 8370 ирэгсдэд давхардсан тоогоор 23050 ширхэг ном, 4004 ширхэг сонин, сэтгүүл танхимаар болон гэрээр олгосон.

2. Үндсэн фонд: 356 уншигч шинээр бүртгэж 1110 ирэгсдэд 3301 ширхэг ном гэрээр олгосон.

3. Хүүхдийн уншлагын танхим: 1251 уншигч шинээр бүртгэж 12420 ирэгсдэд 35649 ширхэг номыг танхимаар болон гэрээр олгосон.

4. Зөөврийн номын сангийн үйлчилгээ: Уншигчдад номын сангийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, номын сангийн уншигчдын тоог нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн хүрээг өргөжүүлэх зорилгоор зөөврийн номын сангийн үйлчилгээг гэрээний дагуу аймгийн Ахмадын хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, МСҮТ, Онцгой байдлын газар, Прокурорын газар, Татварын хэлтэс зэрэг 23 байгууллагын 310 гаруй уншигчдад 1050

ширхэг ном олгосон. Зөөврийн номын сангийн үйлчилгээний тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж Үндэсний номын санд тайлагнадаг.

3.2. Нүүдлийн номын сангийн үйлчилгээ: Эрдэнэбулган сумын 1, 2 дугаар багийн 48 насанд хүрэгч, 112 хүүхэд нийт 160 иргэд, уншигчдад 220 ширхэг номоор, Арслан цохионд байрлалтай тоглоомын талбайд 37 хүүхэд, 3 насанд хүрэгчдэд 45 ширхэг номоор, Булган уулын урд талбайд 20 иргэнд 25 ширхэг номоор тус тус нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэсэн.

3.3. “Их мэдэх” танхим: “Их мэдэх” танхимаар 2023 оны жилийн эцсийн байдлаар 58 багш, эцэг эхчүүд, 689 хүүхэд, багачууд үйлчлүүлж нийт 1026 ном олгосон. Мөн хүүхдийн номын ордон, нийтийн номын сантай танилцаж үйл ажиллагааны талаар мэдээлэл авлаа.

3.4. “Эко” уншлагын танхим: Уншигчдад байгаль орчноо танин мэдэх, хайрлан хамгаалах сэдэл төрүүлэх зорилгоор “Эко” танхимыг ажиллуулдаг. Уг танхимд 2023 оны жилийн эцсийн байдлаар 548 ирэгсэд үйлчлүүлж 713 ширхэг ном олгосон. “Миний

Архангай" сэдвийн хүрээнд хийсэн сурагч, эцэг эхчүүдийн бүтээлийн үзэсгэлэнг үзэж сонирхлоо.

3.5. Ангийн уншлага: Эрдэнэбулган сумын I, II, III, IV сургуулийн бага, дунд бүлгүүд ангийн уншлага тогтмол хийдэг. 2023 оны жилийн эцсийн байдлаар 578 ирэгсдэд 1545 номоор үйлчилгээ үзүүлж үлгэр, өгүүллэг уншиж өгч, ном унших ач тусын талаар мэдээлэл хийсэн байна.

3.6. "Боролдой" үлгэрийн цаг: "Боролдой" үлгэрийн цаг чанга уншлагыг хүүхдийн уншлагын танхимаар үйлчлүүлсэн уншигчдад зориулж их мэдэх танхимд явуулдаг ба 2023 онд 12 удаа чанга уншлага хийж цэцэрлэгийн насны 421 хүүхэд багачуудад хүргэсэн байна.

3.7. Номын үзэсгэлэн: 2023 оны жилийн эцсийн байдлаар 30 удаагийн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 1565 номоор гаргаж 3580 орчим иргэд уншигчдад сурталчлан таниуллаа.

3.8. Лавлагаа, мэдээлэл: 2023 онд 168 уншигч Хүмүүн бичиг, Архангайн амьдрал, Монголын үнэн, Зууны мэдээ, Архангайн үнэн, Өдрийн сонин, Пионерийн үнэн, Төрийн мэдээлэл, Архангайн толь, Утга зохиол урлаг, Өнөөдөр сонин, зэрэг 26 нэр төрлийн 188 багц тогтмол хэвлэлээс лавлагаа, мэдээлэл авлаа.

3.9. Цахим үйлчилгээ: “Архангай – Нийтийн номын сан” пэйж хуудсанд 172 уншигч хандаж и-мэйл хаяг, пэйж хуудсаар дамжуулан ном, тогтмол хэвлэлийн бүтээгдэхүүнээс шүүлгэж лавлагаа мэдээлэл авлаа.

3.10. Мэргэжил, арга зүйн ажил: МСҮТ, Гурван тамир, Цэнхэр, Жаргалант, Их тамир, Чулуут, Төвшрүүлэх, Булган сумдын Соёлын төвийн номын санчдад 20 удаа цахимаар болон утсаар мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн. Сумын Соёлын төвүүдийн номын санчдын группээр мэдээлэл солилцож, мэргэжлийн болон бусад сургалтанд хамруулах, мэдээ мэдээллээр хангаж ажилладаг.

ДӨРӨВ: СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

2023 оны жилийн эцсийн байдлаар 21 СОНА зохион байгуулж 2518 иргэд уншигч оролцож, 4043 гаруй иргэн хамрагдлаа. Үүнээс хүүхэд 1538, насанд хүрэгч 980 байлаа. Цахим орчинд зохион байгуулсан СОНА – аа сурталчлах зорилгоор “Архангай – Нийтийн номын сан” пэйж хуудсанд 121 удаа мэдээлэл байршуулж давхардсан тоогоор 284796 хүн үзэж мэдээлэл авсан байна.

4.1. МЗЭ – ийн гишүүн, утга зохиолын төлөө шагналт зохиолч, сэтгүүлч, эдийн засагч Шадавын Чимидбалдирын “Ирвэсийн эрэлд” хэмээх өгүүллэг, наргиа, цуудам яриа, дурсамж бүхий шинэ номын нээлтийн арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 10 – ны өдөр зохион байгууллаа. Нээлтэнд түүний үр хүүхэд, ач зээ, төрөл төрөгсөд, аймгийн ЗДТГ – ын төлөөлөл, ЭБ сумын Засаг дарга, СУГ – ын хамт олон, Цахир сумын нутгийн зөвлөлийн дарга, Нийгмийн бодлогын хэлтэсийн дарга, “Тамир” телевиз, “Буман үсэг” хэвлэх үйлдвэр, МСНЭ – ийн Архангай аймаг дахь “Сайн оюут” салбар зөвлөлийн хамт олон, “АВ” телевиз, “Архангайн толь” сонины редакци, ахмад сэтгүүлч Вандандорж,

Бараанасан, ахмад багш нар болон ЕБС – ийн багш нар, Хөгжимт драмын театрын уран бүтээлчид, амьд хөгжмийн “QN” хамтлаг, 1 – р сургуулийн дуу хөгжмийн багш сурагчид гэх мэт 80 гаруй хүн оролцлоо.

“Ирвэсийн эрэлд” номын нээлтэнд зориулж постер, баннер, түүний намтар уран бүтээлийн тухай видео контент, “Тамир” телевизтэй хамтран “Номын цаг” нэвтрүүлэг хийж телевиз болон цахим орчинд 37350 гаруй хүнд сурталчлан таниуллаа.

4.2. “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр” - ийг тохиолдуулан 2023 оны 03 дугаар сарын 08 – нд аймгийн Нийтийн номын сан, “Архангайн толь” сонины редакци хамтран “Ээждээ захидал бичээрэй” уралдааныг зохион байгууллаа. Ээжийгээ хайрлах үрс бүхний чин сэтгэлийн халуун дулаан үгсийг захидлаар дамжуулан хүргэх, хүүхэд залуусын дунд захидлын соёлыг түгээн дэлгэрүүлэх, эх хэлний найруулга зүйн чадварыг дээшлүүлэх зорилгын хүрээнд энэ жил сурагч, насанд хүрэгч гэсэн 2 ангиллаар цахимаар болон танхимаар зохион байгууллаа. Ангилал тус бүрээс шагналт 4 байр, онцлох нэг захидал шалгаруулсан. Эрдэнэбулган, Чулуут, Эрдэнэмандал, Тариат, Өлзийт, Өгийнуур зэрэг сумдаас нийт 124 насанд хүрэгч, 170 сурагч нийт 294 оролцогч оролцлоо. Уралдаанд ач холбогдол өгч захидлаа крилл болон үндэсний монгол бичгээр бичиж, ээжийхээ зургийг зурж, фото зургийг хавсаргах, захидлын дугтуйг өнгө будгаар ялган урлах зэргээр оролцогчдын идэвх

санаачилга, бүтээлчээр хандах байдал нэмэгдсэн нь онцлог байлаа.

4.3. Монгол улсад Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 102 жилийн ой, “Монгол цэргийн өдөр” - ийг тохиолдуулан Нийтийн номын сан, Аймгийн цэргийн штаб хамтран 2023 оны 03 дугаар сарын 18 – нд “Аавдаа захидал бичээрэй” уралдааныг насанд хүрэгч, сурагч гэсэн хоёр ангиллаар зохион байгууллаа. Захидлын уралдаанд Улаанбаатар хот болон Эрдэнэбулган, Хайрхан, Чулуут, Цэнхэр, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Тариат, Өлзийт, Өгийнуур зэрэг сумдаас нийт 85 насанд хүрэгч, 184 сурагч нийт 269 иргэд уншигчид оролцлоо.

4.4. 2023 оны 04 дүгээр сарын 21 – нд “Дэлхийн номын өдөр” - ийг тохиолдуулан "АВТОБУСТАЙ УНШЛАГА" арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд аймгийн МСҮТ – ийн номын санч, багш, суралцагчид нийт 48 хүн хамрагдлаа.

2023 оны 05 дугаар сарын 08 – нд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, ном хэвлэл, ёс заншил, үндэсний соёлын өв, монгол хэл бичгийн соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Үндэсний бичиг үсгийн баяр” - ыг зохион байгуулсан ба шагналын санг аймгийн ЗДТГ, Соёлын гавъяат зүтгэлтэн Г. Жамц, аймгийн СУГ - аас ивээн тэтгэлээ. “Зөв сайхан бичигтэн”, “Түргэн уншлага” уралдааныг дунд анги, ахлах анги, насанд хүрэгсэд гэсэн 3 насны ангиллаар, “Уран бичлэг” уралдааныг сурагч, насанд хүрэгч гэсэн 2 ангиллаар танхимаар болон цахимаар зохион байгуулж нийт 650 гаруй иргэд, уншигчид оролцлоо.

Арга хэмжээний үеэр "Тайхар таталбар" сургалтын төв, IV сургуулийн МХУЗ - ын багш Цэрэндэжид, Батцэнгэл сумын ЕБС - ийн МХУЗ - ын багш Ням - Адъяа, V сургуулийн МХУЗ -ын багш Баасан, III сургуулийн МХУЗ - ын багш Дэнсмаа, IV сургуулийн 12а ангийн сурагч Оюун - Эрдэнэ, II сургуулийн 12б ангийн сурагч Билгүүнсаран, IV сургуулийн МХУЗ - ын Наранцэцэг,Их тамир сумын ЕБС - ийн багш сурагчид, Эрдэнэмандал сумын ЕБС - ийн МХУЗ - ын багш Гэрэлсүрэн нарын уран бичлэгийн үзэсгэлэн дэлгэгдлээ.

4.5. “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль”, “Алсын хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” арга хэмжээг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг билээ. “Хүүхэд бүр уншигч” уриатай 33 дахь удаагийн “Номын баяр” - ыг 2023 оны 05 дугаар сарын 26 – 28 – ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд нийт 700 гаруй иргэд, уншигчид хамрагдлаа. Уг арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- 2023 оны 05 дугаар сарын дугаар 26 – нд “Үндэсний бичиг соёл номын өдрүүд - 2023” арга хэмжээний нээлт, “Номтой гудамж” өртөө /МСҮТ, хувь хүн, ХБИ – ийн холбоо,

ЕБС – иудын үйл ажиллагааны сурталчилгаа, өртөөчилсөн хөгжөөнт тоглоом/, ном болон соёлын бүтээлч үйлдэрлэгчдийн худалдаа зэрэг дэлгэгдлээ.

- Нээлтийн үеэр номын сангийн байнгын уншигч 10 сурагчийг Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэг, үнэмлэхээр шагналаа.

- Нийтийн номын сангийн уншлагын танхимд:

✓ Архангай аймгийн түүхт 100 жилийн ойд зориулсан "Архангай 100" сэдэвт номын үзэсгэлэн,

✓ Үндсэн фондын сан хөмрөгт хадгалагддаг ховор, үнэт номын үзэсгэлэн,

✓ “Хамгийн, хамгийн” сэдэвчилсэн ном, хэвлэлийн үзэсгэлэн,

✓ “Үндэсний бичиг үсгийн баяр – 2023” арга хэмжээний “Уран бичлэг” - ийн уралдааны тэргүүн байрын шагналт V сургуулийн МХУЗ - ын багш Баасан, IV сургуулийн МХУЗ - ын багш Наранцэцэг нарын уран бичлэгийн үзэсгэлэн,

✓ Орон нутгийн хэвлэх үйлдвэр "Буман үсэг" ХХК - ийн номын үзэсгэлэн,

✓ “Төгс баясгалант” хийдийн ховор судар, номын үзэсгэлэн,

✓ Өвлөн уламжлагч Х. Батбаярын ховор судар номын үзэсгэлэн дэлгэгдэж номтой хотхон өртөө, үзэсгэлэн, урлагийн тоглолт, худалдаанд оролцогчдод шагнал гардууллаа. Шагналын санг "Сочутранс" ХХК - ийн захирал Б. Чойдог ивээн тэтгэлээ.

- Хүүхдийн номын ордонд ЕБС – ийн сурагчдын дунд "Уншаад урагшилахуй - Цахим орчны зохистой хэрэглээ" ном уншлагыг сурталчлах, сэдэлжүүлэх сургалт, “Номын өргөөний ид шид” номын сангаас уншигчдад өгдөг боломжуудыг дэлгэрэнгүй танилцуулах лекц танилцуулгыг зохион байгууллаа.

- Нийтийн номын сангийн үзэсгэлэнгийн танхимд "Багадаа уншсан ном" уран зохиолын уулзалт, үдэшлэгийг ахмадуудын дунд зохион байгуулж Архангай аймгийн түүхт 100 жилийн ойд зориулан "Нутгийн уул, усны домгийг хэн сайн ярих вэ" тэмцээн явууллаа. Уулзалтын үеэр "Багадаа уншсан ном" сэдэвт хуучны номуудаар үзэсгэлэн гаргасан нь ахмадуудын сонирхлыг татаж ярианы гол сэдэв болж байлаа.

- 2023 оны 05 дугаар сарын 27 – нд "Үлгэрээс үлгэрлэе" Монголын болон дэлхий дахины сонгодог үлгэрүүдээр СӨНХ болон ЕБС - ийн бага ангийн сурагчдад чанга уншлага, ярилцлагыг “Өлзий Pixel gallery” номын дэлгүүр болон ЭБ сумын хүүхдийн 6 – р цэцэрлэг дээр зохион байгуулсан.

- 2023 оны 05 дугаар сарын 28 – нд Архангай аймгийн 100 жилийн ойг тохиолдуулан орон нутгийн түүх, дурсгалт газруудаар “Эко” автобустай "Соёлын өртөөчилсөн аялал" - ыг ЕБС - ийн сурагчдын дунд зохион байгуулж, аяллын хүрээнд "Бийрээ нийлье - Ургаа уудалъя" үндэсний бичиг, угийн бичгийн мэдээлэл сургалтыг хийлээ. “Тайхар таталбар” сургалтын төв болон ЭБ сумын IV сургуулийн МХУЗ - ын багш Б. Цэрэндэжид, ГБХЗХГ - ын гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б. Наранцэцэг, Архангай аймгийн Музейн сан хөмрөгч Б. Баатархүү нар лекц танилцуулга хийж хамтран ажиллалаа.

4.6. 2023 оны 06 дугаар сарын 01 – нд “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” – ийг тохиолдуулан “Ээжтэйгээ хамт уншъя” өдөрлөгийг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд хүүхдийн шинэ номуудаар үзэсгэлэн гаргаж, танин мэдэхүйн “АХА” тэмцээн, бяцхан оролцогчдодоо зориулан “Хамтдаа бүтээе” өнгөөр ялгах хөгжөөнт тоглоом явуулж, шагнаж урамшууллаа.

4.7. Ном уншлага, номын сангийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор нийтийн номын сангаас санаачлан “Номын цаг нэвтрүүлэг” - ийг Тамир телевизтэй хамтран зохион байгуулдаг ба 2023 онд 4 дугаар бэлтгэн үзэгчдэд хүргэлээ. Мөн орон нутгийн “АВ” телевиз, “Тамир” телевиз, “Өнгө” студи, “Архангайн толь” зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагад номын сангийн үйл ажиллагаа, СОНА – ын талаар 18 удаагийн ярилцлага мэдээлэл өгсөн.



4.8. “Номтой Монгол” уриатай 34 дэх удаагийн “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” арга хэмжээг 2023 оны 09 дүгээр сарын 15 – 17 – ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэ арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг төлөвлөн хийж гүйцэтгэлээ:

- Номын баярын нээлтийн үеэр “Тэргүүний уншигч - Д. Нацагдорж” тэмдэгтэн шагнал гардуулах ёслол боллоо. Тус шагналын болзолыг хангасан байнгын уншигч 3 сурагч шагнагдлаа.

- “Хамгийн хамгийн” сэдэвчилсэн номын үзэсгэлэн, “Номтой хотхон” өртөө, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, Архангай аймгийн зохиолчдын гар бичмэлийн үзэсгэлэн дэлгэгдлээ.



- “Зохиолч уншигчдын уулзалт” - нд Архангай аймгийн түүхт 100 жилийн ойгоор СГЗ цолоор шагнагдсан зохиолч, сэтгүүлч С. Барааннасан оролцсон ба түүний амьдрал, уран бүтээлийн талаар халуун яриа өрнүүллээ.

- "Үлгэрийн ертөнц" чанга уншлага, ярилцлагыг "Ирээдүй" цогцолбор бага сургуулийн сурагчдын дунд зохион байгууллаа.

- МУБИС - ийн харьяа Архангай аймаг дахь Багшийн сургуулийн II курсийн оюутнуудын дунд " ЭРДМИЙН ХӨТӨЧ" - танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж, шагналт 3 байр шалгаруууллаа.

- "НОМТОЙ АЯЛАЛ" өдөрлөгийг алслагдсан бүс болох МСҮТ - ийн дотуур байрны оюутнуудын дунд зохион байгуулж зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэсэн.

- “Эрдмийн сувд” подкастын I дугаарыг “Тархины булчин” номын клубтэй хамтран хийж цахим орчинд байршуулан уншигчдад ном уншихын ач тусын талаар болон ном уншихыг уриалж мэдээлэл хүргэлээ.

4.9. “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР” аяны нээлтийн арга хэмжээ: Архангай аймгийн түүхт 100 жилийн ойн хүрээнд Аймгийн утга зохиолын нэгдлийн 70 жилийн ойд зориулсан “Хангайн цом – 2023” яруу найргийн наадмыг “Хан тамир” утга зохиолын нэгдэл, аймгийн ЗДТГ, Эрдэнэбулган сумын ЗДТГ, СУГ, ХДТ – тай хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр “Соёлын эрхийн бичиг” – ийн тандалт судалгааг 16 – 18 насны сурагчдаас цаасаар болон цахимаар авсан ба номын сангийн уншигчын карт нээж, Архангай аймгийн зохиолч, яруу найрагчдын бүтээлийн дээжсээр үзэсгэлэн гаргалаа.

4.10. “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР” аяны II долоо хоног бүтээлч байдал, мэдлэг туршлага сэдвийн хүрээнд хийсэн “ЭРДМИЙН СУВД" подкастын 2 дахь дугаарт номын сангийн байнгын уншигч, буддын шашныг шимтэн судлагч, эрүүл зөв амьдралыг эрхэмлэгч Ж. Алтансүх оролцлоо.

4.11. “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР” аяны III долоо хоног Соёлын хүртээмж - хөрөнгө оруулалт сэдвийн хүрээнд хийсэн “АХМАД УНШИГЧАА СОНСЪЁ” цуврал видео бичлэгийг хийж цахим орчинд 8000 гаруй хүнд хүргэлээ.

4.12. “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд Булган сумын Соёлын төвийн дэргэдэх номын клубын гишүүн сурагчид аймгийн нийтийн номын сантай танилцах аялал зохион байгуулсан ба үйл ажиллагааны талаарх мэдээллээ хүргэлээ.

4.13. "Соёлын бүтээлч сар" аян - Соёлын эрхийн бичиг – ийн хүрээнд "Зохиолч, уншигчдын уулзалт" - ыг аймгийн Боловсрол ШУ - ны газрын гадаад хэлний сургалт хариуцсан мэргэжилтэн, дэлхийн хайкугийн холбооны гишүүн, Монголын хайкугийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, орчуулагч, яруу найрагч Н. Төвшинзаяатай хамтран 16 – 18 насны сурагчдын дунд зохион байгууллаа.

4.15. "Соёлын бүтээлч сар" аян - Соёлын эрхийн бичиг

2023.11.22 - нд 16 - 18 насны сурагчдын дунд "Угийн бичгээ хөтөлцгөөе" сургалтыг Сургагч багш, ГБХЗХГ - ын Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б. Наранцэцэг – тэй хамтран зохион байгууллаа.

4.16. "Соёлын бүтээлч сар" аян - Соёлын эрхийн бичиг

2023.11.22 - нд 16 - 18 насны сурагчдын дунд "Мэргэжлийн чиг баримжаа" сургалтыг Хяналт үнэлгээ шинжилгээ хариуцсан мэргэжилтэн Г. Сумъяабаатартай хамтран зохион байгууллаа.

4.17. Бүтээлч залуус уриатай "Соёлын бүтээлч сар" аяны хаалтын арга хэмжээ. "FUNNY GUYS" хөгжөөнт тэмцээн. Номын сангийн үйлчилгээг сонирхолтой, шинэлэг хэлбэрээр хүргэх зорилгоор МУБИС - ийн харъяа Архангай аймаг дахь Багшийн сургуулийн 2, 3 - р курсийн оюутан залуусийн дунд зохион байгууллаа. Тэмцээн 5 үе шаттай явагдаж шагналт 3 байр шалгаруулаа.

УРАН ЗУРАГ

4.18. “Оюунлаг гэр бүл” өдөрлөгт ЕБ – ын 3 – р сургуулийн 4 – р ангийн 3 бүлгийн 95 сурагч эцэг, эх, гэр бүлийн хамт оролцлоо.

4.19. "Соёлын орон зай" - сургалт мэдээллийг ЕБ - ын III сургуулийн 6, 7, 8, 9 - р ангийн сурагчдад номын сангийн ахмад уншигч Н. Даниновтой хамтран хүргэлээ.

ТАВ. ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Электрон каталоги: Үүлэн технологид суурилсан коха программд 16989 нэр төрлийн 57869 ширхэг номын мэдээллийг оруулсан нь нийт сан хөмрөгийн 90% болно. 2023 оны жилийн эцсийн байдлаар 120 номын мэдээллийг коха программд нэмж оруулсан ба 1100 номын мэдээллийг засаж шинэчлэн бар код нааж шинжлэх ухааны салбараар тавиурт байрлуулсан.

2. “Архангай - Нийтийн номын сан” пэйж хуудсанд үндсэн үйл ажиллагаа, СОНА – ын талаарх мэдээллийг тогтмол байршуулдаг. 2023 онд 121 удаагийн мэдээлэл байршуулж цахим орчинд давхардсан тоогоор 284796 хүнд хүргэсэн байна. Мөн “Номын сангийн тухай хууль”, байгууллагын үйл ажиллагааны танилцуулга зэргийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор хоолойн бичлэг, шторк, мэдээлэл, лайв, видео бичлэг бэлтгэн цахим орчинд нийтэлж, уншигчдад сурталчлан танилцуулж, мэдээлэл хүргэдэг.



3. 24 цагийн харуул хамгаалалт, галын дохиолол, гадна ба дотор хяналтын камер, хөдөлгөөн мэдрэгч бүхий дохиолол, гадна талбайн гэрэлтүүлэг зэргийг хийж аюулгүй байдлыг хангасан.

4. Нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхимд соронзон долгионоор мэдрэгч дохиолол бүхий хамгаалалтын төхөөрөмж байрлуулж чөлөөт сонголтоор ном олгодог ба алдагдахаас сэргийлдэг.

ЗУРГАА. ТӨСӨВ, ОРЛОГО, ЗАРДАЛ:

2023 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвөөс 85.703.8 төгрөг, улсын төсвөөс 194.655.6 төгрөгөөр тус тус санхүүжиж тайлант хугацаанд батлагдсан төсвийн хүрээнд үр ашигтай зарцуулж өр авлагагүй ажилласан.

ДОЛОО. СУРГАЛТ, СЕМИНАР

- ✓ 2023 оны 02 дугаар сарын 06 - нд “Үндэсний бичгээр цахимд бичих арга зүй” сургалт;
- ✓ 2023 оны 03 дугаар сарын 24 – нд ОБГ – аас зохион байгуулсан “Гал түймэр унтраах тархалтын сургуулилалт”;
- ✓ 2023 оны 03 дугаар сарын 27 – нд “Архангай 100 – Соёлын хөгжил” форум;
- ✓ 2023 оны 04 дүгээр сарын 06 – нд ГБХЗХГ – аас зохион байгуулсан “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, Хүүхэд хүмүүжлийн эерэг аргууд” сургалт;
- ✓ 2023 оны 04 дүгээр сарын 10, 11 – нд Австралийн ЭСЯ, МҮҮНС, МНСХ – ноос хамтран зохион байгуулсан “Хил хязгааргүй номын сан” төслийн сургалт;
- ✓ 2023 оны 04 дүгээр сарын 13 – нд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратеги судалгааны хүрээлэнгээс зохион байгуулсан “Үндэсний аюулгүй байдал, нэгдмэл үнэт зүйл” сургалт;
- ✓ 2023 оны 04 дүгээр сарын 21 – нд ГБХЗХГ – аас зохион байгуулсан “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчмууд, Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх нь” сургалт;
- ✓ 2023 оны 05 дугаар сарын 10 – нд “Соёлын сэргэлт” арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Номын сангийн өнөөгийн байдал, эрх зүйн орчин, цаашдын чиг хандлага” сургалт;
- ✓ 2023 оны 05 дугаар сарын 10 – нд “Соёлын сэргэлт” арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Сошиал медиа маркетинг, Соёлын бүтээлч үйлдвэрлэл” сургалт;
- ✓ 2023 оны 06 дугаар сарын 16 - нд Соёлын Яам, UNESCO, МҮНС, “Соёлын өвийн үндэсний төв” - өөс хамтран зохион байгуулсан “Дэлхийн дурсамж хөтөлбөр - Баримтат өв”, “Монголчуудын ном судар бүтээж ирсэн түүхэн уламжлал” цахим сургалт;

✓ 2023 оны 06 дугаар сарын 19, 20 - ны өдрүүдэд Европын холбооны санхүүжилттэй “Монгол улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн “Үр дүнд суурилсан удирдлага” сургалт, семинар;

✓ 2023 оны 10 дугаар сарын 24 - 25, 2023 оны 10 дугаар сарын 30 - 31-.ны өдрүүдэд ЦХХХЯ, БШУЯ, ХНХЯ, Соёлын Яамнаас хамтран зохион байгуулсан “Номын санч, нийгмийн ажилтны цахим ур чадварыг дээшлүүлэх, сургагч багш бэлтгэх 12 цагийн багц цахим сургалт;

✓ 2023 оны 11 дүгээр сарын 01 – нд ЦЕГ – аас зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг” цахим сургалт;

✓ 2023 оны 11 дүгээр сарын 09 - нд Соёлын яамнаас зохион байгуулсан “Соёлын бүтээлч үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” цахим сургалт;

✓ 2023 оны 11 дүгээр сарын 18 - нд СУГ - аас зохион байгуулсан “Соёлын эрхийн бичиг” болон тандалтын судалгааны талаарх цахим сургалт;

✓ 2023 оны 11 дүгээр сарын 20 – нд Стандарт хэмжилзүйн газраас зохион байгуулсан “Эрсдэл ба стандарт”, эрсдэлийн үндэсний форум;

✓ 2023 оны 11 дүгээр сарын 21 – нд МҮНС – аас зохион байгуулсан “Дижитал номын сангийн систем” сургалт;дирдлагын академи болон Төрийн инновации хөгжлийн албанаас хэрэгжүүлж буй “Төрийн албан хаагчдад зориулсан төрийн албаны “Ёс зүй” 1, 2, 3 – р түвшиний сургалтуудад тус тус цахимаар болон танхимаар хамрагдсан.




НАЙМ. БУСАД АЖИЛ:

1. Өдөр бүр хлораминтай усаар цэвэрлэгээний батлагдсан хуваарийн дагуу чийгтэй цэвэрлэгээ хийж, ажлын байрны ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахин ажиллаж байна.

2. Байгууллагын гадна талбайн хог хаягдлыг өдөр бүр цэвэрлэж, ажилтан, албан хаагч, уншигчдад тав тухтай, аюулгүй орчин бүрдүүлж ажилладаг.

3. Улирал бүр хүүхдийн номын ордон, нийтийн номын санд их цэвэрлэгээ хийдэг.

4. Бүх нийтийн их цэвэрлэгээг хамт олноороо хийж гүйцэтгэлээ.

5. Архангай аймгийн түүхт 100 жилийн ойг угтаж байгууллагын гадна талбайд найман төрлийн цэцгийн үрсэлгээг суулгаж, төмөр хайсыг сэлбэн засаж, будсанаас гадна хуучин хашаа, хаалгыг буулгаж шинээр хийлээ. Мөн “Архангай 100 – Ногоон төгөл” – д 15 ширхэг мод, тэр бум мод уриатай “Үндэсний мод тарих өдөр” – т 12 ширхэг мод шинээр тарьлаа. “Архангай – 100” жилийн хүрээнд болон ЭБ сумын хэмжээнд “Бүх нийтийн цэвэрлэгээний өдөр” – ийг тохиолдуулан Аймгийн музей орчмын хуваарьт газарт 2 удаа их цэвэрлэгээ хийсэн. Мөн байгууллагаас 50м доторх талбайн хог хаягдал, цас мөсийг тогтмол цэвэрлэж байна.

6. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт нь баримт бичгийн стандартын дагуу хийгддэг ба ЗД – ын захирамж, албан даалгавар, Гүйцэтгэлийн тайлан, Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайлан, Үйл ажиллагааны бичмэл тайлан, Өргөдөл гомдлын мэдээ тайлан, Зөөврийн номын сангийн тайлан, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, Номын сангийн захирлын аймгийн аймгийн ЗД -тай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан, Шуурхай зөвлөгөөний тайлан, Сарын мэдээ гэх мэт тайлан, мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр хуулийн хугацаанд тайлагнадаг.

7. Шуурхай хуралдаан болон бусад сургалт, семинар, зөвлөгөөн, форумд тогтмол сууж хэвшсэн ба тэндээс гарсан шийдвэрийн биелэлтийг тухай бүрд стандартын дагуу гаргаж холбогдох газарт хүргүүлдэг.

8. Соёлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Номын сангийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шилэн дансны хууль, Соёлын өвийн тухай хууль, байгууллагын дотоод журам, номын сангийн үлгэрчилсэн дүрэм болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж номын сангийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, түргэн шуурхай, соёлтой хүргэж ажилладаг.

9. Төсвийн мэдээ тайлан болон өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллийг ил тод нээлттэй байлгах зорилгоор тогтмол гаргаж www. Shilendans.mn сайт, мэдээллийн самбар болон пэйж хуудсанд байршуулдаг.

10. Байгууллагын дотоод хяналт үнэлгээ хариуцсан ажилтан батлагдсан төлөвлөгөөний дагуу улирал тутамд хяналт тавьж ажилладаг.

11. Соёл, урлагийн ажилтны баярын өдөрт зориулан аймгийн нийт соёлын ажилтан, албан хаагчдын дунд СУГ – аас зохион байгуулсан спортын 3 төрөлт тэмцээн, “Архангайн амьдрал” сонины 20 жилийн ойд зориулан “АВ” телевиз, аймгийн СУГ – ын дэргэдэх соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөл, Биеийн тамир спортын газар хамтран зохион байгуулсан “Ширдэгний шагай” шүүрэх тэмцээнд тус тус баг бүрдүүлэн оролцлоо.

12. Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22 - ны өдрийн 258 дугаар тогтоолыг байгууллагын ажилтан бүр мөрдөж зөрчил дутагдалгүй ажиллалаа.

---oOo---

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН Б. АХТАНЫ НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. ЭРХЭМ ЗОРИЛГО:

Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн техник технологитой хослуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн, түүх соёлын үнэт өв, ном товхимолыг өсвөр хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгэмд мэдээлэлд тулгуурласан мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэх **“Мэдээллийн нээлттэй төв”** болох.

1.2. НОМЫН САНГИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Тус номын сан 1949 онд байгуулагдсан. 2014 онд шинэ байранд орж, нэг ээлжинд 180 хүнийг хүлээн авч ном уншуулах чадвартай 5 уншлагын танхимтай. Насанд хүрэгчдийн танхим, Гэрээр ном олгох танхим, Хүүхдийн уншлагын 1-р танхим /1-3 анги, бяцхан уншигчдын/, Хүүхдийн уншлагын 2-р танхим /4-8 анги/, болон оройн номын сангийн танхимтай. Танхимууд бүгд чөлөөт сонголттой. Нийт 17 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 03-р сарын 09-ний өдрийн 37 тоот тогтоолоор аймгийн нийтийн номын санг зохиолч, яруу найрагч Б.Ахтаны нэрэмжит болгосон.

Цахим хаяг: Б.Ахтаны нэрэмжит Баян-Өлгий аймгийн төв номын сан
Өвлийн цагийн хуваарь: Даваа-Баасан гарагт, Өглөө 8:00-12:00, үдээс хойш 13:00-17:00 цаг, орой 17:00-21:00
Зуны цагийн хуваарь: Даваа-Баасан гарагт, Өглөө 9:00-12:00, Орой 13:00-18:00 цаг
Бямба гарагт: Өглөө 10:00-13:00
Байгууллагын утасны дугаар: 70422504, 95425353
Номын сангийн захирал Д.Алтынгүл

2. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

2.1. Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, бүтэц зохион байгуулалт, боловсруулалт

2023 оны байдлаар 100ш номыг 3038000 төгрөгөөр худалдаагаар, 673ш номыг 9851300 төгрөгөөр бэлэг болон хандиваар фондын бүрдүүлэлт хийгдэж, электрон каталогт оруулан, 773ш баркод хэвлэсэн байна. Бүрдүүлэлтээр авсан бүх номыг нэгдсэн болон нэгбүрчилсэн бүртгэлд авч, уншлагын танхимуудад хүлээлгэн өгч уншлаганд шилжүүлж, 10 төрлийн 618200 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна.

“Ном хандивлах аян” зарлаж, аяны хүрээнд Монгол Улсын Соёлын гавъяат зүтгэлтэн, доктор, профессор, зохиолч, сэтгүүлч Хапышийн ИСЛАМ-ын нэрэмжит хүүхдийн уншлагын 2-р танхимд зохиолчийн үр хүүхдүүд 150 гаруй ном хэвлэлийн дээж хандивлав.



Шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойн хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас хараагүй болон сул хараатай хүмүүсийн оюуны мэлмийг тэлэх зорилгоор хурууны өндгөөр тэмтрэн унших хурууны өндгөнд мэдрэгдэхүйц цэгүүдийн нийлэмж болох товгор үсэгтэй шинэ үндсэн хуулийн брайль номыг бэлэглэлээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар "Монгол нутгийн зураг" түүхэн газрын зургийн цомгийг олны хүртээл болгосон байна. "Монгол нутгийн зураг" түүхэн газрын зургийн цомгийн номыг номын сангийн фондын сан хөмрөгт хадгалуулахаар хандивлав.

"Алтайн бүргэд" холбооноос сурагчдад зориулсан Англи, Монгол, Казах хэлний сурагчдын гарын авлага, роман бүхий 2000 ном хандивлав.

Урлагийн гавьяат зүтгэлтэн,
яруу найрагч Бабийн Ахтаны нэрэмжит төв номын сан

ТАЛАРХАЛ

Монголын казах сурагчдын "Алтайн бүргэд" холбооны ерөнхийлөгч БИРЖАН Хайыпхан танаа

Баян-Өлгий аймгийн Б.Ахтаны нэрэмжит төв номын санд хандивлаж буй Англи, Монгол, Казах хэлний сурагчдын гарын авлага, роман бүхий 2000 номын эхний 540 номыг хүлээж авлаа.

Танай холбооны Монголын Казах сурагч, залууст эрүүлж байгаа оюуны хөрөнгө оруулалтыг бид өндрөөр үнэлж байна.

Иймд аймгийн нийт номд хайртай уншигч, сурагч, залуус, эцэг эхчүүдийн өмнөөс болон хувиасаа ТАЛАРХАЛ илэрхийлж, таны казах залууст үзүүлж буй үлгэр дуурайллыг тань үнэлэн цаашдын ажил амьдралд тань амжилт, эрүүл энхийг хүсье!

Номын цагаан буян мөнх дэлгэрэх болтугай

Баян-Өлгий аймгийн
Б.Ахтаны нэрэмжит төв номын сан

2022 он Өлгий хот

2.2. Номын сангийн фондын хадгалалт, хамгаалалт

Номын сангийн барилга, байгууламж нь гал, усны гэнэтийн аюул, хулгайн гэмт халдлгаас хамгаалах зориулалтын уншлагын танхимууд болон номын сангийн каридор, үүдний өөрөө, хувцасны өлгүүрийн өрөөнүүдэд 7ш, гадна талд 2ш телекамер ажиллаж байсан ба үндсэн фонд болон гадна талд шинээр 6ш телекамер байрлуулан нийт 15ш телекамер, 24ш дохиоллын хэрэгсэл бүрэн бүтэн ажиллаж байна.

2023 оны байдлаар ГНОТанхим-65, Насанд хүрэгчдийн уншлагын танхим-35, Хүүхдийн 1-р танхим-52, Хүүхдийн 2-р танхим-75, Үндсэн фондын-35 номыг тус-тус сэлбэн засаж, номын аюулгүй байдал, хадгалалтыг сайжруулав.

Гэрээр олгогдсон номуудын буцааж авахад ариутгаж авах зориулалт бүхийн 36 литрийн багтаамжтай Ном ариутгагч төхөөрөмж шинээр авч, хуучин 200ш номыг ариутгаж эхлэв.

3. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

2023 онд Өлгий сумын ЕБС-ийн сурагчид болон цэцэрлэгийн хүүхдүүдийг номын санд хамруулах 5 өдрийн хуваарь гаргаж, "Бяцхан уншигчдын танхим", "Оройн номын сан", "Гадны чөлөөт номын сан" "Зуны уншлага" "Зөөврийн номын сан" амралтын өдрүүдэд уншигчдын хүсэлтээр ажиллуулсанаар номын сангийн уншигчдын тоо жилээс жилд нэмэгдэж **11132** уншигчдад шинээр карт нээж, **31895** иргэсдэд нийт **56960** ном олгон уншуулж, уншигчдын эрэлт хэрэгцээг хангаан үйлчилгээ үзүүлсэн.

Танхимууд / Үзүүлэлт	Уншлагын танхим	ГНОТ	ХУТ-1	ХУТ-2	Зөөврөөр	Цахимаар	Нийт
Уншигч	2035	2771	2320	2600	950	456	**11132**
Байнгын уншигч	2505	3150	3700	5405	1180	510	**16450**
Иргэсэд	5600	5271	6804	10150	2125	1945	**31895**
Ном олголт	12920	12478	13120	14750	2858	834	**56960**



3.1."БЯЦХАН УНШИГЧДЫН ТАНХИМ"

Өлгий сумын нийт 11 цэцэрлэгийн бэлтгэл, дунд бүлгийн бяцхан уншигчид "Бяцхан уншигчдын танхим"-д ирж, ярьдаг ном /даналық әліппесі/, хөдөлгөөнт ном үзэж, номын санчийн уншиж өгсөн үлгэрээс ойлгосоноо хуваалцаж, дасгал хөдөлгөөн хийж, шинэ номын сонирхон үлгэрийн баатарын дүрийг зурж, хэл яриагаа хөгжүүлсэн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

МУСГЗүтгэлтэн, доктор, профессор, зохиолч, сэтгүүлч Хавшийн Исламын нэрэмжит хүүхдийн 2-р танхимыг эко танхим болгож хүүхдүүдийг чөлөөтэй ном унших орчин боломжийг бүрдүүлэн хувиарын дагуу нэг ээлжинд 40 гаруй хүүхдийг хамруулан үйлчилж байна.

3.2. ГАДНЫ НОМЫН САН “ЗУНЫ УНШЛАГА”

Б.Ахтаны нэрэмжит аймгийн төв номын сан нь 2023-2024 оны шинэ хичээлийн жилийг тохиолдуулан уншигчддаа зориулж “ГАДНЫ ЧӨЛӨӨТ УНШЛАГА”-ын талбайг ногоон зүлэг болон гадна талын гэрэлтүүлэгтэй болгож тохижуулан 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн уншигчдаа хүлээн авч ажиллав. Мөн ажлын цаг заваараа, болон оройн цагаар бяцхан уншигчдыг салхилуулан эцэг эх, асран хамгаалагч нар

болон хүүхэд залуучуудад ногоон гудамжинд номын үзэсгэлэн гаргаж сурталчилан ном уншуулж, үйлчилгээ үзүүлэв.

3.3. ЗӨӨВРИЙН НОМЫН САНГААР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ.

Номын сангийн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа алслагдсан сум, баг, байгууллагуудын ажилтан албан хаагчдад номын сангийн үйлчилгээг хүргэх, сурталчлах, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Булган, Бугат, Дэлүүн, Сагсай, Алтай, Ногооннуур, Баяннуур сум, 1-р ЕБС,, 4-р ЕБС, 5-р ЕБС,2-р ЕБС, МСҮТ, МУБИС, Цагдагийн газар, Ус цаг уурын газар, Хыдыр ата-Нур ана мешит, Цэргийн 165р-340р анги, ШШГА, Прокурор, Шүүх, ОБГ, Татварын хэлтэс, г.м Өлгий сумын албан байгууллага болон алслагдсан хөдөө сум багуудын ард иргэд, зөөврөөр 2125 уншигчдад 2858 ном уншуулсан.

3.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

Соёлын яамнаас санаачлан гаргасан “Соёлын бүтээлч сар” аян болон аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй “Нэг байгууллага-нэг ажил” аян хүрээнд Өлгий сумын 13 багт оршин суудаг аутизмын, харааны, сонсголын бэрхшээлтэй 30 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг номын санд урьж, номын санг танилцуулан, номын ач тусын тухай зөвлөмж өгч, урлагийн номер, шилдэг болон үнэт ховор номын үзэсгэлэн гаргаж номын сангийн үйлчилгээ үзүүлэв. Уулзалтын үеэр номын сангийн захирал номын санд хүрэлцэн ирсэн иргэдэд гарын бэлэг гардуулан хүндэтгэл үзүүлэв. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэний гэрт нь очиж номын сангийн үйлчилгээ үзүүлэв. Энэхүү ажлыг Өлгий сумын орлогч дарга, 13 багийн засаг дарга нар, нийгмийн ажилтанууд дэмжин хамтран ажиллав.

3.4. НОМЫН КЛУБ, НОМ СОНИРХОГЧДЫН УУЛЗАЛТ

Номын сангийн дэргэдэх 12 сурагчдын бүрэлдэхүүнтэй "Уншигчын клуб"-ын жилийн төлөвлөгөө боловсруулж, зорилгоо тодорхойлон төлөвлөгөөний дагуу жилд хийх үйл ажиллагааны талаар хэлэлцүүлэг, уулзалтыг 2 удаа зохион байгуулав.

3.5. ЦАХИМААР ХҮРГҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

Түүхт ойн баяр болон шинэ номын нийт 650ш номын үзэсгэлэнг уншигчдад онлайн хэлбэрээр видио бичлэгээр сурталчилав. "Үлгэрийн ертөнц" –ийн булан Fase

хуудсыг тогтмол ажиллуулж, үлгэрийн номноос нийт 15 төрлийн үлгэр байршуулсанаар 500 гаруй уншигч лайк дарж , 152 share хийсэн байна.



4. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

Номын сангийн сангаас зохион байгуулах СОНА-ын жилийн төлөвлөгөөг боловсруулан ажилласанаар 2023 онд давхардсан тоогоор нийт 32 төрлийн 61 удаа СОНА зохион байгуулагдаж, 25 төрлийн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнд

1173 ном дэлгэгдэж, 3359 ард иргэдийг соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан.

№	Зохион байгуулагдсан соёл олон нийтийн ажлын нэр	Оролцсон хүний тоо	Зохион байгуулсан газар	Зориулалт
1	“ЭЕРЭГ харилцаа, ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ” сэдэвт аян	30	Уншлагын танхимд	Цагаан сарын баяр
2	“Цагаан сарын баярын онцлог, ёс заншил” сэдэвт уншигчдын уулзалт	25	Уншлагын танхимд	
3	Үндэсний өв, урлаг соёл “Жигит султаны-2022”, “Наурыз бике” уралдаан	110	ХДТ-д	“Наурыз”-ын баяр
4	"БЕСБОҒДАНЫҢ ҮНІ" яруу найрагийн уралдаан	85	Номын санд	
5	“Дин дастүр” сэдэвт уран уншлагын уралдаан	68	Уншлагын танхимд	“Дэлхийн номын баяр-2023”
6	"ТА авч болно, өгч болно" булан	120	Номын санд	

7	“Сайхан бичигтэн” уралдаан /аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын албан хаагчид/	36	Уншлагын танхимд	
8	“Тэргүүний уншигч” уралдаан /ЕБС-ийн 9-12 ангийн сурагчид болон насанд хүрэгчдийн дунд/	30	ГНОТанхимд	**Үндэсний бичиг үсгийн баяр-2023**
9	Бүтээлийн үзэсгэлэнг Өлгий сумын ЕБС-ийн дунд зохион байгуулж “Бүтээлч багш”-1,”Бүтээлч сургууль”	28	Номын санд	
10	“Номын сангийн өртөөчилсөн аялал” /ЕБС-ийн 5,6 ангийн сурагчид	65	Номын санд	
11	Энэтхэгийн зохиолч Дхан Мукержийн Хари ба Кари номноос 6-р ЕБС-ийн 4 “а” ангийн сурагчдын дунд “Уран уншлага” , “Зургийн уралдаан”	35	Хүүхдийн 2-р танхимд	
12	“Үлгэр зохиолын баатаруудын дүр”-ийн тоглолт ЕБС-ийн сурагчид болон цэцэрлэгийн багачуудын дунд /2 удаа/	530	Цахим орчинд	
13	“Бийрээ нийлье, ургаа уудалья” үндэсний бичиг, угийн бичгийн сургалт	40	Уншлагын танхимд	**“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” /хавар, намар/**
14	Номын клуб, ном сонирхогчдын уулзалт	27	Уншлагын танхимд	
15	“НОМ БА УНШИГЧДЫН ОЮУНЫ ХЭРЭГЦЭЭ” сэдэвт илтгэлийн уралдаан	29	Уншлагын танхимд	
16	Зохиолын баатаруудын дүрийн тоглолт, үлгэрийн баатаруудын парад	350	Төв талбайд	
17	Номын флошмоб /2 удаа/	20	Төв талбайд	
18	Зохиолч-уншигчдын уулзалт /Залуу яруу найрагч Х.Аманжол/	30	Уншлагын танимд	
19	Яруу найрагч Халхаман Саринтай Зохиолч-уншигчдын уулзалт /2 удаа/	250	ХДТ, уншлагын танхимд	
20	“ЯРУУ ӨГЛӨӨ” ЗОХИОЛЧ, УНШИГЧДЫН УУЛЗАЛТ	40	MJS Tower	**“Соёлын сэргээлт - 2023”**
21	ҮНС-аас номын санчдын дунд “Чадавхжуулах сургалт”	45	Уншлагын танхимд	
23	Хүүхдийн 2-р танхимаас бага ангийн сурагчдын дунд “Багшаа магтая” уран уншлага	250	Хүүхдийн 2 танхимд	**Багш нарын баяр**
24	ЕБС-ийн сурагчдын дунд шинэ номын үзэсгэлэн гаргаж, номын ач тусын талаар зөвлөмж, уулзалт	260	Номын санд	

25	Үндэсний бичгийн хичээлийн дугуйлан	25	Оройн номын санд	“СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2023”
26	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ	30	Уншлагын танхимд	
27	Зохиолч- уншигчдын уулзалт /Зохиолч, яруу найрагч Х.Адилгазы/	25	Уншлагын танхимд	
28	Монгол бахархалын өдрийг тохиолдуулан “МИНИЙ НУТАГ” сэдэвт зургийн уралдаан	28	Уншлагын танхимд	
29	“Хуунт нуур” номын хэлэлцүүлэг /1-р ЕБС-ийн 6”Б” ангийн сурагчид/	35	Хүүхдийн1-р танхимд	
30	“Ном хандивлах аян”	123	Хүүхдийн1-р танхимд	
31	Номын санд танилцах аялал /Бугат сумын 2-р цэцэрлэг, 15-р цэцэрлэг/	65	Уншлагын танхимд	
32	Орон нутгийн зохиолчдын болон хувь хүний номын нээлт /21 удаа/	525	Уншлагын танхимд	
	Нийт	**3359**		

СЭДЭВЧИЛСЭН НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

Номын үзэсгэлэнгийн нэр	Үзэсгэлэнд дэлгэгдсэн номын тоо	Зориулалт
Ховор ном	20	“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” /хавар, намар/
Хүүхдийн ном	40	
Бабалар сөзи	120	
Сонин сэтгүүл	15	
Хамгийн том ба жижиг ном	14	
Шинэ ном	70	
Орон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн	55	
Үндэсний бичгийн сурагчид болон багш нарын бүтээлийн үзэсгэлэн	45	
Хуучин номын үзэсгэлэн худалдаа	120	
Тэргүүний уншигч хүүхдийн бүтээлийн үзэсгэлэн	47	
Зохиолчдын гар бичмэлийн үзэсгэлэн	10	
Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа	12	
Номын макет/ Жангар, Улаан малгайт, Ахтаны түүвэр зохиол/	4	
Монголын түүх Монгол бахархал	39	Монгол бахархалын өдөр

Их зохиолч Абайн Хунанбаев	32	Их зохиолч Абайн Хунанбаев “Уран уншлага” уралдаан
Шинэ номын цахим үзэсгэлэн /6 удаа/	260	Дэлхийн номын өдөр, хүүхдийн баяр
Эх сайхан монгол хэл	35	Бичиг үсгийн баяр
Багш нарын болон сурагчдын бүтээлийн үзэсгэлэн	58	
Хууль зүйн ном	25	Хууль сурталчлах өдөр
Орон нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн	120	Зохиолч-уншигчдын уулзалт, Уран уншлага, номын нээлт
Доктор, профессор, түүхч Х.Исламын уран бүтээлээс	25	Доктор, профессор, түүхч Х.Исламын танхимын хандивын номын үзэсгэлэн
Монголын түүх Монгол бахархал	39	Монгол бахархалын өдөр
Нийт	**1173**	

НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

ЦАГААН САРЫН БАЯР

Монголын уламжлалт баяр болох цагаан сарын баярыг угтаж номын сангийн ахмад уншигч өндөр настан М.Чойсүрэн, байнгын уншигч түүх нийгмийн багш А.Сарангэрэл нартай монголын ёс зашлын тухай **“Уншигчдын уулзалт”** зохион байгуулж, уншигчдын дунд танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээн явуулж шилдэгүүдээ шалгаруулав. Уг уулзалт болон тэмцээнд 40 гаруй уншигчид оролцов. Монголын ёс заншлын тухай 55ш номын үзэсгэлэн гаргасан.

ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БАЯР

Мөн Олон Улсын Эмэгтэйчүүдийн баярыг угтаж ”Би аав ээжтэйгээ” сэдэвт уралдаан зарлаж, хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх гэр бүлийн гишүүдийн харилцааг бэхжүүлэх номын сан уншигч хоёрын уялдаа холбоог сайжруулах зорилгоор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн ажилчид болон хүүхдүүдийн дунд зохион байгуулав. Нийт 3 гэр бүл 35 гаруй уншигч сурагчид оролцов.

“СУРГААЛ ҮГ ”

Казахийн ард түмний суут хүмүүн, их соён гэгээрүүлэгч, яруу найрагч Абай Хунанбаевийн “Сургаал үг” номноос “Уран уншлага”-ын уралдаан зохион байгуулав. Уралдаанд аймгийн төв болон сумдын ЕБС-ийн ахлах ангийн 60 гаруй сурагчид оролцов.

“УРАН УНШЛАГА”-ЫН УРАЛДААН

Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн, зохиолч яруу найрагч Б.Жанат агсны “Рахман Нур” номноос зохион явуулсан уран уншлагын уралдаан амжилттай үохион байгуулж, шилдэгүүдээ шалгаруулав. Үүнд:

1-байр: Шепен овогтой Инжу Сагсай сумын 1-р сургуулийн 8 дугаар ангийн сурагч
2-р байр: Мухарап овогтой Арай Өлгий сумын Бастама сургуулийн 11 дүгээр ангийн сурагч
2-р байр: Берикжан овогтой Ахтоты Улаанхус/Согог/ 2-р сургууль 6 дугаар ангийн сурагч
3-байр: Бейбит овогтой Нургүл Сагсай сумын 1-р сургуулийн 10 дугаар ангийн сурагч
Тусгай байр: Кенес овогтой Ахбөпе, Бейбит овогтой Аймерей нар шалгарлаа

ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР

Дэлхийн номын өдөр болон зохиогчийн эрхийн өдөр-ийг угтаж аймгийн ахлах ангийн сурагчдын дунд “Дин дастүр” сэдэвт “Уран уншлага” –ын уралдааныг амжилттай зохион явуулж шилдэгүүдээ шалгаруулллаа. Үүнд:

Тэргүүн байр: М.Арай “Бастама” сургуулийн 11-р ангийн сурагч,
1-байр: К.Аманкелди Улаанхус сумын Согог баг
2-байр: К.Алаш Улаанхус сумын Хөх хөтөл баг
3-байр: Е.Зангар Өлгий сум, А.Тилектес Улаанхус сумын Хөх хөтөл баг
4-байр: К.Наташа, Ж.Сүйениш, Ж.Шынарбек, А.Манарбек нар тус тус эзлэв
“Дин дастүр” сэдэвт уралдаанд 25ш номын үзэсгэлэн гаргав.

Наурызын баярыг угтаж мартагдсан Үндэсний өв, урлаг соёлоо хойч үедээ өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 18 жилийн дараа Аймгийн Засаг Даргын Тамгын газартай хамтарч “ЖИГИТ СУЛТАНЫ-2023”, “НАУРЫЗ БИКЕ-2023” уралдаануудыг амжилттай зохион байгуулж шилдэгүүдийг шалгаруулав. Уг уралдаанд сум, аймгийн төвөөс нийт 30 гаруй охид, хөвгүүд идэвхтэй оролцов.

“НАУРЫЗ БИКЕ-2023”

“ЖИГИТ СУЛТАНЫ-2023”

“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР- 2023”

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүр уламжлал болгон зохион явагддаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг угтаж Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, үндэсний бичиг соёлоороо бахархах үзэл, ухамсарыг олон түмний оюун санаанд төлөвшүүлэх соёлын давтагдашгүй өв үндэсний монгол бичгийг нийтэд эзэмшүүлэх, хэрэглэх орчин нөхцөлийг бий болгох, үндэсний хэл бичиг, ёс заншил, уламжлал, өвийг судлах, сурталчлах, өвлүүлэх зорилгоор номын сангаас аймгийн хэмжээний төрийн болон төрийн бус байгууллагуудын албан хаагчдын дунд “САЙХАН БИЧИГТЭН” уралдаан болон ЕБС-ын бүтээлийн нэгдсэн үзэсгэлэнг амжилттай зохион явууллаа. “САЙХАН БИЧИГТЭН” уралдаанд аймгийн хэмжээний төрийн болон төрийн бус байгууллагуудын 50 гаруй албан хаагчид оролцож, шилдэгүүдээ шалгаруулав. Үүнд:
I байр- М.Махбал – “Дарын” цогцолбор сургуулийн бага ангийн багш
II байр- С.Назкеш – Лаборатори 2 дугаар сургуулийн Биологи, эрүүл мэндийн багш
III байр- Х.Нургүл - ЕБС-ийн 5 дугаар сургуулийн математикийн багш
IV байр- /ахмад/ Ц.Баярхүү – Аймгийн ШШГГазар
V байр – Ж.Олонбаяр - Лаборатори 2 дугаар сургуулийн бага ангийн багш
Багш сурагчдын хамтын “БҮТЭЭЛИЙН ҮЗЭГЭЛЭН”-гээр

Багш нарын бүтээл:
I байр- М.Алтанзул - ЕБС-ийн 3 дугаар сургууль
II байр- Б.Батзаяа - Лаборатори 2 дугаар

Сурагчдын бүтээл:
I байр - С.Мейр багштай ЕБС-ийн 5 дугаар сургуулийн 10 дугаар ангийн сурагчид
II байр – Н.Ариунзаяа багштай Лаборатори 2 дугаар сургуулийн сурагчид
III байр – А.Шүрэнцэцэг номын санчтай “Билгэ-Тэгин” сургуулийн сурагчид

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023”

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” арга хэмжээг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2023 оны 5-р сарын 12 -22, 2023 оны 09-р 11-13 ны өдрүүдэд зохион байгуулан ажиллаа. Номын баярын 2 удаагийн арга хэмжээнд 15 төрлийн СОНА ажил зохион байгуулж, нийт 1600 гаруй уншигч, хүүхэд багачууд ард иргэд хамрагдав. Уг арга хэмжээнд

1. “Үлгэр зохиолын баатаруудын дүр”-ийн тоглолт, парад
2. Шинэ номын үзэсгэлэн, Хүүхдийн номын үзэсгэлэн, Сонин сэтгүүлийн үзэсгэлэн, Ховор хуучин номын үзэсгэлэн, Хамгийн том, хамгийн жижиг номын үзэсгэлэн, Орон нутгийн хэвлэлийн үйлдвэр, хэвлэлийн газар, зохиолчдын хэвлэгдсэн номын үзэсгэлэн,
3. Тэргүүний уншигч сурагч, Тэргүүний уншигч анги –хамт олон шалгаруулалт
4. Номын клуб, ном сонирхогчдын уулзалт
5. Номын санчдыг “Чадавхжуулах сургалт”

6. “Яруу өглөө” зохиолч-уншигчдын уулзалт
7. Зохиолч-уншигчдын уулзалт /Залуу яруу найрагч Б.Аманжол/
8. Казахстан улсын Яруу найрагч Халхаман Саринтай Зохиолч-уншигчдын уулзалт
9. “Уран уншлага”-ын уралдаан
10. “НОМ БА УНШИГЧДЫН ОЮУНЫ ХЭРЭГЦЭЭ” сэдэвт илтгэлийн уралдаан

ЗОХИОЛЧ-УНШИГЧДЫН УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА

Казахстан улсын Яруу найрагч Халхаман Саринтай Зохиолч-уншигчдын уулзалт, ярилцлагыг аймгийн бүх ЕБС-ийн ахлах ангийн сурагчид болон яруу найрагч, сэтгүүлч, ном соёлоо дээдлэгч уншигчид ард иргэдийн дунд Номын сан болон ХДТ-д 2 удаа зохион байгуулав. Уулзалтын үеэр нийт 150 гаруй яруу найрагч шинэ номын дээжээсээ аймгийн төв номын сангийн сан хөмрөгт хандивлав.

“НОМ БА УНШИГЧДЫН ОЮУНЫ ХЭРЭГЦЭЭ” сэдэвт илтгэлийн уралдаан

Уншигчдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, уншигчдыг үйлчилгээгээр хангах, хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх, нийтийн номын сан болон боловсролын салбар хоорондын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор аймгийн ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд “НОМ БА УНШИГЧДЫН ОЮУНЫ ХЭРЭГЦЭЭ” сэдэвт илтгэлийн уралдаан зохион явуулж энхий байруудад шалгарсан багш нарыг шагнан урамшуулав.
Үүнд:
1-р байр: ЕБ-ын “ЗАЙД” сургуулийн багш А.Өзгерис
2-р байр: ЕБ-ын 5 дугаар сургуулийн багш нар С.Мейр, Х.Толхын
3-р байр: ЕБ-ын 5 дугаар сургуулийн багш Х.Несибели
Тусгай байр: Сагсай сумын сургуулийн багш Б.Сара
Тусгай байр: ЕБ-ын “БАСТАМА” сургуулийн багш Х.Хумырбек нар тус тус шалгарлаа.

Зохиолын баатаруудын дүрийн тоглолт, үлгэрийн баатаруудын парад /Өлгий сумын цэцэрлэгийн хүүхдийн дунд/

Уншлагыг дэмжих арга хэмжээний хүрээнд Өлгий сумын цэцэрлэгийн хүүхдийн дунд өөрсдийн сонгосон **"Үлгэрийн баатаруудын дүрийн тоглолт"**-ын уралдаанд Өлгий сумын 13 цэцэрлэгээс нийт 135 хүүхэд багачууд оролцов. Үүнд:

1. 1-р байр Х.Гүлжазира багштай 21-р цэцэрлэг
2. 2-р байр Б.Хуралай багштай Бугат сумын 2-р цэцэрлэг
3. 3-р байр А.Гүлжан багштай 14-р цэцэрлэг
4. Тусгай байр Д.Еркежан багштай 4-р цэцэрлэг
5. Тусгай байр А.Жанар багштай 9-р цэцэрлэг
6. Үлгэрийн баатарын шилдэг жүжигчинээр 19-р цэцэрлэгийн Е.Алтынбек, 17-р цэцэрлэг Бахытбол Айбөбе

Жил бүр номын сангаас хамгийн олон ном уншдаг уншигчдыг шалгаруулан Номын баяраар шагнан урамшуулах уламжлал ёсоор номын сайн нөхөр, хамгийн их

ном уншсан "Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн", "Тэргүүний уншигч-байгууллага", "Тэргүүний уншигч-Анги хамт олон", "Тэргүүний ахмад уншигч" нарыг шагнан урамшуулдаг. Үүнд:

"Тэргүүний уншигч -Нацагдоржийн тэмдэгтэн"-ээр

- 6-р ЕБС -ийн 3 "а" ангийн сурагч Алтынбек Ерсултан
- Бастама ЕБС -ийн 3 "а"-р ангийн сурагч Еркинбек Айдай
- Бастама ЕБС -ийн 5 "а"-р ангийн сурагч Аманбек Күнайым
- 2-р ЕБС -ийн 4 "б"-р ангийн сурагч Нурлан Гүлсая
- 2-р ЕБС -ийн 12 "б"-р ангийн сурагч Отгонбаяр Энхзаяа
- Бастама ЕБС -ийн 12 "б"-р ангийн сурагч Хурмет Айсулу
- Дарын ЕБС-ийн 12"а" ангийн сурагч Асылбек Арафад
- 3-р ЕБС-ийн 8"г" ангийн Солтанбек Аружан
- "Тэргүүний уншигч-Байгууллага"-аар: ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР
- "Тэргүүний уншигч-Анги хамт олон"- 6-р- ЕБС-ийн Гулдаурен багштай 3 "б" анги хамт олон
- "Тэргүүний уншигч-Анги хамт олон"- 6-р- ЕБС-ийн А.Дилдаш багштай 5 "г" анги хамт олон
- "Тэргүүний ахмад уншигч" Тохтоган Жолай
- "Тэргүүний ахмад уншигч" өндөр настан Касен Сураган
- "Тэргүүний ахмад уншигч" Хибатын Сьез

“ЗОХИОЛЧ-УНШИГЧДЫН УУЛЗАЛТ”

Аймгийн зохиолчид ба тэдний зохиолуудыг уншигчдад таниулах, уншигчдад зохиолчдын уран бүтээлээр бахархах сэтгэл төрүүлэх, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 34 дэх "Номын баяр-ыг тохиолдуулан “Зохиолч-Уншигчдын уулзалт”-ыг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд яруу найрагч А.Сьез, номын сангийн зөвлөлийн гишүүн Б.Хожабай, Түүхч, яруу найрагч Ш.Тилеубек, Яруу найрагч Б.Аманжол уншигчидад чөлөөт ярилцлага өрнүүлэв.

Номын сангийн дэргэдэх Өлгий сумын ЕБС-ийн дунд ангийн 20 сурагчдын бүрэлдүүхэнтэй “Номын флошмоб” клубын сурагчид номын баярын нээлтийн өдрөөр бүжиглэж сонирхуулав.

“СОЁЛЫН СЭРГЭЛТ 2023” АЯН

“ЯРУУ ӨГЛӨӨ” ЗОХИОЛЧ-УНШИГЧДЫН УУЛЗАЛТ

“Соёлын сэргэлт 2023” аян, “Номын баяр-2023”   үйл ажиллагааны хүрээнд “Яруу өглөө” уулзалтыг зохион байгууллаа. “Яруу өглөө” уулзалтанд Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч, яруу найрагч Р.Шынай, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал, яруу найрагч Б.Ичинхорлоо, Соёлын гавьяат зүтгэлтэн, Хүний гавьяат эмч, яруу найрагч Ш.Хуатхан, зохиолч, яруу найрагч П.Нямлхагва, МЗЭ-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлийн дарга Б.Зархум болон Баян-Өлгий аймгийн зохиолч, яруу найрагч, утга, уран зохиол сонирхогчдын төлөөлөл оролцов.

"СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР" АЯН

Соёлын бүтээлч сар" аяны эхний долоо хоногт номын сангаас Монгол бичиг III үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, босоо бичиг соёолоороо бахархах үзэл ухамсарыг суулгаж хэл бичиг ёс заншил уламжлалыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ЕБС-ийн сурагчид болон номын сангийн ажилтан албан хаагчдад ЕБС-ийн 5 дугаар сургуулийн хэл уран зохиолын багш Х.Несибелтэй хамтран ажиллаж, Үндэсний бичгийн хичээлийн дугуйлан хичээллүүлэн ажиллав.

Өлгий сумын 3, 4, 5, 1-р ЕБС-ийн сурагчдын дунд шинэ номын үзэсгэлэн гаргаж, номын ач тусын талаар зөвлөмж, уулзалтыг амжилттай зохион байгуулав. Уншигчид маань өөрсдийг уншсан номын ач тусын талаар, номынхоо тухай ярилцаж, санал бодлоо чөлөөтэй солилцож, мэдлэгийн хүрээгээ нэмэгдүүлсэн сайхан арга хэмжээ болж зохион байгуулагдав.

“Соёлын бүтээлч сар” аяны 3 дахь долоо хоногт аймгийн төв номын сангаас зохиолчид ба тэдний зохиолуудыг уншигчдад таниулах, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэхэд зорилгоор зохиолч, яруу найрагч Х.Адилгазы-тай зохиолч уншигчдын уулзалт зохион явуулав.

Монгол бахархалын өдрийг угтаж “МИНИЙ НУТАГ” сэдэвт зургийн уралдаан зарлаж, шилдэгүүдээ тодруулլаа. Үг арга хэмжээнд 15 гаруй сурагчид оролцож, өөрсдийн зурсан зурагнуудыг тайлбарлав. Үүнд:

1- р байр А.Султан 3-р ЕБС-ийн 9"а"ангийн сурагч
   2-р байр Б. Жансерик 4-р ЕБС-ийн 12"в" ангийн сурагч 3-р байр Еркежан 2-р ЕБС-ийн 12"в" ангийн сурагч

Тусгай байр Хайрат, Жансая нар тус тус шалгарсан.

ШИНЭ НОМЫН НЭЭЛТ

№	Зохиогчийн нэр	Номын нэр
1	Зохиолч К.Бахыт	Бақыт пен Уақыт
2	Зохиолч А. Шабдан	Енбеги енсели үлы түлга
3	Доктор, профессор Х. Улыхпан	Кожамбетүлы Дөнтай шыгармаларынын жинагы жане эулеттеринин шежиреси
4	Зохиолч З.Рысбек , А.Айшагүл	Өлгийн нутгийн өвөрмөц өв соёл
5	Зохиолч Е.Шопаев	Тогыз хумалахын бодлого ба зарчмууд
6	Зохиолч, яруу найрагч Ш.Тилеубек	Үлгили аке, улагатты үстаз
7	Зохиолч А.Баймурат	Ел айдалып, үриккен жылдарда Отан алдында от кешкендер
8	Зохиолч Х.Үзбен	Тагдыр

5. ЛАВЛАГАА, НОМ ЗҮЙН АЖИЛ

- Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны мессенжер, бичгээр, утсаар, амаар нийт 445 лавлагааг 1420 уншигч хэрэглэгчдэд өгсөн байна.
- Шинээр бүрдүүлсэн 773ш ном хэвлэлийг LIB-4U программын цахим каталогт бүртгэн нийт 350 ширхэг карт шинээр бичиж, холбогдох каталогуудад байрлуулсан.
- Каталогийн лавлагааг уншигчдад өгч номын сангаар хэрхэн үйлчлүүлэх, каталог ашиглах, захиалгын хуудас бичих, номоо хэрхэн хайх, номоо хэрхэн сонгох талаар мэдээлэл өгч, зарим номын шифрийг тодруулах,олдохгүй байгаа зохиолуудыг электрон каталогоос хайлт хийж өгч байсан.
- “Төрийн мэдээлэл”, “Хууль зүйн мэдээ” сэтгүүлийг тогтмол авч лавлагааны фондоо баяжуулан ажиллаж байна.
- Ном зүйн картын санд шинээр “Зуны мэдээ” сониноос “Соёл гэгээрэл” сэдэвт 150ш, “Хууль зүйн” сэдэвт 60ш картыг ном зүйн бичилтийн дагуу бичиж, каталогийн шүгээнд байрлуулав.

- Хүүхэд залуучуудад зориулсан хуулийн булангийн ном зүйн жагсаалт, шинэ номын ном зүйн жагсаалт, Зохиолч, сэтгүүлч Н.Ербахыт, Яруу найрагч З.Рысбек,

нарын санамж өгөх ном зүйн бүртгэл зэрэг 4 төрлийн номзүйн жагсаалтыг тус тус гаргаж уншигчдад сурталчилж байна.

- Баян-Өлгий аймгийн нийт 280 гаруй зохиолч, яруу найрагчдын 1942-2023 он хүртлэх ном зохиолууд болон орон нутгийн ном хэвлэл, сонин сэтгүүлд хэвлэгдэн нийтлэгдсэн бүтээлүүдийн ном зүйн нэгдсэн жагсаалтыг “БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН НОМ ЗҮЙ” хэвлэн гаргуулахаар бэлэн болгосон.

6. МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ

- Lib-4U праграммын PC VERION энгийн хувилварыг ашиглан дотоод сүлжээндээ холбогдон WiFi утасгүй интернетийг ашиглан үйлчилж байна.
- Сумдын соёлын төвийн номын сангуудын цахим програмын нэгдсэн тайлангийн мэдээ, нэгдсэн каталогийн мэдээ, Monbiblio цахим програмд оруулсан нэгдсэн тайлан, нэгдсэн каталогийн мэдээ, мэдээллийн сангийн нөөцийг бэлдэж, нийт 10 сумын номын сангийн Monbiblio цахим програмд ажиллах явцад

гаргасан алдаа, дутагдалын талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Мөн Бугат, Баяннуур, Булган сумын компьютеруудыг форматлаж, хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Номын сангийн бүх уншлагын танхимууд болон каридорд ном алдах эрсдэлээс хамгаалах зорилгоор камержуулалт, хянах дэлгэцийг тогтмол ажиллуулж байна. Камерийн бичлэг хийх төхөөрөмжүүд 7 хоногийн бичлэг хадлагдан ажиллаж байна. Үүдэнд байрлуулсан соронзон хаалга нь хэвийн ажиллаж байна.

- Байгууллагын мэдээллийн ил тод байдал, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор 2023 онд төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж, Иргэдэд үйл ажиллагаагаа цахимаар хүргэх зорилгоор Б.Ахтаны нэрэмжит Fase хуудасыг тогтмол ажиллуулж, номын сангийн үйл ажиллагааны талаар нийт 115 удаа мэдээ, мэдээлэл тавьж сурталчилсан.

- “Дербес” TV, “Саян” TV, ОНОН Радиотой хамтран гэрээ байгуулж, үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор 28 удаагийн мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд сурталчилсан.

7. АРГА ЗҮЙ, СУРГАЛТ

7.1. АРГА ЗҮЙ

- Өгөгдсөн арга зүйн бүртгэл хөтөлж төв номын сангийн номын санчид, хөдөө сумдын соёлын төвийн болон сургуулийн номын санчид, өлгий сумын сургуулийн номын санчдад нийт 54 номын санчдад 85 удаа арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

- Номын сангийн шинэчлэл, номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, номын санчдын мэдлэг, боловсрол, чадавхыг дээшлүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, номын санг сэргээн босгох зорилгоор Баян-Өлгий аймгийн сумдын соёлын төвийн номын сангуудыг **“СЭРГЭЭН БОСГОХ”** арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлаар 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 04-р сарын 07-ны өдөр хүртэл хөдөө сумдын соёлын төвийн номын сан болон сургуулийн номын сангуудад биечлэн очиж, зөвлөн туслах, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор нийт 10 суманд номын сангаас ажлын хэсэг 24 хоног ажиллав. Энэхүү ажлын хэсэгт Б.Ахтаны нэрэмжит төв номын сангаас 7 хүн ажиллав.

- Сумдын Соёлын төвийн номын санчдийн болон сумын номын санчдын ажлыг дүгнэх аргачлалын дагуу 2023 оны үйл ажиллагааны тайлан авч дүгнэж, аймгийн ЗДТГ-д хүргүүлэн ажиллав. Эхний байр эзэлсэн номын санчыг “Өргөмжлөл” номоор шагнан урамшуулав.
- Байгууллагын номын санчдын болон ажилчдын ажлыг дүгнэх аргачлал боловсруулан, 4 улиралаар дүгнэн, ажилчдын хурлаар танилцуулан ажиллав.

7.2. СУРГАЛТ

2023 онд Соёлын яам, ҮНС –аас зохион байгуулсан мэргэжлийн болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын нийт 20 төрлийн сургалтанд 25 удаа оролцож мэдлэг мэргэжлээ дээшлүүлэв. Үүнд:

- Австралийн Элчин Сайдын Яам, Монгол Улсын Үндэсний номын сангийн хамтарсан ажлын хэсэг **“Хил хязгааргүй номын сан”** төслийн хүрээнд 2023 оны 06 сарын 12-13 өдрүүдэд зохион байгуулсан Hoho праграмм сулгаж, техникийн туслалцаа үзүүлэн номын санчдыг чадавхжуулах, туршлага хуваалцах сургалтанд нийт 11 номын санч хаамрагдав.

- Байгууллагын эцэх эхийн зөвлөлөөс зохион байгуулсан “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо” сэдэвт 2 төрлийн сургалтанд хамрагдсан.

- Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг орон нутагт хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, зөвлөн туслах ажлын хүрээнд Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйн өөрчлөлт бүтээмжид нөлөөлөх нь” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт оролцов.

2023 оны 10-р сарын 25 ны өдөр УБ хотын ШУАкадемийн хэл зохиолын хүрээлэнгийн доктор Ж.Бат-Ирээдүй захиралын “Төрийн албан хаагчийн эх хэлний мэдлэг, чадвар, дадал” сэдэвт сургалтанд оролцов.



- МУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон аймгийн ЗДТГ-ын зохион байгуулсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээлэлээр хангах байнгын ажлын хэсгийн гишүүдийг чадавхжуулах” сэдэвт 2023 оны 6-р сарын 26 ны өдрийн 8 цагийн сургалтанд хамрагдав.



- Баян-Өлгий аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс “Төрийн албан хаагчид болон иргэдэд цахим ур чадвар олгох сургалт” сэдэвт сургалтанд оролцсон. Уг сургалтанд “Цахим аймаг” хөтөлбөрийн талаар мэдээлэл, үйл ажиллагаа, үйлчилгээний талаар, цахим ур чадвар, мэдээллийн аюулгүй байдал, тоон гарын үсэг түүний хэрэглээ сэдвүүдийн дагуу хичээл заасан.

- Аймгийн төвийн болон сумдын сургуулийн номын санчдын дунд ҮНС-аас зохион байгуулсан “Чадавхжуулах сургалт” -д аймгийн төвийн сургуулийн болон хөдөө

сумдын сургуулийн номын санчдын ирц авч нийт 48 номын санчдыг идэвхтэй хамруулав.

- Соёлын тухай хууль, Гэр бүлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хүчирхийллийг илэрхийлж сурталчилсан агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа утга зохиолын бүтээлийг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх, аливаа гэмт хэрэг, хорт зуршил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Соёлын яам, Цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт 3 цагийн цахим сургалтад номын сангийн 6 номын санчийг хамруулав.



- Аймгийн Соёл урлагийн газраас “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээнүүд тухай сургалт зохион байгуулсан.



- Монгол улсын ЗГХЭГ-ын хүүний нөөцийн газраас зохион байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэхтэй холбоотой журам, аргачлалын шинэчлэл” сэдэвт нэг өдрийн цахим сургалтанд 3 хүн хамрагдсан.



Соёлын яам, ҮНС-аас зохион байгуулсан “Монголын Номын санч-мэдээллийн ажилтан” сэдэвт улсын X зөвөлгөөнд номын сангийн захиралаар ахлуулсан 4 номын санч оролцож, номын сангийн захирал Д.Алтынгүл аймгийн номын сангийн тэргүүн туршлагаас илтгэл тавьж, номын санчид 2 өдрийн сургалтанд хамрагдав. Мөн УБ хотын төв номын сан, Баянхонгор, Говь –Алтай аймгийн нийтийн номын сангуудад биечлэн очиж үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцов.

“НЭЭЛТТЭЙ БАЯН-ӨЛГИЙ -2023” эдийн засгийн 2 өдрийн чуулга уулзалтанд номын сангаас 120ш номын үзэсгэлэн гаргаж, форумд оролцож байгаа албан байгууллагуудыг ширээ сандалаар хангаж, хамтран ажиллав.

8. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭГ ОНОВЧТОЙ ХИЙХ

8.1. ДОТООД ХЯНАЛТ

1. Дотоод хяналтын 2023 оны төлөвлөгөө боловсруулан хагас, бүтэн жилийн тайланг СУГ-ын соёлын хяналтын улсын байцаагчид хүргүүлэн ажиллаа. Мөн байгууллагад улиралд нэг удаа хийх дотоод хяналтын удирдамж боловсруулан, ажилтан албан хаагчдын өдөр тутмын ажилд хяналт тавьж, гарсан алдаа дутагдалыг хамт олны хуралаар танилцуулан тайлагнав.

2. Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Аймгийн СУГ-ын улсын байцаагчид хяналтын хуудасын дагуу 2 удаа шалгуулж, **“Дунд”** эрсдэлтэй гэсэн үнэлгээ авч, зарим дутагдалыг арилгах зорилгоор тус соёлын хяналтын улсын байцаагчаас ирсэн 2023 оны 05-р сарын 11 ний өдрийн 148 тоот зөвлөмж, 2023 оны 09-р сарын 07 ны өдрийн 05-15/02-16/03-03 тоот албан шаардлагын дагуу тусгай

төлөвлөгөө гаргаж, захиргааны болон хамт олны хуралаар танилцуулж, нийт 16 дутагдлаас 8 төрлийн дутагдалыг арилгаж ажиллав.

8.2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ДОТООД АЖИЛ

- Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулан аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэсийн даргад хянуулж ажилласан.
- Номын сангийн 2023 оны үйл ажиллагааны мэдээ, ажиллагсадын судалгааны мэдээ, тоног төхөөрөмжийн мэдээг хагас, бүтэн жилийн тайлангуудыг цаасан болон цахим хэлбэрээр цаг тухайд нь хүргүүлэн ажиллаа.
- Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн биелэлтийг аймгийн ЗДТГ-ын Соёл хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэв.
- Аймгийн ЗД-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас, жилийн биелэлтийг аймгийн ЗДТГ, СУГ-д тус-тус хүргүүлсэн.
- Соёлын сайдын аймгийн ЗД-тай хийсэн гэрээний хагас, бүтэн жилийн биелэлт
- Номын сангийн 2023 оны үйл ажиллагааны мэдээ /1,2,3,4 улиралаар/
- Үндэсний хөтөлбөрүүд, Дэлхийн номын өдөр, Үндэсний бичиг үсгийн баяр, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” арга хэмжээний хаврын болон намрын төлөвлөгөө, хөтөлбөр тайлангуудыг СУГ-д тус-тус хүргүүлэн ажиллав.
- Номын сангаас 7 хоног болгон зохион байгуулсан СОНА болон захиргааны тайланг 7 хоногийн 4 дэх өдөрт СУГ-д хугцаанд нь хүргүүлэн ажилласан.
- МУ-ын ЗГ-ын ХЭГ-ын 2023 оны 03-р сарын 02, №395 албан тоот, аймгийн ЗД-ын 2023 оны 05-р сарын 09 ний өдрийн А/214 дүгээр захирамж, аймгийн ЗДТГ-ын 2023 оны 06-р сарын 07 ны өдрийн 4-03/579, Өлгий сумын ЗД-ын 2023 оны 03-р сарын 14 ний өдрийн 2/116 албан тоотын биелэлтийг тус тус биелүүлэн ажиллав.
- Авилгалтай тэмцэх газраас ирсэн шалгалтын мөрөөр байгууллагын ажилтан албан хаагчдын хавтаст хэргийн бүрдүүлэлтэнд хяналт хийж, дутуу материалыг нь нөхөж, ирсэн шалгалтын комиссийн бүрэлдэхүүнд шалгуулав.

- Аймагт хяналтад авч буй хэрэгжүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.
- Байгууллагад ирсэн нийт 96 төрлийн албан тоот, 47 явуулсан бичиг, 17 өргөдөл гомдол бүртгэснээс ирсэн зарим хариутай бичгийг судлан тушаал, удирдамж, төлөвлөгөө боловсруулан, өргөдөл гомдлын хариуг цаг тухайд хариу өгч ажилласан.



- Байгууллагын албан хаагчдын “Алтан гадас” одонд -1, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-2, МУ-ын “Соёлын тэргүүний ажилтан”-2. тус тус нэр дэвшсэн албан хаагчдын баримтыг журмын дагуу бүрдүүлэн аймгийн СУГ -д хүргүүлэн ажилласан.

9. БУСАД

9.1. АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАСАН БАЙДАЛ

- Байгууллагын албан хаагчдын жилийн ажлын үр дүнгээр шалгаруулж, “Байгууллагын шилдэг” ажилтан, албан хаагчдыг тодруулан шагнан, урамшуулав. Мөн ажилтан, албан хаагчдаас бүтэн жилийн тайлан авч, ажлын гүйцэтгэлийн үр дүнгээр хангалттай буюу “А” үнэлгээгээр үнэлүүлсэн албан хаагч тус бүрт цалингийн 40%-иар, “В” үнэлгээ авсан албан хаагч тус бүрт 30% -ын урамшуулал олгосон.
- Байгууллагын албан хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор 10 асуулт бүхий санал асуулгыг боловсруулж, 18 албан хаагчийг судалгаанд хамруулсан. Уг судалгааны дүнг хамт олны хурлаар танилцуулсан ба албан хаагчдын сэтгэл ханамж дунджаар 95 хувьтай байна. Байгууллагын галын аюулгүй байдалыг хангах үүднээс 8ш гал унтраагчтай болгож, фондын хамгаалалт, ажилтан албан хаагчид болон уншигчдын гэнэтийн аюул, хулгайн гэмт халдлагаас хамгаалах зориулалтын 5ш теле камер бүхий дохиоллын системээр хангав. Нийт ажиллагсадыг жил бүр нормын хувцасаар хангаж, 3 ээлжийн хувцастай болгосон.

Олон улсын музейн өдрийг угтаж соёлын байгууллагуудын дунд зохион байгуулагдсан биеийн тамирын арга хэмжээнд идэвхтэй оролцож 3-р байр, зуны амралтын өдрөөр байгууллагын ажилтан албан хаагчдын дунд төрөл бүрийн бухиа тэмцээн зохион байгуулан эхний байр эзэлсэн ажилчдыг шагнан урамшуулав.

9.2 СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ

Номын сан нь аймгийн уншигчдын онцлог, уншигч зохиолчдын дугуй ширээний уулзалт, нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдэд, шинэ номын нээлтийн үйл ажиллагаа зэрэг ажлуудад тулгуурлан соёлын бүтээлч үйлдвэрлэлээ гаргаж сурталчилан ажиллаж байна.

Үүнд: Номын сангийн хаягтай, эшлэл үгтэй тэмдэглэлийн дэвтэр, уншсан номын тэмдэглэл, цаг тооны бичиг /календарь/, номын хавчуур , бал г.м

9.3.ОЛОН УЛСЫН АХМАДЫН БАЯР

Эх орон, аймаг орон нутгийнхаа хөгжил дэвшил, хойч үеийнхээ сайн сайхны төлөө цуцалтгүй хөдөлмөрлөж, мэдлэг чадвар, халуун залуу насаа харамгүй зориулж ирсэн ахмадууд, азай буурлуудыг "Олон Улсын ахмадын баяр"~ыг тохиолдуулан хүлээн авч, номын сангийн онцлох үйл ажиллагаанууд болон цаашид хэрэгжүүлэх зарим арга хэмжээг танилцуулан хүндэтгэл үзүүллээ.

9.4. НОМЫН САНД ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Соёлын яамны дэмжлэгээр танхимуудын өрөө тасалгааг агааржуулах зорилгоор уншлагын танхимууд болон сан хөмрөгт шинээр 792 000 төгрөгний 8ш агаар чийгшүүлэгч авч ажилласан.

Гэрээр олгогдсон номуудын буцааж авахад ариутгаж авах зориулалт бүхий 36 литрийн багтаамжтай Ном ариутгагч төхөөрөмж /1ш х1450000₮=1450000₮/ шинээр авч хуучин номуудыг ариутгаж эхлэв.

Танхимуудын аюулгүй байдлыг хангах, галын эрсдэлээс урдьчилан сэргийлэх зорилгоор 5 литрийн багтаамжтай 860000 төгрөгний галын хор 8ш, мөн санхүүгийн боломж бололцоогоор 6 ширхэг хяналтын камер нэм байршуулан, 2 ТВ багтаамжтай SSD загварын санах ой /хард/ /900 000 төгрөг/ нэмж суурилуулав.



Сан хөмрөгөөс гараар ном зөөдөг тул соёлын хяналтын байцаагчийн албан шаардлага болон номын сангийн стандартын дагуу 480000 төгрөгний ном зөөх тэрэгтэй болсон.

Байгуулагын ажилтан албан хаагчдын ажиллаж буй орчныг сайжруулах, уншигчдын ая тухтай байдлыг хангах зориулалт бүхий модон материалар хийгдсэн /ажилчдын хувцасны шүүгээ, гар бичмэлийн шүүгээ, сэтгүүлийн ширээ, хүндэт самбар, дискны шүүгээ, номын тавиур/ зэрэг нийт 16 ширхэг тавилгыг 5.850.000 төгрөгөөр хийлгэж суурилуулав.

Байгууллагын дотоод нөөц бололцоогоор байгууллагын аж ахуйн ажилтанууд барилга байгууламжийн гадна талын гэрэлтүүлэгийн ажлыг хийж гүйцэтгэв.



Өлгий сумын ЗДТГ-аас зохион явуулсан “Орчноо цэвэр байлгъя” аяны хүрээнд байгууллагад Хот тохижуулах албанаас зориулалтын хогийн сав байршуулав.

Байгууллагын дотоод нөөц бололцоогоор байгууллагын аж ахуйн ажилтнууд болон иргэн М.Жандос-ын тусламжтайгаар барилга байгууламжийн дотор талын таазыг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэв.



Байгууллагын ариун цэвэрт анхаарч ажиллах зорилгоор үйлчилгээний ажилтануудыг 630000 төгрөгний угаалгын машинаар хангаж ажилласан.

БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ӨДӨР

“Хоггүй Өлгий” аяны хүрээнд байгууллагын хуваарьт газар болон байгууллагад хийх их цэвэрлэгээний календарчилсан төлөвлөгөө гаргаж, байгууллагын өрөө танхимууд болон гадны орчинд их цэвэрлэгээ хийж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 63 дугаар зарлиг, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд намрын бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан Өлгий сумын хуваарьт талбайд мод тарьж, тус хэсгийн хогыг цэвэрлэж, арчилгаа хийж идэвхтэй оролцож ажилласан.

БҮТЭЭЛЧ АЖИЛ

2023 онд уншлагын танхмуудын номын санчид болон ажилчид өөрсдөө шинээр 10ш цэцэг тарьж, зохиолчдын самбар, дорожник, цаг, хогийн сав , зуны уншлагын асарын 4 талын давуу болон уншигчдад зориулсан 150ш улавчыг өөрсдөө оёж, байгуулллагын хөгжил, уншигчдын ая тухтай байдалыг хангах зорилгоор хувь нэмэрээ оруулан ажиллаа.

ДҮГНЭЛТ

Б.Ахтаны нэрэмжит төв номын сангийн 2023 онд хийсэн бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд хийгдсэн ажилд дүн шинжилгээ хийхэд:

Номын сангаас зохион байгуулагдсан “Дэлхийн номын өдөр-2023”, “Бичиг үсгийн баяр-2023”, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” хавар, намрын арга хэмжээнүүд, “Номын сайн нөхөр”, “Зуны уншлага”, “Соёлын бүтээлч сар”, Зохиолч-уншигчдын уулзалт, “Уран уншлага” “Номын мэтгэлцээн”, “Соёлын өөртөөчилсэн аялал”, ЕБС-ийн бага ангийн сурагчид, Цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Үлгэрийн баатарын дүрийн тоглолт”, “Үлгэрч анги” г.м бүх нийтийн соёлын боловсролыг хөгжүүлэх соёлын олон талт үйл ажиллагааг танхим болон цахим орчинд зохион байгуулж, Өлгий сумын ЕБС-ийн сурагчид болон цэцэрлэгийн хүүхдүүдийг номын санд хамруулах 5 өдрийн график гаргаж ажилласанаар номын сангийн уншигчдын тоо жилээс жилд нэмэгдэж, ард иргэдийг соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан гэсэн дүгнэлтэнд хүрсэн ба тухайн жилд гаргасан үйл ажиллагааны үр дүнгээр түрүүлж, МУ-ын ҮНС-ийн нэрэмжит шагнал болох **“НОМ ЦОМ”** –оор шагнагдсан.

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Эрхэм зорилго. Соёлын бодлогын хүрээнд шинэ ном хэвлэл мэдээллээр сан хөмрөгийг шинэчлэн баяжуулж, өнөөгийн нөхцөл, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт танин мэдэхүйн төв болон, хүн амын боловсрол, соёл, чөлөөт цагийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээг үзүүлэх зорилго тавин 2023 оны үйл ажиллагаагаа зохион байгуулан явууллаа.

Номын сангийн товч танилцуулга. Баянхонгор аймгийн Нийтийн номын сан нь 2023 онд 11 орон тоотой, Нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхим, лавлагаа арга зүйн танхим, чөлөөт уншлагын танхим, гэрээр ном олгох тасаг, монгол, гадаад номын сан хөмрөг, тогтмол хэвлэлийн танхим гэсэн тасаг нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж ирлээ.

Нэг. Номын сангийн үйлчилгээ

1.1. Лавлагаа, ном зүй, арга зүйн ажил

<u>Лавлагаа.</u> Уншигчдад лавлагаа өгөх ажлыг стандартын түвшид зохион байгуулж, амаар 1420 уншигчдад, бичгээр 712 уншигчдад, утсаар 257 уншигчдад нийт 2389 лавлагааг өгч, уншигчдад электрон болон цаасан каталогийг ашиглах, ном хайхад заавар зөвлөгөөг тогтмол өгч ажиллалаа.

<u>Ном зүй.</u> Монголын уран зохиол, ардын аман зохиолын 3146 сэдвээр ном зүйн бүртгэлийг хийж, уншигчдад ашиглуулан, тогтмол хэвлэлийн Zotero программд “Өнөөгийн Баянхонгор” сонины 2023 оны 315 мэдээллийг шивж оруулан, Монголын үндэсний номын сангийн мэдээллийн санд илгээж, 10473 материалын сантай боллоо. Номын санчдаас уншигчдад зориулсан гарын авлага 12 төрлөөр гаргаж, суртчилан ажиллаж байна.

Уншигчдаас хэрэгцээтэй байгаа номуудыг татгалзлаар бүртгэн, шинэ ном худалдан авах захиалгад нийт 22 номыг бүртгүүлж, 18 номыг худалдан авч татгалзлыг 81.8 хувь биелүүлэн ажиллалаа.

<u>Арга зүйн ажил.</u> Аймгийн төвийн ерөнхий боловсролын 8 сургууль, Хөдөө аж ахуйн дээд сургуулийн Баянхонгор аймаг дахь салбар, Политехникийн коллежийн номын сан, мөн хангайн бүсийн 11 сумын соёлын төвийн номын санд арга зүйн зөвлөгөөг өгч, зөвлөн тусалж ажилласаны үр дүнд, номын сангийн бүртгэл хөтлөлтүүд сайжирч, уншлага үйлчилгээний тоо мэдээ үнэн зөв гарах, номын сангийн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт, тавиурын зохион байгуулалт сайжрах зэргээр тодорхой үр дүн, ахиц дэвшил гарч байна.





Орон нутгийн номын сангуудын сан хөмрөгийн тооллогыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/500 дугаар тушаалаар батлагдсан “Номын сангийн сан хөмрөгийн бүртгэл, тооллого хийх журам”-ын дагуу 2022 оноос эхлэн зохион байгуулж, 2023 онд Эрдэнэцогт, Баянцагаан, Баян-Өндөр, Баянговь, Шинэжинст, Жинст, Баянлиг, Богд сумдад зохион байгуулж, данс бүртгэл үнэ зөрүүтэй, ангилал буруу ангилсан, электрон каталогт ороогүй үлдсэн зэрэг зөрчлүүдийг илрүүлж илрүүлж, номын дүн мэдээг залруулж, сум тус бүрд тооллогын акт үйлдэж, номын санчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

1.2. Сан хөмрөгийн ажил, баяжилт, хадгалалт хамгаалалт

Үндсэн фондоос ном, хэвлэлийг уншлагын танхимууд, гэрээр ном олгох тасгаар олгож, буцаан хүлээн авч байрлуулан, шинэ номын мэдээг 4 удаа товч анатаци, номын зураг, ном зүйн бичилтийг хийж, уншигчдад сурталчлан, ашиглуулж ажиллалаа.

Фонд баяжилт:

Ямар журмаар	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн
Хандив	86	98	2,053,200
Худалдаа	369	414	10,396,191
Нийт	455	512	12,449,391

Өдөр тутмын хэвлэл “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”, “Хүмүүн бичиг”, “Утга зохиол урлаг”, “Өнөөгийн Баянхонгор” сонин, “Төрийн мэдээлэл”, “Номын санч” сэтгүүлийг улирал тутам 471,000 төгрөгөөр захиалан авч, нийт 146 уншигчдад үйлчиллээ. Тогтмол хэвлэлүүдийг сар, улирлаар нэгж болгон үдэж сонин сэтгүүлийн дансанд бүртгэж, уншлагын танхим, тасгуудаас урагдаж гэмтсэн 241 ширхэг номыг сэргээн засварлан, уншлаганд гарган ажиллалаа.

Сан хөмрөгийн эргэлтийн судалгаагаар уншлаганд 28576 ном буюу фондын номын 57,2 хувийг уншигчид ашигласан байгаа нь өмнөх оноос 31 хувиар өссөн үзүүлэлттэй байна..

Зөөврийн номын сангийн үйлчилгээг Зөөврийн номын сангийн гэрээг 8 сум, 4 байгууллагатай байгуулж, нийт 12 удаа 361 ном олгож, 1231 уншигчид үйлчилжээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Политехникийн коллеж, Эрдэнэмандал сургууль, Баруун бүс худалдааны төвд нийт 12 удаа 626 номоор 1733 хүнд тус тус үйлчилгээ үзүүлж, соёл танин мэдэхүйн ажил зохион байгуулсан.

Номын үзэсгэлэн: Шинэ номын үзэсгэлэнг 12 удаа 379 номоор, сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 30 удаа 932 номоор, цахимаар 15 удаа 275 номоор тус тус үзэсгэлэн гаргаж, уншигчдад сурталчилан таниулсан.

1.3. Уншлага үйлчилгээ.

Шинээр уншигч	Ирцээр уншигч	Ном олголт
2534	13915	28576

1.4. Уншигчдыг соён гэгээрүүлэх соёл танин мэдэхүйн ажил. 2023 онд уншигчдад зориулсан соёл танин мэдэхүйн 32 төрлийн соёл олон нийтийн ажлыг 145 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж, 9198 хүн хамрагдсанаас гол гол ажлуудыг дор дурдвал:

1. “Үлгэр сонсож үг хэлэлцье” арга хэмжээг 02 дугаар сард 2 удаа зохион байгуулж, Гэгээн сумади, Баян-Ойт, Номундалай, Соого Сейкео сургуулийн нийт 53

уншигч хамрагдлаа. Ахмад настан Г.Дунжаа гуай хүүхдүүдэд үлгэр ярьж, оньсого таалцаж, зүйр үг, хэлц үгээр хүмүүжүүлэх талаар хөөрөлдөж, шагайгаар тоглох "Таа нэмэх" тогтоомыг зааж өглөө.

2. "Мэргэн буухиа" уралдаан. Уламжлалт сар шинийн баярыг угтан үндэсний хувцас, өв соёлоо сурталчлах, ёс заншил, үндэс угсаагаа бахархан судлах зорилготойгоор оюутан, сурагчдын дунд ардын аман зохиолоос сэдэвлэсэн танин мэдэхүйн "Мэргэн буухиа" уралдааныг зохион байгуулж, уг уралдаанд Номундалай, Номгон, Эрдэнэмандал, 5–р сургууль, Соого Сейкео, Гэгээн сумади сургууль, Баацагаан сумын ЕБС, Политехник коллежийн нийт 11 багийн 55 хүн оролцлоо. Тэмцээнд: Хэлц үг, Ертөнцийн гурав, Оньсого, Монгол бичгээс кирилл рүү хөрвүүлэх, Зүйр үг, Бид мэднэ танин мэдэхүйн тоглоом зэрэг 6 төрлөөр явагдаж, Номгон ахлах сургуулийн "Номгон 1" баг тэргүүн байр, Баацагаан сургуулийн "Угсаатан" баг дэд байр, Номундалай сургуулийн "Жавхаа" баг гутгаар байрыг эзэлж өргөмжлөл, дурсгалын зүйл, мөнгөн шагналаар шагнууллаа. Уралдааныг Нийтийн номын сангийн дэргэдэх "Оюунлаг тархи" номын клубын сурагчид, Баянхонгор аймгийн түүх угсаатны зүй, байгалийн музейтэй хамтран зохион явуулж, шүүгчээр Нийтийн номын сангийн захирал Б.Түвшинчимэг, музейн тайлбарлагч Ц.Батсүрэн, Зохиолчдын холбооны тэргүүн Б.Жавзандулам нар ажиллалаа. Төсөвт 159,000 төгрөг зарцуулсан.

3. "Номтой зочин". Цэргийн анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 140 албан хаагчдын дунд "Номтой зочин" танин мэдэхүйн тэмцээнийг явуулж, 1 номыг албан

хаагчдад 15 хоногийн хугацаанд уншуулан, тухайн номын талаар харилцан сэтгэгдлээ хуваалцах ажлыг санаачлан зохион байгууллаа.

<u>4. “Ээждээ бичих захидал” уралдаан.</u> Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ээждээ бичих захидал” уралдааныг ахлах, дунд ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Нийт 50 захидал хүлээн авч шалгаруулснаас ахлах насанд тэргүүн байрт Номгон ахлах сургуулийн 11-з ангийн сурагч Я.Ерөөлтбямба, дэд байрт 5 дугаар сургуулийн 10а ангийн сурагч Д.Ичинхорлоо, гутгаар байрт Номгон ахлах сургуулийн 10Б ангийн сурагч Т.Ануужингоо, дунд насанд тэргүүн байрт Эрдэм сургуулийн 6Г ангийн сурагч Б.Мишээл, дэд байрт Номгон сургуулийн 9Е ангийн сурагч А.Пүрэвбат, гутгаар байрт 5-р сургуулийн 6Б ангийн сурагч Н.Эрхсаран, тусгай байрт "Гэгээн сумади" сургууль, цэцэрлэгийн цогцолборын 6а Ж.Номин-Эрдэнэ нар тус тус шалгарч, шагналын санд 314,900 төгрөг зарцуулсан.

<u>5. “Аавдаа хэлэх чин сэтгэлийн үг” захидлын уралдаан</u>. Монгол цэргийн өдрийг тохиолдуулан “Аавдаа хэлэх чин сэтгэлийн үг” захидлын уралдааныг 2 насны ангиллаар, 10 дахь жилдээ зохион байгууллаа. Насанд хүрэгчдийн ангилалд 33 захидал ирсэнээс тэргүүн байрт Соогоо Сейкео сургуулийн багш С.Мөнхтогтох, дэд байрт Бууцагаан сумын иргэн Б.Цолмонтуяа, гутгаар байрт Эрдэнэмандал сургуулийн багш С.Мөнхзул, ОНЦЛОХ захидлын эзнээр Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн О.Найгалмаа нарын захидал, хүүхдийн насны ангилалд 61 захидал ирсэнээс тэргүүн

байрт Номундалай сургуулийн 11а ангийн сурагч С.Алтанцацрал, дэд байрт 5-р сургуулийн 10а ангийн сурагч Э.Энхзолбоо, гутгаар байрт Эрдэм ахлах сургуулийн 12в ангийн сурагч Б.Өсөхжаргал, ОНЦЛОХ захидлын эзнээр 5-р сургуулийн 9а ангийн сурагч О.Лхамдулам нарын захидал тус тус шалгарлаа. Зохион байгуулагчдын зүгээс "ОНЦЛОХ захидал"-ыг насны ангилал тус бүрд нэгийг шалгаруулан, шагналыг гардуулсан бөгөөд тус уралдааныг санаачлагч иргэн О.Наранцэцэг нийт 470,000 төгрөгөөр шагналын санг ивээн тэтгэсэн.

6."Дэлхийн яруу найргийн өдөр"- ийг Баянхонгор аймгийн Зохиолчдын холбоотой хамтран 10 дахь жилдээ зохион байгуулж, Зохиолчдын холбоонд шинээр элсэж буй гишүүддээ үнэмлэх, тэмдэг гардуулан, яруу найрагчдын дунд "50 номын хожил" уралдаан тэмцээн явуулж, дэлхийн яруу найргийн сонгомол зохиол, хүүхдийн шилдэг 50 гаруй номоор үзэсгэлэн гаргаж сурталчилсан. Үйл ажиллагаанд нийт 50 гаруй хүн оролцсон.

7. "Монгол ёс-Монгол бахархал" тэмцээн. Ёс заншил, үндэс угсаагаа бахархан судлах зорилготой "Монгол ёс-Монгол бахархал" танин мэдэхүй, авхаалж сорьсон тэмцээнийг байгууллагын ажилтнуудын дунд зохион явуулж, хүндэтгэлийн үг, хэлц үг,

ертөнцийн гурав, оньсого таах, шаагайн наадгайн “Та нэмэх” зэрэг 5 төрлөөр багууд өрсөлдөж, шилдгийг шалгаруулсан.

8. “Дэлхийн номын өдөр”-ийн үйл ажиллагаа. Энэ өдрийн хүрээнд Политехникийн коллежийн оюутнуудад “50 номын хожил” танин мэдэхүйн уралдааыг зохион байгуулж, дэлхийн сонгодог өгүүллэгийн 60 номоор номын үзэсгэлэн гаргаж, “Угийн бичиг хөтлөх арга зүй” сэдэвт лекц, сургалтыг аймгийн Төрийн архивын тасгийн дэргэдэх Угийн бичиг судлах танхимын мэргэжилтэн С.Гантуяатай хамтран зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд нийт 70 гаруй хүн оролцлоо.

9. “Дэлхийн хүүхдийн номын баяр”-ын өдөр. Тус өдрийг тохиолдуулан Дани улсын хүүхдийн зохиолч Х.К.Андерсены зохиол бүтээлээс сэдэвлэсэн гар зургийн уралдааныг Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ-тай хамтран зохион байгууллаа. Тус уралдаанд нийт 23 сургуулийн 56 сурагчийн бүтээл ирснээс тэргүүн байрт Богд сумын 6Б ангийн сурагч У.Учралсайхан, дэд байрт Баянцагаан сумын 6Б ангийн сурагч Ц.Энхмаа, гутгаар байрт Гэгээн Сумади цогцолбор сургуулийн 6Б ангийн сурагч Э.Идэрмөнх, тусгай байрт Номундалай сургуулийн 6Д ангийн сурагч Б.Гэгээнээ, 7Б ангийн сурагч Х.Түвшинтулга нар тус тус шалгарч, шүүгчээр Баянхонгор аймгийн Урчуудын эвлэлийн салбарын тэргүүн МУСТА, зураач Г.Цэрэндорж ажиллан, шагналыг “Нийгмийн түншлэлийн сүлжээ” ТББ-ын тэргүүн Ж.Дуламсүрэн 150,000 төгрөгөөр ивээн тэтгэж, хамтран ажилласан.

10. “Үндэсний бичиг үсгийн баяр”. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигаар жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногт "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. Энэ хүрээнд "Үндэсний бичиг, соёл" аймгийн тэргүүний уншигч шалгаруулах уралдааныг Боловсрол Шинжлэх ухааны газартай хамтран 19 сум, аймгийн төвийн 9 сургуулийн сурагчийн дунд зохион байгууллаа. Уралдааны эхний шатанд нийт 587 сурагч, 2-р шатанд 76 оролцож, 8-9 дүгээр ангийн төрөлд тэргүүн байрт Баянлиг сумын 8Г ангийн сурагч М.Золбоо, дэд байрт

Номундалай сургуулийн 9Е ангийн сурагч Ц.Оюунтүлхүүр, гутгаар байрт Номундалай сургуулийн 9Е ангийн сурагч Б.Дэлгэрдалай, тусгай байранд Төгс Алгоритм сургуулийн 9Б ангийн сурагч Э.Мөнх-Анужин, Шинэжинст сумын 8Б ангийн сурагч Ж.Энхмэнд нар, 10-12-р ангийн төрөлд тэргүүн байрт Бууцагаан сумын 12А ангийн сурагч Б.Мөнхзул, дэд байрт Номгон сургуулийн сурагч 12-1 ангийн сурагч Э.Отгонжаргал, гутгаар байрт Номундалай сургуулийн 11Д ангийн сурагч А.Найдан, тусгай байрт Богд сумын 12А ангийн сурагч Г.Мөнххүслэн, Бууцагаан сумын 10А ангийн сурагч Д.Номинзул, Эрдэнэцогт сумын сурагч Б.Рэгзэддулмаа нар тус тус шалгарлаа. Уралдааны шүүгчээр монгол хэл уран зохиолын багш Б.Долгормаа, М.Даваасүрэн, Л.Долгормаа, М.Өлзийжаргал, Ш.Цэдэнсодном, Б.Бямбасүрэн, М.Дэлгэрмаа, Э.Баасансүрэн, Саньюдулам, Лхамноржин нар ажиллаж, төсөвт 500,000 төгрөг зарцуулсан. Тус уралдааны дараагийн шатанд уралдаанд 6 хүүхэд улсад оролцсоноос Баянлиг сумын сурагч М.Золбоо тэргүүн байр эзэлсэн амжилттай.

11.”Найргийн чансаа” яруу найргийн наадам. Монголын Зохиолчдын эвлэлийн гишүүн, Г.Сэр-Одын нэрэмжит шагналт, яруу найрагч А.Батжаргалын санаачилсан “Найргийн чансаа” яруу найргийн наадмыг 4 дэх жилдээ зохион байгууллаа. Тус наадамд 30 хүн оролцож, 2-р шатанд шалгарсан 15 найрагчийн шүлгийг Хүүхдийн Тэмүжин театрын залуу уран бүтээлч Соёлын тэргүүний ажилтан Ж.Алтанчимэг, жүжигчин М.Алтжин, Ү.Ууганбаяр, Э.Түгжээ, сурагч Баярбаатар, Алтанчимэг нар уншиж толилуулав. Шүүгчээр Тэмүжин театрын ерөнхий найруулагч Д.Долгорсүрэн, Нийтийн номын сангийн захирал Б.Түвшинчимэг, ном зүйч Б.Должин, аймгийн Зохиолчдын холбооны тэргүүн, яруу найрагч Б.Жавзандулам, МЗЭ-ийн шагналт яруу найрагч, Г.Сэр-Одын нэрэмжит шагналт А.Батжаргал нар ажилласан. Яруу найргийн наадмын Тэргүүн байрт “Аавын дээл” шилгээр С.Ганболд, Дэд байрт “Мичидмаадаа” шүлгээр Д.Тунгалаг, Гутгаар байрт “Би аавтайгаа уулзаад ирлээ” шүлгээр С.Мөнхтогтох, Тусгай байрт “Эмээгийн бор авдар” шүлгээр С.Баттулга, “Ээждээ” шүлгээр Э.Маралмаа нар шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулав. Наадмыг “Шижир учиг” урлангийн хамт олон ивээн тэтгэсэн.

12."Ардын өв уламжлалыг залуу үеийнхэнд өвлүүлэх нь" ахмад, залуу үеийн уулзалт. Тус уулзалтыг ймгийн Ахмадын холбоотой хамтран Ахмадын ордонд зохион байгуулж, нийт 300 гаруй хүн оролцлоо. Гэрийн номын сандаа "Хамгийн олон номтой ахмад" шалгуруулах уралдааныг зарлаж, нэгдүгээр багийн ахмад настан Д.Лхамноржин, 4 дүгээр багийн ахмад Т.Тэрбиш нар шалгарч, "Д.Нацагдорж дүр" үнэмлэх, тэмдэг, дурсгалын зүйлээр шагнууллаа. Мөн "АХА" тэмцээн, бүжгийн тэмцээнийг явуулж ялагчдыг "Тод од сод ХХК"-ний зүгээс бэлтгэсэн дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.

13.Асуулт хариултын тэмцээн. Танин мэдэхүй, асуулт хариултын АХА тэмцээнийг 16

удаа 850 хүнд, "50 номын хожил" танин мэдэхүйн тэмцээнийг 81 удаа 188 хүнд, Алтан хонх тэмцээнийг 11 удаа 875 хүнд тус тус зохион байгуулжээ.

14.Өглөөний “Номтой уулзалт” аяллыг 6-р сард 2 удаа Оготнотой булаг дээр зохион байгуулж, ном унших сонирхолтой 6-12 дугаар ангийн 15 сурагч хамрагдлаа. Оролцогчид уншсан номынхоо тухай яриа өрнүүлж, хэлэлцүүлэг явагдлаа.

15.“Номын баяр-Орон нутагт” үйл ажиллагааг аймгийн хэмжээнд 5 болон 9 дүгээр сард тус тус зохион байгуулаа. Энэ хүрээнд “Уншаад урагшлахуй”, “Номын өргөөний ид шид" сургалт, “Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага, “Түүхийн жимээр аялахуй” сэдэвт соёлын өртөөчилсөн аялал, зохиолч Д.Жавхлангийн “Тод улаан зураг” шинэ номын нээлт, цахимаар “Номтой Монгол” чанга уншлага, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Өлзийт, Эрдэнэцогт сумдад “Номын хавчуурга” урлах уралдаан, АХА, “Алтан хонх”, “50 номын хожил” танин мэдэхүйн уралдаан, шинэ номын үзэсгэлэн, хуучин номын худалдаа тус тус зохион байгуулж, 5739 хүн хамрагджээ. Шагналын сан, үйл ажиллагааны бусад зардалд нийт 3,744,000 төгрөг зарцуулсан байна. Байгууллагын дэргэдэх “Оюунлаг тархи” номын клуб, аймгийн Түүх угсаатны зүй, Байгалийн түүхийн музейтай хамтран аймгийн төвийн түүх соёл, үл хөдлөх хөшөө дурсгалтай танилцуулах зорилготой “Түүхийн жимээр аялахуй” соёлын өртөөчилсөн аялалыг ЕБС-ийн 6 дугаар ангийн сурагчдад зохион байгуулж, нийт 110 хүүхэд хамрагдсан.

16. “Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага арга хэмжээг өндөр настан Г.Дунжаа гуайтай хамтран 14-р цэцэрлэг, Төгс-Алгоритм сургуулийн бага ангийн нийт 150 гаруй хүүхдүүдэд үлгэр уншиж өгч, үлгэр домгийн талаар ярилцлаа.

17. “Шинэ номын нээлт”. Монголын Зохиолчдын эвлэлийн гишүүн, зохиолч, яруу найрагч Б.Батжаргалын “Гүн цэнхэрлэгт”, яруу найрагч Д.Жавхлангийн “Тод улаан зураг”, зохиолч, яруу найрагч Т.Эрдэнэчулууны “Цээжний аглагт” шинэ номын нээлтийг тус тус зохион байгуулж, номын нээлтэд 80 гаруй хүн оролцсон.

18. “Үсэглэлийн хаад” уралдаан. “Эх хэлний өдөр”-ийн хүрээнд Монгол хэл соёл, бичиг үсгээрээ зөв бичих, ярих, түгээн дэлгэрүүлэх, журамласан үгсийн тайлбар толийг судлах, зорилготой “Үсэглэлийн хаад” тэмцээнийг зохион байгуулж, аймгийн төвийн 4 сургууль, орон нутгаас Баацагаан сумын сургуулийн сурагчдын 6 багийн 30 сурагч оролцож, тэмцээний 1-р үед үг үсэглэх, 2-р үед үг эвлүүлж тайлбарлах, 3-р үед харь хэлний үгээс нутгийн аялгууны үгэнд шингэж өөриймшсөн гадаад үгийг үсэглэх зэргээр өрсөлдсөнөөс 1-р байрт 23 оноогоор Баацагаан сургуулийн С.Цэцэгдэлгэр ахлагчтай баг, 2-р байрт 17 оноогоор Номундалай сургуулийн А.Биндэрьяа ахлагчтай баг, 3-р байрт 16 оноогоор Оюунлаг тархи клубийн Б.Гүнсэлмаа ахлагчтай багууд шалгарлаа.

<u>19. “Хүрэн морь-2023” яруу найргийн наадам</u>. Төрийн шагналт зохиолч, яруу найрагч Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит “Хүрэн морь-2023” яруу найргийн наадмыг 33 дахь жилдээ зохион байгууллаа. Яруу найргийн наадамд 40 яруу найрагч оролцсноос тэргүүн байрт Ховд аймгийн Мянгад сумын харьяат Ц.Отгонбаатар, дэд байрт Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын яруу найрагч Т.Эрдэнэчулуун, гутгаар байрт Баянхонгор аймгийн Жаргалант сумын яруу найрагч М.Санжнамжил, дөтгөөр байрт Баянхонгор аймгийн Баянцагаан сумын яруу найрагч Б.Төгөлдөр, 5 дугаар байрт Дархан-Уул аймгийн яруу найрагч Т.Банзрагч, тусгай байрт Улаанбаатар хотоос оролцогч А.Анхбаатар, Завхан аймгийн яруу найрагч На.Пүрэв-Очир, Улаанбаатар хотоос оролцогч Ж.Цэрэннадмид нар тус тус шалгарлаа. Уралдааны ерөнхий шүүгчээр МЗЭ-ийн гишүүн, Монголын Үндэсний радиогийн уран зохиол, өв соёлын редакцын продюссор Т.Эрдэнэцогт, МЗЭ-ийн Баянхонгор аймаг дахь салбарын тэргүүн Б.Жавзандулам, Утга зохиол шүүмж судлаач, хэл уран зохиолын багш Н.Энхбат, МЗЭ-ийн гишүүн, Г.Сэр-Одын нэрэмжит шагналт зохиолч С.Мөнхтогтох, аймгийн Нийтийн номын сангийн захирал Б.Түвшинчимэг нар ажиллалаа.

<u>20. “Богино өгүүллэгийн уран уншлага”-ын уралдааныг</u> аймгийн Хөгжимт драмын театртай хамтран дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулав. Нийт 6 сургуулийн 50 сурагч оролцож, Ахлах ангийн сурагчдын ангилалд тэргүүн байрт Жаргалант сумын 10а ангийн сурагч Б.Галдолгор, Дэд байрт Номундалай сургуулийн

12а ангийн сурагч С.Алтанцацрал, гутгаар байрт 5-р сургуулийн 10а ангийн сурагч А.Оюун-Эрдэнэ, тусгай байр Гэгээн сумади сургуулийн 10а ангийн сурагч Ц.Батзаяа нар, дунд ангийн сурагчдын ангилалд Тэргүүн байрт 5-р сургуулийн 6в ангийн сурагч А.Тэмүүлэн, Дэд байрт Баацагаан сумын 7а ангийн сурагч С.Мөнхсувд, гутгаар байрт Номундалай сургуулийн 7а ангийн сурагч Б.Лхагвадулам, 4-р байрт 5-р сургуулийн 8а ангийн сурагч Б.Оргилмаа нар тус тус шалгарлаа. Төсөвт 500,000 төгрөг зарцуулсан.

21.“Өсвөрийн яруу найрагчид бид” яруу найргийн уралдааныг 11 дэх жилдээ зохион байгуулж, уралдаанд 6-12 дугаар анги болон Политехник коллежийн 71 сурагч оролцов. Уралдааны ахлах ангийн сурагчдын ангилалд, Тэргүүн байрт Баянцагаан сумын сурагч Ш.Ганцоож "Шилжин явах цом"-ын эзэн, 2-р байрт Шинэжинст сумын 11б ангийн сурагч Х.Нямсүрэн, 3-р байрт Баянбулаг сумын 11б ангийн сурагч У.Мөнх-Оргил, Тусгай байрт Гэгээн сумади сургуулийн сурагч Н.Отгонсүрэн, Номгон сургуулийн 12а ангийн сурагч Д.Даваасүрэн нар, дунд ангийн сурагчдын ангилалд Номундалай сургуулийн 9г ангийн сурагч М.Цэлмүүн "Шилжин явах цом"-ын эзэн, 2-р байрт 5-р сургуулийн 9г ангийн сурагч А.Анужин, 3-р байрт Эрдэнэмандал сургуулийн 8а ангийн сурагч Б.Намуунаа, тусгай байрт Эрдэнэмандал сургуулийн 6г ангийн сурагч Б.Нандин-Эрдэнэ, С.Магнайбаяр нар тус тус шалгарлаа. Төсөвт 560,000 төгрөг зарцуулсан.

22. “Зохиолын баатрууд амилсан нь” дүрийн тоглолт. Монголын шилдэг зохиол бүтээлүүдийг сурталчлах, жүжиглэх, авьяас чадварыг хөгжүүлэх зорилготой “Зохиолын баатрууд амилсан нь” зохиолын дүрийн тоглолтыг зохион байгууллаа. Эхний шат сургуулиуд дээр явагдаж 8 сургуулиас шалгарсан 7 багийн 127 сурагч аймгийн хэмжээнд өрсөлдөж, Тэргүүн байрт Номгон ахлах сургуулийн Е.Энхцэцэг багштай 6Б анги “12 сар” зохиолоор, 2 дугаар байрт Ц.Оюунбаатар багштай 7Е анги “Алтан түлхүүр буюу Буратиногийн адал явдал” зохиолоор, гутгаар байрт Б.Алтанцэцэг багштай 6В анги “Эрэл” зохиолоор, тусгай байрт 5-р сургуулийн Б.Ууганбаяр багштай 6А анги “Цоохор найз” зохиолоор, Эрдэнэмандал ахлах сургуулийн Г.Энхжаргал багштай 7Б анги “Тэнэг хүүгийн үлгэр” зохиолоор тус тус шалгарлаа. Шүүгчээр аймгийн ХДТ-ын ерөнхий найруулагч С.Тогоомөнх, жүжигчин Ч.Бямбаням, Нийтийн номын сангийн захирал Б.Түвшинчимэг нар ажилласан. Уралдааны зохион байгуулалт, шагналын зардалд нийт 1,000,000 төгрөг зарцуулсан.

23. "Дээлтэй Баянхонгор 2023" үндэсний хувцастай өдрөөр өндөр настан Г.Дунжаа гуайг урин уншигчдад үлгэр ярьж өгөх, шагай наадгай тоглох, оньсого таалцаж, хэлц үг цээжлэх гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулж, Гэгээн сумади, Эрдэнэмандал сургууль, Баян-Ойт цогцолбор, 14-р цэцэрлэгийн 357 уншигч хүүхдүүд хамрагдсан.

24. “Тэргүүний уншигчдын сүлд модны наадам”. Уншигчийн шинэ жилийн үйл ажиллагааг зохион байгуулж, энэ онд номын сангаар идэвхтэй үйлчлүүлж, “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж” дүр тэмдэгтэн шалгаруулах болзлыг хангасан 9 уншигч, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажилласан 2 номын санч, 2 багшийг шалгаруулан гарын бэлгээр шагнаж урамшууллаа. Нийт 60 орчим хүн оролцсон.

25. “Номын заяа-Миний буян” уран бүтээлийн үзэсгэлэн. Баянхонгор аймгаас төрөн гарсан нийт 22 зохиолчийн 2023 онд шинээр хэвлүүлсэн номын баярыг МУҮНС, аймгийн Зохиолчдын холбоотой хамтран Улаанбаатар хотод Үндэсний номын сангийн Ерөнхийлөгчийн нэрэмжит танхимд хийж, ахмад номын санч Б.Байгальмаагийн “Номын буян-Миний заяа” уран бүтээлийн үзэсгэлэнг гарган сурталчиллаа. Нийт 60 хүн хамрагдсан.

26. “Номын хавчуурга бүтээх уралдаан”. Уншигчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, гарын доорх материалаар номын хавчуурга бүтээх уралдааныг хангайн бүсийн 8 сумын сурагчдын дунд зохион байгуулж, нийт 4282 сурагч оролцсоноос сум тус бүрт шилдэг 5 оролцогч, нийт 55 хүүхдийг шагнаж урамшуулж 550,000 төгрөг зарцуулсан зэргээр уншигчдыг соён гэгээрүүлэх, соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгууллаа.

2023 онд зохион байгуулсан соёл, олон нийтийн ажлууд:

№	Соёл, олон нийтийн ажлын нэр /2023 он/	Зохион байгуулсан огноо	Хамрагдсан хүний тоо	Байгууллагаас зарцуулсан төсөв	Хамтарсан байгууллагаас ивээн тэтгэсэн төсөв
1	“Үлгэр сонсож, үг хэлэлцье”	II/05	2 удаа 53		
2	“Мэргэн буухиа”	II/10	55	159,000	
3	“Номтой зочин” подкаст цахимаар	6 сард	3 удаа 12		
4	“Ээждээ бичих захидал” захидлын уралдаан	III/08	52	314,900	
5	“Аавдаа бичих чин сэтгэлийн үг” захидлын уралдаан	III/18	94		470,000
6	Дэлхийн яруу найргийн өдөрлөг	III/21	50	160,000	
7	“Монгол ёс заншил”	III/30	10		
8	“Дэлхийн номын өдөр”	IV/21	70		
9	Андерсений зохиолоос сэдэвлэсэн гар зургийн уралдаан	IV/24	56		150.000
10	Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд “Тэргүүний уншигч” шалгаруулах уралдаан	IV/25	75	500,000	
11	“Найргийн чансаа” яруу найргийн уралдаан	V/05	30		250.000
12	“Ардын өв уламжлалыг залуу үеийнхэнд өвлүүлэх нь” уулзалт цэнгүүн	5 сард	300		
13	“50 номын хожил” танин мэдэхүйн уралдаан	Дэлхийн яруу найргаар- 16 хүнд Коллеж-4 у НДС-3 у Номын баяр хавар-54 удаа 108 хүн Номын баяр намар 20 хүнд Соёлын сар-3 уда хүнд ББХТөв 4 уд -12 хүн	81 удаа 188 хүнд		
14	“АХА” асуулт хариултын тэмцээн	Усны өдрөөр 2 у, 25 хүнд. Хүүхдийн баяр-25 хүнд. Наадмаар 30 хүнд Ном баяр-хавар-9 удаа 630 хүнд Ном баяр-намарт 2 удаа 130 хүнд	16 удаа 850 хүнд		
15	Алтан хонх	Номын баяр хавар-720 хүн Номын баяр намар-155 хүн	11 удаа 875 хүнд		
	“Номын баяр”-хавар	v/09-26	4694	3,002,000	
16	1. “Номын баяр” хүрээнд “Номын хавчуурга” бүтээх уралдаан		3492	1170,0	

17	2. “Номын баяр” хүрээнд “Үлгэрээс үлгэрлье” чанга уншлага (“Санхүүч хэрэм” зохиолоор)		150		
18	3. “Номын баяр” хүрээнд “Түүхийн жимээр” соёлын өртөөчилсөн аялал		110		
19	4. “Номтой аялал” уулзалт	VI/09	15		
20	5. “Тод улаан зураг” номын нээлтийг		21		
Номын баяр- намар		IX/08-24	1951	742,000	
21	1. “Номтой монгол” чанга уншлага /цахимаар/		7 удаа 2745 хүн үзсэн		
22	2. “Номын баяр” хүрээнд “Түүхийн жимээр” соёлын өртөөчилсөн аялал		104		
23	3. “Номын баяр” хүрээнд “Номын хавчуурга” бүтээх уралдаан /галуут,жаргалант сумдад/		790	280,0	
24	4. Шинэ номын нээлт:	А.Батжаргалын “Гүн цэнхэрлэгт”, яруу найрагч Т.Эрдэнэчулууны “Цээжний аглагт” номын нээлтийг	50		
25	5.Баганат талбайд номын үзэсгэлэн, худалдаа				
26	Үсэглэлийн хаад	9/13-нд	30		
27	Хүрэн морь	11/08нд	40	5 сая	
28	Богино өгүүллэгийн уран уншлага		50	500,0	
29	Өсвөрийн я/н		71	560,0	
30	Зохиолын дүр		127	1 сая	
31	Дээлтэй баянхонгор		357	-	
32	Манай гэрийн номын сан цахимаар		7 айл буюу 14 хүн		250,0 ГБХЗХГ
Нийт 32 ажил			145 удаа, 9198 хүн	11,937,900	1,120,000

2022 онд уншигчдад зориулсан 26 төрлийн соён гэгээрэл, танин мэдэхүйн ажил, уралдаан тэмцээн 103 удаа зохион байгуулж, 6672 хүнийг хамруулж байсан бол 2023 онд 32 төрлийн ажлыг 145 удаагийн давтамжтай зохион байгуулж оролцсон, хамрагдсан хүний тоо 9198 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс зохион байгуулсан ажлын тоо 23 хувиар, хамрагдсан хүний тоо 38 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.5. Сургалт, семинар.

Номын санчдад зориулан сургалт.

1.БСШУ-ны Сайдын 2007 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм"-д аймгийн Нийтийн номын сан

нь харъяалагдах номын сангуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сургалт семинар зохион байгуулж, номын санчдын мэргэжил боловсролыг дээшлүүлнэ гэж заасны дагуу сургуулийн болон сумдын мэргэжлийн бус номын санчдад номын сангийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад нийт 11 номын санч хамрагдаж, номын сангийн тухай ерөнхий ойлголт, хэрэгжиж буй хууль тогтоомжууд, стандарт, дүрэм журмууд, номын санд хөтлөгдөх бүртгэлүүд, тэдгээрийг хөтлөх аргачлал, сан хөмрөгийн зохион байгуулалт, хадгалалт хамгаалалт, ном зүйн ажил түүний төрөл хэлбэр, ангилал, каталог, номын санчийн албан тушаалын тодорхойлолт, номын сангийн үйлчилгээ, соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулах, цахим каталог, номын санд хэрэглэгддэг программууд зэрэг сэдвүүдийг судалж, дадлага ажлыг хийлгэн, гэрчилгээ олгосон.

2.Орон нутгийн 16 номын санчдад Lib4U программын ахисан шатны сургалтыг Wolves компаний мэргэжилтэн С.Гантулгатай хамтран онлайнаар зохион байгуулсан.

3.Үндэсний номын сангаас орон нутгийн болон сургуулийн номын санчдад “Цахим сан хөмрөгийн ерөнхий ойлголт” сургалтыг цахимаар зохион байгуулахад орон нутгийн 23 номын санчийг хамруулан оролцуулсан.

4.“Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд СУИС-ийн Соёлын сургуулийн номын сангийн тэнхимтэй хамтран сумдын болон сургуулийн номын санч нарыг чадавхжуулах сургалтыг 11 дүгээр сарын 13-нд зохион байгууллаа. Сургалтыг Соёлын сургуулийн багш А.Алтанчимэг, Б.Амарзаяа нар орон нутгийн түвшинд санамж өгөх ном зүйн бүртгэл хийх, google forum ашиглан судалгаа авах, соёлын бүтээлч орон зай үүсгэх, номын сангийн танилцуулга, постер бэлтгэх зэрэг сэдвээр зохион байгуулж, нийт 42 номын санч мэргэжилтнүүд хамрагдан мэдлэг боловсролоо дээшлүүлсэн.

Уншигчдад зориулсан сургалт.

1.”Угийн бичиг хөтлөлт” сэдэвт сургалтыг Баянхонгор аймгийн Төрийн архивын тасгийн дэргэдэх “Угийн бичиг судлах танхим”-ын ажилтан С.Гантуяатай хамтран байгууллагын албан хаагчид, Политехникийн коллеж, ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, Эрдэнэмандал сургуулийн сурагчдад нийт 3 удаа зохион байгуулж, нийт 150 гаруй хүн хамрагдав.

2 .Улаанбаатар хотын Төв номын сангийн уншлагын танхимын номын санч П.Оюунбаяртай хамтран “Тэмтэрч уншдаг товгор үсгийн тухай” сэдвээр хараагүйчүүдэд зориулсан брайль үсгийн сургалт, мэдээллийг цахим орчинд байршуулж 159 хэрэглэгч хамрагдсан.

3. Уншигчдын дунд “Номын өргөөний ид шид” сургалтыг 2 удаа зохион байгуулж, 72 уншигч хүүхдүүдийг хамруулсан.

Албан хаагчдын хамрагдсан сургалт.

1.АЗДТГ, Хууль, эрх зүйн хэлтэс, Төрийн архиваас байгууллагын архив, албан хэрэг хөтлөгч ажилчдын дунд зохион байгуулсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчлэлт-өөрчлөлт” зөвлөгөөн, “Архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн шинэчлэл” нэгдсэн сургалт, “Монгол бичгийн цахим бичвэр боловсруулах арга зүй”, Хүний нөөцийн системд албан тушаалын тодорхойлолтыг оруулах арга зүйн цахим сургалтад архив, бичиг хэргийн ажилтан О.Байгал тус тус оролцов.

2.“Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд Соёлын яамны дэмжлэгтэйгээр, Үндэсний номын сан, Монголын Номын сангуудын консорциум ТББ хамтран 10 дахь жилдээ зохион байгуулж буй “Номын санч-мэдээллийн ажилтны улсын X зөвлөгөөн, “Mongolian library update-2023” арга хэмжээнд захирал Б.Түвшинчимэг, сүлжээний инженер М.Дондовжамц нар оролцов. Сургалт Улаанбаатар хотод энэ оны 11 дүгээр сарын 15, 16-нд зохион байгуулагдав.

3.Төрийн албаны зөвлөл, Төрийн архивын тасаг, АЗДТГ, аймгийн Цагдаагийн газар, Хууль эрх зүйн хэлтээс тус тус зохион байгуулсан угийн бичиг, монгол бичиг,

7:4:10, Авлигын, Төрийн албан хаагчийн ёс зүйн, Төрийн албаны болон Хөдөлмөрийн хуулийг сурталчлах сэдэвт 11 төрлийн сургалтад байгууллагын албан хаагчид хамт олноор болон холбогдох мэргэжилтнүүд тухай бүр оролцож, мэдлэгээ дээшлүүлсэн.

<u>1.6. Дугуйлан:</u> Монгол бичгийн уран бичлэгийн дугуйланг багш Ч.Бямбадолгортой хамтран зохион байгуулж, дугуйланд 10 суралцагч хамрагдаж байна.

Хоёр. Удирдлагын ажил.

2.1.Хууль эрх зүйн хүрээнд. Төрөөс баримтлах соёлын бодлого Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, номын сангийн стандарт, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэн, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу албан хаагчдын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, ажлын гүйцэтгэлээр үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлэн, урамшууллыг олгон ажиллалаа.

Тайлангийн хугацаанд байгууллагын хамт олны хурал 15 удаа, захиргааны зөвлөл 2 удаа, өмч хамгаалах байнгын зөвлөл 3 удаа, баримт нягтлан шалгах комиссын хурал 3 удаа тус тус хуралдав.

А<u>жилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд</u> анхаарч, байгууллагын захиргаанаас ахмадуудыг сар шинийн баяр, ахмадын баяраар хүлээн авч **636,000** төгрөг, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, шинэ жилээр ажилчдын хүүхдүүдийг хүлээн авч баярлуулахад **450,000** төгрөг, 4 ажилтанд **290,000** төгрөг, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа 6 ажилтанд таван жилийн тэтгэмж **28,238,000** төгрөг, эрүүл мэндийн үзлэг оношилгоо, эрдэс бодисын шинжилгээнд хамруулж **2,200,000** төгрөг, байгууллагын 2 шилдэг ажилтанд **200,000** төгрөг**,** ажилчдын улирал, хагас жилийн ажлыг дүгнэж 20-45 хүртэлх хувиар урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгож ажилласан.

Хүний нөөцийн ажил: Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолын дагуу нийт ажилтанд төрийн албанд ажилласан хугацааны, хоол унааны, орон нутагт ажилласны нэмэгдлийг, мөн Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолын дагуу цалингийн өөрчлөлтийг, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийн дагуу албан тушаалын тодорхойлолтуудыг PDF өргөтгөлд хөрвүүлэн хүн тус бүрээр системд бүртгэн, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу нийт албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлж, шинээр ажилд орсон, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээллийг хүний нөөцийн систем, ERP, нийгмийн даатгалын системд тус тус бүртгэсэн.

Гурав. Албан хэрэг хөтлөлтийн ажил: Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг шинэчлэгдсэн хууль, холбогдох журам, баримт бичгийн MNS5140:2021 стандартын дагуу хөтлөн явуулж, хууль, журмыг ажилтнуудад дотоод сүлжээгээр тарааж, сурталчлан таниулж, арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажилласан.

Байгууллагад ирсэн бичиг 132, үүнээс хариутай бичиг 70, явсан бичиг 87, ирсэн захирамж, тогтоол 15, тушаал 61, түр олгосон баримт 22 байна. i-office программыг албан бичиг солилцооны DOCX.gov.mn дундын системтэй холбож, үйл ажиллагаандаа өргөнөөр ашиглаж, байгууллага хооронд харилцаж байна. өргөдөл гомдлын EOFFICE цахим системийг хариуцан ажиллаж, нийт 6 өргөдөл ирснийг бүртгэн, хугацаанд нь шийдвэрлэж, мэдээг улирал тутамд Соёл, урлагийн газарт мэдээллэв.

Архивын ажил: Ажилчдаас ирүүлсэн санал болон өмнөх оны хөтлөх хэргийн жагсаалт, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үндэслэн 2023 оны хөтлөх хэрэгт 176 нэгж баримтыг тусган жагсаалтыг боловсруулж, Төрийн архивын тасагт хугацаанд нь хүргэж, нийт ажилтнуудаас 2022 оны баримтыг бүртгэлээр авч, байнга 55, түр 70 жил 9, түр 10 жил хадгалах 81 баримтын бүртгэл гаргав.

Баримтын тооллого: "Байгууллагын архивын баримтад тооллого хийх тухай" захирлын 2023 оны А/25 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсгийн ахлагч Б.Бүжидмаа, гишүүн Ц.Болорчимэг, Ц.Дэлгэрмаа нар байгууллагад хадгалагдаж буй 2001-2022 оны түр, 70 жил хадгалах баримт, 2021-2022 оны байнга хадгалах баримтыг тоолов. Тоологч ажилтнууд баримтын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хариуцаж тоолсон баримтын арын баталгааны хуудсанд "Тоолсон" тухай тэмдэглэж, баримтыг дэс дараалаар нь хайрцагт буцаан хийж, тавиурт байрлуулав. Байгууллагын архивт нийт 1489 нэгж баримтыг байгууллагын архивт хадгалж байна. Баримтын бүртгэлд орсон өөрчлөлтийг батлуулахаар Төрийн архивд илтгэх хуудас бичиг хүргэсэн.

Цахимжуулалт: Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хүрээнд Төрийн архивын үндсэн санд 2020 оны байнга хадгалах 473 хуудас бүхий 49 нэгж баримтыг цаасаар болон цахим хувиар дансны хамт шилжүүлэв. Баримтыг сканердаж, мастер болон ашиглалтын хувь үүсгэн, баримтын нүүр, ашиглалтын хуудас, дотоод товьёг, баталгааны хуудас бичиж, үдэж хавтаслав. Баримт шилжүүлэхэд картон 52 ширхэг, бичгийн цаас 2 боодол, утас зүү, DVD 1 ширхэг, принтерийн хор тус тус хэрэглэгдэж, төсөвт ойролцоогоор 170,000 төгрөг зарцуулсан. Төрийн архивын AMS программд баримтын өгөгдлүүдийг хүний нэр, газар зүйн нэр, байгууллагын нэрээр шивж оруулав. Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын 1 хувийг DVD-д хуулж, байгууллагад хадгалан, 2023 оны гэрэл зургийн цомгийг 36 ширхэг зургаар бэлтгэн, зааврын дагуу эмхлэн цэгцэлж, Төрийн архивын санд хугацаанд нь хүлээлгэн өгч, хадгалуулав. Зураг угаалгах, зурган файл бэлтгэн өгөх, зургийн альбом зэрэгт нийт 107,000 төгрөг зарцуулсан.

БНШК-ын ажил: Байгууллагад хэрэглэгддэг 7 төрлийн тэмдэг, мөн 9 төрлийн хэвлэмэл хуудсыг захирлын тушаалаар томилогдсон комиссын дарга, гишүүд нүдээр үзэн тоолов. Тэмдэг, хэвлэмэл хуудасны ямар нэг зөрчилгүй, тооллогыг цаг хугацаанд нь гүйцэтгэж, Архивын тасагт тайлан хүргэв. Устгасан 9 ш хэвлэмэл хуудасны бүртгэл хийж, 3420 төгрөгийн төлбөрийг байгууллагын дансанд тушаасан.

Дөрөв.Мэдээллийн үйлчилгээ: Байгууллагын 15 компьютерын дотоод сүлжээ, LIB4U программ, тогтмол хэвлэлийн Zotero программын хэвийн ажиллагааг хангаж, вирустсэн компьютерийг форматлах, компьютер, техник хэрэгслүүд, сүлжээ эвдрэл гэмтэл гарсан тухай бүрд нь засаж хэвийн ажиллагааг хангаж ажилласан. “Номын сан Баянхонгор” facebook цахим хуудсанд уншигч хүүхэд багачуудад зориулан 120 удаагийн танин мэдэхүйн мэдээ мэдээллийг байршуулж, “Цахим уншлага” пэйж хуудсанд зохиол, өгүүллэг, тууж 65 удаа тус тус нийтэлжээ. Нийтлэлийн хүртээмж 97757, нийтлэлтэй харьцах 10165, хуудас шинээр таалагдсан тоо 1780, хуваалцсан тоо 766, шинээр дагаж нэгдсэн 700 хэрэглэгч байна.

Тав. Санхүү, бүртгэлийн ажил: Нийт батлагдсан төсөв 259,392,900 төгрөг, үүнээс үндсэн цалин 111,657,688 төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 22,205,142 төгрөг, урсгал зардал 17,708,700 төгрөг, ном хэвлэл худалдан авахад 10,382,798 төгрөг байлаа. Үр дүнд суурилсан санхүүжилт 15,154,588.76 төгрөгийн санхүүжилтийг авч холбогдох зардлуудыг эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулж, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Монгол Улсын Засгийн газрын

холбогдох тогтоол, шийдвэр, Соёлын яам, Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан журам, шийдвэрийг хэрэгжүүлэн, санхүү бүртгэлийн тайланг цаг тухайд нь гаргаж, шилэн данс, төсвийн мэдээллийн самбараар дамжуулж иргэд, уншигчдад санхүүгийн ил тод байдлыг мэдээлж ажилласан.

Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулан, Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны баримтын маягтын дагуу 13 нэр төрлийн баримтыг шинэчлэн хөтөлж, байгууллагын хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогыг цаг хугацаанд нь зохион байгуулан ажиллаж байна.

Зургаа. Бусад ажил.

Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гамшгаас хамгаалах зөвлөл, өмч хамгаалах байнгын зөвлөл, эцэг эхийн зөвлөл, залуучуудын зөвлөл, авлигатай тэмцэх орон тооны бус ажилтнууд тус тусын алын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Долоо.Байгууллагын тохижолт, ая тухтай байдал. Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол чанартай зохион байгуулж, тогтсон хугацаанд их цэвэрлэгээг хийн, номын сангаар үйлчлүүлж байгаа хүүхдүүдийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Байгууллагын гаднах ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, арчилгааг тогтмол хийж хэвшсэн. Аймаг орон нутгаас зохион байгуулж байгаа бүх нийтийг хамарсан:

-"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн

-"Монгол түмний харвуул их наадам"

-"Хүүхдийн спортын их наадам"

-"Цаг гаргая" аян

-Соёлын сэргэлт" аян

"Соёлын бүтээлч сар"

-Хүмүүнлэгийн ажлуудад хамт олноороо тогтмол оролцож ажиллалаа.

Дүгнэлт:

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 81 ажил төлөвлөснөөс 69 ажил арга хэмжээ бүрэн биелэгдсэн, 12 ажил 90-ээс дээш хувьтай биелэгдэж, нийт гүйцэтгэл 98,4 хувьтай байна.

Ололттой зүйлүүд:

❖ Соёл танин мэдэхүй, соён гэгээрлийн ажлуудад хамрагдаж, оролцож буй иргэдийн тоо өмнөх онуудаас өссөн.

❖ Номын сангийн LIB4U программыг орон нутгийн номын сангуудад нэвтрүүлсэнээр сум орон нутгийн номын сангийн номын тооллого хийх ажил түргэн шуурхай болж, номын дүн, мэдээ, уншигчийн тоо, ном олголтын мэдээ тайлан үнэн зөв гарах давуу талтайгаас гадна өөрийн номын

санд байхгүй ном хэвлэлээ бусад номын сангаас хайн олж, хоорондоо солилцон ашиглах боломжтой болсон.

❖ Уншигч хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх, ая тухтай орчинд үйлчлүүлэх зорилгоор <u>Чөлөөт уншлагын танхимыг</u> байгуулж, шинэлэг үйлчилгээ нэвтрүүллээ. Уг уншлагын танхим нь бүхий л насны иргэдэд зориулсан хувь хүний хөгжил, танин мэдэхүй, толь бичиг, үлгэр өгүүллэг, уран зохиолын номоор ойрын сан хөмрөгөө бүрдүүлсэнээс гадна Лхагва-Ням гарагуудад 11:00-15:00, 16:00-20:00 цагийн хооронд ажилладаг нь бусад уншлагын танхимаас ялгагдаж, гэр бүл, найз нөхөд, анги хамт олноороо үйлчлүүлэх таатай орчинг бүрдүүлсэн.

Цаашид анхаарах ажлууд:

❖ Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ажилд анхаарах.

❖ Сан хөмрөгөөс эргэлтэд гараагүй ном хэвлэлийг уншигчдад сурталчлах, ном зүйн бүртгэлийг төрөл бүрээр бэлтгэн гаргах

❖ Байгууллагын хүүхэд хамгаалал, эцэг эхийн зөвлөлийн ажлыг сайжруулах, хүүхдийн өрөө тохижуулах

❖ Акталсан ном хэвлэлийг данснаас хасах, программ, номын нэгбүрчилсэн бүртгэлийн тулгалт хийх

❖ Цахим номын эхлэлийг тавих, иргэдэд үйлчлэх

БУЛГАН АЙМГИЙН С.УДВАЛЫН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

1. АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ЗОРИЛТ
2. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
3. УНШЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭ
4. ЯВУУЛЫН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
5. САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭЛТ
6. ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ
7. ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ
8. ТАТГАЛЗАЛ
9. МЭРГЭЖИЛ АРГАЗҮЙ
10. НОМЗҮЙ
11. КАТАЛОГ
12. НОМЫН ҮЗЭСГЭЛЭН СУРТАЛЧИЛГАА
13. СУРГАЛТ
14. СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ
15. ШИНЭЛЭГ АЖИЛ, ГАРГАСАН АМЖИЛТ
16. 2024 ОНД ШИНЭЭР САНААЧЛАХ АЖИЛ
17. ХҮНИЙ НӨӨЦ, БОЛОВСОН ХҮЧИН
18. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ
19. БУСАД АЖИЛ
20. СУДАЛГАА
21. ДҮГНЭЛТ
22. СОНА-ЫН ИЛТГЭХ ХУУДСУУД
23. ФОТО ЗУРГУУД

1. АЛСЫН ХАРАА

Чанартай үйлчилгээ

Чадварлаг хамт олон

ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэдээллийг түгээе

Мэдлэгийг цогцлооё

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

Үндэсний соёлын үнэт өв ном хэвлэлийг хадгалж хамгаалах, сурталчилан таниулах, ард иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэх, ном хэвлэл, соёл олон түмний ажлаар дамжуулан соён гэгээрүүлэх, бүтээлч уншлагыг дэмжин үр өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино.

ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Дотоод орчин	
Давуу тал Шинэ барилга баригдахаар 2024 оны улсын төсөвт тусгагдсан Мэргэжлийн удирдлагатай Байршил сайтай Соёл олон нийтийн ажлын зохион байгуулалт сайн Ном хэвлэл 100% цахим каталогт орсон Уншигчийн бүртгэл, ном олгох үйлчилгээ 90% цахим болсон Бүх албан хэрэгцээнд ашиглаж байгаа комьпютерууд вирусын хамгаалалт, нэмэлт hard суулгаж багтаамж, хурд сайжруулсан	Сул тал Дохиолол хамгааллын системгүй Агааржуулалт, ариун цэврийн өрөө дотор ОО байхгүй Сантехник, цахилгааны монтаж муу Заал танхимын багтаамж хүрэлцээ бага Цахим сан хөмрөг бага
Гадаад орчин	
Боломж Соёлын яамтай болсон Төсөл хөтөлбөрт хамрагдах Номын сангууд болон төр бус байгууллагууд хамтын ажиллагаа сайжруулах Номын сангууд нэгдсэн каталог, програм ашиглах Нэгдсэн нэг ангилал ашиглах Гадаадын хөрөнгө оруулалт татах	Аюул Барилга МХГ, ОБГ зэрэг мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтүүд гарсан, ашиглалтын хугацаа дууссан Улс орныг хамарсан гэнэтийн /Ковид 19 гэх мэт/ гамшиг ослын нөхцөл байдлын эрсдэл

2.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

2023 онд Аймгийн засаг дарга, Соёл урлагийн газартай гүйцэтгэлийн гэрээ байгуулан 4 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж 91,3%-тай үнэлэгдлээ.

2023 онд хийсэн ажлын үр дүнгээр 17.068.246 төгрөгний нэмэлт санхүүжилтийг Соёлын яамнаас авч зориулалтын дагуу зарцууллаа.

Номын сангийн шинэ барилга баригдахаар 2024 оны төсөвт тусгагдлаа.

Бүх нийтийн Соёлын боловсрол олгох 12 удаагийн сургалт зохион байгуулж 1055 хүн хамруулсан. Үүнээс 17 номын санчийг аймгийн сургагч багшаар бэлтгэн батламж олгосон.

Үндэсний бичиг, соёл номын өдрүүдийг хуулийн хугацаанд нь хавар, намар зохион байгуулж 2352 хүн хамрагдсан.

Өөрийн номын сангийн цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх зорилгоор зохиогчийн эрхийн зөрчилгүй 10 номыг цахим хэлбэрт оруууллаа.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Буриад улсын Закаменск хотын номын сантай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. 2024 онд Булган аймагт болох буриад үндэсний олон улсын “Алтаргана” наадмыг зохион байгуулахад Буриад “Номын уралдаан”, “Буриад яруу найргийн уралдаан”-ыг хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. Уг хамтын ажиллагааны хүрээнд Улаан-Үүд хотын үндэсний номын сан жишиг болон хөгжиж байгаа 2 дүүргийн номын сангаар номын санчид туршлага судалсан.

АНУ-ын Өмнөд Дакотагийн Их сургуулийн автоматжуулалтын хэлтсийн дарга, Америк Монголын судлалын төвийн номын сангийн судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Д.Энэрэл “СӨН-ны хүүхдийн ном уншлага”-ын хөтөлбөр судалгааны ажлаар хамтран Булган, Тэшиг, Хутаг-Өндөр сумдад ажиллаа.

“Хүүхдийн бүтээлч уншлага” аяныг үргэжлүүлэн хэрэгжүүлж аймгийн хэмжээнд 140 бүлгийн 3494 хүүхдийг ангийн уншлагад идэвхтэй хамруулж 8-15% ахиц гарган ажиллаа.

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр “Зохиолын баатрууд амилсан” маскотыг номын санчид өөрсдийн гараар урлаж оролцсон.

Зохиолч уран бүтээлчдийг алдаршуулах тэдний зохиол бүтээлийг сурталчилах “Тунамал туурвил” хөрөг нэвтрүүлэгийг орон нутгийн “СМ” телевизтэй хамтран хийсэн.

Тэшиг сумын Харгал баг, Хилийн цэргийн 0286 дугаар ангиудад нүүдлийн номын сангаар үйлчилж соёл олон нийтийн ажил зохион байгууллаа.

Байгууллага хамт олныг ном унших дадал хэвшил, тогтмол уншлагын цаг бий болгох зорилгоор “Өглөөний уншлага” аян өрнүүлж 16 байгууллагын 173 албан хаагч 93 удаагийн уншлагад хамруулсан.

Монгол улсын хэмжээнд Соёлын яамнаас зохион байгуулсан Соёлын сэргэлт 2023 аянг, “Хүүхдэд ээлтэй Булган” уриатайгаар Булган аймгийн 16 сум нэг 1 тосгоноо төвийн бүс, хойд бүс, урд бүс гэсэн 3 хэсэгт хувааж Хүүхдийн төв номын сан, Булган аймгийн Соёл урлагийн газар, аймгийн Нийтийн Номын Сан, аймгийн Музей, ХЖТ-ын хамтарсан баг 3 хуваагдаж сум тус бүрт 1 өдрийн үйл ажиллагааг хүүхэд багачууд, иргэдийн дунд зохион байгууллаа.

Соёлын яамнаас зохион байгуулсан “Соёлын эрхийн бичиг”-ээр үзвэр үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2 ажил санаачлан зохион байгуулсан.

Хүний нөөц, боловсон хүчний хангалтыг сайжруулахаар СУИС-ийн Соёлын сургуульд 3 номын санчийг эчнээгээр сургаж мэргэшүүлж байна.

Номын сангийн хамт олон ОХУ-ын Буриад улсын Улаан-Үүд хот, Сэлэнгэ аймгийн номын сангуудаар туршлага судлах аялалыг зохион байгуулсан.

“Номын санч” мэргэжил сурталчилах өдөрлөгийг уламжлал ёсоор зохион байгуулсан.

Улсын хэмжээнд зохион байгуулсан бүх нийтийн эрүүл мэндийг дэмжих “Цаг гаргая” аянд хамт олноороо идэвхтэй оролцож аймагтаа Тэргүүн байр эзэлсэн.

Ажиллагсадын дунд үндэсний бичиг, “Чанга шивнээ” тэмцээн зохион байгуулж жилийн ажлаа дүгнэлээ.

3.УНШЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ

Уншигч: 2648 байнгын 2648, шинэ 1409 байна.

Ирэгсэд: 18035

Ном олголт: Нийт олгосон 16187. Үүнээс ном-15877**,** тогтмол хэвлэл 310

Уншлагын танхимаар 11745, гэрээр 2143 , зөөврөөр 2299 байна.

Ном хангамж: $\dfrac{\text{НФ-37256}}{\text{У-2648}}$ **= 140**

Ном уншилт: $\dfrac{\text{НО-16187}}{\text{У-2648}}$ **= 6,1**

Фондын эргэлт: $\frac{\text{НО-16187}}{\text{НФ-37256}}$ **= 43,4%**

2013-2023 оны уншигч, ирэгсэд, ном олголтын тоон үзүүлэлтийг харуулав



4.ЯВУУЛЫН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

47 газарт 208 удаа 697 уншигч, 3971 ирэгсэдэд 2332 номоор үйлчилсэн.

2015-2023 оны нүүдэл, зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэсэн тоон үзүүлэлт

№	Байгууллага	Он сар өдөр	Уншигч	Ирэгсэд	Ном олголт	нийт очсон тоо	үзэсгэл энгийн ном	Хэн хариуцсан
1	Булган сум	3/24/2023	12	58	22	3	65	Долгор
2	ХХААГ	3/29/2023	7	10	23	2	70	Долгор, Цэндмаа
3	Музей	6/13/2023	7	30	60	5	55	Долгор, Цэндмаа
4	Статистик	6/13/2023	6	10	10	2	51	Долгор, Цэндмаа
5	Аудит	6/19/2023	6	15	13	3	63	Долгор, Цэндмаа
6	СУГ	6/13/2023	6	20	7	4	65	Долгор, Цэндмаа
7	ШШГ	6/20/2023	7	10	6	2	58	Долгор, Цэндмаа
8	Хурдан төв	6/19/2023	4	12	8	4	65	Долгор, Цэндмаа
9	ХХҮГ	6/26/2023	6	20	6	2	58	Долгор
10	ШШГГ	1/9/2023	50	636	322	20	322	Долгор
11	Орхон сум	11/8/2023	25	47	82	1	78	Долгор
12	Хутаг-Өндөр сум	11/17/2023	5	20	35	1	28	Долгор
13	Тэшиг сум	8/8/2024	5	50	63	1	50	Долгор
14	Бүрэгхангай сум		6	32	39	1	32	Долгор
15	3-р сургууль		20	46	51	2	43	Долгор
16	6-р баг зун	6/26/2023	6	70	25	4	120	Долгор
17	5-р баг зун	6/21/2023	10	70	29	4	120	Долгор
18	Тайлбай дээр	6/20/2023	3	130	52	1	40	Долгор, Цэндмаа
19	Эрүүл мэндийн газар	11/16/2023	10	24	18	2	60	Долгор
20	Цагдаагийн газар	10/11/2023	12	50	12	1	52	Долгор
21	Шүүхийн тамгын газар	3/10/2023	5	18	5	1	26	Долгор
22	6-р баг хурал	11/5/2023	6	20	6	1	15	Долгор

23	Тагнуул	10/9/2023	9	30	15	6	120	Отгонцэцэг
24	ГБХЗГ	10/10/2023	5	30	15	6	120	Отгонцэцэг
25	Мал эмнэлэг	4/11/2023	7	50	44	7	140	Ариунжаргал
26	Нийгмийн даатгал	4/11/2023	10	27	16	3	80	Ариунжаргал
27	Ханжаргалант	4/12/2023	29	92	106	22	250	Мөнхгэрэл
28	Нэгдсэн эмнэлэг	4/18/2023	12	86	64	10	200	Мөнхгэрэл
29	ХЖТ	4/21/2023	44	195	180	19	350	Энхбилэг
30	ИТХ	6/12/2023	1	10	20	3	70	Энхбилэг
31	Онцгой	11/7/2023	5	57	6	2	45	Ариунжаргал
32	Цагдаагийн газар	10/18/2023	4	80	28	2	100	Ариунбаяр
33	ХХҮГ	6/26/2023	6	9	3	1	40	Ариунбаяр
34	Бараан зах	11/6/2023	3	10	10	2	25	Мөнхгэрэл
35	Эмийн сан	11/1/2023	2	2	3	1	11	Ариунбаяр
36	Ахуйн үйлчилгээний газар	11/2/2023	2	3	5	2	20	Мөнхгэрэл
37	1-р цэцэрлэг	25/10/2023	27	79	4	3	4	Мөнхгэрэл
38	7-р цэцэрлэг	4/23/2023	64	512	16	8	4	Мөнхгэрэл
39	5-р цэцэрлэг	5/1/2023	49	147	9	3	4	Ариунжаргал
40	2-р цэцэрлэг	4/24/2023	68	154	6	3	4	Ариунбаяр
41	1-р баг зун	6/20/2023	6	64	75	4	100	Ариунбаяр
42	2-р баг зун	6/26/2023	16	81	77	5	85	Энхбилэг
43	3-р баг зун	6/20/2023	2	101	104	4	66	Мөнхгэрэл
44	4-р баг зун	6/26/2023	1	101	103	5	60	Ариунжаргал
45	6-р баг хурал	11/5/2023	5	20	6		15	Ариунбаяр
46	1-р баг хурал	11/5/2023		28		1	25	Ариунжаргал
47	2-р баг хурал	11/4/2023		27		1	30	Ариунжаргал
48	4-р баг хурал	11/4/2023		25		1	32	Ариунжаргал
49	3-р баг хурал	6/20/2023		30		1	20	Мөнхгэрэл
50	ЭӨЦС 4а анги	4/21/2023	23	67	67	3	67	Ариунбаяр
51	ЭӨЦС 3а анги	4/21/2023	38	111	111	3	111	Ариунбаяр
52	1-р 12 жил 7 б анги	10/10/2023	35	345	345	10	345	Отгонцэцэг
	нийт		**697**	**3971**	**2332**	**208**		

5.САН ХӨМРӨГ БҮРДҮҮЛЭЛТ

2023 онд нийт 397 нэр төрлийн 584 ширхэг 9,274,152 төгрөгний номоор фонд баяжилт хийсэн. Үүнээс улсын төсвөөс худалдаагаар 284 нэр төрлийн 457 ширхэг 6,814,752 төгрөгний, бэлгээр 86 нэр төрлийн 100 ширхэг 1,867,900 төгрөгний номоор, 8 нэр төрлийн 25 ширхэг сонин, 2 нэр төрлийн 2 ширхэг сэтгүүл 591,500 төгрөгний 15 удаа орлого авсан байна. Шинээр баяжилт хийсэн ном хэвлэлийн 100% данс бүртгэл, програмд оруулж уншлага үйлчилгээнд гаргасан. 2023 онд сан хөмрөгөөс элэгдэж муудсан уншлагад гаргах боломжгүй эрүүл ахуйн шаардлага хангахгүй хуучин ном

хэвлэлийг акталж цэгцлэх ажлыг эхэлж 977 ширхэг 477,715 төгрөгний үнэ бүхий номыг акталж данс бүртгэлээс хассан.

Н



6.САН ХӨМРӨГИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Мэргэжлийн байгууллагаар 1 удаа ариутгал, 2 удаа шавьж устгал хийж 110,000 төгрөгний төсөв зарцуулсан.

Сан хөмрөгт олон жил хадгалагдан элэгдэж муудсан уншлагад гаргах боломжгүй эрүүл ахуйн шаардлага хангахгүй хуучин ном хэвлэлийг акталж цэгцлэх ажлыг үргэлжилж байна.

Сан хөмрөг, уншлагын танхимуудын ойрын фондын ээлжит бус тооллогыг хийж тооллогоор дутсан ном хэвлэлийг холбогдох ажилтнаар төлүүлэх ажил хийгдэж байна. Үүнд:

- Сан хөмрөгөөс үрэгдүүлсэн 264 номоос 220 номыг алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх журмын дагуу төлүүлж “Үрэгдүүлсэн номын бүртгэл” маягтад бүртгэн авлаа.
- Гэрээр ном олгох танхимаас үрэгдүүлсэн 100 номыг алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх журмын дагуу төлүүлж “Үрэгдүүлсэн номын бүртгэл” маягтад бүртгэн авлаа.
- 2023 оны ээлжит бус тооллогоор дутсан номоос 28 номыг алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх журмын дагуу төлүүлж “Үрэгдүүлсэн номын бүртгэл” маягтад бүртгэн авлаа.

Нийт 396 номыг сэлбэн зассан.

- Сан хөмрөг, Гэрээр ном олгох танхим- 50
- Хүүхдийн уншлагын танхим- 272
- Нийтийн уншлагын танхим- 74

7. ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

Нийт 1680 лавлагаа өгөгдсөн. Үүнээс чанартай лавлагаа 1076, амаар 614, утас, цахимаар 373, бичгээр 89 байна. Өгөгдсөн лавлагаа заал танхим бүрээр дэлгэрэнгүйг дор харуулав. Өгөгдсөн лавлагааны тоо багассан нь лавлагааны бүртгэлийг бүртгэхдээ үйлчлүүлэгчийн асуусан сэдэв, агуулгын хүрээнд хайлт хийж хугацаа орж хариулсан лавлагааг бүртгэдэг болсонтой холбоотой. /1-р улиралд энгийн богино хугацаа орсон 604 лавлагаа байгааг бүртгэлд оруулаагүй болно./

БШСУ-ны сайдын 2005 оны 441 дүгээр тушаалын 11 дүгээр хавсралтаар батлагдсан "Өгөгдсөн номзүйн лавлагааны бүртгэл"-ийн маягтыг орчин цагийн үйлчилгээний стандартад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

- ✓ Хүүхдийн уншлагын танхим-187 /Үүнээс амаар 161, цахимаар, утсаар 26/
- ✓ Нийтийн уншлагын танхим-268 /Үүнээс амаар 244, цахимаар, утсаар 24/
- ✓ Гэрээр ном олгох танхим-45 /Үүнээс амаар 44, цахимаар, утсаар 1/
- ✓ Сан хөмрөг -39 /Үүнээс амаар 33, цахимаар, утсаар 6/
- ✓ Удирдлага -188 /Үүнээс амаар 21, цахимаар, утсаар 167/
- ✓ Арга зүйч 349 /Үүнээс амаар 111, цахимаар, утсаар 149, Бичгээр 89/ үүнээс номын санчдад 434 лавлагаа өгөгдсөн байна.

8. ТАТГАЛЗАЛ:

Нийт 129 ном татгалзалд бүртгэгдсэн. 129 татгалзлаас бусад танхимаас олж хаасан 20, бүрдүүлэлтээр 25 ном худалдан авч хариулсан.

- Хүүхдийн уншлагын танхим- 12, хариулсан 8
- Нийтийн уншлагын танхим- 88, хариулсан 25
- Гэрээр ном олгох танхим-17, хариулсан 3
- Бусад танхим-12, хариулсан 9

Татгалзлын бүртгэлд байнга бүртгэгддэг, хүрэлцдэггүй, чухал гэсэн 25 номоор бүрдүүлэлт хийлээ.

№	Номын нэр
1	Хэрсүү охины өдрийн тэмдэглэл 1-9
2	Харри Поттер цуврал 1-7
3	Санхүүч хэрэм цуврал
4	Ач тусын тухай үлгэрүүд цуврал
5	Гэсэр хүүхдэд зориулсан хялбаршуулсан зохиол
6	Хичээлийн тулгуур лавлах 1-9 цуврал
7	Математикийн 6000 тест
8	Органик химийн дасгалын хураамж
9	Оройгүй сүм
10	Нил ягаан /secret-1,2/
11	Ардын зан үйл аж төрөх арга ухаан
12	Монголын уламжлалт аж төрөх ёсон
13	Ургийн бичиг хөтлөх /товч зөвлөмж/
14	Эх урийн судар
15	Үрийг хүмүүжүүлэх судар
16	Бие сэтгэлийн билгийн рашаан 4,5
17	Платон
18	Сэрэлт бясалгал багц ном
19	Нийгмийн сэтгэл судлал ба сэтгэл зүйн зөвлөгөө
20	Гэр бүлийн сэтгэл судлал
21	Харилцааны сэтгэл судлал
22	Дүүлэн нис
23	Кофе хөрөхөөс өмнө
24	Цагаан бээлий
25	Мэргэжил: Ирээдүйгээ төлөвлөхөд туслах хамгийн шилдэг хөтөч

9. МЭРГЭЖИЛ АРГАЗҮЙ

2023 онд 14 сумын номын сантай танилцаж 20 номын санчид биечлэн мэргэжил арга зүйгээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Нийтдээ номын санчдад 434 удаа лавлагаа мэдээлэл хүргэж ажиллаа.

Дотоодоос зохион байгуулсан сургалтууд:

- Бүх нийтийн соёлын боловсрол сургагч багш бэлтгэх сургалтын үеэр танхимаар сумын 14 номын санчид Номын сангийн хууль, дүрэм, стандарт, Анхан шатны бүртгэл хөтлөлт, СОНА зохион байгуулах тухай мэдээлэл сургалтыг арга зүйч Ч.Цэндмаа хийсэн.
- Соёлын сэргэлт 2023 аяны хүрээнд Могод, Хишиг-Өндөр, Гурванбулаг, Рашаант, Баяннуур, Дашинчилэн, Бүрэгхангай, Орхон, Бугат, Сэлэнгэ, Хялганат, Хангал, Тэшиг, Хутаг—Өндөр зэрэг 14 сумын, сургуулийн 6 номын санчдад биечлэн номын сангийн өдөр тутмын бүртгэлүүд хөтлөх, номын ангилал, фонд зохион байгуулалт, СОНА зохион байгуулах зэрэг мэргэжил арга зүйн зөвлөгөөг захирал Т.Мөнгөнтуяа, арга зүйч Ч.Цэндмаа нар өгч ажилласан.
- Цахим уулзалт зөвлөмжийг 2 удаа зохион байгуулж нийт сум, сургуулийн 25 номын санч хамрагдсан.
- Арга зүйн зөвлөмж яриатай видео, лавлагаа, татгалзлын зөвлөмж, уншигчийн карт, лавлагаа, татгалзлын маягт, нэгдсэн бүртгэл бүртгэх жишээ маягт цахимаар албан имэйлүүдрүү давхардсан тоогоор 75 удаа хүргэсэн.

Гаднаас зохион байгуулсан сургалтууд: Нийт 5 удаа, танхим 3, цахим 2 сургалт авсан. Үүнд:

- "Хил хязгааргүй номын сан" төслийн сургалтад 9 номын санч хамрагдсан.
- Булган аймгийн Рашаан суманд аймгийн соёлын байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулсан сургалт, тэмцээнд аймгийн төвийн 9, сумаас 15 номын санч танхимаар хамрагдсан.
- Номын сангийн Коха программын 2 өдрийн цахим сургалтад 9 номын санч
- Соёлын сэргэлт 2023 "Номын санчдын сургалт"-ыг Хүүхдийн номын ордны хэлтсийн дарга С.Тунгалаг аймаг сумын 20 номын санчид өгсөн.
- "Mongolian library update-2023" Номын санч-Мэдээллийн ажилтнуудын улсын Х зөвлөгөөн, сургалт мэдээлэлд арга зүйч Ч.Цэндмаа танхимаар, аймгийн 21 номын санч цахимаар хамрагдсан.

10.НОМЗҮЙ

Шинээр нэмэгдсэн 584 ширхэг ном хэвлэлийг анхан шатны бүртгэлд тусган техник ажиллагааг хийж, цахим каталогт оруулж заал танхимуудад хувиарлан уншлагананд гаргасан.

Монголын уран зохиолын товчоон I-IX боть, УДНЭ I-XII цуврал номын номзүйн гарын авлага гаргасан. Хуучны Монгол бичгээр байгаа ховор номын санамж өгөх номзүйн гарын авлага, зохиолч З.Доржийн зохиол бүтээлийн санамж өгөх номзүйн гарын авлага тус тус гаргасан.

Өв соёл, танин мэдэхүйн сэдэвт 14 номыг QR кодоор танилцуулга хийж цахимд байршуулсан.

11. КАТАЛОГ

Манай цахим каталогийн bulgan.lib4u.net хаягаар 6701 удаа уншигч, хэрэглэгчид хайлт хандалт хийсэн байна. Манай электрон каталогт 16,489 төрлийн 37,256 ширхэг материал бүртгэгдсэн байна.





12. НОМЫН ҮЗЭСГЭЛЭН, СУРТАЛЧИЛГАА

71 удаа 3952 ширхэг номоор танхимаар болон цахимаар үзэсгэлэн гаргаж 10218 хүн үзсэн.

№	Номын үзэсгэлэнгийн нэр	Үзэсгэлэн гаргасан номын тоо	Эхэлсэн Огноо /тоо хооронд ташуу зураас авах/	Дууссан Огноо /тоо хооронд ташуу зураас	Хаана	Үзсэн хүний тоо танхимаар	Цахимаар	Хариуцсан ажилтан гарын үсэг
1	Шинэ номын үзэсгэлэн	40	9/15/2023	9/16/2023	соёлын ордон	200		Ариунбаяр
2	Дэлхийн болон Монголын уран зохиолууд	35	1/16/2023	1/22/2023	ХУТ танхим, цахим	18		Б.Ариунжаргал
3	Шинэ номын үзэсгэлэн	30	2/3/2023	3/5/2023	ХУТ танхим, цахим	113		Б.Ариунжаргал
4	Цуврал номын үзэсгэлэн	21	3/6/2023	3/27/2023	ХУТ танхим, цахим	775		Б.Ариунжаргал
5	Аман зохиолын цуврал номоор	35	3/28/2023	4/3/2023	ХУТтанхим	150		Б.Ариунжаргал
6	Эх хэлний өдөрт	23	8/31/2023	9/24	ХУТ танхим, цахим	596		Б.Ариунжаргал, Д.Мөнхгэрэл
7	Бүтээлч уншлага нээлтийн үйл ажиллагаа	120	3/15/2023	3/15/2023	соёлын төв	200		Б.Ариунжаргал, Д.Мөнхгэрэл
8	Хуучин номын үзэсгэлэн худалдаа	150	3/15/2023	3/16/2023	Соёлын ордон	200		Баасансүрэн, Алтанцэцэг
9	Номын баярт зориулан Ханддорж талбайд	88	5/19/2023	5/19/2023	хут задгай талбайд	200		Б.Ариунжаргал, Д.Мөнхгэрэл
10	Шинэ номын үзэсгэлэн	70	1/2/2023	1/8/2023	НУТ танхим, цахим	43	18	Г.Энхбилэг
57	Үндэсний их баяр наадам сэдэвчилсэн	45	7/7/2023	7/17/2023	НУТ танхим	20		М.Ариунбаяр
58	Номын баярт зориулан Ханддорж талбайд	115	5/19/2023	5/19/2023	Үндсэн фонд	200		Ц.Долгор
59	"Нээлттэй Булган-Ээлтэй нутаг" өдөрлөг	40	6/20/2023	6/21/2023	Цогт хун тайжийн талб	80		Ц.Долгор
60	Эх хэлний өдөр	43	29/08/2023		Үндсэн фонд НУТ тан:	30		Ц.Долгор
61	Гүн ухааны номын үзэсгэлэн	36	9/25/2023	10/25/2023	ХУТ	135	631	,Б.Ариунжаргал
62	**Утга уран зохиол**	**57**	10/12/2023		ХУТ	256		Д.Отгонцэцэг
63	Утга уран зохиол	82	10/12/2023	10/26/2023	НУТ	513	507	Г.Энхбилэг
64	Адал явдалт - Уран зөгнөл	88	10/27/2023	11/3/2023	НУТ	231	226	Г.Энхбилэг
65	Лавлах болон Түүхэн уран зохиол	22	10/25/2023	11/1/2023	ХУТ	85		Д.Мөнхгэрэл
66	**шинэ номын үзэсгэлэн**	**30**	10/30/2023	11/6/2023	ХУТ	98	102	Б.Ариунжаргал
67	Шинэ номын үзэсгэлэн/ Аман зохиол-15, Уран зохиол-11	26	11/12/2023	11/27/2023	ХУТ	330		Д.Мөнхгэрэл
68	**Улс тунхагласны өдөр үзэсгэлэн**	**72**	21/11/2023	27/11/2023	НУТ	200		Д.Отгонцэцэг
69	**шинэ номын үзэсгэлэн**	**32**	11/7/2023	11/12/2023	ХУТ	18		Б.Ариунжаргал
70	**амьтадын тухай**	**18**	11/28/2023	12/15/2023	ХУТ	110		Б.Ариунжаргал
71	**3,4-р баг**	**131**	6/20/2023	6/30/2023	ХУТ	202		Б.Ариунжаргал Д.Мөнхгэрэл
	НИЙТ	3952				10218	2598	

13. СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ

Номын сангаас Бүх нийтийн соёлын боловсрол олгох “Монгол хүний эрхэмлэх үнэт зүйл”, “Номын соёлт ертөнц” сэдэвт сургалтыг иргэдийн дунд 18 удаа зохион байгуулж, бусад 42 сургалтад ажилтан албан хаагчид хамрагдсан. Нийт 1334 хүн хамрагдсан. Манай өөрийн номын санчид мэргэжлийн чиглэлийн танхимаар 4, цахимаар 2 сургалтад хамрагдлаа. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулав.

№	Сургалтууд	Номын сангаас зохион байгуулсан сургалт хамтран ажилласан	Огноо /тоо хооронд ташуу зураас авах/	Оролцсон хүний тоо	Хаана болсон	Огноо /тоо хооронд ташуу зураас авах/	Оролцсон хүний тоо
1	ОБГ-аас галын аюулгүй байдлын дадлага сургалт				ОБГ, АТНС	1/2/2023	10
2	Татварын хэлтэсээс сургалт				НУТ	1/26/2023	8
3	ЦГ-аас цахим гэмт хэргээс сэргийлэх сургалт				МТ	2/3/2023	9
4	ТАХ-ын 4:7:10 цахим сургалт				Цахимаар	2/9/2023	1
5	"Хил хязгааргүй номын сан" төслийн сургалт /Төслийн багийн хамт олон сургагч багш МНСХ-ны тэргүүлэгч М.Даваасүрэн, МҮНС-ын албаны дарга Г.Гүнжинлхам/				НУТ	2/14/2023	14
6	ХШҮ-ны нэгдсэн системийн сургалт				АЗДТГ	2/16/2023	2
7	2023 оны 01 сарын 01-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль эрх зүйн талаар АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн ХТСДАжилтан С.Амар				АТНС Мэдээлэл арга зүйн танхим	2/10/2023	8
8	Нийгмийн даатгалын багц хуулийн хэлэлцүүлэг, сургалт				ХЖТ	3/9/2023	2
9	Үгийн бичгийн сургалт				МАЗТ	3/15/2023	10
10	Булган аймгийн соёлын байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, тэмцээн-Рашаант				СУГ, Соёлын төвүүд	2023/03/30-04	9
11	БНСБ-ын сургалт	БНСБ-ын сургалт	3/31/2023	140	Рашаант сум, Булган аймгийн Соёлын ажилтнууд		9

№	Сургалтууд	Номын сангаас зохион байгуулсан сургалт хамтран ажилласан	Огноо /тоо хооронд ташуу зураас авах/	Оролцсон хүний тоо	Хаана болсон	Огноо /тоо хооронд ташуу зураас авах/	Оролцсон хүний тоо
48	ТАХ-ын 4:7:10 цахим сургалт /Аз жаргалтай ажлын байр стресс менежмент/				Цахимаар	11/2/2023	8
49	БНСБ-ын сургалт "Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл"	3-р багийн иргэдэд	11/1/2023	32	Булган сумын ЗДТГ-ын зааланд		
50	БНСБ-ын сургалт "Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл"	6-р багийн иргэдэд	11/5/2023	43	6-р багийн хөгжлийн төв		
51	БНСБ-ын сургалт "Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл", Өвлөн уламжлагч ардын авьяастан Х.Мөнхбаатар "Бүтээл төрөх агшин" гэрэл ташуур бүтээх	Соёлын ордонтой хамтран ЭӨЦС-ийн ахлах ангийнханд	11/2/2023	110	ЭӨЦС-ийн урлагийн заал		
52	"Ном соёлын ертөц" сургалт, мэдээлэл	Булган сум	11/2/2023	25			
53	"Номын соёлт ертөнц" сургалт, мэдээлэл	1-р багийн иргэд	11/5/2023	28			
54	"Номын соёлт ертөнц" сургалт, мэдээлэл	2-р багийн иргэд	11/4/2023	27			
55	"Номын соёлт ертөнц" сургалт, мэдээлэл	4-р багийн иргэд	11/4/2023	25			
56	"Номын соёлт ертөнц" сургалт, мэдээлэл	Булган сумын ЗДТГ-ı	11/3/2023	25			
57	Булган аймгийн 2022 оны төсвийн гүйцэтгэл 2023 ОНХС-гаас хийгдсэн ажлын хэлэлцүүлэг				АЗДТГ 107 тоот	11/8/2023	1
58	ТЗУХ, ТАСЗ-өөс зохион байгуулсан ТАХ-ын ёс зүйн сургалт				АЗДТГ 107 тоот	11/15/2023	5
59	БНСБ-ын сургалт "Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл"	Ахмад багш нарын х	11/17/2023	30	Ахмадын өргөө		
60	Номын сангийн мэргэжлийн онцлог, давуу тал, Номын соёлт є	1,2-р сургууль	10/17/2023	149	НУТ		
61	Дижитал номын сангийн сургалт				Цахимаар	11/21/2023	6
62	ТАХ-ын 4:7:10 Монгол улсын тусгаар тогтнол ба Богд хаан				Цахимаар	11/23/2023	2
63	Тусгаар тогтнол бие хүний үнэт зүйл				ХЖТ	11/26/2023	3
64	Монгол бичгийн цахим бичвэрийн сургалт				АЗДТГ 107 тоот	11/29/2023	1
65	Архивын сургалт				АЗДТГ 107 тоот	11/30/2023	1
	Нийт			**1334**			**239**

14. СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ

Номын сангаас 2023 онд 102 соёл олон нийтийн ажлыг зохион байгуулж 13575 хүн оролцсон байна. Соёл олон түмний ажлын дэлгэрэнгүй хүснэгтийг дор оруулаа.

№	Зохион явуулсан ажлын нэр	Хамтран ажилласан байгууллага	Огноо /тоо хооронд ташуу зураас авах/	Оролцсон хүний тоо	Хариуцсан ажилтан гарын үсэг
1	Танилцах аялал	ЭӨЦС-ийн 7г анги	2/2/2023	33	Г.Энхбилэг
2	Танилцах аялал	ЭӨЦС-ийн 9а анги	2/2/2023	26	Г.Энхбилэг
3	"Би ирээдүйд хэн болох вэ?" чөлөөт ярилцлага	ЭӨЦС-ийн 7г анги	2/3/2023	29	Г.Энхбилэг
4	"АХА" танин мэдэхүйн тэмцээн	ЭӨЦС-ийн 7г анги	2/4/2023	33	Б.Эрдэнэцаралт
5	"Ном сэлбэн засах" техник ажиллагаа, дадлага ажил	ЭӨЦС-ийн 7г анги	2/5/2023	33	Г.Энхбилэг
6	"Цаг төлөвлөлтийг хэрхэн гаргах вэ?" чөлөөт ярилцлага	ЭӨЦС-ийн 9а анги	2/10/2023	21	Г.Энхбилэг
7	Танилцах аялал	ЭӨЦС-ийн 12в анги	2/10/2023	33	Г.Энхбилэг
8	"АХА" танин мэдэхүйн тэмцээн	ЭӨЦС-ийн 9а анги	2/11/2023	32	Г.Энхбилэг
9	"Миний мэргэжил?" чөлөөт ярилцлага	ЭӨЦС-ийн 12в анги	2/11/2023	12	Г.Энхбилэг
10	"Ном сэлбэн засах" техник ажиллагаа, дадлага ажил	ЭӨЦС-ийн 9а анги	2/12/2023	32	Г.Энхбилэг
11	"АХА" танин мэдэхүйн тэмцээн	ЭӨЦС-ийн 12в анги	2/12/2023	26	Г.Энхбилэг
12	"Чанга шивнээ" хөгжөөнт, цэнгээнт тэмцээн	ЭӨЦС-ийн 9а анги, 1-р 12 жил 9б анги,	2/13/2023	123	Г.Энхбилэг
13	"Ном сэлбэн засах" техник ажиллагаа, дадлага ажил	ЭӨЦС-ийн 12в анги	2/13/2023	27	Г.Энхбилэг
14	"Цагаан сар-Өв уламжлал" гар зургийн уралдаан	7-12-р анги	2/18/2023	14	Г.Энхбилэг, Б.Эрдэнэцаралт
15	**Номтой нөхөрлөгч эмэгтэйчүүд эвент**	Булган сумын соёлын ордон	3/7/2023	14	Ч.Цэндмаа
16	**Хүүхдийн бүтээлч уншлага жилийн аяны нээлт**	Булган сумын соёлын ордон	3/15/2023	500	Номын санчид
17	**Бүтээлч ном урлан бүтээх уралдаан**		3/21/2023	10	Ч.Цэндмаа
44	АХА тэмцээн	Рашаант 4-р баг	2023/06/28	9	ХУТ
45	Оньсон тоглоом болон эээдрээ тайлах тэмцээн	Рашаант 4-р баг	2023/06/28	9	ХУТ
46	Үндэсний бичгээр 3 төрөлт "ТАТАТУНГА" хөгжөөнт тэмцээн	Аймгийн Музей	2023/06/23	6	Ц.Долгор, Ч.Цэндмаа
47	Үндэсний бичгээр 2 төрөлт "ТАТАТУНГА" хөгжөөнт тэмцээн	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	7/5/2023	4	Ц.Долгор, Ч.Цэндмаа
48	"Уугийн бичиг хөтлөх нь" мэдээлэл сургалт	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, СУ	7/5/2023	4	Ц.Долгор, Ч.Цэндмаа
49	Оньсон тоглоом	4-р баг	6/27/2023	9	Д.Мөнхгэрэл, Б.Ариунжаргал
50	АХА тэмцээн	Тэшиг суман дахь хилийн 236 дугаар ан	8/7/2023	10	Ч.Цэндмаа, Д.Мөнхгэрэл,
51	Үндэсний бичгээр 2 төрөлт "ТАТАТУНГА" хөгжөөнт тэмцээн	Тэшиг суман дахь хилийн 236 дугаар ан	8/7/2023	10	Ч.Цэндмаа, Д.Мөнхгэрэл,
52	Монгол тоглоом тэмцээн	Тэшиг сумын Харгал багийн иргэд, хүүх	8/8/2023	10	Ч.Цэндмаа, Д.Мөнхгэрэл,
53	Ангийн номын сан, гэрийн номын сан сурталчилах өдөрлөг	1-р 12 жил 12в анги хамт олон, багш	9/7/2023	25	Г.Энхбилэг
54	**Намрын 34 дэхь удаагийн "Үндэсний бичиг үсэг, Ном соёлын өдрүүд" -**	Соёлын ордон, Музей	9/15/2023	500	Номын санчид
55	**Намрын 34 дэхь удаагийн "Үндэсний бичиг үсэг, Ном соёлын өдрүүд" -**	Соёлын ордон, Музей	9/16/2023	300	Номын санчид
56	**Монгол тоглоом үзэсгэлэн, сурталчилгаа тэмцээн**		9/15/2023	50	Д.Мөнхгэрэл, Цэндмаа
57	**Номын хэлэлцүүлэг**		9/16/2023	10	Цэндмаа
58	**"Номын амт" сугалаа**		9/15/2023	330	номын санчид
59	**"Бийрэн бичлэг" үзүүлэх сургалт**		9/15/2023	20	Цэндмаа
60	**"Хуруун хүүхэлдэй"**		9/15/2023	20	Долгор, Ариунбаяр

№	Зохион явуулсан ажлын нэр	Хамтран ажилласан байгууллага	Огноо /тоо хооронд ташуу зураас авах/	Оролцсон хүний тоо	Хариуцсан ажилтан гарын үсэг
88	Түргэн хэллэг хэн сайн унших вэ	1-р сургууль 7б	11/24/2023	15	Д.Отгонцэцэг
89	Аман зохиолоор тэмцээн баг болгоод	1-р сургууль 7б	11/24/2023	30	Д.Отгонцэцэг
90	Д.Нацагдоржийн уран бүтээлийн цэнгүүн	Ахмад багш нарын холбоо	11/17/2023	30	Т.Мөнгөнтуяа, Ч.Цэндмаа, Ц.Долгор
91	Гэр бүлийн уулзалт		10/17/2023	12	
92	Номын сангийн мэргэжил сурталчилах эвент	СУГ, 1,2-р сургуулийн 12-р ангийн	11/17/2023	149	Т.Мөнгөнтуяа, Ч.Цэндмаа, Г.Энхбилэг,
93	Чанга шивнээ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	10/26/2023	6	Ц.Долгор, М.Ариунбаяр
94	АХА тэмцээн	Аймгийн Музей	2023/10/16	9	Ц.Долгор, М.Ариунбаяр
95	Чанга шивнээ	Булган цагдаагийн газар	11/1/2023	20	Ц.Долгор, М.Ариунбаяр
96	Чанга шивнээ	Булган сумын тамгын газар	11/2/2023	8	Ц.Долгор, М.Ариунбаяр
97	БНСБ-ыг дээшлүүлэх "Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл"	6-р багийн дарга	11/5/2023	43	Ц.Долгор, Д.Баасансүрэн
98	Та та тунгаа хөгжөөнт тэмцээн	Булган Эрүүл мэндийн газар	12/1/2023	6	Ц. Долгор
99	АХА тэмцээн	1-р сургууль 7а анги	11/21/2023	29	Б.Ариунжаргал
100	"Уламжлалаараа уралдъя" тэмцээн	ЭӨЦС, 1-р сургуулийн 12-р ангиуд	11/21/2023	84	Номын санчид
101	Чанга шивнээ	1-р сургууль 7а анги	11/23/2023	28	Б.Ариунжаргал
102	"Тунамал туурвил" хөрөг нэвтрүүлгийн зураг авалт, уншигч зохиолчдын	Сайхан Монгол ТВ, Баян-Агт сумын Соё	11/24/2023	30	Т.Мөнгөнтуяа
	НИЙТ			13575	

15. ШИНЭЛЭГ АЖИЛ:

1. **“Өглөөний уншлага” 2023 аян:** Насанд хүрэгчдийг номтой нөхөрлүүлэх, ном унших дадал хэвшлийг нэмэгдүүлэх, албан байгууллагуудад зөөвөр явуулын номын сангийн үйлчилгээг хүргэхэд оршино.
2. **“Булган бахархал”**-ын өдрийг угтан Булганы бахархал сэдэвт **“Бүтээлч ном урлан бүтээх”** уралдаан тэмцээнийг зохион байгуулсан.
3. ОУ-ын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан **“Номтой нөхөрлөгч эмэгтэйчүүд”** эвент арга хэмжээ
4. **“Үлгэрийн театрчилсан хүүхэлдэй”** урлаж бодитоор болон цахимаар СӨБ болон бага ангийн хүүхдүүдэд сонирхуулсан.
5. **“Зохиолын баатрууд амилсан”** маскот**:** Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр номын санчид үлгэрийн баатруудын дүрд хувирч соёл олон нийтийн ажлаа зохион байгуулсан нь хүүхэд багачуудын сонирхолыг маш их татсан.
6. **"Тунамал туурвил" хөрөг нэвтрүүлгийн зураг авалт, уншигч зохиолчдын уулзалт”** телевизийн нэвтрүүлэг: Булган аймгийн Баян-Агт сумын яруу найрагч, малчин, өрхийн үйлдвэрлэгч А.Ужимбуурал, зохиолч яруу найрагч агсан Л.Ганзул нарын уран бүтээлийг сурталчилах зорилгоор Сайхан Монгол ТВ, ХЖТ-тай хамтран зохион байгуулсан.
7. **“Мэргэжил сурталчилах” арга хэмжээг** ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагчдын дунд нэгдсэн байдлаар зохион байгуулсан.
8. **“Уламжлалаараа уралдъя”** монгол тоглоом наадгай сурталчилах үзэсгэлэн гаргаж, сурагчдын дунд тэмцээн зохион байгуулав.
9. **“Урлан бүтээхүй”** хүүхдийн чөлөөт цаг, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх зорилготой дугуйланг хүүхдийн уншлагын танхимын дэргэд явуулж эхэлсэн.

10. **“Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл”, “Өв соёлоосоо суралцья”, “Номын соёлт ертөнц”** сургалтуудыг 18 удаа сурагчид болон иргэдийн дунд зохион байгуулсан.

АМЖИЛТУУД:

- “Цаг гаргая” 2023 аяны биеийн тамир спортын арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлуудад хамт олноороо идэвхтэй хамрагдаж “Шугаман бүжиг”, “Ажлын байрны дасгал хөдөлгөөн”, “Явган аялал” гэсэн төрөлд амжилттай оролцож Тэргүүн байр эзэлсэн.
- Булган аймгийн нийтийн номын сангийн захирал Т.Мөнгөнтуяа 2023 оны аймгийн Соёлын салбарын “Шилдэг удирдлага”-аар шалгарсан.

16. 2024 ОНД ШИНЭЭР ХИЙХ АЖЛУУД:

- “Гэр бүлийн уншлагыг дэмжье” аян өрнүүлэх
- Шинэ барилгын ажил эхлэх бэлтгэл ажил хийгдэнэ
- “Үндэсний бичиг, соёлын жил”-ийн хүрээнд соёл гэгээрлийн ажлууд зохион байгуулах

17. ХҮНИЙ НӨӨЦ, БОЛОВСОН ХҮЧИН

Булган аймгийн Нийтийн номын сан нь захирал, арга зүйч, сан хөмрөгч, номын санч 4, нягтлан бодогч, сахиул, үйлчлэгч гэсэн 10 орон тоотой ажиллаа. 2 мэргэжлийн номын санч, 4 мэргэжлийн бус номын санч байна. Номын санч Д.Мөнхгэрэл, Д.Отгонцэцэг, Г.Энхбилэг, Б.Ариунжаргал нар СУИС-ийн Соёлын сургуульд эчнээгээр суралцаж байна. АННС-ийн ажиллагсад мэргэжлийн чиглэлээр танхимаар 4 сургалтад, цахимаар 2 сургалт, бусад чиглэлийн 42 сургалтад танхим ба цахимаар хамрагдаж мэдээлэл авсан.

Булган аймгийн хэмжээнд сумын 17 номын сан, 22 сургуулийн номын санд 39 номын санч ажиллаж байгаагаас 3 сум, 5 сургуулийн 10 буюу 20,0% нь мэргэжлийн номын санч байна.

АННС мэргэжлийн боловсон хүчин 7 ажилтан байхаас 3 мэргэжлийн 4 номын санч эчнээгээр суралцаж, боловсон хүчний хангалт 50%-тай байна.

18. ТӨСӨВ, САНХҮҮ

2023 онд улсын төсвийн санхүүжилт 246580.7, дээд шатны төсвөөс төсвийн байгууллагын өөрийн орлого 10859,0 орон нутгийн төсвийн санхүүжилт 33019,6 төгрөг нийт 290459,3 төгрөгний төсөвтэй ажиллаа.

1. Улсын төсвийн санхүүжилт орлого : 246580,7 /Хоёр зуун дөчин зургаан сая таван хаян мянган долоон зуун төгрөг/

    Үйл ажиллагааны зардал – 80101-186805,7

    Урсгал зардал -80802 – 26847,8

    Эрдэм шинэжилгээний ажлын зардалд-80215- 5000,0

    Нэмэлт дээд шатнаас - 83603 -210801 /Бусдаар гүйцэтгүүлэх ажиллагаа- 10859,0

    Гүйцэтгэл суурилсан санхүүжилт - 17068,2

2. Орон нутгийн төсвийн санхүүжилт орлого: 33019,6 / Гучин гурван сая нэг зуун тавин есөн мянга зургаан зуун төгрөг/

   Иргэд. Аж ахуй нэгж. ТББ -ын хандив – 2459,4 / Ном/

Зарлага: 282784,4/ Хоёр зуун наян хоёр сая долоон зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун төгрөг/

Цалин хөлс,нэмэгдэл, урамшуулал – 163045,8

НДШ – 20727,5

Хангамжийн бараа -7365,3

Нормын хувцас - 11,3

Эд хогшил,урсгал засвар - 7460,0

Дотоод томилолт – 400,0

Бусдаар гүйцгүүлэх ажил үйлчилгээ – 16798,8

Бараа үйлчилгээний зардал - 4069,0

Эрдэм шинэжилгээний ажил - 4999,9

Нэг удаагийн тэтгэмж -766,0

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид -14655,3

Хөдөө орон нутгийн нэмэгдэл – 9854,3

Халаалт, Цэвэр ус, гэрэл цахилгааны зардал - 32631,8

Орон нутгийн төвлөрүүлэх шилжүүлэг -381,8

Дансны үлдэгдэл 7674,8 /Дөрвөн зуун арван зургаан мянга дөрвөн зүүн төгрөг/

2023 онд ажиллагсадын нийгмийн асуудлаар үр дүнгийн урамшуулал давхадсан тоогоор 32 хүнд 11679,0 мян.төг, түлээ, нүүрс, халаалтын зардлын хөнгөлөлт 2560,0 мян.төг олгогдсон байна.

Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ чухал шаардлагатай байгаа техник хэрэгслэлийг 2022 оны гүйцэтгэлийн санхүүжилтээр 6,827,0 мян.төгрөгний үнэ бүхий суурин компьютер-1, бичлэг хийдэг камер -1, Соёлын

сэргэлтийн үйл ажиллагааны зардлаас 3500,0 мян.төгрөгний явуулийн 2 асар, майхан, номын баяжилт худалдан авалт 6814,7, хандиваар 2459,4 мянган төгрөг, сандал – 219,9 зэрэгт 19821,0 мян. төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн.

Цагаан сар, ахмадын баяраар байгууллагын ахмадуудаа хүндэтгэл үзүүлэхэд 491,0 мян.төг төгрөг зарцуулсан байна.

19.БУСАД АЖИЛ

- “Визит Булган” цасны баярт байгууллага хамт олноороо оролцсон.
- Бүх ажиллагсад эрт илрүүлэг эрүүл мэндийн үзлэгт 100% хамрагдсан.
- Булганчуудын бахархалын өдөрт зориулсан "САНСАР МАРАФОН-2023" гүйлтэд эмэгтэй 3000 м, 5000 м зайд амжилттай оролцсон.
- Улсын хэмжээний Команд штабын сургуулилтад бэлтгэл ханган өөрсдийн гараар аранз оёж, гадаа цуглах аюулгүйн тэмдэглэгээ хийн 1 удаа оролцлоо.
- ОБГ-ын хавар, намрын зарлан мэдээллэх дуут дохиогоор, дадлага сургуулилтад бэлтгэл хангаж 2 удаа хамрагдсан.
- Авто зам дагуух бүх нийтийн цэвэрлэгээнд цагдаагийн постноос цааш 800 м хуваарьт газраа 1 удаа цэвэрлэсэн.
- Үерийн даланг цэвэрлэх бүх нийтийн цэвэрлэгээнд нэгдэн хуваарьт газрын далангийн шарилж хогийг 1 удаа цэвэрлэсэн.
- “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сансар-2 цэцэрлэгт хүрээлэнд тарьсан модуудаа хавар, намар хуваарийн дагуу тогтмол усалгаа арчилгааг хийж байна.
- Цэвэр орчин Цэмцгэр Булган-Шарилжгүй Булган аянд нэгдэн байгууллгын 50м газрын хог шарилжийг 2 удаа цэвэрлэсэн.
- Өвлийн турш байгууллага орчмын нийтийн явган зам,
- Нийтийн эзэмшлийн авто замын хуваарьт газрын цасыг цэвэрлэсэн.

20. СУДАЛГАА

Үйлчилгээний чанар хүртээмж, үйлчлүүлэгчийн эрэлт хүсэлт, ном хэвлэлийн хүрэлцээ хангамжийг тандан судлах зорилгоор дараах сэтгэл ханамжийн судалгааг авч ажиллаа.

1. Сэтгэл ханамжийн судалгаа

Энэхүү судалгааны үр дүнд Нийтийн уншлагын танхим **/НУТ/**-ын үйл ажиллагааг сайжруулах, уншигчдын эрэлт хэрэгцээг хангах, зохион байгуулж байгаа СОНА-ын үр өгөөжийг нэмэгдүүлэх юм. ***Судалгаанд оролцогчийн:***

Нас: а. 18 нас хүртлэх б. 18-24 нас в. 25-36 нас г. 51ээс дээш

Хүйс: а. эрэгтэй б.эмэгтэй

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

1. Та Нийтийн уншлагын танхимаар үйлчлүүлдэг үү?
   а. Тийм б. Үгүй в. Заримдаа
2. Таны хэрэгцээт ном, хэвлэл, гарын авлага НУТ-д хүртээмжтэй байдаг уу?
   а. Хангалттай б. Хангалтгүй в. Хүртээмжийг нэмэгдүүлэх
3. НУТ-аас зохион байгуулж байгаа Соёл олон нийтийн ажил таны сэтгэлд нийцэж байна уу?
   а. Маш сайн б. Дунд зэрэг в. Оролцож байгаагүй г. Муу
4. НУТ-ын танд үзүүлж байгаа үйлчилгээнд үнэлгээ өгнө үү?
   а. Сайн б. Муу в. Үйлчилгээг илүү сайжруулах
5. Танхимын номын санчийн харилцаа, хандлага танд ямар санагддаг вэ?
   а. Сайн б. Дунд в. Муу
6. НУТ уншигчдын үйлчлүүлэх тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлж чадсан уу?
   а. Сайн б. Дунд зэрэг в. Муу
7. НУТ-аас та цаашид ямар үйлчилгээ авахыг хүсэж байна вэ? Саналаа бичээрэй.
   ....
   ....

ӨӨРИЙН ҮНЭТЭЙ САНАЛАА БИДЭНД ИЛГЭЭСЭН ТАНД БАЯРЛАЛАА

Сэтгэл ханамжийн судалгааны swot шинжилгээ

Энэхүү судалгааны үр дүнд Нийтийн уншлагын танхим **/НУТ/**-ын үйл ажиллагааг сайжруулах, уншигчдын эрэлт хэрэгцээг хангах, зохион байгуулж байгаа Соёл олон нийтийн ажил /СОНА/-ын үр өгөөжийг нэмэгдүүлэх юм.

Энэхүү судалгааг 50 ширхэг хэвлэж **36** уншигч хамрагдсан. Тус санал асуулгын сэдвийн хүрээнд доорх асуултуудыг асуув. Үүнд:

Нас:

- 18 нас хүртлэх – 4 12%
- 18-24 нас - 7 19%
- 25-36 нас – 18 50%
- 51-ээс дээш – 7 19%

Хүйс:

- Эрэгтэй - 11 30%
- Эмэгтэй - 25 70%

1. Та Нийтийн уншлагын танхимаар үйлчлүүлдэг үү?

- Тийм - 6 17%
- Үгүй - 23 63%
- Заримдаа - 7 20%

2. Таны хэрэгцээт ном, хэвлэл, гарын авлага НУТ-д хүртээмжтэй байдаг уу?

- Хангалттай – 9 25%
- Хангалтгүй – 14 38%
- Хүртээмжийг нэмэгдүүлэх – 13 37%

3. НУТ-аас зохион байгуулж байгаа Соёл олон нийтийн ажил таны сэтгэлд нийцэж байна уу?

- Маш сайн – 10 30%
- Дунд зэрэг – 2 5%
- Оролцож байгаагүй – 24 66%
- Муу – 0 0%

4. НУТ-ын танд үзүүлж байгаа үйлчилгээнд үнэлгээ өгнө үү?

- Сайн – 27 75%
- Муу – 0 0%
- Үйлчилгээг илүү сайжруулах – 9 25%

5. Танхимын номын санчийн харилцаа, хандлага танд ямар санагддаг вэ?

- Сайн – 36 100%
- Дунд – 0 0%
- Муу – 0 0%

6. НУТ уншигчдын үйлчлүүлэх тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлж чадсан уу?

- Сайн – 22 62%
- Дунд зэрэг – 7 19%
- Муу – 7 119%

7. НУТ-аас та цаашид ямар үйлчилгээ авахыг хүсэж байна вэ? Саналаа бичээрэй.

- Бичгээр санал ирүүлээгүй байна.

SWOT: Санал, хүсэлт асуулгаас үзэхэд:

- ✓ Номын санд уншигч иргэсдийг татах шинэлэг ажлыг зохион байгуулах
- ✓ Шинээр гарч байгаа уран зохиолын номнуудаар баяжилт хийх
- ✓ Номын сангийн уншлагын танхимыг орчин үеийн стандартад нийцүүлэн тохижуулах

саналын дагуу зохих арга хэмжээнүүдийг өөрсдийн нөөц боломцоогоо ашиглан цаашид авах шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

2. Сэтгэл ханамжийн судалгаа

Энэхүү судалгааны үр дүнд Хүүхдийн уншлагын танхимын үйл ажиллагааг сайжруулах, уншигчдын эрэлт хэрэгцээг хангах, зохион байгуулж байгаа Соёл олон нийтийн ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх юм.

Энэхүү судалгаанд нийт 30 иргэн хамрагдсан. Тус санал асуулгын сэдвийн хүрээнд доорх асуултуудыг асуув. Үүнд:

Нас:

- 18 нас хүртлэх – 3 10%
- 18-24 нас - 5 17%
- 25-36 нас – 9 30%
- 51-ээс дээш – 13 43%

Хүйс:

- Эрэгтэй - 9 30%
- Эмэгтэй - 21 70%

Боловсрол:

- 60% нь дээд боловсролтой

Санал, сэтгэгдлийн судалгаа

Нас .... Хүйс .... Боловсрол ....

Та номын сангийн аль үйлчилгээг авдаг вэ?

A. Танхимаар
B. Гэрээр ном олгох
C. Нүүдэл зөөвөр
D. Цахимаар

Та номын сангийн одоо байгаа орчин нөхцөлийг юу гэж үнэлэх вэ?

A. Хангалттай
B. Дунд зэрэг
C.Сайжруулах шаардлагатай
D. Мэдэхгүй

Номын санг шинэ барилгатай болохыг дэмжиж байна уу?

A. Маш их дэмжиж байна
B. Дэмжиж байна
C. Дэмжихгүй
D. Мэдэхгүй

Аймгийн Нийтийн номын сангаас зохион байгуулдаг Соёл олон нийтийн ажлын хүртээмж хэр байна гэж боддог вэ?

A. Сайн
B. Дунд
C. Муу
D. Мэдэхгүй
E. Сайжруулах шаардлагатай

Танд номын сантай холбоотой ямар санал, сэтгэгдэл байна вэ?

....

Сэтгэгдлээ хуваалцсан танд баярлалаа.

Сэтгэл ханамжийн судалгааны swot шинжилгээ

Номын сангаар үйлчлүүлсэн уншигчдын сулалгаанаас үзэхэд судалгаанд хамрагдсан уншигчдын ихэнхи хувь буюу 46% нь номын сангаар үйлчлүүлдэггүй, 27% нь сайшаалтай ч, заримдаа 27% байна. Үүнээс дүгнэхэд явуулын номын сангийн үйлчилгээг багт хүргэсэнээр номын сангаар үйлчлүүлэх иргэсэдийн тоо чанаржиж, ном олголтын эргэлт нэмэгдэж байна.

SWOT: Санал, хүсэлт асуулгаас үзэхэд:

- ✓ Номын санд уншигч иргэсэдийг татах шинэлэг ажлыг зохион байгуулах
- ✓ Шинээр гарч байгаа уран зохиолын номнуудаар баяжилт хийх
- ✓ Нэн тэргүүнд шинэ стандартын барилгатай болох шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

21. ДҮГНЭЛТ

Соёлын яамны дэмжлэгээр үр дүнд суурилсан санхүүжилт, бүх нийтийн Соёлын боловсрол олгох болон Соёлын эрхийн бичгийн нэмэлт санхүүжилт нийтдээ 27,927,200

төгрөгний хөрөнгө оруулалт хийгдэж өмнөх жилүүдээс илүү ажлын үр гарч уншигчиддаа оруулсан хөрөнгө оруулалт их байлаа.

Номын сангийн шинэ барилга баригдах асуудал шийдэгдэж 2024 оны улсын төсөвт тусгагдаж бэлтгэл ажлууд хийгдэж байна.

Номын санчдын ажлын ачаалал өндөр, албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй ажил үүргийг гүйцэтгэх зэрэг давхар олон ажил хавсарч хийх нь ажлын гүйцэтгэл үр дүн, үйлчилгээний хүртээмжид сөрөгөөр нөлөөлж байгаа цаашид засаж сайжруулах шаардлагатай байна. Үүнийг Соёлын яам болон шийдвэр гаргах түвшинд уламжлахаар ажиллаж байна.

Нэг номын санч 2-3 ажил хавсран хийж байгаа ч ямар ч нэмэгдэл хавсран ажилласан цалин байхгүй, ур чадварын нэмэгдэл авч чадахгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна. Жнь:

Арга зүйч: Архив, бичиг хэрэг
Ном бүрдүүлэлт
Каталог
Тогтмол хэвлэл
Дотоод хяналт

Сан хөмрөгч: Гэрээр ном олгогч
Нярав
Спорт, эрүүл мэнд......... гэх мэт

Манай хамт олон 2023 онд “Соёлын сэргэлт”, “Зохиолын баатрууд амилсан” маскот, “Номын баяр”, “Хүүхдийн бүтээлч уншлага”, “Өглөөний уншлага”, “Тунамал туурвил” хөрөг нэвтрүүлэг зэрэг олон томоохон ажлын ард гарч их зүйлийг хийж бүтээж түүнийхээ хирээр амжилт бүтээлээ үнэлүүлж төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-гоор нягтлан бодогч Д.Баасансүрэн, Соёлын яамны “Жуух бичиг”-ээр арга зүйч Ч.Цэндмаа, Булган аймгийн Соёлын салбарын “Шилдэг удирдлага”-аар захирал Т.Мөнгөнтуяа, “Шилдэг номын санч”-аар Г.Энхбилэг, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр номын санч Д.Мөнхгэрэл, Ц.Долгор, Б.Ариунжаргал, 2023 оны “Байгууллагын аварга ажилтан”-аар сахиул, үйлчлэгч З.Алтанцэцэг нар шагнууллаа.

22. СОНА-ЫН ИЛТГЭХ ХУУДСУУД

“Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд-2023” үйл ажиллагааг
Зохион байгуулсан тухай илтгэх хуудас

2023-05-22 Булган хот

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалт, “Номын баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 33 дахь удаагийн “Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд”-ийг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 19-ны өдрүүдэд танхимаар болон Чин Ван Ханддоржийн талбайд тэмдэглэн өнгөрүүллээ.

Номын өдрүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын удирдамж, төлөвлөгөөг аймгийн Соёл Урлагийн Газрын даргаар батлуулж Булган сумын Соёлын ордон, Аймгийн Музейтэй хамтран зохион байгуулав. Булган сумын Засаг даргын Тамгын газар тог цахилгааны холболтод дэмжлэг үзүүлж ажиллаа. Номын өдрүүдийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан ажлуудад нийтдээ 600 гаруй хүн оролцлоо. Энэ удаагийн Номын өдрүүдийн үйл ажиллагаанд нийт 445.000 төгрөг зарцууллаа.

Номын баярыг угтаж зохион байгуулсан ажлууд:

- Номын сангийн хууль сурталчлах видео бичлэг
- Монгол ардын үлгэр “Өвгөн баяр хоёр” үлгэрийн баатрууд хэрэглэгдэхүүний өөрсдийн гараар урлан театрчилсан үлгэр бэлтгэн сургуулийн өмнөх нас, бага ангийнханд уншиж сурталчиллаа. Үлгэрээ видео бичлэг болгон бэлтгэж цахимд оруулахаар ажиллаж байна.
- Номын хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг 1-р 12 жилийн сургуулийн 3в ангид Динза цуврал номоор, ЭӨЦС-ийн 9А ангид Монголын нууц товчоо, Нууцыг задруулсан захиа номоор тус тус зохион явууллаа.

“Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд”-2023 оны нээлтийн үйл ажиллагааг 5 дугаар сарын 19-ны өдөр Чин Ван Ханддоржийн зохион байгууллаа.

Үүнд:

- Тэргүүний уншигч анги хамт олон, байгууллага, тэргүүний уншигч “Д.Нацагдорж тэмдэг”-ийн болзол хангасан уншигчдыг танилцуулж шагнал гардуулах үйл ажиллагаа

Тэргүүний уншигч “Д.Нацагдорж тэмдэг”-ээр :

1. Булган сумын 1-р бүрэн дунд сургуулийн 6 А ангийн сурагч Б.Есүхэй
2. ЭӨЦС-ийн 9 А ангийн сурагч Б.Марал
3. ЭӨЦС-ийн 12 В ангийн сурагч Г.Билэгжаргал /
4. Булган аймгийн ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтан Ч.Сугар
5. “Номтой нөхөрлүүлэгч иргэн”-ээр Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх газрын хуяглан хүргэлтийн ажилтан хошууч Б.Баярсайхан /Б.Баярсайхан нь ажиллаж эхэлсэн цагаасаа номын сантай зөөврийн номын сангийн гэрээ байгуулан хорих ангийн хүмүүжигч нарт ном уншуулж соён гэгээрүүлэх ажлыг идэвхтэй зохион байгуулж байна.

Майхант өртөөнд Монгол ардын оньсон болон хөлөгт тоглоом наадгай сурталчилж, шинэ хүүхдийн болон насанд хүрэгчдэд зориулсан 200 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж, бага ангийнханд үлгэрийн хүүхэлдэйн театрчилсан тоглолт үзүүллээ.

- “Хүүхдийн бүтээлч уншлага”-д хамрагдаж байгаа анги хамт олон уншсан “Номын тэмдэглэл”-ийн үзэсгэлэн, сурагчдийн “Гэрийн номын сан”-гийн үзэсгэлэн, “Бяцхан ном”-ын үзэсгэлэн тус тус гаргаж сурталчиллаа.
- Үндэсний бичиг болон крилл үсгээр бүтээсэн шоо хэлбэртэй хайрцаг бэлтгэн “Үг бүтээх” тоглоом тоглууллаа.
- Булган сумын Соёлын ордон гадаад номын үзэсгэлэн гаргаж уншигч хүүхдүүдийн дунд хөгжөөнт тэмцээн явууллаа.
- Тайз засалт, техник хэрэгслийн бэлэн байдлыг хариуцан ажиллаа
- Соёлын ордны дэргэдэх сурагчдын Бэхи хамтлаг болон дугуйлангийн сурагчид, уран сайханчид ая дууны мэндчилгээ өргөлөө.
- Аймгийн Музей нь үнэт ховор ном, барын номоор үзэсгэлэн гаргаж, ирсэн хүмүүс, хүүхэд багачуудад сурталчилан таниуллаа.

ХЯНАСАН: ЗАХИРАЛ Т.МӨНГӨНТУЯА

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН: АРГАЗҮЙЧ Ч.ЦЭНДМАА



БАТЛАВ
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГА Г.АЛДАРМӨНХ

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023” НАМРЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023.09.06 Булган

ЗОРИЛГО: Алсын харва 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, ард иргэдийг номтой нөхөрлүүлэх зорилгоор "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023" арга хэмжээг аймгийн хэмжээнд өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залуусын сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэх, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

№	Зохион байгуулах ажлууд	Хугацаа, хаана	Хэн оролцох	Хариуцах эзэн
1	Талбайн тайз засах, техник хэрэгслийн бэлтгэл ажлыг хангах	09 сарын 15 Цогт хунтайжийн талбайд	-	Соёлын ордон, номын санчид
2	Хуруун хүүхэлдэйн тоглолт	09 сарын 15 Төв талбайд	Цэцэрлэгүүд, сургуулийн өмнөх насны хүүхэд багачууд	Арга зүйч Ч.Цэндмаа, Номын санч Б.Ариунбаяр, Б.Ариунжаргал, Д.Мөнхгэрэл, Сан хөмрөгч Ц.Долгор
3	"Бийрэн бичлэг" үндэсний бичгийн үзүүлэх сургалт	09 сарын 15 Төв талбайд	Иргэд олон нийт	АТНС арга зүйч Ч.Цэндмаа
4	Монгол, гадаад номын үзэсгэлэн, сурталчилгаа	9 сарын 15-17 Төв талбайд	Иргэд олон нийт	Сан хөмрөгч Долгор, Номын санч М.Ариунбаяр, Соёлын ордны номын сан
5	Тэргүүний уншигч "Д.Нацагдорж тэмдэг"-ний болзол хангасан сурагчдыг шалгаруулж шагнаж урамшуулах	9 сарын 15-17 Төв талбайд	ЕБС-ийн сурагчид	Арга зүйч Ч.Цэндмаа
6	МОНГОЛ ТОГЛООМ-ын орон зай - Ардын тоглоом наадгай (шагаа,	9 сарын 15-17 Төв талбайд		Арга зүйч Ч.Цэндмаа, Номын санч Д.Мөнхгэрэл



	үзэсгэлэн, гарын авлага, тэмцээн			
7	"Язгуур үг", "Үсэглэлийн хавд" тэмцээн	9 сарын 15-17 Төв талбайд	ЕБС-ийн сурагчид	Номын санч Г.Энхбилэг, Д.Отгонцэцэг
8	НОМ БА ДИЗАЙН үзэсгэлэн (номоор урласан бүтээлүүд)	9 сарын 9 сарын 15 Төв талбайд	Иргэд олон нийти	Номын санч М.Ариунбаяр, Д.Мөнхгэрэл, Б.Ариунжаргал Арга зүйч Ч.Цэндмаа
9	Ном бичгийн хэрэгсэл модон барын үзэсгэлэн	9 сарын 15-17 Төв талбайд	Иргэд олон нийт	Музейн ажилтан Ж.Ганбат
10	Хуучин номын худалдаа	9 сарын 15-17 Төв талбайд	Иргэд олон нийт	Номын санчид
11	"Номын мэтгэлцээн"	09 сарын 17 номын баярын талбайд	ЕБС-ийн ахлах ангийн сурагчид	Арга зүйч Ч.Цэндмаа, номын санч Д.Мөнхгэрэл
12	Бүтээлч уншигч анги хамт олон танилцуулга, мэдээлэл, ангийн номын сан, номын тэмдэглэлийн үзэсгэлэн	09 сарын 15-17 номын баярын талбайд	ЕБС-ийн сурагчид, багш нар	Номын санч Г.Энхбилэг, Д.Отгонцэцэг
13	"Номын амт" сэдэвт сугалаа	09 сарын 15-17 номын баярын талбайд	Иргэд олон нийт	Номын санчид

“Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд-2023” намрын үйл ажиллагааг зохион байгуулсан тухай илтгэх хуудас

2023-09-18 Булган хот

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалт, “Номын баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 34 дэхь удаагийн “Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд”-ийг НОМТОЙ МОНГОЛ уриан дор 2023 оны 09 дугаар сарын 15, 16-нд 2 өдөр Булган сумын Соёлын ордон /*цаг агаарын байдлаас шалтгаалан*/ дотор зохион байгууллаа.

Номын өдрүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын удирдамж, төлөвлөгөөг аймгийн Соёл Урлагийн Газрын даргаар батлуулж Булган сумын Соёлын ордон, Аймгийн Музейтэй хамтран зохион байгуулав. Номын өдрүүдийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан ажлуудад нийтдээ 900 орчим хүн оролцлоо. Энэ удаагийн Номын өдрүүдийн үйл ажиллагаанд нийт 560.000 төгрөг зарцуулсан.

Тэргүүний уншигч "Нацагдорж тэмдэг" -ээр

- 1-р бүрэн дунд сургуулийн 12 В ангийн сурагч Б.Жаргалмаа,
- 1-р бүрэн дунд сургуулийн 7 А ангийн сурагч М.Дөлгөөн,
- АЗДТГ-ын ТЗУХ-ын дарга Д.Эрдэнэбилэг

"Номч анги хамт олон"-оор 1-р бүрэн дунд сургуулийн Ш.Энхчимэг багштай 12 В анги шалгарлаа.

Тус баярын 2 өдөр дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулав.

- **“Ном ба дизайн”** үзэсгэлэнгийн үзүүлэнг номын санчид өөрсдийн гараар урлан бэлтгэлээ.
- **“Монгол тоглоом”** хэсэгт зориулан Шагаа, Алаг мэлхий, Хорол тоглоом, Ээдрээ тоглоом, Хөлөгт тоглоом гэсэн 5 төрлийн тараах гарын авлага бэлтгэн хүргэлээ.
- **“Хуруун хүүхэлдэй”** тоглолт
- Оролцогчдын дунд **“Номын амт”** сэдэвт 350 сугалаа бэлтгэн сугалуулсан. Сугалаа бүр хонжвортой байсан нь хүүхэд багачуудын сонирхолыг ихэд татлаа.
- **“Монгол тоглоом наадгай”** тэмцээн, танин мэдэхүйн үзэсгэлэн, сурталчилгаа
- **“Номын мэтгэлцээн”** ахлах ангийн сурагчдын дунд
- **“Язгуур үг”, “Үсэглэлийн хаад”** тэмцээн, сурагчдын дунд
- **“Уншсан номын тэмдэглэл”**сурагчдын, **“Бүтээлч уншигч анги”** хамт олны “Ангийн номын сан”-ийн сурталчилгаа, номын үзэсгэлэн
- **Хуучин номын худалдаа, Шинэ номын үзэсгэлэн**

Хамтран зохион байгуулагч байгууллагууд дараах байдлаар оролцлоо.

- **Шинэ номын худалдаа** / Гэгээрүү номын дэлгүүр Б.Орхончимэг/
- Ном бичгийн хэрэгсэл, модон барын үзэсгэлэн, VR сурталчилгаа /Аймгийн музей/
- “АХА”, “Open mic” тэмцээн, Гадаад номын үзэсгэлэн, тайз, тоног төхөөрөмж, орчны бүрдүүлэлт, сугалааг хамтран зохион байгуулсан /Сумын соёлын ордон/

24. ФОТО ЗУРГУУД

Ариутгал, халдваргүйтгэл



Ном сэлбэн засварлах

Сан хөмрөг, НУТ, ХУТ, ГНО, Салбарын ойрын фондын номын ээлжит бус тооллого

Ажилтан, албан хаагчдын үндэсний бичгийн сургалт

“Угийн бичиг хөтлөх” ажлыг хэрэгжүүлэх

“ТАХ”-ын сарын аяны хүрээнд

Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн хүрээнд

“ХБИ”-ийн хөгжил оролцоог хангах ажлын хүрээнд

“Ахмад настны хөгжил оролцоог хангах” ажлын хүрээнд

Бие бялдарын сорил

“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн

Ажиллагсадын оролцсон олон нийтийн, соёлын болон аж ахуйн ажлууд:

“Цаг гаргая” 2023 аян

“Шилдэг удирдлага”

“Визит Булган” цасны баяр

"САНСАР МАРАФОН-2023"

Улсын хэмжээний Команд штаб, зарлан мэдээллэх дуут дохио

Авто зам дагуух бүх нийтийн цэвэрлэгээ

Үерийн далан цэвэрлэх

Цэвэр орчин Цэмцгэр Булган-Шарилжгүй Булган аян

Сургалтууд



Хамтын ажиллагаа



Байгууллагын тохижилт, бүтээлч ажил, байгууллагын гаднах хаяг



Байгууллагын амжилтын булан

Бүтээлч ажлууд



Хүүхдэд зориулсан Эко модон номын тавиур

Номын үзэсгэлэн

Номын худалдаа "Аз хур" ХХК-ийн 72% хямдрал аймагтаа зохион байгуулав.

Зөөвөр, явуулын номын үйлчилгээ

Зуны нүүдлийн номын сан

Соёлын сэргэлт 2023

Соёл олон нийтийн ажлууд

2023 онд зохион байгуулах "Соёл олон нийтийн ажил"-ын товъёог

№	Ажлын нэр	Хамрах хүрээ	Хугацаа	Хэнтэй хамтрах	Хэн хариуцах
1	Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн	Танхимаар болон цахимаар гаргана.	Сард 2-3 удаа		НУТ, ХУТ
2	"Цагаан сар өв уламжлал" гар зургийн уралдаан	Сумын ЕБС-ийн сурагчид	2 сард		НУТ
3	Аймгийн хэмжээнд Хүүхдийн бүтээлч уншлага	Аймгийн 1-12-р ангийн сурагчид	02/01-ээс 12/01 хүртэл	Сум сургуулийн номын сан, СУГазар	Аймаг, сум, сургуулийн номын санчид, АТНС
4	Номын сантай танилцах аялал	Сумын ЕБС-ийн сурагчид	7 хоногт 1-3 удаа		АТНС
5	"Булган бахархал"-ын өдрийг угтан Булганы бахархал сэдэвт "Бүтээлч ном" урлан бүтээх уралдаан	Аймгийн хэмжээнд	03/06-аас 04/03 хүртэл		АТНС, аргазүйч
6	Албан байгууллагуудын дунд "Өглөөний уншлага" аян өрнүүлэх.	Сумын хэмжээнд	03/01-ээс 12/01 хүртэл	Албан байгууллагууд	АТНС
7	СӨБ-ийн 1,2,3,4,5,6,7-р цэцэрлэгийн бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгийнхэнд Үлгэрийн чанга уншлага, явуулын номын сангийн үйлчилгээ үзүүлэх	Сумын цэцэрлэгийн багачуудад	7 хоногт 1 удаа	СӨБ	Номын санчид
8	Үлгэрийн театрчилсан хүүхэлдэй урлаж, тоглуулах	Видео цахимаар	Жилд 1 удаа	Соёлын ордон	Арга зүйч, номын санчид
9	ОУ-ын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан "Номтой нөхөрлөгч эмэгтэйчүүд" эвент арга хэмжээ	Сумын бүх насны эмэгтэйчүүдийн төлөөлөл 10 эмэгтэйн дунд	3/07-нд	Соёлын ордон	АТНС, СО
10	Үндэсний бичиг үсгийн баяр	Аймгийн хэмжээнд	5 сард	Боловсролын газар	АТНС, БГ
11	Үндэсний Номын баяр	Булган сумын бүх насны иргэдийн дунд	5 ба 10-р сар	СУГ, СО	АТНС, СУГ, СО
12	ОУ-ын хүүхдийн баярын арга хэмжээнд Номын өртөө ажиллуулах, "Үлгэрийн баатруудад хувирах"	Сумын бүх насны иргэдийн дунд	06/01-нд		АТНС
13	"Айргны баяр" фестивальд "Өв соёлын өртөө" ажиллуулах	Сумын бүх насны иргэдийн дунд	7-р сард		АТНС
14	Танин мэдэхүйн "АХА" тэмцээн	Сумын ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд	Улиралд 1 удаа		АТНС
15	Номын хэлэлцүүлэг	Сумын насанд хүрэгсэд ба сурагчдын дунд	Хагас жилд 1 удаа		Номын санчид
16	"Үсэглэлийн хаад" тэмцээн	Сумын бүтээлч уншлагын 17 ангийн дунд	Улиралд 1 удаа		НУТ
17	Монгол ардын аман зохиолын 5 төрөлт тэмцээн, Оньсон болон Хөлөгт тоглоом тэмцээн	Сумын ЕБС-ийн сурагчид	Улиралд 1 удаа		АТНС
18	"Ном унших арга", "Номын сангийн хууль" зөвлөмж	Видео ба цаасан хэлбэрээр түгээх	Улиралд 1 удаа		Арга зүйч
19	"Шинэ номын мэдээ", "Сэдэвчилсэн"		Хагас жилд 1 удаа		Арга зүйч
20	Сум, аймгийн номын санчдад Мэргэжил арга зүйн сургалт, зөвлөмж	Цахим, танхим	Жилд 3 удаа		АТНС, Арга зүйч
21	"Номтой яриа" ярилцлага	Цахим	Жилд 1 удаа		АТНС, Арга зүйч
22	"Сонсдог ном" хийх	Видео цахим	Жилд 1 удаа		Арга зүйч, номын санчид
23	Нүүдлийн болон Зөөврийн номын сангийн үйлчилгээ	Аймгийн сумд, Байгууллага, анги хамт олон, иргэдэд	Жилийн турш		АТНС
24	Санамж өгөх номзүйн бүртгэл, мэдээлэл	Цаасаар, видео, слайд, танхимын байдлаар хүргэх	Улиралд 1		Номын санчид

★ биелсэн ★ үргэлжилж байгаа ★ биелээгүй

АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САН

Хавар, намрын номын баяр

Үндэсний бичиг үсгийн баяр-2023

“Зохиолын баатрууд амилсан “ маскот Хүүхдийн баяр 2023

“Хүүхдийн бүтээлч уншлага” 2023

“Өглөөний уншлага” 2023 аян

“Бүтээлч ном урлан бүтээх” уралдаан

“Номтой нөхөрлөгч эмэгтэйчүүд” эвент арга хэмжээ



“Мэргэжил сурталчилах” арга хэмжээ

“Уламжлалаараа уралдъя” тэмцээн

“Урлан бүтээхүй” дугуйлан

"Монгол хүний эрхэмлэх үнэт зүйл" мэдээлэл сургалт

“Номын соёлт ертөнц” мэдээлэл сургалт

"Уншигчдын гурван үеийн төлөөлөл"-ийн уулзалт

Онцлох 10 үйл явдал

Холбоо барих утас: 75098999, 96519091

E mail: bulgannomiinsan@gmail.com

Сошиал хаяг: https://www.facebook.com/Bulgannomiinsan

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОН ТОО БҮТЭЦ

Нийтийн номын сан нь 2023 онд удирдах-1, мэргэжлийн 10, аж ахуй үйлчилгээний -6, нягтлан бодогч 0,5 нийт 17,5 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргатай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн, Нийтийн номын сангийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг ханган биелүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжууд, УИХ, Засгийн газрын тогтоол, Соёлын яам, сайдын тушаал, заавар, зөвлөмжүүдэд үндэслэн өөрийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна.

2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. 2023 оны байдлаар **нийт** 659 шинэ уншигч бүртгэж, 6351 ирцэд 7353 ном олголт хийсэн. Үүнээс 4-р улиралд 176 шинэ уншигч бүртгэж, 1857 ирцэд, 2828 ном олголт хийгдсэн байна.
2. Уншигч үйлчлүүлэгчдийг шинэ мэдээ мэдээллээр хангах зорилтын хүрээнд нийт 199 удаа лавлагаа өгөв.
3. Сонин сэтгүүлийн танхимаар нийт 31 сонин, сэтгүүлээр уншигчдад үйлчилсэн байна. Үүнээс 4-р улиралд 10 сонин сэтгүүлээр уншигчдад үйлчилсэн байна.
4. Фондын номын эдэлгээг уртасгах зорилгоор нийт 315 ширхэг номыг сэлбэн засаж уншлага үйлчилгээнд гаргалаа. Үүнээс 4-р улиралд 110 ширхэг номыг сэлбэн засаж ажиллаа. Жилийн эцсийн байдлаар нийт гэрээр ном олгох тасгаас 65 ном үндсэн фондноос 230 хүүхдийн уншлагын тахимаас 20 ном, нийт 315 ширхэг ном сэлбэн засаж янзаллаа.
5. Нийт 55 номын үзэсгэлэн гаргаж 3500 гаруй хүүхэд багачууд, иргэдэд үйлчилсэн байна.
    - Үндсэн хуулийн өдөрт зориулсан номын сэдэвчилсэн үзэсгэлэн,
    - Туулсийн номоор номын үзэсгэлэн,
    - Монгол ёс заншил, өв уламжлалын номоор,
    - ОУ-ын эмэгтэйчүүдийн өдөрт зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэн,
    - Монгол цэргийн өдөрт зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэн,
    - Наурызын баяраар Баян-Өлгий аймгийн зохиолчдын номоор номын үзэсгэлэн,
    - “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023” арга хэмжээний хүрээнд
    - Алтай хөгжил сонингийн үзэсгэлэн
    - Ховор хуучин номын үзэсгэлэн
    - Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жил сэдэвчилсэн номын үзэсгэлэн,
    - Улсын тэргүүний лабратори 1-р сургуулийн 7 а ангийн сурагчдын үндэсний бичгийн бүтээлийн “Бийрээ нийлье” үзэсгэлэн,
    - Номын хавчуургын үзэсгэлэн,
    - МЗЭ-ийн шагналт зохиолч яруу найрагч Тоомойн Очирхүүгийн 80 насны ойд зориулсан номын үзэсгэлэн,
    - Уншигч хүүхдүүдийн номын тэмдэглэлийн үзэсгэлэн,
    - Үндэсний агуулгатай гар урлалын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн,
    - Хамгийн том, жижиг, онцлог номын үзэсгэлэн
    - Мэргэжил бүхэн сайхан номын үзэсгэлэн

- Багш нарын баярын өдөрт зориулан “Багшийн алдар” номын үзэсгэлэнгүүд дэлгэгдлээ. Тус үзэсгэлэнгүүдийг байгууллагын цахим хаяг болон Алтай телевиз, Алтай мэдээ агентлагын мэдээгээр гарган уншигч түмэнд сурталчлан таниулж ажиллалаа. Мөн цахим хаягаар дамжуулан 35 төрлийн үлгэр, сургамжит өгүүллэгүүдийг байршуулан цахим уншлагын үйлчилгээ үзүүллээ.

НОМЫН ҮЗЭСГЭЛЭН

“Биирээ нийлье” үндэсний бичгийн бүтээлийн үзэсгэлэн

Хүүхдийн номын үзэсгэлэн **МЗЭ-ийн шагналт зохиолч Г.Чардаг**

“Хантайшир-100” **“Ховор номын үзэсгэлэн”** **“Алтайн хөгжил” сонин**

Т.Очирхүүгийн уран бүтээлийн үзэсгэлэн **Үзэсгэлэн үзэж сонирхогчид**

ХАНТАЙШИР-100 номын үзэсгэлэн

8-р сард: Үзэсгэлэнгийн танхимд хүүхэд багачуудын зуны амралтад зориулан 1.Хүүхдийн шилмэл зохиол 2.Дэлхийн сонгодог зохиол 3 Сонгодог өгүүллэгийн дээжис 4.Сонгодог зохиол

5. Сонгодог үлгэрийн цуврал 44 номуудаар үзэсгэлэн гаргаж 82 уншигч, хүүхдүүд үзэж сонирхож байна.

Хүүхдийн номын үзэсгэлэн



Хүүхдийн номын үзэсгэлэн

9-р сард: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар зарлигийн дагуу жил бүрийн 9 дүгээр сарын 01-ний өдрийг **"Эх хэлний өдөр"** болгон зарласан. Бүх нийтээр монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх, төрийн болон захиргааны албан бичиг хэрэг хөтлөлтийг монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээнд нийцүүлэх, монгол хэл бичиг, кирилл үсгийн дүрмээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар санаачилга гарган ажиллах, эх хэлээ сурталчлах, түүгээр бахархах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн эх хэл соёл, түүх, зан заншил, өв уламжлалын тухай мэдээ мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлгийг орон даяар нэвтрүүлэхийг уриалсан байдаг.

Үзэсгэлэнгийн танхимд Эх хэлний өдөрт зориулан үндэсний бичгээр бичигдсэн хуучны ном товхимол, гарын авлага, сурах бичиг зэрэг 42 номын үзэсгэлэн гаргалаа. Уг үзэсгэлэнг 130 гаруй хүүхэд багачууд үзэж сонирхлоо.

Эх хэлээ дээдлэн шамдан сурцгаая.

Үндэсний бичгээ сурч, хос бичигтэн болцгооё.

9-р сард: Үзэсгэлэнгийн танхимд 34 дэх удаагийн **“Үндэсний номын баяр-2023”** арга хэмжээг угтан Хүүхдийн танин мэдэхүйн ном, Сонгодог зохиолын ном, Шилдэг нийтлэлүүд, мөн Говь-Алтай аймгаас төрөн гарсан зохиолч Б.Ваанчиг 90 жил, Т.Очирхүүгийн 80 жил, Ч.Алагсайн 90 жилийн ойг угтан тэдний туурвиж байсан ном зохиол бүтээлийн нийт 170 гаруй номын үзэсгэлэн гаргалаа. Уг үзэсгэлэнг 130 гаруй хүүхэд багачууд үзэж сонирхлоо.

Үзэсгэлэн

Хүүхдийн танин мэдэхүйн номын үзэсгэлэн

Шилдэг ишлэлүүд, болон

соёлын номын үзэсгэлэн

Багшийн алдар" номын үзэсгэлэн

10-р сард үзэсгэлэнгийн танхимд "Олон Улсын Охидын эрхийг хамгаалах өдөр"-т зориулсан "Охидоо хайрлая" сэдэвт 64 номын үзэсгэлэн гаргалаа. Уг үзэсгэлэнг 100 гаруй хүүхэд багачууд үзэж сонирхлоо. 🌞🌹 "Охидоо хайрлая" номын үзэсгэлэн 🌹



10-р сарын 25-нд үзэсгэлэнгийн танхимд Авто замчдын өдөрт зориулан "Авто замчдын хөгжлийн чиг хандлага" сэдэвчилсэн 26 номын үзэсгэлэн гаргалаа. Уг үзэсгэлэнг 120 гаруй хүүхэд багачууд үзэж сонирхлоо.

“Авто замчдын хөгжлийн чиг хандлага”

11-р сард Үзэсгэлэнгийн танхимд Түүхийн сурвалж бичгүүдээс бүрдсэн шинэ 50 номын үзэсгэлэн гаргалаа. Уг үзэсгэлэнг 220 гаруй хүүхэд багачууд үзэж сонирхлоо.

Түүхийн сурвалж бичгүүдээс бүрдсэн шинэ номын үзэсгэлэн

11-р сард Монголын түүхийн сурвалж бичгүүдээс бүрдсэн шинэ 33 номын үзэсгэлэн гаргалаа. Уг үзэсгэлэнг 120 гаруй хүүхэд багачууд үзэж сонирхлоо.

Түүхийн сурвалж бичгүүдээс бүрдсэн шинэ номын үзэсгэлэн

11-р сард 🇲🇳МОНГОЛ БАХАРХАЛЫН ӨДӨР🇲🇳-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд төрт ёсны үнэт өв болох үндэсний бичиг үсгээ дээдлэх, сурах, түгээн дэлгэрүүлэх мөн Эзэн Богд Чингис хааны суу алдар, түүхэн үйл хэргийг сурвалжлан хэлсэн алдартай үг эшлэл, түүхэн гавъяаг магтан дуулсан дуу, шүлэг, ном зохиолыг сурталчлах зорилгоор монголын түүхийн сурвалж бичгүүдээс бүрдсэн шинэ 50 номын үзэсгэлэн гаргалаа. Уг үзэсгэлэнг 150 гаруй хүүхэд багачууд үзэж сонирхлоо.

🇲🇳МОНГОЛ БАХАРХАЛЫН ӨДӨР🇲🇳- т зориулсан номын үзэсгэлэн

12-р сард Монгол Улсад “Хүндлэл-хамгийн тод гэрэл” уриан дор 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд явагдаж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх “Цагаан туузтан” 16 хоногийн аянд Говь-Алтай аймгийн Нийтийн номын

сангийн хамт олон нэгдэж, аяны мэдээлэл, уриаг цахим орчинд түгээх, хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдамжид заасан санаачилгыг дэмжин ажиллаа. Уг ажлын хүрээнд:

Үзэсгэлэнгийн танхимд “Хүндлэл-хамгийн тод гэрэл” уриан дор номын үзэсгэлэн дэлгэж, Говь-Алтай аймгийн нийт иргэд, уншигч үйлчлүүлэгчдэд сурталчилан ажиллалаа.

“Хүндлэл-хамгийн тод гэрэл

3. 2023 онд, каталоги зохион байгуулалт

Жилийн эцсийн байдлаар шинээр улсын төсвөөр 58 нэр төрлийн 426 ш 7,561,700 төгрөгийн шинэ номоор фонд баяжилт хийн уншлага үйлчилгээнд гарган уншигчдад үйлчилж байна. Фондын чийгшилт, хадгалалтыг сайжруулан ажиллаж байна. 9-10 нэр төрлийн 106,600 төгрөгийн сонин, сэтгүүл захиалан нэгж болгон үдэж уншлага үйлчилгээнд гарган уншигчдад үйлчилж байна.

Манай аймаг хэвлэлийн хуудсанаа орон нутгийн картын санд Өдрийн сонин-1, Өнөөдөр сонин-1, Монголын мэдээ-1, Зууны мэдээ-1, Монголын үнэн-1, Хүмүүн бичиг-1, Алтайн мэдээ-1, Соёмбо-1, Утга зохиол, урлаг-1 материал түүвэрлэн баяжилт хийн байрлуулав.

4. Соёл танин мэдэхүйн ажил

1-р сард: Есөнбулаг сумын 3-р цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд үлгэрийн баатрууд амилсан нь дүрийн тоглолтыг цэцэрлэгийн захиргаатай хамтран зохион байгууллаа.
Дүрийн тоглолтыг явуулсанаар хүүхдүүдий хэл ярианы ойлголт**,** хамтач бүтээлч үйлийг илэрхийлэх эцэг эх багш, ажилчдын хамтын үйл ажиллагааг сайжруулан хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжихэд энэхүү ажлын гол зорилго оршиж байсан.

Уг жүжигчилсэн тоглолтонд тус цэцэрлэгийн 6 бүлгийн хүүхэд багачууд оролцон тухайн үлгэрийн агуулга, хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон үлгэр зохиолоор хүүхэд бүрийг хамруулан, эцэг эхчүүд ангийн багштай хамтран тухайн үлгэийн орчинг зохиомжлон тохижуулсан нь хүүхдийн сонирхол хэрэгцээнд нийцсэн үр өгөөжтэй олон хувилбараар дахин ашиглах онцлогтой байлаа.

Багын “А”, “Б” ангиуд орос ардын үлгэр “Манжин”, дунд бүлэг “Эрхий мэргэн”, ахлах бүлэг “Бяцхан байшин”, бэлтгэл бүлэг “Болдоггүй бор өвгөн” үлгэрүүдийг тус тус тоглосон нь хүүхэд багачуудад сонирхолтой ихэд таалагдсан арга хэмжээ боллоо.
1-р байранд ахлах бүлэг “Бяцхан байшин” үлгэр, 2-р байранд дунд бүлэг МАҮ “Болдоггүй бор өвгөн”, 3-р байранд багын Б бүлгийн орос ардын үлгэр “Манжин” үлгэрээр тоглосон дүрийн тоглолтууд тус тус байр эзэлж тэргүүн байр эзэлсэн ангийн багшид өргөмжлөл номыг гардуулан өглөө.

Тоглолтын хэсгээс

Тоглолтын хэсгээс

1-р сард: 3-р цэцэрлэгийн уншлагын заалтай танилцаж “Ховдог 2 бамбарууш”, “Эрхий мэргэн” зэрэг үлгэрээр үлгэрийн цагийг явууллаа.

Үлгэрийн цагийн хэсгээс

4-р сард Нийтийн номын сангийн захирал Э.Оюунгэрэлээр ахлуулсан ажлын хэсэг Алтай сум, Хилийн цэргийн анги, Бугат, Тонхил сумын Тахийн тал, Алтансоёмбо багуудад ажиллаж тус сумуудын соёлын төвийн номын санч нарт нэгдсэн бүртгэл, нэг бүрчилсэн бүртгэл, фонд зохион байгуулалт, анхан шатны бүртгэлүүдийг бүртгэх талаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

5-р сард Хүүхдийн уншлагын танхимд “Содон хуудас” дугуйлангийн яруу найраг сонирхдог хүүхэд багачуудад соёл урлагийн газрын мэргэжилтэн Д.Элбэгзаяа уран бүтээлийн ярилцага хийж хамтран номоор үйлчилж ажиллаа. 2023 оны 05 сарын 06- нд соёл урлагийн

газрын дэргэдэх утга зохиолын “Содон хуудас” дугуйлангийн хүүхэд залуусын болон хантайшир утга зохиолын нэгдлийн яруу найрагчид шүлэг яруу найраг сонирхогч иргэдийн чөлөөт уулзалт Гочоогийн Чардагийн уран бүтээлийг хойч үедээ сурталчлан таниулж хамтран ажиллаа.

“Содон хуудас” дугуйлангийн сурагчид

5-р сард: Ерөнхий боловсролын сургуулийн номын санч нартай хамтран 5 сарын 10-нд 12 жилийн 1-р сургуулийн 9в ангийн сурагчдын дунд “Ламбугайн нулимс” зохиолоор, 5 сарын 12-нд Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 12а ангийн сурагчдын дунд “Чемодантай юм” өгүүллэг, 5 сарын 15-нд III-р сургуулийн 9а ангийн сурагчдын дунд “Дусал нулимс юу өгүүлэв” зохиолоор тус тус номыг мэтгэлцээнийг ном зүйч С.Цэрэнпил амжилттай зохион явууллаа. Мэтгэлцээнд 100 сурагчид хамрагдлаа.

5-р сард: "ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР"- ийг тохиолдуулан соёл урлагийн газар ,аймгийн нийтийн номын сан, "хантайшир" утга зохиолын нэгдэл хамтран " алтайн өсвөрийн 100 зохиолчид" уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-аас 1995 онд 4 дүгээр сарын 23-ныг “Дэлхийн номын өдөр” болгон зарласан билээ. Энэ өдөр дэлхийн улс орнуудад зохиолч, хэвлэн нийтлэгчдэд хүндэтгэл үзүүлэх, ном уншихын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах, өдөрлөг, үзэсгэлэн худалдаа , зохиолч уншигчдын уулзалт зэрэг олон арга хэмжээнүүдыг зохион байгуулдаг байна.

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан аймгийн Нийтийн номын сан, "Хантайшир" утга зохиолын нэгдэлтэй хамтран "Алтайн өсвөрийн 100 зохиолч " уулзалт хэлэлцүүлгийг шүлэг яруу найраг сонирхдог, номонд шимтэн дурлагч хүүхэд залуусын дунд зохион байгуулжээ.

Арга хэмжээний хүрээнд

- Уншигч зохиолчдын уулзалт
- "Ном уншихын ач холбогдол" хэлэлцүүлэг
- Танин мэдэхүйн АХА тэмцээн
- Яруу найргийн чөлөөт уншлага
- "Дэлхийн сонгодог зохиолууд" номын үзэсгэлэн дэлгэгдэж 100 хүүхэд залуус хамрагджээ.

"ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР"- ийн арга хэмжээнээс

5-р сард: " Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023" арга хэмжээний хүрээнд ахмад зохиолч Д.Сүрьягийн нэрэмжит аймгийн Нийтийн номын санд " Ургаа уудалъя" угийн бичгийн сургалт боллоо. Монголчуудын оршихуйн соёлын үнэт өв болох угийн бичгээ хөтлөх аргад суралцуулах, цус ойртолтоос сэргийлэх зорилготой уг сургалтыг аймгийн Соёл, урлагийн газрын соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн угийн бичгийн орон нутгийн сургагч багш Д.Элбэгзаяа Есөнбулаг сумын ахмадуудын дунд зохион байгууллаа.

" Ургаа уудалъя" угийн бичгийн сургалт
Ургаа уудалъя" угийн бичгийн сургалт

5-р сард: Үндэсний бичиг соёл Номын өдрүүд 2023 арга хэмжээг угтан Есөнбулаг сумын СӨБ-ын хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх, номонд дуртай болгох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ардын аман зохиолыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор хүүхэд багачуудад “Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлагыг зохион байгуулна ажиллаа.

Уг үлгэрийн цагийг 5-р сарын 04 -нээс 2023 оны 05 сарын 17 хүртэл тус цэцэрлэгийн 8 бүлгийн хүүхэд багачууд оролцон монгол ардын шилдэг үлгэрүүдээр чанга уншлага хийлээ.

3-р цэцэрлэг Х.Баяржаргал багштай бэлтгэл бүлэг “Мэргэн галуу Тэнэг мэлхий”,6-р цэцэрлэг Баярхишиг багштай бэлтгэл бүлэг “Болддоггүй бор өвгөн”

4-р цэцэрлэг Цэрэндэжид багштай бэлтгэл бүлэг “Тэмээ үнсэнд хөрвөөх болсны учир”

11-р цэцэрлэг: нийт 13 бүлэг “Ухаант туулай” ”Алтан загасны үлгэр” 10-р цэцэрлэг Д.Бямбахүү багштай бэлтгэл бүлэг, ,Арьяабал багштай ахлах бүлэг “Эрхий мэргэн”

2-р цэцэрлэг бэлтгэл бүлэг, ахлах бүлэг “Өнхрүүш” 7-р цэцэрлэг бэлтгэл бүлэг Оюунчимэг багштай “Чигчийн чинээ хүү” 4-р цэцэрлэг ”Өнчин цагаан ботго”

Нийт 510 хүүхдүүд тус үлгэрүүдийг уншиж бяцхан хүүхэд багачуудыг үлгэрийн цагаар аялууллаа.

"Үлгэрээс үлгэрлэе" чанга уншлага

“Үлгэрээс үлгэрлэе" чанга уншлага

5-р сард: Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2023 арга хэмжээний хүрээнд хүүхэд багачуудын дунд *Дэлхийн сонгодог зохиолыг хэн сайн унших вэ? уралдааныг зарлан зохион байгуулсан. Тус уралдаанд аймгийн ЕБС-ийн 7-8-р ангийн сурагчид өргөнөөр хамрагдаж дэлхийн сонгодог зохиолуудыг уншиж судласан. Уралдаанд нийт 70 гаруй хүүхдүүд оролцсоноос 1-р сургуулийн 7г ангийн сурагч Г.Анужин хамгийн олон ном уншиж шалгарлаа. 1-р байр өргөмжлөл мөнгөн шагналаар шагнав.Шилдэг уншигчаар З.Пүрэвжав 3-р сургууль 3в анги,Э.Алтансоёмбо 1-р сургууль 3а ангийн сурагч нар шалгарлаа

1-р байр 1-р сургуулийн 7г ангийн сурагч Г.Анужин

5-р сард: Гадаад хэлний танхимын номын санч Б.Мөнхцэцэг, насанд хүрэгчдийн уншлагын танхимын номын санч Ч.Дариймаа нар "Үндэсний бичиг соёл, номын өдөр-2023" арга хэмжээний хүрээнд Нийтийн номын сангаас "Номтой зочин" аяллыг Алтайчуудын бахархал, үнэт зүйлийг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдлэн, эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэн, нийгмийг соён гэгээрүүлэх зорилгоор Хантайшир уулын аймаг 100, Үндэсний бичиг соёл, номын өдрийг олон нийтэд таниулан, олон нийтийг ном унших сонирхлыг нэмэгдүүлэн ажиллалаа.

2023 оны 05 сарын 17 ны өдөр Эрүүл мэндийн газар, Байгал орчин, аялал жуулчлалын газар гэсэн байгууллагуудын нийт 21 ажилтан албан хаагч мэдлэг оюунаа сорин идэвхтэй оролцсон бөгөөд Алтай телевизээр контент хийлгэн телевиз болон байгууллагын фэйж хаягаар сурталчилан таниуллаа.

"Номтой зочин" контентийн хэсгээс



"Номтой зочин" контентийн хэсгээс

5-р сард: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор УИХ-ын дарга Гомбожавын Занданшатарын ивээл дор "Илүү их уншъя" уриатай 33 дахь удаагийн НОМЫН БАЯР, "ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023" арга хэмжээ 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдөр аймгийн Биеийн тамир спортын газар зохион байгуулагдлаа.
Тус арга хэмжээний нээлтэд аймгийн ИТХ-ын дарга Д.Даваадорж, ЗДТГ-ын дарга Ш. Эрдэнэбат, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Мөнхжаргал, Соёл, урлагийн газрын дарга С.Цагаанбаатар, Нийтийн номын сангийн захирал Э.Оюунгэрэл нар оролцлоо.
"Номын баяр"-ын хүрээнд дараах арга хэмжээ зохион байгуулагдлаа.
Үүнд:
📖📚Хантайшир уулын аймаг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэн
📚📕Алтай хөгжил сонины үзэсгэлэн
📔📒Ховор хуучин номын үзэсгэлэн
📚📙Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жил сэдэвчилсэн номын үзэсгэлэн

Ховор хуучин номын үзэсгэлэн

Улсын тэргүүний лабратори 1-р сургуулийн 7 а ангийн сурагчдын үндэсний бичгийн бүтээлийн “Бийрээ нийлье” үзэсгэлэн

Номын хавчуургын үзэсгэлэн

МЗЭ-ийн шагналт зохиолч яруу найрагч Тоомойн Очирхүүгийн 80 насны ойд зориулсан номын үзэсгэлэн

Уншигч хүүхдүүдийн номын тэмдэглэлийн үзэсгэлэн

Номын солилцоо

Үндэсний агуулгатай гар урлалын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн

Орон нутагт номын худалдаа эрхлэгчдийн номын үзэсгэлэн худалдаа

Аймгийн зохиолч, яруу найрагчдын гарын үсэгтэй номын худалдаа

Хамгийн том, жижиг, онцлог номын үзэсгэлэн зэрэг үзэсгэлэнгүүд дэлгэгдлээ.

Мөн аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Соёл урлагийн газар, Насан туршийн боловсролын төв, Төрийн Архивын тасаг зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулсан төрийн албан хаагч, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын дунд зарласан үндэсний бичгийн “Цахим бичвэр”-ийн уралдааны болон аймгийн Нийтийн номын сангийн шилдэг уншигч, шилдэг уншигч хамт олон, “Үндэсний бичгээ өвлөн бахархъя” сэдэвт эссэ бичлэгийн уралдаануудын шилдгүүдэд шагнал гардуулж, 3-р цэцэрлэгийн дунд бүлгийн хүүхдүүдийн тоглосон “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолт, III, VII, XI-р цэцэрлэгийн хүүхдүүдийн “Шилдэг дүрийн парад” зэрэг арга хэмжээ зохион байгуулагдаж нийт 970 хүн хамрагдлаа.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023”

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023



5-р сард: “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023” арга хэмжээний хүрээнд Монголын Зохиолчдын эвлэлийн болон Чадраабалын Лодойдамба, Мишигийн Цэдэндоржийн нэрэмжит шагналт зохиолч, яруу найрагч Гочоогийн Чардагийн богино өгүүллэгүүдээс унших "Уран жиргээ" уралдаан амжилттай болж өндөрлөлөө.

Утга зохиолоор дамжуулан нийгмийг соён гэгээрүүлэх, Алтай нутгийнхаа зохиолчдын уран бүтээлийг залуу хойч үедээ сурталчлан таниулах, хүүхэд залуусын авьяас чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх зорилготой тус уралдааны

I байрыг Цогт сумын ЕБС-ийн 12 б ангийн сурагч Э. Галмандах,

II байрыг Дэлгэр сумын ЕБС-ийн 10 а ангийн сурагч Ү.Номин-Эрдэнэ,

III байрыг Соёл, урлагийн газрын дэргэдэх “Содон хуудас” дугуйлангийн суралцагч, 3-р сургуулийн 10 а ангийн сурагч З.Агиймаа,

IҮ байрыг 4-р сургуулийн 9 б ангийн сурагч Б. Анударь,

Ү байрыг 3-р сургуулийн 6 б ангийн сурагч Т. Сэвжидмаа нар тус тус эзэллээ.

"Уран жиргээ" уралдаан

6-р сард: Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнд Гэрээр ном олгох тасаг, хүүхдийн уншлагын танхим хамтран Сэдэвчилсэн хүүхдийн номоор номын үзэсгэлэн гаргаж 700 гаруй хүүхэд багачууд үзэж сонирхлоо.

Үзэсгэлэнг үзэж сонирхох хүүхэд багачууд



6-р сард: “Номтой зочин” цуврал контентыг Гадаад хэлний танхим, Насанд хүрэгчдийн уншлагын танхимын номын санч нар Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Тамгын газрын хамт олонтой хамтран зохион явуулж Алтай телевизээр үзэгчдэд хүргэхээр бэлэн болж байна.

“Номтой зочин” цуврал контентын хэсгээс

6-р сард: Өвөрхангай аймгийн Нийтийн номын сангийн 13 хүний бүрэлдэхүүнтэй номын санч нар номын сангийн 4 танхим, ном олголт, бусад үйл ажиллагаатай танилцан туршлага судалж ажиллаа.

Туршлага судлах үйл явц

7-р сард: Нүүдлийн номын сангаар Гуулин тосгоны Андууд зусланд 2023 оны 7 сарын 3-6 ны өдрүүдэд гэрээр ном олгох танхимийн номын санч Х.Цогзолмаа хүүхдийн сонгодог зохиол болон үлгэрийн ном, өгүүллэгийн номоор үйлчиллээ. Уг зөөврийн номын сангийн үйл ажиллагаанд 40 гаруй хүүхэд багачууд хамрагдлаа.

Нүүдлийн номын сангийн үйлчилгээ

7-р сард: Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмын нээлтийн арга хэмжээнд Арга зүйч П.Дарьсүрэн, номын санч Ч.Дариймаа, Б.Мөнхцэцэг, мэдээллийн ажилтан Э.Оюунсувд, сэлбэн засагч С.Халиунаа нар бэлтгэл хийн ажиллаж байна.

Баяр наадмын нээлтийн үйл ажиллагааны бэлтгэлийн хэсгээс

8-р сард: Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадамд зориулан **“Хуурын эгшиг”** яруу найргын наадмыг Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газар, Соёл урлагийн газар, Монголын зохиолчдын эвлэлийн Говь-Алтай аймаг дахь салбартай хамтран амжилттай зохион байгуулж нийт 20 гаруй зохиолч өөрсдийн ур чадвар, авьяас билгээ дайчлан өрсөлдөж 1-р байр шилдэгийн шилдэг яруу найрагч Б.Жамбалдорж, шилдэг яруу найрагч зохиолч Л.Мөнхбаатар, Г.Чардаг, М.Баянмөнх, Э.Гантулга нар шалгарлаа.

Хуурын эгшиг яруу найргын наадамд оролцсон нийт зохиолчдыг хүлээн авч, талархал илэрхийлэн уулзлаа.

“Хуурын эгшиг” яруу найргын наадам

наадмын зохиолчидтой хийсэн уулзалт

8-р сард: Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн төв талбайн хуваарьт газрыг угааж, цэвэрлэн ажиллаа. Мөн аймгийн гэр, байшин хорооллын тохижилт үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд хуваарьт тусгагдсан

Жинст, Индэрт багын айл өрхүүдийн хаалга, хашааг будуулж, зостуулан хогийг цэвэрлүүлэн ачуулж ажиллаа.

Ажлын явц

8-р сард: Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмын нээлтийн арга хэмжээнд 8 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд Арга зүйч П.Дарьсүрэн, номын санч Ч.Дариймаа, Б.Мөнхцэцэг, мэдээллийн ажилтан Э.Оюунсувд, сэлбэн засагч С.Халиунаа нар оролцлоо.

Баяр наадмын нээлтийн хэсгээс

8-р сард: Улсын тэргүүний лабортори I сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Б.Өлзийсайхан багштай хүүхэд багачууд “Хүүхдийг номтой нөхөрлүүлэх, хурдан уншиж сургах” сургалтын хүрээнд нийтийн номын сангийн хүүхдийн уншлагийн танхимд 10 хүүхэд ирж ном уншлаа.

“Хүүхдийг номтой нөхөрлүүлэх, хурдан уншиж сургах” сургалт

8-р сард: Нүүдлийн номын сангаар Говь-Алтай аймгийн нийтийн номын сан нь 2023 оны Нүүдлийн номын сангийн үйлчилгээг Хүнхэр амралт сувилал, Бигэрийн Таван элсний сувилал, Шаргын Хүрхрээнд 2023 оны 8 сарын 23-28-ны өдрүүдэд гэрээр ном олгох танхимийн номын санч Х.Цогзолмаа хүүхдийн сонгодог зохиол болон үлгэрийн ном, өгүүллэгийн ном, гүн ухаан, шинжлэх ухааны номоор үйлчиллээ. Уг зөөврийн номын сангийн үйл ажиллагаанд 50-60 гаруй хүүхэд багачууд, ард иргэд хамрагдлаа.

Нүүдлийн номын сангийн үйлчилгээ

9-р сард: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар зарлигийн дагуу жил бүрийн 9 дүгээр сарын 01-ний өдрийг **"Эх хэлний өдөр"** болгон зарласан. Бүх нийтээр монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх, төрийн болон захиргааны албан бичиг хэрэг хөтлөлтийг монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээнд нийцүүлэх, монгол хэл бичиг, кирилл үсгийн дүрмээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар санаачилга гарган ажиллах, эх хэлээ сурталчлах, түүгээр бахархах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн эх хэл соёл, түүх, зан заншил, өв уламжлалын тухай мэдээ мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлгийг орон даяар нэвтрүүлэхийг уриалсан байдаг.

Үзэсгэлэнгийн танхимд Эх хэлний өдөрт зориулан үндэсний бичгээр бичигдсэн хуучны ном товхимол, гарын авлага, сурах бичиг зэрэг 42 номын үзэсгэлэн гаргалаа. Уг үзэсгэлэнг 130 гаруй хүүхэд багачууд үзэж сонирхлоо.

9-р сард: “Үндэсний номын баяр-2023” арга хэмжээний хүрээнд хүүхдийн уншлагын танхимын номын санч Ч.Бямбадорж 3 дугаар цэцэрлэгийн Бэлтгэл А, Б бүлгийн Бямбажаргал багштай 48 хүүхэд багачууд, 4-р цэцэрлэгийн 56, 6-р цэцэрлэгийн 26 хүүхэд багачуудад “Үлгэрээс үлгэрлэе, чанга уншлага” үлгэрийн цагийг нийт 130 хүүхэд багачуудад хийлээ.

“Үлгэрээс үлгэрлэе, чанга уншлага”

9-р сард: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын

хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Илүү их уншъя” уриатай 34 дэх удаагийн НОМЫН БАЯР, **“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023”** арга хэмжээ 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр аймгийн төв талбайд зохион байгуулагдлаа.

Тус арга хэмжээний хөтлөгчөөр МУСТА Б.Баасанбат хөтөлж, нээлтэд аймгийн Аймгийн ЗДТГ-ын дарга Ш.Эрдэнэбат, Соёл, урлагийн газрын дарга С.Цагаанбаатар, Нийтийн номын сангийн захирал Э.Оюунгэрэл нар оролцож Аймгийн ЗДТГ-ын дарга Ш.Эрдэнэбат нээж үг хэллээ.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023” арга хэмжээний нээлт

Нээлтэд АДБ-ийн “Алтай” чуулгын уран бүтээлчид МУСТА дуучин С.Батсайхан, хөгжимчин Б.Мандахбаяр, хөөмийч У.Лутхад, уртын дуучин н.Дорждулам нар “Алтайн магтаал”, Монгол Ардын уртын дуугаар эгшигэн цэнхэр хадаг өргөлөө.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023” арга хэмжээний нээлт

Мөн нээлтэд Ерөнхий боловсролын 4-р сургуулийн бүжгийн “ЖОНОН” хамтлаг МУСТА Б.Баасанбатын дэглэлт “Эсэргэн, Жонон хонгор” бүжгээр, Ерөнхий боловсролын 2-р дугаар сургуулийн 3а ангийн сурагч Н.Түмэнхүслэн нар ая дуугаа өргөлөө.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023” арга хэмжээний нээлт

Номын баярын үйл ажиллагаанд 3-р цэцэрлэг, 4-р цэцэрлэг, 7-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхэд багачууд, “Үлгэрийн баатруудын дүрийн парад” алхаж “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолт үзүүлэн дуу шүлгээр мэндчилгээ дэвшүүллээ.

“Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолт, парад

“Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолт, парад

“Үлгэрийн баатрууд амилсан нь” парадад оролцсон 3, 4 дүгээр цэцэрлэгийн бэтгэл бүлгийн хүүхэд багачууд

Албан байгууллагуудын дунд шилдэг номын сантай байгууллага хамт олныг шалгаруулж шагнал гардууллаа. Мөн номын сангийн шилдэг уншигчдыг алдаршуулан шагнал гардууллаа.

- ✓ Гэрээр ном олгох тасгийн шилдэг уншигч Бямбаа Оюунчимэг
- ✓ Хүүхдийн уншлагын танхимын шилдэг уншигч 2-р сургуулийн 3а ангийн сурагч М.Эрдэнэбилэг
- ✓ Насанд хүрэгчдийн уншлагын танхимын шилдэг уншигч 1-р сургуулийн 11д ангийн сурагч Батмагнай Манлайбаатар

- ✓ Гадаад хэлний уншлагын номын санч 1-р сургуулийн 12д ангийн сурагч Дагва Ням-Өлзий
- ✓ Албан байгууллагуудын дунд “Шилдэг” номын сан шалгаруулах арга хэмжээ
- ✓ Шилдэг номын сантай байгууллагаар **“Байгаль орчин аялал жуулчлалын газар** ” шалгарлаа.

Шагнал гардуулах үйл ажиллагаа

“Үндэсний бичиг, соёл номын баяр” арга хэмжээний хүрээнд дараах ажлууд зохион байгуулагдлаа. Үүнд:

Алтай хөгжил сонины үзэсгэлэн

Хүүхдийн танин мэдэхүйн шинэ номын үзэсгэлэн

Сонгодог зохиолын болон гадаад номын үзэсгэлэн

Үндсэн фондны үнэт ховор номын үзэсгэлэн

Номын хавчуургын үзэсгэлэн

Говь-Алтай аймгаас төрөн гарсан зохиолч Б.Ваанчиг 90 жил, Т.Очирхүүгийн 80 жил, Ч.Алагсайн 90 жилийн ойг угтан тэдний туурвиж байсан ном зохиол бүтээлийн үзэсгэлэнгүүд

Номын солилцоо

Орон нутагт номын худалдаа эрхлэгчдийн номын үзэсгэлэнгүүд дэлгэгдлээ.

Үзэсгэлэнгүүд

орон нутагт номын худалдаа эрхлэгчдийн номын үзэсгэлэн худалдаа

34 дэх удаагийн НОМЫН БАЯР, "ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023" арга хэмжээнүүдэд нийт 930 гаруй хүүхэд багачууд, ард иргэд хамрагдлаа.

Номын баярын эрхэм уншигчид

Номын баярын эрхэм уншигчид

Номын баярын эрхэм уншигчид

Танилцах үйл явц

9-р сард: Соёлын сэргэлт арга хэмжээний хүрээнд Үндэсний номын сангийн захирал Б.Ичинхорлоо даргатай баг хамт олон нийтийн номын сангийн 4 танхим, ном олголт, бусад үйл ажиллагаатай танилцан мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаа.

Бүх нийтийн соёлын боловсрол, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой СОЁЛЫН СЭРГЭЛТ-2023 арга хэмжээний нээлт 2023.09.18-нд 08:00 Нийтийн номын сангийн уншлагын танхимд “Номтой өглөө уулзалт, чөлөөт ярилцлага ном солилцоо”-ны арга хэмжээгээр эхэллээ.

НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД:

- Соёлын дэд сайд М.Батбаяр,
- Соёлын яамны Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Наранцэцэг,
- Говь-Алтай аймгийн засаг даргын тамгын газрын дарга Ш.Эрдэнэбат,
- Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газрын дарга С.Цагаанбаатар болон албаны бусад хүмүүс оролцлоо.

“Номтой өглөө уулзалт, чөлөөт ярилцлага ном солилцоо”

Үндэсний номын сангийн хамт олон номын сантай танилцаж буй нь

СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ИЛТГЭЛ:

СУИС-ийн Соёлын сургуулийн Соёл судлалын тэнхимийн эрхлэгч доктор Ph.D. Б.Мөнхбадрал **"Үндэсний нэгдмэл үнэт зүйл ба соёлын дархлаа"** сэдвээр, илтгэл тавилаа. Соёлын сэргэлт арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд Ардын дуу бүжгийн Алтай чуулгын үзэсгэлэнгийн танхимд шинэ номын үзэсгэлэнгүүд дэлгэгдэж ард иргэдийн хүртээл боллоо.

Соёлын сэргэлт арга хэмжээний нээлтийн үзэсгэлэн

9-р сард: Арга зүйч П.Дарьсүрэн, ном зүйч С.Цэрэнпил нар Төрийн бодлого чиглэлийг сум, багийн иргэдэд хүргэх 2020-2024 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг танилцуулах, орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх ажилд иргэдийн санал санаачлагыг сонсож, тусгах, иргэд малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхайгаар оршин суугаа газар нутагт нь хүргэх, тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, гарц шийдэл гаргах зорилгоор Тонхил сумын Тамч, Бүс-Уул, Зүйл, Алтайн-Оргил Дарив сумын Ихэс, Үйлдвэр, Жавхлант, Хужирт Тайшир сумын Хуримт, Далан, Галуут, Чандмань сумын Хүрхээ, Талын шанд, Чандмань-Уул, Өлзийбулаг, Эрдэнэ-Уул, Эрдэнэ сумын Сангийн далай, Цагаан-Уул, Цэцэг нуур, Өлзийт:, Цогт сумын Баянтоорой, Хөхморьт сумын Цоохор, Завхан гол, Сангийн далай, Хүйсийн говь, Сайн-Уст, Баян-Уул сумын Баянбогд, Чандмань хайрхан, Баянхайрхан, Хүйсийн говь, Баянговь, Алтангадас, Жаргалан сумын Бүрэн, Тээл, Завхан гол багуудад 09 сарын 19-нөөс 10 сарын 18-ны өдөр хүртэл ажиллаа. Нийтийн номын сангийн өдөр тутмын үйл ажиллагаа болон шинэ ном татан авалт, ном солилцооны талаарх мэдээллийг иргэдэд цаг тухай бүрт нь өгч, цаашид ажилд тусгах санал санаачлагыг тэмдэглэн авлаа.

9-р сард: Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 11 дүгээр ангийн 56 сурагчдын дунд “Номтой нөхөрлөе” номын чөлөөт ярилцлага, уулзалт хэлэлцүүлгийг хамтран зохион байгууллаа. Мөн үзэсгэлэнгийн танхимд дэлхийн сонгодог болон монголын зохиолчдын шилдэг номын дээжсээс 60 номын үзэсгэлэн гаргалаа. Уг үзэсгэлэнг 130 гаруй хүүхэд багачууд үзэж сонирхлоо.

“Номтой нөхөрлөе” номын чөлөөт ярилцлагын хэсгээс

Улсын тэргүүний 1 дүгээр сургуулийн Д.Баярмаа багштай 5а ангийн 37 сурагч,ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 7а,б ангийн 46 хүүхэд номын сантай танилцан, чанга уншлага, номын тэмдэглэл хийн долоо хоног бүрийн 1 өдрийг номтой өдөр болгон номын ертөнцөөр аялахаар боллоо.

Ном уншлага

10-р сард Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн н.Цэцэгбадам багштай 11 дүгээр ангийн 56 сурагчдын дунд "Номтой нөхөрлөе" номын хэлэлцүүлгийг Куинси Жонс зохиолчийн **"12 ноот"** номын үйл явдал өрнөл төгсгөл, зохиолчийн амьдрал уран бүтээлийн талаар санал бодлоо солилцон чөлөөт ярилцлага, уулзалтыг хамтран зохион байгууллаа.

"Номтой нөхөрлөе" номын чөлөөт ярилцлагын хэсгээс

Куинси Жонс зохиолчийн "12 ноот" номын чөлөөт ярилцлага

10-р сард 1 дүгээр цэцэрлэгийн н.Эрдэнэсүрэн багштай бэлтгэл В бүлгийн 31 хүүхэд багачууддаа Монгол ардын үлгэр “Болдоггүй бор өвгөн”, Орос ардын үлгэр “Гурван байвгай” үлгэрүүдээр чанга уншлага хийж номын сангийн үйл ажиллагаатай танилцууллаа.**“Болдоггүй бор”, “Гурван баавгай” үлгэрүүдийн чанга уншлагын**

хэсгээс

Номын сангийн үйл ажиллагаатай танилцаж буй бяцхан уншигчид

10-р сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2011 оны 12-р сарын 19-ний хурлаар жил бүрийн 10-р сарын 11-ний өдрийг "Олон Улсын Охидын эрхийг хамгаалах өдөр" болгон тунхагласан байдаг. Энэ өдрийн гол зорилго нь охидод тулгамдаж буй асуудлуудыг

шийдвэрлэх, тэдний эрхийг хамгаалах, боловсрол эзэмшүүлж, хөгжүүлэхэд нь анхаарал хандуулах, охидын эрхийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд оршдог байна.

🌞🌹❤️"Олон улсын охидын эрхийг хамгаалах өдөр"-ийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд Ерөнхий боловсролын I-р сургууль, III-р сургууль, IV-р сургуулийн төлөөлөл болсон 47 хөөрхөн охид дуу хоолойгоо хүргэн ажилласан. Энэ үйл ажиллагаанд хамтран ажилласан Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын хэсгийн ахлах мэргэжилтэн цагдаагийн хошууч Э.Одбаатар “Хүүхэд хамгаалал, Цахим орчны гэмт хэргээс өөрийгөө хэрхэн хамгаалах” сэдэвт сургалт, чөлөөт ярилцлага

Ерөнхий боловсролын IV-р сургуулийн сэтгэл зүйч Б.Буян-Арвижих “Сэтгэл хөдлөлөө удирдах чадвар” сэдэвт охидын сургалт, харилцан чөлөөт ярилцлага уулзалтыг зохион байгууллаа. Охидын сургалтанд хүрэлцэн ирсэн хөөрхөн охиддоо гарын бэлэг гардуулан ажиллалаа. ❤️🌞🌹

🌞🌹Охидоо хайрлая, хүндэлье, ойлгоё. 🌹🌞🌹

🌞🌹❤️Охидоо хайрлая, хүндэлье, ойлгоё. 🌹🌞🌹

10-р сард 1 дүгээр цэцэрлэгийн Л.Болормаа багштай бэлтгэл бүлгийн 27 хүүхэд багачууддаа Орос ардын үлгэр “Гуталт муур” үлгэрээр чанга уншлага хийж номын сангийн үйл ажиллагаатай танилцууллаа.

“Гуталт муур” үлгэрээр чанга уншлага

10-р сард Стандарт хэмжил зүйн хэлтсийн хамт олон нийтийн номын санд Стандарт хэмжил зүйн 100 жилийн ойд зориулан гаргасан “Хөгжилд тэмүүлсэн 100 жил” номоо хандивлан, Зөөврийн номын сангийн гэрээ байгуулан ажиллаа.

Ном хандивлах үйл явц

10-р сард Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолоор жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдрийг төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа иргэдэд сурталчлах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах “Нээлттэй хаалганы өдөр” болгон зохион байгуулахаар тогтоосон.

Нээлттэй хаалганы өдрийн хүрээнд тус байгууллага нь “Гайхамшигт номын ертөнц”, “Номын жигүүрээр аялцгаая” зэрэг сэдэвчилсэн 56 номын үзэсгэлэн гаргаж, уншигч иргэд, хүүхэд багачуудад үйл ажиллагаагаа 64 иргэнд сурталчлан таниулж ажиллаа.

Нээлттэй хаалганы өдөрт зориулсан номын үзэсгэлэн

Нээлттэй хаалганы өдөрт зориулсан номын үзэсгэлэн

10-р сард 10-р цэцэрлэгийн Ж.Урнаа эрхлэгчтэй хамт олон нийтийн номын сантай Зөөврийн номын сангийн гэрээ байгуулан ажиллаа.

Зөөврийн номын сангийн гэрээ байгуулах үйл явц

11-р сард Дотоодын цэргийн 825-р тусгай салбарын захирагч Г.Золбаяр дэд хурандаагаар ахлуулсан хамт олонд нийтийн номын сангийн үйл ажиллагаа, Зөөврийн номын сангийн гэрээ, ном олгох үйлчилгээний талаар танилцуулга яриаг Гэрээр ном олгох танхимын номын санч Х.Цогзолмаа танилцуулан хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаа.

Зөөврийн номын сангийн гэрээ байгуулах үйл явц



11-р сард Соёлын бүтээлч сар аяны хүрээнд Бүтээлч уншлагын цаг: Хүүхдийн уншлагын танхимаас ЕБС-ийн 4-6 ангийн сурагчдын дунд “Бүтээлчээр уншъя аян”-ыг сарын хугацаатай зохион байгуулан хүүхэд багачуудыг өргөнөөр хамрууллаа. Нийт 10 бүлгийн 250 хүүхэд хамрагдлаа.

Бүтээлч уншлагын цагийн хэсгээс

11-р сард Соёлын бүтээлч сар аяны хүрээнд ЕБС-ийн 12-р ангийн сурагчдын дунд “Номтой зочин” цуврал контентийг бэлтгэн явууллаа. Нийт 6 ангийн 120 сурагчид оролцон авхаалж самбаа, эрдэм мэдлэгээ сорин уралдлаа.

“Номтой зочин” цуврал контентийн хэсгээс

11-р сард Соёлын бүтээлч сар аяны хүрээнд “Гэгээн өглөө” уншигч зохиолчдын уулзалтыг ЕБС-ийн 12-р ангийн сурагчдын дунд “Гэгээн өглөө” уншигч, зохиолчийн уулзалтыг хийлээ. Уулзалтанд зочин оролцогчоор “Алтайн хөх салхи”-ийн зохиолч, яруу найрагч Эрдэнэ-Очир оролцон ГАА-аас төрөн гарсан зохиолчдын тухай сонирхолтой түүх баримтыг өгүүлж мөн өөрийн судалгааны талаарх мэдээллийг хүргэлээ.

“Гэгээн өглөө” уншигч зохиолчдын уулзалтын хэсгээс

11-р сард Соёлын бүтээлч сар аяны хүрээнд Үлгэрийн баатрууд амилсан нь дүрийн тоглолтыг Есөнбулаг сумын 4-р цэцэрлэгийн 5 бүлгийн 100 хүүхэд багачуудын дунд “Үлгэрээс үлгэрлэе-үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолтыг зохион байгууллаа. Үлгэрийн баатрууд амилсан нь дүрийн тоглолтын 1-р байрыг Ц.Наранцацрал багштай бэлтгэл А бүлгийн “Говьдоо үнэнч мазаалай” багшийнх нь зохион найруулсан зохиомжит үлгэр, 2-р байранд Г.Энхбаяр багштай холимог бүлгийн “Барыг айлгасан амьтад” үлгэр, 3-р байранд С.Болор-Эрдэнэ багштай ахлах бүлгийн “Тэнэг бяцхан хулганы үлгэр”-үүд тус тус эзэллээ.

“Үлгэрээс үлгэрлэе-үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолтын хэсгээс

11-р сард “Соёлын бүтээлч сар” арга хэмжээний хүрээнд Улс тунхагласны баярын өдрийг тохиолдуулан Нийтийн номын сангаас “Шагайн наадгай” тэмцээнийг аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд 11-р сарын 28-нд Нийтийн номын санд зохион явуулав. Тус арга хэмжээ нь хүүхэд багачуудад ардын тоглоом наадгайг сурталчлан таниулах ард түмний бахархал, үнэт зүйлийг сэргээн, эх хэл, түүх, өв соёлоо дээдлэн, эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэн, нийгмийг соён гэгээрүүлэх зорилготойгоор явагдлаа.

Шагайн наадгайн тэмцээнд аймгийн төвийн Ерөнхий боловсролын 5 сургуулийн 10-р ангийн нийт 25 сурагч, сургуулийн номын санч бусад багш нараар удирдуулан идэвхтэй оролцлон хурд хүч авхаалж самбаагаа сорин уралдлаа.

1-р байранд 4-р сургуулийн “Таван нүдэн” баг, 2-р байранд 1-р сургуулийн “Домог” баг, 3-р байранд 2-р сургуулийн “Таван шагай” баг, тусгай байранд “Таван эрдэнэ” баг тус тус шалгарлаа.

“Шагайн наадгай” тэмцээний хэсгээс

11-р сард Шүлгийн уралдаан /хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд/

"СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР" аяны хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг угтаж аймгийн ХБ-тэй хүүхэд багачуудын дунд "Миний унших дуртай шүлэг" шүлгийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд нийт 12 хүүхэд оролцлоо. 1-р байранд 3-р сургуулийн 3в ангийн сурагч Ц.Эрхсаран Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгээр 2-р байранд 2-р сургуулийн 7в ангийн сурагч Л.Сэмжид Ц.Хулангийн “Ээждээ” шүлгээр, 3-р байранд 4-р сургуулийн сурагч М.Жавхлантөр П.Бадарчийн “Эхийн сэтгэл” шүлгээр тус тус байр эзэллээ.

"Миний унших дуртай шүлэг"-ийн уралдааны хэсгээс

12 сарын 1-нд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан гэрээр ном олгох тасгаас ХБ –тэй иргэдийн дунд “Би чадна” танин мэдэхүйн уралдааныг амжилттай зохион явууллаа. Уг танин мэдэхүйн уралдаанд 25 хүн оролцсон.

“Би чадна” танин мэдэхүйн уралдааны хэсгээс

12 сарын 1-нд Соёлын яамны санаачилгаар эхлүүлсэн "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд аймгийн хэмжээнд "Өвөл цагийн соёл хүмүүжлийн ажил"-ыг 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 02-ны хооронд нэг сарын хугацаатайгаар зохион байгуулсантай холбогдуулан **"Өвлөгддөг өв" гэрийн номын сан танилцуулах видео бичлэгийн уралдааныг** цахим хэлбэрээр амжилттай зохион байгууллаа. Энэхүү ажлын гол зорилго нь хүүхдүүдийн ихэнхи цагаа өнгөрүүлдэг газар болох гэрийн орчинг номоор тохижуулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах, ард иргэд өөрийн номын сангаа сурталчилах, номын сангийн баяжилт, тохижуулалтаа өөр хоорондоо танилцуулах, ном унших соёлыг түгээн дэлгэрүүлэхэд оршино. Уралдаанд оролцогчид өөрсдийн видео бичлэгээ Говь-Алтай Нийтийн номын сан фэйсбүүк хаягаар дамжуулан хүлээн авч, олон нийтэд түгээн сурталчилсан. Уралдаанд:

- I байранд Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 9Б ангийн сурагч Ц. Цэлмэг 292 like 91 share
- II байранд Төгрөг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 5Б ангийн сурагч Н. Мөнх-Оргил 280 like 68 share
- III байранд сурагч Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12А ангийн сурагч П. Авирмэд 245 like 82 share цуглуулж тус тус шалгарлаа. Уралдаанд оролцож шалгарсан сурагчдад өргөмжлөл, мөнгөн шагнал, номоор шагнаж урамшууллаа.

"Өвлөгддөг өв" гэрийн номын сан танилцуулах видео бичлэгийн уралдааны шагналтнууд

5. СУРГАЛТ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Арга зүйч П.Дарьсүрэн "Алсын хараа-2050" МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023" арга хэмжээний хүрээнд, Номын сангийн тухай хуулийн шинэчилсэн

найруулгаар сумдын номын санч нар болон ЕБС-ийн номын санч нарт цахим сургалт зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

9-р сард: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол улсын Урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Үндэсний номын баяр-2023” арга хэмжээг 2023 оны 09 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлаа хийж байна. Уг ажлын хүрээнд 18 сумын соёлын төвийн номын санч нарт номын сангийн тухай шинэчлэгдсэн журам, шинэ бүртгэлийн программын тухай цахим сургалтыг арга зүйч П.Дарьсүрэн зохион байгууллаа. Мөн уг арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын сургалт мэдээллийн албатай хамтран Ерөнхий боловсролын дунд ангийн сурагчдын дунд “Замын хөдөлгөөний аюулгүй, байдал, дүрмийн тухай” сургалтыг зохион байгууллаа.

Сургалтын явц

Сургалтын явц

9-р сард: Үндэсний номын сангийн гадаад үйл ажиллагаа хариуцсан номын санч Х.Нарандулам нийтийн номын сангийн номын санч нарыг чадавхжуулах сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Сургалтын явц

10-р сард Номын сангийн 10 номын санч, ажилчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” болон хуулийн хэрэглээ”, мөн “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын талаар лекц хичээлийг орж харилцан ярилцлаа.

Сургалтын явц

11 дүгээр сарын 03-нд Соёлын бүтээлч сар аяны хүрээнд Австралийн Элчин Сайдын Яам, Монгол Улсын Үндэсний Номын Сан, Монголын Номын Сангийн Холбоо хамтран хэрэгжүүлж буй “Хил хязгааргүй номын сан” төслийн баг 2023 оны 11 дүгээр сарын 02-04 өдрүүдэд Говь-Алтай аймагт ажиллалаа. Уг арга хэмжээний хүрээнд 11 дүгээр сарын 03 өдөр аймгийн төв Алтай хотод Австралийн ЭСЯ-ны Хөгжлийн хөтөлбөр хариуцсан ахлах менежер Х.Өрнөх, МНСХ-ны Гүйцэтгэх захирал М.Даваасүрэн, МҮҮНС-ийн Хүний нөөцийн мэргэжилтэн Д.Мөнхгэрэл нар чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулж, нийтийн номын сангийн хүүхдийн уншлагын танхимд **хавдиваар 92** үлгэрийн болон танин мэдэхүй, орчин үеийн хүүхдэд нэн хэрэгцээт шинэ шилдэг номоор хүүхдийн номын фондыг баяжуулав.

Австралийн нийтийн номын сан, хэрэглэгч төвтэй үйлчилгээ, технологийн дэвшлийг ашиглан хамтран ажиллах нь сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт аймгийн төв, сумдын нийтийн номын сангийн номын санчид хамрагдлаа.

“Хил хязгааргүй номын сан” сургалт хэлэлцүүлгийн үйл явц

“Хил хязгааргүй номын сан” сургалт хэлэлцүүлгийн үйл явц

Номын сангийн үйл ажиллагаатай танилцах үйл явц

11 сарын 15-16-нд Соёлын бүтээлч сар аяны хүрээнд “**Номын санч-мэдээллийн ажилтны улсын зөвлөгөөн**”-ийг төрийн захиргааны байгууллага, номын сан, хувийн хэвшлийн 120 гаруй төлөөлөл танхимаар, 200 гаруй хот, орон нутгийн нийтийн номын сангийн ажилтнуудыг цахимаар хамруулан зохион байгуулсан арга хэмжээнд Нийтийн номын сангийн арга зүйч П.Дарьсүрэн, ном зүйч С.Цэрэнпил нар хамрагдлаа. Зөвлөгөөнийг үндэсний ном зүйн туршлага, удирдамж гарын авлагад тулгуурлан номын сангийн мэдээллийн нэгдсэн систем, төлөвлөлт, цаашдын хөгжил, хамтын ажиллагааны чиглэлээр албан хаагчдад мэдлэг мэдээлэл олгосон арга хэмжээ боллоо.

“Номын санч-мэдээллийн ажилтны улсын зөвлөгөөн”

12 сард “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх”, “Цагаан туузтан” 16 хоногийн аяны хүрээнд Говь-Алтай аймгийн Нийтийн номын сангийн арга зүйч П. Дарьсүрэн Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын III сургуулийн Тунгалагтуул багштай 10А ангийн сурагчдад 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр “Жендэрийн хэвшмэл ойлголт”, “Жендэрт суурилсан хүчирхийлэл”, “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх цагаан туузтаны аян” зэрэг сэдвээр сургалт зохион байгууллаа. Мөн хүчирхийллийн эсрэг уриа, баннерийг тарааж, сургуулийн мэдээллийн самбарт байршууллаа.

Сургалтын явц

6. ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол улсын ойн тухай хууль, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан “108 сая мод тарьж, ургуулах” аяны хүрээнд 270 ш модыг тарьж, цаашид арчилж тордон, ургуулах ажлыг хариуцахаар боллоо.

Мод тарих явц, усалгаа

2023 оны эхний хагас жилд байгууллагын гадна орчны цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн ажиллаа. Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд аймгийн 40 жил өндөрлөгийг сэргээн засварлаж будаж тохижууллаа.

Өндөрлөгийн засвар үйлчилгээний ажлын үйл явц

Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд байгууллагын гадна талбайд мод тарьж зүлэгжүүлэн ажиллаа.

Мод тарих, зүлэгжүүлэх үйл явц

Цэвэр-Алтай аяны хүрээнд байгууллагын ойр орчмын 50 м газрыг долоо хоног бүрийн баасан гараг тогтмол цэвэрлэн ажиллаж байна.

Цэвэрлэгээ үйлчилгээ

Гадна талбайн өнгө үзэмжийг сэргээн байгууллагын гадна шилэн фасад, бусад засвар үйлчилгээг хийн ажиллаа.

Гадна талбайн өнгө үзэмж сэргээн засварлаж байгаа нь

8-р сард: Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадамд зориулан байгууллагын гадна талбайд тохижилт үйлчилгээ хийн уншигчдын ая тухтай байдлыг хангаан нарны сүүдрэвчийг хийж ашиглалтад оруулаа.

Сүүдрэвч

8-р сард: Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд байгууллагын дулааны болон цэвэр, бохир усны шугам, сүлжээний хоолой, хаалт тагны аюулгүй байдлыг ханган ажиллаа.

Өвөлжилтийн бэлтгэл

8-р сард: Ажилчдын ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэн "Амрах өрөө"-г шинээр тохижуулан ашиглалтанд оруулллаа.

Амрах өрөө

10-р сард Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нийтийн их цэвэрлэгээнд идэвхтэй хамрагдан аймгийн 60 жилийн өндөрлөг болон байгууллагын ойр орчмын 50 метр газрын хог хаягдал, чулуу, хогийн ургамлыг цэвэрлэн ажиллалаа.

Цэвэрлэхийн өмнөх

Цэвэрлэсний дараах

10-р сард Монгол Улсын ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан “108 сая мод тарьж, ургуулах” аяны хүрээнд хаврын мод тарих өдрийн хүрээнд тарьж ургуулсан 260 ширхэг хамгаалалтын модны хог хаягдал, зэрлэг болон хогийн ургамал, шарилжийг цэвэрлэн арчилж тордон, усалгаа хийж нэмэлтээр 10 модоор нөхөн тариалалт хийн ажиллаа.

Мод услах, хог хаягдал болон хогийн ургамал шарилж цэвэрлэх явц

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Удирдлага зохион байгуулалт:

Нийтийн Номын сан нь үйл ажиллагаандаа Номын сангийн тухай хууль, Соёлын тухай хууль, Монгол хэлний тухай хууль болон Төрөөс соёлын талаар баримтлах бодлого хөтөлбөр, бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Энэ хугацаанд үндсэн үйл ажиллагаатай холбоотой “А” тушаал 27, хүний нөөцийн холбогдолтой “Б” тушаал 35, нийт 62 тушаалыг холбогдох хууль эрх зүйн хүрээнд хяналтын дагалдах хуудсыг хавсарган гаргаж, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм журмын дагуу байгууллагаас явсан 132, бусад байгууллагаас ирсэн 89, ирсэн хариутай бичиг 61, өргөдөл 40 хүлээн авч хугацаанд нь хариуг нь шийдвэрлэсэн. Албан бичиг хэргийг үндэсний бичигтэй хослуулан тушаал 7, явсан бичиг 16-г хөтлөн ажилласан.

Албан хэрэг хөтлөлтийг анхан шатанд баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг ханган ажиллаж, хариутай албан бичигт хариуг нь хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

Уншлага үйлчилгээний ажлын хүрээнд:

Нийт 6673 уншигчдад 5587 ном хэвлэл олгож үйлчилсэн. Үүнээс

- Уншлагын танхимаар 2797 уншигчидад 4709 ширхэг ном
- Гэрээр ном олгох үйлчилгээг 250 уншигчдад 417 ширхэг ном
- Зөөврөөр номын үйлчилгээг 167 уншигчдад 340 ширхэг ном
- Тусгай бүлгийн 32 уншигчдад 93 ширхэг ном
- Хөгжлийн бэрхшээлтэй 7 уншигчдад 7 ширхэг ном
- Цахим номын үйлчилгээг 69 уншигчдад 121 ширхэг ном хэвлэл тус тус олгож үйлчилсэн.

Хөдөөгийн 4,5,6 дугаар багын иргэдэд 2023 оны 05 дугаар сарын 04, 05, 06,--ны өдрүүдэд 10 дугаар сарын 28-ны өдөр 4-р багийн 5 өрхөд нүүдлийн номын сангийн

үйлчилгээг 2 удаа 425 уншигчдад хүргэсэн. Байгууллагын үйл ажиллагааны танилцуулга мэдээлэл хүргэж, 150 ширхэг боршур гарын авлага тараасан.
Шинэ номын үзэсгэлэнг 304 ширхэг номоор гаргаж цахим номын үйлчилгээ үзүүлсэн.
Танин мэдэхүйн "Алтан хонх" цэнгээнт тэмцээнийг зохион байгуулж, санал асуулгыг 49 иргэнээс авсан.

Лавлагаа ном зүйн ажлын хүрээнд:

Лавлагаа ном зүйн үйлчилгээг цахимаар болон амаар, бичгээр нийт 764 уншигчдад лавлагаа өгсөн. Номын татгалзалд бүртгэсэн нийт 87 ширхэг ном.

Фондны сан хөмрөгийг баяжуулах ажлын хүрээнд:

Төсвийн хөрөнгөөр 56 нэр төрлийн 133 ширхэг, Бэлэг хандиваар 967 нэр төрлийн 1218 ширхэг, Нийт 1023 нэр төрлийн 1351 ширхэг ном, хэвлэлээр баяжуулсан.

Цахим номын фондыг хандивын хөрөнгөөр түүх, уран зохиол, аман зохиолын хэвлэмэл бус цахим 80 номоор баяжуулсан.

Бэлэг хандиваар ирсэн номыг Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хамтарсан 357/406 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтыг үндэслэн үнэлгээ хийж, данс бүртгэлд тусгасан.
Lib4 программд 1406 номын мэдээлэл болон товч агуулгыг зурагтай нь оруулсан.
Электрон каталогийн 1100 номонд редакц хийж цаасан каталогийг төрөл анги үсэг дараалаар каталогийн шүүгээнд байршуулсан.

"MIND UPDAIT" ТӨСЛИЙН 21 аймгуудын дунд зохион байгуулагдсан "Эерэг давалгаа" челленжид оролцон ялалт байгуулан 2000 номын эзэнээр шалгаран ЕБС-ийн 1,2,3,4,5-р сургуулиудын номын сангийн номын фондыг нийт 1000-н номоор баяжуулсан.



Ном хэвлэлийг сэлбэн засах ажлын хүрээнд: Сан хөмрөгийн урагдаж гэмтсэн 145 номыг сэлбэн засаж уншлагад гаргасан.



Ном хэвлэх сурталчлах ажлын хүрээнд: Шинэ номын үзэсгэлэнг 2 удаа, Сэдэвчилсэн номын үзэсгэлэн 12 удаа гаргаж Нийт 620 ном хэвлэлийг сурталчилсан.

Монгол бичгийн өв соёл, сурвалж, судалгааг сурталчлсан Монгол бичгийн 88 номын үзэсгэлэнг 2023 оны 06 дугаар сарын 05-аас 07-ны өдрүүдэд зохион байгуулж 114 уншигч үзэн сонирхсон.

Сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:

Албан хаагчид жилийн хугацаанд 22 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 90 удаа хамрагдсан.

“Боржигидай сэцэн” утга зохиолын салбартай хамтран “Ном оюуны түлхүүр” уншсан 13 номын хэлэлцүүлэг, ярилцлага, контентийг 4 удаа зохион байгуулсан. “Ирээдүйн Монгол”, “Өсвөрийн номын санч” клубын 163 хүүхдүүд хамрагдсан. “Говьсүмбэр номын сан” цахим хаягаар олон нийтэд хүргэсэн.

Утга уран зохиолд дуртай , бичих, унших сонирхолтой иргэд хүүхэд залуусын дунд чөлөөт ярилцлага контент зохион байгуулсан.

Иргэдийн хамтдаа амьдрах соёл, ахуйн соёл, монголчуудын эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйлээр гарын авлага бэлтгэж ЕБ-ын 2 дугаар сургууль, 1-р сургууль лаборатори 5 дугаар сургуулийн дунд ангийн 129 сурагчдад сурталчилан таниулах арга хэмжээг зохион байгуулсан.

Номын баярын хүрээнд:

"Буйлс цэцэглэх цагаар” Говьсүмбэрт “Илүү их уншъя" уриан дор 33 дахь удаагийн “Үндэсний номын баяр 2023” арга хэмжээг 45 хүний бүрэлдэхүүнтэй 05-р сарын 19-ны өдөр зохиогдсон тус арга хэмжээнд 1934 иргэн оролцсон .Тус арга хэмжээ “Номын ертөнц” сэтгүүлд нийтлэгдсэн.

“Үндэсний номын баяр-2023” УИХ-ын дарга Г.Занданшатарын ивээл дор Улаанбаатар хотод 33 дахь удаагийн номын баярын арга хэмжээнд орон нутгаас манай аймаг анх удаа оролцсон.

Номын баярын үеэр Боржигин нутгийн онцлог, давуу талуудыг сурталчилсан 8 байгууллагын 31 төрлийн 820 ширхэг тараах материал гарын авлагыг тарааж, аймгийн танилцуулга мэдээллийг 2500 гаруй хүнд хүргэлээ.

"Номтой Монгол" уриан дор зохион байгуулагдаж буй 34 дэх удаагийн “Үндэсний бичиг соёл”, “Номын өдрүүд-2023” намрын арга хэмжээг Нийтийн номын сангийн уншлагын танхимд 09 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд 6 төрлийн арга хэмжээнд 221 иргэн оролцсон.

Соёл олон нийтийн ажлын хүрээнд:
“MIND UPDATE” төслийн хүрээнд:
21 аймгуудын дунд зохион байгуулагдсан “Эерэг давалгаа” челленжид оролцон ялалт байгуулан 2000 ном, 10.000.000 төгрөгийн үнэ бүхий иж бүрэн номын сангийн тавилга хийлгэх эрхийн бичгийн эзэн болсон.

“Хамтдаа суралцъя” сэдэвт Монгол бичгийн уншлага 2 үе шаттай зохион байгуулсан.
Аймгийн Боржигадай Сэцэн салбарын гишүүд, иргэд, уншигчдын дунд “Уншсан номын хэлэлцүүлэг”, Утга уран зохиолд дуртай , бичих, унших сонирхолтой иргэд хүүхэд залуусын дунд “Чөлөөт ярилцлага контент” Төрийн болон ТББайгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд “Өглөөний уншлага” зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн.

Соёлын сэргэлт 2023 аяны хүрээнд “Эртэч Оюунлаг” өглөө арга хэмжээ зохион байгуулагдаж, Соёлын дэд асад М.Батбаяр соёлын салбарын төлөөлөлтэй уулзан чөлөөт ярилцлага өрнүүлж, харилцан ном солилцсон. Арга хэмжээнд Аймгийн Соёл урлагийн газар, Нийгмийн бодлогын хэлтэс, Нийтийн Номын Сан, Боржигин өв музей, Боржигин чуулга, Оюун хур номын дэлгүүр зэрэг байгууллагуудын залуучуудын төлөөлөл оролцлоо.

“Оюуны чихэр” үндэсний бичгээр номын тухай онч мэргэн үгсийг хийж угтах үйлчилгээн дээр байрлуулсан.

“Номын хавчуурга” үндэсний бичгээр онч үгс, зүйр цэцэн үгсийг хэвлэн гаргаж шинээр ирсэн 300 ширхэг номонд байршуулсан.

“Номын богц” 2ширхэгийг хийж, зөөврийн номын үйлчилгээнд ашиглаж байна.

“Оюунлаг гэр бүл” ном уншлагын сарын аяныг 2023 оны 04 дүгээр сарын14-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зохион байгуулж 18 гэр бүлийн 72 уншигчид хамрагдсан.

Боржигин нутгийн зохиолч яруу найрагчдын уран бүтээлийн үзэсгэлэнг гаргасны зэрэгцээ “Тусгаар тогтнол ба Богд хаан” сэдвээр СГЗ, зохиолч Б.Шүүдэрцэцэг, “Соёл танин мэдэхүйн ажил гэж юу вэ”, “Номын соёлт ертөнц” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Сувд, “Ном бичихэд бэлэн үү”, ”Уран зохиол утга зохиол гэж юу вэ?” сэдвээр Д.Нацагдоржийн шагналт хүүхдийн зохиолч Д.Мандал нар лекц уншин хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Мөн dream grill ресторантай хамтран “Мэдрэмжийн үдэш” яруу найргийн уншлагыг зохиож орон нутгийн зохиолч яруу найрагчид болон СГЗ, зохиолч Б.Элбэгзаяа, модернист яруу найрагч Б.Галсансүх нар оролцлоо. Боржигин нутгийн зохиолч яруу найрагчдын уран бүтээлийн үзэсгэлэнг гаргасан. Нийт 255 иргэд, уншигчид хамрагдсан.

“Боржигидай сэцэн П.Бөхбат 60” Монгол туургатны яруу найргийн наадам”-ыг Улаанаатар хотноо Улсын Хүүхэлдэйн театрт зохион байгуулсан. 4 орны 63 найрагч оролцож шагналт 5 байр тодруулж 180 иргэд үзэж сонирхсон

Монгол улсын “Алсын хараа 2050” урт хугацааны хөтөлбөрт соён гэгээрлийн уран зохиолын олон талт үйл ажиллагааг хөгжүүлэх, аймгийн Засаг даргын мөрийн

хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд :“Дэлхийн яруу найргийн өдөр”-ийг тохиолдуулан “Зохиолч уншигчид”-ын уулзалт “Найргийн зөн” яруу найргийн уншлагыг 2023 оны 02 дугаар сарын 21 өдөр зохион байгуулсан. Үйл ажиллагааны үеэр МЗЭ-ийн шагналт, Г.Сэр-Одын шагналт яруу найрагч Б.Энхтөрийн “Цагаан хүж” шинэ номын нээлтийг зохион байгуулсан. Нийт 53 иргэд уншигчид хамрагдсан.

МЗЭ-ийн болон Д.Нацагдорж, С.Буяннэмэхийн шагналт, соёлын гавъяат зүтгэлтэн Р.Батжаргалын “Нүцгэн ноён” шинэ номын нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан.Нийт 62 иргэд уншигчид хамрагдсан.

Соёл урлагийн газрын харьяа байгууллагуудын “Нээлттэй өдөрлөг” үйл ажиллагааг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр:

- ✓ Номын сангийн үйл ажиллагааг сурталчилсан мэдээлэл, танилцуулга, видео шторк бэлтгэсэн
- ✓ Танин мэдэхүйн АХА цэнгээнт тэмцээн
- ✓ Цахим номын электрон каталоги сурталчлах
- ✓ Ауидо сонсдог номын үйлчилгээ
- ✓ Шинэ номын үзэсгэлэн худалдаа
- ✓ Шинээр уншигчийн карт нээх
- ✓ Татгалзлын дэвтэрт шаадлагатай номын судалгаа авах
- ✓ Номын сангийн танилцуулга,
- ✓ Номын сангийн хуулинд орсон нэмэлт өөрчлөлтийн танилцуулга
- ✓ Цахим номын танилцуулга
- ✓ Ном унших арга зүй зэрэг гарын авлага хийж иргэдэд уншигчдад сурталчилсан.

Говьсүмбэр аймаг болон Унгар улсын Элчин сайдын яамны хамтын ажиллагааны хүрээнд Унгар улсын алдарт яруу найрагч Пэтөфи Шандорын мэндэлсний 200 жилийн ойг тохиолдуулан тус улсын алдарт яруу найрагч “Пэтөфи Шандорын шүлгүүдийг хэн сайн унших вэ” тэмцээнийг ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Алдарт яруу найрагч Пэтөфи Шандорын “Эрх чөлөөний дууч Пэтөфи Шандор” шүлгийн номыг Говьсүмбэр аймгийн Соёл урлагийн газрын дарга, МЗЭ-ийн шагналт яруу найрагч Баатарын Энхтөр орчуулсан юм.

Дээд шатны удидлагаас болон ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд.

Бүх нийтээр мод тарих ажилд идэвхитэй оролцож, Сум дундын ойн ангийн хуваарилсан газарт 70 ширхэг хайлаас модыг тарьсан.

Байгууллагын хувиарт ногоон байгууламжийн талбай буюу авто замын дагуу баруун талын 2014/11 ойн зурвас газрын хашааг янзалж, ойр орчмын хогийг цэвэрлэн, тарьсан модоо тогоолж шинээр 25 ширхэг агч, 50 ширхэг хайлаас мод нийт 75 мод тарьсан.

2020 оноос хойш тарьсан модны нийт тоо 458, ургасан модны тоо 435. Ургалтийн хувь 95%.

Байгууллагын ойр орчмын 50 метр газрын цэвэрлэгээг зохион байгуулж 14 хоног тутамд 46 удаа цэвэрлэгээ Сүмбэр сумын Засаг Даргын Тамгын Газарт тайланг хүргүүлсэн.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. НОМЫН САНГИЙН АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО ЗОРИЛТ

Алсын хараа: “Мэдлэгийг түгээж, соёлыг өвлүүлнэ”
Эрхэм зорилго: Соёлын үйлчилгээ - Хөгжлийн баталгаа

Төрөөс соёлын талаар баримтлах бодлого шийдвэрийг Аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, соёл танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулж, оюутан сурагчид, иргэд, уншигчдын оролцоог нэмэгдүүлэх, ажил үйлчилгээгээ танхимын болон цахим хосолсон хэлбэрээр явуулж, номын сангийн таатай орчинг бүрдүүлэх, иргэд уншигчдынхаа хэрэгцээ шаардлагыг хангах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг олон хэлбэрээр номын сангийн үйл ажиллагааг сурталчлан ажиллаж байна.

ХОЁР. НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, БОДИТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Дархан-Уул аймгийн Төв номын сан нь:

- Уншигчдад номын сангийн үйлчилгээг үзүүлэх
- Бүх нийтийн соёлын боловсрол олгох
- Түүгээр дамжуулан номын сангийн боловсролын хөтөлбөрүүдийг бий болгож уншигч, иргэдэд хүргэх
- Сан хөмрөгийг байнгын эргэлтэд оруулах
- Номын сангийн үйлчилгээг цахим болгох
- Орон нутгийн нийт номын санчдыг арга зүй мэдээллээр хангах
- Төр хувийн хэвшил, ТББ, ОУБ-уудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг олон талт хэлбэрээр үйл ажиллагааг иргэдэд хүргэхээр зорин ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар манай аймагт Төв номын сангийн төв болон салбар 2, Ерөнхий боловсролын 26 сургуулийн номын сан, номын сан болон номын сангийн булантай цэцэрлэг -15, Их дээд, МСҮТ зэрэг 9 сургуулийн номын сан, Орхон, Хонгор, Шарын гол сумын Соёлын төвийн номын сан 3, Хүүхдийн номын ордон 1, төрийн байгууллага 4, багийн төв 2 нийт аймгийн хэмжээнд 62 номын сан ажиллаж үйл ажиллагааны чиглэл болон уншигчийн бүтэц, үйлчилгээ үзүүлж буй салбарын иргэдийн нас насны онцлогт нийцүүлэн соён гэгээрүүлэх ажлыг явуулж байна.

Мөн Дархан-Уул аймагт номын клуб 6; 680 гаруй ангийн номын сантай сургууль, цэцэрлэг байна. Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа номын сангуудын хамтын ажиллагаа, үйлчилгээ, соёл олон нийтийн ажлуудын оролцоо, иргэдийн унших идэвхийг дэмжих нөлөөллийн ажлуудад оролцож буй тоо өссөн нь номын сангийн үйлчилгээний хүртээмж сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгааг харуулж байна.

Номын санч: Аймгийн ЕБСургуулийн 22, Их дээд, коллежийн 12, Сумдын 3, Хүүхдийн номын ордны 9, Төв номын сангийн 11, нийт **57** номын санчийн судалгааг хүснэгтээр харуулав.

Аймгийн номын санчдын судалгаа

д/д	Байгууллагууд	Насны ангилал			Мэргэжлийн номын санч	Мэргэжлийн бус номын санчид	Нийт номын санчийн тоо
		18-35	**36-55**	**55-аас дээш**			
1	Төв номын сан	**1**	**10**		**8**	**3**	**11**
2	Хүүхдийнномын ордон	**8**	**1**		**7**	**2**	**9**
3	Сумдын Соёлын төв		**3**		**1**	**2**	**3**
4	Их дээд сургууль, коллеж	**2**	**7**	**3**	**6**	**6**	**12**
5	ЕБСургуулиуд	**2**	**15**	**5**	**7**	**15**	**22**
	Нийт						**57**

Номын сангийн үйлчилгээг /соёл олон нийтийн ажил/ тасралтгүй явуулж, боловсон хүчнийг тогтмол сургаж, чадавхижуулах, сан хөмрөгийг баяжуулах, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл, зориулалтын барилга байгууламж, олон нийтийн идэвхгүй байдал зэрэг нь үйл ажиллагааг тогтмол, эрчимтэй явуулахад хүндрэл үүсгэдэг. Иймд дээрх асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд өөрсдийн нөөц боломжийн хэмжээнд шийдвэрлэсэн зарим ажлуудаас тоймлон оруулав.

Жил бүр төсөв дээр номын сангийн програмын төсөв батлагдаж ирдэггүй тул төрийн санд байгууллагын захирлын 2023.10.25-ны 116 тоот албан хүсэлтийг хүргүүлсэнээр, өөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж, 2023 оны darkhan.Lib4U.net номын сангийн программын 1 жилийн лицензийн төлбөрийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний-210801 зардал дээр тавиулж, оны эцэст өр авлагагүй гарлаа.

Монгол Улсын Үндэсний номын сан, Австралийн Элчин Сайдын Яам, Монголын номын сангуудын холбооноос хамтран зохион байгуулсан “Хил хязгааргүй номын сан“ төслийн хүрээнд Дархан-Уул аймгийн нийтийн болон сумдын, их дээд сургууль, ЕБС-ийн 47 номын санчид сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах анги танхим, зэргийг шийдвэрлүүлэх хүсэлтийг 2023.09.12-ны 95 албан тоотоор Аймгийн ЗДТГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэв.

2023 онд нийтдээ санхүүжилт хүссэн 18 удаа албан тоотыг холбогдох газруудад хүргүүлж, 6 удаагийн үйл үйл ажиллагаанд 16,9 сая төгрөгийг гадны байгууллагын санхүүжилтээр олсон байна. Гаднаас олсон санхүүжилтийн мэдээ:

- Да.Дархан ЗДТГ-2,1 сая төгрөг /үндэсний бичиг соёл номын баяр/
- Да.Дархан ЗДТГ-10,0 сая төгрөг /номын үнэ/
- Да.Дархан ЗДТГ-2,0 сая төгрөг /№02-А/47 тоот тушаалаар номын баяр/
- ХААИС-1,0 Сая төгрөг /тэнгэрийн заадас хэлэлцүүлэгт/
- Дархан төмөрлөг-1,3 сая төгрөг /номын баяр/
- Дархан тээвэр-0,5 мянган төгрөг/номын баяр хандив/ нийт **16,9 сая төгрөг**

Дархан-Уул аймгийн Төв номын сан нь төрийн болон ТББ, олон нийтийн байгууллага, ОУБ-уудтай байнгын хамтран ажиллаж үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллийг нэмэгдүүлэх, төсөв санхүүгийн асуудалд дэмжлэг авах, харилцан туслалцах зарчмаар тулгарч буй асуудлуудад шийдэл олж, ажилласаар байна.

“Ном хэвлэлийн стандарт хэлэлцүүлэг”:

Соёлын бүтээлч сар аяны хүрээнд "Ном хэвлэл, утга зохиол"-ын салбарын хамтын ажиллагааг орон нутагт сайжруулах, бэхжүүлэх, Үндэсний номзүйн бүрдүүлэлтийг орон нутагт жишиг болгох зорилгоор “НОМ ХЭВЛЭЛИЙН СТАНДАРТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”-ийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт орон нутгийн зохиолчид, хэвлэлийн үйлдвэр, Төв номын сангийн номын санчид болон ахмад номын санчдын төлөөлөл оролцсон бөгөөд Аймгийн Төв номын сангийн Захиргаа аж ахуйн нэгжийн дарга Г.Нямцэнд "Номын сангийн стандарт ба тулгамдаж буй бэрхшээл", Номзүйч Х.Отгонбаяр "Номын сангийн тухай хууль" сэдвээр танхимын мэдээлэл, МУҮНС-ийн аргазүйч В.Түвшинтогтох "Утга зохиол, ном хэвлэлийн салбар"-ын хамтын ажиллагаа, орон нутгийн соён гэгээрэл сэдвээр цахим сургалтыг хийж, ном хэвлэлийн стандартын алдаа оноогоо ярилцаж, цаашид хэвлэн нийлэгчид өөрийн ажилдаа өнөөдрийн хэлэлцүүлгээс гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхээр болов.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААР

3.1. Номын сангийн сан хөмрөг

Ном бүрдүүлэлтийг “Номын сангийн хууль” болон ном худалдан авах журмын дагуу татгалзлал, уншигчийн судалгаанд үндэслэн номын худалдаа, зохиолч, уран бүтээлчид, ард иргэдийн хандив, тусламжаар фондоо бүрдүүлж ирлээ. 2023 онд нийт 23,598,580 төгрөгийн 769 нэр төрлийн 1152 боть номоор фондоо баяжууллаа. Үүнээс :

- ✓ Хандиваар 319 нэр төрлийн 418 боть 6,193,920 төгрөг
- ✓ Худалдаагаар 450 нэр төрлийн 734 боть 17,404,660 төгрөг

№	*Номын фондын үзүүлэлт*	*2021 он*		*2022 он*		*2023 он*	
		тоо	*үнэ*	*тоо*	*үнэ*	*тоо*	*үнэ*
1	НИЙТ ДҮН	742	15,865,500	1751	15,818,450	1152	23,598,580
2	Худалдаагаар	543	12,473,218	555	9,306,260	734	17,404,660
3	Хандиваар	181	2,274,960	1196	6,512,190	418	6,193,920

Номын сангийн фонд бүрдүүлэлтийн худалдаагаар авсан номын тоог сүүлийн 3 жилээр харуулбал:

№	*Номын фондын үзүүлэлт*	*2021 он*		*2022 он*		*2023 он*	
		тоо	*үнэ*	*тоо*	*үнэ*	*тоо*	*үнэ*
1	Худалдаагаар	543	12,473,218	555	9,306,260	734	17,404,660

Тогтмол хэвлэл:

Өдөр тутмын “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Хүмүүн бичиг”, “Төрийн мэдээлэл”, “Боловсрол судлал”, “Өрхийн үйлдвэрлэл” зэрэг тогтмол хэвлэлүүдийг захиалан уншигчийн хэрэгцээг хангаж ажиллаж байна.

- “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Хүмүүн бичиг” сонины 2022 оны 12 дугаар сар, 2023 оны 1, 2, 3 дугаар сарын дугааруудыг дараалын дагуу **9 нэгж** болгон нааж үдэж, хавтаслан тогтмол хэвлэлийн дансанд бүртгэхэд бэлэн болголоо.
- 2023 оны “Төрийн мэдээлэл”-ийн эхний сарын дугааруудыг нэгжлэн хаягжуулав.

- “Найрамдлын Дархан” сонины 1970, 1971, 1972, 1975, 1980, 1981, 1984, 1985, 1986, 1987, 1988, 1989 оны дугааруудыг он дараалын дагуу шүүж нөхөн бүрдүүлэлт хийхэд бэлэн болгов.

Сан хөмрөгийн бүтэц зохион байгуулалт:

- Монгол номын фонд- 18767 нэр төрлийн 42896 боть 179892542 төгрөг 69 мөнгө
- Орос номын фонд- 7880 нэр төрлийн 8101 боть 6267133 төгрөг
- Англи номын фонд - 722 нэр төрлийн 914 боть 5922390 төгрөг
- Тогтмол хэвлэлийн фонд-1561 боть ном



2023 онд 487,850 төгрөгийн 139 нэр төрлийн 139 боть англи номоор фондоо баяжуулав.

- ✓ Номын сангийн фондод байгаа англи номуудыг эргэлтэд оруулах зорилгоор Англи уран зохиолын номын орчуулгын уралдааныг зохион байгуулж 68 хүүхэд амжилттай оролцож, 1-3 байр дүгнэв.
- ✓ Англи хэлний сургалтыг 12 удаа 52 хүүхдэд багш Scarlett Patton, Sarah May нар үнэ төлбөргүй зааж сургалтын материалаар англи хэл дээрх номуудыг ашиглуулан, 5 удаа 395 номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, давхардсан тоогоор 757 хүүхэд, багачуудад сурталчилсэн байна.

Номын сан хоорондын ном солилцоо: Энэ ажлын хүрээнд нийт 9 удаа 85 нэр төрлийн 148 боть номыг солилцоогоор хүлээн авч уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажиллав.

- 21 нэр төрлийн 37 боть номыг АШУҮИС-ийн номын сангаас
- Дархан дээд сургуулийн номын сангаас хэлний мэргэжлийн 11 нэр төрлийн 16 боть
- Архивын фондоос 11 боть
- УБ хотын Хүүхдийн Төв номын сангийн “Мөрөөдөл” танхимаас 11 боть ном
- 19-р сургуулийн номын сангаас 14 боть ном
- ЕБ-ын 9 дүгээр сургуулийн номын сангаас англи хэлний 2 боть ном гэх мэт

Үр дүн нь: ЕБС-ийн сурагчид болон иргэд өөрсдийн гар дээр байгаа номоо зарах буюу солилцдог болсон.

Номтой өдөр ба ном солилцоо: 11 удаа 850 нэр төрлийн 907 боть номыг 808 иргэдэд олгож үйлчиллээ.

Иргэд хоорондын солилцоо: Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор сар бүрийн 17-нд “Ном солилцох өдөр” болгон зарласантай холбогдуулан 1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, 11 ,12 дугаар сарын 17-ны өдрүүд, Дэлхийн номын өдөрт, 33 дахь удаагийн Үндэсний Номын баярын арга хэмжээний үеэр солилцох нийт 322 боть ном гарган тус арга хэмжээг зохион байгууллаа. Энэ үйл ажиллагаанд өөрийн номоо бусадтай солилцохоор 11 удаа 808 хүн, 907 боть номоор уншигч иргэд оролцож, бие биедээ зарах буюу солилцоо хийлээ.

Номын сангийн тооллого, хадгалалт хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар:
2023 онд Төв уншлагын танхимын фондын номыг дансаар буюу бар кодоор тоолж

- 11 937 нэр төрлийн 13 922 боть 121.422.247.26 төгрөгийн Монгол ном
- 254 нэр төрлийн 260 боть 1 010 070 төгрөгийн Англи ном
- 1 нэр төрлийн 1 боть 25 000 төгрөгийн орос ном хэвлэлийг үндсэн хөрөнгөтэй тулгав. Ойрын фондыг 2 жилд нэг удаа тоолж байгаа нь ном хэвлэл алдагдахаас хамгаалах буюу номын санчийг өрөнд оруулахгүй эрсдэлээс хамгаалах чухал ач холбогдолтой байна.

Салбарын тооллогоор 8517 нэр төрлийн 10 107 боть, 51.817.863 төгрөг 56 мөнгөний ном хэвлэл тоологдов.

Үндсэн хөрөнгийн тооллого буюу номыг нэгбүрчилсэн бүртгэлд бүртгэх:
Номын нэгбүрчилсэн бүртгэлийг номын фонд тус бүрээр шинээр бүртгэж, үндсэн хөрөнгийн тооллоготой тулгалт хийв.Үүнд:

- Төв уншлагын танхим 11765 нэр төрлийн 13752 боть,
- Уншлагын танхимын номын санчид 8664 нэр төрлийн 10332 боть,
- Архивын фондын номын санч 23009 боть ном, нийт 43348 нэр төрлийн 47093 боть номыг нэгбүрчилсэн дансанд бүртгэж дуусгав.

3.2. Номын сангийн үйлчилгээ

Аймгийн Төв номын сан нь уншлага үйлчилгээндээ ном хэвлэлээ тогтмол сурталчилж, шинэ номын жагсаалт гаргах, ном хэвлэлийн тойм хийх, уншигчдад хэрэгцээтэй материалуудыг хувилах, цахим хэлбэрт байршуулах, мэдээллийг түгээх зэргээр уншигчдын эрэлт хэрэгцээг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.Үйлчилгээг сүүлийн 3 жилээр харуулбал:

№	*Төлөвлөгөөт ажил*	*2021*	*2022*	*2023*
1	Уншигч	2,627	5,102	5,235
2	Ирц	32,668	55,053	56,202
3	Ном олголт	35,260	70,937	71,443





***3.2.1*. Уншигчдад номын сангаас үзүүлж буй үйлчилгээ болон номын сангийн үйлчилгээний инноваци, нэн шаардлагатай үйлчилгээний талаар:**

- **УБТЗ-ын тусгай хөтөлбөрт аялалд хамтран ажиллаж байна.**
  Номын сангийн үйлчилгээний хүртээмж иргэдэд хүрч, Улаанбаатар төмөр зам, Saikhnaa's catering төвтэй хамтран ажиллаж, 9 удаагийн аяллаар 338 сурагчийг хүлээн авч номын сангийн боловсролын хөтөлбөрт хамруулсан. Тус аялалд:
  - ГЁТЕ сургуулийн 5 дугаар ангийн 17 сурагчид Төв номын сангийн боловсролын хөтөлбөрт хамрагдаж “Хөгжөөнт тоглоом”-оор,
  - УБТЗ-ын удирдах газрын ажилтуудын 32 хүүхэд хамрагдсан бөгөөд сургалт хөтөлбөр, хөгжөөнт тоглоомд идэвхтэй оролцсон сурагчдад талархал, ном гардууллаа.
  - Улаанбаатар хотын "Оюунлаг" ЕБС-ийн 11а,б,в ангийн 36 сурагчид,
  - "Оюунлаг" ЕБС-ийн 11 дүгээр ангийн 65 хүүхэд, багш нарын хамт Дархан хоттой танилцахын сацуу Төв номын сангийн "Монгол бахархал" боловсролын хөтөлбөрт,

- Нийслэлийн Ерөнхий боловсролын "НОМТ НАРАН" сургуулийн Д.Цолмон багштай 8а ангийн 25 сурагч зочлон ирж номын сантай танилцан, хөгжөөнт тоглоомоор,
- Нийслэлийн ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн 72 хүүхэд,
- Нийслэлийн Ерөнхий боловсролын "Улаанбаатар" сургуулийн Д.Мөнхзул багштай 4а ангийн 22 сурагч зочлон ирж номын сантай танилцан,15 минутын бүтээлч уншлагыг Америкийн зохиолч Х.Вилхелмын "Хөөх ямар заваан юм бэ" номоор хийж, уншсан номын талаарх сэтгэгдлээ ярилцаж, зочид маань "Номтой намар-2023" аяны хүрээнд уншсан номын тэмдэглэлээ бидэнд танилцуулж, биелгээ бүжгээрээ бэлэг барилаа.
- Нийслэлийн Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн М.Энхтуяа багштай 7г ангийн 47 сурагч зочлон ирж номын сантай танилцаж, Бодъё саная сэтгэе холбоё хөгжөөнт тоглоомоор,
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн 4, 5, 6, 7 дугаар ангийн 22 хүүхэд зочлон ирсэнээр номын сангийн "АЛТАН СОЁМБО" боловсролын хөтөлбөрт тус тус хамрагдлаа.

- **Нүүдэл" номын богц аян:** *20 удаа 20 байгууллага хамрагдлаа.*

Соёлын бүтээлч сарын хүрээнд санаачлан эхлүүлсэн "Нүүдэл" номын богц нь ЕБС, СӨББ-ын багш ажилтнуудын хүсэлтээр Од цогцолбор, Энэрэл цогцолбор, Цайхун сургууль, ЕБ-ын 1 дүгээр сургууль, Дархан Эмпати, 13 дугаар цэцэрлэг, 8 дугаар цэцэрлэг, 3 дугаар цэцэрлэг, ОИЦ сургууль, 9 дүгээр сургууль гэх мэт 17 байгууллагын 60 гаруй хүнд 20 богцын 200 боть ном хүрээд байна.

- **Нийтийн уншлага:** "Хамтдаа уншъя" уриан дор 15 минутын уншлага, чанга уншлагыг багтаасан 32 нэр төрлийн 46 удаагийн өдөрлөгийг зохион байгуулж, 2504 сурагчдад 2848 номыг уншуулсан байна. Үүнд:Орхон сумын 9-р цэцэрлэгт "Бэлэн амт хулгана" номоор 60 хүүхдэд, ОИЦ сургуулийн 4-4 р ангийн 44 сурагчдад Оюунцэцэг "Сүүтэй цай" номоор, Эмпати сургуулийн 5-1-р ангийн 25 хүүхдэд "Харилцан шүтэлцээ" сэдвээр, Цайхун сургуулийн 1б ангийн сурагчдад хүүхдийн зохиолч О.Суднуйн "Бичиг мэддэггүй баавгай" зохиол, "Ганган зараа" шүлэг /26 хүүхэд/, "Вагон аялал" хөтөлбөрийн аялагч багачуудад хүүхдийн зохиолч О.Сундуйн "Бичиг мэддэггүй баавгай" зохиолоор /22 хүүхэд/, 5-р цэцэрлэгийн 3 бүлгийн бяцхан уншигчдад Амеркийн зохиолч Х.Вилхэлмийн "Хөөх ямар заваан юм бэ?" зохиолоор /100 гаруй/ гэх мэт...
- "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд 2023 оны **"Шилдэг уншигч"-**дыг шалгаруулан урамшуулах зорилгоор "Автобустай аялал"-ыг зохион байгуулж аймгийн ЕБС-ийн 6-12 дугаар ангийн 90 сурагчийг ШУТИС-ийн Дархан салбар, Аймгийн Музей, 1 дүгээр сургуулиар аялуулж, Дархан хотын бүтээн байгуулалттай танилцуулав.

- **Ном уншихын гайхамшиг өглөөлөг**

Дэлхийн багш нарын 29 дэх өдрийг тохиолдуулан 16-р сургууль дээр Номын санчийн "ХИШИГ ӨДӨР"-ийг зохион байгуулан номын санч мэдээллийн ажилтан П.Булгамаа, И.Пүрэвбат нар зочин багшаар уригдан ажиллалаа. Зочин багш нар маань Д.Батсүрэн багштай 3а ангид "НОМ УНШИХЫН ГАЙХАМШИГ" сэдвээр 15 минутын бүтээлч уншлага, Д.Нацагдоржийн шагналт, хүүхдийн зохиолч О.Сундуйн "ТЭНГЭРТ ӨЛГӨӨТЭЙ БЯСЛАГ" номоор чанга уншлагыг хийлээ.

- "**Оюунлаг Дарханчууд**" **өдөрлөг 41 удаа 6609 хүнд 5987 боть номыг сурталчлав.**

Тус өдөрлөгийг зохион байгуулахад төлөвлөгөө хөтөлбөр боловсруулах, сургалт, танилцуулга, уншлага, номын үзэсгэлэн гаргах, номын үзэсгэлэнгийн жагсаалт гаргах, шагналын болон дурсгалын зүйл бэлтгэх, өргөмжлөл, дурсамж хэвлэх, тээврийн хэрэгслээр үйлчлэх гэх мэтээр баг хамт олноороо оролцож ажилладаг.

Үр дүн нь: 1 цаг гаруй хугацаанд лекц, номын сангийн үйл ажиллагааны мэдээлэл, электрон каталогийн танилцуулга, 15 минутын уншлага, оролцогчдоос дунджаар 3-5 хүн өөрийн уншсан номын талаар ярьж, тухайн номыг үргэлжлүүлэн унших сэдлийг олж авдаг бөгөөд 20-350 хүн нэг дор оролцох боломжтойгоороо давуу талтай.

3.2.2. Номын санд шаардлагатай төсөл - хөтөлбөр боловсруулсан талаар

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050**”,** Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний хүрээнд Аймгийн Төв номын сангаас НОМЫН САНГИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР-ийг бий болгож, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

2023 онд номын сангийн боловсролын хөтөлбөрийг 4 удаа шинээр боловсруулан 55 удаа зохион байгуулж, 1014 сурагчийг хамруулан ***3 331 000*** төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- ✓ ***“Ном бид 2”*** номын сангийн боловсролын хөтөлбөрийг сан хөмрөгч П.Булгамаа, Ангилагч данслагч С.Энхцэцэг нар номын тэмдэглэл хөтлөх, бяцхан ном бүтээх, бүтээлч ажлуудыг хийхийг зааж сургах бөгөөд ном уншихын ач тус сэдвээр лекцийг ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулан 37 сурагч оролцов.
- ✓ ***“Монгол бахархал”*** лекц, сампин зангидаж сурах, номын хавчуурга хийх хөтөлбөрийг сан хөмрөгч О.Дунжидмаа, Сан хөмрөгч мэдээллийн ажилтан И.Пүрэвбат нар хариуцан, сургалт зохион байгуулж, номын санчид хамтран оролцов.
- ✓ ***Би монгол хүүхэд*** боловсролын хөтөлбөрийг номын санч мэдээллийн ажилтан Н.Дэлгэрмаа, О.Мөнхцэцэг нар сураар сүлжиж сурах, бугуйвч хийх аргыг зааж сургав.
- ✓ **Би монгол хүүхэд** боловсролын хөтөлбөрийг 28 удаа зохион байгуулж 270 сурагч
- ✓ “Монгол бахархал”, “Ном бид хоёр” номын сангийн боловсролын хөтөлбөрүүдийг 26 удаа зохион байгуулан, 707 хүн, “Монгол бахархал” номын сангийн боловсролын хөтөлбөрийг Эрүүл мэндийн байгууллагууд, СУГ, Ахмадын хөгжлийн төв, Сумдын ахмадын хороо, Их дээд болон ЕБС-иуд, УБ төмөр замын "Аялалын галт тэрэгний" тусгай хөтөлбөрөөр гаргаж 25 удаа зохион байгуулахад номын санчид баг болон ажиллаж, амжилттай дуусгалаа.
- ✓ ***”Эсгий урлал”*** хөтөлбөрийг сан хөмрөгч О.Дунжидмаа санаачлан, алаг мэлхий наадгай тоглоомын дэвсгэрийг оёхыг зааж өгч урлаж байна.

Үр дүн: Номын сангийн боловсролын хөтөлбөр нь үр дүнгээ өгч насанд хүрэгчид, уншигчид, ахмадууд идэвхтэй оролцож, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлбэл ажилгүй иргэдийг ажлын байраар хангах бизнес болгон өргөжүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

3.2.3. Соёл олон нийтийн ажил зохион байгуулсан талаар:

Төв номын сангийн хэмжээнд соёл олон нийтийн ажлыг Соёлын сайд, Засаг даргатай байгуулсан гэрээ, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллав.

2023 онд соёл олон нийтийн 21 нэр төрлийн ажлыг 415 удаа зохион байгуулж, 26739 хүнд хүргэж, 24166 боть номыг сурталчилсан байна.

д/д	Зохион байгуулсан ажлууд	Хэдэн удаа	Хүний тоо	Номын тоо	Тайлбар
1	Зөвлөн туслах үйлчилгээ	9	15		Аргазүйч С.Нэргүй Их дээд болон ЕБС-дын номын санчдад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэв.
2	Номын санчид болон уншигчдад зориулсан сургалтууд	52	1,474	262	29 нэр төрлийн сургалтыг 52 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 1474 хүнийг соён гэгээрүүлэх үйлчилгээнд хамруулсан байна.
3	Оюунлаг Дарханчууд өдөрлөг	41	6,609	5,987	Оюунлаг Дархан өдөрлөгийг 41 удаа зохион байгуулж, 6609 хүнийг хамруулж, 5987 номоор үйлчилсэн байна.
4	Боловсролын хөтөлбөр	18	494	337	2023 онд номын сангийн боловсролын хөтөлбөрийг 4 удаа шинээр боловсруулан 55 удаа зохион байгуулж, 1014 сурагчийг хамруулан ***3 331 000*** төгрөгийг орлого олсон байна.
5	Номын үзэсгэлэн	95	6,744	8,387	Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гарган сурталчилаа.
6	Лекц	30	1,596	1244	17 төрлийн лекцийг 30 удаа зохион байгуулж, 1519 багш, сурагчид, уншигчдыг хамруулж 1244 хүнд соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж ирлээ.
7	Чанга уншлага	46	2504	2848	46 удаа хийж, 2504 сурагчийг хамруулж, 2848 номыг уншуулсан байна.
8	Номын сантай танилцах аялал	14	444	258	Номын сантай танилцах аялалыг 14 удаа зохион байгуулж, 444 сурагчийг оролцуулж, 258 ном уншуулсан байна.
9	Уралдаан	15	1457	118	15 удаа 1457 хүнийг хамруулсан байна.
10	Шинэ номын нээлт	3	130	62	
11	Зохиолч уншигчдын уулзалт	7	776	292	7 удаагийн уулзалтанд 776 хүн оролцож, 292 номоор үзэсгэлэн гаргав.
12	Номын хандив	6	609	972	Зохиолч болон иргэдийн хандив
13	Номын худалдаа, ном солилцоо	11	808	907	Уншигч иргэд 11 удаа 808 хүн, 907 боть номоор оролцож,
14	Мэргэжил сурталчлах ажлууд	9	432	70	Миний мэргэжил сайхан цахим нэвтрүүлэг

15	УБТЗ аялалын хөтөлбөр	9	370	122	9 удаагийн аялалд 370 сурагч хамрагдаж, манай боловсролын хөтөлбөрт хамрагдаж, товч зангидах, номын хавчуурга хийххийг амжилттай суралцлаа.
16	Эх хэлний өдөр, номын баяр, соёл урлагийн ажилтны өдөр	3	854	2630	Номын баяр, соёл урлагийн ажилтны өдрүүдийг Залуучууд театрын 1-р давхарт зохион байгуулав.
17	Тэргүүний уншигч	3	60		2023 оны Тэргүүний уншигч, Д.Нацагдорж тэмдэг"-ийн болзол хангасан уншигчидаа номын баярын өдрөөрөө шалгаруулан шагнав.
18	Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг	4	84	56	
19	Бусад	19	834	1100	
20	Номзүйн ажлууд	2	2	20	
21	Боловсролын багц хөтөлбөрүүд	19	443		
	НИЙТ ДҮН	***415***	***26,739***	***24,166***	

Тодруулбал:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ			
№	Зохион байгуулагдсан ажлын сэдэв	Хариуцсан эзэн	Гүйцэтгэл
1	“Үеэс үед өвлөгдөх их дээдсийн судар" сэдэвт хэлэлцүүлэг	Төрт ёс, хаадын сан Монголын утга зохиол судлалын төвийн тэргүүн, Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн хүндэт профессор, зохиолч, орчуулагч, түүх судлаач Д.Гүн-Үйлс	Намрын номын баярын зочин зохиолч, орчуулагч, түүх судлаач Д.Гүн-Үйлсийн "Монгол хаад, хатад" ботиор “Үеэс үед өвлөгдөх их дээдсийн судар” сэдэвт хэлэлцүүлгийг багш, оюутнуудын дунд зохион байгуулав.
2	“Ном хэвлэлийн стандарт" сэдэвт хэлэлцүүлэг	Орон нутгийн зохиолчид, хэвлэлийн үйлдвэр, Төв номын сангийн номын санчид болон ахмад номын санчдын төлөөлөл	МУҮНС-ийн аргазүйч В.Түвшинтогтох "Утга зохиол, ном хэвлэлийн салбар"-ын хамтын ажиллагаа, орон нутгийн соён гэгээрэл сэдвээр цахим сургалт, Аймгийн Төв номын сангийн ЗАА-н нэгжийн дарга Г.Нямцэнд "Номын сангийн стандарт ба тулгамдаж буй бэрхшээл", Номзүйч Х.Отгонбаяр "Номын сангийн тухай хууль" сэдвээр танхимын мэдээлэл орлоо.

3	"Хүүхдийн уншлагыг удирдахуй" хэлэлцүүлэг	Од цогцолбор сургуулийн бага, дунд ангийн багш нар	Хэлэлцүүлгээр 2021 , 2023 оны Д.Нацагдорж тэмдэгтэн, Тэргүүний уншигч ангийн багш Ц.Биндэрьяа, А.Пүрэвсүрэн, Тэргүүний уншигч болох зорилго тавин ажиллаж байгаа багш С.Уянга, О.Цасчимэг, М.Саруулзаяа, Д.Жавхлантөгс нар хүүхдийн уншлагыг дэмжихүй сэдвээр тус тус илтгэл тавьж оролцов.
4	"НОМЫН ҮНЭ ЦЭНЭ" уулзалт, хэлэлцүүлэг	Дархан хотын номын клубын гишүүд	Цэцэрлэг, Их сургууль, ЕБС-ийн Номын клуб, "Ид шидийн орон төслийн баг"-ийн гишүүд хүрэлцэн ирж санал бодлоо солилцож цаашид номын сантай болон клуб хоорондоо хэрхэн хамтран ажиллах талаар хэлэлцүүлэг өрнүүллээ.

"ЗОХИОЛЧ ба УНШИГЧ" уулзалт

33 дахь удаагийн Үндэсний номын баярыг тохиолдуудан "ХАВРЫН НОМЫН БАЯР - ХҮҮХЭД БҮР УНШИГЧ" уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, "ЗОХИОЛЧ ба УНШИГЧ" уулзалтыг хөтөлж явуулав. “УУТАН ХАЦАРТ" номын зохиолч МУСГЗ, сэтгүүлч Ө.Рагчаасүрэн, зураач Б.Нямдаваа нарын оролцсон "ЗОХИОЛЧ-ХҮҮХЭД" уулзалтанд 50 гаруй сурагчид, номын санчид оролцов. Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн 6-11 анги, Од цогцолбор сургуулийн 10-2 ангийн сурагчид оролцож "Уутан хацарт" номын талаар, зохиолын дүрүүд, зургийн талаарх сонирхолтой ярилцлагуудыг өрнүүлэн, чөлөөт ярилцлагыг зохион байгууллаа.

Шинэ номын нээлт: Радио телевизийн Тэргүүний ажилтан, МҮОНРТ-ийн ахмад ажилтан Д.Жамсрангийн 3 дахь бүтээл болох "Мэдлэг ба сэтгэлгээ өдрийн тэмдэглэл" номыг Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд өлгийдөн авч "ШИНЭ НОМЫН БАЯР"-ыг зохион байгуулахад оролцож ***40 гаруй*** уншигчид, найз нөхөд оролцов.

Номын баяр: Хаврын номын баяраар 39 нэр төрлийн 76 үйл ажиллагааг зохион байгуулж, 10516 хүнд 4233 ном хэвлэл, соёлын өвийг сурталчилсэн байна. Үүнд: 29 нэр төрлийн 63 үйл ажиллагаанд 6283 хүн, 9 нэр төрлийн 13 удаагийн үзүүлэн таниулах үйл ажиллагаанд 4233 ном хэвлэл, соёлын өвийг сурталчилан ажиллалаа.

Намрын номын баяраар 12 нэр төрлийн 15 удаагийн ажлыг зохион байгуулж, 1655 хүн оролцож, 6 нэр төрлийн 11 удаагийн үйл ажиллагаанд 4468 үзүүлэн таниулах материал, номын үзэсгэлэн, номын худалдааг зохион байгуулж 1590 хүн оролцлоо. Номын баярын үйл ажиллагаанд давхардсан тоогоор **3245** уншигч хамрагдсан байна.

Үр дүн: НИЙТ 2023 ОНЫ НОМЫН БАЯРААР 51 НЭР ТӨРЛИЙН **91** ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛЖ **13760** ХҮН ОРОЛЦОВ.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн: Уншлага үйлчилгээ нь түүхт ой болон тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан номын сангийн фондод байгаа ном хэвлэлээр үзэсгэлэн гаргаж уншигчдад сурталчилдаг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ажилладаг. Энэ төлөвлөгөөт ажлын хүрээнд 20 удаа зохион байгуулахаас:

- **Танхимаар** 39 удаа 3800 уншигчдад 2074 боть номоор,
- **Бүтээлч уншлагад** 32 удаа 2448 уншигч хэрэглэгчдэд 2959 боть номоор,
- **Монгол бахархал** хөтөлбөрт 14 удаа 416 уншигчдад 443 боть,

Соёл олон нийтийн ажлын хүрээнд 10 удаа 1723 уншигчдад 1164 боть номоор, нийт **95 удаа 8387 уншигч хэрэглэгчдэд 6640 боть номоор** үзэсгэлэн гаргаж фондоо сурталчилсан байна.

Иргэд, **олон нийтэд зориулсан сургалт:** *18 нэр төрлийн сургалтыг 35 удаа зохион байгуулж, 1221 албан хаагч, багш сурагчдыг хамруулсан байна.* Сургалтыг хамтран ажилладаг аж ахуйн нэгж байгууллагуудаас сургагч багш нарыг урьж зохион байгуулав.

№	Сургалтын сэдэв	Хэдэн удаа	Хэдэн хүн	Хаана	Гүйцэтгэл
1	Угийн бичиг хөтлөх арга	1	35		Хонгор сумын эрүүл мэндийн газар
2	Угийн бичгийн сургалт	1	30		Шарын гол сумын Ахмадын холбооны хамт олонд
3	Угийн бичиг хөтлөх арга	1	28	15-р багийн Засаг дарга	15-р багийн Ахмадын зөвлөлийн ахмадуудад Сургагч багш Г.Нямцэнд
4	Угийн бичгийн сургалт	4	200	Зулзаын гол зусланд	Г.Нямцэнд
5	Шатрын сургалт	1	14		Шатрын спортын мастер Д.Пүрэвдорж
6	Англи хэлний сургалт	12	50	Scarlett Patton, Sarah May	6-12 насны сурагчдад үнэ төлбөргүй хичээл заав.
7	“Уншаад урагшлахуй” ном уншлагыг сурталчлах, сэдэлжүүлэх сургалт	7	450	Уншлага үйлчилгээний номын санчид	15 минутын уншлага зохион байгуулав.
8	“Ургаа уудалъя” угийн бичгийн сургалт, уралдаан	1	18		Эрүүл мэндийн төв, эмнэлэгт хэвтэн үйлчлүүлэгчдийн дунд
9	Харилцааны 5 зарчим	1	24		Түвшин холбоо эрүүл мэндийн газар
10	Угийн бичгийн сургалт	1	24		Ахмадын хороо,
11	Харилцааны 5 зарчим	1	19		"Гэрэлтэй өрхийн эмнэлэг"
12	"Угийн бичиг", "Хэл бичгээ судлахуй" сургалт	1	40	Хүмүүнлэгийн дээд сургуулийн 1,2-р курсийн оюутнуудад	Үндэсний сургагч багш, Хэл шинжлэлийн ухааны магистр Ж.Эрхэмсайхантай хамтран “Угийн бичгээ хөтөлж сурцгаая”, "Мянган жилийн буурал түүхтэй Монгол бичиг соёлоо дээдэлье"

13	Угийн бичгээ хөтөлж, сурцгаая" сургалт	1	15	13-р багийн ахмадын зөвлөл	СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-ын хүрээнд Төв номын сангийн ЗАА-н нэгжийн дарга Г.Нямцэнд 13-р багийн ахмадын зөвлөлийн хамт олонд орлоо.
14	Харилцааны 5 зарчим	1	24	Сургагч багш Б.Цэцэгсүрэн	Амин холбоо өрхийн эмнэлэг
15	Соёл урлагийн байгууллагуудын ажилтан, албан хаагчид	1	89	Соёлын Яам	МУ-ын соёлын яамны хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат
16	Боловсролын хөтөлбөрийн танилцуулга	2	88	УБ аяллын баг	УБ төмөр замын галт "Аялалын галт тэрэгний тусгай хөтөлбөрөөр
17	Соёл урлагийн байгууллагуудын ажилтан, албан хаагчид	1	89	Соёлын Яам	МУ-ын соёлын яамны хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат
18	Соёлы урлагийн салбарын цалин хөлсний мэдээлэл	1	120		Дугуй танхимд
	ДҮН	***39***	***1357***	***18 нэр төрлийн сургалтыг 39 удаа зохион байгуулж, 1357 албан хаагч, багш сурагчдыг хамруулсан байна***	

3.2.4. Ном уншлагыг сайжруулах, уншлагын төвүүдийг зохион байгуулах, үйл ажиллагааг зохицуулах ажлын талаар

Байгууллагын зүгээс уншлагыг сайжруулах олон талт үйл ажиллагааг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулж ирлээ. Үүнд:

- С.Тунгалагийн "Уншлагыг удирдахуй" номоор "Хүүхдийн уншлагыг удирдахуй" эрдмийн хурлыг Од цогцолбор сургуультай хамтран зохион байгуулж тус сургуулийн 40 гаруй багш оролцож, дараах сэдвүүдээр илтгэл тавилаа. Үүнд:
    - "Уншихуй ба ухаарахуй" сэдвээр Од цогцолбор сургуулийн 2-3-р ангийн багш Ц.Биндэръяа,
    - "Номын нөхөр болоорой" сэдвээр Од цогцолбор сургуулийн 3-4-р ангийн багш С.Уянга
    - "Номын нөхөр болъёо" сэдвээр Од цогцолбор сургуулийн 1-8-р ангийн багш О.Цасчимэг
    - "Хүүхдийн уншлагад эцэг эхийн оролцоо" Од цогцолбор сургуулийн 9 е ангийн монгол хэл уран зохиолын багш М.Саруулзаяа
    - "Хүүхдийн бүтээлч тэмдэглэлийг удирдахуй" 112 ангийн түүх, нийгмийн багш А.Пүрэвсүрэн нар тус тус илтгэл тавьж санал бодлоо солилцлоо.
- 2022 онд "Ахмадын сургаалт алт" сэдвээр төсөл бичиж, аймгийн Хөдөлмөр Халамж үйлчилгээний хэлтэст өгснөөр Ахмад настны зөвлөн туслах үйлчилгээний төсөл шалгарч Аймгийн Ахмадын хөгжлийн төвийн номын сангийн ном хэвлэлийг ангилж, нэгбүрчилсэн бүртгэлд 750 гаруй номыг дансалж, номын сангийн LIB-4U программд оруулж, ном хэвлэлийг ангиллын дагуу тавиурт байрлуулах зэрэг зөвлөн туслах ажлыг 5 ахмад номын санч хийлээ. Энэ төсөл амжилттай хэрэгжсэнээр 2023 онд

“Ахмадын сургааль алт-2” төслийг дахин хэрэгжүүлэх эрхийг авч ном хэвлэлийн ангилах, данслах, техник ажиллагаа хийх ажлыг бүрэн хийж гүйцэтгэв. Ахмадын хөгжлийн төвийн номын сангаар 7 хоног бүр 40-50 ахмад настангууд номын сангийн үйлчилгээ авч, жилдээ 2200 гаруй уншигч бүртгүүлж, ном соёлын үйлчилгээ авч байна.

- Аймгийн ГБХЗХГ-тай хамтран ажиллаж, тэдний *Unitelhub* төслийн хүрээнд байгуулсан цахим үйлчилгээний танхимын суурин компьютерүүдэд 50 гаруй цахим номыг суулган өгснөөр хүүхэд багачууд номын сангийн үйлчилгээг авах боломжоор хангагдаад байна.
- ШШГЕГ-ын харъяа 435, 445-р ангиуд, Онцгой байдлын газрын албан хаагчдад ном тойрсон соён гэгээрүүлэх үйл ажиллагааг жил бүр тогтмол зохион байгуулж, зөөврийн номын сангаар улиралд нэг удаа үйлчилгээ үзүүлдэг ба мөн ШШГЕГын харъяа 445-р анги өөрийн гэсэн номын сантай болж, эрх нь зөрчигдсөн иргэдэд ном соёлын үйлчилгээ үзүүлдэг болсоноор “2022 ОНЫ ШИЛДЭГ УНШИГЧ ХАМТ ОЛОН” -оор шалгарлаа.

3.2.5. Алслагдсан хэрэглэгчдийн үйлчилгээг зохицуулсан байдал

Номын сантай баг: 33 дахь удаагийн Үндэсний номын баяраар Төв номын сангаас санаачлан Дархан сумын алслагдсан багууд болох 15, Малчин багуудыг НОМЫН САНТАЙ БАГ болгохоор номын хандивын аяныг эхлүүлж, 800 гаруй боть номыг бүрдүүлж 2 багт хүлээлгэж өгөв. Ингэснээр тухайн багийн төвүүд дээр иргэд, хүүхэд залуучууд ном соёлын үйлчилгээ авах боломжтой болж тогтмол ажиллаж байна.

Зуслангийн хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр: Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газар, Соёлын байгууллагуудын санаачлан зохион байгуулсан "Соёлын өвийн өртөөчилсөн хөтөлбөр "Зулзагын голын хүүхдийн зусланд 2023.07.07-ны өдөр зохион байгуулагдсан ба тус хөтөлбөрт Аймгийн Төв номын сангаас "Угийн бичиг хөтлөх арга" практикт суурилсан сургалтыг нийт 8 бүлгийн 200 гаруй сурагчдад амжилттай хүргэлээ.

Соёлын сэргэлт сумдад: Нийгмийн соён гэгээрэл, кино урлаг, соёл боловсролын орон зайд байлгаж, хүүхэд залуучуудад кино урлагаар дамжуулан нэмэлт орлого олж болох төрөл бүрийн сургалтуудыг өгч, кино өөрөө эдийн засагт хэрхэн үр өгөөжөө өгдөг талаарх сонирхолтой хэлэлцүүлгийг өрнүүлсэн "Соёлын сэргэлт-2023" аян Дархан-Уул аймгийн Орхон, Хонгор, Шарын гол суманд боллоо. Энэхүү үйл ажиллагаанд Дархан-Уул аймгийн Төв номын сангаас нийт сумынхаа уншигч, иргэддээ зориулан "Тэнгэрийн заадас" шинэ номын худалдаа, "Кино урлаг - Дархан хотод" сэдэвт кино урлагийн тухай сэдэвчилсэн номын үзэсгэлэн 23 боть номоор, "Монгол ахуй" AR технологиор бүтээгдсэн эвлүүлдэг цахим ном тоглоом, Кино таавар АХА тэмцээн зэрэг олон нийтийн оролцоот ажлуудыг үйл ажиллагаанд оролцсон **800 гаруй иргэд**ийн дунд зохион явууллаа.

3.2.6. Зөөврийн үйлчилгээ зохион байгуулсан эсэх

***Нүүдэл зөөврийн үйлчилгээ**:* Номын сангийн тухай хууль болон БСШУ-ны сайдын 2010 оны 570 дугаар буюу “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу **39 удаа 2611 уншигчдад 3196 боть** номоор Зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүллээ.

Ном гэрээр олгох: Номын санд удаан хугацаагаар суух боломжгүй өндөр настан болон тусгай хэрэгцээт иргэд, бусад шалтгаантай нийт 1236 уншигчид 1345 номыг гэрээр олгож үйлчиллээ.

Англи ном: "Хэлтэй бол хөлтэй" англи хэлний номын орчуулгын уралдаанд оролцсон 19-р сургуулийн 5б ангийн сурагчдад 14 ном өгч уншигчийн хэрэгцээг хангалаа.

3.2.7. Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал

Чанга уншлага: ЕБС-ийн бага анги, СӨББ-ын суралцагчдад чанга уншлагыг 6 удаа зохион байгуулж 583 хүүхдэд үйлчлэв.

- 30 дугаар цэцэрлэгийн Ц.Олз, Б.Сарангуа, Г,Маам багштай бэлтгэл 3 бүлгийн 70 гаруй хүүхдэд сан хөмрөгч-мэдээллийн ажилтан И.Пүрэвбат "ЦУУТЫН ЦАГААГЧ ГҮҮ" Монгол ардын үлгэрээр чанга уншлага, зурагт уншлага
- Дархан-Уул аймгийн VI цэцэрлэгийн н.Отгонцэцэг багштай бэлтгэл А бүлгийн 19 хүүхдэд МУУР ХУЛГАНА ХОЁР" Орос ардын үлгэрээр сан хөмрөгч-Мэдээллийн ажилтан О.Дунжидмаа чанга уншлага
- Дархан-Уул аймгийн Хэрэмхэн цэцэрлэгийн Д.Отгонцэцэг багштай Бэлтгэл бүлгийн 25 хүүхдэд УҮН-ийн дарга Н.Норжмаа "ТЭМЭЭ ЭВРЭЭ АЛДСАН НЬ" Монгол ардын үлгэрээр чанга уншлага
- 13-р цэцэрлэгийн 6 бүлгийн 179 хүүхдэд сан хөмрөгч-мэдээллийн ажилтан И.Пүрэвбат "Цуутын цагаагч гүү" Монгол ардын үлгэрээр чанга уншлага
- VIII цэцэрлэгийн 5 бүлгийн 150 хүүхдэд сан хөмрөгч-мэдээллийн ажилтан И.Пүрэвбат "ТЭМЭЭ ЭВРЭЭ АЛДСАН НЬ" Монгол ардын үлгэрээр чанга уншлага
- III цэцэрлэгийн 4 бүлгийн 140 хүүхдэд сан хөмрөгч-мэдээллийн ажилтан И.Пүрэвбат "ЦУУТЫН ЦАГААГЧ ГҮҮ", "ТЭМЭЭ ЭВРЭЭ АЛДСАН НЬ" Монгол ардын үлгэрүүдээр чанга уншлага

Хүүхэд хамгаалал: "Хүүхэд хамгааллын жил", Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Төв номын сан уншигч, үйлчлүүлэгчдэдээ зориулан эрүүл мэндийн "АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХАЙРЦАГ"-ийг байршуулан ажиллуулж байна.

"Хүүхэд хамгааллын жил", "Эрсдэлгүй Дархан" аяны хүрээнд Дархан-Уул аймгийн Төв номын сан бүрэн камержлаа. Ингэснээр номын сангийн орчинд ном дэвтэр, цүнх хувцас зэрэг хаяж гээсэн зүйлээ олж авах, уншигчдын дэг журам сайжрах зэргээр үр дүнгээ өгч байна.

Номын сантай танилцах аялал: Номын сан, ном соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор номын сантай танилцах аялалыг албан байгууллага, сургууль, цэцэрлэгүүдэд **23** удаа зохион байгуулж **878** хүнд **380** боть номыг сурталчилав.

Уралдаан: 2023 онд уншигч иргэдэд чиглэсэн 15 удаагийн уралдаанд 1457 хүн оролцсон байна.

- "Үндэсний бичиг үсгийн баярын өдөр"-өөр аймгийн Төрийн албан хаагчдын дунд "ХОС БИЧИГТЭН" цахим бичвэр, түргэн уншлагын уралдааныг Төрийн албаны салбар зөвлөл, Соёл урлагийн газар, Хэлний бодлогын зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Уралдаанд нийт 11 байгууллагын 23 ажилтан албан хаагч оролцож үндэсний бичгээрээ унших, өгөгдсөн эхийг хөрвүүлэн цахим бичвэрт буулгах чадвараа сорив.

- Хүүхэд залуусыг Эх хэлээрээ зөв сайхан, уран сэтгэмжтэй бичих чадварыг сорин Төв номын сангаас УРАН БИЧГИЙН "БИЙРЭЭ НИЙЛЬЕ", ҮНДЭСНИЙ БИЧГИЙН "ТҮРГЭН УНШЛАГА" уралдаануудыг амжилттай зохион байгууллаа.
- **Хуруун хүүхэлдэйн үлгэрийн уралдаан:** Соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулсан Хуруу хүүхэлдэйн үлгэрийн уралдаанд маань 11 сургууль, цэцэрлэгийн 62 бүтээл ирсэн ба тус бүтээлүүдэд 280 гаруй хүн оролцон тогложээ.

3.2.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал

Аймгийн Төв номын сан нь хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт 53 иргэнд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж байна.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн 4, 5, 6, 7 дугаар ангийн 22 хүүхэд зочлон ирсэнээр номын сангийн "АЛТАН СОЁМБО" боловсролын хөтөлбөрт хамрагдлаа.

3.2.9. Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн эсэх

Номын сангийн сан хөмрөгийг 3 төрлөөр бүрдүүлэн ажиллаж ирлээ. Үүнд:

1-рт худалдаагаар
2-рт хандиваар
3-рт солилцоогоор

- Худалдан авалтаар номын фондыг бүрдүүлэхэд уншигчдын татгалзлал дээр үндэслэн авдаг учраас чанарын шаардлага хангасан шинжлэх ухааны болон хэрэгцээт ном хэвлэлээ фондоо бүрдүүлж байна.
- Харин хандиваар номын фондыг бүрдүүлэхэд хэрэгцээ шаардлага муу, урагдаж гэмтсэн, дийлэнхи хувь нь уран зохиолын номууд ирж байна.
- Улаанбаатар болон бусад байгууллагуудын номын сан хоорондын солилцоогоор ном хэвлэлийг авч уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна.

Номын сангийн фонд бүрдүүлэлтийн худалдаагаар авсан номын тоог өмнөх жилтэй харьцуулан үзэхэд 32,2% хүртэлх өссөн байна.

№	*Номын фондын үзүүлэлт*	*2021 он номын тоо*	*2022 он номын тоо*	*2023 он номын тоо*
1	Худалдаагаар	543	555	734

Аймгийн хүн ам, ард иргэдийн дунд соёлын олон талт соён гэгээрүүлэх үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлснээр уншлага үйлчилгээний хүртээмж нь жилээс жилд өсөж байна. Үйлчилгээг өмнөх жилтэй харьцуулахад уншигч 2,6%, ирц 2%, ном олголт 0,7% өсөлттэй байна.

№	*Төлөвлөгөөт ажил*	*2021*	*2022*	*2023*
1	Уншигч	2,627	5,102	5,235
2	Ирц	32,668	55,053	56,202
3	Ном олголт	35,260	70,937	71443

Номын сангийн үйлчилгээ, ном уншлагыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд соёл олон нийтийн ажлыг тогтмол зохион байгуулах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр нэлээдгүй ажлыг төлөвлөн ажиллаж байна. Сүүлийн онтой харьцуулахад соёл олон нийтийн ажлын нэр төрөл 16.6%, арга хэмжээний тоо 100%, оролцогчдын тоо 100%, ном хэвлэлийн сурталчилгаа 100%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

№	*Зохион байгуулсан ажлын нэр төрөл*	*2021 он*	*2022 он*	*2023 он*
1	Нэр төрөл	17	18	21
2	Арга хэмжээний тоо	30	41	415
3	Оролцогчдын тоо	11766	12973	26739
4	Ном хэвлэлийн сурталчилгаа	1680	3489	24166

3.3 Лавлагаа номзүй, каталоги зохион байгуулалт

2023 онд 678 лавлагааг амаар болон утсаар, 495 лавлагааг цахимаар өгч лавлагааны бүртгэлд бүртгэсэн байна.

Д/д	Хийж гүйцэтгэсэн ажлууд	Хэдэн удаа
1	Лавлагаа номзүйн үйлчилгээ	217
2	Номзүйн мэдлэгийг сурталчлав	20
3	Өгсөн лавлагааг хөтлөх фонд баяжилтанд санал оруулав	68
4	Шинэ номын агуулгын тайлбартай бүртгэл” шинэ ном ирсэн тухай бүрт цахимд мэдээлэл оруулав	6
5	Цахим ном уншигчийн талаар танилцуулга	12
6	Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санд мэдээлэл явуулав	2
7	Шинэ номын мэдээг лавлагааны компьютерт байршуулав	170 боть ном
НИЙТ		**495**

3.3.1. Номын сангийн үйл ажиллагаанд лавлагаа номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, нэвтрүүлэхэд чиглэгдсэн ажлын талаар:

Дархан-Уул аймгийн орон нутгийн хэвлэл Найрамдлын Дархан сонинг цахимжуулах ажлын хэсгийг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж цахим мэдээллийн санд оруулах ажлууд хийгдэж байна. Энэ хүрээнд аймгийн архивын газраас 1965-2000 оныг хамарсан нийт **36** жилийн сонинг зөөврөлөн **44-3061** гаралтын дугаартай **12228** нүүр хуудсуудыг дүрсжүүлэн буулгаж үндэсний тогтмол хэвлэлийн лавлагаа, мэдээллийн нэгдсэн цахим санд оруулсан.

Мөн аймгийн Төв номын сангийн архивын фондод хадгалагдаж буй “Найрамдлын Дархан” сонинд 1966-1990 оны нөхөн бүрдүүлэлтээр нийт **20** жилийн **1052** нүүр хуудсыг цахимжуулан, хэвлэн олшруулж үдэж хавтаслан, сонин тус бүрийн ар нуруунд хэвлэлийн мэдээлэл наан гүйцэтгэв.

Үндэсний тогтмол хэвлэл нийт 25 жилийн 421 дугаарын 970 нүүр

- ✓ Найрамдлын Дархан сонины нөхөн бүрдүүлэлт **25** жилийн **421** дугаарын **970** нүүр хэвлэн нөхөн бүрдүүлэлт хийв.

- ✓ Найрамдлын Дархан сонин 2 жилийн /1999 он, 2000 он/ нийт 53 дугаарын 212 нүүр хуудасны зураг даран цахимд оруулахад бэлэн болгов.
- ✓ Аймгийн архивын газраас “Найрамдлын Дархан сонин”-г нийт 5 удаа солилцоогоор авав.

3.3.2. Ганцаарчилсан хэрэглэгч болон үйлчлүүлэгч байгууллага, хамт олныг мэдээлэл-номзүйн үйлчилгээгээр хангасан байдал: Номзүйн мэдээ– **978** удаа

- ✓ Хүүхдийн уран зохиолын 76 боть номоор номын мэдээ бэлтгэв.
- ✓ Номын сангийн цахим хаягаар нийт 4 удаа ном зүйн мэдээ мэдээлэл дамжуулав.
- ✓ Цахим лавлагаа нийт 58 удаа
- ✓ Сэдэвчилсэн лавлагаа 164 удаа
- ✓ Номзүйн лавлагаа 232 удаа
- ✓ Тодотгосон лавлагаа 38 удаа

Татгалзал: Тайлангийн хугацаанд номын сан нийт 312 боть номыг татгалзалд бүртгэснээс судалгаанд үндэслэн татгалзалын номыг 100% барагдууллаа.

3.3.3. Хэрэглэгчийг мэдээллийн соёлтой болгоход чиглэгдсэн ажлууд

Мэдээ мэдээлэл: Иргэд уншигчдад мэдээ мэдээллийг үнэн зөв, хүртээмжтэй авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор номын сангийн “Дархан-Уул аймгийн Төв номын сан” пэйж хуудсыг тогтмол ажиллуулж өдөр тутамд 1-5 мэдээ мэдээлэл орж байна. Мэдээ мэдээллийг оруулахдаа мэдээллэх чанараас гадна бичиг үсэг, найруулгын өнгө аяс, зураг бичлэгийн чанар, мэдээний агуулгыг анхаарч оруулдаг. Ингэсэнээр 6000 гаруй уншигчид номын сангийн мэдээллийг нэг эх сурвалжаас бодитой авч, бичгийн болон гоо зүйн мэдрэмж, нөлөөлөл харилцаа хандлагын соёлд суралцаж байна. Байгууллагын пэйж хуудасны дагагчдаас 18-24 насныхан 14.6%, 25-34 насныхан 33,2%, 35-44 насныхан 34.2%, 45-54 насныхан 12,5%, мөн 76,7% эмэгтэй, 23,3% эрэгтэй байна. Үүнээс үзэхэд номын сангийн үйл ажиллагааны мэдээллийг 18-44 насныхан түлхүү хүлээн авч байна.

Электрон каталог: Номын сангийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, цахим үйлчилгээг нэвтрүүлж, үйлчилгээний соёлд суралцах хүрээнд электрон каталогийн байнгын ашиглалтыг нэмэгдүүлэх ажлуудыг тогтмол хийж байна. Мөн 2024 онд E-Mongolia системд тулгуурлан номын сангийн 4 төрлийн үйлчилгээг цахимжуулахаар санал хүргүүлээд байна.

3.3.4. Каталог, картын сан, санамж өгөх ном зүйг номзүйн бичилтийн стандартын дагуу хийсэн тухай

Зохиолч уншигчийн уулзалт зохион байгуулахад намтар номзүй болон санамж өгөх номзүйг хэвлэн нийтэлж олны хүртээл болгож байна.

- Нацагдоржийн шагналт хүүхдийн зохиолч О.Сундуй санамж өгөх ном зүйг цаасан болон цахимаар,
- МЗЭ-ийн гишүүн, Утга зохиолын төлөө болон МЗЭ-ийн шагналт яруу найрагч УАА–н ба ХАА-н Боловсролын тэргүүний ажилтан Төмөртогоо Норжмоогийн санамж өгөх номзүй
- Шинэ номын мэдээнүүдийг тогтмол гаргаж олны хүртээл болгож байна.
- Хүмүүн бичиг сониноос орон нутгийн ном зүйн жагсаалтыг сүүлийн 5 жилийн дугааруудаас түүвэрлэж бэлтгэж байна.







Д.Нацагдоржийн шагналт, хүүхдийн зохиолч
Оюунбадамын Сундуй

(санамж өгөх ном зүй)

Бие даасан зохиол бүтээлүүд

1. Сундуй.О. Шүлэгч хүүхдүүд./ Ред. Ж.Мэндээ.-УБ.:Тоонотпринт ХХК., 2014.-92х.-ISBN:978-99973-49-61-3.
2. Сундуй.О. Хонхот гөлчгийд тохиолдсон адал явдал.-УБ.:Мөнхийн үсэг ХХК,2017.-30х.
3. Сундуй.О.Зуны нар мөхөөлдсөнд дуртай:Багачуудад зориулсан хошин шог шүлгүүд.-УБ.:Улаабаатар хэвлэл,2006.-16х.-ISBN:978-999-29-85-1-5-1.
4. Сундуй.О. Учиртай бэлэг:Хүүхдэд зориулсан үлгэр,өгүүллэг,туужис,түүвэр зохиол /Ред З.Түмэнжаргал.-УБ.:Улаанбаатар хэвлэл,2007.-107х.
5. Сундуй.О.Аймаар том нохой буюу наргиатай шүлгүүд:Бага насны хүүхдүүдэд зориулав /Ред Д.Гармаа.-УБ.: Улаанбаатар хэвлэл.,2002.-19х.
6. Сундуй.О.Тэнгэрээс заяат Тэмүжин хүү:Товч тайлбар толь А-Я/Ред Т.Мандир.-УБ.:Сэлэнгэ пресс ХХК,2005.-84х.-ISBN:978-99929-58-0-14.
7. Сундуй.О.Тэнгэрээс заяат төрсөн Тэмүжин хүү:Товч тайлбар толь А-Я. /Ред.Т.Мандир.-УБ.:Тоонотпринт ХХК,2005.-84х.-ISBN:978-99929-58-0-14.
8. Сундуй.О.Нисдэг хулгана Чинүүхэй ба найтаадаг охин:Боть-2.-УБ.:Мөнхийн үсэг ХХК,2006.-39х.-ISBN:99929-6-134-1.
9. Сундуй.О. Зочин:Сургуулийн бага дунд насныханд зориулав.-УБ.: Улаанбаатар хэвлэл,2006.-32х.

3.4. Номын сангийн автоматжуулалт:

Дархан-Уул аймгийн Төв номын сан нь 2010 онд LIB-4U программд номоо оруулж эхэлснээс хойш эдүгээ электрон каталогт 28,243 төрлийн, 56,619 ширхэг материал бүртгэгдээд байна. Волвос ХХК-тай хамтран ажиллах 10 гаруй жилийн хугацаанд монгол номын фонд, орос номын фонд, англи номын фондуудыг программд 100% оруулж дуусгаад байна. 2024 оноос Тогтмол хэвлэлийн модулыг шинээр нэмүүлж, сургалт авч, сонин хэвлэлээ цахим каталогт оруулахад бэлэн болов.

Мөн 2023 онд “Lib4U.net” номын сангийн програмыг үүлэн технологит суурилуулан амжилттай ажиллаж ирлээ.



3.5. Мэргэжил арга зүйн үйл ажиллагаа

Зөвлөн туслах: 14 байгууллагын 20 номын санчид

Төв номын сангийн Мэргэжил арга зүйн нэгж, арга зүйчийн ажил үүргийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 26 ЕБС, 9 их дээд, МСҮТөв, сумдын соёлын төвийн номын санчдад жилийн төлөвлөгөөний дагуу болон өөрсдийн хүсэлтээр нь зөвлөн туслах, арга зүйн зөвлөгөө өгөх, ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгөх ажлуудыг хийж байна.

2023 онд 8-р сургууль, 4-р сургууль, Монгол Оюу, Оюуны ирээдүй цогцолбор сургууль, 2-р сургууль, Турк сургууль, 16-р сургууль, 9-р сургууль, 18-р сургууль, Од цогцолбор А,Б байр, Орхон, Шарын гол, Хонгор сумдын нийт 14 байгууллагын 15 номын санчид номын сангийн үйл ажиллагааны эмх цэгц, фондын номын ангилал байрлал зэргээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

- ✓ Монгол Оюу сургуулийн номын сан нь байнгын уншигч - 400, сурах бичиг болон шинжлэх ухааны 3000 гаруй номын фондтой. Уншигчиддаа анги бүлгийн хуваарь гаргаж хувиарын дагуу үйлчилгээ үзүүлж үйл ажиллагаагаа явуулж байна.
- ✓ Оюуны ирээдүй сургууль 116941.700 төгрөгний 35844 мянган боть номын фондтой, 35000 гаруй байнгын уншигчтай 20,0 мянган ирцэд үйлчилж ажиллаж байна.
- ✓ Шарын гол сумын Соёлын төвийн номын сан нь 800 гаруй боть номын фондтой 12 уншигчийн ширээ сандалтай, Ерөнхий боловсролын 2-р сургуулийн номын сан нь 3000 гаруй сурах бичиг хүүхдийн уран зохиолын номын фондтой 15 хүүхдийн ширээ сандалтай
- ✓ 6-р сургуулийн номын сан нь 2500 гаруй сурах бичиг болон хүүхдийн уран зохиол шинжлэх ухааны номтой 12 хүүхдийн ширээ сандалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.
- ✓ Орхон сумын Соёлын Төвийн номын санч Оюунчимэг, Ерөнхий боловсролын сургуулийн номын санч Бямбаа нарт арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.
- ✓ Хонгор сумын Соёлын төвийн номын сангийн 89 нэр төрлийн 100 боть номонд номын сангийн стандартын дагуу техник ажиллагааг хийж, номын санчдад номыг ангилж дансалж, номтой ажиллах арга барилын талаар арга зүйн зөвлөгөө өглөө.

НЭГ. ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ					
Он сар өдөр	**Зохион байгуулагдах ажлууд**	**Хэдэн удаа**	**Хүний тоо**	**Хаана, Хариуцах эзэн**	**Гүйцэтгэл**
2023:01:12	Зөвлөн туслах	1	1	1-р сургууль	1-р сургуулийн номын санч Д.Буянжаргалд аргазүйн зөвлөгөө өгөв.
2023.02.01	Монгол оюу, ОИЦ	2	2	С.Нэргүй	Зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэв.
2023.08.03	Зөвлөн туслах	1	4	Аймгийн СУГ	ТАЗ-ийн нарийн бичгийн дарга А.Лхагважаргал, СУГ-ын Захиргаа УХ-ийн дарга С.Туяа нар Албан тушаалын боловсруулалтын талаар зөвлөгөө өгөв.
2023.09.12	Зөвлөн туслах	1	3	Шарын гол, Орхон, Хонгор	3 сумдын номын санч

2023.02.08	Зөвлөн туслах үйлчилгээ	2	2	Шарын гол суманд, Аргазүйч С.Нэргүй	Шарын гол сумын 6-р сургууль
2023.02.08	Зөвлөн туслах үйлчилгээ	2	2		Шарын гол сумын 2-р сургууль
2023.04.23	Зөвлөн туслах үйлчилгээ	1	1	Аргазүйч С.Нэргүй	Хонгор сумын номын санч
2023.03.14	Зөвлөн туслах үйлчилгээ	1	2		Орхон суманд Номын санчид
	Од цогцолбор сургуулийн номын санч	2	2		Од цогцолбор сургуулийн А,Б байрны номын санчид
	Турк сургуулийн номын санч	1	1	Турк сургууль	Турк сургуулийн номын санч
	ДҮН	**14**	**20**		

3.6. Хүний нөөцийн асуудал:

Хүний нөөцийн өнөөгийн байдал: Дархан-Уул аймгийн Төв номын сан нь 15 ажилтан албан хаагчтай. Үүнээс: ТҮ-3, ТҮСБ – 12 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Мэргэжлийн буюу номын санч мэргэжлээр төгссөн 8 ажилтан байна.

2023 онд номын санчийн 2 сул орон тоон дээр ажлын байр зарлаж, 3 удаа сунгаж зар мэдээ өгснөөр мэргэжлийн бус 2 номын санчийг шалгаруулан авч ажиллуулав. Цаашид мэргэжлийн баг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэжлийн ур чадвартай болгох зорилгоор 2 ажилтанг Соёлын дээд сургуулийн номын сангийн ангид, нэг ажилтанг мэргэжлийн чадавхижуулах богино хугацааны сургалтанд тус тус суралцуулж байна.

Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл, Соёл урлагийн газраас зөвлөмж, чиглэл өгсөний дагуу Төрийн албаны шинэтгэл, шинэчилсэн хууль тогтоомжууд, төрийн үйлчилгээний байгууллагын стандарт зэрэгт нийцүүлэн Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулахаар хүргүүлээд байна.

Одоогоор манай номын сан боловсон хүчний дутагдалд ороогүй байгаа боловч 2025 оноос 3 номын санч тэтгэвэрт гарах, номын сангийн барилга ашиглалтанд ороход мэргэжлийн боловсон хүчин дутмаг болох эрсдэл үүсээд байна.

Хүний нөөцийг чадавхижуулсан байдал: Мэргэжлийн бус номын санчдыг бакалавр болон чадамжийн гэрчилгээ олгох сургалтуудад суулгахаас гадна нийт номын санчдад мэргэжлийн сургалт, судалгаа хийх аргачлал, чадавхижуулах сургалтуудыг зохион байгуулж байна.

2023 онд номын санчдад зориулсан **мэргэжлийн сургалтыг** 5 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 123 номын санч хамрагдлаа. Үүнд: “Хил хязгааргүй номын сан” Австралийн төслийн сургалтанд аймгийн 31 байгууллагын 49 номын санч, “Соёлын сэргэлт -2023" аяны хүрээнд Соёлын салбарын ажилтнуудыг чадавхжуулах “Мэргэжил арга зүй”-н сургалтад 31

байгууллагын 47 номын санч, “Соёл ба соёлын оролцоо” сургалтад 3 номын санч, Соёл Урлагийн ажилтны өдрүүдийг тохиолдуулан Арга зүйч С.Нэргүй Хонгор сумын номын санч Цэцэгээ, Орхон сумын номын санч Оюунчимэг нарт

- ❖ Номын сангийн ангилал, ном бүрдүүлэлт
- ❖ Номын сангийн үйлчилгээ, бүртгэл хөтлөлт
- ❖ Соёл олон нийтийн ажлын зохион байгуулалт
- ❖ Тайлан мэдээ сэдвээр сургалт явуулав.

<u>Номын санчдад зориулсан хувь хүний хөгжлийн сургалт:</u> 15 нэр төрлийн сургалтыг 17 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 253 номын санчийг оролцуулсан байна.

№	Номын санчдад зориулсан сургалтууд				
	Зохион байгуулагдсан ажлууд	Хэдэн удаа	Хүний тоо	Хариуцах эзэн	Гүйцэтгэл
1	Клиник сэтгэл зүйч болон Эерэг сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтэн Б.Энхтал	1	14	ТНС	Дархан-Уул аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй "БҮХ НИЙТИЙН ЭЕРЭГ СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ"-ийн сургалтанд номын санчид суулаа.
2	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам сэдэвт сургалт	1	11	Аймгийн ТАСЗ	Аймгийн Соёл урлагийн байгууллагын албан хаагчид сургалтанд хамрагдав.
3	Соёл урлагийн байгууллагуудын ажилтан, албан хаагчид	1	14	Соёлын Яам	МУ-ын соёлын яамны хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат
4	Номын сангийн тухай, хууль эрх зүйн баримтын сурталчилгаа, сургалт зохион байгуулав.	1	44	ТНС	Төв номын сан, Их дээд болон ЕБС-ийн номын санчид оролцов.
5	Соёл урлагийн байгууллагуудын ажилтан, албан хаагчид	1	9	Соёлын Яам	МУ-ын соёлын яамны хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат
6	"Амжилтын хөтөч-2023" сургалт	1	15	Цахимаар	Номын санчид албан хаагчид
7	Статистикийн аргазүйн зөвлөгөө өгөх сургалт	1	3	СУГ	Болдмаа
8	Соёлы урлагийн салбарын цалин хөлсний мэдээлэл	1	14		Дугуй танхимд
9	КОХО сургалт	1	4	Цахимаар	МУҮНС-гаас номын санчдад

10	"Соёл ба оролцооны соёлыг төлөвшүүлэх нь" сургалт	1	15	Аймгийн Хөдөлмөр халамжийн газар	Соёл ба оролцооны соёлыг төлөвшүүлэх нь төслийн сургалт номын санчдад зохион байгуулагдлаа.
11	Соёлын сэргэлт -2023 аяны хүрээнд зохион байгуулж байгаа аймгийн нийт номын санчид "Номын сангийн аргазүй" сургалт	1	41	АШУИС-ийн номын сан	Соёлын яамны Урлаг, уран бүтээлийн газрын дарга Б.Сэргэлэн нээж, номын санчдын болоод өнөөгийн номын сангийн тулгамдаж буй асуудлын талаар ярилцаж, тэдний саналыг холбогдох газруудад уламжлахаар болов. Үндэсний Төв номын сангийн арга зүйч Б.Сарандэлгэр удирдан явуулав.
12	ISO 9001 стандарт-чанарын менежментийн тогтолцоо	1	6		Аймгийн хурлын танхимд
13	“Хил хязгааргүй номын сан” төслийн багийн сургалт	1	13	Австралийн ЭСЯ, МУҮНС, Монголын Номын Сангийн Холбоо	Монгол улсад суугаа Австрали улсын Элчин сайд Кэйти Смит, Хөтөлбөр хариуцсан ахлах менежер Х.Өрнөх, МНСХ-ны Гүйцэтгэх захирал М.Даваасүрэн, МУҮНС-ийн ACIP төслийн менежер Б.Сайнбилэг нар Шилдэг туршлагад суурилсан чадавхжуулах сургалтанд аймаг, сумдын номын санч, ажилтнуудыг хамрууллаа.
14	Номын санч-Мэдээллийн ажилтнуудын улсын X зөвлөгөөн	1	11	Соёлын яам, МНСК, МУҮНС, Соёл урлагийн их сургууль	Зөвлөгөөн танхим болон цахим хэлбэрээр явагдаж Төв номын сангийн 11 ажилтан, албан хаагч цахимаар оролцож байна.
15	Монгол бичгийн сургалт	3	42	ТНС дээр	Монгол бичгийн анхан, дунд, гүнзгий шатны сургалтуудыг мэргэжлийн багш нар болон өөрсдөө ажлын хажуугаар давтан амжилттай суралцлаа.
	Нийт оролцсон хүний тоо	**17**	**253**	**15 нэр төрлийн сургалтыг 17 удаа зохион байгуулж, давхардсан**	

				тоогоор 253 номын санчийг оролцуулсан байна.

<u>Шагнал урамшуулал:</u> 2023 онд ажил үүргээ хариуцлагатай, үр дүнтэй, тогтвор суурьшилтай хийж, манлайлан ажилласан 6 хүнийг тодорхойлолж, 5 хүний шагнал шийдвэрлэгдэн ирэв.

2023 оны 05-р сарын 05-ны өдрийн 57 тоот албан бичгээр Ардын хувьсгалын 102 жилийн ойг тохиолдуулан:

- ✓ Монгол Улсын Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн Гавъяаны Улаан тугийн одонгоор ахмад номын санч Д.Лида /СУГ- аар дамжуулан Соёлын яамаар уламжлагдан ЗГ-т хүргэгдээд байна./
- ✓ Хөдөлмөрийн хүндэт тэмдэгээр сан хөмрөгч-мэдээллийн ажилтан И.Пүрэвбат,
- ✓ Сангийн Яамны Санхүү тэргүүний ажилтан тэмдгээр нябо Б.Даваадолгор
- ✓ Соёлын Яамны жуух бичгээр С.Энхцэцэг,
- ✓ Дархан-Уул аймгийн дээд шагнал “Найрамдлын Дархан тэмдэг”-ээр Уншлага үйлчилгээний нэгжийн дарга Н.Норжмаа
- ✓ Дархан-Уул аймгийн “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр сан хөмрөгч О.Дунжидмаа нарын ажил, хөдөлмөрийн тодорхойлолтуудыг бичиж захирал Б.Цэцэгсүрэнгээр хянуулан холбогдох газруудад хүргүүлснээр тус тус төрийн дээд одон медалиудаар шагнагдаад байна.

Мөн Төв номын сангийн номын санчдаас гадна Аймгийн Их дээд, ЕБС-ийн номын санчдыг шагналд тодорхойлж уламжилдаг бөгөөд

- ✓ 18-р сургуулийн номын санч А.Алтанцэцэг-МУСТА,
- ✓ Энэрэл цогцолбор сургуулийн номын санч П.Одгэрэл Аймгийн Тэргүүний ажилтан,
- ✓ ОИЦ сургуулийн номын санч С.Отгонжаргал Аймгийн Тэргүүний ажилтан,
- ✓ 9-р сургуулийн номын санч Д.Мөнхжаргал Найрамдлын Дархан тэмдгээр тус тус шагнагдсан байна.

<u>Үр дүнд суурилсан санхүүжилтийн журмын дагуу</u> нийт ажилтнууд 6,2 сая төгрөгийн урамшуулал, 2023 оны ажлаа дүгнэж Төв номын сангийн 2 номын санч, ЕБС-ийн 1 номын санч, Хүүхдийн номын ордоны номын санчдыг мөнгөн урамшууллаар урамшуулав.

Тулгарч буй бэрхшээл:

Асуудал	**Цаашид ...**
Мэргэжлийн боловсон хүчин дутагдах эрсдэл	Шинээр ажилд орсон ажилтнуудыг мэргэжүүлэх болон мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулах, дэмжих
Мэргэжлээс шалтгаалсан харшил, харааны бэрхшээл зэрэг эрүүл мэндийн шалтгаан үүсэх	Урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах Харшлын нарийн мэргэжлийн үзлэгт хамруулах
Номын сангуудад сургалтын зардалтай болох	Ингэсэнээр орон нутгийн түвшинд болон УБ хот бусад газруудаас сургагч багш, мэргэжлийн хүмүүсийг урьж сургалт авах, тогтмол хөгжих, чадвахижих боломж бүрдэнэ
Номын сангийн LIB-4U програмын зардлын төсөв байхгүй	-

Номын санчдын зэрэг дэвийн журам одоо хүртэл батлагдаагүй.	-

3.7. Захиргаа удирдлагын зохион байгуулалт, төсөв санхүүгийн асуудал:

Аймгийн Төв номын сан нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, Соёлын Яам, орон нутгийн засаг захиргаа, нутгийн удирдлагын байгууллагуудаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж, Соёлын яам, Үндэсний номын сангийн чиглэл, арга зүйн хүрээнд номын сангуудын консерциум болон орон нутгийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаваруудад хариуцлага, санаачлагатай хандан хамтран ажиллаж ирэв.

- Төв номын сан нь 15 ажиллагсадтай, 2 салбар номын сантайгаар орон нутгийн уншигч иргэдэд төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байгаа бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар төсөв 377,779,200 төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэл 333,297,300 төгрөг байна.

Утга	Төсөв	Гүйцэтгэл
Цалин хөлс	322,311,900	265,443,831
Нийгмийн даатгал	40,701,700	35,746,700
Байр ашиглалт	15,144,600	12,928,400
Хангамж бараа	8,471,200	7,478,242
Ном хэвлэл	3,000,000	3,000,000
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	3,557,000	3,557,000

Төв номын сан нь шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах үүднээс “Шилэн дансны болон төсөв санхүүгийн ил тод байдал” самбарыг цаасан болон цахим хэлбэрээр сар бүр тогтмол ажиллуулж номын сангийн төсвийн нээлттэй байдлыг хангаж ажиллаж байна. Мөн 2023 онд өр авлагагүй, төлөвлөгөөний гүйцэтгэлд **8,834,000** төгрөгийг өөрийн орлогоор нөхөн бүрдүүлсэн байна.
Төрийн байгууллагуудын нэгдсэн **Эйбл** программаас шаардлагатай мэдээ мэдээллийг тогтмол авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллав

- ✓ 2023 онд төслөөр 2 notebook, худалдаагаар суурин компьютер 3 ком, уншигчдын хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор хувцасны шүүгээ 2 комыг авч үндсэн хөрөнгөндөө бүртгэв.

ДӨРӨВ. ШИНЭЛЭГ САНАА, ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, ОЛОЛТ АМЖИЛТ

Номын санчийн хишиг өдөр:

- Монгол Улсын Засгийн газрын 2010 оны долоодугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор жил бүрийн есдүгээр сарын хоёр дахь ням гарагт Соёл, урлагийн ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалын дагуу Монгол Улсын Соёл, урлагийн ажилтны 30 дахь өдрийн хүрээнд Төв номын сангаас номын санчийн “ХИШИГ ӨДӨР”-ийг зохион байгууллаа.Хишиг өдрийн зочин номын санчаар Төв номын санд МУСГЗ Ө.Рагчаасүрэн, Цэц.мн сошиал телевизийн сэтгүүлч Т.Гэрэлцэцэг нар ажиллав.

  "Хишиг өдөр"-ийн хүрээнд салбар номын сангийн зочин номын санчаар Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Дархан салбарын дарга Л.Отгонбаатар, Гэр бүлийн 104,5 радиогийн Дархан салбарын хөтлөгч, сэтгүүлч Ц.Тэгшбуян нар ажиллалаа.

Боловсролын хөтөлбөр:
Соёлын бүтээлч сарын хүрээнд номын сангийн боловсролын багц хөтөлбөр хэрэгжүүлсэн байдал:

Он сар өдөр	Сургуулийн нэр	Боловсролын хөтөлбөр хийсэн		
		1-р багц	2-р багц	ДҮН
2023.11.27	ЕБС-ийн 1-р сургууль	3	36	39
2023.11.25	Турк сургууль	10		10
2023.11.28	ЕБС-ийн 18-р сургууль		85	85
2023.11.23	Цайхун сургуулийн 9-10-р анги	15	3	18
2023.11.23	9-р сургууль	85		85
2023.11.29	4-р сургууль	33	33	66
2023.11.27	19-р сургууль	12	12	24
2023.11.28	Монгол оюу		10	10
2023.11.29	30-р сургууль	10	10	20
2023.11.30	16-р сургууль		30	30
2023.11.29			20	20
		5	19	24
2023.11.29	Шинэ алхам		12	12
	ДҮН	***173***	***270***	443

Миний мэргэжил сайхан нэвтрүүлэг: Дархан-Уул аймгийн Төв номын сан байгуулагдсаны 60 жилийн ойг угтан, Үндэсний бичиг соёл номын өдрүүдийн хүрээнд бэлтгэн хүргэж буй "МИНИЙ МЭРГЭЖИЛ ХАМГИЙН САЙХАН" цуврал нэвтрүүлгийн энэ удаагийн дугаарт Дархан-Уул аймгийн Төв номын сангийн ахмад номын санч, МУСТА, Соёл судлалын магистр, доктрантур Ч.Бадамцэцэг, Төрийн дээд шагнал Алтан гадас одонт, МУСТА Цогийн Долгорсүрэн, Төрийн дээд шагнал Алтан гадас одонт, МУСТА Намсрайн Солонго нар болон ЕБС-ийн 3 ахмад номын санчид оролцов. Бид ирээдүйн боловсон хүчин, залуу хойч үедээ мэргэжлээ өвлүүлэх, сурталчилах зорилгоор "Миний мэргэжил сайхан" уулзалт нэвтрүүлгийг 13 дахь удаагаа зохион байгуулж байна.

Төслийн талаар: 2023 онд нийт ***8 удаагийн 89 879 700 төгрөгийн*** *төсөл бичиж холбогдох газруудад нь хүргүүлсэнээс 3 төсөл дэмжигдэж 1800000 төгрөгийн хөдөлмөрийн хөлстэйгээр 5 ахмад номын санчдыг түр ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа..*

- ✓ "Нүүдэл зөөврийн номын сангийн фондын баяжилт" төсөл -10 000 000 төг
- ✓ "Алсын хараа-2050" төсөл - 2 410 000 төг
- ✓ "Цахим номын сан" төсөл – 18 000 000 төг
- ✓ Аймгийн СУГ-аар уламжлуулан 15 999 700 төгрөгний ***"ХЭРЭГЛЭГЧ ХААН*** " тоног төхөөрөмжийн төсөл бичиж НБХ-т хүргүүлэв.
- ✓ "Ургаа уудалъя" номын сангийн боловсролын хөтөлбөр" сэдвээр 42 030 000 төгрөгний төсөл бичиж Соёл, урлагийг дэмжих санд цахимаар https://suds.ictgroup.mn/auth/login бүртгэж явуулсан боловч тэнцээгүй.
- ✓ Ахмадын хөгжлийн төвтэй хамтран ажиллах чиглэлээр ахмад номын санчдын зөвлөн туслах үйлчилгээний "Ахмадын сургааль алт-2" 1 440 000 төгрөгийн төсөл,
- ✓ Аймгийн Төв номын сантай хамтран ажиллах чиглэлээр 15-р багийн ахмад настан Н.Төмөртогоод "Иргэдийн оролцооны соёл"-ыг төлөвшүүлэх нь" 360000 төгрөгийн

төсөл бичиж Дархан-Уул аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт өгч, шалгаран амжилттай хэрэгжиж дууслаа.

- Үр дүнд суурилсан санхүүжилтийн журмын дагуу 2022 оны үйл ажиллагааны дагуу улсад нэгдүгээр байранд орж Соёлын яамнаас 41,0 сая төгрөгийн санхүүжилт авч, журмын дагуу зарцуулан, тайлагнаж байна.
- Бүх нийтийн соёлын боловсрол олгох үндэсний сургагч багшаар Б.Цэцэгсүрэн, Стандартыг нэвтрүүлэх нь сургалтад Б.Цэцэгсүрэн, С.Нэргүй, С.Энхцэцэг, Н.Норжмаа нар сууж гэрчилгээ авав.
- "Соёл ба оролцооны соёлыг төлөвшүүлэх нь" 16 цагийн сургалтанд 15 хүн хамрагдав.

ТАВ. НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Лавлагаа номзүйн нь уншигчдад мэдээллийг хялбар шуурхай түгээж, хэрэгтэй материалыг нэг цэгээс олох боломжийг олгодог.

- Манай номын сан нь 1964 онд байгуулагдсан бөгөөд орон нутгийн картын санг 1980-иад оноос эхлэн бичгийн машинаар каталогоо бичиж, шинжлэх ухааны салбараар нь байрлуулж байв. Үүний дараа 1964-1980 оны хооронд хэвлэгдсэн орон нутгийн картын санг салбарын эрхлэгч Д.Гансүх эмхтгэн хэвлүүлж байсан бөгөөд номын сангийн 40 жилийн ойгоор хамтын бүтээл (1964-2004) хоёр дахь хэвлэлийг Сэргэлэн ХК-аар 150% хэвлүүлж олны хүртээл болгосон. Үүнийг үргэлжлүүлэн номын санч Н.Солонго дахин засварлаж, 500 шахам зохиолч, уран бүтээлчдийн зураг хөрөг, ном, уран бүтээлийн цуглуулга хийж, цагаан толгойн үсгийн дараалалд оруулан ажиллахдаа нэгээр нь дамжуулж, нөгөө нэгний нь зураг намтар түүх, уран бүтээлүүдийг нь олж цуглуулан тэдний сан хөмрөгийг бүртгэн авч Дархан хот, Дархан-Уул аймаг, зохиолч, уран бүтээлчдийн орон нутгийн номзүйн (1965-2018) бүртгэлийг Үндэсний номын сангийн мэдээлэл аргазүйн эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Д.Энхтунгалаг, Үндэсний номын сангийн номзүйч Х.Ундрах, аргазүйч Б.Цогжаргал, аргазүйч Сарандэлгэр, номзүйч Ж.Ганхөлөг нараар хянуулан 350% хэвлэн гаргаж, 21 аймгийн нийтийн номын сангуудад хүргүүлсэн.
- Бидний дараагийн том бүтээл бол “Дархан-Уул аймаг хэвлэлийн хуудаснаа” (1964-2014) 3 боть номзүйн бүтээлийн эхийг бэлтгэн хэвлэхэд бэлэн болгоод байна. Энэхүү номзүйн бүртгэлийг бэлтгэхдээ Монгол Улсын Үндэсний номын сан, Монгол Улсын Хүүхдийн номын ордон, Дархан-Уул аймгийн Төв номын санд хадгалагдаж буй ном хэвлэл, цуврал, эмхтгэл сонин сэтгүүлээс түүвэрлэн авч нэгтгэсэн. Номзүйн бүртгэлд хамрагдсан бүтээлүүд нь гурван хэсгээс бүрдэж байгаа бөгөөд 1-р хэсэгт Дарханы тухай бие даасан ном, 2-р хэсэгт Дарханд байгуулагдсан үйл ажиллагаа явуулж байсан нийгмийн хөгжлийн бүхий л салбарууд тэдгээрт ажиллаж амьдарч хүмүүсийн тухай, 3-р боть нэрсийн хэлхээс, лавлах хэсгүүдээс бүрдсэн. Одоогоор номын сангийнхаа 60 жилийн ойгоор 2024 онд хэвлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

ЗУРГАА. НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

/хавсралтаар/

ДОЛОО. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Музей, номын сангийн цогцолборын барилга угсралтын ажлын талаар:

- ✓ Байршил: Дархан сум, 14-р баг
- ✓ Захиалагч: Дархан Уул аймгийн ЗДТГ
- ✓ Зохиогч: "Балданс" ХХК

- ✓ Гүйцэтгэгч:"Воком констракшн" ХХК
- ✓ Хөрөнгө оруулалт: УТХО
- ✓ Гэрээний дүн: 4,9 тэрбум төгрөг
- ✓ Гэрээний хугацаа 2021.07.01-2023.09.01
- ✓ Нийт ажлын явц: 50%
- ✓ В1 давхарын өрлөгийн ажил-65%
- ✓ 1-р давхарын өрлөгийн ажил-15%
- ✓ 2-р давхарын угсралтын ажил-45%

НАЙМ. ХАВСРАЛТ

- ***Эрдэм шинжилгээний хурал***

"Үеэс үед өвлөгдөх их дээдсийн судар" *сэдэвт эрдэм шинжилгээний* хурлыг зохион байгуулж, 50 гаруй багш сурагчид оролцов.

- ***Зохиолч уншигчдын уулзалт***

"Тэнгэрийн заадаст оршихуй" уран бүтээлийн уулзалтыг зохион байгуулж зочдоор:

- ✓ Монгол Улсын Ардын зураач, УГЗүтгэлтэн, шог зураач Ц.Байды,
- ✓ Монгол Улсын Ардын жүжигчин Г.Мягмарнаран,
- ✓ МУСГЗ, Сэтгүүлч, зохиолч Ш.Ёолк,
- ✓ "Тэнгэрийн заадас" хөрөг номын зохиолч Ж.Буд-Эрдэнэ нар оролцов.

Уулзалтанд 400 гаруй иргэд хамрагдаж зохиогчийн гарын үсэгтэй номын худалдаа, зочдын фото зургийн үзэсгэлэн болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн, шинэ номын худалдааг зохион байгуулав.

“УУТАН ХАЦАРТ" номын зохиолч МУСГЗ, сэтгүүлч Ө.Рагчаасүрэн, зураач Б.Нямдаваа нарын бүтээлээр хийсэн "ЗОХИОЛЧ-ХҮҮХЭД" уулзаланд 50 гаруй сурагчид, номын санчид оролцов

- **Шинэ номын нээлт:**

Радио телевизийн Тэргүүний ажилтан, МҮОНРТ-ийн ахмад ажилтан Д.Жамсрангийн 3 дахь бүтээл болох "Мэдлэг ба сэтгэлгээ өдрийн тэмдэглэл" номыг Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд өлгийдөн авч "ШИНЭ НОМЫН БАЯР"-ыг зохион байгуулахад оролцож ***40 гаруй*** уншигчид, найз нөхөд оролцов.

МЗЭ-ийн гишүүн, Утга зохиолын төлөө хүндэт шагналт, Монголын шог зураачдын “Шогч бийр” холбооны гишүүн, шог зураач Д.Мянганзамын "ЗУРАГДСАН ПЯНЗ" шинэ номын нээлт болов.

Номын клубын сурагчдын дунд уулзалт-хэлэлцүүлгийг зохион байгуулав.

"СОЁЛЫН СЭРГЭЛТ-2023" АЯНЫ ХҮРЭЭНД

"Соёлын сэргэлт-2023" аяны нээлтийн үеэр Соёлын Сайд Ч.Номин манай үзэсгэлэнгээр зочлов. Үзэсгэлэнд Үндэсний бичиг үсгээр 30-р сургуулийн сургалтын менежер Ж.Эрхэмсайхан, “Угийн бичиг” –ийн үзэсгэлэнд 15-р багийн иргэн Г.Мягмар нарыг урьж оролцуулав.

Сургалт, мэдээлэл /ЛЕКЦ/

2022 онд "Нүүдэлчин" Дэлхийн Соёлын Фестивальд Төв номын сангаас соёлын биет бус өвийг хамгаалах сурталчилах зорилгоор баг бүрдүүлэн тус наадамд оролцсон бөгөөд үндэсний хэмжээний шилдэг өвлөн уламжлагчаар дараах баг хамт олны төлөөлөл тодорч шагналаа гардан авлаа.Үүнд:

1. "Монгол бичиг QR код" бүтээлээр Дархан-Уул аймгаас оролцогч багш Б.Булганчимэг,
2. "Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд" төрөлд багш Ж.Эрхэмсайхан,

3. "Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл" төрөлд багш Ц.Буянхишиг нар шалгарч ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ медаль, мөнгөн шагналаар шагнуулллаа.

Номын баяр: Дархан хотын номын баяр- ХҮҮХЭД БҮР УНШИГЧ

Номын баярын нээлтийн үйл ажиллагаа Залуучууд театрын 1-р давхарт

ӨДӨРЛӨГ: Оюунлаг Дарханчууд өдөрлөгийг 40 удаа зохион байгуулж, 5109 хүнийг хамруулж, 4136 боть номыг уншуулсан байна.

БҮТЭЭЛЧ УНШЛАГА: 32 төрлийн бүтээлч уншлагыг 46 удаа зохион байгуулж, 2464 хүнийг оролцуулан, 1803 боть номыг УНШУУЛСАН БАЙНА.

"НҮҮДЭЛ" НОМЫН БОГЦ АЯН"

Нүүдэл номын аяны богцыг 20 гаруй удаа төрийн байгууллага болон ЕБС-аар зохион байгуулав. Мөн Шатрын спортын мастер багш Д.Пүрэвдорж, Америк багш Scarlett Patton нарын ивээн тэтгэлэгээр 25 үүргэвчийг шинээр хийлгүүлэн, ахмад настан, ЕБС-ийн сурагчдад гэрээр ном олгож байна.

НОМЫН САНГИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРҮҮД

Автобустай аялал:
Шилдэг уншигчдийг урамшуулах автобустай “Бүтээлч аялал”-ыг зохион байгуулж аймгийн ЕБС-ийн 5-8-р анги, 9-12 дугаар ангийн 90 сурагчийг хамруулав.

“Миний мэргэжил сайхан” нэвтрүүлгийг ***18 удаа*** зохион байгуулав.

"Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд аймгийн нийт номын санчдын дунд эсгий урлалаар соёлын боловсрол олгох сургалт зохион байгуулав.

"НОМ ХЭВЛЭЛИЙН СТАНДАРТ" ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

"Ном хэвлэл, утга зохиол"-ын салбарын хамтын ажиллагааг орон нутагт сайжруулах, бэхжүүлэх, Үндэсний номзүйн бүрдүүлэлтийг орон нутагт жишиг болгох зорилгоор өнөөдөр "НОМ ХЭВЛЭЛИЙН СТАНДАРТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ"-ийг зохион байгууллаа.

НОМЫН САНЧИЙН ХИШИГ ӨДӨР:

Хишиг өдрийн зочин номын санчаар Төв номын санд МУСГЗ Ө.Рагчаасүрэн, Цэц.мн сошиал телевизийн сэтгүүлч Т.Гэрэлцэцэг, Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Дархан салбарын дарга Л.Отгонбаатар, Гэр бүлийн 104,5 радиогийн Дархан салбарын хөтлөгч, сэтгүүлч Ц.Тэгшбуян нар ажиллав.

Сурагчдын зуны амралтад зориулан “English story hour” англи хэлний сургалтыг 6-12 насны нийт 60 гаруй хүүхэд багачуудад зориулан “English story hour” англи хэлний сургалтыг Scarlett Patton Америк багштай хамтран зохион байгууллаа.

УБТЗ-тай хамтран хэрэгжүүлж буй Галт тэрэгний аялалд Улаанбаатар хотын 29-р тусгай сургуулийн сурагчид хамрагдаж номын сангийн “Боловсролын хөтөлбөр” сургалтыг авлаа.

Дархан-Уул аймгийн нийт Соёл, Урлагийн ажилтан, албан хаагчдын Спортын бага наадамд сагс, волейбол, теннис, даамны тэмцээнд багаараа оролцов.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН НОМЫН ОРДНЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УДИРТГАЛ

НЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД

Зорилт 1.1 Эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал зан заншил зэрэг үндэсний үнэт зүйлийг эрхэмлэн хөгжүүлэх;

Арга хэмжээ 1.1.1 Албан хаагчдын сургалтын хөтөлбөрт ажилтны монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг жил бүр төлөвлөж, тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх, байгууллага, хамт олноороо монгол бичигтэн болох аян, хөдөлгөөн өрнүүлэх;

Арга хэмжээ 1.1.2 Суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан монгол бичгийн сурах бичиг, толь бичиг, сургалтын бусад хэрэглэгдэхүүнээр хангах, сурч боловсрох үйл ажиллагааг дэмжих, “Хүмүүн бичиг” сонинг тогтмол захиалах;

Арга хэмжээ 1.1.3 Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах технологийн орчин бүрдүүлж бэлтгэл ажлыг хангах;

Арга хэмжээ 1.1.4 Монгол бичгийн түүх соёлын үнэт дурсгалуудыг сурталчлах;

Арга хэмжээ 1.1.5 Угийн бичиг хөтлөх журмын дагуу ажилтан албан хаагч, хүүхэд багачуудад сургалт зохион байгуулах,

Арга хэмжээ 1.1.6 Түүх, соёлын дурсгал, утга зохиол урлагийн бүтээл, соёлын биет болон биет бус өвийн тухай мэдээлэл бэлтгэж, уншигч хэрэглэгчдэд хүргэх;

Зорилт 1.2 Бүх нийтийн соёлын боловсрол олгох үйл ажиллагааг ХНО-ны хэмжээнд зохион байгуулах;

Арга хэмжээ 1.2.1 Бүх нийтийн соёлын боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлэх;

Арга хэмжээ 1.2.2 Бүх нийтийн сонгодог урлагийн боловсролыг дээшлүүлэх, сурталчилгааны ажлыг олон нийтийн мэдээллийн сувгаар хүргэх

Зорилт 1.3 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх;

Арга хэмжээ 1.3.1 Бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх, бүтээлч дадал эзэмшүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх, соёлын боловсрол олгох чиглэлээр мэдээлэл бэлтгэж, хэрэглэгчдэд хүргэх;

Арга хэмжээ 1.3.2 Хүүхдийн номын ордны соёлын бүтээлч брэндийг бий болгох, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;

Зорилт 1.4 Соёлын сайд бөгөөд Дархан уул аймгийн засаг даргын хооронд 2023 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах;

Арга хэмжээ 1.4.1 Соёлын сайд болон Дархан-уул аймгийн засаг дарга нарын хооронд байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах;

Зорилт 1.5 Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг ХНО-ны хэмжээнд хэрэгжүүлэх:/Тусгай сонирхолын аялал жуулчлалын төрөл бий болгох/

Арга хэмжээ 1.5.1 "Номтой аялал" арга хэмжээг зохион байгуулах;
Арга хэмжээ 1.5.2 Ажилтан албан хаагчдыг биеийн тамираар хичээллэх боломжийг олгох;
Арга хэмжээ 1.5.3 Мод тарих;
Арга хэмжээ 1.5.4 Агч модны үр түүж савлах, тарих аргачлал боловсруулж хэрэглэгчдэд хүргэх;

Зорилт 1.6 Аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ХНО-ны хэмжээнд хангаж ажиллах;

Арга хэмжээ 1.6.1 "Оюунлаг Дарханчууд" дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллах;
Арга хэмжээ 1.6.2 "Цахим Дархан" дэд хөтөлбөрийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажиллах;
Арга хэмжээ 1.6.3 "Дархан-Уул аймгийн авлага, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" дэд хөтөлбөрийн хүрээнд соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах;
Арга хэмжээ 1.6.4 "Шарилжгүй Дархан" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Зорилт 1.7 Дархан-Уул аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний холбогдох заалтуудыг ХНО-ны хэмжээнд хэрэгжүүлж ажиллах;

Арга хэмжээ 1.7.1 ХНО-ны номын сангийн тоног төхөөрөмжийг шинэчлэх;
Арга хэмжээ 1.7.2 ХНО-ны номын санг зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах;
Арга хэмжээ 1.7.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
Арга хэмжээ 1.7.4 Бие даасан цахилгааны эх үүсвэртэй болох;
Арга хэмжээ 1.7.5 Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах;

ХОЁР: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТИЙН ХҮРЭЭНД:

Зорилт 2.1 Номын сангийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

Арга хэмжээ 2.1.1 Уншигч, ирэгсэд, ном олголтыг стандартын түвшинд хангаж ажиллах;

Арга хэмжээ 2.1.2 Төрөлжсөн танхимуудаар дамжуулан хүүхэд багачуудад номтой нөхөрлөх, бие даан сурч боловсрох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

Арга хэмжээ 2.1.3 Гэрээр ном олгох үйлчилгээ үзүүлэх;

Арга хэмжээ 2.1.4 Нүүдлийн номын сангийн үйлчилгээ хүргэх;

Арга хэмжээ 2.1.5 Зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэх;

Арга хэмжээ 2.1.6 Цахим уншлага үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, уран бүтээлчийн зөвшөөрлөөр уран бүтээлийг цахим хэлбэрт хувиргах үйл ажиллагааг зохион байгуулах;

Арга хэмжээ 2.1.7 Уншигчдад лавлагаа, мэдээлэл өгөх,

Арга хэмжээ 2.1.8 Шинэ номын мэдээ, санамж өгөх ном зүйн бүртгэлүүдийг тогтмол бэлтгэж, уншигчдад хүргэнэ.

Арга хэмжээ 2.1.9 Тусгай бүлгийн уншигчдийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээг хүргэх; /номын санд биеэр ирэх боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан эмнэлэгт байгаа хүүхэд, асрамжийн газар болон тусгай газруудад байгаа хүмүүст гэрээр ном олгох, зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх/

Зорилт 2.2 Ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах, ном унших арга барилд төлөвшүүлэх Соёл Олон Нийтийн арга хэмжээг зохион байгуулж ажиллана

Арга хэмжээ 2.2.1 Номын үзэсгэлэн зохион байгуулах;

Арга хэмжээ 2.2.2 Чанга уншлага, тойм яриа хийх;

Арга хэмжээ 2.2.3 Уншигч зохиолчдын уулзалт зохион байгуулах;

Арга хэмжээ 2.2.4 Дэлхийн номын өдрийг тэмдэглэх;

Арга хэмжээ 2.2.5 “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тэмдэглэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллана.

Арга хэмжээ 2.2.6 “Үдшийн уншлага” арга хэмжээг зохион байгуулах;

Арга хэмжээ 2.2.7 “Тэргүүний уншигч Д.Нацагдорж”- тэмдэгтэний болзол хангасан уншигчдыг шалгаруулах, цомог бэлтгэх;

Арга хэмжээ 2.2.8 “Англиар хэн сайн үлгэр ярих вэ” уралдаан зохион байгуулах

Арга хэмжээ 2.2.9 Бага ангийн сурагчдын дунд сэтгэхүй хөгжүүлэх чиглэлээр уралдаан зохион байгуулах;

Арга хэмжээ 2.2.10 Ахлах ангийн хүүхдүүдийн дунд “Хотын соёл биднээс эхтэй” сэдэвт богино хэмжээний шторк бэлтгэх уралдаан зохион байгуулах;

Арга хэмжээ 2.2.11 Уншигчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах

Зорилт 2.3 Номын сангийн сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хангах, баяжилтад судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах, шинэ номын баяжилт хийх;

Арга хэмжээ 2.3.1 Сан хөмрөгийн тооллого зохион байгуулах;

Арга хэмжээ 2.3.2 Сан хөмрөгийн баяжилт хийх;

Арга хэмжээ 2.3.3 Номын сангийн ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг электрон каталогт оруулах, электрон болон цаасан каталогийг зохион байгуулах

Арга хэмжээ 2.3.4 Каталог ашиглах талаар заавар зөвлөмж боловсруулах, хэрэглэгчдийг каталогт ажиллуулж сургах;

Арга хэмжээ 2.3.5 Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах сургалт зохион байгуулах;

ГУРАВ: ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТИЙН ХҮРЭЭНД:

<u>Зорилт 3.1</u> Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Арга хэмжээ 3.1.1 Төсөв, төслийн болон хандивын хөрөнгийг зориулалтаар нь үр ашигтай зарцуулах;

Арга хэмжээ 3.1.2 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд байгууллага, эцэг эх, олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

Арга хэмжээ 3.1.3 Жендрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана.

<u>Зорилт 3.2</u> Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийг ХНО-ны түвшинд хэрэгжүүлж ажиллана.

Арга хэмжээ 3.2.1 Номын баярын өдрийг тэмдэглэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж ажиллах;

Арга хэмжээ 3.2.2 Эх хэлний өдрийг тэмдэглэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж ажиллах;

Арга хэмжээ 3.2.3 Монгол баатарлаг туульс “Аваргасын таван бодон”, “Алтан ундарга” ,”Бужин даваа хаан”, “Довон хар бөх” “Жангар”, Зул алдар хаан”, “Мөнх сайхан төрт Алтан торц”, “Хан харангуй”, “Хилэн галзуу баатар” зэрэг баатарлаг туульсийг олон нийтэд таниулах арга хэмжээг зохион байгуулах;

<u>Зорилт 3.3</u> Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллана.

Арга хэмжээ 3.3.1 ХНО-ны ёс зүйн зөвлөлийг шинээр байгуулах;

Арга хэмжээ 3.3.2 ХНО-ны ёс зүйн зөвлөлийн 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажилллах;

ДӨРӨВ: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТИЙН ХҮРЭЭНД:

<u>Зорилт 4.1</u> Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангаж ажиллана.

Арга хэмжээ 4.1.1 Холбогдох хууль, тогтоомж, тушаал, заавар судалж ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх;

Арга хэмжээ 4.1.2 ХНО-ны 2021-2024 онд баримтлах “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

Арга хэмжээ 4.1.3 Дархан-уул аймгийн хүүхдийн номын ордны 2023 онд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж баталгаажуулж мөрдөж ажиллах;

Арга хэмжээ 4.1.4 Дархан-уул аймгийн Хүүхдийн номын ордны ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж баталгаажуулан мөрдөх;

Арга хэмжээ 4.1.5 Хүүхдийн номын ордны Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж баталгаажуулах;

Арга хэмжээ 4.1.6 Хамтын гэрээг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллана.

Зорилт 4.2 Бичиг хэрэг, Архивын үйл ажиллагааг стандартын дагуу зохион байгуулах;

Арга хэмжээ 4.2.1 Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамд заасны дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж ажиллах;

Арга хэмжээ 4.2.2 Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журамд заасны дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллах;

Зорилт 4.3 Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

Арга хэмжээ 4.3.1 Төсөв, төслийн болон хандивын хөрөнгийг зориулалтаар нь үр ашигтай зарцуулах;

Зорилт 4.4 Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтанд хяналт тавих, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлөөр хангах;

Арга хэмжээ 4.4.1 Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн анхан шатны бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, заавар журам, стандартын дагуу хөтлөх, тайлагнах;

Арга хэмжээ 4.4.2 Байгууллагын өмч хөрөнгө болон хүлээн авсан бараа материалын хадгалалт, хамгаалалт, эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хангах;

Арга хэмжээ 4.4.3 Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах материалыг бэлтгэх, захиалах, хуваарийн дагуу олгох ажлыг зохион байгуулах;

Арга хэмжээ 4.4.4 Мөнгөн кассын гүйлгээг гүйцэтгэх, хөтлөн явуулах;

Зорилт 4.5 Байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;

Арга хэмжээ 4.5.1 Хүүхдийн номын ордны 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Зорилт 4.6 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;

Арга хэмжээ 4.6.1 Улсын хэмжээнд ажиллаж буй номын сангуудтай харилцан туршлага солилцох, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

Арга хэмжээ 4.6.2 Хэрэглэгчид номын сангийн ажилтнуудтай эсвэл өөр хоорондоо харилцах боломж бүхий шинэлэг орчин, "онлайн" орон зайг бий болгох;

Арга хэмжээ 4.6.3 Байгууллага хоорондын мэдээлэл солилцооны системийн ашиглалтыг сайжруулна.

Арга хэмжээ 4.6.4 Цахим орчноор дамжуулан нийгэмд номын сангийн гүйцэтгэх үүргийг олон нийтийн хэрэгслээр байнга сурталчлах;

Арга хэмжээ 4.6.5 ХНО-ны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг арга хэмжээг зохион байгуулах;

Зорилт 4.7 Мэдээллийн ил тод байдлыг хангах, удирдлагыг мэдээллээр хангах, ажлын төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, статистик тайлан мэдээ гаргах;

Арга хэмжээ 4.7.1 Үйл ажиллагааны талаарх мэдээллийн байгууллагын цахим хуудсанд тогтмол мэдээлэх;

Арга хэмжээ 4.7.2 Төлөвлөгөө боловсруулах, статистик тайлан мэдээ гаргаж, холбогдох газруудад хүргүүлнэ.

УДИРТГАЛ

Хүүхдийн номын ордны алсын хараа: Оюунлаг Дарханчуудыг бүтээнэ.

Хүүхдийн номын ордны эрхэм зорилго: Ирээдүйн уншигчыг хөтөлнө.

Хүүхдийн номын ордны үнэт зүйл:

- ✓ Уншигч
- ✓ Мэдээллийн баялаг сан хөмрөг
- ✓ Чадварлаг хүний нөөц
- ✓ Тохилог орчин, хүртээмжтэй үйлчилгээ
- ✓ Дэвшилтэт техник технологи

Хүүхдийн Номын Ордон нь Монгол улсад хэрэгжиж буй хууль тогтоомж, Номын сангийн үйлчилгээний стандарт хэм хэмжээ, Алсын хараа-2050, Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Соёлын яамны стратеги төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан 2023 онд хамтран ажиллах гэрээ болон бусад холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон аймгийн хэмжээнд хүүхэд багачууд, оюутан залуус, насанд хүргэгчдэд номын сангийн уншлага үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, номтой нөхөрлөх хөдөлгөөнийг өрнүүлэн тэлэх, бие дааж сурч боловсрох, хөгжихөд нь үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

Хүүхдийн номын ордон нь 2023 онд 28 зорилтын хүрээнд 78 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, үүнээс: 28 зорилтын арга хэмжээг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа тайлагнаж байна.

НЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

- “Алсын хараа-2050” Зорилт 1.3;
- Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Зорилт 1.3
- Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хавсралт; “МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР III”
- Дархан-Уул аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Зорилт 1.2

Зорилт 1.1 Эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, соёл, өв уламжлал зан заншил зэрэг үндэсний үнэт зүйлийг эрхэмлэн хөгжүүлэх;

Хэрэгжилт 1.1.1

Нийт 8 ажилтан 16 удаагийн 32 цагийн сургалтад хамрагдаж, монгол бичгийн анхан шатны болон тийн ялгал, олон тоо, холбох эгшгийн дүрэм зэргийг сэргээн судалж, унших бичих чадвараа сайжруулсан.

- ❖ Эхний хагас жилд: 2022 онд шинээр ажилд томилогдсон номын санч-мэдээллийн ажилтнууд Монгол хэл,бичиг-уран зохиолын танхимын номын санч мэдээллийн ажилтан-монгол хэл бичгийн багш Ц.Наранцэцэгийн удирдлага дор анхан шатнаас эхлэн 7 хоног бүрийн лхагва гаригт 2 цагаар хичээллэж эхлээд байна. Нийт 6 ажилтан албан хаагч **8 удаагийн 16 цагийн** сургалтад хамрагдаж анхан шатны мэдэгдэхүүн эзэмшээд байна. Мөн СУГ-ын албан хаагчид монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулсан.
- ❖ Сүүлийн хагас жилд: Монгол хэл,бичиг-уран зохиолын танхимын номын санч мэдээллийн ажилтан-монгол хэл бичгийн багш О.Даваасүрэнгийн удирдлага дор 8 ажилтан **8 удаагийн 16 цагийн** сургалтад хамрагдаж тийн ялгал, олон тоо, холбох эгшгийн дүрэм зэргийг сэргээн судалж, унших бичих чадвараа сайжруулсан.

Хэрэгжилт:1.1.2

- ❖ Монгол хэл –бичиг, уран зохиолын төрөлжсөн танхимын үйлчилгээгээр дамжуулан 752 уншигч хүүхэд, 3844 иргэсдэд 4198 ном хэвлэл, болон хэвлэмэл бус материалаар үйлчилж, Монгол хэл бичгийн хичээлийн агуулгыг бүрэн эзэмшихэд туслан дэмжих, хичээлийн хоцрогдлыг нөхөх, уралдаан тэмцээн, олимпиадад оролцох, анги дэвших болон төгсөх, их дээд сургуульд элсэх шалгалтад бэлтгэхэд туслан хүүхэд залуусыг ном унших арга зүйд сургах, номтой нөхөрлүүлэх олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан.
- ❖ ХНО-ны болон СУГ-ын 24 ажилтан, 120 гаруй уншигч хүүхдүүдэд нэг хаягаа зөв бичүүлж сургасан.
- ❖ “Хүмүүн бичиг” сонинг тогтмол захиалан 24 дугаар хүлээн авч, уншлага үйлчилгээнд ашиглаж байна.

Хэрэгжилт:1.1.3

- Байгууллага дээр ашиглагддаг 12 компьютер техник хэрэгслүүд дээр монгол бичгийн драйвер суулгаж албан хэрэг хөтлөх технолгийн бэлтгэл ажлыг хангасан.
- Номын санч-мэдээллийн ажилтнуудад /8/ монгол бичгээр шивэх дасгалуудыг хийлгэж байна.
- “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хэрэгжилтийг хангах, “Хос бичигтэн байгууллага болох, Монгол бичгийн нийтийн хэрэглээний орчин бий болгох, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Хүмүүн бичиг сонин”-оос “Уншиж хэвшицгээе” уриатайгаар “Кофетой уншлага”-ыг 2 дахь жилдээ зохион байгууллаа. Арга хэмжээнд Хүүхдийн номын ордны албан хаагчид оролцож, “Хүмүүн бичиг сонин”-оос уншлага хийж, уншсан сэдвийнхээ агуулгыг бусдадаа ярьж өгөх, Монгол бичгийн унших, бичих чадварын түвшин тогтоох дасгал ажиллаж, цахим технологи ашиглан үндэсний бичгээр цахимаар бичиж сурах зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

- 2023 оны 11-р сараас эхлэн албан бичгийн монгол бичгээр илгээх ажлыг зохион байгуулж, 3 байгууллагад монгол бичгээр албан бичиг илгээсэн.

Хэрэгжилт: 1.1.4

Монгол бичгийн өв соёл хадгалалт хамгаалалтын талаар 11 мэдээлэл бэлтгэж цахимд байршуулж 1398 хэрэглэгчдэд хүргэсэн.

Хэрэгжилт:1.1.5

Овог, ураг төрөл, үндэс угсаагаа мэдэх, ах дүүсээ хэрхэн хүндлэх, удам угсаагаа цэвэр ариун байлгах, монгол хүний чанарыг сайжруулах, айл өрх бүрт заавал хөтлөдөг нэгэн түүхэн судраа зөв хөтлөх арга зүйд сургах зорилгоор "Угийн бичиг хөтлөх арга зүйд сургах" боловсролын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, нийт 17 удаагийн сургалтад 881 хүүхдийг хамруулаад байна. Сургалтаар :

- ❖ Угийн бичиг хөтлөх ач холбогдол
- ❖ Угийн бичиг хөтөлж буй хүмүүсийн туршлага
- ❖ Угийн бичиг хөтлөх дадлага ажил зэрэг мэдээллүүдийг хүргэн ажиллаж байна.

Мөн "Угийн бичиг хөтлөх арга" сэдвээр 1 багц мэдээлэл бэлтгэн цахим хуудсанд нийтэлж, 441 хэрэглэгчдэд хүргэсэн.

Хэрэгжилт:1.1.6

Нийт 15 мэдээлэл бэлтгэж, 6458 хэрэглэгчдэд хүргэсэн. Үүнд:

1. 2023.02.13-нд Монгол үндэсний язгуур урлагын төрөл- Уран нугаралт
2. 2023.02.17- нд Монгол ёсон "Алаг мэлхий өрж тоглох" тухай
3. 2023.03.07-нд язгуур урлагийн төрөл Бүүвэйн дуу
4. 2023.03.11-нд Монгол Уран бичлэг
5. 2023.04.-8-нд Монгол Ардын дуунууд
6. 2023.04.25-нд Монгол Уран бичлэгийн уламжлал
7. 2023.05.21-нд Хөдөлгөөнт тоглоом
8. 2023.05.25-нд Ээдрээ тайлах тоглоом
9. 2023.06.11-нд Монгол үндэсний уламжлал оёж мэтгэх, нэхмэл хатгамлын урлал
10. 2023.06.18-нд Уран хатгамал- задгай утсан хатгамал
11. 2023.07.09-нд Үндэсний баяр наадам
12. 2023.07.19-нд Монгол цагаан идээ-өрөм
13. 2023.08.30-нд Монгол хэлний салаа утгатай үгс
14. 2023.08.31-нд Уран бичлэгийн үзэсгэлэн
15. 2023.09.6-нд Эх хэлний 4 гайхамшиг

Зорилт 1.2: Бүх нийтийн соёлын боловсрол олгох үйл ажиллагааг ХНО-ны хэмжээнд зохион байгуулах;

Хэрэгжилт 1.2.1

Монгол Улсын Соёлын сайд, Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгэм хамгааллын сайд, Цахим хөгжил, Харилцаа холбооны сайдын 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/152, А/195, А/57, А/40 тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор "Хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын боловсрол олгох хөтөлбөр" /2023-2024/ боловсруулан баталгаажуулж, хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд:

1. "Угийн бичиг хөтлөх" арга зүйд сургах сургалт зохион байгуулах;

2. “Даам тоглож сурцгаая” аян өрнүүлэх;
3. “Кино ээлтэй Дархан” зорилтын хүрээнд кино урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох орчин бүрдүүлэх;
4. “Монголын уламжлалт тоглоом наадгай”

зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, номын сангийн үйлчилгээгээр дамжуулан хүүхэд залуусын нас сэтгэхүйн онцлогт тохирсон соёлын боловсрол олгох албан бус үйлчилгээ үзүүлж, эх хэл, үндэсний өв уламжлалаа дээдэлдэг, өөртөө итгэлтэй, бусдыг ойлгож хүндэтгэдэг, сурах арга барил, авьяас чадвараа нээн хөгжүүлдэг, эрүүл аж төрөх ёс, амьдралын зөв дадал хэвшэл, хүнлэг энэрэнгүй иргэн болж төлөвшүүлэх олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллаж байна. Үүнд:

- “Угийн бичиг хөтлөх арга зүй”-н сургалт нийт 17 удаа зохион байгуулагдаж 881 гаруй хүүхэд,
- “Даам тоглож сурцгаая“ аян 7 хоног бүрийн мягмар гаригт тогтмол зохион байгуулагдаж, нийт 97 хүүхэд,
- “Кинонд ээлтэй Дархан” кино урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох хөтөлбөрт Дархан-Уул аймгийн Засаг дарга Б. Азжаргалын санаачилгаар Монгол контент Маамуу брэндтэй хамтран бүтээсэн "Ами Тами-Хөгжилтэй аялал” анимейшнд Дархан хотын бэлгэдэл Нада буга гол дүрд нь тоглосон хүүхэлдэйн киног 8 цэцэрлэгийн 253 хүүхэд,
- “Монголын уламжлалт тоглоом наадгай” хөтөлбөрийн хүрээнд ардын уламжлалт 3 төрлийн оньсон, 1 хөлөгт тоглоомоор баг, анги хамт олон, гэр бүлээрээ тоглох, бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүлж, 125 хүүхдийн тус тус хамруулсан.

Хэрэгжилт: 1.2.2

6 мэдээлэл 3985 хэрэглэгчдэд хүргэсэн.

- ✓ Сонгодог урлагийн онцлог
- ✓ Дэлхийд алдартай 5 театр
- ✓ Балетийн урлаг
- ✓ Учиртай гурван толгой дуурь
- ✓ Анна каренина
- ✓ Театрын соёл мэдээлэл 3985 хэрэглэгчдэд хүргэсэн

Зорилт 1.3: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх;

Хэрэгжилт: 1.3.1

6 мэдээлэл бэлтгэж 1628 хэрэглэгчдэд мэдээлэл хүргэсэн.

Оруулсан мэдээллийн сэдэв:

- ✓ Ширэн эдлэл -226
- ✓ Хээ угалз -244
- ✓ Оньсон тоглоом -319
- ✓ Хөлөгт тоглоом -199
- ✓ Уран баримал -345
- ✓ Хөгжмийн зэмсэг -295 хэрэглэгчдэд тус тус хүргэсэн.

Хэрэгжилт:1.3.2

- “Хүүхдийн номын ордон”-ы 20 жилийн ойг тохиолдуулан 20 жилийн ойн логог бүтээсэн.

- ХНО-ны 20 жилийн ойн хүрээнд бэлэг дурсгалд зориулан өөрийн ордны хашаанд ургасан Агч модны үрийг түүж, цэвэрлэн тусгайлан бэлтгэсэн эко уутанд савлаж, брэнд бүтээгдэхүүн бий болгосон.
- Мөн ХНО-ны лого, бүхий 30 ширхэг тор хийлгэж, гэрээр байнгын ном авч уншдаг уншигчдад өгч хэрэглээнд нэвтрүүлсэн.

Зорилт 1.4: Соёлын сайд бөгөөд Дархан уул аймгийн засаг даргын хооронд 2023 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах;

Хэрэгжилт: 1.4.1

Гэрээний 2-р хавсралтын Зорилт 2.1-ийн хүрээнд 5 арга хэмжээ, Зорилт 3.3-ийн хүрээнд 2 арга хэмжээ, Зорилт 4.2-ийн хүрээнд 3 арга хэмжээний хэрэгжилтийг тус тус хангаж ажилласан. /Тайланг СУГ-т хүргүүлсэн/

Монгол улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний 2.2 дахь заалтад тусгагдсан арга хэмжээний хүрээнд соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр боловсруулсан “Уншихад урам хайрла” төслийг Соёл, Урлагийн газарт хүргүүлсэн.

Зорилт 1.5: Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг ХНО-ны хэмжээнд хэрэгжүүлэх: /Тусгай сонирхолын аялал жуулчлалын төрөл бий болгох:/

Хэрэгжилт:1.5.1

Уншигч хүүхэд багачуудын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолыг үндэслэн тусгай аялал жуулчлалын төрөлийг бий болгож хөгжүүлэх зорилгоор “Номтой аялал” арга хэмжээг нийт 9 удаа зохион байгуулж, 283 хүүхдийг хамруулсан. Үүнд:

1. Англи хэлний уншлага үйлчилгээний танхимын уншигч хүүхдүүдийн дунд англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх, ярианы чадвараа нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчинтой танилцах, үг цээжлэх зорилгоор “Номтой аялал” арга хэмжээг зохион байгуулж, шинээр байгуулагдсан хөл бөмбөгийн талбайтай танилцаж, хөгжөөнт тоглоом, ном унших, уншсан номоор дасгал ажил хийх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, **18** хүүхдийг хамруулсан.
2. ОИЦ сургуулийн Б.Эрдэнэчулуун багштай 5-4 ангийн сурагчид болон эцэг эхийн төлөөлөл нийт **51** уншигчийг хамруулсан “Байгальд уншья” уриатай аялалыг зохион байгуулж, ном уншлага, чөлөөт ярилцлага, хөгжөөнт тэмцээн, явган аялал зэрэг үйл ажиллагааг хөтлөн явуулсан.
3. Англи хэлний уншлага үйлчилгээний танхимын уншигчид болох Од сургуулийн Сэлэнгэ багштай 5-3 ангийн **30** хүүхэд "Номтой аялал" арга хэмжээний хүрээнд Дархан-Уул аймгийн музейд зочилж, англи хэлээр түүхэн үзвэр болон ан амьтдын үгсийн сангаа баяжуулан англи хэлний хичээлээ бататгасан.
4. “Од” цогцолбор сургуулийн 11-4 анги ***/28/*** “Байгальд уншья” арга хэмжээний хүрээнд Аймгийн музейн үзэсгэлэн үзэж, “Номоо агаарт уншъя" уриатай уншлага 50 цогцолборт хийсэн.
5. Дархан хотын ойн баярын хүрээнд салбар номын сангийн идэвхтэн уншигч хүүхдүүдийн дунд чөлөөт уншлагыг “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсан. Уншлагад 2-14 насны **40** гаруй уншигч хамрагдаж, Дархан-60 цогцолборын бүтээн байгуулалттай танилцаж, Дархан хотын түүхийн холбогдолтой болон танин мэдэхүйн ном уншиж, чөлөөт ярилцлага хийсэн.

6. ОИЦ сургуулийн Лхамаахүү багштай 5-11 ангийн **45** хүүхэд "Номтой аялал" арга хэмжээний хүрээнд "Дархан-50" цогцолбор дээр уншлага зохион байгуулж Дархан хотын түүхийн холбогдолтой болон танин мэдэхүйн ном уншиж, чөлөөт ярилцлага хийсэн.
7. "Од" цогцолбор сургуулийн С.Батцэцэг багштай 11-3 ангийн **28** уншигч-хүүхэд "Номтой аялал" арга хэмжээний хүрээнд "Миний Монгол" цэцэрлэгт хүрээлэн дээр "Зөөврийн номын сан"-гийн үйлчилгээгээр ном хүргүүлэн авч, уншлага зохион байгуулж, Дархан хотын түүхийн холбогдолтой болон танин мэдэхүйн ном уншиж, чөлөөт ярилцлага хийн, шинэ бүтээн байгуулалтуудтай танилцсан.
8. Англи хэлний уншлага үйлчилгээний танхимын уншигч хүүхдүүдийн дунд англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх, ярианы чадвараа нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчинтой танилцах, үг цээжлэх зорилгоор "Номтой аялал" арга хэмжээг "Vinpearl" coffee shop-той хамтран зохион байгуулж, кофены үүсэл гарал, үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэх соёлын талаар мэдээлэл авч, кофе шоптой холбогдолтой үг цээжлэх, англи хэлээр харилцан яриа өрнүүлэх, хөгжөөнт тоглоом тоглох, ном унших, уншсан номоор дасгал ажил хийх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, **25** хүүхдийг хамруулсан.
9. "Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд 16-18 насны өсвөр үеийн сурагчдын дунд явуулж буй "Соёлын эрхийн бичиг"-ийн тандалт судалгаанд ШУТИС-ийн харьяа ахлах сургууль, 9-р сургуулийн 11,12-р ангийн 18 сурагч хамрагдаж, эрхийн бичгээ ашиглан "Номтой аялал" арга хэмжээнд оролцон "Vinpearl" coffee shop-той хамтран зохион байгуулсан "Өсвөр үеийнхний сэтгэл зүй" сэдвээр сургалт, кофены үүсэл гарал, үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэх соёлын талаар мэдээлэл авч, кофе шоптой холбогдолтой үг цээжлэх, англи хэлээр харилцан яриа өрнүүлэх, хөгжөөнт тоглоом тоглох, ном унших, уншсан номоор дасгал ажил хийх зэрэг арга хэмжээнд оролцлоо.
10. "Номтой аялал" арга хэмжээний хүрээнд уншигч хүүхэд багачуудад эерэг нөлөөлөл үзүүлэх зорилгоор "Номтой аялал" видео контент бэлтгэж, өөрийн ордны пейж хуудсанд байршуулж, нийт 229 хэрэглэгчдэд хүргээд байна.

    Холбоос: https://www.facebook.com/Nomiin.ordon/videos/1096411704693272

Хэрэгжилт: 1.5.2

- ОИЦ сургуультай гэрээ байгуулан 7 хоногт 2 цагаар заал түрээсэлж, нийт ажилтан албан хаагчид гар бөмбөгөөр хичээллэж байна. 7 ажилтан цагийн багш хөлсөлж гар бөмбөг, 1 ажилтан ширээний теннис, 1 ажилтан хөлбөмбөгийн спортоор хичээллэж уралдаан тэмцээнд оролцож байна.
- 16 ажилтан, албан хаагчийг бие бялдрын сорилд хамруулж, нийтийн биеийн тамирийн системд шивж оруусан.
- Спортын бага наадам: Соёл, урлагийн ажилтны өдрийг угтан Дархан-Уул аймгийн соёл, урлагийн салбарын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулсан спортын бага наадамд баг, хамт олноо бүрдүүлж, сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, дартс, даам, хөзөр зэрэг спортын 6 төрлүүдээр хурд хүч авхаалж самбаагаа сорьж оролцсон.

Хэрэгжилт:1.5.3

- ❖ Өмнөх жилд тарьсан модоо усалж, арилгаа хийсэн.
- ❖ 3 ажилтан хашаандаа мод 1-2 төрлийн жимсний мод, 5-6 ширхэг агч мод тарьсан.

Хэрэгжилт:1.5.4

"Ордны хашаан доторх агч модны үрийг түүж. 100 граммаар 250 ширхэгийг савлаж, бэлэг дурсгал, уралдаан тэмцээний шагналд зарцуулж байна.

Зорилт 1.6: Аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ХНО-ны хэмжээнд хангаж ажиллах;

Хэрэгжилт:1.6.1

"Оюунлаг Дарханчууд" дэд хөтөлбөрийн хүрээнд 2 видео контент, 11 мэдээлэл бэлтгэж цахим орчинд байршуулж 3483 хэрэглэгчдэд хүргэж, 6 уралдаан зохион байгуулж, 963 уншигч хамрагдсан. Үүнд:

1. <u>Видео контент:</u>

- ❖ Номын санч – мэдээллийн ажилтан Ч.Буяннэмэх, сан хөмрөгч С.Оюунцэцэгтэй хамтран Хорол үндэсний тоглоомын талаарх мэдээллийг бичлэг хэлбэрээр бэлтгэн цахим хуудсанд байршуулан 586 хэрэглэгчдэд мэдээлэл хүргэсэн.
- ❖ УНШИХАД УРАМ ХАЙРЛА контентийг 1 удаа хийсэн. Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд Бийрийн бичлэгийн уралдаанд амжилттай оролцсон 3 охинтой ярилцлаа / хандалт 2414/

2. <u>Мэдээлэл:</u>

- ❖ Танин мэдэхүйн мэдээлэл:
  - ✓ "Хотын соёл" видео мэдээлэл
  - ✓ Хэдэн цаг болж байна вэ?
  - ✓ Эмгэн хумс хэдэн цагт авирсан бэ?
  - ✓ "Мөр гаргах зурхай"
- ❖ Мэдлэг мэдээллийн:
  - ✓ ДУА-ийн ХНО-ны шилдгүүдийн цомог
  - ✓ Номны тухай, ном уншихын ач тус
  - ✓ Ном унших аргууд
- ❖ Гэр бүл хүүхэд хамгаалалын:
  - ✓ Хүүхэд хэрхэн бодож сэтгэдэг юу мэдэрдгийг ойлгоё.
  - ✓ Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга
  - ✓ Эцэг эхчүүд хэрхэн туслах вэ?
  - ✓ ОУ-ын гэр бүлийн өдөрт

<u>3. Уралдаан</u>

- ❖ 2023.03.10 "Уранжиргээ" уран уншлагын наадам /57 хүүхэд оролцсон/
- ❖ 2023.03.16 "Бид эх орны ирээдүй" арга хэмжээ /38 хүүхэд оролцсон/
- ❖ 2023.06.01 "Монгол ёс заншил" сэдвийн хүрээнд АХА тэмцээн /51 хүүхэд оролцсон/ зохион байгуулж нийт /1/ зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийт 186 хүүхэд хамрагдсан.
- ❖ Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Цардмал талбайн зургийн уралдаан", "АХА" тэмцээн, үнэгүй карт нээх, ном уншлага хийх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, нийт 114 хүүхэд хамрагдаж, 550 гаруй хүүхэд, эцэг эхчүүд сонирхсон. Үүнд: Цардмал талбайн зургийн уралдаан 3-5, 6-8, 9-10 насны ангилалд нийт 40 хүүхэд оролцож, 9 хүүхэд шагналт байранд шалгарсан. АХА тэмцээнд 11-14 насны 51 хүүхдүүд оролцож, 3 хүүхэд шалгарсан. 6 хүүхдэд үнэ төлбөргүй карт нээж, 17 хүүхэд ном уншлагад хамрагдсан. Хүүхдийн баярын арга хэмжээнд нийт 336.000 төгрөг зарцуулсан
- ❖ Соёл, Урлагийн ажилтны өдрийг тэмдэглэх үйл ажиллагааны хүрээнд 6 арга хэмжээнд оролцож сургалтад хамрагдах, үзэсгэлэн гаргах, цахим танилцуулга бэлтгэж пейж хуудсандаа байршуулах, спортын бага наадамд оролцох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Соёл, урлагийн газрын Захиргаа удирдлагын хэлтсээс соёлын 7 байгууллагын архив, бичиг хэрэг хариуцсан ажилтнуудад зориулсан албан хэрэг хөтлөлт, бүртгэл товъёог үйлдэх арга зүйн сургалтад бичиг хэргийн ажилтан А.Ариунтуяа хамрагдсан.
- ✓ Өөрийн сан хөмрөг дэх архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлийн 12 боть номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, сургалтад оролцогсдод танилцуулсан.
- ✓ ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “Бийрийн бичлэг”—ийн уралдааны шагналт байранд шалгарсан хүүхдүүдийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж, уншигчдад хүргэсэн.
- ✓ Хүүхдийн номын ордны товч танилцуулгыг видео хэлбэрээр бэлтгэж пейж хуудсандаа байршуулан 438 хэрэглэгчдэд хүргэсэн.
- ✓ “Хүүхдийн номын ордны 1 өдөр” видео контент бэлтгэж, пейж хуудсандаа байршуулан 1865 цахим хэрэглэгчдэд хүргэсэн
- ✓ Соёл урлагийн ажилтан албан хаагчдын спортын бага наадамд байгууллагаар спортын төрлүүдэд баг бүрдүүлж, идэвхтэй оролцсон.

❖ ЕБС-ийн хүүхэд, багачуудын авьяас билиг, зохион бичих ур чадварыг хөгжүүлэх, дэмжин урамшуулах, өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг оны шилдэг шүлэг шалгаруулах “Найргийн даага-2023” уралдааныг Аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 2023.11.17-ны Баасан гаргийн 11.00 цагт буюу их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан Хүүхэд хөгжлийн ордонд 10 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Уралдаан VI – IX, X-XII анги гэсэн ангилалаар 2 үе шаттайгаар зохион байгуулагдсан. Нийт 6 сургуулийн 45 гаруй сурагчид 90 гаруй бүтээлээ ирүүлснээс удирдамжийн дагуу шаардлага хангасан 31 бүтээлийг 2-р шатанд шалгаруулж, оролцогч хүүхдүүд шүлгээ уншиж, шүүгчдийн бүрэлдэхүүн шилдгүүдийг тодруулсан

Хэрэгжилт: 1.6.2

Нийт 7 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 38 ажилтан албан хаагчид болон 8100 гаруй уншигч хэрэглэгчид мэдээлэл хүргэж ажилласан. Үүнд:

1. Тус ордон нь номын сангийн Монбиблио програмаа үүлэн технологид шилжүүлж, онлайн үйлчилгээнд холбогдсон. Электрон каталогийг зөвхөн номын санч ашиглаад зогсохгүй, уншигчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хайлт хийж, номоо захиалах, номын санчид ирэх ачааллыг багасгах, мэдээллийн санг хүссэн үедээ нөөцөлж авах боломжтой болох, програмын шинэчлэлт шууд автоматаар хийгдэх гэх мэт давуу талтай. 2023 онд Электрон каталогт нийт 909 ширхэг боть ном бүртгэгдсэн.
2. Ордны пейж хуудас 2023 оны 11-р сарын байдлаар 8100 дагагчтай ба пейж хуудсаараа дамжуулан мэдээ, мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж, 469 мэдээ, мэдээлэл байршуулж, 8100 дагагчдад (давхардсан тоогоор 4,000,000 гаруй дагагчдад) хүргээд байна.
3. Цахимаар зохион байгуулагдаж буй арга хэмжээ, хурал, зөвлөгөөн, сургалтуудад тусгай программ /zoom, google meet г.м/ ашиглан оролцож хэвшсэн. /12/
4. E darkhan апп-ийг нийт ажилтан албан хаагчид гар утсандаа суулгаж, ашиглаж байна. /17/
5. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг танилцуулах, “Төрийн албан хаагчийн цахим ур чадварыг дээшлүүлэх” сургалтад Нэгжийн дарга Т.Цэрэннадмид, номын санч- мэдээллийн ажилтан Т.Сумандадар, Албан хэрэг хөтлөлт-архив, бичиг хэргийн ажилтан А.Ариунтуяа нар хамрагдаж мэдээлэл авсан. Сургалтын талаарх мэдээллийн нийт ажиллагсдын хурал

дээр танилцуулсан. Мөн аймаг, орон нутгийн цахим бэлэн байдалд үнэлгээ өгөх, хөгжлийн түвшинг тогтоох судалгаанд хамрагдсан. /3/

6. Соёлын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгэм хамгааллын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд нарын хамтарсан 2023 оны А/152, А/195, А/57, А/40 дугаар тушаалаар батлагдсан “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Номын санч, нийгмийн ажилтныг цахим ур чадвар олгох сургагч багшаар бэлтгэх” /10-р сарын 23,24,30,31/ 4 өдрийн 12 цагийн сургалтад 6 номын санч хамрагдаж Номын санч-мэдээллийн ажилтан Ч.Буяннэмэх, Г.Гэрэл, О.Даваасүрэн, Б.Өлзийдэлгэр, М.Оюунгэрэл, Т.Цэрэннадмид “Сургагч багш”-ийн сертифекат авсан./6/
7. Сургагч багш Ч.Буяннэмэх салбар номын сангаар үйлчлүүлэгч 6-7-р ангийн 21 сурагчдад “Гар утасны зохистой хэрэглээ” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Хэрэгжилт: 1.6.3

Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордны 2023 оны Авилга, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсоруулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:

1. Авилгын эсрэг хууль тогтоомжийг пейж хуудсаараа дамжуулан нийтэд сурталчлах; (2 мэдээлэл бэлтгэж 257 хэрэглэгчдэд)
2. Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар мэдээлэл хийх; (нийт ажиллагсдын хурал дээр 2 удаа танилцуулсан)
3. Авилгатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны ном материалаар бүх албан хаагчдыг хангах; (авилгатай тэмцэх газрын пейж хуудасанд нийтлэгдсэн 2 мэдээллийг өөрийн пейж хуудсаараа дамжуулан түгээсэн)
4. Байгууллагын хэмжээнд авилга, ашиг, сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ил тод, иргэдэд хүнд сурталгүй үйлчлэх чиглэлээр мэдээлэл бэлтгэх мэдээллийн самбарт байршуулах (1 мэдээлэл)
5. Ёс зүйн дүрмийг шинээр томилогдсон албан хаагчдад тухай бүр танилцуулж байх; (Англи хэлний уншлага үйлчилгээнийн номын санч-мэдээллийн ажилтнаар томилогдсон албан хаагч)
6. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих;
7. Сул орон тооны зарыг өөрийн цахим хуудсаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;
8. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааны талаар цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах; (Улирал тутмын үйл ажиллагааны тайлан)
9. Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх; (Албан хаагчдын холбогдох утас, албан тушаалыг мэдээллийн самбарт байршуулсан)
10. Албан тушаалтнуудаар хуулийн хүрээнд ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл тайлбарыг зохих журмын дагуу гаргуулах; (3 албан хаагч ХАСХОМ өгсөн)
11. Удирдлагын шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх,
12. Шилэн дансны цахим хуудсанд мэдээ, мэдээллийг хуваарийн дагуу тогтмол оруулж, баталгаажуулах;
13. Иргэдийн өргөдөл / санал, мэдэгдэл/ гомдол, хүсэлтийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байх;

зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ажилласан.

Тайлангийн хугацаанд ямар нэг зөрчил доголдол гараагүй. Ажилтан албан хаагчид болон үйлчлүүлэгдээс санал гомдол ирээгүй.

Хэрэгжилт: 1.6.4

Сар бүр гадна орчны болон хуваарьт газрын цэвэрлэгээг тогтмол хийж, хог хаягдал, цас мөсийг зайлуулан мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан. /Цас, мөсний цэвэрлэгээ-11 удаа, хог цэвэрлэгээ-12 удаа, зэрлэг ургамал түүж зайлуулах- 2 удаа, модны мөчир тайрч зайлуулах-1 удаа/

Зорилт 1.7: Дархан-Уул аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний холбогдох заалтуудыг ХНО-ны хэмжээнд хэрэгжүүлж ажиллах;

Хэрэгжилт: 1.7.1

- Хүүхдийн номын ордны уншлага үйлчилгээний шинэ танхимд анги хамт олон, багаараа ажиллаж боломжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ширээ сандал тоног төхөөрөмжөөр хангах 9.100.000 төгрөгийн өртөг бүхий 1 төсөл боловсруулж АЗДТГ-т хүргүүлсэн.
- Бие даасан цахилгааны эх үүсвэртэй болсон. 13.183.184 төгрөг
- Соёлын Сайд болон аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах байгуулсан гэрээний 2.5 дахь заалтын хүрээнд АЗДТГ-ын 2023.04.19-ний 02-А/47 тушаалаар 10 сая төгрөгийн ном худалдан авах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн.

Үр дүн: Төсөл хэрэгжээгүй боловч бие даасан цахилгааны эх үүсвэртэй болсон. 10.000.000 төгрөгийн санхүүжилтээр 230 нэр төрлийн 556 боть номыг худалдан авч сан хөмрөгөө баяжуулж, уншигчдийн эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна.

Нийт 23,2 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

Хэрэгжилт: 1.7.2

Салбар номын сангийн ном хэвлэл, үйлчилгээг эрсдлээс хамгаалах зорилгоор иж бүрэн камержуулалт, дохиоллын хаалга шийдвэрлүүлэх чиглэлээр 9,379,900 төгрөгийн өртөг бүхий 1 төсөл боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн.

Хэрэгжилт: 1.7.3

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хангаж төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт тендер худалдан авалт, бусад нийт 163 мэдээлэл оруулсан.

Хэрэгжилт: 1.7.4

Хүүхдийн номын ордон нь Дархан сумын 7-р цэцэрлэгээс цахилгаан хангамжийн эх үүсвэрээ авч үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд 7-р цэцэрлэгээс 2022 оны 12-р сарын 12-ны өдрийн 153 тоот албан бичгээр ХНО-ны цахилгаан хангамжийг таслахыг шаардсан. Иймд тус ордон нь өөрийн цахилгаан хангамжийн эх үүсвэртэй болох бэлтгэл ажлыг хангаж ажлын зураг, цахилгаан тоолуур техникийн нөхцөл зэргийг шинэчлэг шийдвэрлэж, “Цац эрчис” ХХК батлагдсан зураг төсөл, стандарт, норм, норматив, өгөгдсөн техникийн нөхцлийн, технологийн дагуу ХНО-ны гадна цахилгаан хангамжийн ажлыг чанартай, бүрэн хийж, 2023 оны 9-р сард ашиглалтад оруулсан. Төсөвт өртөг 13.183.184 төгрөг

Хэрэгжилт: 1.7.5

Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 23 арга хэмжээ төлөвлөснөөс 23 арга хэмжээг хэрэгжүүлж 100% гүйцэтгэлтэй байна Үүнд:

1. Гэрэл, гэрлийн утас, далдлагч утас бэлтгэх, хэмжээ авах, гадна гэрэл суурилуулах
2. Гараашийн дээврийг дусаал гоожилтийг зогсоох шингэн хар лакаар бүрэх;
3. Уншлагын танхимын текийг реклэх;
4. Замын зорчих хэсэгт гарц, санамжийн тэмдэг суурилуулах;
5. Бохирын 3 худгийг мэргэжлийн байгууллагаар буудуулж, лагийг цэвэрлүүлэх;
6. 3-р байшингийн подвальд байрлах узельд 100-гийн хаалт солих талаар 7-р цэцэрлэгтэй хамтарч ажиллах;

7. Гадна орчин болон хариуцсан талбайн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол зохион байгуулах;
8. Дотор орчны болон танхимуудын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх;
9. 1-р давхрын үйлчилгээний ерөнхий танилцуулга шинэчлэх;
10. “Team Room” чөлөөт уншлагаын танхиын 6 сандлыг бүрэх;
11. Дулааны хэвтээ, босоо шугамыг хэсэгчлэн солих;
12. 1-3 давхрын хүйтэн усны шугамыг солих;
13. 1-3 давхрын хүйтэн усны шугам дээр ган мүфт гагнуулах;
14. Цахилгаан хангамжийн ажлыг дуусгах
15. 1-3 давхрын ариун цэврийн өрөөний агаар сэлгэлтийн хоолойн тоноглолыг шинэчлэх, агааржуулалтын сэнстэй болох;
16. Чөлөөт уншлагын танхимын наалт салсан модон ширээний тавцанг наалгах;
17. Уншлагын танхим, Салбар номын сангийн ширээний боолтуудыг чангалах, засах;
18. 201, 202 тоотод утас далдлагч, гарниз хийх;
19. 2 давхрын цэвэр усны шүүлтүүрийг солих;
20. 1 давхарт цэвэр усны шүүлтүүр шинээр суурилуулах, цорго гаргах;
21. Төрөлжсөн танхимуудын эвдрэлтэй хөшигийг солих, сэлбэх;
22. Чингис хааны хөшөөг сэргээж будах
23. Номын үзэсгэлийн хар тавиурын эвдрэлийг засварлах

зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

ХОЁР: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТИЙН ХҮРЭЭНД:

Зорилт 2.1: Номын сангийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

- Соёлын тухай хуулийн 18-р зүйл 18.1.3
- Номын сангийн тухай хуулийн 11-р зүйл 11.2.1

Хэрэгжилт:2.1.1

Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль, Монгол хэлний тухай хуулийг мөрдлөгө болгон аймгийн хэмжээнд хүүхэд багачууд, оюутан залуус, насанд хүргэгчдэд номын сангийн уншлага үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, номтой нөхөрлөх хөдөлгөөнийг өрнүүлэн тэлэх, бие дааж сурч боловсрох, хөгжихөд нь үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 57425:2007 стандарт аймаг, дүүргийн номын сангийн жишгээр уншигч, ирц, ном олголтыг үндэслэн үйл ажиллагааг бодитой төлөвлөдөг.

Үндсэн үйл ажиллагаа 2023 онд: /Эхний 11 сарын байдлаар/

Хүснэгт 1

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
Уншигч	3800	5294	139%
Ирэгсэд	38000	62246	163%
Ном олголт	55000	78792	143%

Дархан-Уул аймагт сурч байгаа ЕБС-ийн нийт /25614/ суралцагчдын 20 % нь буюу 5105 хүүхэд номын сангийн уншигч болж, уншлага үйлчилгээнд хамрагдсан үзүүлэлттэй байгаа юм.

Нийт уншигчдыг насны ангиллаар ангилж үзвэл:

- ✓ 13 уншигч буюу 0,24% нь цэцэрлэгийн хүүхдүүд
- ✓ 3081 уншигч буюу 58.4% нь I-V ангийн сурагчид
- ✓ 1477 уншигч буюу 28% нь VI-VIII ангийн сурагчид
- ✓ 547 уншигч буюу 10.3% нь IX-XII ангийн сурагчид
- ✓ 37 уншигч буюу 0.70% нь оюутан
- ✓ 69 уншигч буюу 1.3% нь насанд хүрэгчид
- ✓ 14 уншигч буюу 0.26% нь ахмад настан
- ✓ 35 уншигч буюу 0.66% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

График 1



Хүйсээр авч үзвэл:

- ✓ 57.1% нь буюу 3014 эмэгтэй уншигч
- ✓ 42.8% нь буюу 2259 эрэгтэй уншигч тус тус байна.

График 2

Хэрэгжилт: 2.1.2

ЕБС-ийн сурагчдын хичээлээс гадуурх чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх, танилцуулах, бие даан сурч боловсроход нь дэмжин туслах, мэдээ мэдээллээр хангах, зөвлөн туслах, хоцрогдол арилгах, ЭЕШ болон бусад уралдаан

тэмцээнд оролцоход бэлтгэх зорилгоор Англи хэл, Байгалийн ухаан, Монгол хэл-бичиг, Book&Coffee, Team Room танхимууд ажиллаж байна.

2023 онд төрөлжсөн танхимуудад нийт 2715 уншигч бүртгэгдэж, 15553 иргэсдэд 17723 лавлагаа мэдээлэл өгч, ном хэвлэлээр үйлчилсэн байна. Үүнд:

Хүснэгт 1

Төрөлжсөн танхимын нэр	Уншигч	Иргэсэд	Ном олголт
Байгалын ухааны у/у /Математик/ танхим	768	4160	4043
Гадаад хэлний /Англи хэл/ уншлагын танхим	570	4324	6255
Монгол хэл, бичиг, уран зохиолын танхим	753	3844	4198
Book&Coffee,	402	2263	2265
Team Room	222	962	962
Нийт	2715	15553	17723

График 3



Хэрэгжилт: 2.1.3

409 уншигчид 1903 боть номыг гэрээр олгож үйлчилсэн. Гэрээр ном олгох үйлчилгээг урьд онтой харьцуулан үзвэл 2%-иар өөссөн үзүүлэлттэй байна. Энэ нь гэрээр ном уншигчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн номоор сан хөмрөгийнхөө тодорхой хувийг баяжуулж байгаагаас шалтгаалан гэрээр ном уншигч, ном олголтын тоо өссөн гэж дүгнэж байна.

Хэрэгжилт: 2.1.4

1. Уншлага үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "ХАМТДАА УНШЬЯ- ХАМТДАА ХӨГЖЬЕ" уриан дор "Номтой өдөр" нүүдлийн номын

сангийн үйлчилгээг 13, 15, 25, 30-р цэцэрлэг тус бүр 1 удаа, ЕБ-ын 4, 9, 18, Энэрэл, Элит, ОИЦ сургуулиудад 7 удаа, нийт 11 удаа, 1-2 өдөр зохион байгуулж, 3482 сурагч, эцэг эх, багш нарын төлөөллийг хамруулан 2838 боть номоор үйлчилсэн.

Үйл ажиллагааны хүрээнд:

- ❖ Уншигчийн карт нээх;
- ❖ Шинэ номын үзэсгэлэн гаргах /160 төрлийн 300ш боть номоор/;
- ❖ Танин мэдэхүйн уралдаан болон хөгжөөнт тоглоом тоглох;
- ❖ Уншлага зохион байгуулж удирдах;
- ❖ Бага ангийн сурагчдад чанга уншлага хийх;
- ❖ Номын тэмдэглэл хөтлөх арга барилд сургах

зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан.

2. Дархан-Уул аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяа "Зулзагын гол" хүүхдийн зуслангийн /2023.06.27-07.03-ны хооронд/ 1-р ээлжинд амрагч 220 гаруй хүүхдүүдэд /7 хоногийн турш 09.00-18.00 цагийн хооронд ажиллаж/ номын сангийн үйлчилгээг хүргэсэн. Нийт амрагч хүүхдүүдээс 43 хүүхэд шинээр карт нээлгэн 298 ирэгсдэд 2151 боть номоор үйлчилсэн. Мөн номын сангийн үйлчилгээгээр дамжуулан хүүхэд багачуудад соёлын боловсрол олгох арга хэмжээний хүрээнд монгол ахуй, гэр, эдлэл хэрэглэлийн талаар 45 хүүхдэд сургалт, "Монгол бахархал" хөтөлбөрийн хүрээнд номын санч мэдээллийн ажилтан-сургагч багш С.Оюунцэцэг "Угийн бичиг" гэж юу вэ?, "Угийн бичгийг хөтлөх, ураг төрлөө танин мэдэхүй" сэдвээр Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Булган, Дархан-Уул зэрэг төвийн бүсийн 5 аймгийн хүүхдүүдийн чуулга уулзалтад оролцож буй Тусгай ээлжийн хүүхдүүдэд сургалт зохион байгуулж 280 гаруй хүүхдүүд хамрагдсан.

Хэрэгжилт: 2.1.5

Зөөврийн номын сангийн үйлчилгээг 5 цэцэрлэг (4, 5, 7, 18, 29)-ийн бэлтгэл 5 бүлэгт, 8 сургууль (1, 4, 9, 16, 18, Од, ОИЦ, Цайхун)-ийн 11 ангид, 1 байгууллага (Тусгаарлах байр) нийт 41 удаа, /давхардсан тоогоор 520 гаруй хүүхдэд/ 1265 боть ном хүргэсэн байна.

Хэрэгжилт: 2.1.6

Цахим орчноос ном унших боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зохиогчийн эрхтэй бүтээл 15 нийтэлж 4687 хэрэглэгчдэд хүргээд байна. Үүнд:

1. Ц.Дамдинсүрэн "Богд Чингисийн магтан сургасан шастир" – 383 хэрэглэгчдэд;
2. Д.Мягмар "Ажилсаг охин" өгүүллэг – 330 хэрэглэгчдэд;
3. Ш.Сүрэнжав "Амьдад нь хүнийг хайрлахын увидас-Очирбатын Дашбалбар" өгүүллэг-258 хэрэглэгчдэд
4. З.Далхжав "Бяцхан өгүүллэгүүд" номоос "Хүрз яагаал зэврэв?" өгүүллэг – 259 хэрэглэгчдэд;
5. Г.Нацагдорж "Алтан хүүхэд" – 444 хэрэглэгчдэд;
6. Д.Аюуш "Анхны олз" -395 хэрэглэгчдэд;
7. "Аргусан хуурчийн домог – 381 хэрэглэгчдэд;
8. "Аргил цагаан өвгөн" баатарлаг туулийн тухай – 339 хэрэглэгчдэд;
9. Д.Цэвэгмэд "Алс өрнөд тив" (Аян замын тэмдэглэл) өгүүллэг – 267 хэрэглэгчдэд;
10. З.Далхжав "Баавгайнаас айдаггүй" өгүүллэг – 246 хэрэглэгчдэд;
11. "Хилин галзуу баатар" тууль – 325 хэрэглэгчдэд;
12. Р.Ядмаа "Ичиг, ичиг, ичиг" өгүүллэг – 383
13. Д.Пүрэвдорж "Бяцхан аялал" шүлэг - 225
14. Э. Сетон-Томпсон Амьтдын тухай номоос "Үнэгний тухай үлгэр" - 194

15. Ш. Гаадамба “ Зүсэм талх” - 258 тус тус нийтлэсэн.

Хэрэгжилт:2.1.7

- Амаар-238
- Утсаар-101
- Пэйж хуудсанд-211

Нийт 550 удаагийн / цагийн хуваарь, номын мэдээлэл, уралдаан тэмцээний мэдээлэл, бусад / лавлагаанд хариулт өгч ажилласан байна.

Хэрэгжилт: 2.1.8

- Ц.Дамдинсүрэн, Д.Гармаагийн намтар уран бүтээлээр санамж өгөх ном зүй-2,
- Шинэ номын мэдээ-17,
- Сэдэвчилсэн номын үзэсгэлэнгийн мэдээ-16 удаа цахимаар бэлтгэн пейж хуудсандаа байршуулж 9854 хэрэглэгчдэд хүргэсэн.

Хэрэгжилт: 2.1.9

- Ахмад настан 14, хөгжлийн бэрхшээлтэй 35, тусгаарлах байрны 12 уншигчид үнэ төлбөргүй карт нээж, зөөврийн номын сангаар 6 удаа 150 боть номоор үйлчилгээ үзүүлсэн.
- Өндөр настан 5 уншигчдад гэрээр ном олгох үйлчилгээгээр 11 удаа 19 боть ном хүргэж ажилласан

Зорилт 2.2:Ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах, ном унших арга барилд төлөвшүүлэх Соёл Олон Нийтийн арга хэмжээг зохион байгуулж ажиллана.

Сурагчдын ном унших хандлагыг дэмжих, уншигч номын сангийн харилцаа холбоог ойртуулах зорилгоор зохион байгуулдаг Соёл олон нийтийн ажлыг уламжлалт болон цаг үндэсний хөтөлбөрүүдтэй уялдуулан нийт 12 ажил төлөвлөснөөс нийт 17 арга хэмжээг (нэг арга хэмжээг 1-4 удаагийг давтамжтай зохион байгуулж буй) 29 удаа зохион байгуулж, нийт 9751 гаруй уншигч, хүүхэд багачууд хамрагдсан.

Хэрэгжилт 2.2.1

Шинэ номын үзэсгэлэнг 16 удаа 344 боть номоор гаргаж, мэдээллийг цахим хуудсандаа байршуулж сурталчилж ажилласан.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг тэмдэглэлт өдөр, баяр ёслолын үйл ажиллагаанд зориулан өөрийн сан хөмрөгөө сурталчлах, номын эргэлтийг сайжруулах зорилгоор нийт 16 удаа зохион байгуулж, 571 боть номын дэлгэн тавьсан. Үүнд:

1. “Цагаан сар”-ын баярт 23 боть номоор
2. “Гэгээн хайрын өдөр”-т 29 боть номоор
3. “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр-т 46 боть номоор
4. “Монгол цэргийн өдөр”-т 23 боть номоор
5. “Олон улсын Хүүхдийн номын өдөр-т 24 боть номоор
6. “Дэлхийн номын өдөр”-т 30 боть номоор
7. “Үндэсний бичиг үсгийн баяр”-т 19 боть номоор
8. Монголын зохиолчдын эвлэлийн Дархан-Уул аймаг дах салбар зөвлөлийн зохиолчдын бүтээлийн үзэсгэлэн-27 боть номоор
9. “Дэлхийн гэр бүлийн өдөр”-т 42 боть номоор
10. “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-т шилэн хорго болон талбайд 134 боть номоор

11. “Монгол наадам”-22 боть номоор
12. “Эх хэлний өдөр”-т 26 боть номоор
13. “Үндэсний монгол бичгээр болон крилл бичгээр бичигдсэн 25 боть номоор
14. Хүүхдийн зохиолч О. Сундуй номын үзэсгэлэн 23 боть номоор
15. Дархан хотын 62 жилийн ойд-17 боть номоор
16. Хүүхдийн зохиолч Г.Мандалын номын үзэсгэлэн- 17 боть номоор
17. Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөрт-21 боть номоор
18. Улс тунхагласны өдөрт-23 боть номоор тус тус гаргасан.

Цахим хэлбэрээр 7 удаа 156 боть номоор бэлтгэн гаргаж, пейж хуудсандаа байршуулж 5359 хэрэглэгчдэд хүргэсэн.

Хэрэгжилт: 2.2.2

Бага насны хүүхдүүдийг номд дуртай болгох, анхаарал төвлөрөх, сонсох чадварыг хөгжүүлэх, сонссон зүйлээ ойлгож, дүн шинжилгээ хийн үгээр илэрхийлэх арга барилд сургах, шинэ ном сурталчлах зорилгоор “Чанга уншлага” арга хэмжээг тогтмол зохион байгуулсан. Үүнд:

- СӨББ 6 цэцэрлэгийн 37 бүлгийн 1036 хүүхэд, 2 сургуулийн 1-5 ангийн 5 бүлгийн 195 хүүхэд багачууд, мөн тусгай бүлгийн 6 ангийн 66 хүүхдүүд / нийт 18 удаа, 1297 хүүхэд/ -ийг хамруулан мини театр, хормогчин үлгэр ашиглан үлгэр уншиж, ном уншихын ач холбогдол сэдвээр ярилцан хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон номуудаар үзэсгэлэн гаргаж, үзүүлж харилцан ярилцаж ажилласан.
- “Ном унших цаг” арга хэмжээний хүрээнд Цайхун, Од, ОИЦ, 9-р сургуулийн 4-5-р ангийн 8 бүлгийн 450 гаруй уншигч хүүхдүүд хуваарьт өдрөө хүрэлцэн ирж ном уншин, тэмдэглэл хөтөлж хэвшиж байна.

Хэрэгжилт: 2.2.3

Уншигч хүүхэд багачуудыг номд дуртай болгох, ном унших арга барилд төлөвшүүлэх, зохиолч уншигчдын амьд харьцааг бий болгох зорилгоор зохиолч уншигчдын уулзалтыг 4 удаа зохион байгуулж, 761 хүүхдийг хамруулсан. Үүнд:

- ХНО захирал Л.Мөнхбаатар “Од” цогцолбор сургуулийн 400 гаруй сурагчдыг хамруулсан "ОЛУУЛАА УНШЬЯ" аяны нээлтийн арга хэмжээнд “Уншихад урам хайрла” уулзалт, лекц:
- Д.Нацагдоржийн шагналт, хүүхдийн зохиолч О. Сундуйтай уншигч хүүхдүүд, номын санч, багш нарийн төлөөлөлтэй уулзах уулзалт, лекцийн арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, нийт 220 гаруй уншигчийг хамруулсан. Зохиолчын товч намтар болон зохиол бүтээлийн талаар мэдээлэл, ордны сан хөмрөг дэх номуудаар цахим үзэсгэлэн зэргийг бэлтгэж ордны пейж хуудсанд байршуулан 3584 цахим хэрэглэгчдэд хүргэсэн. Мөн зохиолчийн гарын үсэгтэй 30-40% хямдралтай худалдааг зохион байгуулж, 31 ширхэг 292000 төгрөгийн ном борлуулж өгсөн.
- “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд зохион байгуулагдсан Д.Нацагдоржийн шагналт, МЗЭ-ийн шагналт удам дамжсан хүүхдийн зохиолч Надмидын Мандалтай уншигч хүүхдүүд, номын санч, багш нарийн төлөөлөлтэй уулзах уулзалтыг зохион байгуулж, нийт 70 гаруй уншигчийг хамруулсан.
- 9-р сургуультай хамтран ЕБС-ийн 7-р ангийн сурагчдын дунд, МЗЭ-ийн “Утга зохиолын төлөө” шагналт зохиолч, нийтлэлч, Паламын Амаржаргалын “Ухаантай тахиа” номын өгүүллэг, туужаас сэдэвлэн дүрийн тоглолттой уншигчдын бага хурал- уулзал зохион байгуулан 71 хүүхдийг хамруулсан.

Хэрэгжилт: 2.2.4

Дэлхийн номын өдрийг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд 4 үйл ажиллагаа зохион байгуулж, 156 уншигч хамруулан, 2546 хэрэглэгчдэд мэдээлэл хүргэсэн.

Хэрэгжилт: 2.2.5

Монгол Улсын Ерөнхийлөгч 2003 онд жил бүрийн 5-р сарын эхний ням гаргийг "Үндэсний бичиг үсгийн баярын өдөр" болгон зарлиг гаргасан. Энэ хүрээнд Хүүхдийн номын ордон жил бүр уламжлал болгон үндэсний хэл бичиг, түүнтэй холбоотой ёс заншил, өвийг судлах, сурталчлах, уламжлан өвлүүлэх талаар хүүхэд багачууд болон залуус, насанд хүрэгчид, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг явуулж, үндэсний бичгээ сурах хүсэл сонирхол төрүүлэх, дэмжин урамшуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна. ХНО-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан "Үндэсний бичиг үсгийн баярын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд 11 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, 411 уншигч хамруулж, 4334 цахим хэрэглэгчдэд мэдээлэл хүргэж ажилласан байна.

Цахимд:

- "Үндэсний бичиг үсгийн баяр" аар зохион явуулсан үйл ажиллагааны видео бичлэг хийн олонд түгээсэн.
- Бийр, уран бичлэгийн уралдааны тухай видео бичлэг олонд түгээсэн.

Хэрэгжилт: 2.2.6

"Үдшийн уншлага-2023" үйл ажиллагаа нь 6 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд миний монгол цэцэрлэгт хүрээнд 2 өдөр ажилласан. Дархан-50 цогцолборт 6 дугаар сарын 28,29,30-ний өдрүүдэд нийт 5 үдэш чөлөөт цагаа агаар салхинд өнгөрүүлж буй иргэдэд номын сангийн үйл ажиллагааг танилцуулж, номтой нөхөрлөх боломжийг бүрдүүлэн ажилласан.

Үйл ажиллагааны хүрээнд:

- ✓ Хүүхдийн номын ордны танилцуулга мэдээлэл
- ✓ Уншигчийн карт нээх
- ✓ Уншлага үйлчилгээ
- ✓ Ном солилцоо
- ✓ Хуучин номын худалдаа
- ✓ Хормогчин үлгэрээр чанга уншлага хийх

зэрэг ажлуудыг зохион явуулсан.

Шинэ уншигч- 12 бүртгэж, нийт 146 ирэгсэд, 251 боть ном уншуулж, гэрээр 2 уншигчдад 4 боть ном олгов.

Хэрэгжилт: 2.2.7

"Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн"-ий болзол хангасан:

1. "Од" цогцолбор сургуулийн Э.Мягмаржаргал багштай 4-10 анги,
2. "Од" цогцолбор сургуулийн Л. Оюун багштай 5-10 анги,
3. 1-р сургуулийн Х.Туяа багштай 5б анги,
4. 4-р сургуулийн Х.Оюунбилэг багштай 5в анги,
5. Од цогцолбор сургуулийн 4-5 ангийн сурагч С. Номуунгоо,
6. Од цогцолбор сургуулийн 4-5 ангийн сурагч А.Аялгуу
7. ОИЦ сургуулийн 2-6 ангийн сурагч Б. Өнөрмөө
8. 18-р сургуулийн 5а ангийн сурагч Э. Тэргэл,
9. 18-р сургуулийн 12в ангийн сурагч А.Дэлгэрхишиг,
10. 15-р сургуулийн 4в ангийн сурагч М. Хүслэн

нарт Үндэсний номын баярын өдөр болон их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан тэмдэг, үнэмлэх гардуулсан.

Мөн “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” болсон анги хамт олон болон хүүхдүүдийн бүтээлийн сангаар Залуучууд театрт зохион байгуулагдсан “Номын баяр”-ын нэгдсэн арга хэмжээ, “Найргийн даага-2023” шүлгийн наадмын үеэр тус тус үзэсгэлэн гаргаж олон нийтэд хүргэсэн.

Арга хэмжээ 2.2.8: “Англиар хэн сайн үлгэр ярих вэ” уралдаан зохион байгуулах

Хэрэгжилт: 2.2.8

Зохион байгуулах хугацаа болоогүй. Үйл ажиллагаа зохион байгуулах, удирдамж, төлөвлөгөө, шаардагдах төсвийг боловсруулж, мэдээллийг хүргүүлсэн.

Арга хэмжээ 2.2.9: Бага ангийн сурагчдын дунд сэтгэхүй хөгжүүлэх чиглэлээр уралдаан зохион байгуулах;

Хэрэгжилт 2.2.9

Зохион байгуулах хугацаа болоогүй. Үйл ажиллагаа зохион байгуулах, удирдамж, төлөвлөгөө, шаардагдах төсвийг боловсруулж, мэдээллийг хүргүүлсэн.

Хэрэгжилт: 2.2.10

Дархан хотын 62 жилийн ойг угтаж хүүхэд залуусыг хотын соёлтой иргэн болгон төлөвшүүлэх, хотын соёлыг төлөвшүүлэхэд хүүхдүүдийн санал санаачилгыг дэвшүүлэх зорилгоор **“Хотын соёл надаас эхтэй”** эсээ бичлэгийн болон богино хэмжээний видео контент бүтээх уралдаан зарлаж, уралдааныг зохион байгуулж дүнгээ гаргасан. Үүнд:

- Эсээ бичлэгийн уралдаанд нийт 67 хүүхэд материалаа ирүүлснээс 1-р байранд 9-р сургуулийн 10в ангийн сурагч Э. Сүхзориг, 2-р байранд 9-р сургуулийн 9в ангийн сурагч Б.Уранзаяа, 3-р байранд 19-р сургуулийн 12а ангийн сурагч Г. Батчимэг нар шалгарсан.
- Видео контент бүтээх уралдаанд 11 бичлэг ирсэнээс “Шилдэг бичлэг”-ээр 4-р сургуулийн 12а ангийн хамт олны баг шалгарч Дархан хотын өдрөөр тус тус шагналаа гардсан авсан.

Хэрэгжилт: 2.2.11

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, санал хүсэлтийг судалж, дүгнэлт хийсний үндсэн дээр номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулахад арга хэмжээ зохион байгуулах зорилгоор уншигчдын сэтгэл ханамжийн судалгааг google ашиглан авсан.

Судалгаанд нийт 202 хүн хамрагдсаны хамгийн их хувийг 41.6% буюу 8-13 насныхан эзэлж байна.

Уншигчдын сэтгэл ханамжийн судалгааг 14 төрлийн асуултаар авсан.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 76% нь эмэгтэй, 52.5% нь байнгын үйлчлүүлэгч, 40%- нь 2 дээш жил үйлчлүүлж буй үйлчлүүлэгч байна.

Мөн 44.4% нь ном унших зорилгоор, 31.6% нь гэрийн даалгвар хийх, 10.7% нь гэрээр ном авах, үйлдсэн хувь нь СОНА ажилд хамрагдах зориолгоор үйлчлүүлдэг байна.

Номын сангийн сан хөмрөгийн баяжилт, шинэ номын хүртээмжийн хувьд 46.2% нь хангалттай 44.7.4% нь дунд 9% нь хангатгүй гэсэн хариулт өгчээ.

Номын санд хэр сэтгэл ханамж вэ? гэсэн асуултад 49.2% сайн, 34.2% нь маш сайн бусад 14% нь дунд, муу гэсэн үнэлгээ өгсөн байна.

Судалгааны үр дүнгээс харахад Хүүхдийн номын ордон хаана, ямар үйл ажиллагаа явуулдаг байгууллага вэ? гэдгийг мэддэг, хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Төлөвлөгөөт бус арга хэмжээ 2.2.12

Нийт арга хэмжээ зохион байгуулж, 2500 гаруй хүнийг хамруулсан. Үүнд:

Хэрэгжилт: 2.2.12.1:

Залуучууд театрт зохион байгуулагдсан **“Бид эх орны ирээдүй”** өдөрлөгийн хүрээнд “Монгол цэргийн өдөр”-т зориулан ХНО-ны сан хөмрөг дэх цэрэг эх орны сэдэвт номоор болон сан хөмрөгт шинээр ирсэн номуудыг олон нийтэд танилцуулах зорилгоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, тус номуудаар уншлага зохион байгуулж, 150 гаруй оролцогчдыг хамруулсан. Мөн уншигчийн картыг хөнгөлөлттэй үнээр нээж, 6 уншигч шинээр бүртгэсэн.

Хэрэгжилт: 2.2.12.2

Соёлын Яамнаас зохион байгуулсан **“Соёлын сэргэлт-2023”** аяны хүрээнд Дархан-Уул аймгийн хүүхдийн номын ордноос дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж оролцсон.

1. **Нэгдсэн арга хэмжээний хүрээнд:** “Соёлын сэргэлт-2023” арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээнээс 7 арга хэмжээнд давхардсан тоогоор 70 албан хаагч оролцон. Үүнд:
   - **1.1** Нээлтийн арга хэмжээ-17 албан хаагч
   - **1.2** Соёл, урлагийн салбарын албан хаагчдын Соёлын сайдтай уулзсан уулзалт-17
   - **1.3** Номын сангийн 2 удаагийн сургалтад 9 /давхардсан тоогоор 18 / номын санч мэдээллийн ажилтан
   - **1.4** Соёлын форум-3 албан хаагч
   - **1.5** Дороны сургалт-3
   - **1.6** Кино нээлт-17
   - **1.7** Шарын гол сумын Соёлын сэргэлт-2023 арга хэмжээнд 4 албан хаагч тус тус оролцсон.
2. **“Соёлын сэргэлт-2023” аяны хүрээнд ХНО-оос дараах** 3 төрлийн арга хэмжээг зохион байгуулж, 1350 гаруй уншигч, хэрэглэгчдийг хамруулсан. Үүнд: **Нээлтийн арга хэмжээнд зориулан:**
   - **2.1** Дархан хотын бэлгэдэл "НАДА" бугийн "Хөгжилтэй аялал” анимейшн хүүхэлдэйн киноны сэдэвт гар зургийн үзэсгэлэн;
   - **2.2** ХНО-ны сан хөмрөг дэх кино урлаг, жүжгийн зохиолын ном, хэвлэлээр сэдэвчилсэн үзэсгэлэн;
   - **2.3** ХНО-ны сан хөмрөг дэх уран зургийн дээж 24 бүтээлийн үзэсгэлэн
   - **2.4** Монголын зохиолын эвлэлийн Дархан салбарын зохиолч уран бүтээлчдийн дээжээс 107 боть ном үзэсгэлэн
   - **2.5** Зохиогчийн гарын үсэгтэй номын худалдаа
   - **2.6** “Миний нэрийн хуудас” монгол бичгийн үзэсгэлэн
   - **2.7** Чанга уншлагын нэг хэлбэр болох “Мини театр”-ийн тайз, түүнд тоглогдох үлгэрүүд, үүхэлдэй зэрэг хэрэглэлийн үзэсгэлэн

2.8 Миний театрт “Үлгэр амилах цаг” хүүхэлдэйн тоглолт хийх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, аяны нээлтэд оролцогсод болон уншигч хэрэглэгчиддээ хүргэсэн.

3. **“Кинонд ээлтэй Дархан” төслийн хүрээнд:** Дархан-Уул аймгийн Засаг дарга Б. Азжаргалын санаачилгаар Монгол контент Маамуу брэндтэй хамтран бүтээсэн "Ами Тами-Хөгжилтэй аялал” анимейшнд Дархан хотын бэлгэдэл Нада буга гол дүрд нь тоглосон хүүхэлдэйн киног ЕБС-ийн бага ангийн сурагчид болон цэцэрлэгийн хүүхдүүдэд үзүүлж, танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулж, сургуулийн 122 сурагч, цэцэрлэгийн 195 хүүхдийг хамруулсан. Хүүхдүүд үзсэн киногоо зургаар илэрхийлж, зурсан зургуудаар үзэсгэлэн гаргасан.
4. **Дархан-Уул аймгийн Шарын гол суманд зохион байгуулагдсан “Соёлын сэргэлт-2023” аяны хаалтын ажиллагаанд оролцож:**
   - **4.1** ХНО-ны сан хөмрөг дэх МЗЭ-ийн Дархан салбарын зохиолч, уран бүтээлчдийн номын үзэсгэлэн, зохиолчдын гар бичмэлийн үзэсгэлэн,
   - **4.2** хуучин номын худалдаа
   - **4.3** Мини театр – чанга уншлага
   - **4.4** Шагайн наадгай
   - **4.5** Угийн бичгийн сургалт зэрэг арга хэмжээг зохион байгуулж, Шарын голын сумын 500 иргэдэд ХНО-ны үйл ажиллагааг танилцуулсан.

Хэрэгжилт:2.2.12.3

Соёлын бүтээлч сарын хүрээнд бүх нийтээр ном унших соёлыг түгээн дэлгэрүүлэх, номоор дамжуулан хүүхэд залуусыг соён гэгээрүүлэх, зохиолч, хэвлэн нийтлэгчдийг алдаршуулах, тэдний шинэ бүтээлүүдтэй уншигчдыг танилцуулах зорилгоор зохиолчдын гарын үсэгтэй, хямдралтай **“Номтой Дархан”** номын худалдаа-өдөрлөгийг 2023 оны 11-р сарын 04-05-ны өдрүүдэд Залуучууд театрт зохион байгууллаа. Тус өдөрлөгийн арга хэмжээнд

- УГЗ зохиолч Б. Пүрэвдорж
- СГЗ зохиолч Б. Шүүдэрцэцэг
- СГЗ зохиолч Б. Сарантуяа:
- Болор цомын эзэн, Д.Нацагдоржийн шагналт модернист яруу найрагч Д.Галсансүх:
- СГЗ, Д.Нацагдоржийн шагналт Доржзодовын Энхболд
- Нацагдоржийн шагналт хүүхдийн зохиолч Н. Мандал:
- МЗЭ-ийн шагналт Э. Амарзаяа:
- МЗЭ-ийн шагналт С. Батжаргал:
- МЗЭ-ийн шагналт хүүхдийн зохиолч Ч.Наранцэцэг:
- Г.Сэр-Одын шагналт Б. Дэлгэрцэцэг:
- Зохиолч Х. Дуламсүрэн
- Нэрт орчуулагч Б.Нямдорж
- Хүүхдийн зохиолч О. Өнөрцэцэг:
- Хүүхдийн зохиолч П. Наранбаатар:
- Залуу зохиолч Ч.Түвшинбилэг:
- Зохиолч, сэтгүүлч Р.Оюунжаргал:
- МУ-ын Зөвлөх Инженер Б.Эрдэнэцэцэг
- Минималист зохиогч Б.Хулан:
- Сэтгэл зүйч Д. Мөнхцэцэг нар

болон

- "AMARZAYA'S BOOK"
- "АМАР ӨРГӨӨ"
- ."УРЛА, ТОГЛО"
- "ХОВИЛТОЙ ДЭВТЭР" бренд
- "АНАР" НОМЫН ДЭЛГҮҮР
- “ШҮҮДЭР ПРОДАКШ” зэрэг номын дэлгүүр, хэвлэлийн газрууд оролцлоо.

Өдөрлөгийн арга хэмжээнд 480 гаруй номын шимтэн уншигч, номын хорхойтнууд хүрэлцэн ирж, зохиолчтой биечлэн уулзан санал бодлоо солилцлж, ном, бүтээлүүдийг нь хямдралтай, гарын үсэгтэйгээр худалдан авсан.

Идэвхтэн уншигчаас

- Хүүхдийн номууд
- Нохой хүн
- Нууцлагдсан зүйлсийг ольё, будья
- Царай муутай ээж
- Арвангуравдугаар зуун
- Сондгой цагаан сувд
- Хавтгай унасан мазаалай
- Минималист, Аура ба Карма
- Хариулт дотор бий, Өөрийгөө танихуй
- Өөрийгөө хайрлахуй
- Удвал, Сүүжин ээмэг, Бүсгүй л хүн болохоор
- Консентрари, Түүхийн шүлгүүд
- Улаан могой, Ялагсад
- Шидтэнүүдийн сургууль
- The story of cittle nomade зэрэг номуудыг хамгийн ихээр худалдан авсан байна.

Зорилт 2.3: Номын сангийн сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хангах, баяжилтад судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах, шинэ номын баяжилт хийх;

Хэрэгжилт: 2.3.1

Ажил хүлээлцэх тооллого 2 удаа, жилийн эцсийн тооллого 1 удаа тус тус зохион байгуулсан. Тооллогоор гарсан зөрчил дутагдалыг тооллогын комиссын актаар баталгаажуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Хэрэгжилт: 2.3.2

- Оны эхний 11 сарын байдлаар 18 удаагийн худалдан авалтаар 19,789,422 төгрөгийн 363 нэрийн 982 боть ном худалдан авч сан хөмрөгөө баяжуулсан.
- Нийт   1455 ширхэг ном сэлбэн зассан.
- Сан хөмрөгийн номын хамгийн их эргэлттэй 3881 ном, гэрээр уншлагад гарсан 1903, нүүдлийн номын сангаар үйлчилсэн 4200 , зөөврийн номын сангаар хүргэсэн 3286 боть номонд ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийсэн.

Хэрэгжилт: 2.3.3

Шинээр ирсэн 932 боть номын электрон каталогт бүртгэж, цаасан каталог зохион байгуулсан. Электрон каталогт нийт 1174 төрлийн 15,341 ширхэг боть ном бүртгэгдсэн байна.

Хэрэгжилт: 2.3.4

Электрон болон цаасан каталогтой ажиллах заавар, зөвлөмж болон электрон каталогийн холбоосыг цахим хуудсанд байршуулан 1152 хэрэглэгчдэд хүргэсэн. Цаасан хэлбэрээр бэлтгэж, байгууллагын зар мэдээллийн самбар болон харагдахуйц газар байршуулж хэрэглэгчдэд хүргэж байна.

Уншлагын танхимаар үйлчлүүлдэг 511, төрөлжсөн танхимаар үйлчлүүлдэг 335, салбар номын сангаар үйлчлүүлдэг 9-12-р ангийн 171, нийт 1017 уншигч, сурагчдад цаасан болон электрон каталогтой ажиллах заавар зөвлөгөө өгсөн.

Хэрэгжилт: 2.3.5

- Салбар номын санг камержуулах "Эрсдэлгүй оюунлаг танхим" төсөл бичсэн.
- Улсын хэмжээнд зохион байгуулагдсан "Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож "Онц байдал" тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа" сэдэвт дадлага сургуулилтад 11 ажилтан, албан хаагчид болон уншигчид хамрагдаж "Од" цогцолбор сургуулийн талбайд цугларч бэлэн байдлыг хангаж ажилласан.

ГУРАВ: ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТИЙН ХҮРЭЭНД:

Зорилт 3.1 Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Арга хэмжээ 3.1.1

Төсөв, төслийн болон хандивын хөрөнгийг зориулалтаар нь үр ашигтай зарцуулах;

Хэрэгжилт:

165.697.100

Хэрэгжилт: 3.1.2

Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд байгууллага, эцэг эх, олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 11 арга хэмжээ зохион байгуулж ажилласан. Үүнд:

1. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2019.10.07 10/657 тоот уриалгыг хэрэгжүүлж 5 ажилтанд хүүхдийнх нь мэндэлсэн өдрөөр хагас өдрийн цалинтай чөлөө олгосон.
2. Ажилтнуудад эцэг эхийн үүргээ биелүүлэх, хүүхдэдээ халамж анхаарал тавих боломжийг олгож, бага насны хүүхэдтэй эцэг эхэд хүүхдээ сургууль цэцэглэгт хүргэж өгөх, авах, "School police" эргүүлд гарах цагийг нь зохицуулан ажиллаж байна.
3. "Анзаар" аяны нээлтэд байгууллагаараа оролцож, хар тамхи, мансууруулах бодисын талаарх сургалтад хамрагдсан./ 2023.03.27/
4. "Олон улсын гэр бүлийн өдөр"-т зориулсан мэдээлэл бэлтгэж цахим хуудсан байршуулж, олон нийтэд түгээсэн.
5. Байгууллагынхаа ажиллагсдын гэр бүлийн "Миний гэр бүл-Миний аз жаргал" зургийн үзэсгэлэн гарган дурсгасан.
6. Явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах зорилгоор хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон тэмдэглэгээг замын 2 талд суурилуулсан.
7. Хөгжлийн бэрхшээлтэй 33 хүүхдэд үнэгүй уншигчийн карт нээж үйлчилсэн.
8. Хүүхдийн Номын Ордны цахим хуудсаар дамжуулан хүүхэд хамгааллын чиглэлээр 6 постер бэлтгэн нийтэлж олон нийтэд хүргэсэн.

9. Түр хамгаалах байрны ахлачтай хамтран ажиллаж, ажиллагсад болон хамгаалах байранд байгаа хүүхдүүдэд номын тэмдэглэл хөтлөх зөвлөгөө өгч зөөврийн номоор үйлчилж байна.
10. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас зохион байгуулсан “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам” -ыг хэрэгжүүлэх арга зүйн цахим сургалтад ХНО-ы “Эцэг, эхийн зөвлөл” -ийн гишүүн Номын санч-мэдээллийн ажилтан М.Оюунгэрэл хамрагдсан.
11. Гэр бүлийн хүрээнд хүүхэд багачуудыг ном унших чиг хандлагад төлөвшүүлэх, уншсан номоор дамжуулан өөрийгөө илэрхийлэх арга барилд сургах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, амралт чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх үйл ажиллагааг дэмжин урамшуулах “Гэр бүлийн өдөрлөг” зохион байгуулсан.

Арга хэмжээ 3.1.3

Жендрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана.
Хэрэгжилт: Нийт албан хаагчдын тоо 17 эмэгтэй-12, эрэгтэй-5 Харьцаа 28/72

Зорилт 3.2 Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигийг ХНО-ны түвшинд хэрэгжүүлж ажиллана

Хэрэгжилт:3.2.1

“Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордоны хэмжээнд “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” арга хэмжээг зохион байгуулах хавар, намрын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, 4 зорилтын хүрээнд 24 арга хэмжээ зохион байгуулж, 1460 гаруй хүүхэд хамруулаад байна.

1. **Хаврын “Номын баяр”-ын үйл ажиллагааний хүрээнд**: “Номын баяр-Хүүхэд бүр уншигч” уриан дор 2023.05.19-нд Аймгийн төв номын сангаас зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээнд хамтран оролцож;
    1.1 “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан анги, сурагчийг шалгаруулах;
    1.2 “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан ангийн бүтээлийн үзэсгэлэн гаргах;
    1.3 Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан ангийн үзүүлэх тоглолт зохион байгуулах;
    1.4 “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан ангийн сурагчдийн дунд АХА тэмцээн зохион байгуулах;
    1.5 ХНО-ны танилцуулга үзэсгэлэн бэлтгэх, гаргах;
    1.6 ХНО-ны ажилтан албан хаагчдын “Миний нэрийн хуудас” монгол бичгийн бичвэрийн үзэсгэлэн гаргах;
    1.7 Уншигчдын карт 50% хөнгөлөлттэй үнээр нээх;
    1.8 Хуучин номын худалдаа зохион байгуулах;
    1.9 Зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа зохион байгуулах

зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийт 310 гаруй хүүхэд багачуудыг хамруулж, ном сан, соёлын үйлчилгээ үзүүлсэн.

Намрын “Номын баяр”-ын үйл ажиллагааний хүрээнд: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны “Номын баярын өдөр тэмдэглэх тухай” 158 дугаар зарлиг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн “Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийг орон даяар тэмдэглэх заалтын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд намрын номын баярын арга хэмжээ 9-р сарын 15-17 өдрүүдэд тохиож, “Номын баяр-Номтой Монгол” уриатайгаар “Залуучууд” театрт зохион байгуулан бүх нийтээрээ ном унших соёлыг түгээн дэлгэрүүлэх, номоор дамжуулан хүүхэд залуусыг соён гэгээрүүлэх, ном хандивлагчид болон зохиолч, хэвлэн нийтлэгч, шилдэг уншигчдийг алдаршуулах, нэн ховор, сонгомол бүтээлүүдийг толилуулах,

зохиолч уншигчдийн уулзалт, шинэ номын нээлт зэрэг оюунлаг арга хэмжээнүүд зохион байгууллаа. Үүнд:

2. “Залуучууд” театр дээр зохион байгуулагдсан **нэгдсэн арга хэмжээнд** ХНО-оос:
   2.1 “Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийг олон нийтэд сурталчлан таниулах;
   2.2 ХНО-ны үйл ажиллагааг сурталчлах;
   2.3 Хамгийн их уншигддаг хүүхдийн зохиолоор үзэсгэлэн гаргаж, уншлага зохион байгуулах;
   2.4 Хуучин номын худалдаа хийх;
   2.5 Уншигчийн карт хөнгөлөлттэй үнээр нээх; /6 карт/
   2.6 “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн” шагналын болзол хангасан уншигчдыг урамшуулж, алдаршуулах; /2 уншигч/
   2.7 “Шилдэг хандивлагч” болон “Шилдэг хамтран ажиллагч” иргэдийг /2 иргэн/ урамшуулан алдаршуулах;
   2.8 “Миний нэрийн хуудас” монгол бичгийн үзэсгэлэн гаргах;

зэрэг арга хэмжээг зохион байгуулан оролцож, **550 гаруй** номыг шимтэн уншигч, идэвхтэн, хүүхэд багачууд хамрагдсан.

3. “Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийг тохиолдуулан **ХНО дээр дараах үйл ажиллагааг зохион байгуулсан**. Үүнд:
   3.1 Сэдэвчилсэн номын үзэсгэлэн зохион байгуулах;
   3.2 ЕБС-ийн бага анги болон СӨББ-ийн хүүхдүүдийн дунд чанга уншлага зохион байгуулах;
   3.3 Зөөврийн болон гэрээр ном олгох үйлчилгээг хүргэх;
   3.4 “Номтой аялал” арга хэмжээг зохион байгуулах;
   3.5 Номын тухай подкаст хийж, олон нийтийн сүлжээнд байршуулах;
   3.6 Уншигчийн карт хөнгөлөлттэй үнээр нээх /22 карт/

зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 351 гаруй уншигч, хэрэглэгчдийг хамруулсан.

4. **Зохиолч уншигчдын уулзалт**: Уншигч хүүхэд багачуудыг номд дуртай болгох, ном унших арга барилд төлөвшүүлэх, зохиолч уншигчдын амьд харьцааг бий болгох зорилгоор 09-р сарын 19-ны өдөр Д.Нацагдоржийн шагналт, хүүхдийн зохиолч О. Сундуйтай уншигч хүүхдүүд, номын санч, багш нарийн төлөөлөлтэй уулзах уулзалт, лекцийн арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, нийт 249 гаруй уншигчийг хамруулсан. Зохиолчын товч намтар болон зохиол бүтээлийн талаар мэдээлэл, ордны сан хөмрөг дэх номуудаар цахим үзэсгэлэн зэргийг бэлтгэж ордны пейж хуудсанд байршуулан 3584 цахим хэрэглэгчдэд хүргэсэн. Мөн зохиолчийн гарын үсэгтэй 30-40% хямдралтай худалдааг зохион байгуулж, 31 ширхэг 292000 төгрөгийн ном борлуулж өгсөн.

Хэрэгжилт: 3.2.2

Монгол улсын ерөнхийлөгчийн 2017 оны 25 тоот зарлигийн хэрэгжилтийг хангах, Эх хэл, түүх соёлоо сурталчлах, эх хэлээрээ зөв ярьж, цахим орчинд зөв бичих дадал хэвшүүлэх зорилгоор 3 мэдээлэл бэлтгэж пейж хуудсандаа байршуулж 1699 хэрэглэгчдэд хүргэж, танхимаар 2 арга хэмжээ зохион байгуулж 52 хүүхдийг хамруулсан. Үүнд:

1. “Эх хэлний өдөр”-ийг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд “Үндэсний монгол бичгээ сурч, хос бичигтэн болцгооё” уриан дор монгол бичгээр шамдан суралцагч хүүхэд багачуудын “Бийрийн бичлэгийн шилдэг бүтээл”-ийн болон ажилтан албан хаагчдын “Миний нэрийн хуудас” үзэсгэлэнг сэргээн шинэчилж гаргасан. Тус үзэсгэлэнг 1-р давхрын зааланд гаргаж, нийт **359 гаруй** уншигч үзэж сонирхсон.

2. Өөрийн сан хөмрөг дэх тухайн чиглэлийн ном хэвлэлийг нийтэд сурталчах, номын эргэлтийг сайжруулах, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 32 боть номоор биет үзэсгэлэн гаргаж 1-р давхрын шилэн хоргонд байршуулсан. Мөн цахим хэлбэрт хувиргаж, пейж хуудсандаа байршуулж, **441 хэрэглэгчдэд** түгээсэн.
3. "Эх хэлний өдөр"-ийг тохиолдуулан хичээлийн шинэ жилийн эхний өдөр ХНО-ны уншлагын танхимаар үйлчлүүлсэн 4-6-р ангийн 17 хүүхдэд "Угийн бичиг гэж юу вэ?, хөтлөх арга, таних тэмдэг"-ийн талаар сургалт зохион байгуулж, дадлага ажил хийсэн.
4. "Зөв бичих арга зүй" сэдвээр мэдээлэл бэлтгэж, 35 уншигч хүүхдүүдэд мэдээлэл хийсэн.
5. Ордны пейжээр дамжуулан "Эх хэлний өдөр"-ийг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд:
    - "Зөв бичих арга зүйн зөвлөгөө" видео шторк
    - Салаа утгатай үг
    - Хатуу зөөлний тэмдэгийн дүрэм
    - Ижил дуудлагатай үгс
    - Хүндэтгэлийн үгс
    - Эх хэлний тухай танин мэдэхүйн мэдээлэл-4 тус тус бэлтгэн байршуулж, 899 цахим хэрэглэгчдэд хүргэсэн.

Хэрэгжилт:3.2.3

- "Тууль, туулийн гарал үүсэл"
- "Монгол баатарлаг туульс"
- "Жангарын тууль"
- "Алтан ундарга туульс" сэдвүүдээр мэдээ бэлтгэж цахим хуудсанд байршуулж 1397 хэрэглэгчдэд хүргэсэн.

Зорилт 3.3 Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллана.
Хэрэгжилт: 3.3.1

Байгууллагын ёс зүйн зөвлөл нь 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд:

Зөвлөлийн дарга	Ч.Буяннэмэх	-Номын санч-мэдээллийн ажилтан
Гишүүд	О.Даваасүрэн	-Номын санч-мэдээллийн ажилтан
	Т.Сумандадар	-Номын санч-мэдээллийн ажилтан

Хэрэгжилт:3.3.2

3 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.

1. Ажилтан албан хаагчдын дунд төрийн албан хаагчийн мэдвэл зохих хууль, дүрэм, журам, ёс зүйн дүрмийн талаар мэдлэгийн түвшин тогтоох 10 асуулга бүхий тест бэлдэж, шалгалт авч сургалт, мэдээллийн хэрэгцээний судалгаа боловсруулсан.
2. Ажилтан, албан хаагчийн ёс зүйн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаар мэдээлэл бэлтгэж, нийт ажиллагсдын хурал дээр 3 удаа мэдээлэл хийсэн.
3. Ажилтан албан хаагчдыг ёс зүй, харилцааны ур чадвар, удирдлагын манлайллын чиглэлээр холбогдох байгууллагаас зохион байгуулж буй сургалт мэдээллийн арга хэмжээнд хамруулсан. Үүнд:

- ✓ Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 7.4.10 хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин сэдэвт цахим сургалтад тус ордны ёс зүйн зөвлөлийн 3 гишүүн хамрагдсан.
- ✓ Удирдлагын академын багш нарын зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, Алсын хараа 2050 шинэ сэргэлтийн бодлого" сэдэвт сургалтад ХНО-ы ёс зүйн зөвлөлийн гишүүн Т.Сумандадар хамрагдсан
- ✓ Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсгээс зохион байгуулсан сургалтад захирал Л.Мөнхбаатар, Нэгжийн дарга Т.Цэрэннадмид, Номын санч-мэдээллийн ажилтан Т.Сумандадар, архив бичиг хэрэг-нярав А.Ариунтуяа нар хамрагдаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад сэдвийн хүрээнд мэдээлэл авсан.

4. Байгууллагын пейж хуудсаар дамжуулан ёс зүйн хуулийн талаар 1 мэдээлэл бэлтгэж, цахим хэрэглэгчдэд хүргэсэн.
5. Шинээр ажилд орж байгаа 1 (Англи хэлний уншлага үйлчилгээний танхимын номын санч-мэдээллийн ажилтан)ажилтанд ХНО-ны ёс зүй дүрэм, номын санчын ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолт зэргийг танилцуулах ажлыг зохион байгуулсан
6. Ёс зүйн зөрчлийн талаарх хагас болон бүтэн жилийн тайлан мэдээг гаргаж, холбогдох газруудад хүргүүлсэн.
7. Тайлангийн хугацаанд ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдол, хүсэлт ирээгүй.

ДӨРӨВ: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТИЙН ХҮРЭЭНД:

Зорилт 4.1 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангаж ажиллана.

Хэрэгжилт: 4.1.1

Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Авлигын тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль ,Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цахим хөгжлийн багц хууль болон бусад холбогдох дүрэм журмуудыг уншиж судлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Хууль сурталчлах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нийт ажиллагсдын хурал дээр тогтмол танилцуулсан.

6 дугаар сарын 23-ны өдрийн 16:00 цагт Залуучууд театрт зохион байгуулагдсан Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах тухай" тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан сэдвийг иргэд, олон нийтэд танилцуулж, санал авах цуглаанд 3 ажилтан албан хаагч хамрагдсан.

Хэрэгжилт: 4.1.2

ХНО-ны "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2021-2024" –ийн хүрээнд хүний нөөцийн бодлого нь дараах зорилтыг хангахад чиглэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Мэргэшсэн, дадлага туршлагатай албан хаагчдаар багаа бүрдүүлэх;
- ✓ Хүний нөөцийн жендерийн харьцаа тэгш байх; / 70:30 хэтрэхгүй байх/
- ✓ Албан тушаал дэвшин ажиллах баталгаа, боломжоор хангах;

- ✓ Аливаа албан тушаалд томилох, албан тушаал дэвшүүлэхэд зөвхөн мэргэшсэн байдал, ажлын гүйцэтгэлийг нь харгалзах;
- ✓ Байгууллагын хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлсон байх;
- ✓ Төрийн албан хаагчдыг хуульд заасан нийгмийн баталгаагаар бүрэн хангах;

1. Нийт орон тоо 17, одоо ажиллаж байгаа 17,   Эмэгтэй 15, эрэгтэй-5
    - ✓ Захирал-1
    - ✓ Нэгжийн дарга-1
    - ✓ Мэргэжлийн номын санч-мэдээллийн ажилтан -6
    - ✓ Номын санч- мэдээллийн ажилтан- англи хэлний багш-1
    - ✓ Мэдээлэл технологийн мэргэжилтэн – 1
    - ✓ Нягтлан бодогч-1
    - ✓ Архив- бичиг хэргийн ажилтан-нярав-1
    - ✓ Харуул-3
    - ✓ Жижүүр- үйлчлэгч-1
    - ✓ Үйлчлэгч – 1
2. Англи хэлний танхимын номын санч-мэдээллийн ажилтан албан тушаалаа өөрчлөн сэлгэн ажиллах болсонтой холбогдуулан, тус орон тоог нийтэд зарлаж, ажлын байрны тодорхойлтод заасан шаардлагад нийцүүлэн шинээр ажилтан шалгаруулан авч ажиллуулж байна. Мөн жирэмсний амралттай байсан 2 ажилтан ажилдаа эгүүлэн томилогдсонтой холбогдуулан түр орон тоонд ажиллаж байсан Д.Энхсаруул, Ц.Наранцэцэг нар ажлаас чөлөөгдсөн.
3. Нийт 17 албан хаагчийн хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу бүрдүүлж бүтцийн нэгж, албан тушаалын ангилал дараалалд оруулж, албан хаагч нэг бүрээр хавтас үүсгэн битүү шүүгээнд мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган эмх цэгцтэй хадгалж байна.
4. 4-р сард шинэ батлагдсан журмыг нийт албан хаагчдад танилцуулж мэдээлэл хийсний дагуу шагнал урамшуулал, сургалтын гэрчилгээ, сертификат, эрүүл мэндийн хуудас зэрэг материалуудаар хувийн хэргийг нэмж баяжуулсан.
5. ХНУМТ цахим системд нийт албан хаагчдын мэдээллийг бүрэн оруулсан.
6. Хүүхдийн номын ордны ажилтан албан хаагчдын сургалтын хөтөлбөр боловсруулж мөрдөж ажиллаж байна.
7. Хүүхдийн номын ордны ажилтан, албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөний дагуу ажилтнуудын нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны хуулийн дагуу бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөв жил бүр тусган хэрэгжүүлэх, ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс, урамшуулал олгох, ажлын байрны орчин нөхцөлийг шат дараалалтай сайжруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна.

Хэрэгжилт: 4.1.3

Төрийн албан хаагчийн сургалтыг ажлын байранд нь сургах, өөр байгууллага, хамт олноос суралцах буюу богино хугацааны зорилтот сургалтаар давтан сургах, боловсролын мэргэжлийн байгууллагад суралцуулах, тодорхой сэдэв эсвэл мэргэжлээрээ дагнан суралцах гэсэн 4 зарчимд тулгуурлан зохион байгуулдаг. Тус 4 зорилтын хүрээнд 46 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 247 ажилтан, албан хаагч буюу 100 % хамрагдсан (Дэлгэрэнгүй тайланг хавсралтаар гаргасан). Үүнээс:

1. ХНО-ы захирал Л.Мөнхбаатар Монголын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа 2050” сэдэвт богино хугацааны 40 цагийн цахим, танхим хосолсон сургалтад хамрагдаж үнэмлэх авсан.
2. Архив-бичиг хэрэг, нярав А.Ариунтуяа ХАБЭА-ы 10 хоногийн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.
3. Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Сургалт Үнэлгээ Судалгааны Институт, Монголын номын сангийн холбооноос хамтран явуулж байгаа номын санчийн мэдлэг олгох үнэмлэх бүхий “Чадамжид суурилсан номын санчийн түр сургалт”-д математикийн танхимын номын санч-мэдээллийн ажилтан Б.Өлзийдэлгэр суралцаж төгссөн.
4. Соёлын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгэм хамгааллын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд нарын хамтарсан 2023 оны А/152, А/195, А/57, А/40 дугаар тушаалаар батлагдсан “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Номын санч, нийгмийн ажилтныг цахим ур чадвар олгох сургагч багшаар бэлтгэх” /10-р сарын 23,24,30,31/ 4 өдрийн 12 цагийн сургалтад 6 номын санч хамрагдаж Номын санч- мэдээллийн ажилтан Ч.Буяннэмэх, Г.Гэрэл, О.Даваасүрэн, Б.Өлзийдэлгэр, М.Оюунгэрэл, Т.Цэрэннадмид “Сургагч багш”-ийн сертифекат авсан.
5. Захирал Л.Мөнхбаатар Дархан политехникийн коллежийн засал чимэглэлийн ангид суралцаж байна.

Хэрэгжилт: 4.1.4

Дархан-уул аймгийн Хүүхдийн номын ордны ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх 24 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулж баталгаажуулан мөрдөж ажиллаж байна.

- Улирал тутам ажиллагсдыг ажлыг дүгнэж, захирлын тушаалаар 40% хүртэлх урамшуулал олгож байна.
- Ажилтны ажлын үр дүнг үнэлж, орон нутгийн болон төрийн шагнал, одон медалиар шагнуулахаар тодорхойлж, 5 ажилтан Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан.
- Хамтын гэрээний 4.8-д заасны дагуу ажилтанд сар бүр хоолны, унааны хөнгөлөлт үзүүлж байна.
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангуулах, тоног төхөөрөмж тавилга шинэчлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг худалдан авч, засвар тохижилт үйлчилгээг хийж ажилласан.
- “Орон нутгийн өмчийн байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ын дагуу 8 ажилтанд тэтгэмжийг олгосон. / ... төгрөг/
- Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээний хүрээнд “Дархан-Уул аймгийн Хүүхдийн Номын Ордны ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 17,18-д заасан арга хэмжээний хэрэгжилтийг хангах, Хамтын гэрээний 4.8-д заасны дагуу ажиллагсдыг эрт илрүүлэг шинжилгээнд хамруулах, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх болон дархлаажуулалтын витаминжуулалтанд хамруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. /4.610.661 төгрөг/Ажилтан албан хаагчдын урамшуулалыг 2022 оны гүйцэтгэлийн тайланг үндэслэн хүний нөөцийн хөгжил буюу мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байдал, санхүүгийн тайлангийн дүгнэлт, орлого төвлөрүүлэлт, нийтийг хамарсан уралдаан тэмцээн, арга хэмжээ, хурал цуглааны ирц, оролцоо, шинэ санал саналчилга, ёс зүй, харилцаа хандлага, ажилласан хугацаа зэрэг тодорхой шалгуураар дүгнэн нийт 13 албан хаагчдад үндсэн цалингийн 17-37%-тай тэнцэх урамшуулал олгосон. /4.610.611 төгрөг/
- Дархан хотын өдрийг тохиолдуулан хөдөлмөр бүтээлээрээ тэргүүлсэн 5 албан хаагч “Аймгийн засаг даргын жуух бичиг”-ээр шагнагдсан.

Хэрэгжилт: 4.1.5

Хүүхдийн номын ордны Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн нийт ажиллагсдын хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж мөрдөж ажиллаж байна. Журамтай холбоотой ямар нэг зөрчил гараагүй.

Хэрэгжилт: 4.1.6

Хамтын гэрээг талууд шинэчлэн боловсруулж, нийт ажиллагсдын хуралд танилцуулж, холбогдох газарт бүртгүүлэн баталгаажуулж мөрдөн ажиллаж байна. Гэрээтэй холбоотой ямар нэг маргаан гараагүй.

<u>Зорилт 4.2 Бичиг хэрэг, Архивын үйл ажиллагааг стандартын дагуу зохион байгуулах;</u>

Хэрэгжилт: 4.2.1

Холбогдох байгууллага, албан хэрэг хөтлөлийн Able программ, байгууллагын цахим шууданд ирсэн албан бичгийг хүлээн авч бүртгэх, холбогдох хүнд танилцуулах, шийдвэрлэлтэд хяналт тавих, мөн шаардлагатай албан бичгүүдийг баримт бичгийн стандартын дагуу боловсруулж холбогдох газруудад хүргүүлэх ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар байгууллагад нийт 59 албан бичиг ирснээс 14 албан бичиг хугацаатай байсныг холбогдох хүнд танилцуулж, хугацаанд нь хариу албан бичиг илгээсэн. Дархан-Уул аймгийн Соёл урлагийн газраас 32, бусад холбогдох байгууллагуудаас -27 бичиг ирсэн байна. Явуулсан бичиг-56: үүнээс 14 нь ирсэн албан бичгийн хариу, бусад 42 нь байгууллагын зүгээс холбогдох газруудад шаардлага, хүсэлт илгээсэн байна.

2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Хүүхдийн номын ордны захирлын А тушаал 23, Б тушаал 8 гарсныг албажуулан мөрдөж ажилласан.

Байгууллагын хамт олны 14 удаагийн хурлын тэмдэглэлийг стандартын дагуу хөтөлж, гарын үсгээр баталгаажуулан хурлаас гарсан шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлж ажилласан.

2023 оны байдлаар ажлаас чөлөөгдөх 2 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд ямар нэг гомдол хүлээн аваагүй.

Хэрэгжилт: 4.2.2

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу:

Байнга хадгалах хэргийн тоо -11

Түр хадгалах хэргийн тоо -14

70 жил хадгалах хэргийн тоо -4 архивын баримт бүрдүүлсэн.

Зорилт 4.3 Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

Хэрэгжилт:4.3.1

Дунд хугацааны төсвийн төслийг төсвийн тухай хуульп зааснаар хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад тушаав.

Зорилт 4.4 Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтанд хяналт тавих, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлөөр хангах

Хэрэгжилт:4.4.1

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, сангийн сайдын баталсан анхан шатны маягт хөтлөх зааврын дагуу байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн анхан шатны бүртгэлийг иж бүрэн хийж толилуулсан болно.

Хэрэгжилт: 4.4.2

- ✓ Байгууллагын мөнгөн болон хөрөнгийн тайланг сар тутам, хөрөнгийн тооллогыг хагас жилд нэг удаа зохион байгуулан эд хариуцагчаар нь бүртгэлжүүлж бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан.
- ✓ Байгууллагын өмч хөрөнгө ашиглалтыг сард 1-2 удаа хянаж, шаардлагатай бол засаж сэлбэх, солих ажил хийгддэг.
- ✓ Агуулахын өрөөнд сард 1 удаа их цэвэрлэгээ хийж хэвшсэн.
- ✓ Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, хүлээн авсан бараа материалыг агуулахын өрөөнд эмх цэгцтэй, бүрэн бүтэн хадгалж шаардлагатай үед нь хэрэглээнд гаргаж ажиллаж байна.

Хэрэгжилт:4.4.3

- ✓ Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах материалыг бэлтгэх, захиалах, хуваарийн дагуу олгох ажлыг зохион байгуулж ажилласан.
- ✓ Мөн бусад урсгал засвар, СОНА зохион байгуулахад шаардлагатай бараа материалыг тухай бүр татаж , бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан.

Хэрэгжилт: 4.4.4

Мөнгөн кассын гүйлгээг гүйцэтгэх, хөтлөх ажлын хүрээнд 2023 оны 12 дугаар сарын байдлаар Уншигчийн картын орлого 7.490.000 төгрөгийн байгууллагын төрийн сангийн дансанд төвлөрүүлж, бэлэн мөнгөний орлогийн баримт хөтөлсөн.

Төрийн сангийн

- ✓ 100190135032 тоот дансанд1300000₮
- ✓ 100190135033 тоот дансанд 6190000₮ тоот дансанд тус тус тушаасан.

<u>Зорилт 4.5 Байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх</u><u>;</u>

Арга хэмжээ 4.5.1

Хүүхдийн номын ордны 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

Хэрэгжилт: 4.5.1

Соёлын яамнаас Аймгийн Соёл, урлагийн байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ хийх, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх ажлын хэсэг ХНО-д ажиллаж, үйл ажиллагаа явуулдаг байр, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, хамааралтай баримт бичгийг хянан үзэж, эрсдэлийн шалгуур үзүүлэлт хяналтын хуудсаар үнэлгээ өгч, зөвлөн туслах үйл ажиллагаа явуулсан.

<u>Зорилт 4.6 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;</u>

Хэрэгжилт:4.6.1

Аймгийн төв ном ын сантай хамтран Үндэсний бичиг үсэг- Номын баярын арга хэмжээг зохион байгуулж нийт 150 хүн хамрагдсан.

Орхон, Булган аймгийн номын сангийн албан хаагчдын төлөөлөл ХНО-ны үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцох уулзалт зохион байгуулсан

Хэрэгжилт: 4.6.2

Хэрэглэгчид номын сангийн ажилтнуудтай эсвэл өөр хоорондоо харилцах боломж бүхий шинэлэг орчин, “онлайн” орон зайг бий болгох зорилгоор facebook, pagi хуудас ашиглан номын сангийн 3-4 группүүдэд холбогдон мэдээлэл солилцож ажиллаж байна.

Цахимаар зохион байгуулагдаж буй арга хэмжээ, хурал, зөвлөгөөн, сургалтуудад тусгай программ /zoom, google meet г.м/ ашиглан оролцож сурсан.

Хэрэгжилт:4.6.3

- Албан харилцааны мейл хаяг,
- Дотоод удирдлагын ERP систем,
- Санхүүгийн программ /Динамик/,
- Нэвтрэлтийн нэгдсэн систем
- Төрийн албаны ХНУМТ систем
- Хөрөнгө ашиглалт хамгаалалтын систем
- Аймгийн ЗДТГ болон бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох ABLE программ
- Номын сангийн Monbiblio
- Facebook
- E Darkhan зэрэг систем программ, платформуудыг ашиглан мэдээлэл солилцож ажиллаж байна.

Хэрэгжилт: 4.6.4

Цахим орчноор дамжуулан номын сангийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор:

1. Номын сангаас зохион байгуулдаг соёл олон нийтийн ажил;
2. Номын сангийн үйлчилгээнүүдийн талаарх мэдээлэл;
3. ХНО-ны сан хөмрөгийн танилцуулга болон шинэ, сэдэвчилсэн номын үзэсгэлэн;
4. Ном унших арга зүйд төлөвшүүлэх ;
5. Цахимаар ном унших боломж

зэрэг чиглэлээр мэдээ мэдээллүүдийг бэлтгэн 8100 гаруй дагагчиддаа хүргэж ажиллаж байна.

Хэрэгжилт:

ХНО-ны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг арга хэмжээ нь 9-р сард зохион байгуулагдсан “Номын баяр” , “Соёлын ажилтын өдөр”-тэй давхцаж зохион байгуулах үйл ажиллагаа нь ижил байсан.

Зорилт 4.7 Мэдээллийн ил тод байдлыг хангах, удирдлагыг мэдээллээр хангах, ажлын төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, статистик тайлан мэдээ гаргах;

Хэрэгжилт: 4.7.1

- Ордны цахим хуудсаар дамжуулан нийт 469 мэдээ бэлтгэн байршуулж, пейж хуудсыг дагагч 8100 хэрэглэгчдэд тогтмол хүргэж ажилласан.
- Салбар номын сангийн нүүр хуудсанд нийт 31 мэдээ мэдээлэл бэлтгэн байрлуулан пейж хуудсыг дагагч 8100 хэрэглэгчдэд (давхардсан тоогоор 12301 хэрэглэгчдэд) хүрсэн байна.
- Төсвийн ил тод байдлын самбарт-6, Байгууллагын мэдээ мэдээллийн самбарт 6 төрлийн мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж байна.
- Албан хэрэг хөтлөлтийн ABLE систем дээр тавигдаж буй мэдээ, мэдээллийг удирдлагад тухай бүр мэдээллэж ажилласан.

Хэрэгжилт:4.7.2

- Гүйцэтгэлийн төлөвлөгөө-1,
- Гүйцэтгэлийн тайлан-1,
- Статистик мэдээ-4
- Улирлын статистик мэдээ-4, сарын мэдээ-12,
- 7 хоног тутмын мэдээ-48,
- бусад холбогдох мэдээ тайланг хугацаанд нь гаргаж гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН А.ЭРДЭНЭ-ОЧИРЫН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА:

1. **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**
2. **САН ХӨМРӨГ, КАТАЛОГ**
3. **УНШЛАГА, ҮЙЛЧИЛГЭЭ**
4. **СОЁЛ, ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ**
5. **БУСАД АЖИЛ**
6. **АРГА ЗҮЙН АЖИЛ**

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Эрхэм зорилго:

Соёлын үнэт зүйл болох ном хэвлэлийг хадгалж хамгаалах, ард иргэдэд ном соёлоор үйлчлэн тэдний оюуныг хөгжүүлэх, бүтээлч санаачлагыг өрнүүлэх, орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, тав тухтай тохилог орчинг бүрдүүлэх, номын сангийн стандартыг хангаж ажиллахад оршино.

1.2 Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Манай номын сан нь **1945** онд байгуулагдсан, одоогийн байдлаар**14** хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Номын сан нь насанд хүрэгчдийн болон хүүхдийн уншлагын танхим, Соёмбо цогцолборт Америкийн соёл мэдээллийн төв уншлагын танхим, гэрээр ном олгох тасаг, үндсэн фонд, хэвлэлийн фонд, гэр бүлийн буюу аз жаргалын өргөө уншлагын танхим зэрэг танхимуудаар үйл ажиллагаагаа явуулдаг. Нийт 484м^{2} талбайг номын сангийн үйлчилгээнд зориулан ашиглаж байна.

Номын сангийн албан ёсны имэйл хаяг: dg.library@yahoo.com
Цагийн хуваарь:
Насанд хүрэгчдийн уншлагын танхим:
Даваа-Лхагва 8^{00}-20^{00}, Пүрэв-Ням 8^{00}-17^{00}
Бусад тасаг танхим:
Даваа-Баасан 8^{00}-17^{00}
Байгууллагын утасны дугаар: 70522706
Номын сангийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Баттогтох

2,САН ХӨМРӨГ, КАТАЛОГ

2,1 Сан хөмрөгийн өнөөгийн байдал

Орон нутгийн онцлог уншигчдын эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн төсөв, төсөл, бэлэг хандивын журмаар фондоо бүрдүүлж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар **39144ш** номтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2.2 Сан хөмрөгийн бүрдүүлэлт

2023 оны фондын бүрдүүлэлтийг төсвийн санхүүжилтээр шинэ ном худалдаагаар **385**ширхэг, хандив аар**22** ширхэгсолилцоогоор , 83ш нийт 490ш **8,532,300** төгрөгийн ном авч сан хөмрөгийн баяжилтыг хийсэн. Мөн 4 нэр т өрлийн сонин, 2 нэр төрлийн сэтгүүлийг улирал бүр тогтмол захиалж828ш **630,920** төгрөгний хэвлэл захиалж иргэдийг өдөр тутмын мэдээ мэлээллээр ханган ажилласан.

Бүрдүүлэлт	Тоо ширхэг	Үнэ /төг/
Шинээр нэмэгдсэн нийт	490	төгрөг 8,502,300
Шинээр нэмэгдсэн ном	Шинэ ном-385 хандив-22 солилцоогоор-83	
Шинээр нэмэгдсэн Сонин, сэтгүүл	828ш	

Хийгдсэн ажил	Тоо хэмжээ
Электрон каталогт бүртгэгдсэн нийт ном	39144
Электрон каталогт шинээр нэмэгдсэн ном	490
Электрон каталогт хийгдсэн хайлтын тоо	2225

2.3 Каталог зохион байгуулалт

Номын санд шинээр ирсэн 490ширхэг номонд техник ажиллагаа хийж данс бүртгэлд тусган электрон катологт бүрэн оруулж тасаг танхимуудад хуваарилан уншлага үйлчилгээнд гарган ажиллаж байна. Нийт номын сангийн хэмжээнд 39144 ширхэг номтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

3, ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 Уншлага үйлчилгээ:

Жилийн эцсийн байдлаар нийт 1386 уншигч, 16449ирцэд 19439ном хэвлэл олгож үйлчиллээ. Энэхүү тоон үзүүлэлт зөвхөн төв номын сангийн уншигч, ирц, ном олголтын тоо юм.

Үзүүлэлт	Тоо, хэмжээ
Дорноговь аймгийн Сайншанд сумын иргэдийн тоо	25910
Бүртгэлтэй уншигчийн тоо	1386
Номын сангийн ирц	16449
Олгосон ном	19439

- Хөдөө орон нутаг болон алслагдсан айл өрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд өндөр настан зэрэг номын санд ирэх боломжгүй хүмүүст номын сангийн үйлчилгээг хүргэх, ном хэвлэлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, уншигчдын хүрээг өргөжүүлэх зорилгоор зөөврийн номын сан болон “Номын багц” үйлчилгээг тогтмол ажиллуулж байна.
    - Зөөврийн номын үйлчилгээ 30 байгууллага аж ахуй нэгжид давхардсан тоогоор 38 удаа үйлчилж 505ном олгож ажилласан байна.

Номын үзэсгэлэн:

Цаг үеийн болон сэдэвт үзэсгэлэнг 23 удаа дэлгэж 3386 номыг 1751 хүнд үзүүлэн фондын ном хэвлэлээ сурталчилан таниулсан.

4. СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ:

“НОМЫН ӨГЛӨГТЭЙ ХУТАГТЫН ЦАДИГ”

Их соён гэгээрүүлэгч Д. Данзанравжаагийн 220 жил, Соёлын бүтээлч сар аяны хүрээнд “Номын өглөгтэй хутагтын цадиг” танин мэдэхүйн цэнгээнт нэвтрүүлгийг Дорноговь телевиз DTV -тэй хамтран зохион явууллаа. Нийт 3 багын 9 хүн оролцлоо.

Үр дүн: Танин мэдэхүйн цэнгээнт нэвтрүүлгийг зохион явуулсанаар Ноён хутагтын тухай түүний амьдрал уран бүтээлийг уншиж судлан мэдлэгийн хүрээгээ тэлж олон ....сайхан шинэ номын эзэд болсон

“АЛТАН БИЙР” ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ

Тус наадмыг МУСГЗ А.Эрдэнэ-Очирын нэрэмжит Дорноговь аймгийн Төв Номын Сан , "Хурмаст тэнгэр" төв, Музей сургалт судалгааны төвөөс эрхлэн, Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран, "Бадрах өргөө" рестораны дэмжлэгтэйгээр зохион байгуулсан.

Энэ удаа тус наадмын шалгаруулалтыг "Хурмаст тэнгэр" төв болон тус аймаг орон нутагт ажиллаж амьдарч буй яруу найрагчдын дунд зарлаж, шилдэг 15 найрагчийг шалгаруулан Сонгодог үдэшт урин, уншлага хэлбэрээр хийлээ.

Үр дүн: Орон нутгийнхаа зохиолч яруу найрагчдын уран бүтээлийг сонсож ..үгийн урлагийн сайхныг мэдэрсэн

“БАРИМЛЫН ШАВРААР УРЛАХУЙ”

Номын баярыг угтаж зохион явуулсан “Баримлын шавраар урлахуй” бүтээлийн уралдааны Тэргүүн байранд У.Чингүүн, Дэд байранд Б.Мөнгөншүүдэр, Гутгаар байранд Э.Энхтамир, Тусгай байранд О. Хаш-Эрдэнэ, А. Билгүүн, Б.Сондор, Г. Хүрэлхүү, ЕБ-ын 5 дугаар сургуулийн 5в ангийн сурагчдын хамтын бүтээл шалгарлаа.

Үр дүн: Хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж тэдний урлан бүтээхэд урам оруулсан.

“МИНИЙ НАНДИН ЭРДЭНЭ”

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Миний нандин эрдэнэ" бүтээлийн уралдааныг долоо дахь жилдээ зохион явууллаа. Нийт 36

бүтээл ирснээс Тэргүүн байрт ЕБС-н 12 жилийн 2-р сургуулийн 3б ангийн сурагч О.Нарангоо, Дэд байрт ЕБС-н 12 жилийн 5-р сургуулийн 4г ангийн сурагч Б.Тэмүүлэн, Гутгаар байрт ЕБС-н 5-р сургуулийн 5а ангийн сурагч С. Арвижих, Тусгай байрт ЕБС-н 12 жилийн 1-р сургуулийн 5д ангийн сурагч Э.Хулан, 2-р сургуулийн 4г ангийн сурагч Б.Шинэ-Өглөө нар байр эзэллээ.

Үр дүн: Өөрийн хүндэлж хайрладаг эрхэм хүндээ сэтгэлийн бэлгийг өөрийн бүтээлээр илэрхийлж сурах мөн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан соёлын уламжлалт ажил болсон.

“ОЛУУЛАА УНШЪЯ” АЯН

Соёлын бүтээлч сарын хүрээнд “Олуулаа уншъя” аяныг ЕБС-ын сургуулиуд, Политехникийн коллеж, АШУҮИС-ын оюутан сурагчдын дунд амжилттай зохион явууллаа. Хамгийн олон уншигчтай сургуулиар ЕБ-ийн 1-р сургууль, Шилдэг хамт олноор ЕБ-ийн 1-р сургуулийн С.Энхсайхан багштай дотуур байр, Шилдэг анги хамт олноор ЕБ-ийн 1-р 12 жилийн 6б анги мөн Шилдэг анги хамт олноор ЕБ-ийн 6-р 12 жилийн 6в анги тус тус шалгарлаа. Нийт оролцсон багш анги хамт олонд талархлаа.

Үр дүн: Сургууль хамт олноороо ном унших арга барилд суралцан улам их унших .сэдэл тэмүүлэлтэй болсон

“ХҮҮХДИЙН ЗОХИОЛЧТОЙ УУЛЗАЛТ”

Хүүхдийн номын өдрийг угтан хүүхдийн зохиолч Л.Мөнхбаттай уншигч - зохиолчын уулзалт, мөн асуулт, хариултын АХА тэмцээн, таавар, орон орны хүүхдийн номын үзэсгэлэн гаргах зэрэг ажлуудыг зохион явууллаа.

Үр дүн: Өөрийн уншдаг шүлэг, дуулдаг дууныхаа зохиогчтой хүүхдүүд нүүр тулан уулзсан нь тэдэнд урам өгсөн шинэлэг ажил боллоо.

"БЯЦХАН ШҮЛЭГЧ"

Говийн тавдугаар ноён хутагт Д.Данзанравжаагийн мэлмий гийсэний 220 жилийн ойг угтан СӨБ-н хүүхдүүдийн дунд хутагтын шүлгийг цээжлэн унших "БЯЦХАН ШҮЛЭГЧ" аян зохион явууллаа. Нийт 46 -н хүүхэд бичлэг ирүүлснээс:

Замын-Үүдийн 4-р цэцэрлэгийн Т.Эрдэнэ-Очир манлайлж ,Дэлгэрэх сумын Б.Равжир удаалж ,Сайншанд сумын 2-р цэцэрлэгийн Ш.Сондор дараалллаа.

Дэлгэрэх сум Хүүхдийн цэцэрлэг Б.Есүй, Замын-Үүд 4-р цэцэрлэг М.Өлзий-Наран, Замын-Үүд 5-цэцэрлэг М.Содномдорж, Сайншанд сумын 12-р цэцэрлэг А.Үнэнбат нарыг тусгайлан шагналаа.




Үр дүн: Багш нар хүүхдэд үлгэр ярих нь багшийн ур чадварыг хөгжүүлэх хүүхэд багшийн шүтэлцэх холбоог бий болгоход тус нэмэр болсон гэж үзэж байна.

"АНХНЫ НОМ"

Анхны уншсан номын тухай нандин мэдрэмжээ хуваалцах "Анхны ном" дурсамж ярилцлагыг зохион явууллаа. Уг арга хэмжээнд нийт 10 хүн оролцов.

Үр дүн: Уншигчид анх уншсан номынхоо талаар дурсамж яриа өрнүүлэн номыг хэрхэн шимтэн уншсан талаараа халуун яриа өрнүүлсэн

“САНАЖ САРВАЙХ НУТАГ, УС МИНУ”

Монгол улсын төрийн соёрхолт, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Балжирын Догмидын “Санаж сарвайх нутаг, ус мину” уран бүтээлийн уулзалт, цэнгүүнийг зохион явуулсан.

Үр дүн: ,Зохиолч өөрийн уран бүтээлийн талаар дурсамж түүхийг өгүүлэн зохиолчийн уран бүтээлээс өгүүлэх урлагийн алдартнууд уншигчдад толилуулсан

НУТГИЙН ЗОХИОЛЧ, ЯРУУ НАЙРАГЧДЫН ГАР БИЧМЭЛ НОМ

Үр дүн: Нутгийн зохиолчдын гар бичмэл номыг




Соёлын бүтээлч сар аяны хүрээнд аймгийн зохиолчдын 20 гар бичмэл ном, зохиол бүтээлийг соёлын баримтат өв болгон сан хөмрөгийг баяжуулж байна.
бичүүлэн авснаар олон арван жилийн дараа дахин олдохгүй үнэт ховор ном болно.

“БУМБАРДАЙ” НОМЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Н.Эрдэнэбаярын зохиол Бумбардай номын эхний гурван цувралаар хэлэлцүүлэг зохион явууллаа. Уг хэлэлцүүлэгт ЕБ-ын 5-дугаар сургуулийн Ц.Эрдэнэцэцэг багштай 5б ангийн хүүхдүүд болон идэвхтэн уншигч хүүхдүүд оролцлоо.

Үр дүн: Хүүхдүүдийн ном унших идэвхийг өрнүүлж, уншсанаа ойлгож ярих чадамж сайжирсан.

"НОМЫН БАЯР 2023"

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор "Үндэсний номын баяр-2023" арга хэмжээг өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүллээ. Энэхүү номын баярыг Аймгийн засаг дарга ивээн тэтгэж Соёл урлагийн газар Боловсролын газар, Нийгмийн бодлогийн хэлтэс, Номын сан хамтран зохиолоо. Номын баярт нийт 600 гаруй иргэд, уншигч, хүүхэд багачууд хамрагдан өргөн цар хүрээтэй болж өндөрлөлөө . Яруу найрагч Болорцомын эзэн Б.Галсансүх Ш.Лхамноржмаа, Нацагдоржийн нэрэмжит шагналт хүүхдийн зохиолч Н.Мандал, мөн хүүхдийн зохиолч Наранцэцэг, Зохиолч Наранбаатар, Энх-Амгалан нар урилгаар ирж хүүхэд багачууд иргэд хөдөлмөрчдөд шүлэг зохиолоо уншлаа. Grand book, Day book, Үлэмжийн чанар зэрэг номын худалдаанууд мөн Зохиолчид өөрсдийн номыг гарын үсэгтэй худалдаалан хамтран ажилласан./ Нийт долоон асарт ном худалдаалсан/ "Тэргүүний уншигч Д.Нацагдорж" тэмдэгээр зургаан уншигч, Тэргүүний хамт олноор нэг анги шалгарч шагналыг гардуулан уншигчдын урмыг нэмж өглөө.

Ном сурталчлах зорилгоор өвөрмөц санаа шийдлээр хийсэн "Том ном"-н үзэсгэлэн мөн хүүхдийн гар урлал, үндэсний уран бичвэрийн үзэсгэлэн гаргаж олны хүртээл болгож орчныг чимэглэн майхан барьж зүлэг дэвсэж жижиг гэр чихмэл тоглоом дэлгэн хүүхдэд таатай орчинг бүрдүүлсэн болно.

Ноён хутагтын 220 жилийн ой угтаж Хутагтын бүтээлийг хамт олноороо цээжлэн унших аянд нэгдсэн анги хамт олныг шагнан урамшуулж мөн энэ үеэр өөрийн болгосон шүлэг зохиолоо хүүхдүүд болон хурсан олонд уншиж өгсөн юм.

Үр дүн: Олон талт ажлыг зохион байгуулж уншигчдын идэвх сайжирсан.

“ХҮҮХДИЙН БАЯР” АРГА ХЭМЖЭЭ

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан арга хэмжээ зохион байгуулав.

Үр дүн: Хүүхэд багачуудын тэмдэглэлт баяраар нь номтой холбоотой төрөл бүрийн тэмцээн уралдаан, сугалаа явуулж баярыг нь дурсамж дүүрэн тэмдэглэн .өнгөрүүлсэн

"ХУУЛЬЧ САНДАГ"-ИЙН НЭРЭМЖИТ ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ

Соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулсан Монголын эртний үг зохиолын нэрт төлөөлөгч "ХУУЛЬЧ САНДАГ"-ийн нэрэмжит яруу найргийн наадам амжилттай болж өндөрлөлөө. Болор цомын эзэн яруу найрагч Д.Галсансүх тэргүүн байр, Х.Дугарсүрэн дэд байр, Э.Анхбаяр гутгаар байр, мөн Д.Эрдэнэзулай, Б.Энхжаргал нар тусгай байрт шалгарлаа.

Үр дүн: Монголын эртний үг зохиолын нэрт төлөөлөгч "ХУУЛЬЧ САНДАГ"-ийг уншигч олон түмэнд сурталчилан таниулсан.

“ХҮҮХДҮҮДТЭЙГЭЭ ҮЛГЭР УНШИЖ-ЦАГ ГАРГАЯ” АЯН

Соёлын бүтээлч сар болон намайг хамгаал" нөлөөлийн аяны хүрээнд гэр бүлээрээ хүүхдүүдтэйгээ үлгэр уншиж-цаг гаргая аяныг зохион явууллаа.
Энэхүү арга хэмжээнд
Тэргүүн байр эзэлсэн- Б.Баясгалангийн гэр бүл хүү ЕБС-ын 1-12 жилийн 3д ангийн сурагч Б.Арвин-Үйлс

Дэд байр эзэлсэн- Д.Анхбаярын гэр бүл охидуудын хамт ЕБС-ын 2-12 жилийн 2в ангийн сурагч А.Анударь А.Есүдарь
Гутгаар байр эзэлсэн- Б.Энхбаярын гэр бүл охин ЕБС-ын 1-12 жилийн 2е ангийн сурагч

Э.Энхжин нар тус тус шалгарлаа.

Үр дүн: Үлгэрээр дамжуулан хүүхэдтэйгээ харилцах гэр бүлийн харилцааг сайжруулсан.

“ЗУНЫ ЗУГААТАЙ УНШЛАГА”

“Зуны зугаатай уншлага” Зөөврийн номын үйлчилгээг Жаргалан зусланд зохион явууллаа.

Үр дүн: Уншигч хүүхдүүдийн зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд номоор үйлчилсэн.

“НОМЫН БАЯР-2023”

"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд- 2023" намрын номын баяр “ИЛҮҮ ИХ УНШЪЯ” уриан дор амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.
Монгол Улсын Ерөнхийлөгчийн 158 дугаар зарлигаар жил бүрийн есдүгээр сарын гурав дахь долоо хоногт “Номын баярын өдөр”-ийг улс орон даяар тэмдэглэхээр шийдвэрлэсэн.
34 дэх удаагийн номын баярыг МУСГЗ яруу найрагч Арлааны Эрдэнэ-Очирын нэрэмжит аймгийн Төв Номын сан, Соёл урлагийн газар, Аймгийн Ахмадын хороо, Боловсрол шинжлэх ухааны газар, Насан туршийн боловсролын төв, ЕБ-ын 3-р сургууль, Музей сургалт судалгааны төвтэй хамтран зохион байгууллаа.
Баярын нээлтийн үеэр "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн" ЕБС-ын сурагч, анги хамт олныг шалгаруууллаа.
Энэ удаагийн "НОМЫН БАЯР"-ын арга хэмжээний хүрээнд МУСГЗ яруу найрагч Л.Эрдэнэбаттай зохиолч, уншигчдын уулзалт, "Амьд ном" Соёлын өвийн өвлөн тээгч МУГЖ Н.Лантуутай уулзалт, ярилцлага хийж, мөн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд "Монгол хэл, бичгийн үг үсэглэлийн" тэмцээн, АХА танин мэдэхүйн тэмцээн, шинэ

шилдэг номын үзэсгэлэн, "Сайхан бичиг" "Уран бичвэр“-ийн үзэсгэлэн зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгууллаа.

Үр дүн: Олон талт ажлыг зохион байгуулж уншигчдын идэвх сайжирсан.

“СУДАРТАЙ АЯЛАЛ”

Аймгийн Ахмадын хороо, Номын сан, аймгийн МАН-ын Ахмадын хороо хамтран 6 дахь жилдээ зохион явууллаа. Арга хэмжээний үеэр сан хөмрөгт хадгалагдаж буй Үнэт ховор номыг нийтэд таниулан, түгээн дэлгэрүүлж номын үзэсгэлэн дэлгэн толилуулав. Ахмадууд Зава Дамдингийн “Сүмбэн”, Ганжуур, Данжуур судруудыг барин БНМАУ-ын баатар Д.Данзанваанчигийн хөшөө хүртэл гороолж алхав. Аймгийн Дэчинчойнхорлин хийдийн лам Ганхүү номын айлтгал өргөж, оролцогчид маани хөгжөөж Ардын дууны уралдаан зэрэг соёл олон нийтийн арга хэмжээг явууллаа.

Үр дүн: Сан хөмрөгт хадгалагдаж байгаа ховор хуучин ном судрыг сурталчлан ахмад үе залуус хүүхдэд ном эрхэмлэх зан үйлийг сурталчилах үлгэр дуурайлал болдог.

“ШАГАЙН НААДГАЙ” ТЭМЦЭЭН

Монголын уламжлалт шагайн наадгайн зан үйл, ёс заншлаас суралцах, үр хүүхдэдээ өвлүүлэн үлдээх, монгол үндэсний өвөрмөц нэгэн тоглоом наадгайг олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор соёлын байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд “Монгол шагай” уралдаан тэмцээнийг зохион явууллаа. "Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд болсон энэхүү шагайн наадамд Саран хөхөө театрын баг хамт олон тэргүүллээ.

Үр дүн: Ардын уламжлалт зан заншил, тоглоом наадгайг сурталчлан таниулсан .ажил болсон

“ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР УРЛАХУЙ ҮЗЭСГЭЛЭН”

МУСГЗ, Нацагдоржийн шагналт Арлааны Эрдэнэ-Очирын " Хос ном"-ын нээлтийг зохион байгууллаа. Яруу найрагчийн 30 гаруй бүтээлийг үндэсний бичгээр урласан үзэсгэлэн номын сангийн уншлагын танхимд байршууллаа.

Үр дүн: Зохиолчийн зохиол бүтээлийг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, номын фондын баяжилт нэмэгдсэн.

“ТОМ НОМ” БҮТЭЭХ УРАЛДААН

Ардын уламжлалт соёл, ёс заншил, үндэсний бичиг үсэг, аман зохиол зэрэг хүүхдийн хүмүүжил, танин мэдэхүйд нөлөөлөх сонирхолтой дүрслэл, бүтээмжтэй ТОМ НОМ” бүтээх бүтээлийн уралдаанд 18 бүтээл ирүүлснээс Тэргүүн байр Сайншанд сумын хүүхдийн 6 дугаар цэцэрлэг, Дэд байр Замын -Үүд сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг, Гутгаар байр Сайншанд сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг тус тус шалгарлаа. Тусгай байр: Сайншанд сумын хүүхдийн 1 , 2, 12 дугаар цэцэрлэг, Дэлгэрэх сумын өндөр настан Д.Алтангэрэл, Сайншанд лаборатори 2 дугаар сургуулийн багш Х. Бямбатөмөр, Сайншанд сум иргэн Ц. Норжин нарын бүтээл шалгарлаа.

Үр дүн: Багш нарын бүтээлч үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдэд .сонирхолтой содон номыг үзүүлж таниулах ач холбогдолтой

“УРАН БИЧВЭРИЙН” УРАЛДААН

Соёлын бүтээлч сарын хүрээнд: Монгол бичгийн “Уран бичвэрийн “ уралдаан монгол хэл,бичиг, уран зохиолын багш нарын дунд амжилттай зохион явууллаа. Тэргүүн байранд Замын-Үүд сумын багш О.Батчимэг, Дэд байранд Сайншанд сумын багш Э.Цэвэгсүрэн, Гутгаар байранд Замын-Үүд сумын багш Б.Эрдэнэцэцэг,
Тусгай байранд Ц.Дэлгэрмаа, М.Наранцэцэг шалгарлаа.





Үр дүн: ,Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлж багш нарын бүтээлийг уншигчдад сурталчилсан

“ЗОХИОЛЧ УНШИГЧДЫН УУЛЗАЛТ”

Дэлхийн хүүхдийн өдрөөр Зохиолч, уншигчдын уулзалт зохион явууллаа.Уулзалтанд Болор цомын эзэн Д.Галсансүх Цагаан уул наадмын тэргүүн шагналт Г.Хашбаатар нар уригдан шүлэг зохиолоо уншлаа.

Соёлын гавьяат зүтгэлтэн, Нацагдоржийн шагналт яруу найрагч Арлааны Эрдэнэ-Очир агсаны төрсөн өдрийг тохиолдуулан сурагчдад намтар уран бүтээлийг нь сурталчлах өдөрлөг, АХА зохиож найрагчийн ээжид хүндэтгэл үзүүллээ.

Үр дүн: Зохиолчидтой биечлэн уулзаж хүүхдүүд өөрсдийн сонирхсон асуулт, шүлэг зохиол хэрхэн зохион бичих тухай мэдлэг мэдээллийг авсан

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НОМЫН САНГИЙН ДЭРГЭДЭХ АМЕРИКИЙН СОЁЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Америкийн Соёл Мэдээллийн төв нь бүх нийтийн Англи хэлийг сайжруулах зорилготой хөтөлбөрүүд, Англи ном уран зохиол, сэтгүүл болон өндөр хурдны интернэт, компьютерээр хангагдсан. Иргэдэд нээлттэй үнэ төлбөргүй үйл ажиллагааг явуулж байна. 2022 оны 1-2 саруудад Америкийн элчин сайдын хөрөнгө оруулалтаар барилгын засвар, тохижилтын ажлыг хийсэн бөгөөд 2022 оны 3-р сараас эхлэн мэргэжлийн Англи хэлний багш ажиллаж эхэлсэн. Тус төвд Англи хэл хөгжүүлэх хөтөлбөрөөс гадна Америк соёлыг түгээх үйл ажиллагааг тогтмол амжилттай явуулж байна.

- **Англи хэлний хөтөлбөр:**
  - **ABC English** - Анхан шатны англи хэлний сургалтыг тогтмол 7 хоногт 2 удаа явуулж байна. Сурагчдын тоо улам нэмэгдэж идэвхтэй оролцож байна.
  - **Тоглоомын өдөр** – Үдээс хойш хичээлтэй сурагчдад зориулж хичээлийн бус цагаар сурагчад англи хэлийг хөгжилтэй сурах боломжийг олгож тоглоомын цагийг 7 хоног бүр явуулж байна. Карт тоглоом болон Би хэн бэ тоглоомуудыг Англи хэлээр тоглож байна.
  - **Ярианы клуб** - Англи хэлний ярианы клубээр англи хэлээ сайжруулах сурагчид хамрагддаг. Бэлтгэсэн асуултанд хариулж ярилцах болон өөрсдийн бэлтгэсэн сэдвийн дагуу ярилцдаг.
  - **Дууны клуб** - Англи хэлийг дуугаар дамжуулж үгийн дуудлага сайжруулах зорилготой дууны клубыг явуулж байна. Сурагчид Англи хэлний сонсголоо болон хэллэгээ сайжруулахын тулд Англи дууг суралцаж гитар тоглох сонирхолтой сурагчдад гитартай дуулах боломжийг олгож байна
  - **Төслийн клуб –** Сурагчдын өөрсдийн сонирхолд тулгуурлан сар бүр хамтран бүтээлч үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь 10-р сард Төслийн клубын сурагчид гарын доорх материал ашиглан баярын чимэглэл хийсэн.

- **Үгсийн сангийн клуб** - Дунд болон ахлах ангийн сурагчид тайлбар толь бичиг ашиглан үгсийн сангаа нэмэгдүүлэхийн тулд тоглоомын аргаар үгсийн сангаа баяжуулдаг. Англи хэлний мэдлэгтэй сурагчдад Олон улсын англи хэлний шалгалтанд ирдэг үгс дээр ажиллаж үгийн нөхцөл, дагаварын даалгавар гүйцэтгэдэг.
- **"Хэлэлцүүлгийн клуб" –** АНУ-н засгийн газрын тэтгэлэгтэй FLEX ахлах ангийн сурагчдын хөтөлбөрийн 2021 оны төгсөгч Пүрэвдарь болон түүний Америк ээжтэй хамтран 7 хоног бүр хэлэлцүүлгийн клубыг өнгөрсөн 3 сараас хойш амжилттай явуулж байна.
- **Кино клуб -** Англи хэлээ кино үзэж сайжруулах зорилготой киноны клубыг явуулж байна. Бэлтгэсэн асуултын дагуу хэлэлцүүлэг хийх болон өөрсдийн сэтгэгдлээ англи хэлээр хуваалцдаг.

Америк соёл мэдээлийг түгээх зорилготой зохион байгуулсан үйл ажиллагаа

Junior Empowering Program

Junior empowering program гэдэг нь өсвөр насныхныг чадваржуулах хөтөлбөр бөгөөд орон нутгийн 10-12р ангийн сурагчдад болон gap year авсан сурагчдад зориулсан хөтөлбөр ба сурагчдад хувь хүний хөгжлийн мэдлэг олгох нийт 7 өдрийн хөтөлбөр юм. Мөн нэг өдрийн сургалт дунджаар 2-4 цаг үргэлжилдэг. Сургалтад нийт 15 хүүхэд хамрагдсан.

“CLEAN UP-2023”

Сайншанд хотын нийтийн их цэвэрлэгээнд ЕБ-ын 1,2,3,5,6-р сургуулийн 400 гаруй сурагч нэгдэж, хүүхэд залуучуудын хамгийн их цагийг өнгөрүүлдэг нийт 8-н багийн 38 тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнг цэвэрлэж, багаараа тоглож, дуулж, зургаа авхуулж, сайн дурын үйл ажиллагааны батламж гардуулж тус өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.

“Mysterio” хөтөлбөр.
Mesterio хөтөлбөр нь тусгайлан сонгосон сэдэв дээр сонгогдсон дадлагажигч нар илтгэл тавьж үүний дараа мэтгэлцээний сэдэв өгөгдөн илтгэгч болоод үзэгч сонсогчдын хамтаар мэтгэлцээн хийдэг хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр ердөө 4 сэдвийн хүрээнд 2 долоо хоногийн хугацаанд явагдсан. 6-р сарын 2,7,9,14- ны өдрүүдэд зохион багуулагдсан. 1 удаагийн хөтөлбөр ойролцоогоор 10-12 оролцогчтой явагдсан ба оролцогч иргэд, хүүхдүүд бусдад өөрийн санаагаа зөв илэрхийлэх, хүнтэй харьцах чадварыг **нэмэгдүүлэх зорилготой.**

Open Mic Night.
Энэ удаад Америкийн Соёл Мэдээллийн төв нь Сайншанд сумын иргэдэд хэдийн танил болсон Sainshand Cover-ийн хамт олонтой хамтран ажилласан. 6-р сарын21-ны үдэш Sainshand Cover-н хамт олны зохион байгуулдаг Open Mic хэмээх залуусын дунд явагддаг дууны хөтөлбөрт бид бүхэн очиж мэдээлэл хүргэх зорилготой байв. Тус үйл ажиллагаанд манай зүгээс хүүхдүүдээс Америк улстай хобоотой асуулт асуун зөв хариулсан оролцогчидод өөрсдийн гараар хийсэн аяган бялуу болон манай төвийн нэр бүхий цаасан наалт брошур зэргийг бэлэглэв.

Америкийн элчин сайдын яамнаас сайн дурын хөтөлбөрийн багшийг урьж хамтран ажиллав.
6-р сарын 21-нээс 7-р сарын 1-ны хооронд манай төвд Америкийн элчин сайдын яамны Фулбрайт хөтөлбөрийн англи хэлний туслах багш хатагтай Wen Wendt зочилон ажиллаж, үйлчлүүлэгч иргэдэд олон төрлийн англи хэл болоод, Америк улстай холбоотой мэдээ мэдээллүүдийг хүргэсэн. Түүнээс дурьдвал: - ахлах ангийн хүүхдүүд болон залуучуудыг хамарсан А.Н.У-д хэрхэн суралцах вэ? лекц , - багачуудад зориулсан англи хэл дээрх тоглоомын цаг, бүх насныханд зориулсан ярианы клуб зэрэг явагдав.

Дорноговь аймгийн Америкийн Соёл Мэдээллийн төв албан ёсны төв болсноо бататган санамж бичигт гарын үсэг зурсан.
8-р сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод болсон Америкийн элчин сайдын яамнаас зохион байгуулсан “Америкийн Нэгдсэн Улсын тусгаар тогтносон түүхт 247 жил”-ийн баярын арга хэмжээнд АСМтөвийн хоёр ажилтан Н. Мөнхгэрэл, О. Баярмаа нар Дорноговь аймгийн Төв номын сангийн захирал А. Байгалмаагийн хамтаар уригдан оролцоод ирсэн билээ. Тухайн үйл ажиллагааны үеэр Дорноговь аймаг дахь АСМТөвийг албан ёсны төв болсныг бататган захирал А. Байгалмаа болон Америкийн элчин сайд Ричард Бунгуан нар төвийн цаашдын үйл ажиллагаа явуулах тухай санамж бичигт гарын үсгээ зурцгаалаа.

Төвийн оффистоо “Maker Space” өрөө гаргах засвар үйлчилгээний ажил явагдав.

Тухайн сарын 14-оос 27-ны өдрүүдэд оффисын барилгад өрөө нэмж гаргах засварын ажил хийгдлээ. Тус өрөөг бид ‘Maker Space” өрөө болгож тохижуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд энэхүү өрөө нь компьютер, оёдлын машин, 3D хэвлэлийн машин зэрэг хүүхэд залуусын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн өрөө болох юм. Maker Space Room нь Улаанбаатар дахь АСМТөвийн хамгийн идэвхтэй, олон үйлчлүүлэгчтэй хөтөлбөрүүдийг зохион байгуулдаг хэсэг бөгөөд АСМТөвүүдэд зайлшгүй байх хэрэгтэй хэсэг гэж үздэг

“Монгол хэл, бичгийн үг үсэглэлийн тэмцээн”

34 дэх удаагийн “Илүү их уншъя” уриатай Номын баярын өдрийг тохиолдуулан манай төв Дорноговь аймгийн Ерөнхий боловсролын 1,2,3 болон 5 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд монгол хэл болон үндэсний бичгийн үг үсэглэлийн 4 шатлалт тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Энэхүү тэмцээнд 3-р сургуулийн сурагчдын баг тэргүүн байр эзэлж, 1-р сургуулийн баг удаалсан билээ. Тэргүүлсэн багуудад багц ном болон Талархлын бичгийг дурсгав. Тус үйл ажиллагаа 9-р сарын 14-ны өдөр зохион байгуулагдсан.

БУСАД АЖИЛ

- Мөн байгууллагынДОРНОГОВЬ ТӨВ НОМЫН САН фэйсбүүк группт Д.Данзанравжаагийн түүвэр зохиол, шүлэг Д.Равжаагийн сургааль, ерөөл магтаал, Адууны тамга дүрс, угийн бичиг хөтлөх, монгол хэл соёлыг таниулах, эзэмшүүлэх зорилгоор хэлц үг, зөв бичгийн журмалсан үг, үндэсний бичгээр 19 үг, монгол хээ угалзын тухай зурагт мэдээлэл, мөн хамтдаа шалгая, хамгаалъя, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай гэх мэт нийт 4 видео бичлэг, 59 зурган постер зэрэг 1396 мэдээллийг бэлтгэн байршуулж 12296 хүний хандалт авсан.
- Соёлын бүтээлч сар"-ын үйл ажиллагаанд үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэн ажиллах хүрээнд "Үндэсний бичиг" ийн анхан шатны сургалтад насан-туршийн боловсролын төвтэй хамтран байгууллагын 13 албан хаагч хамрагдан суралцсан. Мөн аймгийн Засаг даргын тамгын газраас “Үндэсний бичгийн хөтөлбөр 3” үндэсний бичгийн цахим бичвэр боловсруулах 2 удаагийн сургалтад 6 албан хаагчийг хамруулан ажиллаа.

- Соёл олон нийтийн ажлыг шинэлэг олон талт хэлбэрээр зохион байгуулан ажилласан. Байгууллагын ажилчдын төлөвлөгөөнд тусгагдсан СОНА-ууд болон уламжлалт ажлуудаа зохион байгуулан ажиллаж нийт 69 төрлийн ажилд 7339 хүн хамрагдсан.

- Сэлбэн засах шаардлагатай 1094ш ном болон сонин сэтгүүлийг сэлбэ н засах /ажлыг хийж гүйцэтгэсэн. /Ном 565ш, Сонин сэтгүүл 529ш/
- Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан Говийн бүсийн ахмад настаны төрөлжсөн асрамжийн газрын 21 ахмадуудад ардын өв соёл, ёс заншил, танин мэдэхүйн мэдээлэл хүргэн ая дуу өргөн мэндчилгээ дэвшүүлсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зөөврийн 180ш номоор үйлчилсэн.
- Иргэдийн боловсролд нэмэр болох зорилгоор номын сангийн орчин нөхцөл тав тухыг сайжруулан Соёлын яамнаас үр дүнд суурилсан санхүүжилт болох 14сая 800 төгрөг олгосоноор насанд хүрэгчдийн уншлагын танхимыг иж бүрэн тохижуулсан.



АРГА ЗҮЙН АЖИЛ:

- Сумдын номын санч нартай сар бүрийн эхэнд цахимаар холбогдож арга зүйн зөвөлгөөг өгөх хамтран ажиллах санал авах, хэрхэн ажиллах талаар санал хүсэлт авч харилцан ярилцаж хэвшсэн. 6 удаа цахим уулзалт хийж Давхардсан тоогоор нийт-62 номын санч хамрагдсан байна. Дорноговь аймаг дах Төслийн ажил хариуцсан ажилчдад мэргэжлийн ажлын талаар арга зүйн зөвөлгөөг өгсөн. Мөн Даланжаргалан, Хатанбулаг, Эрдэнэ, Улаанбадрах, Айраг, Хөвсгөл зэрэг сумдуудад биечлэн очиж ажил байдалтай нь танилцаж арга зүй зөвөлгөөг өгсөн. Нийт сумдад давхардсан тоогоор цахимаар болон утсаар 58 удаа арга зүйн зөвөлгөөг өгч ажилласан байна.
- Ажилчдын гүйцэтгэлийн үнэлгээг гаргаж материалыг бүрдүүлсэн. Ажилчдын ур чадварыг үнэлсэн баримтыг бүрдүүлсэн. Ажлын байрны тодорхойлолт шинэчлэгдсэнтэй холбогдуулан бүх ажилчдын тодорхойлолтыг шинэчилж даргаар батлуулан хувийн хэргийн хавтасанд байршуулсан.
- Сумдын номын санч нар “анхан шатны бүртгэл хөтлөх”,”СОНАжил” сэдэвт сургалтыг цахимаар зохион явуулж 28 хүн хамрагдсан.
- Мөн номын санч нарын заавал мэдэж байх мэргэжлийн холбогдолтой гарын авлага бэлтгэж сумдын номын санч нарт хүргүүлсэн. Нийт 56 номын санчид хүргүүлсэн.
- Программд байсан нийт номноос 2022 онд актлагдсан 17808ш номыг нэг бүрчлэн хасалт хийж цэгцэлсэн.
- Соёлын яамнаас зохион байгуулсан “цахим иргэн” сургагч багшийн сертификаттай сургалтанд 4 удаа хамрагдаж шалгалтаа өгч тэнцэн сургагч багшийн эрхийн бичгээ арга зүйч Г.Баттогтох хүлээж авсан.

Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ ДОРНОД АЙМГИЙН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ БА ТОВЧ АГУУЛГА

2.1. Мэдээллийг нээлттэй хүргэх түшиц газар байна
2023 онд “Цахим номын сан”-ийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан.

2.2. Номын сангийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж 2023 онд “Цахим номын сан”-ийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх” зорилт дэвшүүлэн, программ хангамжийг нэмэгдүүлэх, хөгжүүлэлтийг сайжруулах, баг хамт олныг бүрдүүлэн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж ажиллалаа.

2.3. Байгууллагын зорилго, зорилт үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх биелүүлэхийн тул зохион байгуулалтын нэгжүүдэд нягт уялдаа холбоотой ажиллан төлөвлөн гүйцэтгэн мэдээг тайланг хянан шийдвэрлэсэн.
Холбогдох хууль дүрэм журмыг мөрдлөг болгон хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журам, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг батлан гарган, номын санчид, албан хаагчдын дадлага туршлага мэргэжлийн ур чадварт тулгуурлан хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын байран дээр сурч хөгжих боломжийг бүрдүүлэхэд голлон анхааран ажилласан.

2.4. Номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэн Цахим номын сан ажиллуулан нийт 864 ном зохиолыг оруулж шинэ үйлчилгээг нэвтрүүлээд байна. Мөн энэ үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Цахим номын сангийн уралдааныг аймгийн төвийн ЕБС-ийн 1-12р ангийн сурагчид, багш, нийгмийн ажилтан, Номын санчдын дунд амжилттай зохион байгуулсан.

2.5. Байгууллагын 2023 оны статистик мэдээг батлагдсан маягт үзүүлэлтүүдийн дагуу үйл ажиллагааны, ажиллагсдын, хөрөнгө санхүүгийн мэдээг хүснэгтийн дагуу тайлан мэдээнд үндэслэн гаргасан.

Статистик мэдээний нэгтгэлийг 2022 оны үзүүлэлттэй харьцуулахад

Үзүүлэлт	2022	2023	Өсөлт, бууралт %
Ном олголт	99121	120185	1.2
Иргэсэд	72675	76523	0,9
Уншигч	5588	6376	1.1
Лавлагаа	2328	1111	0,4
Татгалзал	380	214	0,5
Сургалт, семинар, уралдаан тэмцээн	84	168	0,5
Гэрээр ном олгох үйлчилгээ	13880	11153	0,8
Цахим үйлчилгээ	4031	21445	5.3
Номын баяжилт	284	162	0,5

Дээрх үзүүлэлтээс харахад ном олголт 1.2%, иргэсэд 0.9%, уншигч 1.1, цахим 5.3 хувиар тус тус өссөн.
Гэрээр ном олгох үйлчилгээ 0,8 хувиар буурсан нь уншигчид манайхаас цахимаар авах үйлчилгээ нэмэгдсэнтэй холбоотой. Мөн төсөвт шинээр ном авах зардалгүйгээс

шалтгаалан сан хөмрөгийн баяжилт хийгдээгүйгээс гэрээр ном олгох үйлчилгээ буурсан хэдий ч цахим Номын сантай болсноор цахим уншлага 5.3%-иар өссөн нь шинэлэг үйлчилгээ нэвтрүүлсэнтэй холбоотой

НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

3.1. Сан хөмрөгийн бүрдүүлэлтийг 2023 оны байдлаар худалдаа болон хандивын ном, хэвлэл захиалгаар бүрдүүлсэн.
2023 оны байдлаар 101 нэрийн 124 ширхэг 2.029.400 төгрөгийн номыг бэлэг хандиваар, 26 нэрийн 28 ширхэг 464000 төгрөгийн номыг худалдаагаар бүрдүүлсэн. Хэвлэл захиалгаар 16 нэр төрлийн 800400 төгрөгийн хэвлэл захиалсан.

Фондын эргэлт 1,5 хувь байна.

3.2. Номын сангийн сан хөмрөгт үнэлэлт, дүгнэлт хийж судалгаа хийсэн эсэх,
Аймгийн төв Номын санд хадгалагдаж буй 2261 эртний судар номд тусгай дугаар шифр өгч цахим хэлбэрт оруулан судрын он тоолол, хэмжээ, гэмтэл зэргийг тодорхойлох ажлыг хийж дуусгасан. Уг ажлыг Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн багш нийгмийн ухааны Доктор (PH.D) дэд профессор, төвд эрдэмтэн Д.Ганболд багштай хамтран хийж гүйцэтгэсэн.

3.3. Номын сангийн тооллого, хадгалалт хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар: номын сангийн сан хөмрөгийн бүртгэл тооллого хийх журмын дагуу 2023 онд ээлжийн бус тооллогыг нийт 3 удаа, тооллогын комисс томилон Нийтийн уншлагын танхимд 1 удаа, хүүхдийн уншлагын танхимд 2 удаа бар кодоор тоолох аргаар хийж, ном тоолсон тухай актыг гаргасан болно.

НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Уншигчдад номын сангаас үзүүлж буй үйлчилгээ болон номын сангийн үйлчилгээний инновац, нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлсэн эсэх
Технологийн дэвшлийг ашиглан Номын сангийн үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэх, уншлага үйлчилгээг нэмэгдүүлэх, алслагдсан багийн иргэд, хүүхэд багачууд, олон нийтэд хүргэх зорилгоор Цахим номын сангийн үйл ажиллагааг шинээр нэвтрүүлээд байгаа билээ. Нийт 868 ном зохиолоос бүрдсэн тус сайтыг маань 21445 хүн нэвтэрч орж үзсэн тоо баримт гарсан.

4.2. Номын сангуудад шаардлагатай төсөл-хөтөлбөр боловсруулсан эсэх

Монгол улсын Соёлын яамны санхүүжилтээр Дорнод аймгийн төв Номын санд цахим номын сангийн танхим нээгдлээ. Тус танхим нь цахим орчинд маш хурдтай ажиллах орчин үеийн иж бүрэн 2 суурин компьютер 2 явуулын компьютер, 3 үйлдэлтэй хэвлэгч, 3 киндл төхөөрөмжтэйгөөр үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

Цахим номын сан нь одоогоор 900 орчим номтой бөгөөд хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх техник, технологийн дэвшлийг ашиглан хүүхдийн ном унших сонирхлыг бий болгох номын сангийн уншигчдын тоог нэмэгдүүлэхэд ихээхэн үр дүнтэй хөрөнгө оруулалт боллоо.

Шинээр нээгдсэн цахим уншлагын танхимд хүүхдүүд анги бүлгээрээ ирж ном унших байдал ихэссэн бөгөөд ихэнхдээ танин мэдэхүйн болон уран зохиол, хүний

хөгжлийн тухай зохиолыг илүү уншиж байна. Мөн ном сурах бичиг дутагдалтай байдгаас шалтгаалан гэрийн даалгавраа хийх боломж бүрдэж байгаа нь харагдаж байна. Энэхүү танхимаар үйлчлүүлэгчдийн тоо ихэссэнтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн номын санчдад хуваарь гарган үйлчлүүлж байна.

4.3. Соёл олон нийтийн ажил зохион байгуулсан эсэх
Соёл, танин мэдэхүйн ажлуудаа аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.
Соёлын бүтээлч сар аяны хүрээнд 10 төрлийн соёл олон нийтийн ажлыг зохион байгуулж, 943 уншигч хамрагдсан.

Д/Д	Соёл олон нийтийн ажил	Давтамж	Хамрагдсан хүний тоо
1.	Уралдаан тэмцээн	13	491
2.	Номын үзэсгэлэн	47	4569
3.	Талын найраг	1	120
4.	Үлгэрийн цаг	75	1200
5.	“Ном хожъе”	15	348
6.	Хэлэлцүүлэг	6	229
7.	Аглагхан талаасаа Яруу найргийн наадам	1	400
8.	Тал нутгийн соёл арга хэмжээ	1	560
9.	Номын баяр	2	2450
10	Эх хэлээ дээдэлье	2	950
11	Соёлын бүтээлч сарын аян	1	943
	Нийт	164	12260

Дорнод монголын их шүлэгч, олноо эрээн цавийн хэмээн алдаршсан Данзангийн Нямсүрэн агсны нэрэмжит “АГЛАГХАН ТАЛААСАА” яруу найргийн анхдугаар наадам, Утгын чимэг-2023 богино өгүүллэгийн наадмуудыг зохион байгууллаа.

4.4. Ном уншилтыг сайжруулах. Уншлагын төвүүдийг зохион байгуулах, үйл ажиллагааг нь зохицуулах ажил хийсэн эсэх

“НОГООН НОМЫН САН”
Номын сангийн гадаах талбайд “НОГООН НОМЫН САН” байгуулж хүнд ээлтэй дан мод, элс хайрга, ногоон зүлэг, дугуйн зогсоол, сандал, хогийн сав байршуулан, “Та авч болно, өгч болно” номын буланг шувууны үүр хэлбэртэй хийснээс гадна үнэгүй wifi ашиглуулан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн гацуур, агч, наранцэцэг зэрэг модыг тарьж ургуулсан. Энэ номын сангаар дамжуулан уншлага үйлчилгээг өргөжүүлж, номын сангийн ирэгсдийн тоог нэмэгдүүлэх бүх насны хүмүүст зориулсан соёлын боловсролыг тасралтгүй тогтвортой хангаж ажиллаж байна. Уг номын сан 3.2 сая төгрөгийн төсвөөр хийгдсэн.

“БААСАН ГАРАГТ БАЙГАЛЬД УНШЪЯ” арга хэмжээ
7 хоног бүрийн Баасан гарагт байгальд уншъя” арга хэмжээг Найрамдал цэцэрлэгт хүрээлэнд 5 удаа зохион байгуулж 2700 гаруй хүнд хүрсэн.

Үйл ажиллагаа.

- Хүүхдэд зориулсан оюун ухааны тоглоом, монгол гэр барих явцыг гэр бүл найз нөхөд анги хамт олны дунд
- Номын үзэсгэлэн /Хүүхдийн шинэ ном/
- Англи хэлний сургалт 2 удаа Балжмаа багштай хамтран зохион явуулсан.
- Байгаль эх дэлхийгээ хайрлах хамгаалах талаар зөвлөмж бэлтгэн хэвлэж 800 хүнд сурталчилсан.
- Номын богц гэрээр авч явах үйлчилгээ /10ном/ Гэр бүлд зориулсан номын богц
- Номын сангийн үйлчилгээ, карт нээх ажлыг 300 гаруй хүүхдэд үзүүлсэн

4.5. Алслагдсан хэрэглэгчдийн үйлчилгээг зохицуулсан байдал
Цахим номын санг Дорнод аймгийн төвөөс зайдуу Чулуунхороот, Халх гол сумын Соёлын төвийн номын санчид хэрхэн ашиглах түгээх зааврыг танилцуулан үйл ажиллагааг нутагшуулан ажилласан.

4.6. Зөөврийн үйлчилгээ зохион байгуулсан эсэх
Номын сангийн тухай хууль болон БСШУ-ны Сайдын 2010 оны 570 дугаар “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу 32 удаа 3497 ширхэг номоор үйлчилгээ үзүүллээ.
Алслагдсан сумын иргэдэд Нийгмийн цогц үйлчилгээг, ЕБ-ийн сургууль, албан байгууллагуудад зөөврийн үйлчилгээг нийт 34 удаа 4504 иргэнд 6083 ном олгож үйлчилсэн. Солилцоогоор 5,8 дугаар сургууль, ДИС, Сүхбаатар, Хэнтий аймгийн Нийтийн Номын сан, Баян-Уул сумын нийтийн номын сангаас нийт 24 ном солилцон 60 уншигчид олгосон.

4.7. Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал
Дорнод аймгийн хүүхдийн уншлагын танхим нь ойрын фонддоо 10000 орчин номтой бөгөөд 2023 онд 2406 шинэ уншигч бүртгэн 54512 ирэгсдэд 64786 ном олгон үйлчилсэн. 237 хүүхдэд 489 лавлагааг өгч, гэр бүлийн богц үйлчилгээг 53 удаа, 424ш номоор хүргэсэн байна.

Хүүхдийг багаас нь номтой нөхөрлүүлэх, номд дуртай болгох зорилгоор Дорнод аймгийн 4 дүгээр цэцэрлэгт Номын санг байгуулсан.

- Хүүхдийн уншлагын танхимаас ном солилцоогоор авч унших
- Хүүхдүүд номын богцыг гэрээр унших
- Анги удирдсан багш нар цахим номын санд орсон бүтээлүүдийг хүүхдүүддээ сонсгох, ном уншиж, үлгэр ярьж өгөх
- Ном унших гэр бүлийн цагтай болно

Номын сангаа цаашид өргөжүүлэх номын фондыг нэмэгдүүлэх эцэг эхчүүдтэй хамтран ажиллах боломж бүрдэж байна.
Номын санд ирж амжихгүй, гэр хол хүмүүст хүүхдүүдээр нь дамжуулан гэртээ ном унших, номын сангийн үйлчилгээ авах нөхцөлийг 4 дүгээр цэцэрлэгийн багш нартай хамтран бий болгосон. Цаашид олон цэцэрлэгүүд номын сантай болох, хамтарч ажиллах хүүхэд рүү чиглэсэн оюунлаг ажил боллоо.

4.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал
Хөгжлийн бэрхшээлтэй 45 хүнд карт нээж 150 ном олгосон, тусгай бүлгийн 16 уншигчид карт нээж 59 номоор үйлчилгээ хийсэн. Гэрийн асаргаанд байдаг 201 иргэнд Богцоор 263 ном олгосон.

4.9. Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн эсэх /Энэ хэсэгт номын сангийн үйл ажиллагааны бусад чиглэлийг мөн тусгаж болно. Үүнд: иргэний эх оронч хүмүүжил олгох, соёлын харилцаа, эрүүл амьдралын хэвшил, хүрээлэн буй орчны боловсрол, гоо зүйн хүмүүжил болон бусад/

- “Цахим номын сан”-гийн үйлчилгээг сошиал орчны группт шээрлэх, лайв хийх, Хэрлэн сумын ЕБС-ийн сургуулиудад сурталчлан таниулснаар гаруй уншигчтай болж уншлага үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.
- Албан хаагчид ажлын байрандаа сурч хөгжих боломж бүрдсэн.
- Соёл олон нийтийн ажлын хүртээмж / Ном хожъё, Үлгэрийн цаг г.м / өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн.
- Үр дүнд суурилсан санхүүжилтийг шийдвэрлэснээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад үр нөлөө өгсөн.
- 2024 оны аймгийн ИТХурлаар байгууллагын гадна пассат 116 сая төгрөг, Гэр бүлийн уншлагын танхимыг тохижуулахад 40.400,0 төгрөгийн санхүүжилтийг батлуулсан.
- Өмнөх онтой харьцуулахад цахимаар үзэх уншигчдын тоо нэмэгдсэн.
- Соёл урлагийн шилдэг ажилтан шалгаруулах болзолт уралдаанд ажилтнаа оролцуулж ажил мэргэжлийн онцлогийг харуулах, бидний өдөр тутмын үйл ажиллагаанаас гадна зорилтот бүлгийн иргэдэд хүрч очих, тэдэнд соёлын боловсрол олгох ажлуудыг хийсэн.
- Номын сангийн үйлчилгээг шинэлэг байдлаар ард иргэдэд ойртуулан тэдний сонирхлыг татахуйц хэлбэрээр хийж “Баасан гарагт Байгальд уншъя”, Ногоон-номын сан, “Би шувуу ажиглагч аялал”, Номын богц гэрээр хүргэх үйлчилгээ зэрэг ажлууд 5200 хүнд хүрч Номын сангийн үйлчилгээ олон нийтэд илүү их нээлттэй болсон.

ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1. Номын сангийн үйл ажиллагаанд лавлагаа номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, нэвтрүүлэхэд чиглэгдсэн ажлын талаар
Номын сангийн нийтийн уншлагын танхимд уншигчдад зориулсан цахим орчинд ном хайх хайлтын компьютер байрлуулан ажиллаж байна.
Уншигч үйлчлүүлэгч иргэдэд Номын сангийн лавлагааг цахимаар-271, ном зүй-182, тодотгосон-276, сэдэвчилсэн 345 лавлагаа өгсөн. Сэдэвчилсэн болон зохиолчдын ойн үзэсгэлэнг 47 удаа 1309 номоор гарган 765 хүнд үйлчилсэн.

5.2. Ганцаарчилсан хэрэглэгч болон үйлчлүүлэгч байгууллага, хамт олныг мэдээлэл-номзүйн үйлчилгээгээр хангасан байдал
Зөөврийн үйлчилгээг нийт 15 байгууллагад хүргэн ажилласан бөгөөд аймгийн төв номын санд байгаа бүхий л төрөл ангийн номзүйн мэдээг хүргэн ажилласан. Мөн зохиолчдын ойтой холбоотойгоор хэвлэн гаргасан санамж өгөх номзүйн гарын авлагыг уншигчдад танилцууллаа. Нийт 2 санамж өгөх номзүй / Хүүхдийн аман зохиолын номзүйн мэдээг тавигдах шаардлага стандартын дагуу бичиж гаргасан болно./

ДОЛОО. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1. Номын санд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, технологийн үйл ажиллагааг хэрэглэгчдэд хүргэхэд чиглэгдсэн ажлуудын талаар;

1. **Номын сангийн интернэт, дотоод сүлжээний хэвийн ажиллагаа**

- Шаардлагатай байрлалуудад router, switch нэмж суурилуулах, сүлжээний утас татах зэргээр байгууллагын дотоод сүлжээг тасалдалгүй хэвийн ажиллах нөхцөлөөр ханган ажилласан.

2. Номын санчид болон бусад ажилтан албан хаагчдын компьютер, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх

- Номын санчдын компьютер, техник хэрэгслийг үйлчилгээнд бэлэн байлгахын тулд шаардлагатай үед техникийн болон программын засвар шинэчлэлт хийж ирсэн. Байгууллагын компьютерууддад үзлэг, оношилгоо хийж, ашиглах боломжгүйг актлахад бэлтгэх, сэлбэн засаж хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлуудыг хийсэн.
- Номын санчдыг сүүлийн үеийн программ апплекешний хэрэглээг сурч мэдэхэд зөвлөгөө өгч ажилласан.

3. Вэбсайт /dornod-library.mn/

- Байгууллагын үндсэн вэбсайтын байнгын ажиллагааг хянах, шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээ, шинэчлэлт хийж ирсэн.
- Үйл ажиллагааны мэдээ мэдээлэл байршуулах, цахим номын сантай холбох зэрэг ажлууд хийгдсэн.
- 7 - 14 хоног тутамд вэбсайтын нөөцийг хуулж авч хадгалах, хуучныг устгах ажил хийгдэж байгаа.

Цахим ном

- “Цахим номын сан” –д зориулж цаасан номыг цахимд хөрвүүлэх, интернэт орчин дахь цахим номуудыг татан авч засварлах зэргээр цахим номын нөөцөө нэмэгдүүлсэн. Өнөөдрийн байдлаар 868 ном, зохиолтой болоод байна.
- Өвөр Монголын зарим веб сайтаас үндэсний бичигт хөрвүүлэгдсэн үлгэр зохиолуудыг цахим номын сандаа зориулан засварласан.
- Ном тус бүрийг цахим уншигч төхөөрөмжид зориулан бэлтгэж байгаа. /2 төрлийн өргөтгөлд хувиргах, нүүр зураг бэлтгэх зэрэг.../

4. Цахим номын сан /dnom.mn/

- books.dornod-library.mn домэйн нэрээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн цахим номын сандаа dnom.mn домэйн нэр авч, тухайн 2 серверийн үйл ажиллагааг хянах, засварлах, шинэчлэх ажлуудыг хийсэн. /2 тусдаа вебхост худалдан авах зардалгүйн улмаас/
- Цахим номын сангийн веб сайтаа байнга шинэчилж, өнгө үзэмж, уншигчдад илүү хялбар, хүртээмжтэй байх тал дээр ажиллаж ирсэн. Жишээ нь хамгийн сүүлд 11 – 12 –р сард шүүлтэд ангилал нэмэх, уншигчид өөрийн номын сантай байх зэрэг шинэчлэл хийгдсэн.
- dnom.mn “Цахим номын сан” -ийн веб нь төлбөртэй гишүүнчлэлтэй учраас нөөцлөлтийг өдөр бүр хийж, хэвийн үйл ажиллагааг цаг алдалгүй хянаж байна.
- Цахим номын сандаа зориулсан www.fb.com/dnom.mn пэйж хуудас үүсгэн шинээр оруулсан номуудыг сурталчлах ажил хийгдэж байна.

5. **Хяналтын камер**

- Хяналтын камерын системийн хэвийн ажиллагааг байнга хянаж, шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх, өөрийн талаас боломжгүй тохиолдолд суурилуулсан байгууллагад хандаж засварлуулах ажлыг хийж гүйцэтгэдэг.

НАЙМ. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1. Номын санчдад аргазүйн зөвлөгөөг амаар болон биечлэн хүргэсэн байдал

Политехникийн коллежийн шинээр орсон номын санчид дараах чиглэлийн дагуу арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Үүнд: LIB4U номын сангийн автоматжуулалтын программд шинэ уншигчийг хэрхэн бүртгэх, хэрхэн эрх сэргээх, тооллого хийх, шинэ номыг хэрхэн бүртгэж оруулан бар код болон формулярыг хэвлэх, нийт сан хөмрөгийн бүртгэл хэрхэн хайх, шүүлтүүр хийх зэрэг арга ажиллагаануудыг зааж өгсөн.

Дорнод аймгийн Булган сумын шинэ номын санчид /мэргэжлийн бус/ номын сангийн анхан шатны мэдлэг олгох зөвлөгөөг өгч, номын сангийн тухай ойлголт болон номын санчдын өдөр тутмын бүртгэлүүдийг хэрхэн бүртгэх, тооллого хийх арга ажиллагааг зааж, аймгийн төв Номын сантай танилцуулан, каталоги болон номзүйн талаар ерөнхий ойлголт өгч ажилласан. Энэ үеэр Лавлагаа арга зүйн тасгаас гаргасан “Арга зүйн зөвлөгөө-2023” гарын авлагыг түүнд өгсөн.

8.2. Номын санд томилолтоор явж туршлага судалсан, аргазүйн туслалцаа үзүүлсэн болон дүн шинжилгээ хийсэн байдал (тоо, сэдэв, үр дүн).

Аймгийн Соёл урлагийн газрын дарга, аймгийн Номын сангийн захирлын 2023.01.16-ний өдөр баталсан “Дорнод аймгийн мэргэжлийн сургуулиуд, Төрийн цэргийн зарим байгууллага, Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулиудын номын сангийн үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөмж, чиглэл өгөх, хамтран ажиллах арга хэмжээний удирдамж”-ийн хүрээнд хувиар гарган ажиллалаа.

Үүнд: 1-р сургууль, 2-р сургууль, 5-р сургууль, 8-р сургууль, 11-р сургууль, 12-р сургууль, Хан уул цогцолбор сургууль, Шинэ хөгжил цогцолбор сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллеж, Дорнод их сургууль, Хилийн цэргийн 0132-р анги, Зэвсэгт хүчний 327-р ангиудын номын санчдад арга зүйн зөвлөгөө өгөн, ажил байдалтай танилцан дүгнэн, Соёл урлагийн газрын дарга болон Номын сангийн дарга нарын албан тооттой зөвлөмжийг дээрх номын сангуудад хүргэн ажилласан.

8.3. Мэргэжлийн аргачлал, зөвлөмж боловсруулсан эсэх,

Номын санчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, аливаа ажлыг үр дүнтэй чанартай гүйцэтгэхэд мэргэжлийн зөв суурь ойлголтыг алслагдсан хөдөөгийн болон мэргэжлийн ном байхгүй номын санчдад зориулсан өдөр тутамд шаардагддаг салбарын нэр томьёо, стандарт, шаардлагуудыг багтаасан түргэн хаах боломжтой гарын авлага материалыг Лавлагаа арга зүйн тасгаас “Арга зүйн зөвлөгөө” нэртэйгээр гарган номын санчдад өгсөн.

8.4. Мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулсан эсэх,

Дорнод аймгийн засаг даргын санаачлаагаар Соёл урлагийн газраас анх удаа “Соёл урлагийн шилдэг ажилтан” болзолт уралдааныг 3 үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд Номын сангийн нийтийн уншлагын танхимын номын санч М.Алимаа оролцож “Шидэг ажилтан”-аар шалгарч орон сууц худалдан авахад бодит дэмжлэг үзүүлэн 20,0 сая төгрөгийн шагнал авсан амжилттай байна.

8.5. Номын санчдад зориулсан сургалт семинар зохион байгуулсан байдал.

Номын санч, мэргэжилтнүүдэд орчин үеийн нийтийн номын сангийн шилдэг туршлагаас хуваалцаж, хэрэглэгч төвтэй үйлчилгээ, технологийн дэвшлийг ашиглан хамтран ажиллах боломжийн талаар сургалт, хэлэлцүүлэг явуулах, хүүхдийн номын фондыг баяжуулах зорилгоор "ХИЛ ХЯЗГААРГҮЙ НОМЫН САН" төслийг аймгийн Төв Номын санд 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр амжилттай зохион байгууллаа.
Сургалтад Дорнод аймгийн сумдын нийтийн номын санч, ЕБС-ийн номын сан, Их дээд, мэргэжлийн коллеж, цэргийн ангиудын номын санч нар нийт 37 номын санчид хамрагдсан.
Энэ үеэр номын санч мэргэжилтнүүдэд орчин үеийн нийтийн номын сангуудын шилдэг туршлагаас хуваалцаж, хэрэглэгч төвтэй үйлчилгээ, технологийн дэвшлийг ашиглан хамтран ажиллах боломжийн талаар сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж хүүхдийн уншлагын танхимын фондыг баяжуулсан.
-Австралийн Гадаад хэрэг, Худалдааны яамны төлөөлөгч Ашиш Нагеш,
-Австралийн ЭСЯ-ны Хөтөлбөр хариуцсан ахлах менежер Х.Өрнөх,
-Австралийн тэтгэлгийн төгсөгч, МНСХ-ны Гүйцэтгэх захирал М.Даваасүрэн,
-МУҮНС-ийн Ном бүрдүүлэх, боловсруулах, солилцох хэлтсийн дарга Г.Гүнжинлхам нарын бүрэлдэхүүнтэй ажилласан.
Сургалтын үеэр багийн гишүүд Номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцлоо.

ЕС. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

Байгууллагын “Албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр"ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө баталснаар ажилд томилох, сэлгэн ажиллуулах, сургалтад хамруулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, цалин хөлс, шагнал урамшуулал, нийгмийн асуудлыг шийдэх зэрэг бүхий л хэрэгцээг тодорхойлон ажилласан.

- Ажилтан бүрийн хөдөлмөрийн үр дүнг үнэлэн хамгийн бүтээлчээр

ажиллаж байгаа ажилтнаа урамшуулан цалин хөлс, нэмэгдэл ур чадвар, илүү цагийн хөлсийг олгон ажиллаж байна.

- Бие даан суралцах, мэдлэг эзэмшүүлэх сургалтад хамруулах, боловсролоо дээшлүүлэх, цалинтай чөлөө олгох зэрэг бүхий л нөхцөл боломжоор ханган ажиллаж байна.
- Ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт нь ижил нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхимын 2 номын санчийг хооронд нь сэлгэн ажлуулж байна.
- Ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хамт олны эерэг уур амьсгалыг бий болгох зорилгоор цайны өрөөг тохижуулан өдрийн хоолны зардлыг нэмэгдүүлэн өдрийн 8000 төгрөг болгон нэмэгдүүлсэн.
- Үр дүнгийн урамшууллыг улирал тутам олгон, үр дүнд суурилсан санхүүжилтээс албан хаагчдад урамшуулал олгосон.
- Нормын хувцас хэрэгслээр бүх албан хаагчдыг хангасан.
- “Хувийн хэрэг” аяны хүрээнд шинээр батлагдсан журмын дагуу албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийн анкетыг шинэчилсэн. Цаашид:
- Байгууллагын хэтийн болон ойрын төлөвлөгөөг хэрэгжүүлэх боловсон хүчний хэрэгцээ чухал байна. Үүнд: ном сэлбэн засах ажилтан, цахилгаанчин, сантехникч зэрэг орон тооны ажилтнууд.
- Аймгийн засаг дарга М.Бадамсүрэнгийн санаачилгаар анх удаа соёл, урлагийн ажилтнуудын дунд “Шилдэг ажилтан шалгаруулах болзолт уралдааныг зарлан 3 үе шаттайгаар зохион явуулж шилдэг ажилтнаар Номын

санч мэдээллийн ажилтан М.Алимаа шалгаран орон сууц худалдан авахад бодит дэмжлэг үзүүлж 20.0 сая төгрөгийн шагналыг гардан авсан.

Цаашид:
1. Ном хэвлэлийн зардал байхгүйгээс шинэ номын бүрдүүлэлт хийх боломжгүй.
2. Дээврийн болон сантехникийн их засварын ажлыг зайлшгүй хийж гүйцэтгэх шаардлагатай байна.
3..Жил бүр зохион байгуулдаг Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигтай, аймгийн Засаг даргын захирамжтай төлөвлөгдсөн арга хэмжээ болох “Номын баяр”-ийн үйл ажиллагааг дэмжиж төсөв хөрөнгө тусгуулахад СУГ дэмжлэг үзүүлэх.

10. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ
Байгууллагын 2023 онд улсын төсөв 322.179,6 төгрөг, орон нутгаас 18.754,3 төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэл .... зарцуулсан. Өр авлагагүй ажилласан. Төрийн Аудитаас санхүүгийн баримтын шалгалт хийгдэж ямар нэгэн зөрчилгүй дүгнэлт гарсан. Шилэн дансны мэдээллийг сар болгон тайлагнадаг. Санхүүгийн үйл ажиллагааг ОУНББСтандарт, төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад дүрэм журмын дагуу тайлагнасан.

2023 оны .... сарын байдлаар цалин, шагнал урамшуулалд нийт зардлын ... хувийг зарцуулсан. Хоолны зардалд сар бүр 168000 төгрөгөөр тооцон 17 албан хаагчдад олгож байна. Улирал бүр үр дүнгийн урамшуулал олгож байна.
Үр дүнд суурилсан санхүүжилт нийт 11.487,0 төгрөг ирсэн. Үүнээс урамшуулалд 1.723,0 төгрөгийг албан хаагчдад, багаж хэрэгсэлд 4.594,8 төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх зардал 3.446,1 төгрөг, бараа ажил үйлчилгээ 1.723,0 төгрөгийг тус тус зарцуулсан.

10. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ
Байгууллагын 2023 онд улсын төсөв 322.179,6 төгрөг, орон нутгаас 18.754,3 төгрөгийн төсөв батлагдсан. Өр авлагагүй ажилласан. Төрийн Аудитаас санхүүгийн баримтын шалгалт хийгдэж ямар нэгэн зөрчилгүй дүгнэлт гарсан. Шилэн дансны мэдээллийг сар болгон тайлагнадаг. Санхүүгийн үйл ажиллагааг ОУНББСтандарт, төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад дүрэм журмын дагуу тайлагнасан.

2023 оны 12 сарын байдлаар цалин, шагнал урамшуулалд нийт зардлын ... хувийг зарцуулсан. Хоолны зардалд сар бүр 168000 төгрөгөөр тооцон 17 албан хаагчдад олгож байна. Улирал бүр үр дүнгийн урамшуулал олгож байна.
Үр дүнд суурилсан санхүүжилт нийт 11.487,0 төгрөг ирсэн. Үүнээс урамшуулалд 1.723,0 төгрөгийг албан хаагчдад, багаж хэрэгсэлд 4.594,8 төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх зардал 3.446,1 төгрөг, бараа ажил үйлчилгээ 1.723,0 төгрөгийг тус тус зарцуулсан.

11. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА
Номын сангийн үйл ажиллагааны тайлан мэдээг улирал бүр хугацаанд нь хүргэн ажиллаж байна.
Соёлын хяналтын улсын байцаагч Б.Ганзориг 2023 оны 10 дугаар сарын 9-нөө 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр төлөвлөгөөт хяналт хийсэн. Хяналт шалгалтын явцад 5 алдаа дутагдал илэрснийг арилгуулахаар улсын байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 05-22/02-30/10 албан шаардлагын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
Дохиоллын бүрэн бүтэн байдлыг хэвийн ажиллагааг хангуулах, галын төлөвлөгөө, дүгнэлтийг хугацааг сунгуулах хүсэлтийг Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газарт 2023 оны 10 дугаар сарын 31-нд албан бичгээр хүргүүлсэн.

Гал унтраах галын хор 6 ширхэгийг захиалан авч, Нийтийн уншлагын танхим, гадаад фонд, жижүүрийн өрөөнд тус тус байрлуулсан.
9.1. Номын сангийн хүний нөөцийн өнөөгийн байдал, хангалт (Номын сангийн орон тооны ажилтны тоо, номын санчийн тоо, мэргэжлийн боловсон хүчний тоо /бүрдэлт/-ийг судалгаанд үндэслэж гаргасан байдал)
9.2. Хүний нөөцийг чадавхижуулсан байдал (сургалт, семинар, урамшуулал)
9.3. Номын санд ажиллагсдад тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар

Дорнод аймгийн төв Номын сан "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР" аяны хүрээнд Монгол ардын аман зохиол, үлгэр домог болон зохиогчийн эрхийн зөрчилгүй зохиол бүтээлүүдийг БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны Хөлөнбуйр аймгийн төв номын сантай хамтран хүүхэд багачууддаа түгээн дэлгэрүүлэх ажлыг хийж, номын санчид туршлага судаллаа.
Соёлын бүтээлч сар аяны хүрээн аймгийн Соёл урлагийн газар болон 12-р сургуулийн монгол хэлний багш Т.Одмандах, монгол бичгийн уран бичлэгийн дугуйлангийн сурагчдын бүрэлдэхүүнтэйгээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Шинэ барга баруун хошууны Ухуулга сурталчилгааны хэлтэстэй хамтран цахим номын сангийн ардын аман зохиолын төрлөөс хошууны хүүхэд багачуудад үзэж сонирхуулах, мөн монгол бичгийн үзэсгэлэн гаргах ажлуудыг 11 дүгээр сард амжилттай зохион байгуулсан.

Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймгийн Намын дарга Жан Шяобин нар 7,8,9-р сарыг "Алтан улирал" болгож энэ саруудад хамтын үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсний дагуу 8 сарын 04-06-ний өдрүүдэд Монгол улсын Дорнод аймаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймаг хоорондын гадаад хамтын ажиллагааны хүрээнд 2 аймгийн соёл урлагийн салбарын байгууллагууд хамтарсан тоглолт, уран зураг, уран бичлэгийн үзэсгэлэн гарган, Монгол хэл бичгийн багш нар, сурагчдын хамтарсан 80 гаруй бүтээлийн үзэсгэлэнг дэлгэсэн юм. Тус үзэсгэлэнд 12 дугаар сургуулийн Монгол хэл, бичгийн багш Ө.Одмандах, Хан-Уул сургуулийн Монгол хэл, бичгийн багш Т.Нармандах, 1 дүгээр сургуулийн Монгол хэл, бичгийн багш Э.Ганганмөрөн нар бүтээлээ дэлгэн Хянган аймгийн уран бүтээлчидтэй хамтарч уран бичлэгийн бүтээл туурвиж солилцов.

Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймгийн Утга Урлагийнхны холбооны орлогч дарга Бай юйлиньэр ахлуулсан уран бүтээлчид 30 гаруй бүтээлтэй ирж оролцон 20 бүтээлээ аймгийн Төв номын санд дурсгал болгон хадгалуулан үлдээв. Хоёр улсын хамтарсан үзэсгэлэнг нийт 100 гаруй хүүхдүүд үзэж сонирхсон байна.

12. ХАВСРАЛТ

Dnom.mn Цахим номын сан



Номын сангийн сан хөмрөгийн судалгаа

4.Сан хөмрөгийн мэдээ /тоо/

Үзүүлэлт	МД	Нийт сан хөмрөг	Хэвлэмэл ном	Брайл үсгийн ном	Хэвлэмэл бус	Тогтмол хэвлэл	Сан хөмрөгийн баяжилт	Заавал худалдан авах хувь	Худалдан авсан ном, хэвлэл	Солилцоогоор авсан ном	Хандив, тусламжаар ирсэн ном	Нөхөн бүрдүүлэлтээр авсан ном	Сан хөмрөгөөс хасагдсан	Акталсан	Сэргээн засварласан	Сэлбэн зассан	Цахим сан хөмрөгийн нийт тоо	Шинээр нэмэгдсэн цахим ном	Суудлын тоо
А	Б	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33
Нийт сан хөмрөг *мөр 1=мөр (2÷20)*	1	####	73715	72		1276	162		28		134					9440	868	253	252
Байгалийн шинжлэх ухаан	2	4193	4125			59	7				2								x
Техник	3	4070	4060																x
Хөдөө аж ахуй	4	3931	3926				5												x
Анагаах ухаан	5	3318	3293			17													x
Социологи, статистик, хүн ам зүй	6	1020	965			654	2												x
Түүх	7	3640	3625				15												x
Эдийн засаг	8	3732	3730				2												x
Улс төр	9	1941	1909			26	2		2		2								x
Төр эрх, хууль цааз	10	4121	4086	22			5		6										x
Цэргийн шинжлэх ухаан	11	218	218																x
Соёл, Шинжлэх ухаан, Боловсрол	12	4595	4593				2												x
Хэл шинжлэл	13	2356	2353				1		2										x
Аман зохиол, утга зохиол судлал	14	3119	2298			256	8		18	4	101								x
Уран зохиол	15	####	28961				89			20	29								x
Урлаг	16	1927	1860			264	1												x
Шашин	17	447	397	50															x
Гүн ухаан	18	2179	2170				9												x
Сэтгэл судлал	19	205	205																x
Лавлах судлал	20	957	941				16												x
Суудлын тоо	21	252	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	

БАЛАНСЫН ШАЛГАЛТ: Багана16=Багана(17+19+20+31); Багана21=багана(22÷26); Багана27>Багана28; Багана17> Багана29; Багана17> Багана30; Багана31>Багана32;

Тамга тэмдэг

Тайлан хянасан: Захирал /Албан тушаал/ Н.Алтанцэцэг /Нэр/ .... /Гарын үсэг/

Тайлан гаргаж нэгтгэсэн: Арга зүйч /Албан тушаал/ Ц.Оюунномин /Нэр/ .... /Гарын үсэг/

2024 оны 01 сарын 11 өдөр

Page 1

Цахим номын сангийн танхим

ДОРНОД МОНГОЛЫН ИХ ШҮЛЭГЧ, ОЛНОО ЭРЭЭН ЦАВИЙН ХЭМЭЭН АЛДАРШСАН ДАНЗАНГИЙН НЯМСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ “АГЛАГХАН ТАЛААСАА” ЯРУУ НАЙРГИЙН АНХДУГААР НААДАМ /зохиолч уншигчдын уулзалт /

Дэлхийн яруу найргын өдөрт зориулсан “Талын найраг” яруу найргийн уралдаан
Зөөврийн үйлчилгээ сургууль

Зөөврийн үйлчилгээ байгууллагад

Байгальд уншья

Тал нутгийн соёл

Арга зүйн зөвлөгөө



Ногоон номын сан

Ном хожъё

Номын баяр

Утгын чимэг-2023

Гадаад харилцаа

ДУНДГОВЬ АЙМГИЙН С.БУЯННЭМЭХИЙН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 ТҮҮХЭН ТОВЧООН

1946 онд Соёлын ордны дэргэд “Уншлагын газар” нэртэй, 2000 номтой байгуулагдаж Батнягт гэж эмэгтэй эрхлэгч-номын санчаар ажиллаж байв.

2002 онд МУ-ын ЗГ-ын 11 дүгээр сарын 20-ны өдрийн 237 дугаар тогтоолоор Алдарт гавьяат уранзохиолч С.Буяннэмэхийн 100 жилийн ойг тохиолдуулан их зохиолчийн нэрэмжит болсон. 43.0 мянга орчим номын хөмрөгтэй. Уншлагын 3 танхимтай: насанд хүрэгчдийн, хүүхдийн /”Гэр бүл танин мэдэхүйн танхим” хамт/ гэрээр ном олгох. Чөлөөт сонголтоор үйлчилдэг. “Дуудлагын номын сан” ажиллуулж танхимаар үйлчлүүлэх боломжгүй иргэдэд ном, хэвлэлийн үйлчилгээг хүргэдэг.

1.2 АЛСЫН ХАРАА

Уламжлалд суурилсан цахим үйлчилгээ, оюуныг дээдэлсэн нээлттэй номын сан байна.

1.3 ЭРХЭМ ЗОРИЛГО

Соёлын өв, оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, хадгалан хамгаалж, нээлттэй хүртээмжтэй мэдээллээр иргэдэд шуурхай үйлчилж, хойч үедээ өвлүүлэн үлдээнэ**.**

ХОЁР. ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ ТОВЧ АГУУЛГА

“ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ ЖИЛ - 2023” ЗОРИЛТЫГ ДЭВШҮҮЛЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТӨЛӨВЛӨН АЖИЛЛАЛАА.

2.1. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

“Номын сангийн үйлчилгээг орон нутгийн хүн амын 10-аас доошгүй хувьд хүргэж үйлчлэх” зорилго дэвшүүлж 5 арга хэмжээ, уншлагыг дэмжих 31 арга хэмжээ зохион байгуулсан. Шинэ уншигч 2855, 2022 оноос 21 хувиар өссөн, нийт ирэгсдийн тоо 21894 ба 2022 оноос 3 хувиар өссөн, ном олголтын үйлчилгээ 42718 ба 2022 оноос 4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.(график 1) “Дуудлагын номын сан”, “Танд ойрхон номын сан” зэрэг шинэлэг үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн эрчимжүүлж иргэдийн ном хэвлэлийн хэрэгцээг хангах ажлыг өргөжүүлэн тэллээ. (хавсралт 1, зураг 1) Тус үйлчилгээг 2023 онд 112 хүнд хүргэн 224 ном олгожээ. Алслагдсан иргэдэд зөөврийн номын сангийн үйлчилгээг 4 удаа хүргэсэн ба Политехник коллеж, ШШГГ, Адаацаг сумын нийтийн болон ЕБС, Өндөршил сумын нийтийн болон ЕБС, Мандал сургууль, ЭДЦС, Эрдэнэдалай сумын нийтийн номын сан зэрэг 9 байгууллага, сумдын номын сангуудтай ном солилцоо хийж (369 ном олгосон), мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн гэрээний үндсэн дээр хамтран ажиллав.

“Хил хязгааргүй номын сан” хөтөлбөрт амжилттай оролцсоноор 4 сая орчим төгрөгийн техник хэрэгслээр шагнууллаа.

“Ангийн номын санч” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр уншигч хүүхдүүдийн тоог өмнөх оныхоос 2 хувиар нэмэгдүүлсэн байна.

ГУРАВ. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

“Сан хөмрөгийн баяжилтыг чанартайгаар бүрдүүлэн жил бүр 5-аас доошгүй хувиар нэмэгдүүлж, хадгалалт хамгаалалтыг сайжруулна” зорилгыг дэвшүүлэн 12 арга хэмжээг зохион байгууллаа. Үндсэн фонд, тогтмол хэвлэлийн фонд, 3 уншлагын танхим

дэргэдээ ойрын фондтой. Эдгээрт нийт 43000 номыг хадгалан 21 хувийн эргэлттэйгээр 2023 онд уншигчдад үйлчилсэн байна. Номыг шинжлэх ухааны төрөл анги, үсэг дараалллаар стандартын дагуу байрлуулдаг ба хүүхдийн уншлагын болон гэрээр ном олгох танхимуудын сан хөмрөг чөлөөт сонголттой. Сан хөмрөгийн баяжилтыг худалдан авалт, бэлэг хандив, нөхөн бүрдүүлэлтээр хийдэг ба 2023 онд 174 ширхэг номыг 3,416,600 төгрөгөөр худалдан авч, хандивын журмаар 91 нэр төрлийн 121 ширхэг 1,835,250 төгрөгийн номыг хүлээн авч бүртгэн нийт 5,251,850 төгрөгийн 295 номоор сан хөмрөгийн баяжилт хийсэн байна. 892,400 төгрөгийн 13 нэр төрлийн сонин сэтгүүлийг захиалж тогтмол хэвлэлийн сан хөмрөгөө баяжуулсан. "Ном хандивлах сайхан" эвентийг Улаанбаатар хот дахь Дундговь нутгийнхан, аймгийн төрийн байгууллагуудын дунд зохион байгуулж, үүний хүрээнд "Нэг алба хаагч нэг ном", "Нэг чихэр нэг ном" аяныг тус тус өрнүүлэн төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн алба хаагчдыг хандивын аянд нэгдүүлж ажиллалаа. Хандивт 11 байгууллагын 191 алба хаагчид хамрагдсан. Үүний үр дүнд өөрийн сан хөмрөгийг болон сумдын номын сангуудын сан хөмрөгийн баяжилтыг 3 хувиар нэмэгдүүлсэн байна.
2021 оноос шинээр байгуулж буй Төвөд номын сан хөмрөгийг 139 номоор баяжуулж Дашгэмпилэн хийдийн дэмжлэгээр номын тавиур, ховор судрын шогол зэргийг хийсэн. Сан хөмрөгт зайлшгүй хадгалагдах төвөд хэл дээрх болон монгол хэл дээрх төвөд судлалын номын судалгааг төвөд судлаачийн тусламжтайгаар хийж байна.
Номын санд хөтлөгдөх бүртгэл, дансыг стандартын дагуу хөтлөх, бүртгэх, тооллого хийх, хадгалалт хамгаалатыг сайжруулах зорилгын хүрээнд 6 арга хэмжээ зохион байгууллаа. "Дундговь Ариусгал" ариутгалын байгууллагатай гэрээ байгуулан 2 удаа стандартын дагуу ариутган, тоосжилтыг багасгах зорилгоор чийгшүүлэлтийг тогтмол хийдэг. Төлөвлөгөөт бус 2, хяналтын тооллогыг 1 удаа хийж үр дүнг тооцож ажиллалаа. Байгууллагын 97 ширхэг нэг бүрчилсэн бүртгэлийг LIB4U програмтай тулган баталгаажуулав. Уншигч алдаж үрэгдүүлсэн номын төлбөрийг 4 номын санчийн тусламжтайгаар 100% барагдуулав. Ном орлуулах аргаар төлбөр барагдуулах 3 удаагийн актын шийдвэрийг хэрэгжүүллээ. Үүнд: 11 номын санчийн 233 ширхэг 802,623₮-ийн номыг 1,304,430₮-ийн номоор орлуулан тооцсон байна. Номын санчдын өдөр тутмын анхан шатны бүртгэл хөтөлгөөг 6 удаа, тоон төлөвлөгөөний биелэлтэд улирал бүр хяналт хийж ажилласан.

ДӨРӨВ. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

26 удаагийн соён гэгээрүүлэх, 5 удаа уншлагыг дэмжих олон талт үйл ажиллагааг зохион байгуулан 4217 уншигч, иргэдийг хамрууллаа. Үр дүнтэй ажлуудаас дурьдвал: "Ангийн номын санч хөтөлбөр", "Дуудлагын номын сан", "Уншлагын цаг", "Аймгийн тэргүүний уншигч","Мөнх тэнгэрийн бичиг-2023 сайхан бичигтэн уралдаан", "Уншигч зохиолчийн уулзалт", "Өглөөний номын хэлэлцүүлэг", "Эртэч номын хүүхдүүд клубийн үйл ажиллагаа", "Бяцхан болор цом уралдаан", "Ном таая" залуучуудад зориулсан танин мэдэхүйн өртөө, "Номтой гэр бүлийн болзоо", "Залуус хамтдаа өдөрлөг", "Уран үгсийн чуулган" яруу найргийн үдэш, "Номтой шинэ жил" шилдгүүдийг тодруулах ёслолын үйл ажиллагаа, "Номтой эко явган аялал", "Номын сангийн хишиг өдөр", "Олуулаа уншъя-Номтой нөхөрлөе" аян, "Миний уншсан ном дүрслэх урлагт", "Хамтдаа бүтээцгээе" говийн бүсийн чуулган, "Үндэсний бичиг үсгийн баяр", "Үлгэрийн цаг", "Ахмад настнаа сонсъё", "Адуучны өв соёл, айрагны баяр" аялал жуулчлалын эвент, "Монгол өв соёлын өртөө" зэрэг үйл ажиллагааг хүүхэд залуучууд, тусгай хэрэгцээт иргэд, төрийн алба хаагч, ахмадууд, малчдын дунд зохион байгуулсан нь соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хүртээмжтэйгээр хүргэснээрээ онцлог байсан ба оролцогчдын сэтгэл ханамжид нийцсэн ажлуудыг зохион байгуулсан нь судалгааны үр дүнд гарч ирсэн. Мөн эдгээр үйл ажиллагаагаар дамжуулан орон нутгийн иргэдийн ном

унших дадал хэвшилд нөлөөлөн эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулан ажилласан.
Аймгийн хараагаар бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран "Цагаан таягтны өдөр", "Нүд хуурайшилтаас хамгаалах сургалт"-ыг харааны бэрхшээлтэй иргэдэд, "Дэлхийн хүүхдийн номын өдрийг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд "Дүүрэн бэлэг" хүүхдийн боловсрол хөгжилд үйлчлэх төв НҮТББ, Аймгийн Төв номын сангийн Хүүхдийн уншлагын танхим хамтран "Дэлхийн хүүхдийн номын өдөр"-ийг тохиолдуулан "Хүүхдээс хүүхдэд төсөл"-ийн зорилтот хүүхдүүдэд өөрсдийнх нь онцлог, сонирхолд нийцүүлсэн өртөөчилсөн өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дуу хоолойг илэрхийлсэн зурагт постеруудыг хийж цахимаар сурталчлав. Тус үйл ажиллагаанд 56 хүүхдийг хамруулсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүрч ажиллах ТББ-тай хамтран тусгай хэрэгцээт иргэд хүүхдүүдэд үйлчилгээгээ хүргэж ажилласан сайн туршлага болов.

ТАВ, ЗУРГАА. ЛАВЛАГАА НОМЗҮЙ, ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Орон нутгийн лавлагаа ном зүйн ажлыг сайжруулахын тулд үндсэн сан хөмрөгийн зохион байгуулалтыг шинэчлэн Дундговь аймгийн холбогдолтой 2000 орчим номын тусгай фонд үүсгэн, уншигч болон 5 номын санч–мэдээллийн ажилтан, алба хаагчдад ном зүйн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх нөхцөл бүрдүүлсэн. Тусгай фонд үүсгэснээр 2023 онд 100 жилийн ой тохиож буй 5 сумын номд орох материалын лавлагаа, судалгааг шуурхай бэлдэж өгсөн.

2023 онд тэмдэглэлт ой тохиож буй ардын уран зохиолч Сормуунирширийн Дашдооровын 88, Дэлгэцийн урлагийн нэрт зохиолч Мишигийн Жавганы 85, МУСГЗ, Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэг, аюулгүй байдлын ухааны доктор, С.Буяннэмэхийн нэрэмжит шагналт зохиолч Жамбалын Цогтсугарын 65, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч Аюурбуньяагийн Лхагвын 60 насны ойд тус тус зориулан намтар уран бүтээл, ном зүйн гарын авлага 3-ийг бэлтгэн, цахимаар сурталчлан алдаршууллаа.

Төрөл ангийн каталогийг шинэчлэн зохион байгуулах ажлыг эхлүүлэн номын сангийн LIB4U программын тусламжтайгаар редакц хийн, Байгалийн шинжлэх ухааны 359 картыг шинэчлэн байршуулсан.

Уншигч, иргэдээс ирсэн 187 татгалзал, лавлагааг бүртгэн авсан ба үүний 55 хувийг бүрдүүлж, татгалзал ирүүлсэн уншигчдад тухай бүр утсаар болон цахимаар мэдээлэн уншигчийн эрэлт, хэрэгцээг шийдвэрлэж үйлчилсэн. Онцлох нь: Улаанбаатар хотын МУИС-ийн судлаач Н.Одхүүгийн судалгааны ажлын цахим лавлагаа болох 1991 онд хэвлэгдсэн "Дундговь аймгийн газар зүйн атлас"-ыг цахимжуулан хүргүүлсэн. Ингэснээр Дундговь аймгийн түүхэн газарзүйн зураг "Газарзүйн цахим номын сан" пэйж хаягт байрших боломжтой болж нутаг орноо сурталчлах нэг нөхцөл бүрдсэн. Тухайн ном нь аймгийн музей, номын сангийн сан хөмрөгт байхгүй байсан тул иргэдээс эрэл, хайлт хийн олж уншигчийн эрэлт лавлагааг барагдуулсан. Мөн тухайн номыг өөрийн сан хөмрөгт эх хувь болон цахимаар хадгалахаар бүртгэн авлаа.

Орон нутаг судлах картын сангийн баяжилтыг тогтмол хийж байна. Өдөр тутмын тогтмол хэвлэлээс 4800 мэдээллийг шүүж, картын санг баяжууллаа.

Шинэ номын үзэсгэлэнг 16 удаа 285 номоор, сэдэвчилсэн 28 удаа 2163 ширхэг номоор тус тус гаргаж нийт 2448 номоор үзэсгэлэн гаргалаа.

ДОЛОО. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 35 номын санг нэгдсэн системд холбох зорилго бүхий "Цахим номын сан" төслийг боловсруулж Соёлын яам, аймгийн ЗДТГ, ЮНЕСКО-ийн "Хүүхдийн сан"-д хүргэсэн. Тус төсөл нь аймгийн бүх төрлийн

номын санд ОУ-ын Коха програм нэвтрүүлэх замаар нэгдсэн системд холбож цахим үйлчилгээ явуулах зорилготой юм. Соёлын яам салбарын үндэсний портал бий болгож байгаатай холбогдон төслийг түр зогсоосон байгаа.

Орон нутгийн тогтмол хэвлэлийн 2800 талыг ҮТХЦНСанд байршууллаа. Үндэсний Тогтмол Хэвлэлийн Цахим Нэгдсэн Сангийн серверт засвар хийгдэж байгаа тул цахимжуулалтын ажил түр зогссон. 1958– 1970 оны “Чойбалсанч”, “Улаан туг” сонины 4315 талыг цахим файл болгоод байна.

“Дундговийн амьдрал” сонингийн 2018-2020, 2022 онуудын 648 мэдээлэл, “Боловсрол судлал” сэтгүүлийн 2019 оны 47 мэдээлэл нийт 695 мэдээллийг тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн сан “Зотеро” программд оруулан сонины бичилтийг хянан баталгаажуулж, МҮНС-руу илгээсэн. Мэдээлэл илгээсэн 21 аймгаас эхний 5 дугаар байрт эрэмблэгдэж байна.

НАЙМ. АРГА ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Австралийн Элчин Сайдын Яамны дэмжлэгтэйгээр Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын Нийгмийн Бодлогын Хэлтэс, С.Буяннэмэхийн нэрэмжит Төв номын сан, Монголын Номын Сангийн Холбоо хамтран Дундговь аймгийн нийтийн болон ЕБС-ийн 49 номын санчдад “Хил хязгааргүй номын сан төсөл”-ийг 2 өдрийн турш амжилттай зохион байгууллаа. Төслийн хүрээнд Австралийн Элчин сайдын яамны мэргэжилтэн Х.Өрнөх, Монголын Номын Сангийн Холбооны Гүйцэтгэх захирал М.Даваасүрэн, “Тэрэлж боардинг” сургуулийн Захирал МНСХ-ны УЗ-ийн гишүүн С.Цэндсайхан нар номын сангуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгч төвтэй үйлчилгээг нэвтрүүлэх, технологийн дэвшлийг ашиглах зэрэг орчин үеийн нийтийн номын сангийн шилдэг туршлагуудын талаар сургалт, хэлэлцүүлэг явагдлаа.

“Туршлага хуримтлуулж ажлын бүтээмжээ дээшлүүлье” хөтөлбөрийн хүрээнд сумдын нийтийн болон ЕБС-ийн номын санчдыг ажлын байран дээр чадавхжуулах зорилгоор Төв номын сангийн танхимуудад ажиллуулж онол практик хосолсон сургалтыг явууллаа. 2 өдрийн үйл ажиллагааны үр дүнд номын санчид ажлын байран дээр чадавхжих, орчин үеийн номын сангийн сайн туршлагуудад суралцах, хамтын ажиллагаагаа сайжруулах зэрэг ололт амжилттайгаар сургалтыг өндөрлүүллээ. Мөн тус төслийг орон нутагтаа амжилттай хэрэгжүүлсэн номын сангаар шалгаран 21 аймгийн номын санг төлөөлөн аргазүйч Б.Гэрэлсүрэн “Хил хязгааргүй номын сан төсөл”-ийн хаалтын үйл ажиллагаанд илтгэл тавьж сайн туршлагаа танилцуулахын зэрэгцээ Австралийн Элчин Сайдын Яаманд орон нутгийн номын сангийн үйл ажиллагааг сурталчлан таниулж төслийн дараагийн үйл ажиллагаанд манлайлан оролцох санал хүсэлт гаргаж ирсэн.

“Туршлага хуримтлуулж ажлын бүтээмжээ дээшлүүлье” чадавхжуулах хөтөлбөрийн хүрээнд Хөх хотын Үндэсний номын сан, Хэнтий, Төв, Сүхбаатар аймгуудын нийтийн номын сангуудад туршлага судлах, чадавхжуулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүллээ. Тус хөтөлбөрт сумдын нийтийн болон ЕБС-ийн номын санчид зэрэг давхардсан тоогоор нийт 61 номын санч-мэдээллийн ажилтнуудыг хамруулсан байна. Хөх хотын Үндэсний номын санд туршлага судлах аяллын үр дүнд алба хаагчид орчин үеийн номын сангийн тоног төхөөрөмжийн хэрэглээ, монгол үндэсний соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа, уншигч хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээ соён гэгээрүүлэх үйл ажиллагаатай танилцсан нь ажлын байранд шинэ санал санаачилгатай ажиллахад нь туршлага болсон ба цаашид тус номын сантай хамтран ажиллах санал солилцон гадаад хамтын ажиллагааг бэхжүүлсэн.

Аймгийн БШУГ, Сайнцагаан сумын ЗДТГ-тай хамтран ”Зөвлөн туслах” үйл ажиллагааны хамтарсан удирдамж гарган Сайнцагаан сумын 5 номын сангийн үйл ажиллагаатай биечлэн очиж танилцан номын санчдад аргазүйн дэмжлэг үзүүлж тэдэнд

санал санаачилгатай ажиллаж сурагчдын дунд уншлагыг дэмжих олон талт үйл ажиллагаагаа нэмэгдүүлэх, мэргэжлийн чадвараа дээшлүүлж, мэргэших, сургуулийн номын сангийн орчин нөхцөлийг сайжруулахад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн.

Байгууллагын алба хаагчдыг "ҮБҮХ-3"-ын хүрээнд монгол бичгийн цахим болон танхимын цахим бичвэрийн сургалтад хамруулан 5 алба хаагч буюу 33 хувь нь монгол бичгийн цахим бичвэрийг эзэмшиж, албан ажилдаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийт 23 (давхардсан тоогоор) алба хаагчийг мэргэжил олгох, мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамрууллаа.

ЕС.ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны А/288 дугаар захирамжаар Төв номын сангийн бүтэц, орон тоог 17 ажилтнаар батлуулсан. Төсвийн хуваарилалтаар 15 орон тоогоор батлагдаж ирдэг бөгөөд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9 дэх заалт "Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох" гэж заасныг үндэслэн орон тоог нэмэгдүүлэх боломжгүй 15 орон тоотой ажиллаж байна.

Тус байгууллага нь мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан ч ажиллах хүчин дутмаг үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд: Захирал 1, аргазүйч 1, номзүйч 1, сүлжээний инженер 1, номын санч-мэдээллийн ажилтан 4, нягтлан бодогч 1, архив, бичг хэргийн ажилтан, нярав 1, харуул хамгаалалтын ажилтан 4, үйлчлэгч 1

2023 онд мэргэжил олгох, мэргэшүүлэх 5 төрлийн сургалтад давхардсан тоогоор 20 алба хаагчийг хамруулж сургалтын төлбөрт 2,315,000 төгрөг зарцууллаа. Дурьдвал:Сүлжээний инженер, хүний нөөцийн ажилтан Ө.Уганбаяр "HR Academy Mongolia" Монголын хүний нөөцийн удирдлагын шинэчлэлийн академийн "Хүний нөөцийн ажилтан+ХАБЭА+архив, албан хэрэг хөтлөлт, компьютер" хосолсон эчнээ сургалтад хамрагдаж мэргэжлийн ромбо, дипломтой боллоо. Байгууллагаас сургалтын төлбөрт 500,000 төгрөгийн хөнгөлөлт үзүүлж мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэн нийгмийн баталгааг хангаж ажиллаа.

Засаг даргын тамгын газар, аймгийн Хэлний бодлогын зөвлөлөөс зохион байгуулсан "Монгол бичгийн цахим бичвэр"-ийн дөрвөн 7 хоногийн сургалтад архив, бичиг хэргийн ажилтан, байгууллагын монгол бичгийн сургагч багш нарыг хамруулж, 160,000 төгрөгийн сургалтын төлбөрийг шийдвэрлэв.

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс төрийн болон төрийн бус байгууллагын нярав нарт зохион байгуулсан мэргэшүүлэх сургалтад нярваа хамруулж 100,000 төгрөгийн төлбөрийг шийдвэрлэсэн.

Архивын ерөнхий газраас Дундговь аймгийн бүх шатны төрийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтанд зохион байгуулсан "Архивын үндсэн ойлголт, албан хэрэг хөтлөлт" сургалтад бичиг хэргийн ажилтныг хамруулж сургалтын төлбөрт 70,000 төгрөг зарцуулав.

"Монгол бичиг үндэсний бичиг III" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж байгууллагын нийт алба хаагчдын түвшинг тогтоон монгол бичгийн модуль сургалтад хамруулж, сургалтын төлбөрт 1,485,000 төгрөг зарцууллаа.

АРАВ. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

Хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу цалин хөлс, ур чадвар болон үр дүнгийн нэмэгдэл, түлш, хоолны хөнгөлөлтийг бүх алба хаагчид олгож, 5 алба хаагчдад 5 жилийн мөнгөн тэтгэмж, 3 алба хаагчид эмчилгээний болон шинэ байранд орсны тусламж дэмжлэгийг үзүүлэн нийгмийн баталгааг хангаж ажиллаа.

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж нийт 77.131.316 төгрөгийг зарцуулсан. Үүнд:

1. Ур чадварын нэмэгдэлд 16.262.309 төгрөг
2. Үр дүнгийн нэмэгдэлд 13.077.767 төгрөг
3. Унаа хоолны зардалд 13.327.000 төгрөг
4. Түлшний хөнгөлөлтөд ердийн галлагаатай сууцанд амьдардаг 3 албан хаагчид 750.000 төгрөг
5. Нэг алба хаагчид 800.000 төгрөгийн буцалтгүй тусламж, 151.800 төгрөгийн бензин
6. Ажилчдын сургалтын зардалд 5.775.000 төгрөг
7. Шинэ байранд орсон ажилтанд 200.000 төгрөгийн буцалтгүй тусламж
8. Байгууллагын шилдэг 2 алба хаагчид 800.000 төгрөг
9. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 21.973.440 төгрөгийн зарцуулсан.
10. Чадавхжуулах, туршлага судлах хөтөлбөрт байгууллагын нийт алба хаагчдыг хамруулж 4.014.000 төгрөгийг зарцууллаа.

Иргэдийг соён гэгээрүүлэх олон нийтийн үйл ажиллагаанд ..... төгрөг зарцуулсан.

АРВАН НЭГ. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА (САНАЛ ДҮГНЭЛТ)

“Орлого нэмэгдүүлэх жил 2023” байгууллагын зорилтын хүрээнд дараах хэд хэдэн ахиц өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Орлого өмнөх онд 2,706,000 төгрөгийг төвлөрүүлсэн бол энэ онд 4,239,000 төгрөгийг төвлөрүүлж өмнөх оныхоос нэмэгдүүлсэн байна.
- Уншигчдад хүргэх ном, хэвлэлийн үйлчилгээг илүү ойртуулах, хялбар болгох зорилгоор “Дуудлагын номын сан”, “Танд ойрхон номын сан”-ийн шинэлэг үйлчилгээнүүдийг явуулсан нь уншигчийн тоо ихсэн ном уншилт нэмэгдсэн үр дүн харагдлаа. Улмаар “Дуудлагын номын сан”-г ном хүргэх тээврийн хэрэгсэлтэй болголоо. (цахилгаанаар явагч мопед)
- Хүүхэд багачуудыг номд дуртай болгох, номыг бүтээлчээр уншиж сургах, номын сан түүний үйл ажиллагааг сурталчлах зорилго бүхий “Олуулаа уншъя-Номтой нөхөрлөе” аян, “Эртэч номын хүүхдүүд” клубийн үйл ажиллагаа, “С.Буяннэмэх тэмдэгтэн”, “Уншлагын цаг”, “Ангийн номын санч”олон талт арга хэмжээг зохион байгуулсан нь үр дүнгээ өгч уншигчдын бүтэц, хүрээ өргөжин тэлсэн байна.
- Гадаадын байгууллагын дэмжлэгтэйгээр төсөл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлснээр шинэ санаа, сайн туршлага олж авахаас гадна сан хөмрөгийн баяжилт тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлсэн.
- Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хүртээмжтэй хүргэхийг эрмэлзэж төрийн үйлчилгээ хангалтгүй хүрдэг ААН-үүдийн залуучууд, тусгай хэрэгцээт иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэж ажилласан нь тэгш хүртээмжтэй ажил болсон.

Санал:

1. Орон тоо бүтцийг стандартад заасны дагуу бүрдүүлж ажиллах нөхцөл боломжоор хангах
2. Гадаад орнуудын номын сангуудтай харилцах, туршлага солилцох, хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх зорилгоор “Боловсон хүчний солилцооны хөтөлбөр”-ийг орон нутгийн номын сангуудыг хамруулан хэрэгжүүлэх
3. **МҮНС**-ийн арга зүйчдийн баг орон нутгийн номын сангуудад зөвлөн туслах, ажлын байранд нь чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулах

АРВАН ХОЁР. ХАВСРАЛТ, БАРИМТ

Номын сайн нөхөр шалгаруулах арга хэмжээ



Ангийн номын санч хөтөлбөр

Орон нутгийн номын сангуудад зөвлөн туслах

Номын хөөрөлдөөн: Зохиогч уншигчдын уулзалт

Номын баяр

Дэлхийн номын өдөр

Олон Улсын хүүхдийн номын өдөр

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх



Монгол бахархал ёс заншил үйл ажиллагаа

Тэрбум мод үндэсний хөтөлбөр

Гадаад дотоод сургалт

“НОМТОЙ ЭКО АЯЛАЛ”

“МӨНХ ТЭНГЭРИЙН БИЧИГ” сайхан бичигтэн шалгаруулах уралдаан



Номтой шинэ жил

“Номтой гэр бүлийн болзоо” контент

“Танд ойрхон номын сан-Ахмадуудад”

Туршлага хуримтлуулж, ажлын бүтээмжээ дээшлүүлье

ЗАВХАН АЙМГИЙН Б.ЯВУУХУЛАНГИЙН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга: Завхан аймгийн номын сан нь 1946 онд Гэгээрлийн хэлтсийн даргын 65 тоот тушаалаар аймгийн бага хурлын номын сан нэртэйгээр 500 номтойгоор 1 орон тоотой анх байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 109-р тогтоолоор төрийн соёрхолт, соёлын гавьяат зүтгэлтэн Б.Явуухулангийн нэрэмжит болон 76 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрхэм зорилго: Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн техник технологитой хослуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлэн, түүх соёлын үнэт, өв, ном товхимолыг өсвөр хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгэмд мэдээлэлд тулгуурласан мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэх **“Мэдээллийн нээлттэй”** төв болох

ХОЁР: НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус номын сан нь 2022 оны байдлаар 55304 ширхэг 132477936 төгрөгийн Монгол, Англи, Орос, Төвд хэл дээрх ном хэвлэлтэй бөгөөд Монгол номын фонд- 2, гадаад /орос/ номын фонд- 1, Гадаад /англи/ номын фонд -1 үйл ажиллагаагаа явуулж байна. Сан хөмрөгийн бүрдүүлэлтийг худалдаа, хандиваар бүрдүүлдэг бөгөөд ном хэвлэл худалдан авах журмаар бүрдүүлэн ажиллаж байна.

2022 онд 328 нэр төрлийн 747 ширхэг 11502500 төгрөгийн ном хэвлэлээр сан хөмрөгөө бүрдүүлснээс:

- Худалдаагаар 296 нэр төрлийн 679 ширхэг 10586500 төгрөгийн ном
- Хандиваар 32 нэр төрлийн 68 ширхэг 966000 төгрөгийн номоор фондоо баяжуулан үндсэн фонд болон тасаг танхимуудад хүлээлгэн өгч ажилласан байна.
- Мөн Германы хөрөнгө оруулалтаар 2011 онд Book bridge сургалтын танхим байгуулагдсан ба тус танхимын ном хэвлэл, тавилгыг манай байгууллагад хандивлах зөвшөөрөл 2022 онд ирснээр 4526 ширхэг 4176800 төгрөгийн ном хэвлэлийг номын сангийн данс бүртгэлд тусган ажиллалаа.

Уншлага үйлчилгээнд ашиглагдах боломжгүй болсон **175** ширхэг номыг сэлбэн засах мөн Туяа сонины бүх дугаарыг шинэчлэн үдэж хавтаслах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сан хөмрөгт хадгалагдаж буй Төвд хэлээр бичигдсэн болон гар бичмэл, судруудын хадгалалт хамгаалалтыг сайжруулан сэлбэн засалт болон баринтаг солих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

2022 онд Нийтийн уншлагын танхим, Bookbridge сургалтын танхимын ээлжит тооллого, Хүүхдийн уншлагын танхимын ээлжит бус тооллогыг хийж акт үйлдэн архивт хүлээлгэн өгч ажиллалаа.

Мөн 2022 онд ИТХ-ын А/48 тогтоолоор 2754 ширхэг 2239116 төгрөгийн номыг актлуулан номын сангийн үндсэн бүртгэлүүдээс хасалт хийх ажлыг хийж гүйцэтгэлээ.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан нь Уншлага үйлчилгээний:

- Нийтийн уншлагын танхим
- Хүүхдийн уншлагын танхим
- Гэрээр ном олгох тасаг
- Англи хэлний сургалтын танхимаар үйлчилгээ явуулдаг бөгөөд

Номын сангийн стандартын дагуу жилдээ 3800 уншигчдад 55000 ном олгож үйлчлэхээс 2518 уншигч 7744 ирэгсдэд 10127 ном олгож үйлчиллээ. Уншигч-66.29%-тай, ном олголт 18,4%-тайгаар үйлчилгээ үзүүлсэн байна.

Уншлага үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс тасаг танхмын номын санч нар өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор төрөл бүрийн ном уншлагын аянуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Уншлага үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор дараах СОНА-уудыг зохион байгууллаа. Үүнд:

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн дагуу "Үндэсний бичиг үсгийн баяр" арга хэмжээний хүрээнд "Босоо бичигтэн" уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд энэ жил Албан байгууллагын албан хаагчид болон ЕБС-ын суралцагчид гэсэн ангиллаар амжилттай зохион байгууллаа. Уралдааныг "Бийрэн бичлэг", "Хичээнгүй бичиг", "Уралдаант уншлага" гэсэн 3 төрлөөр зохион байгуулж шилдгүүдээ шагнаж урамшууллаа. Тус үйл ажиллагаанд албан хаагчдын ангилалд 23 оролцогч, ЕБС-н суралцагчдын ангилалд 19 хүүхэд идэвхтэй оролцлоо.

Дорнын их яруу найрагчийн мэндэлсэн өдрийг тохиолдуулан Улиастай сумын ЕБС-иудын бага, дунд ангийн суралцагчдын дунд “Алаг дэлхийд төрсөн минь учиртай” шүлгийн уралдаан зохион байгуулан нийт 125 оролцогч оролцлоо. Мөн ЧЭЛС-ийн 8 дугаар ангийн суралцагчдын дундУншигчдын бага хурал зохион байгуулсан ба их найрагчийн уран бүтээлийг уншигчад сурталчлах зорилгоор пэйж хуудсанд түүний намтар уран бүтээлийн намтар номзүйг байршуулан ажиллалаа. Их найрагчийн мэндэлсэн өдөрт зориулсан арга хэмжээнд нийт 210 гаруй уншигч хамрагдсан дүн мэдээтэй байна.

Хүүхэд багачуудын уран сэтгэмж, танин мэдэхүй авьяас чадварыг хөгжүүлэх зорилготой “Миний дуртай бяцхан ном” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд ЕБС–н 5 сургуулийн 45 суралцагч идэвхтэй оролцож бүтээлээ ирүүлснээс 3-н суралцагчийн бүтээлийг шалгаруулав.

Монгол хэлний үгсийн баялаг, зөв бичих дүрмийг таниулах зорилготой Үсэглэлийн хаад зорилтот уралдааныг ЕБС-н 5-р ангийн суралдагчдын дунд зохион байгууллаа. Уралдаанд 40-н суралцагчид хамрагдлаа. Мөн соёлын бүтээлч сар аяны хүрээнд Д.Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол шүлгийг хэн сайн унших вэ” шүлгийн уралдааныг 6-9-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж нийт 9 бүлгийн 216 суралцагчид хамрагдлаа.

Англи хэл сурч буй хүүхэд багачуудын англи хэл сурахад нь дэмжлэг үзүүлэх, англи хэл дээрх номыг тогтмол уншсанаар хэл сурахад ямар үр дүнд хүрэх давуу талыг олгох, чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэх, тус ажлыг зохион байгуулснаар ЕБС-н англи хэлний багшийн хичээлийн үйл ажиллагаанд нь дэмжлэг болох зорилготой BOOKFRIEND аяныг 1 сарын хугацаанд өрнүүллээ. Аянд ЧЭЛС, БД 3-р сургуулийн 6-8-р ангийн суралцагчдыг хамрагдсан бөгөөд нийт 420 суралцагч тус арга хэмжээнд оролцож 46 хүүхдийг шалгаруулан урамшууллаа. Мөн ангийн суралцагчдаа идэвхтэй оролцуулсан англи хэлний багш нарыг урамшуулж, хамтран ажиллалаа.

Б.Явуухулангийн нэрэмжит Төв номын сангийн дэргэдэх “УНШИХУЙ” клубын гишүүдийн хоёрдугаар ээлжийн уулзалтыг “Ном уншихын ач тус” сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Тус уулзалтад ахлах ангийн 45-н суралцагчид хамрагдлаа.

Ном уншиж номтой нөхөрлөх боломжийг бүрдүүлэн өгдөг оюуны өргөөг магтан алдаршуулах зорилготой “Номын сан-Миний амьдралд” эсээ бичлэгийн уралдааныг зохион байгууллаа. Тус уралдаанд дунд, ахлах бүлгийн 52-н суралцагчид эсээ бичлэгээ ирүүлснээс 6-н суралцагчдын эсээ бичлэгийг шалгаруулан, шагнаж урамшууллаа.



Суралцагчдын авъяас ур чадварыг дэмжих, эх хэлний боловсролыг дээшлүүлэх, монгол хэлний уран үгсийн арвин баялаг сантай танилцах, уран тод ярих, уран сайхны сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор **“Уран жиргээ”** богино өгүүллэгийн уралдааныг ЕБС-ийн 5-8-р дугаар ангийн суралцагчдын дунд зохион байгуулж 26 суралцагчид оролцлоо.

BOOKFRIEND аяны хүрээнд англи хэлний үгсийн санг нэмэгдүүлэх, ярианы хэллэгийг зөв хөрвүүлэн бичих зорилготой SPELLING BEE үсэглэлийн тэмцээнийг 7-8-р ангийн суралцагчдын дунд зохион байгууллаа. Уралдаанд 134 суралцагч оролцож 8-н суралцагч бусдыгаа манлайлан шалгарч амжилттай оролцлоо.

Угийн бичиг хөтлөх, түүний арга аргачлалыг судлан танин мэдэх бусдад түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Төв номын сан пэйж хуудсанд 15-н удаа угийн бичиг хөтлөх, төрөл аргыг харуулсан бичлэг болон цуврал мэдээллийг байршуулсан. Мөн “Удам судраа судалж, угсаа гарлаа мэдье” сэдэвт угийн бичиг хөтлөх арга аргачлалыг таниулах сургалтыг ЕБС-ийн 20 суралцагч, Соёл урлагийн байгууллагын 15 ажилтан, Товцог багийн 55 иргэнд зохион байгууллаа.

Үндэсний бичиг соёл, номын өдрүүд арга хэмжээний хүрээнд

Үндэсний бичиг соёл, номын баярын арга хэмжээг 2022 оны 05-р сарын 20-22-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө гарган Улиастай хотын Төв талбайд нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Хаврын “Номын баяр-2022” арга хэмжээнд 150 гаруй иргэд уншигчид хамрагдлаа. Тус арга хэмжээнд зориулан гэрэл зургийн үзэсгэлэн болон Боролдой номын дэлгүүртэй хамтарсан шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 2080 номоор гаргаж үйлчиллээ. Уншигчдын дунд гар зургийн уралдаан, эссэ бичлэг богино өгүүллэгийн уралдаан, ном уншлагын аян, дүрийн тоглолтууд, номтой зочин, ном хож, зохиолч уншигчдын уулзалт зэрэг 33 нэр төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж нийт 3279 иргэд уншигчид хамрагдлаа.

Намрын “Номын баяр-2022” арга хэмжээг Завхан аймгийн Улиастай сум болон 23 сумдын номын сангууд 2022 оны 09 сарын 16-26-ны өдрүүдэд “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” нэртэйгээр зохион байгууллаа. Сумдын номын сангууд уг үйл ажиллагааг угтаж 92 төрлийн СОНА зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд 4554 идэвхтэн уншигч дэмжин оролцлоо. Мөн энэ үеэр 3289 ширхэг номоор шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж уншигч үйлчлүүлэгчдээ хүргэн ажилласан байна.

Соёлын бүтээлч сар аяны хүрээнд “Бадархундага яруу-2022” яруу найргийн наадмыг Улаанбаатар хотод АЗДТГ, СУГ-тай хамтран зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд Завхан аймгаас төрөн гарсан эрдэмтэн зохиолчдын номын дээжээс түүвэрлэн “Цадиг түүхт цаст уулынхан” нэртэй номын үзэсгэлэнг гаргаж оролцлоо. Нийт 112 ширхэг номоор үзэсгэлэн гаргалаа. Ардын аман зохиол, ерөөл магтаал эртний домог түүхийн талаар цуврал бэлтгэн Б.Явуухулангийн нэрэмжит Төв номын сан пэйж группт 16 удаа мэдээлэл байршуулж тус сэдвийн хүрээнд 5 бичлэг хүлээн авч шалгарууллаа

ДӨРӨВ: КАТАЛОГ, ЛАВЛАГАА НОМЗҮЙН АЖИЛ

Каталог, картын сангийн зохион байгуулалт:

Шинээр ирсэн 747 ширхэг номонд техник ажиллагаа хийн Электрон каталогт оруулан цаасан каталог хэвлэн байрлууллаа.

LIB4U болон Монбиблио програмын хэвийн үйл ажиллагааг ханган сумдын номын санчдад зөвлөгөө өгөн ажиллаж байна.

Номзүйн ажил:

Zotero програмд Туяа сонины 1965 оны өгүүллүүдийг оруулан МҮНС-ийн нэгдсэн системд хүргүүлэн ажиллалаа.





Омека програмд номын сангийн сан хөмрөгт байхгүй дугааруудыг Архивын газраас авч скайнердаж 5 оны дугаарыг оруууллаа.

2010-2022 оны хооронд гаргасан Санамж өгөх номзүйн бүртгэлүүдээ Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сангийн фэйж хуудсанд байршуулан уншигчдад лавлагаа мэдээлэл өгөн ажиллаж байна.

“Завхан цахим түүх” влогт 23 сумын номын санчидтай хамтран Завхан аймгийн 100 жилийн ойг угтан Завхан нутгаас төрөн гарсан Зохиол, Яруу найрагчдын намтар уран бүтээлийг оруулан уншигчдад мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна.

ТАВ. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЖИЛ

Сумдын номын сангуудын Монбиблио програмыг онлайнд холбуулан тэдний ажлыг шууд хянах боломж бүрдэж байгаа бөгөөд СУИС-ийн багш Т.Хайдавтай хамтран уг програмын тухай заавар зөвлөмжийг тухай бүр нь хүргэн ажиллаж байна. Мөн өөрийн байгууллагын LIB4U програмын хэвийн ажиллах нөхцлийг ханган Волвес компанийн инженер Гантулгаас утсаар болон фэйсбүүкээр заавар зөвлөгөө аван өөрийн ажилтнуудад програмын шинэчлэлт, програмд гарсан засвар үйлчилгээний талаар мэдээллийг тухай бүрт нь хүргэн ажиллаж байна.

Номын сангийн цахим сангийн эзлэх хувийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын нөөц сангаас 10 сая төгрөгийг шийдүүлж цахим санг бүрдүүлэхэд шаардлагатай байгаа хэрэгцээт тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан. Сонин бусад ном хэвлэлийг сканердах 4 үйлдэлт скайн, Dell core I7 notebook, Galaxy I7 tab зэргийг авснаар цахим уншлага үйлчилгээнд нэвтрүүлээд байна. Мөн интернэтийн хурдыг сайжруулж “Гайхмаар хурд” ХХК-тай 3 жилийн гэрээ байгуулж 4GB-ийн хурдаар интернэт авч ашиглаж байна.

ЗУРГАА: АРГА ЗҮЙН АЖИЛ

МҮНС-тай хамтран “Уншигчийн судалгаа хийх” сургалтыг 06 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтыг МҮНС-ийн МАЗЭШХ-ийн дарга Т.Хайдав, Арга зүйч В.Түвшинтогтох нар сумдын номын санчдад мэргэжлийн хичээлээр

мөн төв номын сангийн ажилтнуудад уншигчийн судалгаа хийх сургалтыг зохион байгуулан нийт 260 гаруй уншигчдаас судалгаа аван үр дүнг нь тооцон уншлага үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байна. Сургалтад нийт 31 номын санч оролцлоо.

“Монгол бичиг-Сайхан бичиг” уриалга гарган ЧЭЛС-ийн хэл уран зохиолын багштай хамтран Монгол хэл бичгийн 3 удаагийн 20 цагийн анхан шатны сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд 11 албан хаагчдыг хамрууллаа.

ЗДТГ-н төрийн захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Вансэмбэрүү “Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал” сэдэвт сургалтыг сумын номын санч нарт зохион байгууллаа. Мөн “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Ажлын байрны ёс зүй” сэдвүүдээр байгууллагын ёс зүйн хорооны дарга, гишүүд илтгэл тавьж, нийт 11 ажилтнуудыг хамрууллаа.

Монгол бичгээр хэвлэгддэг "Хүмүүн бичиг" сониныг захиалан авч, 7 хоног бүрийн Пүрэв гарагт албан хаагчдад зориулсан "Хүмүүн бичиг, Хүн бүрийн бичиг" уриатай уншлагын цагийг гарган, тус сонины дугаарыг тараан өгч уншуулах ажлыг зохион байгуулж монгол бичгийн хэлний мэдлэгийг нь дээшлүүлж байна.

ДОЛОО: ХҮНИЙ НӨӨЦ

Манай номын сан нь захирал, нягтлан бодогч, ном зүйч, мэдээллийн технологич, мэдээллийн ажилтан, фондчин, номын санч-3, зөөврийн номын санч, үйлчлэгч сахиул гэсэн 11 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Эдгээр ажилтнуудаас Мэргэжлийн номын санч-4, Номын сангийн чиглэлээр Магистр хамгаалсан ажилтан – 3 ажилтан ажиллаж байгаа бөгөөд номын санчдыг мэргэшүүлэн сургах сургалтанд хамруулж чиглэл чиглэлээр нь туршлага судлуулсан дадлага ажлуудыг холбогдох газруудад хийлгэж кредит цагийн сургалтуудад номын санчдыг хамруулах шаардлага тулгарч байгаа.

Байгууллагын ажилтнуудын мэдлэг мэдээллийг тэлэх зорилгоор тухайн жилийн сургалтын хэрэгцээг тодорхойлон улирал бүр мэдлэг олгох сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

8. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд байгууллагын албан хаагчдыг хуваарьт өдрүүдийн дагуу спорт зааланд өглөө бүр эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнд идэвхтэй оролцуулан 7 удаагийн хөдөлгөөнт дасгалд хамруулаад байна.

Хавар намрын бүх нийтийн хог цэвэрлэгээнд байгууллага хамт олноороо өөрийн хуваарьт газар болох богдын гол багийн голын ай сав газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг идэвхтэй гүйцэтгэлээ. Мөн хог хаягдлын хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах үүднээс, орчин тойрны 100 м талбайн цэвэрлэгээ хийж, идэвхтэй хандлагыг өрнүүлэн, хэрэгжилт үр дүнг тооцож мэдээ тайлан Улиастай сумын ЗДТГ-т хугацаанд нь хүргүүллээ.

Байгууллагын гадна талбай болон төв замын цас мөсийг цэвэрлэн халтиргаа гулгаа, осол гэмтлээс сэргийлж ажиллалаа. Мөн холбогдох тайлан мэдээг Улиастай сумын ЗДТГ-т албажуулан хүргэлээ.

Байгууллагын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд төрөл бүрийн цэцгийн үрсэлгээ авч, үрслүүлэн тарьж, цэцгийн төрлөө нэмж байна. Одоогоор тасалгааны 8 нэр төрлийн цэцэг үрслүүлэн тарилаа. Гадна талын талбайн хайсанд цэцгийн мандал ногоон зүлгийг үрслүүлэн тарьж бургас, шар хуайс зэрэг 15-н ширхэг модны суулгацыг тарин ургуулж байна.

ДҮГНЭЛТ

Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан нь 2022 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг 100%-тай хийж гүйцэтгэсэн ба ХШҮДАХ-ээс 94,2%-тай үнэлэгдсэн байна.

Уншлага үйлчилгээний хувьд: Номын сангийн стандартын дагуу жилдээ 3800 уншигчдад 55000 ном олгож үйлчлэхээс 2580 уншигч 7742 ирэгсдэд 10127 ном олгож үйлчиллээ. Уншигч- 66.9%-тай, Ном олголт- 18.6%-тайгаар үйлчилгээ үзүүлсэн байна. Цаашид уншигчийн тоо нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай нь харагдаж байна.

Номын сангийн сан хөмрөгийн хувьд: Өмнөх жилүүдтэй харьцуулахад сан хөмрөгийн нэр төрлийг шинэчлэн уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн ном хэвлэлээр сан хөмрөгөө баяжуулан ажиллалаа. Мөн 2011 онд байгуулагдсан Сургалтын номын сангийн 4526 ширхэг номыг орлогот авах эрх үүсэж данс бүртгэлүүдэд бүрэн тусган ажиллалаа.

Арга зүйн ажлын хувьд: 2022 оны төлөвлөгөөт сургалтуудыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулан ажиллалаа. Цахимаар номын санчдыг сургах олон төрлийн сургалтуудыг зохион байгуулан зохих үр дүнд хүрч ажилласан байна. Сумдын номын санчдыг өөрийн байгууллага дээр дадлагажуулах ажлыг зохион байгуулан тодорхой үр дүнд хүрч байна.

Соёл олон нийтийн ажлын тухайд: 2022 оны төлөвлөгөөнд орсон ажил үйлчилгээ 100% хийгдсэн ба нэмэлтээр олон төрлийн уншигч руу чиглэсэн ажлуудыг хийж гүйцэтгэлээ. 2022 онд 30-40 нэр төрлийн СОНА зохион байгуулан 4500-аас дээш уншигчийг хамруулан ажилласан байна.

ОРХОН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Эрхэм зорилго. Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээг ашиглан хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхитэй, мэдлэгтэй ирэнийг төлөвшүүлэхэд оршино.

Зорилт 1*: “Шинэ ноьмын сангийн барилга ашиглалтанд орсонтой холбогдуулан дотоод ажлын зохион байгуулалт хийх*

“Номын өргөө” шинэ номын сангийн барилга нь 2023 оны 07 сард ашиглалтанд орох төлөвлөгөөтэй ажиллаж байна. / Аймгийн Таван жилийн үндсэн чиглэлийн 1.3.1, ЗДҮАХ-ийн 3.2, 3.1.2 /

Зорилт 2: *Номын сангийн үндсэн фондын сонин хэвлэлийг цэгцлэн үдэж хавтаслах ажлыг зохион байгуулах*

/2022 онд 170 гаруй сонин үдэж хавтаслан цэгцэлсэн байна. Энэ онд үлдсэн сонингуудыг цэгцэлж үдэх ажлыг хийхээр төлөвлөөд байна.

Зорилт 3: ***Номын сангийн ажилчид, уншигчдын ширээ сандлыг шинэчлэх ажлыг хийх***. / 9531.0 мянган төгрөгийн сандал, ширээ бусад тоног төхөөрөмж худалдан авч ажилчид уншигчдын таатай нөхцлийг ханган ажилласан байна./

2023 онд дараах бодлогын баримт бичигт турлгуурлан үйл ажиллагаагаа явууллаа.

- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Соёлын яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөө
- Орхон аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл

- Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Соёлын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ
- Нийтийн номын сангийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

. Аймгийн нийтийн номын сан нь 1 салбар номын сан 4 танхимаар номын сангийн уншлага үйлчилгээг аймгийн 104,0 мянган хүнд ном соёлыг хүргэн ажиллаж 2023 оны 7 сараас салбар номын сан татан буугдаж 4 танхимаар номын сангийн үйлчилгээг хүргэж байна.

ХОЁР. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Аймгийн номын сан нь сан хөмрөгтөө нийт 35,9 мянган номтой бөгөөд 26,0 мянган монгол хэл дээрх, 7,5 мянган орос хэл дээрх, 1,8 бусад хэл дээрх номтой үүнээс танхимуудын ойрын фондуудад 18,8 мянган ширхэг номнууд эргэлтээр уншигдаж байна. Энэ онд үндсэн фондын архиваас 23 нэрийн сонин 168 номыг захиалгаар авч үйлчлүүлсэн байна. Энэ онд байгууллагын төсөвд ном авах зардал 1,5 сая төгрөг батлагдаж, 2023 оны үр дүнд суурилсан зардлаас 4700,0 мянган төгрөгөөр ном худлдан авч нийт төсвөөр 191 нэрийн 208 ширхэг 6128,6 мянган төгрөгийн ном 26 нэрийн 938,5 мянган төгрөгийн сонин, сэтгүүл, хандиваар 111 нэрийн 135 ширхэг 2839,3 мянган төгрөгийн ном авч нийт 302 нэрийн 343 ширхэг 9906,4 мянган төгрөгийн ном, тогтмол хэвлэлээр номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлтийг хийсэн байна.

Тооллого нь номын сангийн төрөл хэмжээ сан хөмрөгийн бүтэц зориулалтаас хамаарч тодорхой хугацаанд хийгдэх ээлжит тооллого, зайлшгүй нөхцөлд хийгдэх ээлжит бус тооллого гэсэн төрөлтэй байна. Энэ онд номын сангийн уншлагын танхимуудын хагас жилийн тооллого 4 удаа 2 хүн жирэмсний амралт авч ном хүлээлцэх тооллого 2 удаа, салбар номын сан татан буугдаж ажил хүлээлцэх тооллого 2 удаа хийж энэ жил 8 удаагийн тооллого хийгдэж тооллогын актыг үйлдэж алдагдсан 100 гаруй номын нөхөн төлүүлэх арга хэмжээ аван ажиллаж байна..

. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар номын сангийн уншлагын танхимын номын санчид нийт 461 ном сонин сэлбэн засаж цэгцэлсэн байна. Үүнээс 290 ном, “Зууны мэдээ”,” Өдрийн сонин”-ы 171 багц сонин сэлбэн засаж, үдэж наасан ажил нь зуны уншлага үйлчилгээний уншигчид багатай үед зохион байгуулсан томоохон ажил болж чадсан байна.

ГУРАВ. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Номын сангийн үйлчилгээ

Номын сангийн уншлагын танхимаар 2023 онд **6516** хүнд шинээр карт нээж **52173** байнгын ирэгсдэд **105,071** ном олгож үйлчилсэн байна. Гэрээр ном олгох уншлагын танхимаас **772 хүнд 1162 ном олгож 915,400** төгрөгийн өөрийн орлого оруулсан байна

Нийт 322 уншигч хэрэглэгчдэд лавлагаа номзүйн үйлчилгээг тухай бүрд тогтмол үзүүлсэн ба үүнээс амаар – 189, цахим, утсаар – 133, сэдэвчилсэн – 150, номзүйн мэдээг тодруулах – 166, статистик тоо баримтын – 6 лавлагаа өгч ажилласан. Уншигч, хэрэглэгчдээс ирсэн лавлагааны хүрээнд төрөл бүрийн номзүйг цаасаар болон цахимаар бэлдэж, зарим уншигч, хэрэглэгчдэд тухайн мэдээллийг хэвлэн гаргаж үйлчилсэн. Мөн цаг үе, тэмдэглэлт үйл явдалтай уялдуулан номзүйн бүтээгдэхүүн боловсруулж мэдээлэл номзүйн үйлчилгээг цаасаар болон цахим хаягаар дамжуулан хүргэсэн. Уншигч, хэрэглэгчдийн судалж буй судалгааны ажилтай холбоотой ном, эх сурвалжуудыг санал болгон ажилласан.

Номын сангийн уншлагын танхимаар шинээр карт нээлгэсэн 6516 уншигчийн картыг нээж, номын сангийн программд шивж оруулан 51401 байнгын уншигч 107899 олгосон номыг программаар уншуулан бүртгэж, цаасаар уншигч, ирэгсэд ном

олголтын өдөр тутмын бүртгэлийг тогтмол хөтөлж, сан хөмрөгт шинээр авсан 314 ширхэг номонд техник ажиллагаа хийж нэгбүрчилсэн бүртгэлд бичиж нэгдсэн бүртгэлээр тоо судалгааг гарган 18 нэрийн сонин 8 нэрийн сэтгүүлд сонин сэтгүүлийн карт хөтөлсөн.

Соёл олон нийтийн ажил

Танхимын уншлага үйлчилгээнээс гадна номын сангийн ажлын нэг гол хэсэг нь уншигч хэрэглэгчдийн хүрээнд зохион явуулах соёл олон нийтийн ажил юм. Энэ онд номын сангаас эсээ зохион бичлэгийн уралдаан, уулзалт ярилцлага, уншигчийн бага хурал, илтгэл, асуулт хариултын тэмцээн, яруу найраг, гар зургийн уралдаан зэрэг олон төрлөөр 47 удаагийн соёл танин мэдэхүйн ажил зохион байгуулагдаж 2427 хүүхэд хамрагдаж улсын төсвөөс 5.0 сая төгрөг зарцуулсан байна.

Цахимаар номзүйч Ч.Эрдэнэсувд 8 удаагийн номын хэлэлцүүлэг зохион байгуулж 5126 хүн хандалт хийсэн байна.

*Орхон аймгийн хэмжээнд "**Үндэсний номын баяр-2023**" арга хэмжээг "Илүү их уншъя", "Хүүхэд бүр уншигч", "Номтой Монгол" уриатайгаар 2023 оны 05, 09 дүгээр саруудад зохион байгуулж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх, номын сангийн үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлэх зорилгоо* зохион байгуулж А. Амарын талбайд нээлтээ хийж бусад арга хэмжээг урт цагааны гудамжинд зохион байгууллаа. Номын өдрүүдээр "Шилдэг номын сантай байгууллага", "Шилдэг номын сантай гэр бүл" шалгаруулах, "Үлгэрийн баатрууд амилсан нь" албан байгууллагын парад жагсаалд 12 байгууллагын 120 гаруй хүн, аймгийн Монголын зохиолчдын холбооны салбар зөвлөлийн зохиолч, яруу найрагчдын гарын үсэгтэй номын худалдаа, танхимуудаас 20 гаруй төрлийн соёл танин мэдэхүйн ажилд нийт 1550 гаруй хүн оролцож үзсэн хүний тоо 10000 гаруй хүн үзсэн тандалт хийлээ. Уралдаан тэмцээний зардлыг аймгийн ЗДТГ-аас 10,0 сая төгрөгөөр гаргасан байна.

Намрын номын баяраар нийтийн номын сангийн танхимууд номын үзэсгэлэн, гэрээр ном олгох, ЕБС-ийн номын санчид багш нарын бүтээл, сургуулийн Тэргүүний уншигч анги хамт олны бүтээлийн үзэсгэлэн, Монголын зохиолчдын эвлэлийн хорооны Орхон аймаг дахь салбар зөвлөлийн зохиолч, яруу найрагчид, Гүн утга уран бүтээлийн нэгдлийн яруу найрагчид өөрсдийн гарын үсэгтэй номын худалдаа, ховор хуучин, шинэ номын худалдаа зохион байгуулж, сумын багийн иргэдийн дунд "Шилдэг номын сантай гэр бүл" шалгаруулах ажлыг хийж нийт 23 айл хамрагдаж, төрийн болон төрийн бус 12 байгууллагын зохиол, үлгэрийн баатруудын дүр бүтээсэн жагсаал, Англи хэл дээр АХА тэмцээн 2 насны ангиллаар, "Үсэглэлийн хаад", "Чихэртэй АХА", "Алтан хонх" зэрэг уралдаан тэмцээнүүдийг 2 өдрийн турш зохион байгууллаа.

Номын баярын өдрүүдээр хийгдэж байгаа ажлуудыг цаг тухай бүр байгууллагын "Эрдэнэт хотын номын сан" пэйж хуудсанд мэдээлэл, бичлэгээр тогтмол хийж тавьсан байна. Мөн орон нутгийн телевиз, сайтуудад мэдээлэл цацагдсан байна. Парад жагсаал, шилдэг номын сантай гэр бүл шалгаруулах уралдааны постер бусад явагдах ажлыг тус тусад нь постер хийж цахимаар сурталчилсан байна.

Номын баярын өдрөөр номын сангаас "Та авч болно өгч болно" уриатай гудамжны номын санд ном хандивлах ажлыг хийж нийт 300 гаруй номыг байршуулсан байна.

***Үндэсний бичиг үсгийн баяр**ыг 2023 оны 5 дугаар сарын эхний долоо хоногт зохион байгуулж аймгийн ЗДТГ, Боловсрол шинжлэх ухааны газрын дэргэдэх Хэлний бодлогын зөвлөлтэй хамтран зохион байгуулж монгол бичгээр хурдан зөв унших*

уралдаан 3 насны ангиллаар, хичээнгүй цэвэр бичих уралдаан 3 насны ангиллаар кириллээс үндэсний бичигт хөрвүүлэх уралдаан 2 насны ангиллаар, бүтээлийн уралдаан 2 насны ангиллаар тус тус зохион байгуулагдлаа. Мөн төрийн байгууллагын ажилтан албан хаагчдын дунд “Алтан хонх” тэмцээн зохион байгуулж энэхүү тэмцээнүүдэд нийт 483 хүн хамрагдсан байна.
Мөн ЕБС-ийн “Амьд бичиг” сургалтын төвтэй хамтран "АМЬД БИЧИГ-2023" уран бичлэгийн улсын уралдаан 05-р сарын 13-ны өдөр болж амжилттай өндөрлөлөө. Энэ жилийн уралдаанд Говьсүмбэр, Булган, Хөвсгөл, Дархан, Улаанбаатар хотоос нийтдээ 50гаруй оролцогчид орж оролцлоо. Уралдаан насанд хүрэгчид, 6-9, 10-12-р ангийн ангилалд жижиг бийр, том бийр, чөлөөт бичвэр гэсэн гурван төрлөөр зохион байгуулагдлаа.

Ном уншилтыг сайжруулах чиглэлээр

Нийтийн уншлагын танхимаас Үндэсний бичиг үсгийн номын өдрүүдийн үзэсгэлэнг байгууллагын гадаа талбайн цонхонд гаргаж 33 ном, урд жилүүдийн номын баярын 20 үзүүлэн тавигдсан байна. Мөн номын баяраар гадаа талбайд лавлагаа номзүй, мэргэжлийн 30 гаруй номуудаар үзэсгэлэн гаргаж, гэрээр олгох танхимын номын санчид үзэсгэлэн гаргаж иргэдэд 10 гаруй ном гэрээр олгож үйлчилсэн байна.

ЕБ-ын 10 гаруй сургуулийн номын санч нар багш нарын гарын авлага, ангиудын тэргүүний уншигч хүүхдүүдийн материалаар үзүүлэн таниулах маягаар үзэсгэлэн гаргасан байна.

Хүүхдийн уншлагын танхимын зүгээс нийт номонд дуртай хүүхэд багачуудынхаа дунд:

- Танин мэдэхүйн аха тэмцээн
- Алтан хонх тэмцээн
- Тоглоомын булан
- Гэрэл зураг-фото агшин
- Хүүхдийн шилдэг номуудаар үзэсгэлэн
- Хуруу хүүхэлдэйн булан
- Үлгэрээр чанга уншлага зэрэг үйл ажиллагааг амжилттай зохион явууллаа.

Хүүхдийн уншлагын танхимаас ЕБС-ийн 6-р ангийн сурагчдын дунд амжилттай зохион явууллаа. Тус тэмцээний тэргүүн байранд 20-р сургуулийн 6 а ангийн сурагч Д. Түвшинбаяр, дэд байранд 20-р сургуулийн сурагч А. Ганди, гутгаар байранд 20-р сургуулийн сурагч Э. Хүслэн, тусгай байранд 13-р сургуулийн 6 а ангийн сурагч Б. Нандин-эрдэнэ нар тус тус шалгарлаа. Энэхүү 2 ажилд нийт 112 хүүхэд хамрагдсан байна

Үндэсний бичиг үсэг номын баяраар байгууллагын уншлага үйлчилгээний албанаас “Шилдэг номын сантай байгууллага”, “Шилдэг номын сантай гэр бүл” шалгаруулах ажлыг баг, байгууллагын захиргаанд албан тоот илгээх, өөрийн цахим хаягаар сурталчилгаа хийж нийт 8 байгууллага 22 гэр бүл бүртгүүлэн 2 өдөр байгууллага, гэр бүлийн номын сантай биечлэн танилцах ажлыг зохион байгууллаа. Нийт оролцсон байгууллагаас Эрдэнэт Дулааны цахилгаан станц, Хөдөлмөр халамжийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс шалгарч, гэр бүлээс Зэст багийн иргэн Г.Номмандах Согоот багийн иргэн Б.Цэрэндондов, Рашаант багийн иргэн Д.Алтангэрэл Согоот багийн иргэн Л.Уламбат,Уртбулаг багийн иргэн О.Мөнхтуяа нарын гэр бүл шалгарч 1,500.0 мянган төгрөгийн урамшуулал олголоо.

Алслагдсан хэрэглэгчдийн үйлчилгээг зохицуулсан байдал

Аймгийн нийт багийн нутаг дэвсгэр дээр орших цэцэрлэг, сургууль, төрийн болон төрийн бус 12 байгууллагын албан хаагчдад 12 удаагийн 451 номоор 375 хүнд ном олгож номын сангийн уншигчаар бүртгэн үйлчилсэн байна.

Зөөврийн үйлчилгээ зохион байгуулсан эсэх

Энэ онд аймгийн ЕБС, албан газрын ажилтан албан хаагчдад зориулсан 82 удаагийн 1754 номоор зөөврийн номын сангийн үйлчилгээ хийж 2516 хүнд хүргэж үйлчилсэн байна. Энэхүү зөөврийн үйлчилгээг сургууль, соёлын төвийн номын санчид авч өөрсдийн сургуулийн хүүхдүүдэд уншуулах ажлыг зохион байгуулдаг. Харин гэрээр олгох танхимаас төлөвлөгөөт ажлын дагуу тухайн байгууллага дээр 5 өдрөөр төрийн 14 байгууллагын 224 хүнд шинээр номын сангийн уншигчаар бүртгэн 191 хүнд 188 ном олгож үйлчилсэн байна. Энэ ажлыг хийх явцдаа 13 байгууллага дээр монгол бичгээр "Алтан хонх" тэмцээнийг зохион байгуулж шалгарсан хүмүүсийн дунд "Үндэсний бичиг үсгийн баяр"-аар финалийн шатыг зохион байгуулж шалгаруулах ажлыг зохион байгууллаа. Тэргүүн байранд Э.Эрдэнэбат ОБГазар, Дэд байранд П.Алтанжаргал МХГ, Гутгаар байранд О.Эрдэнэбулган БӨ сумын ЗДТГ, Тусгай байранд Д.Болортунгалаг МХГ-ын албан хаагчид тус тус байр эзэллээ.

Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал

Номын чанга уншлага, үлгэрийн цаг, номын тойм зэрэг аман ярианы аргууд номын болон зохиогч,хэвлэн нийтлэгчдийн мэдээг дамжуулах уншигчдын уншлагыг удирдан бие дааж болосвроход нь ихээхэн үүрэгтэй бөгөөд амьд үг ашиглан явуулдаг сурталчилгаа юм. Энэ онд номын сангийн уншлагын танхимуудаас сургуулийн өмнөх боловсролын болон бага ангийн сурагчдад жилийн байдлаар 69 удаа чанга уншлага,16 удаагийн номын тойм, 9 удаа үлгэрийн цаг хийгдэж 2360 хүүхэд хамрагдсан байна Дани- Монголын сургалтын төв, Дэлхийн Зөн Монгол ОУБ-аас анх санаачлан, Олон улсын хүүхдийн номын зөвлөлийн Монгол дахь салбартай хамтран хүүхэд багачуудыг дэлхийн болон Монголын зохиолчдын номтой танилцуулж, тэднийг номтой нөхөрлүүлэн, номоор дамжуулан өв тэгш хүмүүжилтэй болгоход нөлөөлөх зорилгоор найм дахь жилдээ олон улсын хүүхдийн "Номын өдөр"-ийг тэмдэглэж байна

Энэхүү номын өдрөөр Айн Рэндийн "Миний худалдаж авсан нөхөр" номоор 17-р сургууль, Аялгуу соёлын төвтэй хамтран номын хэлэлцүүлэг, "Номтой нөхөрлөе" өдөрлөгийг байгууллага дээр бүтэн өдрийн турш зохион байгуулж 430 орчим хүүхэд хамрагдсан байна. Өдөрлөгийн үеэр хүүхэд багачуудад зориулсан үндэсний үлгэр тоглоом наадгайн тэмцээн зохион байгуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ

Номын сангаас зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэрээр ном олгох, гэрт нь ном хүргэж өгөх ажлыг зохион байгуулж байна. Ном хүргэлтийн ажлыг хийхдээ багийн судалгаанаас авч хийдэг болно. Энэ онд 66 удаа 114 номоор үйлчилсэн ба үүний 44 удаагийн өөрсдөө ирж үйлчлүүлэн 22 удаагийн гэрт нь хаягаар өгч үйлчлүүлсэн байна.

Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн

Номын сангийн үйлчилгээг энэ онд уламжлалт танхимын үйлчилгээнээс гадна нэмэлт үйлчилгээнүүдийг мөн хийсэн байна. Танхимын үйлчилгээг харж байхад урд жилийн тоон үзүүлэлттэй харьцуулахад тоон статистик төлөвлөгөөний биелэлтүүд тасарсан байдал харагдаж байна. Энэ нь салбар номын сан 7 сард татан буугдаж тоон төлөвлөгөөнд нөлөөлсөн байдал харагдаж байна. Нэмэлт үйлчилгээ болох зөөврийн номын сан, гэрээр ном олгох, зөөврийн үйлчилгээнүүдийн тоон үзүүлэлт хэвийн өссөн байдалтай харагдаж байна.

ДӨРӨВ. ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цаг үе түүхэн тэмдэглэлт үйл явдалтай холбоотой цахим номзүйн мэдээллийн сан бий болгосон. Үүнд:

1. "Номын цахим хэлэлцүүлэг" – г цахим хаягаараа дамжуулан шууд дамжуулалт хийн бичлэг болгон хадгалсан. Нийт 12 дугаар хадгалсан.

2. QR код ашиглан электрон каталогтой холбогдох боломжтойгоор номын танилцуулгын цахим сан бий болгосон. Нийт 250 ширхэг номын танилцуулга бий болгосон.

Уншигчдын олон төрлийн мэдээллийн хэрэгцээ, шаардлагатай уялдуулан аймгийн хэмжээнд байгаа соёлын биет өвийн судалгааг нэгтгэн, орон нутгийн ач холбогдол бүхий мэдээллийн баазыг бий болгосон. Үүнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг соёлын төв болон аймгийн музейд бүртгэлтэй соёлын биет өвийн судалгааг авч нэгдсэн судалгааг бий болгосон. Одоогийн байдлаар нийт 25 ширхэг хөшөө баримлын тухай мэдээллийн товч танилцуулгатай бүхий мэдээллийн баазыг нэгтгэсэн. Уншигчдын шаардлагатай эрэл хайлтад зориулан ашиглагдах уламжлалт ба электрон лавлагааны болон номзүйн хэвлэлүүд, каталог, картын сангийн ажлыг зохион байгууллаа.

2023 онд ирсэн шинэ номын картыг номын сангийн LIB4U программаас хэвлэн гаргаж байгууллагын нэгдсэн каталогт төрөл анги, үсэг дарааллын дагуу тухай бүрд байршуулан, мөн танхим болон салбар номын санд 1% гарган тараасан. Хуучин каталогт редакц хийсэн. Нийт 314 ширхэг шинээр ирсэн номын картыг каталогт байршуулсан. Уг шинээр ирсэн 314 ширхэг номын “Шинэ номын мэдээ” – г эмхэтгэн цаасаар хэвлэн салбар болон танхимуудад хүлээлгэн өгсөн ба цахим хаягаар дамжуулан шинэ номын мэдээг QR код ашиглан электрон каталогт хандах боломжтойгоор бэлтгэн тухай бүрд мэдээлэл номзүйн ажлыг хүргэн, шинэ номын мэдээг сурталчилсан.

Номын сангийн LIB4U программыг үндэслэн Орон нутгийн зохиолчдын хэвлэн гаргасан ном, хэвлэлээр картын сан бий болгох ажил хийгдэж байгаа бөгөөд одоогийн байдлаар 89 ширхэг номын картыг шүүн хэвлэн гаргасан байна. Каталог, картын сан, электрон каталогийг хэрхэн ашиглах талаарх заавар, зөвлөмжийг байршуулан, зарим уншигч, хэрэглэгчдэд биечлэн хэрхэн хайлт хийх талаар зөвлөгөө өгч ажилласан.

Монгол Улсын Үндэсний номын сангаас хэрэгжүүлж буй Монгол улсын Соёлын сайдын 2021 оны 07 сарын 30-ны өдрийн А/150 тоот тушаалаар батлагдсан "Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим сан" бий болгох ажлын хүрээнд Эрдэнэт хотын анхны тогтмол хэвлэл болох “Эрдэнэт” сонины 1976-1990 оны хоорондох 16 жилийн тогтмол хэвлэлийг цахимжуулж байна. Нийт 1045 дугаарын 4180 нүүр бүхий материалыг цахим болгоод байсан ба 2023 онд уг цахим сан хөмрөгт нэмж “Эрдэнэт” сонины 1991 оны дугаарын нийт 154 нүүр бүхий материалыг цахим хэлбэрт оруулсан. Сонин цахимжуулахдаа гэрэл зургийн аппарат болон гар утас ашиглан нэг бүрчлэн сонинг задлан сониноо нүүр болгоноор зураг дарж сонины нүүрийг файл болгон /JPG өргөтгөл/, файлаа нэр өгч зургийг нь засах /кроп/ үйл ажиллагаа хийсэн. Бэлэн болсон зураг бүрийг он оноор нь тусад нь файл үүсгэн цахим санд хадгалсан.

Ном сурталчлах хамгийн өргөн хэрэглэгддэг тохиромжтой арга нь үзүүлэн таниулах арга юм. Номыг үзүүлэн таниулах аргаар сурталчлах ажлын хэлбэрүүд нь номын үзэсгэлэн, зурагт хуудас, ханын сонин, санамж өгөх номзүйн жагсаалт гэсэн төрлүүдээр гаргадаг. Энэ онд номын сангийн уншлагын танхимууд байгууллагаас гаргасан графикт заагдсан Үндсэн хуулийн өдөр, Март, Цэргийн баяр, Хүүхдийн номын өдөр, үндэсний бичиг үсэг, номын өдрүүдээс гадна төлөвлөгөөт бус цаг үеийн асуудал тэмдэглэлт өдрүүдээр 80 удаа 3126 номоор, монгол бичгийн бүтээл хүүхдийн гар зургийн бүтээл, тэргүүний уншигч анги хамт олны хийсэн бүтээлч ажлын 371 бүтээлээр сэдэвчилсэн 80 удаа шинэ номын 20 удаагийн үзэсгэлэн гаргасан байна.

ТАВ. НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Орхон аймгийн өдөр тутмын хэвлэл болох “Өнөөгийн эрдэнэт”, “Шинэ мэдээ” сонины өгүүллийн нийтлэлийг ZOTERO номзүйн программд оруулсан. Нийт 2023 оны 1-5 сарын дугаарын 192 өгүүлэл оруулсан.

1976 – 2022 оны хооронд Орхон аймгаас төрөн гарсан алдартан, гавьяатнуудын судалгааг нэгтгэсэн. Үүнд: Хөдөлмөрийн баатар-8, Төрийн соёрхолт-2, Гавьяат 89 хүний материал орсон. Мөн уг судалгааг үндэслэн “Орхон аймгаас төрсөн алдартнууд” – г цувралаар бичлэг болгон мэдээллийн сан бий болгож байна. Одоогийн байдлаар нийт 14 хүний танилцуулга бэлтгэн мэдээллийн сан бүрдүүлсэн.

ЗУРГАА. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн 2 давхарын 3 танхим, коридорт камер NBR poEswich-1 ширхэг Juan камер 9 ширхэг нийтдээ кабел, хард 10 ширхэг, 3580,0 төгрөгөөр хийгдсэн байна.Үр дүнгийн санхүүжилтээр олгогдсон төсвөөс гадна 2 ширхэг гадна камерийг шийдвэрлэж ингэснээр нийтийн номын сан бүрэн камержлаа.

Танхимуудын болон ажилчдын суурин компьютерийн хурдын нэмэгдүүлэх зорилгоор 9ш SSD хард диск, *Kaspersky plus вирусны программын лиценз авч суулгаж цахим орчны аюулгүй байдал* хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.

ДОЛОО. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол улсын Үндэсний номын сан нь аймгийн нийтийн номын сангуудыг мэргэжлийн аргазүйн удирдлагаар хангаж үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлж аймгийн нийтийн номын сан нь тухайн нутаг дэвсгэр дээрх номын сангуудад мэргэжлийн аргазүйгээр хангаж ажилладаг.

2023 онд Номын сангийн Уншлага үйлчилгээний албаны дарга Н.Отгонцагаан, Номзүйч Ч.Эрдэнэсувд нар 6 удаагийн аргазүйн зөвлөгөө тусламж үзүүлсэнээс “Аялгуу” “Хэмнэл” соёлын төв, “Миний гэр” цэцэрлэг, ахмадын хорооны номын сан зэрэг байгууллагууд хамрагдсан байна.

Номын санчдын тэмцээнд оролцоход нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй оролцож Хэнтий Сүхбаатар аймгийн төв номын сангуудаар явж туршлага судаллаа.

НАЙМ. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

Аймгийн нийтийн номын сан нь 21 хүний орон тоотой уншлага үйлчилгээний номын санч 9, уншлага үйлчилгээний албаны дарга-фондоч-1, номзүйч 1,мэдээллийн ажилтан 1, болон мэргэжлийн боловсон хүчин 12, захиргаа аж ахуйн ажилтан 9 хүн ажилладаг.4 танхим нь 2 ээлжийн номын санчтай амралтын өдөргүйгээр уншлага үйлчилгээгээ явуулдаг. Хүний нөөцийн хангалт сайн. 2023 онд аймагт Хүүхдийн номын ордон шинээр ашиглалтанд орохоор төлөвлөгдөж байгаа.

2023 онд номын санд 2 номын санч жирэмсэний амралт авч, 2 үйлчилгээний ажилтан ажлаас өөрийн хүсэлтээр гарч 4 албан хаагч шинээр ажилд орсон байна. Нийт 21 албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг хийж шинээр орсон 2 албан хаагчийн хувийн хэргийг бүрэн бүрдүүлэх ажил хийгдэж байна. Нийт албан хаагчдын хувийн хэргйн хавтсыг 359.0   төгрөгөөр шинэчилсэн   байна.

Энэ онд нийт 29 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 20 хүн хамрагдсан байна. Үүнд:

Соёл урлагийн зохион байгуулсан хөдөлмөр аюулгүй байдал, сэтгэлзүй, албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн чиглэлээр 8 удаагийн сургалт

- Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан сургалтууд 6 удаа
- ҮЭ-ээс зохион байгуулсан сургалтууд 4 удаа

- ТАЗ-өөс зохион байгуулсан сургалтуудад цахимаар болон танхимаар ажиллагсадаа хамруулснаас гадна захирал Соёлын яамнаас зохион байгуулсан 8 сургалтанд хамрагдсан.
- Мөн байгууллага хамт олноороо гамшгаас хамгаалах, эрүүл мэндийн сургалтуудыг санаачлан зохион байгуулж байна.
- Улсын номын санчдын зөвлөгөөнд 2 өдөр оролцсон байна.

Номын санд ажиллагсдад тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар

Мэдээллийн эрин зуун дахь технологийн шинэчлэлт нь уламжлалт номын сангийн үйл ажиллагааны орчинг өөрчлөн шинэчилж, нэг талаас сан хөмрөгийг хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй болгох, нөгөө талаас технологийн дэвшил ашиглан хурдан шуурхай үйлчлэх боломжийг номын санд нэвтрүүлэх

- Электрон хэлбэрээр гарах номын тоо өсөхийн хэрээр тэдгээрийг унших, ашиглах, хадгалах хэрэгслүүд шинэчлэгдэн улам боловсронгуй болж уншигчдад олон сонголтууд бий болгох.
- Номын сан хөмрөгт байгаа ганц хувьтай номын жагсаалт, сан хөмрөгт буй цахимжуулах шаардлагатай номын тоо, цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх.
- Цахим мэдээллийн сан үүсгэх техник тоног төхөөрөмжийн судалгаа хийж, техникийн тодорхойлолтын гаргаж нэвтрүүлэх.
- Ном хэвлэлийг цахим хэлбэрт оруулах аргачлалыг нэвтрүүлэх.
- “Цахим ном бэлтгэхэд хэрэглэгддэг программ
    - Дэвтэрчлэн харуулах програмын лиценз
    - Оффис програмын лиценз
    - Зурган файлыг текст хэлбэрт шилжүүлэх програмын лиценз гэх мэт лицензтэй программ ашиглах.

9. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

2023 онд 452350,3 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт авсанаас өөрийн орлогын биелэлт 6046,0 мянган төгрөг болж Сангийн сайдын 74 дүгээр тушаалыг үндэслэн 3714,0 мянган төгрөгийн давсан орлогыг Номын баярын соёл танин мэдэхүйн ажлын шагнал Нэг удаагийн тэтгэмж 1800,0 мянган төгрөг, Урсгал засвар зардал 3714,0 сая гаруй мянган төгрөгийг зарцуулан ажилласан байна. Нийт ажиллагсдын цалингийн сан 311093,5 төгрөгөөр батлагдсанаас үндсэн цалинд 207349,7 төгрөг зарцуулж ур чадвар үр дүн 21827,7 төгрөг, унаа хоолны зардалд 23257,0 төгрөг, илүү цаг, шөнийн нэмэгдэл 2829,4 Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 хавсралтаар орон нутгийн нэмэгдэл 9402,8 төгрөгийг тус тус олгосон байна.. Урсгал засвар 4100,0 мянган төгрөг батлагдсаныг байгууллагын дээврийн засвар, дотор хана шат будах, цахилгааны монтаж шинэчлэх зэрэг ажил хийж гүйцэтгэлээ.

10. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2023 онд номзүйч, мэдээллийн ажилтанг АНУ-ын Элчин сайдын яамны

дэмжлэгээр Америкийн соёл мэдээллийн төвийн үйл ажиллагаатай танилцуулах, Дархан-уул аймгийн Нийтийн номын сан, Хүүхдийн номын сан, Улаанбаатар хотын Төв номын сангийн үйл ажиллагаа, цахимжуулалттай танилцууллаа

- Нийт 55,0 сая төгрөгийн техник хэрэгслийг орон нутгийн төсөвөөр авсан.
- Гүйцэтгэлд суурилсан үр дүнгийн санхүүжилтийн 31 сая төгрөг

олгогдсоноос 40 хувийг нь тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг шинэчлэх, нэмэгдүүлэхэд зориулж байна.

- Мөн Соёлын сайд Орхон аймагт ажиллах үеэр олгосон 10 сая төгрөгийн 50 хувийг ажиллагсдын тоног төхөөрөмж шинэчлэхэд зориулж байна.
- Дээд давхарын 3 танхим, коридорт камер NBR poEswich-1 ширхэг Juan камер 9 ширхэг нийтдээ кабел, хард 10 ширхэг, 3580,0 төгрөгөөр хийгдсэн байна.
- Үр дүнгийн санхүүжилтээр олгогдсон төсвөөс гадна 2 ширхэг гадна камерийг шийдвэрлэлээ.
- Нийт ажиллагсдын витаминжуулалт хийж 1680,0 мянган төгрөг зарцуулсан байна
- Сүхбаатар аймагт болсон Номын санчдын спортын тэмцээнд гар бөмбөгийн холимог баг Хүрэл медаль, дартас теннисээр мөнгө хүрэл медаль тус тус авсан байна.

11.ХАВСРАЛТ

НОМЫН БАЯРЫН НЭЭЛИЙН АЖИЛЛАГАА БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

УРТ ЦАГААНЫ ГУДМАНД ҮРГЭЛЖИЛСЭН НОМЫН БАЯР



Зохиол үлгэрийн баатрууд амилсан

НОМЫН БАЯРЫН ӨДРҮҮДЭЭР ХИЙСЭН СОНА, Яруу найргийн болон дууны

“OPEN MIC”

“ ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН ӨДӨР”

“ДЭЛХИЙН ХҮҮХДИЙН НОМЫН ӨДӨР” ӨДӨРЛӨГ

ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ТУРШЛАГА СУДАЛСАН НЬ

“ХИЛ ХЯЗГААРГҮЙ НОМЫН САН” ТӨСӨЛИЙН СУРГАЛТ

ЗӨӨВРИЙН НОМЫН САН

БАЙГУУЛЛАГА, ГЭРИЙН НОМЫН САН ШАЛГАРУУЛАЛТ



Тогтмол хэвлэлийн сэлбэн засалт

АРДЫН УРАН ЗОХИОЛЧ Д.ПҮРЭВДОРЖИЙН НЭРЭМЖИТ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВ САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. НОМЫН САНГИЙН АЛСЫН ХАРАА ЗОРИЛГО ЗОРИЛТ,ЗОРИЛГО, ЗОРИЛТ А

Алсын хараа:

Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн уншигчдад бие даан суралцах,боловсрол эзэмших, цахимжуулах, номын санг нээлттэй мэдээллийн төв болгон хөгжүүлэхэд оршино.

Зорилго:

Уншигч, иргэдэд мэдээлэл, мэдлэг олж авах орон нутгийн оюуны хөгжлийн нээлттэй мэдээллийн төв болох

Зорилт:

Номын сангийн үйлчилгээг хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхтэй мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс “Соёлын хамтын ажиллагааны жил ” болгон зорилт тавин ажилласан.

ХОЁР. САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Сан хөмрөгт 22606 нэр төрлийн 49152 номтой. Зохион байгуулалтын хувьд: Англи орос номын фонд, Монгол номын фонд   төрөл анги, үсэг дараалаар байрлагдсан.

Танхим бүрд ойрын фондтой. /хүснэгтээр/

№	Танхимын нэр	Номын нэр төрөл	Ойрын фондын номын тоо
1.	Үндсэн фонд	18730	40734
2.	Хүүхдийн номын өргөө /салбар/	2279	2850
3.	Хүүхдийн уншлагын Ирээдүй танхим	859	1547

4.	Боловсрол танхим	556	680
5.	Гэрээр ном олгох танхим	2362	2982
6.	Лавлагаа ном зүй	274	359

Фондын сан хөмрөгийг шинээр хэвлэгдэн гарсан шилдэг ном зохиолууд болон иргэд уншигчдын эрэлт хэрэгцээний дагуу санал хүсэлтийг үндэслэн бүрдүүлж, төсвөөр 9405383 төгрөгний 451 ш, хандиваар 4144051 төгрөгний 415 ш, нийт 13549483 сая төгрөгний 605 нэр төрлийн 866 номоор фондыг бүрдүүлэн уншлага үйлчилгээнд гаргасан.

Уншигчдын захиалгаар Гэрээр ном олгох танхимд 135, Хүүхдийн номын өргөөнд 88 , Хүүхдийн уншлагын "Ирээдүй" танхимд 10, Боловсрол танхимд 7, бүгд 269 номыг сан хөмрөгч шилжүүлгээр олгож үйлчилсэн.

Анагаах ухааны салбар /600-610/ нийгмийн шинжлэх ухааны салбар /370/ ангилан цэгцэлж тавиурын заалт хийн, үсэг дарааллын ялгагч хийв.

Ашиглах боломжгүй сурах бичиг, агуулга хуучирсан урагдаж элэгдсэн 2068.2 төгрөгний 2513 номыг сан хөмрөгөөс чөлөөлж, электрон катологи болон номын нэг бүрчилсэн бүртгэлээс хасалт хийж устгалд оруулав.

Уншлагын явцад урагдаж элэгдсэн уншигчийн шаардлага хангахгүй болсон нийт 259 номыг сэлбэн засаж үйлчилгээнд гаргасан байна. Танхимаар нь авч үзвэл:

-Сан хөмрөг-30
-Хүүхдийн номын өргөө- 83
-Боловсрол танхим-30
-Гэрээр ном олгох-64
-Ирээдүй танхим -52



Номын санчид улирал хагас жилээр ойрын фондоо тоолон, уншигчийн гар дээр удсан хугацаа хэтэрсэн номын судалгааг гарган уншигчдаас авах ажлыг хоёр удаа зохион байгуулж 86 номыг эргүүлэн авсан байна.

Гэрээр ном олгох танхимууд нь ирсэн номыг өдөр бүр цэвэрлэн, нийт 11000 гаруй номыг ариутгах үйл ажиллагаа хийсэн байна. Энэ нь номоор дамжих халдварыг багасгах, эрүүл ахуйн шаардлага хангахад чухал нөлөө үзүүлсэн байна.

ГУРАВ. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Хүүхдийн номын өргөө /салбар номын сан/ Ахлах анги
- Хүүхдийн уншлагын Ирээдүй танхим /1-5 дугаар анги/
- Боловсрол танхим /6-8 дугаар анги/
- Гэрээр ном олгох танхим - / насан хүрэгчид/
- Лавлагаа номзүйн танхим
- Интернэт танхимаар уншигчдад номын сангийн үйлчилгээг /танхимаар, гэрээр, цахимаар, зөөврөөр/ 2637 уншигч, 23210 иргэсдэд 26734 ном олгож уншигчдын оюуны хэрэгцээг хангаж, ном соёлын үйлчилгээг хүргэн ажиллалаа.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг 11 байгууллагад нийт 693 номоор хүргэж үйлчилсэн байна.

- МСҮТөвд -32
- 256 цэргийн ангид-138
- ЕБ-ын 4 дүгээр сургуулийн наранцэцэг багштай 4а анги-80
- ЕБ-ын 2 дугаар сургууль-20
- ЕБ-ын 4 дүгээр сургууль-20
- Мэргэд сургууль-20
- СӨББ 2 дугаар цэцэрлэг-20
- Гэр бүл хүний хөгжлийн төв-20
- Хөгжим драмын театр-38
- “Нэг ном-эрхэм үйлс” аяны хүрээнд цэцэрлэгүүдэд-162
- ЕБ-ын дотуур байр-43
- Номын богц үйлчилгээ цэцэрлэгт -100

Уншигчдыг хичээл давтах, ном уншлагаас гадна цагийг үр бүтээлтэй өнгөрөөх хөгжүүлэх зорилгоор даам, шатар, шагайн наадгай зэрэг оюуны тоглоомыг Хүүхдийн номын өргөөнд бий болголоо.

Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдээр мэдээлллийг цахимаар хүргэн агуулгын тайлбартайгаар 1862 уншигчдад сурталчилсан.

- Үндсэн хуулийн өдөр- 27
- Дэлхийн номын өдөр-50
- Үндэсний бичиг үсгийн баяр -100
- Дэлхийн номын өдөр-215
- АУЗохиолч Д.Пүрэвдоржийн 90 насны ой- 84
- Монгол бахархлын өдөр-38
- Чингис хаан-26
- Олон улсын театрын өдөр-100
- Бүтээлч залуус хөтөлбөр-70
- “Нэг ном эрхэм үйлс” аян-379
- Номын баяр-393
- Шинэ ном -380 тус тус сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэн гаргасан.





Цахим номын санд 300 гаруй номтой. Нийт 45 уншигч 64 номыг уншсан. Мөн сурах бичиг ашиглаж хичээлээ хийж сууж байна. Яруу найрагч МЗЭ-ийн гишүүн Батгэрэл өөрийн 2 номыг оруулах эрхийг өгч цахим номын санд байршуулж уншигчдад хэрэглүүлж байна.



Номын хэлэлцүүлэг уулзалтыг 6 удаа зохион байгуулж 456 уншигч хамрагдсан байна.

ДӨРӨВ .СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

“ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР”-ыг 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдөр Хүүхдийн номын өргөөнд бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг таниулах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх олон нийтэд сурталчилан таниулах соёл танин мэдэхүйн ажлыг явууллаа.

Энэ жил "ХҮҮХЭД БҮР УНШИГЧ" уриатайгаар, хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэх, унших дадалд сургах, ном эрдмийн ажлыг сурталчлан таниулах зорилгоор “БҮТЭЭЛЧ УНШЛАГА-2023" аяныг Өвөрхангай аймгийн хэмжээнд зохион байгуулж 19135 уншигчдад 23574 номоор үйлчилж, бүх нийтийн соёлын боловсрол олгох нөлөөллийн ажилд 7459 хүнийг хамруулсан амжилтаар номоо баяраа угтлаа.

Номын баяр хүүхдийн номын өргөөнд номыг хүндэлдэг, номын сангийн уншигчдын төлөөлөл, тэргүүний уншигчид багш нар, иргэд, Аймгийн нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Сайнжаргал, аймгийн соёл урлагийн газрын хэлтсийн дарга Л.Пүрэвлхам, сумын болон сургуулийн номын санч мэдээллийн ажилтнууд 375 хүн номын баярт оролцсон байна.

Үндэсний бичиг үсгийн баярын хүрээнд “Миний монгол бичиг” аяныг өрнүүлж 6-н төрлийн уралдааныг насны ангиллаар зохион байгуулсан. Нийт 187 хүүхэд шалгаран оролцсоноос:

“Хурдан зөв унших” уралдаан 8-9 дугаар анги:

- 1 – р байр : 2- дугаар сургуулийн 8-а анги О.Нансалмаа
- 2 – р байр : хужирт сум 9-а анги Б.МөнхдалаЙ
- 3 – р байр : 5 – дугаар сургууль 9а анги П.Цэрэндорж

“Хурдан зөв унших” уралдаан 10-12 дугаар анги:

- 1 – р байр : 4- дүгээр сургууль 10а анги Ц.Сайнбилэг
- 2 – р байр : 1- дүгээр сургууль 11-г У.Чанцалдиймаа
- 3 – р байр : 4- дүгээр сургууль 11-а анги Б. Анун

“**Хичээнгүй бичигтэн**” уралдаан 11-12 дугаар анги:

- 1 – р байр: 4 дүгээр сургуулийн 11-а ангийн сурагч Н. Хандсүрэн
- 2 – р байр: 4 дүгээр сургуулийн 11-а ангийн сурагч   Б.Ангараг
- 3 – р байр: 5- дугаар сургуулийн 12-б ангийн сурагч Д.Отгонсүрэн

“Алдаагүй зөв бичигтэн” уралдаан 6-8 дугаар анги

-

- 1 – р байр : ББУлаан сум ЕБС-ийн 8б анги Д.Болор-Эрдэнэ
- 2 – р байр : 4- дүгээр сургууль 7а анги М.Болорчимэг
- 3 – р байр :   2- дугаар сургууль 7в анги М.Долгормаа

-

“Цахим монгол бичиг” уралдаанд /Ахлах анги/

-

- 1 – р байр : 1 дүгээр сургууль 11г анги У.Чанцалдиймаа
- 2 – р байр : Хужирт сум ебс-ийн сурагч С.Ариунжаргал
- 3 – р байр : Мэргэд лабортари сургуулийн 11 а ангийн сурагч Б.Номинзул нар тус тус шалгарсан болно.

Уран дүрст бичлэгийн уралдаанд нийт 60-аад бүтээл ирснээс мэргэжлийн багш нар, иргэд, хүүхдийн ангиллаар шалгаруулан бүтээлийн үзэсгэлэн гарган иргэд багш нараа алдаршуулан нийтэд танилцууллаа.

НОМЫН БАЯР
илүү их уншъя

НОМЫН БАЯР
илүү их уншъя

СОЁЛЫН ЯАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САН
НОМЫН БАЯР

СОЁЛЫН ЯАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САН
НОМЫН БАЯР
илүү их уншъя

СОЁЛЫН ЯАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САН

СОЁЛЫН ЯАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САН

БАЯР

Мөн “Үлгэрийн баатрууд аялсан нь” дүрийн тоглолтын уралдааныг СӨБайгууллагын бэлтгэл бүлгийн дунд зарлаж нийт 9 цэцэрлэгийн 270 сурагч оролцож, ангидаа уншсан номоороо чанга уншлага хийж, ойлгож сонссон үлгэрээ жүжигчилсэн хэлбэрээр ном уншихын ач тусыг ойлгуулан сурталчилсан соёлын боловсролын ажил боллоо.

1 – р байр : Арвайхээр сумын 10 дугаар цэцэрлэг “ Царцаа намжил”

2 – р байр : Арвайхээр сумын 4 дүгээр цэцэрлэг “ 12 жил ”

3 – р байр : Уянга сумын Жаргалант багийн “Царцаа намжил”

“ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ ХАМТ ОЛОН”

- 1-2 дугаар анги:

  1 – р байр : Мэргэд лабортари сургуулийн Сүрэнхорлоо багштай 1-б анги

- 3-5 дугаар анги:

1 – р байр : 4 дүгээр сургуулийн Наранцэцэг багштай 3-а анги

2 – р байр : Мэргэд лабортари сургуулийн Мөнх-Адъяа багштай 5-б анги

3 – р байр : 1 дүгээр сургуулийн Хажидмаа багштай 3-а анги

- 6-8 дугаар анги:

1 – р байр : ЕБ-ийн 4 дүгээр сургуулийн Гүнсэнхорлоо багштай 7-б анги

2 – р байр : : ЕБ-ийн 4 дүгээр сургуулийн Нэргүй багштай 8-в анги

3 – р байр : ЕБ-ийн 4 дүгээр сургуулийн Соронзонбал 7-в анги ангиараа 870-1375 ш ном уншиж тэмдэглэл хөтлөн тэргүүлсэн байна.

“НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ ” УРАЛДААН

3-5 дугаар анги:

1 – р байр : мэргэд сургуулийн 4-а ангийн сурагч М.Хүслэн

2 – р байр : 4 дүгээр сургуулийн 3-а ангийн сурагч Л. Энхжаргал

3 – р байр : 2 дугаар сургуулийн 5-е ангийн сурагч Г.Элбэгбаяр

- 6-8 дугаар анги:

1 – р байр : 4 дүгээр сургуулийн 8-в ангийн сурагч Д.Бямба

2 – р байр : мэргэд сургуулийн 8-а ангийн сурагч Ш.Эрдэнэсүрэн

3 – р байр : Бат-Өлзий сумын ЕБС-ийн 6-а ангийн сурагч Оюунсүрэн

- 9-10 дугаар анги:

1 – р байр : 1 дүгээр сургуулийн 11-г ангийн сурагч С.Болормаа

2 – р байр : 1 дүгээр сургуулийн 11-г ангийн сурагч Э.Цэвэлмаа

3 – р байр : 1 дүгээр сургуулийн 11-г ангийн сурагч Жанцалдиймаа

“НОМЫН БАЯР-БИДНИЙ БАЯР” ЗОХИОН БИЧЛЭГИЙН УРАЛДААН

3-5 дугаар анги:

1 – р байр :Баянгол сумын ЕБ-ийн сургуулийн 5-а ангийн сурагч Юмжирдулам

2 – р байр :Арвайхээр сумын ЕБ-ийн 2 дугаар сургуулийн 4-д ангийн сурагч П.Мөнхгэрэл

3 – р байр : Арвайхээр сумын ЕБ-ийн 4 дүгээр сургуулийн 3-а ангийн сурагч Б.Отгонжаргал

“МИНИЙ УНШСАН НОМ” ГАР ЗУРГИЙН УРАЛДААН

6-10 дугаар ангийн сурагчдын дунд уншсан номоо гар зургаар илэрхийлэх уралдаанд сум сургуулиас шалгарсан нийт 48 бүтээл ирснээс:

1 – р байр : Арвайхээр сумын ЕБ-ийн 1 дүгээр сургуулийн 6-б ангийн сурагч С. Мөнхсаруул

2 – р байр : Төгрөг сумын ЕБС-ийн 9-а ангийн сурагч Ц.Бямбасүрэн

3 – р байр : Баянгол сумын ЕБС-ийн 8-б ангийн сурагч Б.Лхавгарагчаа нар шалгарлаа.

“МОНГОЛЧУУДЫН ЭРХЭМЛЭН ДЭЭДЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛ” ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН

- 9-12 дугаар ангийн төрөлд нийт 58 эссэ ирснээс:

1 – р байр : Баянгол сумын ЕБС-ийн 10-а ангийн сурагч Б.Ганзаяа

2 – р байр : Хархорин сумын ЕБ-ийн гүнзгий сургуулийн 11-а анги Н.Саруул

3 – р байр :Сант сумын ЕБ-ийн сургуулийн 11-а ангийн сурагч О.Сансармаа



Тэргүүний уншигч, Номын эзэд шалгаруулах үйл ажиллагааг зохион нийт 31 сурагч болзлыг хanган номын баяраар тэргүүний уншигч тэмдгээ гардан авлаа.

Номын санч мэдээллийн ажилтнуудын чадавхжуулах зорилгын хүрээнд “Монголчуудын үнэт зүйл” илтгэлийн уралдааныг зарлан номын баяраар дүгнэж, нийт 13 илтгэл ирснээс:

Зүүн баян улаан сумын номын санч мэдээллийн ажилтан Д.Цэцэгмаа

Хархорин сумын номын санч мэдээллийн ажилтан Ц.Цэцгээ

Хужирт сумын номын санч Б. Лхагвадулам нар шалгарлаа.

Номын баярыг хамгийн сайн зохион байгуулсан сумын соёлын төвийг удирдамжийн дагуу шалгаруулан шагналыг гардууллаа.

1. Есөн зүйл сумын соёлын төв
2. Хархорин сумын соёлын төв
3. Сант сумын соёлын төв

Номын баяраар:

-Тэргүүний уншигч Оюундэлгэрийн сэтгэгдэл яриа

-“Үлгэрээ ярья” цэцэрлэгийн бяцхан сурагч Өсөх-Ирээдүй “Шаварт унасан шарга даага” үлгэр

-12 дугаар цэцэрлэгийн дүрийн тоглолт

-Товшуур хөгжмийн тоглолт

-Бүтээлийн үзэсгэлэн

-зургийн үзэсгэлэн

-Бийрэн бичлэгийн үзэсгэлэн,уралдаан

-Сумын номын сангуудын үйл ажиллагааны тайлан,үзэсгэлэн

-Том жижиг ном;

Номын тэмдэглэлийн үзэсгэлэн дэлгэн үзүүллээ.

Номын баярын үйл ажиллагааны зардалд нийт 5000000 сая төгрөгийн зарцуулан, гэрээт байгууллагуудтай хамтран ажиллалаа.

"Энх мэндийн аялгуу" ардын дууны цахим уралдаанд 32 уран бүтээл оролцсоноос:

1- р байрыг Политехник коллежийн Өвөрхангай аймаг дахь салбар сургуулийн багш Б.Чанцал, Н.Ууганбаяр

2- р байрыг Арвайхээр сумын IX СӨББ- ын багш Н.Данаажав

3- р байрыг Хархорин сумын өвлөн уламжлагч Д.Үнэнбаяр нар тус тус эзэллээ.

"Амар байна уу" үндэсний бичгийн захидлын уралдаанд 92 бүтээл оролцсоноос:

Насанд хүрэгчдийн ангилалд:

1- р байрыг Бат- Өлзий сумын иргэн Ц..Баасанжав

2- р байрыг Арвайхээр сумын IV СӨББ- ын нягтлан бодогч Б.Баярмаа

3- р байрыг Хархорин сумын ЕБС- ийн багш И.Чулуунцэцэг

ЕБС- ийн Ахлах насны ангилалд:

1- р байрыг Хархорин сумын ЕБС- ийн 12 дугаар ангийн сурагч Б.Ариунсанаа

2- р байрыг Хужирт сумын ЕБС- ийн 9а ангийн сурагч М.Цэгц

3- р байрыг Арвайхээр сумын ЕБ- ын I сургуулийн 10г ангийн сурагч н.Чанцалдиймаа

Тусгай байрыг: Нарийнтээл сумын иргэн Э.Ариунтуяа нар тус тус эзэллээ

"Золгох нутаг" гар зургийн уралдаанд 116 бүтээл оролцсоноос:

Ахлах анги:

1- р байрыг Богд сумын ЕБС- ийн 12а ангийн сурагч Б.Оюунзаяа

2- р байрыг Арвайхээр сумын Мэргэд лаборатори сургуулийн 10б ангийн сурагч Б.Баярт-Энх

3- р байрыг Арвайхээр сумын ЕБ- ын I сургуулийн сурагч М.Арвин

Тусгай байрыг Тэмүүлэл Эрдэм сургуулийн 9а ангийн сурагч Д.Хулан

Тусгай байрыг Арвайхээр сумын ЕБ- ын II сургуулийн сурагч Ш.Ганхуяг

Золгох нутаг гар зургийн уралдааны

Дунд анги:

1- р байрыг Арвайхээр сумын I сургуулийн 6в ангийн сурагч С.Мөнхсаруул

2- р байрыг Бүрд сумын ЕБ- ын 8а ангийн сурагч Н.Анунгоо

3- р байрыг Арвайхээр сумын I сургуулийн 8а ангийн сурагч С.Буянжаргал

Тусгай байр Арвайхээр сумын ЕБ- ын I сургуулийн 8е ангийн сурагч Б.Номинжаргал

Тусгай байр Арвайхээр сумын ЕБ- ын V сургуулийн сурагч Х.Зулцэцэг нар тус тус эзэллээ.

Амар байна уу арга хэмжээ өв, соёлоо дээдэлсэн үндэсний бичиг үсгээ хичээсэн, ардын дуугаараа түрлэг өргөсөн сайхан арга хэмжээ боллоо.

Нэг ном-эрхэм үйлс аяны хүрээнд “Эртэч оюунлаг Өвөрхангайчууд” арга хэмжээг 25 өдрийн өглөө бүр зохион байгуулж, СӨББайгууллагын 13 цэцэрлэгийн эцэг эх,хүүхэд багш нар,соёлын байгууллагууд, боловсролын салбарын удирдлагуудыг урьж оролцуулан номын сангаа танилцуулан, уншсан номоо ярилцаж,нэг нэгэндээ

бэлэглэж,номын санд карт нээлгэн нийт 1785 иргэн оролцож, бүх нийтийн соёын боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгууллаа.

Дэлхийн номын өдрөөр Аймгийн хөгжимт драмын театрын ажилчдыг урин кофегоор дайлан шинэ ном,сэдэвчилсэн номын үзэсгэлэн гарган бүх нийтийн соёлын боловсрол,бүжгийн боловсрол, хөгжмийн боловсролыг дээшлүүлэх лекц танилцуулгыг 46 хүнийг хамруулан үнэгүй карт нээж 64 ном гэрээр олгож үйлчлэв. Мөн уншигчдад

гитар хөгжмийн тухай ойлголтыг өгч хөгжим ангийн багш нар гитарын сургалт орохоор төлөвлөсөн. Мөн уншигч хүүхдүүд театрын ах эгч нартаа шүлгээр мэндчилгээ дэвшүүллээ.

Намрын номын баярыг “Номтой Монгол” нэрийн дор АУЗ,Төрийн соёрхолт Д.Пүрэвдоржийн 90 насны ойтой хамтатган төлөвлөгөө боловсруулан аймгийн засаг даргад төсөл бичиж 2690000 мянган төгрөгийг шийдүүлж,Хүүхдийн номын өргөөнд болж 352 хүүхэд багачууд уншигчдын төлөөлөл оролцлоо.

Номын баяраар Үлгэрээс үлгэрлэе, Уншаад урагшлахуй, Номын өргөө гэсэн 3 хотхон ажиллуулж номын үзэсгэлэн гаргаж, аман өвийг сурталчилан таниулах зорилгоор

- Монгол ардын аман зохиол
- Монгол ардын үлгэр
- Домог үлгэр
- Зүйр цэцэн үг, Ерөөл магтаал, Оньсого
- Бусад орны орчуулгын аман зохиол

- Дэлгэмэл ном, номон бүтээл гэсэн төрлүүдээр үзэсгэлэн гаргаж уншигч хүүхэд багачууд, баярт хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчид, багш сурган хүмүүжүүлэгчид, зохиолчид, эх эхчүүд хотхоны үйл ажиллагаа танилцууллаа.

  - Зүйр цэцэн үг хэлэх
  - Оньсого таалгах
  - Хэлц үг аман өв сурталчилах үүднээс АХА
  - Танин мэдэйхүйн Алтан хонх зэрэг тэмцээн уралдааныг явуулж шагнал урамшил гардуулсан байна.

АУЗ Төрийн соёрхолт яруу найрагч Д.Пүрэвдоржийн 90 насны ойн хүрээнд “Их найрагчийн эгэлгүй түүх” зохиолч уншигчдын уулзалт боллоо. Уулзалтанд Алтан бярга, Арвайн хүрээ утга зохиолын нэгдлийн зохиолчид, уншигчид 42 **хүн оролцлоо.**

“Соёл” “Альфа book” номын дэгүүртэй хамтран.30-70 хувийн хямдралтай Номын худалдаа зохион байгуулж, 1 сая төгрөгний борлуулалт хийгдсэн байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн Баатар, Ардын Уран Зохиолч Төрийн соёрхолт Яруу Найрагч Дэндэвийн Пүрэвдоржийн 90 насны ойг Аймгийн соёл урлагийн газар, зохиолчдын эвлэлтэй хамтран зохион байгууллаа.

-Монгол Улсын Хөдөлмөрийн Баатар, Ардын Уран Зохиолч Төрийн Соёрхолт Яруу Найрагч Өвөрхангай аймгийн Бүрд сумын уугуул Дэндэвийн Пүрэвдоржийн мэндэлсний 90 насны ойн хүндэтгэлийн арга хэмжээнд ЕБС-ын төвийн 6 сургуулийн 1200 сурагч "Тусгаар тогтнол" шүлгийг хүндэтгэн уншлаа.

-Уран үгсийн чуулган

-Зохиолч уншигчдын уулзалт

- Бүрд сумын эрээн ууланд очиж хүндэтгэл үзүүлэх ёслол

-Залуус цэцэрлэгт 90 мод тарих ажиллагаа

-Ном хандивлах, хүлээн авах ёслол боллоо. Нийт 1600 хүн их зохиолчийн 90 насны ойн арга хэмжээнд хүрэлцэн ирж оролцсон байна.

“БҮТЭЭЛЧ ЗАЛУУС” хөтөлбөр

“Эрүүл хүнс эерэг хандлага” зорилтот жил, “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Арвайхээр сумын засаг даргын тамгын газар, багийн дарга нартай хамтран “Бүтээлч залуус” уулзалт өдөрлөг сургалтыг зохион байгууллаа. Өдөрлөг, сургалтаар 13 багийн нийт 130 хүн хамрагдлаа. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эрүүл хүнсний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, залуучуудын хөпдөлмөрт хандах хандлагыг өөрчлөх,

амжилттай хөдөлмөрлөж байгаа иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх, бүтээлч залуучуудыг ном унших соёлд сургах зорилготой.

- Монголчуудын идээ ундааны уламжлалт соёл
- Өрхийн тариалан,бизнесийг хөгжүүлэх
- Хоршоо жижиг дунд үйлдвэрлэлийн зээл
- Төсөл хөтөлбөр,хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- Газрын тухай ойлголт
- Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйл
- Ном уншихуйн гайхамшиг сургалт танилцуулга хийлээ.

Мөн шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж уншигчийн карт нээх үйлчилгээг үзүүлсэн байна.

Хоёр. “Уншлагыг дэмжье” ном унших хөтөлбөр
Соёлын бүтээлч сарын хүрээнд болон танхимын номын эргэлтийг сайжруулах, уншигчийн тоог нэмэх зорилгоор төрийн албан хаагч, аж ахуй нэгжүүдийн дунд “Уншлагыг дэмжье” ном унших хөтөлбөр зохион байгууллаа. Хөтөлбөрт :

1. Аймгийн ХДТеатр
2. Мэргэд сургууль
3. 4 дүгээр сургууль
4. 2 дугаар цэцэрлэг
5. ЗХ-ны 256 дугаар анги
6. Хуримын ордон
7. 2 дугаар сургуулиуд оролцож байна

Удирдамжийн дагуу 2023-11-22-нд “Өглөөний уулзалт”-ыг зохион байгуулсан ба Төв номын сангийн аргазүйч Д.Отгонболор "Номын сангийн танилцуулга" мэдээлэл, “Ном уншихуйн гайхамшиг” сургалт, Аймгийн СУГ-ын мэргэжилтэн Оюунгэрэл нарын “Монгол хүний эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйл “ лекцэнд хамрагдаж өглөөний цайтай уулзалт боллоо.

Гурав. “Танд ойрхон номын сан” “Номтой цэрэг” хөтөлбөр хэрэгжлээ.

Соёлын бүтээлч сарын төлөвлөгөөнд тусгагдсан “Танд ойрхон номын сан” , “Номтой цэрэг” хөтөлбөрийг ЗХ-ны 256 дугаар ангид хэрэгжүүллээ. /67 албан хаагч , 150 цэрэг оролцсон.

Тус арга хэмжээгээр Аймгийн СУГ-ын мэргэжилтэн Оюунгэрэлийг урин “Монголчуудын эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйл” лекц уншуулан ЗХ-ны 256 дугаар ангийн бие бүрэлдэхүүн, байлдагч нарыг хамрууллаа.

Мөн ажилтан албан хаагчдын дунд “50 номын уналт” танин мэдэхүйн тэмцээн, хугацаат цэргийн албан хаагчдад асуулт хариултын “АХА” тэмцээнийг зохион байгуулан амжилттай оролцсон оролцогчдыг шагнаж урамшууллаа.



Зөөврийн номын сангаар үйлчлэн 118 ширхэг шинэ болон салбар шинжлэх ухааны номууд, хүүхдийн уран зохиолын номуудаар үзэсгэлэн гаргасан ба номын сангийн электрон каталогийг сурталчилан qr кодыг ажилтан албан хаагчдад тараалаа.

Дөрөв. Соёлын бүтээлч сар- Гучин-Ус суманд соёл танин мэдэхүйн ажил зохион байгууллаа.

Ардын боловсролын тэргүүний ажилтан Алтан гадас одонт Шоовдорын Лозвойгийн нэрэмжит “Богино өгүүллэг, найраглалын уран уншлага”-ын уралдаанд номын сан хамтран ажиллав.

Богино өгүүллэг, яруу найргийн тэмцээний тусгай байрын шагналыг ивээн тэтгэж оролцов. Мөн соёлын эрхийн гэрчилгээнд хамрагдсан сурагчдын дунд танин мэдэхүйн “Алтан хонх”тэмцээнд 48, төрийн албан хаагчдын дунд “50 номын уналт” зохион байгуулж амжилттай оролцсон 2 сурагчийг бэлэг дурсгалын зүйлээр, Гучин-Ус сумын ЕБ-ын сургуулийн багш нарын баг тэргүүлж ном хожлоо.

Тав. “Миний ширээний ном” хэлэлцүүлэг боллоо.

Ном уншихаар ердөө мартагдаж өгдөггүй ном гэж бий, найзуудтайгаа ярилцахад ч, ажлаа хийхэд ч, гупамжаар алхахад ч үзэл санаа нь тархи, зүрхнээс салдаггүй гэрэлтээд байдаг ном байдаг. Тиймийн тулд ахлах ангийн охид хөвгүүдийн дунд ном унших, чөлөөт цагаа ашиглах, ном унших дадалд сургах, уншсанаа бусадтай хуваалцах зорилготой номын хэлэлцүүлэгт 56 уншигч оролцлоо. Соёл номын дэлгүүр ивээн тэтгэж оролцлоо.

- ✓ Хамгийн их уншигдсан бэстсэллер номын танилцуулга
- ✓ Ном уншсан сэтгэгдлүүд
- ✓ Ном уншихуйн гайхамшиг
- ✓ Монголын нэрт эрдэмтэн зохиолчдын онч мэргэн хэллэгээс
- ✓ Уншсан номоо бусдадаа зөвөөр ойлгуулсан, ном унших дадал соёлд уриалсан 6 уншигчийг бэлэг дурсгалын зүйлээр урамшуулж талархал гардуулав.
- ✓ “Кофетой агшин”
- ✓ ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 9-р ангийн сурагч С.Одбаяр хувийн номын сангийн номнуудаасаа өөрийн уншсан онцлох номыг авчирч, үе тэнгийн найз нартаа танилцууллаа.

Зургаа. Бүх нийтийн соёлын боловсрол болон цахим мэдээлэл

Аймгийн төв номын сан нь уншигчдын татгалзлын дагуу Гэрээр ном олгох танхим, Боловсрол танхим, Хүүхдийн номын өргөө болон хүүхдийн уншлагын танхимуудад шинэ номыг номын санчидтай хамтран сонголт хийж захиалан авлаа.

Сан хөмрөгт байгаа номыг уншигчдад танилцуулах, цахим орчинд сурталчилан номын сангийн электрон катологит хэрэглэгчийн хандах хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор

- ✓ Хувь хүний хөгжил
- ✓ Соёл урлаг
- ✓ Таны хөгжмийн боловсролд
- ✓ Шинэ ном ирлээ
- ✓ Өврийн хангайн гайхамшгууд
- ✓ Таны унших ном зэрэг цахим мэдээллийг 143 удаа Өвөрхангай төв номын сан, Хүүхдийн номын өргөө болон өөрсдийн fasebook хуудсаар дамжуулан уншигчдад мэдээлж 2120 хүнд хүрч ажилласан байна.

ТАВ. ЛАВЛАГАА НОМ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Номын техник ажиллагааг стандартын дагуу хийх
2. LIB4U программд номыг оруулж мэдээллийн сан бүрдүүлэх
3. Шинээр уншигч программд бүртгэх, эрх сунгах
4. МҮНС-ийн "Үндсэний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн сан"д " Улирал ба зохиолч" сэтгүүлээс мэдээлэл оруулах

5. МУ-ын Соёлын сайдын 2021 оны 07-30-ны А/150 дугаар тушаалын хүрээнд “Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн лавлагаа мэдээллийн цахим сан” бий болгох

6. ЕБС-ийн сурагчдын хичээлээс гадуур судлах эх зохиолын номзүйг хийх
7. Акталсан номыг данснаас хасах
8. Номын мэдээ гаргах
9. “Номын баяр”-ын үйл ажиллагааг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулах
10. Лавлагаа мэдээллээр үйлчлэх
11. Сумдын номын санчдад LIB4U программд ном оруулах талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

МҮНС-ийн “Үндсэний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн сан”д “Улирал ба зохиолч” сэтгүүлээс мэдээлэл оруулаа.

1. •2014-2018 онд 11 дугаараас: 546 мэдээлэл
2. • 2019-2021 онд 4+дугаараас: 166 мэдээлэл
3. • 2022 онд 4 дугаараас:193 мэдээлэл
4. • 2023 оны 3-р улирлын дугаараас: 42 мэдээлэл түүвэрлэн авч:

• Нийт. 947 мэдээ нэгтгэжээ.

МУ-ын Соёлын сайдын 2021 оны 07-30-ны А/150 дугаар тушаалын хүрээнд “Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн лавлагаа мэдээллийн цахим сан” бий болгох ажлын хүрээнд:


Хөдөлмөрийн төлөө


Хөдөлмөрийн төлөө

МУ-ын Соёлын сайдын 2021 оны 07-30-ны А/150 дугаар тушаалын хүрээнд “Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн лавлагаа мэдээллийн цахим сан” бий болгох ажлын хүрээнд 150 сонины 600 орчим нүүрийг засч цэвэрлэн цахимд оруулахад бэлдсэн.

Хөдөлмөрийн төлөө

Хөдөлмөрийн төлөө

Хөдөлмөрийн төлөө

ЕБС-ийн сурагчдын “хичээлээс гадуур судлах эх зохиолын номзүйг” хийх

- **ЕБС-ИЙН БАГА, ДУНД, АХЛАХ АНГИЙН СУРАГЧДЫН ХИЧЭЭЛЭЭР УНШИХ ЗОХИОЛУУДЫН НЭРС**
- / Номын санч, багш, сурагчдад зориулав /
- Монголын уран зохиол: 395 зохиолыг 515 эх сурвалжаас
- Гадаадын уран зохиол: 35 зохиолыг 68 эх сурвалжаас хайлт хийж эмхтгээд бна.
- Ерөнхийдөө 60% тай гэж үзэж бгаа.

Акталсан номыг данснаас хасах

1 •А/604 захирамжаар утга агуулгаар тэнцэхгүй болсон

2. •1657 төрлийн 2445 ширхэг 1.890.701 төгрөгний үнэ бүхий номыг

3. •Нэг бүрчилсэн бүртгэл болон программаас хасав.

Лавлагаа мэдээллээр үйлчлэх

Нийт өгсөн:1250

Тодотгосон лавлагаа-1234

Сэдэвчилсэн болон статистик лавлагаа. 15

Өөрийн орлого төвлөрүүлэх



Төрийн шагналт Ардын уран зохиолч яруу найрагч Д.Пүрэвдоржийн 90 насны ойд зориулсан дурсамж хөрөг цуврал
“Нэг ном эрхэм үйлс” цахим мэдээллийг түгээсэн.

ДОЛОО. АРГА ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Баруунбаян-Улаан, Хархорин, Бат-Өлзий, Есөнзүйл, Баянгол, Уянга сумын номын санчдад Lib4u программ дээр хэрхэн ажиллах талаар зөвлөгөө өгч дадлага хийлгэлээ.

Нийт 51 номын санч мэдээллийн ажилтнуудад арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг хүргэн ажилласан байна.

- Номын сангийн ангилал
- Электрон каталоги зохион байгуулалт
- Номзүйн бичилтээр ном тодорхойлох
- Номын сангийн программ дээр хэрхэн ажиллах
- Ажлын байрны тодорхойлолт
- Байнгын уншигч,иргэдийн талаарх ойлголт
- Номын нэг бүрчилсэн бүртгэл
- Нэгдсэн бүртгэл

- Номын сангийн стандарт
- Хүүхдийн ном зохиолоор сан хөмрөгийг баяжуулах худалдан авах зэрэг сэдвээр мэдээлэл хүргэн ажилласан.

Аймгийн төв номын сан нь нийт 24 удаагийн сургалт семинарыг холбогдох газруудтай хамтран зохион байгуулж 1025 хүн хамрагдсан. Сургалтыг нэрлэвэл:

- С.Молор-Эрдэнэ Философич, зохиолч, лектор, олон нийтийн сэхээтэн."Шинэ номын танилцуулга, уулзалт" арга хэмжээнд оролцсон
- Орчин үеийн номын сангийн чиг хандлага
- Номын санчдын анхан болон ахисан шатны сургалтанд оролцсон.
- Номын амт хэлэлцүүлэгт
- Үлгэрээс үлгэрлье төсөл
- Нэгдсэн каталог, коха программын сургалт
- Номын сангийн аргазүй
- Төрийн албан хаагчдын дунд цахим сургалт
- “Ид шидийн орон” мэдээлэл
- Нийгмийн даатгалын хэлтсийн сургалт
- Улаан загалмайн нийгэмлэгийн сургалт
- Төсвийн шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжилтйин танилцуулга

- Орон нутгийн номын санчдын онлайн сургалт монголын номын санч мэдээллийн ажилтны улсын Х зөвөлгөөн
- Соёлын байгууллагын үр дүнгийн гэрээ баталгаажуулах сургалт- 25
- Номын санч мэдээллийн ажилтны сургалт-28
- Соёлын байгууллагын ажлын үнэлгээ тайлан сургалт-45
- Намайг алгас”сургалт мэдээлэл-13
- “Угийн бичиг” сургалт улсын бүртгэлийн газар -36
- “Угийн бичиг” – нийгмийн ажилтан 18
- Эрүүл мэнд ба электрон тамхи
- Элсэлтийн шалгалт ба мэргэжил сонголт
- Монгол бахархал ба түүх
- Цагаан сарын соёл уламжлал
- Ялгаатай байдлыг ойлгох нь сургалт



Сумдын номын санчдад LIB4U программд ном оруулах талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх

2023 онд сумын номын сангууд нийтдээ: *LIB4U программд 28398 ширхэг номын мэдээллийг оруулсан.*

1500-5000 хүртэлх ном оруулсан сумд

1.Есөн-Зүйл: 2453-4626 ш
2.ЗБаян-Улаан:2903-4165 ш
3.Хархорин: 2718-3879 ш
4.ББаян-Улаан: 1383-2597 ш
5.Баянгол: 1583-2368 ш
6.Нарийн тээл: 1320-2187 ш
7.Баян-Өндөр: 892-2150 ш
8.Бат-Өлзий: 1257-1871 ш

500-1500 хүртэлх ном оруулсан сумд

1.Уянга: 718-1196 ш
2.Өлзийт: 625-819 ш
3.Хайрхандулаан:573-792 ш
4.Төгрөг: 573-730 ш
5. Тарагт: 539-577 ш

1-500 хүртэлх ном оруулсан сумд

1.Богд: 196-200 ш
2.Гучин-Ус: 112-118 ш
3.Сант: 61-62 ш
4.Хужирт: 37-47 ш
5. Бүрд: 14-14 ш

ДОЛОО . ТӨСӨВ САНХҮҮГИЙН АСУУДАЛ

Төсвийн тухай шинэ хуулийг мөрдөн ажиллан байгууллагын эрхэм зорилго,үйл ажиллагааны зорилтод тулгуурлан төсөв болон тодотгосон төсвийн сар,улирлын хувиарын дагуу санхүүжилт авч, өр авлагагүй ажилласан.

2023 онд улсын төсвөөс 368802.0 сая, орон нутгийн төсвөөс 73184.1 сая, нийт санхүүжилт 441.986.1 сая төгрөгийн санхүүжилттэйгээр өр авлагагүй ажилласан. Аймгийн төв номын сан нь 2 номын санч мэдээллийн ажилтан, 1 жижүүр угтагчийн орон тоо шаардлагатай байгаа тул холбогдох соёл урлагийн газарт уламжлан ажиллаж байна

1. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бичиг хэрэгслээр 324600 хангасан.
2. Интернэт, номын сангийн программ хангамж, байнгын тасралтгүй ажиллагааг ханган ажилласан.
3. Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхдээ 8 ажилтанд ур чадварын нэмэгдэл , 2 ажилтанд ажил хавсран гүйцэтгэж буй 20-30 хувийн нэмэгдэл олгон ажилласан.

4. “Өглөөний уншлага” үед ажилласан номын санч ажилтнуудад илүү цагийн хөлсийг олгосон.
5. Ажил үүргээ үр дүнтэй биелүүлж, байгууллагын аваргаар Хүүхдийн өргөөний номын санч О.Долгормаа, номын санч мэдээллийн ажилтан Б.Цэрэнпүрэв нар шалгарч тодруулж Хүндэт цом, мөнгөн шагналаар шагнасан.
6. Байгууллагын ажилчдын үр дүнгийн урамшууллыг улирал жилээр тооцон ажлын үр дүнг харгалзан 70-80 хувийн урамшуулал олголоо.
7. Гэр бүлийн гишүүн өвдсөн тохиолдолд цалинтай чөлөө олгосон ба цахимаар ажиллуулсан.
8. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажилласан.
9. Эх үрсийн баяраар ажилчдын 16 хүртэлх насны хүүхдүүдэд 420.0 мянган төгрөгний хүүхдийн бэлэг олгосон.
10. Ажилчдад сар бүр хоолны мөнгө олгож байгаа бөгөөд 8120.0 төгрөг зарцуулсан.
11. Байгууллагаас тэтгэвэрт орсон ахмадуудад цагааан сар,ахмадын баяраар 300.0 төгрөг олгосон.
12. Үр дүнгийн санхүүжилтээр улсад 5 дугаар байрт орж, 31000000 сая урамшуулал авч ажилчдад цалингийн нэмэгдэл,нийгмийн асуудал мөн 13000000 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан.

АЙМГИЙН ТӨВ НОМЫН САН

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Номын сангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ялангуяа цахим үйлчилгээний чанар, хүртээмжид онцгой анхаарч ажиллаа.

УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Үзүү-лэлт	Хүүхдийн уншлагын танхим	Нийтийн уншлагын танхим	Гэрээр ном олгох танхим	Мэдээллийн төв	Сан хөмрөг	Зөөврөөр	Цахим	Нийт
Уншигч	1633	1040	253	165				**3091**
Ирэгсэд	4015	3100	3558	418	340	5256	31794	**48481**
Ном олголт	12282	4015	5034	502	1100	4723	31794	**59450**

Урилгат үйлчилгээ

Хүүхдийг номын сангаар үйлчлүүлэх соёлд сургах, ном уншихад урин дуудах анги хамт олны урилгат үйлчилгээнд нийт 36 анги, хамт олны 1058 хүүхдийг хамруулан 1480 ном олгон номын сангийн үйлчилгээ болон шинэ номын танилцуулга, ном уншлагыг дэмжсэн уншлага арга хэмжээ зохион байгууллаа.

1. II/08. 4-р сургуулийн Л.Батсүх багштай 9А анги (37 хүүхэд 53 ном)
2. I/09. Даланзадгад сумын 1-р цэцэрлэгийн Дунд А бүлгийн 24 хүүхдэд 30 номоор уншлага үйлчилгээ хүргэсэн.
3. II/09. Даланзадгад сумын Улсын тэргүүний 2-р сургуулийн 6б ангийн 31 сурагчдад 52 номоор уншлага үйлчилгээ хүргэсэн.
4. II/09 4-р сургуулийн М.Батхүү багштай 9Д анги (34 хүүхэд 37 ном)
5. II/10. 4-р сургуулийн Б.Одончимэд багштай 9В анги (31хүүхэд 47 ном)
6. III/21. 4-р сургуулийн С.Долгормаа багштай 8Б анги (33хүүхэд 53 ном)
7. III/06. 4-р сургуулийн А.Алдармөнх багштай 8а анги (27 хүүхэд 35 ном)
8. IV/07. 4-р сургуулийн Б.Цэнд-Аюуш багштай 8в анги (28 хүүхэд 41 ном)
9. IV/07. 4-р сургуулийн Ц.Сайнзаяа багштай 9а анги (21 хүүхэд 33 ном)
10. IV/12. 7-р сургуулийн Б.Отгонжаргал багштай 9б анги(26 хүүхэд 26 ном)
11. IV/13. 7-р сургуулийн Ч.Нарангарав, багштай 8а(34 хүүхэд 33 ном)
12. IV/13. 7-р сургуулийн Г.Аззаяа 9а анги(23 хүүхэд 26 ном)
13. IV/14. 7-р сургуулийн Э.Ариунбуян багштай 10а анги(27 хүүхэд 42 ном)
14. IV/18. 7-р сургуулийн У.Батнасан багштай 10б анги(18 хүүхэд 37 ном)
15. IV/21. 2-р сургууль 10Б(14 хүүхэд 30 ном)
16. VII/03. “Bees English” сургалтын төвийн 31 сурагчдад 40 номоор уншлага үйлчилгээ хүргэн “Алтан хонх” танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн явуулсан.

Зураг 1. Урилгат үйлчилгээ

17. VII/04. Хүрмэн сумын 1-р багийн ЕБС-ийн болон СӨБ-ын 16 сурагчдад 32 номоор уншлага үйлчилгээ хүргэж, хормогчин театрын үлгэрийг хамтдаа ярилцлаа.
18. IX/27.Даланзадгад сумын 5-р сургуулийн 4в ангийн 41 сурагчдад 50 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
19. X/09. Даланзадгад сумын 2-р цэцэрлэгийн Ч.Мөнхцэцэг багштай Бэлтгэл Б бүлгийн 41 хүүхдэд 47 номоор уншлага үйлчилгээ хүргэн үлгэрийн зурагт номыг сонирхолтой байдлаар хамтран ярилцаж уншиж өгсөн.
20. X/10. Даланзадгад сумын 2-р цэцэрлэгийн Ахлах Б бүлгийн 30 хүүхдэд 32 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
21. X/11. Оюуны мэлмий 4-р сургуулийн Мөнх-эрдэнэ багштай 4а ангийн 28 сурагчдад 40 номоор уншлага үйлчилгээ үзүүлж, сурагчид 60 минутыг ном уншихад зарцуулж бүтээлч уншлага хийсэн
22. X/27. ШУТИС Коосэн ТК-ийн оюутнууд (30 хүүхэд 35 ном)
23. X/30. 2-р сургуулийн О.Амармэнд багштай 8а анги(22 хүүхэд 30 ном)
24. X/31. Улсын тэргүүний 3-р сургуулийн 4в ангийн 45 сурагчдад 90 номоор уншлага үйлчилгээ хүргэн номын сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч ажилласан.
25. XI/07. “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Даланзадгад сумын 5-р сургуулийн 3в ангийн 16 сурагчдад 32 номоор уншлага үйлчилгээ хүргэсэн.
26. XI/13. 1-р сургуулийн Э.Мөнхцэцэг багштай 8д анги(27 хүүхэд 32 ном)
27. XI/17. “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Улсын тэргүүний 2-р сургуулийн 39 сурагчдад 55 номоор уншлага үйлчилгээ хүргэж, номын сангийн үйл ажиллагааны талаар танилцуулсан.

28. XI/20. “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Улсын тэргүүний 2-р сургуулийн 6а ангийн 40 сурагчдад 40 номоор уншлага үйлчилгээ хүргэж, номын сангийн үйл ажиллагааны талаар танилцуулсан.
29. XI/22. 3-р сургуулийн Э.Дэлгэрмаа багштай 8в анги(20 хүүхэд 37 ном)
30. XI/23. “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Улсын тэргүүний лаборатори 1-р сургуулийн 6г ангийн 35 сурагчдад 50 номоор уншлага үйлчилгээ хүргэж, уншсан номоороо анги хамт олон хэлэлцүүлэг хийв.
31. XI/23. “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Даланзадгад сумын спортын 7 дугаар сургуулийн 7б ангийн 27 сурагчид 27 номоор уншлага үйлчилгээг хүргэн, анги хамт олноороо хүүхдийн уншлагын танхимтай танилцаж, номын сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авч, урилгат үйлчилгээнд хамрагдсан.
32. XI/24. “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Улсын тэргүүний лаборатори 1-р сургуулийн Э.Номиндарь багштай 3а ангийн 32 сурагчдад 40 номоор уншлага үйлчилгээ хүргэж, танин мэдэхүйн үгэн тоглоом болох оньсого таалган, Улс тунхагласны баярын талаар мэдээлэл өгч ажиллалаа.
33. XI/30. Улсын тэргүүний лаборатори 1-р сургуулийн Т.Эрдэнэсайхан багштай 7е ангийн 23 сурагчдад 69 номоор уншлага үйлчилгээ хүргэж, номын сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэлээ.
34. XII/01. Улсын тэргүүний 2-р сургуулийн 2а ангийн 42 сурагчид номын сантай танилцах аялал хийж бидний зүгээс 59 номоор уншлага үйлчилгээ хүргэж, уншигчийн карт нээн, номын сангийн үйл ажиллагааны талаар танилцуулсан
35. XII/04. 1-р сургуулийн Үүрмандах багштай 9Г анги (34 хүүхэд 35 ном)
36. XII/07. 1-р сургуулийн Саранцэцэг багштай 8А анги(31 хүүхэд 33 ном)

Зөөврийн номын сангийн үйлчилгээ

Иргэдэд номын сангийн үйлчилгээг ойртуулах, ном хэвлэлийг сурталчлах зорилгоор зөөврийн номын сангийн үйлчилгээг 77 удаа 5256 ирцэд хүргэн 4723 ном олгож ажилласан байна.

Цэцэрлэгүүдэд /10 удаа 1143 ирцэд 593 ном олголт/

1. III/14. 25-р цэцэрлэгийн 108 хүүхдүүдэд уншлагын танхимд шинээр ирсэн үлгэрийн болон зурагтай 90 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
2. III/14. 26-р цэцэрлэгийн 120 хүүхдүүдэд уншлагын танхимд шинээр ирсэн үлгэрийн болон зурагтай 53 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
3. IX/25. Даланзадгад сумын 8-р цэцэрлэгийн 152 хүүхдүүдэд уншлагын танхимд шинээр ирсэн үлгэрийн болон зурагтай 80 номоор уншлага үйлчилгээг хүргэж, хормогчин театрын үлгэрийг ярьж сонирхуулсан.
4. IX/27. Даланзадгад сумын 4-р цэцэрлэгийн 155 хүүхдүүдэд уншлагын танхимд шинээр ирсэн үлгэрийн болон зурагтай 80 номоор уншлага үйлчилгээг хүргэж, хормогчин театрын үлгэрийг ярьж сонирхуулсан.
5. IX/28. Даланзадгад сумын 1-р цэцэрлэгийн 112 хүүхдүүдэд уншлагын танхимд шинээр ирсэн үлгэрийн болон зурагтай 100 номоор уншлага үйлчилгээг хүргэж, хормогчин театрын үлгэрийг ярьж, үлгэрийн зурагт номыг хамтдаа харилцан ярилцаж, хөгжөөнт тоглоом тоглуулан ажилласан.
6. X/19. Даланзадгад сумын 2-р цэцэрлэгийн Бямбасүрэн багштай Ахлах А, Бүлгийн 28 хүүхдүүдэд уншлагын танхимд шинээр ирсэн үлгэрийн болон зурагтай 70 номоор уншлага үйлчилгээг хүргэж, хормогчин театрын үлгэрийг ярьж сонирхуулсан.
7. XI/23. Даланзадгад сумын 24-р цэцэрлэгийн ахлах а,б болон бэлтгэл а, б бүлгийн 144 хүүхдүүдэд Хүүхдийн уншлагын танхимд шинээр ирсэн үлгэрийн болон

зурагтай 80 номоор уншлага үйлчилгээг хүргэж, хормогчин театрын үлгэрийг ярьж, зурагт номыг сонирхолтой байдлаар хамтран ярьж сонирхуулсан.

8. XII/05. Даланзадгад сумын 9-р цэцэрлэгийн ахлах а,б болон бэлтгэл а, б бүлгийн 113 хүүхдүүдэд Хүүхдийн уншлагын танхимд шинээр ирсэн үлгэрийн болон зурагтай 70 номоор уншлага үйлчилгээг хүргэж, хормогчин театрын үлгэрийг ярьж, зурагт номыг сонирхолтой байдлаар хамтран ярьж сонирхуулсан.
9. XII/06. Даланзадгад сумын 23-р цэцэрлэгийн ахлах а,б болон бэлтгэл а, б бүлгийн 104 хүүхдүүдэд Хүүхдийн уншлагын танхимд шинээр ирсэн үлгэрийн болон зурагтай 70 номоор уншлага үйлчилгээг хүргэж, хормогчин театрын үлгэрийг ярьж, зурагт номыг сонирхолтой байдлаар хамтран ярьж сонирхуулсан.
10. XII/07. Даланзадгад сумын 11-р цэцэрлэгийн ахлах а,б болон бэлтгэл а, б бүлгийн

Зураг 2. Зөөврийн номын сан цэцэрлэгүүдэд

107 хүүхдүүдэд Хүүхдийн уншлагын танхимд шинээр ирсэн үлгэрийн болон зурагтай 70 номоор уншлага үйлчилгээг хүргэж, хормогчин театрын үлгэрийг ярьж, зурагт номыг сонирхолтой байдлаар хамтран ярьж сонирхуулсан.

Сургуулиудад /10 удаа 1037 ирцэд 519 ном олголт/

1. III/13. Улсын тэргүүний 3-р сургууль дээр зөөврийн номын сангийн үйлчилгээг 60 номоор хүргэж нийт 70 хүүхэд хамрагдсан.
2. III/15 Улсын тэргүүний 2-р сургууль дээр зөөврийн номын сангийн үйлчилгээг 38 номоор хүргэж нийт 94 хүүхэд хамрагдсан.
3. V/2. 4-р сургууль (54 ном 70 хүүхэд)
4. V/2. 7-р сургууль(57 ном 63 хүүхэд)
5. X/04 Даланзадгад сумын спортын 7-р сургууль зөөврийн номын сангийн үйлчилгээг 53 номоор 50 сурагчдад хүргэн ажилласан.
6. X/13. Политехникийн коллеж (110 ном130 ирц)
7. X/17. 4-р сургууль (20ном 40 ирц)
8. X/17 Даланзадгад сумын Оюуны мэлмий 4-р сургууль дээр зөөврийн номын сангийн үйлчилгээг уншлагын танхимд шинээр ирсэн 80 номоор 40 сурагчдад хүргэн ажиллаж, танин мэдэхүйн асуулт хариултын АХА тэмцээн зохион байгуулж, сурагчид өөрийн уншсан сэтгэлд үлдсэн хамгийн гоё номуудаасаа бусдадаа санал болгож, ярилцлага өрнүүлсэн.

9. XI/15“Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Даланзадгад сумын 5-р сургууль дээр зөөврийн номын сангийн үйлчилгээг хүүхдийн 32 номоор 55 сурагчдад хүргэн ажилласан.
10. XI/22 “Соёлын бүтээлч сар”-ын хүрээнд Даланзадгад сумын Улсын тэргүүний лаборатори 1-р сургууль дээр зөөврийн номын сангийн үйлчилгээг 50 номоор 41 сурагчдад хүргэн, уншигчийн карт нээж, номын сангийн үйл ажиллагааг танилцуулж ажилласан.

Зураг 3. Зөөврийн номын сан сургуулиудад

Байгууллагуудад /21 удаа 1921 ирцэд 1737 ном олголт/

1. III/14. Ахмадын чөлөөт холбооны хамт олонд 50ш номоор уншлага үйлчилгээ үзүүлэн 9 уншигчид карт нээж 23 ирцэд хүрч үйлчилсэн.
2. III/16. Хаан банкны хамт олонд 50ш номоор уншлага үйлчилгээ үзүүлэн 4 уншигчид карт нээж 17 ирцэд хүрч үйлчилсэн.
3. III/27. Гандирс худалдааны төвийн хамт олон болон үйлчлүүлэгчдэд 50ш номоор 28 ирцэд хүрч үйлчилсэн
4. VII/06. 0167-р ангид алба хааж буй Оюутан цэргүүдэд 120ш номоор 93 ирцэд уншлага үйлчилгээ үзүүллээ.
5. IX/22. Нүүдлийн номын сангийн үйлчилгээгээр Хүндэт хилчин хошууч генерал Чогын Сандрын нэрэмжит Цэргийн гавьяаны одонт Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн цэргүүдэд 100ш номоор 88 ирцэд уншлага үйлчилгээ үзүүллээ.
6. IX/25. Нүүдлийн номын сангийн үйлчилгээгээр Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн ажилтан албан хаагч нарт 50ш номоор 4 уншигчид карт нээж 32 ирцэд уншлага үйлчилгээ үзүүллээ.
7. X/13. Политехникийн коллежийн ажилтан алба хаагч сурагчдад 70ш номоор 130 ирцэд уншлага үйлчилгээ үзүүлсэн.
8. X/16. ХЖТ-д зохиолч уншигчдын уулзалтын үеэр нүүдлийн номын сангийн үйлчилгээг ард иргэдэд хүргэн ажилсан. 100ш номоор 6 шинэ уншигч бүртгэн 178 ирцэд үйлчилсэн.
9. X/28. Хөдөлгөөнт баг арга хэмжээний хүрээнд 100ш номоор 6 шинэ уншигч бүртгэн 192 ирцэд хүрч үйлчилсэн.
10. XI/07. Өмнөговь аймгийн Цагдаагийн хэлтсийн хамт олонд 50ш номоор 5 шинэ уншигч бүртгэн 63 ирцэд хүрч үйлчилсэн.

11. XI/07. Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн хамт олонд 73ш номоор 13 шинэ уншигч бүртгэн 42 ирцэд хүрч үйлчилсэн.
12. XI/09. Дижитал вишны хамт олонд 50ш номоор 5 шинэ уншигч бүртгэн 10 ирцэд хүрч үйлчилсэн.
13. XI/21. Нутгийн удирдлагын ордны хамт олонд 60ш номоор 10 шинэ уншигч бүртгэн 38 ирцэд хүрч үйлчилсэн.
14. XI/23. 0131-р ангийн хамт олонд 70ш номоор 15 шинэ уншигч бүртгэн 119 ирцэд хүрч үйлчилсэн.
15. XII/12. 0167-р ангийн хамт олонд 60ш номоор 130 ирцэд хүрч үйлчилсэн.

Идэвхтэн уншигчид болон байгууллагуудтай хамтран зөөврөөр /6 байгууллагад 31 удаа 624 ирцэд 608 ном олголт/

16. ШШГГазар/нийт 24 удаа 519ш ном 444ирц/
17. БТСГазар /нийт 1 удаа 15ш ном 25 ирц/
18. Алтайн өвөр говь дахь сав газар /нийт 2 удаа 40ш ном 20 ирц/
19. Ахмадын чөлөөт холбоо/нийт 1 удаа 10ш ном 23 ирц/
20. Ханхонгор сумын номын сан /нийт 1 удаа 13ш ном 28 ирц/
21. 0131-р цэргийн анги /нийт 2 удаа 27ш ном 58 ирц/

Зураг 4. Зөөврийн номын сан байгууллагуудад

Зураг 5. Зөөврийн номын сан сумдад

Сумдад /5 удаа 531 ирцэд 611 ном олголт/IV/03. Ханбогд суманд Дэлхийн хүүхдийн номын өдрийн хүрээнд бүтээлчээр уншихуй уулзалт уншлага арга хэмжээг зохион байгуулж 25 хүүхдийг хамруулав.

1. IV/11. Баяндалай сумын ард иргэдэд номын сангийн үйлчилгээг хүргэж, шинэ ном хэвлэлийг танилцуулах Зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэх, “Уншдаг хүүхэд хөгждөг аян”-ы үйл ажиллагаатай танилцан ажилласан. 83 ирцэд 80 ном олгож үйлчиллээ.
2. XI/16. Баяндалай сумын иргэд, хүүхэд багачууд болон залуучууд, эцэг эхчүүдэд номын санд шинээр ирсэн уран зохиол, хүүхдийн танин мэдэхүй болон англи хэл дээрх хүүхдийн номуудаар үзэсгэлэн гаргаж танилцуулахаас гадна шинэ номын худалдаа, соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. /141 номоор 257 ирцэд/
3. XI/23. Цогт-Овоо сумын иргэд, хүүхэд багачууд болон залуучууд, эцэг эхчүүдэд номын санд шинээр ирсэн уран зохиол, хүүхдийн танин мэдэхүй болон англи хэл дээрх хүүхдийн номуудаар үзэсгэлэн гаргаж танилцуулахаас гадна шинэ номын худалдаа, соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. /141 номоор 163 ирцэд/
4. XI/28. Мандал-Овоо сумын иргэд, хүүхэд багачууд болон залуучууд, эцэг эхчүүдэд номын санд шинээр ирсэн уран зохиол, хүүхдийн танин мэдэхүй болон англи хэл дээрх хүүхдийн номуудаар үзэсгэлэн гаргаж танилцуулахаас гадна

шинэ номын худалдаа, соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. /141 номоор 55 ирцэд/

Соёл танин мэдэхүйн ажил

Иргэд, хүүхэд залуучуудын соёлын боловсролыг дээшлүүлэх, номоор дамжуулан хөгжүүлж нийгэмдээ идэвхтэй, оролцоотой байхад дэмжлэг үзүүлэх “Ирээдүйн эрдэмтэн“, “Тусч уншигч”, “Номтой өглөө” , “Мэдээллийн боловсрол”, “Бүтээлч уншлага”, “Монгол уламжлал” боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн нийт 70 удаагийн соёл танин мэдэхүйн ажилд 6613 хүнийг хамруулсан байна. Үүнд:

1. ***I/09-I/13. Сурагчдын амралтад зориулсан сургалт.*** Сурагчдын өвлийн амралтад зориулан IV-V ангийн сурагчдад ярих болон бичих чадварын хөгжүүлэх сургалт зохион байгууллаа. Хүүхдийн тоо-12
2. ***I/09-20. Сурагчдын амралтад зориулсан сургалт.*** Сурагчдын өвлийн амралтад зориулан бага ангийн сурагчдад зориулан сургалт зохион байгуулсан. Сургалтад 7

Зураг 6. Сурагчдын өвлийн амралтад зориулсан сургалтууд

сурагч хамрагдсан.

3. ***II/19. “Цагаан сарын ёсон”*** Сар шинийг тохиолдуулан уламжлалт баярын зан заншил, тоглоом наадгай, мэндлэх хүндлэх ёсыг хүүхэд багачуудад таниулан сурталчлах зорилгоор ХУТанхимд, орон нутгийн Мэлмий сайт, ахмадын Чөлөөт холбоотой хамтран 15 хүүхэд, ахмадуудыг хамруулан зохион байгууллаа.

Зураг 7. Цагаан сарын ёсон соёл танин мэдэхүйн ажил

4. ***III/21. Ном унших, номын тэмдэглэл хөтлөх сургалт.*** 4-р сургуулийн С.Долгормаа багштай 8Б ангид ном унших арга болон номын тэмдэглэлийн сургалт зохион байгуулж дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан "НОМ" сэдэвт дөрвөн мөрт шүлгийн тэмцээнийг сурагчдын дунд зохиолоо. (нийт 33 хүүхэд)
5. ***III/21. "ЯРУУСЛЫН ҮДЭШ"*** арга хэмжээг МЗЭ-ийн Өмнөговь аймаг дахь салбар, Даланзадгад сумын 1-р багийн төвтэй хамтран зохион байгууллаа. Өмнөговь

Зураг 8. Яруюслын үдэш СТМА

аймгийн зохиолч, яруу найрагчдын номоор үзэсгэлэн гарган танилцуулж, уригдсан яруу найрагчид маань шүлэг яруу найргийн дээжээс уншиж, оролцогчдын дунд "Шүлгийн чөлөөт уншлага" зохион байгууллаа. Үдэшлэгт нийт 48 хүн ирснээс 13 хүн нь монголын шилдэг шүлэг, яруу найргаас унших чөлөөт уншлага уншиж оролцсоноос ХЖТ-ийн бүжигчин Б.Ариунтуяа /Д.Пүрэвдорж "Хөх даалимбан тэрлэг"/, яруу найрагчдаас Ц.Буянхүү / Ш.Гүрбазар "Би монголоороо гоёдог"/, шүлэг яруу найраг сонирхогчдоос Г.Буянтогтох /Д.Пүрэвдорж "Чингис" / нарыг шалгаруулж шагнаж урамшууллаа. Мөн нийт оролцогчдоосоо 2 азтан тодруулан номоор мялаалаа.

6. ***III/21. Ном унших, номын тэмдэглэл хөтлөх сургалт.*** 4-р сургуулийн А.Алдармөнх багштай 8а ангид ном унших арга болон номын тэмдэглэлийн сургалт (27 хүүхэд)

Зураг 9. Хүүхдийн сургалтууд

7. ***III/31. “Дэлхийн хүүхдийн номын өдөр”***-ийг угтан "Уншъя-Зуръя-Хөгжье" боловсролын хөтөлбөрт 5-7-р ангийн сурагчдыг хамрууллаа. Хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдэд номын сангийн үйлчилгээ болон Дэлхийн номын өдрийн хүрээнд гарсан үзэсгэлэнг танилцуулан номын тэмдэглэл хөтлөх номыг үр дүнтэй унших аргуудыг зааж, Ханс Христиан Андерсений шагналт хүүхдийн зохиолч Цао Вэньшуанийн "Удвал цэцэгт хүүхэлдэй" зохиолыг хамтран уншиж хэлэлцүүлэг өрнүүлж, зургийн Paint программ ашиглах аргад суралцан уншсан зохиолын дүр болон утга санааг зургаар илэрхийлэх сонирхолтой, зугаатай хөтөлбөрт оролцууллаа.

8. ***IV/03. "Уул уурхайн өгөгдөл мэдээлэлтэй ажиллах нь" сургалт***

Ханбогд сумын төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл 14 хүнд уул уурхайн нээлттэй өгөгдлүүдийн эх сурвалж нээлттэй өгөгдлөөс бий болох үнэ цэнийг танилцуулсан сургалт зохион байгууллаа.

9. ***IV/3. "Нугасны муухай дэгдээхэй" зохиолын хамтын уншлага***

Бүтээлчээр уншихуй дугуйлан"-ийн хүүхдүүдтэй хамтарч Ханс Христиан Андерсений "Нугасны муухай дэгдээхэй" зохиолыг хамтран уншиж хэлэлцүүлэг өрнүүлэв. Хүүхдийн тоо 8

10. ***IV/07. Ном унших, номын тэмдэглэл хөтлөх сургалт.*** 4-р сургуулийн Б.Цэнд-Аюуш багштай 8в ангид ном унших арга болон номын тэмдэглэлийн сургалт (28 хүүхэд)
11. ***IV/07. Ном унших, номын тэмдэглэл хөтлөх сургалт.*** 4-р сургуулийн Б.Цэнд-Аюуш багштай 8в анги (28 хүүхэд 41 ном)
12. ***IV/12. Ном унших, номын тэмдэглэл хөтлөх сургалт.*** 7-р сургуулийн Б.Отгонжаргал багштай 9б анги ном унших арга болон номын тэмдэглэлийн сургалт (26 хүүхэд)
13. ***IV/13. Ном унших, номын тэмдэглэл хөтлөх сургалт.*** 7-р сургуулийн Г.Болорчимэг, багштай 6а ном унших арга болон номын тэмдэглэлийн сургалт(16 хүүхэд)
14. ***IV/13. Ном унших, номын тэмдэглэл хөтлөх сургалт.*** 7-р сургуулийн Ч.Нарангарав, багштай 8а6а ном унших арга болон номын тэмдэглэлийн сургалт (34 хүүхэд)
15. ***IV/13. Ном унших, номын тэмдэглэл хөтлөх сургалт.*** 7-р сургуулийн Г.Аззаяа 9а анги 6а ном унших арга болон номын тэмдэглэлийн сургалт (23 хүүхэд)
16. ***IV/14. Ном унших, номын тэмдэглэл хөтлөх сургалт.*** 7-р сургуулийн Э.Ариунбуян багштай 10а анги 6а ном унших арга болон номын тэмдэглэлийн сургалт (27 хүүхэд)

Зураг 10. Номын тэмдэглэл хөтлөх сургалтууд

17. ***IV/17. Компьютерын хэрэглээний сургалт.*** Хүүхэд багачуудыг хөгжүүлэх зорилгоор Microsoft Word программын хэрэглээний сургалт зохион байгуулсан. Сургалтад 7-9 дүгээр ангийн 8 сурагчд хамрагдлаа.
18. ***IV/18. Ном унших, номын тэмдэглэл хөтлөх сургалт.*** 7-р сургуулийн У.Батнасан багштай 10б анги 6а ном унших арга болон номын тэмдэглэлийн сургалт (18 хүүхэд)
19. ***IV/20. Дэлхийн номын өдрийг угтсан “Кофе хөрөхөөс өмнө” номын хэлэлцүүлгийг*** ахлах ангийн сурагчдын дунд зохион явуулсан. Нийт 11 сурагч хамрагдан 284 хүнд хүрсэн.

20. **IV/22. *“Ном бид 2” номын хэлэлцүүлэг.*** Хэлэлцүүлгийг насанд хүрэгчдийн дунд 3 үе шаттайгаар зохион явуулсан. Нийт 13 хүн хамрагдаж 476 хүнд хүрсэн.
21. ***IV/27. “Бүх нийтийн соёлын боловсрол” сургалт***, хэлэлцүүлгийг хүүхдийн чиглэлээр хамтран ажилладаг 12 байгууллагуудын төлөөллүүдэд /30хүнд/ зохион байгуулж цаашид хамтран ажиллах чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулаа.

Зураг 11. Номын хэлэлцүүлгүүд

V/6.2023 оны “ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР”-ын үйл ажиллагааг аймгийн ЗДТГазрын дэмжлэгтэйгээр “Говийн ирээдүй хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийнхаа **3102** гаруй иргэд сурагчдыг цахим болон танхимаар хамруулж,

үндэсний өв болсон монгол бичгээ эзэмшүүлэх, сурталчлан таниулах, сурч эзэмшсэн багш, сурагчдын бүтээлүүдийг олон нийтэд түгээж өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлсэн. “БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛ БИЧИГ” монгол бичгийн хичээнгүй, эвэр ичлэгийн уралдаанIV/24-V/3. Үндэсний утга соёлын нандин өв болсон монгол бичгийг хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, сурталчлах, хүүхэд багачуудын монгол бичгийг сурч эзэмших идэвхийг дэмжих зорилгоор “Бидний бахархал-Монгол бичиг” хичээнгүй, цэвэр бичлэгийн уралдааныг Өмнөговь аймгийн ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд Д.Равжаагийн “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу” хэмээх сургаалыг монгол бичгээр сайхан бичих уралдаан зарласан. Энэхүү уралдааны мэдээ постерыг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан. Уг уралдаанд төв, хөдөөгийн 10 сургуулийн **211** сурагчдын хичээнгүй, цэвэр бичиг ирснээс мэргэжлийн багш нарын бүрэлдэхүүнтэй комисс үзэж шалгаруулллаа.

Сурагчдын хичээнгүй, цэвэр бичгийг Ц.Амарсайхан /Монгол хэлний багш/, Ч.Цоодол /Монгол хэлний багш/, Т.Мөнгөнтуул /СУГазрын дарга/ нар шүүгчдээр ажиллаж, шилдэг бичвэрүүдийг шалгаруулсан.

1-р байр 2-р сургуулийн 9б ангийн сурагч Б.Маралжингоо
2-р байр Манлай сумын ЕБСургуулийн 9а ангийн сурагч Э.Санчирболд
3-р байр 2-р сургуулийн 9а ангийн сурагч М.Хонгорзул
Тусгай байр Цогтцэций сумын 2-р сургуулийн 9в ангийн сурагч З.Саруулзаяа
нарыг шалгаруулан Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнан урамшууллаа.

22. *“Өмнөговь аймгийн үндэсний бичгийн” тэргүүний уншигч шалгаруулах уралдаан*

Зураг 12. Үндэсний бичиг үсгийн баяр



Зураг 13. Үндэсний бичгийн хурдан ушигч шалгаруулах тэмцээн

V/5. Монгол үндэсний бичиг, соёл, түүх, уламжлалаа хойч үедээ өвлүүлэх, монгол үндэсний хэл бичгээ сурч эзэмших, сурталчлан дэлгэрүүлэх, суралцагчдыг хөхүүлэн дэмжих зорилгоор монгол бичгээр хурдан унших уралдааныг Өмнөговь аймгийн ЕБС-ийн 8-9-р анги, 10-12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Оролцогчдыг нэг минутын хугацаанд алдаагүй зөв уншсан үгийн тоогоор шалгаруулж ангилал тус бүрээс 3 шилдэг уншигчийг тодрууллаа.

VIII-IX ангийн төрөлд

1-р байр 3-р сургуулийн 9а ангийн сурагч Т.Азбаяр
2-р байр Цогтцэций сумын 2-р сургуулийн 9в ангийн сурагч С.Ариунгуа
3-р байр 2-р сургуулийн 9б ангийн сурагч Ж.Ангирмаа

X-XII ангийн төрөлд

1-р байр Цогтцэций сумын 2-р сургуулийн 11а ангийн сурагч Б.Ану
2-р байр 4-р сургуулийн 12б ангийн сурагч Г.Батсолонго
3-р байр 1-р сургуулийн 12г ангийн сурагч З.Нандинцэцэг нар тус тус шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

23. *“ЦАХИМ БИЧВЭРИЙН” уралдаан*

V/5. Монгол бичгийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх, монгол бичгээр цахим бичвэр боловсруулах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Монгол бичгийн цахим бичвэр" уралдааныг Даланзадгад сумын төрийн албан хаагчид, иргэдийн дунд зохион байгуулсан.

Уралдаанд Даланзадгад сумын 10 төрийн албан хаагчид монгол бичгээр бичигдсэн эхийг компьютер 15 минутад Юникодын Mongolian baiti фондоор шивж оролцсон.
1-р байр *Цаг уур орчны хэлтсийн дарга* Х.Өнөржаргал
2-р байр 4-р сургуулийн математикийн багш Д.Отгонжаргал
3-р байр **Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба**ны байцаагч Ж.Туяа нар шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Зураг 14. Монгол бичгийн цахим бичвэрийн тэмцээн

24. *“БАГШИЙН ЭРДЭМ ШАВЬД” багш, сурагчдын монгол бичгийн уран бичвэрийн үзэсгэлэн*

V/6. /Монгол бичгийг өвлөн уламжлуулж, түгээн дэлгэрүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж буй багш, шавийн нандин холбоо, харилцааг сурталчлах, сурагчдад монгол бичгээ илүү ахисан түвшинд суралцах хүсэл тэмүүллийг төрүүлэх зорилгоор “БАГШИЙН ЭРДЭМ ШАВЬД” багш, сурагчдын монгол бичгийн уран бичвэрийн үзэсгэлэнгийн уралдааныг зарласан. 17 оролцогч

Зураг 15 . Багшийн эрдэм шавьд үзэсгэлэн уралдаан

Уралдаанд Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын багш 5-с багагүй шавьтайгаа хамтран өөрийн болон шавь нарынхаа монгол бичгийн уран бичвэрийн төрлөөр хийсэн бүтээл, гарын авлага, үзүүлэн таниулах материалаар үзэсгэлэн гаргаж, Б.Ренчиний “Монгол хэл” шүлгийн 4 мөрийг уран бичвэрээр бичиж бүтээл гаргаж мэргэжлийн багш нарын бүрэлдэхүүнтэй комисс зохион байгуулалт,

үзэсгэлэнгийн зохиомж, бичвэрүүдийн ур чадвар зэргийг харгалзан үзэж шалгаруулсан.
1-р байр О.Гангамөрөн багштай 3-р сургуулийн баг хамт олон
2-р байр Ж.Сугирпүрэв багштай 5-р сургуулийн баг хамт олон
3-р байр С.Буянболдмаа багштай 4-р сургуулийн баг хамт олныг шалгаруулан Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

25. *V/22. Номын баяр.*

МУ-ын ерөнхийлөгчийн 2012 оны "Номын баярын өдөр тэмдэглэх тухай" 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, иргэд, хүүхэд, залуучуудыг номтой нөхөрлүүлэх, бүх нийтийн ном уншлагыг дэмжих, Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын хэрэгжилтийг ханган 33 дахь удаагийн Үндэсний номын баяр-2023 арга хэмжээг “Хүүхэд бүр уншигч” уриан дор 05 сарын 19-22-ны өдрүүдэд орон нутагт тэмдэглэн өнгөрүүлж, үндэсний бичиг соёлыг сурталчлах, номын сангийн өв санг арвижуулах, бүх нийтийн ном унших хандлагыг нэмэгдүүлэх, дэмжих, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн Хөгжимт жүжгийн театрт нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын санаачилгаар "Говийн ирээдүй хүүхэд" хөтөлбөрийн хүрээнд хүүхдэд бага наснаас ном унших дадал хэвшлийг бий болгох, номтой нөхөрлөх, номоос суралцах соёлыг дээдлэн хөгжүүлэх, ном уншихын ач холбогдлыг таниулах, бүтээлчээр унших арга зүйд сургах зорилгоор 2022-2023 оны хичээлийн жилд зохион байгуулагдсан **"Уншдаг хүүхэд хөгждөг"** аянд оролцож шилдгээр шалгарсан ЕБСургууль, цэцэрлэгүүд энэхүү өдрийн үйл ажиллагаанд тус аяны хүрээнд хийж бүтээсэн бүтээлүүдээ иргэд олон нийтэд сурталчлан таниулж, тайлагналаа.

Нээлтийн арга хэмжээнд Аймгийн ЗДТГазар Нийгмийн Бодлогын хэлтэс, Соёл, урлагийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Төв номын сан, ХЖТеатр, Өмнөговь аймаг, сумдын ЕБСургуулиуд, цэцэрлэгүүд, төрийн болон төрийн бус байгууллагуудын 400 гаруй иргэд олон нийт хамрагдлаа.

Зураг 16. Номын баяр-2023

Номын баярын арга хэмжээний үеэр:

- Урлагийн үзүүлбэр
- “Уншдаг хүүхэд хөгждөг” аяны шилдэг оролцогчдын бүтээлийн үзэсгэлэн
- “Уншдаг хүүхэд хөгждөг” сайн туршлагаа хуваалцахуй
- Тэргүүний уншигч сурагчдад Д.Нацагдорж тэмдэг гардуулах
- “Гэр бүлийн шилдэг номын сан” шалгаруулах уралдааны шагнал гардуулах
- “Би зурах дуртай” гар зургийн уралдаанд оролцогчдын бүтээлийн үзэсгэлэн
- Танин мэдэхүйн “АХА” тэмцээн

- “Оюуны чихэр” номын азтан шалгаруулах онч үгтэй сугалаа
- Шинэ номын худалдаа
- Төв номын сангийн Хүүхдийн уншлагын танхимын “Үе үеийн шилдэг хүүхдийн ном”-ыг танилцуулах үзэсгэлэнг гаргаж нийтэд толилууллаа.

Өмнөговь аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын шилдэг уншигч, бүтээлч сурагчдыг Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдгээр шагнан урамшууллаа.

1. Цогтцэций сумын 2-р сургуулийн 6а ангийн сурагч Г.Энэрэл
2. Мандал-Овоо сумын ЕБСургуулийн 2а ангийн сурагч М.Баясгалан
3. Ханбогд сумын 1-р сургуулийн 5б ангийн сурагч А.Мишээл
4. Манлай сумын ЕБСургуулийн 3б ангийн сурагч Б.Даваажаргал
5. Даланзадгад сумын 4-р сургуулийн 11а ангийн сураг М.Түмэнжаргал
6. Даланзадгад сумын 1-р сургуулийн 5в ангийн сурагч М.Булгансор
7. Даланзадгад сумын 5-р сургуулийн 4д ангийн сурагч Н.Эгшиглэн
8. Даланзадгад сумын 3-р сургуулийн 6б ангийн сурагч А.Баярбаясгалан нарыг шилдэг сурагчаар өргөмжиллөө.

“ҮЕ ҮЕИЙН ХҮҮХДИЙН ШИЛДЭГ НОМ”-ын үзэсгэлэн

Арга хэмжээний үеэр номын сангийн Хүүхдийн уншлагын танхимд байрлах 49 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж нийтэд танилцуулан сурталчилж ажиллалаа.

“ШИНЭ НОМ”-ын худалдаа

Аз хур номын их дэлгүүртэй хамтран номын баярын өдрүүдэд иргэдэд зориулсан хувь хүний хөгжил болон уран зохиолын олон нэр төрлийн номын худалдааг зохион байгууллаа.

26. V/19"УНШААД УРАГШЛАХУЙ" номын хэлэлцүүлэг

Хүүхэд залуучуудын ном уншлагыг дэмжих, уншсан номоо бусадтай хуваалцан эерэг хандлагыг бий болгох, ном унших хөгжих боломж боломцоог ханган бусдыг уншлагад уриалан номын соёлыг түгээх зорилгоор зохион байгууллаа. Өөрийн унших дуртай номоо өөр өөрийнхөө өрнөл төсөөлөл, сэтгэл хөдлөл, эмоциор уншсан сэтгэгдлээсээ бусад уншигчдад танилцуулан, сонирхсон номоо хэрхэн сонгож уншдаг талаараа харилцан ярилцсан хэлэлцүүлэгт нийт 6 сургуулийн 21 сурагч хамрагдлаа.

Зураг 17. Уншаад урагшлахуй хэлэлцүүлэг

Оролцогчдын дундаас азтанаар шалгарсан 4-р сургуулийн 9а ангийн сурагч А.Мөнхгэрэлд номын багцаар шагнаж урамшууллаа.

27. V/10-18.“ГЭР БҮЛИЙН ШИЛДЭГ НОМЫН САН” шалгаруулах уралдаан

Номын баярыг угтан **“ГЭР БҮЛИЙН ШИЛДЭГ НОМЫН САН”** шалгаруулах уралдааныг өрх гэр бүлийн гишүүдийн ном уншлагыг дэмжих, гэр бүлийн шилдэг номын сангийн туршлагыг нийтэд түгээн дэлгэрүүлж сурталчлах зорилгоор Даланзадгад сумын өрх, гэр бүлүүдийн дунд зарлаж 10 гэр бүл оролцож,танилцуулга материалаа ирүүллээ.

- ✓ Номын сангаа жил бүр баяжуулдаг эсэх
- ✓ Номын сангийн эмх цэгц
- ✓ Өрхийн гишүүдийн номын сангийн хэрэглээ
- ✓ Гэр бүлийн гишүүн бүр унших боломжтой номууд номын санд нь багтсан зэргийг харгалзаж танилцуулгаа ирүүлсэн өрх гэр бүлүүдээс шилдэг 3 номын санг шалгаруулллаа.

Зураг 18. Гэр бүлийн шилдэг номын сан уралдааны шагналт гэр бүл

1-р байр: Э.Итгэлийн гэр бүл
“Өргөмжлөл, 200,000 төгрөгийн үнэ бүхий гэр бүлийн номын багц”
2-р байр: Б.Хандсүрэнгийн гэр бүл
“Өргөмжлөл, 150,000 төгрөгийн үнэ бүхий гэр бүлийн номын багц”
3-р байр: Г.Амартүвшингийн гэр бүл
“Өргөмжлөл, 100,000 төгрөгийн үнэ бүхий гэр бүлийн номын багц”-аар тус тус шагнан урамшуулсан.

28. *V/10-18.“БИ УНШИХ ДУРТАЙ” гар зургийн уралдаан*

Үндэсний бичиг соёл, номын өдрүүдийн хүрээнд **“БИ УНШИХ ДУРТАЙ”** гар

Зураг 19. Би унших дуртай гар зургийн уралдаан

зургийн уралдаан нь сурагчдын авьяас чадварыг дэмжих, номоор дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, өөрсдийн дуртай арга хэлбэр ашиглан чөлөөтэй сэтгэн, урнаар дүрслэн зурах зорилгоор Даланзадгад сумын ЕБС-ийн 1-6-р ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Энэхүү уралдаанд нийт **175** сурагч бүтээлээ ирүүлж оролцсоноос өөрийн бүтээлч байдал, уншсан номынхоо утга агуулга, дүр дүрслэлийг илэрхийлэн, зурсан зургаараа

✓ 1-3-р ангийн төрөлд нийт 97 сурагчид бүтээлээ ирүүлснээс:

1- р байр 3-р сургуулийн 2в ангийн сурагч Х.Монголжин
2- р байр 1-р сургуулийн 3а ангийн сурагч Б.Хонгорзул
3- р байр 2-р сургуулийн 3а ангийн сурагч А.Эгшиглэн
Тусгай байр 1-р сургуулийн 1в ангийн сурагч М.Ундрах

Тусгай байр 5-р сургуулийн 2в ангийн сурагч Х.Хэрлэн нарыг шилдэг зургийн эздээр тодруулж Дурсамж, зургийн хэрэглэгдэхүүн, номоор шагнан урамшууллаа.

✓ 4-6-р ангийн төрөлд нийт 78 сурагчдын бүтээл ирсэн байна.

1- р байр 1-р сургуулийн 5а ангийн сурагч С.Анирлан
2- р байр 1-р сургуулийн 4а ангийн сурагч Э.Анарж
3- р байр 1-р сургуулийн 5г ангийн сурагч О.Нандин-Эрдэнэ
Тусгай байр 2-р сургуулийн 4б ангийн сурагч А.Сарнай

Тусгай байр 3-р сургуулийн 6а ангийн сурагч Б.Анударь нарыг тус тус шалгаруулж Дурсамж, зургийн хэрэглэгдэхүүн, номоор шагнан урамшууллаа.

Зураг 20. Оюуны чихэр-Номын азтан

29. ***V/22 “АХА” танин мэдэхүйн тэмцээн***

Номын баярын арга хэмжээнд оролцогч хүүхэд багачуудын дунд танин мэдэхүйн АХА тэмцээнийг амжилттай зохион явууллаа. Тэмцээнд нийт 36 хүүхэд хамрагдаж оюуны мэдлэг, авхаалж самбаагаа сорьж оролцсоноос 1-р сургуулийн 11г ангийн сурагч Б.Суманчулуун шалгарч номын багцаар шагнууллаа.

30. ***V/22 “ОЮУНЫ ЧИХЭР” онч үгтэй сугалаа***

Арга хэмжээний үеэр оролцогчдын дунд номын багцын азтан шалгаруулах онч мэргэн үгтэй сугалаа сугалж 2 оролцогчийг азтанаар шалгаруулллаа.

Азтанаар 5-р сургуулийн 4д ангийн сурагч Д.Нандин-Эрдэнэ, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ц.Бадамцэрэн нар шалгарч тус бүр номын багцаар шагнууллаа.

31. ***V/31. Хүүхдийн баярыг угтан "ҮЛГЭРЭЭР ҮЛГЭРЛЭЕ"*** арга хэмжээг зохион байгуулж 1-3-р ангийн сурагчдыг хамруулан Монгол ардын үлгэр “Цуутын цагаагч гүү” номоор чанга уншлага хийж, оролцогчдод хүүхдийн баярын бэлэг гардуулан бүтээлч уншлага өрнүүллээ. Хамрагдсан хүүхдийн тоо 14.

Зураг 21. Хүүхдийн баярын уралдаан, үйл ажиллагаа

32. **VI/01** Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан номын сангийн хүүхдийн уншлагын танхимын шинэ номын үзэсгэлэн, шинэ номын худалдаа хүүхдийн номын зохиолч С.Гантогтохтой хамтран зохион байгуулсан “Номтой бэлэг-5” уралдаанд оролцогчдын бэлэг гардуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.
33. ***VI/05. “Соёлын сэргэлт-2023”*** арга хэмжээнд зориулан шинэ номын үзэсгэлэн азтан бүхий номын сангийн үйлчилгээний талаарх санал асуулга арга хэмжээг Ажнай талбайд зохион байгууллаа.

Зураг 23. Соёлын сэргэлт-Талбайн үзэсгэлэн

34. ***VI/13-VI/. “Ургамал судлаач” хөтөлбөр.*** Сурагчдын зуны амралтад зориулан хүүхдийг бүтээлч уншлагад хөтлөн аливаа зүйлийн талаар шинжлэх ухаанчаар судлан суралцах арга барил эзэмшүүлэх, байгаль эхээ танин мэдэх хайрлан хамгаалах сэдэл төрүүлэх зорилгоор Ирээдүйн эрдэмтэн боловсролын хөтөлбөрийн “Ургамал судлаач” хөтөлбөрт 6-8-р ангийн 12 сурагчдыг хамрууллаа. 14 хоногийн хугацаанд, 5 өдрийн хөтөлбөрийг

Зураг 22. Ургамал судлаач сургалт

- Ургамал гэж юу вэ?
- Үр хэрхэн соёолдог вэ?
- Мод хэрхэн ургадаг вэ?

- Сонирхолтой бас мэдээлэлтэй.
- Мэдсэнээ гараараа бүтээцгээе! сэдвийн хүрээнд Номын санч Н.Даваажаргал, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа нар хамтран хэрэгжүүллээ.

35. ***VI/13-23. “Амьтан судлаач” хөтөлбөр.*** Сурагчдын амралтад зориулан Ирээдүйн эрдэмтэн хөтөлбөрийн “Амьтан судлаач” хөтөлбөрт 4-6-р ангийн 13 сурагчдыг хамруулллаа. Хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдэд үлэг гүрвэл түүний үүсэл, төрөл зүйл Монголын говь Өмнөговиос олдсон үлэг гүрвэлийн олдворын талаарх мэдээллийг олгож хүүхдийн бүтээлч уншлага, судлан шинжлэх, эрж хайх, олж мэдэх чадварыг хөгжүүлэн ажиллаа. Хөтөлбөрийг Фондчин Т.Нямсүрэн, Каталогч М.Баасанжав нар хэрэгжүүллээ. Ирээдүйн эрдэмтэн хөтөлбөрийн сургалтуудын хэрэглэгдэхүүний зардлыг “Чойжил Амаа сан” ТББ ивээн тэтгэж ажиллав.

Зураг 24. Амьтан судлаач сургалт

36. ***VII/06. АХА танин мэдэхүйн тэмцээн.*** 0167-р ангид алба хааж буй Оюутан цэргүүдийн дунд ном зохиол болон танин мэдэхүйн асуултууд бүхий АХА тэмцээн зохион байгууллаа. /76 оролцогч/

37. ***VIII/09-11, VIII/14-16 “Бүтээлчээр уншихуй” дугуйлан.***
Хүүхдийн зуны амралтад зориулсан “Бүтээлчээр уншихуй” дугуйлангийн **12** хүүхдүүдэд бүтээлч уншлагын хичээл орсон.

38. ***VIII/06. "Компьютерт зураг зурах, хөдөлгөөнд оруулах” сургалт*** Сурагчдын зуны амралтыг тохиолдуулан хүүхдийн бүтээлч уншлагыг дэмжих, авьяасыг хөгжүүлэх зорилгоор компьютерт зураг зурах анимешн бүтээх сургалтыг зохион байгуулж 6 хүүхэд хамрагдлаа.

39. ***VIII/25. "Ардын аман зохиол” сэдэвт хэл яриа хөгжүүлэх сургалт*** Сурагчдын зуны амралтад зориулсан "Ардын аман зохиол” сэдэвт хэл яриа хөгжүүлэх 3 өдрийн сургалт амжилттай зохион явуулсан. Сургалтаар
    - Ардын аман зохиол болон Түргэн хэллэг
    - Оньсого таавар
    - Монгол ардын үлгэр зэрэг ардын аман зохиолын төрөл зүйлүүдийн ялгааг таниулан танилцууллаа. /Оролцогч 10/

40. IX/11-IX/20. Үндэсний бичиг соёл номын өдрүүд

МУ-ын ерөнхийлөгчийн 2012 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн "Номын баярын өдөр тэмдэглэх тухай" 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал,утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулах зорилтын хүрээнд, Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын хэрэгжилтийг ханган34 дэх удаагийн Үндэсний номын баяр-2023 арга хэмжээг “Илүү их уншъя” уриан дор 09 дүгээр сарын 11-20-ны өдрүүдэд үндэсний бичиг, соёлын өвийг сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг өргөн хүрээнд зохион байгуулах зорилгоор тэмдэглэн өнгөрүүллээ.

Зураг 25. Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2023

Өмнөговь аймгийн соёл урлагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Музей, Төв номын сан, Хөгжимт жүжгийн театр зэрэг байгууллагууд хамтран орон нутгийн иргэд, төрийн албан хаагчид, СӨБ-ын байгууллагууд, ЕБСургуулиудын 200 гаруй иргэдийг хамруулан аймгийн Хөгжимт жүжгийн театрт нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Иргэдийг соён гэгээрүүлэх, номын соёлыг дэлгэрүүлэх намрын номын баярын арга хэмжээг нээж АЗДТГазрын дарга Ц.Амартөгс нээн үг хэлж, номын сангийн дэргэдэх "Ирээдүйн ээзэд" номын клубийн сурагчид флашмоб бүжгээр, Тавдугаар сургуулийн 7в ангийн сурагчид “Миний ном”дуугаар мэндчилгээ дэвшүүлж ирсэн зочдын сонор, мэлмийг мялаалаа.

IX/11-20 өдөр

Номын баярын өдрүүдэд зохион байгуулагдсан арга хэмжээ:

- “Соён гэгээрүүлэх” лекц
- “Шагнал гардуулах” арга хэмжээ /Шилдэг сургууль, цэцэрлэг, номын санч, тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэг/
- “Хүүхэд бүрийн заавал унших ном”-ын үзэсгэлэн
- “Шинэ, хуучин ном”-ын худалдаа, солилцоо
- Ирээдүйн эрдэмтэн зуны хөтөлбөр”-ийн үзэсгэлэн
- “Зохиолчдын ном”-ын үзэсгэлэн
- “Д.Содномдорж”-ийн номын үзэсгэлэн
- “Монгол улс” номын үзэсгэлэн
- “Номын хандив”
- “Ном бид хоёр” номын хэлэлцүүлэг
- “Монгол бичгийн цахим бичвэр” сургалт зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгууллаа.

34 дэх удаагийн Номын баярын арга хэмжээний мэдээлэл сурталчилгаа, зарлал, зурагт хуудаснуудыг өөрийн цахим хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллээр олон нийтэд мэдээлснээр 1300 гаруй хандалт авсан.

Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, ном хэвлэлийг сурталчлах, сумд болон аймгийн төвийн гэр хорооллын хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээг сонирхолтой, шинэлэг байдлаар хүргэж ном уншлагад татах, сан хөмрөг баяжуулахад шаардлагатай 20,971,510 мянган төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.

Ингэснээр иргэдийн санал хүсэлтэд тулгуурласан уран зохиолын болон бусад төрлийн шинжлэх ухааны шинэ номууд, харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх брайл ном, номын сангийн үйлчилгээний зөөврийн асар, номын тавиур, бусад хэрэглэгдэхүүнүүдийг үйл ажиллагаандаа ашиглахаар тусгасан.

IX/11“СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ” лекц

Бүх нийтийн соёлын боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр МУИС-ын АБАНХ-тэй хамтран “Уран зохиол ба ёс суртахуун”/Доктор профессор, СГЗ Д.Дагвадорж/, “Хотын соёл” /Философийн шинжлэх ухааны доктор, нэрт соёл судлаач Т.Дорждагва/, “Монгол үг сургаалын эрчим хүч” хэл шинжлэлийн ухааны доктор Л.Чулуунбаатар нар номын баярын нээлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэд, албан хаагчдад зориулан зохион байгууллаа.

Лекцийн үеэр МУИС-ийн эрдэмтэн, докторуудын эмхэтгэн гаргасан эрдэм шинжилгээний бүтээл, туурвилын дээжээсээ номын сангийн сан хөмрөгт гардуулан өглөө.

Зураг 26. Соён гэгээрүүлэх лекц

IX/11. “ШАГНАЛ ГАРДУУЛАХ” үйл ажиллагаа

Аймгийн Засаг даргын санаачилгаар "Говийн ирээдүй хүүхэд" хөтөлбөрийн хүрээнд хүүхдэд бага наснаас ном унших дадал хэвшлийг бий болгох, номтой нөхөрлөх, номоос суралцах соёлыг дээдлэн хөгжүүлэх, ном уншихын ач холбогдлыг таниулах, бүтээлчээр унших арга зүйд сургах зорилгоор 2022-2023 оны хичээлийн жилд зохион байгуулагдсан **"Уншдаг хүүхэд хөгждөг"** хөтөлбөрт хамрагдсан Даланзадгадын ЕБСургуулиуд, СӨБоловсролын хамт олон нээлтийн үйл ажиллагаанд зориулан тус аяны үеэр хийж бүтээсэн бүтээлүүдээ иргэд олон нийтэд сурталчлан танилцууллаа.

Шилдэг сургууль: Сурагчдыг номтой нөхөрлүүлэн, номоор дамжуулан хөгжүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан шилдэг туршлага үзэсгэлэнгээ Үндэсний бичиг соёл, номын өдрүүдээр олон нийтэд танилцуулан номын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд манлайлан ажилласныг үнэлж Даланзадгадын Долоодугаар сургуулийн хамт олныг өргөмжлөл, номын багцаар шагнаж урамшуулсан.

Шилдэг цэцэрлэг: Хүүхдийг багаас нь номтой нөхөрлүүлэн номоор дамжуулан хөгжүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж буй шилдэг туршлага үзэсгэлэнгээрээ

Даланзадгадын Хоёрдугаар цэцэрлэгийн хамт олон шалгарч өргөмжлөл, номын багцаар шагнаж урамшуулсан.

Шилдэг уншигч: Номын сангийн Гэрээр ном олгох танхимын уншигч Бямбаабатын Ундрам 2023 онд нийт 226 ширхэг ном уншиж шилдэг уншигч өргөмжлөл, номын багцаар шагнууллаа.

Шилдэг номын санч: Орон нутагт номын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд оруулсан хувь нэмэр, хүүхэд, залуучуудыг номтой нөхөрлүүлэн бүтээлч, шинэлэг ажлуудыг санаачлан хэрэгжүүлж ажилласан Сэврэй сумын номын санч Ц.Дэлгэрмааг шилдэг номын санч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

Тэргүүний уншигч Д.НАЦАГДОРЖ тэмдэг:

Өмнөговь аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын шилдэг уншигч, бүтээлч сурагчдыг алдаршуулах, урамшуулах зорилгоор Д.Нацагдорж тэмдгээр шагнан урамшууллаа.

Зураг 27. Номын баяр-Шагнал

1. Б. Намуун (1-р сургуулийн 11Б анги)
2. У.Аззаяа (5-р сургуулийн 8В анги)
3. А.Соёл-Эрдэнэ (5-р сургуулийн 8В анги)
4. Э.Сондор (2-р сургуулийн 6А анги)
5. Б.Золжаргал (4-р сургуулийн 12А анги)
6. О.Золбоо (4-р сургуулийн 12А анги) нарыг тэргүүний уншигчаар өргөмжлөн Д.Нацагдорж тэмдгээр шагнаж урамшууллаа.

IX/11“ХҮҮХЭД БҮРИЙН ЗААВАЛ УНШИХ НОМ”-ын үзэсгэлэн

Баярын үеэр номын сангийн Хүүхдийн уншлагын танхимын уран зохиолын 27 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж нийтэд танилцууллаа.

IX/11“ШИНЭ, ХУУЧИН НОМ”-ын худалдаа, солилцоо

Номын баярт зориулан хүүхдийн болон уран зохиолын олон нэр төрлийн номын худалдаа, солилцоог зохион байгууллаа.

IX/11“ИРЭЭДҮЙН ЭРДЭМТЭН ЗУНЫ ХӨТӨЛБӨР”-ийн үзэсгэлэн

Хүүхдийг бүтээлч уншлагад хөтлөн аливаа зүйлийн талаар шинжлэх ухаанчаар судлан суралцах арга барил эзэмшүүлэх, номтой нөхөрлүүлэн хүүхдийн ярих чадвар, бүтээлч байдал, чөлөөт цагийг үр бүтээлтэй

Зураг 28. Номын баяр-Үзэсгэлэн

өнгөрүүлэх зорилгоор “Ирээдүйн эрдэмтэн” зуны хөтөлбөрийн хүрээнд “Амьтан судлаач”, “Ургамал судлаач” сургалтыг зохион байгуулсан.

Сургалтад ЕБС-ийн 4-8 дугаар ангийн 20 хүүхдийг хамруулж хичээллэсэн. 14 хоногийн хөтөлбөрт хамрагдсан сурагчдын төлөөллүүд номын баярт зориулан бүтээлүүдээрээ үзэсгэлэн гаргаж иргэдэд танилцууллаа.

IX/11“ЗОХИОЛЧДЫН НОМ”-ын үзэсгэлэн

- МЗЭ-ийн гишүүн, “Утга зохиолын төлөө” шагналт, яруу найрагч Ваанчигийн Өсөхбар орон нутгийнхаа зохиолчдыг төлөөлөн өөрийн бүтээн туурвисан номуудаар үзэсгэлэн гаргаж хамтран ажиллалаа.
- Өмнөговь аймгийн Музейн хамт олон “Түүх соёл, шинжлэх ухаан”-ы судалгааны 25 ширхэг номоор үзэсгэлэн гаргалаа.

IX/09-15 “Д.СОДНОМДОРЖ”-ийн номын үзэсгэлэн

МЗЭ-ийн шагналт, Нацагдоржийн нэрэмжит шагналт хүүхдийн зохиолч, яруу найрагч Дамдинцоогийн Содномдоржийн 33 шилдэг номын үзэсгэлэнг Хүүхдийн уншлагын танхимд гаргаж 141 хүнд хүргэн ажиллалаа.

IX/11-20 “МОНГОЛ УЛС” номын үзэсгэлэн

Манай сан хөмрөгт хадгалагдаж байдаг улс үндэстэн, байгаль, түүх, нийгэм, эдийн засаг газарзүйн олон талт мэдээллийг агуулсан атлас болон зургийн цомог бүхий "МОНГОЛ УЛС" сэдэвт номын үзэсгэлэнг үндэсний бичиг, соёл номын өдрүүдийн хүрээнд Нийтийн уншлагын танхимд гаргаж, уншигч үйлчлүүлэгчдэд сурталчилсан. Нийт 26 ширхэг номоор 108 хүнд хүргэсэн.

IX/11-15 “НОМЫН ХАНДИВ”

Номын баярын өдрүүдэд хувь хүмүүсийн хандиваар 28 нэр төлийн, 38 ширхэг номоор сан хөмрөгөө баяжууллаа.



Зураг 29. Номын баяр-Танхимын үзэсгэлэн

41. IX/14 “НОМ БИД ХОЁР” номын хэлэлцүүлэг

Зураг 30. “Ном бид хоёр” номын хэлэлцүүлэг

Ном уншлагыг дэмжих, уншсан номоо бусадтай хуваалцан эерэг хандлагыг бий болгох, ном уншиж хөгжих боломж боломжоог хангах, бусдыг уншлагад уриалан номын соёлыг түгээх зорилгоор зохион байгуулсан уг хэлэлцүүлэгт 12 хүн хамрагдлаа. Хэлэлцүүлгийн дундуур оролцогчдоос 2 номын азтан шалгаруулж М.Ууганбаяр, М.Түмэнжаргал нар номын багцын эзэд боллоо.

42. IX/14 “МОНГОЛ БИЧГИЙН ЦАХИМ БИЧВЭР” сургалт

Үндэсний бичгээ сэргээн санах, албан болон хувийн хэрэгцээнд ашиглаж эхлэх зорилгоор компьютер дээр Монгол бичгээр бичих, анхны шатны мэдэгдэхүүн олгох танхимын сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 6 төрийн албан хаагчийг хамрууллаа.

Зураг 31. Монгол бичгийн цахим бичвэр сургалт

43. X/09. “Нээлттэй өгөгдлийн үнэ цэн” сургалт

Эмэгтэйчүүдийн манлайлал дугуйлангийн эмэгтэйчүүдэд зориулан Нээлттэй өгөгдлийн үнэ цэн, нээлттэй өгөгдлүүдийн эх сурвалжийг танилцуулах сургалтыг зохион байгуулж иргэний нийгэм, төрийн байгууллагын 12 эмэгтэй хамрагдлаа.

44. XI/09. “Тусч уншигч” хөтөлбөрийн ээжүүдэд зориулсан сургалт

Зураг 32. Хүүхдээ номоор хөгжүүлэхүй ээжүүдэд зориулсан сургалт

Сургууль цэцэрлэгүүдийн эцэг эхийн төлөөлөл 15 эцэг эхэд хүүхдийг номоор хөгжүүлэхийн ач холбогдол, номын сангийн ном хэвлэл, үйлчилгээг танилцуулсан үзэсгэлэн танилцуулга, номын сангийн уншигч залуу ээж А.Баттуулын хүүхдээ багаас нь номоор хөгжүүлж буй туршлагаас хуваалцсан сургалтыг зохион байгууллаа.

45. X/10. Номтой өглөө-Нийгмийн салбарын удирдлагуудын уулзалт

Нийгмийн салбарын байгууллагуудын удирдлагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, номын сангийн үйл ажиллагаатай танилцуулах өглөөний арга хэмжээг зохион байгуулж шинээр ирсэн болон орон нутгийн сан хөмрөгийн номын дээжээс үзэсгэлэн гарган танилцуулж хүүхдээ ойлгож тэдэнтэй харилцах хамгийн сайн арга бол тэдний уншдаг номыг уншиж харилцан ярилцах гэдэг агуулгын хүрээнд өглөөг хүүхдийн

номоор эхлүүлэхийг уриалан хүүхэд багачуудын сүүлийн үед хамгийн их уншигдаж буй номуудаа ирсэн зочдодоо сонголтоор уншуулж Номтой өглөөг эхлүүллээ.

Дарга А.Одончимэг "Нээлттэй өгөгдөл" сургалтаараа нээлттэй өгөгдөл гэж юу болох түүнийг ашиглан үнэ цэнийг хэрхэн бүтээж болох нээлттэй өгөгдлүүдийн эх сурвалжуудыг танилцууллаа.

Зураг 33. “Номтой өглөө” уулзалт

46. XI/30. МОНГОЛ БИЙ БИЕЛГЭЭ-СББӨ сургалт

Өмнөговь аймгийн 14 сумын Соёлын төвийн дарга, Соёлын өвийн ажилтан бүжгийн багш, Хөгжимт жүжгийн театрын бүжиг ангийн хамт олон зэрэг нийт 48 хүнд Соёлын биет бус өв-Монгол бий биелгээ цахим сургалтыг Соёл урлагийн газартай хамтран зохион байгууллаа.

Сургалтын хүрээнд соёлын биет бус өвийн тухай ойлголт, ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт болон Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтын ялгаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, “Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох чадварыг тогтворжуулах нь” төслийн танилцуулгыг “Монгол улсын Соёлын биет бус өвийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх, сургагч багш бэлтгэх” сургалтад хамрагдсан Төв номын сангийн дарга А.Одончимэг, Соёл, урлагийн газрын Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Халиунаа нар хамтран зохион байгууллаа.

47. XI/7. “Нээлттэй өгөгдлийг ашиглах нь” сургалт

Нээлттэй өгөгдөлд дүн шинжилгээ хийж түүнийгээ мэдээллийн болон үйлчлүүлэгчийн хэрэгцээ онцлогт нийцүүлэн дүрслэх арга барил олгох төлбөрт сургалтыг зохион байгуулж 20 хүнийг хамруулан мэдээлэлтэй ажиллах ур чадварыг дээшлүүллээ.

Зураг 34. Нээлттэй өгөгдлийг ашиглах нь сургалт

48. X/14-X/15. "НОМТОЙ ӨМНӨГОВЬ" зохиолчдын өдөрлөг арга хэмжээ

Иргэдийн ном унших идэвхийг дэмжих, өрхийн болон байгууллагын номын сангаа баяжуулахад хямдралтай үнээр номын худалдан авалт хийх, зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа, зохиолч уншигчдын уулзалт “Номтой Өмнөговь” арга хэмжээг Соёлын Гавьяат зүтгэлтэн Д.Жамъян, Төрийн шагналт зохиолч С.Оюун тэргүүтэй 30 гаруй зохиолчдын багийг орон нутагт урин зохион байгууллаа.
Уг арга хэмжээний үеэр зохиолч уншигчдын уулзалт, Эрхэм зохиолч танаа зохиолчид хандсан сэтгэгдэл бичих, зохиолчтой хамт зураг авхуулах, номын азтан тодруулах зэрэг үйл ажиллагааг иргэдийн дунд зохиолоо.

Зураг 35. Номтой-Өмнөговь зохиолчдын өдөрлөг

Арга хэмжээнд оролцсон зохиолчдын зүгээс 25 нэр төрлийн 32 ширхэг 612,000төгрөгийн номыг сан хөмрөгт хандивлалаа.

49. XI/9. “Paint программ” сургалт

Хүүхдийн бүтээлч байдал, авьяасыг хөгжүүлэх номын сангийн үйлчилгээ үйл ажиллагааг танилцуулах зорилгоор зохион байгуулсан зургийн программ ашиглах сургалтад 20 хүүхдийг хамруулллаа.

50. XI/11. Соёл урлагийн байгууллагуудын ажилтан ажиллагсдад зориулсан Соёлын биет бус өв сургалт

Төвийн соёл урлагийн байгууллагууд болон сумдын соёлын төвийн ажилтан ажиллагсдад зориулсан “Соёлын биет бус өв” сургалтыг Соёл урлагийн газартай хамтран зохион байгууллаа. Сургалтын хүрээнд Юнескогийн СББӨ-ийн конвенцын үзэл баримтлал, Монголын СББӨ-ийн өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдлэг ойлголтуудыг танилцууллаа.

51. XI/16. Эцэг эхчүүдэд зориулсан Хүүхдээ номоор хөгжүүлэхүй сургалт - Баяндалай сум

Баяндалай суманд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааны хүрээнд эцэг, эхчүүдэд хүүхдийг номоор хөгжүүлэх боломжийг танилцуулсан лекц сургалтыг зохион байгуулан хүүхдийн номын чиг хандлага, хүүхдийн нас хөгжлийн

онцлогт тохируулан ном сонгон ярьж унших өгөх аргуудаас танилцууллаа. /Оролцогч 33/

52. XI/16. “30 ном уншъя” танин мэдэхүйн тэмцээн -Баяндалай сум

Баяндалай суманд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааны хүрээнд сурагчдын дунд ном зохиол, танин мэдэхүйн сэдэвт “30 ном уншъя” танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулан 83 үзэгч, оролцогчид оролцлоо.

53. XI/23. Эцэг эхчүүдэд зориулсан Хүүхдээ номоор хөгжүүлэхүй сургалт –Цогт-Овоо сум

Цогт-Овоо суманд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааны хүрээнд эцэг, эхчүүдэд хүүхдийг номоор хөгжүүлэх боломжийг танилцуулсан лекц сургалтыг зохион байгуулан хүүхдийн номын чиг хандлага, хүүхдийн нас хөгжлийн онцлогт тохируулан ном сонгон ярьж унших өгөх аргуудаас танилцууллаа. /Оролцогч 30/

Зураг 36. Хүүхдээ номоор хөгжүүлэхүй эцэг эхчүүдэд зориулсан сургалт-сумдад

54. XI/23. “Номын тэмдэглэл хөтлөх аргууд” сургалт –Цогт-Овоо сум

Цогт-Овоо суманд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааны хүрээнд сурагчдад зориулан номыг бүтээлчээр унших буюу номын тэмдэглэл хөтлөх аргуудаас танилцуулсан сургалтыг зохион байгууллаа.

Зураг 37. Номын тэмдэглэл хөтлөх сургалт-Сумдад

55. XI/23. “Оюуны чихэр номын азтан” –Цогт-Овоо сум

Цогт-Овоо суманд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааны хүрээнд онч үг бүхий сугалаанд 28 хүүхэд оролцсоноос 1 азтан тодруулан 50,0мянган төгрөгийн номын багцаар урамшууллаа.

56. XI/23. Хэн хамгийн олон шүлэг мэдэх вэ? тэмцээн.

0131-р ангийн хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэх ажлын хүрээнд зохион байгуулсан уг тэмцээнд 12 оролцогч оролцон авьяас, оюуны хурдаараа өрсөлдлөө.

57. *XI/26. Түүхийн жимээр-Өмнөговь номын нээлт*

Өмнөговь аймгийн иргэдийн өнөөгийн түүхийг бүтээн буй хүмүүсийн ярилцлага хөрөг бүхий Түүхийн жимээр-Өмнөговь номын нээлтийг Эх түүхийн жимээр ТВ-тэй хамтран зохион байгууллаа. Арга хэмжээнд аймгийн төвийн болон сумдын төлөөлөл уг номд мэдээлэл нь орсон 74 хүн оролцлоо.

Зураг 38. СТМА зургууд

58. *XI/28. Уул уурхайн нээлттэй өгөгдлүүдийг ашиглах боломжийг танилцуулах "Early commers" арга хэмжээ, сургалт*

Уул уурхайн нээлттэй өгөгдлүүдийг ашиглах боломжийг танилцуулах "Early commers" арга хэмжээ, сургалтад тус номын сангийн дарга А.Одончимэг оролцон иргэний нийгмийн төлөөлөл болон сэтгүүлчид бүхий 20 хүнд уул уурхайн нээлттэй өгөгдлүүдийн талаарх мэдлэг ойлголт өгөх сургалтыг зааж оролцлоо.

59. *XI/28. Эцэг эхчүүдэд зориулсан Хүүхдээ номоор хөгжүүлэхүй сургалт – Мандал-Овоо сум*

Мандал-Овоо суманд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааны хүрээнд эцэг, эхчүүдэд хүүхдийг номоор хөгжүүлэх боломжийг танилцуулсан лекц сургалтыг зохион байгуулан хүүхдийн номын чиг хандлага, хүүхдийн нас хөгжлийн онцлогт тохируулан ном сонгон ярьж унших өгөх аргуудаас танилцууллаа. /Оролцогч 22/

60. *XI/28. “Номын тэмдэглэл хөтлөх аргууд” сургалт –Мандал-Овоо сум*

Мандал-Овоо суманд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааны хүрээнд сурагчдад зориулан номыг бүтээлчээр унших буюу номын тэмдэглэл хөтлөх аргуудаас танилцуулсан сургалтыг зохион байгууллаа.

61. *XI/28. “Оюуны чихэр номын азтан” –Мандал-Овоо сум*

Мандал-Овоо суманд зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэх үйл ажиллагааны хүрээнд онч үг бүхий сугалаанд 41 хүүхэд оролцсоноос 1 азтан тодруулан 50,0мянган төгрөгийн номын багцаар урамшууллаа.

62. XI/28. Уул уурхайн нээлттэй өгөгдлүүдийг ашиглах боломжийг танилцуулах "Early commers" арга хэмжээ, сургалт

Уул уурхайн нээлттэй өгөгдлүүдийг ашиглах боломжийг танилцуулах "Early commers" арга хэмжээ, сургалтад тус номын сангийн дарга А.Одончимэг оролцон иргэний нийгмийн төлөөлөл болон сэтгүүлчид бүхий 20 хүнд уул уурхайн нээлттэй өгөгдлүүдийн талаарх мэдлэг ойлголт өгөх сургалтыг зааж оролцлоо.

63. XI/28. "Quiz evening" мэдээллийн арга хэмжээ

ЕБСургуулийн ахлах ангийн сурагчид болон оюутнуудад зориулсан "Quiz evening" арга хэмжээг Олон улсын санхүүгийн корпорац, МУУҮАссиоцацитай хамтран зохион байгууллаа. 33 хүүхэд залуучууд оролцон “Мэдлэгт хөтлөх 50 асуулт, хариулт” номын танилцуулга мэдээллийг хүлээн авч, уул уурхайтай холбоотой мэдлэг сорьсон асуултаар баг болон өрсөлдлөө.

64. XI/28. "Анхны анимэйшн" сургалт

Даланзадгад сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 12а ангийн 31 сурагч, 7-р сургуулийн 11б ангийн 2 сурагч, 7-р сургуулийн 11а ангийн 3 сурагч нийт 36 сурагч компьютерт зураг зурах, зурсан зургаа хөдөлгөөнд оруулах анимэйшн бүтээх анхан шатны сургалтад Соёлын эрхийн бичгээр хамрагдлаа.

Зураг 39. Анхны анимэйшн сургалт

65. XI/29. "Анхны анимэйшн" сургалт

Даланзадгад сумын Ерөнхий боловсролын 7-р сургуулийн 12а ангийн 27 сурагч компьютерт зураг зурах, зурсан зургаа хөдөлгөөнд оруулах анимэйшн бүтээх анхан шатны сургалтад Соёлын эрхийн бичгээр хамрагдлаа.

66. XII/8. “Түүхт хөшөө” эссэ бичлэгийн уралдаан

Аймгийн түүхэн ном зохиолыг сурталчлах, сурагчдын орон нутгийн түүхийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор аймгийн ЕБСургуулийн 8-12-р ангийн сурагчдын дунд “Түүхт хөшөө” эссэ бичлэгийн уралдааныг 11-р сарын 23-ны өдрөөс 12-р сарын 8-ны өдрийг хүртэлх хугацаанд зарлан зохион байгуулж байна.

67. ***XII/12. “Миний нутгийн гайхамшиг” гар зургийн уралдаан***

Цахим уншигчийг идэвхжүүлэх зорилгоор “Миний нутгийн гайхамшиг” гар зургийн уралдааныг аймгийн ЕБСургуулийн 4-7-р ангийн сурагчдын дунд 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12-р сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж 36 сурагчид оролцлоо.

68. ***XII/22. “Номын сангийн өнөөдөр ба маргааш” хэлэцүүлэг***

Номын сангийн өнөөгийн байдал, хэтийн чиг хандлагыг тодорхойлж, соёл олон нийтийн ажил болон сургалт, судалгааг хөгжүүлэх,уншигч, номын санчдын уялдаа холбоог сайжруулах зорилгоор уншигчид болон ахмад номын санчид хамтрагч байгууллагуудын төлөөлөл оролцсон хэлэлцүүлгийг зохион байгуулж номын сангийн үйлчилгээ үйл ажиллагаанд хэрэгжүүлэх санал шүүмжийг сонслоо.

Мэдээлэл сурталчилгаа

Номын сангаас зохион байгуулсан арга хэмжээнүүдийг Мэлмий сайтаар 3 удаа, Олон нийттэй харилцах хэлтэст 7 удаа, Монцамэ агентлагийн сайтаар 3 удаа тус тус хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 13 удаа, байгууллагын нүүр ном хуудсаар 233 удаа мэдээ, мэдээлэл тавьж /31794 хандалт/ олон нийтэд үйлчилгээ үйл ажиллагаагаа сурталчилж ажиллав. 110 хүнд интернэт компьютерын үйлчилгээ үзүүлж мэдээлэл өгч ажиллав.

Сан хөмрөгийн хуучин ном хэвлэлийг сурталчлах, тэмдэглэлт өдрүүд, тодорхой сэдвийг хамарсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 48 удаа 1636 ширхэг номоор гарган 5920 хүнд, шинэ ном хэвлэлийг уншигчид олон нийтэд танилцуулах номын үзэсгэлэнг нийт 21 удаа 651 ширхэг номоор гарган 2276 хүнд танилцуулж ажиллалаа.

Шинэ номын үзэсгэлэн /21 удаа 651 ширхэг номоор 2276 хүнд/

- Нийтийн уншлагын танхим – 3удаа 79 ширхэг номоор /356 хүнд/
- Гэрээр ном олгох танхим – 4 удаа 179 ширхэг номоор /907 хүнд/
- Хүүхдийн уншлагын танхимаас- 5 удаа 184 ширхэг номоор/591 хүнд/
- Үндсэн сан хөмрөгөөс -5 удаа 132 номоор 206 үзэгч
- Мэдээллийн төвөөс – 3 удаа 77 номоор 216 хүнд

Номын сэдэвчилсэн үзэсгэлэн /48 удаа 1636 ширхэг номоор 5290 хүнд/

Нийтийн уншлагын танхимаас 10 удаагийн үзэсгэлэнг нийт 453 ширхэг номоор гаргаж 1190 хүн үзэж сонирхсон

1. II/17. Монгол бичгийн сурах бичгийн номын үзэсгэлэн 30 ном 131хүн
2. III/06. Амтат хоол үзэсгэлэн 34 ном 157 хүн үзсэн
3. III/21. Өмнөговь аймгийн зохиолч, яруу найрагчдын номын үзэсгэлэн 48 номоор 53 хүнд
4. IV/1. Эдийн засгийн номоор үзэсгэлэн гаргасан 32 номоор 83 хүнд
5. IV/11. Өрхийн үйлдвэрлэл сэтгүүлээр үзэсгэлэн гаргасан.98 сэтгүүл160 хүнд
6. VI/08. Хувь хүний номоор үзэсгэлэн гаргасан 34 номоор хүнд
7. VII/7. Залуу эмэгтэй заавал унших номын үзэсгэлэн 42 номоор 193 хүн
8. X/13. Политехникийн коллеж дээр мэргэжлийн номоо үзэсгэлэн гаргасан61 номоор 130 хүн үзсэн
9. IX/26. Ахлах ангийн сурагчдад зориулсан 25 номоор 83 хүн

10. XI/06. Монголын эх түүх номын үзэсгэлэн 49 номоо 200 хүн

Зураг 40. Сэдэвчилсэн үзэсгэлэн

Хүүхдийн уншлагын танхимаас 10 удаа 308 номоор үзэсгэлэн гаргаж 1339 хүүхэд, багачуудад танилцуулсан байна

1. I/20-II/03. Танин мэдэхүйн ШУ-ны тухай 20 номоор үзэсгэлэн гаргаж нийт цахимаар 77 хүн үзэж, танхимаар 234 хүүхэд уншиж танилцсан байна.
2. II/10-II/27. Д.Мягмар зохиолчийн 34 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 132 хүн үзэж, танхимаар 56 хүүхэд уншиж танилцсан байна.
3. III/14-III/24. “Монгол ардын үлгэр” үзэсгэлэнг 24 номоор гаргаж цахимаар 152 хүн үзэж, танхимаар 151 хүүхэд уншиж танилцсан байна.
4. III/30-IV/02. Хүүхдийн номын өдөрт зориулсан Х.К.Андерсений зохиол 26 номоор гаргаж цахимаар 276 хүн үзэж, танхимаар 55 хүүхэд уншиж танилцсан байна.
5. V/25-VI/12. Хүүхдийн баярт зориулсан хүүхдийн хүмүүжилтэй холбоотой 51 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 193 хүн үзэж, танхимаар 148 хүүхэд уншиж танилцсан байна.
6. VI/14-VI/30. Хүүхдийн зуны амралтад зориулсан “Домог яриад өгөөч” номын үзэсгэлэнг 20 номоор гаргаж цахимаар 140 хүн үзэж, танхимаар 81 хүүхэд уншиж танилцсан байна
7. VII/3-VII/17. Д.Гармаа зохиолчийн уран бүтээл 29 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 175 хүн үзсэн.
8. IX/1-IX/7. Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан “Хүүхэд бүрийн заавал унших ном”-ууд гэсэн үзэсгэлэнг 26 номоор гаргаж 2 номын азтан шалгаруулж цахимаар 51 хүн үзсэн.
9. IX/8-IX/15. Намрын номын баярыг угтаж хүүхдийн зохиолч Д.Содномдоржийн 33 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 106 хүн үзэж, танхимаар 43 хүүхэд уншиж танилцсан байна.
10. X/19. Зохиолч Л.Түдэвийн уран бүтээл болох 52 номоор сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж цахимаар 112 хүн үзсэн байна.

11. ***Гэрээр ном олгох танхимаас үзэсгэлэнг 10 удаа 340 номоор гаргаж 1244 хүн үзэж танилцсан***

1. II/13. “Хайр” сэдэвт номын үзэсгэлэн 32ш номоор 129 хүнд хүрсэн.
2. II/17. “Ёс заншил” сэдэвт номын үзэсгэлэн 32ш номоор 68 хүнд хүрсэн.
3. III/07. “Бүсгүйчүүдийн заавал унших ном” сэдэвт номын үзэсгэлэн 32ш номоор 259 хүнд хүрсэн.
4. III/17. “Эрчүүдийн заавал унших ном” сэдэвт номын үзэсгэлэн 32ш номоор 185 хүнд хүрсэн
5. V/12. “Жаргалтай гэр бүл” сэдэвт номын үзэсгэлэн 32ш номоор 118 хүнд хүрсэн
6. V/29. “Бяцхан уншигчдадаа сэдэвт номын үзэсгэлэн 32ш номоор 152 хүнд хүрсэн
7. IX/27. Хувь хүний хөгжил сэдэвт номын үзэсгэлэн 32ш номоор 63 хүнд хүрсэн
8. XI/10. Д.Пүрэвдоржийн уран бүтээлээр номын үзэсгэлэн 30ш номоор 198 хүнд хүрсэн
9. XI/30. Эрүүл мэнд сэдэвт номын үзэсгэлэн 34ш номоор 36 хүнд хүрсэн
10. XII/13. Баярын ширээ сэдэвт номын үзэсгэлэн 32ш номоор 46 хүнд хүрсэн

Үндсэн сан хөмрөгөөс 13 удаагийн үзэсгэлэнг 384 ширхэг номоор 1185 хүн үзэж танилцсан.

1. II/10 Сар шинийн баярт зориулан “**Монголын уламжлалт ёс заншил**” сэдэвт номын үзэсгэлэн /35 ширхэг номоор 146 ирцэд/
2. III/3.Түмэн тэмээний баяр-2023 тохиолдуулан **“Тэмээ”**сэдэвт номын үзэсгэлэн/19 ширхэг номоор 61 ирцэд/
3. III/3-10 Олон улсын эмэгтэйчүүдийн баярт зориулан гаргасан **"Монголын эмэгтэйчүүд"**сэтгүүлийн үзэсгэлэн /20 ширхэг номоор 140 ирцэд/
4. III/17 **“Дэлхийн яруу найргийн өдөр”-**ийг тохиолдуулан гаргасан яруу найргийн номын үзэсгэлэн/38 ширхэг номоор 157 ирцэд/
5. IV/21 Дэлхийн номын өдөрт зориулсан **“Дэлхийн хүмүүс”** сэдэвт номын үзэсгэлэн /29 ширхэг номоор 172 ирцэд/
6. **“Говийн яргуй”** хүүхдийн яруу найргийн наадамд хүүхдийн зохиолчдын шүлгийн номын үзэсгэлэн /40 ширхэг номоор 27 ирцэд/
7. V/6 **“Үндэсний бичиг үсэг монголын соёлын үнэт өв”** сэдэвт номын үзэсгэлэн /45 ширхэг номоор 96 ирцэд/
8. V/11 Гэр бүлийн өдөр зориулсан номын үзэсгэлэн /36 ширхэг номоор 10 ирцэд/
9. VII/6 Баяр наадамд зориулсан номын үзэсгэлэн /32 ширхэг номоор 122 ирцэд/
10. IX/11-**20 “Монгол улс”** сэдэвт номын үзэсгэлэн /26 ширхэг номоор 109 ирцэд/
11. X/10-19 **“Өмнөговь нутгийн бахархал”** сэдэвт номын үзэсгэлэн/34 ширхэг номоор 47 ирцэд/
12. XI/26 Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсаа зарлан тунхагласан түүхэн өдөрт зориулсан номын үзэсгэлэн /10 ширхэг номоор 48 ирцэд/
13. Тусгаар тогтнолын өдөрт зориулсан номын үзэсгэлэн /20 ширхэг номоор 50 ирцэд/

Мэдээллийн төвөөс 5 удаагийн үзэсгэлэнг гаргаж 151 ширхэг номоор 332 хүн үзэж танилцсан.

- IV/18. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аяны хүрээнд 15 номоор үзэсгэлэн гарган 61 хүнд танилцуулсан

- V/5.СОЁЛЫН СЭРГЭЛТ-2023 арга хэмжээний хүрээнд ажнай талбай дээр шинэ ирсэн 27 номоор үзэсгэлэн гаргаж танилцуулсан.
- V/09. “ИХ ХААДЫН ЕРТӨНЦ: БАТМӨНХ ДАЯН ХААН” эрдэм шинжилгээний хурал дээр холбоотой 10 номоор үзэсгэлэн гаргаж 60 үзсэн.
- VI/14. Англи хэл дээрх Шинжлэх ухааны номын үзэсгэлэн 44ш номоор гаргаж 112 хүнд хүргэсэн.
- XI/06. "Англи хэл сурах гарын авлага, номууд" сэдэвт англи хэл дээрх 50ш номоор үзэсгэлэн гаргасан. 79 хүнд хүргэн ажилласан.

САН ХӨМРӨГИЙН БАЯЖИЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

2023 онд 770 нэр төрлийн 994 ширхэг монгол ном, сонин, сэтгүүлээр сан хөмрөгөө баяжуулсан байна. / Нийт 22,389,300 төгрөгийн/. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр:142 нэр төрлийн 228 ширхэг ном **4,391,800**
Сонин сэтгүүл: 32 нэгж **608,600** төгрөг
Заавал авах хувь:3 нэр төрлийн 11 ширхэг ном **660,000**
Бэлэг хандиваар:593 нэр төрлийн 723 ширхэг ном **16,729,300**

- Ашиглалтын явцад урагдаж гэмтсэн **309** ширхэг номыг сэлбэн засаж ашиглалтыг уртасгах арга хэмжээ авч ажиллалаа.
- Байгууллагын их цэвэрлэгээний өдрөөр өрөө танхим болон ном хэвлэлийг ариутган ажиллахын зэрэгцээ гэрээр болон танхимаар уншлага үйлчилгээнд гарсан ариутгах ажлыг зохион байгуулж ажиллав.
- III/31,XII/8-ны өдрүүдэд Зоонозын Өвчин судлалын төвөөр өрөө танхимуудын шавьжгүйтгэл, ариутгалыг хийлгэв.



Зураг 41. Сан хөмрөгийн баяжилт/Төрөл ангиар/

КАТАЛОГИ, НОМЗҮЙ, ЛАВЛАГАА

Иргэд, уншигчдад цахим болон бусад хэлбэрээр нийт 4773 лавлагааг хүргэснээс

- Цахим 4548
- Сэдэвчилсэн лавлагаа 109
- Ном зүйн лавлагаа 28
- Тодотгосон лавлагаа 88

- Татгалзалд 48 ном бүртгэгдсэн байна.

Цахим каталогийн хандалтын тоо: 4504

Ном зүй: Мэргэжлийн ажиллагсдын бэлтгэсэн 4 ном зүйг үйлчлүүлэгчдэд танхим болон вэб хувилбараар ашиглах боломжийг бүрдүүллээ.

- Гэрээр олгох танхим М.Сувданцэцэг Монголын уламжлалт Анагаах ухаан Сэдэвт ном зүйг 1 удаа хийсэн.
- Нийтийн уншлагын танхимын номын санч Н.Даваажаргал “Дэлхийн монголчуудын түүх цуврал” сэдэвт номоор 1 удаа ном зүй хийсэн байна.
- Фондчин Т.Нямсүрэн Монгол хаад 13 боть номоор ном зүйг 1 удаа хийсэн.
- Хүүхдийн уншлагын танхимын номын санч Г.Ренчиндаваа "Хүүхдийн хүмүүжил" санамж өгөх ном зүйг 1 удаа хийсэн байна.

Шинэ номын мэдээ 4 удаа бэлтэн гаргаж үйлчлүүлэгчдэд танилцуулав.

I/19. Шинэ ирсэн 26 номын танилцуулж цахимаар үзсэн хүний тоо 79 танилцсан байна.

III/23.Хандив бэлгээр ирсэн 8 ширхэг номоор шинэ номын мэдээ хийж 44 хүнд цахимаар танилцуулсан.

IV/24. Шинэ ирсэн 38 ном танилцуулж цахимаар үзсэн хүний тоо 93 танилцсан байна.

X/26. Шинээр сан хөмрөгт ирсэн хүүхдийн номоор 32 номоор.

- Үндэсний тогтмол хэвлэлийн цахим сан Зотерод Монгол говь болон Говийн мэдээ сонины 10 нэгж 2044 нийтлэл мэдээллүүдийг оруулж МҮНСанд илгээв.
  - Номын санч Н.Даваажаргал 1962, 1966,1970,1978 оны говийн мэдээ сонины нийт 827 нийтлэл оруулсан байна.
  - Гэрээр олгох номын санч М.Сувданцэцэг 1968,1964, 1963 оны говийн мэдээ сонины нийт 953 нийтлэл оруулсан 1961 оны
  - Фондчин Т.Нямсүрэн 1959 оны говийн мэдээ сонины нийт 103 нийтлэлийг оруулсан байна.
  - Каталогч М.Баасанжав 1960 оны сонины 95 нийтлэлийг оруулсан байна.
  - Сүлжээ мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа 1961 оны говийн мэдээ сонины нийт 66 нийтлэл оруулсан байна.
  - Номын сангийн автоматжуулалтын программ хангамжийг цахим ном бүртгэх, цахим ном унших, баримт олголт болон цахим үйлчилгээний тоо мэдээ гарах боломж бүхий веб хувилбарын модулиар өргөтгөн 10 цахим номыг веб хувилбараар байршуулан иргэдийг онлайнаар унших боломжийг бүрдүүлэв.

СУРГАЛТ, АРГА ЗҮЙ

- IV/17- IV/21. Ажлын байрны 5 өдрийн дадлагажих сургалтад сумдын шинээр ажилд орсон 3 номын санчийг хамруулав. Манлай сумын Соёлын төвийн номын санч А.Алтанцэцэг, Баян-Овоо сумын номын санч Г.Уранзаяа, Цогт-Овоо сумын номын санч Н.Отгонзаяа нарт Openbiblio программ, номын санд хөтлөгдөх данс бүртгэлүүд, ББК ангилал болон номд техник ажиллагааны талаар арга зүйн зөвлөгөө сургалтыг өглөө.

Зураг 42. Сумдын номын санчид Төв номын санд дадлагажуулах сургалтад хамрагдаж байна.

- XI/16, 23, 28-ны өдрүүдэд Баяндалай сумын номын санч С.Сарантуяа, Сэврэй сумын номын санч Ц.Дэлгэрмаа, Цогт-овоо сумын номын санч Н.Отгонзаяа, Мандал-Овоо сумын номын санч Г.Баярмаа нарын ажилтай танилцаж арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.
- Австралийн Элчин сайдын яам, Монгол Улсын Үндэсний номын сан, Монголын номын сангийн холбоо хамтран хэрэгжүүлж буй "Хил хязгааргүй номын сан" төслийн сургалтад сумд болон сургуулиуд, аймгийн төвийн 18 ном санчийг хамруууллаа.

Зураг 43. Хил хязгааргүй номын сан төслийн сургалт

Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 Арга зүйн сургалт: нийт 8 удаа 68 ажилтан ажиллагсад

1. II/09. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин
2. III/30. Үндсэн хуулийн үзэл баримтлал
3. V/11. Зөөлөн менежмент
4. VI/15. Монгол мандсан шалтгаан

5. X/19. Төрийн албан хаагч ба дипломат ёслол
6. X/26. Аз жаргалтай ажилтан
7. X/27. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль
8. X/27. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сургалт /Номын сангийн ажиллагсад/
9. XI/09. Амжилтад хүрэх хүсэл
10. XI/23. Монгол улсын тусгаар тогтнол ба Богд хаан сургалтуудад номын сангийн ажилтан албан хаагчид тогтмол хамргадаж ирсэн.

Засгийн газрын зорилтот сургалт: Нийт 5 удаа 26 ажилтан ажиллагсад

1. III/21- III/23. “Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх”сургалт/Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
2. IV/21- V/29. МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны 40 цагийн цахим сургалт/10 ажилтан ажиллагсад/
3. XI/01. “Гэр бүлийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” цахим сургалт/дарга А.Одончимэг, фондчин Т.Нямсүрэн/
4. XI/13. “Оюуны бүтээлийг ашиглах, зохиогчийн эрхийг зөрчих гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, ойлголт олгох” цахим сургалтад /дарга А.Одончимэг, фондчин Т.Нямсүрэн/

Мэргэжил дээшлүүлэх сургалтууд:

1. ШУТИС-ийн “Бизнесийн удирдлагын магистрант”/Дарга А.Одончимэг/
2. СУИС-ийн Соёлын сургуулийн “Номын сан судлал” мэргэжлээр бакалаврын эчнээ анги /ХУТ-ын номын санч Г.Ренчиндаваа, каталогч М.Баасанжав/

Мэргэжлийн бусад байгууллагын сургалт: Нийт 32 удаа

1. I/13. СУИС-ийн Соёлын сургууль, ХТНС-тай хамтран зохион байгуулсан “Номын сангийн үйл ажиллагаа” сэдэвт ЕБС-ийн номын санчдад зориулсан цахим сургалт /Фондчин Т.Нямсүрэн/
2. I/23. Санхүүгийн нэгдсэн систем, Шилэн дансны программын шинэчлэл /Дарга А.Одончимэг, Нягтлан бодогч Т.Нарантуяа/
3. II/03. **“**Өмнөговь аймгийн номын санчдыг чадавхжуулах” сургалт/Номын санчид/
4. III/28. Австралийн Элчин Сайдын Яам, Монголын номын сангийн холбоотой хамтран хэрэгжүүлж буй “Хил хязгааргүй номын сан” төслийн номын санчдад зориулсан сургалт. /Номын санчид/
5. IV/22. Төрийн өмчийн тооллогын тайлан, программын шинэчлэлт/Нягтлан бодогч Т.Нарантуяа/
6. IV/25. “Нийгмийн эрүүл мэнд” сургалт /Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
7. V/18. Өмнөговь аймгийн төсвийн удирдах ажилтны зөвлөгөөн/Дарга А.Одончимэг/
8. V/19-V/20. Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, төсвийн төлөвлөлтийн анхаарах асуудал-шийдэл/Нягтлан бодогч Т.Нарантуяа/
9. V/24. “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн чадавх бэхжүүлэх цахим сургалт /Дарга А.Одончимэг Фондчин Т.Нямсүрэн/
10. V/24-V/25. Санхүүгийн боловсрол олгох зэрэг сургалт/Нягтлан бодогч Т.Нарантуяа/

11. VI/05. Соёлын сэргэлт-2023 арга хэмжээний чадавхжуулах сургалт /Номын санчид/
12. VI/20. “И-оффист Dock систем” программ хангамж нэвтрүүлэх тухай танилцуулга сургалт/Сүлжээ-мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
13. VII/26,27. Коха программын сургалт/Номын санчид/
14. IX/18-IX/23. СББӨвийн Үндэсний сургагч багш бэлтгэх сургалт/Дарга А.Одончимэг/
15. IX/21. “Хүмүүн байхын утга учир ёс суртахуунд оршвой”/Үйлчлэгч Ц.Бадамханд, Нягтлан бодогч Т.Нарантуяа, Сүлжээ-мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
16. IX/25. ХАБ сургалт / Каталогч М.Баасанжав/
17. X/04. ХАБ сургалт / Каталогч М.Баасанжав/
18. X/23. Сум, агентлаг, төсөвт байгууллагын удирдлага, хүний нөөц, дотоод ажил хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалт /Дарга А.Одончимэг/
19. X/23-X/24. “Хүний нөөцийн хөгжил” сургалт /Дарга А.Одончимэг, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
20. XI/03. “Кибер аюулгүй байдлын тухай” сургалт /Дарга А.Одончимэг, Сүлжээ-

Зураг 43. Сургалтын зургууд

Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/XI/3. Кибер аюулгүй байдлын тухай хууль болон мэдээллийн аюулгүй байдлын тухай сургалт /Дарга А.Одончимэг/
21. XI/6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дотоод аудитын чиглэлээр салбарын албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, хэлэлцүүлэг/Дарга А.Одончимэг, Фондчин Т.Нямсүрэн/
22. XI/08. ГБХЗХГ-аас "Хамтдаа шалгая, Хамтдаа хамгаалъя" аяны осол гэмтэл болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт /Номын санч М.Сувданцэцэг/
23. XI/10. "Өмнөговь аймгийн түүх, соёлын өв" эрдэм шинжилгээний хурал/Дарга А.Одончимэг Фондчин Т.Нямсүрэн/

24. XI/10. Говийн бүсийн ус хангамжийн тогтвортой эх үүсвэр ба усны төслүүдийг хэрэгжүүлэх боломж ГОВЬ+УС эрдэмтэд судлаачдын чуулган /Нярав үйлчлэгч Ц.Бадамханд/
25. XI/11. Соёлын салбарын ажилтнуудыг чадавхжуулах соёлын өв, угийн бичиг, санхүүгийн сургалт /Дарга А.Одончимэг, Нягтлан Т.Нарантуяа, номын санч Н.Даваажаргал/
26. XI/15. “MONGOLIAN LIBRARY UPDATE-2023” номын санч- мэдээллийн ажилтнуудын X зөвлөгөөн /Каталогч М.Баасанжав, ХУТ-ын номын санч Г.Ренчиндаваа/
27. XI/17. Төрийн үйлчилгээний байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын харилцаа, хандлага, ёс зүй дээшлүүлэх сургалт/Дарга А.Одончимэг/
28. XI/21. "Дижитал номын сангийн ажил" Үндэсний номын сангаас зохиоын байгуулсан цахим сургалт /Дарга А.Одончимэг Фондчин Т.Нямсүрэн Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
29. XI/20. Эрсдэл ба стандарт үндэсний форум /Нярав/ үйлчлэгч Ц.Бадамханд, Харуул З.Батхуяг, жолооч/ харуул Х.Мөнххуяг/
30. XI/30. Нийгмийн салбарын удирдлагуудыг чадавхжуулах сургалт /Дарга А.Одончимэг/

Ажилчдын мэдлэг, ур чадвар, харилцаа хандлага, хууль эрх зүйг дээшлүүлэх дотоодын сургалтууд: Нийт 16 удаа

1. I/19. “ХХОАТатварын тухай, тайлан илгээх тухай” /Номын сангийн ажиллагсад/
2. I/19. “Гар утсаар зураг дарах тухай” Г.Ууганбямба /Номын сангийн ажиллагсад/
3. II/02. “Ажлын байрандаа эерэг соёл түгээцгээе!”/Номын сангийн ажиллагсад/
4. II/09. “Нээлттэй өгөгдөл”/Номын сангийн ажиллагсад/
5. II/16. Зотеро программд сонин оруулах тухай. /Номын сангийн мэргэжлийн ажиллагсад/
6. III/02. “Нийгмийн даатгалын тухай” сургалт /Номын сангийн ажиллагсад/
7. III/16. “Компьютер дээр Монгол бичгээр бичих”/Номын сангийн мэргэжлийн ажиллагсад/
8. III/29. “Байгууллагын соёл”/Номын сангийн ажиллагсад/
9. IV/06. "Энэ жилдээ-Эрүүл жиндээ" аянд хамрагдаж анхан шатны мэдээллийн сургалт /Номын сангийн ажиллагсад/
10. IV/20. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2023" аяны хүрээн дэх “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн" сургалт /Номын сангийн ажиллагсад
11. V/16. “Монгол бичгийн түвшин тогтоох” сургалт /Номын сангийн мэргэжлийн ажиллагсад/
12. VII/05. Видео эвлүүлэг, видео сурталчилгааг гар утсаар хийх боломж сургалт/Номын сангийн мэргэжлийн ажиллагсад/
13. IX/09. “Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах, үр дүнг үнэлэх зөвлөмж” сургалтыг Соёлын хяналтын улсын байцаагч О.Уламцэцэг/11 ажилтан ажиллагсад/
14. IX/13. Номын баярыг тохиолдуулан Монгол бичгээр бичих анхны шатны мэдэгдэхүүн олгох сургалт /6 төрийн албан хаагч/
15. IX/20. “Өрхийн төсөв”санхүүгийн боловсрол олгох сургалт /Номын сангийн мэргэжлийн ажиллагсад/

16. X/09. “Төрийн албан хаагчдад цахим ур чадвар олгох” сургалт/Номын сангийн ажиллагсад/



17. XI/20. “Lib4u программын цахим ном бүртгэх, цахим үйлчилгээ үзүүлэх”

Зураг 44. Дотоод сургалтуудаас

сургалт/Номын сангийн мэргэжлийн ажиллагсад/

Туршлага судлах үйл ажиллагаа

- XII/14. Төв аймгийн Нийтийн номын сангийн чөлөөт сонголт бүхий орчин үеийн шийдлээр тохижуулсан танхимууд, үйл ажиллагааны онцлоготой танилцаж туршлага судлав.

Зураг 45. Туршлага судлах аялал-сургалт

- XII/14-XII/16. МҮНСангийн үйл ажиллагаатай танилцаж "Үндэсний тогтмол хэвлэлийн лавлагаа, мэдээллийн нэгдсэн сан" сургалтад хамрагдав.
- XII/15. Орчин үеийн тохижилт шийдэл бүхий номын сангийн үйлчилгээ, номын худалдаа, хүүхэд болон гэр бүлийн чөлөөт уншлага, чөлөөт цагийн үйл ажиллагаа зохион байгуулдаг “Чимээтэй номын сан”-тай танилцлаа.
- XII/16. Дундговь аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж онцлог үйл ажиллагаа ном хүргэлтийн үйлчилгээний туршлагыг судлав.

хөрөнгө оруулалт

- Цахим уншлагын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх иргэдийн мэдээлэлтэй ажиллах мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт арга хэмжээнд ашиглах ухаалаг самбар, зөөврийн болон суурин компьютер, цахим ном унших төхөөрөмж зэрэг 12 ширхэг 31,269,980 төгрөгийн үнийн дүн бүхий тоног төхөөрөмжийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хүлээн авч үйлчилгээ үйл ажиллагаанд ашиглаж байна.

Зураг 46. VI/22.Тоног төхөөрөмж хүлээн авлаа

- Орон нутгийн хөрөнгө оруулалтын 20,0сая төгрөгийн зөөврийн номын сангийн үйлчилгээнд ашиглах тавиурууд, зөөлөн сандал, асар, хэвлэмэл ном /136 нэр төрлийн 187 ширхэг 8,045,300төгрөг/ аудио ном /24ширхэг364,700төгрөгийн/, брайл ном /2ширхэг 105,000төгрөгийн/ -ийг хүлээн авлаа.



Зураг 47. Зөөврийн номын сангийн асар, тавиур. Сан хөмрөгийн баяжилт-орон нутаг

- Номын сангийн шинэ барилгын интьерерийн зураг төсвийг орон нутгийн төсвөөр Skyline ХХК боловсруулж байна.

ажилчдын нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд

- Ажилчдын өдрийн хоолны мөнгийг сар бүр олгов.
- Хүүхдийн баярын хүрээнд ажилчдын 15 хүүхдэд номтой бэлэг гардуулан хүүхдээ сонсох арга хэмжээг зохион байгууллаа.

- 9-р сарын 14-ний өдөр гэр бүлийн хамтын спортын өдөрлөг зохион байгуулж гар бөмбөг, дартсын тэмцээн зохион байгуулав.
- Ахмадын баярыг тохилдуулан 6 ахмадыг Ар үр сувилалд амрах эрхийн 50%-ийн хөнгөлөлтөд 600,0 мянган төгрөгийг шийдвэрлэн дэмжлэг үзүүлэв.
- 11-р сард. Манал говь уламжлал, шүдний эмнэлэгт үйлчлүүлэх 1440,0 төгрөгийн эрхийг шийдвэрлэн ажилчдыг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруууллаа.
- Ажиллагсдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр дүгнэн ажилласан ба 1-4-р улирлын үр дүнгээр урамшуулал олгов.
- Номын санч Н.Даваажаргал, фондчин Т.Нямсүрэн нарыг Аймгийн ТАХ-ын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт дэмжих бичиг хүргүүлэн орон байрны нөхцөлөө сайжруулах дэмжлэгт хамруулав. Номын санч Г.Ренчиндаваа, Каталогч М.Баасанжав нарыг сургалтын төлбөрийн дэмжлэгт хамруулахаар тодорхойлов.
- Дотоод журамд заасны дагуу хүсэлт гаргасан ажилчдын чөлөөний асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж ажиллав.

БУСАД АЖИЛ

- Номын сангийн уншлага, арга хэмжээнд сурагчдыг татан оролцуулах, номын сангийн үйлчилгээ үйл ажиллагааг сурагчдаар дамжуулан сурталчлах, хүүхдийг номоор хөгжүүлэх зорилтын хүрээнд Төв номын сангийн дэргэдэх "Ирээдүйн эзэд" номын клубийг ажиллуулж байна. Клубийн хүүхдүүд 7 хоног бүрийн 1 өдөр цуглан хамтын уншлага, хэлэлцүүлэг өрнүүлэхийн зэрэгцээ, ном сэлбэн засах зэрэг номын санчийн өдөр тутмын ажилд туслан номын сангийн соёл танин мэдэхүйн ажилд оролцдог.
- Шинэ барилгын ажлын явцтай харьяа газар хэлтэстэйгээ хамтран танилцаж хяналт тавив.
- Шинэ барилгын интерьерийн зураг төсвийн ажлын талаар Нийгмийн бодлогын хэлтэст хандан орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх тендерийн ажлын даалгаварт санал боловсруулж оруулав.
- Сар бүрийн сүүлийн долоо хоногийн 5 дахь өдөр байгууллагын их цэвэрлэгээг зохион байгуулж ажиллав.
- V/12. Даланзадгад сумаас Цогт-Овоо сум хүртэлх 62км автозамын дагуу үүссэн хог хаягдлыг цэвэрлэх нэгдсэн арга хэмжээнд хамрагдаж хуваарьт газрын хогийг түүж цэвэрлэлээ.
- МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд манай хамт олон "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн нээлтэд оролцон, хуваарилсан талбайдаа модоо тарилаа.
- VI/05. Соёлын сэргэлт -2023 говийн бүсийн нээлтийн арга хэмжээнд хамт олноороо оролцов.
- Нийгмийн салбарын агентлаг байгууллагуудын спортын тэмцээнд хамт олноороо оролцов.

Зураг 48. Бүх нийтийг хамарсан арга хэмжээ, ариутгал, цэвэрлэгээнд хамт олон

Дүгнэлт

Давуу тал

1. Өмнөх жилүүдтэй харьцуулахад иргэдийг сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх соёл танин мэдэхүйн ажлыг 70 удаа зохион байгуулсан. Энэ нь Соёлын яамнаас үйл ажиллагаа зохион байгуулах төсөв хуваарилсантай холбоотой төдийгүй орон нутгийн дэд хөтөлбөрүүдтэй үйл ажиллагааг уялдуулан дэмжлэг авсан болон төр болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд юм.
2. Номын сангийн сан хөмрөгт шинэчлэл хийсэн жил байлаа. Үүнд:

   Брайл ном 2 нэр төрлийн 2 ширхэг 103,100төгрөгийн
   Цахим ном 16 нэр төрлийн 32 ширхэг ном 396,900төгрөгийн
   Аудио буюу сонсдог ном 24 ширхэг 364,700 төгрөгийн

3. Номын сангийн бүх нийтийн боловсролын хөтөлбөр болон хүүхдийн боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгч иргэд номын санд зөвхөн ном унших үйлчилгээнээс гадна өөр олон үйл ажиллагаанд оролцох боломжтой хөгжих боломжтой гэдгийг таньж мэдсэн явдал байлаа.
4. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар цахим уншлага үйлчилгээнд ашиглах тоног төхөөрөмжүүдтэй болсны үр дүнд үйлчлүүлэгчдийг цахим болон аудио ном унших боломжоор хангасны зэрэгцээ тэднийг мэдээллийн боловсролоо дээшлүүлэхэд сургалт арга хэмжээг зохион байгууламж боломж бүрдсэн давуу тал бий болсон.
5. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бодитой үр дүн гарсан жил байлаа. Номын санч Г.Ренчиндаваа, Каталогч М.Баасанжав нар орон нутгийн дэмжлэгт хамрагдсан СУИС-ийн Соёлын сургуулийн Номын санч-Мэдээллийн

ажилтны эчнээ ангид суралцаж мэргэжлийн боловсон хүчин болон бэлтгэгдэж байгаа бол Номын санч Н.Даваажаргал, Фондчин Т.Нямсүрэн нар орон нутгийн "Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх хөтөлбөр"-т хамрагдан орон сууцны нөхцөлөө сайжруулах чиглэлээр дэмжлэг авсан. Ажилчдын цалин хөлс нэмэгдсэн, 5 жил тутмын нэмэгдэл авдаг болсон зэрэг нь ажилчдын ажиллах урам зоригийг нэмэгдүүлсний дээр энэ салбарт ажиллах хүмүүсийн сонирхлыг нэмэгдүүлсэн.

6. Ажилтан албан хаагчид мэргэжил боловсролоо дээшлүүлэх сурч хөгжих чиглэлээр өмнөх жилүүдтэй харьцуулахад хамгийн олон сургалт, семинар туршлага судлах арга хэмжээнд хамрагдан шинэ санал санаачилга гарган ажиллажээ.

12.2. Сул тал

1. Соёл танин мэдэхүйн ажил номын сангийн байранд явуулахад багтаамж муутай, соёлын шинэ барилгууд ашиглалтад орж үйл ажиллагаа өргөжихийн хирээр тэр стандарт чанарт нийцсэн үйлчилгээ тав тухтай орчныг иргэд үйлчлүүлэгчид хүсэн хүлээж байгаа төдийгүй тэр шаардлагад бид нийцэж чадахгүй байгаа нь бидний нэг сул тал болж байна.

2. Номын сангийн үйлчилгээг иргэдэд ойртуулах тал дээр олон ажил санаачлан хэрэгжүүлж болох хэдий ч номын сангийн одоо байгаа хүний нөөц хангалтгүй, зөөврийн номын сангийн үйлчилгээнд ашигладаг байсан фургон автомашиныг Орон нутгийн өмчийн газраас Нийтлэг үйлчилгээний албанд шилжүүлсэн нь туулах чадвартай найдвартай тээврийн хэрэгсэлгүйгээс төлөвлөгөөт ажлаа хийж гүйцэтгэхэд бэрхшээлтэй байдал бий болдог.

12.3. Боломж

2024 онд шинэ барилга ашиглалтад орсноор үйлчилгээний тав тухтай орчин бий болж иргэдэд үзүүлэх үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, цар хүрээ дээшлэх боломжтой.

Зөөврийн номын сангийн үйлчилгээнд ашиглах тавилга, асар зэрэг хэрэглэгдэхүүнүүдийн тусламжтай багууд болон сумдад зөөврийн номын сангийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, баялаг хөтөлбөртэй зохион байгуулах боломж бүрдэнэ.

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Иргэдэд ном, соёлын үйлчилгээг тасралтгүй хүргэх, тэднийг мэдээ мэдээллээр хангах, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслах чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Захиргаа удирдлага зохион байгуулалтын ажил:

Аймгийн нийтийн номын сан нь нийтдээ 12 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Засаг даргатай болон Соёл, урлагийн газрын даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж, гарын үсэг зурж, баталгаажуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгээр амжилттай үнэлэгдэн “А” үнэлэгдлээ.

Монгол Улсын Соёлын яамны дэд сайд Батбаяраар ахлуулсан ажлын хэсэг Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн салбарын албан хаачидтай уулзаж, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж ажилласны үр дүнд цалинг нэмэгдүүлэн, 5 жилийн нэмэгдлийг олгуулсан.

Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг боловсруулж баталж, хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлын хуваарийн шинэчилсэн төлөвлөгөөг гаргаж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хөдөлмөрийн дотоод журмыг захирлын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/23 тоот тушаалаар шинэчилж, ажил эрчимжүүлэх 04 дүгээр улирлын төлөвлөгөөг гарган ажилласан.

Соёл, урлагийн газраас номын сангийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, мэргэжил арга зүйн удирдагаар хангаж ажилласны хүрээнд 2023 оны ХХНЖ-ыг үйлдэн, захирлын тушаалуудыг хууль эрх зүйн үндэслэл, утга агуулгын найруулгын зүйл заалтыг анхаарч бичин, хянасан боловсруулсан тэмдэглэгээг тогтмол хийж, тушаалын хавсралтын тамга, тэмдгийн дутууг нөхөж хийлээ.

Албан хаагчдын хувийн хэргийг бүрдлийн дагуу бүрдүүлж, анкетыг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын дагуу шинэчлэн, дутуу материалыг нөхөж бүрдүүлж, 2022 оны архивын баримт бичгийг

нягтлан шалгаж, баримтын эх хувийг хавсаргаж, ирсэн, явсан бичиг, тушаал, өргөдөл, албан тоотуудаа дугаарлан, стандартын дагуу үдэж хавтаслан, архивт хүлээн авсан.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтыг сайжруулах тал дээр цаашид анхаарч, санхүүгийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт, хүний нөөц, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын чиглэлээр дотоод хяналтыг сайжруулж ажиллахаар төлөвлөж байна.

Уншигчдын ая тухтай орчин бүрдүүлэхэд анхаарч, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, номын ээлжит тооллогыг хийж, ангилал солигдсонтой холбогдуулж, тавиур дахь номыг эмхэлж цэгцлэн ажилласан ба үйлчилгээний танхимуудад ширээ 20, сандал 10 ш нэмж, өвлийн бэлтгэл ажлыг хангаж, өрөө, тасалгаа бүрт халаагч авч тавив.

Байгууллагын эрсдлийн үнэлгээг шилэн хяналтын системд хийж гүйцэтгэхэд барилга байгууламж зориулалтын бус байгаагаас болж, 76 оноо буюу Их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна.

Байгууллагын захирлын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/06 тоот тушаалаар Төлбөрт үйлчилгээний орлого төвлөрүүлэх, зарцуулах тухай журмыг баталж, номын санч нар картын орлогыг сар бүрийн 25-ны өдөр няравтай тооцоо нийлэн тушааж, байгууллагын нэмэлт үйлчилгээний орлогын дансанд хийж, холбогдох журмын дагуу зарцуулалтыг тайлагнаж байхыг тусгаж, нийт 642300 төгрөгний орлого төвлөрүүлсэн.

Соёл олон нийтийн үйл ажиллагаа явуулах бүр хөтөлбөр, төлөвлөгөө, удирдамжийг боловсруулж, захирлаар батлуулан, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнаж хэвшсэн.

Соёл, урлагийн газрын даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтийг улирал тутам, Соёлын Сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж, СУГ-т хүргүүлсэн.

СҮХБААТАР АЙМАГ
НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

Баруун-Урт сум

ЗАХИРАЛ Э. АМАРБАТ

СҮХБААТАР АЙМАГ
НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 02 өдөр Дугаар А/12 Баруун-Урт сум

Ажил эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Соёл, урлагийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 01/57 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад дүгнэлт хийж, бусад үйл ажиллагаануудыг сайжруулах, ажил эрчимжүүлэх зорилгоор 04 дүгээр улирлын ажлын төлөвлөгөөг хавсралтаар батлсугай!

2. Номын ээлжит тооллого хийсэнтэй холбогдуулан тооллогонд ороогүй номыг 10 дугаар сарын 20-ны дотор оруулж дуусгахыг номын сан нарт үүрэг болгож, тогтоосон хугацаанд холбогдох журмын дагуу тооллогоны дүн мэдээг үнэн зөв гаргаж, тайлагнахыг тооллогоны комисст даалгасугай!

3. Дээрхи ажлууд нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажил дүгнэх үзүүлэлтэнд нөлөөлөх тул анхаарч ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай

ЗАХИРАЛ Э. АМАРБАТ

C:My :Doc:Tushaal /2023/



БАТЛАВ.
АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ
Э. АМАРБАТ

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРААС НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗӨВЛӨН ТУСЛАХ, МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН УДИРДАГААР ХАНГАЖ АЖИЛЛАСНЫ ХҮРЭЭН ДЭХ ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, бүтэц зохион байгуулалт, боловсруулалт, байрлуулалт, эргэлтийн байдал

Иргэд, уншигчдад зохих үйлчилгээг журмын дагуу хүргэх, номын сангийн сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хангах, номын эргэлтэд байнга судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулан ажиллаж, номын татгалзлын дагуу ном, хэвлэл авах, иргэд, уншигчдаас санал хүсэлтийг авч ажиллалаа. Фондын сан хөмрөгийг уншигчдын эрэлт хэрэгцээт ном болон тогтмол хэвлэл, хэвлэмэл бус бүтээгдэхүүн, нутгийн зохиолчдын уран бүтээл, хүүхдэд зориулсан зохиол, шилдэг номоор бүрдүүлж:

Төсвөөр: 96 ширхэг 142 ширхэг 3826000

Хандиваар: 65 нэр төрлийн 78 ширхэг 1415000

Нийт 161 нэр төрлийн 220 ширхэг 5241000 ном авч, фондоо баяжуулан 50205 номын фондтой болж, үндсэн данс бүртгэлд тусган, техник ажиллагаа хийж, электрон каталогит оруулан баркоджуулж, танхимуудад хүлээлгэн өгч, уншлага үйлчилгээнд гаргасан.


ХҮҮХДИЙН УНШЛАГЫН ТАНХИМ

ТАТГАЛЗЛЫН БҮРТГЭЛ

БАРУУН-УРТ 2022 ОН





Номын сангийн тооллого, хадгалалт хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар:

Номын сангийн сан хөмрөг дахь ээлжит тооллогыг байгууллагын захирлын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/12 тоот тушаалын дагуу эхлүүлж, 18509 нэр төрлийн 44077 номноос Фонд-22904, Гэрээр ном олгох-6726, Хүүхдийн танхим-5832 ном тоологдож, дутагдсан номын тооцоог хийж дуусгах хугацаатай үүрэг өгч ажиллаж байна.

Цахим каталогит ороогүй орос ном-384, англи ном-135, монгол ном-113 оруулж, тогтмол хэвлэлийн өрөөг цэгцэлж янзлан, хуучин сонинг хавтасжуулах ажлыг хийж гүйцэтгэн, 160 нэгж сонинг үдэж хавтасжуулан, бүртгэлжүүлсэн. Урагдаж гэмтсэн номыг тухай бүр сэлбэн засалт хийж, тооллогоны явцад 180 номыг ялган авч сэлбэн зассан.

Номын сангийн Lib4u программд тогтмол хэвлэл болох Зууны мэдээ, Өдрийн сонин, Өрхийн үйлдвэрлэл, Сүхбаатарын өнгө, Төрийн мэдээлэл, Улирал ба зохиолч, Утга зохиол урлаг, Хүмүүн бичиг зэрэг 80 сонинг бүртгэсэн.

НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Уншигчдад номын сангаас үзүүлж буй үйлчилгээ болон номын сангийн үйлчилгээний инноваци, нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлсэн эсэх

Номын сангийн үйлчилгээг чанартай явуулах зорилгоор үйлчилгээний журмыг захирлын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/06 тоот тушаалын дагуу шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Танхимаар

- Байнгын уншигч-1663
-Ирэгсэд-9380
-Ном олголт-10843

НОМЫН ҮЗЭСГЭЛЭН: Номын үзэсгэлэнг шинэ номоор болон тэмдэглэлт өдрүүдэд зориулж тогтмол гарган сурталчилсан.

- Шинэ ном -220 ном
- Д. Сүхбаатарын мэндэлсний 130 жилийн ойд-35
- Олон улсын хүүхдийн эрхийн өдөрт-120
- Хил хязгааргүй номын сан- 59
- Нутгийн зохиолчдын бүтээлээс-240 ном
- Англиар уншиж судалцгаая- Англи номын үзэсгэлэн 354 ном
- Дэлхийн яруу найрагчдын өдөр-50 ном
- Дэлхийн номын өдөрт - 40 ном
- Танин мэдэхүйн мэдээлэл- 50 ном
- Элсэлтийн ерөнхий шалгалтанд- 42
- Хоол зүй- 30 ном
- Хүүхдийн зохиолчдын бүтээлээр -35 ном
- Судар эгшиглэн -10 ном
- Д. Нацагдоржийн намтар уран бүтээлээс-20 ном
- Монголын нууц товчоо -15 ном
- Монгол бичгийн ном-120 ном
- Гэрийн номын сан" 75 номоор нийт давхардсан тоогоор 32 удаа 1395 номоор гаргаж сурталчилсан.

Цахим үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн цахим буланг:
- Номын танилцуулгын булан
- Танин мэдэхүйн булан
- Нутгийн зохиолчийн ярилцагын булан нэртэйгээр эрхлэн явуулж байна.

Номын танилцуулгыг цахимаар:

Шинээр ирсэн хүүхдийн номууд Хошин үлгэр, 101 ёгт үлгэр, Еврей ардын ухаант үлгэр, Үлэмж шилмэл үлгэр туульс, Нисдэг хулгана, Чинүүхэй ба найтайдаг охид, Хүүхэлдэйн чинээ ээж, Мөчрөн хуруут охин, Нисдэг хулгана Чинүүхэй ба Алимаа охин цуврал, Аялагч байшин, Харандаахан хүү, Баллуурхан хүү цуврал, Сайн уу Найзуудаа 4 цуврал, Шидэт модон байшин цуврал, Саран дээр буусан нь, Луун хаантай танилцсан нь, Сүнстэй хотод очсон нь, Арслантай танилцсан нь, Сэлмэн соёоттой танилцсан нь, Сүнстэй хотод очсон нь зэрэг номоор цахим танилцуулгыг хийж сурталчилсан.



Танин мэдэхүйн цахим мэдээллийн буланг:

-Шувуудын тухай 1000 баримт-10 цуврал

-Сааны тухай сонирхолтой мэдээлэл

- Монголын нууц товчоо

-Шатар

-Танин мэдэхүйн мэдээлэл”-1.2.3

-Дэлхийн гайхамшгаас

-Дэлхийн оргилууд

-Байгалийн урлан

- Үлэг гүрвэлийн цувралаас

-Хорхой шавьж

- Хүүхдийн эрх сэдвээр 16 удаа байгууллагын цахим хуудсаар сурталчилсан.





Номын сангийн шинэлэг үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр

Монгол улсын зах зээл дээр гаргах /гавъяат багш Ш. Чулуунбор/ “Сониуч хүүгийн адал явдал” цуврал өгүүллэгээр / Дүрст видео ном, Аудио сонсдог ном / дабль CD, хуурцаг / бүтээх төслийг бичиж, уг төсөл шалгарч, 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр нээлтээ аймгийн “ЖААХАН ШАРГА” театрт хийсэн бөгөөд Эх үрсийн баяраар хүүхэд багачуудад нээлттэй байдлаар үзүүлж нийт 560 цэцэрлэгийн болон ЕБС-ийн сургуулийн сурагчид эцэг эхчүүд үзэж сонирхууллаа. Мөн энэхүү төслийг үзэж сонирхож буй хүүхэд багачуудыг үзэж сонирхох зүйлсийг нэмж Баруун-Урт сумын ЕБ-ын 3 дугаар сургуулийн сурагч, “СОНИУЧ ХҮҮГИЙН АДАЛ ЯВДАЛ” төслийн дижитал зураач Э.Оюумаагийн гар зургийн болон дижитал зургийн үзэсгэлэнг зохион байгуулж, сонсдог 10 ном нь **YouTube сувагт** байршиж, олны хүртээл болоод байна.

ОНЫ ШИЛДЭГ УНШИГЧ ШАЛГАРУУЛАХ “СУДАР ЭГШИГЛЭН-2023” ТӨСӨЛ

Оны шилдэг уншигч шалгаруулах “Судар эгшиглэн” төслийг 3 дахь жилдээ хэрэгжүүлж, 2023 оноос улсын хэмжээнд зохион байгуулж, Улаанбаатар хот, Өвөрхангай, Увс, Баян-Өлгий, Баянхонгор, Дорнод, Дундговь, Хэнтий, Дорноговь, Сүхбаатар аймгаас нийт 5000 гаруй оролцогчийн 20000 гаруй номын тэмдэглэл ирснийг байршуулсан. “Судар эгшиглэн” номын тэмдэглэл эрхлэн хэвлүүлэх төслийг Соёл урлагийн дэмжих санд илгээн, 1 дүгээр шатны 375 төсөл, 2-р шатанд 90 төслөөс шалгарч, ивээн тэтгэгчдийн зүгээс 3000.0 төгрөгөөр номын тэмдэглэл хэвлүүлсэн бөгөөд төслийн сулд дуу болох "Бид унших дуртай" дууны уралдааны цэцэрлэг болон сургуулийн бага ангийн хүүхдүүдийн дунд зарлахад 15 цэцэрлэгийн бүлгийн 428 суралцагч, 13 сургуулийн 315 сурагчид, нийт 743 хүүхдүүд оролцсон.



Австралийн Элчин сайдын яам, МУҮНСан, Монголын Номын сангийн холбооноос зохион байгуулж буй “Хил хязгааргүй номын сан” төсөл хэрэгжиж 21 аймаг, алслагдсан дүүрэг зэрэг 30 нийтийн номын сангуудад хэрэгжиж байгаатай холбогдуулан аймагтаа урьж авчран дэлхийн номын сангуудын шилдэг туршлага, шинэ технологи, орчин үеийн номын сангийн үйлчилгээний чиг хандлагын тухай уулзалт хэлэлцүүлэг хийгдэж, төвийн 5 сургуулийн номын санч нар танхимаар, сумдын соёлын төвийн болон сургуулийн номын санч нар онлайнаар нийтдээ 40 орчим номын санч мэдээллийн ажилтнууд хамрагдсан.

НОМЫН САНГИЙН АВТОМАТЖУУЛАЛТ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, КАТАЛОГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ :

“Үүлэн технологи”-д суурилсан шинэлэг үйлчилгээг 2019 оноос нэвтрүүлэн ажиллаж, номын сангийн “LIB4U программ”-д 12 сумдын соёлын төвийн номын сангийн сан хөмрөгийг нэгдсэн мэдээллийн баазад нэгтгэх, программ хангамжийн ашиглалтыг сайжруулахад анхаарч ажиллаж, аймгийн хэмжээнд нийт 24246 нэр төрлийн 60069 ном байршуулаад байна.

Соёлын бүтээлч сарын хүрээнд "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ЦАГ-LIB4U программ хангамж-2023-I, II, III- онлайн сургалт, Соёлын төвийн номын санчдын “Ганцаарчилсан

цахим сургалт”-уудыг зохион байгуулахад давхардсан тоогоор   20 гаруй номын санч, мэдээллийн ажилтнууд хамрагдсан. Уг сургалтаар программ хангамж, бататгах цуврал хичээл, дадлага ажил, мэдээллийн технологи зэрэг шинэлэг сэдвүүдээр сургалт өгч номын санг автоматжуулах ажлыг түргэвчлэх, орчин үеийн үүлэн технологид суурилсан шинэлэг үйлчилгээг орон нутгийн иргэдэд хүртээмжит хэлбэрээр түгээх үр дүнтэй ажлын нэг болсон. 12 сумын соёлын төвийн бүх номын санчидтай онлайнаар холбогдон lib4u-ийн ганцаарчилсан сургалт буюу дадлага ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж сургалт өгч идэвхтэй хамруулан ажилласан.



СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Номын үзэсгэлэнг шинэ номоор болон тэмдэглэлт өдрүүдэд зориулж гарган сурталчилж, цахим номын болон танин мэдэхүйн буланг тогтмол эрхлэн явуулж: Дэлхийн яруу найргийн болон Дэлхийн номын өдөр, Үндэсний бичиг үсгийн баяр, Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2023, Зуны зугаатай өдөр, Соёлын сэргэлт, “Яруу үдэш” Эх хэлний өдөр, Монгол бахархлын өдөр, Соёлын бүтээлч сарын хүрээнд олон талт ажлыг зохион байгууллаа.

Д. Сүхбаатарын мэндэлсний 130 жилийн ойн хүрээнд түүний намтар түүх, үйл хэрэг, түүхэн баримтуудаас сурталчилж, номын үзэсгэлэнг нийт 40 номоор гаргаж сурталчилж, уншигчдад хүргэлээ. Мөн байгууллагын цахим хуудсаар танин мэдэхүйн чиглэлээр олон нийтэд уг номуудыг цуврал видео хэлбэрээр сурталчилсан.

Танхимаар сурталчилсан байдал:

Танин мэдэхүйн чиглэлээр Д. Сүхбаатарын намтар түүх, үйл хэрэг, түүхэн баримтуудыг цахимаар сурталчлав.

ДЭЛХИЙ ЯРУУ НАЙРГИЙН ӨДӨР:

Дэлхий яруу найргийн өдрийг тохиолдуулан "Шинэ шүлгийн уншлага" Яруу найргийн баяр-2023" арга хэмжээг МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж, уг арга хэмжээнд яруу найрагчид болон шүлэг яруу найраг сонирхдог 20 яруу найрагч оролцсон бөгөөд яруу найрагчдын уншсан шүлгийг эмхтгэж, товхимол гаргасан. Мөн 2022, 2023 онд оролцсон яруу найраг сонирхогч сурагч, идэвхтэн бичигч, Соёлын гавьяат зүтгэлэн, Сүхбаатар нутгийн 40 гаруй уран бүтээлчийн шинэ шүлэг, яруу найргууд багтсан бүтээлээр "Яруу эгшиг" шинэ номыг эмхэтгэн гаргаж, нийтийн хүртээл болгон, Үндэсний бичиг, соёл-Номын өдрүүд-2023" арга хэмжээний үеэр нээлтээ хийсэн.

ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР:

Дэлхийн номын өдөрт Сүхбаатар аймгийн харьяат Нийслэлийн 31 дүгээр сургуулийн 10-р ангийн сурагч Э. Энхтулгын Номин-Эрдэнийн "Өвлийн цаг агаар чи..." шинэ номын нээлтийг зохион байгуулж, уг нээлтийн арга хэмжээнд МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлийн төлөөлөгчид, ахмад номын санчид, СУГ-ын мэргэжилтнүүд, ЕБС-ийн номын санчид, хүүхэд багачууд, номын клубын нийт 100 гаруй сурагчид оролцсон. Мөн номын зохиогч, уншигчийн уулзалтыг хийж, шүлэг яруу найраг

сонирхдог хүүхэд багачууд шүлэг, яруу найраг уншиж сонирхуулж, зохиогч гарын үсэгтэй номоо дурсгав.

ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯР

Монгол үндэсний бичиг соёл, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, судлах, монгол бичгээ сурч эзэмших, хойч үедээ өвлүүлэх, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх сурталчлах зорилгоор “МОНГОЛ БИЧГИЙН “АВАРГА УНШИГЧ” уралдааныг уламжлал ёсоор зохион байгуулав. Уралдааныг ахмад багш С. Оюунцэцэг, "Жаахан шарга" ХЖТ-ын дуучин А. Идэрзаяа, арга зүйч Т. Чандмань нар шүүн явуулав. Уг уралдаанд Баруун-Урт сумын ЕБ-ын 1-4 сургууль, МСҮТ-ийн сурагчдаас гадна Түвшинширээ сумын ЕБС-ийн сурагчид ирж оролцон, өргөн хүрээтэй явагдсан.

6-7-р ангийн ангилалд 64 сурагч,

ЕБС-ийн 8-12, МСҮТ-ийн ангилалд 58 сурагч

Насанд хүргэсдийн ангилалд 16 хүн нийт 138 хүн оролцсон.

“СОЁЛЫН СЭРГЭЛТ-2023”

Монгол улсын Соёлын яамнаас бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "СОЁЛЫН СЭРГЭЛТ -2023" аяныг Сүхбаатар аймагт зохион байгуулж, энэ хүрээнд “Судар эгшиглэн” төслийн номын тэмдэглэлийн дэвтэрийн нээлт, Сүхбаатар нутгийн зохиолчдын номын үзэсгэлэнг 120 номоор гаргаж сурталчилсан.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулган:

Хөрөнгө оруулалт хөгжлийн чуулганы арга хэмжээнд Сүхбаатар нутгийн зохиолч, яруу найрагчдын уран бүтээлээр номын үзэсгэлэнг 120 ном, номын худалдааг 50 гаруй номоор гарган сурталчилсан.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2023” ХАВРЫН АРГА ХЭМЖЭЭ:

“Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд-2023” хаврын арга хэмжээг 05 дугаар сарын 27-28-ний өдрүүдэд “Номын баяр-Хүүхэд бүр уншигч” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлсэн. Уг арга хэмжээний хүрээнд:

1. Номын сангийн тухай хууль, эрх зүйн баримтыг байгууллагын цахим хуудсаар сурталчлах

2. “Уншаад урагшлахуй” ном уншлагыг сурталчлах, сэдэлжүүлэх ажлын хүрээнд ЕБС-ын 1-5 ангийн сурагчдын дунд "Олуулаа уншицгаая" аян

3. “Үлгэрээс үлгэрлэе” хүрээнд “Хормогчин хүүхэлдэй”-гээр СӨНХ, бага ангийнханд Монголын болон дэлхийн сонгодог үлгэрүүдээр чанга уншлага

4. "Яруу эгшиг-Шинэ шүлгийн уншлага-2022. 2023" номын нээлт

5. Номын санд хандив өргөсөн хөрөнгө оруулсан хувь хүн, байгууллагыг урамшуулах

6. Нутгийн зохиолч, яруу найрагчдын уран бүтээлийг цахимаар цувралаар сурталчлах

7. Номын үзэсгэлэн:Шинэ болон сэдэвчилсэн, Монгол бичгийн, Нутгийн зохиолч, яруу найрагчдын, Номын фондон дахь хуучин, ховор номын

8.Уншигч хүүхдүүдийн бүтээл, номын тэмдэглэл, ном, баринтаг, хавчуургын бүтээлээр үзэсгэлэн /Судар эгшиглэн төслийн уралдаанд оролцогчдын бүтээлээр

9. Тэгш ой /80,90,100 /тохиож буй нутгийн зохиолчдын бүтээлийг сурталчлах

10. Онцлог бүхий номын үзэсгэлэн

11.Судар эгшиглэн номын тэмдэглэлийн нээлт

12. “Book flashmob”

13.Нутгийн зохиолчдын болон хувь хүмүүсийн гар дээрхи номын худалдаа

14.Үндэсний агуулгатай тоглоомын худалдаа

15. Гар урлалын үзэсгэлэн зэрэг

16. ЕБ-ын сургуулиудын номын сан, МСҮТ-ийн номын сангийн танилцуулга

17. Монголын уламжлалт тоглоом наадгай

18. Гар урлал эрхэлдэг хүмүүсийн үзэсгэлэн

19. Урлагийн үзүүлбэр

20. Шагнал гардуулах арга хэмжээ зэрэг соёл, урлагийн 20 үйл ажиллагааг зохион байгуулж, Соёл, урлагийн газар, зохиолч, яруу найрагчид, ахмад номын санчид шилдэг тэргүүний уншигчид, сум, сургуулийн номын санчид, иргэд олон нийт, уншигч хүүхдүүд, номын клубын хүүхдүүд, “Нарны хүүхдүүд” дуу бүжгийн клубын хүүхдүүд зэрэг 2000 гаруй хүн оролцов

Номын нээлтийн арга хэмжээ:

Номын үзэсгэлэн:

“Судар эгшиглэн” бүтээлийн үзэсгэлэн

“Судар эгшиглэн” тэмдэглэлийн дэвтрийн нээлт:

Нутгийн зохиолчдын хувь хүний гар дээрх номын худалдаа:

Шагнал гардуулалт:

Тоглоом:

Ховор номын танилцуулга:



Баруун-Урт сумын ЕБС, МСҮТ-ийн номын санчид оролцож, номын сангаа болон сурагчдад хүргэдэг онцлох үйлчилгээгээ танилцуулсан.

Гар урлалын үзэсгэлэн, худалдаа

‘’ЗУНЫ ЗУГААТАЙ ӨДРҮҮД’’ ХӨТӨЛБӨР

Сурагчдын зуны амралтанд зориулан ‘’Зуны зугаатай өдрүүд’’ хөтөлбөр зохион байгуулж, хүүхдүүд бие биентэйгээ танилцан, шатар, даам, шоо эвлүүлэх, 3D зураг



сурах зэргээр цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэн идэвхитэй суралцсан.

“Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жил”, “Зуны зугаатай амралт” хөтөлбөрийн хүрээнд “MAGIC BRUSH art room”-ийн захирал О. Номинтой хамтран зургийн сургалт зохион байгуулж, нийтдээ 30 гаруй хүүхэд хамрагдан, зурж, будаж, баримлын шавраар бүтээл хийж, олон өнгийн цаасаар наамал хийх зэргээр суралцаж, олон зүйлийг хийж сурцгаасан.

ЭХ ХЭЛНИЙ ӨДӨРТ: Эх хэлний өдрийг тохиолдуулан Соёлын яамнаас санаачилсан "Хос бичигтэн болцгооё!" уриалгад нэгдэж, байгууллагын цахим хуудсаар монгол бичгээр бичвэр бичиж оруулан, Эх хэл, бичиг, Өв соёлын талаар мөн бяцхан уншигчдад зориулж эх хэлтэй холбоотой хүүхдийн шүлэг, яруу найргаас оруулан сурталчилсан. Уг өдрийг тохиолдуулан “ЗОЧИН ПОДКАСТ” хийж, зочноор сэтгүүлч, СОТА Я. Түмэннаст, Монгол хэл, уран зохиолын багш, Боловсролын тэргүүний ажилтан С. Оюунцэцэг нар уригдан оролцсон бөгөөд 1600 хүн тандалт өгч үзсэн байна.

Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болсон язгуур соёл, өв уламжлалаа эрхэмлэн дээдлэх, эх хэл, түүх соёлоо сурталчлах, иргэн бүр төрөлх монгол эх хэлээрээ зөв ярьж, зөв бичих, хүүхэд багачуудад эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор СӨБ-ын ахлах, бэлтгэл бүлэг, ЕБС-ийн 1-12 ангийн сурагчдын “ЭХ ХЭЛ - МИНИЙ БАХАРХАЛ” цахим шүлгийн уралдааныг явуулахад 18 сурагч оролцож:



Цэцэрлэгийн насны ангилалд:
Тэргүүн байр: А. Баяржаргал / Эрдэнэцагаан сумын 1-р цэцэрлэгийн Ахлах Б бүлгийн сурагч/
Дэд байр: Б.Мишээл /Түмэнцогт сумын Ахлах-Б бүлгийн суралцагч/
Гутгаар байр: Б. Буяндэлгэр /Сүхбаатар аймгийн 4-р цэцэрлэгийн Бэлтгэл А бүлгийн суралцагч/
ЕБС-ийн 1-5 ангийн ангилалд:
Тэргүүн байр: Б. Нандинцэцэг /Түмэнцогт сум 5б анги/
Дэд байр: У. Түвшинсайхан /Халзан сум ЕБС-ийн 5А ангийн сурагч/
Гутгаар байр: Ч. Намуун /2-р сургууль 5 анги /
6-12 ангийн ангилалд:
Тэргүүн байр: Д. Даваадорж /Эрдэнэцагаан сумын 12 анги/
Дэд байр: Г. Баярцэцэг /1-р сургууль 6е анги/

Гутгаар байр: Э. Ганганцэцэг /Түмэнцогт ЕБС-ийн 6б анги/ нар тус тус шалгарч, шагналыг МЗЭ-ийн эвлэлийн Сүхбаатар салбартай хамтран зохион байгуулсан "Яруу увдис" арга хэмжээн дээр гардуулж, шалгарсан хүүхдүүд маань шүлэг, яруу найргаасаа уншиж сонирхуулсан.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛ НОМЫН ӨДРҮҮД-2023” НАМРЫН АРГА ХЭМЖЭЭ:

Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа”-2025” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлж, 2023 оны намрын номын баярыг 09 дүгээр сарын 10-17-ны өдрүүдэд “Илүү их уншъя” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлсэн.

Монгол Улсын Их хурлын даргын ивээл дор жил бүр зохион байгуулдаг номын баярын нээлтийн үйл ажиллагааг "Илүү их уншъя" уриан дор Жаахан шарга театрын хойд талын талбайд зохион байгуулж, Соёл, урлагийн газар, Хөгжимт жүжгийн театр, МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлийн гишүүд, ахмадууд, иргэд олон нийт, уншигч хүүхдүүд, номын клубын хүүхдүүд зэрэг 2000 гаруй хүн оролцов.

Арга хэмжээний үеэр: Номын баяр болон үйл ажиллагаанд бусдыгаа манлайлагч "Эрдмийн эрэл"- клубын гишүүн Г.Булгантамир, "Оюунлаг ирээдүй" клубын гишүүн Мөнхсолонго, "Ухаарахуй" клубын гишүүн Б.Батхүрэл, "Номтой нөхөрлөе" клубын гишүүн Н. Ангарагмаа, "Book time" клубын гишүүн Г. Мөнгөндөл, "Бид уншигч" клубын гишүүн Г. Болорчимэг нар “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж” тэмдэгээр шагнагдсан. Аймгийн Засаг даргын “Баярын бичиг”-ээр ЕБ-ын 4 дүгээр сургуулийн номын санч М. Адъяа шагнагдсан..

Онцлог тал гэвэл: Яруу найргийн “OPEN MIC” арга хэмжээг зохион байгуулж, 35 хүн оролцсон нь онцлог үйл ажиллагаа болсон бөгөөд мөн Соёлын ажилтны баяртай хамтатган зохион байгуулсан явдал юм.

Зохион байгуулсан үйл ажиллагаа:

1.Номын сангийн тухай хууль, эрх зүйн баримт, Номын сангийн үйл ажиллагааны тухай байгууллагын цахим хуудсаар сурталчлах
2."Олуулаа уншъя" аян
3.“Үлгэрээс үлгэрлэе” урианы хүрээнд “Хормогчин хүүхэлдэй”
4. Нутгийн зохиолч, яруу найрагчдын уран бүтээлийг сурталчлах
5.Бүх нийтийн соёлын боловсролын сургагч багш бэлтгэх сургалт
6.Шинэ номын болон онцлох номын үзэсгэлэн
7. Байгууллагын үйл ажиллагаа, ажил мэргэжил сурталчлах
8. “Эх хэл-Бидний бахархал” цахим шүлгийн уралдаан
9. “Open mic” яруу найргийн нээлттэй арга хэмжээ
10. Соёл-спорт өдөрлөг
11. "АЯЛАГЧ-УНШИГЧ "
12. “Яруу увдис” яруу найргийн арга хэмжээ

13. “Бие биедээ ном бэлэглэе” арга хэмжээ

14. Шагнал гардуулах арга хэмжээ

15. Байгууллагын үйл ажиллагааны болон уншигчдын сэтгэл ханамжийн судалгаа авах .зэрэг соёл, урлагийн **15** үйл ажиллагааг зохион байгуулсан.

Мэдээлэл, сургалт сурталчилгааны ажил

<u>Номын сангийн тухай хуулийн сурталчилгаа, хэлэлцүүлэг</u>

Номын сангийн fb хуудсаар Номын сангийн тухай хууль, эрх зүйн баримт, Номын сангийн үйл ажиллагааны тухай-Та үүнийг мэдэх үү, 2023-2025 онд хамгийн эрэлттэй 10 мэргэжил аудио хэлбэрээр цуврал, номын сангийн Электрон хайлтын тухай, Эх хэл, Тусгаар тогтнол, өв соёлын тухай яруу найрагчдын уран бүтээлээс лавлагаа мэдээллүүд оруулан байгууллагын цахим хуудсаар сурталчлахад 893 хүн хандалт өгчээ.

Соёл, Урлагийн газраас "Бүх нийтийн соёлын боловсрол" анхан шатны сургалт зохион байгуулагдаж, арга зүйч, сан хөмрөгч хамрагдав.

НУТ-ын дэргэдэх "БИД-УНШИГЧ" номын клубын сурагчид нь "СУДАР ЭГШИГЛЭН" төсөлд Англи номын тэмдэглэлээр оролцож байгаа ба ээлжит уншлагыг "Twobad Mice" " Power Palace" номоор хийсэн. Уншлагыг ЕБ-ын 4-р сургуулийн англи хэлний багш Ч. Нацагням удирдаж, ЕБ-ын 3-р сургуулийн 12 ангийн сурагч Намуун урилгаар оролцсон.

А. Борогчин багштай ЕБ-ын 3-р сургуулийн 12б анги, Түвшинзаяа багштай ЕБ-ын 2-р сургуулийн 12б анги, Хонгорзул багштай ЕБ-ын 3-р сургуулийн 10б ангийн сурагчид анги хамт олноороо уншигчийн карт шинээр нээлгэсэн.

"ҮЛГЭРЭЭС ҮЛГЭРЛЭЕ" аяны хүрээнд 2-8, 11-р цэцэрлэгийн бэлтгэл, ахлах, дунд бүлгийн хүүхэд багачуудад орос ардын үлгэр "Манжин", "Өнхрүүш" үлгэрээр хормогчны театр ашиглан үлгэр уншиж өгч, 750 гаруй хүүхдэд жүжигчилсэн дүрийн тоглолтыг үзүүллээ.

10д ангийн хамт олонтойгоо "Номтой цаг" үйл ажиллагааны хүрээнд аймгийн нийтийн номын сангаар зочлон, уншлагын танхимуудтай танилцаж, уншигчийн карт нээлгэн,

7-р цэцэрлэгийн 32 сурагч

ЕБ-ын 3-р сургуулийн 10г ангийн 20 сурагч, 11б ангийн сурагч

Халзан сумын ЕБС-ийн 9г ангийн 15 сурагч, номын клубын 5 сурагчид номын сангийн үйл ажиллагаатай танилцлаа .

ЕБС-ын 1-5 ангийн сурагчдын дунд "Олуулаа уншицгаая" аян өрнүүлж “Цахим” урилга илгээн 3-5 ангийн 300 хүүхдэд шинээр карт нээн 590 хүүхдэд 1103 номоор үйлчилсэн.

Үзүүлэн таниулах ажил-аар Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн:
Номын баярын нээлтийн арга хэмжээ болон “Яруу увдис” арга хэмжээн дээр

- ✓ Сүхбаатар нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн
- ✓ Хүүхдийн уран зохиолын шинэ номууд
- ✓ Онцлог номын үзэсгэлэн 10
- ✓ Шинэ номын худалдаагаар 50 гаруй номоор үзэсгэлэн гарган сурталчилсан.

Уралдаан тэмцээн: МЗЭ-ийн Сүхбаатар салбараас "Яруу увидас" арга хэмжээг зохион байгуулж, 100 гаруй хүн оролцож, уран бүтээлч О.Одхүүгийн уран бүтээлийн цэнгүүн зохион байгуулан алдаршуулж, “ Соёлын түшиг” холбооны Соёлын гавъяа одонгоор шагнасан.

Эх хэлний өдөрт зориулсан “**ЭХ ХЭЛ - МИНИЙ БАХАРХАЛ”** цахим шүлгийн уралдаанд оролцож, байр эзэлсэн хүүхдүүдийн шагналыг уг арга хэмжээн дээр гардуулж, шалгарсан хүүхдүүд шүлэг, яруу найргаасаа уншиж сонирхууллаа.

Уулзалт хэлэлцүүлэг:

Нийтийн уншлагын танхимын дэргэдэх номын клуб, ЕБС-ын номын клубүүд, МСҮТ-ийн номын клубтай хамтран "АЯЛАГЧ-УНШИГЧ" уншлагыг Амгалан хошуунд зохион байгуулж, ном унших соёл, ач холбогдлыг сонсож, уншсан номын хүүрнэл ярилцлагаар хоорондоо мэтгэлцэж, оюуны болон хөгжөөн баясгах тэмцээнүүдээр уралдаж, уншигч хүүхдүүд орчны бохирдлыг цэвэрлэлээ. Уг үйл ажиллагааг орон нутгийн BBS телевизээр сурталчлав.

“Ном бэлэглэе, солилцьё" аянд лаборатори 1 дүгээр сургуулийн Ш. Дэлгэрцэцэг багштай 1е ангийн 36 сурагчид оролцлоо.

Халзан сумын Соёлын төвийн номын сангийн дэргэдэх “Номтой найзалъя” номын клуб, ЕБС-ийн Л.Дэлгэрмаа багштай 9а ангийн хамт олон, нийтийн номын сангийн уншлагын танхимын дэргэдэх “Бид уншигч” клубын сурагчид уулзалт зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа ажлуудаасаа туршлага солилцсон.

Номын худалдаа

Номын баярын нээлтийн үеэр шинэ номын худалдаа болон онцлох номын үзэсгэлэн худалдааг зохион байгуулав.

УНГАРЫН АЛДАРТ ЯРУУ НАЙРАГЧ ФЭТӨФИ ШАНДОРЫН ШҮЛГИЙГ ХЭН САН УНШХ ВЭ? ШҮЛГИЙН УРАЛДААН



Унгарын элчин сайдын яамны дэд тэргүүн Фөлөн Жигмон манай аймагт айлчилж, аймгийн удирдлагуудтай уулзаж, ЕБС-ын 12 дугаар ангийн сурагчдад тус улсын тухай болон Унгарын алдарт яруу найрагч Фэтөфи Шандорын 200 жилийн ойд зориулж түүний талаар танилцуулж, богино хэмжээний кино үзүүлж, мөн Унгарын Засгийн газрын "Stipendium Hungaricum"тэтгэлэгт хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөв. Мөн ЕБ-н 1-4 дүгээр сургууль, МСҮТ-ийн сурагчид Фэтөфи Шандорын шүлгээс уншиж сонирхуулав. Шүлэг уншиж оролцсон хүүхэд багачуудад Унгарын элчин сайдын яамнаас гарын бэлэг гардуулж урамшуулав.

Сүхбаатар сумын Соёлын төвийн номын сангийн дэргэдэх номын клуб, АННС-ын НУТ-ын дэргэдэх "Бид-Уншигч" номын клубын сурагчдын хамтарсан "БИД НОМЫН САЙН НӨХӨР" нөхөрсөг уулзалтыг Сүхбаатар суманд зохион байгуулж, "Уншигч сурагчдын номын хүүрнэл ба ярилцлага" "Номын клубын гишүүдийн үүрэг оролцоо" сэдвээр харилцан ярилцлага хийж, "Бид уншигч" клубын хийсэн ажлаа тайлагнаж, орон нутаг судлах музей, түүхэн дурсгалт газруудтай танилцаж нөхөрсөг хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгуулсан. Мөн олон улсын охидын баярыг тэмдэглэн өнгөрүүлж дурсгалын бэлэг солилцов.

УИХ-ын гишүүн Ганибалын ивээл дор Насан туршийн боловсрол төвөөс зохион байгуулагдсан СУРАЛЦАГЧ АЙМАГ 3"7"3 уралдаанд Бид-Уншигч" номын клуб оролцсон.

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР- ын хүрээнд тусгай төлөвлөгөө гаргаж, Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг аян, Өглөөний уншлага, Монголын нууц товчоо-том жижиг номын уралдаан, Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн, Үндэсний бичгийн уншлагын өдөр, цаг, Яруу увдис өдөрлөг, Хормогчин театр, Монголын номын сангуудын спортын олон төрөлт наадам, "Бүтээлч уншлага", "Найргийн орны хүүхдүүд" шүлгийн тэмцээн, Яруу найрагч Ч. Эрдэнэбаатарын "Монгол ухааны эрхин хэлхээ" номын хэлэлцүүлэг, "Номын булантай анги, хамт олон, Угийн бичгийн уралдаан, Соёлын боловсролын хөтөлбөр олгох сургалт зэргийг зохион байгуулж, Сүхбаатар аймгийн байгалийн үзэсгэлэнт түүхэн газруудаар видео танилцуулга хийж цахимаар хүргэж сурталчилсан.

"ХҮМҮҮН БИЧИГ-ХҮН БҮРИЙН БИЧИГ" ТЭМЦЭЭН

Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд Аймгийн ЗДТГ, БШУГ, НТБТ, ННС хамтран "Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг" уралдааныг 6 дах жилдээ амжилттай зохион байгуулахад 9 багийн 45 хүн оролцсоноос:

-ТЭРГҮҮН БАЙР- Нийгмийн даатгалын хэлтэсийн "Таталбар" баг

-ДЭД БАЙР – "Жаахан Шарга" ХЖТ-ын "Жаахан Шарга" баг

-ГУТГААР БАЙР- ЕБ-ын 2 дугаар сургуулийн "Судар бичиг" баг тус тус эзэлж

- Шилдэг видео контент: "Жаахан Шарга" ХЖТ-ын "Жаахан Шарга" баг
- Хамгийн хурдан уншигч баг: Нийгмийн даатгалын хэлтэсийн "Таталбар" баг тус тус шалгарсан.

"БИД УНШИГЧ" номын клубын сурагчдын ээж нарыг өглөөний уншлагад урьж

оролцуулж, хүүхдүүдийнхээ номын тэмдэглэлтэй танилцаж, клубын танилцуулга болон сурагчдын оролцсон, хийсэн, хийхээр төлөвлөсөн ажлуудтай танилцаж, клубын гишүүн

охид ээж нартаа "Ном уншихын ач холбогдол" "Тэмдэглэл хөтлөх үндсэн аргачлал" сэдвүүдээр сургалт хийн, уншсан номын болон англи номын хүүрнэлийг ярьж сонирхуулсан.

НОМЫН БУЛАНТАЙ АНГИ ХАМТ ОЛОН Иргэд албан хаагчдыг номтой нөхөрлүүлэх, бүтээлчээр унших арга болон ном унших соёлд суралцах, ном унших орчныг илүү өргөн хүрээнд дэмжих, хөгжүүлэх болон номтой нөхөрлөгч, номыг дэмжигч “Номын булан”-тай хамт олныг шалгаруулах уралдаанд

Тэргүүн байр ЕБ-ын 4 дүгээр сургуулийн М. Түвшинжаргал багштай 4б анги

Дэд байр: ЕБ-ын 4 дүгээр сургуулийн М. Алтантуяа багштай 4в анги

Гутгаар байр: ЕБ-ын 2 дугаар сургуулийн Цолмонгэрэл багштай 5в анги хамт олон шалгарсан.

Тусгай байр ЕБ-ын 2 дугаар сургуулийн И. Цолмон багштай 4г ангийн хамт олон тус тус шалгарсан.

"МОНГОЛ УХААНЫ ЭРХИН ХЭЛХЭЭ" НОМЫН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын уугуул, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч Ч. Эрдэнэбаатарын "Монгол ухааны эрхин хэлхээ" номын уулзалт, хэлэлцүүлгийг 2023 оны 11-р сарын 28-ны өдөр зохион байгуулж, АХА тэмцээнийг явуулахад ЕБС-ийн болон ноомын клубын 100 гаруй хүүхэд хамрагдсан.

АХА тэмцээний Тэргүүн байранд: Ерөнхий боловсролын 3-р бүрэн дунд сургуулийн 10 а ангийн сурагч Намуун /Цом-Өргөмжлөл-300,000 төг/

Дэд байранд Ерөнхий боловсролын 3-р бүрэн дунд сургуулийн 12 б ангийн сурагч Пүрэвбат /Цом-Өргөмжлөл-200,000 төг/

Гутгаар байранд Ерөнхий боловсролын 3-р бүрэн дунд сургуулийн 10г ангийн сурагч Эрдэнэбаатар /Цом-Өргөмжлөл-100,000/ нар шалгарсан.

“НАЙРГИЙН ОРНЫ ХҮҮХДҮҮД” ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ

Хүүхэд багачуудыг номд дурлуулах, оюуны хөгжлийг нь дэмжих, цахим ертөнцөөс хол байлгах зэрэг эерэг дадлуудыг олгох зорилгоор зохион байгуулдаг “Сүхбаатарын өнгө” сонины нэрэмжит “Найргийн орны хүүхдүүд” уран уншлагын наадмыг хоёр дахь жилдээ явуулахад 5-18 насны 130 орчим хүүхэд оролцож, авьяас чадвараа сорилоо.

Цэцэрлэгийн нас:

Тэргүүн байр: М. Хишигбаяр -1 дүгээр цэцэрлэг

Дэд байр: А. Мөнхцэнгэл-2 дугаар цэцэрлэг
Гутгаар байр: Б. Насанжаргал- 2 дугаар цэцэрлэг
1-5 дугаар анги
Тэргүүн байр: У. Түвшинсайхан-Халзан сум. ЕБС. 5а анги
Дэд байр:Т. Түвшинбаяр-Онгон сум. ЕБС. 5а анги
Гутгаар байр: Г. Жаргалан-3 дугаар сургууль. 5в ангийн сурагч
6-9 дүгээр анги
Тэргүүн байр: А. Уранбилэг-Халзан сум.ЕБС. 8а ангийн сурагч
Дэд байр:Б. Дэлгэрбуян-Сүхбаатар сум. ЕБС.9а ангийн сурагч
Гутгаар байр: М. Энхнаран. Мөнххаан сум. ЕБС. 7в ангийн сурагч
10-12 анги
Тэргүүн байр: Д. Есүгэн-Мөнххаан. ЕБС.11а ангийн сурагч
Дэд байр:Х. Энхжин. Баруун-Урт сумын 2 дугаар сургууль. 10с1 ангийн сурагч
Гутгаар байр: Ө: Дөлгөөн. Баруун-Урт сумын 2 дугаар сургууль.10с2 ангийн сурагч
4 цаг Утга зохиолын нэгдлийн нэрэмжит шагнал- Ч. Бямба-Эрдэнэ-Сүхбаатар сум. ЕБС. 9б ангийн сурагч
МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь салбарын нэрэмжит шагнал-Х. Эрдэнэдалай.ЕБ-ын 2 дугаар сургууль. 5б ангийн сурагч
Соёл, урлагийн газрын нэрэмжит шагнал-Д.Нарансолонго-Мөнххаан. ЕБС.11а ангийн сурагч
“Манай ирээрэй” номын өргөөний нэрэмжит шагнал- О. Соёмбо. 9 дүгээр цэцэрлэг
Аймгийн Нийтийн Номын сангийн нэрэмжит шагнал-Б. Энхлэн-2 дугаар цэцэрлэг
“Монлайн Сүхбаатар салбар”-ын эрхийн бичиг Э. Гүнжидмаа-3 дугаар сургууль. 1а анги
Б. Даваахүү-Дарьганга сумын цэцэрлэг.
Э. Цогнэмэх--Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль.7б ангийн сурагч
С. Баяржавхлан-Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль. 10г ангийн сурагч нар тус тус шалгарсан.

“ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ-Д.НАЦАГДОРЖ ТЭМДЭГТЭН”-Жил бүр бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн” уралдааныг зохион байгуулж, “Шилдэг уншигч анги хамт олон”-оор ЕБ-ын 4-р сургуулийн Алтантуяа багштай 4в анги, “Шилдэг бүтээлч анги хамт олон”-оор ЕБ-ын 4-р сургуулийн Түвшинжаргал багш 4б анги, Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэнээр ЕБ-ын 1-р сургуулийн 5д ангийн сурагч Г. Хүслэн нар шалгарсан бөгөөд “Тэргүүний уншигч-

Нацагдорж тэмдэгтэн" хүүхдүүдтэй уулзалт хийж, Тэргүүний уншигч Г. Хүслэнгийн "Гэрийн номын сан"-ийн үзэсгэлэнг 75 номоор гаргасан.

"ТОМ ЖИЖИГ НОМ" ХИЙХ БҮТЭЭЛИЙН УРАЛДААН: Монгол бахархлын өдрийг угтан Монголын нууц товчоог мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 02 дугаар сарын 18 -ны өдрийн №23 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын нууц товчоо номны агуулгаар "Том жижиг ном" хийх бүтээлийн уралдаанд 3 сургуулийн 19 бүтээл ирж шилдэгээ шалгаруулсан.

ЗӨӨВРИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

№	Олгосон газар	Тоо ш	Тайлбар
	Фонд:		
1.	Ахмад багш Ш. Борчулуун	15	
2.	3-р сургууль	41	
3.	Ахмад сэтгүүлч Я. Түмэннаст	3	
4.	Сүхбаатар хөрөнгө оруулалт-2023 Соёлын сэргэлт-2023 Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-Номын баяр 2023 Яруу увдис/ *нутгийн зохиолчдын* /	447	
5.	ЕБ-н 2 дугаар сургууль	5	
6.	ШШГГ	41	
7.	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	12	
8.	Д. Сүхбаатарын мэндэлсэн 130 жил	23	
9.	Англи шинэ номын танилцуулга	135	
10.	Үндэсний бичиг үсгийн баяр, Номын баяр 2023, Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг"-арга хэмжээ /*хуучин монгол бичгийн* /	96	
11.		828	
	Насанд хүрэгсдийн танхим		
12.	10 –р цэцэрлэг	30	

13.	4-р БДС	15	
14.	1-р БДС	5	
15.	Угсаатны зүйн музей	25	
16.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд	30	
17.	2- р БДС	25	
18.	3-р БДС	25	
19.	ШШГГ	12	
20.	МСҮТ	68	
21.	Байгаль орчны газар	20	
		255	
Хүүхдийн танхим			
22.	9-р цэцэрлэг	69	
23.	Нутгийн хүүхдийн зохиолчид бүтээлээр 1-р сургуульд	35	
24.	2-р сургуулийн номын санд Зөөврийн номын санг	29	
25.	1-р Цэцэрлэгт насны онцлогт тохирсон	14	
26.	7-р цэцэрлэгт	19	
27.	2-р цэцэрлэг	10	
28.	4-р сургууль	65	
29.	5-р цэцэрлэгт	20	
30.	6-р цэцэрлэг	3	
31.	Түвшинширээ сумын сургууль ном	2	
32.	Уулбаян сум	18	
33.		284	
Гэрээр ном олгох танхим			
34.	Барилгын цэргийн 338-р анги	112	
35.	Түмэнцогт сумын соёлын төв	150	
36.	Брайль ном /12 сумдаар /	15	
37.		277	
	Нийт	**1644**	

ХҮҮХДЭД НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ

Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг захирлын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/11 тоот тушаалаар шинэчлэн байгуулж, гэр бүл, эцэг, эхийн зөвлөлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, ажилтан, албан хаагчдад ёс зүйн дүрмийг танилцуулсан. Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн сургагч багш бэлтгэх сургалтанд зөвлөлийн гишүүн, сан хөмрөгч Ө. Хонгорзул хамрагдаж сертификат авсан.

"Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсоох олон улсын өдөр" эцэг эхчүүд, асран хамгаалагчид, сурган хүмүүжүүлэгчид хүүхэдтэй хэрхэн харилцах, хүүхэд хүмүүжүүлэх зэрэг аргууд, эцэг эхчүүд хүүхдээ зодож шийтгэлгүйгээр хүмүүжүүлэх талаар гарын авлага тараах материалыг эцэг эх, хүүхдүүдэд чихрийн хамт өгч сурталчлав.

Танин мэдэхүйн булангаар хүүхдийн эрхийн талаарх мэдээллийг аудио хэлбэрээр бэлтгэн, хүүхдэдээ тавих анхаарал халамжаа сайжруулж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмжийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан сурталчилсан. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж хүүхдийн уран зохиол, танин мэдэхүйн 100 гаруй номоор гадаа талбайд үзэсгэлэн гаргаж сурталчилж, албан хаагчдын 32 хүүхдэд 554782 төгрөгний бэлгийг гардуулан өгсөн. 0-18 настай хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийнх нь төрсөн өдрөөр цалинтай

чөлөө, хичээлийн шинэ жилийн нээлтэнд нь хамт оролцох боломжийг олгож 1 өдрийн цалинтай чөлөө олгосон. Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын хүүхдийн дунд “Аав ээж би” гэсэн сэдэвтэй зургийн уралдаан зарлаж, оролцсон хүүхдүүдэд гарын бэлэг гардуулсан.

ХАБЭА-н сарын аяны хүрээнд ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн дархлааг дэмжиж /363.400 төгрөг/ витаминжуулсан.

Хүүхдийн зохиолч Х. Андерсений зохиол бүтээл болон хүүхдийн шилдэг номоор үзэсгэлэн гаргаж, чанга уншлагыг “Сайхан сэтгэл”, “Заанаас өндөр хүн“, “Өнхрүүшхэн” үлгэрээр хийж, “Хормогчин театр”-г “Манжин”, “Өнхрүүшхэн” үлгэрээр дүрийн тоглолтыг 1-11 цэцэрлэгийн бага, дунд, ахлах, бэлтгэл бүлэг, Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн багачуудад, 4-р сургуулийн 1-р ангийн нийтдээ 2000 гаруй хүүхдэд жүжигчилсэн дүрийн тоглолт хийж үзүүлсэн.

ЕБС-ын сурагчдын дунд "Олуулаа уншицгаая" аян өрнүүлж “Цахим” урилга илгээн 1-7 ангийн 950 хүүхдэд карт нээн 6120 номоор үйлчилсэн.Түвшинширээ суманд очиж, хүүхэд багачуудад "Ном унших дадал" сэдвээр мэдээлэл өгч, харилцан ярилцаж, танин мэдэхүйн "АХА" тэмцээнийг зохион явуулахад 300 гаруй сурагчид хамрагдаж, шалгарсан хүүхдүүдийг номоор шагнаж урамшуулсан.

“Хүүхэд хөгжил, хамгааллыг дэмжих жил- 2023” хүрээнд байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс “Аав, ээж, би” гар зургийн уралдааныг ажилтан, албан хаагчдынхаа хүүхдүүдийн дунд зохион байгуулж, гарын бэлэг гардуулсан.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ

Луй Брайлийн мэндэлсэн өдрийг тохиолдуулсан “АХА” хөгжөөнт уралдааныг зохион байгуулахад 30 хүн хамрагдаж, мэдлэг чадвараа сорьсон.

Хараагы бэрхшээлтэй иргэдийн холбоо, хөгжлийн бэрхэшэлтэй иргэдийн холбоотой хамтран 12 сумдаар брайль ном сурталчлах, брайль үсэг заах, сургалт зохион байгуулж, 300 гаруй харааны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ном сурталчилсан. Брайль номын фондонд 30 ширхэг библь судар нэмэгдсэн.

ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн үйл ажиллагаанд лавлагаа номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, нэвтрүүлэхэд чиглэгдсэн ажлын талаар

Байгууллагын үйл ажиллагааг Сүхбаатар аймгийн Номын сан www.facebook.com/, МУСГЗ, Г. Мэнд-Ооёогийн нэрэмжит Сүхбаатар аймгийн нийтийн номын сан фэйж хуудас, Sukhbaatar-library.com блогоор дамжуулан байгууллагын үйл ажиллагааг сурталчилж, төрөл бүрийн мэдээллийг уншигч, үйлчлүүлэгчдэд амаар, бичгээр, утсаар, цахимаар хүргэж, түүхт ой, тэмдэглэлт өдрүүд, цаг үеийн үйл явдлуудад зориулан соёл танин мэдэхүйн талаар 5420 гаруй мэдээлэл оруулж 11210 хүн хандалт өгчээ. Д.Сүхбаатарын мэндэлсэний 130 жилийн ой, Цагаан сар, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, 33,34 дэх Номын баяр, Үндэсний бичиг үсгийн баяр, Танин мэдэхүйн цувралууд, Тэгш ой тохиож буй нэрт хүмүүс, Найргийн цаг булангаар нутгийн найрагч, нутгийн найрагч бүсгүй, уншигчийн сэтгэгдэл, номын тухай яриа, эерэг хандлага, шинэ номын булан, Соёлын бүтээлч сарын Сүхбаатар аймгийн үзэсгэлэнт байгаль түүхийн дурсгалт газрууд гэх зэргээр лавлагаа номзүйн мэдээллийг тогтмол бэлтгэн сурталчилсан.

Сүхбаатар аймгийн яруу найрагчдыг сурталчлах зорилгоор “Нутгийн найрагч” булан тогтмол ажиллуулан залуу найрагч Дамдинсүрэнгийн Батцэцэг, Батсүхийн Төгсжаргал, Чанцалын Үл-Олдох, Амжигийн Мөнхбат, Гончигийн Сүхзориг нарын уран бүтээлээс аудио-хэлбэрээр бэлтгэн тогтмол сурталчлахад 3690 гаруй хүний хандалт авсан.



НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОРОН НУТГИЙН КАРТЫН САН, НОМЗҮЙН БҮРТГЭЛ ЭРХЛЭН ГАРГАСАН ЭСЭХ

Дэлхийн яруу найргийн баярт зориулж, “Шинэ шүлгийн уншлага-2023” арга хэмжээнд зориулан лавлагааны материал, гарын авлагаар 50 гаруй хуудастай товхимол бэлтгэн гаргаж, оролцогчдын гарт хүргэсэн.

Орон нутаг судлалын сан хөмрөгийг бүрдүүлж, хөгжүүлэх талаар хийсэн ажлын талаар

Үндэсний тогтмол хэвлэлийн Zotero программд “Сүхбаатарын өнгө” сонины 2022 оны 176 мэдээллийг, 2023 онд 29 дугаарын 160 мэдээллийг шивж оруулан Үндэсний номын руу илгээсэн.

НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын санд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, технологийн үйл ажиллагааг хэрэглэгчдэд хүргэхэд чиглэгдсэн ажлуудын талаар:

Байгууллагын вэб сайтыг шинээр вордпрессийн платформыг ашиглан үүсгэсэн ба загвар болон цэснүүд, дата баазыг шинээр үүсгэн, мэдээ мэдээллийг оруулж эхлээд байна. Цаашдаа www.sukhbaatar-library.com домайн нэрийг ашиглах, вэб хостинг үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаа хийгдэж локал дээр дээр бэлдсэн вэб сайтын баазыг хуулах, интернэтэд байршуулах үйл ажиллагаа хийгдэж, өдөр тутмын мэдээ мэдээллийг оруулан ажиллаж байна.

E-Mongolia болон Erp.e-mongolia системийн ашиглалтыг сайжруулан, өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна.





АРГА ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын санчдад арга зүйн зөвлөгөөг амаар болон биечлэн хүргэсэн байдал

Аймгийн Соёл, Урлагийн газраас зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллаж, Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/49 тоот албан тоотоор зөвлөмж ирсний дагуу тусгай төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж, зөвлөмжийн хариуг хүргүүлсэн.




Номын санчдын нэгдсэн сургалтын үеэр номын сангуудын 2022 оны тайлангийн дүгнэлтийг танилцуулж, цаашид анхаарах асуудлын талаар хэлэлцэж, Түмэнцогт, Онгон сумын номын санчдад сан хөмрөг дэхь номыг данс бүртгэлд хэрхэн бүртгэх талаар болон Халзан, Түвшинширээ сумын соёлын төвийн номын санд очиж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч мэргэжлийн чиг үүргээр ханган ажилласан.

Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байдал

Номын санч сэтгүүлийн 2023 оны №01(121) дугаарт номын сангийн үйл ажиллагаанд хөтлөгдөх, бүртгэл, маягтын асуудлыг голлон хөндөж, энэ чиглэлийн өгүүллүүдийг нийтлэхээр төлөвлөсөнтэй холбогдуулж, уг сэтгүүлд материал бэлтгэн, 11 аймгийн нийт 168 номын санч, мэдээллийн ажилтнуудаас судалгаа авч, бүртгэл маягтын хэрэглээ

ямар түвшинд байгааг, өнөөгийн нөхцөл байдалд таарч буй эсэхийг тодруулахыг зорьж, судалгааг нэгтгэн нэн яаралтай шинэчлэх хэрэгцээ шаардлагатай байгаа, цахим хэрэглээ, программ хангамжтай уялдуулан хөгжүүлбэл таатай болох нь судалгаанд хамрагдагсдын санал хүсэлтээс тодорхой харагдаж байгаад дүгнэлт хийн ажиллаж, Номын санч сэтгүүлд хэвлүүлсэн.

26

Тамсагдоржийн ЧАНДМАНЬ
Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн арга зүйч

НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮРТГЭЛҮҮД, ТЭДГЭЭРИЙН ОРОН НУТАГТ ХӨТЛӨГДӨЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Үндэсний номын сангаас эрхлэн хэвлүүлдэг "Номын санч" сэтгүүлийн 2023 оны шинэ дугаарын голлох сэдвээр номын сангийн үйл ажиллагаанд хөтлөгдөх, бүртгэл, данс, маягтыг онцлох болсонтой холбогдуулж номын санч, мэдээллийн ажилтнуудаас дээрх сэдвийн дагуух судалгааг ***цаасаар болон цахимаар*** авлаа.

Судалгаанд Сэлэнгэ, Говьсүмбэр, Дархан, Өвөрхангай, Баян-Өлгий, Булган, Хэнтий, Баянхонгор, Дорноговь, Говь-Алтай, Сүхбаатар зэрэг ***11 аймгийн нийт 168 номын санч, мэдээллийн ажилтан хамрагдав.*** Аймгийн болон сумдын номын санчид дийлэнх хамрагдсанаараа энэхүү судалгаа онцлог юм. Санал асуултын асуултыг энгийн, ноон тодотгоор явуулахыг эрхэмлэсэн болно.

"Номын сангийн бүртгэлүүд ажлын гүйцэтгэл, чанарыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг" гэсэн асуултад 149 уншигч хамрагдаж 111 буюу 74.5 хувь нь тийм хэмээн хариулжээ. Үүнээс харахад номын сангийн бүртгэлийн гол ач холбогдлыг ойлгож байгаа ч ***тэдгээрийг хэрэглэхгүй, ашиглахгүй байгаа нь, ойлголт сул байгаа нь*** дараах хоёр асуултын хариултаас тодорхой болсон юм. ***"Номын санд хөтлөгдөх анхан шатны хэдэн бүртгэл байдаг вэ?"*** хэмээх асуултад 75 номын санч 1, 3 номын санч 31, 17 номын санч 21, 4 номын санч 10, 2 номын санч 6 гэж хариулжээ. ***"Бүртгэлүүдийг нэрлэнэ үү"*** хэмээх нээлттэй асуулт бөгөөд уг асуултад 70 номын санч нэг бүрчилсэн бүртгэл, 67 номын санч өдөр тутмын бүртгэл, 64 номын санч нэгдсэн бүртгэл, 37 номын санч татгалзсан бүртгэл, 15 номын санч сонин, сэтгүүлийн бүртгэл, 12 номын санч номын сан хоорондын ном солилцооны бүртгэл, мөн 12 номын санч өгөгдсөн лавлагааны бүртгэл, 7 номын санч уншигчийн карт, 6 номын санч фонд тоолсон тухай акт, 4 номын санч номын формуляр, мөн 4 номын санч ном захиалгын хуудас, 3 номын санч каталогийн карт, 1 номын санч үрэгдүүлсэн номын оронд авсан номын бүртгэл, мөн 1 номын санч соёл олон нийтийн ажлын бүртгэл гэж зэргээр нэрлэжээ. Уг асуултад ажилчдын цагийн бүртгэл, ажлын байрны тодорхойлолт, ажлын тайлан, ажлын төлөвлөгөө, үр дүнгийн гэрээний биелэлт, ном сэлбэн засалтын дэвтэр, цахим хаяг хөтлөлт, цахим бүртгэл, тооллогын бүртгэл

НОМЫН САНЧ 2023/01


27

зэрэг *батлагдаагүй, мэргэжлийн бүртгэлүүдийг нэрлэсэн тохиолдол гарчээ.*

Номын сангийн анхан шатны бүртгэлүүдийг ***нэгд***: номын сангийн фондын бүртгэл, ***хоёрт***: үйлчилгээний бүртгэл, ***гуравт***: лавлагаа, ном зүйн бүртгэл, ***дөрөвт***: маягтууд гэж ангилах бөгөөд тэдгээрийн үйлчилгээнд хэрхэн ашиглаж буй талаар ***"Номын сангийн үйл ажиллагаанд хөтлөгдөх бүртгэлүүд таны ажилд хэр ашиглагддаг вэ?"*** гэсэн асуултад 73.8 буюу 110 нь сайн ашигладаг, 24 хувь нь буюу 36 номын санч тийм ч их ашигладаггүй, 2 хувь нь буюу 3 номын санч ашигладаггүй хэмээн хариулжээ. Үүнээс харахад 27 хувь нь буюу 40 орчим номын санч мэргэжлийн бүс бүртгэл, маягтуудын талаар ойлголтгүй, хэрэглэдэггүй нь харагдаж байна. ***"Номын сангийн бүртгэлүүдийг өөрчлөх, шинэчлэх шаардлагатай юу? Тийм бол яагаад"*** гэсэн асуултад 81 номын санч өөрчлөх шаардлагагүй, 37 номын санч өөрчлөх шаардлагатай гэсэн боловч ***номын сангийн бүртгэлийн шинэчлэлд таны оруулах санал*** гэсэн хэсэгт шинэчлэх хэрэгтэй гэсэн боловч ямар бүртгэл юуг, яаж сайжруулах тухай тодорхой гаргаж чадаагүй байв. Тодорхой байсан саналуудаас дурдвал:

НОМЫН САНЧ 2023/01


28

нэр хэрэгцээтэй гэж үзэх уншигчийн тоог авч болохоор өөрчлөх" гэсэн саналуудыг тус тус гаргажээ.

Бүртгэл маягтуудын талаарх номын санчдын ойлголт сул, хэрэглээ бага байгаагийн нэг шалтгаан бол сумдын соёлын төвийн номын санчид бөгөөд санал асуулгын хэсэгт *"Хөдөөгийн номын санч нэг хүн дундаа Соёлын төвийн номын санчид Соёлын төвийнхөө нярав, номын санч, бичиг хэрэг, соёлын төвийн ажилтан гээд бүгдийг хийж байна. Иймээс бүртгэл хөтлөх цаг олддоггүй"* гэсэн бол *"Бүртгэлүүдийг аймгийн төв, сумдын номын санчдад өөрчлүүлж, газар дээр заах, зааварчилгаа өгөх"* гэсэн саналуудыг тус тус гаргажээ.

Энд номын сангийн бүртгэлүүдийн талаар ярьж байгаа боловч номын сангийн мэргэжлийн боловсон хүчний асуудал давхар хөндөгдөж байна. Орон нутагт мэргэжлийн боловсон хүчин дутмаг байгааг анхаарч үзүүштэй. Сүхбаатар аймагт 37 номын санч ажиллаж байгаагаас 11 хүн л мэргэжлийн байна. Энэ 11 дотроо өдрийн анги төгссөн хүн цөөн. Ихэнх нь эчнээ, курсээр төгссөн байна.

Энэ нөхцөлд бүртгэлийг үнэн зөв бичих, статистик тоо баримт бодитой гарах тухай бодох ч хэрэггүй юм. Сургалт явсан соёлын төвийн болон бусад номын санчид тогтвортой ажиллахгүй байгаа нь дээр дурдсан ажлын ачаалал, төсөвгүй хуваарилал, цалин хангамжаас үүдэж байгаа нь тодорхой.

Уг судалгаа хийж явахдаа бүртгэл маягтын хэрэглээ ямар түвшинд байгааг, өнөөгийн нөхцөл байдалд нийцэж буй эсэхийг тодруулахыг зорьсон бол судалгааг нэгтгэх явцад нэн яаралтай шинэчлэх хэрэгцээ шаардлагатай байгаа нь тогтоогдлоо.

Ингэхдээ цахим хэрэглээ, программ хангамжтай уялдуулан хөгжүүлбэл нэн таатай болох нь судалгаанд хамрагдагсдын санал хүсэлтээс тодорхой харагдаж байна.

НОМЫН САНЧ 2023/01

ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

Батлагдсан төсвийн хүрээнд / 204,228.30 ₮/ үйл ажиллагаа явуулж, төсвийн тогтвортой байдал, ил тод, үнэн зөв байдлыг ханган, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

Хүний нөөцийг чадавхижуулсан байдал (сургалт, семинар, урамшуулал)

Аймгийн номын санчдын шинэчилсэн судалгааг авахад нийт 37 номын санч ажиллаж байна. Үүнд: Сумдын соёлын төвд-12, ЕБС-т 12, Баруун-Урт ЕБС-4, МСҮТ-1, АННС-8, 11 хүн буюу 30%-нь мэргэжлийн номын санч байна.

Байгууллагын 2023 оны сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах чиглэлээр төлөвлөн ажиллаж, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд ажилтан, албан хаагчдад нийт 8572000 төгрөгний хоолны мөнгө олгож, дархлааг дэмжиж витаминжуулалтанд 363.400 төгрөг, тооллогоны үеэр нэг удаагийн хамгаалах хэрэгсэлд 167.000 төгрөг зарцуулсан байна. Ажилтан, албан хаагчдын ажлыг дүгнэж урамшуулан 17814950 төгрөг олгож, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж өрөө, тасалгаа бүрт халаагч тень, уншигчийн ширээ сандал нэмж авч уншигчдын ая тухыг ханган ажиллаж байна.

Монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулж баталж, байгууллагын цахим хуудсаар үйл ажиллагаатай

холбоотой мэдээлэл, аппиш, хөтөлбөр, удирдамжийг кирилл, монгол бичгээр бичиж, байгууллагын гаднах хаяг болон өрөө тасалгааны хаягийг хос бичгээр шинэчлэн, захирлын тушаал болон албан бичгийг хос бичгээр хөтлөн явуулж байна.

Байгууллагын захирлын 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/40 тоот тушаалаар долоо хоног бүрийн мэдээллийн цагийн дараа "Үндэсний бичгийн уншлагын

өдөр, цаг"-тай болж, ажилтан, албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэн ажиллаж байна. “Хүмүүн бичиг” сонинг тогтмол захиалж бүх нийтэд монгол бичгийг сургах, нийтийн хэрэглээ болгох талаар тогтмол сурталчилж ирсэн.

Номын санч, мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулж хөгжүүлэх, цахим технологийн ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор "Мэдээллийн боловсрол ба цахим хэрэглээний ач холбогдол" номын санчдын нэгдсэн сургалтыг сум, сургуулийн номын санч, мэдээллийн ажилтнуудын дунд 2023 оны 03 сарын 22-ны өдөр зохион байгуулж, сургалтанд Монголын номын сангуудын консерциумын гүйцэтгэх захирал, Super Jump сургалтын ОУ-ын III зэргийн мастер, оюуны дасгалжуулагч багш, МУБИС-ийн номын сангийн дарга, Соёл, урлагийн газрын ахлах мэргэжилтэн НТБТ-ийн иргэний боловсролын багш нар илтгэл тавьж оролцсон. Уг сургалтаар "Цахим орчны боломжуудыг ашиглан бүтээмжээ нэмэгдүүлэх нь", "Мэдээллийн боловсрол", "Өөртөө суулгах 8 дадал, “Цахим соёл", "Монгол бичгийн кимо хөрвүүлэгчийг хэрхэн ашиглах", "Номын танилцуулга хийхэд ашиглах программ, хэрхэн хийх" талаар сургалт өгч,   2022 оны тайлангийн дүгнэлт болон цаашид анхаарах асуудал, номын сангуудын спортын наадам зохион байгуулах талаар ярилцсан.

МУ-ын Засгийн газраас зохион байгуулсан Төрийн албан хаагчдад зориулсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, түүний эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ын цахим болон танхимын сургалтанд 8 албан хаагч хамрагдаж, сертификат авсан.

Байгууллагын нийт албан хаагчид угийн бичгээ хөтөлсөн бөгөөд 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд угийн бичгийн бичиглэлийг баяжуулах, зураглалыг сайжруулах уралдааныг явуулахад номын санч А. Цэцэгмаа, Ө. Хонгорзул, С. Байгальмаа, бичиг хэрэг, архивын ажилтан Х. Сонинчимэг нар шалгарсан.



1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд өсвөр насны хүүхэд, залуучуудыг холбогдохоос урьдчилан сэргийлэх
2. “Соёл урлагийн салбарын албан хаагчдыг чадавхижуулах сургалт”
3. “Жендэрийн мэдрэмжтэй харилцаа холбоо”
4. “Хил хязгааргүй номын сан” төслийн сургалт
5. “Төрийн албаны шинэтгэл”
6.СУГ-аас зохион байгуулсан Соёлын албан хаагчдыг чадавхжуулах сургалт
7.“Манлайлал” сургалт /7/4/10/
8. “Байгууллагын дэргдэх эцэг эхийн зөвлөлийн сургагч багш” бэлтгэх сургалтанд хамрагдаж, Сертификат авсан.
8.Эмийн зохистой хэрэглээ ба түүний үр дагаврын талаарх сургалт
9.Төрийг албаны зөвлөлөөс Төрийн албан хаагчдад зориулсан сургалт
10. ХАБЭА-н сургалт
11.Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт
12.Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ
13.Цахим аймаг
14.Үндэсний номын сангаас зохион байгуулсан Орон нутгийн номын санчдын цахим сургалт-2023
15.Дижитал номын сангийн систем
16.Төрийн цахим үйлчилгээ
17.“Mongolian library update-2023”
18.Манлайлал” сургалт /7/4/10/сургалт
19.Төрийн албаны шинэтгэл-5ш” Сургалт
20.Хүний нөөцийн чиглэлээр
21."Бүх нийтийн соёлын боловсрол" анхан шатны сургалт

22. Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн “Бүтээлч залуус” уулзалт, зөвлөгөөнд нийт ажилтан, албан хаагчид хамрагдсан.








БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:
“НОМЫН САНГУУДЫН СПОРТЫН XIY ДЭХ НААДАМ”

Аймгийн соёлын байгууллагуудын спортын наадамд амжилттай оролцож, Хошой алтан медаль хүртсэн ба Монголын номын сангуудын консерциумаас жил бүр номын сан, мэдээллийн төвүүдийн хамтын ажиллагааг дэмжих, номын санчдыг чадавхжуулах, хөгжүүлэх зорилгоор зохион байгуулдаг “Номын сангуудын спортын XIY дэх наадам” Сүхбаатар аймагт 2023 оны 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж, Завхан, Ховд, Орхон, Дундговь, Төв, Хэнтий, Сүхбаатар аймгууд, МНСК, Дотоод хэргийн их сургууль, Батлан хамгаалах их сургууль, ЕБС-ын холбоо зэрэг 200 гаруй тамирчид оролцож, багийн дүнгээр:

Тэргүүн байр: Завхан аймаг
Дэд байр: Ховд аймаг
Гутгаар байр: Сүхбаатар аймаг эзэлсэн.

Байгууллагын үйл ажиллагааг Үндэсний олон нийтийн телевиз болон орон нутгийн BBS телевизээр 5 удаа сурталчилсан.

Соёл, урлагийн газрын дэргэдэх Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл 2023 оны ээлжит хурлыг хийж, уг хурлаар хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон бусад асуудлыг хэлэлцэж баталсан бөгөөд байгууллагын залуучуудын зөвлөлийн дарга, гишүүд оролцсон.

Зарлан мэдээллийн дохиогоор бүх нийтийн дадлага, сургуулилтад ажилтан, албан хаагчид хамрагдаж, барилга байгууламжаас гарч, өөрсдийн аюулгүй байдлаа ханган идэвхитэй оролцсон.

ХАБЭА-н ажлын хүрээнд цахилгааны шийд, гэрлийг сольж, унтраалга шинэчлэн, танхимуудын цонхнууд болон хаалга, цонхонд дулаалгыг хийж, хаалганы бариулыг шинэчлэн солх ажлыг хийсэн.

Жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласны дагуу аймгийн 4.5 дугаар тойргийн зам, Тэрбум модны хүрээнд Амгалан хошуунд 100 мод нэмж тарьж, усалж тордон, нийтийн эзэмшлийн хуваарьт газар болон ХЖТ-ын зүүн талын талбайг тогтмол цэвэрлэсэн.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. ТАЙЛАНГЫН БҮТЭЦ, ТОВЧ АГУУЛГА
3. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ
4. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ
5. ЛАВЛАГАА НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
6. НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
7. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
8. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
9. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ
10. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ
11. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА
12. ХАВСРАЛТ /ЗУРАГ, СХЕМ, ДИАГРАММ/

2. ТАЙЛАНГЫН БҮТЭЦ, ТОВЧ АГУУЛГА

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь 2023 онд

- Алсын хараа: Номын сан хөгжлийн хөтөч
- Эрхэм зорилго: Шинэ технологи, шинэлэг аргачлалыг нэвтрүүлж жишиг мэдээллийн төв болно.

Нийт ном 41000 | Уншигчид 22233 | Шинэ уншигч 1717 | Цахим ном 400

Ном олголт 31942 | Сэтгүүл 1 | Сонин 4

Жилийн болон улирлын ажлын төлөвлөгөөг “Алсын Хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Соёлын яамны 2021-2024 стратеги төлөвлөгөөтэй

уялдуулан, Засгийн Газрын 100 дугаар тогтоолын хүрээнд боловсруулж, Сэлэнгэ Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажил арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлж бодлогын баримт бичгийн хэрэгжилт 90%, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх үйл ажиллагаа 87.6% гүйцэтгэлтэй үнэлэгдэж, үр дүнтэй ажиллалаа.

Уншигч хэрэглэгчдэдээ ном унших таатай орчин бүрдүүлэх, тэдэнд уншлага үйлчилгээг хүргэх, соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, номын сангийн уламжлалт үйлчилгээг төгөлдөршүүлэх, шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх ажлуудыг хэрэгжүүлж, шинээр үүсэн буй болж байгаа цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлж байна.

Ажилтан албан хаагчдад Алсын Хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Соёлын салбарын шинэ сэргэлтийн бодлого төлөвлөлтийг танилцуулж сурталчлан таниулах ажлыг улирал тутам зохион байгуулж, бодлого төлөвлөлтийн шинэчлэлтүүдийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.

Номын сангийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж Захиргаа аж ахуй, Арга зүй мэдээлэл, Уншлага үйлчилгээний гэсэн 3 хэлтэс болон үйл ажиллагааны уялдаа холбоо, ажлын чиг үүргийн ялгарал холбоо хамаарлыг тодорхой болгон ажлын чиг үүргүүдийн шинэчлэн зохион байгуулав.

Ажиллагсдын “Нийгмийн баталгаа” хөтөлбөрийн хүрээнд ажилтанд амьдралын нөхцөлөө сайжруулах, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, гэр байшингаа тохижуулах ажилд нь дэмжлэг үзүүлэн тус бүр 1-14 хоногийн цалинтай чөлөөг олгож, 0-12 насны хүүхэдтэй ээжүүдэд гэрээр ажиллах, богиносгосон цагаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн, улиралын урамшуулалыг зохих хувиар тогтмол олгож , байгууллагын эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн зохион байгуулж, ажиллагсдын ажиллах таатай орчинг бүрдүүлэн ажиллалаа.

Номын сан нийгмийн сайн сайхан байдлын төлөө “Ногоон орчин” бий болгох, зам талбайгаа цэвэрлэх иргэдэд ээлтэй таатай орчин бүрдүүлэх мод цэцэг тарих ажлыг тогтмол зохион байгуулж ирлээ.

Номын санг мэдээлэл хөгжлийн төв болгох зорилгоор Дэлхийн Зөн ОУ-ын байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт болон иргэд албан байгууллага аж ахуйн нэгжүүдэд зориулсан хүний хөгжлийн сургалтуудыг 18 удаа зохион байгуулж, хүүхэд хамгаалал, хүний эрхийг хамгаалах чиглэлээр үлгэрлэн ажилласан.

3. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Соёлын өвийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх сурталчлах, иргэд аж ахуй нэгжтэй хамтран ажиллах, зөвлөмж, зөвлөгөө өгөх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх ажлыг Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт номын санч нарыг хамруулан ажиллаж байна.

Монгол болон Гадаадын уран зохиолын 5200 ном хэвлэлд гаралтын мэдээний судалгаа авч дүгнэн номын үзэсгэлэнг 6 удаа, 600 номоор 8 номзүйн бичилт хийж 2300 уншигч хэрэглэгчдэд үйлчилсэн. Фондын ховор ном болон бусад шинжлэх ухааны ном, хэвлэлийг сурталчлах, судалгааны эргэлтэнд оруулах, хувь хүмүүсийн гар дээр байгаа ховор ном бүтээлийг илрүүлэх, сан хөмрөгийн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулсан.

- Соёлын өвийг хамгаалах орон нутгаас нээн илрүүлэх ажлын хүрээнд багийн дарга нартаа хамтран хувь хүн, байгууллагад хадгалагдаж байгаа шинжлэх ухаан болон бусад салбарын үнэт ховор ном, гар бичмэл материалын судалгаа хийсэн.
- Фондонд хадгалагдаж буй ховор ном, судар болон бусад шинжлэх ухааны номуудыг эргэлтэнд оруулж нийтийн уншлагын танхимаар үзэсгэлэн гаргаж ном олголтыг нэмэгдүүллээ.

Халгалалт хамгаалалт :

Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 3,2,6-д заасны дагуу ном хэвлэлийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, урагдаж гэмтсэн 56 ширхэг номонд сэлбэн засалт хийв. Номын сангийн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын стандартыг сахиж, хөмрөгийг физик, хими болон биологийн шинж чанарын өөрчлөлтөөс үүсдэг шавьж хорхойноос хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ном ариутгагч төхөөрөмжийг ашиглан сар бүрийн 25-нд 50ш ном ариутгаж нийт 250ш ном ариутгасан байна. Ном хэвлэлийг хуурайшилтаас хамгаалах зорилгоор агаар чийгшүүлэгчийг байнга ажиллуулж байна.

Мөн хортон шавьж үүрлэхээс сэргийлэх төрөл бүрийн хор болон ариутгалын хлорамины 2%-ийн уусмалыг бэлтгэн тавиур болон номыг арчиж,ариутган чийгтэй цэвэрлэгээг улиралд нэг удаа хийж байна.

Үндсэн фондын төрөл анги болон шинжлэх ухааны номын ялгагч, тавиур болон хадгалагдаж буй баримтуудын нийт 120 ширхэг ялгагчуудыг бүрэн сольж шинэчлэн, сайжрууллаа.

Монголын язгуур урлагийн нэгэн онцгой төрөл болох туульсын гарал үүслийг танилцуулах ажлыг цаасан болон цахим хэлбэрээр зохиол бүтээлийг цувралаар уншигчдад сурталчлан таниулах ажил 12 удаа хийж 60 ширхэг гарын авлага бэлтгэн иргэдэд танилцууллаа.

Номын үзэсгэлэн :

Үзүүлэн таниулах ажил 6 удаа 667 зохиол бүтээл, 1 сонсдог сонгодог зохиол бүтээлээр нийт 1000 гаруй иргэдэд үйлчиллээ.

“Соёлын сэргэлт 2023“ Соёлын байгуулагуудын хамтарсан нээлттэй үзэсгэлэн, хэлэлцүүлэгт үеэр 120 гаруй зохиолоор үзэсгэлэн гаргаж иргэдэд үйлчиллээ.

Улс орон даяар нийтээр зохион байгуулагддаг “ Номын баяр “ нэгдсэн арга хэмжээний Сэлэнгэ аймгийн хэмжээнд өргөн цар хүрээтэй нэгэн зэрэг тэмдэглэн өнгөрүүлж, фондноос 80 бусад танхим нийлсэн 400 гаруй зохиол бүтээлийг танилцуулан олон талт арга хэмжээ зохион байгууллаа.

Нийтийн номын сангаас “ Илүү их уншья” уриатай номын өдөрлөг Партизаны талбайд зохион байгуулагдаж үндсэн фондноос ховор ном, судар болон Сэлэнгэ аймгийн зохиолчдын нийт 86 ширхэг уран бүтээлийг иргэдэд сурталчлан ажиллаа.

Сүхбаатар сумын Г.Бумцэндийн нэрэмжит 1 дүгээр сургуулийн нийт багш, сурагчдад “Номын баяр” арга хэмжээний хүрээнд уран зохиол, шинжлэх ухаан, түүх, танин мэдэхүйн нийт 100 гаруй ном зохиолоор үзэсгэлэн гаргаж номын сангийн үйл ажиллагааг сурталчлав.

УИХ-ын гишүүн Ч.Ундрамын санаачлагаар Сэлэнгэ аймагт анх удаа зохион байгуулсан “Шинжлэх ухааны бүтээл” уралдааныг дэмжин ажиллаж шинжлэх ухаан, хувь хүний хөгжлийн 120 гаруй зохиол бүтээлээр үзэсгэлэн гаргаж 250 сурагчдыг хамрууллаа.

Бусад ажил

Байгууллага хамт олноороо хос бичигтэн болох зорилго тавин Монгол бичгийн сургалтанд сууж бичих унших чадвараа хөгжүүллээ.Мөн аймгийн онцгой байдал улаан загалмайн хамтарсан сургалтан сууж мэдээлэл авлаа.

Загвар номын сангийн ажлын хүрээнд Аргазүйч, мэдээллийн ажилтантай хамтран 5-р сургуулийн номын санд ажиллаж фонд зөв зохион байгуулалт, номонд техник ажиллагаа хийлээ

Санамж өгөх номзүйг хөдөө аж ахуйн чиглэлийн номоор “Хүнсний ногоо,жимс жимсгэнэ” сэдэвтэй бэлтгэн гаргаж номын сангаар үйлчлүүлж буй уншигчдад

танилцуулж байна. Үндсэн фондын төрөл ангийн номын ялгагчийг шинэчлэн сольж дуусгав. Үндсэн фонд нь номын баяжилт байнга хийж байгаа тул тавиурын багтаамжийг нэмэгдүүлэх, номын өсөлтөнд анхаарч нөөц тавиурын талбай, байрлалтанд анхаарч зөв зохион байгуулах ажлыг хийж байна.

4. **НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ**

Сэлэнгэ аймгийн иргэдийг ном хэвлэлээр хангаж, уншлага үйлчилгээний чанарыг сайжруулах, ном олголтын хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл олон нийтийн ажлыг тогтмол зохион байгуулах зорилго тавин ажиллаж байна.

Уншлагын танхимаар үйлчлүүлж байгаа сургуулийн өмнөх болон 1-12 ангийн сурагчид, иргэд олон нийтийн уншлагын чанарыг сайжруулах, шинэ уншигч, ирэгсэд, ном олголтыг нэмэгдүүлэх, Соёл олон нийтийн ажлуудыг өргөн хүрээнд хамруулан зохион байгууллаа.

Уншлага үйлчилгээ

2023 оны жилийн эцэст 1721 шинэ уншигч, 23029 ирэгсдэд 35589 ширхэг ном хэвлэлээр үйлчиллээ. Уншигчдад өдөр тутмын тогтмол хэвлэл болон шинэ мэдээ мэдээллээр үйлчилж байна.

Номын сангийн өдөр тутмын бүртгэл, сонин сэтгүүлийн бүртгэлүүдийг стандартын дагуу бүртгэж, номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 3.2.6-д заасны дагуу ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд уншигчдын гар дээр уншигдаж байх явцад урагдаж гэмтсэн болон ярлык, уут, формуляр нь алга болсон 576 ширхэг номонд сэлбэн засалт хийв. Өгөгдсөн номзүйн лавлагааг 592 хүнд өгч, татгалзлыг 80 хүнд өгсөн. Уншигчдад өгсөн татгалзлын дагуу шинээр нөхөн бүрдүүлэх ном хэвлэлийн бүтээгдэхүүнийг бүрдүүлж фондын хүрээ хүртээмжийг нэмэгдүүлсэн.

Зөөврийн номын сангийн үйлчилгээ нь Номын сангийн үйлчилгээний хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх үр дүнг чанаржуулах зорилго тавин ажиллаа. 2023 оны 01-р сарын 02-оос 12-р сарын 28-ны байдлаар тусгай чиг үүргийн байгууллага болох Хилийн цэргийн 0243 анги , Хилийн цэргийн 0101 анги ,ШШГГ,ЕБ-ын 5-р сургууль, МСҮТ Алтанбулаг сумын соёлын төв,СБ сумын Баянханы 4-р Бор гүвээ 5-р удирдлагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллаа

Зөөврийн номын сан нь 2023 оны 01-р сараас 11 сарын 30 хүртэлх хугацаанд ГНОТ-аас 71 удаа 1340 ном, фондоос 11 удаа 82 ном, ХУТ-аас 17 удаа 308 ном авч хамтран ажиллаа. Зөөврийн номын үйлчилгээг тусгай чиг үүргийн байгууллагад 36 удаа 167 /шинэ уншигч/ 962 ирэгсэд 1620 ном олголт 14 шинэ уншигч /хүүхэд/ 13

ирэгсэд /хүүхэд/ 27 ном олголт нийт 1156 уншигчид 1647 ном олголт мөн ЕБ 5-р сургууль МСҮТ- 24 удаа 92 шинэ уншигч, 228 ирэгсэд 400 ном олголт 300 шинэ уншигч /хүүхэд/ 541 ирэгсэд /хүүхэд/ 997 ном олголт нийт 1161 уншигчид 1397 ном олголт Алтанбулаг сум,СБ-сумын алслагдсан Баянханы 4-р баг,Бор гүвээ 5-р багийн иргэдэд 14 удаа 67 /шинэ уншигч/ 181 ирэгсэд 301 ном олголт 50 шинэ уншигч /хүүхэд / 57 ирэгсэд /хүүхэд/ 111 ном олголт нийт 355 иргэнд 412 ном олголт хийн үйлчиллээ.

Тусгай чиг үүргийн байгууллагууд,ЕБС,МСҮТ, СБ-сумын алслагдсан 4,5-р багт нийт 74 удаа, 2672 уншигчид 3456 ном олголт хийн тус тус үйлчиллээ Зөөврийн номын сангийн үйлчилгээ нь Номын сангийн үйлчилгээний хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх үр дүнг чанаржуулах зорилго тавин ажиллалаа. 2023 оны 01-р сарын 02-оос 11-р сарын 30-ны байдлаар тусгай чиг үүргийн байгууллага болох Хилийн цэргийн 0243 анги , Хилийн цэргийн 0101 анги, ШШГГ, ЕБ-ын 5-р сургууль, МСҮТ СБ сумын Баянханы 4-р Бор гүвээ 5-р удирдлагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллалаа

Зөөврийн номын сан нь 2023 оны 01-р сараас 11 сарын 30 хүртэлх хугацаанд ГНОТ-аас 66 удаа 1262 ном, фондоос 11 удаа 82 ном, ХУТ-аас 16 удаа 305 ном авч хамтран ажиллаа. Зөөврийн номын үйлчилгээг тусгай чиг үүргийн байгууллагад 34 удаа 163 /шинэ уншигч/ 898 ирэгсэд 1535 ном олголт 14 шинэ уншигч /хүүхэд/ 13 ирэгсэд /хүүхэд/ 27 ном олголт нийт 1088 уншигчид 1562 ном олголт мөн ЕБ 5-р сургууль МСҮТ- 21 удаа 92 шинэ уншигч, 204 ирэгсэд 361 ном олголт 300 шинэ уншигч /хүүхэд/ 523 ирэгсэд /хүүхэд/ 974 ном олголт нийт 1119 уншигчид 1335 ном олголт СБ-сумын алслагдсан Баянханы 4-р баг, Бор гүвээ 5-р багийн иргэдэд 14 удаа 67 /шинэ уншигч/ 181 ирэгсэд 301 ном олголт 50 шинэ уншигч /хүүхэд / 57 ирэгсэд /хүүхэд/ 111 ном олголт нийт 355 иргэнд 412 ном олголт хийн үйлчиллээ.

Тусгай чиг үүргийн байгууллагууд,ЕБС, МСҮТ, СБ сумын алслагдсан 4,5-р багт нийт 69 удаа, 2562 уншигчид 3309 ном олголт хийн тус тус үйлчиллээ

Соёл олон нийтийн ажлын хүрээнд:

Иргэд олон нийтэд бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор уншлагын танхимуудаас дараах ажлыг зохион байгууллаа.

41 зорилтын хүрээнд 192 соёл олон нийтийн ажил арга хэмжээ зохион байгуулж танхимаар 8395, цахимаар 40488, нийт 48883 хүүхэд багачууд, иргэд хамрагдсан. Үүнд:

Зохиолч- Уншигчдын уулзалтанд 260 хүн хамрагдав.

- СГЗ зохиолч Б.Шүүдэрцэцэг
- СГЗ зохиолч Б.Пүрэвдорж

- МЗЭ-ийн шагналт зохиолч Э.Амарзаяа
- "Анар" номын дэлгүүр
- "Amarzaya's book"-хэвлэлийн газар

"White House" хэвлэлийн газрууд оролцож зохиол бүтээлийн дээжсээ уншигчидтайгаа хуваалцахын сацуу зохиолч уншигчдын хооронд халуун яриа өрнүүлсэн уулзалт ярилцлага, номын сэтгэгдэл хуваалцах, гарын үсэгтэй хямдралтай номын худалдааг тус тус амжилттай зохион байгуулагдлаа.

"Соёл урлагийн байгууллагатай танилцах аялал-Мэргэжил сурталчлах өдөрлөг"-т 18 сурагчид хамрагдлаа.

Соёл урлагийн байгууллагууд болох Нийтийн номын сан, АДБ-н Сэлэнгийн долгио чуулга, Нэгдсэн Музейн мэргэжлийн албан хаагчдын ажлын онцлог, үйл явц үйл ажиллагааны талаар мэргэжил сурталчлах аялалыг Сүхбаатар сумын Хүүхдийн зөвлөлтэй хамтран соёл урлагийн чиглэлээр суралцах хүсэлтэй ЕБ-ын 1, 2, 3, 4, 6 сургуулийн 10-12 ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Зохион байгуулсан ажлууд:

Сэлэнгэ аймаг нийтийн номын сангийн уншлагын танхим болон бусад нарийн мэргэжил, үндсэн фонд, аргазүй мэдээллийн танхим, удирдлагын өрөөтэй танилцаж, Аргазүйч Т.Нарандалай өөрийн ажлын туршлага, дурсамжаас хуваалцлаа.

АДБ-ийн Сэлэнгийн Долгио чуулга-ийн дууны ангийн дасгал сургуулилт, бүжиг ангийн бүжгийн мэндчилгээ, хөгжим ангийн хөгжмийн зэмсгүүдийг үзэж сонирхож, захиргаа, тайзны арын болон гэрэлтүүлгийн хэсгийн ажилтан, ажлын байртай танилцлаа.

Сэлэнгэ Аймгийн Нэгдсэн Музейн сан хөмрөг үзвэрийг үзэж Музейн бүртгэл мэдээллийн ажилтан Д.Наранчимэг "Музейн ажилтан гэж хэн бэ" сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн ажилтнуудын үүрэг оролцооны талаар мэдээлэл өглөө.

"Зохист аялгуу-2023" хүүхдийн богино өгүүллэгийн наадам

Хүүхдийн богино өгүүллэгийн наадамд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1,2,3,5,6 дугаар сургууль болон Алтанбулаг, Орхон сумууд, Дулаанхан, Бугант, Номгон, Рашаант тосгоны сургуулиудаас 1-ийн давaанд шалгаран ирсэн 23 авьяаслаг сурагчид өөрийн бичсэн богино өгүүллэгээ уншин сонордуулснаас:

Тэргүүн байранд: Сүхбаатар сумын УТ-ний 2 дугаар сургуулийн 12а ангийн сурагч М. Намуун Ирээдүйгээс ирсэн захидал, Зовлонгоор чинь нэг жаргаад үзье

Дэд байранд: Сүхбаатар сумын УТ-ний Г. Бумцэндийн нэрэмжит 1 дүгээр сургуулийн 6д ангийн сурагч М. Энгүүн Эх орны тухай үлгэр, Цасан хүн

Гутгаар байранд: Сүхбаатар сумын УТ-ний Г. Бумцэндийн нэрэмжит 1 дүгээр сургуулийн 11в ангийн сурагч Б. Наранхүү Өөрийгөө өөрчилсөн буухиа, Ганц онооны мөн чанар ,

Тусгай байранд: Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын 7а ангийн сурагч А. Амарзаяа Од, Миний найзын гэр

Тусгай байранд: Алтанбулаг сумын Б.Ренчины нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн 5в ангийн сурагч О. Лхагва-Эрдэнэ Миний эмээ, Аав

Үндэсний бичиг үсгийн баяр-2023 ажлын хүрээнд 3 ажил арга хэмжээ зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангаас Боловсрол Шинжлэх Ухааны газартай хамтран Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, үндэсний бичиг үсгийн баярыг үндэсний хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх зорилгоор үндэсний бичиг үсгийн баярыг “ҮНДЭСНИЙ БИЧИГ-ӨВ СОЁЛ" уриан доор амжилттай зохион байгууллаа. Сүхбаатар сумын төрийн албан хаагчдын дунд уралдаануудыг зохион байгуулсан.

Тус арга хэмжээний хүрээнд Сүхбаатар сумын төрийн албан хаагчдын дунд

“Шилдэг үндэсний өв тээгч” зөв цэвэр бичигтэн

“Шилдэг үндэсний бичиг үсэг сонордуулагч” түргэн тод уншигч

“Шилдэг үндэсний өв соёлоо эрхэмлэгч байгууллага шалгаруулах уралдаануудыг зохион байгуулж нийт 14 байгууллагын 27 албан хаагчид оролцлоо.

“Шилдэг үндэсний өв тээгч” зөв цэвэр бичигтэнээр Хилийн цэргийн 0101 ангийн Ахлах шалгагч Л.Оюунжаргал.

“Шилдэг үндэсний бичиг үсэг сонордуулагч” түргэн тод уншигчаар Хилийн цэргийн 0243-р ангийн Санхүүгийн албаны дарга Б.Баяржаргал.

“Шилдэг үндэсний өв соёлоо эрхэмлэгч байгууллага”-аар Сүхбаатар сумын Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хамт олон шалгарлаа.

Үндэсний бичиг соёл номын өдрүүд- Номын баяр-2023 арга хэмжээнд 2 зорилтын хүрээнд 18 ажил арга хэмжээнд 1495 иргэд хамрагдав.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” арга хэмжээг Сэлэнгэ аймгийн хэмжээнд 3 дахь удаагаа зохион байгууллаа. Номын баярыг Монгол Улсын Их Хурлын гишүүн Ч. Ундрам, Сэлэнгэ аймгийн тамгын газартай хамтран зохион байгуулсан. Нийт 9 төрлийн уралдаан тэмцээн, арга хэмжээнд 695 хүүхэд багачууд, эцэг эхчүүд хамрагдсан. Арга хэмжээний хүрээнд:

1. Сэлэнгэ аймгийн нийт сум, сургууль, байгууллага нарын номын санчдын дунд “Номын сангийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сургалт

2. Сайхан сумын 2-р сургуулийн Ш. Ариунаа багштай 10а ангийн “Уран бичлэгийн үзэсгэлэн” худалдаа
3. “Цахим ертөнц” номын худалдаа
4. Номын санч нарын дунд зохион байгуулагдсан “Бүтээлчээр ном урлая” уралдааны үзэсгэлэн
5. “Билгийн дээд” номын үзэсгэлэн
6. Ном солилцоо, хуучин номын худалдаа
7. “Үлгэрийн баатрууд амилсан нь” нэгдсэн парад зохион байгуулагдсан.
8. Сурагчдын мэндчилгээ
Номын баярын хүрээнд зохион байгуулагдсан уралдаануудын шагналыг гардуулсан.1.Тэргүүний уншигч байгууллагаар Сүхбаатар сумын 4-р багийн дарга Т. Мөнхтуяа
2. Шилдэг соёлын төвийн номын сангаар Хушаат соёлын төвийн номын сан соёлын төвийн номын санч Ж.Ганцэцэг
3. Шилдэг сургуулийн номын сангаар Сүхбаатар сумын ЕБ-ын 3 дугаар сургуулийн номын сан 3-р сургуулийн номын санч А. Байгальмаа
4. Шилдэг уншигч ангиар
• Мандал сумын ЕБ-ын 1-р сургуулийн Б.Буянчимэг багштай 8г анги
• Зүүнбүрэн сумын ЕБ-ын Э. Оюумаа багштай 10а анги
• Сайхан сумын ЕБ-ын 2-р сургуулийн Ш. Ариунаа багштай 10а анги
5. Сэлэнгэ аймгийн хэмжээнд “Тэргүүний уншигч- Нацагдорж тэмдэгтэн”-ий болзлыг хангасан сурагчдыг шалгаруулла.
6. “Шилдэг гэрийн номын сантай айл өрх” –өөр Сүхбаатар сумын иргэн И.Уламбаяр
7. Үлгэрээр хүмүүжүүлье-Үлгэр өгүүлэх уралдаанд
• Тэргүүн байранд Сүхбаатар сумын 8 цэцэрлэг
• Дэд байранд Сүхбаатар сумын 1 цэцэрлэг
8. “Бүтээлчээр урлая” ном бүтээх уралдаанд
• Хүдэр сумын ЕБС-ийн номын санч Б. Батнасан
• Сант сумын соёлын төвийн номын санч М. Жаргалсайхан
9. “Бүтээлчээр уншъя” шилдэг номын тэмдэглэл хөтлөгч сурагчаар
• Сүхбаатар сумын Г.Бумцэндийн нэрэмжит УТ-ий 1 дүгээр сургуулийн Ч.Оюунтөгс багштай 4б ангийн сурагч Б.МӨНХЦАЦРАЛ
• Сүхбаатар сумын Г.Бумцэндийн нэрэмжит УТ-ий 1 дүгээр сургуулийн Ч.Оюунтөгс багштай 4б ангийн сурагч Ч.ЭМҮЖИН
• Мандал сумын ЕБ-ын 1-р сургуулийн 8г ангийн сурагч А.Булгантамир

• ерөө сумын бугант тосгоны ебс-ийн 5а ангийн сурагч Э. Амарзаяа

Намрын номын баярыг Сэлэнгэ аймгийн хэмжээнд өргөн цар хүрээтэй нэгэн зэрэг тэмдэглэн өнгөрүүлж, хүүхдийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор нд Партизаны талбайд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж 800 иргэд олон нийт хамрагдав..

Үйл ажиллагааны хүрээнд:

1. “Номын баяр” сэдэвт гар зургийн уралдаан

• 1-3 дугаар анги

• 4-6 дугаар анги

• 7-9 дүгээр анги

• 10-12 дугаар анги гэсэн ангиллаар зохион байгуулж 71 сурагчид оролцлоо.

Дүнг 2023.09.15 нд Сэлэнгэ аймаг нийтийн номын сан хаяг дээр танилцуулах болно.

2. “Open mic” арга хэмжээ

• Хүүхэд залуус сайн дураараа шүлэг зохиол, дуу, бүжиг уран бүтээлээ чөлөөтэй хүргэж 67 сурагчид оролцлоо.

3. Задгай номын номын сан

• Нийтийн номын сангийн хүүхдийн уншлагын танхимын үйлчилгээгээр

-Монгол наадгай тоглоом

-Эвлүүлдэг тоглоом

-Хөлөгт тоглоом

-Танин мэдэхүйн тоглоом

-Зурагт номтой уншлага зохион байгуулж хүүхдэд зориулсан үйлчилгээ явууллаа.

4. Номын худалдаа

•Монгол шуудан- Internom номын дэлгүүр оролцлоо

5. Номын үзэсгэлэн

• Ховор ном судар

• Сэлэнгийн зохиолчдын номын үзэсгэлэн гаргаж танилцууллаа.

6. “Оньсон өртөө” ардын аман зохиолын арга хэмжээ

7. “Бүтээлч хүүхэд” гар урлалын бүтээл урлах болон бүтээлийн үзэсгэлэнд Жавхлант сумын ЕБ-ын сургуулийн өвлөн уламжлагч хүүхэд багачуудын хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргаж хүүхэд багачууд баримлын шавар, шүрээр урлан бүтээлээ.

8. Сэлэнгэ аймгийн Хүүхдийн зөвлөлийн асар

• Хүүхдийн зөвлөлийн үйл ажиллагааны танилцуулга

• Ном солилцоо, худалдаа

• "Ном таны хувьд" сэтгэгдэл явууллаа.

9. Сэлэнгэ аймгийн зохиолчдын асар

Номын баярын арга хэмжээг нээж яруу найрагч М.Болортунгалаг "Сувдан нулимс" шүлэг өгүүллэгийн анхны түүврээ өргөн барилаа.

10. Сэлэнгэ аймгийн МСҮТөвийн номын санч оюутан суралцагчдын хамт оролцож мэргэжлийн ном хэвлэл, элсэлтийн талаар мэдээлллийг хүүхэд залууст танилцууллаа.

Соёлын сэргэлт-2023 арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд 3 ажил арга хэмжээний хүрээнд 288 иргэд хамрагдсан.

Арга хэмжээний хүрээнд номын хотхоноо хүүхэд багачууд, эцэг эхчүүд, залуустаа хүргэн номын мэдээлэл, зуны хөтөлбөрийн танилцуулгыг сурталчлан ажилласан. Бяцхан палеонтологич, амьтдын мөр боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Соёлын байгууллагын залуучуудын зөвлөлийн төлөөллүүдийг хамруулсан "Байгальд ээлтэй урлагтай өглөө" өглөөний уулзалтад оролцож салбарын залуусын дуу хоолойгоо хүргэсэн.

Соёл урлагийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтанд хамрагдсан. Соёл урлагийн байгууллагын төлөөлөлтэй уулзалт хийж соёлын салбарын өнөөгийн нөхцөл байдал болон цаашид авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх нээлттэй хэлэлцүүлэгт хамрагдсан. 3 Арга хэмжээнд нийт 288 иргэд хамрагдсан.

"Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд 6 төрлийн арга хэмжээнд 398 сурагчдыг хамрууллаа.

Соёлын бүтээлч сарын хүрээнд хүүхэд залуус, иргэдийн дунд 6 төрлийн арга хэмжээ зохион байгуулсан. Үүнд: Байгууллагын алсын хараа эрхэм зорилго тодорхойлох сургалт, ноосон нэхмэлийн сургалт, гоо зүй хүмүүжлийн сургалт, зохист аялгуу богино өгүүллэгийн наадам, мэргэжил сурталчлах өдөрлөг, танин мэдэхүйн өртөөчилсөн аялал гэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Соёлын эрхийн бичгийн мэдээлэл өгөх сургалт мэдээллийн ажлыг 1,2,3,4,5 дугаар сургуулийн 275 сурагчид хамрагдсан. Соёлын эрхийн бичгээр Гоо зүйн сургалт, танин мэдэхүйн өртөөчилсөн аялал сургалтуудыг зохион байгуулж 123 сурагчид хамрагдсан. Нийт 398 сурагчид хамрагдсан.

"Тоглонгоо уншъя" гэр бүлийн өдөрлөгын хүрээнд 5 ажил арга хэмжээ

Тоглонгоо уншъя өдөрлөгөөр хүүхдийн ном унших хүсэл сонирхлыг эцэг эхийн дэмжлэг, үлгэр дууриалалаар бий болгох зорилгоор 5 ажил арга хэмжээ зохион

байгуулж Сүхбаатар сумын 8 багийн 110 хүүхэд багачуудад, асран хамгаалагч хамрагдсан.

- 1 дүгээр сард –

“Тоглонгоо уншъя” өдөрлөгийг 5 гэр бүлүүдийн дунд зохион байгуулж нийт 15 иргэд, хүүхэд багачууд хамрагдсан.

Өдөрлөгийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан.

1. Гэр бүлийн танилцуулга
2. Хайрын 5 хэл гэр бүл, хүүхдэд зориулсан сургалт
3. Монгол ардын үлгэрийн чанга уншлага хийж, хамтдаа зураг зурах
4. Та уурлахаараа ямар амьтан болдог вэ? 3D баримлын шавраар бүтээл хийх
5. Хайртай дотны хүмүүстээ чин сэтгэлийн сэтгэлийн захиа бичих
6. Үйл ажиллагааны сэтгэгдлээ бичих

- 3 дугаар сард-

“Тоглонгоо уншъя” өдөрлөгийг Сүхбаатар сумын 1,2,3,4,5 дугаар багийн төлөөлөл 5 гэр бүлүүдийн дунд зохион байгуулж нийт 15 иргэд, хүүхэд багачууд хамрагдсан.

Өдөрлөгийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан.

1. Хүүхэд таны толь хүүхдийн эрхийн богино бичлэг үзүүлэх
2. Монголын зохиолчдын өгүүллэг, туужаас сонгож, хамтран уншлага хийх, ярилцах
3. Дасгал/Хурдан удаан темпээр алхах
4. Аав ээжийн төлөөлөл 'Ууртай бяцхан тахиа' өгүүллэгээр чанга уншлага хийх
5. Сэтгэл мэдрэмжээ илэрхийлэх дасгал хийх
6. Номын сангийн ой тогтоолт хөгжүүлэх, алжаал тайлах тоглоомууд тоглох
7. Уншигчийн карт үнэгүй нээх

Хүүхдүүдтэйгээ хөгжилтэйгээр тоглонгоо ном уншингаа амралтын өдрийг гэр бүлээрээ үр бүтээлтэй өнгөрүүлсэн.

- 4 дүгээр сард

Сүхбаатар сумын Улсын тэргүүний 1 дүгээр сургуулийн Э. Уянга багштай 6г ангийн ээжүүд, охидууд, хөвгүүдийн дунд зохион байгуулж нийт 20 иргэд, сурагчид хамрагдсан. Арга хэмжээний хүрээнд сурагчид, ээжүүдийнхээ дунд САНХҮҮЧ ХЭРЭМ санхүүгийн боловсрол олгох цуврал номоор ээжтэйгээ найзуудтайгаа хамтран уншлага хийж ярилцаж, танин мэдэхүйн карт хосоороо таах тоглоом тоглож, ээжүүд охид хөвгүүдийн төлөөлөл Шаазгай хүү үлгэрээр уншлага зохион байгуулсан.

- 11 дугаар сард

Сүхбаатар сумын ЕБ-ын Спортын бүрэн дунд сургуулийн бага ангийн сурагчдын эцэг эхийн төлөөлөл дунд зохион байгуулж нийт 60 иргэд, сурагчид хамрагдсан. Арга хэмжээний хүрээнд сурагчид, ээжүүдийнхээ дунд САНХҮҮЧ ХЭРЭМ санхүүгийн боловсрол олгох цуврал номоор ээжтэйгээ найзуудтайгаа хамтран уншлага хийж ярилцаж, танин мэдэхүйн карт хосоороо таах тоглоом тоглож, ээжүүд охид хөвгүүдийн төлөөлөл Шаазгай хүү үлгэрээр уншлага зохион байгуулсан.

“Өвлийн хөтөлбөр-2023” ажлын хүрээнд 6 ажил арга хэмжээнд 80 сурагч, иргэд хамрагдлаа.

“Уншъя, хөгжье, урагшилъя” сурагчдын өвлийн амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилготой хөтөлбөрийг 01 сарын 05-аас 01 сарын 30 хүртэл зохион байгуулсан. Дараах сургалт дугуйлангуудыг хичээллүүлсэн. Нийт 80 сурагч, иргэд хамрагдсан.

-Ном бүтээлчээр уншиж номын тэмдэглэл хөтлөх дугуйлан

-Номын сэтгэгдэл ярилцах дугуйлан

-Урлан бүтээх дугуйлан

-Англи хэлний анхан шатны сургалт

-Орос хэлний анхан шатны сургалт

-Монгол бичгийн анхан шатны сургалтыг тус тус зохион байгуулж Ерөнхий боловсролын сургуулийн 1-7 ангийн нийт 62 сурагч, 12 төрийн албан хаагч хамрагдсан.

Ном бүтээлчээр уншиж номын тэмдэглэл хөтлөх дугуйлан

Номын тэмдэглэл бүтээлчээр хөтлөх дугуйланг Ерөнхий боловсролыг сургуулийн 1-5 ангийн 17 сурагчид хамрагдаж номын тэмдэглэл хөтлөх арга аргачлалаас суралцаж, зөв бичих, зурах, ном унших, бүтээлч чадваруудаа хөгжүүлэн амралтын хугацаагаа үр бүтээлтэй өнгөрүүллээ. Нийт хамрагдсан сурагчдад талархал гардуулан өгсөн.

Номын сэтгэгдэл ярилцах дугуйлан

Ерөнхий боловсролыг сургуулийн 1-5 ангийн 13 сурагчид хамрагдаж уншсан номоо үе тэнгийн найзуудтайгаа хуваалцаж, өөрийгөө илэрхийлэх, төсөөлөн бодох, ярих чадваруудаа хөгжүүлэн амралтаа үр бүтээлтэй өнгөрүүллээ. Нийт хамрагдсан сурагчдад талархал гардуулан өгсөн.

Англи хэлний анхан шатны сургалт

Англи хэлний анхан шатны сургалтыг МУБИС-ийн 3р дамжааны оюутан Б. Анударь дадлагажигч багш удирдан зохион байгуулж Ерөнхий боловсролыг сургуулийн 4-7 ангийн 15 сурагчид хамрагдаж англи хэлний анхан шатны хичээлийг

судлан, англиар унших, бичих, ярих, дуулах чадваруудаа хөгжүүлэн амралтаа үр бүтээлтэй өнгөрүүллээ. Нийт хамрагдсан сурагчдад талархал гардуулан өгсөн.

Орос хэлний анхан шатны сургалт

Орос хэлний анхан шатны сургалтыг МУБИС-ийн 3р дамжааны оюутан Б. Анударь дадлагажигч багш удирдан зохион байгуулж Ерөнхий боловсролыг сургуулийн 4-9 ангийн 10 сурагчид хамрагдаж орос хэлний анхан шатны хичээлийг судлан, оросоор унших, бичих, ярих, дуулах чадваруудаа хөгжүүлэн амралтаа үр бүтээлтэй өнгөрүүллээ. Нийт хамрагдсан сурагчдад талархал гардуулан өгсөн.

Монгол бичгийн анхан шатны сургалт

Монгол хэл уран зохиолын Ц.Эрдэнэтуяа багшаар монгол бичгийн анхан шатны хичээлүүдийг Нийтийн номын сангийн мэргэжлийн 12 албан хаагчид хос бичигтэн хамт олон болох зорилт тавин суралцаж унших, бичих, ярих чадвараа ахиулан хичээллэж хамрагдсан.

Урлан бүтээх дугуйлан

Урлан бүтээх дугуйланг Номзүйч Ц. Гэрэлцэцэг, С. Шинэчимэг багш нар удирдан зохион байгуулж шүрээр төрөл бүрийн гоёлууд урлах болон хос зүү, дэгээ зүүн нэхмэлийн анхан шатны хичээлийг Ерөнхий боловсролыг сургуулийн 1-7 ангийн 13 сурагчид хамрагдаж шүрээр толгойн гоёл, унжлагат ээмэг, цагиран ээмэг, бугуйвч, бөгж, зүүлт, хос зүүн нэхмэлээр анхан шатны чадваруудаа хөгжүүлэн амралтаа үр бүтээлтэй өнгөрүүллээ. Нийт хамрагдсан сурагчдад талархал гардуулан өгсөн.

Оюунлаг бүтээлч ирээдүйн төлөө уриатай “ЗУНЫ ХӨТӨЛБӨР”-ыг 2 ээлжийн 13 төрлийн сургалт 218 хүүхэд залуус хамрагдсан.

Сурагчдын амралт, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, үе тэнгийн найз нөхдөөсөө суралцаж, оюунлаг, бүтээлч сэтгэлгээтэй зөв хүн болгон хүмүүжүүлэх зорилготойгоор 2 ээлжийн 13 төрлийн сургалт, дугуйлан хичээллүүлж байна.

1. Номын тэмдэглэл хөтлөх дугуйлан
2. Номын сэтгэгдэл ярилцах дугуйлан
3. Шүрээр урлах дугуйлан
4. Нэхмэлийн дугуйлан
5. Англи хэлний анхан шатны сургалт
6. Бяцхан санхүүч сургалт
7. “Flex” хөтөлбөрийн хүрээнд “Эсээ хэрхэн бичих вэ?” сургалт
8. Сайн зан чанарын сургалт

Эдгээр дугуйлангуудад сургуулийн насны 218 хүүхэд залуус хамрагдсан.

“Үлгэрээр хүмүүжье чанга уншлага”-ыг 11 ажил арга хэмжээ 286 хүүхэд багачууд хамрагдсан.

Үлгэрээр хүмүүжье чанга уншлагыг 11 удаа зохион байгуулж, Сүхбаатар сумын 2,3,4,5 дугаар цэцэрлэгийн суралцагсад, ЕБ-ын 6 сургуулийн 1 ангийн сурагчид, ЕБ-ын Спорт сургуулийн 1а,2а,3а,5а ангийн сурагчид нийт 286 хүүхэд багачууд хамрагдсан.

- Бага насны хүүхдийн уншлагыг дэмжих, номонд дурлуулах зорилгоор Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн Н.Энх-Амгалан багштай бэлтгэл бүлгийн 20 хүүхэд багачуудад шинэ номын танилцуулга мэдээлэл хүргэж “Цагаан сартай танилцсан нь” номоор чанга уншлага зохион байгуулсан.
- Бага насны хүүхдийн уншлагыг дэмжих, номонд дурлуулах зорилгоор Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн н.Нэргүй багштай бэлтгэл бүлгийн 20 хүүхэд багачуудад шинэ номын танилцуулга мэдээлэл хүргэж “Ууртай тахиа” номоор чанга уншлага зохион байгуулсан
- Үлгэрээр хүмүүжье чанга уншлагын арга хэмжээний хүрээнд Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн О. Анхтуяа багштай бэлтгэл А, Б бүлгийн 35 суралцагчдад “Хамтдаа олцгооё” номоор чанга уншлага хийж, 1-5 насны хүүхдийн шинэ номын мэдээллийг сурталчлан таниулсан.
- Сургуульд орох бяцхан дүү нартаа ном унших хүсэл сонирхол төрүүлэх зорилгоор Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн Н.Дэлгэрмаа, С.Болорцэцэг багштай бэлтгэл В 17 сурагчдад нас сэтгэхүйн онцлогт тохирсон ном уншуулж, Хамтдаа олцгооё номоор чанга уншлага хийж, танин мэдэхүйн карт танилцуулж хөгжилтэй тоглоом тоглож номын ертөнцөөр аяллаа.
- Уншиж бичиж сурч буй бяцхан дүү нарынхаа ном унших хүсэл сонирхлыг нь дэмжих зорилгоор Сүхбаатар сумын 6-р сургуулийн Д. Дүүрэнбаяр багштай 1-р ангийн 23 сурагчдад шинэ ном, үелж унших номууд танилцуулж, Өөрөөрөө байх шиг сайхан зүйл үгүй номоор чанга уншлага хийж номын ертөнцөөр аялуулсан.
- Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн Бямбасүрэн багштай “Ахлах Б” бүлгийн 30 багачууд номын өргөөтэй танилцаж “Эмээ бид хоёрын тухай бяцхаан үлгэр” номыг сонсож олон сонирхолтой ном, тоглоомоор тоглож цагийг хөгжилтэй өнгөрөөсөн.
- Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн Э.Энхмаа багштай “Бэлтгэл” бүлгийн 20 багачууд номын өргөөтэй танилцаж “Эмээ бид хоёрын тухай бяцхаан үлгэр” номыг сонсож олон сонирхолтой ном, тоглоомоор тоглож цагийг хөгжилтэй өнгөрөөсөн.

- Сүхбаатар сумын ЕБ-ын Спортын дунд сургуулийн бага ангийн сурагчдад номын сангийн үйл ажиллагааг танилцуулж “Эмээтэйгээ унших үлгэр”, “Аз жаргалтай хүүхдийн 7 дадал” номын чанга уншлага, монгол ардын үлгэр, зурагт номын унших арга хэмжээг зохион байгуулж 116 сурагчид хамрагдсан.. Уншлаганд:

  Ж.Баярмагнай багштай 1а ангийн 31 сурагч

  О.Буянжаргал багштай 2а ангийн 34 сурагч

  Ж.Цолмон багштай 3а ангийн 20 сурагч

  С.Оюунцэцэг багштай 5а ангийн 31 сурагчид тус тус хамрагдсан.

“Уншигч анги-Урилгат уншлага” ажлын хүрээнд 9 ажил арга хэмжээ 235 сурагчид хамрагдав.

Уншигч анги урилгат уншлагыг 9 удаа зохион байгуулж нийт 235 сурагчид хамрагдсан.

- Хүүхэд залуусын уншлагыг дэмжих зорилгоор урилгат уншлага зохион байгуулж Ерөнхий боловсролын Спортын бүрэн дунд сургуулийн О.Энхзул багштай 6а ангийн 19 сурагч, Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн Ш.Должинсүрэн багштай 7а ангийн 26 сурагч, Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн М.Өнөрцэцэг багштай 7а ангийн 21 сурагч, 1-р сургуулийн Б.Баттунгалаг багштай 7р ангийн 20 сурагчид хамрагдсан. Урилгат уншлагаар хүүхэд залуус номын сантай танилцаж, үнэгүй уншигчийн картаа нээлгэж, монгол ардын үлгэр, тууж, өгүүллэгээр чанга уншлага хийж, төрөл бүрийн ном уншиж номын тэмдэглэл хөтлөх аргачлалаас суралцаж, уншсан номуудаа хоорондоо ярилцаж, оюун ухаан сэтгэхүй хөгжүүлэх алжаал тайлах тоглоомууд, танин мэдэхүйн картаар тоглож чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлж байна.
- Сүхбаатар сумын Г. Бумцэндийн нэрэмжит Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Ц.Алимантуяа багштай 6г ангийн 29 сурагчид номын сангаар зочилж хүүхдийн уншлагын танхимд төрөл бүрийн ном уншиж, номын сэтгэгдлээ хуваалцаж, үнэгүй уншигчийн картаа нээлгэсэн.

“Олуулаа уншъя” урилгат уншлагыг 12 ажил арга хэмжээнд 308 хүн хамрагдав.

- Олон нийтийг номтой нөхөрлүүлэх, ном уншихийн ач холбогдлыг сурталчлах зорилгоор “Олуулаа уншъя” урилгат уншлагыг Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн ажилтан албан хаагчдыг урьж номын сангийн үндсэн фонд, уншлагын танхимуудтай танилцуулан “15 минутын уншлага” зохион явуулж уншсан номын сэтгэгдэлээ солилцон ярилцлаа. Урилгаар 8 төрийн албан хаагч хамрагдав. Энэхүү уншлагад ирсэн албан хаагчдаас номын сангийн үйлчилгээний хүртээмж үр өгөөжийн талаар асуулга авч дараах дүгнэлтэнд хүрлээ. Үүнд: Бага насны хүүхэд багачуудад номонд дуртай болгох заавар зөвлөмж, гэр бүлийн өдөртэй болох, байгууллага хамт олныг хамруулсан соёл олон нийтийн ажлыг тогтмол зохион байгуулах ажлуудыг санал дэвшүүлсэн байна.

- Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 1 курсын суралцагч нарыг урин Номын сангийн үндсэн фонд, Хүүхдийн уншлагын танхим, Лавлагаа ном зүйн булан, Гэрээр ном олгох, нийтийн уншлагын танхимуудтай танилцав. Урилгаар дотуур байрны ажилтан н. Энхцэцэгээр ахлуулан 11 суралцагч ирж ном унших ач тусын талаар зөвлөгөө мэдээлэл аван уншигчийн карт нээлгэн, өөрсдийн сонирхсон номоо уншиж бусадтайгаа харилцан ярилцав.
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Г.Нандинцэцэг багштай 11а, 12а, 12б, ангийн 124 сурагчдад номын сангийн уншлагын танхимын үйл ажиллагаа, ном унших нь ахлах ангийн сурагчдад ямар ач холбогдолтой вэ? мэдээлэл, 15 минутын уншлагын арга хэмжээг тус тус зохион байгууллаа. Нийт эмэгтэй 61 эрэгтэй 63 эмэгтэй хамрагдлаа.
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн Гэрэлцэцэг багштай 12а ангийн 20 сурагчдад номын сангийн уншлагын танхимын үйл ажиллагаа, ном унших нь ахлах ангийн сурагчдад ямар ач холбогдолтой вэ? мэдээлэл, 15 минутын уншлагын арга хэмжээг тус тус зохион байгууллаа. Нийт эмэгтэй 11 эрэгтэй 9 эмэгтэй хамрагдлаа.
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын УТ-ний Лабортори 4-р сургуулийн н.Хүсэлт багштай 9б ангийн 32 сурагчдад номын сангийн уншлагын танхимын үйл ажиллагаа, ном унших нь ахлах ангийн сурагчдад ямар ач холбогдолтой вэ? мэдээлэл, 15 минутын уншлагын арга хэмжээг тус тус зохион байгууллаа. Нийт эмэгтэй 17 эрэгтэй 16 хамрагдлаа.
- Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын 70 ажилтан албан хаагчдад оновчтой уншлага, ном уншихын ач тусын талаар мэдээлэл өгч 15 минутын уншлагын арга хэмжээг тус тус зохион байгууллаа. Нийт эмэгтэй 23 эрэгтэй 47 хамрагдлаа.
- Сэлэнгэ аймгийн УТ-ний 4 дүгээр сургуулийн 12а, 12б, 12в ангийн 82 сурагчдад номын сангийн үйл ажиллагаа, електрон каталоги ашиглах заавар, 15 минутын уншлага зохион байгууллаа. Нийт эмэгтэй 43 эрэгтэй 39
- Спорт сургуулийн 9а ангийн 43 сурагчдад номын сангийн уншлагын танхимын үйл ажиллагаа, ном унших нь ахлах ангийн сурагчдад ямар ач холбогдолтой вэ? мэдээлэл, 15 минутын уншлагын арга хэмжээг тус тус зохион байгууллаа. Нийт эмэгтэй 27 эрэгтэй 16 сурагч хамрагдлаа.

“Номын сантай танилцах аялал” сурталчлан таниулах 6 ажил арга хэмжээнд 134 хүүхэд багачууд хамрагдсан.

Сүхбаатар сумын 2,3,4, 5 цэцэрлэгийн бэлтгэл а.б бүлгийн 105 суралцагсад, ЕБС-ийн 6 ангийн 29 сурагчид номын сантай танилцаж “Туулайн бяцхан байшин” дүрийн тоглолт, видео үлгэр үзүүлж, зурагт ном уншиж, уншлагын танхимын үйл ажиллагааг сурталчлан таниулах 6 ажил арга хэмжээ зохион байгуулж, нийт 134 хүүхэд багачууд хамрагдсан.

Монгол баатарлаг туульсаа түгээн дэлгэрүүлэх 3 ажлын хүрээнд 115 иргэдэд сурталчлав.

Монгол баатарлаг тууль сурталчлах 3 ажил арга хэмжээ зохион байгуулсан.

Цахимаар монгол баатарлаг тууль болох Жангар, Гэсэр туулийг сурталчлан нийт 1011 иргэдэд хүрсэн. Танхимаар туулийн тухай мэдлэг олгох тараах материалыг 115 хүнд сурталчлан таниулсан.

1. **Монголын нууц товчоог сурталчлах ажлын хүрээнд**

   Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх “Монголын нууц товчоог дээдлэх” сурталчлах зорилгоор хүүхэд залууст зориулан гаргасан Зохиогч Б. Батцэцэг Зураач Б. Төрмөнхийн "Монголын нууц товчоон" зохиолоор Улсын тэргүүний 2 дугаар сургуулийн 3-4 ангийн сурагчид дунд харилцан ярилцаж, чанга уншлагыг зохион байгууллаа. Нийт 20 сурагч Эр-2 Эм-18

2. **Хүүхэд багачуудад эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх зохиол бүтээлийг сурталчлан таниулах 4 ажил арга хэмжээнд 44 сурагчид хамрагдсан.**

   Алсын хараа-2050 арга хэмжээнд тусгагдсан зорилтын хүрээнд хүүхэд багачуудад эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх утга зохиолын бүтээлийг сурталчлан таниулах зорилгоор Чингис хаан комикс, Гэсэр тууль, Б.Явуухулан Би хаана төрөө вэ? Найраглал, Б.Инжиннашийн Хөх судар зохиолиудаар 4 арга хэмжээ явуулж номын тойм яриа, чанга уншлагуудыг зохион байгуулсан. Нийт ЕБС-ийн 2-7 ангийн 44 сурагчид хамрагдсан. Цахим хаягаар хүүхэд залууст эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх зохиол бүтээлийн мэдээлэл 12 удаа сурталчлан таниулж нийт 2854 хүнд хүрсэн.

3. **Хүүхдэд зориулсан монголын нууц товчоог сурталчлан таниулах 4 ажил арга хэмжээнд 51 сурагчид хамрагдсан.**

   Монгол улсын Ерөнхийлөгчийн Монголын нууц товчоог мөнхөд эрхэмлэн дээдлэх зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Хүүхдэд зориулсан Монголын нууц товчоо номыг судалж унших урт хугацааны хөтөлбөр арга хэмжээ зохион байгуулж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд номын тойм яриа, мэдээлэл хүргэх ажлыг 4 арга хэмжээ зохион байгуулж ЕБС-ийн 1-7 ангийн ний 51 сурагчид хамрагдсан. Цахим хаягаар монголын нууц товчоо хүүхдэд зориулсан мэдээллийг 7 удаа сурталчлан нийт 1726 хүнд хүрсэн.

4. **“Номтой цаг” уншлагын цаг зохион байгуулах 8 ажлын хүрээнд 255 сурагчид хамрагдсан.**

   Номын сангаар үйлчлүүлдэг байнгын уншигч хүүхдүүдийн дунд “номтой цаг” уншлагын цагийг гарган уншсан ном, өөрсдийн насны хүүхдийн уншвал зохих номуудаас судлан танилцаж, шинэ ном зохиолын талаар чөлөөтэй ярилцах үйл ажиллагааг зохион байгуулж

байна. Номтой цаг арга хэмжээг 8 удаа зохион байгуулж ЕБС-ийн 1,2,5, 6, Спорт сургуулийн нийт 255 сурагч хамрагдсан.

5. **Ном хэвлэл сурталчлах, номын санг танилцуулах арга хэмжээ**

Шинэ номын танилцуулга хийх, номын сангийн танхимуудын үйл ажиллагааг сурталчлах, хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Сүхбаатар сумын Цагаан эрэг 2 дугаар багийн 13 иргэдэд үнэгүй карт нээх, уран зохиолын болон хүүхдийн ном зохиолоо танилцуулж, зөөврийн номын сангаар үйлчлүүлэх боломж боломжцоог судлан, цаашид номын сангаас ямар үйл ажиллагаа зохиох вэ 1 асуулгат судалгааг авч, багийн иргэдэд номын сангийн үйл ажиллагааг сурталчлан таниулсан.

6. **Номын клуб байгуулах**

Сүхбаатар сумын ЕБ-ын 7 сургууль, МСҮТ-ийн төлөөллөөс хамруулсан 25 сурагчдыг номын клубын гишүүнээр элсүүлэн үйл ажиллагаа, эрхэм зорилгоо тодорхойлон номын хэлэлцүүлэг, ном сэлбэн засах үйл ажиллагаа, номын сэтгэгдлийн ярилцлага авах 3 ажил арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

7. **Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Номын хотхон”-оор 6 ажил арга хэмжээнд 550 иргэд хамрагдсан.**

ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Номын хотхон”-ы үйл ажиллагааг зохион байгуулсан. Үйл ажиллагааны хүрээнд

1. Үлгэрийн баатруудтай зураг авалт
2. Танин мэдэхүйн картын худалдаа
3. Хүүхдийн номын үзэсгэлэн
4. Бидний баяр зургийн уралдаан зохион байгуулах

Нийт 10 хүүхдийн дунд зохион байгуулж тэргүүн байранд 1-р сургуулийн 6-р ангийн сурагч Б. Энэрэл, Спорт сургуулийн 6-р ангийн сурагч Э.Мөнгөнсарнай, 4-р сургуулийн 6-р ангийн сурагч Б.Номиндаваа нар тус тус шалгарч дурсгалын бэлгээр шагнаж урамшуулсан.

5. Монгол ардын аман зохиолын тэмцээн зохион байгуулах

Нийт ЕБС-ийн 3-7 ангийн 10 сурагчдын дунд зохион байгуулж тэргүүн байранд 1-р сургуулийн 5-р ангийн сурагч Э.Маргад-Эрдэнэ, дэд байранд 1-р сургуулийн 6-р ангийн сурагч Г.Орхонтуул нар тус шалгарч гарын бэлгээр шагнаж урамшуулсан.

6. Хүүхдүүдэд гарын бэлэг тараах үйл ажиллагааг зохион байгуулж арга хэмжээнд нийт 550 сурагчид хамрагдсан.

8. **Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн сурагч шалгаруулах**

Номын баярын хүрээнд Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгоны нийт 44 сурагчдыг үндсэн шалгуурын дагуу Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэидгээр шагнаж урамшуулсан. Мөн Нацагдоржийн мэндэлсэн өдөр буюу 11 сарын 17 нд сурагчдыг шалгуурын дагуу 8 сурагч шалгаруулан нийт 52 сурагч тэргүүний уншигчид болсон.

9. **Улирлын шилдэг уншигч шалгаруулах**

1,2,3,4 дугаар улиралд хүүхдийн уншлагын танхимын шилдэг уншигч 4 сурагчийг шалгаруулсан.

1 улирлын шилдэг уншигч сурагчаар 2-р сургуулийн 6р ангийн сурагч М.Мөнхжигүүр

2-р улирлын шилдэг уншигч сурагчаар 1-р сургуулийн 7р ангийн сурагч А.Анун

3-р улирлын шилдэг уншигч сурагчаар 2-р сургуулийн 5б ангийн сурагч М.Мандарива

4-р улирлын шилдэг уншигч сурагчаар Спорт сургуулийн 3а ангийн сурагч

Э. Эрдэнэсүрэн нар тус тус шалгарсан.

10. Д.Пүрэвдорж зохиолчийн намтар уран бүтээлийг сурталчлах 3 арга хэмжээний хүрээнд 85 сурагчид хамрагдсан.

Их зохиолчийн мэндэлсний 90 жилийн ойг тохиолдуулан бага насны сурагчдад зохиолчийг таниулах, уран бүтээлийг унших, судлах, сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үйл ажиллагаанд нийт 85 сурагчид хамрагдсан.

1. Д.Пүрэвдорж зохиолчийн намтар, уран бүтээлийн танилцуулга гарын авлага бэлтгэж, сурагчдад танилцуулсан.
2. “Сэгс цагаан богд”, “Тусгаар тогтнол” найраглалыг сурагчдаар цээжлүүлсэн.
3. Номын үзэсгэлэн гаргаж толилуулсан.

11. Эрдмийн баярын үйл ажиллагаа

Номын сангийн гадна талбайд хүүхдийн номын үзэсгэлэн гаргаж номын сангийн үйл ажиллагааг сурталчлан таниулах 1 ажил арга хэмжээ зохион байгуулж, нийт 152 сурагчид хамрагдсан

12. Бид эх орны хүүхдүүд ажлын хүрээд

Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн Соёл гэгээрлийн албаны дарга, хэвлэлийн төлөөлөгч хошууч Г.Энхжинтэй хамтран Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1-6 дугаар сургуулийн 10-12 дугаар ангийн Сурагчдад Эх оронч, эр зоригийн хүмүүжил олгох, эх орноо хайрлан хамгаалах сэтгэлтэй болгох зорилгоор "Бид эх орны хүүхдүүд” өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. Нийт 22 сурагч эрэгтэй 15 эмэгтэй 7 сурагч хамрагдлаа.

13. Сэтгэлд хоногшсон өдөрлөг

Цэргийн баярыг тохиолдуулан хүчний байгууллагад ажиллаж байсан ахмадуудыг урин тэдний өөрт тохиолдсон сэтгэлд хоногшсон дурсамж, ажил амьралынхаа үүх түүхийг хуваалцан, залуу хойч үедээ сургамж зөвлөмж өгч дотно ярилцаж, санал сэтгэгдлээ хуваалцлаа. Нийт 6 эрэгтэй 1 эмэгтэй хамрагдлаа.

14. Ахмадын баярын АХА тэмцээн

Сэлэнгэ аймгийн 4 дүгээр багийн 150 ахмад буурлуудад зориулсан арга хэмжээнд танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулж мөн 45 шинэ номын үзэсгэлэн гаргалаа.

15. **Талархалын зан чанар сургалт**

Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын Баянхан 4-р багийн засаг дарга Т.Мөнхтуяа болон багш Б.Ганчимэгтэй хамт уншигч багачууддаа хамтран “Талархлын зан чанар” сэвдийн хүрээнд Онцгой байдлын 25 ах нартаа талархаж явдаг тухайгаа илэрхийлж, аавуудын баярын мэнд хүргэж дурсгалын зураг татуулсан.

16. **Бяцхан санхүүч сургалт**

Санхүүгийн боловсрол олгох Бяцхан санхүүч сургалтыг ДЗОУБ Сэлэнгэ аймаг дахь салбарын хамт олонтой хамтран Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд зохион байгуулж 2-7 ангийн нийт 16 сурагч хамрагдсан. Сургалтад хамрагдсанаар бага насны хүүхдүүд санхүүгийн анхан шатны боловсрол олгох, мөнгөтэй зөв харьцаж сурах, тооцоолох чадвартай болох, өөрийн хэрэгцээгээ зөв тодорхойлж сурах чадваруудыг олгох сургалтыг сарын хугацаанд зохион байгуулсан.

17. **“Байгаль бидний гэр” гар зургийн уралдаан**

Соёлын сэргэлт 2023 төвийн бүсийн нээлтийн арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотын байгалийн түүхийн музей, Соёл урлагийн газартай хамтран Сэлэнгэ аймгийн нийт ЕБС-ийн 1-12 ангийн сурагчдын дунд “Байгаль бидний гэр” гар зургийн уралдаан зарласан. Нийт 42 сурагчид хамрагдсан. Тэргүүн байранд Ерөө сум,Бугант тосгоны 6а ангийн сурагч А.Амарзаяа, Дэд байранд Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 4г ангийн сурагч У.Дүүрэнбаяр, Гутгаар байранд Сүхбаатар сумын 1-р сургуулийн 10б ангийн сурагч Д.Нандин-Эрдэнэ, тусгай байранд Цагааннуур сумын ЕБС-ийн 12а ангийн сурагч Д.Үрээхэй, шүүгчдийн нэрэмжит шагналаар ЕБ-ын 4-р сургуулийн 10в ангийн сурагч Н.Хулан,үзэгчдийн таашаал хүртсэн уран бүтээлчээр сүхбаатар сумын ЕБ-ын 5-р сургуулийн 5а ангийн сурагч С.Оюун, ирээдүйтэй уран бүтээлчээр сүхбаатар сумын ЕБ-ын сургуулийн 1г ангийн сурагч А.Гэгээнээ нар тус тус шагнаж урамшуулсан: Сурагчдын бүтээлээр Сэлэнгийн долгио чуулгад үзэсгэлэн гаргасан.

18. **Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд оролцох**

Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын Баянхан 4-р багийн даргатай хамтран гамшгийн үеийн бэлэн байдлын үед иргэд олон нийтэд ном хэвлэлийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, зуны хөтөлбөрийн мэдээлэл хүргэж бүртгэл явуулах, номын үзэсгэлэн дэлгэн нийт 85 иргэд хамрагдсан.

19. **Танин мэдэхүйн өртөөчилсөн аялал**

Сэлэнгэ аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны 25 оюутнуудад зориулан түүхэн дурсгалт газруудын талаар танилцуулга, түүхийн талаар өртөөт аялал зохион байгуулав. Үүнд: Мод боловсруулах үйлдвэрлэлийн цагаан хаалга, Хулан хатны хөшөө, Гурван мэргидийн хөшөө зэрэг түүхэн дурсгалт газруудыг сурталчлан таниуллаа.

20. **Зуны зугаатай уншлага**

ЕБС-ийн 3-6 дугаар ангийн 16 хүүхэд багачуудын дунд номоо хэрхэн зөв сонгон унших зөвлөмж, өөрийн дуртай номыг байгаль цэвэр агаарт уншин өөрт төрсөн сэтгэгдэлээ хуваалцан ярилцаж түүнээс төрсөн санаагаа хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгууллаа.

21. **Австралийн элчин сайдын яам**

Монгол улсын үндэсний номын сан, Монголын номын сангийн холбооноос санаачлан хэрэгжүүлсэн “Хил хязгааргүй номын сан” төсөл хэлэлцүүлэгт оролцов.

Австралийн ЭСЯ, Монгол Улсын Үндэсний Номын Сан, Монголын Номын Сангийн Холбооны санаачлан хэрэгжүүлж буй "ХИЛ ХЯЗГААРГҮЙ НОМЫН САН" төслийн хүрээнд Сэлэнгэ аймагт номын санчдыг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг амжилттай зохион байгуулагдсан.Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан, сумдын соёлын төвийн номын сан, ерөнхий боловсролын сургуулийн номын санч, Хилийн цэргийн 0101, 0243-р ангийн болон МСҮТ, политехник коллежийн 56 номын санч мэргэжилтнүүдэд орчин үеийн нийтийн номын сангийн шилдэг туршлагаас хуваалцаж, хэрэглэгч төвтэй иргэний номын сангийн үйлчилгээ, дижитал номын сан, технологийн дэвшлийг ашиглан хамтран ашиглах боломжийн талаар сургалт, хэлэлцүүлэг явуулах, Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн фонд баяжуулалтанд хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон уран зохиолын шилдэг бүтээл болон шинжлэх ухааны зурагт ном хандивлах гэх мэт олон сайхан үйл ажиллагааг зохион байгууллаа.

Австралийн Тэтгэлгийн төгсөгч МНСХ-ны гүйцэтгэх захирал М. Даваасүрэн "Австралийн нийтийн номын сангийн туршлага" номын сангийн салбарын онцлог, хэрэгжүүлж буй номын сангийн үйлчилгээ, хөтөлбөр, ОУ-ын номын сангийн холбооны 88 дахь удаагийн уулзалтын талаарх мэдээлэл, иргэний номын сангийн жишиг үйлчилгээ сургалт мэдээлэл хүргэлээ

МУҮНС-ын ACIP төслийн ерөнхий зохицуулагч Б. Сайнбилэг (Ph.D) "Дижитал номын сангийн туршлага" олон улсын туршлага, МУҮНС-ын ACIP төслийн дижиталчлалын туршлага хөтөлбөрийн талаар сургалт явууллаа.

Дэлхийн олон улсын номын сангийн үнэт зүйл, чиг хандлагаас суралцаж, орон нутгийн онцлогт тохирсон инновацийг тодорхойлох, хөгжүүлэх, иргэн төвтэй номын сангийн үйл ажиллагаа руу шилжих шаардлага байгааг онцлон тэмдэглэлээ.

22. **УИХ-ын гишүүн Ч.Ундрамын санаачилгаар Сэлэнгэ аймагт анх удаа Шинжлэх ухааны уралдаанд номын үзэсгэлэн зохион байгуулав**

Сурагчдыг шинжлэх ухаанч хандлагатай болгох зорилгоор Сэлэнгэ аймгийн ЕБС-иудын сурагчдын дунд зохион байгуулагдаж буй уралдааныг дэмжин ажиллаж шинжлэх ухааны холбогдолтой шинэ содон, сонирхолтой 120 гаруй номын үзэсгэлэнг хүүхэд залуус, багш эхчүүддээ танилцуулж, уншигчийн карт нээж, гэрээр ном олгож ажиллалаа

Мөн арга хэмжээг хамтран зохион байгуулагч "Гэртээ туршъя" төрийн бус байгууллагаас фонд баяжилтанд ном хандивлалаа

Арга хэмжээнд шинжлэх ухаан сонирхдог 250 гаруй сурагчид, эцэг эхчүүд, багш нар хамрагдлаа

23. **Монголын алтан үе болон шинэ үеийн зохиолчдыг сурталчлан таниулах ажлын хүрээнд 12 удаагийн 585 иргэд хамрагдлаа. Цахимаар 971 хүнд хүрсэн.** Үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулах зорилгоор Сүхбаатар сумын Цагаан эрэг 2 дугаар багийн иргэдэд Жамбын Пүрэв гуайн намтар уран бүтээлийг сурталчилан түүний гаргасан 20 номоор номын үзэсгэлэн гаргаж үйлчиллээ. Нийт 12 иргэн хамрагдлаа. Иргэдээс номын сангаас ямар үйлчилгээ авахыг хүсч байгаа талаар асуулга авхад зөөврийн номын сангийн үйлчилгээ болон 2 багийн ахмадуудад чиглэсэн үйл ажиллагаа үйлчилгээг хүссэн байна.

БНМАУ-ын нэрт зохиолч Монголын уран зохиолын сод төлөөлөгч, Төрийн хошой шагналт эрдэмтэн, зохиолч Ч. Лодойдамба агсны намтар түүх, XX зууны шилдэг зохиолоор тодорсон “Тунгалаг тамир” роман хэрхэн бүтсэн, романы сонин хачнаас мэдээлэл бэлтгэн хүргэж, хэлэлцүүлэг өрнүүллээ. Хилийн 0243 дугаар ангийн 40 гаруй ажилтан албан хаагч хамрагдав.

Зууны шилдэг роман гэж нэрлэгдэх шалтгаанууд?

Романы үйл явдал баатрууд хувь заяаны эгзэгтэй хэсгийн тухай

Тунгалаг тамир романд нийт хэдэн дүр байдаг талаар дүрүүдийн зан чанарыг өнөө үетэй харьцуулан ярилцлаа.

БНМАУ-ын нэрт зохиолч Хөдөлмөрийн баатар, Төрийн соёрхолт, Ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдорж-ийн 90 насны ойг тохиолдуулан түүний намтар, уран зохиолыг сурталчлан таниулж түгээн дэлгэрүүлэх зорилгогоор түүний намтар, уран зохиолууд болон монголынхоо зохиолчдын уран бүтээлүүдээр номын үзэсгэлэн гаргаж Шаамар сумын МСҮТ-ийн 37 багш, ажилтан албан хаагч, сурагчдад 15 минутын уншлага зохион байгууллаа. Хэлэлцүүлэг өрнүүлэхэд дараах асуултуудыг дэвшүүлж харилцан ярилцаж мэдлэг мэдээллээ солилцлоо.

Монголын нэрт яруу найрагч Г. Аюурзана-ын "Хар цагаан улаан " хэмээх зохиолыг танхим болон цахимаар сурталчлан таниулхад 109 иргэд үзэж сонирхсон байна. Танхимаар 25 сурагчдад мэдээлэл хүргэв.

- Ц. Цэнджавын намтар болон “Миний нутаг” шүлэгийг танхим болон цахимаар сурталчлав. Цахимаар 343, танхимаар 19 иргэдэд мэдээлэл хүргэв.
- Лодонгийн Түдэвийн намтар “Хорвоотой танилцсан түүх” зохиолын гол санааг танхим болон цахимаар зохион явууллаа. Цахим 189, танхим 17 иргэдэд мэдээлэл тус тус хүргэв.
- Ерөөлч Гэлэгбалсангийн намтар, ерөөлийн тухай мэдээлэл бэлтгэн уншигчдад танилцуулав. Танхим 13 Цахим 176 иргэдэд мэдээлэл хүргэв.
- Б.Шүүдэрцэцэг зохиогчийн “Уулсын домог Хотулун” роман номны мэдээлэйиг бэлтгэн уншигчдад хүргэсэн. Танхим 15 Цахим 250
- Б.Пүрэвдорж зохиолчийн намтар уран бүтээл “Билгүүн хөх салхи” романы талаар мэдээлэл бэлтгэн уншигчдад хүргэсэн. Танхим 16 Цахим 211
- Б.Явуухулан зохиогчийн товч намтар, уран бүтээлийн тухай мэдээлэл бэлтгэн уншигчдад хүргэсэн. Танхим 19 Цахим 54
- Б.Лхагвасүрэн зохиогчийн намтар уран бүтээлийн товч мэдээлэлийг бэлтгэн уншигчдад хүргэсэн. Танхим Цахим 291
- Г.Мэнд – Ооёогийн “Гэгээтэн” романы тухай товч мэдээлэлийг бэлтгэн уншигчдад хүргэсэн. Танхим 19 Цахим 54

24. Дэлхийн сонгодог зохиолийг цахим болон танхимаар 24 удаа сурталчилав. Танхимаар- 1064, Цахимаар- 7521 гаруй

- Пауло Коэльо намтар түүний Алхимич зохиолоор мэдээлэл бэлтгэн пэйж хаягаар сурталчлан таниулхад 236 иргэд үзэж, 17 иргэдэд мэдээлэл хүргэж сонирхсон байна.

- Жек Лондонгийн намтар түүний Мартен Иден зохиолоор мэдээлэл бэлтгэн пэйж хаягаар сурталчлан таниулхад 234 иргэд үзэж, танхимаар 16 иргэдэд мэдээлэл хүргэсэн.

- Михаил Булгаковын “Мастер Маргарита” хоёр зохиолоор мэдээлэл бэлтгэн пэйж хаягаар сурталчлан таниулхад 136 иргэд, танхимаар 18 иргэд үзэж сонирхсон байна.
- Стефан Цвейгийн “Танихгүй эмэгтэйн захидал” зохиолоор мэдээлэл бэлтгэн цахимаар сурталчилан таниулхад 205 иргэн үзэж, танхимаар 21 иргэнд мэдээлэл хүргэлээ.

- Цао Шюнчинь, Гао О “Улаан асрын зүүд ” зохиолоор мэдээлэл бэлтгэн танхим болон пэйж хаягаар сурталчлан таниулхад 150 иргэд үзэж сонирхсон байна. Танхимаар 19 иргэдэд мэдээлэл хүргэлээ.
- Нобелийн шагналт зохиолч Сельма Лагерлёфийн намтар уран бүтээлийг сурталчлав. Танхим 28 иргэнд, цахимаар 206иргэн үзэж сонирхов.
- Селинжер Жеромын сонирхолтой намтар түүх болон түүний хамгийн нэрт зохиол болох “Хөх тариан харуул” романыг сурталчлан таниулав. Цахим 200, Танхим 12 иргэдэд хүргэв.
- Франсуа Рабле-н намтар уран бүтээлээр мэдээлэл бэлтгэн уншигчдад хүргэсэн Танхим 16 Цахим 144
- Дэлхийн сонгодог   зохиол “Үлгэрийн далай “ номны танилцуулга бэлтгэн уншигчдад хүргэсэн. Танхим 23 Цахим 177

25. Монгол өв соёл, ёс заншил ажлын хүрээнд 12 удаа мэдээлэл бэлтгэж танхимаар 206, цахимаар 4119 хүнд танилцуулав.

- “Отор нүүдэл хийх” мэдээллийг цахимаар сурталчлан таниулхад 313 иргэд үзэж, 30 иргэдэд танхимаар мэдээлэл хүргэв.
- Монгол ардын өв соёл уламжлалын талаар цуврал мэдээлэл бэлтгэх ажлын хүрээнд монгол аман зохиолын нэг төрөл болох“Тууль”-ийн талаарх мэдээллийг цахимаар сурталчлан таниулхад 199 иргэд үзэж сонирхсон байна. Танхимаар 19 иргэдэд хүргэв.
- “Гар урлал ” мэдээллийг цахимаар сурталчлан таниулхад 342 иргэд үзэж сонирхсон байна. Танхимаар 18 иргэдэд хүргэв.
- Монгол гэр, ёс заншлын талаарх мэдээллийг цахимаар сурталчлан таниулхад 2051 иргэд үзэж сонирхсон байна. Танхимаар 32 иргэдэд хүргэв.
- “Азарганы дэлийг авдаггүй учир” мэдээллийг танхимаар 16 цахимаар 269 хүнд мэдээлэл хүргэв.
- Зан заншил “Мөсөн шагай” талаарх мэдээлэл бэлтгэн чанга уншлага зохион байгууллаа. Нийт 225 хүнд хүрсэн.
- Үеэс үед уламжлагдаж ирсэн монгол ардын өв соёл уламжлалын талаар цуврал мэдээлэл бэлтгэх ажлын хүрээнд эрт дээр үеэс монгол эр хүний хүч самбааг сорих эрийн гурван наадмыг сурталчилж “Монгол наадам”-ийн талаарх мэдээллийг цахим хаягаар болон уншлагын танхимын уншигчдад сурталчлан таниулхж цахим хаягаар 350 иргэд, танхимаар 10 уншигчдад хүргэлээ.

- Монгол ардын нэгэн ёс болох “Бэр гуйх” ёсны талаар цуврал мэдээлэл бэлтгэн 19 танхим болон цахимаар уншигчдадаа сурталчлан таниулж 199 иргэд үзэж сонирхсон байна.
- Үеэс үед уламжлагдаж ирсэн монгол ардын өв соёл уламжлалын талаар цуврал мэдээлэл бэлтгэх ажлын хүрээнд “Даалин гэж юу вэ?” мэдээллийг танхимаар 25, цахимаар сурталчлан таниулхад 98 иргэд үзэж сонирхсон байна.
- Монгол уламжлалт аргаар “Эсгий хийх” мэдээллийг танхимаар 24, цахимаар 86 иргэдэд сурталчлав.

26. Номтой холбоотой зөвлөмж

Ээж аав асран хамгаалагч нарт номтой холбоотой сар бүр 1 зөвлөмж тараах материал бэлтгэж нийт 12 зөвлөмжийг 600 гаруй уншигчдад хүргэлээ. 5782 хүнд хүрсэн

Цахим уншлагыг дэмжих ажлын хүрээнд:
Уншлагын танхимиудаас дараах цуврал мэдээллийг хүүхдэд багачууддаа зориулан хүргэлээ. Үүнд:

Монголын болон дэлхийн уран зохиол, бүтээлийг сурталчлан таниулах, соёлын боловсрол олгох нийт 56 удаагийн цахим мэдээ мэдээлэл бэлтгэн хүргэж 27877 иргэд олон нийтэд хүрсэн.

1. Шинэ номын мэдээллийг 7 удаа сурталчлан 4170 хүний хандалт авсан байна.

2. Монголын нууц товчоо хүүхдэд зориулсан мэдээллийг 13 удаа сурталчлан нийт 4859 хүнд хүрсэн.

3. Хүүхэд залууст эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх зохиол бүтээлийн мэдээлэл 12 удаа сурталчлан таниулж нийт 6274 хүнд хүрсэн.

-Чингис хаан комикс зохиолыг сурталчлан таниулж нийт 506 хүний хандалт авсан байна.

-Гэсэр хүүхдэд зориулсан зохиолыг сурталчлан таниулж нийт 500 хүний хандалт авсан байна.

-Жангар туулийг иргэд олон нийтэд сурталчлан таниулж нийт 470 хүний хандалт авсан.

-Б.Явуухулан зохиолчийн “ Би хаана төрөө вэ” шүлэг найраглалыг хүүхэд залууст сурталчлан таниулж нийт 857 хүний хандалт авсан байна.

- Ж.Инжиннаши зохиолчийн Хөх судар зохиол бүтээлийн мэдээлэл сурталчлан таниулж нийт 269 хүнд хүрсэн.

- Ж.Лхагва зохиолчийн 10 шилдэг богино өгүүллэгийн мэдээлэл сурталчлан таниулж нийт 252 хүнд хүрсэн.

-Ж.Дашдондог зохиолчийн Малгайтай заан зохиолыг сурталчлан 246 хүнд хүрсэн.

-Монгол хүн Д.Нацагдорж зохиолыг сурталчлан 378 хүнд хүрсэн.

-Монгол хүн Норовбанзад зохиолыг сурталчлан 450 хүнд хүрсэн.

Х.Зандрайбаадий Дамиран гайхал зохиолыг сурталчлан 689 хүнд хүрсэн.

Д.Пүрэвдорж Тусгаар тогтнол найраглалыг сурталчлан 1048 хүнд хүрсэн.

Д.Содномдорж Норовын намтар зохиолыг сурталчлан 480 хүнд хүрсэн.

4. Дэлхийн сонгодог зохиол бүтээлийн мэдээллийг 12 удаа сурталчлан таниулж нийт 6921 хүнд хүрсэн.

-Михаил Энде зохиолчийн “Момо” зохиолын мэдээлэл бэлтгэн иргэд олон нийтэд сурталчлан таниулж 571 хүнд хүрсэн.

-Жек Лондон зохиолчийн “Цагаан соёот” зохиолын мэдээлэл бэлтгэн иргэдэд сурталчлан таниулж 643 хүнд хүрсэн.

-Маржери Уильямс зохиолчийн “ Хамбан туулай” зохиолыг сурталчлан таниулж 364 хүнд хүрсэн.

-А.Н.Толстой зохиолчийн “Буратино алтан түлхүүр ба буратиногийн адал явдал зохиолыг сурталчлан таниулж 492 хүнд хүрсэн.

-Дэлхийн сонгодог өгүүллэгүүдийг сурталчлан таниулж 615 хүнд хүрсэн.

-1001 шөнийн үлгэр зохиолыг сурталчлан 978 хүнд хүрсэн.

-Огги бид хоёр зохиолыг сурталчлан 1108 хүнд хүрсэн.

-Маршакын үлгэрүүд зохиолыг сурталчлан 1205 хүнд хүрсэн.

-Дүрсгүй жаалын өдрийн тэмдэглэл зохиолыг сурталчлан 945 хүнд хүрсэн.

5. Ээж аав асран хамгаалагч нарт номын сангаар хэрхэн үйлчлүүлэх 12 зөвлөмж бэлтгэн хүргэж нийт 5782 хүнд хүрсэн.

-Хүүхдээ номонд дуртай болгох нь зөвлөмжийг бэлтгэн хүргэж нийт 495 хүнд хүрсэн.

-Хүүхэдтэйгээ ном уншихдаа зөвлөмжийг бэлтгэн хүргэж нийт 172 хүнд хүрсэн.

-Дөнгөж уншиж сурч байгаа хүүхэдтэйгээ ажиллахдаа зөвлөмжийг бэлтгэн хүргэж нийт 488 хүнд хүрсэн.

-Номын сангаар үйлчлүүлэх соёл зөвлөмжийг бэлтгэн хүргэж нийт 221 хүнд хүрсэн.

-Номын тэмдэглэл хэрхэн хөтлөх вэ? зөвлөмжийг бэлтгэн хүргэж нийт 1171 хүнд хүрсэн.

Номын үзэсгэлэн

2023 онд 18 удаагийн сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэнг дэлгэж нийт 8854 хүүхэд багачууд, иргэдэд хүрсэн.

1. Монгол баатарлаг туулийг сурталчлах ажлын хүрээнд “Монгол тууль” номын үзэсгэлэнг дэлгэж нийт 789 иргэд, хүүхэд багачууд үзэж танилцсан.
2. Багачууд” номын үзэсгэлэнг дэлгэж 330 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
3. Заавал унших номын үзэсгэлэнг дэлгэж 330 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
4. Шинжлэх ухааны номын үззсгэлэнг дэлгэж 501 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
5. Яруу найргийн номын үзэсгэлэнг дэлгэж 510 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
6. Монгол ардын аман зохиолын номын үзэсгэлэнг дэлгэж 405 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
7. Түүх номын үзэсгэлэнг дэлгэж 542 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
8. Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан монгол бичгээр бичигдсэн Бичиг үсэг өв соёл номын үзэсгэлэнг дэлгэж 684 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
9. Англи номын үзэсгэлэнг дэлгэж 532 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
10. Хүүхдийн уран зохиолын номын үзэсгэлэнг дэлгэж 739 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
11. Сонгодог зохиолууд номын үзэсгэлэнг дэлгэж 345 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
12. Түүхийн жимээр аялахуй номын үзэсгэлэнг дэлгэж 402 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
13. Шинэ номын үзэсгэлэнг дэлгэж 574 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
14. Таньд хэрэгтэй номын үзэсгэлэнг дэлгэж 521 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
15. Шинжлэх ухааны номын үзэсгэлэн
16. Монголын хүүхдийн зохиолчдын номын үзэсгэлэн
17. Дэндэвийн Пүрэвдорж зохиолчийн номын үзэсгэлэн
18. Шинэ номын үзэсгэлэн

7. КАТАЛОГИ, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн номзүйн ажлыг хэрэгжүүлэх, уншигч хэрэглэгчдэд төрөл бүрийн номзүйн лавлагаа мэдээллийг өгөх, католог зохион байгуулах ажлын хүрээнд жилийн байдлаар төсвийн хөрөнгөөр 213 ширхэг 5,010,400 төгрөгний ном, Хандиваар 213 ширхэг 2,739,155 төгрөгний нийт 426 ширхэг 7,49,555 төгрөгний номуудаар фондоо бүрдүүлэн ажилласан. Номын сангаар үйлчлүүлж байгаа 126 уншигчдад номзүйн лавлагаа, 86 иргэнд сэдэвчилсэн лавлагаа өгч, соёл олон нийтийн 16 ажилд оролцсон байна.

Монгол улын Ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд 15 ажил арга хэмжээ зохион байгуулж нийт 3610 хүүхэд багачууд эцэг эхчүүд хамрагдсан. Танхимаар 873 иргэд, цахимаар 2737 иргэд хамрагдсан.

Уншигч хэрэглэгчдэд ном хэвлэлийг сурталчлан таниулах зорилгоор шинэ номын мэдээ 3 удаа, сэдэвчилсэн номзүйн мэдээлэлийг 6 удаа цахимаар болон танхимаар сурталчилж нийт 2885 хүнд хүрсэн байна.

Номын сангийн 212 уншигчдад төрөл бүрийн лавлагаа мэдээлэл хүргэж, хандиваар ирсэн номуудын каталогийн картыг хэвлэн, нийт 263 ширхэг карт шоголд байрлууллаа.

Сэлэнгэ аймгийн 18 зохиолчдын ном хэвлэлээр 317 ширхэг картын санг зохион байгуулж, сумдын соёлын төвийн номын санчдад танилцуулан, сурталчилсан.

Уг картын санг номын сангаар үйлчлүүлж байгаа 162 уншигч хэрэглэгчид үзэж сонирхсон байна.

Орон нутгийн зохиолчдын номзүйн бүртгэл гаргах зорилгоор зохиолчидтой уулзаж, судалгаа хийж, мэдээлэл цуглуулах, ажлыг хийж байна. Одоогийн байдлаар Сэлэнгэ аймагт уран бүтээлээ туурвиж байсан болон одоо ажиллаж амьдарч байгаа 62 зохиолчдын намтар уран бүтээлийг судлаад байна. Цаашид өөр орон нутагт амьдарч байгаа зохиолчдын мэдээллийг хүлээн авах, уулзах ажлуудыг төлөвлөн, зохиолчдын намтар уран бүтээлийн мэдээллийг шинэчилсээр байна.

Түүх, соёл урлаг, ардын аман зохиол, бүтээлийг иргэд олон нийтэд сурталчлах зорилгоор монгол гэрийн үүсэл хөгжлийн талаар цахимаар сурталчлан 820 гаруй иргэдэд хүрсэн байна.

Соёлын яамнаас орон нутгийн соёлын төвийн номын сангуудад олгосон санхүүжилтийн судалгааг 17 сумын соёлын төвөөс авч холбогдох байгууллагад хүргүүлсэн. 16 иргэдэд лавлагаа мэдээлэл өгч, хандиваар ирсэн номуудын каталогийн картыг хэвлэн, нийт 26 ширхэг карт шоголд байрлууллаа.

Сэлэнгэ аймгийн зохиолчдын ээлжит хуралдаанд оролцон үйл ажиллагаатай нь танилцаж цаашид хийх арга хэмжээнд нь хамтран ажиллахаар боллоо. Мөн МЗЭ-ийн гишүүн Т.Доржсүрэн Сэлэнгэ аймгийн зохиолчдын номзүйн бүртгэл гаргах ажлыг дэмжин хамтран ном хэвлэх ажилд оролцохоо илэрхийлж нийт зохиолчдын материалуудтай танилцаж байна.

Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгоны номын сангуудын статистик тайлан мэдээг цахимаар хүлээн авч нэгтгэн МҮНСанруу илгээсэн.

1-р улиралын үйл ажиллагааны судалгаа, тайлан мэдээг нэгтгэн удирдах газарт илгээсэн.

Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэгчдэд зориулан мэдээлэл, зөвлөмж, номын танилцуулгуудыг 2 удаа хүргэж нийт 356 иргэд олон нийтэд хүрсэн байна.

Сэлэнгэ аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэлэлцүүлэг”-т хамт олноороо оролцсон.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүр зохион байгуулдаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын арга хэмжээг “Үндэсний бичиг үсэг-Үндэсний өв соёл” уриатайгаар 2023 оны 05-р сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд Соёл Урлагын Газар, Боловсрол, Шинжлэх Ухааны газар, Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгатай хамтран үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөж нэгдсэн удирдамжийг гарган удирдлагуудаар батлуулан ажилласан. Мөн Засаг даргын дэргэдэх хэлтэс агентлагууд, аж ахуй нэгж байгууллагын албан хаагчдын дунд “Шилдэг үндэсний өв тээгч”, “Шилдэг үндэсний бичиг үсэг сонордуулагч” уралдаануудыг зохион байгуулахаар болж удирдамжийг Сүхбаатар сумын 34 байгууллагад хүргүүлэн ажилласан байна.

“Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд “Гоо зүйн хүмүүжлийн сургалт”-ыг ЕБС-ын 12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж нийт 45 сурагчдыг хамруулан зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мөн Соёлын эрхийн бичгийг хэрхэн ашиглах талаар ЕБ-ын сургуулийн 216 сурагчдад мэдээлэл өгсөн.

Соёлын салбарын ажиллагсдын зөвлөгөөн, тайлан хамгаалах уулзалтанд хамт олноороо оролцож, 3 сургалтанд хамрагдсан.

Хамт олноороо “Хос бичигтэн” болох зорилтын хүрээнд Монгол бичгийн анхан шатны хичээлүүдийг заалган суралцаж, унших, бичих, чадвараа сайжруулан хамрагдсан.

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын ерөнхий газраас “Газар хөдлөлтөөс өөрсдийгөө болон гэр бүлээ хэрхэн хамгаалах вэ? сургалтанд хамрагдаж, анхан

шатны тусламж хэрхэн үзүүлэх талаар, шарханд хэрхэн боолт хийх, чиг тавьж боож сурах, тархины гэмтэлд хэрхэн боолт хийх талаар суралцсан.

Дэлхийн зөн олон улсын байгууллагаас зохион байгуулсан “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх” сургагч багш бэлтгэх 2 өдрийн сургалтанд хамрагдсан. Уг сургалтыг гэр бүл, албан байгуулагуудад зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн үйлдвэрчний эвлэлийн сургалтанд хамт олноороо хамрагдсан.

НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн үйлчилгээг цахимжуулах, иргэд уншигчдад хандсан номын сангийн мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор ажиллаж байна. Сургалт мэдээлэл 4 удаа нийт 75 хүн, тохижилтын ажил 1 удаа, Сэтгүүл 2 удаа 200 ширхэг, гарын авлага 80ш, бусад төрлийн хэвлэлийн бүтээгдэхүүн 437ш, цахим мэдээлэл 19, постер 18 бэлтгэн гаргасан байна.

Номын сангийн Вэб сайтад ажиллах заавар хичээлийг үйлчилгээ үзүүлэгч компанитай хамтран бэлтгэж Вэб сайтын ажиллах зарчим болон цаашдын чиг хандлагын тухай номын санчдад 2 удаа сургалт мэдээлэл хүргэж давтан тоогоор 14 хүн хамрагдав. Номын сангийн вэб сайтын сурталчилгааны 4 төрлийн постер, QR code бүхий 300ш хэвлэмэл материал бэлтгэн гаргав. Цахим орчинд вэб сайтруу нэвтрэх хаяг бүхий сурталчилгааг нийт 13 удаа хийв.

“НОМЫН САНЧ” онол аргазүйн сэтгүүлийг Аргазүйч, Номын санчтай хамтран хоёр дугаар бэлтгэж 200 ширхэгийг хэвлэсэн.Ардын аман зохиолыг сурталчилан таниулах зорилгоор номзүйчтэй хамтран гарын авлага бэлтгэж Номын баярын арга хэмжээнд нийт 80 ширхэгийг хэвлэн тараав.

Аргазүй мэдээллийн танхимын зурган самбарын зургуудыг болон ГНОТ болон ХУТ-уудын номын ялгагч, номын сангийн шинэ уншигч болох танилцуулгыг бүрэн шинэчлэн сайжрууллаа.

Аргазүйн танхим, ГНОТ, ХУТ-уудын ажлын хүрээнд “Үндэсний бичиг үсгийн баяр”,2 удаагийн “Номын баяр”, “Соёлын сэргэлт” арга хэмжээ, Соёлын бүтээлч сар, Үндэсний бахархалт ном судрыг сурталчлан таниулах гэх мэт нийт 19 ажил арга хэмжээний хүрээнд 56 төрлийн 954 ширхэг тараах материал, бусад 11 төрлийн 32 ширхэг хэвлэлийн бүтээгдэхүүн, 36 төрлийн постер, 12 төрлийн 44 ширхэг өргөмжлөл, талархал, 3 төрлийн 4 ширхэг видео бэлтгэн гаргаж бүхий л төрлийн ажил, арга хэмжээнд иргэд, уншигчдад тараав.

Монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан Хилийн 0101-дүгээр анги болон Гэрээр ном олгох, нийтийн уншлагын танхимтай хамтран өсвөр насны хөвгүүдэд зориулж “Бид эх орны хөвгүүд ” цэргийн алба, амьдралыг танилцуулах уулзалт зохион байгуулж зураг, видео бэлтгэв.

Хилийн 0243 дугаар ангийн номын санч, Ухаарлын жимээр ТББ-тай хамтран ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад Бэлтгэл хурандаа асан Бат-Очир гуайн дурсамж уулзалт зохион байгууллаа. Уг уулзалтын 2 төрлийн бичлэг, зураг бэлтгэн цахим хаягаар сурталчлав.

Номын сангийн цахим номын баазад нийт 400 ширхэг гадаад монгол ном болон 107 ширхэг сонсдог номыг шинээр байршуулсан ба номын сангийн цахим хуудсанд нээлттэй хэлбэрээр 150 ширхэг номыг унших татах боломжтойгоор байршуулсан ба 50mbps бүхий өндөр хурдны интернэтийг байгууллагын дотоод хэрэгцээнд ашиглахаас гадна уншигч үйлчилүүлэлгчдэд зориулан “FREE WIFI ZONE” буюу нээлттэй интэрнэт орчин бүрдүүлэн ажиллаж байна.

Загвар номын сангийн ажлын хүрээнд Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 5-р сургуулийн номын санд 3000 гаруй номыг дансалж, номын сан номзүйн ангилалаар ангилж, техник ажиллагаа хийн фондонд байрлуулах ажилд хамтарч ажиллав.

E-mongolia цахим платформд номын сангийн үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр Номзүйчтэй хамтран 4 төрлийн үйлчилгээний загварыг бэлтгэн холбогдох нэгжид хүргүүлэв.

“Соёлын бүтээлч сар 2023”-н хүрээнд 2 удаагийн арга хэмжээг хамтран зохион байгуулж 4 төрлийн 18 ширхэг постер бэлтгэн shoppy.mn-д үйлчилгээгээ байршуулах ажлыг хамтран хийж гүйцэтгэв.

- “Номын хотхон”-ы үйл ажиллагааны хүрээнд 2 төрлийн постер 1 удаагийн цахим мэдээлэл 60ш тараах материал хэвлэн хүүхэд багачуудад бэлтгэн хүргэлээ.

- Соёлын сэргэлт аяны хүрээнд зохион байгуулагдах ажлуудтай холбоотой 3 төрлийн постер, 100 ширхэг тараах материал хэвлэн сурталчлав.

- Байгууллагын дотоод сүлжээнд засвар, эмхэтгэл хийв.

- “ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ЦАХИМ ХӨГЖЛИЙН ЖИЛ” уриатай 2023 оны аймгийн жилийн төлөвлөгөөнд Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн хэрэгжүүлэх “Цахим хөгжил”-ийн төлөвлөгөөг бэлтгэв.

Сумдын номын сангийн хүрээнд

Аймгийн сумд болон сургуулиудын нийт номын санчдад Номын сангийн программын шинэчлэлтэй холбоотойгоор “Үүлэн технологид суурилсан номын сангийн программ” сэдэвт сургалтыг зохион байгуулж 24 номын санч хамруулслаа. Сум болон сургуулийн номын санчдийн мэдээлэл солилцох 41 гишүүнтэй 37 хүнд facebook group үүсгэсэн бөгөөд түүгээрээ дамжуулан Lib4u cloud программын мэдээллийг 1 удаа бэлтгэн нийтэлсэн, мөн ZOOM-р 1 удаагийн сургалт зохион байгууллаа.

8. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аргазүйн ажлын хүрээнд сумд болон сургуулиудын номын санчдад аргазүйн зөвлөгөөг Сэлэнгэ аймгийн нийт давхардсан тоогоор 188 номын санчдад танхимаар 18, цахимаар 10 удаа сургалт зохион байгуулж мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Төрөөс баримтлах бодлого алсын хараа-2050 хэрэгжүүлэх ажлын хүрээнд 144 номын санч мэргэжлийн ажиллагсдыг хамруулслаа.Үүнд:

- Номын сангийн өнөөгийн байдал цаашдын чиг хандлага
- ЕБСургуулийн номын санчдад “Өөрийгөө хөгжүүлэх”
- Төвийн бүсийн номын санчдад “Загвар номын сан” үйл ажиллагаа
- "Дижитал номын сангийн туршлага" олон улсын туршлага
- МУҮНС-ын ACIP төслийн дижиталчлалын туршлага хөтөлбөрийн талаар сургалт
- Дэлхийн олон улсын номын сангийн үнэт зүйл, чиг хандлага
- Орон нутгийн онцлогт тохирсон инновацийг тодорхойлох, хөгжүүлэх, иргэн төвтэй номын сангийн үйл ажиллагааны туршлага зэрэг сургалт зохион байгууллаа.

Номын санчдад зориулж тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэхийн тулд “Номын санд хөтлөгдөх маягт,бүртгэл дэвтрүүдийг хөтлөх” , “Номын сангийн зарим дүрэм, журам” гарын авлага , “Номын санч онол аргазүйн сэтгүүл”-ын хоёр дугаар гарган номын санчдад хүргэв.

Нийтийн номын сангийн мэргэжлийн ажилтан албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх мэргэжлийн ур чадварын тэмцээнийг гурван үе шаттайгаар зохион байгуулсан.

Загвар номын сангийн үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ЕБ –ийн 5-р сургуулийн номын сангийн фондыг номын сангийн стандартын дагуу зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэ ажлын хүрээнд төвийн бүсийн 12 номын санчийг хамруулан дадлагад суурилсан сургалтыг явуулж нийт 3000 гаруй номонд тенхик ажиллагаа хийж номын сангийн нэг бүрчилсэн бүртгэлд дансалж, ангилав.

Номын сангийн үйл ажиллагааны хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд , Хилийн цэргийн 0101-р цэргийн анги, Сүхбаатар сумын МСҮТ –ийн нийт 67 албан хаагч, сурагчдад ном хэвлэлийн хэрхэн унших талаар “Ном унших ач тус” ,” Хүүхдийн уншлагыг удирдахуй “ сэдвээр сургалтыг зохион байгууллаа.

Шаамар МСҮТ- номын сантай хамтран нэрт зохиолч Хөдөлмөрийн баатар, Төрийн соёрхолт, Ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн 90 насны ойг угтан, уран бүтээлийг нь сурталчлан танилцуулах, алдаршуулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Үйл ажиллагаанд МСҮТ-ийн 35 гаруй багш, сурагчид идэвхтэй оролцон, сурагчид “Тусгаар тогтнол”, ”Сэгс цагаан богд” зэрэг алдарт найраглалуудыг уншиж сурталчиллаа.

Аймгийн хэмжээний нийтийн болон ерөнхий боловсролын сургуулийн номын санчдын дэлгэрэнгүй судалгааг нэгтгэн шинэчиллээ.

Сэлэнгэ аймгийн номын санчдын судалгаа

Нэр	Номын санчийн тоо	Номын санч мэргэжилтэй	Мэргэжлийн бус
Аймгийн нийтийн номын сан	9	5	4
Мандал нийтийн номын сан	4	2	2
Соёлын төвийн номын санч	20	15	5
ЕБС-ийн номын санч	39	11	28
Нийт	72	33	39

МУИС –ийн номын сангаас зохион байгуулах сургалттай холбогдуулан, сумдын соёлын төвийн болон ерөнхий боловсролын 50 гаруй номын санчдаас, сургалтын санал болон замын зардлын судалгааг гаргалаа.

2025 оноос албан бичиг хос бичгээр хөтлөх журмын дагуу өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэн монгол бичгийн сургалтанд хамрагдан суралцлаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 100 жилийг ойг угтан, аймгийн ЗДТГ- ааас зохион байгуулсан “Үндсэн хуулийн дугуйлан төсөл” сургалтанд хамрагдаж цаашид хийх арга хэмжээнүүдтэй танилцлаа

Аймгийн цагдаагийн газраас зохион байгуулсан “Анзаар” сэдэвт хүүхэд залуучуудыг хараа хяналтгүй орхих ,буруу үйлдэлд уруу татагдагдах байдлаас сэргийлэх тухай сургалтанд хамрагдлаа.

МУЗГХЭГ-аас зохион байгуулсан Монгол Улсын Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах хэлэлцүүлэгт оролцлоо.

9. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь нийт 18 орон тоогоор батлагдаж үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнээс 8 нь захиргаа үйлчилгээний ажилтан, 10 Мэргэжлийн ажиллагсад ажиллаж, төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд үзүүлж байна.

Номын санчдын мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлж, сургалт семинарт тогтмол хамруулж, ажлын байрандаа хөгжих боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. “Монгол Улсын Үндэсний Номын Сан”, “Авсралийн Элчин Сайдын Яам”-ны хамтарсан цахим болон танхимын сургалтаар “Хил хязгааргүй номын сан төсөл” сургалтанд хамрагдаж туршлага хуримтлуулсан. Нийт сумдын болон Ерөнхий боловсролын сургууль, байгууллагын 56 номын санчдыг хамруулан зохион байгуулав.

Улаанбаатар хотын Хүүхдийн төв номын сантай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн номын санчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, туршлага солилцох танилцах арга хэмжээнд хамрагдсан. Цахим болон танхимын сургалтанд нийт 85 номын санч хамрагдсан.

Монголын Үндэсний номын сангийн аргазүйн хэлтсээс зохион байгуулсан “Цахим сан хөмрөг бүрдүүлэх тухай”,”Аймаг Нийслэлийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийг шинэчлэх” санал асуулга,”Соёлын бодлого ба бүтээлч үйлдвэрлэл”,”Соёлын бодлого хэрэгжилтийг үнэлэх үзэл баримтлал,бодлого хэрэгжилт” зэрэг цахим сургалтанд хамрагдлаа.

Номын санд ажиллагсдад тулгарч буй бэрхшээл

- Номын санчдыг хөгжүүлэх нэгдсэн бодлого байхгүй
- Номын санчдыг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт семинарт хамруулах төсөв, санхүүгийн дэмжлэг байхгүй.
- Номын санчийн нийгмийн асуудалд анхаардаггүй, төрөөс гаргасан бодлого шийдвэр нь хэрэгждэггүй зэрэг шалтгааны улмаас мэргэжлийн боловсон хүчин хүний нөөцийн хангамж дутмаг байгаагаас номын санд мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байгаа нь номын сангийн үндсэн үйл ажиллагааг алдагдуулж номын сангийн салбар хөгжихгүй байх гол шалтгаан болж байна.

10. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

Номын сангийн төсвийг үр дүнтэй удирдаж 2023 онд өр авлага үүсгэхгүй ажиллаж, сар бүрийн 15-нд шилэн дансандаа мэдээлэл оруулж, ил тод байдлыг самбарыг тогтмол хөтлөн ажилласан.

11. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгууллагын хүүхэд хамгаалах баримт бичгийг боловсруулж, Нэгдүгээрт хүүхдэд аяны хүрээнд орсон орлогын 30% хүүхдэд зориулсан үйл ажиллагаанд зарцуулсан. Хүүхэд хамгааллын хүрээнд “Сэтгэл хөдлөлийн оюун ухаан”, “Хүүхэд хамгаалал”, “Гэр бүл, нийгэм дэх хүүхэд хамгаалал” “Иргэд орон нутгийн оролцоо-хөгжлийн түлхүүр, хурдасгуур болох нь” 4 сургалтыг ТББ, иргэд олон нийтэд зохион байгууллаа.

“Угийн бичгээ хөтөлж-Ураг удмаа мэдье” сургалтыг Сэлэнгэ аймгийн нийт угийн бичиг хариуцсан 56 мэргэжилтнүүд дунд цахимаар зохион байгууллаа.

Тусгай хэрэгцээт иргэдэд зориулж 4 арга хэмжээ явуулав. “Сэтгэлд хоногшсон өдөрлөг”, “Танин мэдэхүйн АХА” тэмцээн, ДЗОУБ-тай хамтран “Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө” сургалт зохион байгууллаа. Сургалт өдөрлөгт, 52 иргэн хамрагдсан.

Орон нутгийн онцлог болон номын сангийн онцлогийг тусгасан “Сарнай ба Буудай” брэндийн дүр төрхийг нэхмэл хүүхэлдэйгээр бий болгож, брэнд дүр бүтээх 4 сургалт арга хэмжээг зохион байгууллаа. Нийт 75 иргэн хамрагдлаа.

Зохист аялгуу хүүхдийн богино өгүүллэгийн наадмын оролцогчдын 2022, 2023 онуудын сурагчдын бүтээл болон сургамжит өгүүллэг уралдаанд ирсэн бүтээлүүдийг нэгтгэн зохиолч, яруу найрагч Т.Доржсүрэн хянан тохиолдуулан ном болгон хэвлэн гаргалаа.

12. ХАВСРАЛТ /ЗУРАГ, СХЕМ, ДИАГРАММ/

Уншлага үйлчилгээний схем 1

2023 оны Соёл олон нийтийн ажлын тоон үзүүлэлт

Д/д	Зохион явуулсан Соёл олон нийтийн ажил	Хамрагдсан оролцогчид		Зарцуулсан төсөв	Зохион байгуулсан огноо
		Бүртгэлтэй	Бүртгэлгүй		
1.	Өвлийн хөтөлбөр	80			2023.01.04
2.	Хүүхэд багачуудад эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх арга хэмжээ	44			2023.01.06
3.	Номтой зөвлөмж	600			2023.01.07. -12.07
4.	Хүүхдэд зориулсан Монголын нууц товчоог сурталчлах	51			2023.01.07
5.	Монголын алтан үе болон шинэ үеийн зохиолчдыг сурталчлан таниулах	585			2023.01.15-12.25

6.	Монгол өв соёл, ёс заншил сурталчлах	206			2023.01.10-12.25
7.	Дэлхийн сонгодог зохиол сурталчлах таниулах	1064			2023.01.15-12.25
8.	Номтой зөвлөмж	600			2023.01.15-12.25
9.	Үлгэрээр хүмүүжье чанга уншлага	286			2023.01.20-10-20
10.	Номтой цаг	255			2023.01.21-12.01
11.	Олуулаа уншъя урилгат уншлага	308			2023.01.25-12-11
12.	Тоглонгоо уншъя	110	126		2023.01.28-05.25
13.	Монгол баатарлаг туульсаа түгээн дэлгэрүүлэх	100			2023.02.07
14.	Ном хэвлэл сурталчлах, номын санг танилцуулах		13		2023.02.09
15.	Урилгат уншлага	235			2023.02.12-10-22
16.	Монголын нууц товчоо сурталчлах	20			2023.02.28
17.	“Сэтгэлд хоногшсон...” өдөрлөг	12			2023.03.17
18.	Бид эх орны хөвгүүд	20	2		2023.03.28
19.	Улирлын шилдэг уншигч шалгаруулах	4			2023.04-12.25
20.	Үндэсний бичиг үсгийн баяр	27			2023.05.05
21.	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ		85		2023.05.09
22.	Үндэсний бичиг үсэг номын баяр 33, 34 дэх удаагийнх	545	950		2023.05.20, 09.14
23.	Байгаль бидний гэр гар зургийн уралдаан	42			2023.06.01
24.	Номын хотхон	235	315		2023.06.01

25.	Соёлын сэргэлт-2023	88	200		2023.06.05
26.	Оюунлаг бүтээлч ирээдүйн төлөө уриатай “Зуны хөтөлбөр”	146	76		2023.06-12-08.22
27.	Бяцхан санхүүч	16			2023.06.12
28.	Номын сантай танилцах аялал	32	102		2023.06.13-12.04
29.	Зуны зугаатай аялал	16			2023.07.04
30.	Талархалын зан чанарын сургалт	25			2023.08.08
31.	Эрдмийн баяр	88	64		2023.09.01
32.	Танин мэдэхүйн өртөөчилсөн аялал	25			2023.09.28
33.	Хил хязгааргүй номын сан төсөл	8	48		2023.09.21
34.	Зохиолч уншигчдын уулзалт	86	174		2023.09.29
35.	Ахмадын баярт зориулсан АХА тэмцээн	67	83		2023.10.01
36.	Д. Пүрэвдорж зохиолчийн намтар уран бүтээл сурталчлах	53	32		2023.10.12
37.	Соёл урлагын байгууллагатай танилцах аялал- Мэргэжил сурталчлах өдөрлөг	10	8		2023.10.23
38.	Соёлын бүтээлч сар Бүх нийтийн соёлын боловсрол	113	285		2023.11.01
39.	“Зохист аялгуу-2023”	8	15		2023.11.13
40.	“Тэргүүний уншигч Д. Нацагдорж тэмдэгтэн сурагч болцгооё” аян зохион байгуулах	6	46		2023.11.17
41.	Номын сангийн дэргэдэх номын клуб байгуулах	10	15		2023.11.22
	Нийт дүн	6226	2639		

Номын үзэсгэлэн

д/д	Номын нэр	Дэлгэгдсэн номын	Хамрагдсан хүүхдийн тоо

		Тоо	
1.	“Монгол тууль” номын үзэсгэлэн	34	789
2.	“Багачууд” номын үзэсгэлэн	55	330
3.	Шинэ номын үзэсгэлэн	142	574
4.	Заавал унших номын үзэсгэлэн	59	330
5.	Шинжлэх ухааны номын үззсгэлэн	62	501
6.	Х. Андерсен зохиолчийн номын үзэсгэлэн	38	66
7.	Яруу найргийн номын үзэсгэлэн	34	510
8.	Монгол ардын аман зохиолын номын үзэсгэлэн	74	405
9.	Түүх номын үзэсгэлэн	88	542
10.	Бичиг үсэг өв соёл номын үзэсгэлэн	54	684
11	Англи номын үзэсгэлэн	62	532
12	Хүүхдийн уран зохиолын номын үзэсгэлэн	92	739
13	Сонгодог зохиолууд номын үзэсгэлэн	49	345
14	Түүхийн жимээр аялахуй номын үзэсгэлэн	65	402
15	Таньд хэрэгтэй номын үзэсгэлэн	96	521
16	Монголын хүүхдийн зохиолчдын номын үзэсгэлэн	36	156
17	Дэндэвийн Пүрэвдорж зохиолчийн номын үзэсгэлэн	29	114
18	“Төрийн шагналт зохиолууд “номын үзэсгэлэн	55	189
19	“Монголын шилдэг уран зохиол” номын үзэсгэлэн	135	238
20	“Монгол төрийн хаадууд “номын үзэсгэлэн	115	415
21	Түүхэн номын үзэсгэлэн	43	312
	Нийт	1417	8694

Соёл олон нийтийн ажлын зурган тайлан

1. Зохиолч уншигчдын уулзалт

2. “Соёл урлагийн байгууллагатай танилцах аялал-Мэргэжил сурталчлах өдөрлөг”

“Зохист аялгуу-2023” хүүхдийн богино өгүүллэгийн наадам



3. Үндэсний бичиг үсгийн баяр

“Илүү их уншъя” уриатай 33 дахь Номын баяр

“Илүү их уншъя” уриатай 34 дэх удаагийн Номын баяр

4. Соёлын сэргэлт

5. Соёлын бүтээлч сар

6. Тоглонгоо уншъя өдөрлөг Өвлийн хөтөлбөр

7. Зуны хөтөлбөр

8. Үлгэрээр хүмүүжье чанга уншлага

9. Урилгат уншлага

10. Олуулаа уншъя уншлага

11. Номын сантай танилцах аялал

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023
ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ: ТӨРИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, НОМЫН САНГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

1.1 Монгол улсын төрийн бодлого, чиглэлийн хүрээнд номын сангийн үйл ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулах, хэрэгжилтийг хангах: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", "Монгол улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Төрөөс соёлын талаар баримтлах бодлого", Монгол улсын Засгийн газар болон Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүд, Аймаг, сумын 2023 оны хөгжлийн төлөвлөгөө зэрэг төрийн бодлого, чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор тухайн бодлого, хөтөлбөрүүдэд номын сан, соёлын талаар тусгасан заалтуудын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг байгууллагын 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.

1.2 Соёл, урлагийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн "Цахим соёл, "Бүх нийтийн соёлын боловсрол", "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II" үндэсний хөтөлбөрүүд, "Номын сайн нөхөр" сумын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах:



“Цахим соёл”, “Бүх нийтийн боловсрол”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөр, “Соёлын баримтат өвийг хамгаалах” үндэсний хөтөлбөр, “Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, БСШУЯ-ны “Номын сан, соёлын салбарын талаар төрөөс баримтлах бодлого” хөтөлбөр, “Соёл, урлаг хүний хөгжилд” аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах, Монголын уламжлалт бичиг соёлын өвийг хадгалан үлдээх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах, иргэд, хүүхэд, залуусыг номтой нөхөрлүүлэх ажлуудыг байгууллагын бодлого төлөвлөлтөд тусган хэрэгжилтийг хангаж байна.

Иргэдэд үйлчлэх номын сангийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, уншигчдад хүрч үйлчлэх, номоор дамжуулан иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор цахим хэрэгслийг ашиглан 230 удаа цахим мэдээлэл оруулж, 12666 удаагийн хандалттай ажиллаж, үндэсний болон танин мэдэхүйн сэдэвт соёл, олон нийтийн ажлыг 12 удаа зохион байгуулж, нийт 46 байгууллага, 2813 хүнийг хамруулллаа. Мөн албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлж, чадваржуулах сургалтад хамруулж албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлж байна.

1.3 Аймгийн "Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн *жил"* зарласан жилийн хэрэгжилтийг хангах: Аймгийн "Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн *жил"* зарласан жилийн хэрэгжилтийг хангах зорилгоор 5 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Уншигчдад үйлчлэх цахим үйлчилгээнд ашиглах 5ш 8039,600 төгрөгийн үнэ бүхий компьютер техник, хэрэгслийг шинээр авч, цахим мэдээлэл, цахим номоор уншигчдад байгууллагын цахим хуудас болон цахим фондоор дамжуулан үйлчилж байна.

1.4 Номын сангийн олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлж, иргэд, байгууллагуудтай хамтран ажиллах: Хамтран ажилладаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн хүмүүжигч С.Очиртөмөрийн хүмүүжих хугацаандаа бичсэн "77" нэртэй шүлгийн номын нээлтэд оролцож, арга хэмжээнд хамрагдсан 256 хүний дунд номын үзэсгэлэн, танин мэдэхүйн асуулт, хариултын уралдааныг зохион байгуулж, шагнаж урамшууллаа.

“Амар амгалан маргаашийн Монгол” НҮТТБ-аас санаачлан зохион байгуулж буй “Хамтаараа амьдрах соёл” соёл, төлөвшлийн урт хугацааны хөтөлбөр, нөлөөллийн аянд нэгдэж, “Хамтаараа амьдрах соёл” цахим хуудсанд нэгдэж, байгууллагын цахим хуудсанд брэнд бүүкийг байрлуулж, өөрийн профайл зурагт “Мэндэлье, Хүндэлье, Хайрлая” хүрээг нэмж, албан хаагчид болон уншигчид, иргэдэд мэдээллийг түгээж ажиллаж байна. Мандал сумын зохиолч, уран бүтээлчдийн “Хараагийн уянга” нэгдэлтэй хамтран ажиллаж, 2 Соёл олон нийтийн ажлыг хамтран зохион байгууллаа.

ХОЁР: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭЛТГЭХ, ЧАДАВХЖУУЛАХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

2.1 “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”, “Хүний хөгжлийн бодлого”, “Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлж, албан хаагчдыг сургалтад хамруулах: “Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2022-2024” богино хугацааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг хангаж, төв, орон нутгийн сургалт, хэлэлцүүлэгт 23 удаа 54 албан хаагч, ажлын байрны сургалтад 5 удаа 33 албан хаагч, нийт 28 удаагийн сургалтад давхардсан тоогоор 87 албан хаагчийг хамруулсан нь тайлант оны төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжиж буй үр дүнтэй байна.

№	Сургалтын нэр	Хэзээ	Хүний тоо	Хаанаас зохион байгуулсан
Нэг. Төв, орон нутгийн богино хугацааны сургалт				
1	Соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны ажлын төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, салбарын удирдах ажилтны чадавхыг дээшлүүлэх сургалт, хэлэлцүүлэг	2023.01.16-2023.01.17	1	Сэлэнгэ аймаг Соёл урлагийн газар
2	Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд нэмэгдэл цалин хөлс бүртгэх, зөвлөмж өгөх уулзалт	2023.01.19	1	Төрийн албаны зөвлөл
3	Авилгаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал	2023.02.02	1	Авлигатай тэмцэх газрын ахлах комиссар П.Нарантуяа
4	“Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин”	2023.02.09	3	Төрийн албаны зөвлөл
5	Төрийн албан хаагчдын зөвлөгөөн	2023.02.17	1	Сумын ЗДТГ
	“Анзаар” сургалт, нөлөөллийн арга хэмжээ	2023.03.15	6	Мандал сум Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
7	“Үндсэн хуулийн мэдлэг” сургалт	2023.03.29	2	Сумын ЗДТГ
8	“Алсын хараа-2050 шинэ сэргэлтийн бодлого” цахим сургалт	2023.04.27-2023.05.03	1	Удирдлагын академи
9	“Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих шаардлага” сургалт, СУГ-аас зохион байгуулсан “Тушаал хэрхэн төлөвлөх вэ?” арга зүйн сургалт	2023.05.12	1	Аймгийн Засаг Даргын Тамгын Газар
10	Хүний эрхийн комиссын танилцуулга, хүний эрхийн тухай ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага	2023.05.16	3	Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс
11	“Сэтгэлзүй”-н сургалт	2013.05.26	2	УИХ-ын гишүүн Д.Өнөрболорын ажлын албанаас
12	“Үр дүнд суурилсан санхүүжилт”	2023.04.20	1	Соёлын яам
13	Тушаал хэрхэн төлөвлөх талаар арга зүйн сургалт	2023.05.10	1	Сэлэнгэ аймаг СУГ
14	Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” сургалт	2013.05.26	3	Төрийн албаны зөвлөл
15	“Нудээ нээе”	2023.09.11	5	Мандал сумын Засаг дарга
16	“Хил хязгааргүй номын сан”	2023.09.19	1	Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар
17	Соёлын эрхийн бичгийн талаарх давтан сургалт	2023.10.17	3	Сэлэнгэ аймаг Соёл урлагийн
18	“номын санч, Нийгмийн ажилтныг цахим ур чадвар олгох сургагч багш бэлтгэх” сургалт	2023.10.18	1	Монгол улсын цахим хөгжил, харилцаа холбооны яам
19	Соёлын эрхийн бичгийн талаарх давтан сургалт	2023.10.19	3	Соёлын яам

20	“Номын санч-хөгжлийн хөтөч”	2023.10.20	3	Сэлэнгэ аймгийн н Нийтийн Номын сан
21	Орон нутаг дахь хүгий эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам”	2023.10.23	6	Сэлэнгэ аймгийн засаг дарга
22	Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын сургалт	2023.10.25-27	3	Мандал сумын Засаг даргын Тамгын газар
23	Номын сангийн үндэс	2023.12.11-12.21	2	Соёл урлагийн Их сургууль
23 удаа 54 хүн хамрагдсан				
Хоёр. Ажлын байрны сургалт				
1	“Хос бичигтэн” сургалт	2022.12.28-2023.01.20	8	Багш Х.Бямбасүрэн
2	“Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах”, “Галын аюулгүй байдлын тухай хууль”-ийн дагуу иргэн, аж ахуй нэгж байгууллагын эрх, үүрэг хариуцлага, гал унтраагуурын ажиллах зарчим, техник үзүүлэлт, гал түймэр гарсан үед гал унтраах шуурхай төлөвлөгөөний дагуу хэрхэн ажиллах талаар	2023.05.05	6	Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын Мандал сум дахь Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 19 дүгээр ангиас
3	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу, авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааны талаарх мэдээлэл болон “Амар амгалан маргаашийн Монгол” НҮТТБ-аас санаачлан зохион байгуулж буй “Хамтаараа амьдрах соёл” соёл, төлөвшлийн урт хугацааны хөтөлбөр, нөлөөллийн аяны тухай	2023.05.09	8	Номын сангийн арга зүй албанаас
4	“Төрийн албан хаагчийн ёс зүй”	2023.09.07	5	Номын санч: Г.Одгэрэл
5	“Жендэрт суурилсан хүчирхийлэл”	2023.11.29	6	Номын санч: С.Цэндсүрэн
5 удаа 33 хүн				

Хос бичигтэн сургалт: Хамт олноороо “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын хүрээнд “Хос бичигтэн болцгооё” монгол бичгийн давтан сургалтад хамрагдлаа.

“Монгол бичгийн цагаан толгойн үсэг” нүдлэх, тогтоох, холбох, уншиж, бичих дадлага ажил, монгол хэлний зөв бичгийн дүрэм, найруулга зүй, авиа зүйн 22 цагийн сургалтыг Зүүнхараа Политехник коллежийн монгол хэлний багш Х.Бямбасүрэнтэй хамтран танхимаар зохион байгуулж, албан хаагчдыг бүрэн хамруулж, мэдлэгийг бататгав.

ГУРАВ: НОМЫН ФОНДЫГ БАЯЖУУЛЖ, НОМ ХЭВЛЭЛИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, КАТАЛОГЖУУЛАЛТЫН АЖЛЫГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

3.1 Номын фондын баяжилтыг нэмэгдүүлэх: 2023 онд төсөвт ном худалдан авах зардал тусгагдаагүй бөгөөд номын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор **2876860**

төгрөгийн үнэ бүхий 350 нэр төрлийн 383 ш номыг хандиваар авч, фондын номын нийт тоо 0,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

№	Төрөл	Ямар журмаар авсан	Хаанаас	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнэ
1			Сумын ИТХ-ын ажлын алба	1	3	15300
2			Зохиолч Дамдины.Жамьян	30	30	101020
3			Яруу найрагч Б.Дэлгэрцэцэг	3	9	19140
4	Ном	Хандив	Иргэн П.Энхмаа	63	63	207 900
5			Шонхорбаатар	5	5	12 500
6			Австралийн элчин сайдын яам “Хил хязгааргүй номын сан” төсөл	58	68	2 014 900
			УИХ-ын гишүүн Ч.Ундрам	190	205	726500
	НИЙТ			**350**	**383**	**2876860**

Нийтийн номын сангийн фондын нийт номын дүн:

Он	2021 он	2022 он	2023 он	Үзүүлэлт
Номын тоо	28524	29137	29520	0,61%

3.2 Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, ариутгал, цэвэрлэгээ, сэлбэн засалт хийх: Эрүүл ахуйн шаардлагыг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ном хэвлэлийг уншлагад гаргах, авахдаа ариутгалын уусмалаар тухай бүр тогтмол ариутгаж, фондод 16 удаа ариутгал, халдваргүйтгэл хийсэн нь тайлант оны төлөвлөгөө 53,3 хувиар, ашиглалтын явцад элэгдэж, гэмтсэн нийт 401 ш номд сэлбэн засалт хийсэн нь тухайн оны төлөвлөгөө 80,2 хувиар биелэгдэж буй дүнтэй байна. Шинээр бүрдүүлсэн 194 ш номд техник ажиллагаа хийлээ.

Ном сэлбэн засалт, техник ажиллагааны тоон мэдээ:

	Номын сэлбэн засалт	Техник ажиллагаа
Нийт	**401**	**194**

3.3 Ном, хэвлэлийн анхан шатны данс бүртгэлүүд, номын тооллого тооцоо, цаасан каталогийн зохион байгуулалтыг сайжруулах: Нийтийн уншлагын танхимын ойрын фондод 1 удаа төлөвлөгөөт бус тооллогыг 2023.03.09-2023.03.14-ны өдрүүдэд зохион байгуулж, дутагдсан 43 ш нийт 667,315 төгрөгийн номыг эргүүлэн төлүүлэх ажлыг хийж байна.
Үндсэн фондод орсон, гарсан хүмүүсийн бүртгэлийг тухай бүр хөтөлж ном алдагдахаас сэргийлж байна.
Шинээр авсан 42 ш номыг Monbiblio программын цахим бүртгэлд бүрэн бүртгэлээ.

ДӨРӨВ: ИРГЭДЭД НҮҮДЛИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

4.1 Нүүдлийн номын сангийн үйлчилгээний уншигч, ном олголтыг нэмэгдүүлэх: Сумын төвөөс алслагдсан иргэд, малчдад хүргэх явуулын болон зөөврийн номын сангийн үйлчилгээг сайжруулах зорилгоор жил бүр нүүдлийн номын сангийн үйлчилгээг зохион байгуулж байна. 2023 онд Түнхэл тосгонд 1 удаа 59 ш номоор, 126 уншигчдад, Билүүтийн аманд зуссан 10 өрхийн 51 хүнд 70 гаруй номоор,байгууллага, аж ахуйн нэгж, хаалттай бүлгийн иргэдэд хүргэх зөөврийн номын үйлчилгээгээр ШШГА-ны 413-р ангийн албан хаагч, хүмүүжигчдэд 212 ш номоор 256 хүнд, Мандал сумын 2, 9-р багийн байранд 300 гаруй хүнд 326 ш номоор нийт 733 хүнд 667 ш номоор үйлчилсэн нь тайлант оны төлөвлөгөө олгосон номын тоо 140 хувиар, үйлчилсэн хүний тоо 66,7 хувиар биелсэн дүнтэй байна.

д/д	Байгууллагын нэрс	Хүний тоо	Уншсан номын тоо
1	Түнхэл тосгон	126	59
2	ШШГ 413-р анги	256	212
3	Билүүтийн аманд зусаж байгаа малчдад	51	70
4	2, 9-р багуудад	300	326
	НИЙТ	**733**	**667**

ТАВ: ИРГЭДИЙГ НОМТОЙ НӨХӨРЛҮҮЛЭХ СОЁЛ, ОЛОН НИЙТИЙН АЖИЛ, НОМЫН СУРТАЛЧИЛГАА, ЛАВЛАГАА НОМ ЗҮЙН АЖЛУУДЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

5.1 Соёл олон нийтийн ажлыг зохион байгуулах: Иргэдэд номын сангийн үйлчилгээг сурталчлах, номтой нөхөрлүүлэх, мэдлэгийг нь нэмэгдүүлэх зорилгоор соёл, олон нийтийн ажлуудыг 12 удаа зохион байгуулж, 2813 уншигч, 46 байгууллагыг хамруулаад байгаа нь тайлант оны төлөвлөгөөний биелэлт зохион байгуулсан арга хэмжээний тоо 100 хувиар, хамруулсан хүний тоо 468,8 хувиар хэрэгжиж, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулсан дүнгээр зохион байгуулсан арга хэмжээний тоо 33,3 хувиар буурч, хамруулсан хүний тоо 62 хувиар өссөн дүнтэй байна. Соёл, олон нийтийн ажлын урамшуулал, зохион байгуулалтын зардалд нийт 9,696,700 төгрөгийг зарцууллаа.



<u>Соёл олон нийтийн ажлын сүүлийн гурван жилийн харьцуулалт:</u>

Соёл, олон нийтийн ажлын жагсаалт, тоон мэдээ:

№	Зохион байгуулсан СОНА		Хугацаа	Оролцогчдын тоо	Байгууллагын тоо	**Төсөв**
1	“Номын сан-4 улиралд” Хаврын номын сан: “Анхны яргуй-Шидэт ном” номын тэмдэглэл хөтлөх уралдаан		2023.02.01-2023.03.01	12		1,230,000
2	“Үндэсний Номын баяр”-ыг тохиолдуулан баярын арга хэмжээг зохион байгуулах	“Номтой жагсаал” зохион байгуулах шалгаруулах	2023.05.21	275	7	1,210,800
		“Номын сайн нөхөр” тэргүүний уншигч хүүхэд		3		
		“Шинэ номын худалдаа” зохион байгуулах		131		
		Асуулт, хариултын “АХА” тэмцээн		21		
		Зохиогч, уншигчийн уулзалт	2023.05.30	420	5	
3	“Үндэсний бичиг соёл-номын өдөр”-ийг тохиолдуулан “Монгол өв соёл-Монголын дархлаа” үзэсгэлэн, өдөрлөг зохион байгуулах		2023.09.15	683	4	900,000
4	“Угийн бичгээ хөтөлж-ураг удмаа мэдэцгээе” сургалт, өдөрлөгийг зохион байгуулах.		2023.11.28-2023.12.09	154	2	2,198,600
5	“Хараагийн аялгуу-9” хүүхдийн яруу найргийн наадам		2023.04.05-2023.04.30	26		688,000
6	“Гэрийн шилдэг номын сан” -г шалгаруулах уралдаан		2023.04.24-2023.05.10	8	1	936,000
7	“Мөрөөдлийн ном” хаалттай болон зорилтот бүлгийн иргэдийг номтой нөхөрлүүлэх 1 сарын аян		2023.04.24-2023.05.10	10		1,376,500
8	Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Эх хэлний өдөр зарлах тухай” 25 дугаар зарлигийн хүрээнд “Хос бичигтэн болж-Зөв найруулж бичиж сурцгаая” аян		2023.09.15-2023.09.30	720	24	450,000
9	“Бүх нийтийн уншлага” ном уншлагын 1 сарын аян		2023.10.01-2023.10.31	300	2	50,000
10	“Миний сайхан Мандал сум” түүх, өв, соёлын үзэсгэлэн өдөрлөг					
11	“Би уншиж ойлгосноо ярьж чадна” ном уншлагын уралдаан		2023.04.05-2023.04.20	27		606,800
12	“Дэлгэцийн донтолтоос сэргийлж- Цахим орчинд хайр түгээе” цахим сэтгэгдлийн уралдаан		2023.10.20-2023.11.10	23	1	50,000
		Нийт		**2813**	**46**	**9,696,700**

5.1.1 ‘’НОМЫН САН-4 УЛИРАЛД” ХӨТӨЛБӨРИЙН ‘’АНХНЫ ЯРГУЙ – ШИДЭТ НОМ‘’ номын тэмдэглэл хөтөлж сурах хаврын хөтөлбөр

Хүүхдүүдийн номтой нөхөрлөх сонирхлыг нэмэгдүүлэх, тэргүүний уншигчдыг урамшуулах, номыг зөв унших арга барилд сургах зорилгоор зохион байгуулж буй ‘’Номын сан-4 улиралд” сэдэвт хөтөлбөрийн V-VII ангийн сурагчдын дунд зохион байгуулсан ‘’Анхны яргуй – шидэт ном‘’ номын тэмдэглэл хөтөлж сурах хаврын хөтөлбөрт 10 сурагч оролцож, номын тэмдэглэл хөтлөхөд суралцан, найз нөхдөдөө зааж сургах арга барил эзэмшлээ.

"Алтан навчис- амтат ном” уншсан номоороо бүтээл хийх намрын хөтөлбөрт ЕБ-ын 2, 3, 4 дүгээр сургуулийн нийт 12 сурагч хамрагдаж:

-I байр- IV сургуулийн 7в ангийн сурагч Х. Хишигдүүрэн

-II байр- 4а ангийн сурагч Х. Намуун

-III байр- III сургуулийн 5а ангийн сурагч Э. Ананд нар шалгарч, шинэхэн номоор шагнууллаа.

Сурагчид уншсан номынхоо утга агуулгыг улиралтайгаа уялдуулан, цэцэг, навчис, хичээлийн иж бүрэн хэрэгсэл ашиглан бүтээл урласан ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Сурагчдын зуны амралтыг зугаатай өнгөрүүлэх зорилгоор сумын хэмжээний ЕБС-ийн 4-5-р ангийн сурагчдын дунд “Зуслангийн найзууд-Зугаатай ном” зуны хөтөлбөрт уншсан номоороо бүтээл хийх уралдаан зохион явууллаа. Уралдаанд нийт 11 сурагч оролцож, нэг өдрийг Хараа голын эрэг дээр уншсан номын тухай ярьж, зохиолын баатруудын тухай асуулт, хариултын “АХА” тэмцээн зохиож зугаатай өнгөрүүллээ. Идэвхтэй оролцсон сурагчдаа урамшуулан багц номоор урамшууллаа.

Өөрийн уншсан номоор гэрийн бяцхан номын санг бүтээлчээр бий болгож сургах зорилгоор “Мөсөн аялал-Цасан ном” өвлийн хөтөлбөрт гэрийн бяцхан номын санг бүтээлчээр бий болгож сурах хөтөлбөрийг зохион байгууллаа.

Уралдаанд нийт 13 сурагч оролцсоноос идэвхтэй оролцсон 3-р сургуулийн 7-б ангийн сурагч Г.Мичидмаа, 9-б ангийн сурагч М.Анужин, А.Ариунзаяа нарыг   багц номоор шагнаж урамшуулав.

Хүүхдийг номтой нөхөрлүүлж, бие даан мэдлэг, боловсролоо нэмэгдүүлэн, багаар ажиллаж, бүтээлчээр сурах, унших арга барилд сурч, цаашид анги хамт олон,

найз нөхөд, гэр бүлдээ мэдээлэл түгээх, зааж сурах чадвар суулгасан ач холбогдолтой ажил боллоо.

5.1.2 “ҮНДЭСНИЙ НОМЫН БАЯР”-ыг тохиолдуулан баярын арга хэмжээг зохион байгуулах

Үндэсний 33 дахь удаагийн Номын баярыг тэмдэглэх ажлын хүрээнд "Номын баяр-Бидний баяр" арга хэмжээг зохион байгуулж, нийт 275 уншигчдыг хамрууллаа. Арга хэмжээний хүрээнд:

- “Номын баяр-Бидний Баяр” баярын жагсаал
- “Ухаан далай номоос эхтэй” АХА тэмцээн
- “Номын сайн нөхөр” тэргүүний уншигчдыг алдаршуулах
- “Ном зөв мэдлэгт хөтөлнө” шинэ номын худалдааг тус бүр зохион байгуулж, шилдэг оролцогчдыг шалгаруулан урамшууллаа.

Үүнд:

I байр: Мандал 3-р сургуулийн 10-б анги- Өргөмжлөл, Мөнгөн шагнал 300,000 төг

II байр: Хэрх тосгоны сургуулийн 10-а анги –Өргөмжлөл, Мөнгөн шагнал 200,000 төг

III байр: Мандал 4-р сургуулийн 6-б анги-Өргөмжлөл, Мөнгөн шагнал 100,000 төг

Тусгай байр - 4 тус бүр Дурсамж, Мөнгөн шагнал 50,000 төг, нийт 200,000 төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Арга хэмжээний нийт мөнгөн шагналд 700,000 төг, нийт зардалд 1210,800 төг зарцуулав.

Мөн "Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэг"-ээр:

- Мандал 1-р сургуулийн 6а ангийн сурагч Н.Хаш-Эрдэнэ
- Мандал 4-р сургуулийн 7в ангийн сурагч Г.Хонгорзул

-Мандал 4-р сургуулийн 3б ангийн сурагч Б.Мөнхзоригт тус тус шагнагдлаа. Дээрх арга хэмжээ нь ном унших ач холбогдлыг сурталчилж, тэргүүний уншигчдыг урамшуулсан үр дүнтэй ажил боллоо.

“НОМЫН БАЯР-2023” баярын хүрээнд зохион байгуулсан зохиогч, уншигчийн уулзалт

Мандал Сумын Засаг Даргын Тамгын газар, Мандал сумын ЕБ-ын 5 дугаар сургуулиас зохион байгуулсан "ЭХ ХЭЛ ЭРДМИЙН ТҮЛХҮҮР" шилдэг зохиолчидтой хийх уулзалтад хамтран оролцож, зохиолчдын туурвисан бүтээлээр номын үзэсгэлэн гаргаж, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн 420 гаруй сурагчдыг хамруулллаа.

Уулзалтад:

- МУСГЗ зохиолч Б.Сарантуяа
- МУСГЗ зохиолч Д.Жамъян
- МЗЭ-ийн шагналт зохиолч Соёрхын Пүрэвсүрэн
- Яруу найрагч Б.Дэлгэрцэцэг нар хүрэлцэн ирж сурагчидтай уулзалт, ярилцлага хийж зохиолчид өөрсдийн бичсэн номоор гарын үсэгтэй үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Уулзалтад оролцсон МУСГЗ зохиолч Д.Жамъян 20 ш ном, яруу найрагч Б.Дэлгэрцэцэг 10 ш ном тус тус номын санд хандивлалаа.

Дээрх арга хэмжээ нь зохиолч, уншигчдын халуун дотно яриа өрнүүлэх, өсвөрийн хүүхдүүдэд үлгэр дууриалал үзүүлэх, номтой нөхөрлөх урам зориг төрүүлэх ач холбогдолтой ажил боллоо.

5.1.3 “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ-НОМЫН ӨДӨР”-ийг тохиолдуулан “МОНГОЛ ӨВ СОЁЛ-МОНГОЛЫН ДАРХЛАА” үзэсгэлэн, өдөрлөг зохион байгуулах

Үндэсний бичиг соёл-номын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, номын соёлыг түгээх, хүүхэд залуусыг номтой нөхөрлүүлэх, оюунлаг мэдлэгтэй ирээдүйг бэлтгэх, номын сайн нөхөр тэргүүний уншигчдыг урамшуулах зорилгоор 34 дэх номын баярыг “Монгол өв соёл-монголын дархлаа” сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Үүнд:

1.“Монгол өв соёл-монголын дархлаа”сэдэвт баярын жагсаал

2.”Би монгол хүн” сэдэвт уйгуржин монгол бичгийн уран бичлэгийн уралдаан

3.“Шидэт ном” сэдэвт дүр бүтээх уралдаан

4.Шинэ болон ховор хуучин номын үзэсгэлэн худалдаа, номын солилцоо

5.”Өсөхөөс сурсан үндэсний хэл-Мартаж болшгүй соёл” сэдэвт уйгуржин монгол бичгийн уран бичлэгийн бүтээлийн үзэсгэлэн

6.“Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах

7.“Сумын шилдэг номын санч” шалгаруулах арга хэмжээг тус тус зохион байгуулав.

Энэхүү номын баярын үйл ажиллагаанд сумын ЕБС-ийн 260 гаруй багш, сурагчид, албан хаагчид хамрагдлаа.

Баярын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон анги хамт олныг байр эзлүүлж шагнаж урамшуулав.Үүнд:

I байр: 300,000 төг- ЕБ-ын Эко I сургууль

II байр: 200,000 төг- ЕБ-ын II сургууль

III байр: 100,000 төг- ЕБ-ын IV сургууль

-"Идэвхтэн оролцогч номын санч" шагнал, 50.000 төг, ном- V сургуулийн номын санч Т.Батхонгор

-"Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн шагнал", шинэ номын багцаар-уншигч Б.Отгонжаргал нарыг тус тус урамшуулав.

34 дэх НОМЫН БАЯР итгэл, зүтгэл, сэтгэл, шингэсэн өрсөлдөөнтэй хамтын ажиллагааг өргөжүүлсэн, бие биеэсээ суралцаж, Монгол соёлooроо бахархсан сайхан өдөр болж өндөрлөлөө.

5.1.4.“УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ-УРАГ УДМАА МЭДЭЦГЭЭЕ” сургалт, өдөрлөгийг зохион байгуулах.

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган “Угийн бичиг хөтлөх”-ийн ач холбогдлыг сурталчлан, иргэдэд мэдлэг олгох арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Үүнд:

1.“Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд “Соёлын эрхийн бичиг”-ийн хөтөлбөрт Мандал сумын ЕБ-ын I, IY сургуулийн ахлах ангийн 94 сурагч хамрагдлаа.

2.Сумын Ахмадын хороотой хамтран "Угийн бичгээ хөтөлж- ураг удмаа мэдэцгээе" сургалт өдөрлөгийг 2023.12.09-ний өдөр зохион байгууллаа. Үүнд:

-Угийн бичиг хөтлөх сургалт

-Угийн бичгийн фото зургийн үзэсгэлэн зохион байгууллаа.

Сургалтын чиглүүлэгч багшаар: Т.Батбаяр (Ugiinbichig.mn цахим хуудас болон програм хангамжийг эрхлэн гаргагч) "Угийн бичиг цахим орчинд" сэдвийн хүрээнд "Угийн бичиг" 3.0 програм, "Ugiinbichig.mn" 1.0 гар утасны апп зэрэг дэвшилтэд технологийг ашиглаж угийн бичиг хөтлөх талаар, Х.Дүнгээ (Монголын угийн бичгийн академийн Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлийн тэргүүн) "Угийн бичиг хөтлөх аргачлал", хууль эрх зүйн орчин сэдвээр тус тус мэдээлэл өгч, дадлага ажил зохион байгууллаа.

Угийн бичиг хөтлөх тулгамдсан шаардлага, цус ойртолт түүний уршиг, үр дагавар, угийн бичиглэл хийхэд холбогдох мэдээлэл, үлгэрчилсэн загвар, ураг төрлийн холбооны уламжлалт нэр нэршлийн талаар онол, оролцогчид угийн бичиглэл хийх дадлага, зураглал хийх дадлага зэргийг зааж сургалаа

Өдөрлөгт 60 орчим иргэн хамрагдаж угийн бичиг хөтлөлтийн талаар шинэлэг мэдээлэл авч, мэдлэгээ баталгаажуулж, угийн бичиг хөтлөлтөд тулгамдаж буй асуудлуудаар хамтран ярилцаж, ахиц дэвшилт гаргасан үр өгөөжтэй сургалт болж өндөрлөлөө.

Соёл олон нийтийн ажлын зардлаас нийт 2.198.600 төгрөгийн төсөв зарцуулагдсан.

5.1.5 “ХАРААГИЙН АЯЛГУУ-10" хүүхдийн яруу найргийн наадам

Өсвөр үеийн хүүхдүүдийн эх хэлний уран яруу хэллэг, үгийн баялгийг нэмэгдүүлэх, тэдний уран сэтгэмж, найруулан бичих чадварыг хөгжүүлэх, авьяас сонирхлыг нь дэмжих зорилгоор “Хараагийн аялгуу” хүүхдийн яруу найргийн наадмыг 10 дэх жилдээ уламжлал болгон 11-14 нас, 15-18 нас гэсэн 2 насны ангилалаар зохион байгууллаа. Наадамд шүлгээ ирүүлсэн 2 тосгон, 8 сургуулийн 26 сурагчийн бүтээлийг “Сэлэнгэ Мандал Номын сан” цахим хаягаар сурталчилж, олны хүртээл болгон ангилал тус бүрээс шилдэг 10 оролцогчийг 2-р шатанд оролцуулж, танхимаар шүлгээ уншиж, 2023.05.02-ны өдөр шилдгүүдээ шалгаруулж урамшууллаа.Үүнд:

11-14 насны ангилалд:

I байр: А.Навчаа (Түнхэл тосгоны ЕБС-ийн 8а ангийн сурагч)- Өргөмжлөл, Мөнгөн шагнал 50,000 төг

II байр: Ц.Өнөржаргал (2-р ЕБ-ын сургуулийн 6а ангийн сурагч)- Өргөмжлөл, Мөнгөн шагнал 40,000 төг

III байр: С.Тэмүүлэн (5-р ЕБ-ын сургуулийн 6б ангийн сурагч)- Өргөмжлөл, Мөнгөн шагнал 30,000 төг

15-18 насны ангилалд:

I байр: Г.Номиннарс (Хэрх тосгоны ЕБ-ын сургуулийн 11б ангийн сурагч) - Өргөмжлөл, Мөнгөн шагнал 50,000 төг

II байр:Б.Баттулга (1-р ЕБ-ын сургуулийн 12а ангийн сурагч) - Өргөмжлөл, Мөнгөн шагнал 40,000 төг

III байр: Х.Хүслэн (3-р ЕБ-ын сургуулийн 12б ангийн сурагч) - Өргөмжлөл, Мөнгөн шагнал 30,000 төг

Ангилал тус бүрээс тусгай байр-7 нийт 14 оролцогчийг 140,000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулж, арга хэмжээний зардалд нийт 688,000 төг зарцуулав.

Мандал сумын Нийтийн номын сангаас-1, Мандал сумын “Хараагийн уянга” зохиолч, уран бүтээлчдийн нэгдлээс-2 нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй комисс ажиллаж, өсвөрийн яруу найрагч хүүхдүүдийг урамшуулан, зөвлөгөө өгч, хүүхдүүдийн эх хэлний уран яруу хэллэг, үгийн баялгийг нэмэгдүүлэх, тэдний уран сэтгэмж, найруулан бичих чадварыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах үр дүнтэй ажил боллоо.

5.1.6 .“ГЭРИЙН ШИЛДЭГ НОМЫН САН” -г шалгаруулах уралдаан

Гэрийн номын сан бий болгосон уншигч, бүтээлч иргэдийг таниулан сурталчлах, урамшуулах, ном соёлоо дээдлэх, номтой нөхөрлөхийн ач холбогдлыг сурталчлах зорилгоор гэрийн номын сантай айл өрхүүдээс “Гэрийн шилдэг номын сан”-г шалгаруулах уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд гэрийн номын сандаа дэлхийн шилдэг сонгодог уран зохиол, хүүхдийн зохиол, үлгэр, аман зохиол, танин мэдэхүй, шинжлэх ухааны номын цуглуулгатай 8 иргэн нэг анги, хамт олон оролцож, идэвхтэй оролцогчдыг шалгаруулж, урамшууллаа. Үүнд:

I байр: Ахмад уншигч Д.Чулуунбат- Өргөмжлөл, Мөнгөн шагнал 300,000 төг

II байр: Б.Магсар- Өргөмжлөл, Мөнгөн шагнал 200,000 төгрөгөөр тус бүр шагнаж урамшууллаа.

Арга хэмжээний зардалд нийт 936,000 төг зарцуулав.

Орчин цагт хамгийн их хэрэгцээтэй байгаа мэдээллийн технологийн ур чадварын үзүүлэлтүүд ч номтой холбоотой бөгөөд гэртээ номоор хүрээлүүлж өссөн хүмүүсийн өрсөлдөх чадвар илүү өндөр байгаа нь номтой нөхөрлөж яваагийн үр дүн юм.

5.1.7. “МӨРӨӨДЛИЙН НОМ” зорилтот бүлгийн иргэдийг номтой нөхөрлүүлэх 1 сарын аяныг зохион байгуулах

Сумын зорилтот бүлгийн хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх зорилгоор ЕБС-уудын дунд номтой нөхөрлөх аян зарлаж, аянд идэвхтэй оролцсон сурагчдаас сургуулиудын саналыг харгалзан сонгосон зорилтот бүлгийн 10 сурагч тус бүрд номын тавиур, хүүхдийн уран зохиолын багц ном бэлэглэж, номын сангийн уншигчаар бүртгэн, номтой нөхөрлүүлж байна. Арга хэмжээний нийт зардалд 1376,500 төгрөгийн төсөв зарцуулагдсан.

<u>“Мөрөөдлийн ном” сайн үйлсийн аянд хамрагдсан сургуулийн тоон мэдээ:</u>

№	Сургуулийн нэр	Хүүхдийн тоо
1	1-р сургууль	2
2	2-р сургууль	2
3	3-р сургууль	2
4	4-р сургууль	2
5	5-р сургууль	1
6	Түнхэл ЕБС	1
	Нийт	**10**

5.1.8. “ХОС БИЧИГТЭН БОЛЖ-ЗӨВ НАЙРУУЛЖ БИЧИЖ СУРЦГААЯ” аян

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Эх хэлний өдөр зарлах тухай” 25 дугаар зарлиг, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, иргэдийг номтой нөхөрлүүлэх, ном уншлагад бүх нийтийг хамруулах, эх хэлээрээ зөв, найруулга сайтай бичих дадалд суралцаж, хойч үедээ үлгэр дууриалал үзүүлэн, оюунлаг, бүтээлч иргэнийг төлөвшүүлэх зорилготой “Хос бичигтэн болж-зөв найруулж,

бичиж сурцгаая” аяныг зохион байгуулж, төр төсвийн 24 байгууллага, 720 гаруй албан хаагчдыг хамруулаа. Үүнд:

1.Байгууллагууд ”Хос бичигтэн болж-Зөв найруулж, бичиж сурцгаая” сэдвээр албан хаагчдынхаа дунд монгол хэл, бичгийн дүрэм, кирил үсгээр зөв бичих, найруулга зүйн сургалт, уйгуржин монгол бичиг сурах, түгээн дэлгэрүүлэхийн ач холбогдлын талаарх сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулаа.

2.Байгууллагынхаа хаяг, хаягжилтыг кирил болон уйгуржин монгол бичгээр хослуулан хэвлүүлж, хэрэглэж байгаа олон байгууллагууд байгаа нь давуу тал байлаа.

3.”Эх хэлний өдөр” болон монгол, хэл бичгийн талаарх төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаарх танилцуулгыг байгууллага бүрт очиж, номын санч нар танилцуулж, мэдээлэл солилцлоо.

Тус аянд идэвхтэй оролцсон байгууллагуудыг дараах байдлаар шагнаж урамшууллаа. Үүнд:

-Нэгдүгээр байр 200 000 төг, Өргөмжлөл - Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн хамт олон

-Хоёрдугаар байр 150 000 төг, Өргөмжлөл - Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн хамт олон

-Гуравдугаар байр 100 000 төг, Өргөмжлөл -ЕБ-ын 1 дүгээр сургуулийн хамт олон тус тус шалгарлаа.

Нийт оролцсон байгууллага, албан хаагчдад яруу сайхан хэл соёлоо эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх их үйлсэд хамтран ажилласан үр дүнтэй ажил боллоо.

5.1.9.“БҮХ НИЙТИЙН УНШЛАГА” ном уншлагын 1 сарын аян

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан “Бүх нийтийн уншлага-2023” арга хэмжээг “Өдөр бүр 5 хуудас ном уншъя” уриатайгаар Мандал сумын Ширхэнцэгийн 2-р баг, Баян-Арцатын 9-р багийн байранд зохион байгууллаа. Үүнд:

-“Ном бид хоёр” сэдэвт захидлын уралдаан

-“Алтан намар”, “Соёлын бүтээлч сар- шинэ ном”-ын үзэсгэлэн

-“Little Free Library” ном солилцооны булан

-“Угийн бичиг” асуулга судалгаанд 40 гаруй иргэдийг хамруулав.

Тус арга хэмжээг зохион байгуулснаар номын сангийн шинэ уншигчийн тоог 39 хүнээр нэмэгдүүлж, идэвхтэй оролцсон 2 иргэнийг өргөмжлөл, монголын нууц товчоо номоор шагнаж урамшуулан, нийт 300 гаруй иргэнд ном соёлын үйлчилгээг багийн байранд хүргэсэн үр дүнтэй ажил боллоо.

5.1.10.“МИНИЙ САЙХАН МАНДАЛ СУМ” түүх, өв, соёлын үзэсгэлэн өдөрлөг:

Сумын номтой нөхөрлөдөг үлгэр жишээ иргэд, соёлын өв өвлөн тээгчдийг дүрсжүүлэн баримтжуулах, сумын соёлын өвийн санг бүрдүүлэх, баяжуулах зорилгоор “Миний сайхан Мандал сум” баримтат дүрс бичлэгийн ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Тус ажилд 3,601,400 төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн.

5.1.11. “БИ УНШИЖ ОЙЛГОСНОО ЯРЬЖ ЧАДНА” ном уншлагын уралдаан:

Бага насны сурагчдын унших чадварыг нэмэгдүүлэх, номтой нөхөрлүүлэх зорилгоор “Би уншиж ойлгосноо ярьж чадна" уралдааныг 1-р ангийн цагаан толгойн үсгээ үзэж дуусаад ном уншиж сурч буй бяцхан уншигчдын дунд нэг сарын турш Дэлхийн хүүхдийн алдарт зохиолч, Данийн үлгэрч Ханс Христиан Андерсений төрсөн өдөр болох 4 дүгээр сарын 2-ны өдрийг “Дэлхийн хүүхдийн номын өдөр” болгон тэмдэглэдэг тул тус уралдаанд оролцох сэдвийг дээрх зохиолчийн“Нугасны муухай дэгдээхэй”, “Эрэлхэг тугалган цэрэг”, “Цасан хатан”, “Бяцхан лусын дагина”, “Ямх охин”, “Шүдэнз зардаг бяцхан охин” зэрэг богино хэмжээний хүүхдийн зохиолоос аль нэгийг хүүхэд өөрөө багш, гэр бүлийн туслалцаатайгаар сонгож, уншиж, бэлдэж оролцлоо.

Эхний шатыг цахимаар зохион байгуулж 2-р шатыг 2023.04.28-ны өдөр Хүүхдийн уншлагын танхимд зохион байгууллаа.

Уралдаанд 26 сурагч оролцсоноос 2-р шатанд оролцсон шилдэг 10 сурагч тус бүрийг өргөмжлөл, эрхийн бичгээр, мөнгөн шагналаар, анги хамт олноо сайн зохион байгуулж, олон хүүхдийг хамруулж, тэмцээнд амжилттай сайн оролцуулсан 3-р сургуулийн 1-б ангийн багш Ц.Аюуш, 1-р сургуулийн 1-б ангийн багш С.Сарангэрэл, 4-р сургуулийн 1-а ангийн багш Э.Оюунтунгалаг нарыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав. Үүнд:

I байр: Өргөмжлөл, шинэ ном, 50,000 төг

II байр: Өргөмжлөл, шинэ ном, 40,000 төг

III байр: Өргөмжлөл, шинэ ном, 30,000 төг

Тусгай байр-7: Өргөмжлөл, 10,000, нийт 70,000 төгрөгөөр шагнаж, урамшууллаа.

Урамшуулад нийт 606,800 төг, арга хэмжээний нийт зардалд 606,800 төг зарцуулав.

Ном эрдмийн далайд аялж, хорвоотой танилцаж яваа бяцхан сурагчид маань бүтэн сарын хугацаанд өдөр бүр эгдүүтэй хөөрхөн төрх, ухаалаг яриагаараа “Сэлэнгэ Мандал Номын сан” нүүр номыг чимж, Монголын ирээдүйн оюунлаг иргэн болохоор суралцаж, хөгжиж, том болж байгаагаа аав, ээж, гэр бүл, багш, нүүр номын найзууддаа харуулж, уншсан номынхоо талаар тоймлон ярих, найзуудтайгаа харилцан ярилцах, хамтран уншихад суралцан цагийг бүтээлчээр өнгөрөөж, мэдлэгээ нэмэгдүүллээ.

5.1.12.“ДЭЛГЭЦИЙН ДОНТОЛТООС СЭРГИЙЛЖ- ЦАХИМ ОРЧИНД ХАЙР ТҮГЭЭЕ” цахим сэтгэгдлийн уралдаан

Хүүхдүүдийн утас, дэлгэцийн хамаарлыг бууруулж, номтой нөхөрлүүлэх зорилгоор “Дэлгэцийн донтолтоос сэргийлж- Цахим орчинд хайр түгээе” цахим сэтгэгдлийн уралдааныг зохион байгууллаа.

Мандал V дугаар сургуулийн Ч.Мөнхцэцэг багштай
3-б ангийн 23 сурагчдад ном уншлага зохион байгуулан, дэлгэцийн хамаарлын талаар мэдээлэл хүргэж, цахим хэрэглээгээ зөв зохицуулах, номтой нөхөрлөхийн ач холбогдлын талаар таниулан, нийт 50,000 төгрөгийн үнэ бүхий бяцхан бэлгээр урамшуулсан нь хүүхдүүдийн дэлгэцийн хамаарлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, номтой нөхөрлүүлэх, урамшуулах үр дүнтэй ажил боллоо.

Өнөөдрийн нийгмийн тулгамдсан асуудал болох хүүхдийг цахим донтолтоос сэргийлэх үндсэн зорилготой "Дэлгэцийн донтолтоос сэргийлж-ном уншъя" уриан дор цахим хэрэглээгээ зөв зохицуулахад зориулж, дэлгэцийн хэрэглээний хор уршиг, хүүхдүүдэд дэлгэцээс ангид дадал хэвшил суулгах, эцэг эхчүүдийг үр хүүхдэдээ эергээр нөлөөлж, гэр бүлийн амьд харилцааг эрхэмлэхийг уриалсан зөвлөмжийг “Сэлэнгэ Мандал Номын сан” цахим хаягаар цувралаар хүргэлээ.

5.2 Ном хэвлэлийн танхимын сурталчилгааг уламжлалт хэлбэрээр зохион байгуулах: Фондын эргэлтийг сайжруулах, ном, хэвлэлийг танилцуулах зорилгоор номын танхимын сурталчилгаагаар тойм яриа, чанга уншлагыг 42 удаа 1272 хүнд, номын үзэсгэлэнг 18 удаа 354 хүнд нийт 60 удаагийн сурталчилгаагаар 1626 хүнд үйлчилсэн нь тайлант оны төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжиж буй дүнтэй байна. Өмнөх оны мөн үеэс зохион байгуулсан ажлын тоо 3,4 хувь, хамруулсан хүний тоо 5,9 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Номын сурталчилгааны төрөл, тоон мэдээ:

№	Үзүүлэлт	Хэдэн удаа	Хамрагдсан хүн
1	Тойм яриа, чанга уншлага	10	804
2	Номын үзэсгэлэн	7	184
	Нийт дүн	**17**	988

Сүүлийн гурван жилийн харьцуулалт:

№	Нэр	2021 он	2022 он	2023 он	Биелэлтийн Хувь
1	Зохион байгуулсан тоо	34	58	60	3,4 %
2	Хамрагдсан хүний тоо	793	1534	1626	5,9 %

5.2.1 “Ном уншихын ач холбогдол” сургалтыг зохион байгуулах: “Ном уншихын ач холбогдол” сургалтад ЕБС-иуд болон “Нархан” цэцэрлэгийн 13 анги бүлгийн 460 хүүхдийг хамруулж, номын ач тус, номтой нөхөрлөхийн үр дүн, номыг хэрхэн зөв унших, номын тэмдэглэл хөтлөх талаарх мэдлэгийг нь нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил болж, тайлант оны төлөвлөгөөний биелэлт 100 хувь биелэгдсэн дүнтэй байна.

Тоон мэдээ:

Зохион байгуулсан тоо	Оролцсон хүний тоо
13	460

№		Хамрагдсан сургууль, анги	Хэдэн хүн
1	2023.02.13	Б.Буянчимэг багштай 1-р сургуулийн 8-г анги	30 хүүхэд
2	2023.02.14	Б.Саранчимэг багштай 1-р сургуулийн 6-а	29 хүүхэд
3	2023.02.15	1-р сургуулийн Н.Дүүрэнцэцэг багштай 9-г анги	30 хүүхэд
4	2023.02.15	Т.Болортуяа багштай 1-р сургуулийн 8-а анги	30 хүүхэд
5	2023.02.17	1-р сургуулийн О.Отгончимэг багштай 9-а анги	12 хүүхэд
6	2023.04.20	Түнхэл Тосгоны соёлын төвд	126 хүүхэд
7	2023.05.03	М.Цэрэнпунцагмаа "Нархан" цэцэрлэгийн бэлтгэл бүлэг	36 хүүхэд
8	2023.05.03	Т.Мөнхсоёл багштай "Нархан" цэцэрлэгийн бэлтгэл бүлэг	40 хүүхэд
9	2023.05.26	"Мөрөөдлийн ном сайн үйлс"-ийн аянд хамрагдагсад	10 хүүхэд
10	2023.11.28	4-р сургууль 11-р ангийн сурагчид	35
11	2023.11.29	4-р сургууль 12-а анги	15
12	2023.11.29	1-р сургууль 11-р ангийн сурагчид	44
13	2023.12.01	V дугаар сургуулийн Ч.Мөнхцэцэг багштай 3-б ангийн	23
Нийт		13 удаа	460 хүүхэд хамрагдсан

5.2.2 "Ноён уул-түүх соёлын үнэт өв" сэдэвчилсэн ном зүйн бүртгэл хийх. Лавлагаа, татгалзлын бүртгэлийг хөтлөх: Лавлагаа мэдээллээр уншигчдыг хангах зорилгоор уншигчдын сонирхсон асуултанд хариулахад лавлагаа болж чадах гарын авлага болон толь бичгүүд, фондод байгаа сүүлийн үед хэвлэгдсэн эх материалыг ашиглан 1340 хариулт өгч, н омын татгалзлын бүртгэлд 29 ш номыг бүртгэлээ.

"Ноён уул-түүх соёлын үнэт өв" сэдэвчилсэн Номзүйн бүртгэлийг хийх материал цуглуулах, бүртгэлжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, Ноён уултай холбоотой ном, хэвлэл, цахим орчинд нийтлэгдсэн мэдээллийн бүртгэлийг хийж эхлээд байна.

ЗУРГАА: ИРГЭДИЙГ НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ӨРГӨНӨӨР ХАМРУУЛЖ, УНШИГЧДЫН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

6.1 Уншигчдын хүрээг өргөжүүлж, ном олголтыг нэмэгдүүлэх: Иргэдийг номтой нөхөрлүүлэх, номын сангийн уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор ном тойрсон олон талт ажлуудыг зохион байгуулж, ном уншлагын клуб, дугуйланг ажиллуулж, байгууллагын нөөц бололцоог дайчлан ажиллаж байна. Нийт 2044 шинэ уншигч, 8211 иргэсдэд, 12276 ш ном олгосон нь жилийн төлөвлөгөөний биелэлт шинэ уншигч 102,2 хувь, иргэсэд 102,6 хувь, ном олголт 81,84 хувь хэрэгжиж, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулсан дүнгээр шинэ уншигч 3,7 хувь, иргэсэд 2,6 хувь, ном олголт 8,5 хувиар тус тус өссөн дүнтэй харагдаж байна.

Сүүлийн гурван жилийн жилийн харьцуулалт:

Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	Хувь
Суудлын тоо	42	42	42	42
Уншигчдын тоо (байнгын /шинэ)	**439**	1972	**2044**	3,7%
Ирэгсэд	**1235**	8003	**8211**	2,6%
Олгосон номын тоо	**1685**	11315	**12276**	8,5%

Уншигч, ирэгсэд, ном олголтын төрөл:

№	Нэрс	Танхимын үйлчилгээ	Гэрээр	Явуулын үйлчилгээ	Номын солилцоо	Бүгд
	Уншигч	1819	193	32		2044
	Ирэгсэд	7322	547	330	12	8211
	Ном олголт	8672	2966	611	27	12276

УНШИГЧ, ИРЭГСЭД, НОМ ОЛГОЛТЫН БҮРТГЭЛ-2023 ОН

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 441 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт 1.1

2023 оны Номын сангийн өдөр тутмын бүртгэл - Уншигчийн байдал

он сар өдөр	Бүх уншигчийн тоо	Ажил эрхлэлт									Боловсрол					Нас					Хүйс		Иргэншил	
		Ажилтан, албан хаагч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Бусад	Сургуулийн өмнөх насны	Дунд сургууль I-IV анги	Дунд сургууль V-VIII анги	Дунд сургууль IX-XII анги	Их дээд сургууль, Коллеж	МСҮТ	Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд	18 хүртэлх	18-24 нас	25-35 нас	36-50 нас	50-с дээш нас	Эрэгтэй	Эмэгтэй	Монгол	Гадаад
2023 он	**2044**	**204**	**177**	**81**	**6**	**556**	**594**	**407**	**19**		**173**	**1109**	**628**	**33**	**101**	**1577**	**314**	**48**	**66**	**39**	**727**	**601**	**2044**	

2023 ОНЫ НОМЫН САНГИЙН ӨДӨР ТУТМЫН БҮРТГЭЛ - НОМ ОЛГОЛТ

2023 ОН	ном	хэвлэмэл бус	сонин	сэтгүүл	хөлөгт тоглоом	сонсдог ном	интернет орчинд	**Нийт**	байгаль	техник	ХАА	анагаах ухаан	социологи	түүх	эдийн засаг	улс төр	төр эрх хууль цааз	цэргийн шинжлэх ухаан	соёл ш/у боловсрол	хэл шинжлэл	аман зохиол	уран зохиол	урлаг	шашин	гүн ухаан	сэтгэл судлал	лавлах хэвлэл	монгол	орос	англи	ирэгсэд
Нийт	11879	19			40	21	317	12276	388	205	74	242	19	374	210	68	38	2	20	71	2701	7527	198		10	22	107	12254	9	13	8211

”УРИЛГАТ УНШЛАГА” АЯН

Хүүхдүүдийг номтой нөхөрлүүлж, уншигчдын тоог нэмэгдүүлэх ”Урилгат уншлага” аянд нийт 6 ангийн 150 хүүхэд хамрагдлаа.

Огноо	Зохион байгуулсан арга хэмжээ	Хамрагдсан анги хамт олон	Хэдэн хүүхэд
02.17	Номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, уншигчийн карт нээлгэн, байнгын уншигчид болж энэхүү арга хэмжээнд хүрэлцэн ирсэн сурагч Э.Энхриймаагийн төрсөн өдөр нь тохиож "Өвөрмөц нэгэн захидал"-ын эзэн болж түүнд захирлын гарын бэлгийг гардууллаа. Номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, уншигчийн карт нээлгэн, байнгын уншигчид болсон.	1-р сургуулийн О.Отгончимэг багштай 9-а анги	12 хүүхэд
02.15	Номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, уншигчийн карт нээлгэн, байнгын уншигчид боллоо. Сурагчдын дунд асуулт, хариултын "АХА" тэмцээн зохион байгуулахад авхаалж, самбаа, мэдлэгээрээ шалгарч сурагч З.Баясгалан түрүүллээ.	1-р сургуулийн Н.Дүүрэнцэцэг багштай 9-г анги	30 хүүхэд
02.15	Номын сантай танилцан, анги хамт олноороо номын сангийн уншигчид боллоо. Өгөгдсөн өгүүллэгийг уншиж, ойлгож ярих дадалд сургах зорилготой "Эх зохиолоор аялахуй" тэмцээнийг сурагчдын дунд зохион байгууллаа	Т.Болортуяа багштай 1-р сургуулийн 8-а анги	30 хүүхэд
02.14	Номын сантай танилцан, анги хамт олноороо номын сангийн уншигчид боллоо. Өгөгдсөн өгүүллэгийг уншиж, ойлгож ярих дадалд сургах зорилготой "Эх зохиолоор аялахуй" тэмцээнийг сурагчдын дунд зохион байгууллаа	Б.Саранчимэг багштай 1-р сургуулийн 6-а	29 хүүхэд
02.13	Номын сантай танилцан, анги хамт олноороо номын сангийн уншигчид болж, “Ном уншихын ач холбогдол” сургалтыг зохион байгууллаа.	Б.Буянчимэг багштай 1-р сургуулийн 8-г анги	30 хүүхэд
12.01	Номын сантай танилцан, анги хамт олноороо номын сангийн уншигчид болж, “Ном уншихын ач холбогдол” сургалтыг зохион байгууллаа	Мөнхцэцэг багштай 5-р сургуулийн 3-б анги	23 хүүхэд
	Нийт	**6 удаа**	**150 хүн хамрагдсан**

Идэвхтэн уншигчдыг урамшуулах: 2023 онд Номын сангаас зохион байгуулсан соёл, олон нийтийн ажилд идэвхтэй оролцсон 305 хүн, 14 анги хамт олон, 3 өрхийг 4,936,300 төгрөгийн төсөв бүхий шагналаар, 4 уншигчийг “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж” тэмдгээр, “Аймгийн шилдэг уншигч анги”-аар ЕБ-ын 1-р сургуулийн Б.Буянчимэг багштай 8г анги, “Бүтээлчээр уншъя” аймгийн шилдэг номын тэмдэглэл хөтлөгч сурагчаар ЕБ-ын 1-р сургуулийн 8-г ангийн сурагч А.Булгантамир шалгарч өргөмжлөл, дурсгалын зүйлээр тус тус шагнууллаа.

№	Хийгдсэн ажил	Шагнал, урамшуулал	
		Хэдэн хүн шагнуулсан	**Хэдэн төгрөгөөр**
1	“Номын сан-4 улиралд” Хаврын номын сан: “Анхны яргуй-Шидэт ном” номын тэмдэглэл хөтлөх уралдаан	10 хүүхэд	190,000
2	“Би уншиж ойлгосноо ярьж чадна” ном уншлагын уралдаан	10 хүүхэд, 3 багш	280,000
3	“Хараагийн аялгуу-9” хүүхдийн яруу найргийн наадам	20 хүүхэд	380,000
4	“Номын баяр”-2023 арга хэмжээ	7 анги хамт олон	884,800
5	“Мөрөөдлийн ном” хаалттай болон зорилтот бүлгийн иргэдийг номтой нөхөрлүүлэх 1 сарын аян	10 хүүхэд	1,376,500

6	“Гэрийн шилдэг номын сан” -г шалгаруулах уралдаан	3 өрх	600,000
7	“Үндэсний бичиг соёл-номын өдөр”-ийг тохиолдуулан “Монгол өв соёл-Монголын дархлаа” үзэсгэлэн, өдөрлөг зохион байгуулах	4 сургууль 260 багш сурагчид	650,000
8	Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Эх хэлний өдөр зарлах тухай” 25 дугаар зарлигийн хүрээнд “Хос бичигтэн болж-Зөв найруулж бичиж сурцгаая” аян	3 байгууллага	450,000
9	“Бүх нийтийн уншлага” ном уншлагын 1 сарын аян	3	75,000
10	“Дэлгэцийн донтолтоос сэргийлж- Цахим орчинд хайр түгээе” цахим сэтгэгдлийн уралдаан	2	50,000
		305 хүн, 14 анги хамт олон, 3 өрх	**4,936,300**

6.2 Ном уншлагын клуб, дугуйлан хичээллүүлэх: “Өсвөрийн номын санч” дугуйланд 13 хүүхэд хамрагдаж, номын санчийн ажил, номтой ажиллах мэдлэгээ нэмэгдүүлж байна.

ӨСВӨРИЙН НОМЫН САНЧДЫН УУЛЗАЛТ, СУРГАЛТ

Номын санчийн мэргэжил, номтой нөхөрлөхийн ач холбогдлыг сурталчлах зорилгоор “Өсвөрийн номын санчдын уулзалт, сургалт”-ыг зохион байгуулж, 13 хүүхдийг хамруулж, номын санчийн ажлын талаар мэдлэг олгож, мэдээлэл хүргэсэн ач холбогдолтой ажил боллоо.

ДОЛОО: ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЖ, ЦАХИМ НОМЫН ФОНД, КОМПЬЮТЕР, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

7.1 Ном, хэвлэлийн цахим сурталчилгаа, мэдээллээр үйлчлэх: Номын сангийн үйлчилгээг цахим хэрэгсэл ашиглан зохион байгуулж, ном хэвлэлийн сурталчилгаа, цахим ном, үндэсний өв соёл, танин мэдэхүй, орон нутгийн түүх, соёлын талаарх мэдээллийг 95 удаа цахим хуудсаар хүргэж, 6117 хандалттай байгаа нь тайлант оны төлөвлөгөөний оруулсан мэдээллийн тоог 63,3 хувиар, хандалтын тоог 122,3 хувиар хэрэгжүүлж буй дүнтэй байна.

Ном, хэвлэлийн цахим сурталчилгааны тоон мэдээ:

“Цахим номын үзэсгэлэн, сурталчилгаа”	10
“Ном унших ач холбогдлын тухай зөвлөмж”	25
“Үндэсний бичиг, өв соёлыг сурталчлах” цахим булан	6
“Үлгэрийн цаг” цахим булан	18
“Дэлхийн сонгодог богино хэмжээний өгүүллэгүүд, сонирхолтой сургамжит зохиолууд”	33
“Миний сайхан Мандал сум” түүхийн цахим булан	3

Нийт 95 удаа 6117 хандалт

7.2 Номын цахим /электрон/ каталогиор үйлчлэх: Фондод хадгалагдаж буй 29,000 гаруй номыг бүрэн оруулсан Mandal.monbiblio.mn цахим каталогиор уншигчдад үйлчилж байна.

7.3 “Цахим номын фонд”-ын баяжилтыг нэмэгдүүлэх: Цахим номыг гэрээсээ үнэгүй унших “Номтой нөхөрлөе” бүлэг





нь 668 дагагчтай, 514 номтой ажиллаж байна. Оны эхний хагас жилд 20ш шинэ цахим номоор баяжилт хийлээ.

7.4 “Цахим засаглал хөтөлбөр”-ийн хүрээнд номын сангийн үйл ажиллагааг цахимжуулах компьютер, техник хэрэгслийн тоог нэмэгдүүлэх: Нэн шаардлагатай техник, хэрэгсэл болох 1939,900 төгрөгийн үнэ бүхий 1ш зөөврийн компьютер, 499,900 төгрөгийн үнэ бүхий 1ш суурин компьютерийн дэлгэц, 2299,900 төгрөгийн үнэ бүхий 1ш суурин компьютерийн процессор, 2799,900 төгрөгийн үнэ бүхий 1ш А3 принтер, 500,000 төгрөгийн үнэ бүхий 1ш проекторын дэлгэц **нийт 5ш 8039,600** төгрөгийн үнэ бүхий техник, хэрэгслийн санхүүжилтыг шийдвэрлүүлэхээр АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Аймгийн Засаг даргад хүсэлт гарган, шийдвэрлүүлж, техник, хэрэгслийн шинэчлэлт хийсэн амжилттай ажиллаж байна.

Мөн 2023 оны үр дүнд суурилсан санхүүжилтийн гүйцэтгэлээр төсөвт тусгагдсан нийт 8,231,000 төгрөгийн санхүүжилтийн зарцуулалтыг хамт олны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, соёл олон нийтийн ажилд хэрэглэх 1,300,000 төгрөгийн үнэ бүхий Nicon-5500 дүрс бичлэгийн камер, 70,000 төгрөгийн үнэ бүхий лед гэрэл, 550,000 төгрөгийн үнэ бүхий энгэрийн микрофон, 150,000 төгрөгийн үнэ бүхий камерын хөл, 3,899,900 төгрөгийн үнэ бүхий i5 32 gb компьютерийн процессор, 659,900 төгрөгийн үнэ бүхий Dell 24 суурин компьютерийн дэлгэц, 589,900 төгрөгийн үнэ бүхий Dell 22 суурин компьютерийн дэлгэц, 460,000 төгрөгийн үнэ бүхий 18-55 мм-ийн дүрс бичлэгийн камерын дуран, 273,300 төгрөгийн үнэ бүхий ус буцалгагчийг худалдан авч ашиглаж байна.

НАЙМ: ОРОН НУТГИЙН НОМЫН САНГУУДАД МЭРГЭЖИЛ, АРГАЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

8.1. “Ахмад номын санч-Бидний бахархал” сэдэвт мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгуулах: Номын санчийн мэргэжлийг ахлах ангийн сурагчдад сурталчлан таниулах, эрэлттэй байгаа "Номын санч" мэргэжлээр суралцах хүүхдүүдийн тоог нэмэгдүүлэх, номын сангийн ажилтнуудад ажил мэргэжлээрээ бахархах, урамших сэдлийг төрүүлэх зорилготой тус өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгөөр ахлах номын санч Б.Байгалмаа номын санч мэргэжлийн талаар сургалт хэлэлцүүлгийг өрнүүлж, шинэ ном уншигчийн гарт очих хүртэл хийгдэх техник ажиллагааны талаарх мэдлэгийг дадлага сургуулилтаар олголоо. Сурагчид номын санч мэргэжлийн талаар шинэ мэдлэг мэдээллийг олж авч, дадлага ажил ихээхэн сонирхолтой байгааг илэрхийлж байлаа. Өдөрлөгт сумын ЕБ-ын сургуулийн номын санч мэргэжлээр суралцах сонирхолтой 17 сурагч хамрагдсан.

8.2 “Хараа” бүсийн номын санчдын сургалт зохион байгуулах: Орон нутгийн номын санчдад мэргэжил, арга зүйн ажилд туслалцаа үзүүлэх зорилгоор “Хараа бүсийн номын санчдын сургалт”-ыг Түнхэл тосгонд зохион байгуулагдсан “Дэлхийн номын өдөр”-ийн арга хэмжээнд 1 удаа 15 хүнийг хамруулж, мөн УИХ-ын гишүүн Ч.Ундрамын урилгаар Улаанбаатар хотын МУИС-ын номын сан болон Төрийн ордон, Монгол банкны “Эрдэнэсийн сан”-тай танилцах аялалд Хараа бүсийн номын сангийн салбарын 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр 1 удаа туршлага судалж, номын сангийн хамтын ажиллагаагаа бэхжүүллээ.

8.3 Орон нутгийн номын сангуудад ажлын байрны аргазүйн зөвлөгөө өгөх: Ажлын байрны мэргэжил арга зүйн зөвлөгөөг 16 хүнд 7 удаа, уулзалт хэлэлцүүлэгт 25 хүнийг 2 удаа нийт 9 удаа 41 хүнийг хамруулж, номын санч нарын мэдлэгийг нэмэгдүүлсэн нь тайлант оны төлөвлөгөөний биелэлт 100 хувь биелэгдсэн үр дүнтэй байна.

№	Сэдэв	Хаана	Зөвлөгөө авсан	Зөвлөгөө өгсөн	Хамрагдсан хүний тоо
1	Номын баяр-2023-ын хүрээнд сургалт хэлэлцүүлэг	Түнхэл тосгоны Соёлын төвд	Хараа бүсийн номын санч нар	Мандал сумын Нийтийн номын сан Г.Одгэрэл	15
2	Монбиблио програмд ажиллах	Нийтийн номын сангийн байранд	Номын санч Г.Одгэрэл, С.Цэндсүрэн	Аргазүйч Б.Байгалмаа	2
3	Номтой жагсаалын тухай	ЕБ-ын 4-р сургууль	Номын санч Б.Шүрэнцэцэг	Аргазүйч Б.Байгалмаа	1
4	Байгууллагын үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийх	Цахимаар	Хараа бүсийн сургуулийн номын санчид	Аргазүйч Б.Байгалмаа	7
5	МУИС-ийн номын сангийн арга туршлага	МУИС-ийн номын сан	Хараа бүсийн номын санчид	МУИС-ийн ном зүйч М.Золбоо	10
6	Номын сан ном зүйн ангилал	ЕБ-ын II сургууль	Номын санч Т.Дуламсүрэн	Аргазүйч Б.Байгалмаа	1
7	“Хос бичигтэн болж- Зөв найруулж бичиж сурцгаая” аяны тухай	ЕБ-ын I сургууль	Номын санч М.Марта	Номын санч Г.Одгэрэл	1
8	МНСХ-ны үйл ажиллагаа болон хил хязгааргүй номын сангийн танилцуулга	Нийтийн номын сангийн байранд	Мандал сумын Нийтийн номын сан номын санчдад	МНСХ-ны Гүйцэтгэх захирал “Хил хязгааргүй номын сан” төслийг санаачлагч М.Даваасүрэн	3
9	Номын техник ажиллагааны тухай	Нийтийн номын сангийн байранд	ЕБ-ын II сургууль Номын сан М.Долгоржав	Номын санч С.Цэндсүрэн	1
	Нийт				**41**

Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт:

ЕС: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

9.1 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж ажиллан “Хөдөлгөөн эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх: Албан хаагчдын эрүүл мэндэд анхааран, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөөг 16 зүйлтэйгээр боловсруулж, хэрэгжилтийг хангаж байна. Байгууллагын “ХАБЭА-н дүрэм”, "Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хими, биологийн бүтээгдэхүүний нэгдсэн жагсаалт”, “Химийн бүтээгдэхүүнтэй зүй зохистой харьцах, хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж”, “Химийн бүтээгдэхүүний хордлогод өртөж болзошгүй эрсдэл бүхий ажлын байр, албан хаагчдын нэгдсэн жагсаалт”-ыг тус бүр шинэчлэн гаргаж, хэрэгжүүлж байна. Албан хаагчдыг чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх нөхцөлийг бүрдүүлж ажиллах, эмчилгээ, сувилалд хамруулах, дархлааг дэмжих, түр амрах, хооллох нөхцөлийг хангаж, шинэ ажилтнуудад “Зааварчилгааны хяналтын хуудас”-аар ХАБЭА-н зааварчилгааг өгч байна. Албан хаагчдыг ажлын байрны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/05 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсан “Мандал сумын нийтийн номын сангийн албан хаагчид ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэглэм баримтлах анхааруулга, санамж”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, албан хаагчид ажлын ээлж эхлэх бүртээ анхааруулга санамжтай танилцан гарын үсэг зурж ажлаа эхлүүлж байна. “Ажлын байрны ХАБЭА-н үзлэг, хяналтын төлөвлөгөө”-г 5 зүйлтэйгээр боловсруулж, ажлын байрны хяналт шалгалтыг 1 удаа, өдөр тутмын хяналтыг тогтмол зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулж байна. Байгууллагын “Хөдөлгөөн эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд албан хаагчид өглөө ажил эхлэхээс өмнө эрүүл мэндэд тустай дасгал хөдөлгөөн хийж, спортоор хичээллэн эрч хүч дүүрэн ажлаа эхлүүлж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ёс зүйн ажлыг сайжруулах үүднээс “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюулгүй орчинд ажиллах” хөтөлбөрийн хүрээнд ажил зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах үүднээс албан хаагчдад ээлжит болон ээлжит бус “Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа”-г гүйцэтгэх ажил үүрэгт нь тохируулан тухай бүр бичгээр гаргаж танилцуулан, байгууллагын Захирлын гарын үсэг, тэмдэг, танилцсан албан хаагчдын гарын үсэг, огноогоор баталгаажуулан, эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 12 дугаар сард багтаан Улаанбаатар хотод хамруулахаар төлөвлөж, бэлтгэлийг хангаж байна.

Ариутгал, цэвэрлэгээ, болзошгүй эрсдэл, гэнэтийн эрүүл мэндийн тусламжид бэлэн байлгах эрүүл мэндийн бүтээгдэхүүний нөөцийг бэлэн байдалд байлгаж, одоогийн байдлаар нийт 510,793 төгрөгийн 831 ш бүтээгдэхүүний нөөцтэй байна.

<u>Ариутгал, халдваргүйтгэлийн хэрэгслийн нөөц:</u>

№	Материал	Ширхэг	Боодол	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Зарцуулсан	Үлдэгдэл	Үнэ
1	Малгай /Нэг удаагийн/	4		450	1 800	1	3	1 350
2	Халаат /Нэг удаагийн/	1		4 000	4 000	1	0	0
3	Бээлий /Нэг удаагийн/	100	2	22 500	45 000	100	0	0
4	Халуун бууруулах эм	1		2 500	2 500	0	1	2 500
5	Духны халуун хэмжигч	1		80 000	80 000	0	1	80 000
6	Жавельсин	300		150	45 000	300	0	0

7	Электрон даралтны аппарат	1		90 000	90 000	0	1	90 000
8	Улавч /Нэг удаагийн/	25		120	3 000	0	25	3 000
9	Амны хаалт /Нэг удаагийн/	200	4	15 000	60 000	100	100	30 000
10	Комбинзон /Нэг удаагийн/	1		23 500	23 500	1	0	0
12	Шал угаах автомат хувин, алчуур	1		50 000	50 000	0	1	50 000
13	Гар ариутгагч / Санитол /	2		16 000	32 000	2	0	0
	Нөөцийн баяжилт 2021.04.02							
14	Гар ариутгагч / Санитол /	2		16 000	32 000	2	0	0
15	Бээлий /Нэг удаагийн/	50	1	32 000	32 000	0	50	32 000
16	Ариун цэврийн цаас	42	1	25 000	25 000	42	0	0
	Нөөцийн баяжилт 2021.04.30 “Шуурхай штаб”-аас							
17	Гар ариутгагч / Санитол /	10		5 000	50 000	10	0	0
18	Ариун цэврийн цаас	12		600	7 200	12	0	0
	Нөөцийн баяжилт 2021.05.21 “Шуурхай штаб”-аас							
19	Гар ариутгагч / Санитол /	20		5 000	100 000	18	2	10 000
20	Жавельсин	300	1	32 000	32 000	0	300	32 000
21	Бээлий /Нэг удаагийн/	50	1	16 000	16 000	20	30	9 600
	Нөөцийн баяжилт 2021.05.27							
22	Амны хаалт /Нэг удаагийн/	250	5	100	25 000	0	250	25 000
23	KF-94 амны хаалт	50	10	800	40 000	0	50	40 000
	Нөөцийн баяжилт 2021.09.06							
24	Ариун цэврийн цаас	42	1	25 000	25 000	30	12	7 143
25	Мананцарын буу	1		70 000	70 000		1	70 000
26	Санитол	1		23500	23500		1	23500
27	Парацетамол	2		400	800		2	800
28	Ибуденк	1		3900	3900		1	3900
	НИЙТ	**1 470**			**919 200**	**639**	**831**	**510 793**

АРАВ: АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

10.1 “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр хэрэгжүүлэх:

- Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018.03.14-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” аймгийн хөтөлбөрийн байгууллагын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна.
- “Албан хаагчдын цалин, хөлс”-ний судалгааг шинэчлэн гаргасан.
- Ур чадварын нэмэгдлийг давхардсан тоогоор 68 хүнд 25 хувиар олголоо. Улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг олгох эрх төсөвт тавигдаагүй учир одоогийн байдлаар олгогдоогүй байна.
- Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ын дагуу зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 4 албан хаагч хамрагдаж, тэтгэмжийг зохих журмын дагуу олголоо.
- Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийн гүйцэтгэлээр төсөвт тусгагдсан нийт 2,872,300 төгрөгийн урамшууллыг байгууллагын 9 албан хаагчдад тэгш хуваарилан олголоо.
- Байгууллагын “Албан хаагчдын орон сууцны судалгаа”-г бүрэн гаргасан. Одоогийн байдлаар нийтийн орон сууцанд 3 албан хаагч, хувийн хашаа байшинд 5 албан хаагч амьдарч байна. Албан хаагчдад хувийн орон сууц худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх талаар анхаарч

банкны зээлд хамрагдахад нь шаардлагатай байгууллагын тодорхойлолтыг гаргаж туслалцаа үзүүлдэг.

- “Албан хаагчдын гэр бүлийн судалгаа”-г шинэчлэн гаргаж, бага насны хүүхдээ сургууль, цэцэрлэгт өгч, авдаг албан хаагчдад ажлын цагаар хүссэн үед нь чөлөө олгодог. Одоогийн байдлаар цэцэрлэг, сургуулийн бага ангийн насны хүүхэдтэй 2 албан хаагч байна.
- “Албан хаагчдын банкны зээлийн судалгаа”-г тус онд шинэчлэн гаргасан бөгөөд одоогийн байдлаар 8 албан хаагч 6 төрлийн зээлд хамрагдаж, тус онд 7 албан хаагч шинээр банкны зээл авсан байна. Албан хаагчдын банкнаас авах цалингийн болон бусад хэрэглээний зээлд байгууллагаас шаардлагатай баримт материалыг саадгүй гаргаж өгдөг.
- Төрийн албан хаагчдын хүн амын орлогын албан татварын хөнгөлөлт эдлэхэд байгууллагаас шаардлагатай баримт материалыг гаргаж өгдөг.
- “Албан хаагчдын газар өмчлөлийн судалгаа”-г гаргалаа. Үүнд: байгууллагын 9 албан хаагчаас өөрийн нэр дээр өмчлөлийн газар бүхий 3 албан хаагч, газаргүй 5 албан хаагч, газар авахаар хүсэлт гаргасан 1 албан хаагч байна.
- Албан хаагчдын нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн болон шийдвэрлэж байгаа талаарх, албан хаагчдын ажилласан жил, зэрэг дэв, шагнал урамшуулал олгосон тухай “Албан хаагчдын шагнал, урамшууллын судалгаа”-г гаргаж, тухай бүр баяжилт хийж байна. Байгууллагын 1 албан хаагчийг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар, 2 албан хаагчийг Соёлын яамны "Жуух бичиг", 2 албан хаагчийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тэргүүний ажилтан цол, тэмдгээр, 1 албан хаагчийг Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр тус бүр тодорхойлон шагнууллаа.
- Албан хаагчдын 2023 оны ээлжийн амралтын хуваарийг баталж, хуваарийн дагуу амралтыг олгож, биеэр эдлүүлж байна.
- Урт болон богино хугацааны сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдын цалинг бүрэн олгодог бөгөөд тайлант хугацаанд 2 албан хаагч хамрагдсан.

АРВАН НЭГ: БАЙГУУЛЛАГЫН АРХИВ, ТӨСӨВ САНХҮҮ, ДОТООД АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

11.1 Дотоод хяналтын ажлыг эрчимжүүлэх: Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор “Дотоод хяналт”-ын комиссыг Мандал сумын Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/27 тушаалаар шинэчлэн томилсон. Дотоод хяналтын комиссын гишүүд 1 удаа хуралдаж, доорх асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

- 2023 оны төлөвлөгөө болон 2022 оны тайланг сонсож дүгнэлт хийж, харилцан ярилцлаа.
- Уншигч үйлчлүүлэгчдээс орчин нөхцөл болоод номын санчдын харилцаа хандлагын судалгааг авч, дүгнэж байна.

“Дотоод хяналтын комисс”-ын үйл ажиллагааг сайжруулж, дотоод хяналтын ажилтанг “Монголын дотоод хяналтын институт”-ын дотоод мэргэшсэн аудитор бэлтгэх анхан шатны сургалтад хамруулж, гарын авлага, заавар зөвлөмжөөр хангагдлаа.

Дотоод хяналтын ажилтан нь номын сангийн үйл ажиллагааны ил тод байдал, эд хөрөнгийн ашиглалт бүрэн бүтэн байдал, ариутгал халдваргүйтгэл, уншигч үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, үйлчилгээний орчин нөхцлийн талаар судалгаа хийн, байгууллагын хяналтын камерын бичлэгт хяналт хийж, болзошгүй эрсдлээс сэргийлж байна. Одоогийн байдлаар ямар нэгэн зөрчил илрээгүй байна.
Байгууллагад иргэдээс ирсэн өргөдөл, гомдол байхгүй, албан хаагчдаас ирсэн 4 ш өргөдөл, хүсэлтийг “Өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэр”-т бүртгэн тухай бүр шийдвэрлэж байна.

11.2 Хүний нөөцийн бүрдүүлэлт, ТАХ-ын хувийн хэрэг, цахим системийн бүртгэлийг хангах: Хүний нөөцийг бэлтгэх, мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдах зорилгоор 2 номын санчийг СУИС-ын Соёлын дээд сургуулиас зохион байгуулж буй “Номын сангийн үндэс” анхан шатны 3 кредитийн онлайн сургалтад хамруулж, сертификат эзэмшүүллээ.

“Номын санч сонгож авах нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2 удаа зарлаж, сумын Хөдөлмөр эрхлэлтийн албанд хүсэлт гаргасан боловч мэргэжлийн номын санч олдохгүй мөн цаашид номын санч мэргэжлээр суралцаж, тогтвор суурьшилтай ажиллах хүн олдохгүй хүнрэлтэй нөхцөл байдалд ажиллаж байна.

Номын сангийн нийт албан хаагчдын мэдээллийг төрийн албан хаагчийн цахим бүртгэл, мэдээллийн системд бүрэн бүртгэж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар төрийн албан хаагчдын анкетыг шинэчилж, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05-р дугаар тогтоол, 2019 оны 3-р тогтоолын дагуу, байгууллагын Захирлын 2023 оны А/03 тоот тушаалаар баталгаажуулан хувийн хэргийн баяжилт, бүрдүүлэлтийг тухай бүр хийж байна.

11.3 Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хангах: Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны бичиг баримтыг “Түр хадгалах хадгаламжийн нэгжийн баримт”, “Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн баримт”, “70 жилээр хадгалах хадгаламжийн нэгжийн баримт”-ыг архивын 20 нэгж болгон бүрдүүлэв.

Байгууллагын архивт хэрэглэгдэж буй цахим программын судалгааг гаргаж сумын ЗДТГ-т хүргүүллээ.

Архивын өрөөний чийгшил, баримт бичгийн хадгалалтад байнга хяналт тавьж байна.

Сүхбаатар суманд болсон “Архивын ажилтнуудын сургалт”-д 1 албан хаагч, Аймгийн Соёл, урлагийн газраас зохион байгуулсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах арга зүй”-н сургалтад 2 албан хаагч 1 удаа хамрагдаж, мэдээлэл авлаа.

Аймгийн Соёл, урлагийн газрын албан даалгаврын дагуу Хэвлэмэл хуудасны дугаар буюу индекс өгөх зааврыг баримтлан байгууллагын архив, бичиг хэрэгт тусган ажиллаж эхэллээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан бичгийн биелэлтийг хангах, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/263 дугаар тушаалаар батлагдсан “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм” болон Сэлэнгэ аймгийн Төрийн архивын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Хэвлэмэл хуудас хийлгэх, хянуулах тухай” зөвлөмжийн дагуу дараах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж байна. Үүнд:

-Байгууллагын албан баланкны зарцуулалтын тоо ширхэгийг хянаж, дууссан тохиолдолд Архивын ерөнхий газарт хүсэлт хүргүүлж хэвлүүлэх

-Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022 стандартын дагуу байгууллагын монгол бичгийн хэвлэмэл хуудсын эх бэлтгэлийг Архивын ерөнхий газарт хүсэлт хүргүүлэн хийлгэж, бэлтгэх

-Архивын өрөөнд баримт бичгийн тавиурыг тусгаарласан вакум хаалт, хаалга хийлгэх

-Архив болон Үндсэн фондын өрөөнд Стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулсан температур, чийг хэмжигч тавих

-Вакум, хаалга хаалтад гэрэл бууруулах наалт наах, хар өнгийн хөшиг хийх

-Баримт бичгийн тавиураас 50 см-ээс багагүй зайд гэрэлтүүлэг суурилуулах

-Галын буланг сайжруулж, элс, багаж хэрэгсэл, галын хорны бүрэн бүтэн байдлыг хангах

-Галын аюулаас сэргийлэх санамж бүхий самбарыг шинэчилж, шинээр хэвлүүлж тавих

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Монгол улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”, “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дугаар тогтоолын хавсралт “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” хөтөлбөр зэрэг төрийн бодлого хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын хаяг, хаягжилт, төрийн албан хаагчийн анкет, ажлын хавтас

зэргийг бүрдүүлэх ажилд уйгуржин монгол бичгийг тусгаж, нэр хаягийг хос бичгээр үйлдэх ажлыг эрчимжүүлэн зохион байгуулахыг байгууллагын Захирлын 2023 оны А/31 тоот тушаалаар албан хаагчдад үүрэг болгон ажиллаж байна.

11.4 Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажлыг хангах: Төсвийн зарцуулалтыг зохих журмын дагуу явуулж, тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж, өр авлага үүсгэлгүй ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ авах тухай бүрт нь худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байна.

“Шилэн данс”-ны мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хуулийн хугацаанд бүртгэж 140 ш мэдээллийг оруууллаа.

Ашиглалтын хугацаа дуусаж, элэгдэж хуучирсан 7967,839.65 төг-ийн үнэ бүхий 28 нэр төрлийн 94 ш эд хөрөнгө, техник хэрэгслийг актлуулахаар сумын Өмч хамгаалах комисст хүсэлт гаргалаа.

2023 оны аудитын шалгалтад хамрагдаж эрсдэлгүй үнэлгээ авлаа.

Санхүүгийн ил тод байдлыг ханган байгууллагын “Санхүүгийн ил тод байдал”-ын самбарт тайлант оны төсөв, санхүүгийн мэдээллийг тухай бүр 91 ш мэдээлэл байрлуулж, иргэдийг мэдээллээр хангаж байна.

Соёлын сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/238 тоот тушаалын хавсралт “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтын аргачлал”-ыг судалж, байгууллагын бодлого, төлөвлөлтөд тусгаж байна.

Шинээр нэмэгдсэн багаж, техник хэрэгсэл, эд хөрөнгийг байгууллагын Захирлын 2023 оны А/12, А/34 дүгээр тушаалуудаар үндсэн хөрөнгөд бүртгэж, байгууллагын Захирлын 2023 оны А/35 дугаар тушаалуудаар албан хаагчдад хүлээлгэн өгч баталгаажуулж, хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдлыг хангаж байна.

Байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг байгууллагын Захирлын 2023 оны А/36 дугаар тушаалаар шинэчлэн томилж, эд хөрөнгийн тооллогын ажлыг байгууллагын Захирлын 2023 оны А/37 дугаар тушаалаар зохион байгууллаа.

АРВАН ХОЁР: БАЙГУУЛЛАГЫН ОРЧНЫ НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

12.1 Байгууллагын орчны нөхцөлийг сайжруулан тохижилт, урсгал засварын ажлыг зохион байгуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх: Байгууллагын урсгал засвар, тохижилтын ажлыг хамт олны өөрсдийн хүчээр хийж байна. Үүнд:

- "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөний хүрээнд байгууллагын хашаанд 15 ш шар хуайс модыг нэмж тарилаа.

- Байгууллагын хашаанд ургаж буй бүх модонд хавар, намрын тайралтыг хийж, засаж хэлбэржүүлэн, цэнэг усалгааг хийж, тогтмол арчилж байна.
- Ариун цэврийн өрөөний босгонд шинээр плита наалаа.
- Ариун цэврийн өрөөний шалны 5м2 хуучирч муудсан плитанд шалны зориулалтын хуулга нааж, өнгө үзэмжийг сайжрууллаа.
- Мод, зүлэгний усалгаанд ашиглах 30м шаланкыг 75,800 төгрөгөөр худалдан авч хуучин усалгааны шаланкыг сольж, шинэчиллээ.

- Ариун цэврийн өрөөний шаланд 5м2 плитаг шинээр суулгаж, ханыг эко хавтангаар өнгөлж, гарын угаалтуур, хогийн сав зэргийг шинэчиллээ.
- Элэгдэлд орсон нийт 16 ширхэг буюу 36 м2 вакум цонхыг төсөвт тусгагдсан 9,216,000 төгрөгийн зардлаар бүрэн шинээр сольж, засвар үйлчилгээг хийв.
- Үүдний 50х40 хэмжээтэй хаягийг 108,900 төгрөгөөр, 60х40 хэмжээтэй цагийн хуваарийг 108,900 төгрөгөөр тус бүр шинээр хийлгэж байрлууллаа.
- Хашааны блок, төмөр хашлага тус бүрийг будаж, өнгө үзэмжийг сайжрууллаа.
- Үүдний гонх, хаалга хэсгийн ханыг шинээр шавардаж, будаж заслаа.
- Цэцгийн мандалд үр суулгаж, цэцэгжүүлэлтийн ажлыг хийж, арчилгаа, усалгааг тогтмол хийж байна.
- Дугуйн зогсоолын төмрийг гагнаж, засварлав.
- Коридорын цонхонд 1 ш модон тавцанг шинээр хийлээ.
- Гадна үүдний 1 ш гэрлийг шинээр сольж хийлээ.
- Дээврийн төмрийг хадаж, засварлав.
- Сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/460 тоот захирамжийн дагуу байгууллагын хуваарьт 50м хүртэлх нийтийн эзэмшлийн талбай, авто болон явган хүний замын цасыг 2 удаа, байгууллагын Захирлын шийдвэрээр 2 удаа, Минжийн хангайн 7 дугаар багийн Засаг даргын мэдэгдлээр 1 удаа тус бүр цас, мөс цэвэрлэх ажлыг зохион байгуулж, цас орох бүрд цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, халтиргаа гулгаа үүсэхээс сэргийлж ажиллаж байна.
- Байгууллагын байрны дотор их цэвэрлэгээг 2 удаа, гадаа хашааны болон хуваарьт нийтийн эзэмшлийн талбайн их цэвэрлэгээг 3 удаа зохион байгууллаа.
- Дотор тохижилтод нийт 1400,000 төгрөгийн үнэ бүхий номын санчийн ширээ 4ш, 300,000 төгрөгийн үнэ бүхий бичгийн шүүгээ 1ш, 500,000 төгрөгийн үнэ бүхий бичгийн шүүгээ 1ш, үүдний хүлээн авах өрөөнд нийт 578,000 төгрөгийн үнэ бүхий хүлээлгийн зөөлөн сандал 2ш, 220,000 төгрөгийн үнэ бүхий сэтгүүлийн жижиг ширээ 1ш, архивын өрөөнд 1,216,800 төгрөгийн үнэ бүхий 3,6х2 хэмжээтэй вакум хаалтыг тус бүр засварлаж, материалыг худалдан авч засвар үйлчилгээг хийж, өнгө үзэмжийг сайжрууллаа.
- Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд: Мандал энерго ОНӨААТҮГ-аас ирүүлсэн мэдэгдлийн дагуу болон байгууллагын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд:

-Төвийн халаалт, дулааны шугамын лоткид байрладаг номын сангийн цэвэр усны 25 м шугам хагарч ус алдаж, цаашид ашиглах боломжгүйгээр муудсан тул сумын Засаг даргад хүсэлт гаргаж, 1500,000 төгрөгийн өртөг бүхий (145250 төгрөгийн зардал номын сангаас гарсан) засварын ажлыг Мандал энерго ОНӨААТҮГ-аар хийлгэж, бүрэн ажиллагааг хангалаа.

-Дулааны шугамыг сайжруулж, худгийг шаттай болголлоо.

-Цонх, хаалганы дулаалгыг сайжруулж, дулаан алдагдлыг бууруууллаа.

-Халаах хэрэгслээс ус авч буй хаалтыг авч зориулалтын хий авагч тавилаа.

-Халаалт, цэвэр усны шугам, усны тоолуурт тогтмол үзлэг хийж, үүсэх эрсдэл, цэвэр усны алдагдлаас сэргийлж байна.

АРВАН ГУРАВ: ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ, ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ОРОЛЦООГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

13.1 Дээд шатны байгууллага удирдлагаас өгөгдсөн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг хангах, номын сангийн үйл ажиллагаанд холбогдох тайлан мэдээг тухай бүр гаргах: Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөө, Үндэсний зорилтот хөтөлбөрүүд болон бусад холбогдох эрхзүйн баримтын хүрээнд зохион байгуулсан ажлын биелэлт, байгууллагын сар, улирал, жилийн ажлын мэдээ, тайлан, холбогдох судалгаа зэрэг мэдээ, тайлангуудыг тухай бүр, хуулийн хугацаанд гаргаж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж байна. Үүнд:

- Номын сангийн үйл ажиллагааны 7 хоног бүрийн тойм мэдээг- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагын 2023 оны 1-р улирлын статистик мэдээг-Аймгийн Соёл, урлагийн газарт
- 2022 оны хөрөнгө санхүүгийн мэдээ- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагад хөтлөгдөж буй архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын судалгааг- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагын эрсдэлийн үнэлгээг - Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагын барилга, байгууламжийн судалгааг- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагын газар эзэмшлийн судалгааг- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагын хүний нөөцийн судалгааг- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Аймгийн Засаг даргаас, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусгах саналаа- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагын 2022 оны статистик мэдээг- Аймгийн Соёл, урлагийн газарт
- Байгууллагын архивын програм хангамжийн судалгааг- Сумын ЗДТГ-т
- Байгууллагын нийтийн хог цэвэрлэгээнд оролцсон ажлын мэдээг- Сумын ЗДТГ-т
- Байгууллагын олон нийтийн мод тарилтад оролцсон ажлын мэдээг- Сумын ЗДТГ-т
- Байгууллагын газар хөдлөлтийн дадлага сургуулилтад оролцсон ажлын мэдээг- Сумын ЗДТГ-т
- Байгууллагын мэдээлэл, холбооны техник хэрэгслийн судалгааг- Сумын ЗДТГ-т
- Байгууллагын сар бүрийн ажлын мэдээг- Сумын ЗДТГ-т гэх мэт тус тус гаргаж явууллаа.

“Соёлын салбарын албан хаагчдын нэгдсэн судалгаа”-нд хамт олноороо бүрэн хамрагдлаа.

13.2 Төв, орон нутгаас зохион байгуулж буй цаг үеийн шаардлагатай ажил, хурал зөвлөгөөн болон бүх нийтээр мод тарих ажил, хог цэвэрлэгээ, гамшгаас хамгаалах ажилд байгууллага хамт олноороо оролцох, нийгмийн хариуцлагаа биелүүлэх:

- **Сумын ИТХ-ын ойн ном бүтээх ажилд оролцох:** Нийтийн номын сан нь ИТХ-ын 30 жилийн ойн баярт зориулсан “Иргэдийн итгэл-Нутгийн хөгжил-Хамтын зүтгэл. Хугас жарны цадиг” номыг бүтээхэд оролцон ажиллаж, 1 албан хаагч ИТХ-ын Хүндэт Жуух бичгээр шагнагдлаа.

- **Нийтийн цас цэвэрлэгээнд оролцох:** Сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/460 тоот захирамжийн дагуу манай хамт олон хуваарьт 50м хүртэлх нийтийн эзэмшлийн талбай, авто болон явган хүний замын цасыг цэвэрлэлээ.
- **Нийтийн хог цэвэрлэгээнд оролцох тухай:** Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/156 тоот захирамж, Сумын Засаг даргын 2023 оны 01/213 тоотын дагуу ” Нийтийн хог цэвэрлэгээ”-ний ажилд оролцож, Ширхэнцэг уулын орчимд хамт

олноороо цэвэрлэгээ хийлээ. Сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/207 тоотын дагуу хогийн цэгийн зүүн хэсэгт хур хог цэвэрлэх "Нийтийн хог цэвэрлэгээ"-ний ажилд хамт олноороо оролцлоо.

- **Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай:** Сумын Засаг даргын 2023 оны 09 дугаар сарын 11-ний өдрийн А/460 тоот захирамжийн дагуу өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангаж, байгууллагын ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж, урсгал засвар хийж байгууллагын өнгө үзэмжийг сайжруууллаа.
- **"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тухай:** Сумын Засаг даргын 2023 оны 05 сарын 12-ны өдрийн А/159 тоот захирамжийн дагуу байгууллагын хашаанд 15 ширхэг шар хуайс модыг тарилаа. Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/352 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх намрын мод тарилтын ажилд хамт олноо зохион байгуулж оролцож, Хараа голын эрэгт 10 ш бургас мод тарилаа.
- **Сумын "ДӨЛ" тэмцээний шүүгчээр ажилласан тухай:** 2022.05.06-ны өдөр Сумын ЗДТГ-ын даалгаврын дагуу сумын "ДӨЛ" тэмцээний шүүгчээр Нийтийн номын сангийн албан хаагч-2, асуулт хариултын тэмцээн, эссэ бичлэгийн уралдааныг шүүж, оноо байрыг эзлүүлэх ажлыг хийлээ. Мөн асуулт, хариултын тэмцээнд ашиглагдсан монголын түүхийн сэдэвт 70 асуултыг 8-12 дугаар ангийн түүхийн сурах бичгээс бэлтгэн оролцлоо.
- **Хурал, зөвлөгөөнд оролцох:** 2023.02.09-ний өдөр Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Энх-Амгалангаар ахлуулсан ажлын хэсгийн Сэлэнгэ Аймгийн соёлын салбарын ажилтан, албан хаагчидтай хийсэн уулзалтад 2 албан хаагч, УИХ-ын гишүүн Д.Өнөрболорын зохион байгуулсан "Сэтгэл зүйн сургалт, Үндсэн хуулийн хэлэлцүүлэг", Сумын ЗДТГ-аас зохион байгуулсан "Үндсэн хуулийн мэдлэг" сургалт, УИХ-ын гишүүн Ч.Ундрам, УИХ-ын гишүүн Т.Доржхандтай хийсэн олон нийтийн уулзалт, УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбаттай хийсэн олон нийтийн уулзалтад хамт олноороо идэвхтэй оролцлоо. Сумын удирдах ажилтны зөвлөгөөнд 1 хүн оролцлоо.
- **Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл хангах "Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулилт":** Нийтийн номын сангаас "Газар хөдлөлтийн үеийн стратегийн дадлага сургууль"-ийн "Ухуулга сурталчилгааны хэсэг"-т 2 албан хаагч оролцон ажиллаж, сумын Төмөр замчдын 1 дүгээр баг болон Баянхангайн 6 дугаар багийн нийт гудамж, олон нийтийн зам талбай, худалдаа үйлчилгээний байгууллага, айл өрхүүдэд газар хөдлөлтийн дуут мэдээг хүргэж ажиллалаа. Мөн 135 иргэнд гарын авлага тарааж, иргэд олноор цуглах 7 байршилд А3 хэмжээтэй мэдээллийн хуудсыг байршууллаа. Мөн Нийтийн номын сангийн 5 албан хаагч дуут дохиогоор заасан байршилд цуглаж, мэдээллийг авч, цахим орчинд Мандал сумын Засаг даргын Тамгын газрын группэд тавигдсан дадлага, сургуулилтын талаарх мэдээ мэдээллийг Нийтийн номын сангийн цахим хуудсаар 9 удаа шэйр хийж, 153 хандалттайгаар ажиллалаа.
- **Ой хээрийн түймэр, гамшгийн үеийн бэлтгэл бэлэн байдлыг хангах:** Ой хээрийн түймэр, гамшгийн үеийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж, болзошгүй аюулаас сэргийлэх албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэн мэдээлэл хүргэж, "Гамшгийн дадлага, сургуулилалт"-ыг сумын Онцгой байдлын хэлтэстэй хамтран Номын сангийн байранд 1 удаа хийлээ.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай" тухай А/134 тоот захирамжийн дагуу сумын ЗДТГ-ын байранд жижүүрээр ажиллах албан хаагчдын хуваарийг гаргаж 2023 оны 05 дугаар сарын 31-ний 08.00 цагаас 22.00 цаг хүртэл ажиллалаа.

Гамшгийн эрсдэлийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх үүрэг бүхий "Гамшгаас хамгаалах штаб"-ыг Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/31 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/52 тоот тушаалаар тус штабын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан, бэлтгэл бэлэн байдлыг хангаан ажиллаж байна. Зохион байгуулсан ажлын тайланг гаргаж Сумын ЗДТГ-т хүргүүллээ.

- **“Хамтаараа амьдрах соёл” нөлөөлийн аянд нэгдэх:** “Амар
амгалан маргаашийн Монгол” НҮТТБ-аас санаачлан зохион байгуулж буй “Хамтаараа амьдрах соёл” соёл, төлөвшлийн урт хугацааны хөтөлбөр, нөлөөллийн аянд нэгдэж, “Хамтаараа амьдрах соёл” цахим хуудсанд нэгдэж, байгууллагын цахим хуудсанд брэнд бүүкийг байрлуулж, өөрийн профайл зурагт “Мэндэлье, Хүндэлье, Хайрлая” хүрээг нэмж, албан хаагчид болон уншигчид, иргэдэд мэдээллийг түгээж ажиллаж байна.
- **“Соёлын сэргэлт аян”-д оролцох**: Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/315 дугаар захирамжийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Мандал суманд зохион байгуулагдсан “Соёлын сэргэлт-2023” аянд оролцож ховор хуучин болон шинэ номын үзэсгэлэн, “Ноён уул”, “Угийн бичиг” сэдвүүдээр фото зургийн үзэсгэлэн болон бусад холбогдох материалуудыг бэлтгэж оролцлоо.
- **“Хамтдаа шалгая, хамгаалъя” аянд нэгдэх**: Сэлэнгэ аймгийн
Мандал сумын Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 02/987 дугаар албан бичгийн дагуу, улс орон даяар явагдаж буй “Хамтдаа шалгая, хамгаалъя” аянд нэгдэн, байгууллагын бүх албан хаагч нараар цахим судалгааг бөглүүлж, байгууллагын орчинд үнэлгээ хийж, илэрсэн эрсдэлийг зурагжуулж баталгаажуулах, эрсдэлийг арилгах, цахим орчинд байршуулан олон нийтийг уриалах ажлуудыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж байна.
- **“Шилдэг эцэг, эхийн зөвлөл” шалгаруулах уралдаанд оролцох тухай:**
Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 02/1015 дугаар албан бичгийн дагуу, Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зарласан “Шилдэг эцэг, эхийн зөвлөл” шалгаруулах уралдаанд оролцож, хэрэгжилтийг хангалаа.
- **Сумын түүхийн дурсгалт, бахархалт газруудыг тогтоох ажилд оролцох:**
Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 3/216 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангаж, Мандал сумын нутаг дэвсгэрийн 55 байршилд буй 152 ш соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг тогтоосон тул уг соёлын үл хөдлөх өвүүдийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15, 16, 17 дугаар зүйлүүдэд заасан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сумын Засаг даргын Соёлын өвийн талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийн дагуу “Сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д оруулан баталж, хадгалалт, хамгаалалтыг хангах саналыг Сумын Засаг даргын тамгын газарт хүргүүллээ.
- **Сумын түүхт 100 жилийн ойд зориулсан сэтгүүл зурагт альбом гаргах
ажилд оролцох:** Сэлэнгэ аймгийн Мандал сумын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан сумын түүхэн хөгжлийн талаар сэтгүүл эрхлэн гаргах ажилд Нийтийн номын сан голлох үүрэгтэй ажиллах болсон тул түүхийн материалыг эмхэтгэх, сурвалжлан олох ажлуудыг зохион байгуулж байна.
- **“Жендэрт суурилсан хүчирхийлэл”-тэй тэмцэх аянд оролцох:** Мандал
сумын нийтийн номын сангийн хамт олон тус аянд нэгдэж, номын санч С.Цэндсүрэн “Хүчирхийллийн эсрэг” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг байгууллагын хэмжээнд зохион байгуулж 6 албан хаагчийг хамрууллаа. Тус сургалтаар албан хаагчид “Жендэрт суурилсан хүчирхийлэл”-ийн талаарх хууль эрх зүйн мэдлэгээ нэмэгдүүлж, ажлын байрандаа “Хүндлэл хамгийн тод гэрэл” уриаг хэрэгжүүлэн, байгууллагын цахим хуудсаар иргэдэд уриалга, мэдээллийг хүргэж ажиллаж байна.
- **Соёлын бүтээлч сар, соёлын эрхийн бичиг олгох ажил:** Соёлын тэгш
хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын боловсролтой иргэнийг бэлдэх зорилгоор “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд “Соёлын эрхийн бичиг”-ийн хөтөлбөрт Мандал сумын ЕБ-ын I, IV сургуулийн ахлах бүлгийн 16-18 насны 94 сурагчийг “Угийн бичгээ хөтөлж, удмын сангаа хамгаалъя” сургалт, хөтөлбөрт хамрууллаа.

Эрхийн бичгээр сургалтад хамрагдсан анги хамт олон

д/д	Арга хэмжээний нэр	Хамрагдсан сургууль, анги хамт олон	Хэдэн хүүхэд
1	“Угийн бичгээ хөтөлж, удмын сангаа хамгаалъя” сургалт	4-р сургууль 11-р ангийн сурагчид	35
2		4-р сургууль 12-а ангийн сурагчид	15
3		1-р сургууль 11-р ангйин сурагчид	44
	Нийт		94 сурагч

Соёлын бүтээлч сар аяны хүрээнд Мандал V дугаар сургуулийн Ч.Мөнхцэцэг багштай 3-б ангийн 23 сурагч номтой нөхөрлөж, анги хамт олноороо номын сангийн уншигчид болж, бүтээлч уншигчаар сурагч Ж.Идэржавхлан шалгарч, шинэ номоор шагнууллаа.

13.3 Байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг сайжруулан, эрчимжүүлэх:

Байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-өөс “Хүүхдээ сонсъё-II” аяныг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж эхлэн, “Хүүхэд хүмүүжүүлэх арга” сургалтыг 1 удаа ажлын байранд зохион байгуулж, 6 албан хаагчийг хамруууллаа.

АРВАН ДӨРӨВ: ХУУЛЬ ЭРХЗҮЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛЖ УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

14.1 Төрийн болон номын сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн биелэлтийг хангаж иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг сайжруулах, албан хаагчдын ажлын хариуцлага, биелэлтийг сайжруулж, “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг сайжруулах нь” хөтөлбөрийн хүрээнд хууль эрхзүйн мэдлэгийг нэмэгдүүлэн, төрийн албан хаагчийн ёс зүйг сахиулж, авилга, ашиг сонирхлын зөрчил болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх:

Төрийн албаны хуулийг хэрэгжилтийг хангаж, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн, сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, хамт олны эв нэгдлийг дээдлэн, иргэдэд ээлтэй төрийн үйлчилгээг бэхжүүлэх үүднээс Төрийн албаны болон бусад холбогдох хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон байгууллагын ажлын зохион байгуулалтыг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Удирдлагын баг”, “Мэргэжил-аргазүйн алба”, “Аж ахуйн алба”, “Гамшгаас хамгаалах штаб”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус байнгын комисс” гэсэн ажлын хэсгүүдийг шинээр байгуулан томилж, “Дотоод хяналтын комисс”, “Баримт бичиг нягтлан шалгах комисс”, “Эцэг, эхийн зөвлөл”, “Ёс зүйн зөвлөл”, “Ариутгал халдваргүйтгэлийн баг” гэсэн ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнтэйгээр хууль, эрхзүйн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгууллагын албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын гүйцэтгэлд анхан шатанд нь хяналт тавих зорилготой Номын сангийн Мэргэжил -аргазүйн албаны номын санчдын болон аж ахуйн албаны албан хаагчдын "Эртэч уулзалт"-ыг зохион байгууллаа. Албан хаагчдын ажил үүргийн биелэлтийн үр дүнг тооцон “Эртэч уулзалт” арга хэмжээг 2 удаа зохион байгуулан ажлын явц, үр дүн, шинэ арга туршлагаа харилцан ярилцлаа.

Иргэдэд номын сангийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй хүргэх, уншигчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор “Эелдэг харилцаа, ээлтэй үйлчилгээ” уриан дор номын сангаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Уншигчаа сонсъё” аян, “Хөтөч номын санч”-ийн үйлчилгээгээр дамжуулан уншигчдадаа хүрч үйлчилж, “Үйлчилгээний ажилтны авир төрхийн шаардлагууд”-ыг дагаж мөрдөн, төрийн албан хаагчийн мөрдөх

зарчим, журам, ёс зүйн талаарх мэдээллүүдийг албан хаагчдын өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээнд нь хувилан тарааж, мэдээллийн самбарт байрлуулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

2023 онд Аймгийн ЗДТГ-ын "Төр төсвийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үр дүнг үнэлэх тухай" шалгалтад хамрагдаж, байгууллагын үйл ажиллагааг шалгуулж, ажилттай дүгнэгдсэн үр дүнтэй ажиллаж байна.

Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 10ш хяналтын камерыг 3.500,000 төгрөгөөр Улаанбаатар хотын GRID NETICS ХХК-иар хийлгэж, байгууллагын хяналтын камеруудыг шинэчиллээ.

Уламжлалт цагаан сарын баяраар хариуцлагатай эргүүл жижүүрүүдийг хуваарийн дагуу ажиллуулж сумын тамгын газрын 70367010 утсанд өдөрт гурван удаа мэдээгээ өгч ажиллалаа.

Байгууллагын "Ёс зүйн зөвлөл"-ийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж, "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоолын дагуу төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлага, дэг журмыг чанд сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэн, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг дээдлэн, алдаа дутагдал гаргахгүй ажиллах талаарх мэдээллийг албан хаагчдад тогтмол хүргэн сануулж, боловсон хүчинтэй холбоотой тушаал шийдвэрт тогтмол тусган, албан хаагчдад "Ёс зүйн зааварчилгаа"-г ээлжит болон ээлжит бусаар тогтмол өгч, "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдэвт ажлын байрны сургалтад 1 удаа 8 албан хаагчийг хамруууллаа.

Сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 03/71 тоот албан бичгийг үндэслэн 2023 онд байгууллагад хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Засгийн газрын 2023 оны 03 сарын 17-ны өдрийн хэг/595 тоот "Чиглэл хүргүүлэх тухай" албан даалгаврын дагуу Засгийн газраас зарласан "Шүүр" ажиллагааны талаарх байгууллагад хамаарах мэдээллийг зохих журмыг дагуу гаргаж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн, тухайн ажиллагааны талаарх мэдээллийг албан хаагчдад хүргэж, байгууллагын бодлого, төлөвлөлтөд тусган ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 55 дугаар албан бичгийн биелэлтийг хангаж, "Монголын хүүхдийн оролцооны үндэсний чуулган"-аас гаргасан зөвлөмжийг баримтлан, "Хүүхдийн эрхийг дээдэлье" уриан дор номын сангийн үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг дээдлэх ажлыг зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж байна.

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 53 дугаар албан бичгийн биелэлтийг хангаж, "Хөшиг нээгдэх бүрд-Хүргэх нэг үг" уриалгыг хэрэгжүүлэн, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үүргийг сануулсан уриалга үг, постерыг тусгайлан бэлтгэж, ном уншлага, соёл, олон нийтийн ажил эхлэх бүрийн эхэнд уншигч, иргэдэд танилцуулж хэвшин, хэрэгжилтийг хангаж байна.

Зохиогчийн эрхийн хуулийг дээдэлж, номын сангийн үйл ажиллагаа, ном уншлага, соёл олон нийтийн ажил явуулах, цахим мэдээлэл түгээхдээ оюуны өмчийг зөрчихгүй байхад анхаарч, албан хаагчдыг оюуны өмчтэй холбоотой гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахыг байгууллагын Захирлын 2023 оны А/30 дугаар тушаалаар албан хаагчдад үүрэг болгон ажиллаж, хэрэгжилтийг хангаж байна.

Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу "Албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох үнэлгээний хуудас"-ыг тус байгууллагын Захирлын 2023 оны А/01 дүгээр тушаал, "Албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох үнэлгээний хуудас"-ыг байгууллагын Захирлын 2023 оны А/02 дугаар тушаалаар батлан тус тус хэрэгжилтийг хангаж байна.

Захиргааны чиглэлээр Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлын 2023 оны эхний хагас жилд зохион байгуулж хийж гүйцэтгэсэн ажлын тайлан гаргаж хүргүүллээ.

Байгууллагын "Хуулийн мэдээллийн сан"-г нэмэгдүүлэн баяжуулж байна.

Дээрх ажлуудыг зохион байгуулж, албан хаагчдын ажлын хариуцлага, биелэлтийг хангаж, авлига, гэмт хэрэг, ёс зүйн зөрчлүүдээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

14.2 Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд ил тод, шуурхай хүргэх: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийн хэрэгжилтийг хангаж, цахим орчинд, Байгууллагын үйл ажиллагааны талаарх өдөр тутмын мэдээлэл болон СОНА-ын талаарх мэдээллийг Сэлэнгэ Мандал номын сан цахим хуудсанд 102 удаа тус тус оруулж 5134 хандалттай ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны талаарх өдөр тутмын мэдээлэл болон СОНА-ын талаарх мэдээлэл	102
Нийт 102 удаа 5134 хандалт	

- Цаг үеийн мэдээ болгож МОНЦАМЭ агентлаг өөрийн цахим хуудсаараа
манай байгууллагаас "Эх хэлний өдөр"-ийг тохиолдуулан зохион байгуулсан "Хос бичигтэн болж- Зөв найруулж, бичиж сурцгаая" аяныг мэдээлж, сурталчилсан.
- Монголын Үндэсний Телевиз-ийн "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөрөөр
манай байгууллагын үйл ажиллагаа, онцлох ажлын талаар нэвтрүүлсэн.

Мэдээллийн самбар-т, байгууллагын танилцуулга, уриа, номын сангийн үйлчилгээний журам, Номын сангийн холбогдолтой хууль дүрэм, байгууллагын захирлын тушаал, зөвлөгөө, зөвлөмж, шинэ номын мэдээлэл, сарын мэдээ тайлан зэрэг мэдээллийг 15 удаа шинэчлэн тавьсан.

14.3 Нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдэд аливаа эрсдлээс хамгаалах мэдлэг олгох мэдээллийг тогтмол хүргэх: Сэлэнгэ Мандал номын сан цахим хуудсанд танин мэдэхүй, эрүүл мэндийн талаарх мэдээлэл, хүчирхийллийн эсрэг мэдээ мэдээллийг нийт 33 удаа иргэдэд хүргэж, 1415 хандалттайгаар ажиллаж байна.

Танин мэдэхүй, эрүүл мэндийн талаарх мэдээлэл	21
Нийт 21 удаа 967 хандалт	

Хүчирхийлэлд өртөх эрсдлээс сэргийлэх зөвлөмж	12
Нийт 12 удаа 448 хандалт	

15.2.3 "Уншигчаа сонсъё" аяныг уламжлал болгон зохион байгуулах: Байгууллагад иргэдээс ирсэн өргөдөл, гомдол байхгүй. Албан хаагчдаас ирүүлсэн 4 ш өргөдөл, хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж, хариуг шуурхай өгч ажиллаж байна.

Уншигчдын санал, хүсэлтийг сонсох, номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээний түвшинд үнэлгээ хийх, ажил сайжруулах үүднээс жил бүр уламжлал болгон "Уншигчаа сонсъё" аяныг зохион байгуулж, уншигч, иргэдээс санал хүсэлт, судалгааг авч үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

- Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа: Түүврээр 43 уншигч үйлчлүүлэгчээс, номын сангийн тохижилт үйлчилгээ, номын санч, туслах ажилчдын харилцаа хандлагын талаар судалгаа, санал хүсэлт ирсэн байна.

№	Асуулт	Хариултын тоо буюу нийт 5 хүний сэтгэгдэлээс эзлэх хувь		
		Тийм	хааяа	үгүй
1	Та номын сангаар тогтмол үйлчлүүлдэг үү	34 буюу 79 %	9, буюу 20,9%	-
		Сайн	Дунд	-
2	Номын санчдын үйлчилгээний талаарх таны бодол	41 буюу 95.3 %	2 буюу 4,6 %	-

3	Номын санчдын харилцаа, хандлагын талаарх таны бодол	39 буюу 90,6 %	2 буюу 4,6 %	1 буюу 2.3 %
		Чаддаг	Заримдаа	Чаддаг гүй
4	Та уншихыг хүссэн номоо тухай бүртээ авч уншиж чаддаг уу	39 буюу 90,6 %	2 буюу 4,6 %	1 буюу 2.3 %
5	Гэрээр ном олгох үйлчилгээгээр ном зохиолоо авч уншиж чаддаг уу	41 буюу 95.3 %	2 буюу 4.6 %	-
6	Номын сангийн удирдлагад хүргүүлэх таны санал	Үргэлж цэвэрхэн дулаахан орчинд бидэнд дуртай номоо уншиж, хичээлээ хийх боломжоор хангаж өгдөг номын сангийн ах, эгч нартаа баярлалаа. Номын сангийн байрыг томруулж өгч болох уу, бид олноороо суухад хүрэлцдэггүй.		

- Санал хүсэлтийн хайрцаг: Санал хүсэлтийн хайрцгаар уншигчдаас санал ирээгүй.

- Сэлэнгэ Мандал Номын сан цахим хуудас: Мөн байгууллагын цахим хуудсанд уншигчдын сэтгэгдэл бичигдэж байна.

Шийдвэрлэсэн байдал:

№	Санал	Хүрсэн үр дүн
1	Хүүхдийн уншлагын танхимын тохижилтыг сайжруулах	Хүүхдийн уншлагын танхимд номын тавиур авлаа.
2	Компьютер ашиглаж цахим ном унших үйлчилгээтэй болох	Номын сангийн компьютер, техник хэрэгслийг сайжруулах зорилгоор Аймгийн Засаг даргад хүсэлт гаргасны дагуу 8 сая гаруй санхүүжилт авч, компьютер техник хэрэгслээр хангагдлаа. Дотоод нөөц бололцоогоо ашиглан уншигчдад электрон каталог ашиглуулах техник хэрэгслийн буланг гаргалаа.
3	Хүлээлгийн танхимыг тохижуулах	Уншигчдын тав тухыг хангаж, зөөлөн сандал, ширээ бүхий хүлээлгийн хэсгийг тохижууллаа.

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШИН:

Үзүүлэлт		**2021 он**	**2022 он**	**2023 он**	**Хувь**
Суудлын тоо		42	42	42	
Уншигчдын тоо	Шинэ уншигч	439	1972	2044	3,7 %
	Ирэгсэд	1235	8003	8211	2,6 %
Олгосон номын тоо	Нийт	1685	11315	12276	8,5 %
Номын фонд	тоогоор	28524	29137	29520	0,61%
Шинээр авсан ном	тоогоор	254	613	383	-70,9%

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЧМЭЛ ТАЙЛАН

АГУУЛГА

1. Номын сангийн мэдээлэл

1.1. Эрхэм зорилго

1.2. Номын сангийн ерөнхий мэдээлэл

2. Сан хөмрөг

2.1. Сан хөмрөгийн баяжилт

2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт

3. Үйлчилгээ

3.1. Уншлага, үйлчилгээ

3.2. Зөөврийн номын сангийн үйлчилгээ

3.3. Цахим номын үйлчилгээ

3.4. Номын үзэсгэлэн

3.5. Зугаатай зуны хөгжилтэй уншлага

3.6. Номын хэлэлцүүлэг

3.7. Зохиолч уншигчдын уулзалт

3.8. Лавлагаа мэдээлэл

3.9. Мэргэжил арга зүйн ажил

4. Соёл олон нийтийн ажил

5.Байгууллагын аюулгүй байдал

6. Гадаад харилцаа

7. Төсөл хөтөлбөр

8. Сургалт, семинар

9. Дугуйлан, Ногоон байгууламж

10. Хөрөнгө оруулалт, Төсөв

11. Монгол бичгийн албан хэрэг хөтлөлт

12.Бусад ажил

Тайлбар:

Төв аймгийн нийтийн номын сангийн 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг 11 бүлэгт хуваан тайлагналаа.

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Эрхэм зорилго: Мэдлэг оюунд тулгуурласан мэдээллийн эрин зуунд дэвшилтэд техник технологийг ашиглан уншигч, үйлчлүүлэгчдэд хэрэгцээт мэдээллийг

нээлттэй хүргэх, Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн нийтийн номын санг “Хүний хөгжил-цахим мэдээллийн төв” болгоно.

1.2. Номын сангийн ерөнхий мэдээлэл: Төв аймгийн Нийтийн номын сан нь анх 1944 оны 4-р сарын 28-нд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 54 дүгээр тогтоолоор олон түмэнд ном хэвлэлээр үйлчлэх үйл ажиллагаагаа эхэлж байсан бол 1989 оны 8-р сарын 1-нд нэг ээлжиндээ 120 хүн хүлээн авах, 100.000 ном байрлуулах хүчин чадалтай зориулалтын байранд шилжин орж үйл ажиллагаагаа явуулж байна. 2016 онд Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн нийтийн номын сан болсон. Төв аймаг, БНСУ-ын Пёнтек хотын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд 2020 онд Пёнтек хотоос 920 сая, ОНТ-өөс 276 сая нийт 1 тэрбум 196 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар шинэчлэл хийгдэн уншигч, үйлчлүүлэгчид мэдээллээ чөлөөтэй олж авах чөлөөт сонголт бий болгож, тав тухтай орчин бүрлүүлж номын сангийн үйл ажиллагааг 1 дахин нэмэгдүүлж 238 хүний суудалтай болгон өргөжүүлсэн. Орон тооны нийт 13 ажилтан, албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийтийн номын сан нь:

- Захирлын өрөө
- Сургалтын танхим
- Лавлагаа мэдээллийн танхим
- Тогтмол хэвлэл
- Насанд хүрэгчдийн уншлагын танхим
- Цахим мэдээллийн танхим
- Нягтлан бодогчийн өрөө
- Архивын өрөө
- Хүүхдийн уншлагын танхим
- Гэрээр олгох танхим
- Цайны өрөө

Цахим хаяг: “Төв Нийтийн номын сан” – Фейсбүүк хаяг Library.to.gov.mn – Вэб сайт
Цагийн хуваарь: Даваа - Баасан гаригт 9:00 - 13:00, 14:00-18:00 цаг, /13:00 – 14:00 цайны цаг/

Байгууллагын утас: 77682770

Номын сангийн захирал: Б.Зоригтбаатар

ХОЁР. САН ХӨМРӨГ

2.1. Сан хөмрөгийн баяжилт: Уншигчдын эрэлт хэрэгцээг үндэслэн татгалзлалын дэвтэр хөтөлж тухайн жилийн батлагдсан төсвөөс сан хөмрөгийн баяжилтаа хийж ирсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар төсвийн хөрөнгөөр 7,951,939 төгрөгийн 356ш ном,

Хандив тусламжаар 3,111,300 төгрөгийн 269ш ном нийт 11,063,239 төгрөгний 625ш номоор сан хөмрөгөө баяжуулан электрон каталогт оруулан уншигчдын хүртээл болголоо.

2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт: Номын сангийн чухал зүйлийн нэг бол сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт байдаг. Ийм учраас 2023 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Уншлагын танхимуудын сан хөмрөгийн урагдаж гэмтсэн, шаардлага хангахгүй болсон 127 ширхэг номыг өөрсдийн нөөц бололцоог ашиглан сэлбэн засаж, уншлага үйлчилгээнд гаргасан.

2. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа нийт ном, хэвлэл болон тавиурын тоосыг арчиж цэвэрлэсэн.

3. Байгууллагын өрөө тасалгаануудад жилд 2 удаа цэвэрлэгээ, ариутгал хийлгэсэн.

4. Шинээр ирсэн 625 ширхэг номыг бүртгэж, 3 танхимдаа хуваарилан танхим тус бүр техник ажиллагаагаа хийж ШУ–ны салбаруудаар тавиурт байрлуулсан.

5. Улирал бүр “Номын санч сэтгүүл” , ”Улирал ба зохиолч” , ”Төрийн мэдээлэл”, “Уламжлал” гэсэн 4 нэр төрлийн 195 ширхэг сэтгүүл захиалж уншигчдад хүргэж хаягжуулж, тогтмол хэвлэлийн фондод байршуулсан.

6. “Өдрийн сонин” , ”Зууны мэдээ” , ”Хүмүүн бичиг” , ”Утга зохиол урлаг” гэсэн 4 төрлийн сонинг захиалан уншигч үйлчлүүлэгчдэд хүргэсэн. “Өдрийн сонин” , ”Зууны мэдээ” сонины 258 дугаарыг сар сараар нь багцлан үдэж, ”Хүмүүн бичиг” сонины 42 дугаарыг багцлан үдэж тус бүр хаягжуулан архивласан.

7. Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй “Анхдугаар таван жил” сонины 1961 оноос 1990 он хүртэлх дугааруудыг хавтаслаж үдэн хадгалалт хамгаалалтыг сайжруулсан. Мөн Байгууллагын www.library.to.gov.mn Вэб сайтад 1963, 1964 оны 82 дугаарыг цахимд оруулан уншигчийн хүртээл болгосон.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ

Нийтийн номын сан нь Насанд хүрэгчдийн уншлагын танхим, Хүүхдийн уншлагын танхим, Гэрээр олгох танхим гэсэн 3 танхимаар иргэд, уншичдад үйлчилж 2913 байнгын уншигч, 13605 ирэгсэд, 35351ном, 201 сэтгүүл, 520 сонингоор танхимаар болон гэрээр олгож үйлчилгээ үзүүлсэн.

3.1. Уншлага, үйлчилгээ: Уншлага үйлчилгээг дараах байдлаар тус тус хүргэсэн байна.

1. Насанд хүрэгчдийн уншлагын танхим: 975 байнгын уншигч, 4536 ирэгсэд, 11807 ном танхимаар болон гэрээр олгосон.

2. Хүүхдийн уншлагын танхим: 978 байнгын уншигч, 4536 ирэгсэд, 11772 ширхэг ном танхимаар олгосон.

3. Гэрээр олгох танхим: 960 байнгын уншигч, 4534 ирэгсэд, 11772 ширхэг ном танхимаар болон гэрээх олгосон.

3.2. Зөөврийн номын сангийн үйлчилгээ: Аймгийн нийтийн номын сан нь Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө орон нутгийн иргэд, уншигч, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх, цар хүрээг өргөжүүлэх, мөн шинэ номын танилцуулга хийх зорилготойгоор Баянхангай, Эрдэнэсант, Лүн, Өндөрширээт, Баянцогт, Баянхангай, Дэлгэрхаан, Бүрэн, Өндөрширээт, Эрдэнэ, Эрдэнэсант, Архуст, Сэргэлэн, Баянчандмань, Зуунмод сумын 6-н баг, МСҮТ, УБЦТС-Зуунмод ХҮГ, Нархан хүүхэд хөгжлийн төв, Ахмадын сувилал, ХЦА Сургуулийн Б дотуур байр, ХЦБ Сургуулийн 3б ангийн багш, 016-р цэргийн анги гэсэн байгууллагуудын сургуулийн номын санч нартай хамтран 1-3 сарын хугацаатайгаар “Зөөврийн номын сан”-ийн үйлчилгээг хүргэсэн. Нийт 15 сум, 8 байгууллагын **1757** иргэнд **2700** номыг олгож уншуулсан.

3.3. Цахим номын үйлчилгээ: 1. Байгууллагын цахим хуудсанд электрон каталогоо байрлуулан иргэд, уншигчид орон зай харгалзахгүйгээр **14134** төрлийн **36060** номын мэдээллийг авах боломж бүрдсэн. Мөн байгууллагын Facebook цахим хуудсанд видео мэдээлэл 45, цахим ном 110, хүүхдийн уншлагын танхимаас 52 үлгэр, хөгжөөнт бодлого 37, танин мэдэхүй 57 нийт **301** мэдээ мэдээллийг бэлтгэн байршуулж **122096** иргэн хандалтаар орж мэдээлэл авсан. Цахим мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор цахим сайтад 39 удаагийн цахим номын үзэсгэлэнг гарган 5947 уншигч, үйлчлүүлэгч зочилж мэдээлэл авсан.





2. Гэртээ хүүхдээ харж байгаа ээжүүддээ зориулаад **“Оюунлаг Эмэгтэйчүүд”** групп чат нээж зөөврөөр болон цахим номын үйлчилгээг хүргэж байна. “Оюунлаг Эмэгтэйчүүд” групп нийт **715** байнгын уншигч гишүүдтэй болж нийт 91ш номоор зөөврийн номын үйлчилгээг хүргэсэн. Ээжүүд номын тэмдэглэл хөтөлж хэвшсэн.












3.4. Номын үзэсгэлэн: 1. 2023 онд Нийтийн номын сангийн сан хөмрөгийн төрөл анги болон уран зохиолын номоор шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 25 удаа зохион байгууллаа. “Үндсэн хууль тусгаар тогтнол”, “Бидний эх хэл”, “Монголын гуа хатад”, “Эх орны эзэд”, “Номтой нөхөрлөе”, “Дэлхийн шилдэг зохиолууд”, “Ханс Кристион Андерсений зохиол”, “Үндэсний бичиг соёл”, Монгол ёс заншил” “Хамгийн хамгийн” “Бидний ирээдүй гэрэлтэй сайхан”, “Монгол наадам”, “Эх хэл бидний бахархал”, “Сурагчдын заавал унших зохиол” “Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолчдын номын үзэсгэлэн” “Монгол бичиг-ёс заншил, бийрэн бичлэг” зэрэг сэдэвчилсэн 20, шинэ номын 5 удаагийн үзэсгэлэнг 1967 номоор гаргаж 16518 уншигч иргэдэд хүргэсэн.

- **2.** Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд **“Бүтээлээр мөнхөрсөн Төв аймагчууд”** сэдэвт номын үзэсгэлэнг 06.12-08.01-ний хооронд Нийтийн номын санд дэлгэн гаргаж нийт 2500-аад хүн үзэж сонирхсон байна.

- **3.** Богдхан уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ой, Төв аймгийн баяр наадамд зориулж марк сонирхогч, цуглуулагч, Монгол улсын Зөвлөх инженер, Баянцагаан сумын уугуул Өөхөнхүүгийн Ууганжаргал өөрийн цуглуулгаас бүрдсэн “АДУУНЫ ӨВ СОЁЛ” марк, ил захидал, дугтуйн үзэсгэлэнгийн нээлтийг 2023 оны 07 дугаар сарын 24-ны өдөр хийлээ. Адууны өв соёлоор дагнасан уг үзэсгэлэнг Нийтийн номын сангийн “Хүүхдийн уншлагын танхим”-д баяр наадмын өдрүүдээр буюу 07 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл дэлгэн гаргаж нийт 1500-аад марк сонирхогч хүмүүс үзэж сонирхсон.

- **4.** Богдхан уулын аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ой, Төв аймгийн баяр наадмыг тохиолдуулан Төв аймгаас төрөн гарсан зохиолчид, эрдэмтэн судлаачдын хамтын бүтээл “Төв аймгийн түүх” гурван боть номын нээлтийг Их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн Нийтийн номын санд зохион байгуусан .
Номын Ерөнхий редактороор Академич С.Чулуун ажилласан бол Тэргүүн ботийн зохиогчоор аймгийн Эрдэмтдийн зөвлөлийн гишүүд, II дугаар боть болох “Хөгжлийн түүчээ Төв аймаг” номын зохиогчоор Нацагдоржийн нэрэмжит шагналт, МЗЭ-ийн нэрэмжит шагналт, зохиолч, яруу найрагч, Соёлын гавьяат зүтгэлтэн Ш.Цэрэндоо, III дугаар боть болох “Зууныг бүтээсэн Төв аймгийнхан” номын зохиогчоор Болор цомын эзэн, яруу найрагч Ц.Эрдэнэбаатар нар ажилласан байна. Уг номын нээлтийн үйл ажиллагаанд нийт 80-аад хүн оролцсон.

- **5.** Богдхан уулын аймаг байгуулагдсаны түүхт 100 жил, Төв аймгийн баяр наадмыг тохиолдуулан Төв аймагчууд бидний омогшил, ондоошил, аугаа их соёл болсон эрийн гурван наадмын зуун жилийн түүхийг өгүүлэх “Зуунаар өртөөлсөн уухай”, “Төв түмний эрийн гурван наадам, спортын алдартнууд”, “Богд Дүнжингаравын бөхчүүд” номууд нээлтээ хийлээ. Уг бүтээлүүдэд Төв сайхан нутгаас төрсөн эрдэмт уяачид, удамт хурдан хүлгүүд, алдар цуугаа мандуулсан хүчит бөхчүүд, Үндэсний сурын харваа болон Шагайн харвааны мэргэчүүд, жороо морьд, Тив, дэлхий болон Олимпын их наадамд улсын нэрийг цуурайтуулсан Хөдөлмөрийн баатрууд, дасгалжуулагчид, их спортын амжилтаараа манлайлсан гавьяат тамирчдын талаар өгүүлсэн. Уг номнуудын нээлтийн үйл ажиллагаанд 80-аад хүн орлцсон.

“Зуунаар өртөөлсөн уухай” “Төв түмний эрийн гурван “Богд Дүнжингаравын бөхчүүд”

Номын зохиогчоор наадам” номын зохиогчоор номын зохиогчоор

Цэдэвдоржийн Энхбат **МУ-ын хөдөлмөрийн баатар, Гавъяат малчин, XX зууны Манлай уяач Д.Даваахүү** **Амгалангийн Идэрпүрэв**

3.5. Зугаатай зуны 100 хөгжилтэй уншлага: Нийтийн номын сан нь Зуунмод сумын 6 багтай хамтран "ЗУГААТАЙ ЗУНЫ ЗУУН ХӨГЖИЛТЭЙ УНШЛАГА" арга хэмжээг хүүхэд багачуудын дунд амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд “Номын уншлага” хийж Үлгэрийн ном, Оюун ухаан, Танин мэдэхүй, Адал явдалт номуудыг уншиж, дүгнэлт хийн утга санааг хамтран ярилцлаа. Уншигч хүүхдүүддээ зориулан Шанага долоон одны домог, Үнэг Тогоруу хоёр, Ухаантай хүү, Алтан Шувуу, Нэг төө өвгөн, Нугасны муухай дэгдээхэй, Худалч гүнж зэрэг үлгэрүүдийг дэлгэцээр үзүүлж, үлгэрээс авах сургамж, эерэг ба эсрэг дүрүүдийн тухай харилцан ярилцсан. Мөн “АХА” тэмцээн, эвлүүлдэг “PUZZLE” зэрэг тоглоомуудыг хүүхдүүдийн дунд зохион байгуулахад мэдлэг оюунаа уралдуулан баг хамт олноороо идэвхтэй оролцож байлаа. Арга хэмжээнд оролцсон насанд хүрэгчид болон хүүхдүүдэд номын сангийн уншигчийн картыг үнэгүй нээсэн. Нийт 256 уншигч хүүхэд багачуудыг хамруулаад байна.

3.6. Номын хэлэлцүүлэг: Нийтийн номын сангийн дэргэдэх “Ертөнц” номын клубыг ХЦАСургуулийн 10-12-р ангийн 11 сурагч хамрагдан байгуулсан. Нийтийн номын сангийн Гэрээр олгох танхимаас ЕБСургуулийн ахлах ангийн 11 сурагчдад (эр-3, эм-8) "Цойлогсод" номоор номын хэлэлцүүлгийг хийлээ. Хэлэлцүүлгийн гол зорилго нь:

Еврейчүүдийн амжилт, сэтгэл зүй, зуршил, хүмүүнлэгийн гайхамшигт нууцаас танин мэдэж хамтран ярилцах, санал бодлоо солилцоход оршиж байсан бол Хэлэлцүүлэгийн дүгнэлтээс хүүхдүүд "Мөрөөдөл чамайг гараанаас гарахад тусална, Харин дадал зуршил чинь л гагцхүү чамайг хаа хүрэхийг шийдэх болно." гэсэн ишлэлээс Физиологийн хувьд бид Еврей хүн байж чадахгүй ч сэтгэлгээ, сахилга бат, дадал, тууштай байх чанаруудыг эрхэмлэх нь чухал гэдгийг ойлгож авсан.

-Нийтийн номын сангийн дэргэдэх "Ертөнц" номын клубээс Номын баяр-2023 арга хэмжээнд ХЦДС-ийн 3 бүлгийн 132 сурагчдыг хамруулан Өгүүллэг сонсгож хүүхэд бүрт төрсөн сэтгэгдэлийг нь зургаар илэрхийлэн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

3.7. Зохиолч уншигчдын уулзалт: Төв аймгийн Соёл Урлагийн газар, Нийтийн номын сан хамтран 2 удаагийн -“Номын баяр-2023” арга хэмжээг тохиолдуулан “Зохиолч уншигчдын уулзалт”-ыг зохион байгууллаа. Уулзалтын зочдоор Зохиолч Бямбажавын Баярхүү, Зохиолч-Яруу найрагч, Зохиолчдын эвлэлийн гишүүн Хишигнямын Дуламсүрэн нар урилгыг хүлээн авч хүрэлцэн ирж ном эрдмийг шимтэн уншдаг номын садангууд иргэд-хүүхэд залуучуудад сургамж, тэдний сонирхлыг төрүүлсэн халуун дотно яриа өрнүүлж зохиолчид шүлэг яруу найргаасаа толилууллаа. Уулзалтанд Зэвсэгт хүчний 016-р нэгтгэл, Зуунмод Политехникийн коллеж, ХЦБС-ийн Эрдэнэцэцэг багштай 7г ангийн хамт олон, Нийтийн номын сангийн дэргэдэх “Ертөнц” номын клуб-ын хүүхдүүд нийт 67 хүүхэд, залуучууд, иргэд хамрагдсан.

-Молор-Эрдэнэ “философийн академ"-ийг үүсгэн байгуулагч философич, зохиолч, лектор С.Молор-Эрдэнийн 2 цагийн лекцэнд нийт 75 уншигч, үйлчлүүлэгчид хамрагдлаа.

-“Номын Хур-2023" чуулганд тусгай зочноор “Болор цом-39” наадмын дэд байрын шагналт, яруу найрагч Тө.Бямбасүрэн хүрэлцэн ирж Болор цомын тайзнаа уншсан шүлгүүдээ уншиж, яруу найргийн талаарх яриа өрнүүлсэн. Энэ удаагийн чуулганаар уран зохиол залуучуудын нүдээр хэрхэн харагддаг, залуучууд хэрхэн мэдэрдэг, юуг сонирхон судладаг талаар түлхүү ярилцсан. Илтгэгчид маань бүгд залуу үеийн төлөөллүүд байснаараа онцлог байсан.

3.8. Лавлагаа мэдээлэл: Лавлагаа, номзүйн үйлчилгээг танхимаар 51, цахимаар 40 нийт 91 уншигч, үйлчлүүлэгч лавлагаа мэдээлэл авсан.

3.9. Мэргэжил арга зүйн зөвлөгөө: Аймгийн нийтийн номын сан нь 2023 онд Лүн, Өндөрширээт, Баянхангай, Эрдэнэсант, сумдын соёлын төв болон ЕБС-ийн номын санч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэлээ. Сумдын номын сангийн үйл ажиллагаатай танилцан номын сангийн нэгдсэн бүртгэл, нэг бүрчилсэн бүртгэл болон өдөр тутмын бүртгэлийг хэрхэн хөтлөх, ном ангилах арга зүйн зөвлөгөөг 4 сумын 10 номын санчдад өгч, төв аймгийн түүхт 100 жилийн ойн номоор хандив өргөлөө.

ДӨРӨВ. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

4.1. “Ухаарлаас ургасан бодол” яруу найргийн уралдааныг зохион байгууллаа. Тус уралдаанд 8 сумын 8-12-р ангийн 31 сурагч хамрагдан оролцлоо.

Энэхүү уралдаан нь уран үгийн ертөнцөд өөрийн билэг оюуныг сорих, яруу найраг шимтэн сонирхож уран унших, зохион найруулах, авьяас чадварыг урамшуулах, үнэт зүйлсээ эрхэмлэн дээдлэх, шинээр төрж буй залуу авьяастнуудыг чадавхжуулах зорилготойгоор зохион байгуулагдсан бөгөөд Төв аймгийн 100 жилийн ойг тохиолдуулан Их зохиолч Д.Нацагдоржийн шүлэг яруу найргийг сурталчлан таниулах, утга зохиолын үйл ажиллагааг

олон нийтэд түгээн дэлгэрүүлж, соён гэгээгүүлэх зорилгыг агуулсан. Тэмцээнийг 3 үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд Нэгдүгээр үе шат нь чөлөөт сэдвээр өөрсдийн зохиосон яруу найргийг унших, Хоёрдугаар үе шат нь зохион байгуулагч байгууллагаас өгсөн сэдвийн дагуу шүлэг зохиох, Гуравдугаар үе шат нь Их зохиолч Д. Нацагдоржийн шүлэг яруу найргаас сонгон чээжээр уран яруу уншиж хүүхдүүд авьяас билгээ сорин оролцсон.

4.2.“Дэлхийн хүүхдийн номын өдөр”-ийг угтан Хүүхдийг уран зургаар дамжуулан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, ном унших, номын утга агуулгыг ойлгон ухаарч өөрийнхөөрөө сэтгэх, номын сангийн хөгжилд хүүхдийн оролцоог нэмэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зорилгоор “**ҮЛГЭРЭЭР ХҮМҮҮЖҮҮЛЬЕ**” гар зураг болон бүтээлийн уралдааныг ЕБС-ийн 1-6 ангийн сурагчдын дунд зохион байгуулж нийт **7** сумын **117** бүтээл ирүүлсэн бөгөөд 1-3, 4-6 гэсэн 2 насны ангиллаар шалгаруулалтаа явуулж 8 хүүхдийн бүтээл шалгарсан.

4.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигаар жил бүрийн тавдугаар сарын эхний ням гарагийг Монголын Үндэсний бичиг үсгийн баярын өдөр болгож, үндэсний хэл бичиг, ёс заншил, уламжлал, өвийг судлах, сурталчлах, уламжлан өвлүүлэх талаар олон талт арга хэмжээг зохион байгуулж үндэсний бичгээ сурах хүсэл сонирхол төрүүлэх ажил өрнүүлж ард нийтээрээ тэмдэглэж ирсэн билээ.

Д.Нацагдоржийн нэрэмжит Төв аймгийн нийтийн номын сангаас Үндэсний оюуны соёлын их өв болсон Монгол бичгээ эрхэмлэн дээдлэх, эх хэл бичгээ зөв эзэмших, хэрэглэх, түүнд суралцах, хадгалан хамгаалах, хос бичигтэн болох, хойч үедээ өвлүүлэх, өөрийн мэдлэг чадвараа сорих, сурах хүсэл эрмэлзэл төрүүлэх зорилгоор **"ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯРЫН ӨДӨР"**-ийг тохиолдуулан төрийн албан хаагчдын хаагчид болон ЕБС-ийн 8-р ангийн сурагчдын дунд “Эх хэл бидний бахархал” сэдэвт **“АЛТАН ҮСЭГ”** тэмцээн, ЕБС-ийн 7-12-р ангийн сурагчдын дунд “**УРАН БИЧВЭР**” тэмцээнийг зохион байгууллаа.



4.4. Бяцхан хүүхэд багачуудыг “Үлгэрээр хүмүүжүүлье” уриатайгаар номд дурлуулах, номтой нөхөрлөхийн үнэ цэнэ, ач холбогдлыг таниулах, хүүхдийн ном унших сонирхлыг төрүүлэх зорилгоор “Хүүхдийн уншлагын танхим”-с **“КИНО ӨДӨР”** арга хэмжээг зохион байгуулан нийт 21 удаагийн үлгэрээр **402** хүүхэд багачуудыг үлгэрийн ертөнцөөр аялуулж, кино зохиолын ялгааг таниулсан.

4.5. Монгол Улсын урт хугацааны “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын хүрээнд бүх нийтийн соёлын боловсрол, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой **“СОЁЛЫН СЭРГЭЛТ-2023”** аяны нээлт, **НОМЫН БАЯР-2023”** арга хэмжээг уламжлалт зан заншлаа хөгжүүлж, ард иргэд хүүхэд залуусын ном эрдэмд гэгээрэн нөхөрлөх хандлагыг дэмжих, иргэд уншигч, хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, зөв хүн болгон төлөвшүүлэх, үндэсний бичиг соёлыг сурталчилах зорилгоор 33,34 дэх удаагаа **“ХҮҮХЭД БҮР УНШИГЧ”** уриан дор, Төв аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтан 10*10 хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж 1000 хүүхдийн бий биелгээгээр үйл ажиллагаагаа эхлүүлж Уг арга хэмжээнд нийт 3000 гаруй иргэд, хөдөлмөрчид, хүүхэд залуус оролцсон. **“ХҮҮХЭД БҮР УНШИГЧ”** уриан дор 33 дахь номын баярын хүрээнд ЕБС-ийн сурагчдын дунд “Флаш моб, Хүүхдийн ковер, Бий биелгээ, Буратино дүрийн тоглолт, Кино өдөр, Уран бичвэр, Алтан хонх, танин мэдэхүйн АХА, Монгол ёс заншил-Монгол бахархал” гар зургийн уралдаан, Зохиолч уншигчдын уулзалт, Төрийн албан хаагчид болон иргэдийн дунд “Босоо бичиг-Бидний бахархал номын үзэсгэлэн, Алтан үсэг тэмцээнийг зохион байгуулсан.

4.6. “Соёлын бүтээлч сар" аян хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулж буй Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх,

Ардын уламжлалт тоглоом наадгай Монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулж сургах, өвлүүлэх зорилгоор **"МОНГОЛ БАХАРХАЛ"** тэмцээн нь Зуунмод сумын 6 багийн нийт 96 ахмадуудын дунд амжилттай зохион байгуулагдлаа.

4.7.“Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд, Орчин үеийн утга зохиолыг үндэслэгч Төв аймгийн уугуул Д.Нацагдоржийн мэндэлсний 117 жилийн ойг угтаж албан байгууллага, иргэд хүүхэд өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, зохиолчдын уран бүтээлийг уншигчдад сурталчлах, эх хэлний зөв хэрэглээг хэвшүүлэх, хэл яриаг хөгжүүлэх, зохиолын баатрын дүрд хувиран жүжиглэх, сайн муу ялган хүүхэд багачуудад үлгэр дуурайлал болгох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор **“ЗОХИОЛ АМИЛСАН НЬ”** дүрийн тоглолтыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг билээ.

Үйл ажиллагаанд: Албан байгууллага, иргэд. хүүхэд, өсвөр үеийнхний нийт 576 /Насанд хүрэгчид-196, /Хүүхэд-380, /Үүнээс Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэд-45/ иргэдтэйгээр арга хэмжээ эхлэн Монгол туургатан театрын уран бүтээлчид мэндчилгээ дэвшүүллээ.

4.8. "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд "Монгол өв соёлоо эрхэмлэн дээдлэе" номын болон оньсон тоглоом наадгайн үзэсгэлэн, Их зохиолч Д.Нацагдорж болон төв аймгаас төрөн гарсан ардын 5 уран зохиолчдын бүтээлийн номын үзэсгэлэнг гаргасан.

4.9. Очир эрдэнийн гэрэл контент нэвтрүүлэг: Төв аймгийн нийтийн номын сангаас Их зохиолч Д.Нацагдоржийн амьдрал уран бүтээлийг иргэд, хүүхэд, залуучуудын мэдлэг, боловсролыг ахиулах зорилгоор "Очир-Эрдэнийн гэрэл" цуврал 2 удаагийн контент нэвтрүүлгийг Төв Телевиз, Д.Нацагдоржийн болон МЗЭ-ийн шагналт зохиолч, судлаач Ш. Цэрэндоотой хамтран гаргасан.

5.0. Номын сангийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд **"Өглөөний уншлага"** арга хэмжээг зохион байгуулж "Ном уншихын ач тус" Яагаад ном унших ёстой тухай сургалт, хэлэлцүүлэгийг зохион байгууллаа.

- Сургалтын өмнө хүүхдүүдтэйгээ хамт хөгжимт хөдөлгөөнт дасгалыг хийж
- Сургалтын дараах сэтгэл ханамжийн судалгааг авлаа Мөн ангийн номын санд нь номын хандив өргөлөө.

5.1. Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэд, хүүхдүүдэд Нийтийн номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээг танилцуулах зорилгоор **"Төв Аймаг, Пара-хөнгөн"** атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн"-ны үеэр номын сангийн уншлагын танхимуудаас тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн 50 хүүхэд болон насанд хүрэгчидэд нийт 150 ш үнэгүй карт нээж 375 номоор зөөврийн үйлчилгээ үзүүлж, 58 ширхэг номын хандив өргөлөө. Мөн тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдийг байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж, иргэдэд өөрсдийн саналаар Сонсдог ном, 45ш номоор зөөврийн номын үйлчилгээ хүргэсэн.

- **"ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ТЭГШ ХҮРТЭЭМЖ"** чуулга уулзалтыг цахим, танхим хослуулан цахимаар 238 иргэн, танхимаар 76 иргэн оролцонд нийтийн номын сангийн "Хүүхдийн уншлагын танхим"-с шинэ номын танилцуулга, хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэнг дэлгэн гаргаж, Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн нийт-37 иргэдэд уншигчийн картыг үнэгүй нээж, 41 номоор зөөврийн номын үйлчилгээг хүргэсэн.

Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн нийт 126 иргэдэд, 416ш номоор зөөврийн номын үйлчилгээг хүргэлээ.

5.2. Зэвсэгт хүчний 016-р нэгтгэлтэй хамтын ажиллагаа өрнүүллээ. Тус арга хэмжээнд нийт 150 байлдагч оролцсон бөгөөд Төв аймаг байгууллагдсаны түүхт 100-н жил, Зэвсэгт хүчний 016-р нэгтгэлийн 100 жилийн ойг угтан 10*10 хөтөлбөр, Номын сангийн Боловсролын хөтөлбөрийн хүрээнд "Ном уншихын ач тус" сэдэвт сургалт мэдээлэл, "100 номын хожил" хөгжөөнт тэмцээн, "Зөөврийн номын сан" үйлчилгээг тус тус зохион байгууллаа.

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийтийн номын сан нь 24 цагийн харуул хамгаалалт, галын дохиолол, гадна ба дотор хяналтын камер, гадна талбайн гэрэлтүүлэг зэргийг хийж аюулгүй байдлыг хангасан.Мөн үүдний хаалганд соронзон долгионоор мэдрэгч дохиолол бүхий хамгаалалтын төхөөрөмж байрлуулж ном алдагдахаас сэргийлсэн.

ЗУРГАА. ГАДААД ХАРИЛЦАА

6.1.Япон улсын Тоттори мужийн номын сан болон Д. Нацагдоржийн нэрэмжит Төв аймгийн нийтийн номын сан хооронд адил тэгш байх зарчимд тулгуурлан 5 жилийн хугацаатай 20 ном солилцоо хийх үйл ажиллагааг эхлүүлж 2023 оны 01 сарын 09 нд 20 номоо Тоттори мужийн номын санд илгээж тотори мужаас 12 сард ном солилцооны 20 ном ирж уншигч, үйлчлүүлэгчдийн хүртээл болгосон.

6.2. Төв аймгийн 100 жилийн ойн баяр наадмыг тохиолдуулан Солонгос улсын Пёнтэк хотын Бэдари номын сан, Япон улсын Тоттори мужийн номын сангийн төлөөлөгчид номын сангийн үйл ажиллагаа болоод ойн баяр наадмыг тохиолдуулан гаргасан номын үзэсгэлэн, картын үзэсгэлэнтэй танилцан цаашид хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх талаар санал бодлоо солилцлоо.

Солонгос улсын Пёнтэк хотын Бэдари номын сангийн зочин төлөөлөгчид:

Япон улсын Тоттори мужийн номын сангийн зочин төлөөлөгчид:

ДОЛОО. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

7.1. Нийтийн номын сан нь 2023 оны жилийн эцсийн байдлаар Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 20,000,000 төгрөгний тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг хүлээн авч үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Соёлын яамны үр дүнд суурилсан санхүүжилт, үйл ажиллагааны хөрөнгө оруулалтаар “Монгол Уламжлалт танхим”-г 15,695,000 төгрөгөөр бий болгон ажиллаж байна.



7.2. Хүүхэд багачуудыг соён гэгээрүүлж, оюун ухаан, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, гар утас, дэлгэцийн хамааралтай болхоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Оюуны оньс” төсөл боловсруулан Дэлхийн Зөн Төв Орон Нутгийн хөгжлийн хөтөлбөрт уламжилсан. 2023 оны 11 сарын 18 нд уламжлалт оньсон тоглоом наадгай, сэтгэхүй хөгжүүлэх эвлүүлдэг, угсардаг, хөлөгт тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний 2,592,045 төгрөгийн хөрөнгө оруулалтыг авсан.

НАЙМ. СУРГАЛТ, СЕМИНАР

8.1. Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 17 удаагийн сургалтад албан хаагчдаа хамруулсан. Хамрагдсан сургалтуудыг жагсаавал: “Соёл ба хөгжил” сургалтад 8 албан хаагч, “Ахисан түвшний жендерийн дүн шинжилгээ”,“Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээ”-ний цахим сургалтад номын сангийн мэргэжлийн 7 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан. “Менежментийн чадавхыг бэхжүүлэх нь”, “Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт”, “Жендерийн мэдрэмжтэй харилцаа холбоо” цахим сургалтад 1 албан хаагч,

“Залуучуудын чуулга” уулзалтад 3 албан хаагч, Төрийн архивын тасгаас зохион байгуулсан архив албан хэрэг хөтлөлтийн 2 удаагийн сургалтад 1 албан хаагч, Авлигатай тэмцэх газраас олон нийтийн авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, үйл ажиллагаагаа танилцуулах зорилгоор “Таны эрх, таны оролцоо-авлигад үгүй гэж хэлье” сэдэвт сургалтад 1 албан хаагч, Зуунмод цэцэрлэгжүүлэлтийн газраас зохион байгуулсан “Мод ургуулах ашиг тус”, “Оффисын ногоон байгууламж” түргэвчилсэн сургалтад 2 албан хаагч, emongolia цахим систем сургалтад 2 албан хаагч, тоон гарын үсэг цахим шилжилт сургалтад 2 албан хаагч, Төрийн архивын тасаг, хэлний бодлогын зөвлөлөөс зохион байгуулсан “Цахим бичвэрийн сургалт”-д 1 албан хаагч, Онцгой байдлын газрын “Газар хөдлөлтийн аюул” сургалтад 6 албан хаагч, Цагдаагийн газрын “Гэр бүлийн харилцаа” сургалтад 7 албан хаагч, “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд “Нандин бүхнээ хамгаалъя” сургалтад 7 албан хаагч, Архив албан хэрэг хөтлөлт сургалтад 7 албан хаагч, төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 цахим сургалтад албан хаагчид 7 хоног бүр нийт 29 удаагийн танхим, 13 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 156 ажилтан албан хаагч хамрагдсан байна.

8.2. Номын санч мэргэжилтэнүүдэд орчин үеийн Нийтийн номын сангийн туршлагаас хуваалцаж, Австралийн ЭСЯ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй номын сангийн үйлчилгээ, технологийн дэвшлийг ашиглан хамтран ажиллах талаар сургалт хэлэлцүүлэг явуулах бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгын хүрээнд 2023 оны 03 сарын 24-ны өдөр 27 сумын соёлын төв, сургуулийн номын санч нарт мэргэжил арга зүйн сургалтыг зохион байгуулсан.

ЕС. ДУГУЙЛАН, НОГООН БАЙГУУЛАМЖ

9.1 Хүүхэд багачуудыг соён гэгээрүүлж, оюун ухаан сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, гар утас дэлгэцийн хамаралтай болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Оюуны оньс” дугуйланг хичээллүүлсэн. Дугуйлангийн үйл ажиллагаагаар монгол өв соёл, тоглоом наадгайг танилцуулан сэтгэхүй хөгжүүлэх оньсон тоглоом зэрэг 2 төрлөөр хичээллүүлж нийт 56 хүүхэд хамрагддаг.

9.2. Байгууллагын гадна талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн олон наст үрийг суулган, гадна тохижилтыг албан хаагч нар хийсэн. Мөн албан хаагч бүр тасалгаанд цэцэг тарьж ургасан цэцгийг гадна тохижилтод цэцгийн мандал болгон байршуулан ажилласан.

АРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨВ

2023 оны байдлаар Улсын төсвийн санхүүжилтаар 161,977.5 төгрөгийн санхүүжилт орсноос 311,014.5 төгрөгийн гүйцэтгэлтэй. Мөн Орон нутгийн санхүүжилтаар 115,012.1 төгрөг орсноос 140,829.6 төгрөгийн зардал гарч байна. Шилэн дансны ил тод байдлыг ханган хуулийн хугацаанд мэдээллийг бүрэн гүйцэт байршуулан тухайн сарын 8-ны дотор тайлагнаж байна. Нийт 163 мэдээлэл байршуулахаас 160 мэдээлэл оруулсан.

АРВАН НЭГ. МОНГОЛ БИЧГИЙН АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

Төв аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл, Төв аймгийн төрийн архивын тасаг, Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийг үндэсний монгол бичгээр хөтлөх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлнэ” гэж тусгасны дагуу 1. Байгууллагын гадна болон дотор хаяг, албан хаагчдын хувийн хэрэг, байгууллагын үйл ажиллагааны хавтсыг кирилл монгол бичгээр хослуулан хаягжуулан албан хэрэгцээнд

хэрэглэж байна. 2. Номын сангийн 8 албан хаагчид кирилл, монгол бичиг хосолсон энгэрийн тэмдэгтэй болсон. Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаад нийт 13 албан хаагчаас 8 албан хаагч хамрагдаж гарааны үнэлгээгээ тогтоолгосон. Үүнээс 70-с дээш хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдэж гэрчилгээ авах болзол хангасан нэг албан хаагч сургалтаас чөлөөлөгдсөн. “Өв соёлоо эрхэмлэж үндэсний бичгээ сурцгаая 2025” аяны хүрээнд Эх хэлний өдрийг сар бүр тогтмол зохион байгуулж хэвшсэн. Үүний хүрээнд: Монгол бичгийн бататгал хичээл, Монгол тоо тоолол хичээлүүдийг тус тус явуулсан. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилт хангах хүрээнд Засгийн газрын 2022 оны 7 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны А246 дугаар захирамжийн заалтуудыг ажил болгон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Төрийн албан хэрэг хөтлөлтийг үндэсний монгол бичгээр хөтлөх ажлыг шат дараалалтайгаар хэрэгжүүлнэ” гэж тусгасны дагуу байгууллага, иргэдтэй харилцаж байгаа албан бичгийг Mongolia bati фонтыг ашиглан хос бичгээр хөтлөн хавсаргаад байна.

АРВАН ХОЁР. БУСАД АЖИЛ:

1. Байгууллагын гадна талбайн хог хаягдлыг өдөр бүр цэвэрлэж, ажилтан, албан хаагч, уншигчдад тав тухтай, аюулгүй орчин бүрдүүлэн ажилладаг.

2. Бүх нийтийн их цэвэрлэгээг хамт олноороо хийж гүйцэтгэдэг

2. Монголын номын санчдын спортын их наадам”-д 2023 оны 10 дугаар сарын 28 – 30 ны өдөр Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан тэмцээн уралдаанд баг хамт олноороо амжилттай оролцсон

3.Шагнал урамшуулал : Нийгмийн салбарын харъяа агентлаг, байгууллагуудын оны шилдэгүүд тодруулах арга хэмжээнд Нийтийн номын сан “ Нийгмийн салбарын 2023 оны онцлох ажил”-аар “ Хүүхэд бүр уншигч ” арга хэмжээ тодорсон.

4.Байгууллагын ажилтан албан хаагчдыг хөдөлгөөниы дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Идэвхитэй хөдөлгөөн-Эрүүл мэнд” сургалт хөгжлийн цагийн төлөвлөгөөг боловсруулан үндсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж байна.



БАТЛАВ
НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
ЗАХИРАЛ Б.ЗОРИГТБААТАР

"ИДЭВХИТЭЙ ХӨДӨЛГӨӨН - ЭРҮҮЛ МЭНД" СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН ЦАГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗОРИЛГО: Байгууллага хамт олны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эв санаа-эв нэгдлийг бататгах, ажлын байран дээр өөрийгөө хөгжүүлэхэд оршино.

2023.01.19 Зуунмод

№	Хэрэгжүүлэх ажил	Чиглэл	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах байгууллага
1	Урлаг соёлын арга хэмжээ	Өглөө бүр "Номын сан" дуу эгшиглүүлэх	08.50-09.10 цагийн хооронд	Арга зүйч - Хүний нөөцийн мэргэжилтэн, Мэдээлэл технологийн ажилтан	-
2		Өдөр бүр ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх	11.00 цагт		
3	Спортын арга хэмжээ	Хөгжөөнт бүүхиа [illegible]	7 хоног бүрийн 4 дэх өдөр 17.00 - 19.00 цагийн хооронд	Арга зүйч - Хүний нөөцийн мэргэжилтэн, Харицсан багууд	ХГБЗХГ-аар
4		Гар бөмбөг тоглох			
5		Сагсан бөмбөг тоглох			
6	Мэдлэг чадвараа дээшлүүлэх, бие биенээсээ суралцах сургалтын цаг	Ёс зүйн сургалтуудыг үе шаттай зохион явуулах /ажлын байрны/	Тухай бүр	Арга зүйч - Хүний нөөцийн мэргэжилтэн, Номын санчид	-
7		Дугуй ширээний чөлөөт ярилцлага хийх	Тухай бүр		-
8		Ном зүйн бүртгэл хийх, зөвлөмж гаргах	Тухай бүр		

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН :
АРГА ЗҮЙЧ-ХҮНИЙ НӨӨЦ Б.ЛХАМНОРЖМАА

.... o O o ....

УВС АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Агуулга

1. Ерөнхий мэдээлэл
2. Сан хөмрөг каталог
3. Уншлага үйлчилгээ
4. Цахим үйлчилгээ
5. Зөөвөр, Солилцоо, Нүүдлийн номын сангийн үйлчилгээ
6. Соёл олон нийтийн ажил /СОНА/
7. “Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2023” 33, 34 дэх Номын баярын арга хэмжээнүүд
8. Байгууллагын дотоод ажил
9. Сургалт мэдээлэл
10. Төсөв санхүү

Тайлбар:

Увс аймгийн Нийтийн номын сангийн 2023 оны үйл ажиллагааны тайланг дээрх 10 бүлэгт хуваалаа.

Нэг. Ерөнхий мэдээлэл

Нийтийн номын сан нь 15 орон тоотойгоор ажиллаж байна.

Үүнд: Захиргаа аж ахуй-8
Уншлага үйлчилгээний тасаг-5
Лавлагаа-мэдээлэл аргазүйн тасаг-2

Алсын хараа: “Ард иргэд оюуны өргөн мэдлэг, мэдээлэл олж авахад уламжлалт болон мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ зөвлөн туслагч нь байна”.

Эрхэм зорилго:

“Үйлчлүүлэгчдийнхээ оюуны эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж чадахуйц хөгжлийн түвшинд хүрч, номын санг иргэдэд үйлчлэх “Нээлттэй мэдээллийн төв” болгоно”.

Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Манай номын сан нь 1936 онд байгуулагдсан бөгөөд өдгөө 87 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Одоогоор 15 ажилтантай, уншлага үйлчилгээний 5 танхимтай, 20 гаруй шинжлэх ухааны 22705 нэр төрлийн 72133 ширхэг ном хэвлэлээр иргэдэд үйлчлэхээс гадна тэдний дунд ном хэвлэл уншуулах, номонд сонирхолтой болгох, ном унших үйл ажиллагааг нь дэмжих чиглэлээр төрөл бүрийн соёл олон нийтийн ажлуудыг зохион байгуулсаар байна.

Манай байгууллагын уншигчдад мэдээлэл хүргэх, хэлбэр нь:

Үндсэн үйлчилгээ,

Вэб сайт: http://uvslibrary.blogspot.com , http://uvslibrary.weebly.com

Сошиал медиа: http://facebook.com/uvslib

Номын сангийн албан ёсны имэйл хаяг: libraryofuvs@gmail.com

Ажиллах цагийн хуваарь:

Даваа-Баасан гарагт Өглөө 8,30-20,00 цаг

Бямба, Ням гарагуудад Өглөө 10,00-17,00 цаг хүртэл ажилладаг.

Байгууллагын утасны дугаар: 70452477

Хоёр. Сан хөмрөг, каталог

Сан хөмрөгийн өнөөгийн байдал:

Орон нутгийн онцлог, уншигчдын эрэлт хэрэгцээ, шаардлагыг үндэслэн төсөв, төсөл, бэлэг хандивын журмаар фондоо бүрдүүлж байна.

Сан хөмрөгийн бүрдүүлэлт:

- 2023 онд нийт **648** нэр төрлийн **708** ш **11560530** төгрөгийн ном, хэвлэлээр фондоо баяжуулсан. Төсвийн хөрөнгөөр **205** төрлийн **207** ширхэг **4732900** төгрөгийн ном хэвлэл, мөн хандив, бэлэг хөрөнгө оруулалтаар **443** төрлийн **501** ширхэг **6827630** төгрөгийн ном, хэвлэлээр фондоо баяжууллаа.
- Номын фондод тавигдах Монгол улсын стандарт MNS5742:2007 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Фондын стандартыг сайжруулахын тулд шинээр орж ирсэн номыг ангиллын дагуу байрлуулж, дотоод зохион байгуулалт, эмх цэгц, ангилал, стандартыг сайжруулах зорилгоор ШУ-ны ангийн ялгагч тухай бүрд нь шинэчилж, уншигчдын гар дамжин гэмтсэн номоо сэлбэн засах ажлыг тогтмол хийж байна. 2023 онд номын санчид **3248** ширхэг номыг сэлбэн заслаа. Мөн фондын өрөөнд байнга нойтон цэвэрлэгээ хийж, чийгшүүлэх зорилгоор савтай ус, мэрэгч амьтадаас хамгаалах хор тавьж, хлорминтай усаар тавиур болон номоо арчиж, ариутгаж байна.



- Стандартад заагдсанаар тавиур хоорондын зай, гэрэлтүүлэг, агааржуулалт, номын багтаамж зэргийг хангаж ажилласнаас гадна фондын дулаан хэмжих багаж тавьж тогтмол бүртгэл хөтлөж байна.
- Сан хөмрөгийн номын эргэлтийг сайжруулах зорилгоор canva программ дээр видео бэлдэх, шууд Live хийх зэргээр олон нийтэд сурталчилж ажилласан.

Каталог зохион байгуулалт:

2023 онд шинээр ирсэн 708 номонд техник ажиллагаа хийж, тасаг танхимуудад хуваарилан уншлага үйлчилгээнд ашиглуулж байна.

Цахим каталогт 2023 оны жил эцсийн байдлаар 22705 төрлийн 72133 ширхэг ном материал бүртгэгдсэн байна. Нийт сан хөмрөгөө 100% цахим каталогтоо бүртгэж дуусаад байна. Мөн төрөл ангийн цаасан каталог хэвлэн каталогийн шүүгээнд байрлуулаад байна.

2022 онд УИХ-аас батлан гаргасан шинэ хуулиудад карт бичиж, каталогийн шүүгээнд ялгагч хийж, стандартын дагуу хуулийн картын сангаа баяжуулсан.

Гурав. Уншлага, үйлчилгээ

Үйл ажиллагаа

- уламжлалт цаасан номын үйлчилгээ
- цахим номын үйлчилгээ
- интернет үйлчилгээ
- гэрээр ном олгох үйлчилгээ
- нүүдлийн болон зөөврийн номын үйлчилгээ
- соёл олон нийтийн ажил
- сургалт, мэдээлэл
- тэргүүний уншигч шалгаруулах, рекорд ном шалгаруулах, сурталчлах гэх мэт ажлуудыг зохион байгуулан ажилладаг.

Уншигч: /давхардсан тоогоор/

2023 онд 3789 шинэ уншигч бүртгэж, 5166 байнгын уншигчид, 15942 ирэгсдэд 25375 ном, хэвлэл олгож үйлчиллээ.

Үүнээс: Насанд хүрэгчид нь 1017, оюутан 434, сурагч хүүхэд багачууд 3715

Насны байдлаар авч үзвэл: 18 нас хүртэлх- 3715
18-24 насныхан- 434
25-35 насныхан- 375

36-50 насныхан -356

51-ээс дээш насныхан -286 уншигч байна.

Хүйсийн байдлаар нь авч үзвэл: эрэгтэй уншигч 1897,

эмэгтэй уншигч 3242 байна.

Боловсролын түвшингээр нь: бага боловсролтой- 1206,

суурь боловсролтой- 1940,

бүрэн дунд боловсролтой-400,

тусгай дунд боловсролтой- 518,

дээд боловсролтой- 1102

2023 онд нийт 28341 ширхэг ном хэвлэл олгож үйлчилсэн. Үүнээс: Гэрээр- 18649, Зөөврөөр-1841, Танхимаар- 7851 ном олгосон.

Нийт олгосон номыг шинжлэх ухааны ангилалаар нь авч үзвэл:

- Байгалийн шинжлэх ухааны 1278 ширхэг ном хэвлэл
- Техникийн шинжлэх ухааны 417 ширхэг ном хэвлэл
- Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны 235 ширхэг ном хэвлэл
- Анагаахын шинжлэх ухааны 323 ширхэг ном хэвлэл
- Социологи, статистикийн шинжлэх ухааны 242 ширхэг ном хэвлэл
- Түүхийн шинжлэх ухааны 1120 ширхэг ном хэвлэл
- Эдийн засгийн шинжлэх ухааны 646 ширхэг ном хэвлэл
- Улс төрийн шинжлэх ухааны 137 ширхэг ном хэвлэл
- Төр эрх, хуулийн шинжлэх ухааны 301 ширхэг ном хэвлэл
- Цэргийн шинжлэх ухааны 118 ширхэг ном хэвлэл
- Соёл боловсролын шинжлэх ухааны 1039 ширхэг ном хэвлэл
- Хэл шинжлэлийн ухааны 1195 ширхэг ном хэвлэл
- Аман зохиол, утга зохиолын 2904 ширхэг ном хэвлэл
- Уран зохиолын 14675 ширхэг ном хэвлэл
- Урлагийн 182 ширхэг ном хэвлэл
- Шашины 181 ширхэг ном хэвлэл
- Гүн ухааны 1349 ширхэг ном хэвлэл
- Сэтгэл судлалын 1535 ширхэг ном хэвлэл
- Лавлах мэдээллийн 358 ширхэг ном хэвлэлээр үйлчилгээ үзүүлсэн байна.

Дөрөв. Цахим үйлчилгээ:

Номын сангийн Lib4U программын шинэчилсэн Вэб хувилбарыг үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.

- Шинээр http://uvslibrary.weebly.com блог сайтыг эхлүүлэн уншигч үйлчлүүлэгчдэд хүргээд байна.



❖ Номын сангийн http://uvslibrary.blogspot.com вэб хаягаа тогтмол шинэчилж байна. Үүнд:

- Шинээр ирсэн номыг урсдаг хэлбэрээр 5 удаа оруулж шинэчилж байна.
- Цахим ном 10 удаа
- СОНА-ын тухай 16 удаа

❖ Сан хөмрөгт хадгалагдаж байгаа 1911-1941 онд хуучин Монгол бичгээр хэвлэгдэн гарсан "Өдөр шөнө болох ба наран саран барилдахуй" номыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

❖ МУСГЗ зохиолч Б.Норовын зөвшөөрлөөр "Зүрхний чимэг", "Үлэмж үзэхүй", "Суман үг" зэрэг 5 ш номыг бүрэн эхээр нь цахим хэлбэрт оруулан http://uvslibrary.weebly.com сайтын цахим ном цэсэд байршуулаад байна.



Zotero программд 2022 оны "Увсын өнгө" сонины 62 мэдээлэл, "Өглөөний сонин"-ы 240 мэдээлэл оруулж Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим санд илгээлээ. Мөн 2023 оны сонины материал оруулж байна.

❖ "Дижитал аймаг" хөтөлбөрийн хүрээнд номын сангийн зарим үйлчилгээг цахимаар явуулж, 60 ш номыг цахим хэлбэрт оруулаа. Мөн Монголын уран зохиолын дээжээс 1 зохиолыг бүрэн эхээр нь электрон хэлбэрт оруулсан.





❖ https://erp.e-mongolia.mn/ Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем дахь Цаг бүртгэлийн модулийг бүх ажилтнууд ашиглаж байна.



❖ Номын сангийн Page хуудсанд 28 мэдээлэл оруулж, 57886 сэтгэгдэл, 30418 хандалт авсан байна.





❖ Lib4U – программын тогтмол хэвлэлийн модульд тогтмол хэвлэлээ бүртгэж байна.

❖ Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим санд http://122.201.23.46 орон нутгийн анхны хэвлэл “Тэргүүний малчин” сонины дутуу дугааруудыг Архивын тасгаас авч цахим санд нэмж орууллаа.





❖ 2023 оны эхний улирлын “Увсын өнгө”, “Өглөөний сонин”-ы материалыг Zotero програмд сонгон оруулж бааз үүсгэн ҮНС-ын тогтмол хэвлэлийн мэдээллийн сангийн баазад илгээлээ.

❖ Социал медиа http://facebook.com/uvslib цахим хуудсаар Номын санд зохиогдсон соёл олон нийтийн ажлын тухай, мөн шинэ номын мэдээ, цаг үеийн холбогдолтой, уншигчдийг соён гэгээрүүлэх мэдээллээр өдөр бүр тогтмол шинэчилэн ажиллаж байна.

1	Явуулын номын сан Гивааны талбай	23.06.28	3423	412
2	Гивааны талбайн Гэр номын сан бичлэг	23.06.28	449	
3	Гэр номын сан Гашууны гол	23.07.05	17980	3273
4	Хяргас нуурын арга хэмжээ	23.07.25	2659	347
5	Гэр номын сангийн пост	23.07.26	2689	359
6	Баруун зуслан Номын сан малчны хотонд пост	23.07.31	1510	138
7	АСМТ-ийн мэдээлэл	23.09.12	964	84
8	Соёл урлагийн ажилтны өдрийн мэндчилгээ пост	23.09.09	268	7
9	АСМТ-ийн мэдээлэл	23.9.8	596	20
10	“Номын баяр-2023” Хөшөөны хүндэтгэл	23.09.13	7516	1094

11	Явуулын номын сан Гиваaны талбай	23.06.28	3423	412
12	Гиваaны талбайн Гэр номын сан бичлэг	23.06.28	449	
	Нийт			**57886**

Тав. Зөөвөр, Солилцоо, Нүүдлийн номын сангийн үйлчилгээ:

Зөөврийн үйлчилгээгээр нийт 1841 ном хэвлэл хүргэж үйлчилсэн байна.

- ЕБ-ын 4-р сургуулийн Б.Гэрэлмаа багштай 5б ангийн 29 хүүхдэд зөөврөөр 29 ширхэг ном,
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт 45 ширхэг номоор 21 хүнд,
- Улаангом сумын 7-р багт 62 ширхэг номоор 26 хүнд,
- ХЦ-ийн 0245-р ангид 156 ширхэг номоор 98 хүнд тус тус үйлчилгээ үзүүлсэн.

- УПК-ын номын санч Я.Нансалмаатай хамтран УПК-ын байрны оюутнуудын чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлж номтой нөхөрлүүлэх, ном уншихын ач тусыг таниулах зорилгоор "Номтой богц" аяныг зохион явууллаа. Аяны хүрээнд 6 богц аялуулан нийт 120 хүүхдэд уран зохиолын болон хувь хүний хөгжлийн 116 номоор үйлчилсэн.
- УЦУОШТ-ын 38 хүнд 49 ширхэг номоор үйлчиллээ.
- ЕБ-ын 2-р сургуулийн дотуур байрны багш Д.Сэргэлэнтэй хамтран зөөврийн номын үйлчилгээ үзүүллээ. Үүнд: Байрны 72 хүүхдэд номын сангийн уншигчийн карт нээн, 125 ширхэг ном олгосон.
- ХДС-ийн багш С.Ганзоригт зөөврөөр 69 ширхэг ном өгсөн.
- Увс аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, ШШГАлба зэрэг байгууллагад зөөврөөр өгсөн номоо буцааж авах, захиалсан номыг хүргэж өгөх үйлчилгээ үзүүлсэн.
- Хяргас нуурын хөвөөнд болсон "Ойрадын өв соёл-аялал жуулчлал" эвент арга хэмжээнд 7-р сарын 20-24-ний өдрүүдэд очиж ажиллалаа. Энэхүү арга хэмжээнд: Амьдрах ухаан, Сэтгэл судлал, Гүн ухаан, Монголын уран зохиолын номоор үзэсгэлэн гаргаж, номын сангийн уншигчийн картыг 24 хүнд нээж, 32 ширхэг ном олгосон.
- ЕБ-ын 3-р сургуулийн Т.Энхбат багштай 3г анги, О.Янжиндулам багштай 3б ангид 2 удаа зөөврийн ном хүргэж үйлчиллээ. Нийт 67 ном олгосон.
- Улаангом сумын ЕБ-ын 3-р сургуулийн номын санд 24 ш ном
- Малчин сумын ЕБС-ын номын санд 2 ш ном
- Цогцолбор II-р сургуулийн номын санд 1ш ном
- Цагаанхайрхан сумын соёлын төвд 6 ш ном
- Өмнөговь сумын соёлын төвийн номын санд 20 ш ном
- Улаангом сумын ЕБ-ын 5-р сургуулийн дотуур байранд 149 ном
- Түргэн сумын соёлын төвийн номын санд 3ш ном
- Хилийн цэргийн 0245-р ангийн номын санд 60ш ном
- Улаангом сумын ЕБ-ын 4-р сургуулийн дотуур байранд 49 ном
- Наранбулаг сумын соёлын төвд 146ш ном
- Тэс сумын соёлын төвд 80ш ном
- Баруунтуруун сумын соёлын төвд 25 ш ном
- Эрдмийн эхлэл сургуулийн номын санд 102
- Улаангом коллежийн номын санд 90 ш ном олгож үйлчилсэн.
- Аймгийн Засаг даргын тамгын газарт зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүллээ. Үүнд: Хувь хүний хөгжлийн болон уран зохиолын 100 гаруй номоор үзэсгэлэн гаргасан.
- ЗДТГ, ХХҮГ, ГБХЗХГ хамтран "Бэрх биш ээлтэй" аяны хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэд"-ийн өдөрлөг зохион явууллаа. Уг арга хэмжээнд: Монголын уран зохиол, Амьдрах ухаан, Брайль номоор үзэсгэлэн гаргаж, карт нээж, ном олгож үйлчиллээ.
- ЕБ-ын 6-р сургууль дээр Зөөврийн номын үйлчилгээ үзүүлж, карт нээж ном олгож үйлчиллээ. Мөн Сан хөмрөгийн номын санч Д.Уранчимэг "Гар утасны зохистой хэрэглээ,

зөв зохистой ашиглах нь” сэдвээр яриа хийлгэлээ. Хүүхдийн уран зохиол, Шилдэг, Шинэ ном сэдвийн дор номын үзэсгэлэн гаргаж ажиллалаа.

- 2023 оны 07-р сарын 01-нд Улаангомын сумын баяр наадмаар номын санч Т.Дээшин, Д.Уранчимэг, Ч.Жаргал нар наадмын талбайд номын сангийн үйлчилгээ үзүүлж, ардын тоглоомоор үзэсгэлэн гаргалаа.

  Үүнд:
  -Монголын уран зохиол
  - Орон нутгийн ном
  - Амьдрах ухааны ном
  - Хүүхдийн уран зохиолын нийт 349 номоор үзэсгэлэн дэлгэж,
  - Уламжлалт болон орчин үеийн тоглоом наадгайн булан гаргаж уншигчийн карт нээж, ном олгож үйлчиллээ.

- Гашууны голд "Нүүдлийн номын сан" ажиллууллаа.

  Увс аймгийн Нийтийн номын сангаас иргэдийн зуны амралтыг үр өгөөжтэй өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх зорилгоор Гашууны голын зусланд зуны турш Гэр номын сан ажиллуулж, “Танд ойр номын сан - Зуны зугаатай уншлага" аяныг 2 дахь жилдээ хэрэгжүүлж ажилласан. Үүнд: монголын уран зохиол, гадаадын уран зохиол, хүүдийн уран зохиол, амьдрах ухааны номоор үзэсгэлэн гаргаж уламжлалт болон орчин үеийн тоглоом наадгайгаар хүүхдүүдээ тоглуулж, насанд нь тохирсон номыг уншиж өгөх орчин бүрдүүлсэн. Үндсэндээ 2023 оны 7-р сарын 3-аас 8-р сарын 4-ний хооронд 1 сар гаруйн хугацаанд өглөө 10 цагаас оройны 20 цаг хүртэл Гэр номын сан тасралтгүй ажилласан. Баяр наадмын өдрүүдээр хүртэл тасралтгүй ажилласан нь ард иргэдийн талархлыг хүлээсэн ажил болсон. Энэ үеэр Гашууны голын зусланд зуссан 500 гаруй айл өрхийн хүүхэд багачууд, насанд хүрэгчид өдөр бүр номтой нөхөрлөж, зуныг зугаатай өнгөрүүлсэн. Мөн аймгийн төвийн

оршин суугчид Гашууны голын гэр номын санд хүүхдүүдээ аваачиж ном уншуулж байлаа. Гэр номын сан маань өдөр өнжүүлэх шиг ажиллаж, өдөр бүр хүүхдээр дүүрэн байсан. Зуслангийн гэр номын сангийн зориулалтаар ашиглах гэр олдохгүй байсан тул Нийтийн номын сангийн захирал Б.Батхүү өөрийнхөө аавын гэрийг сар гаруйн турш ямар ч үнэ хөлсгүйгээр авч ашигласан. Тус гэрийг мөн Хяргас нуурын хөвөөнд болсон арга хэмжээнд аваачиж барьж, Гэр номын сангийн зориулалтаар ашигласан. Цаашдаа манай байгууллага нүүдлийн, зөөврийн зориулалтаар ашиглах гэр номын сантай болох зайлшгүй шаардлагатай байна.

❖ Гиваан баатрын талбайд Гэр номын сан ажиллууллаа.
- Иргэд, хүүхэд багачуудын зуны амралтыг үр өгөөжтэй өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх зорилгоор 2023 оны 07 сарын 25-31-ний хооронд Гиваан баатрын талбай дээр Гэр номын сан ажиллууллаа. Энэ үеэр 21 хүнд карт нээж, 60 ш ном олгосон. Нийт 180 гаруй номоор үзэсгэлэн гаргасан. Үүнд:
- Хүүхдиийн номын үзэсгэлэн
- Монголын уран зохиол
- Гадаадын уран зохиол
- Уламжлалт болон сэтгэхүй хөгжүүлэх тоглоом гэсэн сэдвээр уншигчдад хүрч үйлчиллээ. Мөн Чанга уншлага 3 удаа хийсэн.
-

- ❖ Улаангом сумын Хархираа 2-р багийн нутаг “Баруун зуслан”-д нүүдлийн номын сангийн үйлчилгээ үзүүллээ.

Улаангом сумын Хархираа 2-р баг болон Хөндлөн 8-р багийн ард иргэдэд 2023 оны 7-р сарын 31-ээс 8-р сарын 4-ний өдрүүдэд Нүүдлийн номын сангийн үйлчилгээг үзүүлж карт нээж ном олгох үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Нийт 300 гаруй номтой явсан. Үүнд:

- Хүүхдиийн номын үзэсгэлэн
- Монголын уран зохиол
- Гадаадын уран зохиол
- Уламжлалт болон сэтгэхүй хөгжүүлэх тоглоом гэсэн сэдвээр уншигчдад хүрч үйлчиллээ.

Нийтдээ 50 уншигчид карт нээж 230 ш ном олгож ажиллалаа. Байгууллагаас 45 л бензин өгсөн дээр нэмж Харуул Н.Алтансүх 10 л бензин, Номын санч Ч.Жаргал 10л бензин хийж, малчин айл өрхүүдээр орж номын сангийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Гэр гэрт нь номоо хүргэж үйлчилсэн. Харуул Н.Алтансүх айлуудаар явж номоо цуглуулахдаа хүний мотоцикль гуйсан. Гэр номын сандаа суугаад уншигч хүлээн гэсэн зүйл байхгүй тул явж үйлчилсэн. Нүүдлийн номын сангийн үйлчилгээнд иргэд ам сайтай, дуртай хүлээж авсан. Нүүдлийн номын сангийн үйлчилгээ үзүүлж ажиллахдаа номын сонголт сайтай, баяжилт ихтэй явахыг хичээсэн. Энэ жил Гэр номын сан зуны турш ажилласан болохоор номнууд элэгдэлд их орсон. Бас уншигчдын асуусан ном номын санд хувь цөөтэй байдаг болохоор хүртээмж муутай байлаа. Сүүлийн үед хэвлэгдэж байгаа номнуудыг сураглаж байсан.



❖ 2023 оны 7-р сарын 20-24-ний өдрүүдэд Хяргас нуурын хөвөөнд болсон “Ойрадын өв соёл-аялал жуулчлал” эвент арга хэмжээнд оролцож, Шинэ болон сэдэвчилсэн 5 төрлийн 1000 гаруй номоор үзэсгэлэн гаргасан.
  - Уламжлалт болон орчин үеийн тоглоом наадгай
  - Хуучин номын худалдаа явуулж номын сангийн уншигчийн карт нээж, ном олгож, амарч буй иргэддээ үйлчиллээ. Энэ үеэр амрагч иргэдийг бааз дээр барьсан гэртээ хүлээгээд суусангүй, нуурын эргээр явж үйлчилгээ үзүүлсэн.

Зургаа. Соёл олон нийтийн ажил:

❖ Хяргас нуур дээр зохион байгуулагдсан “Мөсний баяр-2023” арга хэмжээнд номын үзэсгэлэн гаргаж, үндэсний тоглоом наадгайг сурталчилсан зурагт үзүүлэн гаргаж оролцлоо.

- Ойрадын Равжамба Зая бандида Намхайжамц “Тод үсэг” зохиосны 375 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “БАРУУН МОНГОЛЫН БИЧИГ, НОМЫН ӨВ СОЁЛ” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг аймгийн ЗДТГ, “Тод номын гэрэл төв” ТББ-тай хамтран зохион байгуулсан. Энэ үеэр Тод бичгийн дурсгалд зориулсан хөшөөг Нийтийн номын сангийн гадна талбайд сүндэрлүүлж, хөшөөний нээлтийг өргөн цар хүрээтэй хийсэн.



“БАРУУН МОНГОЛЫН БИЧИГ, НОМЫН ӨВ СОЁЛ” эрдэм шинжилгээний хуралд МУБИС-ийн түүхийн тэнхимийн багш, дэд профессор Надмидын Сүхбаатар, МУБИС-ийн доктор, профессор, Ардын багш Ц.Өнөрбаян, Академич Ш.Болд тэргүүтэй эрдэмтэдээс гадна ОХУ-ын Халимаг, Тува улсын, БНХАУ-ын Шиньжаан, ӨМӨЗО-ны эрдэмтэн докторууд хүрэлцэн ирж илтгэл тавилаа. Энэхүү үйл ажиллагаа нь 2023 оны 8-р сарын 19-ны өдөр аймгийн ЗДТГ-т болсон юм.
Уг хурлаар дараах илтгэлүүд хэлэлцэгдлээ.

1. "Гаадан багштан Тува улсад морилсон нь" Тод номын гэрэл төвийн гүйцэтгэх захирал На.Сүхбаатар

2. “Ойрадын Зая бандида Намхайжамц дүрслэлийн толинд гэрэлтсэн нь” магтууг МУСТА У.Пүрэвсүрэн

3. "Тод үсэг ба Ойрадын шашин” На.Сүхбаатар /МУБИС-ийн дэд профессор, түүхийн ухааны доктор Тод номын гэрэл төвийн гүйцэтгэх захирал/
4. "Тод үсгээр уламжилсан анагаах ухааны ном бүтээл, дурсгалууд" Ш.Болд /АШУҮИС-ийн профессор, Анагаахын шинжлэх ухааны доктор/Sc/, академич, Монголын Анагаах ухааны академийн ерөнхийлөгч/

5. “Ойрадын бичиг соёлд мэдлэг оюунаа зориулсан эрдэмтэн Ю.Цэндээ” илтгэлийг Ц.Өнөрбаян /МУБИС-ийн профессор, хэл бичгийн шинжлэх ухааны доктор Sc, Монгол Улсын Ардын багш/

6. “Увс аймагт Тод үсгийн дурсгалыг хадгалах хамгаалах, Тод үсгийг өвлөн уламжлуулж ирсэн нь 1990-2000-аад он” Д.Нямбилэг Увс аймгийн Нийтийн номын сангийн ажилтан

7. “Монгол улсад зохион байгуулагдсан Тод үсэг судлалын хурлууд” Н.Наранжаргал Тод номын гэрэл төвийн ЭША, Түүхийн ухааны доктор

8. “Зая Бандида Намхайжамцын орчуулгын бүтээлүүдийг крилл бичигт буулгасан туршлага, Найман мянгат Алтангэрэл судрын жишээн дээр” Г.Ядамжав /Тод номын гэрэл төвийн шашны асуудал хариуцсан захирал, магистр/

9. “Хотон угсаатны нэрний талаарх үзэл бодол” Хачинхүү /БНХАУ-ын Шаньси багшийн их сургуулийн Хятадын баруун хилийн судалгааны хүрээлэн докторант/

10. “ОХУ-ын Бүгд найрамдах Халимаг улсын Үндэсний архив дахь зүүн гар хаант улстай холбогдолтой Тод үсгээр бичсэн баримтууд” Арван Карманов /Хальмаг улсын Үндэсний их сургуулийн Хальмаг хэл бичиг болон Дорно дахины их сургуулийн магистр/



11. “Увс аймгийн музейн сан хөмрөгт буй Тод үсгийн дурсгалууд бүрдэл, нэр, тоо үнэ цэнэ” Б.Цэнд-Аюуш /Увс аймгийн музейн сан хөмрөгч/

Эрдэм шинжилгээний хурлаар 19 илтгэл хэлэлцэгдсэн. Эдгээр илтгэлүүд нь “Тод номын гэрэл” төвөөс эрхлэн гаргадаг цуврал боть номын үргэлжлэл болж хэвлэгдэн, уншигчдын гар дээр хүрээд байна.

Эдэм шинжилгээний хуралд илтгэгчдээс гадна 100 гаруй хүн оролцож, сонирхолтой илтгэлүүдийг сонслоо.

Ойрадын Равжамба Зая бандида Намхайжамц “Тод үсэг” зохиосны 375 жилийн ойд зориулсан хөшөөний нээлт мөн энэ өдөр Нийтийн номын сангийн гадна талбайд болсон.

Нээлтийн үйл ажиллагааны үеэр Ойрадын Зая Бандида Намхайжамцын хөрөг зургийг Нийтийн номын сангийн гол танхимд залсан. Энэхүү үйл ажиллагаанд Монголын бурхан шашны төв Гандантэгчинлин хийдийн хамба, Хамба номун хан, Гавж Д.Чойжамц бараа бологчдын хамт морилон саатсан. Энэ үеэр "Тод номын гэрэл" төвийн тэргүүн, түүхийн ухааны доктор На.Сүхбаатар Ойрадын түүхийг агуулсан 120 боть цуврал номыг тус номын санд бэлэглэлээ.

Аймгуудын номын сангуудаас анхдагч болж, олон улсын хэмжээний томоохон эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан нь үнэхээр үр дүнтэй ажил болсон. Энэ хурлаар ойрад судлал, тэр дундаа баруун монголын бичиг номын өв соёлын талаар нэн чухал илтгэлүүдийг авч хэлэлцсэн нь энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлыг нэг шатаар ахиулсан гэж үзэж болно.

- “Увс аймгийн Нийтийн номын сан нь Зая бандида Намхайжамцын нэрэмжит болсноор Тод бичгээр бичигдсэн ном судрыг цуглуулан Ойрад судлалын өв сан үүсгэхээс гадна ирээдүй хойчдоо унших судлах орчин бий болгох зорилт тавин ажиллах хэрэгтэй” хэмээн доктор На.Сүхбаатар энэ үеэр онцлон хэлсэн юм.

Эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд зориулж аймгийн ЗДТГ-аас 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Цаашдаа жил бүр эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах шаардлагатай байна.

“Зохиолч уншигчдын уулзалт”-ыг зохион явууллаа. Уг арга хэмжээнд: МЗЭ-ийн Увс салбар "Огторгуйн далай" УЗН-ийн тэргүүн Г.Оюун-Эрдэнэ, МУСТ-Зохиолч яруу найрагч Г.Пүрэвдорж, МУСТ-Зохиолч яруу найрагч Б.Жаргалсайхан, Залуу яруу найрагч Ү.Анх-Тамжид, Ардын авъяастан Л.Дүгэрсүрэн нар халуун яриа өрнүүлэхийн зэрэгцээ уран бүтээлээсээ уншиж сонирхууллаа.

- Д.Мягмар “Тээрэмчин” тууж, Д. Батбаяр” Цахилж яваа гөрөөс” тууж, Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжиг, Д.Намдаг “Хөгшин чоно ульсан нь” өгүүллэг гэсэн уншигчдын эрэлт хэрэгцээтэй материалуудаар viplat програм ашиглан 4 ширхэг гарын авлага хийж уншигчдад үйлчиллээ.

- “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд болон Монгол бахархалын өдрийг угтаж Зая бандида Намхайжамцын нэрэмжит Нийтийн номын сан ажилчдынхаа дунд "Дээлтэй монгол" өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж, ажилчдаа шагнаж урамшууллаа.

  Үүнд: Хөгжөөнт АХА тэмцээн
  Төрийн дуулалаа монгол бичгээр бичиж үзэсгэлэн гаргах
  Гоё дээлтэй эрэгтэй, эмэгтэй шалгаруулах гэх мэт.

- Ажилчдынхаа дунд “Миний уншсан ном” ном унших сарын аян зарлаж, 2023 оны 10-р сарын 30-ны өдрөөс эхлэн 7 хоног бүрийн 1, 3, 5 өдрүүдэд өглөө 09 цагаас "Номтой өглөө" өглөөний ярилцлага явуулж, шилдэгүүдийг шалгаруулан шагналаа.

- Соёлын бүтээлч сар аяны хүрээнд болон Монгол бахархалын өдрийг угтаж Зая бандида Намхайжамцын нэрэмжит Нийтийн номын сан ажилчдынхаа дунд "Дээлтэй монгол" өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж , ажилчдаа шагнаж урамшууллаа.
  Үүнд: Хөгжөөнт АХА тэмцээн
  Төрийн дуулалаа монгол бичгээр бичиж үзэсгэлэн гаргах
  Гоё дээлтэй эрэгтэй, эмэгтэй шалгаруулах гэх мэт

- Нийтийн номын сангийн дэргэдэх Америкийн соёл мэдээллийн төв нь 2023 оны 11-р сарын 3-ны өдрөөс эхлэн албан ёсны Америкийн соёл мэдээллийн төв боллоо. Ингэснээр дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 600 гаруй Америкийн соёл мэдээллийн төвийн нэг болж, Америкийн Засгийн газраас жил бүр тодорхой хэмжээний санхүүжилт авч, үйл ажиллагаагаа явуулах эрх нь нээгдсэн. Албан ёсны төв болсонтой холбогдуулан 4 хүний бүрэлдэхүүнтэй баг Америкийн элчин сайдын яамнаас ирж, 7 хоног ажиллаад буцлаа. Албан ёсны төвийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах, өрөөний өнгө дизайн шинэчлэх, тоног төхөөрөмж шинэчлэх, шинэ хөтөлбөрт ажиллах заавар зөвлөгөө өгсөн.

  Америкийн соёл мэдээллийн төвийн хоёр өрөөг бусад төвүүдийн жишгээр засаж тохижуулан, орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор бүрэн хангаад байна.

❖ НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас жил бүрийн 12 дугаар сарын 03-ны өдрийг "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдөр" болгон зарласан. Энэхүү өдрийг угтан Увс аймгийн ЗДТГ, ХХҮГ, ГБХЗХГ хамтран “Бэрх биш ээлтэй” аяны хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд”-ийн өдөрлөг зохион явууллаа. Уг арга хэмжээнд: Монголын уран зохиол, Амьдрах ухаан, Брайль номоор үзэсгэлэн гаргаж, карт нээж, ном олгож үйлчиллээ.

❖ Зая Бандида Намхайжамцын нэрэмжит Увс аймгийн Нийтийн номын сангаас “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд ЕБ-ын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд "Эх түүх-Бидний бахархал"сэдэвт тунгаамал тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээнд ЕБС-ийн

"Хязгааргүй" баг
"Эх оронч" баг
"Алгинч" баг
"Хүлэгү" баг
"Гэрэгэ" баг
" Алтан Гэрэгэ" баг
"Нууц товчоо" баг
"Их Эе" багууд оюун ухаан, мэдлэгээ сорин оролцлоо. Үүнд:
1-р байр: 1-р сургуулийн “Хязгааргүй” баг Өргөмжлөл, 100,000₮
2-р байр: 2-р сургуулийн “Алтан Гэрэгэ” баг Өргөмжлөл 80,000₮
4- р байр: 2-р сургуулийн “Их Эе” баг Өргөмжлөл 50,000₮-өөр тус бүр шагнууллаа.



❖ ***Америкийн соёл мэдээллийн төвөөс зохион байгуулсан СОНА***

1. Game day буюу тоглоомын өдөр 7 хоног бүрийн 1 дэх өдөр бүр явагдаж байна.
2. “American English for high school juniors and seniors” нэртэй төсөл хэрэгжиж байна. Төслийн үргэлжлэх хугацаа 2023 оны 9-р сарын 1-ээс 2024 оны 6 сар хүртэл үргэлжилнэ. Тус төслийн сургалтад нийт 25 сурагч идэвхтэй хамрагдаж байна.
3. Movie night кино үдэш 7 хоног бүрийн Баасан гаригт уншигчдад кино үзүүлдэг. Кинонд дурлагсад маань өдөр алгасахгүй ирж үзэж киноныхаа тухай ярилцан тухлан суудаг.
4. Intermediate English for high schools буюу ахлах ангийнханд зориулсан англи хэлний сургалт явагдаж байна.
5. Америкийн ЭСЯ-ны page хуудсаар явагддаг Төгсөгчдийн яриа цуврал болон бусад live цувралуудыг American Corner Uvs page хуудсаараа дамжуулан хуваалцаж олон нийтэд хүргэж байна.
6. “Увс аймгийн залуучуудын хөгжлийн зөвлөл” 7хоног бүр хуралддаг. Хуралдаанаар залуус цаашид хийх ажил болон өөрсдийгөө хөгжүүлэх хөгжилтэй тоглоом, сургалт уулзалт зохион байгуулж ярилцдаг.
7. Увс +300 клубын илтгэл, мэтгэлцээний 2-р шатны сургалтын хаалтын ажиллагаа манай төвд ажилттай зохион байгуулагдаж сургалтад хамрагдсан хүүхдүүд үндсэн гишүүнчлэлийн батламжаа гардан авлаа.
8. Цагдаагийн хэлтсийн төлөөлөгч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, 2022 оны цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны тайланг номын сангийн ажилтнуудад танилцууллаа.
9. Б.Ариунжаргал багштай хамтран эсгий урлалын сургалт зохион байгууллаа. Сургалтад 15 хүн хамрагдаж боловсруулсан эсгийгээр түлхүүрийн оосор хийж, цаашид өөрийн сурсан

   мэдсэнээ ашиглах гэр ахуйдаа олон зүйлийг хийх талаар ярилцаад сэтгэл ханамжтай буцлаа.
10. “Увс аймгийн хүүхдийн зөвлөл” шинэ гишүүдтэйгээ танилцаж уулзалт зохион байгуулж, цаашид хийх ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны дүрэм, журам, мөрдөх зүйлс, хаана хувиарлагдан ажиллах гээд ажлын төлөвлөгөөгөө гарган сургалт хийлээ.
11. Хонины ноос эсгийрүүлж гэрийн шаахай хийх сургалт Алтанчимэг багштай хамтран зохион явуулсан. Сураглтанд 10хүн бүртгүүлж 3хүн хамрагдаж гэрийн шаахайтай болсон.
12. Хувьцаа ба Хөрөнгө оруулалт сургалт маань тун амжилттай болж өнгөрлөө. Сургалтад хамрагдсан хүмүүс сэтгэл хангалуун байлаа. Бидэнд мэдлэгээ харамгүй хуваалцсан Б.Мөнхдорж багш маань өөрийн бодит туршлагаас хуваалцаж, хэрхэн яаж ашиг олж, шатаж байснаа хуваалцсан. Гурван жилийн хугацаанд увуулж цувуулсаар 7 сая төгрөгөөр авсан хувьцаагаа 19 сая төгрөг болгож гурав нугалсан түүхээ ч хуваалцлаа. Сургалтанд маань 15 хүн бүртгүүлсэнээс 3 хүн хамрагдсан.
13. Америкийн төвүүдийн захирал Д.Болормаа даргатай баг хамт олон ирж хөтөлбөрүүдэд зөвлөгөө өгч, танхимын үйл ажиллагаа болон шинэ анги тохижиж буй үйл явцтай танилцлаа.
14. “Увсын цэнхэр хязгаар” цас мөсний баярт байгууллагаараа ардын тоглоом наадгай сэдвээр ном болон тоглоом наадгайгааар гэр тохижуулж, монгол бичгийн бүртээлүүдээр үзэсгэлэн гаргаж тус арга хэмжээнд оролцлоо.
15. “Хаан банк”-ны удирдлагууд ирж хамтарч ажиллах болон, цаашдын ажил бидэнд тавьж болох шинэ санлуудаа танилцуулж хамтран ажиллах санал тавьсан.

16. Долоо хоногт 1 удаа монгол бичгийн хичээл орж байна. Баруун бүс хүүхэд хөгжлийн төвөөс сургагч багш н.Жавзмаа ирж 1 сарын турш сургалт явуулсан. Үүнд анхан шатны 7 хүн дунд шатны 7 хүн хамрагдаж анхан шатны хүмүүс үсгээ нүдэлж холбож уншиж сурсан бол дунд шатны хүмүүс үгийг хэрхэн зөв бичих болон нөхцөлүүдээ хэрхэн зөв холбон бичиж сурсан. Төв номын сан монгол бичгийн грүппэд монгол бичгийн холбогдолтой мэдээ, мэдээллийн байршуулан ажиллаж байна.
17. Улаангом сумын 1-р цэцэрлэгийн Б.Амгалан багштай дунд бүлэгт “Заан огтоно хоёр” үлгэрээр чанга уншлага хийсэн.
18. Улаангом сумын 7-р цэрлэгийн С.Онон багштай ахлах бүлэгт “Долоон бор огтоно” үлгэрийн үзэж сонирхуулсан.
19. Spelling bee буюу англи дээр үг үсэглэх тэмцээн зохион явуулсан. Тус тэмцээнд 15 хүүхэд бүртгүүлсэнээс 9 хүүхэд оролцож

    1-р байранд 1-р цогцолбор сургуулийн 12а ангийн сурагч Б.Сэргэлэн,
    2-р байранд 1-р цогцолбор сургуулийн 12а ангийн сурагч А.Номин-Эрдэнэ,
    3-р байранд 1-р цогцолбор сургуулийн 12а ангийн сурагч Л.Анхням нар шалгарсан. Тус хүүхдүүдэд мөнгөн шагнал өгсөн. Мөн захирал Б.Батхүү хувиасаа “Моби Дек” гэсэн монгол хүүхдийн орчуулгатай англи ном бэлэглэсэн.
20. 2023 оны 7-р сарын 17-28-ны хооронд Америкийн элчин сайдын яамны дэмжлэгээр сайн дурын ажилтан Wen Wendt ирж Увс аймгийн хүүхэд залуучууд болоод насанд хүрэгчдэд 14 хоногийн хугацаанд Англи хэлний үнэ төлбөргүй сургалтыг явуулсан. Цаашдаа Америкийн соёл мэдээллийн төвөө түшиглэн америкаас сайн дурын ажилтнуудыг орон нутагтаа урт хугацаагаар урьж, англи хэлний багшаар ажиллуулах боломжийг судлаж байна. Wen Wendt багшийн сургалтад давхардсан тоогоор 250 орчим хүүхэд, насанд хүрэгчид хамрагдсан.

21. Америкийн соёл мэдээллийн төвд 2023 оны 09 сарын 13-ны 15 цагт FLEX хөтөлбөрийн төгсөгч Б.Уранзаяа ирж хөтөлбөрийн талаар танилцуулга ярилцлага, өөрийн туршлагаас хүүхэд багачуудад хуваалцсан.

22. Student Intership Program

2023 оны 11-р сарын 7-ны өдөр SIP (Student Internship Program) хөтөлбөрийн нээлтийг Америкийн Соёл мэдээллийн төвд хийлээ. Хөтөлбөрийн нээлтэнд 50 гаруй зочид хүрэлцэн ирж, хөтөлбөрийн талаарх мэдээлэлтэй танилцлаа.

23. Sip шалгаруулалт

Student Internship Program хөтөлбөрт 10-12-р ангийн 18 сурагчаас өргөдөл хүлээн авч, 3 шатны шалгаруулалтаас 7 хүүхэд сонгон шалгарсан. Эдгээр хүүхдүүдтэй 6 сарын хугацаанд гэрээ хийж, дадлагажигчаар ажиллуулахаар болсон.Мөн 12 сардаа 2-3 хөтөлбөр зохиож ажиллахаар төлөвлөөд байна.

Мэдээлэл, лавлагаа, ном зүй, арга зүйн ажлын хүрээнд:

❖ Лавлагаа, Татгалзал:

Лавлагаа ном зүйн үйлчилгээ:
Үүнээс:
Цахимаар өгсөн лавлагаа-12
Сэдэвчилсэн лавлагаа-212
Ном зүйн лавлагаа-5
Тодотгосон лавлагаа-7
Статистик тоо баримт-28
Номын татгалзал-63 өгч ажилласан байна.





- “Соёлын сэргэлт-2023” аяны багт дөрвөн номын санч маань орж, Увс аймгийн 18 суманд 9-р сарын 15-20 өдрүүдэд ажиллалаа.

  Энэ үеэр номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаа, номын санд хөтлөгдөх бүртгэл, номын сангийн программын ашиглалтын байдалтай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, шинэ номын үзэсгэлэн гаргаж, боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэн ажилласан.

Мөн Сумдын соёлын төвийн болон сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай нэг бүрчлэн танилцаж, зөвлөмж зөвлөгөө өгөх ажлыг хийж, цаашид хийх ажлын талаар тайлбар зөвлөмж өгч үүрэг болгож ажилласан. Анхан шатны данс бүртгэл хөтлөлт, программ ашиглалт, тооллого тооцоо зөрөөтэй, орчны болон үйл ажиллагааны стандарт хэрэгжүүлэх тал дээр дутагдалтай байдал зарим номын сан дээр байгаа нь номын санчид санаачилгагүй ажиллах, сургуулийн бичиг хэргийн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь ажлаа цалгардуулах бас нэг шалтгаан болж байна. Энэ бүхнийг цаашид засаж залруулах анхаарч ажиллах шаардлагатай байна. Цаашид сургуулийн номын санчийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай байна.



“Тэргүүний уншигч Д.Нацагдорж”-тэмдэгээр Өмнөговь сумын ЕБС-ийн 8 А ангийн сурагч Б.Түвшин, Малчин сумын малчин Ц.Сайнбилэг нар шалгарч шагналаа гардан авлаа.

- Сумдын Monbiblio програмыг эвдрэл гэмтэл гарсан үед нь шуурхай засаж хэвийн байдалд оруулан аргазүйн мэдээлэл өгч ажиллаж байна. Үүнд:
    - Өлгийн сумын Соёлын төвийн номын сангийн,
    - Баруунтуруун сумын Соёлын төвийн номын сангийн Monbiblio програмуудыг засаж хэвийн байдалд оруууллаа.
    - Хяргас сумын Соёлын төвиийн Номын сан үүлэн технологид суурилсан програм ашиглах болсонтой холбоотойгоор уг програм дээр нь тохируулга хийж ашиглалтанд бэлэн болголоо.

Сум, сургуулийн програмыг нийтдээ 16 удаа засаж, шинээр суулгасан байна.

- “Эрдмийн эхлэл” ахлах сургууль дээр номын сангийн үндсэн үйл ажиллагаа сайжруулах талаар номын санч 5 хүнтэй баг бүрдүүлэн ажиллаж, бүх номонд техник ажиллагаа хийж ангилах, тамгалах, нэг бүрчилсэн бүртгэлд тусгах, Monbiblio программ суулгах номыг электрон катологт оруулах гэх мэт нарийн мэргэжлийн ажлыг хийж гүйцэтгэн тухайн номын сангийн үйл ажиллагааг чанаржуулж ажиллалаа.
- Аймгийн төвийн 7 сургууль, Улаангом политехник коллеж, хилийн цэргийн 0245 ангийн номын сангуудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
- "ХИЛ ХЯЗГААРГҮЙ НОМЫН САН" ТӨСЛИЙН БАГ УВС АЙМАГТ АЖИЛЛАЛАА
Австралийн Элчин Сайдын Яам, Монгол Улсын Үндэсний Номын Сан, Монголын Номын Сангийн Холбоо хамтран хэрэгжүүлж буй “Хил хязгааргүй номын сан” төслийн баг 2023 оны 06 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Увс аймагт ажиллав.
Аймгийн төв, ЕБС, сумдын номын сангийн 40 гаруй номын санчид Австралийн номын сангийн туршлага, хэрэглэгч төвтэй үйлчилгээ, номын сангийн нэгдсэн системийн талаар танхим, цахимаар чадавхжуулах сургалт зохион байгуулж, Увс аймгийн Төв номын санд хүүхдийн шилдэг бүтээлүүд хандивлалаа.

Багийн бүрэлдэхүүнд Австралийн ЭСЯ-ны Хөтөлбөр хариуцсан ахлах менежер Х.Өрнөх, МНСХ-ны Гүйцэтгэх захирал М.Даваасүрэн, ЭМШУ-ны Төв номын сангийн Захирал, МНСХ-ны УЗ-ийн гишүүн З.Баярцэнгэл нар ажиллав. Энэ үеэр аймгийн бүх номын санчдад цахим, танхим хосолсон хоёр өдрийн сургалтыг хийлээ.

Долоо. “Хүүхэд бүр уншигч” 33 дахь, “Номтой Монгол” 34 дэх Номын баярын арга хэмжээнүүд

“Хүүхэд бүр уншигч” уриатай 33 дахь номын баяр:

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158-р зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2023” арга хэмжээг улс орон даяар өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтийн уншлагыг дэмжих, номын өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр соёл олон нийтийн ажлыг олноор зохион байгууллаа.

Нийтийн номын сангаас “Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2023” арга хэмжээ 33 дахь Номын баярыг “Хүүхэд бүр уншигч” уриатайгаар 2023 оны 5 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Гиваан баатрын талбай болон өөрийн байранд зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээнд дараахь СОНАжлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Монгол бичгээр хурдан уншигч шалгаруулах уралдааныг төрийн албан хаагчдын дунд зохион явууллаа. Үүнд 16 байгууллагын 36 алба хаагч оролцсоноос багийн дүнгээр:
   1-р байр :НДХ-ийн хамт олон-200 үг
   2-р байр: Архивын газарын хамт олон-143 үг
   3-р байр: Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн хамт-138 үг уншиж эхний байруудыг эзэллээ.

2. "Монгол бичгийн бүтээл"-ийн уралдааныг зохион явууллаа. Уг уралдаанд сум, сургууль, цэцэрлэгээс нийт 60 бүтээл ирснээс:

Сурагч төрөлд:

1-р байр : Тэс сумын ЕБ-ын сургуулийн 11в ангийн сурагч Ж.Оролзод
2-р байр : Наранбулаг сумын ЕБ-ын сургуулийн 11а ангийн сурагч О.Тэмүүлэн
3-р байр : ЕБ-ын 6-р сургуулийн 11а ангийн сурагч Б.Анар
Тусгай байр: ЕБ-ын 5-р сургуулийн 10а ангийн сурагч Ч.Ану-Үжин
Тусгай байр: ЕБ-ын 6-р сургуулийн 10в ангийн сурагч Х.Есүй

Насанд хүрэгчдийн төрөлд:

1-р байр: 13-р цэцэрлэгийн багш Ц.Ууганбаяр, Б.Сольхүү
2-р байр: Түргэн сум Г.Элбэгдорж нар тус тус эзэллээ.

3. "Ном уншихын ач тус" номын хэлэлцүүлэг зохион байгууллаа.
Уг арга хэмжээнд: "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж" тэмдэгтэн Хөдөлмөрийн дээд сургуулийн оюутан Б.Батням "Зуршлын хүч" номоор яриа хийж, аз жаргалд хүрэх шидэт жор гэж байдаггүй ч хийж байгаадаа бүрэн төвлөрч, туйлын сайхан мэдрэмжийг авч ирээдүйн зорилгоо тодорхойлж, номыг хэрхэн шимтэн унших, дадлын талаар харилцан ярилцлаа.

4. Англи хэл дээр “Үсэглэлийн хаад” тэмцээн зохион явууллаа.
5. 1-р Цэцэрлэгийн Б.Амгалан багштай дунд бүлгийн хүүхдүүдэд “Заан огтоно хоёр”

үлгэрээр чанга уншлага хийсэн.

6. “Сайхан бичигтэн” тэмцээн зохион явууллаа.

“Хүүхэд бүр уншигч” уриатай “Үндэсний бичиг үсэг- Номын баяр 2023” арга хэмжээний хүрээнд “Сайхан бичигтэн” тэмцээнийг ЕБС-ийн 6-9-р ангийн сурагчдын дунд зарлалаа. Тэмцээнд нийт 40-д бүтээл ирснээс:

1-р байр: Цогцолбор 1-р сургуулийн 7г ангийн сурагч Г.Эрхэмбаяр /30,0/
2-р байр: Цогцолбор 1-р сургуулийн 7д ангийн сурагч О.Дөлгөөн /20,0/
3-р байр: Цогцолбор 1-р сургуулийн 7д ангийн сурагч Э.Энхжүслэн /10,0/
Тусгай байр:
Цогцолбор 1-р сургуулийн 6ж ангийн сурагч Б.Нандин- Эрдэнэ /10,0/
Цогцолбор 1-р сургуулийн 6ж ангийн сурагч М.Мөнхзаяа /10,0/
Цогцолбор 1-р сургуулийн 6д ангийн сурагч Л.Аззаяа /10,0/
Цогцолбор 1-р сургуулийн 7д ангийн сурагч Б.Сайнзаяа /10,0/ нар шалгарлаа. Шагналыг “Номын баяр-2023” арга хэмжээн дээр гардууллаа.

7. “Алтан Хонх” тэмцээн зохион явууллаа.

“Хүүхэд бүр уншигч” уриатай “Үндэсний бичиг үсэг- Номын баяр 2023” арга хэмжээний хүрээнд Цогцолбор 1-р сургуулийн 6, 7-р ангийн сурагчдын дунд Монгол бичиг хичээлийн зөв бичих дүрмээр “Алтан Хонх” тэмцээнийг зохион явууллаа.

Тэмцээнд тус сургуулийн 6, 7-р ангийн 40-д сурагч хамрагдсанаас 7д ангийн сурагч О.Намуунбайгаль тэргүүлж 6а ангийн сурагч Д.Сувд, 6ж ангийн сурагч Ч.Отгонзаяа нар удааллаа. Тэмцээнд оролцсон бүх сурагчдадаа баярлалаа.

“Аав, Ээж, Би” тэмцээнийг зохион явууллаа.

Дэлхийн Гэр бүлийн өдрийг угтан ЕБС-ийн 3-р сургуулийн 3г ангийн эцэг, эх, сурагчдын дунд “Аав, Ээж, Би” тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээнийг:

Аавуудын дунд усны савнаас гар салгахгүй 15 удаа тойроод дараагийн ширээн дээр зогсож буй эхнэр дээрээ очиж уруулыг нь будаж өгөх

Ээжүүдийн дунд ширээн дээр байгаа 5 ш аягыг гар оролцуулахгүйгээр шаараар дараагийн ширээнд зөөж хүргэх даалгавар биелүүлэх

Хүү ээжийг ирэнгүүт Спорт өрөлтийн аяга өрж өрсөлдлөө. Нийт 8 баг оролцсоноос Б.Энхболдын гэр бүл /хүү Болдсайхан/ тэргүүлж Д.Пүрэвсайханы гэр бүл, Ё.Очирын гэр бүлүүд удааллаа. Мөн ирсэн сурагчдын дунд өртөөчилж тоглох Хөгжөөнт буухиа тэмцээнийг зохион явуулж “Их хотын баг” тэргүүлж “Гарын таван хуруу”, “Шонхор” багууд удааллаа.

“Уншаад урагшлахуй” Улаангом сумын ЕБ-ын 3-р сургуулийн 6-А анги, Цогцолбор 1-р сургуулийн 7-р ангийн сурагчдад “Ном уншихын ач тус, Номын тэмдэглэл хөтлөх” сэдвээр лекц танилцуулга хийсэн.

8. **“Үлгэрээс үлгэрлэе”** - Улаангом сумын 7-р цэцэрлэгийн дунд бүлгийн сурагчдад “Би өөрөө” номоор чанга уншлага хийлээ.

9. Т.Бямбадорж “Ардын тоглоом наадгай” номоос “Оньсого таавар”- Ойрад аялгаар нэртэй гарын авлага гаргаж сурталчиллаа.

10. **Ном хэвлэлийн хүрэлцээ, уншигчдын сэтгэл ханамжийн судалгаа**г цаас болон цахимаар авсан. Судалгаанд нийт 60 хүн оролцлоо. /Цахимаар-22, цаас-38/

11. “Нэг ном, нэг цонх” ном хандивлах аяныг нэг сарын турш зарлан явууллаа. Хугацаа 2023 оны 5 сарын 15-аас 6 сарын 15 хүртэл үргэлжилсэн.

12. **"Номын анд" аяныг** зарлаж зохион явууллаа. Уралдаанд Наранбулаг, Түргэн, Ховд, Тариалан, Зүүнхангай сумаас уншигчид зурагт хуудас, номын хавчуурга, бяцхан ном, уншсан номын тэмдэглэл зэрэг 200 гаруй хүүхдийн материал ирсэн.

Уралдаан нь:
-3-5-р анги
-6-9-р анги
-10-12-р анги гэсэн 3 төрөлд явагдсан.
6-9-р ангийн ангилалд:
1- р байр: Зүүнхангай сумын сургуулийн 6б ангийн сурагч Д.Дэлгэрмаа Өргөмжлөл, 50,000₮
2- р байр: Улаангом сумын 5-р сургуулийн 8-б ангийн сурагч Будханд Өргөмжлөл, 40,000₮
3- р байр: Тариалан сумын 1-р сургууль 9-а ангийн сурагч Б.Мөнхтуяа Өргөмжлөл, 30,000₮
Тусгай байр: Тариалан сумын 1-р сургууль 9-а ангийн сурагч Б.Мөнхзаяа Өргөмжлөл, 20,000₮

10-12-р ангийн ангилалд:
1- р байр: 5-р сургууль 10-в ангийн сурагч Б.Амин-Эрдэнэ Өргөмжлөл, 50,000₮
2- р байр: 3-р сургууль 12-б ангийн сурагч Э.Буянхишиг Өргөмжлөл, 30,000₮
3- р байр: 3-р сургууль 11-в анги сурагч Нэмэхдулам Өргөмжлөл, 20,000₮

Анги хамт олон 3-5-р ангийн ангилалд:
1-р байр: Цогцолбор 2-р сургууль А.Кулчаря багштай 4-г анги Өргөмжлөл, 50,000₮
2-р байр: 5-р сургууль Д.Мөнхцэцэг багштай 2-б анги Өргөмжлөл, 30,000₮
3-р байр: 3-р сургууль Б.Одгэрэл багштай 5-а анги Өргөмжлөл, 20,000₮
Тусгай байр: 1-р сургууль Х.Нэргүй багштай 5-д анги Өргөмжлөл, 20,000₮
Цогцолбор 1-р сургуулийн Д.Хишигдэлгэр багштай 7-д анги Өргөмжлөл, 30,000₮ тус бүр шагнаж урамшууллаа.

"Тунгаамал"танин мэдэхүйн тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээнд ЕБС-ийн 10-12-р ангийн
1-р сургууль "Шидэт үсэгнүүд" баг
1-р сургууль "Акс" баг
2-р сургууль "Хүмүүн баг"
2-р сургууль "Эх хэлний ээдэ" баг
3-р сургууль "Хүмүүн бичиг" баг
4-р сургууль " Титэм" баг
5-р сургууль "Эх хэл" баг, "Тунгаагч" баг
Эрдмийн эхлэл сургууль "Эхлэл" зэрэг 9 баг оюун ухаан, мэдлэгээ сорин оролцлоо.

Үүнд:
1. Багийн мэндчилгээ
2. Үгийн утга тайлбарлах
3. Хэлц үгийн утга тайлбарлах
4. Найруулгын алдааг олж засах
5. Монгол бичгээр хөрвүүлэн бичих зэргээр явагдлаа.

1-р байр: 1-р сургууль "Акс" баг Өргөмжлөл, 80,000₮
2-р байр: 4-р сургууль "Титэм" баг Өргөмжлөл,50,000₮

3-р байр: 3-р сургууль "Хүмүүн бичиг" баг Өргөмжлөл,30,000 төгрөгөөр тус бүр шагнаж урамшууллаа.

“Номын баяр-2023” арга хэмжээний үеэр **Бийрийн уран бичлэг**ийн уралдаан зохион байгууллаа.

1-р байр: Наранбулаг сумын ЕБС-ийн сурагч О.Тэмүүлэн
2-р байр: Наранбулаг сумын ЕБ-ийн сурагч Г.Гүндэгмаа
3-р байр: Цогцолбор 2-р сургуулийн сурагч С.Үүрийнтуяа нар шалгарлаа.

Номын үзэсгэлэнгүүд:

1. Бестселлер номын үзэсгэлэн, Шилдэг шинэ ном,

2. Номын тэмдэглэл, Номын хавчуурга зэргээр үзэсгэлэн

3. “Ховор ном” судар номын үзэсгэлэн

4. Энэ жил тэгш ойн тохиож буй /80, 90, 100/ Улсын болон Увс аймгийн харьяат зохиолчдын бүтээлээр үзэсгэлэн гаргалаа.

5. Боловсролын шинжлэх ухааны номын үзэсгэлэн

6. Шинэ номын үзэсгэлэн, Хүүхдийн уран зохиол гэсэн 2 сэдвийн хүрээнд номын үзэсгэлэн

7. Гадаадын уран зохиол болон Хэл шинжлэлийн номын үзэсгэлэ

8. Амьдрах ухаан, Монголын уран зохиол,Түүх нийгмийн шинжлэх ухаанаар сэдэвчилсэн номын үзэсгэлэн

9. “Сайхан бичигтэн” уралдаанд ирсэн бүтээлүүдийн үзэсгэлэн



10. Тэгш ой тохиож байгаа зохиолчдын намтар уран бүтээлийг бичиж, хэвлэлийн газарт өгч хэвлүүлэн суртачиллаа.

11. Монгол бичгийн бүтээлийн үзэсгэлэн гаргаж суртачиллаа.



“Номтой Монгол” уриатай 34 дэх Номын баяр:

Увс аймгийн Нийтийн номын сан нь “Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2023” 34 дэх Номын баярын арга хэмжээг “НОМТОЙ МОНГОЛ” уриатайгаар 2023 оны 9 дүгээр сарын 14-17-ний хооронд Спортын ордон болон өөрийн байранд зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээнд дараахь СОНАжлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Үзэсгэлэнгүүд зохион байгууллаа.
    - Амьдрах ухаан   / 34 ширхэг ном/
    - Хэл шинжлэлийн ухаан /35 ширхэг ном/
    - Сэтгэл судлал, Гүн ухааны шинжлэх ухаан /42 ширхэг ном/
    - Бестселлер номын үзэсгэлэн /51 ширхэг ном/
    - Эдийн засаг   /38 ширхэг ном/
    - Түүх, Нийгмийн шинжлэх ухаан /34 ширхэг ном/
    - Утга зохиол, Аман зохиол /37 ширхэг ном/
    - Мэргэжлийн номын үзэсгэлэн /28 ширхэг ном/
    - Номын хавчуурганы үзэсгэлэн
    - Номын тэмдэглэл хөтлөх үзэсгэлэн гэх мэт үзэсгэлэнг гаргалаа.

Нийт 8 төрлийн шинжлэх ухааны 299 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

ЕБ-ын 6-р сургуулийн номын санч М.Алтантуул, байрны багш Э.Энхцэцэг нартай хамтран 2023 оны 9-сарын 8-аас 10-р сарын 8 хүртэлх хугацаанд “Номын нөхөр” ном унших 1 сарын аян зарлаж, зөөврийн 149 ном хүргэж өгч үйлчиллээ.





2. 34 дэх удаагийн Номын баярын хүрээнд "Ном уншихын ач тус, номтой нөхөрлөх" сэдэвтэй Уншигчдын бага хурлыг Хүүхдийн уншлагын танхимд ирсэн 7-р ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Уншигчдын бага хуралд Цогцолбор 1-р сургуулийн Монгол хэл уран зохиолын багш Г.Нарангэрэл хүрэлцэн ирж сурагчдад илтгэл яриа хийлээ.

3. 34 дэх удаагийн "Номын баяр", Соёлын сэргэлт-2023 аяны хүрээнд Ойрадын Равжамба Зая Бандида Намхайжамц "Тод үсэг" зохиосны 375 жилийн ойн арга хэмжээний хүрээнд номын сангийн гадна талбайд сүндэрлэсэн Тод бичгийн дурсгалд зориулсан хөшөөнд хүндэтгэл үзүүлж Тод номын гэрэл төвөөс номын сангийн сан хөмрөгт ном хандивлах арга хэмжээг зохион байгууллаа.

34 дэх удаагийн Номын баярын хүрээнд Ө.Бадрахын талбайн сүүдрэвчинд “ТА АВЧ, ӨГЧ БОЛНО” уриатай чөлөөт номын санг хоёр ширхэгийг шинээр нэмж барилаа.

Найм. Байгууллагын дотоод ажил:

- Бүх нийтийн цэвэрлэгээнд оролцож ойр орчмын 50м газрын хогийг цэвэрлэж хогоо ачиж хогийн цэгт аваачиж асгав.

- Байгууллагын гадна талбайд харуул Н.Алтансүх, З.Амарсанаа нар 3 портер хайрга ачиж ирж газар тэгшлэв.

- Номын сангийн гадна талбайд босох хөшөөний талбай тэгшлэх хайрга Hovo машинаар ирснийг буулгалаа. Буулгасан хайрга тэгшлэж цемент цутгаж хөшөөний байрлуулах талбай бэлдлээ.

- Тод үсгийн дурсгалд зориулсан хөшөөг буулгаж, засаж тэгшилсэн талбайд байрлуулав. 8/19нд хөшөөний нээлтийн үйл ажиллагаа болов.

- Хөдөлмөрийн дээд сургуулийн зогсоол дээр байрлах “Та авч болно, өгч болно” уриатай Чөлөөт номын сангийн тавиурын хаяг салсан байсныг засаж, хагарсан шилийг сэлбэж, ном хэвлэлээр тогтмол цэнэглэж байна.

- АСМТ-ийн өрөөнүүдийн тохижилт

Америкийн соёл мэдээллийн төвийн хөтөлбөрийн болон сургалтын танхимд:

сандал- 36
ширээ- 22
ханын хэвлэл-6
шинэ суурин компьютер- 3
ажилтны ширээ-2 зэрэг зүйлс шинэчлэгдсэн байна.Мөн дотоод заслын ажил хийгдэж өнгө төрхөө шинэчилсэн.

- ❖ Намрын мод тарих өдрөөр Зохиолчдын хамтран Номын сангийн арын хашаанд мод тарилаа.

- ❖ Байгууллагын ажилчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хийсэн ажлын тайлан хамгаалалт, тайлангийн хурал хийж 2023 оны “Байгууллагын аварга”, “Дэд аварга”-ыг шалгаруулаа.

Ес. Сургалт, Мэдээлэл:

❖ "Соёлын сэргэлт-2023" аяны хүрээнд Увс аймгийн Нийтийн номын сангаас Монгол Улсын Үндэсний номын сангийн аргазүйч Б.Гантулгатай хамтран Аймгийн хэмжээний 19 сумын соёлын төвийн номын санч, ЕБ-ын сургуулийн номын санчдад 2 өдрийн сургалт зохион байгууллаа.

Уг сургалт нь:

1 өдөр

1. Номын сангийн салбарын эрх зүйн орчин, салбарын цаашдын чиг хандлага
2. Нийтийн номын сан Мэдээллийн боловсрол
3. Номын сангийн анхан шатны бүртгэлүүд, ном бүрдүүлэлт, ном ангилал, каталог зохион байгуулалт

2 өдөр

1. Үндэсний ном зүй цахим мэдээллийн сан
2. Номын сангийн “Koha” программын тухай
3. Олон улсад хэрэглэж буй каталогжуулалтын стандарт MARC 21 сэдвүүдийн хүрээнд болж өнгөрлөө.

Б.Гантулга аргазүйч аймгийн Нийтийн номын сангийн ажилчдын ажилтай танилцаж мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн сургалтын үеэр СУИС-ийн соёл судлалын профессор Ж.Долгорсүрэн илтгэл уншлаа. Энэ үеэр сайн ажилласан сум, сургуулийн номын санчдыг аймгийн ИТХ-ын даргын болон Засаг даргын нэрэмжит шагналаар шагнасныг захирал Б.Батхүү гардуулан өглөө.

❖ Угийн бичгийн сургалт хийлээ

Жангар судлаач, соёл судлалын доктор Ж.Дэлэг аймгийн Нийтийн номын сангийн ажилтнуудад Баруун монголчуудын угийн бичгийн талаар 2023 оны 11-р сарын 1-ний өдөр сургалт хийлээ. Тухайн сургалт нь монгол хүний удмын сан генийг цэвэр ариунаар авч үлдэх үндсийн үндэс нь хүн бүр угийн бичгээ хөтөлж удам судар, ах дүүгээ 9 үе хүртэл сайн мэддэг байх нь чухал гэдгийг онцоллоо.

Удам угсаагаа сайн мэдэхгүйгээс ах дүү хүмүүсийн дунд гэр бүл бололцож удамшлын болон бусад удамших хандлагатай өвчин, эмгэгүүд эрс ихэсдэг байна.

Ураг, удам, уг гэсэн 3 үг нь тус тусдаа утгатай гэдгийг оролцогчдод тайлбарлалаа. Үр хүүхэд, ач зээгийн үеийг бид “ураг”, аав ээжийн төрлийн авга, нагац, ах дүү хамаатан садан болох хүмүүсээ “удам” гэж, харин 5 дахь үеэс дээших садан төрлөө “уг, угсаа” гэж нэрлэдэг байна. Ж.Дэлэг багш сургалтынхаа төгсгөлд угийн бичиг бичих аргуудаас танилцуулж, номын сангийн ажилтан Ч.Ганигмаагийн угийн бичгийг гардуулж өглөө. Мөн номын сангийн ажилтнуудад ургийн бичгээ бичих даалгавар өгч, 2024 оны 1-р улиралд ажилтнуудын угийн бичгээ бичсэнтэй танилцан, зөвлөгөө өгөхөөр боллоо.

❖ Онцгой байдлын газраас байгууллагын ажилчдад сургалт орж гал унтраах дадлага, сургуулилт хийлгэв.
❖ Хүчирхийлэл, түрэмгийлэл, гэмт хэрэг, цахим орчинд хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урдьчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Цагдаагийн газрын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран сургалт хийлээ.



❖ Зая бандида Намхайжамцын нэрэмжит Номын сан боллоо.

Увс аймгийн ИТХ-ын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 15 дугаар хуралдаан 2023 оны 9-р сарын 27-ны өдөр хуралдсан бөгөөд уг хурлаар аймгийн Нийтийн номын санг Төр, шашины нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч Зая бандида Намхайжамцын нэрэмжит болгох асуудлыг захирал Б.Батхүү оруулж, шийдвэрлүүллээ. Аймгийн Нийтийн номын санг Зая бандида Намхайжамцын нэрэмжит болгосноор Увс аймгийг тойрсон 1000 км-ын радиус дотор орших суугаа монгол цустай эрдэмтэдийн тод үсгээр бичсэн ном бүтээл, сурах бичиг, гарын авлага, судалгаа шинжилгээний материалууд нэг цэгт буюу Увс аймгийн Нийтийн номын санд хуран төвлөрөх юм. Үндсэндээ Баруун Монголын бичиг, номын биет өв соёл, сан хөмрөгийг бий болгохыг манай хамт олон зорьж байна.
Энэ хүрээнд Ойрадын суут хүмүүн Зая бандида Намхайжамцын намтар түүх, бүтээл туурвилыг судлах, ялангуяа түүний зохиосон Тод үсгээр бичигдсэн ном судар, бичиг дурсгал, шүлэг найраг, орчуулгын бүтээлүүдийг судлаж шинжлэх, олж илрүүлэх, ирээдүй хойч үедээ өвлөн уламжлуулах чиглэлээр шат дараатай арвин их ажил хийх шаардлага бидний өмнө зүй ёсоор тавигдаж байна.
Цаашдаа жил бүр олон улсын болон улсын хэмжээний эрдэм хэмжээний томоохон хурлуудыг зохион байгуулж, Баруун Монголчуудын өв соёл, бичиг үсэг, намтар түүхийн талаар судалгаа шинжилгээний ажлуудыг ихээр хийх болно.

Арав. Төсөв, Санхүү:

➢ Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд санхүүгийн мэдээллийг тогтмол хүргэж, “Шилэн данс” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн самбар ажиллуулж, иргэд олон нийтэд мэдээллэж байна.



- Байгууллагын Вэб сайт болон www.shilendans.gov.mn шилэн дансны вэб сайтад жил, улирал, сар, тухай бүрд төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах өр авлага үүссэн шийдвэрийг байршуулан ажиллалаа.



- Батлагдсан төсвийг хуулийн хүрээнд зарцуулж байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72-р зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 -р зүйлийн 12.2 .2 дахь заалтын дагуу байгууллагын Эд хөрөнгийн тооллогыг хийж гүйцэтгэлээ.

ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

МУСГЗ.М.Баянзулын нэрэмжит Нийтийн номын сан нь Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг соёлын үйл ажиллагаанд иргэн, гэр бүл, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, монгол хүнийг бага наснаас нь хүмүүнлэг, оюунлаг, соёл, уламжлалаа дээдэлдэг иргэн болгон төлөвшүүлэх зорилго зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулан явуулж байна.

Бидний алсын хараа: Уламжлалт болон мэдээллийн технологид суурилан, нийгмийг мэдлэг, мэдээллээр хангахад бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ манлайлагч байна.

Зорилго: Орон нутгийн хүн амын боловсрол, соёл, мэдээлэл, чөлөөт цагийн эрэлт хэрэгцээнд нийцсэн номын сан ном зүйн үйлчилгээг үзүүлж, бие хүнийг бүтээлчээр хөгжүүлэхэд оршино.

Соёлын бодлого, байгууллагын зорилго зорилтын хүрээнд номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах “Оюунтүлхүүр” багц хөтөлбөр боловсруулж, аймгийн Засаг даргын 2021-2025 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт оруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Статистик үзүүлэлт:

2023 оны статистик тоон мэдээллийг төлөвлөгөөтэй харьцуулбал:









содон мэдээллээр хангаж байна.

Байгууллагаас зохион байгуулж буй соёл олон нийтийн ажил болон хийгдэж буй арга хэмжээ, мэдээлэл сурталчилгааг Фэйсбүүк хуудсанд тогтмол байршуулан баяжуулан ажиллаж байна. Фэйсбүүк хуудас үүсгэж LIKE 200 аас 1000-аар өсөж шинэ



Шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрд нь www.shilendans.gov.mn сайтад шивж оруулж тайланг улирлаар цаг тухайдны илгээсэн.

Байгууллагын админаар захирал Т.Эрдэнэтуяа, хэрэглэгчээр Нягтлан бодогч О.Чанцалмаа Мэдээллийн ажилтан Д.Нямгэрэл нарыг томилон цаг тухай бүрд нь мэдээллийг тогтмол шивж оруулжажилласан.

Байгууллагын 2023 оны Ирсэн бичиг, Явуулсан бичиг, Захиралын /А,Б/ тушаал, ажилтнуудын тайлан, үр дүнгийн гэрээ, хурлын тэмдэглэл, үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг архивын баримт бичгийг хавтаслаж, товъёог үйлдэж, баталгааны хуудас хийж архивлав.

Байгууллагаас зохион байгуулж буй соёл олон нийтийн ажил болон хийгдэж буй арга хэмжээ, мэдээлэл суртачилгааг Фэйсбүүк хуудсанд тогтмол байршуулан баяжууланажиллаж байна. Мөн E-Mongolia-д Номын сангийн онлайн үйлчилгээг нэвтрүүлэн оруулжажиллаа.

“ОЮУН-ТҮЛХҮҮР” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД



“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД 2023” ХАВРЫН НОМЫН БАЯР

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг, Аймгийн “Оюун түлхүүр” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх зорилготой энэ удаагийн номын баярыг 6 чиглэлээр зохион байгуулан явууллаа. Үүнд:

Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:

1. “Уншаад урагшлахуй” ном уншлагыг сурталчлах, сэдэлжүүлэх сургалтыг ЕБС-ийн сурагчид болон Хөгжил политехник сургуулийн оюутнуудад 4 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж, нийт 145 хүн хамрагдлаа.
2. “Номын өргөөний ид шид” номын сангаас уншигчдад өгдөг боломжуудыг танилцуулах контентийг цувралаар хийхээр төлөвлөж, эхний контентийг Нийтийнномын сангийн тасаг танхимуудыг танилцуулж хийлээ. Та номын санд ирснээр хэрэгцээт мэдээ мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай авах боломжтой.
/Цахим хандалт 500 гаруй/
3. “Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага арга хэмжээнд ЦАЦ сургуулийн Энхзаяа багштай 3д анги, 1-р сургуулийн 5в ангийн сурагчид болох 45 хүүхэд оролцлоо.
4. “Бийрээ нийлье, ургаа уудалъя” угийн бичгийн сургалтыг аймгийн Татварын хэлтсийн хамт олон болох 32 хүн хамрагдлаа.
5. “Соёлын өртөөчилсөн аялал” номын сан, музейгаар аялах. Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн ахлах бүлгийн 60 хүүхэд багш нартайгаа Номын сангийн үйлажиллагаатай танилцах аялал хийв.
6. “Соёлын боловсрол” олгох үйл ажиллагаа: ЕБС-ийн сурагчдад соёлын боловсрололгох зорилгоор “Номтой зочин” аяныг Жаргалант сумын ЕБ-ын 7 сургуулийн сурагчдад хүрч мэдлэг мэдээлэл өгч ажиллаа. Хамрагдсан сурагчдын тоо 1702.

Үзүүлэн таниулах ажлын хүрээнд:

1. Тэгш ой тохиож буй зохиолчдын бүтээлийн чуулган, үзэсгэлэн
2. Онцлог бүхий номын үзэсгэлэн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн:

Гандaнпунцагчойлон хийдийн судруудыг олон нийтэд танилцуулж, үндсэн фондоос тод бичгийн номуудаар болон шинээр ирсэн номын үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

3. “Номын соёл” соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэнд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд Ховд аймгийн нийтийн Номын сан нь тухайн сардаа явуулах үйл ажиллагаагаа сурталчилсан календарь, дэлхийн суут хүмүүсийн титэм үгтэй номын хавчуурга, номын сангийн логотой түлхүүрийн оосор, номын сангийн зурагтай соронзон наалт, хүүхэд багачууд сонирхол татах зурагтай уншсан номын тэмдэглэл хөтлөх зэрэг 100 гаруй бүтээлүүдээр үзэсгэлэн гаргалаа
4. Уншигчдын бүтээл, номын тэмдэглэлийн үзэсгэлэн: Номын тэмдэглэл хөтлөгч "Шилдэг анги хамт олон" шалгарлаа. Сургууль бүр энэхүү уралдаанд хичээнгүйлэн оролцож 300 хүүхдийн олон мянган тэмдэглэлээрээ үзэсгэлэн гаргалаа. Тус арга хэмжээг "Ном хөлцийт" номын дэлгүүр ивээн тэтгэж оролцлоо.

Уралдаан, тэмцээн:

1. “Зохиолын баатруудын дүрийн уралдаан” парад: Баярын парадад ЕБ-ын 7 сургуулийн 120 хүүхэд оролцлоо. “Зохиолын баатрууд амилсан нь”, “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн уралдааныг 2 насны ангиллаар зохион байгуулж нийт 84 сурагч оролцлоо.
2. “Дэлхийн болон монголын шилдэг зохиолчдын нэрэмжит уншлагын уралдаанд 120 хүүхдийн 100 гаруй бүтээл ирж, үзэсгэлэн гаргаж шалгаруууллаа.
3. “Book battle” номын мэтгэлцээнд Прогресс сургуулийн 10б анги, 1-р сургуулийн 10а ангийн сурагчид Монголын болон гадаадын уран зохиолоор цэц мэргэнээ уралдуулж мэтгэлцлээ. 62 сурагч оролцсон.
4. “Book flashmob” 2 өдрийн арга хэмжээний нээлтэд МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургууль, Хөгжил политехник сургуулийн оюутнууд, 1-р сургууль, Прогресс сургуулийн сурагчдын хамтлагууд оролцлоо. Оролцогчдын тоо 200

Уулзалт, хэлэлцүүлэг:

1. Номын клуб, ном сонирхогчдын уулзалт Энэ үйл ажиллагаанд сургуулиудын номын клуб, ном сонирхогч хүүхдүүдийн уулзалтыг зохион явууллаа. 50 хүүхэд хамрагдлаа.
2. Ном бэлэглэх ёслол: Номын санд 88 ширхэг номын хандив өргөсөн хүмүүст талархал гардууллаа
3. Зохиолч, уншигчдын уулзалт, ярилцлага: Энэ уулзалтыг Ард Аюушийн талбай дээр зохион байгуулж 100 гаруй хүн оролцлоо.
4. Яруу найргийн цаг: Номын баярын 2 дахь өдрийн арга хэмжээний хөтөлбөрийн дагуу талбай дээр зохионбайгуулж 200 хүн хамрагдлаа.
5. “Эрдмийн сувд” подкаст FM 88.7 радиотай хамтарч “Эрдмийн сувд Подкаст” нэвтрүүлэг хийлээ.

Номын худалдаа:

1. Зохиолчдын гарын үсэгтэй номын худалдаа: МЗЭ-ийн Ховд аймаг дахь Алтай салбарын зохиолч уран бүтээлчид өөрсдийн бүтээлээ худалдаллаа.
2. .Шинэ номын худалдаа. Арга хэмжээнд Номин төв, Цэцэг төв, Ном хөлцийт номындэлгүүрүүд шинэ номоо хямдралтай үнээр худалдаж оролцогчдын

талархыг хүлээсэн үйл ажиллагаа боллоо.

Судалгаа:

1. Ном хэвлэлийн хүрэлцээ хангамжийн судалгаанд 22 хүн
2. Уншигчдын сэтгэл ханамжийн судалгаанд 36 хүн оролцсон байна.

Ард Аюушийн талбайд болсон 2 өдрийн номын баярын арга хэмжээний үйл явцынмэдээллээс дурдвал: Эхний өдрийн арга хэмжээний нээлтэд Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди, Засаг дарга, Баруун бүсийн зөвлөлийн дарга Э.Болормаа, Нийгмийнбодлогын хэлтсийн дарга Б.Даваадорж, Соёл урлагийн газрын дарга М.Пүрэвхүү нар оролцож мэндчилгээ дэвшүүллээ. Хөтөлбөрийн дагуу “Тэргүүний уншигч —Д.Нацагдорж” тэмдэгтэн шагналыг гардууллаа. Шагнал авсан сурагчид Ерөнхий боловсролын III сургуулийн 2в ангийн сурагч С.Ивээл , Прогресс сургуулийн 3б ангийн сурагч Г.Гэрэлт- Од, II сургуулийн 4а ангийн сурагч Б.Сансармаа, 2-р сургуулийн 5г ангийн сурагч Э.Аззаяа, 7-р сургуулийн 6а ангийн сурагч Ч.Нандин-Эрдэнэ, 6-р сургуулийн 7б ангийн сурагч

А.Болд-Эрдэнэ, Цаст-Алтай сургуулийн 8а ангийн Г.Гантуяа, I сургуулийн 9а ангийн сурагч Б.Түмэндэмбэрэл, Прогресс сургуулийн 10б ангийн сурагч Т.Гантуул, Цаст Алтай цогцолбор сургуулийн 11в ангийн сурагч Л.Аюуш, II сургуулийн 12а ангийн сурагч М.Ариунжаргал, Политехник коллежийн Бетон Арматурын II ангийн оюутан Э.Хүрэлтулга, МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн харьяа ЕБ-ын ахлах сургуулийн 12а ангийн сурагч Б.Энхтогтох нар шагнагдлаа. МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн оюутнууд, 1 дүгээр сургуулийн сурагчдын Book flashmob мэндчилгээ, Зохиолын баатрууд парад, “Үлгэрийн баатрууд амилсан нь”, “Зохиолын баатрууд амилсан нь” дүрийн уралдааныг бага болон дунд ахлах насны гэсэн ангиллаар зохион байгуулж явууллаа. Уралдааны бага насны ангиллын Тэргүүн байрыг ЦАЦ сургуулийн 4-р ангийн сурагчид, Дэд байрыг 3-р сургуулийн 2в анги, Гутгаар байрыг Прогресс сургуулийн 5-р анги, Дунд болон ахлах насны ангиллын Тэргүүн байрыг 6-р сургуулийн 8-р анги, Дэд байрыг 7-р сургуулийн 6-р анги,Гутгаар байрыг Хөгжил политехник коллежийн оюутнууд ээлж мөнгөн шагналаар шагнагдлаа. Зохиолч уншигчдын уулзалтад МЗЭ-ийн Ховд аймаг дахь Алтай салбарын захирал, яруу найрагч Г.Төрмөнх, МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн багш, доктор В.Янжиндулам, МЗЭ-ийн гишүүняруу найрагч Г.Бямбаа нар оролцлоо. 2 дахь өдрийн арга хэмжээний нээлтийг Хөгжил политехник коллежийн оюутнууд, Прогресс сургуулийн сурагчдын Book flashmoboop эхэллээ. Хөтөлбөрийн дагуу “Яруу найргийн цаг” арга хэмжээнд МЗЭ-ийн Алтай салбарын захирал яруу найрагч Г.Төрмөнх, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Бямбаа, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Б.Оюунхүү, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Т.Отгонхишиг, залуу яруу найрагч багш Хүлэгбоорчи, шүлэг яруу найраг сонирхогч хүүхдүүд оролцлоо. “Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлагад ЦАЦ сургуулийн Энхзаяа багштай 3д ангийн сурагчид, 1-р сургуулийн 5в ангийн сурагчид оролцож үлгэрийн ертөнцөөр аяллаа. “Bookbattle” номын мэтгэлцээнд 1-р сургуулийн Энхжаргал багштай 10а, Прогресс сургуулийнБаасанжав багштай 10б ангийн сурагчид Монголын болон дэлхийн уран зохиолоор цэц сорин мэтгэлзлээ. Ном сонирхогч клубын сурагчид, оролцогчдын дунд “Хөгжөөнтэй цаг”арга хэмжээг зохион байгууллаа. Уншсан

номын тэмдэглэл хөтлөх уралдааны тэргүүн байрыг Нямсүрэн багштай 11б анги, Дэд байрыг 6-р сургуулийн М.Сарантуяа багштай 6в анги, гутгаар байрыг 3-р сургуулийн Батсүх багштай 4б ангийн хамт олон ээлж Ном хөлцийт номын дэлгүүрийн шагналаар шагнагдлаа. “Дэлхийн болон монголын уран зохиолыг судалж, уншсан номоор хийсэн бүтээлийн уралдаанд Прогресс сургуулийн Баяртунгалаг багштай 8г анги, 3-р сургуулийн Батсүх багштай 4б ангийн сурагчид амжилттай оролцлоо. Тэргүүний шилдэг уншигч анги хамт олныг шагнаж, Нийтийн номын сангийн нэрэмжит дарцаг гардууллаа. Тэргүүний уншигчид Прогресс сургуулийн Я.Адилбиш багштай 1а, 1-р сургууль Энхцэцэг багштай 2в, ЦАЦ сургуулийн Б.Энхзаяа багштай 3д, ЕБ 6-р сургуулийн Х.Хадуан багштай 4б, р сургуулийн Амгаланхишиг багштай 5е,7-р сургуулийн Уянга багштай 6б, 2-р дугаар сургуулийн Эрдэнэшүр багштай7в, Цаст-Алтай сургуулийн Н.Отгонбаяр багштай 8б, 2-р суруулийн З.Мягмардоржбагштай 9б, Лаборатори 1-р сургуулийн Б.Энхжаргал багштай 10а, Цаст алтай цогцолбор сургуулийн Б.Оюунжаргал багштай 11в, 6-р сургуулийн н.Зулцэцэг багштай 12г ангийн хамт олон боллоо.Номын хандив өргөсөн Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди, иргэн Ц.Ичинхорлоо, Б.Лхамгаажав, Б.Онцгэрэл, Б.Оюунтөгс эмч Амаржаргал нартаа талархлаа. Өнөөдрийн арга хэмжээний хүрээнд номын үзэсгэлэн, худалдаагаар оролцсон ЕБС-ийн номын санч нар, МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн болон Хөгжил политехник сургуулийн номын санчид, МЗЭ-ийн Ховд дахь Алтай салбарын зохиолч яруу найрагчид, номын худалдааны төвийн хамт олон, мөн хувиараа Буянт сумаас ирж “Малчин өрхийн гэрийн номын сан” –ийн номоороо үзэсгэлэн гаргаж оролцсон иргэн Сарантуяа, онцлог ном болох ховор судар номын үзэсгэлэнд оролцсон Ганданпунцагчойлон хийдийн хамт олон зэрэг маш их хүмүүс хамтран оролцлоо.

Дүгнэлт: Номын баярын арга хэмжээг удирдамж хөтөлбөрийн дагуу олон ажлыг амжилттай зохион байгуулж явууллаа. Энэ удаагийн арга хэмжээнд төрийн болон ТББ олон байгууллагын төлөөллүүд оролцсоноороо онцлог байлаа. Угтаж хийсэн олон төрлийн ажлуудад болон талбай дээр зохион байгуулсан 2 өдрийн арга хэмжээнд нийтдээ давтагдсан тоогоор 4068 хүн хамрагдсан нь урьд жилүүдээс их хүн оролцсон амжилттайгаар зохион байгууллаа.

1. Цаашид авах арга хэмжээ: Номын баярын үйл ажиллагааг илүү өргөн хүрээтэй,алслагдсан иргэдэд явуулын нэг цэгийн үйлчилгээг ойртуулж ажиллах
2. Номын худалдаа эрхэлдэг томоохон аж ахуй нэгжүүдийн номын худалдааг аймагорон нутагт зохион байгуулах
3. Төрийн шагналт болон нэртэй зохиолчдыг орон нутагт ажиллуулах
4. Номын баярын үйл ажиллагаанд сурагчдыг татан оролцуулахын тулд Боловсрол,шинжлэх ухааны яамтай хамтрах

“Нээлттэй хаалга”-ны өдөр өдөрлөг:

Оны эхэнд “Чиглүүлэх сар” аяны хүрээнд 2022 оны “Тэргүүний уншигч сургууль”-р шалгарсан Цаст-Алтай цогцолбор сургууль дээр өдөрлөгийг тусгай удирдамж хөтөлбөр гарган зохион байгуулж явууллаа.

Тус өдөрлөгийг ЕБ-ын 7 сургууль, МУИС-ийн Ховд дахь салбар сургууль, Хөгжил политехник сургуулийн дотуур байрны оюутнуудад, Төрийн байгууллага болох Гадаадын иргэн харъяатын газар, НДХ, Татварын алба, Цаг уур ОШГ зэрэг нийт 11 байгууллага дээр зохион байгуулж явууллаа. Тусгай удирдамж хөтөлбөрийн дагуу аян зарлаж, зохион байгуулсан ажлын үр дүн, чанар хүртээмжид дүгнэлт өгч ажиллаа. Аяны хүрээнд шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж сурталчлах, “Номтой зочин” нүүдлийн болон зөөврийн номын үйлчилгээг анги бүлэг бүрт хүрч үйлчлэх “Номын сайн нөхөр” аяныг зохион байгуулж шилдэг 10 сурагч, шилдэг уншигч анги хамт олныг шалгаруулан урамшуулж, алдаршуулах, төрийн байгууллагууд дээр “Номтой өглөө” арга хэмжээ зэрэг номтой нөхөрлүүлэх олон төрлийн үйлчилгээг зохион байгууллаа. Нийт хамрагдсан хүний тоо 6312.

“Баялаг түүх, соёлоороо бахархая” арга хэмжээ:

Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үндэсний өв соёлын уламжлалт, язгуур хэв шинжийг хадгалан хамгаалах, ахмадуудын ажлын туршлага, түүхэн замналыг сонсох, орон нутагт ажиллаж, амьдарч буй гадаадын иргэдэд уламжлалт ёс заншлыг таниулах, олон нийтэд сурталчилан, түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор энэхүү үйл ажиллагааг зохион байгууллаа.

Бага ангийн сурагчдын дунд “Дөрвөн бэрх” танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулж, Цаст-Алтай цогцолбор сургуулийн Уранчимэг багштай 4б, Ариунбаяр багштай 4д, Цоггэрэл багштай 4в ангийн Тэмээчин, Ямаачин, Адуучин багуудэхний 3 байрыг эзэллээ. Нийт 4 багийн 20 сурагч хамрагдлаа.

Дунд ангийн сурагчдын дунд “Монголын уламжлалт хөлөгт тоглоом наадгайг хэн сайн мэдэх вэ? Арга хэмжээнд Цаст — Алтай цогцолбор сургуулийн 5-а, 5-б, 5-в, 5-г ангийн 35 сурагч оролцлоо. Ахлах ангийн сурагчдын дунд “Цаст — Алтай цогцолбор сургуулийн 8-а, 8-б, 8-в, 8-г ангийн 40 сурагч хамрагдснаас 8-б ангийн сурагч Б,Гансүх, 8-а ангийн сурагч Ө.Ундралцэцэг, 8-б ангийн сурагч Ч.Хүсэлсондор нар шалгарлаа. Сурагчдад “Түүх соёл бидний бахархал” лекц, мэдээлэл өгөв. Оюутан залуусын дунд “Ахмадын сургаал алт” сэдэвт танин мэдэхүйн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. МУ-ын гавьяат эмч П.Бямбаа “Монгол эмэгтэйн ёс зүй”, Жаргалант сумын ахмадын хорооны дарга Г.Сонин “Монгол хүний зан чанар”, МУ-ын гавьяат багш Б.Даваадорж “Монгол бичгийн үүсэл гарал”, МУ-ын соёлын тэргүүний ажилтан Ш.Ирбуян “Монгол ёс заншил” сэдвээр оюутан залууст мэдээлэл өгөв. “Дэлхийн номын өдөр”

Бүх нийтийг соён гэгээрүүлэх, хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэх, зохиолч уран бүтээлчдийн уран бүтээлийг алдаршуулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, чөлөөт уншлагыг дэмжих зорилготой жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг 28 дахь өдрийн Дэлхийн номын өдөрт зориулсан үйл ажиллагааг тусгай удирдамж, хөтөлбөр гарган төлөвлөсөн ажлыг 100 хувь биелүүлж ажиллаа.

Хөтөлбөрийн дагуу “Дэлхийн номын өдөр” арга хэмжээний мэдээллийг зохион байгуулах ажлын хэсэгт танилцуулан зөвлөгөө мэдээлэл өгөв

- Орон нутгийн зохиолчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж сурталчиллаа. Тус үзэсгэлэнд 142 ширхэг номыг уншлагын их танхим, Эрдэм шинжилгээ, чөлөөтуншлагын танхимаар сурталчилж, нийт 200 гаруй хүн үзэж танилцлаа.
- Уншигчдын хамгийн их уншсан номын мэдээлэл гаргаж нийтэд сурталчиллаа.
- Монголын уран зохиолын 108 боть бүтээлийг танхим болон цахимаар сурталчиллаа.
- Хүүхдийн номын өргөөний урд байрлах автобусны зогсоолыг засварлаж “Гудамжны номын сан”-г буй болгож нээлтээ хийлээ. Номын тавиурын шилэнхоргонд 112 ширхэг ном байршууллаа.
- Жаргалант сумын ЕБ-ын 7 сургууль очиж, сурагчид, багш, албан хаагчдад “Номтой зочин” явуулын уншлага зохион байгууллаа. Үүнд: 230 хүнд 370 номолгож үйлчиллээ.
- “Миний онцлох ном” хэлэлцүүлгийг МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн лицэй ахлах сургуулийн болон Жаргалант сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж явууллаа. Хэлэлцүүлэгт оролцсон оролцогчдоос хамгийн их санал авч бүх нийтээрээ унших номоор Ад үзэгдэх зориг ном онцлох ном боллоо. Хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулж, 98 хүүхэд оролцлоо.
- Номын тухай подкастын зочноор ЕБ-ын 7 дугаар сургуулийн сурагч Б.Амарзаяа, МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн оюутан Н.Буянбат, лицэй ахлах сургуулийн сурагч Энхийннаран нар оролцлоо.
- Алслагдсан ЕБ-ын 7 дугаар сургуулийн дотуур байрны сурагчдад уншлагын танхимын бүх номын санчид явуулын номын сангаар үйлчилж, хүүхдүүдийн дунд номын хэлэлцүүлэг, үлгэрийн цаг арга хэмжээ, багаар ажиллах чадвар, асуулт хариултын тэмцээн зэрэг соёл, танин мэдэхүйн үйл ажиллагааг зохионбайгууллаа. Дотуур байрны 99 хүүхэд хамрагдлаа.
- Дэлхийн номын өдөр арга хэмжээнд нийт 9 ажил төлөвлөснөөс бүгд 100 хувьбиелүүлж, нийт 1000 гаруй хүн хамрагдлаа.

“ЭРТНИЙ СУРГААЛЫН ЗОХИОЛООС СУРАЛЦЪЯ” арга хэмжээ:

Нийгмийн бүхий л салбарт хурдацтай хөгжлийн замыг туулж буй энэ цаг үед сургаалын зохиолоор дамжуулан Монгол хүн бүрийн үндэсний үзэл ухамсар, ёс суртахууныг сэргээх хэл, соёл, түүх, зан үйл, өв, шашин шүтлэг, монгол аман бичгийн эртний уламжлалт ёс түүхийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилготой Монгол УлсынСоёлын яам, номын коллектор, үндэсний ТВ-тэй хамтран зохион байгуулж буй энэхүү улсын YI уралдаанд манай номын сангийн зүгээс Жаргалант сумын ЕБ-ийн 7 сургуулийн сурагчдад сургаалийн зохиолоор мэдээлэл хийж сурталчиллаа. Мөн уншлагын танхимуудад байгаа зохиолын эх сурвалжуудыг хүртээмжтэй уншихад зориулж, тухайн номуудаар танхимын болон цахим үзэсгэлэн гаргалаа. ЕБ-ын сургуулийн 15-18 насны сурагчдад “ЭРТНИЙ СУРГААЛЫН ЗОХИОЛООС СУРАЛЦЪЯ” нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, эссэ бичих аргачлал, бичсэн бүтээлээ тухайн хаяг руу илгээх, дараагийн шатанд шалгарсан тохиолдолд асуулт хариултад бүрэн зөв хариулах, удирдамжид тусгагдсан бүх зохиолуудыг уншиж судалсан байх зэрэг мэдээллийг танилцуулж,

мөн уншсан сургаалуудаас өөрт төрсөн сэтгэгдлээ бусадтайгаа хуваалцах зэрэг олон талын арга хэмжээг зохион байгууллаа. Ховд аймагт ажиллаж амьдарч буй англи, тува иргэдийн дунд “Монголын цагаан сар” соёлын өв, уламжлалт ёс заншлыг таниулах арга хэмжээг хөгжөөнт тэмцээн хэлбэрээр зохион байгууллаа. Арга хэмжээнд 2 багийн 10 гишүүн оролцлоо.

Шинэ номын нээлт:

МЗЭ-ийн шагналт, зохиолч, яруу найрагч, сэтгүүлч, нийтлэлч Хиргис Гонгоржавын Төрмөнхийн шинэ номуудын нээлтийн ёслол, "Ном тойрч ярилцъя" сэдэвт уулзалт 2023оны 02 сарын 15-ны өдөр Ховд аймгийн Нийтийн номын санд зохион байгуулагдлаа. Энэхүү үйл ажиллагаа нь зохиолчийн шинээр хэвлэгдсэн "Санамсаргүй мадаггүй", "Мэтгэлцэх өгүүллүүд", " Монголын шилдэг нийтлэл" нэртэй 3 номын нээлт төдийгүй ном,номын соёл, ном унших сэдэл, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зэрэг сэдвүүдээр "Ном тойрч ярилцъя" зохиолч, судлаач, уншигчдын дундах хэлэлцүүлэг, ярилцлага хийлээ

Монгол Улсын Соёлын яамнаас орон даяар зохион байгуулж буй “Соёлын сэргэлт-2023” аяны хүрээнд Дэд сайд Батбаярын санаачилгаар “Өглөөний уншлага” номсолилцох хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулж явууллаа. 50 хүн хамрагдсан.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр “Номтой нөхөрлөе” өртөөг зохион байгуулж явууллаа. Энэ үеэр хүүхдийн зохиолын болон үлгэрийн 260 номоор үзэсгэлэн гаргаж сурталчлах, “Үлгэрийн цаг” хуруу хүүхэлдэйн театрчилсан тоглолт, “Багийн ажиллагаа” багаар ажиллах чадвар хөгжүүлэх хөгжөөнт тоглоомоор тоглуулах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. 100 гаруй хүүхэд хамрагдлаа.

Дүгнэлт: Төлөвлөгөө гарган зохион байгуулсан 37 ажлууд нь төлөвлөсний дагуу үр дүнтэй зохион байгуулснаар 48 ажилд 5200 хүн оролцсон үзүүлэлт гарлаа. Цаашид хийж төлөвлөсөн арга хэмжээнүүддээ дүгнэлт хийж, илүү олон хүн хамруулж, номын сангийн үйлчилгээний чанарт анхааран, сан хөмрөгийн баяжилтын судалгааг өргөнхүрээтэй зохион байгуулах сан хөмрөгийн эргэлийг сайжруулах зэрэг ажлуудыг эрчимжүүлэх зорилт тавин ажиллах хэрэгтэй юм байна. Цахим орчинд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх чанар стандартын шаардлага хангасан техник тоног төхөөрөмж, нүүдлийн, зөөврийн, явуулын номын сангийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэхэд теник, бензин шатахуун, сан хөмрөгийн баяжилтыг сайжруулах төсвийг зохих хэмжээнд нь тавьж өгөх асуудлыг шийдэж өгөхийг дээд шатны эрх бүхий байгууллагуудад уламжилж, шийдүүлж өгөх хэрэгтэй байна.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД 2023” НАМРЫН НОМЫН БАЯР

Хавсралт: Нээлтийн үйл

ажиллагаа:

“Үлгэрийн баатрууд амилсан нь”, “Зохиолын баатрууд амилсан нь” дүрийн уралдаан

Зохиолч уншигчдын уулзалт

“Яруу найргийн цаг”

“Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага

“Book battle” номын мэтгэлцээн

Ном сонирхогч клубын сурагчид, оролцогчдын дунд “Хөгжөөнтэй цаг” арга хэмжээ

Тэргүүний шилдэг уншигч анги хамт олон

Талбай дээр гаргасан үзэсгэлэн худалдаанууд

Номын худалдаа

Номын баярыг угтаж зохион байгуулсан үйл

ажиллагаа Номын сангийн тухай хуулийн

сурталчилгаа:

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
НОМЫН САНГИЙН ТӨРӨЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ЭРХ, ҮҮРЭГ

10 ДУГААР ЗҮЙЛ.НОМЫН САНГИЙН ТӨРӨЛ

10.1.Номын сан нийтийн, сургалтын, хүүхдийн, эрдэм шинжилгээний болон бусад төрөлтэй байна.
/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./
10.2.Нийтийн номын сан нийгмийн бүх гишүүнд үйлчилгээ үзүүлнэ.
10.3.Бүх шатны боловсролын байгууллага сургалтын номын сантай байх бөгөөд сургалтын номын сан нь багш, суралцагчийн сурч, хөгжих үйл явцыг дэмжихэд чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ.
10.4.Эрдэм шинжилгээний номын сан судалгаа шинжилгээ, мэдээллийн түшиц газар байж, судалгаа шинжилгээний үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий үйлчилгээ үзүүлнэ.
10.5.Хүүхдийн номын сан нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ном, мэдээллийн үйлчилгээг үзүүлнэ.
/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./
10.6.Бүх төрлийн номын сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, салбарын хөгжлийн бодлого боловсруулахад санал, дүгнэлт өгөх үүрэг бүхий орон тооны бус Номын сангийн Үндэсний зөвлөл соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана. Уг зөвлөлийн ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
/Энэ хэсгийг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн./

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ХУУЛИЙН ЗОРИЛТ

1.1.Энэ хуулийн зорилт нь номын сангийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, номын сангийн төрөл, зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлж, уншигчийн эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 ДУГААР ЗҮЙЛ.НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

2.1.Номын сангийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 ДУГААР ЗҮЙЛ.ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно.
3.1.1."номын сан" гэж уншигчид тодорхой хугацаанд ашиглуулах зориулалттай сан хөмрөг бүхий мэдээлэл, соёл, боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, нэгжийг;
3.1.2."номын сангийн үйл ажиллагаа" гэж уншигчид ном, ном зүйн мэдээллийн үйлчилгээг хүргэх болон номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагааг;
3.1.3."сан хөмрөг" гэж уншигчийн эрэлт, хэрэгцээг хангах зорилгоор бүрдүүлсэн хэвлэлийн бүтээгдэхүүн болон мэдээллийн бусад эх сурвалжийн хадгаламжийг;
3.1.4."цахим уншлагын үйлчилгээ" гэж уншигч цахим сүлжээг ашиглан эх сурвалжийг ашиглах үйлчилгээг;
3.1.5."номын татгалзал" гэж номын сангийн сан хөмрөгт байхгүй, эсхүл уншлагад хүрэлцээгүйгээс уншигчийн хүсэлтэд удаа дараа татгалзсан хариу өгсөн номын бүртгэлийг;
3.1.6."уншигч" гэж номын сангийн үйлчилгээг хүртэгч иргэн, хуулийн этгээдийг;
3.1.7."тусгай бүлгийн уншигч" гэж хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон номын санд биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй иргэнийг;
3.1.8."хэвлэн нийтлэлийн мэдээ" гэж тухайн хэвлэлийн бүтээгдэхүүнийг эрхлэн гаргасан байгууллага, зохиогч, гаралтын болон тооны мэдээ, олон улсын стандартын дугаар бүхий мэдээллийг.

4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Энэ хууль номын санд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр адил тэгш үйлчилнэ.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД 2023” НАМРЫН НОМЫН БАЯР

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг, Аймгийн “Оюун түлхүүр” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, үндэсний бичиг соёлыг сурталчлах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх, бүх нийтийг соён гэгээрүүлэх зорилготой энэ удаагийн номын баярыг 6 чиглэлээр зохион байгуулан явууллаа. Үүнд:

Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:

7. “Уншаад урагшлахуй” ном уншлагыг сурталчлах, сэдэлжүүлэх сургалтыг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад 2 удаа өгч нийт 70 гаруй сурагч хамрагдсан.
8. “Номын өргөөний ид шид” номын сангаас уншигчдад өгдөг боломжуудыг танилцуулах аялалыг ЕБС-ийн 1 дүгээр ангийн сурагчдад зориулж зохион байгууллаа. Энд 52 сурагч хамрагдсан байна.
9. “Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага арга хэмжээнд 82 хүүхэд оролцлоо.
10. “Бийрээ нийлье, ургаа уудалъя” угийн бичгийн сургалтыг ахлах ангийн сурагчдадзөвлөгөө хэлбэрээр явууллаа. Нийт 35 сурагч хамрагдсан.
11. “Номын эзэн”-ийг алдаршуулах үйл ажиллагаа: “Болор цом”-ын эзэн яруу найрагчийн “Хөөдөөн Эрдэнэбаатар” шинэ номын нээлтийг зохион байгуулж нийт47 хүн хамрагдлаа.

Үзүүлэн таниулах ажлын хүрээнд:

5. Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн
6. Онцлог бүхий номын үзэсгэлэн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн:

МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн номын сангаас Тод бичгийн 53 боть, Агнистийнгэгээ номын 43 боть цуврал номууд, үндсэн фондоос тод бичгийн номуудаар болон шинээр ирсэн номын үзэсгэлэн гаргаж сурталчиллаа. Нийт 360 гаруйномын үзэсгэлэн гаргалаа.

7. “Номын соёл” соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэнд ЕБС-ийн сургуулийн болон Хөгжил политехник коллежийн номын санчид сурагчдын хийсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргалаа
8. Уншигчдын бүтээл, номын тэмдэглэлийн үзэсгэлэн: Номын тэмдэглэл хөтлөгч "Шилдэг анги хамт олон" шалгарлаа. Сургууль бүр энэхүү уралдаанд хичээнгүйлэн оролцож 200 гаруй хүүхдийн олон тэмдэглэлүүдээр үзэсгэлэн гаргалаа.

Уралдаан, тэмцээн:

5. “Зохиолын баатруудын дүрийн уралдаан” парад: Баярын парадад ЕБ-ын 7 сургуулийн 130 хүүхэд оролцлоо. Энэ удаагийн уралдаанийг бусдыг номтой нөхөрлүүлэх уриалгаар зохион байгууллаа.
6. “Book battle” номын мэтгэлцээнд ЦАЦ сургуулийн 10г анги, 1-р сургуулийн 10б ангийн сурагчид Монголын болон гадаадын уран зохиолоор цэц мэргэнээ уралдуулж мэтгэлцлээ. 44 сурагч оролцсон.
7. “Book flashmob” 2 өдрийн арга хэмжээний нээлтэд Прогресс сургууль, Нийтийн номын сангийн хамт олон оролцлоо. Оролцогчдын тоо 45

Уулзалт, хэлэлцүүлэг:

6. Ном бэлэглэх ёслол: Номын санд 20 ширхэг номын хандив өргөсөн хүмүүст талархал гардууллаа.
7. “Яруу найргийн нээлттэй микрофон”: Номын баярын 2 дахь өдрийн арга хэмжээний хөтөлбөрийн дагуу талбай дээр зохион байгуулж 50 хүн хамрагдлаа.

Номын худалдаа:

3. Шинэ номын худалдаа. Арга хэмжээнд Номин төв болон хувиараа шинэ номоо хямдралтай үнээр худалдаж оролцогчдын талархыг хүлээсэн үйл ажиллагааболлоо.

Судалгаа:

3. Ном хэвлэлийн хүрэлцээ хангамжийн судалгаанд 22 хүн
4. Уншигчдын сэтгэл ханамжийн судалгаанд 36 хүн оролцсон байна.

Ард Аюушийн талбайд болсон 2 өдрийн номын баярын арга хэмжээний үйл явцын мэдээллээс дурдвал: Эхний өдрийн арга хэмжээний нээлтэд Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди, Соёл урлагийн газрын дарга М.Пүрэвхүү нар оролцож мэндчилгээ дэвшүүллээ.

Намрын номын баярыг 09 сарын 15-16 хооронд 2 өдрийн хөтөлбөр, удирдамж гарган зохион байгуулж явууллаа. Хөтөлбөрийн дагуу “Тэргүүний уншигч – Д.Нацагдорж” тэмдэгтэн шагналыг гардууллаа. Шагнал авсан сурагчид

- Прогресс сургуулийн 11-в ангийн сурагч Д.Билэгжаргал
- 7 дугаар сургуулийн 3-г ангийн сурагч Ж.Элбэгзаяа
- ЦАЦ сургуулийн 12-а ангийн сурагч И.Номингэрэл
- 1 дүгээр сургуулийн 12-а ангийн П.Хэрлэн
- 2 дугаар сургуулийн 12-б ангийн сурагч Т.Женерке
- 3 дугаар сургуулийн 6-а ангийн сурагч Г.Анармаа
- 6 дугаар сургуулийн 7-в ангийн сурагч Д.Удвал
  "Зохиолын баатрууд амилсан нь" дүрийн уралдаанд:
- Алтангадас одонт 1-р сургуулийн "Номын нөхөд" клубын Ч.Лодойдамбын Манайсургуулийнхан, Т.Энхтуяа багштай 8е ангийн 12 жил үлгэр
- 2 дугаар сургуулийн "Тархи цэнэглэгч" клубын сурагчдын жагсаал
- 3 дугаар сургуулийн Тодгэрэл багштай 2в ангийн сурагчдын жагсаал
- Цаст-Алтай цогцолбор сургуулийн Ариунбаяр багштай 5г ангийн парад
- Прогресс сургуулийн Амаржаргал багштай 5в ангийн С.Маршакийн Муурынбайшин
- 6 дугаар сургуулийн сурагчдын Альфонс Додегийн Сүүлчийн хичээл дүрийнпарад
- 7 дугаар сургуулийн Болормаа багштай 6в ангийн "Үнсгэлжин"
- 7 дугаар сургуулийн Занданхүү багштай 6г ангийн "Эрхий мэргэн"
- 7 дугаар сургуулийн Майрегүль багштай 7а ангийн "Муур багш"
- 7 дугаар сургуулийн Уянга багштай 7д ангийн Тансан лам баруун этгээдэдзорчсон нь" парад оролцсоноос

ЦАЦ сургуулийн 5-г, 1 дүгээр сургуулийн номын клубын, Прогресс сургуулийн 5в ангийнсурагчдын үзүүлбэрүүд шалгарлаа.

"Номын сангийн шилдэг үйлчилгээ" уралдаанд ЕБ-ын 1 дүгээр сургууль, 7 дугаар сургууль, Прогресс сургуулийн номын сангууд шалгарлаа.

"Номын шилдэг тэмдэглэл" уралдаанд ЦАЦ сургууль, Прогресс сургууль, 7 дугаарсургуулийн сурагчдын бүтээл шалгарлаа.

"Номын шилдэг худалдаалагч" уралдаанд Номин ХХК, хувиараа ном худалдаалагчиргэн Сайнбилэг нарыг урамшуулав.

"Book battle" номын мэтгэлцээнд 1-р сургуулийн Цэнд-Аюуш багштай 10б, ЦАЦ сургуулийн 10г ангийн сурагчид амжилттай оролцлоо.

Дүгнэлт: Номын баярын арга хэмжээг удирдамж хөтөлбөрийн дагуу олон ажлыг амжилттай зохион байгуулж явууллаа. Энэ удаагийн арга хэмжээнд ЕБС-ийн номын

санчдын дунд "Номын сангийн шилдэг үйлчилгээ" уралдааныг зохион байгуулж бусдын сайн туршлагыг ажилдаа тусган хэрэгжүүлэх, нийтэд өөрийн үйл ажиллагааны

онцлогийг танилцуулах нийтийн оролцоог хангаж ажилласнаараа онцлог байлаа. Мөн номын баярыг уншигч үйлчлүүлэгчдийн тав тухыг хангаж, хиймэл зүлэг байршуулж, тэдний дунд олон талт арга хэмжээг өртөө хэлбэрээр зохион байгууллаа. Угтаж хийсэн олон төрлийн ажлуудад болон талбай дээр зохион байгуулсан 2 өдрийн арга хэмжээнд нийтдээ давтагдсан тоогоор 4100 хүн хамрагдлаа.

Цаашид авах арга хэмжээ: Номын баярын үйл ажиллагааг илүү өргөн хүрээтэй, алслагдсан иргэдэд явуулын нэг цэгийн үйлчилгээг ойртуулж ажиллах

5. Номын худалдаа эрхэлдэг томоохон аж ахуй нэгжүүдийн номын худалдааг аймагорон нутагт зохион байгуулах
6. Төрийн шагналт болон нэртэй зохиолчдыг орон нутагт ажиллуулах
7. Номын баярын үйл ажиллагаанд сурагчдыг татан оролцуулахын тулдБоловсрол, шинжлэх ухааны яамтай хамтрах

Нээлтийн үйл ажиллагаа

“Уншаад урагшлахуй” Сургалт, хэлэлцүүлэг

“Номын өргөөний ид шид” танилцах аялал, хэлэлцүүлэг

“Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага

“Номын эзэн”-ийг алдаршуулах шинэ номын нээлтийн үйл ажиллагаа

Уралдаан тэмцээн: Дүрийн уралдаан Үзэсгэлэнгүүд:

“Book battle” номын мэтгэлцээн:

“Яруу найргийн нээлттэй микрофон”

Уралдаан тэмцээний шалгаруулалт:

“Угийн бичиг”-ийн сургалт

Ховд аймгийн татварын газрын хамт олон, Гадаадын иргэн Харьяатын газрын нийт хамт олонтой хамтран "Нээлттэй хаалга"-ны өдөр зохион байгуулж нийт албан хаагчдын дунд "Угийн бичиг"-ийн сургалт, сэдэвчилсэн номын үзэсгэлэн гарган ажиллаа. Нийт **80** гаруй албан хаагч хамрагдав.

Хил Хамгаалах Ерөнхий газар, ЗГХА, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Ховд аймгийн ГБХЗХГ-аас Хилийн цэргийн 130 дугаар ангийн нийт бие бүрэлдэхүүнд "Угийн бичиг хөтлөхийн утга учир" сургалт. Мөн Булган, Үенч, Алтай сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд "Угийн бичиг хөтлөх шалтгаан" сэдэлжүүлэх сургалтыг хамтран хийж ажиллаа.

Мөн Иргэдийн өдрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран зохион байгуулах үеэр ШШГА-ны **36** албан хаагчдад Угийн бичгийн сургалт явуулж, шинэ номын үзэсгэлэн гаргаж номын сангийн үйл ажиллагааг сурталчилж уншлага үйлчилгээ үзүүллээ.

Алагтолгой багийн засаг дарга Б.Нямсүрэнтэй хамтран Монгол Цэргийн баярын өдрийг тохиолдуулан Жаргалант сумын Алагтолгой багийн аавуудад "Аавын сургааль алт" номын өдөрлөг зохион байгуулж Угийн бичигийн сургалт явуулах, Номын сангийн тасаг танхимуудын үйл ажиллагаатай танилцуулах, карт нээж ном, сонин сэтгүүлээр үйлчилэх зэрэг ажлууд зохион байгуулав.

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан ХГБЗХГ-аас зохион байгуулсан "Аз жаргалтай гэр бүл" уулзалт хэлэлцүүлэгт оролцсон нийт төрийн албан хаагчдад Нийтийнсангаас "Угийн бичиг"-ийн сургалт явуулж хамтран ажиллав.

Аймгийн Нийтийн номын сангаас Жаргалант сумын ЗДТГ-тай хамтран “Ээжүүд уншиж байна” бүтээлч номын өдөрлөгийг зохион байгуулав. Энэ үйл ажиллагаанд гэртээүр хүүхдээ асран хүмүүжүүлдэг ээжүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие биенээ хүндэтгэх, өөрийгөө бусдад таниулах бусад ээжүүдээс суралцах, тэднийг ном уншлага үйлчилгээнд татан оролцуулах мөн

номын сангийн үйл ажиллагааг сурталчлахзорилгоор Жаргалант сумын 12 багийн 60 залуу ээжүүдийг хүүхдүүдийн хамт оролцууллаа.

Тус арга хэмжээний үеэр Гэрээр ном олгох тасгаас “Угийн бичгийн сургалт” зохион байгуулав.

Булган суманд “Соёлын ажилтны өдөр”-т зориулан төрийн албан хаагчдад “Угийнбичиг”-ийн сургалт зохион байгуулж ажиллалаа.

“Уншаад урагшлахуй” сургалт:

Ном уншлагыг сурталчлах, сэдэлжүүлэх сургалтыг ЕБ-ийн 3-дугаар сургуулийн ахлах ангийн 8, 9, 10-р ангиуд, Цаст-Алтай сургуулийн ахлах ангийн 8, 9-р ангийн нийт 115 сурагчдад зохион явууллаа. Мөн өөрийн танхимын танилцуулга хийж мэдээлэл өгөв.

Уулзалтаар ном сонирхогч хүүхдүүд хэрхэн номонд дурласан, анхны уншсан номынхаа талаар ярилцаж,номын талаар хэлэлцүүлэг хийж, хоорондоо танилцах зорилгоор хөгжөөнт тоглоом тоглож, номын тухай амттай/ чихэртэй/ ярилцлага хийсэн.

ЭРДМИЙН СУВД ПОДКАСТ

МУИС-ын салбар сургуулийн Бизнесийн тэнхимийн 1-3-р курсын оюутан болон багш нарт мэргэжлийн номын үзэсгэлэн гаргаж, Нийтийн номын сангийн үйл ажиллагааны талаар танилцууллаа.



КОНТЕНТ

Нийтийн номын сангийн тасаг танхимуудыг танилцуулсан контент хийлээ. Та номын санд ирснээр хэрэгцээт мэдээ мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай авах боломжтой.

Соёлын боловсрол олгох “НОМТОЙ ЗОЧИН” аялуулсан нь:Дунд ангийн сурагчдад “Номтой зочин” явуулын номын сангийн үйл ажиллагаа явууллаа.

Ахлах ангийн сурагчдад “Номтой зочин” явуулын номын сангийн үйл ажиллагаа явууллаа.

Талархалт уншлага:

Бүтээлч уншлага:

Гэр бүлийн уншлага:

Урилгын уншлага:

“Үлгэрээс үлгэрлэе чанга уншлага”

“Дурсамжит уншлага” Төгсөх ангийн сурагчид 1 дүгээр ангийн дүү нартаа уншихдадалд сургасан нь:

“Нээлттэй хаалга”-ны өдөр өдөрлөг:

Харилцан хүндэтгэе-Хамтдаа бүтээе" аяныг ЕБС-ийн Цаст-Алтай Цогцолбор сургууль дээр зохион байгууллаа. Аяны хүрээнд "Нээлттэй хаалганы өдөр" өдөрлөг зохион байгуулж нийт 150 гаруй багш сургчид хамрагдаж ажиллаа.

ЕБС-ийн 2 дугаар сургууль

ЕБС-ийн 1 дүгээр сургууль

“Номын сайн нөхөр” аяны хүрээнд "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгийг ЕБ 3-р сургууль дээр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд шинэ болон, сэдэвчилсэн номын үзэсгэлэн, номын танилцуулга, "Kahoot" танин мэдэхүйн тэмцээн боллоо.

Прогресс сургууль дээр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд шинэ болон, сэдэвчилсэн номын үзэсгэлэн, номын танилцуулга, мэдээ мэдээлэл хийлээ.

Номтой өглөө Төрийн байгууллагууд

Гадаадын Иргэн Харьяатын Газрын албан хаагчдад “Номтой өглөө” арга

хэмжээ зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн танилцуулж, карт нээж, ном олгож үйлчиллээ.

Нийгмийн даатгалын хэлтэс.

Татварын хэлтэс

Цаг уур орчны шинжилгээний газар

"Өв соёл. Уламжлал: Бага ангийн сурагчдын дунд "Дөрвөн бэрх" тэмцээн

"БАЯЛАГ ТҮҮХ СОЁЛООРОО БАХАРХАЯ" ардын уламжлалт тоглоом

Өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор Алтан хонх тэмцээнийгзохион байгууллаа.

Хөгжил политехник коллежийн 1, 2-р курсийн оюутнуудад, мэргэжлийн номуудаар үзэсгэлэн гаргаж, үйл ажиллагааг сурталчилсан.

“Ахмадын сургаал алт” хэлэлцүүлэг:

“Цагаан сар” өв соёлоо сурталчилъя” Ховд аймагт амьдарч буй гадаадын иргэд

Дэлхийн номын өдөрт “Миний онцлох ном” хэлэлцүүлэг:

"Шүлэг, яруу найраг сонирхогчдын клубын хүүхдүүд МУИС-н Ховд дахь салбар сургуулийн МХУЗ-ын багш профессор В.Янжиндулам, И.Жавхлан нартай уулзалт зохион байгууллаа.

Орон нутгийн зохиолчдын болон МУЗД 108 боть номын үзэсгэлэн сурталчилгаа:

Тэгш ой тохиож буй зохиолчдын намтар уран бүтээлийг сурталчлах:



ДОРЖ ЗУНДУЙН /1943-2015/

АЮУШ ШИРНЭНГИЙН /1903-1938/

МЯГМАР ДЭМБЭЭГИЙН /1933-1997/

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр “Номтой нөхөрлөе” өртөө:

"Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг" уралдаан

Номын хандив, солилцоо: "Та авч болно, Та өгч болно"

Соёлын сэргэлт: Соёлын дэд сайд Батбаярын санаачилсан Өглөөний уншлагааянд нэгдэж ном солилцов.

Номын санчдын цахим сургалт:

Бусад үйл ажиллагаа: Соёл урлагийн газраас зохион байгуулсан инноваци:

Англи хэлний элсэлтийн шалгалтанд бэлтгэх давтлага хичээл

Ховд аймгийн Засаг дарга Э.Болормаа долоо хоног бүрийн бямба гаригт хичээл заадаг.

СОЁЛЫН_БҮТЭЭЛЧ_САР

Mongolian Library Update 2023 улсын X зөвлөгөөнд оролцов.

Хүний хөгжлийн сургалтад хамрагдлаа.

“Хил хязгааргүй номын сан” төслийн арга хэмжээг тусгай хөтөлбөрөөрзохион байгууллаа.

“Номын сан өдөр тутам хөтлөгддөг бүртгэл”, “Номын сангийн ангилал”, “Номын сангийн катологи зохион байгуулалт”, “Ном зүйн бичилт” сургалт

Буянт сумын соёлын төвийн туршлага арга зүйн зөвлөлгөө

Баян Өлгий аймгийн Нийтийн номын санруу туршлага солилцох мэдээ мэдээлэл авах үйл ажиллагаанд хамт олноороо хамрагдлаа.

Энэхүү туршлага судлах ажилд Хэнтий нийтийн номын сан, Сүхбаатар аймгийн нийтийн номын сангаар зочилж, үйл ажиллагаатай нь танилцаж, харилцан туршлага судаллаа.

Гудамжны номын сан байгуулав.

Цагаан уул цогцолбор ахмадын сувилалын газарт Номтой өглөө, үдэш аян зохионбайгууллаа.

Нийтийн номын сан нь Тунгалаг Буянт голынхоо хөвөөнд зусаж байгаа айлуудад зориулсан ГЭР НОМЫН САН-г зуны 2 сарын турш ажиллаа.

Буянт голын хөвөөнд зусаж буй иргэд, хүүхэд багачууддаа "ШАР_ГЭР" өдөр бүр нээлттэй ажиллаж төлөвлөгөөт хуваарийн дагуу "Урилгат уншлага" арга хэмжээ явуулан урилгаар ирж гэр номын сангаар үйлчлүүллээ. Хүүхдүүддээ сонирхолтой, адал явдалтай, шинэ шинэ номоор үйлчилж, олон сонирхолтой тэмцээн уралдаан, кино өдрүүдийг явуулж байна.Амралтын өдрүүдэд зориулсан Нүүдлийн номын сангийн үйлчилгээ Их , бага гүүрний дунд "Гэрээр ном олгох, цахим ном kindle, асуулт хариултын хөгжөөнт тэмцээн" явууллаа.

“Зуны зугаатай уншлага” арга хэмжээнд төлөвлөгөөт “Үлгэрийн цаг” –аараа бяцхан уншигчдадаа шинэ содон сонирхолтой үлгэрээр бэлэг барьж хуруун хүүхэлдэй ашиглан үлгэрчилсэн тоглолт явууллаа.

Аймгийн төвийн “Тусгай хэрэгцээт” иргэдэд “Үлгэрийн цаг” арга хэмжээг явууллаа. Нийт хүүхэд том хүн нийлсэн 21 иргэн үйлчлүүллээ.Эдгээр иргэд зурганд орохыг зөвшөөрөөгүй болно.

Ховд аймгийн Соёлын газраас зохион байгуулсан “Соёлтой үдэш” аргахэмжээнд номын үзэсгэлэн гаргаж оролцлоо.

Нүүдлийн номын сан ажиллууллаа. Дотоодын цэргийн анги болон Цагаачлалын албаныханд багаар ажиллах чадвархөгжүүлэх сургалт, тоглоомыг тоглуулж хамтран ажиллалаа.

2023 Оны хамгийн их уншигдсан аварга номнууд

АСТөв 186 удаа уншигдсан

115удаа уншигдсан





Уншлагын их танхимын

М.Шагдарсүрэн Махабхарата 298 удаа уншигдсан.
Л.Түдэв Оройгүй сүм 184 удаа уншигдсан.

Пауло Коэльо Алхимич 154 удаа уншигдсан.





Үл мэдэх танхимаас 2023 оны шилдэг номоор А.Дэлгэржаргалын "Динза " 46

цуврал ном 3380 удаа уншлаганд гарч оны шилдэг номоор шалгарлаа. шилдэг ном нь "Гоё үлгэр" цуврал нь 2849 удаа уншлаганд гарч удаах байр эзэлсэн байна.





Гэрээр ном олгох тасаг нь Б.Сарантуяагийн зохиол Самар хатан зохиолыг 150 удаа, Ц.Оюунгэрэлийн Ногоон нүдэн лам романыг 200 удаа уншлаганд гаргаж үйлчиллээ.







Эрдэм шинжилгээ чөлөөт уншлагын танхимаас “Баян аав ядуу аав-2” Мэргэжил болон ажлаа зөв сонгосноор санхүүгийн эрх чөлөөнд хүрэх нь,мөн Монголын нууц товчоо ном шилдэг номоор шалгарлаа.

"УНШИГЧДЫН ШИНЭ ЖИЛ 2023"

Соёлын бүтээлч сар аян

Ховд аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын 16-18 насны 544 сурагчдад Соёлын эрхийн бичиг тараагдаж Нийтийн номын сангаас дараах 3 төрлийн үйлчилгээг санал болгож улмаар shoppy.mn-д байршуулан сурталчиллаа. Энэхүү үйл ажиллагааг 2023 оны 11 сарын 15 наас -30 ныг дуустал хэрэгжүүлэн ажиллалаа. Энэ хугацаанд бид ЕБС-н 12-р ангийн 23 бүлэг 11-р ангийн 1 бүлгийн нийтдээ 538 сурагчдад анги танхимаар биечлэн очиж /5-6удаа/ мэдээллээ хүргэж уг эрхийн бичгийг хэрхэн ашиглах,тусгагдсан 3 үйлчилгээг яаж сонгон үйлчлүүлэх талаар, shoppy апплэкейшн хэрхэн татаж суулгах, Mplus, Mmusic хугацаа болон ашиглалт, судалгааг хэрхэн бөглөх, Соёлын эрхийн бичгийн кодоо үнэн зөв хийх талаар, сагслах, зэргийг хүүхэд нэг бүрт биечлэн зааж зөвлөн ажиллалаа.Нийтийн номын сангаас дараах 3 үйлчилгээг санал болгосон. Үүнд:

1. Угийн бичгийн сургалт
2. Тоглонгоо суралцъя англи хэлний сургалт
3. Funny days-14 event зэрэг үйл ажиллагаанд нийт сурагчдыг байгууллага дээрээ урьж авчирч үйл ажиллагаа тус бүр үйлчилгээг үзүүлсэн.

Funny days -14 event, Тоглонгоо суралцъя англи хэлний сургалт 2023 оны 11 сарын 15 наас-30 хүртэл явагдаж хүүхдүүд хамрагдсан. Тухайн хөтөлбөрүүд shoppy.mn-д байршуулах хугацаа хоцорч орсон тул хүүхдүүд сонголт хийж чадаагүй.

Угийн бичгийн сургалт 2023 оны 11 сарын 27-ноос 30 хүртэл багц хэлбэрээр сонголт хийгдсэн. Үүний үр дүнд нийтийн номын сангаар үйлчлүүлэгчдийн тоо өсөн нэмэгдэж, сурагчдын үйлчилгээнд хамрагдах идэвх оролцоо бий болж, соёлын үйлчилгээг мэдэх болсон.

Хавсралт зураг

“Соёлын бүтээлч сар” аяны нээлтийн арга хэмжээг Ховд аймгийн СУГ, Театр, Музей, Нийтийн номын сан хамтран хийлээ. Тус арга хэмжээний хүрээнд Нийтийн номын сангаас ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд "Уран бичиг"-ийн уралдаан зохион байгуулж шилдгүүдээ шалгаруулла.



Нийтийн номын сангийн Америкийн төвийн үйл ажиллагааIELTS шалгалтын талаар лекц

Баян-Өлгий аймгийн Алтай Академийн багш Акебай овогтой Берикбол Ховдаймгийн Америк Соёл Мэдээллийн төвд гадаадад суралцах сонирхолтой, IELTS-өгөх сурагчидтай уулзан гадаадад сурах боломжууд, хэрхэн өргөдөл гаргах болон IELTS-ийн шалгалтад хэрхэн бэлдэх талаар лекц уншин чөлөөт

ярилцлага явууллаа. Нийтдээ 86 хүн оролцлоо.

Англи хэлний 7 хоног бүрийн хөтөлбөрүүд

Уншлагын дугуйлан

Сурагч бүр сурсан зүйлээ зургаар илэрхийлсэнээр энэ нь тэднийг сэтгэн бодох, уран сэтгэмжээрээ зурахад хүргэсэн учраас үнэхээр сонирхолтой байлаа. Энэ хичээлийн үеэр хүн бүр өөрийн санал, бодлоо англи хэлээр илэрхийлэхийг хичээсэн. Bookaholics Reading клуб нь унших чадвар, шүүмжлэлт сэтгэлгээгээ сайжруулах хүсэлтэй оюутнуудад зориулагдсан юм. Долоо хоног бүрийн 15:00 цагаас болдог. AC-ийн багш ангийг хоёр бүлэгт хувааж, багаар ажиллахыг дэмжинэ. Уншсаны дараа оюутнууд бүлгээрээ хэлэлцэж, санал бодлоо солилцож, танил бус үгсийг тодорхойлолтоор бичиж эхэлдэг; түлхүүр үгс; Зарим сурагчид үйлдлийг өөрийн төсөөллөөр зурахыг илүүд үздэг. Багш тэдэнд бүлгийн ажлаа бэлтгэх цаг өгдөг. Хийж дууссаны дараа тэд самбар дээр ирж хичээлээ тайлбарладаг. Нийтдээ 536

Баасан гариг бүрийн кино үдэш

16 цагаас кино үдэш зохион байгууллаа. Бага ангийн сурагчдад “Хүн зөгий” киногүзүүллээ. Кино сонирхолтой, хөгжилтэй байсан тул сурагчид анги бүрт шинэ үг цээжилж,харилцан яриа өрнүүллээ.

“Америкийн тухай ярилцъя” хөтөлбөр

Бид Мартин Лютер Кингийн өдрийг тэмдэглэж АС багш Мартин Лютер Кингийн тухай илтгэл тавьсан. Жишээ нь: Зүүд зүүдэл. Тэрээр хэлсэн үгэндээ бусдыг мөрөөдөж, юу ч байсан мөрөөдөж, мөрөөдөж байхыг уриалсан. Хэзээ ч битгий бууж өг. Хэрэв та амжилтанд хүрэхийг хүсч байвал бүтэлгүйтэлтэй нүүр тулж, түүнийг тойрон гарах арга замыг хайж сурах хэрэгтэй. Өнгөрсөн ба одоо үеийн агуу удирдагчдыг харах нь биднийгамьдралдаа илүү сайн зүйл хийхэд урам зориг өгч чадна. Энэ нь бидэнд хүний мөн чанарын тухай, бидний мөн чанарын тухай зааж чадна. Мартин Лютер Кингийн хүсэл эрмэлзэл, түүний хүсэл мөрөөдөлгүйгээр энэ ертөнц тэс өөр, илүү аймшигтай газар байх байсан. Бид оюутнуудын АНУ-ын талаарх мэдлэгийг дээшлүүлэх "Америкийн тухай дэлгэрэнгүй" хөтөлбөрийг санал болгож байна. АС багш нь сэдэв, ажлын хуудас, сэдэвтэй холбоотой видео бичлэг, даалгаврын дагуу өнгөлөг илтгэл бэлтгэдэг. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь зөвхөн сүүлийн үеийн мэдээлэл өгөх бус, АС-ийн багш түүхэн хүмүүсээр дамжуулан тэдэнд амьдралын сургамж өгөхийг хичээж байгаа юм, учирнь бид оюутнуудад бодит ертөнцийг ойлгох, өөрийгөө хайрлах, өөрийгөө хөгжүүлэхэд тусалдаг гэдэгт үнэнчээр итгэдэг. өөртөө итгэх итгэл бол оюутнуудад хамгийн сайн зүйлюм. Гурван удаа зохион байгуулсан. Сэдвүүд нь

Англи хэлний ярианы клуб

Англи хэлний ярианы чадвар дээшлүүлэх клуб 7 хоногт 1 удаа зохион байгуулагддаш. Энэ клубт тарийн албан хаагчид, оюутан сурагчид хамрагддаг. Энэ сарднийтдээ хөтөлбөрт 285 хүн оролцлоо.

Бүтээлч сэтгэхүй хөгжүүлэх клуб

Англи хэлээ сайжруулахыг хүссэн хүн бүхэнд нээлттэй үнэ төлбөргүй бөгөөд хувь хүний хөгжлийг дэмжих, бүтээлчээр суралцах хөтөлбөрүүд зохион байгуулагдсан.

АНУ ЭСЯ-ны олон нийттэй хариалцах алба болон бусад аймгуудын Америкийн төвийн ажилчдын Мягмар гариг бүрийн 10 цагаас тогтмол хуралд сууж мэдлэг мэдээллээ олж байна. Энэ үеэр 7 хоног бүрийн Америкийн төвийн үйл ажиллааг болн хийгдэх

ажлуудыг ярилцаж төлөвлөж байдаг бөгөөд мөн maker space хөтөлбөрийн талаар сургагч багш хичээл заадаг. 7 хоног бүр англи хэл дээр хамгийн сайн байсан үйл ажиллагааын талаар тайлан бичиж илгээдэг.

Тасаг танхимын номын тавиуруудын ном товхимол, тоглоом зэргийг цэгцэлж их цэвэрлэгээ хийлээ.





Ахмадад зориулсан кофетой танилцуулга хийлээ. Номын сангийнхаа талаар мэдээлэл хүргэж зарим настан хүмүүст үнэгүй зарт нээж. Эргээд холбогдох утас хаяг нэрсийн авлаа.

Хоцрогдол арилгах тойм хичээл

Бид хоцрогдсон оюутнуудад туслах, сурах алдагдлыг бууруулах зорилгоор давталтын хичээлийг өгдөг. АС багш илтгэл, ажлын хуудас бэлтгэдэг. Хиёээлийн үеэр бид Present simple, Present Perfect, Adjectives сэдвүүдийг хөндөж заалаа.

Подкаст цаг

Баасан гараг бүр бид Podcast цагийн хөтөлбөртэй. Бид Ухаалаг утас, Аз жаргалыншувуу, Ярилцлага гэх мэт янз бүрийн сэдвүүдийг сонсдог. Энэ хөтөлбөр нь дунд болон ахлах ангийн сурагчдад зориулагдсан. Хөтөлбөрийн зорилго нь оюутнуудын ярианы ур чадварыг дээшлүүлэх, тэднийг дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргахад татан оролцуулахявдал юм. Энэ нь тэдний шүүмжлэлтэй сэтгэх чадварыг сайжруулахад тусална гэж найдаж байна. Нийтдээ 83 сурагч ирсэн.

Америкийн тухай илүү ихийг мэдье лекц хичээл

IELTS шалгалтад бэлтгэх сургалт

Пүрэв, Баасан гаригт Тристан багшийн заадаг IELTS-ийн бэлтгэл сургалт нь оюутнуудыг шалгалт өгөхөд бэлтгэх зорилготой хичээл юм. Оюутнууд англи хэлний ерөнхий сэдвүүдээс гадна шалгалт өгөх стратеги судалдаг.

Бид оюутнуудын АНУ-ын талаарх мэдлэгийг дээшлүүлэх "Америкийн тухай дэлгэрэнгүймэдье" хичээлийг зааж байна. Багш сэдэв, ажлын хуудас, сэдэвтэй холбоотой видео бичлэг, даалгаврын дагуу өнгөлөг илтгэл бэлтгэдэг. Зарим үед оюутнууд өөрсдөө илтгэлээ бэлдэж тавьдаг.

Насанд хүрэгчдийн англи хэлний ярианы клуб

Энэ сард бид энэ хөтөлбөрийг эхлүүлсэн. Гол зорилго нь насанд хүрэгчдэдхарилцааны ур чадвараа дээшлүүлэхэд нь туслах явдал юм. 4 удаа зохион байгуулсан.

Англи хэлний сургагч багш Энхзаяа иогийн багш Солонго нар ажил амьдралдаа маш их завгүй, иог хийх хангалттай цаг гаргаж чадахгүй байгаа багш оюутнуудад зориулсан сандлын иогийн хичээл заалаа. Өдөр бүр сандлын иогийн дасгал хийх нь бидний хувьд хамгийн сайн боломж эрүүл мэндэд нэн хэрэгтэй дасгалууд байлаа.

Сандалтай иогийн хичээл

Англи хэлний сургагч багшийн кино хичээл

Багш нарын сонсох, ярих чадварыг сайжруулах зорилгоор киноны үдэшлэг зохион байгууллаа. Бид үзэхийн өмнөх, үзэх, үзэхийн дараах ярилцлагууд үйл явдлыг англиар ярилцаж дараалалд орууллаа.

АНУ ЭСЯ-нгы англи хэлний хөтөлбөр хариуцагч Т.Алтанцэцэг Ховд аймагт ирж англихэлний багш нарт зориулсан заах аргай зүйн сургалтыг 2 өдрийн турш явууллаа.

Тоглоомын өдөр

Бага насны хүүхдүүдийн хамгийн дуртай хөтөлбөрүүдийн нэг бол "Тоглоомын өдөр" хэмээх олон талт хөтөлбөр бөгөөд багаар ажиллахыг дэмжээд зогсохгүй англи хэлний үгсийн сан, бүтээлч байдлыг нэмэгдүүлнэ.

Fun English англи хэлний хөгжөөнт тэмцээн

Уг тэмцээнд нийтдээ 5 баг оролцож Лицей ахлах сургуулийн Red wolves баг тэргүүнбайр эзэлж өргөмжлөл дурсгалын зйүлээр шагнагдав.

Номтой үдэш ХОИС 1,2-р дотуур байранд ажиллав. Энэ үеэр Номын сангийн шйл ажиллагааны талаар Америкт сурах 5 алхам сэдвээр лекц уншиж, багаар ажиллах чадвар хөгжүүлэх тоглоом тоглуулж оюутнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхномтой нөхөрлөх аяныг өрнүүлэж ажиллалаа.

Тоглонгоо суралцъя бага ангийн сурагчдад зориулсан сургалт

Бага ангийн сурагчдад зориулж тоглонгоо суралцъя англи хэлний сургалтууд 7 хоног бүр явуулж хүүхдүүдийн англи хэлний сонсох ярих чадварыг дээшлүүлж шинэ дуушүлэг англи хэл дээр зааж, хөдөлгөөнт дуу дасгалыг тогтмол зааж байна.

Цагаан хоолтны сургалт зохион байгуулагдлаа.

Америкийн тэмдэглэлт баярууд болох Halloween, Thanksgiving тэмдэглэн өнгөрүүллээ.

10 сарын 26ний өдөр “Girls Coding Bootcamp”ийн хоёр дахь өдрийн сургалт, оролцогчид, хөтөлбөрийн ахлагч @itznaranjn -ын хамт амжилттайгаар Ховд аймаг дах Америкийн соёл мэдээллийн төвд зохион байгуулагдлаа. Энэ удаагийн уулзалтаараа бид танин мэдэхүйн асуултуудад хариулж мөн C++ хэлний анхан шатний хичээлийг үзэж судалсан билээ. Нийт сурагчиддаа Сертификат гардууллаа.

I can sing англи дууны тэмцээн

Лицей ахлах сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж нйитдээ анги бүрийнхамтлаг дуу 6, гоцлол дуу 8 дуулагдаж 11 а ангийн Hard баг тэргүүллээ.

Бусад ажил

Ховд аймагт зохион байгуулагдсан “МӨНГӨЛӨГ ШАГШУУРГА-2023” олон нийтийн үйл ажиллагааны хүрээнд явагдсан “САЙХАН ХУВЦАСЛАСАН ХОС”, “САЙХАН ТЭМЭЭТЭЙ ГАНГАН ХОС”, “САЙХАН МОРЬТОЙ ГАНГАН ХОС”, “ ДЭЭЛТЭЙ МОНГОЛ

ХҮҮХЭД” гэсэн дөрвөн төрлийн тэмцээнийг Нийтийн номын сангийн хамт олон хамтранамжилттай зохион байгуулж ажиллаа. Эдгээр уралдаан тэмцээнд хоёр өдрийн турш бүртгэл нь үргэлжилсээр нийт 101 хос болон оролцогч идэвхтэй оролцсон байна.

“Сайхан тэмээтэй ганган хос” уралдаанд 12 хос оролцсон

Дээлтэй Монгол хүүхэд" уралдаанд 53 хүүхэд оролцсон

Сайхан морьтой ганган хос” уралдаанд 12 хос оролцсон

Сайхан хувцасласан хос" уралдаанд 24 хос оролцсон.

Монголын номын сангуудын Спортын тэмцээн

Гар бөмбөг, Сагсан бөмбөг, Теннис, Дартс гэсэн 4 төрлийн тэмцээнээс манай багтамирчид Теннис — алтан медаль, Гар бөмбөг- алтан медаль, Сагсан бөмбөг- алтан медаль гээд нийт гурван тэмцээнд алтан медаль авч амжилттай оролцлоо.

Жангар цайны зам Монгол туургатны соёлын өвийн IV наадмын хүрээнд Нийтийн номын сангаас "Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн, Номын худалдаа, мэдээлэл"зэргийг ард иргэдэд үйлчиллээ.

МЗЭ-ийн шагналт 2009 оны "БОЛОР ЦОМ" наадмын эгшиглэнт эхийн яруу найрагч Хөөдөөгийн Эрдэнэбаатарт зориулж МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн хэл зохиолын багш И.Жавхлан "ХӨӨДӨӨГИЙН ЭРДЭНЭБААТАР" шинэ номын нээлт, болон Х.Эрдэнэбаатар агсны нэрэмжит танхимд "Үнэт зүйлсийг" шилэн хоргонд хийж үзэсгэлэнд гаргалаа.

Ард иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соёлын үйл ажиллагааг тэгш хүртээмжтэй хүргэх, залуусын авьяасыг нээн хөгжүүлэх зорилгоор зохион байгуулагдаж буй "СОЁЛТОЙ ҮДЭШ" үдшийн арга хэмжээ амжилттай болж өнгөрлөө. Нийтийн номын сангийн тасаг танхимууд “Шинэ номын үзэсгэлэн гаргаж ажиллаа.

2023 оны 6-р сарын 8-ны /пүрэв гаригт/ гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохио дуугарлаа.дохио дуугарахад, байгууллагын албан хаагчид түр цугларах талбайд цугларлаа.

Нийтийн номын сангийн урсгал засвар үйлчилгээг хийж дуусгалаа.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлж буй хавар, намрын улирлын мод тарих аяндНийтийн номын сангийн хамт олон нэгдэж хуваарьт талбайд улиас мод тарилаа.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам болон Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/515 дугаар захирамжаар батлагдсан аргачлалын дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн үзүүлэлт, байгууллагын нээлттэй байдал гэсэн үндсэн зорилтын хүрээнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын ажил хэрэгч шийдвэр (Захирамж, албан даалгавар, хуралдааны тэмдэглэл)
- Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлт
- Аймгийн Засаг даргаас агентлаг байгууллагын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний үүргийн биелэлт
- Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
- "Нэрлэсэн жил"-ийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Байгууллагын ил тод байдал
- Авилгын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний үр дүнд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 6.2, 6.3, 2021 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 374 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан арга зүйгээр дээрх 10 үзүүлэлтээр үйл ажиллагааны үнэлгээний тайланг гаргалаа.

Аргачлалын 9 дүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Нэг. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	-	0.6	
	2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100		
	3. Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний биелэлт	-		
	4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	100		
Хоёр. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	100	0.2	
	2. Аймгийн Засаг даргаас агентлаг, байгууллагын даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	100		
	3. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	100		
	4. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100		
	5. Өмнөх оны дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ	100		
	6. “Нэрлэсэн жил”-ийн төлөвлөгөөний хэрэгжилт	100		
Гурав. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	-		
	3. Авилгын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ	-		
Ерөнхий үнэлгээ:		100%	1.0	

1.АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Соёл-Олон ястны өв” үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймгийн Нийтийн номын сан 6 зорилт хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, хяналтанд авч ажилласан бөгөөд хэрэгжилт 100%-тай үнэлэгдсэн.

“Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, салбар дундын хамтын оролцоонд тулгуурлан соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлнэ” зорилт арга хэмжээний хүрээнд “Бүх нийтийн соёлын боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Номд хөтлөх ухаан” номын сангийн боловсролын хөтөлбөрийг боловсруулж, 2023-2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Уг хөтөлбөр нь;

- Ардын уламжлалт тоглоом наадгай
- Бяцхан театр
- Ургаа мэдье-Удмаа судалья
- Дараагийн хуудас
- Зуны зугаатай уншлага
- Хамтдаа уншья-гэр бүлийн уншлага
- Тэгш, хүртээмжтэй номын сан гэсэн агуулга, сэдвийн хүрээнд явагдаж байна.

Хөтөлбөрийн гол зорилго нь хүүхэд багачуудын соёлын боловсролыг дээшлүүлэх, эерэг хандлагатай, бүтээлч иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэж байгаа бөгөөд дараах арга хэмжээнүүд авч ажиллаа. Үүнд:

1.Зуны зугаатай уншлага: Сургуулийн хүүхдүүдийн зуны амралттай уялдуулан цэвэр агаарт, чөлөөтэй орчинд, сонирхолтой арга хэлбэрээр номын сангийн үйлчилгээг хүргэх зорилгоор ардын уламжлалт “Үүчүүр”, “Хорол”, “Алаг мэлхий өрөх” тоглоомуудуур тоглонгоо суралцах боломж нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Энэ хугацаанд нийт давхардсан тоогоор 1200 орчим уншигч, ирэгсэд хамрагдаж, 2700 ширхэг ном хэвлэлийг зөөврөөр гаргаж уншлага үйлчилгээ үзүүлжээ.

2.“Ургаа мэдье-Удмаа судалья” хөтөлбөрийн хүрээнд угийн бичиг хөтлөх арга зүй, угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, одоо үед хөтөлж байгаа угийн бичгийн төрөл, хэлбэр зэрэг сэдэв агуулгын хүрээнд ажилтан албан хаагчид, уншигч хүүхдүүдийг хамруулсан 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 219 хүн хамрагдсан. Мөн энэ сэдвээр гарсан ном, хэвлэлийн бүтээгдхүүнээр цахим болон танхимаар 15 удаагийн үзэсгэлэн гаргаж 3804 уншигч, ирэгсдэд түгээсэн. Нийт 4023 хүнд угийн бичиг хөтлөх анхан шатны мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийж ажилласан байна.

3.Тэгш хүртээмжтэй номын сан хөтөлбөрийн хүрээнд “Номын богц” зөөврийн номын үйлчилгээг нэвтрүүлж, Мөрөн сумын Ахмадын хорооны чийрэгжүүлэх 8 төв, Ахмад настны асрамж үйлчилгээний төв, ШШГГ-т байгаа 5 хүн, тусгай хэрэгцээт "Дэлбээ" бүлгийн 5 сурагч, нийт 68 хүнд, 401 ном, хэвлэлийн бүтээгдхүүнээр үйлчлээд байна. Мөн "Дэлбээ" бүлгийн сурагч Ану-Үжин, “Аутизм ба гоц ухаан” НҮТББ-тай хамтран Мөрөн сумын Аутизмтай хүүхдүүдэд “Номын богц” үйлчилгээг тогтмол хүргэхээр болсон бөгөөд үйл ажиллагаагаа эхлээд байна.

4. “Дараагийн хуудас” боловсролын хөтөлбөрийн хүрээнд шүлэг зохиол бичих сонирхолтой, авьяастай хүүхдүүдийг нэгтгэн тэднийг хөгжих, суралцах боломжийг хангах зорилгоор Мөрөн сумын ЕБС-ын ахлах ангийн 20 сурагчийн бүрэлдэхүүнтэй “Утга зохиолын дугуйлан”-г ажиллуулж байна. Утга зохиолын дугуйлан 3 сараас эхлэн нийт 25 удаагийн сургалт орж, хагас бүтэн жилээр “Дотоод инээмсэглэл” чөлөөт уншлагын уулзалт хийсэн. Чиглүүлэгч багшаар аймгийн Утга зохиолын нэгдлийн гишүүн зохиолч, сэтгүүлч О.Элбэгтөгстэй хамтран ажиллаж байна.

“Уламжлалт монгол ахуй өв соёл, зан заншлаа дээдлэн хадгалж сурталчлан түгээн дэлгэрүүлэх, угийн бичиг хөтлөх үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих замаар удмын санг хамгаална” зорилт, арга хэмжээний хүрээнд аймгийн Соёл Урлагийн хэлтсийн дарга Х.Баасансүрэн Нийтийн номын сангийн нийт албан хаагчдад “Угийн бичиг хөтлөх аргазүй” сэдвээр сургалт орлоо.

Нийтийн уншлагын танхим, Гэрээр ном олгох танхим, Хүүхдийн уншлагын танхимуудад номын үзэсгэлэн “Удмаа мэдье, ургаа уудлая”, “Угийн бичиг удмын хэлхээ”, “Шадар ван Чингүнжав”-ын угийн хэлхээг зураглалын аргаар, нийт 4 удаагийн үзэсгэлэнг 48 ширхэг номоор гаргаж, 1800 гаруй уншигч иргэсдэд мэдээлэл түгээлээ.

Хүүхэд багачууддаа угийн бичиг, удмын түүхээ танин мэдэх, тэдгээрийн нэршлийг зөв тогтоож, нэрлэж сургах зорилгоор “Номын сангийн боловсролын хөтөлбөр”-т “Ургаа судалъя удмаа мэдье” сургалтыг хүүхдийн уншлагын танхимаас боловсруулж,   нийт 5 удаагийн сурталтаар 162 уншигч хүүхдэд, Нийтийн уншлагын танхимаас “Ураг удмаа судалж мэдэхийн ач тус” ахлах ангийн сурагчдад сургалт мэдээлэл өгч 42 уншигч, нийт 204 уншигч хамрагдлаа.

Мөн байгууллагын цахим хуудсаар дамжуулан угийн бичиг хөтлөх арга, удмаа таньж мэдэхийн ач холбогдолын талаар дээрх хийсэн ажлуудаа уншигчдад тухай бүр сурталчилж ажиллалаа. Нийтийн уншлагын танхимаас 2 удаа, гэрээр ном олгох танхимаас 3 удаа, хүүхдийн уншлагын танхимаас 6 удаагийн мэдээлэл оруулж сурталчиллаа.

Уламжлалт монгол ахуй,өв соёл,зан заншлаа түгээн дэлгэрүүлэх чиглэлээр номын сангийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд “Монгол ардын уламжлалт тоглоом наадгай” –г сурталчлах, тоглож сурах зорилгоор “Хамтдаа тоглоё” арга хэмжээг зохион байгуулсан. Мөн энэ чиглэлээр цахимаар 10 удаа, танхимаар 2 удаагийн мэдээлэл, сурталчилгааны цувралуудыг явуулсан.

“Орон нутгийн төр, хувийн хэвшлийн байгууллагуудад эцэг эхийн зөвлөл ажиллуулж, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг мөрдүүлэх, хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангахад иргэн бүрийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ” зорилт, арга хэмжээний хүрээнд:

- Мэргэжил сурталчлах, олон улсын гэр бүлийн өдөр, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрүүдээр номын үзэсгэлэн гаргасан.

- Жил бүрийн дөрөвдүгээр сарын 30-ныг “Хүүхдийг зодож шийтгэхийг таслан зогсооё” олон улсын өдрөөр “Хүмүүжлийн эерэг арга түүнд суралцах нь”, 5 сарын 15-ны өдөр тохиодог "Гэр бүлийн өдөр"-өөр “Аз жаргалтай гэр бүл ” сургалтуудыг байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулан зохион байгуулсан.

- Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрөөр хүүхдүүдийн дунд АХА тэмцээн тэмцээн зохион байгуулав. Тэмцээнд 61 хүүхэд оролцсон бөгөөд тэргүүн байранд Э.Төгөлдөр, Дэд байранд О. Амаржаргал, Гутгаар байранд О.Тунгалаг нарыг шагнаж, урамшуулав.

- Нийтийн номын сангийн дэргэдэх Эцэг эхийн зөвлөлөөс байгууллагын эцэг эхчүүддээ "Бүх хайраа гэр бүлдээ" уриан дор "Оюунлаг аав ба ээжүүд" тэмцээн зохион байгууллаа. Уг тэмцээнийг шатар, дартс, тататунга гэсэн 3 төрлөөр зохион байгуулж, I, II ,III-р байранд орсон гэр бүлийг мөнгөн шагнал, талархал хадгалуулав.

- **“Нэгдүгээрт Хүүхэд”** арга хэмжээний хүрээнд “Цахим орчин дах аюулгүй байдал” болон “Дээрэлхэлтийг таслан зогсооё” сургалт 7а, 7в ангид зохион байгууллаа. Уг сургалтаар үе тэнгийн найзуудынхаа эргэн тойронд аюулгүй байдал болон өсвөр насны дээрэлхэлт, хүүхдүүдэд бусдын ялгаатай байдлыг ойлгон хүндэтгэх болон дээрэлхэлт, дарамтаас сэргийлэх агуулгаар сургалт орлоо.

“Бүх нийтийн хүний эрх, жендерийн боловсрол олгох, үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална” зорилт арга хэмжээний хүрээнд:

- Хөвсгөл аймаг дахь хүний эрхийн референт М.Тунгалагмөрөнтэй хамтран албан хаагчдад жендерийн тухай, жендерийн тэгш эрхийн тухай цогц ойлголтуудыг өгөхийн тулд эхлээд Хүний эрхийн мэдлэг, мэдээлэлтэй болгох зорилготойгоор “Хүний эрхийн тухай үндсэн ойлголт ” сургалтыг зохион байгуулж, музей номын сангийн хамт олныг хамруулллаа.

- Хөвсгөл аймгийн эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгч гишүүн Д.Оюунтай хамтран бусдад баярласан талархсанаа илэрхийлж, уучлал гуйж сурах нь таныг аз жаргалтай болгож оюун санааны хувьд эрүүл, эерэг хандлагатай нэгэн болгох зорилготой "Уучлал ба талархал" сургалтыг зохион байгуулж, 60 гаруй уншигч иргэдэд музей, номын сангийн ажилтан албан хаагчид оролцсон.
- "Харилцан хүндэтгэе" "Надаас танаас биднээс эхлэлтэй" сарын аяны уриа постерийг байгууллагын фэйсбүүк пэйж хуудсаар сурталчлан ажиллалаа.
- ХГБЗХГ, байгууллагын эцэг эхийн зөвлөлтэй хамтран байгууллагын албан хаагчдад жендер гэж юу вэ сургалт зохион байгуулсан үүнд Музей Номын 20 гаруй албан хаагч оролцож жендерийн мэдлэг мэдээлэлтэй боллоо.
- ХГБЗХГ-тай хамтран өсвөр үеийн хүүхэд залуучуудад жендэрийн ойлголт, мэдлэгтэй, мэдрэмжтэй болгох зорилгоор Мэргэжил сонгоход хүйс хамаатай юу сэдвээр Гурван-Эрдэнэ сургуулийн 11-12 ангид сургалт зохион байгууллаа.
- Гэрээр ном олгох уншлагын танхимд "Жендерийн булан" ажиллуулж байна. Уг буланд жендерийн холбогдолтой ном товхимол, хууль постер мэдээллүүдийг өдөрт дунджаар 30-40 уншигч иргэдэд сурталчлан ажиллаж байна

Номын үзэсгэлэн, мэдээлэл 4 удаа бэлтгэж нийтдээ 1500 гаруй уншигч иргэдэд сурталчиллаа.

- Өсвөр үеийнхэнд зориулсан Охид, хөвгүүдийн бэлгийн хүчирхийлэл, Үе тэнгийнхний дээрэлхэл, Цахим орчин дахь зохистой хэрэглээ, сургалт нөлөөллийн арга хэмжээнүүдийг Авьяас, Гурван-Эрдэнэ сургуулиудын 7,11,12 дугаар ангийн нийт 150 гаруй сурагчдад зохион байгууллаа.
- "Уучлал ба талархал" сэдвээр Хөвсгөл аймгийн Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгч Д.Оюун, "Цахим орчин дахь хүүхэд хамгаалал" сэдвээр ЦГ-ын Хүүхдийн асуудал эрхэлсэн ахлах мэргэжилтэн Г.Бямбахишиг, ГБХЗХГ-ын Хүүхдийн эрх хамгааллын мэргэжилтэн Х.Сэрчмаа нартай хамтран Авьяас сургуулийн 7а,7в ангийн сурагчдад сургалт зохион байгууллаа.
- "Хүндлэл бол хамгийн тод гэрэл " сарын аянд номын сангийн албан хаагчид, уншигчид нэгдэж, уриа постерийг байгууллагын фэйсбүүк пэйж хуудсаар сурталчлан ажиллалаа.
- Хүндлэлийг илүү хүртэх 7 зөвөлгөө мэдээллийг бэлтгэж цахим хуудсуудаар сурталчлан ажиллалаа.
- Хөвсгөл аймгийн Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгч Д.Оюунтай хамтран ДМЦС-ийн Пагмадулам багштай 7а ангид "Хүндлэл гэж юу вэ?", "Охид хөвгүүд бие биенээ

хэрхэн ойлгож хүндлэх вэ?", "Гэр бүл, найз нөхөд орчин тойрондоо хэрхэн хүндлэл хайрыг бий болгох вэ?" гэдэг талаар сургалт мэдээлэл орж хамтран ярилцлаа.

- Хөвсгөл аймгийн Социал демократ Монголын эмэгтэйчүүдийн холбооны дарга Д.Бямбадалайтай хамтран ”Хандлага гэж юу вэ?”, “Орчин тойрондоо хэрхэн эерэг хандлага түгээх вэ?” сургалт, мэдээлэл авлаа.



2.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын тогтоол-3, Засгийн хуралдааны тэмдэглэл -5, УИХ-ын байнгын хорооны тогтоол-1, Засгийн газрын албан даалгавар -1, нийт 10 шийдвэрийн 12 заалтыг хяналтанд авч ажилласан. Хэрэгжилт – 100%

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05-ны Дугаар 2022_6

1.2.""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд “Алсын хараа-2050” 9 боть номоор үзэсгэлэн гаргаж, уншигчдад мэдээлэл, танилцуулга хийсэн.

2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 41 дүгээр тэмдэглэл 2023-10-11

Дугаар 2023_41

1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт

Байгууллагын орчны хог хаяглыг 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр арын хашаа болон урд замын хашаа хайсны хог хаягдлыг цэвэрлэн, гэр хороололд амьдардаг албан хаагчдадаа хашааны эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх чиглэл өгч ажиллаа.

Мөн бүх нийтийн хог цэвэрлэгээнд идэвхтэй оролцож хавар болон намар 4-р хорооноос хойш 400метр газрыг байгууллага хамт олноороо цэвэрлэлээ.

Орон нутгийн болон улсын чанартай авто зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээг Тариалан сумын нутаг дэвсгэр дээр 3 км газрыг цэвэрлэв.

Байгууллагын орчны цэвэрлэгээг арын хашаа, урд талын талбайн хайсны хог хаягдлыг авч, бут сөөгийг усалж бүх нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцсон.

3.МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

7 үндсэн чиглэлийн хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөн ажилласан.

Хэрэгжилт – 100%

100% буюу үр дүнтэй бүрэн хэрэгжсэн -7

Соёлын тухай хуулийн 24.1.2

“Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх талаар холбогдох сургалтыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэн тогтвортой ажиллуулах” арга хэмжээний хүрээнд:

- Ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, хувь хүний хөгжил, эрүүл мэнд, идэвхтэй хөдөлгөөн, хүний нөөцийн болон бусад чиглэлээр цахимаар 21, танхимаар 18 нийт 39 төрлийн 4 цагаас дээш сургалт хамрагдаж 3 арга хэмжээнд оролцсон.
- МҮНС-тай хамтран10 албан хаагчдад 16 цагийн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан.
- Мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажиллуулахад анхаарлаа хандуулан ажиллаж байгаа бөгөөд сул /түр/ гарсан орон тооны нээлтэй зарыг цахим сүлжээнд байршуулан, хүсэлт гаргасан иргэдийн материалыг бүртгэн, сонгон шалгаруулалтын зарчмаар ажлын байранд авч, ажиллуулж байна.



Соёлын тухай хууль 37.9, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 21.1.16, 22.1.17

“Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх” зорилт арга хэмжээний хүрээнд номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Номтой нөхөрлөе” сарын аяныг өрнүүлж, Мөрөн сумын ахмадын хорооны чийрэгжүүлэх 8 төвд, Ахмад настны асрамж үйлчилгээний төвд зөөврийн номын сангаар 356 ширхэг ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчилсэн.

Номын сангийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх зорилгоор Мөрөн сумын хэмжээнд 1-12 дугаар ангийн тусгай хэрэгцээт хүүхдийн судалгааг гаргаж, “Хамтдаа уншъя, хамтдаа хөгжье” уриан дор Титэм ерөнхий боловсролын сургуулийн тусгай хэрэгцээт "Дэлбээ" бүлгийн сурагчдыг урьж, номын сангийн үйл ажиллагаатай танилцууллаа. "Дэлбээ" бүлгийн сурагч Ану-Үжинд "Номын богц" үйлчилгээг 5 удаа хүргэж, түүний номын тэмдэглэл, хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргаж уншигч, үйлчлүүлэгчдэдээ танилцуулсан.

“Аутизмыг таниулах дэлхийн өдөр”-өөр цахим орчинд постер мэдээллийг түгээж, аймгийн “Аутизм ба гоц ухаан” НҮТББ-тай хамтран “Номын богц” үйлчилгээг 4 уншигчид хүргэж үйлчиллээ.

ШШГГ-т байгаа 4-5 тусгай хэрэгцээт уншигчдад 40-50 ширхэг ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчиллээ. Тухайн иргэдэд номын богц үйлчилгээг хүргэхдээ 10 дугаар сарын 16-28-ны хугацаанд номын түрээсийн төлбөрөөс чөлөөлөн ажиллалаа.

Сонсголын бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй болон бусад уншигчиддаа зориулсан номын үзэсгэлэн гаргасан.

(Тусгай хэрэгцээт “Дэлбээ” бүлгийн сурагчидтай ажиллаж байгаа нь)

(Ахмадын асрамж үйлчилгээний төвд)

Бүх нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.17, Номын сангийн тухай хуулийн 23.2, 24.4, БСШУСайдын 2018 оны А/683 дугаар тушаал, МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг
“Дэлхийн номын өдөр”, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” арга хэмжээ”-ний хүрээнд

“Дэлхийн яруу найргийн өдөр”, “Хүүхдийн номын өдөр”, “Дэлхийн номын өдөр”,
“Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд- 2023” “Хүүхэд бүр уншигч” уриатай 33 дахь хаврын баярын үйл ажиллагаа, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” “Номтой монгол” уриатай 34 дэх намрын баяр зэрэг үйл ажиллагааг тэмдэглэн өнгөрүүллээ. Нийт 5 төрлийн эвэнт арга хэмжээг зохион байгуулж сургалт, мэдээ мэдээлэл, сурталчилгааны, үзүүлэн

таниулах, уралдаан тэмцээн, уулзалт, хэлэлцүүлэг, номын худалдаа зэрэг чиглэлээр 54 төрлийн ажлыг зохион байгуулж, танхимаар 17556, цахимаар 31000 гаруй уншигч иргэдэд хүрч үйлчилсэн байна. Эдгээрээс дурьдвал:

- Аймгийн Нийтийн номын сангийн гадна талбайд нээлтээ хийж, номын баярын хүрээнд хийсэн ажлуудаа тайлагнаж, “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-үүд болон уралдаан тэмцээнд идэвхтэй оролцсон уншигч үйлчлүүлэгчидээ шалгаруулж, шагнал урамшуулсан.
- Мөн энэ үеэр уншигч хүүхдүүдийн урлагийн тоглолт, Шинэ номын үзэсгэлэн, “Үндэсний бичиг-бидний өв” сэдэвчилсэн номын үзэсгэлэн, уншигчдын номын тэмдэглэлийн үзэсгэлэн, ном солилцоо, хуучин номын худалдаа зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

Уг арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

1. 7 сарын 1-нээс 9 сарын 1-нийг хүртэлх хугацаанд "Зуны зугаатай уншлага" зөөврийн номын сангийн үйлчилгээг "Хамтдаа уншья-Хамтдаа хөгжье" уриан дор аймгийн төвөөс 2 км-ийн зайд орших Соёмбо цогцолборт тогтмол явууллаа. Энэ үйл ажиллагааны хүрээнд "English spelling" тэмцээн, чанга уншлага, боловсролын хөтөлбөрийн хүрээнд Үүчүүр, хорол, алаг мэлхий өрөх зэрэг ардын уламжлалт тоглоом наадгайг зааж сургах, хамтдаа тоглох зэргээр тэнд зорин очсон хүүхэд залуучуудыг номтой нөхөрлөх хүсэл эрмэлзлийг төрүүлэх, чөлөөт цагийг нь үр дүнтэй өнгөрөөхөд ач холбогдолтой ажил болсон. Энэ хугацаанд нийт давхардсан тоогоор 1200
2. орчим уншигч, иргэсэд хамрагдаж, 2700 ширхэг ном хэвлэлийг зөөврөөр гаргаж уншлага үйлчилгээ үзүүлжээ.
3. Номын сан хөмрөгөө сурталчлах, мэдээлэх зорилгоор "Номд хөтлөх ухаан", "Томруулдаг шил" танин мэдэхүйн булангаараа сэдэвчилсэн болон шинэ номын, тэгш ой тохиож буй зохиолчдын, тэмдэглэлт баяр, өдрүүдийг тохиолдуулан гаргасан үзэсгэлэнг 80 удаа, танин мэдэхүйн мэдээ мэдээллийг 32 удаа тус тус бэлтгэн цахимаар түгээсэн бөгөөд нийт 4000 гаруй хүнд хүрсэн байна.

4. Номын сангийн үйлчилгээний хүртээмж, чанар болон уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Шилдэг уншигч-Төрийн албан хаагч”, нутгийн зохиолч МУСГЗ Д. Даваанямын уран бүтээлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Хамгийн өвөрмөц номын тэмдэглэл”, “Урнаар өгүүлэхүй” уран уншлагын уралдаануудыг нас насны ангилалаар зохион байгуулсан. Хамрагдсан хүүхдүүдийн номын тэмдэглэлээр үзэсгэлэн гаргаж, уран уншлагад оролцсон хүүхдүүдийг цахимаар сурталчилж олны хүртээл болгосон. Энэ үйл ажиллагаанд нийт 112 хүүхэд хамрагдсан бөгөөд тэд бие биенээсээ суралцаж, урам зориг, санаа сэдэл авч, тухайн зохиолчийн намтар, уран бүтээлтэй танилцаж, шүлгийг нь цээжилсэн үр дүнтэй ажил болсон.

Номын тэмдэглэл:

1–р байр /Мөрөн Гурван –Эрдэнэ ЕБС-ийн 12в анги Б. Нямсүрэн

2-р байр /Авьяас сургууль 11а анги/ Б. Билгүүнзаяа

3-р байр /ЭДЦС-ийн 9а анги/ Б. Хишигбаяр

Тусгай /Мөрөн-Гурван-Эрдэнэ ЕБС-ийн 12в анги/: И. Ариунзаяа

Тусгай: /Мөрөн Гурван-Эрдэнэ сургууль 9в анги/ Анх-Оргил

Уран уншлага:

1–р байр Авьяас сургуулийн 7в ангийн сурагч Д. Мөнхзаяа

2–р байр ЭДЦС-ийн 5а ангийн А. Анир /

3 –р байр/ Нутгийн аваргууд сургууль 2в ангийн сурагч А. Балжинням

Тусгай: /ДМЦС-ийн 2в анги/ Б. Урансолонго

Тусгай: /Жаргалант сум 6а анги/ Н. Түвшинсайхан

Тэргүүний уншигч төрийн албан хаагч:

1-р байр Төмөрбаатар овогтой Наранхүү / Сод-Эрдэм сургуулийн сургалтын менежер/

2-р байр Отгонсүрэн овогтой Энхжаргал / Хилийн цэргийн 0257 ангийн Хангалт үйлчилгээний тасагийн Үндсэн хөрөнгийн нярав/

3-р байр Батсуурь овогтой Оюунцэрэн /Титэм ЕБС-ийн Түүх нийгмийн багш/

4.Мөрөн сумын ЕБС-иудын ахлах ангийн 80 сурагч, Түүх нийгмийн багш нарт "Монголчуудын эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйл" сэдвээр Соёл урлагийн газрын мэргэжилтэн Г.Галтболдыг урьж, сургалт зохион байгууллаа.

5.Жил бүр мэргэжил нэгт нөхдөө ажил үйлсээрээ манлайлсан аймгийнхаа шилдэг номын санчийг шалгаруулж МУСГЗ Д.Сүрэнжавын нэрэмжит шагналыг гардуулдаг. Энэ жилийн шилдэг номын санчаар Шинэ-Идэр сумын нийтийн номын сангийн номын санч Д.Батцэцэг шалгарч өөрийн онцлох ажил, арга туршлагын талаар ярьж, уншигчдынхаа бүтээлээр үзэсгэлэн гаргалаа. Энэ нь хөдөөгийн номын санчдын мэргэжлээрээ бахархах сэдлийг төрүүлэх, ажилдаа амжилт гаргах урам зоригийг бадрааж өгдөгөөрөө ач холбогдолтой.

1.“Номын богц” үйлчилгээнд төрөхийн хүндрэлийн улмаас бусад хүүхдүүд шиг гүйж ярьж чадахгүй ч 4 наснаасаа эхлэн уншиж сурсан, номд маш их дуртай 14 настай Э.Ану-Үжин охиныг хамруулж, нийт 500 гаруй ном хэвлэлээр үйлчилсэн нь өөрийгөө хөгжүүлэх, нийгэмшүүлэх нөцхөл боломжийг олгоход чухал нөлөө үзүүлсэн.

2.“Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн”-үүдээ тодрууллаа. Үүнд:

Титэм ЕБС-ийн 11в ангийн сурагч Т. Мичидмаа

Эрдмийн Далай Цогцолбор сургуулийн 10б ангийн сурагч Н. Ариунхишиг

Титэм ЕБСийн Дэлбээ бүлгийн сурагч Э. Ану-Үжин

Титэм ЕБС-ийн 10г ангийн сурагч Э. Бадамзул

Титэм ЕБС-ийн 10б ангийн сурагч Н. Долгорсүрэн

Соёлын тухай хуулийн 4.1.2, 14.2.1, Монгол хэлний тухай хуулийн 7.2, 14.1.1, 17 дугаар зүйл "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III" 3.2.15."Монгол бичгийн өв соёл, сурвалж, судалгааг сурталчлах, монгол бичгээр дагнасан үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулах" зорилт, арга хэмжээний хүрээнд:

- Хөвсгөл аймгийн Нутгийн аваргууд ЕБС-ийн сурагчид, багш ажилчид, эцэг эхийн дунд "Ном, Судар, бүтээл " монгол бичгээр хэвлэгдсэн ном, хэвлэлийн бүтээлээр үзэсгэлэн, соёл олон нийтийн ажил зохион байгуулж, нийт 715 уншигч хамрагдлаа.
- Үндэсний бичгээр аймгийн "Тэргүүний хурдан уншигч" шалгаруулах тэмцээнийг Боловсрол Шинжлэх Ухааны газартай хамтран зохион байгуулаа. Нийт 17 сургуулийн ахлах болон дунд ангийн ангилалд 72 хүүхэд оролцож, шилдгүүдээ тодруулплаа.
- Гэрээр ном олгох танхимд монгол бичгээр хэвлэгдсэн ном хэвлэлийн сан хөмрөгийг нэмж байрлуулан чөлөөт сонголтоор үйлчилгээ үзүүлж байна.
- Долоо хоног бүрийн мягмар лхагва, гаригт албан хаагчдын дунд минутын уншлага хийж байгаа нь монгол бичгийнхээ чадварыг дээшлүүлэхэд ахиц гарч ажилтан албан хаагчдын 80%-нь үндэсний бичгээрээ уншдаг болсон

4.АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 66 ажил төлөвлөн ажилласан. Хэрэгжилт 100%. Үүнээс 100% тай буюу үр дүнтэй бүрэн хэрэгжсэн -51, хэрэгжилт тооцохгүй -15 арга хэмжээ байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах ажлын хүрээнд 2023 онд 6 зорилтын хүрээнд 21 арга хэмжээ төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд гүйцэтгэлийг 100%-тай тайлагнан Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн.

“Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлнэ” зорилтын хүрээнд:

- “Цахим соёл” арга хэмжээ
- “Бүх нийтийн соёлын боловсрол”
- “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн тайлагнан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон байгууллагын үйл ажиллагааг Хөвсгөл Нийтийн номын сан цахим хаягаар цаг тухай бүрд нь мэдээ мэдээлэл, зохион байгуулагдах гэж буй ажлуудыг контент, live, бичлэг хэлбэрээр сурталчилж бусад группт шейр хийж түгээдэг. Мөн Соёл, урлагийн газраас Хөвсгөлийн өнгө, Түмний телевизүүдтэй хамтран ажиллах гэрээ хийгдсэний дагуу зохион байгуулагдаж буй ойн баяр, тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээний бичлэгийг live, болон бичлэгээр хүргэж ажилладаг.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гарсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 2023 оны байдлаар байгууллагад хандсан уншигч, үйлчлүүлэгчдээс ирсэн өргөдөл гомдол байхгүй, байгууллагын албан хаагчдаас чөлөө олгохыг хүссэн өргөдөл 5, ээлжийн амралт авахыг хүссэн өргөдөл 15, жирэмсний амралт олгохыг хүссэн 1, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан 3, ажилд орохыг хүссэн өргөдөл 5 ирж шийдвэрлэгдсэн.

Өргөдөл гомдлын тайланг хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Байгууллага бүр веб сайтад байршиж буй мэдээллийг тайлагнах ажлын хүрээнд “Бидний номын сан” цахимаар мэдээ, мэдээллийг түгээх аянаар

- Номд хөтлөх ухаан булангаар нийт- 151
- Номын сангийн эргэн тойронд булангаар нийт – 151ш
- Томруулдаг шил булангаар нийт- 56ш нийт 358 мэдээ, мэдээллийг бэлтгэж

https://www.facebook.com/nomiinsan.kh, https://www.facebook.com/KhuvsgulLibrary хаягаар нийтэд сурталчилсан нь 91902 хүнд хүрсэн байна.

Цахим орчинд нийтэлсэн 358 мэдээ мэдээллээс видео пост -41, зурган пост -263 текст пост-54 байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган нээлттэй байх 68 төрлийн мэдээллийг холбогдох хэлтэст цаг хугацаанд нь тайлагнасан.

Байгууллагын дэргэд ёс зүйн хороог байгуулж, иргэдээс төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой ирүүлсэн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх, төрийн албан хаагчдад сургалт, мэдээлэл өгөх ажлын хүрээнд: Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх , соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажилд байгууллагынхаа ажилтан, албан хаагчдыг Монгол Улсын Соёлын яам, болон Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн танилцуулга, тайлбарт сургалтанд цахим болон танхимаар бүрэн хамруулсан.

Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтууд, Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага, байгууллагын дотоод журмыг зөрчсөн зөрчил, энэ талаар иргэдээс ирсэн өргөдөл гомдол байхгүй байна.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” шинээр батлагдсантай холбогдуулан байгууллага бүр ёс зүйн дэд хороотой байх заалтыг журмын дагуу хэрэгжүүлж, ажил хэрэг болгох ажлыг 2024 оны 1 сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Байгууллагын албан хаагчдад “Стрессгүй ажлын байр” сургалтыг ГБХЗХГ-тай хамтран зохион байгуулсан.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэд олон нийтэд эрх зүйн сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах талаар төлөвлөлт хийж үр дүнг тооцох ажлын хүрээнд архи тамхины талаарх мэдээллийн олон эх сурвалжид дүн шинжилгээ хийх, иргэд олон нийтэд үнэн зөв мэдээлэл олох үүднээс “Архи, тамхины хор хөнөөл” сэдэвт номын үзэсгэлэнг 20ш номоор гаргаж нийт 4000 орчим иргэд уншигчдад хүргэсэн байна.

Номын сангийн пейж хуудсаар үзэсгэлэнд гаргасан ном бүрийн мэдээллийг танилцуулж сурталчиллаа.

Цахим орчинд хүүхдийг аливаа зохисгүй агуулга бүхий мэдээ, мэдээлэл, контентоос хамгаалах, цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалж, аюулгүй зөв, зохистой оролцоход зөвлөгөө мэдээлэл өгөх, цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр аймгийн ГБХЗХГ, Аймгийн Цагдаагийн газартай хамтран Номын сангийн уншигчид, байгууллагын албан хаагчдад "Үе тэнгийнхэний дээрэлхэлтийг таслан зогсооё" мөн "Цахим орчин дахь хүүхэд хамгаалал" сэдвээр ЦГ-ын Хүүхдийн асуудал эрхэлсэн ахлах мэргэжилтэн Г.Бямбахишиг, ГБХЗХГ-ын Хүүхдийн эрх хамгааллын мэргэжилтэн Х.Сэрчмаа нар сургалт, мэдээлэл хийлээ.

Улс, орон нутаг болон бусад эх үүсвэрээр байгууллагад шинээр бий болсон хөрөнгийн бүртгэл хяналтыг сайжруулж, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 10 сая төгрөгийн санхүүжилт авч, уншигч, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан сүүлийн үед хэвлэгдсэн болон нөхөн бүрдүүлэлт хийх шаардлагатай ном хэвлэлийн бүтээгдхүүнээр сан хөмрөгөө баяжуулсан. Баяжилтаар авсан ном хэвлэлийг үндсэн хөрөнгөдөө бүртгэж, хүлээн авсан.

Мөн өөрийн зардлаар шинээр худалдан авсан тоног төхөөрөмж, бараа материал зэргийг тухай бүрд нь бүртгэл хөтлөж, бараа материал болон үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусган ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан Мод тарьж ногоон суварга босгоё аянд албан хаагчид болон албан байгууллагаа идэвхтэй оролцуулах ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон суварга босгоё” аяны хүрээнд нийтээр мод тарих аянд нэгдэж хавар соёмбо цогцолбор дээр 20 ширхэг бургас, намар Нутгийн аваргууд сургуулийн тоглоомын талбайд 30 ширхэг хайлаас мод тарьж усалгаа арчилгаа хийлээ.

Мөн байгууллагын хашаан дах бут, мод, сөөгийг байнга усалж арчилгаа хийж, өрөө тасалгаан дах цэцгийн хөрсийг сольж, тайралт хийн сав солих шаардлагатай цэцгийн савыг сольж хэвшсэн.

“Хоггүй Хөвсгөл” төсөл, Хог хаягдлын менежментийн сайжруулах чиглэлээр байгууллага дээрээ ажил зохион байгуулах ажлын хүрээнд байгууллагын орчны хог хаяглыг 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр арын хашаа болон урд замын хашаа хайсны хог хаягдлыг цэвэрлэн, гэр хороололд амьдардаг албан хаагчдадаа хашааны эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх чиглэл өгч ажиллаа.

Бүх нийтийн хог цэвэрлэгээнд идэвхтэй оролцож хавар болон намар 4-р хорооноос хойш 400 метр газар, орон нутгийн болон улсын чанартай авто зам дагуу Тариалан сумын нутаг дэвсгэрт 3 км газрыг тус тус байгууллага хамт олноороо цэвэрлэв.

Байгууллагын орчны цэвэрлэгээг арын хашаа, урд талын талбайн хайсны хог хаягдлыг авч, бут сөөгийг усалж бүх нийтийнцэвэрлэгээнд идэвхтэй оролцсон. Хог хаягдлыг ангилах хогийн сав хийж байгууллагын үүдэнд байршуулсан.

5.БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Аймгийн нийтийн номын сан 2022 онд 5 үндсэн зорилтын хүрээнд 43 арга хэмжээ төлөвлөн ажилласан. Үүнд: 100%-тай буюу үр дүнтэй бүрэн хэрэгжсэн – 43 арга хэмжээ. Хэрэгжилт 100%

1. **“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023” 33,34 дэхь номын баярын арга хэмжээг зохион байгуулах**

2. 33 дахь номын баяр, “Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2023” арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

<u>Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:</u>

Шинэ номын мэдээ, танилцуулга, подкаст, шторк, цаг үеийн мэдээ мэдээллийг нийтэд сурталчилж танилцуулах зорилготой Номд хөтлөх ухаан, Номын сангийн эргэн тойронд, Томруулдаг шил булан гэсэн гурван буланг ажиллууллаа.

Номд хөтлөх ухаан булангаар нийт – 33

Номын сангийн эргэн тойронд булангаар нийт – 44ш

Томруулдаг шил булангаар нийт – 18ш мэдээ, мэдээлэл бэлтгэж нийт 95 мэдээллийн номын сангийн https://www.facebook.com/nomiinsan.kh, https://www.facebook.com/KhuvsgulLibrary хаягаар нийтэд хүргэж сурталчилсан байна.



“Уучлал ба талархал” сургалт:

Хөвсгөл аймгийн эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгч гишүүн Д.Оюунтай хамтран бусдад баярласан талархсанаа илэрхийлж, уучлал гуйж сурах нь таныг аз жаргалтай болгож оюун санааны хувьд эрүүл, эерэг хандлагатай нэгэн болгох зорилготой “Уучлал ба талархал” сургалтыг зохион байгуулж, 30 гаруй уншигч иргэсдэд музей, номын сангийн ажилтан албан хаагчид оролцсон.

“Угийн бичиг хөтлөх” анхан шатны сургалт:

МУГБ, аймгийн Угийн бичгийн сургагч багш П. Лхагвасүрэнг урьж Титэм ЕБС-ийн Ц. Цэвээнсүрэн багштай 10б ангийханд "Угийн бичиг" хөтлөх анхан шатны сургалтыг

амжилттай зохион байгууллаа. Уг сургалтыг явуулсанаар Өвөг дээдэс, садан төрлөө зөв мэдэх, таних, хүндлэх бахархах, удам угсааныхаа алдрыг ахан дүүс, удмаараа хамгаалах, удам судраа цэвэр ариунаар авч явж, эрүүл чийрэг бие бялдартай иргэдийг бий болгох ач холбогдолтой юм.

<u>Үзүүлэн таниулах ажлын хүрээнд:</u>

Монгол Улсын Төрийн шагналт, Ардын уран зохиолч, яруу найрагч Дэндэвийн Пүрэвдоржийн мэндэлсний 90 насны ойд зориулсан “Хөх даалимбан тэрлэг” номын үзэсгэлэнг 24ш номоор гаргаж 1260 орчим уншигч ирэгсдэд сурталчиллаа.

Монгол Улсын Төрийн шагналт нэрт зохиолч Дэмбээгийн Мягмарын мэндэлсний 90 жилийн ойд зориулан "Найрын ширээний ууц" номын үзэсгэлэнг 30ш номоор гаргаж нийт 2500 орчим уншигч, ирэгсдэд сурталчилж байна.

Монгол Улсын Төрийн шагналт, Ардын уран зохиолч, яруу найрагч Дэндэвийн Пүрэвдоржийн мэндэлсний 90 насны ойд зориулсан “Сэгс цагаан богд” найраглал, “Улаанбаатар минь баяртай”, “Тэмээчин бүсгүйн захидлын хариу”, “Цэнхэр дурдан алчуур” дууны домог зэрэг шилдэг бүтээлүүдийг нь бичлэг болгон номын сангийн Пейж хуудсандаа байршуулж иргэд уншигчдадаа хүргэж үйлчиллээ.



Нутгийн зохиолчдыг алдаршуулах, шинэ номыг сурталчилах, нийтэд түгээх зорилгоор Хөвсгөл аймгийн Галт сумын уугуул Шилдэг бүтээлийн Алтан-Өдийн эзэн зохиолч Ц. Ганболдын "Шувуу зүйрмэглэх зуур" шинэ номын нээлтэнд зориулж аймгийн Утга зохиолын нэгдлийн гишүүдийн ярилцлагыг авч нэгтгэн номын сангийн Пейж хуудасаар дамжуулж нийтэд сурталчиллаа.

Уралдаан, тэмцээн:

33 дахь Номын баяр, "Үндэсний бичиг үсгийн өдрүүд-2023" Монгол бичгийн аймгийн "Тэргүүний хурдан уншигч" шалгаруулах тэмцээнийг аймгийн Боловсрол Шинжлэх Ухааны газартай хамтран амжилттай зохион байгууллаа. Сумын 7 сургуул, төвийн 10 сургуулийн нийт 17 сургуулийн ахлах болон дунд ангиас нийт 70-аад хүүхэд оролцож шилдэгүүдээ тодорууллаа.

Дунд насны ангилалд:

- ✅ I байр- Б.Нарангарав 9Г анги Дэлгэр Мөрөн Цогцолбор Сургууль
- ✅ II байр- Т. Наранцэцэг 8Д анги Титэм сургууль
- ✅ III байр- Н.Анхцэцэг 9Б анги Цагаан-Уул сум

- ✅ Тусгай байр: Анударь 8А анги Эрдэнэбулган сум,
- ✅ Тусгай байр: Даянцэцэг 8А анги Эрдэнэбулган сум

Ахлах насны ангилалд:

- ✅ I байр- Б.Энхмэнд 12А анги Шинэ-Идэр сум
- ✅ II байр- Т. Цэрэнням 11А анги Титэм сургууль
- ✅ III байр- Ч. Мягмарнаран 10Б шинэ-Идэр сум
- ✅ Тусгай байр: Түвшинзаяа 11Б анги Эрдмийн Далай Цогцолбор Сургууль
- ✅ Тусгай байр: Б.Цэрэнням 12А анги Дэлгэр Мөрөн Цогцолбор Сургууль тус тус амжилттай оролцлоо.

<u>Тэргүүний уншигч шалгаруулах болзолт уралдаан:</u>

Үндэсний бичиг соёл-Номын өдрүүд – 2023 үйл ажиллагааны хүрээнд Нийтийн номын сангийнхаа шилдэг уншигчдыг тодоруулж Тэргүүний уншигч Нацагдорж тэмдэгийг нь гардуулан өглөө.

Энэ жилийн тэргүүний уншигчдаар дараах хүүхдүүд тодорлоо.

- Эрдмийн далай цогцолбор сургуулийн 12в ангийн сурагч Дэлгэрмаа овогтой Бямбасүрэн
- Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 11в ангийн сурагч Баасандорж овогтой Нямбат
- Титэм Ерөнхий боловсролын сургуулийн 10г ангийн сурагч Батжанчив овогтой Алтангоо

- Дэлгэр мөрөн цогцолбор сургуулийн 10а ангийн сурагч Цэрэнсодном овогтой Норовсүрэн
- Авьяас сургуулийн 10б ангийн сурагч Бат-Амгалан овогтой Нандин-Эрдэнэ
- Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 10б ангийн сурагч Батцэнгэл Мягмарсүрэн
- Эрдмийн Далай Цогцолбор сургуулийн 5в ангийн сурагч Сүхбаатар овогтой Төгөлдөр
- Эрдмийн Далай цогцолбор сургуулийн 12г ангийн сурагч Сайн баяр овогтой Анударь

<u>Уулзалт, хэлэлцүүлэг</u>

Аймгийн Соёл Урлагийн газар, Аймгийн Утга зохиолын нэгдэлтэй хамтран “Гэгээн цаг” уншигч зохиолчдын уулзалтыг Мөрөн сумын ЕБС-ын утга зохиолын дугуйлангийн сурагчтай уулзах уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтанд урилгаар Хөвсгөл аймгийн Утга зохиолын нэгдлийн тэргүүн, МУСТА, Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт, Гомбын Сэр-Одын нэрэмжит шагналт, яруу найрагч Б. Сарантуяа,шилдэг бүтээлийн Алтан-Өдийн эзэн, Монголын Зохиолчдын эвлийн шагналт, Зохиолч Ц. Ганболд,шилдэг бүтээлийн Алтан-Өдийн хоёр удаагийн эзэн, Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт, зохиолч, яруу найрагч П. Майнбаяр,Монгол Улсын Соёлын Тэргүүний ажилтан, яруу найрагч, найруулагч Ж. Даваадамдин, зохиолч, яруу найрагч О. Элбэгтөгс нар оролцлоо.

Аймгийн Нийтийн номын сангийн дэргэдэх Утга зохиолын дугуйлангийн сурагчидтай Хатгал тосгоны ЕБС-ийн Идэрчүүдийн холбооны сурагчдын төлөөлөл туршлага судлах зөвлөлөх уулзалтыг зохион байгууллаа. Алтан Гадас, Хөдөлмөрийн Гавьяаны Улаан Тугийн Одонт, Ардын Боловсролын Тэргүүний ажилтан, Ахмад багш О. Цулаа багш тус хүүхдүүдэд сургалт, мэдээлэл хийлээ.

Үндэсний бичиг үсэг, номын баяр – 2023 үйл ажиллагааг угтан Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн дэргэдэх Утга зохиолын дугуйлангийн сурагчдын “Дотоод инээмсэглэл” яруу найргийн чөлөөт уншлагыг аймгийн Засаг даргын тамгийн газрын Соёмбо танхимд зохион байгууллаа. Аймгийн Утга зохиолын нэгдэлийн гишүүд, Мөрөн сумын ЕБС-ын багш, сурагчид хүрэлцэн ирж сонирхолоо.

Номын худалдаа:

МЗЭ-ийн шагналт, Алтан өдийн эзэн Ц.Ганболдын "Шувуу зүүрмэглэх зуур" зохиогчийн гарын үсэгтэй шинэ номын худалдааг зохион байгууллаа.Иргэд уншигчдаас хандивласан хуучин номын худалдааг зохион байгуулав.

Уншигч үйлчлүүлэгчдийнхээ дунд "Ном солилцоо" – г ажиллуулав. Нийт 120 гаруй уншигч 200 орчим номыг өөр хоорондоо солилцоо хийв.

Нийтийн номын сангийн уншигчдын бүтээлээр үзэсгэлэн гаргав. Уг үзэсгэлэнд 56 ширхэг уншсан номын тэмдэглэл, 78 ширхэг уншигчийн бүтээл нийт 134 ширхэг бүтээлийг олон нийтэд сурталчлав.

<u>Үйл ажиллагаанд оролцогчдын тоон мэдээ</u>

Нээлтийн арга хэмжээ -321

Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд-1665

Үзүүлэн таниулах ажлын хүрээнд-2161

Уралдаан, тэмцээн-267

Уулзалт, хэлэлцүүлэг-213

Номын худалдаа-467

Цахим-10610

Үйл ажиллагаанд оролцогдын тоон мэдээ-15704

2.Уншлага үйлчилгээ:

Өмнөх оны хувьд уншигч 8100, ирэгсэд 33300, ном олголт 51890 байсан бол энэ онд

уншигч 8450, ирэгсэд 33871, ном олголт 58215 болж өссөн байна. Үүнийг графикаар харьцуулалт хийж үзүүлбэл:



	2022	2023
Уншигч	8,110	8,450
Иргэс эд	33,300	33,871
Ном олголт	56,914	58,215

	2022	2023
Хандив	2,346,800	1,527,700
Төсөв	5,000,000	4,000,000
онхс	3,000,000	10,000,000

3.Сан хөмрөгийн баяжилт:

2022 он болон энэ онд хийсэн сан хөмрөгийн баяжилтийг үнийн дүнгээр харьцуулалт хийж графикаар харуулбал:

4.Ахмад настны хөгжил-хамгаалал:

- Нийтийн номын сангийн захирлын 2020 оны 10 сарын 20-ны өдрийн А/15 тоот тушаалаар “Ахмадын зөвлөл байгуулах тухай”, мөн оны А/13 тоот тушаалаар “Ахмадын сан байгуулах тухай”, 2022 оны 10 сарын 06-ний өдрийн А/34 тоот тушаалын хавсралтаар Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн “Ахмадын сангийн ажиллах журам”-ыг тус тус батлан үйл ажиллагаагаа жигдрүүлэн, хэвийн явагдаж байна.
- Ахмадын сангийн хуримтлалыг ажилтан албан хаагчдаас сар бүр тогтоосон хэмжээгээр мөнгө хурааж, тусгай данс үүсгэн хуримтлуулж байна. Энэ онд 378000 төгрөг хуримтлуулж, өмнөх оны үлдэгдэл 608000 нийт 986000 төгрөгөөс 909872 төгрөгийн зарцуулалт хийгдсэн байна.

“Ахмадын сан”-гийн хуримтлалыг журманд заасны дагуу ахмадуудын эрүүл мэнд, амьдрал ахуй, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, сэтгэл зүйг нь дэмжих зорилгоор бэлэг дурсгал өгөх зэрэг үйл ажиллагаанд зарцуулж байна. Тухайлбал:

- Өндөр настан П.Нямжавын өргөдөл хүсэлтийг “Ахмадыг зөвлөл”-өөр хэлэлцэн сангаас 100000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж
- “Хаврын дархлаажуулалт”-ын аяныг жил бүр зохион байгуулж, энэ жил нийт 10 хүнд 100000 төгрөгөнд “Витаминжуулалтын багц” бэлгтэн хүргэж, санал сэтгэгдлийг нь сонсох ажлыг зохион байгууллаа.
- Өндөр настнуудаа төрийн дээд одон медальд тодорхойлж, холбогдох анкетыг маягтыг бэлтгэн дээд газарт хүргүүлж байгаагийн үр дүнд сан хөмрөгчөөр ажиллаж байгаад гавьяаныхаа амралтанд гарсан П.Ваняд “100 жилийн ойн медаль”-иар шагнуулсанд баяр хүргэж, ахмадын сангаас бэлэг дурсгалын зүйлс гардуулсан.
- Шинэ жилийн баярыг тохиолдуулан ахмадуудынхаа гэр гэрт нь очиж, мэндчилгээ дэвшүүлж, баярын ширээний бялууг нь гардууллаа.

“Олон улсын Ахмадын өдөр”-ийг номын сангаас тэтгэвэрт гарсан ахмадуудынхаа дунд жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг. “Олон улсын Ахмадын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж, 10 сарын 25-ны өдөр ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

- Ахмадуудынхаа баярын нээлт хийж, энэ онд номын сангийн үйл ажиллагаа болон ахмадуудын дунд хийсэн ажлын талаар номын сангийн захирал Э.Даваачулуун товч мэдээлэл хийлээ.
- Нийтийн номын сангийн Ахмадын зөвлөлийн дарга Б.Дашхүү “Ахмад настны тухай хууль”-ийн талаар “Та үүнийг мэдэх үү?” мэдээлэл бэлтгэлж сонордууллаа.
- Ахмадуудын дунд “Үг таая” хөгжөөнт тэмцээн, “Дартс”-ын тэмцээнүүдийг зохион байгуулсан.
- Номын сангийн залуу үеийн төлөөлөл ахмадууддаа зориулж, мэндчилгээ дэвшүүлж, ахмадууд өөрийн бичсэн номоо номын сандаа хандивлах үйл ажиллагаа явагдлаа.
- Баярын үйл ажиллагааны үеэр “Ахмадуудаа сонсоё” чөлөөт ярилцлагыг зохион байгуулж, тэдний санал сэтгэгдлийг сонсож, өөрийн үйл ажиллагаанд тусгах, мөн цаашид хэрэгжүүлэх ажлын талаар нэгдсэн саналд хүрлээ.
- Ахмадууд маань номын сангийн байр, танхимуудаар явж өөрсдийн арга туршлага, үүх түүхээ ярилцаж, дурсамжаа сэргээлээ.
- Мөн энэ үеэр Аймгийн СУГ-аас зарим ахмадуудад гарын бэлэг гардууллаа.

- Тэмцээнд идэвхтэй оролцсон ахмадууд болон хүрэлцэн ирсэн бүх ахмадууддаа Нийтийн номын сангийн дэргэдэх “Ахмадын сан”-аас гарын бэлэг өгсөн.

Дээрх уламжлал болгон зохион байгуулдаг ажлуудаас гадна

- Аймгийн Нийтийн номын санд бүртгэлтэй, энэ байгууллагаас өндөр настны тэтгэвэр тогтоолгосон ахмадуудынхаа мэдээллийн санг бүрдүүлж, байнга шинэчилж, баяжуулж байна. Энэ мэдээллийн санд тухайн ахмадын овог нэр, нас хүйс, ажилласан жил, ажилласан байдал, шагналын бүртгэл, ам бүлийн тоо, гэр бүлийн байдал, өрхийн орлого, амьжиргааны түвшин, гэрийн хаяг, утасны дугаар гэх мэдээллүүд багтаж байна.7-р хороонд байрлах “Дүүрэн билэг” ахмадын төвд номын булан байгуулж, ном хандивлах үйл ажиллагаа зохион байгуулсан.Олон улсын Ахмадын өдөрийг угтсан 8 төрөлт спортын наадамд мөнгөн дэмжлэг үзүүлсэн.

6.“НЭРЛЭСЭН ЖИЛ”-ИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

“Хөвсгөлд зочлох жил” аймгийн нэрлэсэн жилийн ажлын хүрээнд 6 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 100%-тай байна.

- “Хөвсгөл аймагт заавал үзэх 10 газар”, “Хөвсгөлийн зургаан ястан” танилцуулга мэдээлэл бэлтгэж цахим хуудсаар сурталчилсан.
- Дотоод, гадаадын жуулчдад зориулан Соёмбо цогцолборт байрлах Мэдээллийн төвд “Зуны зугаатай уншлага” зөөврийн номын сангийн үйлчилгээг, аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн үйлчилгээ болон аж ахуй нэгжийн танилцуулга боршуур, тараах материалаар үйлчилсэн.
- “Нүүдэлчин” фестивальд Хөвсгөл аймгийн баг бүрэлдэхүүнд багтаж үйл ажиллагаанд оролцсон.
- "Нээлттэй Хөвсгөл - 2023” үйл ажиллагаанд “Соён гийгүүлэгчдийн өлгий нутаг”, “Нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн”, “Шинэ номын худалдаа”, “Номын хандив”, “Зохиолчдын чөлөөт уулзалт” зэрэг арга хэмжээг зохион байгуулж оролцлоо. Хоёр өдрийн үйл ажиллагааны үр дүнд 120 гаруй хандивын номоор сан хөмрөгөө баяжуулж, 5000 гаруй хүнд номын сан болон нутгийн зохиолч, эрдэмтэн судлаачдынхаа уран бүтээлийг сурталчиллаа.
- Соёмбо цогцолборт байрлах Мэдээллийн төвд “Зуны зугаатай уншлага” зөөврийн номын сангаар амрагч иргэдэд үйлчлэхээс гадна номын сангийн шошго бүхийн эко даавуун тор, “Миний номын тэмдэглэл” уншсан номын тэмдэглэл хөтлөх дэвтэр, тэмдэглэлийн дэвтэр, үзэг зэрэг номын санг сурталчилсан худалдааг зохион байгуулж ажилласан. Номын санг сурталчлах 4 бүтээгдэхүүн хийсэн.
- Хөвсгөл аймгийн домог хууч яриа номын үзэсгэлэн

7.ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Нийт 7арга хэмжээ төлөвлөн ажилласан.

Үр дүнтэй бүрэн хэрэгжсэн буюу 100%-тай -6

Хэрэгжилт тооцогдохгүй -1

Хэрэгжилт-100%

Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалтуудад хамруулах

Ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, хувь хүний хөгжил, эрүүл мэнд, идэвхтэй хөдөлгөөн, хүний нөөцийн болон бусад чиглэлээр цахимаар 21, танхимаар 18 нийт 39 төрлийн тус бүр 4 цагаас дээш сургалтад сууж, 3 арга хэмжээнд хамруулсан байна. Үүнд:

- ТББ-ын залуучуудын анхдугаар зөвлөгөөн
- Нээлттэй Хөвсгөл-2023
- Мөрөн сумын хог хаягдлын менежментийг олон нийтийн оролцоотой сайжруулах нь
- Эрүүл зөв хооллолт
- Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөн
- Цахим сургалт Doc.X
- Соёлын салбарын цалингийн талаар хэлэлцүүлэг
- Хөөрхөн залуус
- Анзаар
- Архив албан хэрэг хөтлөлт
- ХАБЭА ажлын байранд болон гамшгийн үед албан хаагчдын аюулгүй байдал, сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах нь сургалт
- Уулзалт сургалт Үндэсний аюулгүй байдлын тухай
- Орон нутгийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах нь
- Соёлын салбарын хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн хэрэгжилт
- “Хяналт шинжилгээ, үнэлгээ болон дотоод хяналтын чиглэлээр салбарын албан хаагчдыг чадавхжуулах сургалт
- Зөрчилгүй цахим архив, албан хэрэг хөтлөлт
- Нийгмийн даатгалын багц хууль
- “Хамтдаа нөлөөлье-Өөрчилье” уулзалт зөвлөгөөн
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн тайлбарт сургалт

- Цахим ур чадварыг дээшлүүлэх нь
- Цахим сан хөмрөгийг бүрдүүлэх нь
- Гэр бүлийн хүчирхийлэл,хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь
- Дотоод хяналт, эрсдэлийн тухай ... гэх мэт

Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх

Номын сангийн ажлын байрны онцлог нь их хэмжээний цаас, цаасан бүтээгдхүүнийг нэг дор хадгалдагаас агаарын хэт хуурайшилт, нарийн тоос тоосонцор үүсдэгээс тэнд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр байдаг. Иймд ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргах, ажлын байрны эрүүл, аюулгүй орчны талаар мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор Улаанбаатар хотын “Хэлт энд сэфти солушинс” ХХК-ны үнэлгээний багтай хамтран сургалт зохион байгуулж, 3 өдрийн турш хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгууллаа.

Уг ажлын хүрээнд ажлын байран дахь тоос тоосонцор хэмжээ, дуу авианы түвшин, агаар чийгшилт зэргийг зориулалтын төхөөрөмжийг ажилтанд 8 цаг, ажлын байранд 2 өдөр байршуулан хэмжилт хийсэн.

Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн



Улаанбаатар хотод СУИС, МҮНС-ийн хамтан зохион байгуулсан Ном зүйчийн 1.5 кредит цагийн сургалтанд Сан хөмрөгч хамрагдсан. (замын зардал 120,000)

МҮНС-тай хамтран 10 албан хаагчдад 16 цагийн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан. (сургагч багш нарын зардалд 1,258,200)

Одоогийн байдлаар шилжилт хөдөлгөөн хийсэн ажилтан, албан хаагч байхгүй байна.

8.ӨМНӨХ ОНЫ ДҮГНЭЛТ,ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх, гаргасан алдаа дутагдлыг засах зорилгоор дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- Байгууллагын албан хаагчдыг цахим болон танхимаар 4 удаагийн сургалтанд хамруулсан.
- Холбогдох дүрэм журмын дагуу, хугацаанд нь тайлан мэдээг явуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор Нийтийн номын сангийн захирлын “Бодлогын баримт бичиг, шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө тайлангийн биелэлтийг хариуцан ажиллах тухай” 2023 оны 10 сарын 12-ны А/18 тоот тушаалыг батлуулан, хариуцсан албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусган хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 374 дүгээр тогтоолын нэмэлт өөрчлөлт, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/515, 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/393 дугаар захирамжийг тус тус мөрдлөгө болгоход зориулж, тайлан мэдээ гаргадаг албан хаагч бүрт гарын авлага бэлтгэн өгч, тухай бүрд нь зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллаж байна.

- Аймгийн орон нутгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Ч.Ганцэцэгээс биечлэн болон цахимаар зөвлөн туслах үйлчилгээ авсан.

• Хэрэгжилтийг тайлагнахдаа үр нөлөө, үр дүнг бичих, баримтаар баталгаажуулах, батлагдсан загвар хүснэгтийн дагуу хийх, албан хэрэг хөтлөлтийн стандартыг баримтлах, үг үсэг, утга найруулгын алдаагүй байх хяналтанд авсан заалтуудыг бүрэн хамруулах, үнэлгээ бодитой байх, хэрэгжээгүй бол шалтгаан нөхцөлийг дурьдсан байх зэрэгт анхаарлаа хандуулан тайлан мэдээ бүрийг хянаж, гаргасан алдаа дутагдлыг тухай бүрд нь засуулах ажлыг хийж байна.

9.НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус байгууллагад хамаарах 5 зорилтын 34 шалгуур үзүүлэлтүүдээс үр дүнтэй бүрэн хэрэгжсэн -33, хэрэгжилт тооцохгүй -1 байна. Хэрэгжилт – 100%

Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал

Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;

Бид эрхэм зорилгоо “Аймгийн хүн амын иргэдэд мэдээлэл, соёл боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, бүх нийтэд соёлын боловсрол олгох оршино” хэмээн тодорхойлсон бөгөөд;

- Нийтийн номын санг мэдээлэл-хөгжлийн төв болгон хөгжүүлэх
- Номзүйн мэдээллийг автоматжуулан лавлагаа мэдээллийн сүлжээ бий болгох
- Номын сан хөмрөгийг нийгэм, хувь хүний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн баяжуулж, мэдээллийн өргөн баазыг бий болгох
- Цахим үйлчилгээг өргөжүүлэн стратегийн тэргүүлэн зорилт арга хэмжээгээ тодорхойлон хэрэгжүүлж байна.
- Зорилго, зорилтоо хэрэгжүүлэх ажлын хүрээнд энэ жил нийт 21 сумын соёлын төвийн номын санд үүлэн технологид суурилсан Lib4U программыг нэвтрүүлснээр нэгдсэн каталогид холбогдож, үйл ажиллагаагаа цахимжууллаа.Цахим үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлж, шинэ номын мэдээ мэдээлэл, боловсрол, танин мэдэхүйн ач холбогдолтой “Томруулдаг шил”, “Номын сангийн эргэн тойронд” “Номд хөтлөх ухаан“ зэрэг олон цахим булангуудыг ажиллуулж байгаа нь олон уншигчид, хэрэглэгчдийн хандалтыг аваад байна. Үйлчилгээ, үйл ажиллагааныхаа агуулга, хэлбэрийг боловсронгуй болгохоос гадна бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор байгууллагын дотоод журам

ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулж, ажлын давхардал, хийдэгдлийг арилгахад анхаарч ажилласан.



Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;

Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн болон олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг зэргийг мэдээллийн самбар болон https://www.facebook.com/KhuvsgulLibrary https://www.facebook.com/nomiinsan.kh хаягт байршуулсан



Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;

Номын сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх “Номын сангийн тухай хууль”, “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах болзол журам, “Алдагдсан буюу гэмтээсэн ном хэвлэлийг төлүүлэх журам”, “Ном хэвлэлийг дахин үнэлэх журам”, “Уншлагыг дэмжих журам”, “Нийтийн номын сангийн үйлчилгээний дотоод журам”, “Хөвсгөл аймгийн нийтийн номын сангийн ёс зүйн дүрэм”, “Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм” зэргийг өөрийн үйл ажиллагаандаа нийцүүлэн боловсруулж, уншлагын танхимууд болон мэдээллийн самбар, пэйж хуудсанд цувралаар тавьж байна. Мөн Засгийн газраас

төрийн албанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр бусад эрх зүйн актуудыг мөрдөн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.



ГЭРЭЭР НОМ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ:

1. Хөвсгөл аймгийн Нийтийн номын сангаас номыг гэрээр олгоход энэхүү журмыг дагаж мөрдөнө.
2. Энэхүү журам нь номын сангийн үйлчилгээг хүн бүрт хүртээмжтэй хүргэх зорилготой
3. Энэхүү журмыг ном, хэвлэлтэй харьцаж буй номын санч, уншигч бүр дагаж мөрдөнө.

ХОЁР. ГЭРЭЭР НОМ ОЛГОХ ТУХАЙ:

1. 1-2 хувьтай ном, хэвлэлийг гэрээр олгохгүй, 3-с дээш хувьтай ном хэвлэлийг гэрээр ном олгох журмын дагуу олгоно.
2. 1-3 ширхэг номын 1-5 хоногийн хугацаатай олгоно.
3. Нэг номыг 1 хоногт ашигласаны төлбөрийг 200 төгрөгөөр тооцно.

ГУРАВ. УНШИГЧИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА:

1. Уншигч нь уншихаар авсан ном хэвлэлийг бүрэн бүтэн байдлыг хариуцах ба тогтоосон хугацаанд нь тушаах.
2. Уншигчын эрх нээлгэх төлбөр болон номын түрээсийн төлбөрийг бэлэн мөнгөөр хийх.
3. Хэрэв ном хэвлэлийг алдаж үрэгдүүлсэн, урж гэмтээсэн, өнгө үзэмжийг бууруулсан, мэдээллийн утгыг алдагдуулсан тохиолдолд " Алдагдсан буюу гэмтээсэн ном хэвлэлийг төлүүлэх журам " – ын дагуу төлж номын санг хохиролгүй болгох.
4. Уншигч нь гэрээр ном олгох журмын 2 дахь заалтыг мөрдөж үйлчлүүлнэ.

ДӨРӨВ: НОМ ХЭВЛЭЛИЙГ ТӨЛҮҮЛЭХ

1. Алдагдсан ба гэмтээсэн ном, хэвлэлийг төлүүлэхдээ хөдөлмөрийн хуулийн 63 дугаар зүйлийн 2, 64 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу төлүүлнэ.
2. Уншигч буюу номын санч нь номын сангийн захиргаанаас тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулахгүй бол дараагийн шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.



9. АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

Авилгын эсрэг үйл ажиллагааны хүрээнд 7зорилтын хүрээнд 16 арга хэмжээ төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулж байгаа "Нэгдье" аянд нэгдэж Авлигатай тэмцэх газраас бэлтгэж ирүүлсэн постер шторкийг сурталчлах, түгээх үйл ажиллагааг зохион байгуулан байгууллагын цахим хуудас болон, албан хаагчдын цахим хаягаар тогтмол түгээж нийт 20.000 иргэнд хүргэсэн байна.
- "Авлигын эсрэг" номын үзэсгэлэн тогтмол гаргаж нийт 5000 орчим иргэд уншигчдад сурталчлалаа.
- Манай байгууллагын үйлчилгээ бүгд цахимд шилжсэн нь байгаа тул нийтэд үйлчлэхэд ямар нэгэн хүнд суртал гаргах нөхцөлийг бууруулсан.
  - Төсвийн орлого, зарлагыг тухай бүрд нь шилэн дансандаа байршуулах мөн байгууллагын төсвийн самбарт байрлуулж иргэд албан хаагчдад ил тод нээлттэй мэдээлж байна.

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ТАЙЛАН

НЭГ. НОМЫН САНГИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

1.Уншлага үйлчилгээ

Байнгын уншигч 4076, ирцээр уншигч 39991, тэдгээрт 55032 ном олгож уншигчдад үйлчилсэн байна.

Үүнд: Ном олголт танхимаар 31016 ном, гэрээр 19236 ном Зөөврөөр 4780 байна. Үүнийг танхим тус бүрээр харуулахад:

1.Нийтийн уншлагын танхим байнгын уншигч 1109, ирцээр уншигч 16000, олгосон ном 13800, үүнээс танхимаар 12000, зөөврөөр 1800,

2.Хүүхдийн уншлагын танхим байнгын уншигч 2166, ирцээр уншигч 12065, олгосон ном 20994, үүнээс танхимаар 16731, гэрээр 2263, зөөврөөр 2000,

3. Гэрээр ном олгох танхим байнгын уншигч 580, ирцээр уншигч 11200, олгосон ном 17000, үүнээс гэрээр 13735, танхимаар 2285, зөөврөөр 980,

4. Сан хөмрөг байнгын уншигч 221, ирцээр уншигч 726, олгосон ном 3238 байна.

2. Зөөврийн номын сангийн үйлчилгээ

Зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 40 удаагийн давтамжтайгаар 4000 хүнийг хамруулан 4780 ширхэг номоор үйлчилсэн.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг Батширээт, Баянмөнх, Өмнөдэлгэр, Бэрх, Дадал сумын хилийн цэргийн 0287-р анги, Жаргалтхаан, Баянхутаг нийт 7 сум, ШШГГазар, Бэрх ОУС, төвийн 4 цэцэрлэг, ЕБ-ын Хан Хэнтий ЦС, Тэмүүжин ЦС, ААНБ-д 32 удаагийн давтамжтайгаар, Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн 60 иргэдэд болон ШШГГазартай хамтран гэрээ хийж 8 удаа 240 ширхэг номоор зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлж давхардсан тоогоор 2600 хүнд үнэ төлбөргүй үйлчилсэн.

3. Номын үзэсгэлэн

Номын үзэсгэлэнг 43 удаа 8700 номтойгоор дэлгэж 5350 иргэд олон нийтэд хүргэсэн байна.

Үндсэн хуулийн өдөрт, Эх орончдын өдөрт, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Хан Хэнтийн зохиолчид, Монгол өв соёл, Соёлын сэргэлт аян, зэрэг тэмдэглэлт өдрүүд болон шинэ номын үзэсгэлэнг тус тус гаргаж олон нийтэд танилцууллаа.

Нийтийн номын сангийн сан хөмрөгт байгаа нийт 53644 номыг электрон каталогт бүрэн оруулсан. Хан Хэнтий нутгаас төрөн гарсан нийт 220 зохиолч, яруу найрагчдын судалгаа бүртгэл хийгдсэн ба үүнээс 14 орчуулагчдын намтар, орчуулгын бүтээлээр цахим

мэдээллийн сан бүрдүүлсэн. Цахимаар 130 номын зурагт тайлбар танилцуулга бэлтгэж хүргэсэн байна.

4. Номын баяжилт

2023 онд нийт 301 нэр төрлийн 383 ширхэг 7273.4 мян/төг-ийн номоор сан хөмрөгөө баяжууллаа.

Үүнээс хандиваар 5931,2 мян/төг-ийн 261 нэр төрлийн 338 ширхэг номоор , Төсвийн хөрөнгөөр 40 нэр төрлийн 45 ширхэг 1342.2 мян/төг-ийн ном байна.

Эдгээрээс сан хөмрөгт 52 ширхэг, 1300.5 мян/төг-ийн , Нийтийн уншлагын танхимд 43 ширхэг, 1246.6 мян/төг-ийн

Гэрээр ном олгох танхимд 208 ширхэг, 3426.4 мян/төг-ийн, Хүүхдийн уншлагын танхимд 80 ширхэг 1299.9 мян/төг-ийн номыг тус тус хуваарилж уншлага үйлчилгээнд гаргалаа.

Өдөр тутмын Өдрийн сонин, Үндэсний шуудан болон Утга зохиол, урлаг, Зууны мэдээ, Хүмүүн бичиг, орон нутгийн Хэнтий мэдээ сонингууд, Улирал ба зохиолч, Төрийн мэдээлэл, Өрхийн үйлдвэрлэл зэрэг сонин сэтгүүлийг тус бүр энэ онд нийтдээ 649.2мян.төг-ийн хэвлэлийг захиалан уншигчиддаа хүргэж байна.

Байгууллагын 2021 оны жилийн эцсийн тооллогоор ашиглах хугацаа дуусаж элэгдлээ бүрэн нөхсөн 7930 нэр төрлийн 11300 ширхэг ном актлах хүсэлтийг шийдвэрлэх түвшний байгууллагад хүргэснээс Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 10 дугаар сарын 16-ны 310 тоот шийдвэрийг үндэслэн 7930 нэр төрлийн 11299 ширхэг 7505.441,16 төгрөгийн үнэ бүхий номыг данс бүртгэлээс хасав.

2023 оны эхэнд нийт 53304 ширхэг номтой байснаас 2023 онд жилийн эцсийн байдлаар /актлагдсан 11299 ном хасагдснаар/ **42345** ширхэг номтой боллоо.

5. Номын сангийн каталоги зохион байгуулалт

Цахим сан үүсгэсэн нийт номоос энэ онд 84 буюу уран зохиолын ангилалын номын стандарт бичилттэй тулгалт, хяналт, засварлалт хийж 7000 номны цаасан каталогийг хэвлэж гаргаад байна.

Шийдвэрлэх түвшний байгууллагаас ирсэн шийдвэрийг үндэслэн 7930 нэр төрлийн 11299 ширхэг 7505.441,16 төгрөгийн үнэ бүхий номыг актлаж электрон каталогоос хасалт хийсэн.

6. Сан хөмрөгтөө хадгалагдаж буй ном хэвлэлийн хадгалалт

Сан хөмрөг, Хүүхдийн болон нийтийн уншлагын танхим, гэрээр ном олгох танхимын сан хөмрөгт буй 5020 ширхэг номонд сэлбэн засалт хийсэн.

2022 оны болон 2023 оны өдөр тутмын сонин хэвлэлүүдийг 100% үдэж хэрэглэгчдэд хүргэж үйлчилж байна.

Номын санч бүр уншлаганд гарсан номын ариутгалын төхөөрөмжөөр ариутгаж энэ хугацаанд 7800 ширхэг ном ариутган уншлага үйлчилгээнд гаргасан байна.

7. Lib4U програмд бүрэн нэвтрүүлж цахим үйл ажиллагааг идэвхжүүлж, электрон каталогийн үйлчилгээ

Энэ онд Нийтийн номын сангийн 4 танхим, 19 сумын соёлын төвийн номын сан Lib4U програмд бүрэн нэвтрүүлж цахим каталогит 27895 нэр төрлийн 65328 ном байршуулж уншлага үйлчилгээгээ явуулж байна.

Электрон каталогит байршуулсан номын мэдээллийг олон нийтэд хүргэж танхим хоорондох болон сумдын номын сангуудтай түр шилжүүлгийн бүртгэлээр 639 ном шилжүүлж үйлчилгээнд гаргаж, электрон каталогит 5224 уншигч хайлт хийж хандсан байна.

QR код уншуулж http://khentii.lib4u.net/ электрон каталогт нэвтрэх боломжтой болгож 80 номын мэдээлэл бэлтгэж үйлчилгээний хүртээмжээ сайжруулж байна.

8. Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

Зорилтот буюу тусгай хэрэгцээт бүлгийн иргэдэд энэ онд 4 арга хэмжээ нийт 273 иргэнд, Зөөврийн номын сангийн үйлчилгээг 8 удаагийн давтамжтайгаар 240 номоор 2600 хүнд үйлчилгээ үзүүлээд байна.

Соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тусгай хэрэгцээт буюу Хэнтий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ангид байгаа хүмүүжигч нарт болон зорилтот бүлгийн иргэдийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад нийцсэн номоор тогтмол үйлчилж “Түүхэн эрхмүүдийн цадиг” сэдэвт ярилцлага хэлэлцүүлэг 200 хүмүүжигчийн дунд,

Соёл гэгээрлийн “Та чадна” өдөрлөгийг хөгжлийн бэрхшээлтэй 35 иргэнийг хамруулан зохион байгуулсан. Мөн харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан 5 ширхэг барайл. 2 ширхэг аудио номоор сан хөмрөгөө баяжууллаа.

9. Салбарын статистик мэдээ тайланг хугацаанд нь үнэн бодитой гаргаж хугацаанд нь тайлагнах

7 хоногийн мэдээг Пүрэв гараг бүр, 1 дүгээр улирлын статистик мэдээг тус тус дээд шатны байгууллагад үнэн зөв бодит тоон үзүүлэлт, бичмэл тайланг хугацаанд нь явуулсан.

МҮНСанд 2022 оны жилийн эцсийн хүснэгтэн тайлан, бичмэл тайлан, судалгааг заасан хугацаанд нь хүргүүлсэн.

2023 онд улирал тутмын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж удирдах дээд шатны байгууллагад хугацаанд нь өгч дүгнүүлж ажилласан.

10. Zotero програм ашиглан орон нутгийн “Урагшаа” сонины товч агуулга, мэдээллийг байршуулсан байдал

МҮНСангийн Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санд Zotero програм ашиглан орон нутгийн “Урагшаа” сонины 1982,1996,1997, 1998 онуудын, Хэнтий мэдээ сонины 2019, 2021 онууд, 1985 оны 1-р улирлын нийт 534 мэдээний товч агуулга, мэдээллийг байршуулж үйлчилгээнд нэвтрүүлээд аймгуудын үзүүлэлтээр 2-т эрэмблэгдээд байна.

ХОЁР. ИРГЭДИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Энэ онд соёл олон нийтийн ажлыг 64 удаа зохион байгуулан 22284 иргэд олон нийт хамрагдаж үүнээс: Хүүхэд 16845, ХБИ 213, тусгай бүлгийн 200 иргэн байна.

“Үндсэн хууль бидэнд”, үзэсгэлэн, ярилцлага, “Эх орны дуулал” яруу уншлагын уралдаан, бага, дунд ангийн сурагчдын дунд “Сансар огторгуй миний нүдээр” гар зургийн уралдаан, насанд хүрэгчид, ахлах ангийн сурагчдын дунд “Усыг үнэлэхүй” эсээ бичлэгийн уралдаан, Дэлхийн номын өдөр, Соёлын сэргэлт аяны хүрээнд Ахлах ангийн сурагчдын дунд “Мэргэжил бүхэн сайхан” зочны ярилцлага, “Уран зохиолын кафе” уншигчдын уулзалт, Алтан хонх уралдаант тэмцээн, Оюуны чихэр, Шинэ номын үзэсгэлэн худалдаа, Бийрэн бичлэгийн үзэсгэлэн, үзүүлбэр, Соёлын сэргэлт аян, номтой өдөрлөг, монгол наадгай, бүтээлч урлан, номтой сугалаа, Өртөө өдөрлөг тэмцээн, Хөтөч номын санч, номын сангаа танилцуулъя өдөрлөг, Хуучин сурах бичгийн солилцоо, Номын дүр бидэнтэй сургуулийн өмнөх боловсролын болон ЕБС-ийн бага ангийн сурагчдын дүрийн тоглолт, Мэргэжил бүхэн сайхан ахлах ангийханд зориулсан нөлөөллийн ажил, “Илтгэх урлаг” уран илтгэлийн уралдаан 40 хүүхэд зэрэг тэмдэглэлт өдрүүдэд болон тусгайлан соёл гэгээрэл, нөлөөллийн ажлуудыг тус зохион байгууллаа.

2. Дэлхийн яруу найргийн өдөрт “Хавар...” яруу найргийн чөлөөт уншлага, уулзалтыг МЗЭ-ийн салбар Хэрлэн тооно утга зохиолын нэгдлийн яруу найрагчид, эхлэн бичигч хүүхдүүдийн оролцоотойгоор 2 удаа 60 хүнийг хамруулан,

Номтой зочин, “Дэндүү богинохон хүүхэд нас” зохиолч уншигчдын уулзалтыг Хэрлэн, Баян-Адарга, Биндэр, Батширээт сумдад нийт 4 удаа 500 хүүхдүүдийг хамруулан,

“Яруу найргийн өдөр” дугуйлангийн 40 хүүхдийн уулзалт,

“100 уншигч” уншигчдын уулзалт ярилцлага

Яруу найргийн опен мик 30 хүүхэд,

“Хан Хэнтийн зохиолч яруу найрагчид” сэдэвчилсэн номын үзэсгэлэн, Уншигчийн уран бүтээлийн үзэсгэлэн Нутгийн зохиолчдын болон орон нутгийн түүхэн 80 номын мэдээллийг QR кодтой болгож Хэнтий -100 логотой, Соёлын бүтээлч сар аяны бренд логотойгоор цахимд байршуулсан.

Нийт зохион байгуулсан ажил үйлчилгээ 11, оролцогчдын тоо 1380

3. "Номын баяр-2023” арга хэмжээг 5, 9 дүгээр саруудад “Хил хязгааргүй номын сан” Номын санчдын чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг, Хүүхэд бүр уншигч уриан дор ном бэлэглэх, хандивлах үйл ажиллагаа, Хан Хэнтий 100 жил хүүхдийн уран бүтээлийн үзэсгэлэн, “Бүтээлч уншлага” номын тэмдэглэл хөтлөх аян, “Номын баяр- бидний баяр” гар зургийн уралдаан, “Монгол наадгай” тэмцээн, Номын дүрийн парад, уралдаан, “Шилдэг номын сантай өрх” уралдаан, “Зайрмагтай номын баяр” 1000 зайрмагны баяр, Сонины шаргал хуудаснаа үзэсгэлэн, Шинэ ном, хэвлэлийн худалдаа үйлчилгээ, уншигчийн уран бүтээлийн үзэсгэлэн, бүтээлч урлан, Бүтээлч урлан, Монгол наадгай, Дааганы уралдаан, Аргал түүе, Номтой сугалаа, Шинэ номын танилцуулга, “Тэргүүнийн уншигч Нацагдорж тэмдэгтэн”-ий болзол хангасан хүүхдүүдэд тэмдэг гардуулах ёслол, “Нэг төгсөгч-нэг ном” хандивын аян, ДЗМОУБ-ын Бор-Өндөр 2 хөтөлбөрийн багтай хамтран Бид номонд дуртай өдөрлөгийг 150 хүүхдэд Лидер сурагч академийн гишүүдийн оролцоотойгоор,

Баянмөнх сум, Бэрх соёлын төв, ОУ-ын хөтөлбөрт сургууль, Жаргалтхаан, Өмнөдэлгэр сумын ЕБС, тус сумын Чандган бригадад тус тус номын өдөрлөг хамтран зохион байгууллаа.

Номын баярын хүрээнд нийт 33 арга хэмжээг зохион байгуулж 9156 хүн хамрагдсан. Үүнээс хүүхэд 7646 ХБИ-18

4. Монгол бичгийн өв соёл, сурвалж, судалгааг сурталчлах, монгол бичгээр дагнасан 4 удаагийн үзэсгэлэн гаргаж 1800 иргэд хүүхэд залуучуудад хүргэсэн. Багш, сурагчдын уран бүтээлээр үзэсгэлэн гаргаж иргэдэд уран бичлэгийн гайхамшгийг үзүүлэн энтертайнмет үзүүлбэрүүдийг үзэж сонирхууллаа. Уг арга хэмжээнд насанд хүрэгчид 15, хүүхэд 20, нийт 35 хүн оролцож 120 үзэгч хамрагдлаа.

“Соёлын сэргэлт аян”ы хүрээнд уйгаржин монгол бичгийг сурталчлах түгээх зорилгоор бийрэн бичлэгийн багшийн бүтээлийн үзэсгэлэн гаргаж, нийт оролцогчдод дурсгалын үг бичиж дурсгасан, Иргэдийг соён гэгээрүүлэх, соёлын боловсрол олгох монгол бичгээр бичиж сурах, галиграф бичгийн өв соёлыг түгээн дэлгэрүүлэх ажил үр дүнд хүрч сургууль болон төрийн байгууллага бүр монгол бичгийн сургалт сурталчилгааг хийж хэвшүүлээд байна. Мөн “МНТ”-гоо уншъя уриалга гаргаж

цахимд байршуулсан. Нийт номын санчдын дунд Уран бичвэрийн уралдаан зарлаж 24 номын санч хамрагдсан.

"Монголын нууц товчооны нууцад нэвтэрье" уриан дор бичиг үсгийн баярыг 2023 оны 04 сарын 28, 29-ний өдрүүдэд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум, Хэрлэнгийн хөдөө аралд зохион байгуулагдсан. Аймгийн сургууль, цэцэрлэгийн төлөөллүүд нийт 380 гаруй иргэд оролцсон юм.

Монгол бичгийн уран сэтгэмжит бичвэр, үндэсний түүх соёлын нийт 32 бичвэрийг олон нийтэд,

Байгууллагаараа монгол бичгийн анхан шатны сургалтанд хамрагдаж анхан шатны мэдлэгтэй болсон.

“Эх хэлний өдөр”-т зориулан 65 ш номоор үзэсгэлэн гаргаж сэдэвт үйл ажиллагааг 45 хүүхдийн дунд зохион байгуулсан

Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд 8 арга хэмжээ зохион байгуулж хамрагдалт 2243 байна. Үүнээс хүүхэд 2178. ХБИ-20

4. Хүүхдийн уншлагын танхимын дэргэдэх хүүхдийн дугуйлан “Үлгэрийн цаг”, “Өглөөний уншлага” 10 удаа 200 хүүхдэд, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран “Оролцоод хөгжье” клубыг зохион байгуулж 1-5 дугаар ангийн 90 сурагчдад чадавхжуулах сургалт,

Гэрээр ном олгох танхим нь шүлэг, яруу найрагч бичигч 12 хүүхдүүдийн дугуйланг ажиллуулж уулзалтыг зохион байгуулж тогтмолжуулан ажиллаж байна.

“Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо” зөвлөгөөнд оролцож гэр бүл хүүхэд залуучууд руу чиглэсэн 2 удаагийн сургалт, яриа таниулга зохион байгуулж 30 хүүхэд 10 насанд хүрэгчид хамрагдсан.

ТЦС-ийн Шударга ёс клубтэй хамтран "Эерэг хандлага-хувь хүний соёл" чөлөөт ярилцлага 60 хүүхдэд,

Танхимын дэргэдэх "Хөтөч" клубын хүүхдүүдтэй "Туршлага" чөлөөт ярилцлага,

-Нийтийн уншлагын танхим нь танхимынхаа дэргэдэх Гэрэлт цох хүүхдийн оролцооны клубтэйгээ хамтран "Оролцоод хөгжье" чиглүүлэх сургалтыг 8-10 настай сурагчдын дунд, ДЗОУБ-ын Бор-Өндөр-2 ОНХ-ийн дэмжлэгтэйгээр 40 хүүхдийн яруу найргийн өдөрлөг,

Алслагдсан сумын хүүхдүүдэд зориулан 200 ширхэг 4800.0мян/төг-ийн номын бэлэгтэй өдөрлөгийг 2 удаа зохион байгуулсан,

"100 уншигч" уншигчдын уулзалт ярилцлага,

"Хөтөч номын санч" 10 хүүхэд ажиллуулж "Номын сангаа танилцуулъя" үйл ажиллагааг зохион байгуулж 100 уншигчид уншигчийн эрхийг олгосон байна.

Мэргэжил бүхэн сайхан нөлөөллийн ажлыг эрүүл мэнд, цагдаа, барилгын салбарын төлөөллийг урьж 50 хүүхдэд,

Уншлага үйлчилгээний танхим тус бүр дэргэдэх дугуйлантайгаа хамтран 12 удаа соёл гэгээрлийн ажил зохион байгуулж 692 хүүхэд хамрагдсан.

“Түүхэн эрхмүүдийн цадиг” уншигчийн уулзалт 9 удаа зохион байгуулж 458 хүн хамрагдсан.

“Номын баатрууд бидэнтэй” жүжигчилсэн тоглолт 16 байгууллагын 160 хүүхэд хамрагдсан.

ГУРАВ. СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

1. Уйгаржин бичгийн 10 номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж "Чингис хот буюу Хэнтий аймгийн Дадал сумын Онон багийн уугуул Лүнээхир овгийн хүмүүсийн угийн зураглал" номоор сан хөмрөгөө баяжуулан уг бүтээлд түшиглэн сургагч багштай хамтран угийн бичгийн хөтлөлт, төрөл чиглэлээр сургалт зохион байгуулж 150 хүүхэд хамруулсан.

Байгууллагын нийт албан хаагчид энэ оны хагас жилийн байдлаар 100% угийн бичиг хөтлөөд байна. Сумын нийт 24215 өрхөөс 2023 онд нэмж хөтөлсөн өрх 850, нийт хөтөлсөн өрх-12150 буюу 50%-тай байна.

2. Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх эх хэл боловсрол олгох чиглэлээр Аймгийн засаг даргын ивээл дор "Эх орны дуулал" яруу уншлагын уралдааныг хүүхэд насанд хүрэгчдийн дунд зохион байгуулж 11 том хүн 60 хүүхэд нийт 71 хүн оролцож,

Эх хэл боловсрол, соёл урлагийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор танин мэдэхүйн АХА, "Алтан хонх" , "100 номын хожил" зэрэг тэмцээн уралдаануудыг "Дэлхийн зөн" Олон улсын байгууллагатай хамтран 128 хүүхдэд,

Номын тухай ярилцлага, бүтээлч уншлага номын тэмдэглэл аян бага дунд ангийн 80 сурагчдын дунд,

"Буриад хэл аялга, соёл, ахуй" сэдэвт хэлэлцүүлэг, өдөрлөг 100 хүүхэд 5 насанд хүрэгч оролцож,

Англи хэлний мэдлэгт зориулан ахлан ангийн сурагчдын 10 орчуулгыг олон нийтийн сүлжээгээр хүргэсэн,

“Зуны зугаатай уншлага” 6 удаа зохион байгуулж 106 хүүхэд,

"Эх түүхийн жимээр 2023" аялал Чингис хааны Их аураг орд-ны туурь, Аураг рашаан, Тосон нуур, Жаргалтхаан, Дэлгэрхаан сумын орон нутаг судлах танхимтай танилцах аялал 45 хүүхэд,

“Түүхэн эрхмүүдийн цадиг” өдөрлөгийг ахлах ангийн сурагчид, ШШГГ хүмүүжигч тусгай хэрэгцээт бүлгийн 200 иргэнд, ЕБС-ийн ахлах ангийн **242** сурагчдад нийт **458** олон нийтийг хамруулсан байна.

Энэхүү зорилтын хүрээнд 9 арга хэмжээ зохион байгуулж 1075 олон нийтэд хүрч үйлчилсэн байна.

3. Төрийн шагналт Р.Чойномын нэрэмжит “Эрхин сонет” яруу найргийн наадам боллоо. Уг наадамд Хэрлэн тооно утга зохиолын нэгдлийн болон чөлөөт уран бүтээлч 20 хүн оролцож шүлэг найргаа өргөлөө. Уг наадмын үеэр Чойномын уран бүтээлийн үзэсгэлэнг 80 номтойгоор гаргаж 120 гаруй иргэд олон нийтэд хүргэлээ.

МЗЭ-ийн Хэнтий аймаг дах салбар зөвлөл “Хэрлэн тооно” утга зохиолын нэгдэлтэй хамтран “Хэрлэн” цуврал сэтгүүлийн 10 дах дугаарыг гаргаж 1000ш хувь хэвлүүлж олон нийтэд хүргэсэн.

Хан Хэнтий орчуулагчдын орчуулгын бүтээлийн судалгаа хийж 14 орчуулагчийн танилцуулга бэлтгэж мэдээллийн сан бүрдүүлсэн.

Нутгийн орчуулагчдын намтар номзүйн эх бэлтгэлийн ажил хийгдэж гарын авлага 50 ширхгийг гаргаж уншигчдад ашиглуулахад бэлэн болсон байна.

Аймаг орон нутгийн түүх, алдартнуудын амьдрал, гавъяа зүтгэл, бүтээл туурвилыг Урагшаа сониноос түүвэрлэн зурагт мэдээллийг олон нийтэд хүргэсэн.

Хан Хэнтийгээс төрөн гарсан уран бүтээлчдийн номоор сан хөмрөгөө баяжуулан бүтээл туурвилыг уншигчдад хүргэж байна.

Хан Хэнтий уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд гаргасан шинэ номын эх бэлтгэлд техникийн туслалцаа үзүүлсэн.

ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

1. **Хүний нөөцийг бэлтгэх чадавхижуулах мэргэжил дээшлүүлэх талаар**

Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулахаар Гэрээр ном олгох танхимын номын санч нь СУИС-ийн номын сан судлал эчнээ ангид Номын санч-мэдээллийн ажилтны мэргэжил эзэмшихээр нийт 62 кридет судлан 3.57 голч дүнтэйгээр суралцаж байна.

Байгууллагын ажилтан балбан хаагчид удирдлагын академаас зохион байгуулсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны цахим, танхим хосолсон сургалтанд хамрагдаж үнэмлэх авсан.

Номын сангийн Lib4U програмын анхан болон дунд шатны сургалтуудыг сумдын номын санч нарт цахим, танхимаар 2 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж давхардсан тоогоор 35 номын санч хамрагдсан.

Австралийн элчин сайдын яам, МҮНСантай хамтран “Хил хязгааргүй номын сан” төслийн номын сандаа хэрэгжүүлж аймгийн 38 номын санчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан.

“Нэмэх цэнэг 60 минут” цахим сургалтанд хамт олноороо 8 удаа, Монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтанд 12 удаа Үндэсний бичгийн мэдлэг бататгах цахим бичвэр

танхимын сургалтанд 2 номын санч, Авилга ашиг сонирхолын зөрчилд анхаарах сургалтанд, Архив албан хэрэг хөтлөлт, Нийгмийн даатгалын багц хуулийн хэлэлцүүлэгт 4, Номын санч мэдээллийн ажилтаны 10 дугаар зөвлөгөөн, ТАХ-ын төлөвлөгөө боловсруулах, батлах, тайлагнах,үнэлэх, ТАХ-ын ёс зүйн сургалт, 2023 онд Баянмөнх, Дэлгэрхаан, Хэрлэнбаян-Улаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Батширээт сумын соёлын төвийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж номын санчид мэргэжлийн зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Үүнд хангалттай үнэлгээ авсан 1, дундаж үнэлгээтэй 4 хангалтгүй ажил сайжруулах шаардлагатай 2 номын санч байна.

Нийт 33 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 147 албан хаагчид хамрагдсан.

2. **Нийт төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулж, биелэлтэнд хяналт тавьж ажилласан байдал**

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг дээд шатны байгууллагаар баталгаажуулан нийт ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

3. **Байгууллагын дэргэдэх ХАБЭА-н зөвлөлөөр дамжуулан үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж ажилласан байдал**

Байгууллагын дэргэдэх орон тооны бус ХАБЭА-н зөвлөл нь 1 удаа хуралдаж хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөгөө гаргаж баталгаажуулсан.

Ажилтан, албан хаагчдын эрүүл, тохилог орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажлын хувцсаар жигдэлж, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангаж, албан хаагчдыг эрт илрүүлэгт хамруулан ажилласан.

4. **Байгууллагын дотоод хяналт шалгалт**

Байгууллагын орон тооны бус дотоод хяналт, шалгалт хариуцсан ажилтан тухайн жилд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө гаргаж байгууллагын удирдлагаар баталгаажуулсан.

Нийтийн уншлагын танхимын ээлжит номын тооллогод хяналт тавьж ажиллалаа.

Байгууллагын санхүүгийн бүртгэлд хяналт тавьж ажилласан байна.

ТАВ. ХУУЛИАР ОЛГОГДСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

1. **Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар**

2023 онд гаднаас өргөдөл гомдол ирээгүй, дотооддоо хувийн чөлөө хүссэн өргөдөл 5, бусад өргөдөл нийт 7 өргөдөл байна. Байгууллагын дэргэдэх орон тооны бус Ёс зүйн зөвлөл 1 удаа, ББНШКомисс 1 удаа хуралдсан.

Долоо хоногийн хийсэн ажлын тайланг 1 сард 4 удаа буюу СУГ-ын холбогдох мэргэжилтэнд Пүрэв гараг бүрийн 09:00 цагт хүргүүлж хэвшсэн.

ХХНЖ-ын дагуу 2022 оны 37 баримтыг стандартын дагуу үдэж хавтаслаж архивлав. Үүнд: байнга хадгалах-16 ХН, түр хадгалах-19 ХН, 70 жил хадгалах -2 ХН байна.

Хадгалах хугацаа дууссан 22 баримт бичгийн бүртгэлийг хийж, журмын дагуу бүртгэлээс хасуулахаар архивт шилжүүлхээр бэлдээд байна.

2. **Төсөв, санхүүтэй холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөж ажилласан байдал.**

Тайлант хугацаанд 204.467.5 мян.төг-ийн санхүүжилт авч, 204.467.5мян/төг-ийн бараа үйлчилгээний зардал гарсан. Нэмэлт дансанд 1716.5мян/төг төвлөрүүлэн зарцуулалт бүрэн хийгдсэн байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 2212.5 мян/төг-ийн орлого төвлөрүүлж зарцуулалт бүрэн хийгдсэн байна.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр 11.476.0 мян/ төг-ийг хүлээн авч уран бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд 30%, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, орчин нөхцөлийг сайжруулахад 15%, соёлын ажилтан албан хаагчдын үо дүнд суурилсан цалин хөлсний урамшуулалд 15%-ийг тус тус зарцуулсан.

Шилэн дансанд байгууллагын 136 мэдээлэл байршуулахаас мэдээллийг бүрэн гүйцэд оруулсан.

Соёлын Яамнаас хандиваар 2434.3мян/төг-ийн, Аймгийн ЗДаргын хандиваар 3259,8, нийт 2 ширхэг 5694.1мян/төг-ийн иж бүрэн компьютерын хөрөнгө оруулалт хийгдлээ.

Байгууллагын эд хөрөнгийн тооллогоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ашиглах хугацаа дууссан элэгдлээ бүрэн нөхсөн ном актлах данс бүртгэлээс хасах хүсэлтээ шийдвэрлэх түвшний байгууллагад хүргэсний дагуу ОНӨГ-аас ирсэн шийдвэрийг үндэслэн 7930 нэр төрлийн 11299 ширхэг 7505.441,16 төгрөгийн үнэ бүхий номыг данс бүртгэлээс хасахаар байгууллагын дэргэдэх өмч хамгаалах зөвлөл хуралдаж, байгууллагын дэргэдэх устгалын комисст шилжүүлж дүгнэлтийн дагуу актлаж байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл, номын электрон каталогоос тус тус хасалт хийсэн.

3. **Эд хөрөнгө, үндсэн хөрөнгийн болон ном хэвлэлийн тооллого зохион байгуулсан талаар**

Байгууллагын 2022 оны үндсэн хөрөнгийн тооллого, 2023 оны хагас болон бүтэн жилийн тооллогыг чанартай хийж гүйцэтгэж тайлагнасан.

Байгууллагын даргын тушаалаар тооллогын комисс томилогдож нийтийн уншлагын танхимд номын ээлжит тооллого хийгдэж нийт 14774 ном тоологдож, данс тулгалт бүрэн хийгдэж дууссан.

Нийт 5 удаагийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулж байгууллагын дэргэдэх орон тооны бус өмч хамгаалах зөвлөл 2 удаа хуралдаж тус тооны дүгнэлт гаргасан байна.

4. **Ахмад настны чадамжийг дэмжиж ажилласан талаар.**

Байгууллагын ахмадын сантай болсон. Байгууллагаас гарсан ахмадуудад төсвийн бусад зардлаас сар шинийн өдөр, олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан 300.0мян/төг-ийн мөнгөн тусламж үзүүлсэн. Ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг дэмжих зорилгоор үйлчилгээний ажилтан Б.Батбаярт 100.0мян/төг-ийн, байгууллагын Нягтлан бодогч Ш.Гантуяа зуурдаар нас нөгчсөнтэй холбогдуулан гэр бүлд нь 200.0мян/төг-ийн буцалтгүй тусламжийг үзүүлсэн. Нийт 600.0мян/төг зарцуулсан.

5. **Аймаг орон нутгаас зохион байгуулж буй бүхий л олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох**

Аймгийн 100 жилийн ойг угтаж байгуулагадаа засвар үйлчилгээ хийж, орон нутгаас зохион байгуулж буй олон нийтийн ажилд хамт олноороо 12 удаа идэвхтэй оролцсон.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 28 мод тарьсан.

Хэрлэн сумын Засаг даргын захирамж, албан тооны дагуу “Бүх нийтийн хог цэвэрлэгээг 14 хоног тутамд байгууллагын 50 метр хүртэлх ойр орчмын гудамж талбайн хог хаягдал, цасыг цэвэрлэж хэвшсэн.

6. **Байгууллагын үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчдын хяналтын хуудас хэрэглэх журмын хэрэгжилтийг ханган ажилласан талаар**

Байгууллагын дэргэдэх орон тооны бус “Ёс зүйн зөвлөл” нь энэ улиралд 1 удаа хуралдаж жилийн ажлын төлөвлөгөөгөө гаргаж ажилласан.

Ёс зүйн зөвлөлд ирсэн гомдол, санал байхгүй ба байгууллагын стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна.

7. **Дотоод удирдлагын нэгдсэн системийг / www.Erp.e-mongolia.mn/ албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж хэвшсэн талаар:**

E-Mongolia системийг ажилтан, албан хаагчид бүрэн ашиглаж байна.

E-Mongolia болон Erp.e-mongolia системийн үйл ажиллагааг албан хэрэгцээндээ 100 хувь ашиглаж байна. Энэ хугацаанд ирсэн бичиг 197, үүнээс хариутай бичиг 38 , хугацаанд нь хариуг хүргүүлсэн 38, явсан бичиг 76, захирлын тушаал А-26, тушаал Б-21, хурлын тэмдэглэл 7 тус тус байна.

8. **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар:**

Нийтийн номын сангийн “Хэнтий аймаг Номын сан” олон ниитийн сүлжээнд байгууллагынхаа үндсэн үйл ажиллагааны 910 мэдээ, мэдээлэл байршуулснаас 130 шинэ шилдэг номын мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэйгээр хүргэж ажиллалаа.

“Шударга ёс, хөгжил дэвшил” нээлттэй самбарыг байршуулж 7 хоногийг үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, тухайн оны сар бүрийн санхүүгийн гүйцэтгэлийн мэдээг танилцуулж байна.

1.Уншлага үйлчилгээ, Зөөврийн номын сангийн үйлчилгээ

5. **Номын баяжилт**



6. **Номын сангийн каталоги зохион байгуулалт**

7. Lib4U програмд бүрэн нэвтрүүлж цахим үйл ажиллагааг идэвхжүүлж, электрон каталогийн үйлчилгээ



8. Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

9. Zotero програм ашиглан орон нутгийн "Урагшаа" сонины товч агуулга, мэдээллийг байршуулсан байдал

Тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн санд оруулсан мэдээллийн статистик

№	Номын сан	Шүүсэн хэвлэлийн нэр	Эхний хагаст шүүсэн Он	Оруулсан бичлэгийн тоо	Сүүлийн хагаст шүүсэн Он	Оруулсан бичлэгийн тоо	Нийт бичлэг
1	МУ-ын Үндэсний номын сан	Номын санч,	2023	19			**6868**
		Өнөөдөр	2020-2022	4744	2022, 2023	389	
		Өдрийн сонин	2022	688	2022, 2023	779	
		Зууны мэдээ	2013	249			
2	Улаанбаатар хотын ТНС	Зууны мэдээ	2019	639			**639**
3	СУИС-ийн ТНС	Монголын соёл, урлаг судлал		1244			**1244**
4	Ач АУИС-ийн номын сан	Анагаах ухаан /Монголын анагаах ухаан/	2022, 2023-01	89	2023	15	**104**
5	Баянхонгор аймгийн ТНС	Өнөөгийн баянхонгор	2022-2023	225	2023 оны 2-р хагас жил	22	**247**
6	Дархан ТНС	Найрамдлын дархан			1996	41	**41**
7	Дорнод аймгийн ТНС	Дорнод	2023	151	2023	80	**231**
8	Дундговь ТНС		2018	205			**205**
9	Орхон аймгийн ТНС	Өнөөгийн Эрдэнэт	2019, 2021, 2022, 2023	335	2023	138	**473**
10	Өвөрхангай	Улирал ба зохиолч				40	**40**
11	Өмнөговь аймгийн ТНС	Говийн мэдээ	1959, 1960, 1961, 1962, 1963	903	1964, 1966, 1968, 1970, 1978	876	**1779**
12	Сүхбаатар аймгийн ТНС	Сүхбаатарын өнгө	2023	84		74	**158**
13	Ховд аймгийн ТНС	Ховдын толь	2023	61	2023	24	**117**
		Ховдын мэдээ	2023	32			
14	Хэнтий аймгийн ТНС	Урагшаа	1982, 1996, 1997, 1998	219	1985 оны 1-р улирал	104	**534**
		Хэнтийн мэдээ	2019, 2021	211			
15	Увс аймгийн ТНС	Өглөөний сонин	2022	223			**223**
	Бүгд			**10321**		**2582**	**12903**

10. Соёл олон нийтийн ажил

ЧИНГИСИЙН ТАЛБАЙ-Д
2023.05.19 НД
10:00 ЦАГТ

СҮХБААТАР ХӨГЖЛИЙН ЛИГ

МОНГОЛЫН НОМЫН САНГУУДЫН
СПОРТЫН ОЛОН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН
БАРУУН-УРТ ХОТ 2023.10.27-29
"АНД" KARAOKE & PUB

өргөмжлөл

НАМТАР



11.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар

12. Сургалт

СОЁЛЫН
БҮТЭЭЛЧ САР
БҮТЭЭЛЧ ЗАЛУУС
2023 MONGOLIAN LIBRARY UPDATE

СОЁЛЫН
БҮТЭЭЛЧ САР
БҮТЭЭЛЧ ЗАЛУУС
2023 MONGOLIAN LIBRARY UPDATE

13.Бусад

14.Тооллого



ХАВСРАЛТ
№1 Ном олголт

№	Номын сан	Стандарт хэмжээ	Үйлчилсэн тоо хэмжээ	Хувь	Оноо
1	Дорнод	55000	120185	219	26
4	Дархан ХНО	55000	77954	142	25
6	Хөвсгөл	55000	69689	127	24
2	Улаанбаатар ХоТНС	112500	141184	125	23
8	Ховд	55000	64203	117	22
3	Орхон	112500	129418	115	21
16	Өмнөговь	55000	59816	109	20
7	Баян-Өлгий	55000	56960	104	19
17	Хэнтий	55000	55032	100	18
5	Архангай	55000	50604	92	17
10	Дундговь	55000	42718	78	16
13	Дархан АТНС	112500	75984	68	15
14	Дорноговь	55000	36720	67	14
21	Сэлэнгэ	55000	35589	65	13
12	Төв	55000	35351	64	12
19	Баянхонгор	55000	33429	61	11
20	Өвөрхангай	55000	28046	51	10
11	Увс	55000	27885	51	9
15	МҮНС	130000	61559	47	8
9	ХүТНС	112500	47600	42	7
22	Булган	55000	16187	29	6
24	Завхан	55000	13121	24	5
18	Сүхбаатар	55000	12939	24	4
25	Говь-Алтай	55000	8330	15	3
23	Сэлэнгэ Мандал	55000	8211	15	2
26	Говь-Сүмбэр	55000	5587	10	1

№02 Ирц

№	Номын сан	Тоо хэмжээ	Оноо
1	Дорнод	76523	26
2	Улаанбаатар ХоТНС	69401	25
6	Дархан ХНО	64246	24
3	Орхон	61207	23
4	Дархан АТНС	56202	22
8	Ховд	48601	21
7	Хөвсгөл	43215	20
14	Хэнтий	39991	19
10	МҮНС	32388	18
9	Баян-Өлгий	31895	17
11	Архангай	28461	16
13	ХүТНС	22980	15
16	Дорноговь	16449	14
15	Увс	15503	13
24	Завхан	14200	12
20	Сэлэнгэ	14083	11
12	Дундговь	14049	10
25	Баянхонгор	13915	9
17	Булган	13665	8
5	Өмнөговь	12149	7
18	Өвөрхангай	12149	6
21	Сүхбаатар	9604	5
22	Говь-Алтай	8324	4
23	Сэлэнгэ Мандал	8211	3
26	Говь-Сүмбэр	3214	2
19	Төв	3010	1

№3 Байнгын уншигчид эзлэх ирцийн хувь хэмжээ

№	Номын сан	Стандарт хэмжээ	Байнгын уншигч	Ирц	Хувь	Оноо
7	Ховд	3800	2956	48601	1644	26
16	ХүТНС	7500	1462	22980	1572	25
12	Дорноговь	3800	1102	16449	1493	24
6	Дорнод	3800	5588	76523	1369	23
5	Дархан ХНО	3800	5294	64246	1214	22
3	Дархан АТНС	7500	5235	56202	1074	21
9	Архангай	3800	2840	28461	1002	20
1	Өвөрхангай	3800	2659	26571	999	19
10	Хэнтий	3800	4076	39991	981	18
8	Орхон	7500	7571	61207	808	17
20	Сүхбаатар	3800	1672	9604	574	16
18	Баянхонгор	3800	2534	13915	549	15
22	Завхан	3800	2668	14200	532	14
14	Булган	3800	2648	13665	516	13
17	МҮНС	8000	6700	32388	483	12
11	Дундговь	3800	3000	14049	468	11
19	Төв	3800	2913	13605	467	10
21	Говь-Сүмбэр	3800	701	3214	458	9
15	Хөвсгөл	3800	9515	43215	454	8
4	Өмнөговь	3800	3091	12149	393	7
23	Улаанбаатар ХоТНС	7500	25115	69401	276	6
24	Увс	3800	6960	15503	223	5
25	Баян-Өлгий	3800	16450	31895	194	4
2	Сэлэнгэ Мандал	3800	5333	8211	154	3
26	Сэлэнгэ	3800	10667	14083	132	2
13	Говь-Алтай	3800	7585	8324	110	1

№4 Сан хөмрөгийн баяжилт

№	Номын сан	Тоо хэмжээ	Оноо
2	Улаанбаатар ХоТНС	4313	26
3	МҮНС	3407	25
7	Говь-Сүмбэр	1351	24
4	Дархан АТНС	1181	23
12	Өмнөговь	994	22
9	Дархан ХНО	982	21
8	Өвөрхангай	866	20
6	Ховд	819	19
13	ХүТНС	793	18
10	Баян-Өлгий	773	17
17	Увс	708	16
21	Хөвсгөл	656	15
16	Булган	584	14
24	Төв	569	13
15	Баянхонгор	512	12
20	Дорноговь	490	11
1	Завхан	475	10
22	Дундговь	474	9
11	Сэлэнгэ	426	8
14	Говь-Алтай	426	7
25	Орхон	343	6
18	Хэнтий	338	5
19	Сүхбаатар	336	4
5	Архангай	223	3
23	Сэлэнгэ Мандал	178	2
26	Дорнод	162	1

№05 Сан хөмрөгийн баяжилтад худалдаж авсан номын эзлэх хувь хэмжээ

№	Номын сан	Нийт баяжилт	Худалдаж авсан	Хувь	Оноо
18	МҮНС	3407	997	29.3	26
3	Дархан ХНО	982	982	100.0	25
14	Хөвсгөл	656	573	87.3	24
16	Ховд	819	562	68.6	23
10	Булган	584	484	82.9	22
24	Өвөрхангай	866	451	52.1	21
21	Дархан АТНС	1181	435	36.8	20
5	Баянхонгор	512	396	77.3	19
9	Дорноговь	490	385	78.6	18
11	Төв	569	358	62.9	17
15	ХүТНС	793	350	44.1	16
8	Өмнөговь	994	260	26.2	15
26	Улаанбаатар ХоТНС	4313	228	5.3	14
19	Сэлэнгэ	426	213	50.0	13
6	Орхон	343	208	60.6	12
4	Увс	708	207	29.2	11
23	Завхан	475	202	42.5	10
13	Дундговь	474	200	42.2	9
1	Говь-Алтай	426	189	44.4	8
7	Сүхбаатар	336	167	49.7	7
20	Архангай	223	164	73.5	6
17	Баян-Өлгий	773	100	12.9	5
22	Говь-Сүмбэр	1351	43	3.2	4
12	Хэнтий	338	41	12.1	3
25	Дорнод	162	28	17.3	2
2	Сэлэнгэ Мандал	178	0	0.0	1

№06 Сан хөмрөгийн эргэлт

№	Номын сан	Олголт	Сан хөмрөг тоо	Эргэлтийн хувь	Оноо
1	Дархан ХНО	77954	15861	4.9	26
2	Орхон	129418	36031	3.6	25
3	Дорнод	120185	74829	1.6	24
4	Дархан АТНС	77984	59149	1.3	23
5	Дундговь	42718	41886	1.0	22
6	Төв	35351	36060	1.0	21
7	Баян-Өлгий	56960	59680	1.0	20
8	Говь-Сүмбэр	5587	12964	0.4	19
9	Хөвсгөл	69689	68945	1.0	18
10	Ховд	64203	76707	0.8	17
11	Дорноговь	19439	39972	0.5	16
12	Өмнөговь	59450	43701	1.4	15
13	Увс	27885	72133	0.4	14
14	ХүТНС	47600	92630	0.5	13
15	Архангай	67593	127127	0.5	12
16	Хэнтий	55032	42454	1.3	11
17	Сэлэнгэ Мандал	12376	29520	0.4	10
18	Булган	16187	37256	0.4	9
19	Улаанбаатар ХоТНС	141184	388667	0.4	8
20	Сүхбаатар	12939	51443	0.3	7
21	Сэлэнгэ	35589	47242	0.8	6
22	Баянхонгор	33429	50051	0.7	5
23	Өвөрхангай	28046	49152	0.6	4
24	Говь-Алтай	8330	46515	0.2	3
25	Завхан	13121	56665	0.2	2
26	МҮНС	61559	2722205	0.0	1

№7 Олгосон ном

№	Номын сан	Үйлчлэх хүн ам	Нийт олголт	Хүн амд эзлэх хувь	Оноо
1	Архангай	21849	67593	3.1	26
2	Дундговь	16394	42718	2.6	25
3	Төв	17313	35351	2.0	24
4	Дорнод	47153	120185	2.5	23
5	Ховд	31980	64203	2.0	22
6	Баян-Өлгий	39711	56960	1.4	21
7	Хөвсгөл	42423	69689	1.6	20
8	Орхон	106145	129418	1.2	19
9	Увс	32912	27885	0.8	18
10	Булган	12810	16187	1.3	17
11	Дорноговь	27405	19439	0.7	16
12	Хэнтий	24115	55032	2.3	15
13	Өмнөговь	28854	59450	2.1	14
14	Дархан АТНС	87595	77984	0.9	13
15	Сүхбаатар	23103	12939	0.6	12
16	Говь-Сүмбэр	13152	5587	0.4	11
17	Дархан ХНО	87595	77954	0.9	10
18	Сэлэнгэ	22412	35589	1.6	9
19	Завхан	16580	13121	0.8	8
20	Говь-Алтай	18867	8330	0.4	7
21	Баянхонгор	32454	33429	1.0	6
22	Өвөрхангай	34605	28046	0.8	5
23	Сэлэнгэ Мандал	27017	29520	1.1	4
24	Улаанбаатар ХоТНС	1539252	141184	0.1	3
25	МҮНС	1539252	61559	0.0	2
26	ХүТНС	1539252	47600	0.0	1

№08 Өгөгдсөн лавлагааны тоо

№	Номын сан	Лавлагааны тоо	Оноо
4	Хэнтий	5304	26
2	Сүхбаатар	4300	25
3	Улаанбаатар ХоТНС	4064	24
6	Баянхонгор	2389	23
1	Булган	1680	22
7	Өвөрхангай	1579	21
10	Дорноговь	1254	20
9	Дархан АТНС	1233	19
5	Дорнод	1111	18
8	ХүТНС	1000	17
16	МҮНС	915	16
11	Говь-Сүмбэр	764	15
19	Сэлэнгэ	592	14
14	Дархан ХНО	551	13
12	Архангай	512	12
13	Баян-Өлгий	487	11
21	Завхан	390	10
17	Хөвсгөл	369	9
18	Орхон	322	8
20	Өмнөговь	318	7
22	Увс	264	6
24	Говь-Алтай	199	5
15	Дундговь	193	4
25	Төв	156	3
23	Ховд	151	2
26	Сэлэнгэ Мандал	134	1

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ 04

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН...5-51

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН ……...52-82

Б.БААСТЫН НЭРЭМЖИТ ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН...83-96

АРХАНГАЙ АЙМГИЙН С.ЖАМЬЯНГАРАВЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН...96-126

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН Б. АХТАНЫ НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 127-171

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 172-195

БУЛГАН АЙМГИЙН С.УДВАЛЫН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 196-238

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН Д.СҮРЬЕЭГИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 239-284

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН...284-291

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН....... …………………………………………………………………….............292-326

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН...327-363

ДОРНОГОВЬ АЙМГИЙН А.ЭРДЭНЭ-ОЧИРЫН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 364-383

ДОРНОД АЙМГИЙН Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 384-397

ДУНДГОВЬ АЙМГИЙН С.БУЯННЭМЭХИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 399-409

ЗАВХАН АЙМГИЙН Б.ЯВУУХУЛАНГИЙН НЭРЭМЖИТ ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 410-419

ОРХОН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН..419-429

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН....430-462

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.........462-506

СҮХБААТАР АЙМГИЙН Г.МЭНД-ООЁОГИЙН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.... 507-539

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 539-584

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 585-619

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 620-642

УВС АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 643-686

ХОВД АЙМГИЙН МУСГЗ М.БАЯНЗУЛЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 687-741

ХӨВСГӨЛ АЙМГИЙН Д.СҮРЭНЖАВЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН....742-782

ХЭНТИЙ АЙМГИЙН Р.ЧОЙНОМЫН НЭРЭМЖИТ НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН....783-800

ХАВСРАЛТ 802

ГАРЧИГ....810